

SCIENCE НААДАМ 2023

ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ЗОХИОН
БАЙГУУЛАГЧ



Санхүү Эдийн Засгийн
Их Сургууль



Глобал Эдийн Засгийн
Судалгааны Хүрээлэн

ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХТГЭЛ



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Улаанбаатар хот
2023 он

ННА-74.58
ДАА-378
Э-395



ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Глобал Эдийн Засгийн Судалгааны Хүрээлэн
Ахисан Түвшний Сургууль

“ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл

Эрхлэн гаргасан: **ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН
АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ**

Редакцын зөвлөлийн дарга:

Г.Батхуяг Доктор (Ph.D), дэд профессор

Редакцын зөвлөл:

Ц.Даваадорж	МУ-ын ШУ-ны гавьяат ажилтан, ШУ-ны доктор, хүндэт профессор
Р.Амаржаргал	Доктор (Ph.D), профессор
Д.Батжаргал	МУ-ын гавьяат багш, доктор (Ph.D), профессор
Ж.Батхуяг	МУ-ын гавьяат багш, доктор (Ph.D), профессор
Ж.Сүхбаатар	МУ-ын гавьяат багш, доктор (Ph.D), профессор
Д. Гэрэлмаа	Доктор (Ph.D), профессор
Ц.Батсүх	Доктор (Ph.D), профессор
С.Түвшинзаяа	Доктор (Ph.D), профессор
Ч.Наранчимэг	Доктор (Ph.D), профессор
А.Түвшинтөгс	Доктор (Ph.D), профессор
Т.Цэнд-Аюуш	Доктор (Ph.D), профессор
З.Оюунцацрал	Доктор (Ph.D), профессор
С.Норжинлхам	Доктор (Ph.D), дэд профессор
Т.Оюунгэрэл	Доктор (Ph.D), дэд профессор
Б.Мөнхзаяа	Доктор (Ph.D), дэд профессор
Б.Амарсанаа	Доктор (Ph.D), дэд профессор
П.Авралт-Од	Доктор (Ph.D), дэд профессор
Г.Гантулга	Доктор (Ph.D), дэд профессор
Ю.Хорлоо	Доктор (Ph.D), дэд профессор

Эмхэтгэсэн: Д.Мөнгөнтуул

Цаасны хэмжээ: А4
Үсгийн гарнитур: Times New Roman
Бодит хэвлэлийн хуудас: 75.9
Улаанбаатар хот, 2023 он

©Зохиогчийн зөвшөөрөлгүй энэ номыг олшруулах, электрон хувилбараар бүтнээр болон хэсэгчлэн тараах болон дахин хэвлэхийг хатуу хориглоно.

ISBN: 978-9919-9906-1-9

ГАРЧИГ

НЭГДСЭН ХУРАЛДААН

Дэлхийн эдийн засгийн Полиперма хямрал, эдийн засгийн сэтгэлгээний шинэ хандлага, парадигмууд

*Доктор (Ph.D), профессор Р.Амаржаргал
(Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд, СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн дарга)
Доктор (Sc.D), хүндэт профессор Ц.Даваадорж
(СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн)*

7

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

Гол нэрийн зарим хүнсний барааны нийлүүлэлтийн сүлжээн дэх үнийн асимметрик дамжилт

*Доктор (Ph.D.) Д.Түвшинжаргал (СЭЗИС)
Доктор (Ph.D) П.Гантөмөр (СЭЗИС)
Магистр (MA) Д.Өнөржаргал (СЭЗИС)*

25

Монгол Улсын экспортын тодорхойлогч хүчин зүйлийн судалгаа: Бейсийн загвар дундажлах арга

Магистр (M.Sc) А.Дэлгөөн (СЭЗИС)

39

XX зууны макро эдийн засгийн Д.Кейнс ба М.Фридманы онолууд болон дэлхийн томоохон орнуудын эдийн засгийн бодлогод ашигласан үр дүн

*Доктор (Sc.D) профессор С.Будням (МУЭИС)
Доктор (Ph.D) В.Отгонжаргал. (ОУУИС)*

45

Монгол улсын хүн амын бодлого, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нь.

*Магистр (MBA) Б.Отгонжаргал (УЭИС)
Магистр (M.Sc) Б.Батжаргалсайхан (Оксфордын Их Сургууль)*

52

Зээлжих зэрэглэл ба түүний эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

*Магистр (MPM) Ж.Эрдэнэчулуун (СЭЗИС)
Магистр (MBA) Т.Оюунгэрэл (СЭЗИС)*

68

Монгол Улс болон БНХАУ-ын худалдааны тэнцлийн хоёр талын тодорхойлогч хүчин зүйлс

*Доктор (Ph.D) Ч.Сутъяа (ШУА, Олон Улс судлалын хүрээлэн)
Доктор (Ph.D) Ч.Наранчимэг (СЭЗИС)
Магистр (M.Sc) Ч.Даваасүрэн (СЭЗИС)*

80

Олон улсын худалдаанд тээвэр логистикийн үзүүлж буй нөлөө

Магистр (M.Sc) Цэлмэг (Өвөрмонголийн СЭЗИС)

90

On the Relationship Between Industrial Restructuring and Sustainable Growth of Local Fiscal Revenue in China

Master Zhang Ke, University of Finance and Economics

103

Expansion of trade cooperation between Russia and Mongolia: commodity and regional aspects

*Cand. Sc. (Economics), Associate Professor, SHINKAREVA Olga (Moscow City University)
Doctor of Economics ALEKSEICHEVA Elena (Moscow City University)*

108

The effect of natural resource on economic growth in Transition economies

Master D.Enkh-Amgalan (National University of Mongolia)

113

САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Монгол дахь цахим банк хэрэглэгчдийн хүртээмжийн судалгаа <i>Магистр (МВА) Б.Тулга (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Э.Тамир (СЭЗИС)</i>	123
Mongolian remote communities and digital banking transformation <i>Bolitohtokh. D, Assistant Professor, Financial Management Department of UFE</i> <i>Dashpil. Ya, Senior Lecturer, Financial Management Department of UFE</i>	141
Монголын хөрөнгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь <i>Доктор (Ph.D) Т.Оюунгрэл (СЭЗИС)</i> <i>Магистр (МРМ) Ж.Эрдэнэчулуун (СЭЗИС)</i>	153
“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн I ангиллын хувьцааны өгөөжийн хэлтийлт болон овойлтын эмпирик судалгаа <i>Магистр (МВА) Г.Ичинноров (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Г.Цэлмэг (СЭЗИС)</i>	169
Давхар даатгалын үйл ажиллагаа ердийн даатгалын компанийн гарцад үзүүлэх нөлөөлөл <i>Магистр (МВА) Э.Төгсжаргал (СЭЗИС)</i>	179
The impact of Climate risk on financial performance in Mongolian mining companies <i>Bolitohtokh. D, Department of Financial Management, University of Finance and Economics</i> <i>Enkh-Otgon. G, Department of accounting and analyses, Mandakh University</i>	190
Ипотекийн зээлийн хүү, шимтгэлийн тухай ойлголт, эдийн засгийн ба банкны үр ашгийн хамаарлын судалгаа <i>Доктор (Ph.D) З.Оюунцаирал (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Г.Намуужин (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Г.Ариун-Эрдэнэ (СЭЗИС)</i>	200
ЗАСАГЛАЛ БА МЕНЕЖМЕНТ, БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ	
Залуу ажилтнуудын ажлын байрны үнэт зүйлийн судалгаа. Z үеийнхний жишээн дээр <i>Магистр (МВА) Б.Баярсайхан (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) С.Сайн-Од (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Б.Идэрцогт (СЭЗИС)</i>	214
Клиник эмнэлгийн эмнэл зүйн засаглалыг үнэлэх судалгаа <i>Магистр (МВА) Ц.Үрэлцэцэг (СЭЗИС)</i> <i>Доктор (Ph.D), Д.Гэрэлмаа (СЭЗИС)</i>	222
Хэрэглэгчийн худалдан авах хандлагад нөлөөлөх дэлгүүрийн орчны хүчин зүйлсийн судалгаа <i>Магистр (МВА) Б.Мөнхжаргал (СЭЗИС)</i> <i>Доктор (Ph.D), Б.Оюунтунгалаг (ШУТИС)</i> <i>Доктор (Ph.D) Т.Сүнжидмаа (ШУТИС)</i>	231
Төрийн үйлчилгээний бүтээмжийн хэмжилтэд гарцын индекс чухал болох нь <i>Доктор (Ph.D) Д.Отгонтуяа (Шинэ Монгол сургууль)</i>	245
Суралцагч байгууллагын соёл ба гүйцэтгэлд мэдлэг хуваалцах хүсэл, байгууллагын иргэншлийн зан төлөвийн нөлөөлөл <i>Магистр (МВА) Ц.Азбаяр (Хан Голомт консалтинг)</i>	256
Пигмалион эффектийн нөлөөлөл <i>Магистр (МВА) С.Эрхэмбаяр (СЭЗИС)</i> <i>Магистр (МВА) Б.Идэрцогт (СЭЗИС)</i>	271
Факторы развития трудового потенциала регионального АПК <i>О.А. Каурова (Восточно-Сибирский государственный г. Улан-Удэ)</i> <i>Е.Б. Дондокова (Восточно-Сибирский государственный г. Улан-Удэ)</i> <i>Митюхин Д.С. (Восточно-Сибирский государственный г. Улан-Удэ)</i> <i>Имидеева И.В (СЭЗИС)</i>	280

Төрийн албаны төв байгууллагын хөгжил, чиг хандлага

Доктор (Ph.D), Б.Цауралт (СЭЗИС)

289

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ, ТҮҮНИЙ АСУУДЛУУД

Байгаль орчин, нийгэм, засаглалын шалгуур үзүүлэлтийн компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөөлөл

Доктор (Ph.D) Т.Туяа (СЭЗИС)

Магистр (МВА) Я.Дашипил (СЭЗИС)

304

Тойрог эдийн засгийн туршлагын зөрүүтэй байдлын судалгаа

Доктор (Ph.D), дэд профессор Т.Оюунгэрэл (СЭЗИС)

Магистр (МВА) Б.Баярсайхаан (СЭЗИС)

Магистр (МВА) Г.Сайнбилэг (СЭЗИС)

313

Тогтвортой хэрэглээний ойлголтыг эрхэмлэх зүйлээр тодруулах нь (СЭЗИС-ийн оюутнуудын жишээн дээр)

Магистр (МА) Ц.Гэрэл (СЭЗИС)

Магистр (МА) Ц.Мөнх-Өлзий (СЭЗИС)

Магистр (МВА & MSc) Г.Дагвасүрэн (СЭЗИС)

327

Монголчуудын гадаадын жуулчинд хандах хандлага

Бакалавр Б.Мөнхзул (МУИС)

338

ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

“Суурь боловсролын чанарыг ахиулахад мэдээлэл, харилцааны технологийг оновчтой ашиглах нь” төслийн үр дүнгийн судалгаа

Доктор (Ph.D) Ж.Сүхбаатар (СЭЗИС)

Доктор (Ph.D) Юмэ Ямагучи

349

Цахим гэмт хэрэг ба өнөөгийн байдал

Доктор (Ph.D) Л.Хаш (СЭЗИС)

Магистр (МА) Б.Мөнгөннахиа (СЭЗИС)

362

Монгол улсад хууль, эрх зүйн боловсролын суурь тавигдсан нь (1911-1950 он)

Магистр (LLM) Б.Дэлгэрмаа (СЭЗИС)

Магистр (LLM) Ж.Хулан (СЭЗИС)

374

Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэн гэм хорын эрх зүйн зохицуулалт, хэрэглээ

Магистр (LLM) Ж.Хулан (СЭЗИС)

МА Ц.Даваасүрэн (СЭЗИС)

387

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн бүтэц (Уул уурхайн салбарын жишээн дээр)

Доктор (Ph.D) М.Түвшинжаргал (University Of Erciyes-Turkey)

401

Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах, ЗХШХШтХ-ийн 18.3.1, 18.3.2 дахь заалтад хийсэн дүн шинжилгээ

МА Б.Мөнгөннахиа (СЭЗИС)

Доктор (Ph.D) Л.Хаш (СЭЗИС)

421

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хянах чиг хандлага

Д.Отгонбаяр (МУИС)

435

Их сургуулийн нийгмийн хариуцлагын судалгаа

Магистр Б.Түвшинжаргал (СЭЗИС)

445

Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрх, түүний эрх зүйн зохицуулалт

Магистр (LLM) Д.Оюун (СЭЗИС)

Магистр (LLM) Ж.Хулан (СЭЗИС)

451

Оюутны дүн болон багш сонголтыг Нэйви Байесийн ангилагч ашиглан таамаглах нь /СЭЗИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутнуудын үнэлгээний жишээн дээр/

Доктор Ph.D П.Гантөмөр (СЭЗИС)

MS А.Г.Авирмэд (СЭЗИС)

MS Н.Аргилсан (СЭЗИС)

458

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн лицей ангиудын элсэлтийн ерөнхий шалгалтуудын үр дүн, түүнд хийсэн дүн шинжилгээ

MS Ш.Ганболд (СЭЗИС)

MS Г.Авирмэд (СЭЗИС)

471

Бакалаврын дипломын ажилд хийсэн ажиглалт, шинжилгээ

Доктор (Ph.D) С.Норжинлхам (СЭЗИС)

Доктор (Ph.D) Т.Туяа (СЭЗИС)

482

БНХАУ-ын дээд боловсролын чанарыг батлах аргын судалгаа

MA Б.Буянтогтох (Өвөрмонголын СЭЗИС)

491

Номын сангаар үйлчлүүлэх нь оюутны сурлагын амжилтанд нөлөөлөх нь

Доктор (Ph.D) Г.Гантулга (СЭЗИС)

Ч.Өнөржаргал (СЭЗИС)

Ц.Хатанхангай (СЭЗИС)

496

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРГИЦ, МАРКЕТИНГ, ОЛОН УЛСЫН БИЗНЕС

Tourism to mongolia from russia: development prospects

Associate Professor Шинкарева Ольга Владимировна (Moscow City University)

Doctor of Economics ALEKSEICHEVA Elena (Moscow City University)

Cand. Sc. (Economics) Kulomzina Elena (Moscow City University)

505

Хүргэлтийн үйлчилгээнд хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйл

Магистр (МВ) Т.Намуун (Мандах Их Сургууль)

Доктор (Ph.D) Б. Гэрэлмаа (Мандах Их Сургууль)

519

Банкны үйлчлүүлэгчийн харилцах банкаа солих зан төлөвийн судалгаа

Магистр (МВА) Б.Ганшагай (СЭЗИС)

Доктор (Ph.D) Б.Амарсанаа (СЭЗИС)

521

Аж үйлдвэрийн хөгжилд инновацын гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага

Магистр (МВА) Б.Цэцэнтана /Siqintana/ (Өвөрмонголын СЭЗИС)

Доктор (Sc.D) Л. Оюунцэцэг (ШУТИС)

533

Экспортын боломжийг хөгжүүлэхүй: тогтвортой аялал жуулчлалын менежмент

Магистр (МВА) З.Ундрах (ХААИС)

544

Улсын төсвийн болон гадаад худалдааны алдагдлын урт хугацаан дахь хамаарал

Доктор (Ph.D) Ч.Наранчимэг (СЭЗИС)

Магистр (M.Sc) Ч.Даваасүрэн (СЭЗИС)

561

Дижитал маркетингийг ашиглан брэнд хоногшуулалт бий болгох боломжийн судалгаа

Магистр (МВА) Э.Жаргалмаа (СЭЗИС)

570

МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БА ТЕХНОЛОГИЙН МЕНЕЖМЕНТ

Тоон гарын үсгийн ашиглалтыг сайжруулах нь (гадаадад оршин суугч иргэдийн жишээн дээр)

Доктор (Ph.D) Л.Эрдэнэсайхан (СЭЗИС)

Бакалавр Ц.Соёлмаа (СЭЗИС)

578

Программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын менежментийг сайжруулах арга зам

Магистр (M.Sc) Н.Саранчимэг

Бакалавр О.Хулан

Бакалавр С.Гэрэлт-Од

590



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ISBN: 978-9919-9906-1-9

**ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ПОЛИПЕРМА ХЯМРАЛ, ЭДИЙН
ЗАСГИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ШИНЭ ХАНДЛАГА, ПАРАДИГМУУД**

Р.Амаржаргал¹, Ц.Даваадорж²

¹ Монгол улсын 21 дэх Ерөнхий сайд, СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, доктор (Ph. D)

² СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн, хүндэт профессор, доктор (Sc. D)



Түлхүүр үг:

Эдийн засгийн ардчилал,
поликризис, эдийн засгийн
шинэлэг сэтгэлгээ

Хураангуй

Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралт байдлыг эрдэмтэд, судлаачид алдагдсан арван жил, полиперма хямралын үе гэж нэрлэх боллоо.

ХүнНийгэм хөгжил дэвшлийн зэрэгцээгээр полиперма (олон талт ба байнгын) хямралтай тэмцэх амьдралын шинэ хэлбэр рүү шилжиж эхэллээ. Өнөөгийн дэлхийн соёл иргэнишл эдийн засаг нь:

- байгаль дэлхий, хүрээлэн буй орчин, цаг уурын өөрчлөлтүүдийг урьдчилан сэргийлж, хөнөөлт аюул уршгаас зайлсхийж амжсангүй (HIV, SARS, MERS, EBOLA, гахай, шувууны ханиад гэх мэт),
- улс гүрнүүдийн хоорондох харилцаа хамгийн зэрлэг хэлбэр, дайн байлдаанаас ч ангижирч чадсангүй,
- харин ч тэдгээртэй дасах, зохицох үйл ажиллагааг стратегийн зорилго болгон дэвшүүлэх төлөвтэй,
- мөн хүн нийгмийн эдийн засгийн үйл ажиллагааны эцсийн үр дүн буурах хандлага түргэсэхийн зэрэгцээгээр, зарим нөхцөлд, бүр ч хор хөнөөлтэй үйл ажиллагаа болон хувирах шинжтэй болжээ,

Эдгээр байдал эдийн засгийн шинэлэг сэтгэлгээ, парадигмыг боловсруулах, нэвтрүүлэх шаардлагатай тулгарсныг илэрхийлнэ.

**ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ, УНАЛТ БА ХЯМРАЛЫН ТУХАЙ
ШИНЭЛЭГ ОЙЛГОЛТУУД**

Эдийн засгийн хэвшмэл сэтгэлгээний зарчмаар бол эдийн засгийн өсөлт, тэлэлтийн сонгомол дотоод хүчин зүйлүүдийн хүрэлцээ: ажиллах хүчний, эрчим хүчний ба түүхий эдийн нөөц ресурс хангалттай мэт боловч дэлхийн эдийн засаг зогсмол байдлаас ангижирч чадалгүй нэлээд удаан хугацаа өнгөрлөө.

Эдүгээ, эдийн засгийн өсөлт хөгжлийн эдгээр дотоод хүчин зүйлүүдийн ашиглалт хэрэглээг хязгаарлах гадаад шинэ нөхцлүүдийн үйлчлэл, нөлөөлөл үлэмжхэн ихэсч идэвхжлээ. Дэлхийн байгаль цаг уур, хүрээлэн буй орчны эргэлт буцалтгүй, таатай бус өөрчлөлтүүд

болон улс гүрнүүдийн, олон улсын эдийн засгийн харилцааны сонгомол зарчмуудыг үгүйсгэсэн үл итгэлцэл, дайн байлдааны ажиллагаа эхэлсэн нь дэлхийн эдийн засгийн хөгжилд үлэмжхэн сөрөг нөлөө үзүүлэх боллоо.

Эдийн засгийн өсөлт хөгжлийг тодорхойлдог хөдөлмөр, капитал, газар (L, C, Land)-ын ашиглалт хэрэглээг хязгаарлах гадаад шинэ нөхцлүүдийн үйлчлэл, нөлөөлөл үлэмжхэн ихэсч идэвхжлээ.

- Цар тахлаас хойш гурван жил гаруй хугацаа өнгөрсөн боловч дэлхий нийтийг хамарсан хямралт байдал үргэлжилсээр.
- Цар тахлын шинэ мутациуд дэлгэрч, үүний зэрэгцээгээр цаг уурын өөрчлөлтийн хүндрэлт нөхцлүүд улам гүнзгийрэв.
- Аюулт үзэгдлүүд олширч, дайн байлдааны бодит байдал ширүүсэх төлөвтэй.

Хямралт байдал хүн нийгмийн амьдралын бүх төрлийг хамарсан **поликризис** буюу нийт соёл иргэншлийн хямрал хэлбэрээр өргөжиж, **перманент** урт удаан хугацаагаар үргэлжлэх магадлал өндөр болжээ.

Хүн нийгэм эдийн засгийн хямралт байдлыг эн тэргүүнд эдийн засгийн өсөлтийн хурдац саарсан, ажилгүйдэл нэмэгдсэн, инфляци хэт өссөн, зарим улс оронд стагфляци хэлбэрт шилжсэн зэрэг хүмүүсийн өдөр тутмын амьдралын доройтолт, хүндрэлийн мэдэгдэхүйц илрэлүүд, үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн ойлгодог жамтай. Эдийн засгийн хөгжлийн түүхэнд хямралт байдлууд олон удаа, мөчлөг байдлаар тохиолдож байсан боловч тодорхой цаг хугацааны дараа эдийн засаг сэргэж, дахин өсөж тэлсээр иржээ.

Эдийн засгийн үйл ажиллагааг хэрхэн тодорхойлдог вэ?

1. *Практик амьдрал дээр эдийн засгийн үйл ажиллагааны цар хүрээг тухайн цаг үед нэмж үйлдвэрлэж бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээгээр,*
2. *Өртөг үнээр бол нэмэгдсэн өртгийн буюу дотоодын нийт бүтээгдэхүүн хэмээх үзүүлэлтээр тодорхойлсоор иржээ.*
3. *Ингэхдээ ашигладаг assumption нь: Зарчмын хувьд хүмүүсийн бүтээсэн, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээ бүхэн*
 - a. *хүний амьдралд нэн чухал хэрэгцээтэй,*
 - b. *тэдгээрийг хүмүүс бүрэн хэрэглэж, хог хаягдалгүй эдэлж дуусдаг,*
 - c. *эдийн засгийн бүх үйл ажиллагаа байгаль дэлхийд ээлтэй, сөрөг үр дагаваргүй гэсэн бодол санаанд тулгуурласаар иржээ*

Нэг хүнд ногдох ДНБ үзүүлэлт ч улс орны эдийн засгийн бодит байдлыг харуулах чадваргүй болжээ. Улс орнуудын иргэдийн орлогын түвшин эрс ялгаатай болсон нөхцөлд “1 хүнд ногдох ДНБ” хэмжээ нь зөвхөн улс төрийн ухуулга сурталчилгаанд ашиглах зорилготой. Харин “медиан хүнд ногдох ДНБ” үзүүлэлт нь хөдөлмөрийн хүмүүсийн орлогын түвшинг баримжаалан харуулах боломжтой боловч ядуу дорой хүмүүсийн бодит байдлыг мөн л илэрхийлэх боломжгүй.

Эволюци хөгжил, өөрчлөлтүүд

Эдүгээ ашигласаар буй үндэсний тооцоо баримжаа нь хүн нийгмийн эдийн засгийн хөгжлийн дээхэн үе буюу доройдуухан, хомсдлын үе шатнаас үүсэл гаралтай. Энэхүү

хандлага, сэтгэлгээний парадигм нь хүмүүсийн эдийн засгийн үйл ажиллагаанд бараг 200 жил гаруй хугацааны турш уламжлал болон хэрэгжиж ирсэн түүхтэй.

Эдүгээ, хүн нийгмийн эдийн засгийн үйл ажиллагаа өөр утга агуулгатай болж байгаа бөгөөд оролцогч этгээдүүдийн роль үүрэг өөрчлөгдөж, тэдгээрийн сонирхлын хоорондох зөрчил гүнзгийрч, эдийн засгийн хөгжлийн тухай, ялангуяа эдийн засгийн үр дүн, өгөөжийн талаарх ойлголт, хандлагууд үлэмжхэн зөрүүтэй боллоо. Бараг бүх улс орнуудын баячууд, супер баячууд өөрийн гэсэн харьцангуй тусгаарлагдмал, өвөрмөц бөгөөд шинэлэг, өндөр үнэтэй, тансаг бараа таваар, үйлчилгээний зах зээлтэй болжээ.

Техник технологийн хөгжлийн явцад

- материаллаг үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин эрс хумигдаж,
- үйлдвэрлэлийн функцийн бүрэлдэхүүн хэсгүүдийн эзлэх байр суурь үлэмжхэн өөрчлөгдөж,
- энгийн хөдөлмөрийн роль үүрэг үлэмжхэн багасаж,
- капитал санхүү, өндөр интеллекттэй хөдөлмөр голлосон эдийн засаг төлөвших зураглал ажиглагдана.

Өнөөгийн нөхцөлд эдийн засгийн хөгжил, өсөлт тэлэлт гэж юу вэ?

- Энэхүү ойлголт нь өнгөрсөн цаг үеийн үйл ажиллагааг давтан үргэлжлүүлж, цар хүрээ нь тэлэх, өсгөх төдийхөн хэлбэрээр хязгаарлагдах бус
- шинэ хэлбэрийн үйл явдлуудыг амьдралд нэвтрүүлэх, инновацийг дэлгэрүүлэх,
- соёл иргэншлийг өвөрмөц хэлбэрээр хөгжүүлэхэд чиглэгдэх боллоо.

Гэвч аливаа юмс үзэгдэл хоёр талтай:

1. Эдийн засгийн шинэлэг үйл ажиллагаа нь хиймэл оюун ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, программ хангамжийн болон үйлчилгээний зэрэг бөгөөд өндөр үр өгөөжтэй ажиллагааны зэрэгцээгээр
2. хүн нийгэмд халтай, алсдаа сөрөг үр дагавартай ажиллагаанаас сэргийлэх зэрэг нь
 - a. эрүүл мэндийн салбарын хөгжлийн ачаар өвчин эмгэгийг анагаах болсон хэдий ч хүний генфондыг муутгаж байна
 - b. шинжлэх ухаан, боловсролын хөгжил, хүмүүсийн интеллектгийн болон мэргэжлийн онцгой өндөр түвшин шаардах өвөрмөц зах зээл, эдийн засгийг төлөвшүүлэх хандлагатай боллоо.

Эдүгээ эдийн засгийн өсөлт тэлэлт хэмээх ойлголт нь өнгөрсөн цаг үеийн үйл ажиллагааг давтан үргэлжлүүлж, цар хүрээ нь тэлэх, өсгөх төдийхөн хэлбэрээр хязгаарлагдах бус шинэ хэлбэрийн үйл явдлуудыг амьдралд нэвтрүүлэх, инновацийг дэлгэрүүлэх, соёл иргэншлийн өвөрмөц хэлбэрээр хөгжүүлэхэд ихэвчлэн чиглэгдэх боллоо.

Тухайлбал, өнөөгийн хүн нийгмийн эдийн засгийн үйл ажиллагаа нь дэлхийн ертөнцийн гадаргуугаар хязгаарлагдсан орон зайн зэрэгцээгээр, ойрын сансар огторгуйг хамран өргөжиж хөгжих төлөвтэй.

- Өөрөөр хэлбэл сансрын эдийн засаг хэмээх хүн нийгмийн шинэлэг үйл ажиллагаа ойрын жилүүдэд төлөвшин тогтох нь ээ. Сансрын эдийн засаг нь эхлэл, төлөвшил

төдий түвшинд байгаа боловч хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашиг нь уламжлалт эдийн засгуудын үзүүлэлттэй тэнцэхүйц хэмжээнд хүрчээ.

- Эдүгээ сансрын эдийн засгийн цар хүрээ хагас триллион доллар орчим хэмжээгээр үнэлэгдэж байгаа боловч эрдэмтийн тооцоогоор ойрын жилүүдэд дунджаар 9 хувиар өсөх боломжтой ажээ (Ryan Brukardt, 2023).

Эдгээрийн зэрэгцээгээр эдийн засгийн уламжлалт бөгөөд олон зуун жил хүн нийгмийн соёл иргэншлийн эрчим хүчний бааз суурийн үүргийг гүйцэтгэж ирсэн чулуун нүүрс, газрын тос олборлох, боловсруулах ашиглах салбарууд ойрын ирээдүйд бүрмөсөн хаагдаж, эрчим хүчний эдийн засаг үндсээрээ өөрчлөгдөх нь зайлшгүй боллоо.

Эрчим хүчний салбарт инновацийг нэвтрүүлэх, ялангуяа сэргээгдэх эрчим хүчийг хангалттай хэмжээгээр үйлдвэрлэх ажиллагаа өндөр эрсдлүүдтэй тулгарч, тодорхойгүй байдлыг үүсгэх төлөвтэй. Америкт саяхан, сэргээгдэх эрчим хүчний салбарт үлэмжхэн хөрөнгө оруулсан арилжааны банк дампууралд өртлөө.

Ер нь орчин үеийн шинэлэг технологиудын үр өгөөж нэн тодорхой бус, шаардагдах хөрөнгө ресурс үлэмжхэн өсөх хандлагатай байгаа нь банк санхүүгийн системд ихээхэн дарамт үзүүлж 2008 оны санхүүгийн хямралт байдалтай төстэй нөхцөл орчныг ч сэргээж болзошгүй.

Дэлхийн геополитикийн чиг хандлага ч үлэмжхэн өөрчлөгдөж “ээлжит” дайн байлдааны мөчлөг сэргэж, батлан хамгаалах, цэрэг дайны эдийн засаг тэргүүлэх чиглэлийн эдийн засаг болж өргөжих магадлалтай.

Байгаль ертөнц, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан аюулт үзэгдлүүдийн хохирлыг нөхөх байнгын эдийн засаг ч төлөвшиж болзошгүй.

Хүн нийгмийн соёл иргэншлийн явцад төлөвшсөн хүн ам зүйн гол асуудлууд парадокс хэлбэр загвартай болж, хөгжингүй орнуудын хүн амын өсөлт саарч, ядуу дорой орнуудын хүн ам улам олширч, цагаачдын урсгал хөдөлгөөн замбараагүй боллоо.

Ковид-19 цар тахлаас хойш дэлхий нийтийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа улам өргөжиж, Францын эдийн засагч Jacques de Larosiere¹-ийн зөгнөснөөр “**хүний амь насны эдийн засаг**” хэлбэрээр эрүүл мэндийн, боловсролын, нийгмийн халамжийн, хүрээлэн буй орчны асуудлуудыг нэгтгэн төлөвших магадлалтай боллоо.

Эдгээр шинэ чиг хандлагууд нь капитал ба өндөр интеллекттэй боловсон хүчний эрэлтийг нэмэгдүүлж жирийн хөдөлмөрч хүмүүсийн эдийн засгийн идэвх оролцоог хязгаарлах хандлага ажиглагдана. Дэлхийн олон улс орнуудын чинээлэг иргэдэд зориулагдсан зугаа цэнгээний, үзвэрийн, том спортын үйл ажиллагаа төрөлжсөн эдийн засгуудын шинжтэй болж, жирийн хөдөлмөрч иргэдийн оролцоо хумигдаж, олох орлого нь ч хомсдох төлөвтэй боллоо.

Эдүгээгийн соёл иргэншлийн бааз суурь болсон эрчим хүчний гол ресурс (чулуун нүүрс, газрын тос), үр ашгаасаа илүү хор нөлөө учруулах болсон ба эрчим хүчний шинэ хэлбэрүүд тодорхой бус нөхцөлд төлөөвшиж буй тул эрчим хүчний эдийн засаг нь ерөнхийдөө

¹ Advisor to the President at BNP Paribas since 1998, President of the European Bank for Reconstruction and Development (1993-1998)

перманент хэлбэрийн хямралд өртөх хандлагатай болжээ. Ер нь **полиперма** хямралыг, өдөөсөн хүчин зүйлүүдийг цар тахлын дэгдэлт, байгаль орчны доройтол, өөрчлөлт, дайн дажны уршиг төдийхнөөр тайлбарлах нь учир дутагдалтай. Соёл иргэншлийн хямралыг түүний динамик өөрчлөлт, төлөвшсөн түүхэн замнал, зөрчилдөөний дотоод орчны мөн чанартай холбож судлах шаардлага гарсан гэж үзэх үндэслэлтэй.

Эдүгээг хүртэлх соёл иргэншлийн хөгжил дэвшлийг шинжлэх ухаан, техник технологийн хувьсгалууд (аж үйлдвэрийн), тэдгээр дээр түшиглэсэн нийт хүн нийгмийн ерөнхий ба дагнасан мэдлэг, туршлагууд, боловсрол соёлын хөгжил, мөн хүн нийгмийн улс төр, нийгмийн байгууллын системийн эерэг динамик зэрэг нь синергетик хэлбэрээр хангаж, тэтгэж байсан бололтой.

Үр өгөөж, орлого бүтээмж буурдаг эдийн засгийн зарчим нь соёл иргэншлийн ерөнхий үр дүнд ч нөлөөлдөг ажээ. Жишээ нь:

- Шинжлэх ухаан, техник технологийн анхны хувьсгалуудын үр нөлөө үлэмжхэн өндөр байснаа, эцэстээ өнөөгийн инновацийн хүн нийгэмд үзүүлэх эерэг үр нөлөө харьцангуй буурах хандлагатай болсныг бараг хүн бүр мэдрэх боллоо.
- Мэдээлэл, дижитал, хиймэл оюуны эрин үеийн олон шинэлэг үйл явдлууд хүний ёс суртахуун амьдралын чанарыг дээшлүүлэх, байгаль дэлхийгээ хамгаалах, хүрээлэн буй орчноо хэвийн байлгах талаар дорвитой, хүн бүгдэд мэдрэгдэхүйц амжилтад хүрсэнгүй.
- Харин ч хиймэл оюуныг нийгмийн амьдралд өргөн ашиглах боломж үүссэн нь хувь хүний эрх чөлөө, сонголт, ёс суртахуунд сөрөг нөлөөлөх хандлага ажиглагдана.

Үүний зэрэгцээр техник, технологийн аливаа хувьсгал, инноваци эерэг нөлөөллийн хамт сөрөг үр дагавартай бөгөөд амьдралд өргөн нэвтрэх явцад урьд өмнө ажиглагдаагүй олон хэлбэрээр дэлгэрэн илэрч, хор нөлөө нь хуримтлагдан өсч, тэдгээрийг хүн нийгмийн амьдралд үргэлжлүүлэн ашиглах боломжгүй түвшинд хүрэх бөгөөд эцэс адагтаа сөрөг нөлөөлөл нь давамгайлж, урт удаан хугацаанд өөрийгөө үгүйсгэдэг жам, зарчимтай ажээ.

Ер нь бидний хямрал гэж нэрлэсэн нэршил нь нэлээн хялбаршуулсан ойлголт юм. Бидний хямрал гэж ойлгож буй зүйлс нь ХүнНийгмийг бүхэлд нь хамарсан трансформацийн нэг хэсэг бололтой.

- 1. Өнөөгийн нийгэм, эдийн засгийн систем, түүний гадаад дотоод харилцан хамаарал, харилцан үйлчлэл зэрэг нь аж үйлдвэрийн өмнөх хувьсгалуудын технологи дээр суурилсан бөгөөд мэдээллийн технологиуд хямралыг улам гүнзгийрүүлж байна. (Үнэндээ, яг одоо бидний оршин буй цаг хугацааг тодорхойлох, түүний мөн чанарыг илэрхийлсэн ойлголт нэр томъёо хараахан алга байна. Де-глобалчлал, ре-глобалчлал, геополитикийн дисперси, антропоцени зэрэг олон шинэ нэр томъёо дэлгэрч байгаа бөгөөд эдгээр нь хэр удаан настайг хэлэх аргагүй)*
- 2. Улс гүрэн, нийгмийн цөм нь овог аймаг, гэр бүл, хувь хүн гэх мэтчилэн улам атомжиж байна.*
- 3. Дэлхийн улс төр, геополитик гэдгийг улс хоорондын харилцаа гэж ойлгож ирсэн бол өнөө цагт глобал, транснациональ, монополь корпорациудын өрсөлдөөний талбар боллоо.*

4. Хүний тархи угаах, санаа бодол, хүсэл шунал, сэтгэлийг нь тодорхой чиглэлд хандуулах төвлөрүүлэх нь хамгийн ашигтай биенес боллоо. Энд жирийн рекламны тухай бус хүний ухамсрыг бүхэлд нь залах хэрэгслийн тухай (нүүр ном, тик ток гэх мэт олон нийтийн сүлжээ) хөндөж байна.
5. Танин мэдэхүйн процесс, үр дүн нь эргэлзээтэй боллоо. Та, бид ямар нэгэн объектой учраад төрж буй бодол нь миний оюуны дүгнэлт үү эсвэл миний биеийн далд ухамсарын түвшинд суулгасан зүйл үү гэдгийг шууд хэлэхэд амаргүй болжээ.
6. Үүнийг дагаад мэдлэг боловсролын уламжлалт тогтолцоо, нийгмийн үнэ цэнэ, үнэлэмж, ач холбогдол эрс буурч байна.
7. Удирдлагын бүх шатны тогтолцоо итгэл даахгүй боллоо. Мэдээллийн үерт автагдсан удирдлагын тогтолцоо, ард олны тархи угаах гэсэн асар их чармайлт гаргаж (Монголын төр саарал ордноос социал сүлжээнд шилжээд удаж байна) буй нь ч эцсийн үр дүнд өөрсдийн зохиосон үлгэртээ өөрсдөө итгэдэг болгожээ. Асуудлыг цогцоор нь харж шийдэх чадвар үгүй болсон. Авьяаслаг чадалтай хүмүүсийг (тэднийг удирдах тун хэцүү) удирдлагын бүх шатанд ялангуяа төрийн албанд татах хэрэгцээ байгаа ч тэднийг хэрхэн ажиллуулах талаар мэдэхгүй байна.
8. Хэний ч өмнө хариуцлага хүлээдэггүй удирддагчтай тогтолцоог бид феодализм гэдэг. Хэн ч сонсоогүй, хэний ч өмнө хариуцлага хүлээхгүй 1147 хүн дэлхийн эдийн засгийн 60 хувийг атгасан корпорацийг толгойлж байгаа бөгөөд тэдгээрийн цөм болох 150 корпораци нь дэлхийн эдийн засгийн 40 хувийг хянадаг. Хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээнэ гэх мэт нь нэгэнт мега, мета болсон корпорацийн хувьд бусдын “нүд хууралт” юм.
9. Төр нь худал үнэн нь ч гэсэн ажилгүйдлийг анзаардаг бол корпорацийн хувьд огт хамаагүй асуудал. Тиймээс хүн-ажиллах хүчний үнэ цэн буурч байна. Нийгмийн маржинал хүмүүсийг гэрт нь суулгаад түргэн хоол, нетфлекс, фейсбүүкээр зугаацуулан нийгмийн ялангуяа улс төрийн амьдралаас тусад нь байлгах эдийн засгийн бололцоо дэлхийн эздэд бүрдсэн.
10. Дундаж давхарга илт ширгээж байна. Нийгэмд орон гэртэй, машин тэрэгтэй, угаалгын машинтай боловч, уг утгаараа люмпен хүмүүс нэмэгдэж байна. Нийгмийн хувьсгал ойртож байна.
11. Улсын төсвөөр паразитлэн амьдардаг бүхэл бүтэн давхарга буй болсон. Жишээлбэл: Монголын дундаж давхарга ихэвчлэн паразит аргаар төсвөөс ашиг хүртээгсэд болжээ.

Хүн нийгмийн эдийн засгийн хөгжлийн төвүүдийн роль үүргийг гүйцэтгэсэн бөгөөд иргэншлийн томоохон ололтын нэгийг илэрхийлэх **хотжилт** хэмээх хүн төрөлхтнийг бөөгнөрүүлэн төвлөрүүлж, соёлжуулсан агуу том үйл явдлын сөрөг үр нөлөөлөл нь сүүлчийн зууны эцсээс эхлэн мөн л огцом өсөх хандлага ажиглагдана. Эдүгээ дэлхийн томоохон хотуудын эдийн засаг хүндрэлт байдалд орж, агаарын бохирдолд өртөж, хүмүүсийн эрүүл мэндэд үлэмжхэн сөрөг нөлөөтэй бөгөөд олон сая тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бөглөрөл, түгжрэлийн эх уурхай болон хувирах төлөвтэй. 2019 оны цар тахлыг ч хүн амын хэт төвлөрийн сөрөг нөлөөлөл ч гэж үзэх үндэслэлтэй. Хотжилт нь хүн нийгмийн эрчим хүчний хэрэглээг үр ашиг бага хэлбэрээр үлэмжхэн нэмэгдүүлэх болон оршин

суугчдын цаг завьг үр бүтээл багатай олон төрлийн үйл ажиллагаанд үлэмжхэн хэмжээгээр зарцуулах нөхцөл болон хувирч эхэллээ. Хүн амын төвлөрөл, хотжилт нь мөн үр шимээр хомс, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хиймэл хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн эрэлтийг эрс өсгөж, ирээдүйд хүн нийгэмд хор хөнөөлтэй үйл ажиллагаа болж хувирах магадлал өндөр.

Мэдээлэл, дижитал, хиймэл оюуны эрин үеийн олон шинэлэг үйл явдлууд хүний ёс суртахуун амьдралын чанарыг дээшлүүлэх, байгаль дэлхийгээ хамгаалах, хүрээлэн буй орчноо хэвийн байлгах талаар дорвитой, хүн бүгдэд мэдрэгдэхүйц амжилтад хүрсэнгүй. Харин хиймэл оюуныг нийгмийн амьдралд өргөн ашиглах боломж үүссэн нь хувь хүний эрх чөлөө, сонголт, ёс суртахуунд сөрөг нөлөөлөх хандлага ажиглагдана. Мэдээллийн агуу их сан бүрэлдэж, хиймэл оюун цэгцлэн боловсруулж буй өнөө үед үнэн мөнийг цуурхал, худал хуурмагаас ялгаж ойлгох, зөв зохистой сонголт хийхэд үлэмжхэн бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал AICG (AI Content Generation) технологи нь үнэн мөн ба худал хуурмагийг ялгах аргагүй болгож хувь хүн ба нийгэмд өөрийнхөө санал байдлыг **тулган** толилуулах боломжтой боллоо. Энэ нь атомын зэвсэг, өлсгөлөн ба тахлаас ч илүү аюул, хөнөөлтэй үйлдэл, эрсдэл болох магадлалтай гэнэ. (Карелов, 2022)

Өнөөгийн соёл иргэншлийн бүтэц бүрэлдэхүүний гол чухал хэсэг болох дэлхийн улс орнуудын улс төр нийгмийн байгууллын систем нь зарим улс оронд уг утгаараа нэн хоцрогдмол, дундад зууны үеэс уламжлалтай эзэнт гүрний хэлбэр статусаа хадгалсаар байгаа нь харамсалтай. Эдийн засгийн хөгжил, аж үйлдвэрийн хувьсгалуудын түүхэн явцад Европ, Хойд Америкт засаглалын либерал ардчилсан хэлбэрүүд төлөвшсөн боловч ХХ зуунд Энэтхэг, Япон, Өмнөд Солонгос, Австралиас бусад оронд тэлж, өргөжиж чадсангүй, Ази, Африк, Ойрхи Дорнодын олон улс гүрнүүд автаритар дэглэмүүдээс ангижирч амжсангүй.

Ер нь сүүлийн үеийн улс төр, нийгэм судлалын дүгнэлтүүдээс үзвэл орчин үеийн дэлхийн соёл иргэншлийн хямралт байдал нь хүн нийгмийн шинжлэх ухаан техник технологийн хөгжлийн өндөр түвшин ба олон улс орнуудад ноёрхож буй нийгмийн байгууллын хоцрогдмол хэлбэр буюу хүчирхийлэл, айдас, албадлагад тулгуурласан төрийн засаглалын хоорондох зөрчлөөс үлэмжхэн хамааралтай нь нотлогдож байна.

Эл нөхцөлд баримжаалах улс орон байна уу?

- *Соёл иргэншил, эдийн засгийн ойрын ирээдүйн хөгжлийн чиг баримжааг томъёолох асуудлын хүрээнд Финлянд улс иргэдийнхээ “амьдралын аз жаргалын индекс” үзүүлэлтээр дэлхийд тэргүүн байр эзэлсэн туршилагыг дэлхий нийтээр судалж, хэрэгжүүлэх боломжтой.*
- *Финлянд улс эдийн засгийн потенциалын хувьд хүчирхэг улс бус, эдийн засгийн хурдац ч өндөр бус боловч эцсийн өгөөж, үр дүнгийн үзүүлэлтүүдээ эрс дээшлүүлж чадсан гайхамшигтай туршилагыг хүн нийгэмд өргөн нэвтрүүлбэл эдийн засгийн оптимал системийг бүрдүүлэх боломжтой болно.*

ЭДИЙН ЗАСГИЙН АРДЧИЛЛЫН МӨХӨСДӨЛ

Соёл иргэншил, хүн нийгмийн ба хувь хүний амьдралаас гадуур орших бөгөөд бүрэн тусгаарлагдмал, биеэ даасан эдийн засаг хэмээх ойлголт байх үндэсгүй.

Хүн нийгмийн амьдралын хэлбэр, салбар нэг бүрийг дагасан бөгөөд хүмүүсийн үйл ажиллагааны мөнгөн үр дүн, түүний санхүүгийн илэрхийллийг л эдийн засаг хэмээн ойлгож иржээ. Хялбарчилж энгийнээр тодорхойлбол, эдийн засаг гэдэг бол хүмүүсийн аливаа нэгэн үйл ажиллагаа нь хувь хүн ба нийгэмд хэрэгцээтэй, эсвэл огт хэрэггүй гэдгийг харуулдаг чухал ойлголт, үзүүлэлт. Жишээлбэл, түүхэн хөгжлийн явцад гэр аж ахуйгаас салж, дагнасан бөгөөд хоршоолсон томоохон мал аж ахуй, газар тариалан хэмээх үйл ажиллагаа өрнөж, хүмүүсийн амьдралын нэн чухал хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнийг хангалттай хэмжээгээр үйлдвэрлэж эхэлснээр хөдөө аж ахуйн эдийн засгийн тухай ойлголт, жам зүй үүсжээ. Хөдөө аж ахуйн эдийн засагт хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хувиарлалт, арилжаа наймаа, эцсийн хэрэглээний бүх асуудлууд хамаарагдана.

Өнөө үед хүн нийгмийн болон хувь хүний бараг бүх үйл ажиллагаа эцсийн дүндээ эдийн засгийн утга агуулгатай болсон бөгөөд мөнгө санхүүгээр илэрхийлэгдэх тул оролцогч хувь хүн “Homo economicus” (Mill, 1836) эдийн засгийн хүний шинжтэй болжээ.

“Homo economicus” - аливаа улс гүрний нийт хувь хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаанд адил тэгш эрхтэйгээр, идэвхтэй, ухамсартай өргөн оролцох, энэхүү үйлдэл, ажиллагаанаас хүртэх ашиг орлого нь оруулсан хувь нэмэр, бүтээмжээсээ шууд шалтгаалах зарчмаар илэрхийлэгдэх бөгөөд өмч, хөрөнгө, баялаг эзэмших тэгш эрхтэй зэрэг болзол, үзүүлэлтүүдээр баталгаажих тухай ойлголт юм.

Товчхондоо, “Homo economicus” гэдэгт эдийн засгийн ардчиллын гол зарчим, дотоод утга агуулга, мөн чанар тусгалаа олсон бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаа нь анх үүсэх, төлөвших цаг үеэс эхлэн ардчилсан утга агуулга, потенциалтай байсны гэрч илрэл.

Эдийн засгийн ардчиллын гол зарчим, дотоод утга агуулга, мөн чанар нь аливаа улс гүрний нийт хувь хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаанд адил тэгш эрхтэйгээр, идэвхтэй, ухамсартай өргөн оролцох, энэхүү үйлдэл, ажиллагаанаас хүртэх ашиг орлого нь оруулсан хувь нэмэр, бүтээмжээсээ шууд шалтгаалах зарчмаар илэрхийлэгдэх бөгөөд өмч, хөрөнгө, баялаг эзэмших тэгш эрхтэй зэрэг болзол, үзүүлэлтүүдээр баталгаажна. Эдийн засгийн ардчиллын онолын эдгээр зарчмууд нь 1948 онд НҮБ-ын ерөнхий ассамблейн баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын утга санаатай бүрэн нийцнэ. Эдийн засгийн ардчиллын гол зарчмууд нь практик амьдрал дээр хөдөлмөрлөх хүмүүсийн тоо, оролцох хүрээ өсөх, тэлэх, орлого баялаг нь нэмэгдэх, микро ба макро түвшинд сонголт шийдвэр гаргах зэрэг үйлдлүүдээр хэрэгжинэ.

Энэхүү логик утга агуулгаас үндэслэн дүгнэвэл аливаа улс орны хөдөлмөрийн насны нийт иргэд дотор хэдий чинээ олон хүн ажиллаж хөдөлмөрлөж, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, өндөр цалин хөлс, орлоготой, хангалуун амьдралтай байвал эдийн засгийн ардчилал хэрэгжиж, улс орон төдий чинээ өөдрөг, эдийн засгийн хувьд хөгжил, дэвшилттэй байна.

Хэрэв хүн нийгмийн дунд эдийн засгийн хямралын тухай яриа, мэдээлэл гарч байгаа бол энэ нь хүмүүсийн үйл ажиллагааны тодорхой хэсэг бүлэг салбарын үйл ажиллагаа хямралд

өртсөн, улс нийгмийн нийт эдийн засаг-макро эдийн засаг тэнцвэрээ алдаж, хуримтлагдсан баялгийн үнэлгээ багасч буй болон байгаль дэлхийд хэт халтай болсон тухай ойлголтуудыг төрүүлнэ. Эдийн засгийн хямрал нь юуны өмнө эдийн засгийн ардчиллын зарчимд сөргөөр нөлөөлж ажилгүйдэл өдөөдөг.

Эдүгээгийн эдийн засгийн хямралыг полиперма хямрал гэж нэрлэж байгаа нь хүн нийгмийн бараг бүх салбарыг хамарсан ажил, үйл явдлын хямрал үүсч, эдийн засгийн ардчилал хумигдах хандлагатай болсон ба энэ нь перманент, урт удаан хугацаагаар үргэлжлэх төлөвтэй болохыг илэрхийлнэ.

Нөгөө талаар, эдийн засгийн хөгжил зогсонги байдалд орж, полиперма хэлбэрээр хямрал үүсэж, даамжрах үзэгдлүүд тохиолдож буй нь хүн нийгмийн соёл иргэншлийн динамикт өмнөх үеийн урт удаан хугацаанд хуримлагдсан сөрөг нөлөөллүүд гүнзгийрч, идэвхжсэний үр дүн, сөрөг синерги үүсгэж буй гэж томъёолж болно.

Ер нь эдийн засгийн хөгжил дэвшлийн динамик нь ямагт өсөх тэлэх хэлбэрээр, хэрэгждэггүй, хөгжил дэвшил ба хямрал нь мөчлөг хэлбэрээр давтагдан, ерөнхий чиглэл нь өсөх тэлэх хандлагатай байна. Эдийн засгийн хөгжил дэвшлийн явцад хуримтлагдсан сөрөг нөлөөллүүд нь цаг хугацааны хожимдолтойгоор, нэлээд хожим хямрал хэлбэрээр илэрдэг жамтай ажээ.

Эдийн засгийн зогсонги байдал ба хямрал нь ихэнх төлөвдөө улс төр, нийгмийн ба бизнесийн дээд удирдлагуудын бодит мэдлэгийн хомсдол, тэдний явцуу сонирхол, сонголт шийдвэрийн алдаа, эдийн засгийн ардчиллыг хумигдуулсан буруу үйлдэлтэй хамааралтай. Өнөөгийн хямралт байдалд Оросын өдөөсөн дайн байлдаан ч үлэмжхэн нөлөөлсөн нь ойлгомжтой.

Дайн байлдаан нь глобалчлал, интернационалчлал, хамтын ажиллагаа, худалдаа арилжааг бүрэн үгүйсгэж дэлхий нийтийн бүх улс гүрэн, хувь хүмүүсийн ажил амьдралыг бусниулах, ардчиллыг устгаж, ирээдүйдээ итгэлгүй болох, айдас эрсдлийн гол нөхцөл болдог.

Уг нь дэлхийн бүх хувь хүмүүс “Номо еconomicus” хэлбэрээр энхтайван нөхцөлд, эдийн засгийн амьдралд *бүх нийтээрээ хамрагдаж, идэвхтэй оролцсон тохиолдолд* эдийн засгийн ардчиллын статус дээд цэгтээ хүрч, дэлхийн эдийн засаг, улс гүрнүүдийн эдийн засаг, айл гэрийн аж ахуй хямралгүй, хамгийн өндөр үр дүнд хүрч, байгаль орчиндоо харьцангуй ээлтэй нөлөөлөх боломжтой байхсан.

Улс төр, нийгмийн байгууллын системийн ардчилал, эдийн засгийн ардчиллууд утга агуулгын хувьд ижил төстэй боловч *эдийн засгийн ардчилал нь* бодит амьдрал дээр хувь хүмүүсийн идэвх оролцоог хамрах хүрээ нь өргөн, хүн нэг бүрийн шийдвэр сонголтыг тусган авах боломжоор илүү буюу шууд оролцох хэлбэр нь өндөр үр дүнтэй гэж үзэж болмоор.

Эдийн засгийн ардчилал төгс боловсронгуй болсон цаг мөчид эдийн засгийн динамикийн гол үзүүлэлт нь оптимал буюу зөв зохистой хэмжээс байх бөгөөд гол зорилго нь тухайн үеийн хүн нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэгцээт чанар өндөр, олон түмний бодит амьдрал хангалуун, байгаль дэлхийд ээлтэй, энх тайвны орчин амьдралаар илэрхийлэгдэх ёстой.

Эдийн засгийн ардчилал нь анх, дэлхий нийтийн бүх хүмүүсийн доройдуу, хомсдолын хэлбэртэй боловч бүх улс гүрэн, бүх иргэдийн үйл ажиллагааг хамарсан гэр ахуйгаас үүсэлтэй бөгөөд яваандаа, дагнасан том үйлдвэрлэл, дотоод гадаад худалдаа, арилжаа болон банк, санхүү, хөрөнгө оруулалтын зэрэг олон төрлийн хэлбэрээр өргөжиж, гар үйлдвэрлэлээс орчин үеийн машинт, том үйлдвэрлэл, мэдээллийн ба үйлчилгээний эрин үеийг хүртэл хөгжсөн түүхтэй.

Хүмүүсийн нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаа нь эволюци, хөгжлийн түүхэн процесс бөгөөд өөрчлөлт динамик ихтэй, ялангуяа бүтэц бүрэлдэхүүн болон оролцогч субъектүүдийн роль үүрэг түргэн өөрчлөгдөх жам зүйтэй.

Зах зээлийн эдийн засаг хэлбэрээр үргэлжилж буй өнөөгийн эдийн засгийн үйл ажиллагаа орчил эргэлт хэлбэрээр хэрэгжих бөгөөд энэ нь нэг талаас биет бүтээгдэхүүн үйлчилгээний урсгал, хөдөлгөөнийг хамрахын зэрэгцээгээр нөгөө талаас тэдгээрийн өртөг, мөнгөн илэрхийллийг ч харуулдаг.

Эдийн засгийн онол, практикаар бол үнэхээр капитализмын хөгжлийн явцад капиталистуудын ашиг орлого нь хөдөлмөрчдийн цалин хөлснөөс илүү түргэн өсөж, цар хүрээгээрээ асар өргөжин, соёл иргэншлийн томоохон ололтуудыг санхүүжүүлсэн түүхтэй. Нөгөө талаар ажилчдын тоо, ажиллагчдын хүрээ тэлж, цалин хөлсний хэмжээ ч мөн дагалдан өсөж, амьдралын түвшин эрс дээшилсэн баримт ч олон.

Эдийн засгийн орчил эргэлтэнд олон субъект, талууд оролцох боловч тэдгээрийг ерөнхийд нь гэр аж ахуй, бизнес, банк санхүүгийн төлөөллүүд болон төр засгийн оролцоо гэсэн үндсэн хэсгүүдээс бүрэлдэн тогтоно.

Зах зээлийн эдийн засгийн үед биет бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд бизнес ажиллагааны дүнд бараа таваар үйлдвэрлэгдэх бөгөөд тэдгээрийн эцсийн хэрэглэгчид нь гэр аж ахуй байдаг. Зах зээлийн эдийн засгийн үед гэр аж ахуйн төлөөлөл-ажилчид, хөдөлмөрчид бараа таваарыг худалдан авахын тулд бизнес аж ахуй дээр хөдөлмөрлөж цалин хөлс авдаг бөгөөд үүнийг эдийн засгийн хэллэгээр ажиллах хүчний нийлүүлэлт гэж үздэг.

Эдийн засгийн орчил эргэлт нь гэр аж ахуйгаас бизнес ажиллагаанд ажиллах хүчийг нийлүүлэх ба эргээд, бизнес аж ахуй нь гэр аж ахуйд бараа таваар нийлүүлэх хэлбэрээр хэрэгжинэ. Орчил эргэлтийн мөнгөн загвар нь үүний хуулбар хэлбэрээр хэрэгжих боловч оролцогч субъектүүдийн хүрээ тэлж өргөждөг. Бараа таваарыг үйлдвэрлэж борлуулсан бизнес аж ахуйгаас болон цалин хөлс авсан хөдөлмөрчдөөс төр засаг татвар авна. Төсвийн мөнгөн хөрөнгөнөөс гэр аж ахуй, хөдөлмөрчдөд тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэрээр мөнгөн урсгал шинээр үүснэ. Мөн бизнес аж ахуй нь банк санхүүгийн сектороос зээл, хөрөнгө оруулалтыг авч ашиглана. Ингэж орчил эргэлтийн мөнгөн хэлбэрт төр засаг ба банк санхүүгийн үйл ажиллагаа нэмэгдэж хамаарагддаг. Зах зээлийн эдийн засгийн орчил эргэлт нь биет бүтээгдэхүүн ба мөнгөн урсгалуудаар нэгэн зэрэг хэрэгжих тул оролцогч олон этгээд, субъектүүдтэй байна.

Эдийн засгийн орчил эргэлт хэлбэрээр үргэлжлэх эдийн засгийн үйл ажиллагаа нь оролцогч субъект бүхэн бусад талуудын үзүүлж буй үйлчилгээ, нийлүүлэлтийг зөв зохистой үнэлсэн цагт арилжаа наймаа буюу А.Смитийн хэлснээр чөлөөт худалдааны хэлбэрээр хэрэгжинэ.

Энэ талаар А.Смитийн алдартай философи сэтгэлгээг ишлэвэл: “Махны худалдагч, шар айраг исгэгч, талхчны сайхан санаа нь бус гагцхүү өөрийнхөө эрх ашгийг хичээсэн үйлдэл нь бидний өмнө хоол тавьж байгаа юм. Бид тэдний хүмүүнлэг чанар руу нь бус хувиа бодсон үзэл рүү нь хандаж, өөрийнхөө хэрэгцээний тухай бус тэдний ашгийн тухай сануулдаг. Хөрөнгө, хөдөлмөрөө хөдөлгөж буй ямар ч хүнд олон түмний ашгийг бодох сэдэл байхгүй... Тэдний ашгийг яаж хамгаалж байгаагаа ч мэдэхгүй... Ихэнхдээ л өөрийн эрх ашгаа хичээсэн үйлдэл нь аяндаа олон түмэнд ашигтай болж буй хэрэг” (Smith, 1776)

Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагаа нь ардчилсан утга агуулгатай буюу аль ч субъект, нөгөөгөө албадан тулгах хэлбэрээр ажиллуулж чадахгүй, мөнгө орлогыг нь ч булаан авах боломжгүй зөвхөн ардчилсан буюу арилжаа наймааны зарчмаар, оролцооны эрх тэгш хэлбэрээр, чөлөөт худалдааны сонголт, шийдвэрээр хэрэгжинэ.

Дашрамд дурдахад эдийн засгийн ардчиллын зарчмуудыг ёс суртахууны болон хүмүүнлэгийн шударга журмын тэгшитгэн хуваарилах зарчмуудаас ялгаатайг дурдууштай.

Эдийн засгийн ардчилал нь зөвхөн эдийн засгийн үйл ажиллагааны хүрээг хамрах бөгөөд оролцогч субъектүүдийн жам ёсны эдийн засгийн эрх чөлөө буюу эрх ашгийн тэгш байдлыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл эдийн засгийн ардчилал нь оролцогч этгээдүүдээс эдийн засгийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэрт тохирсон ашиг орлого (эквивалент) хүртэх буюу харилцан ашигтай төлбөр тооцоо хэлбэрээр хэрэгждэг.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд орж буй аль ч субъект А.Смитийн томъёолсноор “ухаалаг бүх арилжаагаар наймаачин, худалдан авагчийн аль аль нь хожихоос биш, нэг нь нөгөөгөө хохироох ёсгүй” ажээ.

Философи сэтгэлгээний зарчмаас үндэслэн дүгнэвэл эдийн засгийн ардчиллын үндэс суурь нь эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч нэгэн субъект, төр хэмээх институцээс бусад субъектүүд хөрөнгө мөнгөний, үйлдвэрийн эзэд болон ажиллагчид хөдөлмөрчид бүгдээрээ нэг талаас үйлдвэрлэгч (нийлүүлэгч) болон нөгөө талаар хэрэглэгчид (худалдан авагчид) хэмээх функц, үүргүүдийг давхар гүйцэтгэдэг зарчим мөн. Энэхүү сэтгэлгээний парадигмд тулгуурлан үзвэл аливаа улс үндэстний эдийн засгийн ардчиллын хөгжил, хамаарах хүрээ нь юуны өмнө эдийн засгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож буй бүх субъектуудын тоо нэмэгдэх буюу эсвэл нийт хүн амын дотор эзлэх хувийн жин нь өсөх хандлагаар илэрхийлэгдэнэ.

Эдийн засгийн ардчиллын маргаантай гол асуудал бол субъект этгээдүүдийн оролцооны түвшин, нийлүүлсэн хувь нэмэр болон түүний төлбөр болгон авч буй ашиг, орлого, цалингийн хэмжээг тодорхойлох аргачлал, тооцоог бүх нийтээр хүлээн зөвшөөрөх, бодит амьдрал дээр хэрэгжүүлэх боломжийн тухай ойлголт байдаг.

XX зуунд капитализмыг төгс төлөвших цаг үе хүртэл олон эрдэмтэд, сэтгэгчид капиталист эдийн засгийн гол шинж нь үйлдвэрлэл бүтээн босголтод ихэвчлэн ажилчид, хөдөлмөрчид оролцох бөгөөд тэдний оруулсан хувь нэмрийг дутуу үнэлж, цалин хөлсийг зохих хэмжээнээс багаар олгож, завсраас нь нэмүү өртгийг капиталистууд завшиж авдаг гэсэн номлолоор илэрхийлэгддэг байв.

Эдийн засгийн онол, практикаар бол үнэхээр капитализмын хөгжлийн явцад капиталистуудын ашиг орлого нь хөдөлмөрчдийн цалин хөлснөөс илүү түргэн өсөж, цар

хүрээгээрээ асар өргөжин, соёл иргэншлийн томоохон ололтуудыг санхүүжүүлсэн түүхтэй. Нөгөө талаар ажилчдын тоо, ажиллагчдын хүрээ тэлж, цалин хөлсний хэмжээ ч мөн дагалдан өсөж, амьдралын түвшин эрс дээшилсэн баримт ч олон.

Вэслианы (Wesleyan) их сургуулийн профессор Стэнли Лэбэрготт Америкт 1900-1970 оны хооронд амьдралын стандарт сайжирч ирснийг харуулах статистикийн шинжилгээ хийжээ (Skousen, 2001).

Гэрт байгаа зүйл	1900 оны бүх айлуудад (%)	1970 онд ядуу гэр бүлийн дунд (%)
Гүйдлийн устай жорлон	15	99
Крантны ус	24	92
Төвийн халаалт	1	58
Хүн бүр тусдаа өрөөтэй	48	96
Цахилгаан	3	99
Хөргөгч	18	99
Автомашин	1	41

Эх сурвалж: *The Making of Modern Economics, Mark Skousen (2001)*

Эдийн засгийн өндөр хөгжилтэй Америк улсын жишээгээр бол 1980-2019 оны 40 жилд орлого олж татвар төлсөн иргэдийн тоо 145 сая хүн болж 56 % өсжээ. (York, 2020)

Сайн дураар татвар төлөгчдын тоо, төлсөн татварын хэмжээ нь эдийн засгийн ардчиллын гүнзгийрэлтийг илэрхийлэх нэг үзүүлэлт байх боломжтой.

Эдийн засгийн ардчиллын хүч нөлөө нь олон сая хөдөлмөрийн хүмүүсийн зорилтын чиг хандлагыг хооронд нь уялдуулан нийцүүлж синергетик хэлбэрээр эдийн засгийн хөгжлийг үлэмжхэн түргэсгэдэг жам зүйгээр хэрэгждэг. Нөгөө талаар хөдөлмөрч олон түмний буруу ташаа сонголт, шийдэл зарим нөхцөлд макро эдийн засгийн хямрал, хүндрэлд ч хүргэж байсан түүхтэй. Өнгөрсөн зууны 1929-1932 оны эдийн засгийн их хямралын гол шалтгааныг тэр үеийн хөдөлмөрч олон түмний орлого нэмэгдэж, амьдрал эрс дээшилж, бараг бүх нийтээрээ хуримтлах, хадгалах, зардлаа хэмнэх үйлдэлд шилжсэн нь макро эдийн засгийн нийт эрэлтийг багасгаж, эдийн засгийн идэвхжлийг сааруулсан гэдгээр тайлбарлагддаг.

Эдийн засгийн ардчиллын хүрээнд хамрагдах, зарчмын бөгөөд томоохон асуудлуудын нэг бол **эрх мэдэл, засаглалыг хэрэгжүүлэх ба сонголт шийдвэрийг эцэслэн гаргах үйл явдалд оролцогч субъектүүдийн гүйцэтгэх роль үүргийн тухай үзэл баримтлал** байдаг.

Энэ талаар хиймэл оюуны (OpenAI-AI research and deployment company , 2015-2023) боловсруулсан эссе бичлэгийн гол утга санаа нь эдийн засгийн ардчиллын асуудлыг зөвхөн засаглал ба сонголт, шийдвэр гаргах хүрээгээр хязгаарлан тодорхойлсон нь ажиглагдана. Түүний (AI) бичсэнээс ишлэвэл “Эдийн засгийн ардчиллын зорилго бол засаглалыг олон хүмүүс хуваалцан хэрэгжүүлэх, цөөхөн хэсэг бүлэг болон корпорациудын гарт төвлөрөхөөс болгоомжлоход чиглэгдэх ёстой” гэжээ. Энэ үзэл санаагаа цаашид үргэлжлүүлэн “эдийн засгийн ардчиллын утга санаа нь эрх мэдэл, засаглалаар хэрэгжих ба сонголт шийдвэр гаргах үйл ажиллагааг цөөхөн хүмүүс, элитүүд гүйцэтгэх бус өргөн дэлгэр, бүх нийтээрээ хэрэгжүүлэх итгэл найдвараар илэрхийлэгдэнэ” хэмээн бичжээ.

Ер нь засаглал хэрэгжүүлэх ба шийдвэр гаргах, тэдгээрийн хэрэгжилтийн энэхүү чухал асуудал нь эдийн засгийн ардчиллын зөвхөн нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд,

ихэвчлэн микро түвшинд, богино хугацаанд илүү их нөлөөтэй. Соёл иргэншил, эдийн засгийн хөгжлийн урт удаан эволюци хөгжлийн явцад эдийн засгийн ардчиллын гол ноён нуруу, ялангуяа улс орны эдийн засгийн макро түвшинд нийт ажиллагчид хөдөлмөрчдийн өргөн оролцоо, тэдгээрийн боловсрол мэдлэгийн өндөр түвшин л эцэслэн тодорхойлдог гэдгийг дахин тэмдэглүүштэй.

Засаглал ба шийдвэр гаргалтын ихэнх асуудлууд зөвхөн нийгмийн дийлэнх олонх болох ажиллагчид, хөдөлмөрчдийн ухамсар, сонголтод нийцэн тохирч, тэдгээрийн хүлээн зөвшөөрсөн цаг үед бүрэн хэрэгжиж, биелэлээ олдог жамтай. Өөрөөр хэлбэл эдийн засгийн үйл ажиллагаанд оролцогч цөөнх хэсэг болох том компаниуд, монополиудын засаглал, шийдвэр гаргалт нь хүн нийгмийн амьдралд шууд хэрэгжих бус, зөвхөн нийгэм олноор дамжин хэрэгждэг эволюци хөгжлийн жам зүйтэй ажээ.

Хүн нийгмийн хөгжлийн чиглэл баримжааг тодорхойлон томъёолсон аж үйлдвэржилтийн хувьсгалуудын бараг бүх ололт, амжилтууд тухайн цаг үеийн анхны хуримтлал, капиталын шийдвэрлэх хүч нөлөөгөөр, техник технологийн хөгжлийн хэлбэрээр хэрэгжсэн боловч тэдгээр түүхэн үйл явдлуудын эцсийн үр дүн, бүтээгдэхүүнийг ажилчид, хөдөлмөрчид бүх нийтээрээ хүлээн авч, үйлдвэрлэх ба хэрэглэх процессд нь өргөн оролцсоноор хэрэгжсэн билээ.

Эдийн засгийн онолын зарчмаар бол ажиллагчид, хөдөлмөрчид олон түмний эцсийн шийдвэр гаргалт нь ихэнх төлөвдөө макро эдийн засгийн түвшинд илрэх бөгөөд улс орны бүтээсэн ДНБ-ий ($C + Pi + Gi + G + Xn$) бүрэлдэхүүн хэсэг² болох иргэдийн хэрэглээгээр (C -consumption) дамжин хэрэгжинэ.

XX зууны эцэс үед хөгжингүй орнуудын макро эдийн засгийн цар хүрээ, хэмжээг харуулах ДНБ-ий үйлдвэрлэлт, хэрэглээний 60-70%-ийг иргэдийн хэрэглээ (C) эзэлж байжээ. Энэ нь онолын хувьд хөдөлмөрч олон түмэн нэг талаас орлого, цалингийн хэмжээгээр сонголт, шийдвэр гаргах эрх мэдэлтэй бөгөөд нөгөө талаар бизнес аж ахуйнуудын санаачлан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бүрэн хэрэглэх замаар тэдний шийдвэр сонголтыг хүлээн зөвшөөрснийг илэрхийлнэ. Ингэж хөдөлмөрч хувь хүмүүс олноороо нэгдэж, макро эдийн засгийн түвшинд эдийн засгийн ардчиллыг хэрэгжүүлэх хүчин зүйл болон хувирч буйн нотолгоо болно.

Үүний зэрэгцээгээр бизнесийн хүрээн дэх засаглалын ба шийдвэр гаргалтын өндөр ач холбогдлыг үгүйсгэх үндэсгүй. Мэдээж, том бизнесийн дээд удирдлагын эрх мэдэл, сонголт, шийдвэр гаргалт нь микро түвшинд далайц, цар хүрээний хувьд энгийн хөдөлмөрч хүний сонголт шийдвэрээс илүү хүч нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой.

Нөгөө талаас бизнесийн хүрээнийхэн засаглалаа хэрэгжүүлэх бололцоог хангах учиртай өмчийн эрх, хэлцлийн эрх зэргийг төрийн зүгээс хязгаарлах, заримдаа илт дээрмийн чанартай үйлдэл хийх, эдийн засаг дах төрийн оролцоог тасралтгүй өсгөж буй байдал, баялаг бүтээгчдийг сөргүүлэн люмпен нарын гуйлгачин сэтгэлгээг дэвэргэсэн популист улс төрийн үйл ажиллагаа, орлогын ялгарал, санхүүгийн системийн хоцрогдол, шүүх, прокурор, хүчний байгууллагын ялзрал, улс төрийн системийн тухайлбал, авилгалд идэгдсэн төрийн

² GDP=Private Consumption + Gross Private Investment + Government Investment + Government Spending + Net Export

байгууламж, нам, сонгуулийн системийн гаж тогтолцоо зэрэг нь бизнесийн хүрээний эдийн засгийн ардчиллыг эрс хөсөрдүүлэн хумиж байна.

Нийгмийн баялаг үйлдвэрлэх, хуваарилах, арилжаалан солилцох болон хэрэглэх шат бүхэнд эдийн засгийн ардчилал хэрэгжих учиртайгаас гадна эдгээрийн харилцан хамаарал, эргэх холбоо, тэдгээрийг үүсэх эерэг/сөрөг синергийг тухайлбал, Монгол улсын хөгжлийн өнөөгийн шат, гадаад орчны өгөгдөлтэй уялдуулан даацтай онол болон policy research тун ч их үгүйлэгдэж байгааг тэмдэглүүштэй.

Бидний ойлгож байгаагаар макро болон салбарын түвшинд Монгол улсын өнөөгийн хөгжлийн шатанд дээр дурьдсан 4 үе шатын аль нь тэргүүлэх ач холбогдолтой байх, ямар нөхцөлд олон түмний бүтээгч сэтгэхүйг тэтгэх талаар нарийвчлан судалж, төрийн бодлого үйл ажиллагааг тодорхойлох нь зүйтэй.

Эдийн засгийн хөгжил, ардчиллын үзүүлэлтүүдийн хооронд шууд харьцааны эргэх холбоо хэлбэртэй харилцан нөлөөлөл үүсдэг. Улс орны эдийн засаг хөгжихийн хэрээр ажиллагчид, хөдөлмөрлөх хүмүүсийн тоо өсөх бөгөөд эргээд ажиллагчдын тоо, тэдгээрийн оролцоо өргөжих нь эдийн засгийн өсөлтийн нэг чухал нөхцөл болно. Энгийнээр, “хүн нэмбэл, хүнс нэмнэ” гэсэн ойлголт боловч уг концепци нь экстенсив хөгжлийн загвар бөгөөд XVIII зуун хүртэл маргаангүй үйлчилж байсан юм.

Өнөөгийн нөхцөлд “нэмэгдэх ёстой хүн нь” XXI зууны эрэлт хэрэгцээг хангасан байх ёстой бөгөөд үүний тулд хүнээ хөгжүүлэх, хүндээ, хүүхдэд хөрөнгө оруулалт хийх асуудал нь эдийн засгийн ардчиллын нэг шалгуур болгох ёстой.

Практик амьдрал дээр бизнесийн олон дээд удирдлуудын сонголт, шийдвэр болон ухаалаг, ухамсарт хандлага, харилцаа нь хөдөлмөрч олон түмний сонирхолтой нийцсэн цаг үе, нөхцөлд бизнес үйл ажиллагааны үр дүн нь өндөр, бүх нийтээрээ сэтгэл хангалуун байдаг жамтай.

Эдийн засгийн ардчилал тууштай, ямагт өргөжих хөгжих динамиктай байсангүй. XX зууны эхэн үе хүртэл аж үйлдвэрийн хувьсгалуудын хөгжлийн явцад эдийн засгийн амьдралын олон хэлбэр салбарт ажиллагчид, хөдөлмөрчдийн оролцоо, ач холбогдол харьцангуй өндөр байжээ. Харин XX зууны эцэст техник технологийн, мэдээллийн хувьсгалуудын үед капиталын оролцоо нэмэгдэж, хөдөлмөрчдийн роль үүрэг багасаж, эдийн засгийн ардчиллын хамрах хүрээ хумигдах хандлагатай болжээ.

Улс төр, эдийн засгийн ардчиллын ач тусаар, шууд нөлөөллөөр Америк ба Европын хөгжингүй орнууд эдийн засгийн хувьд XX зуунд үсрэнгүй хөгжсөн түүхтэй. Эдийн засгийн хөгжлийн нийтлэг жам зүй, улс төр, эдийн засгийн ардчиллын ач нөлөөг барууны судлаачид Америк, Европын орнуудын хөгжлийн онцлог, хүмүүсийн бүтээлч, хөдөлмөрч чанар төдийхнээр тайлбарлах нь ч бий³.

XX зууны эхэнд Америк улс дэлхий дээр анх удаа 1 сая автомашин үйлдвэрлэсэн нь үнэхээр гайхамшигтай. Мөн үүнийг зохион санаачилж, хэрэгжүүлсэн хувь хүн ч Генри Форд мөн. Эдүгээ Америкт Генри Фордын намтрын түүхч хэмээх судлаачид ч олширсоор. Суут Генри

³ Жишээлбэл, сүүлийн үеийн Блүүмбергийн теле нэвтрүүлгээр Америкийг тэргүүний, хүчирхэг улс болгон “бүтээн буй болгосон автомашины үйлдвэрлэл”, түүнийг үүсгэн санаачилсан хувь хүмүүсийн тухай үлэмжхэн баримтуудыг харуулж дэлгэх болжээ.

Форд бол эдийн засгийн хөгжлийн түүхэнд бичигдэх капиталист компанийн эзэн, энтерпренер менежер, шинийг санаачлагч, түүчээ, зоримог, ухаалаг хүн мөн бөгөөд тэрээр хүн нийгмийн хэрэглээний эволюци хөгжлийн чиг баримжааг зөв таамаглаж, автомашины үйлдвэрлэл, хэрэглээ Америкийн эдийн засгийн хөгжлийн нэгэн чухал хүчин зүйл болохыг зөгнөсөн билээ.

Форд эдийн засгийн ардчиллын гадаад хэлбэрийн оновчтой системийг том аж үйлдвэрт нэвтрүүлэн, эдийн засгийн үр ашгийг үлэмжхэн нэмэгдүүлэн, ашиг орлогынхоо зохих хэсгийг өөрийнхөө үйлдвэр дээр ажиллаж хөдөлмөрлөж байсан олон мянган жирийн хүмүүстэй шудрагаар хуваалцаж, капиталистууд ба хөдөлмөрийн хүмүүсийн хоорондох зөрчлийг олон арван жилийн турш намсгах практик аргыг сүвэгчлэн хэрэгжүүлснээрээ алдартай. Генри Форд өөрийнхөө ажилчидтайгаа уулзахдаа “Би та нарт хувиасаа цалин өгч байгаа хэрэг бишээ. Та нарын үйлдвэрлэж байгаа машин чинь та нарт цалин өгч байгаа хэрэг” (Burlingame, 1954) гэж хэлсэн гэдэг. Мөн тэрээр автомашиныхаа хамгийн хямд “Форд-Т” загварыг өөрийн санаачлан бүтээсэн конвейер дээр олноор нь үйлдвэрлэж, өртгийг нь эрс хямдруулан, түүнийгээ өөрсдийнхөө ажилчдад өргөнөөр борлуулах арга замыг ч хүртэл сэдэж чадсан билээ. Форд анх удаа өөрийн үйлдвэр дээр өдрийн 8 цагийн хөдөлмөрийн дэгийг нэвтрүүлсэн бөгөөд ажлын цагийн хөлсийг 5 доллар хүргэсэн зэрэг эдийн засгийн ардчиллын олон зарчмуудыг санаачлан хэрэгжүүлсэн билээ.

Энэхүү эдийн засгийн ардчиллын философи нь XIX зууны дунд үеэс Европт дэлгэрч эхэлсэн коммунист үзэл баримтлал “капиталист ба ажилчдын хоорондох эвлэршгүй зөрчил, үүнээс шалтгаалсан капиталист системийн зайлшгүй мөхлийн” талаарх К.Марксын сургаалыг лав л бүтэн зуун жил үгүйсгэж, хойшлуулж чадсан түүхтэй.

Гэхдээ эдгээр дурдсан үйл явдлууд нь эдийн засгийн ардчиллын дотоод мөн чанараас урган гарсан, хөгжил дэвшлийн явцтай шууд холбоотой бус болохыг цохон тэмдэглүүштэй. Энэхүү жам зүйг оновчтой хэлбэрээр өөрийн оронд түр зуур хэрэгжүүлж амжсан сүүлийн үеийн жишээгээр Хятадыг дурдаж болно. Хятад улс дэлхийн эдийн засгийн глобалчлалын цаг үеэр, барууны орнуудын эдийн засгийн бодлого, санхүүгийн дэмжлэгээр XX зууны эцэс үед олон зуун жил үргэлжилсэн гар үйлдвэрлэлээ хөгжүүлж, олон сая ажилчид хөдөлмөрчдийнхөө идэвх зүтгэлд тулгуурлан, гадаадын хөрөнгө оруулалтын тусламжтайгаар, өөрөөр хэлбэл мөн л түр зуурын боловч эдийн засгийн ардчиллын ач нөлөөгөөр орчин үеийн аж үйлдвэржсэн бөгөөд эдийн засгийн хувьд хүчирхэг орон болж чадсан билээ.

Эдийн засгийн хөгжил динамикийн явцад ардчиллыг түр зуур хэрэгжүүлэх боломжийг буй болгосон жам зүй бол эдийн засгийн төвлөрөл, бөөгнөрөл, капиталын цар хүрээ өсч, үүнийг дагаж ажиллагчид хөдөлмөрчдийн тоо, тэдний оролцоо нэмэгдэх зарчим мөн. Аж үйлдвэрийн хувьсгалуудын үр дүнд XX зууны эхэн үе гэхэд газрын тос олборлолт үлэмжхэн нэмэгдэж, аж үйлдвэрт ширэм, ган үйлдвэрлэл эрс өсч, машин үйлдвэрлэл, химийн аж үйлдвэр түргэн хөгжих болсон нь Америк, Европын аж үйлдвэрийн салбарт капиталын бөөгнөрөл, төвлөрийг эрс түргэсгэжээ. Мөн энэ үед банк, санхүүгийн систем биеэ даасан хэлбэрээр хөгжих болсон нь капиталын бөөгнөрөл төвлөрөлд эерэг нөлөө үзүүлсэн билээ. Капиталын анхны хуримтлал, төвлөрөл бөөгнөрөл нь эдийн засгийн практик амьдрал дээр томоохон фирм, компаниудыг үүсгэх боломжоор хангаж, эдгээр үйлдвэрүүд дээр олон сая ажилчид хөдөлмөрлөж, хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлэн капиталистуудын

орлого, ашгийг ч өсгөх боломжийг буй болгосоны зэрэгцээр тэр үеийн онцлогоос шалтгаалан ажилчид хөдөлмөрчдийн цалин хөлсийг ч үлэмжхэн нэмэгдүүлэх бодит нөхцөл бүрдүүлсэн түүхтэй.

Энэ утгаар эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй ба хоцрогдсон орнуудын ялгаа учир шалтгааныг хамгийн энгийнээр томъёолбол: хөгжингүй орнуудын нийт хүн амын дотор ажиллагчид, хөдөлмөрчдийн эзлэх хувийн жин нь өндөр, бүтээмж нь дээгүүр, хүртэх орлого нь ч илүү гэдэг баримжаа, сэтгэхүйн хялбарчилсан дүгнэлт хийж болно. Өөрөөр хэлбэл хөгжингүй орнуудын ажиллагчид, хөдөлмөрчдийн эдийн засгийн оролцоо, идэвх илүү өндөр буюу эдийн засгийн ардчиллын нэг чухал үзүүлэлт нь харьцангуй дээгүүр гэж дүгнэж болмоор.

Эдийн засгийн хөгжил, ардчиллын үзүүлэлтүүдийн хооронд шууд харьцааны эргэх холбоо хэлбэртэй харилцан нөлөөлөл үүсдэг. Улс орны эдийн засаг хөгжихийн хэрээр ажиллагчид, хөдөлмөрлөх хүмүүсийн тоо өсөх бөгөөд эргээд ажиллагчдын тоо, тэдгээрийн оролцоо өргөжих нь эдийн засгийн өсөлтийн нэг чухал нөхцөл болно.

Технологи, Инновацийн нөлөөлөл

Дэлхий нийтийн эдийн засгийн хөгжлийн түүхэн явцад шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн дагуу капиталын эрэлт эрс нэмэгдэж, шинэлэг техник, технологи нэвтрэхийн хэрээр “нэгж инновацид” шаардагдах хөрөнгө мөнгөний хэмжээ үлэмжхэн өсч иржээ. Үйлдвэрлэл, үйлчилгээний ерөнхий цар хүрээ, масштаб өсөх хандлагын дагуу, санхүү капиталын ач холбогдол улам ихэсч, барууны хөгжингүй орнууд үнэхээр “капиталист” орнууд гэсэн статусаа бататгаж чаджээ.

Эдийн засгийн өсөлт хөгжлийн хүчин зүйлүүдэд үлэмжхэн өөрчлөлт гарч, санхүү, капиталын оролцоо эрс өссөн нь хүн нийгэм, түүний дийлэнх олонх, хөдөлмөрийн хүмүүсийн нийтлэг сонирхол **эдийн засгийн ардчиллыг дэлгэрүүлэх зорилго ба зах зээлийн эдийн засгийн жам зүйн хоорондох зөрчил** улам гүнзгийрэн тодрох илрэх хандлагатай болсон нь эдийн засгийн хямралт байдлын гол шалтгаан мөн.

Манай нийгмийн өнөө цагийн үндсэн зөрчил нь нэг талаас эдийн засгийн ардчиллыг дэлгэрүүлэх замаар зах зээлийн харилцааг өргөтгөн төгөлдөржүүлэх шаардлага, нөгөө талаас түүнд саад болж буй “К.Марксын томъёоллоор “хуучин нийгмийн мэнгэ толбоноос” салж чадахгүй байгаа” үйлдвэрлэлийн харилцаа, макро болон микро түвшинд бүрэлдсэн дисбалансууд юм. Бас нэгэн зүйлийг онцлоход: Эдийн засгийн хямралд өртхийн хэрээр эдийн засгийн ардчилал улам бүр хумигдах хандлага ажиглагдах болжээ. Эдгээр байдлаас дүгнэж үзвэл эдийн засгийн ардчилал нь хүн нийгэм, соёл иргэншлийн явцад түүнийг байнга дагалдан өргөжих боломжгүй бөгөөд хувь хүний зан суртахуун, зан төлөв, амьдралын сонирхлын мөн чанар болон эдийн засгийн жам зүйгээс урган үүсээгүй учир түр зуурын үйлчилгээтэй, ерөнхийдөө багасах, хумигдах хандлагатай үзэгдэл ажээ.

Зах зээлийн эдийн засагт оролцогч үндсэн этгээдүүд нэг талаас капиталист хөрөнгөтнүүд, үйлдвэрийн эзэд, дээд шатны энтрепренер, менежер (хөрөнгөтнүүд, үйлдвэрлэлийн удирдагчид, зохион байгуулагчид) болон нөгөө талаас биеийн хөдөлмөр эрхлэгчид (ажилчид, хөдөлмөрчид) хэмээх нийгмийн өөр өөр статустай анги бүлгүүдийн эдийн

засгийн сонирхлууд харилцан адилгүй, өвөрмөц, үүгээр ч зогсохгүй хоорондоо зөрчилтэй болох нь түүхэн явцад илэрч мэдрэгдэх болов.

XX зууны эцсээс эхэлсэн технологийн дэвшил, мэдээлэл, дижитал ертөнцийн хөгжилд капитал, хөрөнгө оруулалтын оролцоо улам ихэсч, жирийн хөдөлмөрийн роль үүрэг багасч, хумигдах хандлага ажиглагдах болов.

Өндөр хөгжилтэй Америкийн статистик баримтуудаас үзвэл 1980-2019 онуудын 40 жилд эдийн засаг нь (ДНБ үзүүлэлтээр) 7,5 дахин өссөний дотор 1980 онд нийт ажиллагчид 94,5 сая хүн байснаа 2019 онд 145 сая болж 56 гаруй хувиар нэмэгджээ. Харин нийт иргэдийн орлого үлэмжхэн нэмэгдэж орлогын хуваарилалтад ихээхэн өөрчлөлт гарч, баячуудын орлого асар түргэн өсжээ (York, 2020).

1980 онд нийт ажиллагчдын мөнгөн орлого 1,6 их наяд доллар, үүний дотор хамгийн баян 1 хувь хүмүүсийн орлого 138 тэрбум доллар буюу нийт орлогын 8 хувийг эзлэж байв. Ажиллагчдын тэн хагас нь (50 хувь) буюу бага орлоготой хэсэг нь нийт дүндээ 342 тэрбум долларын орлоготой буюу нийт орлогын 17 хувийг бүрдүүлж байжээ. 2019 онд нийт ажиллагчдын орлого 11,9 их наяд доллар хүрч 7,3 дахин өссөний дотор 1 хувь баячуудын орлого 17,3 дахин, нөгөө 50 хувийн хэсэгт хамаарагдах хүмүүсийн орлого 4,7 дахин өсчээ.

Нарийвчлан тооцоолж үзвэл өнгөрсөн 40 жилийн сүүлчийн 20 жилд эдгээр өөрчлөлт динамикийн хурдац нь эхний 20 жилийнхээс түргэссэн нь ажиглагдана. Эдүгээ, иргэдийн орлогын түвшин эрс ялгаатай болсон бөгөөд үүнийг өндөр орлоготой 1 хувь баячуудын жилийн дундаж орлого ба бага орлоготой 50 хувь хүмүүсийн дундаж орлогын зөрүүгээр ойлгож болно.

1980-2019 онуудад 1 хувь баячуудын мөнгөн орлого 10,9 дахин, бага орлоготой 50 хувь хүмүүсийн орлого 3,1 дахин өссөн ба баячуудын дундаж орлого 2019 онд 1,6 сая доллар, харин ядуулаг хэсгийн дундаж орлого нь 18900 доллар болж даруй 85 дахины зөрүүтэй болжээ. Баячууд ба жирийн хөдөлмөрийн хүмүүсийн орлогын хоорондох үлэмжхэн ялгаа нь макро эдийн засгийн тэнцвэрийг илэрхийлэх орчил эргэлтийн процессд ч зохих өөрчлөлт оруулах нь зүйн хэрэг.

Нийт ажиллагчдын орлогын зөрүү хэт ихэссэний улмаас улс орны макро эдийн засагт харьцангуй тусгаарлагдмал бөгөөд зэрэгцээ орших хоёр орчил эргэлт,

- нэг талаас зөвхөн баячуудын оролцоотой шинэлэг, тансаг бөгөөд сайн чанартай, өндөр үнэтэй бүтээгдэхүүн үйлчилгээтэй зах зээл,
- нөгөө талаас жирийн хөдөлмөрчдийн орлого, хэрэглээний уламжлалт зах зээл хэлбэрээр хэрэгжиж байгаа ба
- эдгээрийн хоорондох хэлхээ холбоо суларч, макро эдийн засгийн хүндрэлт байдлыг төрүүлэх бас нэгэн сөрөг нөлөөлөл үүсч эхэллээ.

Энэ нь хүн нийгмийн амьдралд олон төрлийн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаа богино, хоромхон хугацаанд нэвтэрч, тэдгээрийн эерэг ба сөрөг үр дагаврыг урьдчилан томъёолоход төвөгшөөл учруулах бөгөөд хамгийн чухал нь эдгээр технологиуд, шинэ үйлдлүүд, инновациуд соёл иргэншлийн эволюци хөгжлийн чиг хандлага, бодит шаардлагатай тохирох эсэхийг тодорхойлох, тооцоолох боломжийг эрс багасгах эрсдэлтэй.

Нийгмийн өнөөгийн шатанд үүсч буй эдийн засгийн үндсэн зөрчил, эдийн засгийн төрөл бүрийн түвшинд үүссэн дисбаланс буюу тэнцвэргүй байдал, ялангуяа орлогын эрс ялгарал зэрэг нь алсдаа нийгмийн хувьсгалд хүргэж болзошгүй гэдгийг санууштай.

Эцэст нь дурдахад эдийн засгийн ардчиллын эерэг нөлөөг уртасгах, үргэлжлүүлэх болон хүн нийгмийн соёл иргэншлийн эволюци хөгжлийн чиг хандлагатай зохицон амьдрахын тулд төрийн ба том бизнесийн нийгмийн хариуцлагыг эрс дээшлүүлэх бодит шаардлагатай тулгарсныг бүх нийтээрээ ухамсарлах цаг болжээ.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Burlingame, R. (1954). *Henry Ford: A Great Life in Brief*. New York: Knopf.

Mill, J. S. (1836). *On the definition of Political Economy and on the method of investigation proper to it*.

OpenAI-AI research and deployment company . (2015-2023). *OpenAI*. OpenAI:
<https://openai.com/product/gpt-4>-ээс Гаргасан

Ryan Brukardt, J. K. (2023). *Space: The missing element of your strategy*. McKinsey & Company.

Skousen, M. (2001). *The Making of Modern Economics: The Lives and Ideas of the Great Thinkers* . New York: M.E. Sharpe Inc.

Smith, A. (1776). *The Wealth of the Nation*. Nepko publishig.

York, E. (2020). *Summary of the Latest Federal Income Tax Data*. Washington DC: Tax Foundation.

Карелов, С. (2022). *AICG technology*.

OpenAI-AI research and deployment company . (2015-2023). *OpenAI*. Retrieved from OpenAI:
<https://openai.com/product/gpt-4>



**ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ
ХӨГЖҮҮЛЭХҮЙ**
ЭРДЭМ ШИНЖИЛЭГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

**ГОЛ НЭРИЙН ЗАРИМ ХҮНСНИЙ БАРААНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН
СҮЛЖЭЭН ДЭХ ҮНИЙН АСИММЕТРИК ДАМЖИЛТ
(ASYMMETRIC PRICE TRANSMISSION)**

Д.Түвшинжаргал¹, П.Гантөмөр², Д.Өнөржаргал³

¹ Доктор (Ph.D) дэд профессор, СЭЗИС,

² Доктор (Ph.D) профессор, СЭЗИС,

³ Магистр (MA) багш, СЭЗИС



Түлхүүр үг:

үнийн асимметрик
дамжилт, босготой
коинтегрэшин

Хураангуй

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бараа, үйлчилгээний үнэ жил бүр өсөж ирлээ. Энэ байдлыг иргэд нэгэнт өссөн барааны үнэ буурдаггүй гэж шүүмжилдэг. Эдийн засгийн судалгаанд нийлүүлэлтийн сүлжээний дагуу үйлдвэрлэгч, импортлогч үнээ өөрчлөхөд бөөний болон жижиглэн худалдаачид хариу үнийн өөрчлөлт хийхдээ үйлдвэрлэгчийн үнэ өсөж, буурсан эсэхээс хамаарч харилцан ялгаатай хурдтай байхыг үнийн асимметрик дамжилт (Asymmetric price transmission-) гэж тодорхойлдог. Иргэдийн дээрх барааны үнэ нэгэнт өссөн бол буурдаггүй гэх шүүмжлэл бол үнийн асимметрик дамжилтын эерэг хэлбэр юм. Эерэг үнийн асимметрик дамжилт гэдэг нь үнийн өөрчлөлт нэгээс нөгөөд дамжихдаа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөө нь бүтээгдэхүүний үнийн бууралтын нөлөөнөөс илүү хурдан байхыг хэлдэг. Бид, энэхүү судалгааны ажилд өргөн хэрэглээний бараанаас үхрийн мах, өндөг, цагаан будаа гэсэн гурван барааг сонгож, Enders ба Siklos нарын боловсруулсан босготой коинтегрэшин арга зүйг ашиглан үнийн асимметрик дамжилт байгаа эсэх, байгаа бол түүний хэлбэрийг тодорхойлохыг зорилоо. Загварын үнэлгээний үр дүнгээр импортын өндөгний үнэ ба Улаанбаатар хотын өндөгний үнэд асимметрик дамждаг байна. Харин импортын цагаан будааны үнийн хувьд Engle-Granger нарын нийтлэг арга зүйгээр коинтегрэшин хамааралгүй гарсан ч Enders ба Siklos нарын аргаар эсрэг гарч байна. Мөн Дорнод аймгийн үхрийн махны үнэ ба Улаанбаатар хотын үхрийн махны үнийн хооронд асимметрик дамжилттай, Хэнтий аймгийн хувьд асимметрик дамжилттай таамаглалыг няцааж байна.

Удиртгал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бараа, үйлчилгээний үнэ жил бүр өсөж улмаар эрэлт болон нийлүүлэлтийн инфляцын эргүүлэгт орох хандлагатай болоод байгаа билээ. Энэ байдлыг иргэд нэгэнт өссөн барааны үнэ буурдаггүй гэж шүүмжилдэг. Эдийн засгийн судалгаанд нийлүүлэлтийн сүлжээний дагуу үйлдвэрлэгч, импортлогч үнээ өөрчлөхөд бөөний болон жижиглэн худалдаачид хариу үнийн өөрчлөлт хийхдээ үйлдвэрлэгчийн үнэ өсөж, буурсан эсэхээс хамаарч харилцан ялгаатай хурдтай байхыг үнийн асимметрик дамжилт (*Asymmetric price transmission*-) гэж тодорхойлдог. Иргэдийн дээрх барааны үнэ нэгэнт өссөн бол буурдаггүй гэх шүүмжлэл бол үнийн асимметрик дамжилтын нэг хэлбэр юм. Гадаадын судлаачид үнийн асимметрик дамжилтыг 2000-аад оноос гол төлөв ХАА-н бүтээгдэхүүний хувьд түлхүү судалжээ. Үүнд нөлөөлсөн нэг гол хүчин зүйл нь нийлүүлэлтийн сүлжээний бүтэц өөрчлөгдөж бөөний болон жижиглэн худалдааны шатанд төвлөрөл үүссэнтэй холбоотой. Энэ нь фермийн түвшинд үнэ өсөхөд хурдан дамжуулах, эсрэгээр буурахад удаан байх асуудал гаргаж ирсэн юм. Мөн бүтээгдэхүүний нэр төрөл, арилжааны хэлбэр өөрчлөгдсөн нь үнийн дамжилтад нөлөөлжээ. Үнийн асимметрик дамжилтыг эконометрик загвараар тодорхойлоход босготой авторегрессийн загвар (*TAR*)-т тулгуурласан босготой коинтегрэшн, босготой алдаа-засварлалтын арга зүй өргөн ашиглаж байна.


Монгол Улсын хувьд хүнс болон бусад өргөн хэрэглээний барааны үнэ үнийн асимметрик дамжилттай гэх ам дамжсан яриа байдаг хэдий ч тодорхой судалгаа хомс байна. Тухайн бүтээгдэхүүний зах зээл үнийн асимметрик дамжилттай байгаа, түүний хэлбэр, шалтгааныг тодорхойлох нь нэг талаар зах зээл үр ашигттай ажиллаж, үнэ хөшүүргийн дохио түргэн өгч чадахгүй байгааг харуулах; зах зээлд оролцогчдын хооронд баялгийн тэгш бус хуваарилалт байгааг илтгэх ач холбогдолтой. Тухайлбал, ферм, үйлдвэрлэгчийн үнэ буурахад зах зээлийн төвлөрөлтэй бөөний болон жижиглэн худалдаачид (эерэг үнийн асимметрик дамжилттай байх) түүнийг дамжуулахгүй эцсийн хэрэглэгчид хохирч байгаа талаар шүүмжилж зарим улсын засгийн газраас зах зээлд хөндлөгөөс оролцдог. Бид энэхүү судалгааны ажилд иргэдийн өргөн хэрэглэдэг гурван барааг сонгож, Enders ба Siklos нарын боловсруулсан босготой коинтегрэшн арга зүйг ашиглан үнийн асимметрик дамжилт байгаа эсэх, хэлбэрийг тодорхойлов. Бидний сонгосон барааны нэг нь үхрийн махны үнэ бөгөөд нийлүүлэлт нь улирлаас хамаарч үнийн хэлбэлзэл дагуулдаг. Мөн бид цагаан будаа, өндөгний импортын үнийг судалгаанд ашиглалаа. Эхнийх нь хэрэглээ тасралтгүй өсөж байгаа, сүүлийнх нь зах зээлийн бүтэц өөрчлөгдөж, дотоодын ханган нийлүүлэлт өсөж байгаа бараануудын төлөөлөл юм.

Үнийн асимметрик дамжилт

Үнийн асимметрик дамжилт (*Asymmetric price transmission*-) гэдэг нь бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралт нэг зах зээлээс нөгөө зах зээл рүү, эсвэл нийлүүлэлтийн сүлжээ дагуу нэг шатнаас нөгөө шат руу тэгш бус байдлаар дамжих явдал юм. Судлаачид үнийн асимметрик дамжилтыг хэд хэдэн төрлүүдэд хуваадаг. Эхнийх нь бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт бусад орлох бүтээгдэхүүний зах зээлд эсвэл тухайн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний дагуу бусад үе шатад нөлөөлж байгаагаас нь хамааруулан босоо болон хөдлөн гэж ангилдаг. Босоо асимметрик дамжилт гэдэг нь нийлүүлэлтийн сүлжээний дагуу үнийн өөрчлөлт нэг үе шатаас нөгөө шатанд (жишээ нь, үйлдвэрлэгчийн үнэ ба

борлуулагчийн үнийн хооронд) асимметрик дамжиж байгааг хэлнэ. Харин хэвтээ асимметрик дамжилт гэдэг нь үнийн өөрчлөлт орлох бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт (жишээ нь, тухайн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнэд ижил төстэй бүтээгдэхүүний гадаад зээлийн үнийн өөрчлөлт)-д асимметрик дамжих гэж тодорхойлдог (Meyer & Cramon-Taubadel, 2004). Хоёр дахь нь Peltzman (2000)-ий тодорхойлсноор үнийн асимметрик дамжилтыг бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралт нийлүүлэлтийн сүлжээний дагуу эсвэл нэг зах зээлээс нөгөөд хэр хурдан дамжиж байгаагаас нь хамааруулан эерэг ба сөрөг гэж ангилдаг.

Зураг 2.1. Үнийн эерэг болон сөрөг асимметрик дамжилт



Эх сурвалж: Meyer & Cramon-Taubadel, (2004)

Эерэг үнийн асимметрик дамжилт гэдэг нь үнийн өөрчлөлт нэгээс нөгөөд дамжихдаа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөө нь бүтээгдэхүүний үнийн бууралтын нөлөөнөөс илүү хурдан байхыг хэлдэг. Жишээлбэл, нийлүүлэлтийн сүлжээний дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд борлуулагч (бөөний эсвэл жижиглэн худалдаачин)-ийн үнэ нь үйлдвэрлэгчийн үнэ буурахтай харьцуулахад хурдан хариу үзүүлж өсөх явдал юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчийн үнэ буурахад борлуулагчийн үнэ хурдан буурдаггүй, эсрэгээр үнэ өсөхөд борлуулагчийн үнэ хурдан өсөх ба үнийн өсөлтийн нөлөө бүрэн дамжина (Зураг 2.1А). Сөрөг үнийн асимметрик дамжилт нь эерэг үнийн асимметрик дамжилтын эсрэг ойлголт бөгөөд нийлүүлэлтийн сүлжээний дагуу үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд борлуулагчийн үнэ төдийлөн өсөхгүй, харин үйлдвэрлэгчийн үнэ буурахад борлуулагчийн үнэ хурдан буурч, үнийн бууралтын нөлөө бүрэн дамжихыг хэлнэ (Зураг 2.1Б).

Үнийн асимметрик дамжилт үүсгэх олон шалтгаан байдгаас хамгийн түгээмэл нь зах зээлийн хүч (market power), тохируулгын зардал (adjustment cost) болон зах зээл дэх төрийн оролцоо зэрэг юм. Эдгээрээс гадна зах зээлд оролцогчид тэгш бус мэдээлэлтэй байх, зах зээлийн эрэлт болон нийлүүлэлтийн өөрчлөлт зэргийг нэрлэж болно (Meyer & Cramon-Taubadel, 2004).

□ *Зах зээлийн хүч*

Үнийн асимметрик дамжилт үүсдэг нийтлэг шалтгаан бол зах зээлийн хүч юм. Нийлүүлэлтийн сүлжээний дагуу боловсруулалт, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч зах зээлийн хүч өндөртэй байснаар үнийн асимметрик дамжилтын эерэг болон сөрөг хэлбэр аль

аль нь үүсэж болно. Тухайлбал, монопол пүүсийн хувьд зах зээлийн хүч нь эерэг үнийн асимметрик дамжилтыг үүсгэдэг бол олигопол пүүсийн хувьд зах зээлийн бүтэц болон бүтээгдэхүүний шинж чанараас шалтгаалан эерэг болон сөрөг хэлбэрийг үүсэж болдог байна. Монопол пүүс зах зээлийн хүч ихтэй тул орцын үнийн өсөлтөд бүтээгдэхүүний үнээ хурдан нэмж, орцын үнийн бууралтад бүтээгдэхүүний үнээ удаан буулгаж эерэг үнийн асимметрик дамжилт үүсгэдэг (Ganzalo J. Varela, 2014). Олигопол зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг пүүсийн хувьд бараа, үйлчилгээний үнээ өсгөх нь тус пүүсийн зах зээлд эзлэх хувийг бууруулах эрсдэлтэй байвал энэ пүүс үйлдвэрлэлийн орцын үнэ өссөн ч бүтээгдэхүүний үнээ өсгөхгүй байх хандлагатай байдаг. Энэ нь сөрөг үнийн асимметрик дамжилтыг үүсгэдэг ба төгс бус өрсөлдөөнтэй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлд их ажиглагддаг (Ward, 1982).

□ *Тохируулга болон цэсний зардал*

Үнийн асимметрик дамжилтын өөр нэг гол шалтгаан нь тохируулгын зардал юм. Пүүсүүд үйлдвэрлэлд орцын хэмжээ, үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ болон үнийг тодорхойлоход зардал гаргах ба үүнийг тохируулгын зардал гэдэг. Тохируулгын зардлаас хамаарч зах зээл дээр эерэг болон сөрөг үнийн асимметрик дамжилт үүсч болдог. Үйлдвэрлэлийн орцын үнэ өсөх буурах бүрт пүүс үйлдвэрлэлийн хэмжээгээ өөрчлөх хэрэгтэй болж, тохируулгын зардал гардаг. Тохируулгын зардлаас хамаарч үйлдвэрлэлийн орцын үнэ буурахад гарцын үнэ төдийлөн буурахгүй ба орцын үнэ өсөхөд эцсийн бүтээгдэхүүний үнэ өсөж байдаг. Ингэснээр эерэг үнийн асимметрик дамжилт үүсэх боломжтой (Peltzman, 2000). Гэхдээ энэхүү нөлөө нь барааны шинж чанараас хамаарах боломжтой талаар судлаачид дурьдсан байдаг. Тухайлбал, хадгалах хугацаа богино, түргэн мууддаг хүнсний бүтээгдэхүүний үнэ өсөхөд борлуулалт буурч, улмаар борлуулагдаагүй бүтээгдэхүүн хаягдах тул энэ төрлийн бүтээгдэхүүний худалдаачин үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд бараан үнээ тэр бүр өсгөдөггүй. Харин үйлдвэрлэгчийн үнэ буурахад барааны үнээ бууруулж, сөрөг үнийн асимметрик дамжилт үүсдэг байна. (Ward, 1982).

□ *Зах зээл дэх төрийн оролцоо*

Үнийн асимметрик дамжилтын өөр нэг боломжит шалтгаан нь зах зээл дэх төрийн оролцоо юм. Улс орнуудад засгийн газраас зарим бүтээгдэхүүний доод болон дээд үнийг тогтоох бодлого хэрэгжүүлдэг. Эдгээрийн үр дүнд үнийн асимметрик дамжилт үүсэх боломжтой. Жишээлбэл, ХАА-н бүтээгдэхүүний үнийн доод түвшнийг тогтоох бодлого хэрэгжүүлэхэд ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн үнэ буурахад худалдаачид энэхүү үнийн бууралтыг түр зуурынх гэж үзэн, үнээ тэр бүр бууруулдаггүй. Харин үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд, үнийн өсөлтийг байнгын гэж үзээд бүтээгдэхүүний үнээ өсгөх магадлалтай. Үүний үр дүнд эерэг үнийн асимметрик дамжилт үүсэх боломжтой байдаг (Kinnucan & Forker, 1987).

Судлагдсан байдал

Abdulai (2002) Швейцарь улсын үйлдвэрлэгч болон жижиглэнгийн гахайн махны үнийн хоорондын хамаарлыг урт хугацааны тэнцвэр рүү чиглэсэн асимметрик тохируулгыг судлах боломжийг олгодог босго коинтегрэшн тестийг ашиглан судалгааг гүйцэтгэсэн. Асимметрик алдаа засварлах загвар болоод ердийн симметрик алдаа завсарлах загваруудаар үнэлгээг гүйцэтгэж хоёр загварын үр дүнг харьцуулан богино хугацааны тохируулгыг авч үзжээ. Үйлдвэрлэгчийн үнэ өсөхөд жижиглэнгийн үнэ хурдан өсдөг боловч үйлдвэрлэгчийн

үнэ буурахад жижиглэнгийн үнэ хурдан буурдаггүй гэсэн үр дүн гарсан нь Швейцарь улсын гахайн махны үнийн өөрчлөлтөд эерэг асимметрик дамжилт ажиглагдсан байна. Мөн Rezitis (2011) нар ижил арга ашиглан Грек улсын сүүний зах зээлийн үнийн шилжилтийн механизмыг судалж, богино хугацаанд үйлдвэрлэгчийн үнэ буурах биш өсөх үед л жижиглэнгийн үнэ шууд өөрчлөгддөг гэсэн үр дүнд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, урт хугацаанд жижиглэнгийн худалдаачид урт хугацааны тэнцвэрээс хазайх сөрөг хазайлтад хариу үйлдэл үзүүлж байхад, жижиглэнгийн үнийн эерэг хазайлтад хариу үйлдэл үзүүлэхгүй байгаа нь эерэг асимметрик дамжилттай болохыг харуулжээ. Fałkowski (2010) босготой алдаа-засварлах загвар ашиглан Польшийн сүүлийн салбарт гарсан бүтцийн өөрчлөлт үнийн асимметрик дамжилт бий болгож буй эсэхийг судалсан байна. Польшийн сүүний салбарт шилжилтийн үе эхэлснээс хойш нийлүүлэлтийн сүлжээний уруудах шат (downstream)-д зах зээлийн төвлөрөл үүсч тэр хэрээр зах зээл хүч нэмэгдсэн бол эсрэгээр өгсөх шат буюу фермийн түвшинд фермийн холбоод задарч олон тооны жижиг фермүүд үүсч тэр хэрээр зах зээл хүч багасжээ. Улмаар загварын үр дүнгээр фермийн болон жижиглэнгийн худалдааны түвшин хоорондын үнийн шилжилт богино болон урт хугацааны асимметрик байдлаар нөлөөлдөг болохыг тогтоосон байна.

Bayaner (2014) нар Туркийн шингэн сүүний зах зээлд фермээс жижиглэнгийн үнэ шилжихэд үнийн эерэг асимметрик байдал байгаа тул жижиглэнгийн үнэ буурахаас илүүтэйгээр түүний үнийн өсөлтөд хурдан дасан зохицож, хэрэглэгчдийн сайн сайхан байдлыг бууруулахад хүргэж байгаа тогтоожээ. Тэд, энэ байдал нь Турк улсын сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлийн бүтцийн сүүлийн үеийн өөрчлөлт, түүнчлэн шингэн сүүний нийлүүлэлтийн сүлжээний онцлог шинж чанартай холбоотой байж болохыг тайлбарласан байна. Тодруулбал, ХАА-н зах зээлийн “либерал өөрчлөлт” нь зах зээл дээр эрх мэдлээ хадгалдаг хэдхэн цөөн пүүсийн оролцоотойгоор өрсөлдөөнгүй орчныг бий болгож болзошгүй ба тариаланч, хэрэглэгчдийн зардлаар өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн нийлүүлэлтийн сүлжээг зохион байгуулах чадвартай болох явдал зэрэгт оршиж байна гэжээ. Varela (2014) нар Индонезын дотоодын улаан буудайн гурилын үнэ ба олон улсын зах зээл дэх улаан буудайн үнийн хооронд асимметрик дамжилттай байгаа шалтгааныг цөөн тооны гурилын үйлдвэр зах зээлд төвлөрсөнтэй холбосон байдаг. Gizaw (2020) нар бүтээгдэхүүний онцлог, тохируулгын зардал үнийн асимметрик дамжилтад нөлөөлж буйг тодорхойлсон байна. Тухайлбал, судалгааны ажлын үр дүнгээс харахад илүү боловсруулсан бүтээгдэхүүний өртгийн сүлжээнээс бага боловсруулагдсан бүтээгдэхүүний өртгийн сүлжээнд үнийн дамжуулалт илүү төгс бөгөөд хурдан явагддаг. Тодруулбал, шинэ хулд загасны сүлжээнүүдийн хооронд Франц, Испанийн зах зээлд үнийн дамжуулалт илэрсэн боловч утсан хулд загасны өртгийн сүлжээнд аль алинд нь үнийн дамжуулалт илрээгүй. Тэнцвэрт түвшнээс хазайх хазайлт нь тэнцвэрийн түвшнээс доогуур байх үед агентууд шокод илүү хурдан хариу үйлдэл үзүүлдэг гарчээ.

АРТ-ийг үнэлэх арга зүй

Бид шинжилгээ хийхдээ эхэлж *Augmented Dickey-Fuller (ADF)* тестээр хугацааны цуваа бүрийн хувьд стационар эсэхийг шалгаж, улмаар босготой автрорегрессийн загвар буюу *Threshold Autoregressive (TAR)*-г тулгуурласан босготой коинтегрэшн арга зүй ашиглан коинтегрэшн хамаарал буюу үнийн асимметрик дамжилт байгаа эсэхийг тодорхойлсон. Энэ хэсэгт уг арга зүйг тодорхойлж, шинжилгээний үр дүнг дараагийн хэсэгт авч үзнэ.

Эдийн засгийн агентууд үнийн тохируулга хийхэд мэдэгдэхүйц зардал гаргаж байгаа үед үнэ тэнцвэрээс хазайж, зөвхөн тодорхой хязгаар (бид босго утга гэж нэрлэж байгаа)-аас давсан үед л хариу үзүүлдэг (Enders & Granger, 1998). Энэ үйл хөдлөл нь нийлүүлэлтийн сүлжээ дагуу бүтээгдэхүүн үнийн өөрчлөлт асимметрик дамжилт дагуулдаг. Бид, судалгааны ажилдаа Enders ба Siklos нарын боловсруулсан босготой коинтегрэйн арга зүйг ашиглалаа. Уг арга зүй нийлүүлэлтийн сүлжээний өгсөх (upstream) хэсэг ба уруудах (downstream) хэсэг хооронд үнийн асимметрик дамжилт, тохируулга явагдаж болох тохиолдолд коинтегрэйн хамаарлыг шалгадаг онцлог давуу талтай (Enders & Siklos, 2001). Үүнийг тодруулахын өмнө Engle-Granger нарын нийтлэг арга зүйг авч үзье. Хоёр хугацааны цувааны хооронд урт хугацааны хамаарал буюу коинтегрэйн байгаа тохиолдолд түүнийг дараах байдлаар илэрхийлж болно.

$$\gamma_t = \alpha + \beta X_t + \mu_t \quad [1]$$

Энд Y_t нь судалж буй бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээний урдуудах шатны хэсэг (эцсийн хэрэглэгчид ойр) дэх оролцогчийн үнэ, харин нь X_t эсрэгээр нийлүүлэлтийн сүлжээний өгсөх шат буюу үйлдвэрлэгчийн үнийг илэрхийлнэ. Бидний шинжилгээнд ашиглах бүтээгдэхүүний жишээ дээр Y_t нь Улаанбаатар хотын үхрийн махны жижиглэнгийн үнэ X_t нь Дорнод аймгийн үхрийн махны үнэ болно. Engle-Granger нарын аргаар хоёр хугацааны цуваа стационар бус шинжтэй, дээрх тэгшитгэл (1)-ийг Хамгийн Бага Квадратын Арга (ХБКА)-аар үнэлсэн үнэлгээний үлдэгдэл (μ_t) нь стационар шинжтэй байвал хоёр хугацааны цуваа урт хугацааны хамааралтай буюу коинтегрэйн гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Engle-Granger нарын арга зүйд дараах тэгшитгэл 2-н ρ -г ХБКА-аар үнэлдэг.

$$\Delta\mu_t = \rho\mu_{t-1} + \sum_{i=1}^T \gamma_i \Delta\mu_{t-i} + \varepsilon_t \quad [2]$$

Энд T нь хугацааны хожимдлын тоо, нь цагаан шуугиан шинж бүхий алдааны бүрэлдэхүүнийг илэрхийлнэ. Тэгшитгэл 2-т нь μ_{t-1} эерэг сөрөг байхаас үл хамааран нэг үеийн өмнөх үлдэгдэл (μ_{t-1})-ийн дундаж нөлөөг үнэлдэг. Энэ нь үнийн тохируулга симметрик шинжтэй гэсэн нөхцөл тавьсныг илтгэх ба аливаа гадаад шокийн хариуд үнийн өөрчлөлтүүд тэгш хэмтэй буюу симметрик байдлаар явагдана. Хэрэв үнийн дамжилт асимметрик бол дээрх уламжалт арга зүй хазайлттай үнэлгээ болно. Enders ба Siklos нарын босготой коинтегрэйн арга зүй Enders ба Granger (1998) нарын тодорхойлсон босготой авторегрессийн загвар (TAR)-т тулгуурладаг. Дараах тэгшитгэл 3-т TAR загварыг илэрхийлэв.

$$\Delta\mu_t = I_t \rho_1 \mu_{t-1} + (1 - I_t) \rho_2 \mu_{t-1} + \sum_{i=1}^T \gamma_i \Delta\mu_{t-i} + \varepsilon_t \quad [3]$$

Энд I_t нь дараах тэгшитгэл 4-өөр тодорхойлогдох индикатор хувьсагч, τ нь босго утга бөгөөд μ_{t-1} уг босго утгаас их бол I_t нь 1 утга, эсрэг тохиолдолд 0 утга авна.

$$I_t = \begin{cases} 1 & \text{if } \mu_{t-1} \geq \tau \\ 0 & \text{if } \mu_{t-1} < \tau \end{cases} \quad [4]$$


Хэрэв μ_{t-1} босго утга τ -аас их гэвэл энэ үе дэх дамжилт, тохируулгыг тэгшитгэл 3 дахь $\rho_2 \mu_{t-1}$ хэсэг харуулах бол эсрэгээр μ_{t-1} босго утга τ -аас бага үед $\rho_1 \mu_{t-1}$ хэсэг дамжилтыг

харуулна. Хэрэв $\rho_1 = \rho_1$ нөхцөл хангагдаж байвал үнийн дамжилт симметрик шинжийг агуулах ба тэгшитгэл 3 нь давхар тэгшитгэл 2-ийг илэрхийлнэ. Бид үнийн дамжилт асимметрик шинжтэй байж болох тохиолдолд коинтегрэшн шалгахын тулд тэгшитгэл 2-н оронд тэгшитгэл 3-г ашиглана. Улмаар тэгшитгэл 3-г үнэлж, $\rho_1 = \rho_1 = 0$ тэг таамаглалыг шалгах ба үүнийг няцаавал коинтегрэшн хамаарал үүсдэг. Цаашлаад $\rho_1 = \rho_1$ нөхцөл буюу симметрик байдлыг шалгах руу хөтөлдөг. Ингээд аль аль тэг таамаглал няцаагдвал хувьсагчдын хоорондох урт хугацааны хамаарлыг босготой коинтегрэшн гэж нэрлэдэг. Enders ба Siklos нарын арга зүйгээр босготой коинтегрэшн шалгахад F стандарт тестийг дагадаггүй ба үнэлгээнээс гарсан F тооцооны утгыг Enders ба Siklos (2001)-ийн боловсруулсан онолын утгатай харьцуулна. Харин симметрик байдлыг шалгахад стандарт F тестийг дагана. Тэгшитгэл 4 дахь босго утга τ -г ихэнх судалгааны ажил Chan (1993) боловсруулсан аргаар тодорхойлдог. Уг арга зүй нь тэгшитгэл 1-ийг ХБКА-аар үнэлж, регрессийн үнэлгээний үлдэгдлийг эрэмбэлж, дээд болон доод 15%-ийг хасаж, үлдсэн 70%-ийн утга боломжит босго утгууд болдог. Эдгээр нь TAR загварын үнэлгээнд ашиглагддаг.

Өгөгдөл

Бид үнийн асимметрик дамжилт тодорхойлох шинжилгээг цагаан будаа, өндөг, үхрийн мах гэсэн гурван барааны хувьд хийж үзлээ. Цагаан будааны хувьд дотоодын хэрэглээг бүрэн импортоор хангадаг төдийгүй дотоодын хэрэглээ сүүлийн арван жилд 4-5 дахин өсөж, 2022 оны байдлаар импортын хэмжээ 54 мянган тонн болсон байна. Харин өндөгний хувьд дотоодын хэрэглээний 50 гаран хувийг импортоор хангадаг. Өндөгний дотоодын үйлдвэрлэлд “НВЦ ХХК”, “Түмэн шувуут ХХК” гэсэн компаниуд голлох байр суурийг эзэлдэг бөгөөд эдгээрээс гадна 8 орчим жижиг шувууны фермүүд үйл ажиллагаа явуулдаг байна. Хүн амын өндөгний хэрэглээ нэмэгдэхийг дагаж импортын хэмжээ ч өсөж байна. Тухайлбал, 2021 онд 222.5 сая ширхэг өндөг импортолж, 2011 онтой харьцуулахад 3 дахин өндөр байна. Харин махны үнийг сонгож авсан нь дотоодын мах бэлтгэл улирлаас хамаарч хэлбэлздэг, тэр хэрээр жижиглэн худалдааны үнэд нөлөөлдөгтэй холбоотой. Иймээс бид импортын хоёр барааны үнэ, улирлаас хамаарч нийлүүлэлт нь хэлбэлздэг дотоодын нэг барааны үнийн өгөгдөл дээр шинжилгээ хийлээ. Зураг 5.1-т өндөгний Улаанбаатар хотын жижиглэн худалдааны болон импортын үнийг 2014 оны 1-р сараас 2022 оны 6-р сарын байдлаар харуулав. Энэ хугацаанд импортын үнэ дунджаар 169 төгрөг, Улаанбаатар хотын жижиглэн худалдааны дундаж үнэ үүнээс хоёр дахин өндөр 355 төгрөг байжээ (Хүснэгт 5.1). Үнийн хандлагын хувьд 2020 оны сүүл хүртэл харьцангуй тогтвортой байсан хэдий ч сүүлийн хоёр жилд хэлбэлзэл ихтэй байна.


Зураг 5.1. Өндөгний Улаанбаатар хотын болон импортын үнэ (ширхэгийн үнэ, төгрөгөөр), 2014-2022 он, сараар



Эх сурвалж: ҮСХ

Зураг 5.2-т мөн цагаан будааны Улаанбаатар хотын жижиглэн худалдаа болон импортын үнийг 2014 оны 1-р сараас 2022 оны 6-р сарын байдлаар харууллаа. Импортын дундаж үнэ 1415 (кг) төгрөг, дотоодын жижиглэн худалдааны дундаж үнэ өндөгтэй ижил импортын үнээс хоёр дахин өндөр 3048 төгрөг байжээ (Хүснэгт 5.1). Үнийн өөрчлөлтийн хандлагыг харвал 2018 он хүртэл хоёр үнийн хөдөлгөөн ижил, харин 2019 оноос дотоодын үнэ импортын үнээс хурдацтай өсжээ.


Зураг 5.2. Цагаан будааны Улаанбаатар хотын болон импортын үнэ (кг, төгрөгөөр), 2014-2022 он, сараар



Эх сурвалж: ҮСХ

Бид, дотоодоос ханган нийлүүлдэг өргөн хэрэглээний бараануудаас үхрийн махны үнийг шинжилгээнд багтаав.

Зураг 5.3. Дорнод, Хэнтий, Улаанбаатар хотын үхрийн ястай махны үнэ (кг, төгрөгөөр), 2014-2022 он, сараар



Эх сурвалж: ҮСХ

Судалгааны хүрээ нийлүүлэлтийн сүлжээ дагуух босоо асимметрик дамжилтыг сонирхож байгаа тул шинжилгээ хийхэд орон нутгийн бөөний худалдааны үнийн мэдээлэл хэрэгтэй. Гэтэл аймаг, орон нутгаар махны бөөний үнийн статистик албан ёсоор гардаггүй тул бид түүнийг сонгосон аймгуудын жижиглэн худалдааны үнээр орлуулан ашиглалаа. Зураг 5.3-т сонгогдсон Дорнод, Хэнтий аймаг болон Улаанбаатар хотын үхрийн махны үнийг харуулав. Улаанбаатар хотын жижиглэн худалдаанд үхрийн махны үнэ 9558 (кг) төгрөг бөгөөд Дорнод аймгийн жижиглэн худалдааны дундаж үнээс 14.2%-аар өндөр байна (Хүснэгт 5.1). Махны нийлүүлэлт нь улирлын онцлогоос шалтгаалан хэлбэлздэг тул үнэ дагаж өсөж буурах хандлагатай байдаг. Хэнтий, Дорнод аймаг болон Улаанбаатар хотын үхрийн махны үнийн өсөлт, бууралтын хандлага нь ойролцоо байна.

2020 оноос хойш Дорнод аймгийн болон Улаанбаатар хотын үхрийн махны үнийн зөрүү өсжээ.

Хүснэгт 5.1. Өндөг, цагаан будаа, үхрийн махны үнийн тодорхойлогч статистик

Бүтээгдэхүүний үнэ	Дундаж	Стандарт хазайлт	Хамгийн бага утга	Хамгийн их утга
<i>Өндөг (ширхэг, төгрөг)</i>				
Жижиглэн худалдааны үнэ	335	55	263	479
Импортын үнэ	169	38	111	275
<i>Цагаан будаа (кг, төгрөг)</i>				
Жижиглэн худалдааны үнэ	3048	659	2270	4722
Импортын үнэ	1415	247	733	1974
<i>Үхрийн махны үнэ (кг, төгрөг)</i>				
Жижиглэн худалдааны үнэ	9558	2552	5862	15387
Хэнтий аймгийн үнэ	9313	2368	5940	14948
Дорнод аймгийн үнэ	8372	2029	5185	12813

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үнийн асимметрик дамжилтыг тодорхойлох босготой коинтегрэйн загвар үнэлэхийн өмнө нэгж язгуур тест буюу хугацааны цуваа стационар эсэхийг Augmented Dickey-Fuller test (*ADF*) тестээр шалгаж, үр дүнг Хүснэгт 5.2-т харуулав. Тэг таамаглал нь хугацааны цуваа стационар бус бөгөөд бүх үнийн хувьсагчид түвшин дээрээ стационар бус, харин ялгавар дээр стационар байна. Дараагийн хэсэгт стационар бус хугацааны цуваануудын хоорондын коинтегрэйн хамаарлыг Enders-Granger нарын нийтлэг арга зүй болон Enders ба Siklos (2001)-н тооцсон босготой коинтегрэйн хамаарлыг илрүүлэх арга зүйгээр тус тус тодорхойлно.

Хүснэгт 5.1. Хугацааны цувааны стационарыг шалгасан Unit-root тестийн үр дүн

Үзүүлэлт	Түвшин		Ялгавар	
	Оновчтой лаг	Тест статистик	Оновчтой лаг	Тест статистик
Махны үнэ				
Улаанбаатар	6	1.23	5	-7.62***
Дорнод	1	-1.73	0	-8.12***
Хэнтий	0	-0.14	0	-8.69***
Өндөгний үнэ				
Улаанбаатар	2	-1.49	1	-7.15***
Импорт	3	-2.53	2	-7.67***
Цагаан будааны үнэ				
Улаанбаатар	1	0.78	0	6.49***
Импорт	1	-0.93	0	15.49***

Тайлбар: *, **, *** нь харгалзан 90%, 95%, 99% итгэл магадлалын түвшинд тухайн хувьсагч level болон first different түвшинд unit-root байна гэх таамаглалыг няцаахыг илтгэнэ.

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Шинжилгээний үр дүн

Улаанбаатар хотын үхрийн махны үнэ ба Дорнод, Хэнтий аймгуудын үхрийн махны үнийн хооронд, мөн түүнчлэн Улаанбаатар хотын өндөг, цагааны будааны үнийг эдгээр барааны импортын үнийн хооронд тус тус босготой коинтегрэйн хамаарал байгаа эсэхийг Босготой Авторегрессийн загвар (*TAR*)-ыг үнэлэх замаар шалгасан. Уг загварыг үнэлэхийн өмнө Enders-Granger нарын нийтлэг арга зүй ашиглан дээрх хувьсагчдын хооронд коинтегрэйн хамаарал байгаа эсэхийг шалгаж, үр дүнг Хүснэгт 6.1-т харуулав. Enders-Granger тестэд коинтегрэйн шалгахад ашигласан регрессийн үлдэгдлээр байгуулсан хугацааны цувааг тестээр шалгаж нэгж язгуур гэсэн тэг таамаглаж, улмаар няцаавал тухайн хоёр хувьсагч коинтегрэйн хамааралтай гэж үздэг. Үнэлгээний үр дүнгээс харахад импортын өндөгний үнэ ба Улаанбаатар хотын өндөгний үнийн хооронд, мөн Дорнод, Хэнтий аймгуудын үхрийн махны үнэ ба Улаанбаатар хотын үхрийн махны үнийн хооронд тус тус коинтегрэйн хамааралтай байна (Хүснэгт 6.1). Харин импортын цагаан будааны үнэ Улаанбаатар хотын цагааны будааны үнэд шууд нөлөөлж, хувьсагчийн статистикийн утга өндөр байгаа хэдий ч эдгээр хувьсагчийн хооронд коинтегрэйн хамааралгүй гэх тэг таамаглалыг няцааж чадахгүй байна.

Хүснэгт 6.1. Engle-Granger-оор коинтегрэшин шалгасан үр дүн

Өндөг	Цагаан Будаа	Үхрийн мах	
		Хэнтий	Архангай
148.57 (9.175)	75.283 (0.318)	-155.55 (-0.597)	-291.91 (-0.761)
1.04 (11.859)	2.10 (12.750)	1.043 (38.453)	1.176 (26.411)
-3.195**	-1.530	-5.002***	-5.377***

Тайлбар: Хаалтад байгаа тоонууд харгалзах хувьсагчийн үнэлгээний t статистикийг харуулна. α, β , нь коинтегрэшин регрессийн үнэлгээний коэффициентууд бол нь коинтегрэшин регрессийн үнэлгээний үлдэгдэл нэгж язгуур эсэхийг Augmented Dickey-Fuller тестээр шалгасан статистикийн утга. *, **, *** нь харгалзан 90%, 95%, 99% итгэл магадлалын түвшинд үлдэгдэл нэгж язгуур гэсэн таамаглалыг няцаахыг илтгэнэ.

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Босготой Авторегрессийн загвар буюу загварын TAR үнэлгээний үр дүнг Хүснэгт 6.2-т харуулав. Загвар 3-ыг үнэлэхийн өмнө үлдэгдлийн өөрчлөлт ($\Delta\mu_t$)-ийн хугацааны хожимдлын тоог AIC -аар тодорхойлсон. Түүврийн тоо 100, нэг хугацааны хожимдолтой үед Enders ба Siklos (2001)-н тооцсон босготой коинтегрэшин хамаарал шалгах статистикийн онолын утга 90%, 95%, 99% итгэл магадлалын түвшинд харгалзан 5.95, 6.99, 9.39 байдаг. Хүснэгт 6.2-ыг харвал Улаанбаатар хотын өндөгний үнэ ба импортын өндөгний үнийн хооронд босготой коинтегрэшин шалгах тооцооны F буюу Φ_μ утга 5.99 байна. Энэ нь $\rho_1 = \rho_2 = 0$ тэг таамаглалыг сул итгэх магадлалын түвшинд няцааж байна. Тэг таамаглалыг няцаавал $\rho_1 = \rho_2 = 0$ нөхцөл буюу симметрик байдлыг стандарт F тестээр шалгадаг. Хүснэгт 6.2-ын сүүлийн $Asym$ нэртэй мөр уг таамаглалыг шалгах тооцооны F утгуудыг харуулна. Уг тооцооны утгыг харьцуулах тархалтын онолын утга 95% итгэл магадлалын түвшинд 3.94 байна. Иймд $\rho_1 = \rho_2$ тэг таамаглалыг няцааж, Улаанбаатар хотын өндөгний үнэ ба импортын өндөгний үнийн хооронд босготой коинтегрэшин хамааралтай бөгөөд үнийн асимметрик дамжилттай байна. Цагаан будааны хувьд ADF тестээр коинтегрэшин хамааралгүй гарсан ч Φ_μ утга 7.09 байгаа нь 95% итгэл магадлалын түвшинд $\rho_1 = \rho_2 = 0$ тэг таамаглалыг няцаав. Түүнчлэн үнийн дамжилт симметрик гэх тэг таамаглал ($\rho_1 = \rho_2$)-ыг энгийн F тестээр няцаагдаж Enders ба Siklos нарын аргаар босготой коинтегрэшин хамааралтай байна.

Хүснэгт 6.2. TAR загварыг үнэлсэн үр дүн

	Өндөг	Цагаан будаа	Үхрийн мах		
			Дорнод	Хэнтий	Архангай
ρ_1	-0.78***	-0.47****	-0.99***	-0.34**	-0.21
ρ_2	-0.29***	-0.29**	-0.71***	0.43	-0.006
Лаг	1	3	1	1	3
τ	22.44	12.06	378.81	-611.36	-877.99
Таамаглал шалгасан тест					
Φ_μ	5.99*	7.09**	11.44***	7.30**	4.71
$Asym$	11.78**	14.45**	13.53**	4.07**	-

Тайлбар: *, **, *** нь харгалзан 90%, 95%, 99% итгэл магадлалын түвшинд тухайн хувьсагч статистикийн ач холбогдолтой болохыг харуулна. нь $\rho_1 = \rho_2 = 0$ гэсэн тэг таамаглалыг шалгасан статистикийн тооцооны утгыг харуулна. нь $\rho_1 = \rho_2$ гэсэн тэг таамаглалыг шалгасан статистикийн тооцооны утгыг харуулна.

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Сонгож авсан аймгуудын үхрийн махны үнэ ба Улаанбаатар хотын үхрийн махны үнийн хооронд босготой коинтегрэшин хамаарал шалгасан үр дүнг авч үзвэл Дорнод аймгийн үхрийн махны үнэд харгалзах Φ_μ -ийн утга 99%-н итгэл магадлалын түвшинд $\rho_1 = \rho_2 = 0$ тэг таамаглалыг няцааж байна. Мөн үнийн дамжилт симметрик гэх тэг таамаглал ($\rho_1 = \rho_2$)-ыг энгийн тестээр F няцаагдаж, Дорнод аймгийн үхрийн махны үнэ ба Улаанбаатар хотын үхрийн махны үнийн хооронд ADF тестээр коинтегрэшин гарснаас гадна босготой коинтегрэшин хамааралтай байна. Цаашлаад Хэнтий аймгийн махны үнэ 95%-н итгэл магадлалын түвшинд $\rho_1 = \rho_2 = 0$ тэг таамаглалыг няцааж, мөн үнийн дамжилт симметрик гэх тэг таамаглал ($\rho_1 = \rho_2$)-ыг энгийн F тестээр няцааж байна. Гэхдээ босготой коинтегрэшин хамаарал үүссэн байгаа үед загварын үнэлгээний үлдэгдэл утгын цувааны хувьд $\rho_1 < 0, \rho_2 < 0 (1 + \rho_1) (1 + \rho_2) < 1$ гарцаагүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл биелэх ёстой. Хэнтий аймгийн хувьд ρ_2 -ийн үнэлгээ эерэг, статистикийн ач холбогдолгүй гарсан тул босготой коинтегрэшин хамааралтай гэж үзэхгүй байна. Иймд сонгосон хоёр аймгаас зөвхөн Дорнод аймгийн үнэ ба Улаанбаатар хотын махны үнийн хооронд босготой коинтегрэшин хамааралтай, Хэнтий аймгийн хувьд F тестээр коинтегрэшин хамааралтай гэж гарсан тул үнийн симметрик дамжилттай гэж таамаглаж байна.

Хоёр хугацааны цуваа босготой коинтегрэшин хамааралтай үед үнийн асимметрик дамжилтыг дотор нь ангилдаг. Хэрэв $|\rho_1| < |\rho_{12}|$ үед үнийн асимметрик дамжилтыг эерэг үнийн асимметрик дамжилт гэдэг. Энэ нь нийлүүлэлтийн сүлжээний өгсөх (upstream) хэсэгт үнэ өсөхөд уруудах (downstream) хэсэгт хариу үнэ өсөхдөө өгсөх хэсэгт үнэ буурах үетэй харьцуулахад хурдан байхыг хэлнэ. Эсрэг тохиолдолд сөрөг үнийн асимметрик дамжилт гэж тодорхойлдог. Хүснэгт 6.2-аас харахад босготой коинтегрэшин хамааралтай гарсан бүтээгдэхүүн бүр сөрөг үнийн асимметрик дамжилттай байна. Жишээ нь, импортын өндөгний үнэ буурахад Улаанбаатар хотын өндөгний үнэ хариу импортын өндөгний үнэ өсөхтэй харьцуулахад хурдан буурдаг байна.

Дүгнэлт хэлэлцүүлэг

Бид, Дорнод аймгийн үхрийн махны үнэ ба Улаанбаатар хотын үхрийн махны үнэ хооронд сөрөг үнийн асимметрик дамжилт гарсан үр дүнг хоёр шалтгаантай холбож үзлээ. Эхнийх нь, тухайн бүтээгдэхүүн орлуулах олон бүтээгдэхүүнтэй тохиолдолд сөрөг үнийн асимметрик дамжилт үүсч болдог. Энэ нь тухайн бүтээгдэхүүнийг орлуулах олон бүтээгдэхүүн байхын хэрээр үнийн өсөлт удаан, эсрэгээр аль нэг бүтээгдэхүүний үнэ буурахад хариу бусад бүтээгдэхүүний үнэ буурахдаа хурдан байхыг хэлнэ. Ялангуяа тухайн бүтээгдэхүүн түргэн муудах шинжтэй үед энэ нөлөө хүчтэй байна. Махны үнийн дамжилт сөрөг асимметрик гарсан нь энэ нөлөөтэй холбоотой байж болно. Бид зөвхөн Дорнод аймгийн үнэ ба Улаанбаатар хотын үнийн хамаарлыг авч үзлээ. Нийслэлийн махны ханган нийлүүлэлт ганц Дорнод аймгаас хийгдэхгүй олон эх үүсвэртэй тул орлуулах бүтээгдэхүүн

олон байна. Өөрөөр хэлбэл, Дорнодын махны үнэ өсөхөд махны бөөний худалдаачид бусад аймгаас мах худалдан авах боломжтой тул түүний хариуд Улаанбаатар хотын үнэ хурдан өсөхгүй байна. Эсрэгээр Дорнодын махны үнэ буурах зун намрын саруудад нийслэлд махны нийлүүлэлт нэмэгдэх тул үнийн бууралт хурдан байна. Удаах нь ХАА-н бүтээгдэхүүний үнийн зохицуулалт гэж үзэж байна. Kinnucan ба Forker (1987) нар ХАА-н бүтээгдэхүүний үнийн зохицуулалт (татаас) нь үнийн асимметрик дамжилт бий болох нэг шалтгаан болохыг тодорхойлсон. Улаанбаатар хотын махны жижиглэн худалдааны үнэд нөлөөлөх зорилгоор засгийн газраас махны нөөц бүрдүүлж, хаврын саруудад зах зээлд нийлүүлдэг. Энэхүү зохицуулалт нь махны жижиглэн худалдааны үнийн тааз тогтоохтой ижил нөлөөтэй бөгөөд сөрөг үнийн асимметрик дамжилт үүсгэж болно. Учир нь, орон нутагт махны үнэ буурахад бөөний худалдаачид үүнийг байнгын гэж үзэн үнээ хурдан бууруулах, эсрэгээр орон нутагт махны үнэ өсөхөд, ялангуяа хаврын саруудад бөөний худалдаачид үүнийг байнгын гэж үзэхгүй учир нь төрийн зохицуулалтаар бэлтгэсэн нөөц нийлүүлэлтэд гарах бөгөөд үнэ нэмэгдүүлэхдээ удаан байна.

Өндөгний үнийн хувьд сөрөг үнийн асимметрик дамжилт гарсан үр дүнг тохируулгын зардал (adjustment cost)-тай холбож байна. Пүүс бүтээгдэхүүний үнэ өөрчлөхтэй холбоотой тохируулгын зардал үнийг өсгөх, бууруулсан эсэхээс хамаарч ялгаатай байвал үнийн асимметрик дамжилт үүсгэдэг. Тохируулгын зардалд бүтээгдэхүүний түргэн муудах шинж нөлөөлдөг. Түргэн муудах бүтээгдэхүүн борлуулдаг жижиглэн худалдаачин борлуулалт буурч муудсан бүтээгдэхүүнтэй үлдэхээс болгоомжлон үнэ нэмэх дээр хойрго ханддаг. Энэ нь сөрөг үнийн асимметрик дамжилтыг дагуулдаг. Бид, өндөгний импортын үнэ ба Улаанбаатар хотын өндөгний жижиглэн худалдааны үнэ хооронд сөрөг үнийн асимметрик дамжилт гарсан үр дүнд өндөгний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүний шинж нөлөөлсөн гэж үзэж байна. ОХУ-аас импортолж байгаа өндөгний үнэ өсөхөд бөөний худалдаачид бүтээгдэхүүнийг удаан хадгалах боломжгүй, борлуулалт буурах эрсдэлээ тооцож, тэр даруй худалдах үнэ нэмэгдүүлэх үйлдэл хийдэггүй гэж таамаглаж байна. Түүнчлэн өндөгний үнэ сөрөг асимметрик дамжилт байхад өмнөх махны үнэ дээр авч үзсэнтэй адил давхар бүтээгдэхүүнийг оруулах боломж нөлөөлсөн байна. Дотоодын үйлдвэрлэл төрийн бодлогын дэмжлэгээр сүүлийн жилүүдэд нэмэгдэж, нийт хэрэглээний 50 гаран хувийг хангадаг болжээ. Хэрэв өндөгний импортын үнэ өсвөл жижиглэн худалдаачид дотоодын үйлдвэрээс илүү худалдан авах тул жижиглэн худалдааны үнэ хурдан өсөхгүй. Харин импортын үнэ буурвал дотоодын үйлдвэрүүд ч борлуулалтаа хадгалахын тулд үнэ бууруулах ба тэр хэрээр жижиглэн худалдааны үнэ хурдан буурна гэж таамаглаж байна.

Цагаан будааны үнийн хувьд мөн сөрөг үнийн асимметрик дамжилт гарсан үр дүнг зах зээлийн бүтэцтэй холбож байна. Бид, эерэг үнийн асимметрик дамжилт үүсэх нэг шалтааныг зах зээлийн (market power) гэж тодорхойлов. Мөн зарим судлаач зах зээлийн хүч нөгөө талаас сөрөг үнийн асимметрик дамжилт үүсгэхийг тайлбарладаг талаар авч үзжээ. Тодруулбал, түгээлтийн шатанд зах зээлийн бүтэц олигопол шинжтэй үед бөөний болон жижиглэн худалдаачид зах зээлийн байр сууриа алдахаас болгоомжилж үйлдвэрлэгчийн үнэ өсөхийн хариуд дагаж үнэ хурдан нэмэгдүүлэхгүй, эсрэгээр үнэ буурахад хурдан бууруулна гэж таамагладаг. Монгол Улс цагаан будааг 100% импортолж хүнсний хэрэгцээг хангадаг. Цагаан будааг цөөн тооны бөөний худалдааны аж ахуй нэгж импортолдог гэх мэдээ бий. 2017 оны тоо мэдээллээр 20 гаруй аж ахуй нэгж байна. Энэ нь цагаан будаа

импортлон бөөнөөр худалдах хэсэг илүү олигопол зах зээлийн бүтэцтэй болохыг харуулна. Энэ байдал нь сөрөг үнийн асимметрик дамжилттай байх нэг шалтгаан гэж дүгнэж байна. Мөн дотоодын бараа бүтээгдэхүүний тээвэрлэлт, логистикийн тааруу байдал тохируулгын зардлыг нэмэгдүүлж улмаар сөрөг үнийн асимметрик дамжилт гарахад нөлөөлсөн гэж үзэж байна. Учир нь, 2012 онд Монголбанкнаас хийсэн “гадаад худалдааны тээвэр, логистикийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” судалгааны ажилд цагаан будаа нийлүүлэгч улсаас Замын-Үүд боомт хүртэлх тээвэр, тээвэртэй холбоотой зардал, Замын-Үүд боомтоос Улаанбаатар хүртэлх тээврийн зардал өндөр байдагтай холбоотойгоор цагаан будааны хил дээрх үнэ болон Улаанбаатарын зах дээр борлуулагдаж буй үнүүд маш их зөрүүтэй байгааг дурдсан билээ. Өнөөдөр ч үнийн их зөрүү хэвээр байна. Тухайлбал, 2022 оны 6-р сард Улаанбаатар хотын нэг кг цагаан будааны жижиглэнгийн үнэ 4625 төгрөг байсан бол импортын үнэ 1974 төгрөг байна. Энэ байдал нь импортын үнэ өсөхөд худалдаачид тэр даруй үнээ нэмэгдүүлэхийг хязгаарлаж, харин импортын үнийн бууралтад хурдан хариу үнэ бууруулах нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзэхээр байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Abdulai, A. (2002). Using threshold cointegration to estimate asymmetric price transmission in the Swiss pork market. *Applied Economics*, 34(6), 679-687.
- Bayaner, A., & Ismihan, Mustafa. (2014). Asymmetry in farm-retail price transmission in the Turkish fluid milk market. *Mediterranean Journal of Economics, Agriculture and Environment*, 13(2), 1594-5685.
- Enders, W., & Granger, C. (1998). Unit-Root Tests and Asymmetric Adjustment with an Example Using the Term Structure of Interest Rates. *Journal of Business & Economic Statistics*, 16(3).
- Enders, W., & Siklos, P. (2001). Cointegration and threshold adjustment. *Journal of Business & Economic Statistics*, 19(2).
- Fałkowski, J. (2010). Price transmission and market power in a transition context: evidence from the Polish fluid milk sector. *Post-communist economies*, 22(4), 513-529.
- Ganzalo J. Varela, K. T. (2014). Asymmetric Price Transmission in Indonesia's Wheat Flour Market. *ADB Economics Working Paper Series*.
- Gizaw, D., Myrland, Øystein, & Xie, Jinghua. (2020). Asymmetric price transmission in a changing food supply chain. *Aquaculture Economics & Management*, 25(1), 89-105.
- Meyer, J., & Von Cramon-Taubadel, S. (2004). Asymmetric price transmission: a survey. *Journal of agricultural economics*, 55(3), 581-611.
- Kinnucan, H., & Forker, O. (1987). Asymmetry in Farm-Retail Price Transmission for Major Dairy Products. *European Journal of Political Economy*, 285-292.
- Peltzman, S. (2000). Price rice Faster than They Fall. *Journal of Political Economy*, Vol.108, No. 3, 466-502.
- Rezitis, A., & Reziti, Ioanna. (2011). Threshold cointegration in the Greek milk market. *Journal of International Food & Agribusiness Marketing*, 23(3), 231-246.
- Varela, G., & Taniguchi, Kiyoshi. (2014). Asymmetric price transmission in Indonesia's wheat flour market. *Asian Development Bank Economics Working Paper Series*, 394.
- Ward, R. W. (1982). Asymmetry in Retail, Wholesale, and Shipping Point Pricing for Fresh Vegetables. *American Journal of Agricultural Economics*.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛЫН ЭКСПОРТЫН ТОДОРХОЙЛОГЧ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА: БЕЙСИЙН ЗАГВАР ДУНДАЖЛАХ АРГА

А.Дөлгөөн

Магистр (M.Sc), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль



Түлхүүр үг:

Бейсийн загвар дундажлах арга, Бейсийн теором, Экспортын ДНБ-д эзлэх хувь, Экспортыг тодорхойлох хүчин зүйлс

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын экспортын тодорхойлогч хүчтэй хүчин зүйлсүүдийг тодорхойлж, загварыг тодорхойлох зорилготой. Монгол Улсын экспорт нь эрдэс бүтээгдэхүүнээс хамаардаг ба хэдийгээр бодлого боловсруулагчид өөрсдийн бодлогыг тодорхойлон дэмжиж байгаа ч энэхүү судалгааг хийснээр аль хэсэгт илүү анхаарал хандуулах талаар мэдээллийг харж болох юм. Судалгаанд 1990 оноос хойших буюу гадаад худалдааг чөлөөт эдийн засгийн тогтолцоотой болсон үеэс 2021 он хүртэл Дэлхийн банкны мета дата сангийн статистик үзүүлэлтийг ашиглан нийт 12 хувьсагч ашиглан тооцооллыг гүйцэтгэв. Тооцооллын үр дүнгээс харахад улсын төсвийн тэнцэл, шинэ бизнес эрхлэх зардал, цэвэр гадаад шууд хөрөнгө оруулалтын хэмжээ хамгийн хүчтэй нөлөөлж байгаа гэсэн үр дүн гарсан байна.

Удиртгал

Эдийн засгийн тогтвортой өсөлт бол бүхий л улс орнууд, тэр дундаа хөгжиж буй манайх шиг орнуудын хамгийн том зорилго юм. Манай орны эдийн засаг бол уул уурхайн салбараас асар хамааралтай орон билээ. Монгол Улсын 2022 оны экспортын 83.7% -ийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд нийт экспортын 83.1%-ийг урд хөрш болох БНХАУ-руу гаргаж байна¹.

Олон судлаач өөрсдийн үзэл бодлыг илэрхийлсээр байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн ганц гарц бол гадаад худалдааны бодлогын өөрчлөлт гэж дуу нэгтэйгээр дуугарч, Засгийн газраас ч гадаад худалдааны гол зорилго нэг салбараас хараат бус байх, үүний тулд уул уурхай, эрдэс бодисоос бусад төрлийн бараа бүтээгдэхүүний экспортыг дэмжих, гадаад худалдааны олон хамтрагчтай болох гэж тодорхойлсон байдаг. Гэвч одоо ч хараахан үр дүнгээ өгөөгүй хэвээр байна.

Аливаа улсын экспортод нөлөөлөгч маш олон хүчин зүйлс байдаг. Тэгвэл улсын экспортыг таамаглах болон удирдахад ямар экспортыг тодорхойлох шаардлага тулгардаг. Олон эрдэмтэн өөрсдийн зүгээс олон аргаар тодорхойлсон байдаг. Бейсийн теоромыг олон улсын

эрдэмтэн судлаач өөрсдийн бүтээлдээ сүүлийн 10 гаруй жил түлхүү хэрэглэж байна. Экспортод нөлөөлөх маш олон хүчин зүйл байх ба түүнээс аль нь хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгааг тайлбарлахад Бейсийн загвар дундажлах аргыг хэрэглэх нь сүүлийн жилүүдэд эрдэмтэн судлаачдын түгээмэл ашиглах болжээ. Иймээс энэхүү судалгаа нь Бейсийн загвар дундажлах аргыг ашиглан Монгол Улсын экспортод нөлөөлөх хамгийн хүчтэй хүчин зүйлүүдийг илрүүлж, хамгийн сайн экспортыг тодорхойлох загварыг сонгох зорилготой юм. Хэдийгээр маш олон нөлөөлөгч хүчин зүйлс байх ч нийт 12 төрлийн нөлөөлөгч хүчин зүйл байж болох хувьсагчдыг сонгон 1990-2021 оны дата мэдээлэл дээр үндэслэн тооцооллыг гүйцэтгэлээ.

Bayesian Model Averaging (BMA)

Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалтын тодорхойлогчдын Онолын болон импарик судалгааны ажлууд дээр ГШХО-тай маш олон хувьсагчид хамааралтайг харуулсан байна. 2009 онд Faetch (Faeth, 2009) ГШХ урсгалыг тайлбарладаг 9 онолын загварыг эмпирик судалгаатай нь ГШХО тодорхойлогчдын судалгаандаа тусгажээ. Мөн тэрээр ГШХ-ын цор ганц онол гэж байхгүй бөгөөд харин ч олон төрлийн онолын загварууд ГШХО-ыг тайлбарлахаар оролдсон гэдгийг харуулсан юм. Өөрөөр хэлбэл, тэдгээр 9 онолын бүх тодорхойлогч нь ажиллаж байна гэсэн үг биш юм. Иймээс ГШХО тодорхойлогчдыг онолын олон загварыг ашиглан илүү өргөнөөр тайлбарлах хэрэгтэй.

Нэгэнт энэ онол нь эмпирик загварыг сонгоход шаардагдах хангалттай чиг баримжааг олгож чадахгүй учир загварын тодорхойгүй байдал гарч ирж байна. Өнөөдрийг хүртэл хийж ирсэн судалгааны ажиллуудад ГШХО тодорхойлогчдыг хэр хүчтэй болохыг судалж байгаагүй аж. Загварын дундажлах арга нь бидний тодорхойгүй загварт хэрэглэгдэхээр зориулагдсан юм. Энгийн үгээр тайлбарлавал энэхүү арга нь өөр өөр загварын үл мэдэх параметруудийн тархалтыг тооцох явдал юм.

18 зуунд Их Британийн математикч Томас Баяейс нөхцөлт магадлалын томъёог танилцуулсан бөгөөд үүнийг Bayes теором гэж түүний нэрээр нэрлэжээ. Нөхцөлт магадлал гэдэг нь өмнөх үр дүнгээс шалтгаалан үр дүн гарах эсэх шалтгаалдаг гэсэн үг.

$$P(A|B) = \frac{P(B|A)P(A)}{P(B)}$$

A, B = үйл явдалууд

$P(A|B)$ = B үйл явдал болбол A үйл явдал болох магадлал (*Posterior Probability*)

$P(B|A)$ = A үйл явдал болбол B үйл явдал болох магадлал (*Likelihood*)

$P(A), P(B)$ = дангаараа байх магадлал (*Prior Probability*)

ТОМЬЁО 1 BAYESIAN THEOROM

Bayes-ийн теором нь Prior probability буюу өгөгдөл ажиглалт, эсвэл шинэ мэдээлэл дараах авахаас өмнөх үеийн магадлал дээр тулгуурлан Posterior probability буюу ажиглалт, эсвэл шинэ мэдээлэл авсны дараах үеийн магадлал таамагладаг. Posterior probability тооцооллоор

BMA шууд загварын сонголтын аргыг бий болгодог. Posterior probability хувийн жин болгон ашигласнаар бүхий л байж болох загваруудын дундажыг тооцож чадна.

$$\pi(M_i|Y) = \frac{\pi(Y|M_i)\pi(M_i)}{\sum_{m=1}^{2^p} \pi(Y|M_m)\pi(M_m)}$$

M_i = Загвар

2^p = магадлалууд буюу байж болох бүх загварууд p нь хувьсагдын тоог илэрхийлнэ

Y = set of prior probability density

ТОМЬЁО 2 POSTERIOR PROBABILITY FORMULA

Bayesian Model Averaging (BMA) арга нь маш олон эмпарик судалгаан дээр нэлээд өргөн ашиглагддаг. 2001 онд Fernandez (Fernandez, 2001) улсын өсөлтийн шугаман регрессийн хамгийн хүчтэй регрессийг тооцохдоо ашигласан байна. 2008 онд Prufer болон Tondl нар ГШХО холбоотой өсөлтийн нөлөөллийг бусад өсөлтийг хүчин зүйлсүүдийн доторх хүчтэй байдлыг шалгахын тулд ашигласан байна.

Bayesian Model Averaging (BMA) нь загвар сонголтын асуудлын Bayesian-ий таамаглалт аргын өргөжилт буюу хэрэглээ болсон ба энэхүү таамаглалт арга нь шууд загварыг гаргаж өгдөг тооцоолол болон таамаглалын хослолыг хэлдэг. Гэхдээ заримдаа BMA арга нь шууд загвар гаргаж ирэхгүйгээр заримдаа олон төрлийн таамаглал болон нөхцөлт сонголтуудыг гаргаж өгдөг. Загваруудын сонголт болон хослолын хувьд BMA нь олон төрлийн асуудлуудад хариулт өгдөг.

$$\pi(\Delta|data) = \sum_m^{2^p} \pi(\Delta|M_m, data)\pi(M_m|data)$$

ТОМЬЁО 3 DELTA- ИЙН POSTERIOR PROBABILITY

Δ -ийн Posterior probability тооцоолохдоо бүх боломжит загваруудын тус бүрийн Posterior probability тооцоолоод хамгийн өндөр Posterior probability илүү их хувийн жингээр харин бага байх тусмаа хувийн жин буурч тооцоолно.

Томьёо 3 болон 4 байгаа Δ нь бүх загварт байгаа ижил параметрууд болон ирээдүйн ажиглалт эсвэл үр дүн буюу одоохондоо цуглуулагдаагүй байгаа өгөгдлүүдээр дундаж загварыг тооцоолох боломжтой болно.

Мөн бид Δ -ийн хүлээгдэж буй Posterior probability тооцож болох ба загвар тус бүрийн Posterior probability тооцоолоод түүнийг хүлээгдэж буй хувийн жинд үржүүлэн тооцоолно. Энэхүү 2 арга нь хоёулаа загваруудын хувийн жингийн дунджаар тооцогдож байгаа учир энэхүү аргын нэр нь Bayesian Model Averaging гэж нэрлэж байгаа юм. Магадлалуудыг

хувийн жингийн аргаар тооцоолсон тооцооллоос бүх хувийн жинд хамгийн өндөр магадлалтай загвар нь хамгийн сайн загвар хэмээн нэрлэгдэнэ. Ингэснээр логритм үнэлгээний дүрмээр ганц загвар ашигласнаас бага эрсдэлтэй болно гэсэн таамаглалд хүргэж байгаа юм.

$$E(\Delta|data) = \sum_m^{2^P} E(\Delta|M_m, data)\pi(M_m|data)$$

Томьёо 4 Delta-ийн хүлээгдэж буй Posterior Probability

Хувьсагчид

2017 онд Mehrara, Seijani нарын хөгжиж буй орнуудын дэвшилтэт технологиудын экспортыг тодорхойлох хүчин зүйлийн судалгаанд тэд 1996-2013 оны 24 орны 12 хувьсагчдын мэдээллийг ашиглан тодорхойлсон байдаг бол 2019 оны Экспортын зах зээлийн хувийг тодорхойлох хүчин зүйлийн судалгаанд Benkoskis, Bluhm, Vobelca нар 25 орны 48 хувьсагчийг сонгон авч Бейсийн загвар дундажлах аргыг ашиглан хамгийн тохиромжтой загваруудыг тодорхойлсон байна.

Exports of goods and services (% of GDP)	EXP	1990-2021	world bank
LABOR FORCE	LABOR	1990-2021	world bank
Cost of business start-up procedures (% of GNI per capita)	Cost	2003-2021	world bank
GDP growth (annual %)	GDP	1990-2021	world bank
External debt stocks (% of GNI)	DEBT	1992-2021	world bank
Foreign direct investment, net (BoP, current US\$)	FDI	1992-2021	world bank
Population, total	POP	1990-2021	world bank
Inflation, consumer prices (annual %)	INF	1993-2021	world bank
Government expense, annual % of total budget	EXPENSE	1990-2021	world bank
Profit tax (% of commercial profits)	TAX	2003-2021	world bank
Access to electricity (% of population)	ELEC	2000-2021	world bank
Air transport, registered carrier departures worldwide	AIR	1991-2021	world bank

Тэдгээрийн үр дүнгээс харахад хамгийн хүчтэй нөлөөлж байсан харахад тухайн бүс нутаг, нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байсан хэдийн хамгийн хүчтэй нөлөөлж болох 12 хувьсагчийн сонгон 1990 он буюу улс орнуудтай чөлөөтэй худалдаа хийх боломж бий болсон цаг хугацааг сонгон авлаа.


Үр дүн

Үр дүнгээс харахад нийт 216 загвар сонгогдсон ба түүнээс 5 хамгийн тохиромжтой Монгол Улсын экспортыг тодорхойлох загвар сонгогдсон байна.

	p!=0	EV	SD	model 1	model 2	model 3	model 4	model 5
Intercept	100.0	-1.278e+00	9.147e-01	-1.666e+00	-1.625e+00	-3.487e-01	-1.396e+00	-1.289e+00
LABOUR	24.9	4.706e-08	5.882e-07	6.872e-07
COST	61.5	1.039e+00	1.140e+00	1.776e+00	1.462e+00	.	1.262e+00	1.796e+00
GDP	17.1	1.588e-02	3.958e-01
DEBT	24.3	-9.054e-03	6.351e-02
FDI	47.9	1.324e-11	1.912e-11	.	1.826e-11	3.286e-11	.	2.886e-11
POP	44.3	1.993e-07	3.582e-07	3.517e-07	3.522e-07	.	.	.
INF	12.1	1.434e-03	2.001e-01
EXPENSE	93.4	1.293e+00	6.645e-01	1.108e+00	1.330e+00	1.866e+00	9.628e-01	1.638e+00
TAX	35.1	-4.424e-01	1.030e+00	.	.	-1.639e+00	.	-1.377e+00
ELEC	23.5	1.224e-01	3.707e-01	.	.	.	8.794e-01	.
AIR	12.9	-3.347e-07	8.018e-06
nVar				3	4	3	3	5
r2				0.498	0.553	0.475	0.468	0.601
BIC				-4.243e+00	-3.501e+00	-3.407e+00	-3.166e+00	-2.732e+00
post prob				0.034	0.023	0.022	0.020	0.016

Зураг 1 Үр дүн

Үр дүнгээс харахад эхний загвар нь шинэ бизнес эрхлэх зардал, цэвэр гадаад шууд хөрөнгө оруулалт, засгийн газрын төсвийн тэнцэл нар экспортын ДНБ-д эзлэх хувьд хамгийн хүчтэй тодорхойлогчид болохыг Р утгаас харж болохоор байна. Харин татварын хувь хэмжээ сөрөг нөлөө үзүүлэхээр байна.



Зураг 2 Үр дүн хамгийн хүчтэй нөлөөлөгчид

Нэгдүгээр загварын posterior probability хамгийн өндөр гарсан байна гэвч 0.034 гарсан байгаа нь зөвхөн энэ загвараар ердөө нийт экспортын ДНБ эзлэх хувийг 0.034-г илэрхийлж чадахаар байгааг харуулж байна. # нь бүгд 0.5 дотогч гарсан байгаа нь загварууд тодорхойлох хувьсагчууд Экспортын тодорхойдох чадамж бага байгааг илэрхийлж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаанаас харахад Экспортыг тодорхойлоход өгөгдсөн 12 хувьсагчаас хамгийн ихээр Засгийн газрын төсвийн тэнцэл, шинэ бизнес эрхлэх зардал, цэвэр гадаад шууд хөрөнгө оруулалт, хүн ам нөлөөлж байна. Мөн posterior probability нэлээд бага гарсан байгаа нь хувьсагчдын сонголтыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Asian Development Bank. (2019, 9). *Asia-Pacific Trade Facilitation Report 2019*.

Chadwick F. Alger, J. E. (1985). *Global Education: Why? For Whom? About What?*

Christensen, B. V. (2016). challenges of low commodity prices for Africa.

Faeth, I. (2009). Determinants of Foreign Direct Investment-A Tale of Nine Theoretical Models .
Journal of Economic Survey, 165-196.

Fernandez, C. L. (2001). Model Uncertainty in Cross-country Growth regressions. *Journal of Applied Econometrics*, 563-576.

K. Benkovskis, B. E. (2017). What drives export market shares? It depends! An Empirical analysis using BMA. *Empirical Economics*, 819-865.

Mohsen Mehrara, S. S. (2017). Determinants of high tech export in developing countries based on Bayesian Model Averaging.

World Bank. (2018). Retrieved from
https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD?year_high_desc=true

World Trade Organization. (2018).



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

**XX ЗУУНЫ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН Д.КЕЙНС БА
М.ФРИДМАНЫ ОНОЛУУД БОЛОН ДЭЛХИЙН ТОМООХОН
ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГОД АШИГЛАСАН ҮР ДҮН**

С.Будням¹, В.Отгонжаргал²

¹Доктор (Sc.D), Профессор, Монгол Улсын Эрдмийн Их Сургууль

²Доктор: (Ph.D), Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль



Түлхүүр үг:

Эдийн засгийн онол, эдийн засгийн бодлого, Кейнсианс, монетаризм, рейганомик

Хураангуй

Уг өгүүлэлд эдийн засгийн бодлогын боловсруулалтын хоёр хандалага: Кейнсианс ба монетаризмын талаарх шинжилгээг авч үзсэн болно. Түүхийн контексийн хувьд Д.Кейнс ба М.Фридманы үндсэн санаа болгон тэдгээрийг хямралын эсрэг эдийн засгийн бодлого боловсруулахад суурь болон ашиглах боломжийг үзсэн болно.

XX зууны 70-80-аад онуудад М.Фридманы санаа Америкийн эдийн засгийн удаан хугацааны зогсонги байдлаас гарахыг хангах боломж өгч, улмаар АНУ нь дараагийн 10 жилд инновацийн хүрээнд болон эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан байна. Мөн Их Британийн ерөнхий сайд М.Тетчер удирдаж байх үед монетар санаа чухал амжилтад хүргэснийг харуулав. Гэвч орчин үеийн глобал шинжтэй эдийн засагт нэг онолыг ашиглах нь хангалтгүй ба янз бүрийн санаагаар зэвсэглэхийг шаардаж байна. Универсаль синтетик онол буй болоогүй байна.

Удиртгал

XX зууны хоёр агуу эдийн засагчид Джон Мейнард Кейнс ба Милтон Фридман нарын онолын боловсруулалт нь орчин үеийн дэлхийн эдийн засгийн зогсонги болон турбулент хямралын үед чухал авч холбогдолтой юм. Учир нь, янз бүрийн орнуудад хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлого нь ихэндээ тэдгээрийн санаанд тулгуурласан болно.

Эдийн засгийн шинжлэх ухааныг үндэслэгчид Адам Смит ба Давид Рикордо нар өөрсдийн судалгааг нэгдэх аж үйлвэрийн хувьсгалын үе XVIII зууны дунд болон XIX зууны эхэнд хийсэн юм. Тэр үед капитализмын материал техникийн суурь нь зөвхөн буй болж эхэлж байсан ба эдийн засгийн сул хөгжилтэй байв. Иймд тэр үед хямрал, эдийн засгийн давтамж мэдрэгдэх болоогүй байлаа. Тэгвэл анхны хямрал аж үйлдвэрийн нэгдэх орон Англид 1825 онд үүссэн бол АНУ, Европын орнуудад 1857 онд хямрал болсон байна.

Тэр үед сонгомол эдийн засгийн онолын постулат нь чөлөөт худалдаа, чөлөөт өрсөлдөөн байлаа. Адам Смит эдийн засгийн үйл ажиллагааны үндэслэл нь <<зах зээлийн үл харагдах гар>> гэсэн алдарт метафорийг дэвшүүлсэн болно. [1]

Төр бол зах зээлийн харилцаанд оролцох ёсгүй бөгөөд харин зохицуулагч үүрэг гүйцэтгэнэ гэжээ. Өөрөөр хэлбэл, хянагч үүргээр хязгаарлагдана гэсэн үг юм. Тэгвэл ХХ зууны 1929 – 1933 онуудад <<их хямрал>> дэлхийг донсолгож, зах зээлийн эдийн үндэсийг эвдсэн болно. Хэн ч сүйтгэгдсэн амьдралыг хэрхэн сэргээхийг мэдэхгүй байлаа. Зах зээлийг хүлээх боломжгүй тул төрийн шийдвэртэй арга хэмжээ хэрэгтэй болсон юм. Ийм шалтгаанаар Кейнсианс үүсэж, анхны макро эдийн засгийн нэгдмэл онол үүссэн байна. Түүнээс өмнө макро эдийн засаг нь бие даасан судалгааны объект хэмээн анхаарал татдаггүй байлаа.

<<Их хямрал>>, дэлхийн эдийн засгийн шинэ нөхцөлд

Кейнсиансийн давтамж болон хямралыг шинэчлэх онол

Английн агуу эрдэмтэн, эдийн засагч, философич Д.Кейнс 1920 оны гүнзгий хямралаас гаргах арга хэмжээний боловсруулалтад оролцож, <<Их хямралын>> учир шалтгааныг судалж, зах зээлийн эдийн засгийн өөрийгөө зохицуулах үзэл санааг анх удаа үгүйсгэж, хэрэгцээ ба нийлүүлэлт цаг ямагт балансажгүй бодлохыг баталсан билээ.

Иймд хэрэгцээг дэмжихийн тулд төрөөс туслаж, таваар болон үйлчилгээний нийлүүлэлтийг тодорхойлох санал дэвшүүлжээ. Энэхүү санааг олон улс орнуудын засгийн газар хүлээн авсан байна. Ингэснээр Кейнсийн онол ялангуяа эдийн засгийн давтамж, хямралын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн идвэхтэй оролцооны үндэс болсон билээ. Эдийн засгийн хямралуудын төлөвийг дараах хүснэгтээр харуулья.

Эдийн засгийн шинэ түүхэн дахь үндсэн хямралууд

Хүснэгт: 1

Онууд	Хямралууд
1857	Дэлхийн нэгдэх хямрал. АНУ, Европын орнуудад үйлдвэрлэл хумигдсан
1873-1878	Хамгийн урт үргэжилсэн дэлхийн хямрал
1890- 1893	Герман, АНУ, Англи, Орос зэрэг орныг хамарсан хямрал
1920	Дэлхийн гүнзгий хямрал Их Британь-33%, АНУ-16%, Европын орнуудад-11% үйлдвэрлэл буурав
1929-1933	<<Их хямрал>> Аж үйлдвэржсэн орнуудын үйлдвэрлэл 46% буурч ажилгүйдэл 25%, бодит орлого 58% -аар багассан
1937	Дэлхийн хямрал. Аж үйлвэрлэл АНУ-21%, Европын орнуудад-11% - аар буурч ажилгүйдэл ихсэв.
1948-1949	АНУ, КАНАД, Европын орнууд дахь хямрал. Аж үйлдвэржсэн орнуудад үйлдвэрлэл 6% -аар буурав.
1973-1975	Дэлхийн ерөнхий хямрал нь эрчим хүчний хямралтай зэрэгцэн гарч ОПЕК -ийн орнууд нефтийн үнээ хэд дахин нэмэв, мөн хэдэн жил ургац алдагдсан
2007-2009	Дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал. Дэлхийн эдийн засаг 1% -аар буурч хөгжингүй орнуудад 3.5% -аар буурав.

Эндээс харахад 1857 – 1937 онуудад 80 жилийн туршид хямрал үргэжлэн үүсч байжээ. Тэдгээрийн гүнзгийрэл өсөж байв. Харин дэлхийн II дайны дараах хямралуудын хооронд хугацаа багассаг, хямрах хүрээ нь хумигдсан байна. Эл байдлыг капитализмын гол орон АНУ-д 1948 – оос өнөөг хүртэл хугацаанд үндсэн хямралыг үзүүлэлтүүдээр нэгдсэн хүснэгтээр харуулъя. Энэ хугацаанд АНУ-д “Эдийн засгийн судалгааны товчооны” өгөгдлөөр 32 хямрал болсон байна. Хямралтай уялдсан эдийн засгийн давтамж дайны дараа 1.5 дахин өссөн боловч, гүнзгийрэл эсрэгээр хоёр дахин багассан байна. Энэ нь хямралын эсрэг бодлогод эдийн засгийн хөгжилд төрийн үүрэг идэвхтэй байснаар тайлбарлаж байна.

XX зууны хямралын онцлог

Хүснэгт:2

Үзүүлэлт	1937 – 1957	1921 – 1948
Хямралын тоо	19	13
Нэг давтамжийн сарын дундаж тоо	55	73
Эдийн засгийн уналтын дундаж хэмжээ	15	6

Ийнхүү төрийн эдийн засгийн шинэ бодлого юуны өмнө Кейнсийн онолд тулгуурлаж байсныг тэмдэглэе.

Д.Кейнсийн үндсэн суурь бүтээл бол <<хөдөлмөр эрхлэлт, хүү зээл, хөрөнгө мөнгөний ерөнхий онол>> ном бөгөөд 1936 онд хэвлүүлсэн ба монгол хэлээр 2014 онд доктор Ш.Батбаяр хөрвүүлсэн билээ. [2]. Д.Кейнс уг бүтээлдээ хэрэгцээ, нийлүүлэлтийн балансжихгүй боломжийн шалтгааныг шинжилсэн байна. Эдийн засгийн үндсэн хөдөлгөгч хүч нь орлогоос хамаарсан хэрэгцээ болохыг Д.Кейнс номлосон байдаг. Гэвч энэхүү хамаарал нь шууд биш юм. Учир нь, хүмүүс орлогын нэг хэсгээ хадгалдаг болно. Тэдгээрийн хэрэглээ зохистой бус бөгөөд тэдэнд янз бүрийн нөхцөл байдал нөлөөлдөг. Иймд өөрчлөгдөж буй хэрэгцээ, таваар үйлчилгээний нийлүүлэлтэд нийцэх шаардлагтай тулгарах ба харин тэр үйлдвэрлэлийг өдөөх тул ажил эрхлэлт болон орлогыг буй болгоно. Иймд Д.Кейнс төрийн оролцоогоор эдийн засгийн үндсэн хөдөлгөгч хүч хэрэгцээг зайлшгүй засварлах хэрэгтэй гэсэн онолын болон практик дүгнэлт хийсэн байна. Тэгвэл 1929 – 1933 оны хямрал Нью-Йоркийн биржийн байгаагүй нуралтаас эхэлсэн байна. АНУ – ын аж үйлдвэр хоёр дахин хумигдаж, тогтмол ажилтай хүмүүсийн 25% ажилгүй болж хүн амын бодит орлого сүйрэлийн төлөвтэй буурсан байна. АНУ – д хямралын эсрэг арга хэмжээг тухайн үеийн ерөнхийлөгч Герберт Гувер эхлүүлж, түүний үндсэн хэсгийг амьдралд Франклин Рузвельт Д.Кейнсийн санааг удирдамж болгон хэрэгжүүлсэн байна. Д.Кейнсийн санаа төрийн санхүүжилттэй нийгмийн үйл ажиллагааг өргөнөөр явуулж, ажилгүйдлийг бууруулах боломжтой хэмээн үзжээ. Энэхүү санааг Франклин Рузвельт амжилттай ашигласан байна. Ингэснээр Франклин Рузвельт байдлыг тогтворжуулж, 1937 онд АНУ – д үүссэн хямрал үйлвэрлэл 21% хумигдсан байна. Мөн дэлхийн II дайны дараа 1948 – 1949 онуудад АНУ, КАНАД, Европын орнуудыг хамарсан хямрал дахин үүссэн бөгөөд эдгээр орнуудын засгийн газар хямралын эсрэг арга хэмжээнд мөн л Д.Кейнсийн санааг ашиглан хохирол багатай хямралаас гарсан байдаг. Тэгснээр тэдгээрийн аж үйлдвэр түүхэндээ анх удаа дунджаар 6% - аар өссөн болно. Дараагийн 10 орчим жил дайны дараах сэргэлт явагдаж, харин 1957 – 1958 онд шинэ томоохон хямралтай АНУ, Европын орнуул учирсан байна. Энэ хямралын үед АНУ-ын аж үйлдвэр 12.6% - аар хумигдсан бол Европын орнууд арай бага

нэрвэгдсэн байна. Дараа нь бараг 15 жил технологийн салбарын хөгжлийн хурдасгалтай холбогдон эдийн засгийн эрчимтэй хөгжил явагдсан байна. Энд ялангуяа электроник, компьютер, атомын аж үйлдвэр, сансарын эзэмшилтийн технологи чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд үүний үр дүнд биотехнологи, эм үйлдвэрлэл, цөмийн эмнэл зүй зэрэг шинэ салбарууд үүсч инновацын эдийн засгийн эхлэл тавигдсан болно. Гэвч энэхүү инновацын өсөлт 1973 – 1975 оны ердийн бус хямралаар таслагдан, нефть нийлүүлэгч ОПЕК – ийн орнуудын үнийн нэмэгдэл, хөдөө аж ахуйн ургацын хураалт буурсан төлөв байдалтай дэлхий дахин тулгарсан билээ. Энэ тохиолдолд Д.Кейнсийн онол хүчин мөхөсдөж ашиглах боломжоор багассан байна. [3,4].

М.Фридманы макро эдийн засгийн шинэ онол

XX зууны 1970 – аад оны эхэнд хямралын дараах цацанги болон стагфляц төлөвтэй тулгарсан АНУ – ын ерөнхийлөгч Г.Форт төлөв байдлыг өөрчлөхийн тулд хямралын эсрэг уламжлалт (Д.Кейнс) арга хэмжээг хэрэгжүүлэх оролдлого хийсэн билээ. Уг оролдлого амжилтгүй болсноор АНУ -ын ерөнхийлөгчөөр Д.Картер сонгогдсон болно. Гэвч Д.Картерийн хямралын эсрэг бодлого амжилгүй болж инфляц 13.5% хүртэл өсөж ажилгүйдэл барга 11% хүрсэн билээ. Америкийн түүхэнд хоёр ерөнхийлөгч ийнхүү азгүйдсэн тохиолдол хоёр дахь хугацаанд дахин сонгогдож чадаагүй байв. Эцэст нь, Рональд Рейган ялалт байгуулсан билээ. Шинэ ерөнхийлөгч Форд, Картерийн үед байсан Д.Кейнсийн онолыг баримтлагч эдийн засгийн зөвлөхүүдийг бүгдийг халж М.Фридманы шавь нарт найдлага тавьсан билээ. АНУ – ын Чикагийн их сургуулийн эдийн засагчид эдийн засгийн хөгжилд хувийн өмчтөнүүд зах зээлийн өөрөө зохицуулалтад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжтой гэсэн санааг дэвшүүлсэн болно. Тэд хэрэгцээний оронд гол үзүүлэлт таваар, үйлчилгээний нийлэлт хэмээн үзэж инновацад мөрий тавьж болно хэмээн М.Фридманы үзсэн ба түүний судалгаа нь маш их бодит материал, юуны түүрүүнд зах зээлийн санхүүгийн чиглэлд анхаарал хандуулсан байна. Түүний туурвисан алдартай бүтээл нь А.Шварцтай хамтарсан <<АНУ – ын 1967 – 1963 хүртэл монитарын түүх>> бөгөөд 1963 онд хэвлэгдсэн болно. [4]

М.Фридман, А.Шварц нар их хэмжээний бодит материалд дүн шинжилгээ хийснээр <<их хямрал>> нь Америкийн Банк санхүүгийн буруу бодлогтой холбоотойг харуулсан ба 1920 – аад оны хоёрдугаар хагаст АНУ – д мөнгөний масс мэдэгдэхүйц буурч, харин банкууд нэгэн зэрэг зээл олгож зах зээлийг хоёр дахин халааснаас болсон хэмээн дүгнэлт хийсэн байдаг. Энэ нь Д.Кейнсийн уг хямралын шалтгааныг тайлбарласнаас тэс өөр үзэл баримтлал байлаа. М.Фридман бол Д.Кейнсийн нэгэн адил кабинетын эрдэмтэн байгаагүй бөгөөд эдийн засгийн бодлогод идвэхтэй оролцдог байсны жишээ бол ерөнхийлөгч Р.Рейганы зөвлөхөөр өөрийн шавь нарын хамт ажиллаж байсныг дурдахад хангалттай юм. М.Фридман тухайн үед АНУ-ийн эдийн засгийн зогсонги байдлаас гаргах <<рейганомик>> хөтөлбөр боловсруулсан нь Д.Кейнсийн хөтөлбөрөөс эрс ялгаатай байсан болно. Р.Рейган эдийн засгийн бодлогодоо Лафферийн муруйд үндэслэсэн бөгөөд уг муруй нь нэмэлт бизнесээс орох татварыг багассанаас татвар төлөлтийн нийт дүнгийн хамаарлыг харуулдаг ба тэрхүү хөнгөлөлтөөс олох дүнг хөгжилд зарцуулах зорилт тавьжээ. Тухайн үедээ Р.Рейган Лафферийн муруйг зурагтаар тайлбарлаж байлаа. [5]. Уг нь эдийн засгийн зогсонги нөхцөлд эдийн засгийн өсөлтгүй, санхүүгийн үйлчилгээ зогсонги, төр хөрөнгийн хомсдолтой,

ажилгүйдэл нэмэгдсэн, ядуурал өсөж байхад татварыг багасгах нь утгагүй зүйл байлаа. Учир нь, төрөөс нийгэм-эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэж байв. Гэвч Р.Рейган конгресстэй тэмцэлдэн ерөнхийлөгч байх хугацаандаа татварыг хөнгөлөлтийг 750 миллиард доллароор буулгаж чадсан байв. Нэмүү өртгийн татвар эхний хоёр жилд 70% - аас 50% хүртэл, сүүлд 28% хүртэл буулгасан байна. Америкийн олон эрдэмтэн, тэдгээрийн дотор Нобелийн шагналтнууд Р.Рейганы хөтөлбөрийн эсрэг саналтай байсан ба энэ нь сүйрэлд хүргэнэ хэмээн үзэж байлаа. Тэгвэл ямар үр дүнд хүрсэн бэ? гэсэн асуултын хариултыг сонирхье. Түүнийг хүснэгтээр харуулбал:

Ерөнхийлөгч Р.Рейганы найман жилийн нийгэм-эдийн засгийн үр дүн:

Хүснэгт:3

Үзүүлэлтүүд	Өгөгдөл
Дотоодын нийт бүтээгдэхүүн	1980 он хасах 0.3%, жилийн дундаж өсөлт хамгийн их нь (3.95%), түүний дотор 1984 онд 6.8%
Ажилгүйдэл	Хөтөлбөрийн эхлэлтээс өмнө 9.8%. 1988 онд 5.5%
Инфляц	1980 онд 13.5%, 1988 онд 4.1%, хамгийн бага нь 3.2%
Хүн амын бодит орлого	20% - аар өсч, ядуугийн тоо буурсан
Нийт татвар ба хураалт	8 жилд татвар болон хураалт 750 миллиард доллароор буурч, дотоодын нийт бүтээгдэхүүний 19.7% (1981 он), 17.4% (1984 он) эзлэж байв.
Хүн амын нэмүү өртөгийн татвар	нэмүү өртгийн татвар эхний хоёр жил 70% -аас 50%, дараа нь 28% хүртэл буурсан
Хүн амын татвар ба хураамж	8 жилд 30% - аар буурсан
Ашгийн корпоратив татварын хувь	48% - аас 34% хүртэл буурсан
Төсвийн зардал	8 жил буурсан ба зарим жилүүдэд тухайлбайл 1982 онд 35.2 миллиард доллароор өмнөх жилээс буурч байв.
Улсын үндэсний өр	930 миллиард доллароос 2.7 их наяд доллар хүртэл өссөн. Төлөлт удаашралтай байв.

Ийнхүү <<Рейганомик>> хөтөлбөр АНУ – ын нийгэм-эдийн засгийн хөгжилд хүчтэй түлхэц өгч шинэчлэлийн явцад амортизацын хугацаа эрс багасч үндсэн капитал Америкийн түүхэнд байгаагүй шинэчлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, татварыг бууруулснаар хүн ам, бизнесээс авсан хэдэн зуун миллиард доллар тэдгээрийн аж амьдралын өсөлтөд зөвхөн ашиглагдаагүй, улмаар шинэ техник, төхөөрөмжид хөрөнгө оруулалтыг өдөөсөн байна. Ингэснээр АНУ – ын инновацийн хөгжлөөр тэргүүлэх байр сууриа эргүүлэн авч тухайн үед Япон, Өмнөд Солонгос, Тайванаас 1970 – аад онуудад хоцрогдож байснаас гарсан байдаг. Ингэснээр АНУ – ын 2007 – 2009 оны хямрал хүртэл 25 жил ямар нэгэн хямралгүй хөгжсөн байна. Иймд Р.Рейганыг АНУ – ын түүхэн дэх агуу ерөнхийлөгч хэмээн Америкчууд үнэлсэн байдаг.

М.Фридманы макро эдийн засгийн шинэ онолыг төрөөс баримтлах эдийн засгийн бодлогодоо амжилттай ашигласан өөр жишээ нь Их Британийн ерөнхий сайд М.Тетчер юм. [6].

М.Тетчер засгийн эрх авахад Их Британи улс түүхэндээ байгаагүй ядуурлын түвшинд хүрсэн байлаа. М.Тетчерийн өмнөх удирдлагууд татварыг өсгөж, нийт эдийн засгийн 10% - ийг улсын мэдэлд авч төрийн зардалыг эрс ихэсгэж, дээд боловсролыг үнэгүй болгож,

нийгмийн тэтгэмж, хөнгөлөлтийг үндсээр нь өргөтгөсөн байлаа. Мөн тэрээр эрүүл мэндийн санхүүжилт буурч, инфляц барга 20%, ажилгүйдэл 10% -ийг давж байв. Тэгвэл <<төмөр хатагтай>> нэртэй М.Тетчер 11 жил Их Британийг удирдахдаа дотоодын нийт бүтээгдэхүүнийг 23% хүртэл өсгөж, Францаас тасарсан байна.

М.Тетчерийн нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг хүснэгтээр харуулбал:

М.Тетчерийн үйл ажиллагааны нийгэм-эдийн засгийн үр дүн:

Хүснэгт: 4

Үзүүлэлтүүд	Өгөгдөл
Дотоодын нийт бүтээгдэхүүн	11 жилд 23% -аар өсч Францаас түрүүлж Их Британи тэргүүлэх байр сууриа буцаан авав.
Төсвийн зардлын хурдац бүхэлдээ: эрүүл мэнд, нийгмийн даатгал	1980 онд 10.8 -аас 1988 онд 5.5% хүртэл буурав 12.9%, 31.8%, 33.3% тус тус өсчээ
Инфляц	18% -аас 8% хүртэл буурав
Ажилгүйдэл	9.8% -аас 6% хүртэл буурав
Аж ахуйн нэгжийн ашгийн шууд татвар	50% -аас 30% хүртэл буурав
Хувьчлал	Нийт хугацаанд төрийн өмчийн 30% -ийг хувьчилсан байна.
Лондонгийн санхүүгийн бирж	Өмнөх хугацаанд АНУ -аас хоцорч, европд франкфуртын биржид байраа тавьж өгсөн байсныг либералчлалын ачаар европод нэгдүгээрт, Нью-Йорктийн нэгэн адил тэргүүлэгч болов

М.Тетчерийн үйлд ажиллагаанд сэтгэл дундуур байх асуудал дээд боловсролын төлбөрийг АНУ -аас бага болгосонд байдаг бөгөөд тийм учраас Оксфордын их сургуулийн хүндэт доктороор сонгогдоогүй билээ.

М.Фридманы зөвөлгөөг европын орнууд түүний Пост-социалист орнууд авч байлаа. Түүний зөвлөмж Чили улсад амжилтгүй болсон хэмээн түүний онолыг эсэргүйцэгчид дүгнэсэн байдаг. Чилийн амжилтгүй болсон нь эдийн засгийн бодлогод А.Пиночетын гэмт хэргийн үйл ажиллагаанаас үйлдэлтэй юм. Чилийн эдийн засгийн хувьд М.Фридманы онолоор дэвшилтэд хүрч орчин үед Латин Америкийн тэргүүлэх орнуудын нэг болсон билээ. Өмнөх өгүүлснээс харахад Дж.Кейнсийн санаа 1970 – аад оны дунд хүртэл эдийн засгийн бодлогод давамгайлж байсан бол түүнээс хойших хугацаанд М.Фридманы онол макро эдийн засагт ноёрхох болсон байна. Ингэснээр Д.Кейнсийн болон М.Фридманы макро эдийн засгийн хоёр үндсэн онолыг буруутгах нь мэдээжийн хэрэг зөв бус юм. Мөн тэрээр бодит материалын шинжилгээ түүний дотор орчин үеийн эдийн засаг – математикийн загвар ба аргууд Дж.Кейнс, М.Фридманы тусгайлсан үзэл санаа зөв болохыг баталгаажуулсан байгаа билээ. Иймд орчин үеийн глобалчлагдсан дэлхийн засаг дахь хүндрэлийг давахад макро эдийн засгийн ерөнхий онолд эдгээр онол ашиглагдах нь мэдээж юм. Одоохондоо эдгээрийг холбосон синтез харагдахгүй байна.

Орчин үеийн глобалчилагдсан эдийн засгийн төлөв байдлыг тайлбарлах талаар дэлхийн тэргүүлэх эдийн засагчдын санааг хүснэгтээр харуулбал:

2010 - 2020 онуудад эдийн засагчдын түлхүүр ажлуудын тойм

Хүснэгт: 6

Либерализм (Фритредерс)		Протекционизм	
Түлхүүр байх суурь	Зохиогчид, онол	Зохиогчид, онол	Түлхүүр байр суурь
... Бидэнд үндэсний улс, олон улсын худалдааны хооронд интеграц сонголттой хийх хэрэгтэй. Хэрвээ бидэнд гүнзгий глобалчлал хэрэгтэй бол үндэстэн улсаас татгалзах хэрэг гарна. [Rodrik, 2014]	Daha Podrik The Golbalization paradox, 2014. (глобалчлалын онол)	Йошка Фишир How the EU Must change 2022. (интеграцын онолын шүүмж)	Европын холбоо ирээдүйд --- бүрэн гишүүнчлэлийн оронд ... ерөнхий зах зээлд явцуу хүрээнд оролцох санал болгоно. (Fisher, 2022)
... үндэсэрэх болон тусгаарлах нь глобал удирдлагын үр дүнд занал учруулж ... Глобал эрсдэл үүсгэнэ. [Schwab, Malleret 2020]	Клаус Шбаб, Тьерри Malleret The great Reset 2020 (Либерализмын онолд)	Майкл Спенс Will Russia's War Spur Trade Diversification 2022	... Санцц ... Барууны үндсэн зэвсэг ... Хамгийн чухал үйлдэл бол найдваргүй худалдааны хамрагчаас салах
Нээлттэй худалдаа хөгжиж буй болон хөгжингүй орнуудад ашигтайд эргэлзэх зүйлгүй (Acemoglu, 2022)	Даран Аджемоглу Understanding the new Nationalism Trade, and Productivity, 2022 (глобалчлалын онолд)	Джозеф Стиглиц Shock therapy for Neoliberals 2022 (неолиберализмийн онолыг шүүмжлэх)	Зах зээл өөрөө холч бодлоггүй ... Тэдгээр нь эрсдэлийг тооцдоггүй ... Одоо үндсэн асуудал бол нийцтэй глобал нормыг тогтооход оршино. (Stiglitz, 2022)

Энэхүү хөрсөн дээр Европын холбооны түвшинд <<Green Deal>> буюу <<дахиад шинээр сайн байгуулая>>, АНУ-д (“Build Back Better”) хөтөлбөрүүд боловсрогдон хэрэгжүүлэх шатандаа ороод байна. Турболент динамик бүхий дэлхийн эдийн засгийн оновчтой шийдэл ирээдүйд хийгдэх судалгаанаас гарна гэдэгт итгэх л үлдээд байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Смит А. Теория нравственных чувств. М.Республика 1997. 330

Кейнс Дж.М. Общая теория занятости, процент и денег. Эксмо. 2007. 960 с

Freidman M. Capitalism and freedom. University of Chicago press 2020.167 p

Freidman M. Schwartz. A monetary history of the united States-1867-1960. //Princeton Unirersity press, 2008, va 14

Laffer A.B the latter curve: Past, present, and future. //Backgrounder, 2004, Vol.1765, №1. P1-16

Darby M.R. Lothian. JR British economic policy under Margaret Thatcher: A midterm examination //Carnegie-Rochester Conference series on public policy. North-Holland 1983 vol.18 Pp.157-204.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН БОДЛОГО, ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛӨХ НЬ.

Б.Отгонжаргал¹, Б.Батжаргалсайхан²

¹Магистр (MBA), Улаанбаатар Эрдэм Их Сургууль

²Магистр (M.Sc), Оксфордын Их Сургууль



Хураангуй

Хүн ам зүйн цонх / хүн амын бонус/ үеийн тухай ойлголт, энэхүү насны бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтийг урамшуулах нөхцөл болдог тул түүний эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг бүрэн ашиглах талаар төрөөс баримталж буй хүн амын бодлогод хэрхэн тусгасан талаар авч үзлээ. Монгол Улсын хүн амаа өсгөх, хүн амын хөгжлийн зорилго нь бодлого, эрх зүйн орчинд хэрхэн тусгагдсан, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө гэсэн асуудлын хүрээнд судалсан үр дүнг илэрхийллээ.

Түлхүүр үг:

харилцан хамаарал,
ажиллах хүчний оролцоо,
насжилт, хүний
капиталын бүтээмж

Оршил

Монгол орны газар нутагт анхны төрт улс тогтсон үе буюу одоогоос 2000 гаруй жилийн өмнөөс хүн амаа бүртгэж, хүн амын бодлого баримталж эхэлсэн бөгөөд хүн ам зүйн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглэсэн бодлогын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн түүхтэй⁴. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед улс орны эдийн засгийн боломж хязгаарлагдмал байсан ч хүн ам зүйн бодлого нь социалист нийгмийн үндсэн үзэл санааг хэрэгжүүлэн, “Бүхнийг хүний төлөө” гэсэн зарчмын хүрээнд хүн амаа өсгөх, боловсрол, эрүүл мэндийг нь сахин хамгаалах зорилгод чиглэж байв. Харин зах зээлийн эдийн засгийн шилжилтийн жилүүдэд төрөлт эрс буурч, хүн амын тооны өсөлт удааширч, энэ үйл явц цааш үргэлжилбэл ирээдүйд улс орны үндэсний хөгжилд сөрөг үр нөлөө үзүүлэх талаар ярьж эхэлсэн байна.⁵

Хүн ам зүйн “цонх үе” нь “demographic bonus” гэсэн Англи үгнээс гаралтай бөгөөд 1998 онд НҮБ-ийн хүн амын бодлогын газрын тайлан болон Дэлхийн хүн амын тайлбар тольд орсноор нийтээр ашиглаж судлах судлал ойлголт болж, энэ хурдтай түгэн тархсан. Эрдэмтдээс Рональд Лий (Ronald Lee) болон Андроу Мейсон (Andrew Mason) нар судалгааныхаа дүнд хүн амын бонусын үед гардаг төрөлтийн хувь болон дундаж наслалт, насны бүтцийн өөрчлөлт нь эдийн засгийн өсөлтийг урамшуулах нөхцөл болдог учраас энэ

⁴ Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба хөгжлийн асуудал, нөлөөллийн хүчин зүйлс Бодлогын судалгаа, дүн шинжилгээ, УИХ-ын Судалгааны төв, 2011 он, хуудас 11

⁵ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратеги, судалгааны хүрээлэн, 2021 он, 7 сар

хугацаанд хадгаламж болон капиталын өсөлт хурдасдаг гэсэн дүгнэлт хийгээд 1960-1990 оны Азийн эдийн засгийн хөгжлийн гуравны нэгээс дөрөвний нэг хувь нь хүн амын бонусын үр дүнд бий болсон гэж тодорхойлогджээ.

Азийн хүн амын судалгааны төвөөс Азийн хүн амын хэтийн төлвийн талаар судалгаа хийж гаргасан илтгэлд Зүүн болон Зүүн Өмнөд Азийн орнуудад хүн амын бонус 1960 оноос үзэгдэж эхэлсэн бөгөөд Япон, Солонгос, Хонг Конг, Сингапур, Тайланд, Малайз зэрэг 6 оронд 1960 оноос хойшихи хүн амын өсөлт нь эдийн засгийнхаа өсөлтөд сөргөөр нөлөөлөх вий гэж эдийн засагчид санаа зовж байсан боловч хөгжиж эрчимтэй чадсан нь дараах 3 нөхцөл бүрдсэнтэй холбоотой гэж үзсэн байна. 7Үүнд: нэгдүгээрт төрөлт буурснаас үүдэн хүн амын өсөлт буурсан, хоёрдугаарт эдийн засгийн таатай орчинд тохирсон үр ашигтай хөгжлийн бодлого явуулсан, гуравдугаарт хүн амын хүчин зүйл нь эдийн засгийн өсөлтөнд эерэгээр нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл хүн амын өсөлт ажиллах хүчний өсөлтийн хувь хэмжээний хоорондох харьцааг илэрхийлэх хүн ам зүйн хүчин зүйл, хөрөнгө оруулалт болон хадгаламжийн хувийг нэмэгдүүлэхүйц бодлогын хүчин зүйлүүд эдийн засгийн хөгжилд түлхэц өгч чадсан байдаг.

Азийн орнуудаас Япон улсад хамгийн анх хүн амын бонус илэрсэн бөгөөд одоо энэ бонусын үе дууссан гэж үздэг. Японы хувьд төрөлтийн бууралтаас шалтгаалсан эдийн засгийн хөгжил хурдассан бөгөөд Японы эдийн засагт томоохон өөрчлөлт оруулсан нь хүн ам зүйн хүчин зүйл юм гэсэн дүгнэлтийг Японы их сургуулийн эрдэмтэн Огава Наокиро хийсэн бөгөөд тэрээр төрөлтийн бууралт их байх тусам тэр хэмжээгээр өрхийн хэрэглээ буурч, үүний үр дүнд өрхийн хадгаламж нэмэгдэн хөрөнгө оруулалт өсөх үйл явц болон төрөлт буурч байхад ч хөдөлмөрийн насны хүн ам тодорхой хугацаанд өсөж байна гэсэн хоёр нөхцөл хоёулаа хангагдсан үед бонус илэрнэ гэж тодорхойлсон байна⁶. Хүн амын бонус нь ялангуяа хөгжиж буй орнуудын эдийн засгийн хөгжилд чухал нөлөөтэй боловч хүссэн цагтаа бонусыг бий болгох юмуу олон дахин ашиглах боломжгүй юм. Ямар ч улс орны хүн амын урт хугацааны өөрчлөлтийг авч үзэхэд хүн гэнэтийн хурдтай өсөлт, төрөлтийн огцом бууралт аль нэг үед нь зайлшгүй тохиолдох боловч бүх улс орнууд энэ үзэгдлийг бонус болгон засгийн хөгжилдөө ашиглаж чаддаггүй.

Харин хүн амын бонусыг эдийн засгийн хөгжилдөө үр дүнтэй ашиглаж чадсан улсуудын нэг нь Япон улс бөгөөд 1965 оны үед бонусын гол үеийг өнгөрөөгөөд одоо хөгшрөлтийн нийгэмд хэдийнээ хөл тавьсан байна. Зүүн болон Зүүн Өмнөд Азийн бусад орнуудын хувьд Солонгос 1965-1985, Сингапур 1965-1980, Хонг Конг 1965- 1980, Тайланд 1965-1975, Малайз 1965- 1980 оны хооронд хүн амын бонусыг үр дүнтэйгээр ашиглан эдийн засгаа хөгжүүлж чадсан юм. Эдгээр орнуудад хүн амын бонус 15-20 жил үргэлжилсэн байдаг.

Мөн хөдөлмөрийн насны хүн амын өсөлт, хөгжилт, сэтгэлгээний болон мэргэжил, мэргэшлийн талаарх ойлголт, өөрчлөлтийг бий болгоход 45 жилийн хугацаа шаардлагатай гэж ч судлаачид үздэг. Энэ бол хөдөлмөрийн наснаас тэтгэврийн нас хүртэлх хугацаа юм. Иймээс хүн амын өсөлтийн бодлого, хөдөлмөрийн талаарх хүний сэтгэлгээний өөрчлөлтийн

⁶ Mason Andrew, 1997, "Population and Asian economic miracle", Asia- Pacific Population and Policy, No.43

⁷ East West Center Research Program, 2002. Population and Health (ed). The future of Population in Asia, Honolulu: East – West Center

⁸ Огава Наохиро, 2003, Хүн ам, эдийн засаг, нийгмийн баталгааны загвар дахь урт хугацааны төлөв, Япон их сургуулийн хүн ам судлалын газар

цикл 45 жил гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл наад зах нь 45 жилийн дараах байдлыг төсөөлж хүн амын бодлогыг явуулна гэсэн үг.

Тэгвэл манай улсын нийт хүн амын 2022 оны байдлаар 61 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж "хүн ам зүйн цонх" 2010 онд нээгдсэн гэж үздэг бөгөөд бидний хийсэн хэтийн тооцооллоор 2045 гэхэд хаагдах магадлалтай байна.

Хүн амын насны бүтцэд бий болоод байгаа одоогийн өөрчлөлтийг хүчээр зохицуулах боломжгүй учраас хүн амд нөлөөлөх бус хүн амд тохируулах бодлого баримтлах нь илүү ач холбогдолтой.

Хүн ам зүйн цонх үеийн эдийн засгийн таатай нөхцөл боломжийг хүн амын бодлогоор хэрхэн яаж ашиглах төрийн бодлогоор зохицуулах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ.

Хүн амын талаар баримталж ирсэн бодлого, хэрэгжилтийн өнөөгийн байдал

Хүн амын талаарх бодлого нь судалгааны үр дүнгээр гарч ирсэн эерэг, сөрөг үр дагавраас үндэслэн зорилго, зорилт, түүнийг зохицуулах арга зам. Манай улсын хүн ам 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор 3278.290 мянга хүн ам бүртгэгдсэн. 1921 оноос эхлэн хүн амаа өсгөх, эрүүлжүүлэх нь төрийн бодлогын цөм асуудал байсаар ирсэн бөгөөд Монгол Улсад 1962 онд 1 сая дахь иргэнээ өлгийдсөн. 1988 оны долоодугаар сард 2.0 сая болж, түүнээс хойш 2013 оны долоодугаар сард 2.9 сая, 2014 оны эхний улиралд 2930.0 мянга, 2015 онд 3.0 сая хүрсэн. 2000 он болон 2010 оны хүн амын тооллогын төрөлтийн дундаж түвшинд үндэслэсэн статистик тооцоогоор 2016 онд гурван сая иргэнтэй болох хугацааг бүтэн нэг жилээр нааш татан 2015 оны эхний улиралд гурван сая хүн амтай болох итгэлийг төрүүлж байсан зарим судлаачид судалгааны үр дүнг өөрсдийн бүтээлүүддээ хэвлэн нийтэлж байдаг.

1970-1990 онд жилдээ 60000 гаруй хүүхэд төрсөн аж. 1988 онд энэ тоо 75000-д хүрсэн нь хамгийн олон хүүхэд төрсөн жил болсон. Харин зах зээлийн эдийн засагт шилжиж байсан 1992-1994 оны үед ард түмний амьдрал доройтож жилд 40000 гаруй хүүхэд төрж байсан үе ч байна. Энэ үед хүн ам 30.0 орчим мянган хүнээр нэмэгдэж байлаа. 1988 оны амжилтаас хойш төрөлт ингэж буурч байсан ч 2007 оноос хүн ам эрчимтэй өсөж 2012 онд хүн амын төрөлт 74.8 мянгад хүрсэн байна. Гэтэл 2013 онд 79000 эх амаржсан нь 1990 онд 72209 эх төрсөн дээд амжилтаас 23 жилийн дараах дээд амжилт болсон. Тэгвэл энэ өсөлтийн ганцхан жилийн дараа буюу 2014 онд 82839 хүүхэд төрж⁹, 1439 ба 2015 оны дээд амжилт тогтоосон эхээр хүн ам 3.0 сая болж нэгэн том шалгуур давсан бол 2018 оны эхэнд 3.2 сая болж өссөн. Улсын хэмжээнд 2018 оны эхний байдлаар өнгөрсөн жилийн мөн үеэс 75734 хүүхэд төрсний 74328 (98.1%) нь Монгол Улсад, 1406 (1.9%) нь гадаадад төрсөн байв. Төрсөн хүүхэд өмнөх оны мөн үеэс 3648 (4.6%)-иар, нас барсан хүн 340 (2.1%)-иар тус тус буурчээ. 2018 оны эхээр өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ногдох төрөлт 23.8, нас баралт 5.0, ердийн цэвэр өсөлт 18.8 байв. 1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 1.6 пункт, нас баралт 0.2 пункт, хүн амын ердийн цэвэр өсөлт 1.4 пунктээр тус тус буурчээ. 2019 онд төрөлтийн тоо 79580 болсон байна. Төрөлт өсөхөд дараах зүйл нөлөөлсөн:

⁹ "Монгол Улсын статистикийн эмхэтгэл-2014". УБ. 2015. 23 дахь талд.

- УИХ-аар 2004 онд баталсан хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “Гэр бүлийн хос, гурав ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлж, эсэн мэнд өсгөхийг урамшуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэл баримтална” гэсэн бодлогын заалтын үр дүн
- Хүн амын өсөлт өндөр байсан 1970-1980-аад онд олноор төрсөн хүүхдүүд одоо нөхөн үржихүйн насанд хүрч байгаа
- Хүүхдийн мөнгөний дүнг нэмж 20 000 төгрөг олгодог болсон
- Хүүхдээ асарсаны мөнгөн урамшууллыг эхэд олгох болсон
- Шинээр төрсөн эх болон гэр бүл болсон хүмүүст олгож байсан мөнгөн дэмжлэг
- Олон хүүхэд төрүүлсэн эхчүүдэд олгодог эхийн алдар I, II зэргийн Одонг олгох журмыг өөрчлөн 2011 оноос эхлэн нэг эхийн төрүүлж өсгөсөн хүүхдийн тооны болзлыг бууруулахын зэрэгцээгээр тодорхой хэмжээний Мөнгөн урамшуулал олгодог болсон зэрэг төр засгаас хүн амын төрөлтийг дэмжсэн бодлогын үр дүн юм.

Судалгааны үр дүнгээр гарч ирсэн хүн хүчний нөөц боломжийн үндэс болсон эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажиллах хүчний гол цөм нь хөдөлмөрийн насны хүн ам бөгөөд энэ нь хүн амын насны бүтцийг тодорхойлох гол хэмжүүр юм. Хүн амын насны бүтэц нь эдийн засгийн өсөлтийн нэг гол нөөц, боломж. 2014 онд манай улсын нийт хүн амын тоо 2995.9 мянга болж өмнөх оноос 2.2 хувиар өссөн байна. 1980-аад оны дундуур дэлхийн хүн амын дундаж өсөлт 2 хувь байх үед манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2.8 хувь байснаа 1990-ээд оны дунд үед 1.5 хувь болж буурсантай харьцуулахад 2011-2014 онд хүн амын жилийн дундаж өсөлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Манай хүн амын тоо 3.0 сая байгаа нөхцөлд жилийн дундаж өсөлт 2.8-1.2 хувь хүртэл буурсан нь үндэсний аюулгүй байдалд ч сөрөг нөлөө үзүүлэх асуудал болж байв. Харин хүн амын жилийн дундаж өсөлт 2014 онд 2.2 хувь болсон нь ахиц дэвшил юм. 1995- 2020 онд хүн ам 2317.5-3296.9 мянга болж 142.3 хувиар өссөн нь нэгэн үеийн түүхэн амжилт гэж бичигдсэн байна.

Манай улсын хүн амын насны бүтэц ерөнхийдөө идэрших хандлагатай болж, залуу насны хүн ам дийлэнх хувийг эзэлж, хүн амын тоонд 15-64 насны хөдөлмөрийн насны болон нөхөн үржихүйн насны хүн амын эзлэх хувийн жин өндөр хүн ам зүйн цонх үе нээлттэй байна. Энэ үеийг улс орнууд урьдчилан тооцож эдийн засгийн нөөц боломжийг бүрдүүлэх, хөгжлийн бодлогыг харилцан уялдаатайгаар авч үзэх, хүний нөөцийн бүрдэлт, ашиглалт, ажиллах хүчний хэрэгцээ, нийгмийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн хэмжээ, салбаруудын ирээдүйн эрэлт, хэрэгцээг тодорхойлж, бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх суурь нөхцөл болгодог. Тухайлбал энэ үе нөхөн үржихүйн таатай үе байж, хүүхэд залуучуудын тоо өсөх тул тэдэнд эрүүл мэнд, боловсролын тэгш үйлчилгээ үзүүлэх, чадамжтай хүний нөөцийг бий болгох, мөн эрүүл урт наслалтад бэлтгэх зэрэг бодлого, үйл ажиллагааг боловсруулан, хэрэгжүүлэх ёстой. Хүн амыг нэмэгдүүлэх бодлогын үр дүн болон шилжилтийн эдийн засгийн үед хүн ам бага өссөн нь Монгол Улсад хүн амын тоо хэмжээ, өсөлтөөс илүүтэй насны бүтцийн асуудлыг бодлогын хэмжээнд авч үзэх шаардлагыг бий болгоод байна.

Бидний хийсэн хүн амын хэтийн тоооноос харахад хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 2050 он хүртэл 54 хувиас буурахгүй байгаа нь хүн ам зүйн цонхны хоёрдугаар үе манай

оронд ойрын 27 жилд үргэлжлэхээр байгааг харуулж байна. Энэ үеийн боломжийг үр өгөөжтэй, оновчтой ашиглах асуудал нь Монгол Улсын эдийн засгийн бодлогын цөм асуудал болно.

Хүн ам зүйн динамик ба нийгэм-эдийн засгийн хөгжлийн хоорондын уялдаа холбоог Английн эдийн засагч Томас Мальтус¹⁰ анх удаа онолын үндэстэй гарган тавьсан. Хүн амын өөрчлөлт болон эдийн засгийн өсөлт нэг нь нөгөөдөө нөлөөлдөг. (Bloom et al., 2000). Эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн хурд, мөн чанар нь хүн ам зүйн шилжилтийн үйл явцыг илэрхийлдэг бол хүн ам зүйн шилжилтийн янз бүрийн үе шатууд нь эдийн засгийн өсөлт, хөгжилд өөрийн гэсэн үр нөлөөг үзүүлдэг.

Манай улсын эдийн засгийн өсөлт 1990-2018 оны хооронд ихээхэн хэлбэлзэлтэй байсаар ирсэн ба 1995-2000 онд эдийн засгийн өсөлт 2.7% байсан бол 2005-2010 онд 10.2% хүрч, харин 2010-2017 онуудад эдийн засгийн өсөлт 8.1% байсан бөгөөд 1990-2017 онуудад жилийн дундаж өсөлт 4.4% байжээ.

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хувиар

ДНБ, 2005 оны зэрэгцүүлсэн үнээр		Жилийн дундаж өсөлт (%/жил)	
Он	(сая. төгрөг)	Он	%
1990	2,227,311	1990-1995	-0.27
1995	1,941,470	1995-2000	2.7
2000	2,221,690	2000-2005	6.5
2005	3,041,406	2005-2010	6.5
2010	4,162,785	2010-2015	10.2
2015	6,762,785	2015-2016	1.2
2016	6,841,925	2016-2017	5.1
2017	7,189,074	2005-2017	7.4
		2010-2017	8.1
		1990-2017	4.4

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2017, ҮСХ, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2019 оны 2 дугаар сар, ҮСХ

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

Үзүүлэлт	Эдийн засгийн өсөлтийн үе		Эдийн засгийн уналтын үе		Эдийн засгийн сэргэлтийн үе	
	2019	2020	2021	2022	2023	
Эдийн засгийн өсөлт	5.1	-2.1	4.6	4.8	5.4	
Бодит ДНБ-ий өсөлт	5.5	-4.4	1.4	2.5	5.8	
Инфляц	7.3	3.7	7.1	10.5	7.5	

Эх сурвалж: Азийн хөгжлийн банкны тайлан., УБ 2023 он.]


Хэрэв 1980-1990 оны хооронд тогтвортой байсан хүн амын жилийн дундаж өсөлт 2.5 хувийг 1990 оноос хойших 15 жилд хадгалж чадсан бол манай улсын хүн амын тоо 2005 онд гэхэд 3.0 саяд хүрэх тооцоотой байсан юм.

¹⁰ Article, Changes In Population Age Structure and Economic Development, Bangladesh, 2016

Манай улсад сүүлийн үед үр хөндүүлэлт улам залуужиж, ганцхан жилд насанд хүрээгүй 3000 гаран охин тээж буй ургаа устгуулсан байна. 2012 оны байдлаар төрийн болон хувийн өмчийн 126 эмнэлэг эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээ үзүүлж байв. Эдгээрээс 13 нь үр хөндөх албан ёсны эрхтэй боловч бусад нь нууцаар үр хөндөлт хийж байв.

Манай улс 1957 онд анх алдарт эхийн одон олгохоор хууль баталж наймаас дээш хүүхэд төрүүлсэн эхэд нэгдүгээр, таван хүүхэд төрүүлсэн эхэд хоёрдугаар зэргийн одон өгдөг болсон. 2010 онд дөрвөөс дээш хүүхэдтэй гэр бүл 26706 байв. Таван хүүхэдтэй гэр бүл 11497, зургаан хүүхэдтэй 5768 гэр бүл, долоон хүүхэдтэй 3950, наймаас дээш хүүхэдтэй 3357 гэр бүл байв. “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай” шинэ хууль батлав. Энэ хууль батлагдсанаар 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд “Эхийн алдар” 2 дугаар, 6 ба түүнээс дээш бол 1 дүгээр зэргийн одон өгч жилдээ 100.0 ба 200.0 төгрөгийн мөнгөн тусламж өгөх болов. 2011 онд "Эхийн алдар" одонтой нийт 204313 эх бүртгэгдсэн бол 2022 оны байдлаар алдарт эхийн одонтой 2043401 ээж байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр Монгол Улсын харьяат хүн амын тоо 3 357.5 мянга болсон нь 2010 оны тооллогын он жилтэй харьцуулахад 542.2 мянган хүнээр буюу 19.7 хувиар өссөн бөгөөд эрэгтэйчүүд 18.7 хувиар, эмэгтэйчүүд 20.6 хувиар нэмэгджээ. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хүн амын 49.1 хувийг эрэгтэйчүүд, 50.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.¹¹

Зураг 1. Хүн амын нас хүйсийн суварга, 2020 он




Эх сурвалж: ҮСХ

Сүүлийн 9 жилийн хугацаанд төрөлт нэмэгдсэний улмаас суваргын суурь хэсэг илүү өргөссөнийг дээрх зургаас харж болох бөгөөд энэхүү суварга манай улсын хүн амын нас, хүйсийн бүтэц, цаашдын чиг хандлагыг илэрхийлэх хамгийн тодорхой, ойлгомжтой дүрслэл юм. Хүн амын нас, хүйсийн бүтэц нь тухайн орны хүн амын нөхөн үржихүйн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход ач холбогдолтой юм.


Монгол Улсын хүн ам 28 жилийн дараа 4707570 мянга болох магадлалтай байна.

¹¹ ҮСХ(6), 2020.

Зураг 3. Монгол Улсын хүн ам, хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь /хэтийн тооцоо 2020-2050 он/



Зураг 4. Хүн амын нас хүйсийн суварга, 2050 он



Бидний тооцоолсон 2050 оны хүн ам нас хүйсийн суварга нь тоон эх сурвалжийн хувьд ҮСХ-ны гаргасан хэтийн тооцоо, хүн амын нас хүйсийн суваргаас ялгаатай. Бид үндэсний статистикийн хорооны 2018 оны хүн амын тоонд үндэслэн системийн динамикийн Vensim системийн Vensim5.PLE хувилбарыг ашиглан компьютерийн симуляци хэлбэрээр хүн амын хэтийн тооцоог Дэлхийн банкнаас гаргадаг хүний капиталын индекс тооцдог томъёог ашиглан хийсэн болно. 2050 оны хүн амын нас хүйсийн суварга нь бидний хийсэн хэтийн тооцоонд үндэслэн байгуулсан хувилбар болно. Хүн амын нас хүйсийн суваргаас харахад нийт хүн амд ногдох хөдөлмөрийн насны хүн ам 54 орчин хувь байх төлөвтэй байна.

Дэлхийн банкны судлаачдын үзэж байгаагаар тухайн улс орны эдийн засгийн өсөлтийн 40 хувийг хүний капитал бүрдүүлнэ гэж үзэж байна.

ХКИ дараах байдлаар эдийн засагт нөлөөлнө гэж тооцов.

$$y = Ak^a p k^{(1-a)}_h$$

Үүнд: y - нэг ажиллагсадад ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн, k_p – нэг ажиллагсадад ноогдох биет капитал, k_h - нэг ажиллагсадад ноогдох хүний капитал. A – нийт бүтээмж.

Дэлхийн банкны The Human Capital Index, 2017 оны тайланд дурьдсанаар Монгол улсын Хүний капиталын индекс 0.64 буюу судалгаанд хамрагдсан 151 орноос 51-дүгээрт жагсаж байсан бол 2020 оны байдлаар хүний капиталын индекс нь 0.61 буюу 151 орноос 59-д жагсаж 8 орноор ухарсан үзүүлэлттэй байна.

Хүн амын талаар баримталж ирсэн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд 1990-ээд оны эхэн үед хүн ам зүйн үйл явцад гарч байсан огцом өөрчлөлтийг эдийн засгийн хямралын үед хүн амын амьжиргааны тэнцвэрт байдлыг хадгалах түр зуурын, зүй ёсны үзэгдэл байсан гэж үзэж болох боловч энэ байдал удаан үргэлжилбэл Монгол Улсын хүн амын хэтийн тогтвортой өсөлтийг хангах нөөц алдагдах нөхцөл байдал бий болох төлөвтэй байжээ.

Энэ үед хамгийн том ололт нь Монгол Улсын төр засгийн тэргүүн нар Хүн амын асуудлаар Бухарестад 1974 онд, Мехикод 1984 мөн 1994 Каирт, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжинд тус тус хуралдсан олон улсын бага хуралд оролцож, хурлаас гаргасан хүн ам, эдийн засгийн тогтвортой өсөлтийн чухал шийдвэрийн мөрөөр хүн амын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих болон дүгнэх үүрэг бүхий удирдлага зохион байгуулалтын бүтцийг төрийн захиргааны төв байгууллагад бий болгож “Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам”-ыг тухай үеийн Засгийн газрын бүтцэд ажиллуулсан явдал юм.

Тухайн үед Монгол Улс хүн амын талаар мэдээ цуглуулах тогтолцоо бүрдсэн, иргэний бүртгэлийн мэдээллийн сантай, хүн амын тооллого харьцангуй сайн хийж байсан хэдий ч цуглуулсан мэдээлэлдээ чанарын дүн шинжилгээ хийх, түүнийг хөгжлийн төлөвлөлтөд ашиглах явдал хангалтгүй байсан. Учир нь мэдээлэл боловсруулалт хамгийн үндсэн буюу ерөнхий үзүүлэлтэд чиглэгдэж байсан аж. Өөрөөр хэлбэл манай улсад хүн ам судлал хөгжөөгүй байсан үе гэж үзэх үндэстэй юм.

Иймд хүн ам ба хөгжлийн асуудлаар дэлхийн болон улс орны хэмжээнд тавигдаж буй зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тухайн үеийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг улам боловсронгуй болгох, хүн амын бүртгэл, мэдээлэл судалгааны чанарыг цаашид сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж хүн ам зүй, хөгжлийн тулгамдсан эдгээр олон асуудлыг шийдвэрлэх төрийн бодлого боловсруулах хэрэгцээ гарсан.

Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам нь хүн ам зүйн асуудлаар мэргэшсэн үндэсний мэргэжилтэн ч байгаагүй энэ үед НҮБ-ын хүн амын сан болон бусад олон улсын байгууллагатай хүн амын чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлж, МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Хүн амын сургалт судалгааны төвийг байгуулснаар хүн ам, хөгжлийн талаар судалгаа шинжилгээний ажлыг хийх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого, боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, судалгаа, шинжилгээний байгууллагын бүтцийг бий болгосон аж.

Монгол Улсын Засгийн газар 1994 оны Кайрын Хүн амын хөгжил олон улсын бага хурал (ХАХОУБХ)-ын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (ҮАМХ)-г тусгагдсан зорилго, зорилтуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөртөө тусган Монгол Улсаас хүн амын бодлогыг нийгмийн харилцааны шинэ нөхцөл болон Үндсэн хуулийн үзэл санаанд

нийцүүлэн тодорхойлох шаардлага тавигдаж 1996 онд “Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын бодлого” баримт бичгийг УИХ-ын 24 дүгээр тогтоолоор баталсан байдаг.

Энэхүү бодлого нь дэлхийн хөгжлийн хандлагад хүн ам ба тогтвортой хөгжлийг нягт уялдуулах, хүн ам зүйн зорилтыг хүний хөгжил, сайн сайхан аж амьдралыг хангах, ядуурлыг бууруулах зорилттой нягт холбоотой шийдвэрлэх үндсэн зарчмыг баримталж байгааг харгалзан хүн ам ба хөгжлийн асуудлыг хамарч 8 бүлэг 105 зорилт дэвшүүлсэн бөгөөд Хүн амын бодлого нь Монгол Улсын хөгжлийн ойрын ирээдүйн буюу 21-25 жилийн хугацаанд хүн амын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох хүн ам, тогтвортой хөгжлийн тулгуур баримт бичиг” гэж үзжээ.

Үе үеийн төр засгаас баримталж ирсэн бодлого нь хүн амаа өсгөхөд чиглэгдэж ирсэн бөгөөд энэхүү бодлогод хүн амыг **тогтвортой өсгөх** зорилтыг хангахын тулд **төрөлтийг дэмжих, эх хүүхдийн эндэгдлийг бууруулах** болон **үр хөндөлтийг зохицуулах**, нөхөн үржихүйн асуудлаарх мэдээлэл, гэр бүлийн үйлчилгээг өөрийн орны онцлог байдалд тохируулан явуулах болон хүн амын байршил, дотоод гадаад шилжих хөдөлгөөнийг зохицуулах талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхой тусгаснаараа онцлог юм.

Ялангуяа байгаль орчны даац, хүн амын өсөлт, нийгмийн үйлчилгээний тэнцвэртэй харьцааг хослуулах үндсэн дээр хот, сууринг монгол хүний сэтгэл зүйд нийцсэн үндэсний өвөрмөц хэв шинжтэй хөгжүүлэх чиглэл баримтлах, нийслэл болон томоохон хотын хүн амын хэт төвлөрлийг багасгах, дагуул хотууд, бүс нутгийн төвүүдийг хөгжүүлэхэд түлхүү анхаарах талаар ч тусгасан байна.

Түүнчлэн даяаршил, олон улсын шинжих хөдөлгөөний асуудалд анхаарч Монголд байнга оршин суух гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүсийн тоо, бүтэц болон ажиллах хүч оруулах, гаргах, тус улсын иргэд цагаачлахтай холбогдсон асуудлыг улс орны аюулгүй байдал, хүн амын өсөлт, нийгэм эдийн засгийн хөгжлийн цаг үеийн шаардлага, хүний эрхийг хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчимд нийцүүлэн төрөөс зохицуулна гэж үзжээ. Мөн Монгол Улсын иргэд гадаадад түр шилжин суурьшихтай холбогдсон гэрээ хэлэлцээрт иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг тусгаж, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настны эрх ашгийг хамгаалахад онцгойлон анхаарна гэсэн зорилт дэвшүүлсэн байдаг.

Эдгээрээс дүгнэхэд хүн ам ба тогтвортой хөгжлийн уялдааг хангах талаар баримтлах бодлого, зах зээлийн харилцааны нөхцөлд хүн ам зүйн асуудлыг эдийн засаг нийгмийн хөгжлийн бодлого, зорилттой нягт холбоотой боловсруулж хэрэгжүүлэх нь тогтвортой хөгжил ба хүн амын сайн сайхан аж амьдралыг хангах гол нөхцөл гэж үзэж энэ талаар баримтлах бодлогыг тусгай хэсэг болгон тодорхойлсон анхны бодлого гэж дүгнэж байна. 2000 онд баталсан Мянганы хөгжлийн зорилтууд болон олон улсын бага хурлуудаас хүн ам, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжил, эмэгтэйчүүдийн боловсрол, тэдгээрийн эдийн засгийн статусыг ахиулах, ядуурлыг бууруулах, улс орны хөгжлийг хүний хөгжлийн түвшнээр тодорхойлоход чиглэсэн амин чухал олон асуудлыг авч хэлэлцэн чухал шийдвэр гаргасан, Ялангуяа Каирын "Хүн ам ба хөгжил" сэдэвт олон улсын бага хурлаас 2004 он хүртэлх хүн ам зүйн асуудлаар гаргасан үйл ажиллагааны хөтөлбөр нь дэлхийн орнуудын хүн ам ба хөгжлийн асуудлаар баримтлах мөрийн хөтөлбөр болж, хурлуудаас гарсан шийдвэр, тунхаг бичгийг бодит амьдралд хэрэгжүүлэх, үүний тулд шаардлагатай бүх арга

хэмжээ, үүний дотор хууль тогтоох, эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг амлалт авсан байдаг. Үүний дагуу

Хүн амын бодлогын асуудлыг 1992 оны Үндсэн хуульд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” хэмээн шинэ утга агуулгаар баяжуулан хуульчилсан байдаг.

Гэр бүлийн тухай (1999), Хөдөлмөрийн тухай (1999), Боловсролын тухай хууль (2002), Ажиллах хүчин гаргах, гаднаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (2015), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2004), Хүний хөгжил, сангийн тухай хууль (2009), Эрүүл мэндийн тухай хууль (2011), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011), Ахмад настны тухай хууль (2005), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016, Хүүхдийн эрхийн тухай хууль (2016), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2017), Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017), Ахмад настны тухай хууль (2017) зэрэг хуулиар хүн амын хөгжил нэн ялангуяа эрэгтэй, эмэгтэй хүн, охид хөвгүүд, ахмад насны эрх тэгш байдал, нийгмийн шударга ёсыг хангах зэрэг нийт 16 хуульд **хуульчилсан** болон Засгийн гараас 19 үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээрийн 6 нь хүчингүй болсон буюу хэрэгжиж дууссан байна. УИХ-р 2004 онд батлагдсан “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-д 2025 он гэхэд хүн амын өсөлтийн түвшин 0.9 хувьд хүрэх магадлалтай гэдэгт анхаарч гэр бүлийн 3 дахь хүүхэд болон залуу гэр бүлийг дэмжих мөнгөн тэтгэмж, урамшуулал олгох зохицуулалтыг хийсэн хэдий ч хүн ам зүйн цонх үеийг хэзээ тохиох, хэрхэн үр ашигтай ашиглах талаарх зохицуулалтын асуудалд онцгойлон анхаарч тодорхой арга хэмжээ аваагүй тул хүн ам зүйн бонусын 1 дүгээр үеийг бүрэн ашиглаагүй гэж дүгнэж болохоор байна.

2016 онд Засгийн газраар батлагдсан Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод Хүн ам зүйн цонх -2 дугаар үеиг ашиглах тухайн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн аж. Бодлогын баримт бияигт тусгасан зорилго, түүний хэмжигдэхүйц зарим үзүүлэлтийн хэрэгжилтийн байдлыг бид судалж үзэхэд (Хүснэгт 1) 12 гол шалгуур үзүүлэлт, үр дүнгээс 8 үзүүлэлт суурь түвшнээс доогуур байна. 2 үзүүлэлт нь зорилтот түвшиндээ хүрсэн, 1 үзүүлэлт Ковид-19 цар тахлын цаг үетэй холбоотойгоор хүрсэн түвшинээ хадгалж чадаагүй байна. Харин дундаж наслалт зорилтот түвшиндээ хүрээгүй ч суурь түвшнээс өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийн байдал

Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Дунд хугацаанд хүрсэн түвшин
Хүн амын жилийн дундаж өсөлт	2.1%	2.1 %	019-2022 онд 1.7 ¹²
Төрөлтийн нийлбэр коэффициент, хүүхдийн тоо	3%	3%	2019 онд 3.0 ¹³

¹² ҮСХ, 2020, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал

¹³ ҮСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Хүн амын ердийн хөдөлгөөний мэдээлэл 2019

Дундаж наслалт	Эм-75.8 жил Эр- 66.0 жил	77.5 жил	2019 онд 76.0 ¹⁴
Эхийн эндэгдлийн харьцаа	26	25	2020 онд 51 ¹⁵
Нялхсын эндэгдлийн түвшин	15	13	2020 онд 11 ¹⁶
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	18.0	15.0	2020 онд 14.0 ¹⁷
Нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь	32.0	38.0	2020 онд 32.0 ¹⁸
Хүний хөгжлийн индекс	90.0	85.0	2020 онд 99.0 ¹⁹
Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь	61.5	66.0	2020 онд 60.5 ²⁰
Ажилгүйдлийн түвшин	7.5	6.0	2020 онд 10.0 ²¹
Ядуурлын түвшин	21.6	18	2019 онд 28.4 ²²
Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	32	31.5	2020 онд 32 ²³

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, түүний хэрэгжилтийн байдлыг дүгнэж үзэхэд хүн ам зүйн цонхны 2 дугаар үеийг эдийн засгийн өсөлтөд бүрэн ашиглахтай холбогдуулан засгийн газраас тодорхой стратеги, шийдвэр гараагүй, хэрэгжүүлэх түвшинд ч идэвхи санаачилга сул хэмээн дүгнэхээр байна.

Бидний тооцоогоор хүн ам зүйн цонх үе манай оронд 2045 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байна 2021 онд хүн ам 2000 оноос ажиллагчид 19.3 хувиар өссөн бол 2025 онд 8,9 хувиар буурах боловч 2030 онд 6.5 хувиар өсөх 2035 онд 5.7 хувиар, 2040 онд 4.7 хувиар 2045 онд 4 хувиар 2050 онд 3.6 хувиар тус тус өмнөх 5 жилийн түвшинээс өсөх төлөвтэй байна. Энэхүү хүн амын бонусыг үр дүнтэй ашиглаж чадвал Монголын эдийн засаг цаашид улам эрчимтэй хөгжих боломжтой хувилбар гарч ирэх болно.

Хүн амын бонусын үр ашиг тухайн орны хөгжлийн үе шатнаас хамаарна. Хэдийгээр хөдөлмөрийн насны хүн ам өсч байвч хөдөлмөрийн зах зээлийн хөгжил хоцрогдож байвал өсөн нэмэгдэж буй ажиллах хүчийг зах зээл өөртөө шингээж, эдийн засгийн хөгжлийн нэгэн түлхэц болгож чадахгүй. Өөрөөр хэлбэл, тухайн орны үйлдвэрлэлийн, ажил эрхлэлтийн, санхүүгийн бодлого зэрэг нь хүн амын бонусын үр ашигт ихээхэн нөлөө үзүүлнэ. Иймд

Хүн амын өсөлт, эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарлын судалгаа, дүн шинжилгээ.

Хүн амын бодлогын хүрээнд дэвшүүлсэн зарим зорилт, дотоодын нийт бүтээгдэхүүн хоорондын холбоо хамаарлыг эконометрикийн түүний дотроос дисперс корреляцийн

¹⁴ www.1212.mn 4 www.1212.mn 5 www.1212.mn

¹⁵ ҮСХ, 2020, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал.

¹⁶ ҮСХ, 2020. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал

¹⁷ ҮСХ, 2020. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал

¹⁸ ҮСХ. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын нэгдсэн дүн, Улаанбаатар, 2020, 70 дахь тал

¹⁹ <http://hdr.undp.org/en/content/latest-human-development-index-ranking>

²⁰ ҮСХ, 2020. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2016-2019 оны танилцуулга

²¹ ҮСХ. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл 2019

²² <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>

²³ ҮСХ. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Өрхийн орлого, зарлагын мэдээлэл 2020

шинжилгээгээр оношлон харилцах хамаарлыг нөлөөллийг Ковв-Дугласын үйлдвэрлэлийн функцийг аргаар судаллаа.

Нэг хүнд ноогдох ДНБ нь тухайн улсын эдийн засгийн өсөлтийг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг юм. Хүний Хөгжлийн Индекс (ХХИ) нь ДНБ-ий өөрчлөлтөд хүний хүчин зүйлийн (хүмүүн капиталын) нөлөөлөл, ашиглалт, үр ашгийг хэмжихэд нэмэр болдог бөгөөд тус судалгаанд ДНБ-д эрүүл мэнд, боловсролын зардлын эзлэх хувь, амьжиргааны түвшинг төлөөлөх үзүүлэлт – дундаж наслалт зэргийг авав.

Хүснэгт 4. Хамаарлын (корелляцын) матриц нь дээр дурдсан хувьсагчдын хооронд хамаарал байгаа эсэхийг харуулж байна.

	Нэг хүнд ноогдох ДНБ	ХХИ	ДНБ-д Боловсролын салбарын эзлэх хувь	Дундаж наслалт	Эмэгтэй ажиллах хүчний оролцоо	ДНБ-д Эрүүл мэндийн салбарын эзлэх хувь
Нэг хүнд ноогдох ДНБ	1	0.723	0.268	0.914	-0.126	-0.244
Хүний хөгжлийн индекс		1	0.526	0.901	-0.722	0.164
ДНБ-д Боловсролын салбарын эзлэх хувь			1	0.498	-0.305	0.134
Дундажж наслалт				1	-0.807	0.071
Эмэгтэй ажиллах хүчний оролцоо					1	-0.124
ДНБ-д Эрүүл мэндийн салбарын эзлэх хувь						1

“Эдийн засгийн өсөлтийн үр дүнд эрүүл мэндийн үйлчилгээ чанаржиж улмаар нас баралт буурч, дундаж наслалт нэмэгддэг.

Эдийн засгийн сонгодог, шинэ сонгодог хийгээд дотоод өсөлтийн онолоор эдийн засгийн өсөлтөд:

- Капиталын өсөлт /хөрөнгө оруулалт/;
- Хөдөлмөрийн өсөлт /ажлын байрны өсөлт/;
- Хүмүүн капиталын өсөлт /мэдлэг, дадлага туршилага, ур чадвар гэх мэт/;
- Институцийн хөгжил /засаглал, хууль тогтоомж, дүрэм журам, татвар гэх мэт/ зэрэг үзүүлэлт нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг.

Манай улсын хувьд эдийн засгийн өсөлтөд ямар ямар хүчин зүйлс, ямар хэмжээгээр нөлөөлдгийг тодорхойлох зорилгоор Ковв-Дугласын үйлдвэрлэлийн функцийг сонгон ашиглалаа.”

$$Q = b_0 L^{b_1} K^{b_2}$$

Үндсэн хөрөнгө, ажиллах хүч ба эдийн засгийн өсөлтийн хоорондын хамаарлыг харуулахын тулд:

Q - ДНБ

K - капиталын хэмжээ, үндсэн хөрөнгө

L - ажиллах хүч, ажиллагсад

b_0, b_1, b_2 , – нь Кобба Дугласын үйлдвэрлэлийн функцийн параметрууд бөгөөд тухайн хүчин зүйлсийн үйлдвэрлэлийн хэмжээнд нөлөөлөгч үзүүлэлтэд үзүүлэх мэдрэмжийн коэффициент байна. Үнэлгээнд ашигласан үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Эдийн засгийн өсөлтөд Кобба-Дугласын үзүүлэлтийн харилцан хамаарал

Он	ДНБ (Q)	Капиталын хэмжээ (K)	Ажиллах хүч (L)	Эмэгтэй ажиллах хүч (Lf)	Ln(Q)	Ln(K)	Ln(L)	Ln(Lf)	Он
2000	1224.1	355.1	809.0	412,8	7.110	5.9	6.7	12.93	2000
2001	1391.9	350.4	832.3	429,6	7.238	5.9	6.7	12.97	2001
2002	1550.6	382.1	870.8	447,4	7.346	5.9	6.8	13.01	2002
2003	1829.1	590.1	926.5	475,7	7.512	6.4	6.8	13.07	2003
2004	2361.2	736.3	950.5	503,0	7.767	6.6	6.9	13.13	2004
2005	3041.4	1141.4	968.3	507,3	8.020	7.0	6.9	13.14	2005
2006	4027.6	1445.3	1009.9	536,8	8.301	7.3	6.9	13.19	2006
2007	4956.6	1918.5	1024.1	536,9	8.508	7.6	6.9	13.19	2007
2008	6555.6	2856.0	1041.7	546,5	8.788	8.0	6.9	13.21	2008
2009	6590.6	2265.3	1006.3	542,8	8.793	7.7	6.9	13.20	2009
2010	9756.6	4106.3	1033.7	540,3	9.186	8.3	6.9	13.20	2010
2011	13173.8	7660.6	1037.7	529,2	9.486	8.9	6.9	13.18	2011
2012	16688.4	9328.6	1056.4	550,5	9.722	9.1	7.0	13.22	2012
2013	19174.2	10215.2	1103.6	571,7	9.861	9.2	7.0	13.26	2013
2014	22227.1	7818.4	1110.7	567,8	10.009	9.0	7.0	13.25	2014
2015	23150.4	6114.6	1151.2	585,5	10.050	8.7	7.0	13.28	2015
2016	23942.9	6161.6	1147.8	592,3	10.083	8.7	7.0	13.29	2016
2017	27876.3	8744.4	1238.3	635,5	10.236	9.1	7.1	13.36	2017
2018	32411.2	12830.5	1253.0	628,0	10.386	9.5	7.1	13.35	2018
2019	37280.8	14740.3	1146.2	591,9	10.526	9.6	7.0	13.29	2019

$$\text{Log}(Q) = \log b_0 + b_1 * \log(K) + b_2 * \log(L)$$

Хүснэгт 2-ын мэдээлэл дээр үндэслэн статистик шинжилгээний регрессийн аргаар бодсон 2 үр дүн нь дараах байдалтай гарч байна.

Эхнийх нь ДНБ (Q)-ий хэлбэлзлэлд K- капиталын хэмжээ, үндсэн хөрөнгө; L- нийт ажиллах хүчний хэлбэлзлийн нөлөөллийг харуулсан тооцооны үр дүн юм.

Эхний үр дүн:

<i>Regression Statistics</i>	
Multiple R	0.98869148
R Square	0.97751085

Adjusted R Square	0.97486507
Standard Error	0.18357015
Observations	20

ANOVA					
	<i>df</i>	<i>SS</i>	<i>MS</i>	<i>F</i>	<i>Significance F</i>
Regression	2	24.9001291	12.4500646	369.460041	9.8123E-15
Residual	17	0.572866	0.033698		
Total	19	25.4729951			

	<i>Coefficients</i>	<i>Standard Error</i>	<i>t Stat</i>	<i>P-value</i>	<i>Lower 95%</i>	<i>Upper 95%</i>	<i>Lower 95.0%</i>	<i>Upper 95.0%</i>
Intercept	-14.5923	5.6438	-2.5855	0.0192	-26.4998	-2.6848	26.4998	-2.6848
ln(K)	0.6614	0.0845	7.8245	0.0000	0.4830	0.8397	0.4830	0.8397
ln(L)	2.6384	0.9017	2.9261	0.0094	0.7360	4.5408	0.7360	4.5408

Үр дүн: R квадратын утга 0.97751085 байгаа нь ДНБ-ий өөрчлөлт нь 97.75% -аар капиталын хэмжээ, ажиллах хүчний өөрчлөлтөөс хамааралтай гэсэн үг юм. Үлдсэн 2.25% дээрх хоёр хүчин зүйлээс бусад хувьсагчийн хэлбэлзлээс ДНБ-ий хэлбэлзлэл нь хамааралтай юм. Ln (K) утга нь капитал (үндсэн хөрөнгө)-ын хэмжээ, ажиллах хүч тус бүр 10%-аар нэмэгдэхэд ДНБ 6.6 % ба 26.3 % дагаад өсөх юм. Капитал (үндсэн хөрөнгө)-н хэмжээ ln(K), ажиллах хүчний ln(L)-ний t Stat шалгуур үзүүлэлтүүд нь статистикийн ач холбогдолтой байна.

Хоёр дахь үр дүн нь ДНБ (Q) -ний хэлбэлзлэлд K - капиталын хэмжээ, үндсэн хөрөнгө; L – эмэгтэй ажиллах хүчний хэлбэлзлэл хэрхэн нөлөөлж байгааг харуулсан тооцооны үр дүн юм.

<i>Regression Statistics</i>	
Multiple R	0.98869148
R Square	0.97751085
Adjusted R Square	0.97486507
Standard Error	0.18357015
Observations	20

ANOVA					
	<i>df</i>	<i>SS</i>	<i>MS</i>	<i>F</i>	<i>Significance F</i>
Regression	2	24.7823273	12.3911637	304.994363	4.8096E-14
Residual	17	0.69066779	0.04062752		
Total	19	25.4729951			

	<i>Coefficients</i>	<i>Standard Error</i>	<i>t Stat</i>	<i>P-value</i>	<i>Lower 95%</i>	<i>Upper 95%</i>	<i>Lower 95.0%</i>	<i>Upper 95.0%</i>
Intercept	-22.115038	11.7208	-1.8868	0.0764	-46.8437	2.6136	46.8437	2.6136
ln(K)	0.72992104	0.0857	8.5175	0.0000	0.5491	0.9107	0.5491	0.9107
ln(Lf)	1.91714535	0.9352	2.0499	0.0561	-0.0560	3.8903	-0.0560	3.8903

R квадратын утга 0.97288627 байгаа нь ДНБ-ий өөрчлөлт нь 97.29%-аар капиталын хэмжээ, эмэгтэй ажиллах хүчний өөрчлөлтөөс хамааралтай гэсэн үг юм. Үлдсэн 2.71 % дээрх хоёр хүчин зүйлээс бусад хувьсагчийн хэлбэлзлээс ДНБ-ий хэлбэлзэл нь хамааралтай гэж гарсан байна. Ln (K) утга нь капитал (үндсэн хөрөнгө)-ын хэмжээ, ажиллах хүч тус бүр 10%-аар нэмэгдэхэд ДНБ 7.3 % ба 19.2 % дагаад өсөх юм. Капитал (үндсэн хөрөнгө)-ын хэмжээ ln(K), эмэгтэй ажиллах хүчний ln(L) -ний t Stat шалгуур үзүүлэлтүүд нь статистикийн ач холбогдолтой байна.

Зөвлөмж/ Дүгнэлт:

1. Хүн амын өсөлт буурч 1 ээс бага 2050 он гэхэд 0.6 хувь хүрэх төлөвтэй байгаа тул төрөлтийг дэмжсэн, эх/эцэг/-д асарлын эдийн засгийн ажил, мэргэжлийн төрөл, чиглэлийг судлан тогтоох, хүүхдээ асарч байгаа эх/эцэг/д олгох тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах,
2. Хүүхдийн мөнгөн дүнгийн хэмжээг хүүхдийн насны онцлог, тэдний наад захын хэрэгцээг хангах түвшинд нийцүүлэн нэмэгдүүлэх хэрэгтэй бөгөөд олгохдоо нөхцөлт /сургуульдаа бүрэн хамрагдаж боловсрол эзэмжсэн байх, вакцинд хугацаандаа хамрагдсан байх, шимт хүнс хоол худалдан авсан байх/ мөнгөн тэтгэмж хэлбэрээр олгох.
3. Хүн ам зүйн цонх, ирэх 30 жилдээ нээлттэй байх боловч цаашдаа ахмад насны хүний тоо хурдацтай өсөх нь тул Насжилт- маркетинг гэж үзэж “Silver Economy” болон ахмад настнуудад зориулсан үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бий болгох талаар дэлхийн улс орнуудын шилдэг туршлагаас суралцах, судалгаа, шинжилгээний ажил хийх нь чухал.
4. Хүн ам баялаг бүтээгч, баялагийг хэрэглэгч. Монголын баялаг болсон хүний капитал аа эх орондоо үлдээж тэднийг бүрэн ашиглах төрийн бодлого зохицуулалтыг хийх. Зүүн өмнөд Азийн өндөр хөгжилтэй орнууд руу олон мянган иргэн орлого дагасан шилжих хөдөлгөөнд хамрагдаж байгаа явдлыг таслах зогсоох төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Хүн амын насжилт хурдан явагдах төлөвтэй байгаа нь Монгол Улсын эдийн засаг, нийгэмд дараагийн арван жилээс ихээхэн тулгамдсан асуудлыг авчрах тул нэмэгдэж буй ахмадуудын нийгмийн үйлчилгээний хүртээмжид анхаарах шаардлагатай болно. Ахмад настнуудад зориулсан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох шаардлага улам тулгамдаж байгааг анхаарч урт хугацаагаар тооцсон—төрийн бодлогын төлөвлөгөөг—одооноос боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үүнд
6. “Насжилт- маркетинг” гэж үзэж “Silver Economy” болон “Morning Star” аялал жуулчлалын үйлчилгээг өндөр настнуудад зориулан тусгайлан зохион байгуулж, маркетингийн олон төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг одооноос судалж, судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж насжилтад бэлтгэх бизнес, маркетингийн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.
7. Хөдөлмөрийн зах зээлийн оновчтой төлөвшлийг бий болгож, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг бүрдүүлэхэд ажиллагчдын тооны өсөлт наад зах нь жилд 4.0- өөс дээш хувиар өсөх шаардлагатай байгаа тул энэ өсөлтийг хангах

ажлын байрыг бий болгох хэрэгтэй байна. Хүн амын бодлогод хөдөлмөр эрхлэлт, ядуурлаас гарах дөт зам гэсэн бодлогын үзэл баримтлалыг тогтвортой баримтлан хууль эрх зүйн хүрээнд дараах зохицуулалтыг хийхийг зөвлөмж болгож байна.

Үүнд:

- Хүн ам зүйн цонх үеийг эдийн засгийн өсөлтөд бүрэн ашиглах, Хүн ам баялаг бүтээгч, баялгийг хэрэглэгч тул “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-д Засгийн газар эдийн засгийг нэмэгдүүлэх салбарын стратеги, бодлогыг тодорхойлох
- Засгийн газар нь ажил олгогчидод санхүүгийн дэмжлэг үзүүлэх; ажил олгогч нар өөрийн бизнесээ өргөжүүлэх ажлын байрны захиалгыг 2 жил тутам эдийн засаг, хөгжлийн яаманд гаргаж өгөх байх талаар засгийн газар болон ажил олгогч нарын эрх үүргийг тодорхой заасан хуулийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх.
- Эдийн засгийн хөгжлийн яам ажил олгогч эздээс ирсэн ажлын байрны захиалгыг БСШУЯ-д уламжлан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн боловсон хүчнийг богино хугацаанд бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг боловсролын тухай хуульд хуульчилж өгөх замаар хүн ам зүйн цонх үеийг зөв, зохистой ашиглах бодлогын зөвлөмж санал б Эдийн засгийн өсөлт, хөгжилд хүн ам зүйн цонх үе хамгийн чухал нөлөөтэй асуудал гэж дүгнэв. Улс орны хөгжлийн цөм нь баялагийг бүтээгч хүн бөгөөд ёс зүй, ёс суртахуунтай мэдлэг боловсролтой, ур чадвартай хүмүүн капиталыг төлөвшүүлэн хөгжүүлэхийг онцлов. Улс орныхоо хөгжлийг эрчимжүүлэхэд хувь нэмрээ оруулах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах нь нэн шаардлагатай байна хэмээн үзэж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын ҮСХ-ны тайлан, УБ, 2000,2018, 2020 он.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай (legalinfo.mn)

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (legalinfo.mn)

Гэр бүлийн тухай (legalinfo.mn)

УИХ-ын Судалгааны төвийн хийсэн “Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба хөгжлийн асуудал, нөлөөллийн хүчин зүйлс” сэдэвт Бодлогын судалгаа, дүн шинжилгээ (2011)

“Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь хүн ам зүйн өөрчлөлтийн нөлөөллийг судлах судалгаа” (2012)

Global Human Capital Report, 2017, World Bank Group <https://www.weforum.org/reports/the-global-human-capital-report-2017>

Global Human Capital Report, 2020, World Bank Group <https://www.weforum.org/reports/the-global-human-capital-report-2020>

Changes in Population Age Structure and Economic Development,

Florya Chronicles of Political Economy - Year 3 Number 1 - April 2017

Rashed Al Mahmud Titumir, Md. Zahidur Rahma,n Changes In Population Age Structure and Economic Development: The Case Of Bangladesh 2019,

Человеческий капитал: Изд-во ЛГУ, 1991



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

**ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ БА ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛӨЛ**

Ж.Эрдэнэчулуун¹, Т.Оюунгэрэл²

¹Магистр (МРМ), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

²Магистр (МВА), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль



Хураангуй

Санхүүгийн зах зээл хөгжиж хөрөнгө оруулалтын олон боломж бий болсноор зээлжих зэрэглэлийг тогтоох нь чухал асуудал болжээ. Хэрэв зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагын үнэлгээний аргачлалыг оновчтой таамаглаж чадах юм бол улс орнууд тэр дундаа монгол улсын хувьд зэрэглэл тогтооход нөлөөлдөг хүчин зүйлс дээрээ оновчтой төвшинд байгаж зэрэглэлээ өсгөх боломжтой. Улмаар улс орны зэрэглэлээс хамаарсан бусад олон зүйлс тухайлбал гадаад бондын өгөөж /гаргагч талаасаа зардал/ өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах боломж, банкуудын зээлийн хүүг тайлбарлах боломжтой.

Түлхүүр үг:

Зээлжих зэрэглэл, бондын өгөөж, зээлийн хүү, хадгаламжийн хүү, хүүний зөрүү, хүүний загварчлал, дэглэм хоорондын шилжилт.

Удиртгал хэсэг

Судалгааны үндэслэл:

Санхүүгийн зах зээл хөгжиж хөрөнгө оруулалтын олон боломж бий болсноор зээлжих зэрэглэлийг тогтоох нь чухал асуудал болжээ. Учир нь зээлжих зэрэглэл нь санхүүгийн зах зээл дээрх хөрөнгө оруулалтын олон бүтээгдэхүүний хувьд төлбөрийн чавар, найдвартай байдлыг илэрхийлэх индикатор болж чаддаг. Одоогоор дэлхийд Standard and Poor's, Fitch, Moodys гэсэн зэрэглэл тогтоогч 3 байгууллага нийт зах зээлийн 95%-г хамарч үйл ажиллагаагаа явуулж байна. Зээлжих зэрэглэлийг улс орон, байгууллага эсвэл тэдгээрийн гаргаж буй бонд, өрийн бичигт тус тусад нь засаглал, эдийн засаг, төсөв санхүүгийн үзүүлэлтүүдийг нь нэгтгэн тогтоодог байна. Үнэлгээг олон тооны шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр тогтоодог бөгөөд энэхүү үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах мөн зэрэглэл тогтоогч байгуулгуудын тогтоосон зэрэглэл нь нийт эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг тогтоох нь нэн сонирхолтой юм.

Судалгааны ач холбогдол:

Манай улсад зээлжих зэрэглэлийн байгууллага үүсч хөгжөөгүй учраас энэ төрлийн үйлчилгээг авахын тулд зөвхөн олон улсын байгууллагад хандах шаардлагатай байна. Дэлхийд Standard and Poor's, Fitch, Moodys гэсэн зэрэглэл тогтоогч байгууллагын гаргасан үнэлгээнээс хамаарч тухайн улсын гаргаж буй бонд, өрийн бичиг бусад санхүүгийн хэрэгсэлд хүчтэй нөлөө үзүүлдэг байна. Улсын зэрэглэл өндөр байх нь маш чухал. Учир нь

тухайн улсын компани, санхүүгийн байгууллага, банк даатгал хэчнээн сайн үзүүлэлттэй байлаа ч улсынхаа зэрэглэлээс өндөр тогтоогдох боломжгүй байдаг учраас эдийн засгийн байдалд шууд нөлөөлдөг байна.²⁴ Энэ хүү судалгааны ажлын ач холбогдол нь хэрэв бид зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагын үнэлгээний аргачлалыг оновчтой таамаглаж чадах юм бол улс орнууд тэр дундаа Монгол улс нь зэрэглэл тогтооход нөлөөлдөг хүчин зүйлс дээрээ оновчтой төвшинд байлгаж зэрэглэлээ өсгөх боломжтой. Улмаар улс орны зэрэглэлээс хамаарч бусад олон зүйлс тухайлбал гадаад бондын өгөөж /гаргагч талаасаа зардал/ өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах боломж мөн арилжааны банкуудын тогтоож буй дундаж нэрлэсэн зээлийн хүүний хэмжээг бууруулах боломжийг судалж улмаар зээлийн хүүг бууруулснаар иргэд хувийн хэвшлийн өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр авах боломжийг бий болгож энэ нь ДНБ өсгөж эдийн өсөлтийг бий болгох боломжтой юм.

Судлагдсан байдал:

Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар:

Олон улсад хийгдсэн ижил төстэй судалгааны ажлуудаас дурьдвал:

В Cantor R. and F. Packer (1996), (Тусгаар улсын зээлжих зэрэглэийг тодорхойлох нь) Энэхүү судалгааны ажил нь credit rating –н судалгааны ажлуудаас хамгийн эхнийх гэж хэлж болно. 1996 онд S&P болон Moody агентлагуудын тайлан нь олон нийтэд нээлттэй болж байсан үе юм. Судалгаа үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

1. Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлсийг үндсэн 8 тайлбарлагч хувьсагчаас хамааруулан авч үзсэн бөгөөд тодорхойлоход чиглэсэн.
2. Тусгаар улсуудын зээлжих зэрэглэлээс хамаарч гадаад бондын өгөөж хэрхэн хамаарч өөрчлөгдөж буйг тодорхойлох (USA bond spread) хувьд.
3. Зэрэглэл тогтоосны дараа 60 өдрийн дотор зэрэглэл дахин өөрчлөгдөхөд улс орны бондын өгөөж хэрхэн өөрчлөгдөж буй эсэх болон бусад макро үзүүлэлт мэдрэг 2байгаа эсэхийг харуулдаг.

Манай улсын хувьд:

Б. Хүслэн (2016) “Улсын зээлжих зэрэглэлд нөлөөлөгч хүчин зүйлс, зээлжих зэрэглэлийн дараагийн бондод үзүүлэх нөлөөлөл” энэхүү судалгааны ажилаар Зээлжих зэрэглэл тогтоодог компаниудын албан ёсны зээлжих зэрэглэл тогтоосон мэдээлэл, ижил түвшний зээлжих зэрэглэлтэй орнуудын зээлжих зэрэглэлийн өөрчлөлтийг судлахад чиглэсэн.

Зээлийн хүүг бууруулах зээлийн хүүнд нөлөөлөх хүчин зүйлийн талаар:

Олон улсад хийгдсэн ижил төстэй судалгааны ажлуудаас дурьдвал

Олон улсын судалгаанууд зээлийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлс тус бүрийг судлахаас илүүтэй макро эдийн засагын бүлэг хувьсагчийг зорилготой бодлогын арга хэмжээг ашиглан зах зээлд гарч буй өөрчлөлт нь бодлогын хүүг, депозитын хүү, хүүний зөрүүг багасгах замаар хийгдсэн байдаг байна.

²⁴ Credit rating “ИМПАКТ” and Mongolians economy сэтгүүл хуудас (11-15)

Хүүний зөрүүг судалсан судалгааны ажлууд (жишээ нь, Но болон Sanders 1981, Maudoes and Guevare 2004, Valverde болон Fernández 2007) нь хүүний зөрүүнд зах зээлийн бүтэц (төвлөрөл, өрсөлдөөн), хүүний эрсдэл, зээлийн эрсдэл болон үйл ажиллагааны зардлаас өндөр хамааралтай болохыг тогтоосон.

Эконометрик шинжилгээний хувьд зээлийн хүү нь хүүний зөрүү болон хадгаламжийн хүүний нийлбэр тул нөлөөлөгч хүчин зүйлсийг хүүний зөрүүний Maudoes and Guevare (2004)-ын загвар болон хадгаламжийн хүүний эмпирик загварууд (Hannan болон Berger 1989, 1991, De Bondt 2005, Raquel болон Vecente 2005)-д суурилан тодорхойлсон.

Манай орны хувьд

Зээлийн хүүг бууруулах талаар цөөнгүй судалгаа хийгдээд байна.

Эхний бүлэг судалгаа нь банкуудын бодитой төлөгдсөн зээлийн хүүг тооцож зарлах, яагаад тус хүү нь зарласан хүүнээс доогуур байдаг талаар тайлбарласан (Б.Энххуяг 2005, Д.Дуулал 2006, Д.Энхзаяа, Л.Дөлгөөн болон Д.Даваасүх 2012). Дараагийн бүлэг судалгаа нь хүүний зөрүү, хадгаламжийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсэд илүүтэй анхаарсан. Тухайлбал, (Ган-Очир 2016 Монголын эдийн засаг дахь зээлийн өндөр хүүний оньсогыг тайлах нь) . Энэхүү судалгааны ажил нь Зээлийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг нягтлан бодох бүртгэлийн задаргааны шинжилгээ болон хугацааны цувааны Марков-шилжилтийн эконометрик загвар ашиглан судалсан байна.

Судалгааны зорилго, зорилт

Судалгааны зорилго:

Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудын зэрэглэл тогтоох аргачлалыг судлаж зээлжих зэрэглэлд нөлөөлөгч хүчин зүйлийг тодорхойлох. Ингэснээр зээлжих зэрэглэл нь нийт эдийн засагт хэрхэн нөлөөлж Монгол улсын хувьд ямар боломж бий болж байгааг илрүүлэх юм.

Судалгааны зорилт:

1. Монгол улсын зээлжих зэрэглэл болон макро эдийн засгийн өнөөгийн байдлыг судлах.
2. Эконометрикийн арга загвар ашиглан зэрэглэл тогтоодог байгууллагууд яаж улсын зээлжих зэрэглэлийг тогтоож байгааг таамаглах.
3. Зээлжих зэрэглэлээр улс орнуудын засгийн газрын гаргасан гадаад бондын хүүг тайлбарлахад ашиглах.
4. Зээлжих зэрэглэлийн ялгаатай мөчлөгт банкуудын тогтоож буй зээлийн хүүг бууруулах боломжийг судлах

Судалгааны ажлын шинэлэг тал

Энэхүү судалгааны ажлаар өмнөх олон улсад хийгдсэн судалгаанууд дээр үндэслэн зээлжих зэрэглэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тооцохдоо нийгмийн тогтвортой байдал, болон эдийн засгийн чадавхи гэсэн 2 үндсэн үзүүлэлтийг авсан байдаг бол улс төрийн нөлөөлөл засаглалын эрсдэл хэрхэн нөлөөлж болох талаар авч үзэв.

Мөн Монголд зээлийн хүү яагаад өндөр байгаа шалтгаан, түүнийг бууруулах боломжийн талаар судаллаа. Ялангуяа энэ судалгаа нь Зээлжих зэрэглэлийн ялгаатай түвшинд зээлийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж, бодлогын зөвлөмж гаргахад чиглэсэн болно.

Зээлийн хүүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг (1) макро орчны өөрчлөлт (2) хугацааны цувааны Марков-шилжилтийн эконометрик загвар ашиглан судалсан нь энэхүү судалгааны ажлын бусад судалгааны ажлаас ялгагдах онцлог юм.

Судалгааны онол арга зүй

Энгийн шугаман регрессийн загвар, ХБКА, ANCOVA ЗАГВАР

Хэрэв регрессийн тэгшитгэл нь шугаман байвал түүнийг шугаман тэгшитгэл гэнэ. 2 хувьсагчийн шугаман регрессийн тэгшитгэл нь дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ:

$$Y_i = \beta_1 + \beta_2 X_i + u_i \quad (1)$$

Энд β_1, β_2 нь эх олонлогийн хоёр хувьсагчийн регрессийн коэффициентүүд бол u_i нь санамсаргүй хэлбэлзлийн хувьсагч, Y_i нь хамааран хувьсагч, X_i нь чөлөөт хувьсагч юм. Бидний зорилт бол Y ба X хувьсагчид бүхий эх олонлогийн тэгшитгэлийг ашиглан β_1, β_2 параметруудийг үнэлэх явдал юм. Гэвч практикт үүнийг үнэлэх боломжгүй байдаг. Харин бидэнд X, Y хувьсагчдын талаар n нэгж бүхий (X_i, Y_i) ажиглалтын хос мэдээ өгөгдсөн гэж саная. Энэхүү хос мэдээ буюу түүвэр олонлогийн мэдээнд тулгуурлан регрессийн эмпирик тэгшитгэлийг үнэлж параметрийг тодорхойлох хэрэгтэй болдог.

$$\hat{Y}_i = \hat{\beta}_1 + \hat{\beta}_2 X_i \quad (2)$$

Бидний зорилго бол $e_i = Y_i - \hat{Y}_i = Y_i - \hat{\beta}_1 - \hat{\beta}_2 X_i$ бодит утга болон үнэлсэн нөхцөлт дунджийн зөрүүг хамгийн бага байлгах явдал юм.

$\sum e_i = 0$ байдаг тул тооцоонд ашиглах боломжгүй байдаг иймээс $\sum e_i^2$ -г ашигладаг. Бидний зорилго $\sum e_i^2$ -г хамгийн бага байлгахад оршино. Эндээс $\hat{\beta}_2 = \frac{\sum (X_i - \bar{X})(Y_i - \bar{Y})}{\sum (X_i - \bar{X})^2}$, $\hat{\beta}_1 = \bar{Y} - \hat{\beta}_2 \bar{X}$ гэж олдог.

ANCOVA ЗАГВАР Регрессийн загварт тоон болон чанарын хувьсагчид хамтдаа орсон тохиолдолд нэрлэдэг бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

$$Y_i = \beta_1 + \beta_2 D_{2i} + \beta_3 D_{3i} + \beta_4 X_i + u_i \quad (3)$$

Марков шилжилтийн загварууд

Markov switching загварууд нь энгийн дамми хувьсагчийн аргачлалын илүү ерөнхийлсөн хэлбэр юм.

Нийт боломжит тохиолдлуудыг m төлөвт /states/ хуваагаад $y_t, i=1, \dots, m$ гэж нэрлэе.

Төлөвийн хувьсагчийн режимүүдийн хооронд шилжих шилжилт нь Марков процессоор тодорхойлогдоно.

Марков процесс гэж таамаглах тохиолдолд y_t нь $j \in (1, \dots, n)$ -тэй тэнцүү байх магадлал нь зөвхөн хамгийн сүүлийн ажиглалт болох Y_{t-1} -ээс хамаарах бөгөөд энэхүү процессийн шинж чанар нь дараах байдлаар тодорхойлогдоно.

$$P[a < y_t \leq b \mid y_1, y_2, \dots, y_{t-1}] = P[a < y_t \leq b \mid y_{t-1}] \quad (4)$$

Шилжих шилжилт нь Марков процесс буюу зөвхөн нэг үеийн өмнөх санамжтай процессоор тодорхойлогдоно. Хэрэв хувьсагч Марков процессоор тодорхойлогдож байгаа бол, дараагийн

үед өгөгдсөн режимд байх магадлал нь одоогийн магадлал болон шилжих магадлалын матрицаар тодорхойлогдоно. Энд P_{ij} режим i -аас j -руу шилжих магадлал.

$$P = \begin{bmatrix} p_{11} & \dots & p_{k1} \\ p_{12} & \dots & p_{k2} \\ \vdots & \ddots & \vdots \\ p_{1k} & \dots & p_{kk} \end{bmatrix} \quad (5)$$

Энэхүү P матрицын бүх элементүүд нь сөрөг биш утга авах бөгөөд багана бүрийн нийлбэр нь 1-тэй тэнцүү байна. Марков шилжилтийн загварийн магадлалын матрицийн чанарын талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Hamilton (1994)-аас харах боломжтой.

$$\text{Prob}[z_t = 1 \mid z_{t-1} = 1] = p_{11} \quad \text{Prob}[z_t = 2 \mid z_{t-1} = 1] = 1 - p_{11} \quad \text{Prob}[z_t = 2 \mid z_{t-1} = 2] = p_{22}$$

$\text{Prob}[z_t = 1 \mid z_{t-1} = 2] = 1 - p_{22}$ Энд p_{11} ба p_{22} нь харгалзан, өмнөх үед режим 1 байснаа одоо режим 1-д байх магадлал, ба өмнөх үед режим 2 байснаа одоо режим 2-д байх магадлал юм. Өөрөөр хэлбэл p_{11} , p_{22} нь шилжихгүй байх магадлал юм.

Эмпирик судалгаа:

3.1 Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлийн эмпирик шинжилгээ

Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлийн R.Cantor & F.Packer (1997) нарын болон түүний өргөтгөл загваруудын эмпирик шинжилгээг дийлэнхдээ зэрэгцүүлсэн тоон мэдээлэл дээр өгөгдөг ашиглан судалсан байдаг байна. Иймд зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлсийн эмпирик тэгшитгэлийг онолын хэсэгт тодорхойлсон экономитрик загвар ашиглан өмнө хийгдэж байсан судалгааны ажилуудын хүчин зүйлсэд суурилан дараах байдлаар тодорхойлов:

$$y_t = f(\text{GDP}_t^*, G_g_t^*, \text{Inf}_t^*, \text{Fis_bal}_t^*, \text{Cap_res}_t^*, \text{FX_rate}_t^*, \text{Fis_bal}_t^*, \text{debt_gdp}_t^*, \text{Curr_Acc}_t^*, \varepsilon_t)$$

Тоон мэдээлэл болон эмпирик үр дүн

3.1.1 Шинжилгээнд ашигласан тоон өгөгдөл

Bloomberg, WordBank, Tradingeconomics, CBond зэрэг эх сурвалжаас тоон мэдээллийг авсан бөгөөд 2015 оныг суурь он болгон авсан. Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг хийхдээ R.Cantor & F.Packer нарын судалгаан дээр суурилсан бөгөөд ЭХБК арга ашиглан үнэлсэн байдаг.

Хүснэгт 1. Шинжилгээнд ашигласан хувьсагч болон түүний хүлээгдэж буй утга

	Хувьсагчид	Эдийн засгийн үндэслэл	Хувьсагчидын хүлээгдэж буй утга
1	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	Нэг хүнд ногдох ДНБ хэмжээ нь өрийн эргэн төлөгдөх чадварыг харуулдаг.	+
2	Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	Эдийн засгийн хурдацтай өсөлт нь тухайн улсын өрийн дарамтыг бууруулна.	+

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

3	Инфляцийн түвшин	Инфляцийн түвшин өндөр байх нь санхүүгийн секторын дэд бүтэц асуудалтай байгааг илэрхийлэх бөгөөд цаашлаад улс төрийн тогтворгүй байдлыг үүсгэдэг.	-
4	Төсвийн тэнцэл	Төсвийн алдагдал нь хувийн хадгаламжийг бууруулж засгийн газрийн зардал санхүүжүүлэх болон өр төлөх чадварыг бууруулдаг.	+
5	Нийт капитал дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Капиталын нөөц сайн байх нь урт хугацааны төлбөрийн чадварыг сайжруулна.	+
6	Бодит валютын ханшны түвшин	Эдийн засгийн худалдааны өрсөлдөх чадварыг илэрхийлнэ.	-
7	Нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	ДНБ-д эзлэх өрийн хэмжээ нь тухайн улсан өрийн дарамтыг илэрхийлэх бөгөөд дефолт үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.	-
8	Reserves to GDP	Уг харьцаа өндөр байх нь өрийн төлөлтөнд дайчлагдах нөөц сайн байгааг илэрхийлнэ.	+
9	Current account	Алдагдал удаан хугацаагаар үргэлжлэх нь улсын тогтвортой байдалд нөлөөлдөг.	-

3.1.2 Эмпирик үр дүн

Хувьсагчид	Хүлээгдэж буй тэмдэг	S&P	Moody's	Fitch	TERating
Огтлогч		0.2259 (2.7231)	-0,8899 (3.0213)	-0.8497 (2.9611)	-4.086 (14.544)
Log(Нэг хүнд ногдох ДНБ)	+	2.7988*** (0.7438)	2,9579*** (0.832)	2.7822** (0.8269)	13.856*** (4.0351)
Инфляци	-	-2.7820*** (0.60228)	-2.7154*** (0.6617)	-2.2910*** (0.65018)	-16.93*** (3.1856)
Ажилгүйдэлийн түвшин	-	-0.1863*** (0.049921)	-0.1739** (0.05)	-0.1580** (0.0609)	-1.0106*** (0.262)
Авилгалын түвшин	+	0.096469*** (0.019)	0.0967*** (0.022)	0.0952*** (0.021)	0.4753*** (0.108)
Төсвийн тэнцэл	+	0.2135** (0.083)	0.2563** (0.097)	0.2303** (0.0966)	0.67952 (0.4688)
Эдийн засгийн өсөлт	+	0.3027** (0.059)	0.0143 (0.066)	-0.0322 (0.0654)	-0.3732 (0.3190)
Capital-н GDP-д эзлэх хувь	+	0.056 (0.04013)	-0,0533 (0.0451)	-0.0749* (0.4422)	-0.0358 (0.21571)

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

Current account	+	1.8795	-5.03	-4.062	-9.8E-12
GDP – д эзлэх	+	(3.112)	(0.1545)	(3.42)	1.68E-11
хадгаламжийн	+	0.0935*	0.1007*	0.1152*	0.309761
хувь	^	(3.11)	(0.0345)	(0.045)	(0.2257)
Эдийн засгийн	^	0.0935***	0.1787	0.1015	0.4492
өсөлт	^	(0.0418)	0.1401	(0.137)	(0.6748)
South Asia	^	-3.4161***	-4.134**	-3.5909**	-18.11**
Middle east &	^	(1.108)	(1.250)	(1.2234)	(6.017)
north Africa	^	3.4613**	-2.0750*	-1.8573**	-8.336
Europe & central		(1.108)	(1.085)	(1.0652)	(5.2246)
Asia		-1.7611*	-1.72971*	-1.8243*	-7.777*
Sub sahara Africa		(0.9644)	(0.0391)	(0.808)	(3.9525)
Latin America &		-1.73415*	-1.5383	-1.0750	-5.4780
Caribbean		(0.9482)	(1.0638)	(1.0421)	(5.1214)
North America		-1.9734**	-2.066**	-1.8616**	-10.270**
		(0.7097)	(0.799)	(0.7829)	(3.8471)
R ²		0.9013	0.8746	0.8697	0.877
Adjusted R ²		0.8763	0.8452	0.8387	0.848

Тэмдэглэгээ: Коэфф = Коэффициент, Огтлогч нь регрессийн тогтмол гишүүнийг илэрхийлнэ. *** нь $p < 0.01$, ** нь $p < 0.05$, * нь $p < 0.10$ -ийг илэрхийлнэ East Asia and Pacific-г суурь хувьсагч гэж үзсэн

Зээлжих зэрэглэлд эдийн засгийн тухайн үеийн өсөлт биш урт хугацааны дундаж өсөлт илүү нөлөө үзүүлж байна. S&P болон Moody's нь 7 жилийн дундаж өсөлтөнд хамгийн ач холбогдолтой өсөлт байсан бол Fitch болон TRating нь 6 жилийн дундаж өсөлт нь хамгийн ач холбогдолтой байсан.

Улс орнуудын газарзүйн байрлал зээлжих зэрэглэлд нөлөөлнө гэсэн таамаглал дээр үндэслэл ANCOVA загвараар үнэлэхэд статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан нь газарзүйн байрлал нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна.

Зээлжих зэрэглэлд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Нэг хүнд ногдох ДНБ, инфляци, ажилгүйдэлийн түвшин, авилгалын түвшин, төсвийн тэнцэл, эдийн засгийн урт хугацааны өсөлт болно.

3.2 Зээлжих зэрэглэл болон бондын өгөөж хамаарал

Монгол улсын гадаад өрийн өнөөгийн байдал

Засгийн газар олон улсын зах зээлд 2017 оны 3 сарын 9-ний өдөр 600 сая ам.долларын Хуралдай бондыг, 11 сарын 1-ний өдөр 800.0 сая ам.долларын Гэрэгэ бондыг амжилттай арилжлаа. Хуралдай бонд нь 8.75 хувийн хүүтэй 2024 онд эргэн төлөгдөх хуваарьтай 7 жилийн хугацаатай бонд бөгөөд уг бондоор Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны 580.0 сая ам.долларын евро бондын 82.0 хувь буюу 476.0 сая ам.долларыг дахин санхүүжүүлээд байна. Харин Гэрэгэ бондын хувьд 5.625 хувийн хүүтэй, 5.5 жилийн хугацаатай бөгөөд энэхүү бондын эх үүсвэрээр Чингис бонд болон Дим-сам бондын эргэн төлөлтийн тодорхой хувийг санхүүжүүлэх юм. Ингэснээр Монгол Улс ойрын хугацаанд гадаад өр төлбөрийн дефолтын эрсдэлээс сэргийлсэн явдал болов.

Хүснэгт 2. Монгол улсын өрийн өнөөгийн байдал

Нэр	Он	Дүн	Хүү	Хугацаа	Зэрэглэл S&P хувьд
Евро бонд	2012 он	580 сая USD	5.75	5 жил	BB-
Чингис бонд	2013 он	1.5 тэрбум USD	500сая USD хүү нь 4.1	5 жил	BB-
			1 тэрбум USD хүү нь 5.1	10 жил	BB-
Самурай бонд	2013 он	24.3 тэрбум иен	1.5	10 жил	B+
Димсам бонд	2015 он	Нэг тэрбум юань	7.5	3 жил	B
Мазаалай бонд	2016 он	500 сая USD	10.1	5 жил	B-
Хуралдай бонд 1	2017 он	476 сая USD	8.7	7 жил	B-
Хуралдай бонд 2	2017 он	124 сая USD	7.6	7 жил	B-
Гэрэгэ бонд	2017 он	800 сая USD	5.6	5.5 жил	B-

Эх үүсвэр: Bloomberg.com

Монгол улс гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх дээд хувь хэмжээг 40 хувь гэж тогтоосон байдаг. Гэвч Монгол улсын засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2014 онд 54.7% байсан бол 2016 оны эцэст 79.4 % болж өссөн бөгөөд 2017 онд одоогийн байдлаар нийт 1.4 тэрбум ам долларын дүнтэй 3 бонд нэмж гаргасан нь дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх гадаад өрийн хувийг нэмэгдүүлэх хандлагатай байна. Энэ нь улсын өрийн дарамтыг нэмэгдүүлж байна. Монгол улс энэ гадаад өрийн эргэн төлөлтөнд зориулж 800 сая ам долларын дүнтэй гэрэгэ бондыг 5.6%-ийн хүүгийн түвшинд гаргаад байна

R.Cantor & F.Packer нарын судалгааны ажилаас үзэхэд гадаад бондын өгөөжид нөгөө талаас гаргагч талаасаа өртөг багатай санхүүгийн эх үүсвэр татахад агентлагуудаас гаргасан зэрэглэл улс ороны зээлийн эх үүсвэрт шууд нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг байна. 2017 оны 10 сарын байдлаар Хятад, Хонгконг, Сингапур, Малайз etc улсын ЗГ-ууд бонд босгон санхүүжилт татсан байна.

Хүснэгт 3: Гадаад бондын өгөөжүүдийн жинлэсэн дундаж хүү болон тухайн улсын бонд гаргах үеийн зээлжих зэрэглэл

Улс нэр	ЖДХ	Rating
China Government Bond	2.77%	A+
Government of Mongolia	7.64%	B-
Hong Kong Government Bond Programme	2.16%	AA+
Singapore Government	2.52%	AAA
The Hong Kong Special Administrative Region Government	2.15%	AAA
Malaysia Government Investment Issue	4.1%	A-

Хэрэв улс орнууд зэрэглэлээ сайжруулж чадах юм бол одоо байгаагаасаа өртөг багатай эх үүсвэр татах бүрэн боломжтой юм.

Хүснэгт 4: Олон улсын зээлжих зэрэглэл ба гадаад өрийн өнөөгийн байдал

Худалдаа Хөгжлийн банкны бонд	Монгол улсын засгийн газрын бонд / Хуралдай/	АНУ-ын засгийн газрын бонд	Польш улсын засгийн газрын бонд	Унгар улсын бонд	
Тухайн бондын зэрэглэл /Moody'5/	B3	Saa1	AAA	A2	Ba1
Хугацаа	5 жил	7 жил	5 жил	10 жил	5 жил
Нэрлэсэн хүү	9.38%	8.75%	1.75%	3.25%	4.13%
Гаргасан он	2015	2017		2015	2017
Тухайн үеийн улсын зээлжих зэрэглэл /Moody'5/	B2	Saa1	AAA	A2	A1
Эх сурвалж	Худалдаа хөгжлийн банкны жилийн тайлан 2015	Bloomberg	Bloomberg	Сангийн яам, Польш улс	Сангийн яам, Чех улс

Хүснэгтээс харвал Монгол улс Саа1 үнэлгээтэй, бондын хүү нь 8.75% байна. Харин АНУ AAA үнэлгээтэй, бондын хүү нь 1.75%, Польш улс А2 үнэлгээтэйгээр 3.25%, Унгар улс Ва1 үнэлгээтэйгээр 4.13% хүү санал болгосон байна. Эдгээр улсууд нь зээлжих зэрэглэл өндөртэйгээс ийнхүү бага хүү төлж байгаа юм. Зарим засгийн газар өндөр хүүтэй бонд санал болгодог ч, үнэ нь богино хугацаанд өөрчлөгдөн өгөөж нь буурч, зээлжих зэрэглэлийнхээ төвшинд ирдэг.

Дүгнэлт санал зөвдөмж:

4.1 Зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлийн эмпирик шинжилгээний дүгнэлт

Зээлжих зэрэглэлд эдийн засгийн тухайн үеийн өсөлт биш урт хугацааны дундаж өсөлт илүү нөлөө үзүүлж байна. S&P болон Moody's нь 7 жилийн дундаж өсөлтөнд хамгийн ач холбогдолтой өсөлт байсан бол Fitch болон TERating нь 6 жилийн дундаж өсөлт нь хамгийн ач холбогдолтой байсан.

Улс орнуудын газарзүйн байрлал зээлжих зэрэглэлд нөлөөлнө гэсэн таамаглал дээр үндэслэл ANCOVA загвараар үнэлэхэд статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан нь газарзүйн байрлал нөлөөгүй гэдгийг илэрхийлж байна. Зээлжих зэрэглэлд дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Нэг хүнд ногдох ДНБ, инфляци, ажилгүйдэлийн түвшин, авилгалын түвшин, төсвийн тэнцэл, эдийн засгийн урт хугацааны өсөлт Аль дэглэмд байгаагаас хамаарч зээлжих зэрэглэл (cr_rate), хөрөнгийн зах зээлийн үнэлгээ (Cap_mar), төгрөгийн хадгаламжийн дундаж хүү ($Save_int$)-ийн зээлийн хүү (r_L)-нд үзүүлэх нөлөө ялгаатай байна. Харин инфляци (INF), дотоод нийт бүтээгдхүүний (GDP), эдийн засгийн өсөлт ($econ_growth$) зээлийн хүүнд үзүүлэх нөлөө нь дэглэмээс хамаарч өөрчлөгдөхгүй, гэхдээ статистикийн хувьд ач холбогдолтой байна.

4.2 Зээлжих зэрэглэл болон бондын өгөөж хамаарал

Монгол улс Саа1 үнэлгээтэй, бондын хүү нь 8.75% байна. Харин АНУ ААА үнэлгээтэй, бондын хүү нь 1.75%, Польш улс А2 үнэлгээтэйгээр 3.25%, Унгар улс Ва1 үнэлгээтэйгээр 4.13% хүү санал болгосон байна. Эдгээр улсууд нь зээлжих зэрэглэл өндөртэйгээс ийнхүү бага хүү төлж байгаа юм. Зарим засгийн газар өндөр хүүтэй бонд санал болгодог ч, үнэ нь богино хугацаанд өөрчлөгдөн өгөөж нь буурч, зээлжих зэрэглэлийнхээ төвшинд ирдэг.

Гадаад бондын өгөөжүүдийн жинлэсэн дундаж хүү болон тухайн улсын бонд гаргах үеийн зээлжих зэрэглэлийг харьцуулж үзэхэд хэрэв улс орнууд зэрэглэлээ сайжруулж чадах юм бол одоо байгаагаасаа өртөг багатай эх үүсвэр татах бүрэн боломжтой юм.

4.3 Зээлжих зэрэглэл болон зээлийн хүүний загварчлалын дүгнэлт

Зээлийн хүүний динамик дахь дэглэм өөрчлөгдөхөд зээлжих зэрэглэл (cr_rate) нөлөөлж байна. Ялангуяа зээлжих зэрэглэлийн өсөлт нь дэглэм нэгээс нөгөө дэглэмд нэгдээ үлдэх магадлалыг бууруулдаг байна. Манай зээлжих зэрэглэл В3 тогтвортой төлөвөөс дээш үед зээлийн хүү өсөх магадлалыг бууруулж байна. Өөрөөр хэлбэл Moodys агентлаг манай орны зээлжих зэрэглэл өндөрөөр тогтоосон В3(stable) төлөвт байсан 2005М10 -2014М4 сар оны хооронд банкны дундаж зээлийн хүү 28.2-19.4 хувийн хооронд тасратгүй буурч байсан байна.

Мөн зээлийн хүү нь хадгаламжийн хүүтэй эерэг хамааралтай байгаа бөгөөд банкуудын хувьд өндөр өртөгтэй эх үүсвэр татаж байгаа нь мөн зээлийн хүү өндөр байгаа нэг шалтгаан бөгөөд хадгаламжийн хүү өндөр байгаа нь зээлийн хүү өндөр байгаагийн суурь шалтгаан юм. Хадгаламжийн хүү болон зээлийн хүүний зөрүүг багасгах замаар зээлийн хүүг бууруулах боломжтой юм.

Зээлийн хүүний задаргаанаас харахад депозитын хүү өндөр байгаа нь зээлийн хүү өндөр байх суурь нөхцөл болж байна. Тухайлбал, 2008-2016 оны бодитой төлөгдсөн зээлийн хүү 14.2 хувь байгаагийн 8.7 нэгж хувь нь депозитын хүү, үлдсэн 5.5 нэгж хувь нь хүүний зөрүү байна.

Өөр нэг сонирхолтой үр дүн бол хөрөнгийн зах зээлийн өөрчлөлт нь зээлийн хүүнд нөлөөлж байна. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ өсөх нь зээлийн хүүг бууруулах чиглэлд статистикийн хувьд ач холбогдолтой нөлөөтэй бөгөөд нөлөө нь маш их байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Гадаад эх сурвалж:

- Cantor.R,Parker.F (1996) Determines and impact of sovereign credit rating.Economic policy Review
Ap.Gwilgn, and O.Alska (2011) Sovereign rating actions: Is the criticism Justified
Kray A. And Newreh (2004) When the debt sustainable U Whasington DC World bank Policy research working paper

Дотоод эх сурвалж:

- Б.Батсүх 2011 Зээлжих зэрэглэлийн нөлөө ба монгол улсын эдийн засаг
Монгол банк 2016 Монгол улсын зээлжих зэрэглэлийн судалгаа (Албан ажилын хэрэгцээнд)

Монголын банкны холбоо (2015) Зээлжих зэрэглэлийн нөлөө ба Монгол улсын эдийн засаг

Я. Банзрагч “Эконометрикийн арга, загварууд”, УБ 2007

Chirs Brooks, “Introductory Econometrics For Finance”, 2008 second edition

Цахим эх сурвалж:

- www.sprating.com
- www.fitchrating.com
- www.moodys.com
- www.tradingeconomics.com
- www.bloomberg.com
- www.cbond.com
- www.worldbank.com

Хавсралт

Сонгодог Шугаман Регрессийн Загварын санамсаргүй алдаа дараах нөхцөлүүдийг хангах ёстой.

1. $E(u_t) = 0$
2. $Var(u_t) = \sigma^2 < \infty$
3. $Cov(u_i, u_j) = 0$
4. X матриц давтагдсан түүврүүдийн хувьд стохастик бус буюу тогтмол
5. $u_t \sim N(0, \sigma^2)$

Хетероскедастикийн шалгуур

Бид алдааны вариацийг тогтмол гэж авч үзэж байгаа. Үүнийг σ^2 нь хомоскедаст байна гэдэг. Хэрэв алдааны вариаци нь тогтмол биш бол хетероскедаст болно. Хэрэв бид ХБКА-ыг хетероскедастын үед ашиглавал бидний стандарт алдаанууд тохиромжгүй болж, цаашилбал дүгнэлтүүд маань худал болно. Ийм учраас хетероскедаст үүссэн эсэхийг Breusch-Pagan, White-ийн шалгуураар шалгалаа.

	Breusch-Pagan шалгуур		White шалгуур	
	H ₀ Таамаглал	prob	H ₀ Таамаглал	Prob
S&P	хомоскедастик	0.8729	хомоскедастик	0.5133
Moody's	хомоскедастик	0.9177	хомоскедастик	0.5078
Fitch	хомоскедастик	0.9067	хомоскедастик	0.8400
TERating	хомоскедастик	0.4409	хомоскедастик	0.7628

Хетероскедастик байгаа эсэхийг шалгахын тулд Breusch-Pagan шалгуур болон White-ын шалгуур явуулахад бүгд функцийн хэлбэр зөв гэсэн H₀ таамаглалыг хүлээн авсан ба хетероскедастик үүсээгүй байна

Загвар оновчтой байдлыг шалгах Рамсейн ресет шалгуур

Энэ нь загвар оновчтой эсэхийг тэгшитгэлийн хэлбэрээр шалгадаг арга юм.

$$y = \beta_1 + \beta_2 X + \gamma_1 \hat{y}^2 + \gamma_2 \hat{y}^3 + \dots + \gamma_{n-1} \hat{y}^n + \varepsilon$$

Тэг таамаглал нь $\gamma_1 = \gamma_2 = \dots = \gamma_p = 0$ гэж тавигдана.

	H ₀ Таамаглал	Prob
S&P	Фүнкции хэлбэр зөв	0.5036
Moody's	Фүнкции хэлбэр зөв	0.4142
Fitch	Фүнкции хэлбэр зөв	0.6844
TERating	Фүнкции хэлбэр зөв	0.6605

Рамсейн ресетын шалгуураар шалгахад бүгд фүнкции хэлбэр зөв гэсэн H₀ таамаглалыг хүлээн авсан.

Үлдэгдэл нормал тархалттай эсэхийг шалгах

Сонгодог шугаман регрессийн 5 дахь нөхцөл болох үлдэгдэл хэвийн тархалттай эсэхийг Jarque-Bera-ээр тестээр шалгалаа.

	H ₀ Таамаглал	Prob
S&P	Үлдэгдэл хэвийн тархалттай	0.0043
Moody's	Үлдэгдэл хэвийн тархалттай	0.3785
Fitch	Үлдэгдэл хэвийн тархалттай	0.1112
TERating	Үлдэгдэл хэвийн тархалттай	0.2015

Jarque-Bera-гийн тестээр шалгахад S&P нь ганцаар үлдэгдэл хэвийн тархалттай гэсэн H₀ таамаглалыг няцаасан. Энэ нь сондгойрогч байснаас болсон ба тэрэнд зориулж хуурмаг хувьсагч үүсгэн алдааг засахад prob нь 0.6287 болсон.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

**МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ХУДАЛДААНЫ ТЭНЦЛИЙН
ХОЁР ТАЛЫН ТОДОРХОЙЛОГЧ ХҮЧИН ЗҮЙЛС**

Ч.Сумьяа¹, Ч.Наранчимэг², Ч.Даваасүрэн³

¹ ШУА, Олон улс судлалын хүрээлэн, доктор

² СЭЗИС, СШУТ-ийн доктор, профессор

³ СЭЗИС, СШУТ-ийн ахлах багш



Хураангуй

Энэхүү судалгаагаар 2015-2022 оны хугацааны цуваан өгөгдлөөр Монгол Улс, БНХАУ-ын эдийн засгийн хоёр талын худалдааны тэнцлийн хөдөлгөгч хүчин зүйлс, чөлөөт худалдааны хэлэлцээр, худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөөний эмпирик судалгааг хийхээр зорилоо. Авторегрессийн лаг тархсан загварын алдаа засах загвар (ECM) нь худалдааны тэнцлийг тайлбарлагч хувьсагчид урт хугацаандаа харилцан хамааралтай эсэхийг тодорхойлоход ашиглагдана. Судалгаанаас үзэхэд нөлөө үзүүлж байна гэж тооцогдох хани нь урт хугацаанд гадаад худалдааны тэнцэлд эерэг, богино хугацааны хувьд сөрөг нөлөө үзүүлсэн, төнгөний нийлүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн нь богино болон урт хугацаандаа худалдааны тэнцэлд маш бага нөлөө үзүүлсэн болох нь судалгаагаар тогтоогдсон.

Түлхүүр үг:

загвар, худалдааны ашиг, алдагдал, валютын хани

УДИРТГАЛ

Монгол улс эдийн засгаа өсгөх, улмаар өсөлтийг дэмжих зорилгоор дотоодын болон гадаадын үйлдвэрүүдийг байгуулж гадаад худалдаагаа сэргээхийг зорьж байна. Үүний тулд бусад орнууд, ялангуяа хүчирхэг эдийн засагтай орнуудтай хэд хэдэн гэрээ байгуулсан²⁵. 2016 оны Улаанбаатар хотод болсон ASEM чуулга уулзалтын үеэр төрийн айлчлал хийсэн БНХАУ-ын төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Көчян хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгдэхдээ Эрээн хот Замын-Үүд сумын чөлөөт худалдааны бүсийг хөгжүүлэх, чөлөөт худалдаа байгуулах ажлыг эхлүүлэх талаар мэдэгдэж байсан²⁶. Чөлөөт худалдааны бүс байгуулснаар хоёр улсын эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, тэр дундаа гаалийн татвар, хямдралтай худалдаа, монополийн эсрэг арга хэмжээ авах үндэс суурийг тавих юм. Эдгээр ашиг тустай үйл ажиллагааг БНХАУ-тай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрт

²⁵ Inclusion in EU-Georgia Trade Relations: A Critical Institutionalist Analysis of the Georgian Domestic Advisory Group. European Foreign Affairs Review, 26(3).

²⁶ Premier Li pledges to expand cooperation with Mongolia: (<http://english.gov.cn>)

хэрэглэх нь зүйтэй. 2022 оны Дэлхийн худалдааны статистикийн тоймд мэдээлснээр, Европын холбоо ба БНХАУ-ын нийт хүн ам 2 тэрбум орчим, зах зээлийн үнэлгээ нь 34 их наяд ам.доллар²⁷ байгаа нь манай улсын экспортийн үйлдвэрүүд энэ том хэмжээний эдийн засгуудаас ашиг хүртэх боломжтой гэдгийг харуулж байгаа юм. БНХАУ-тай байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрийн ачаар Монгол улс гадаадын шууд хөрөнгө оруулалт, технологийн дэвшил, техникийн ур чадварыг татах асар их нөөц бололцоотой болсон. Одоогийн байдлаар зөвхөн долоон улс л Европын холбоо болон БНХАУ-тай хоёр талын чөлөөт худалдааны гэрээ байгуулсныг энд дурдах нь зүйтэй. Энэ нь МУ-ыг Европын холбоонд бараа бүтээгдэхүүн экспортлох гадаадын хөрөнгө оруулалтыг татах, БНХАУ-ын хөрөнгийг Европын холбооны улсууд руу экспортлох боломжийг олгож байна.


Чөлөөт худалдааны хэлэлцээр нь манай улсын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгож, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр том, жижиг бизнес эрхлэгчдэд ашиг олох боломжийг олгоно. Мөн бизнес эрхлэгчид болон хэрэглэгчдэд өрсөлдөхүйц үнэтэй бараа, үйлчилгээ, шинэ технологи, бүтээлч туршлагыг илүү өргөн хүрээтэй авах боломжийг нэмэгдүүлэх юм. БНХАУ-тай чөлөөт худалдаа хийснээр тус улсыг Европын холбооны зах зээлд баттай байр сууриа олоход мөн тустай. Энэхүү хэлэлцээр нь хоёр орны худалдааны харилцааг хөгжүүлэх, түвшинг дээшлүүлэхэд тус дөхөм болно гэж харж байна. Хоёр улсын чөлөөт худалдааны хэлэлцээр нь хувийн хэвшлийн үйлдвэрлэлд таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дөхөм болохоос гадна манай улсын бүтээгдэхүүнийг 1.4 тэрбум хүн амтай зах зээлд нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа онцлог юм. Түүнчлэн манай улсын экспорт ойрын жилүүдэд мэдэгдэхүйц өсөх төлөвтэй байна.

Манай улс нээлттэй эдийн засагтай жижиг улс бөгөөд БНХАУ-ын экспорт сүүлийн хэдэн жилд тогтмол өссөөр байна. Ийм том эдийн засагтай чөлөөт худалдааны хэлэлцээрийг эцэслэх нь МУ болон томоохон эдийн засгийн хооронд хамгийн тохиромжтой, таатай, сонирхол татахуйц худалдааны платформ бий болох том боломжийг олгож байна. Монгол улс бизнесийн орчин сул, татвар бага, засаг захиргааны хувьд саад бэрхшээлтэй боловч, Европын холбоотой хийх худалдаагаар тэргүүлэгч байр суурь эзэлдэг нь МУ-ыг БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах улс болгож, тэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Европын холбооны орнуудад борлуулах боломжийг өгч байна. БНХАУ-ын хөрөнгө оруулалт хийгдснээр үйлдвэрлэлийн технологийн шинэ ноу-хау дагалдаж орж ирэх болно. Энэ нь манай улсын экспортын бүтцийг шинэчлэх, сэргээхэд хувь нэмэр оруулах ёстой бөгөөд Европын холбооны худалдан авах чадвар өндөртэй зах зээлийг хөгжүүлэх үндэс суурь болж магадгүй юм.

БНХАУ, Монгол улсын худалдааны хэмжээ нэмэгдэж байгаа нь ирээдүйдээ ашиглах боломжтой нэг үзүүлэлт юм. Монгол улсаас БНХАУ руу экспортолсон экспортийн мэдээллийг Зураг 1-д харуулсан бөгөөд манай улсын худалдааны гол түншийн нэг болох БНХАУ-тай хийсэн худалдаа нэмэгдсэн нь тодорхой харагдаж байна.

²⁷ World Trade Statistical Review 2022 https://www.wto.org/english/res_e/booksp_e/wtsr_2022_e.pdf


Зураг 1. Хоёр орны худалдааны статистик, сараар 2015-2023 /сая.ам.доллараар/



Эх сурвалж: Худалдааны статистик, БНХАУ статистикийн хороо

Хоёр улсын хийсэн худалдааны тэнцэл эерэг байгаа ч Монгол улс БНХАУ-аас импортлох бараа бүтээгдэхүүн мөн асар их өсөлттэй байна. (Зураг 2)

Зураг 2. Экспорт 2015-2023 он /сая.ам.доллараар/



Эх сурвалж: Худалдааны статистик, БНХАУ статистикийн хороо

Бид 2015-2022 оны хооронд хоёр улсын эдийн засгийн худалдааны тэнцлийг тодорхойлогч, хөдөлгөгч хүчин зүйлсүүд болон чөлөөт худалдааны хэлэлцээрийн МУ-БНХАУ-ын худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөөг ашиглан эмпирик судалгааг хийх зорилготой. Судлаачид улс орнуудын худалдааны тэнцлийн алдагдлын ялгааг тайлбарлахын тулд уян хатан чанар, шингээлт, мөнгөний гэсэн арга аргачлал, хандлагыг ашигладаг. Эдгээр аргууд тус бүр нь өөр өөр хүчин зүйлс дээр тулгуурладаг. Худалдааны тэнцлийг сайжруулахын тулд уян хатан аргын элэгдлийн тооцоог ашиглана. Нөгөө талаар шингээлтийн арга нь

худалдааны тэнцэлд орлого, үнийн түвшний нөлөөлөл дээр суурилдаг бол мөнгөний хандлага нь худалдааны тэнцэлд мөнгөнөөс хамаарах хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг. 2015-2022 оны хугацаан цуваан өгөгдлөөр худалдааны тэнцлийг үнэлэхийн тулд авторегрессийн лаг тархалттай алдаа засах загвар (ЕСМ) нь худалдааны тэнцэл болон түүнийг тайлбарлагч хувьсагчид урт хугацааны тогтвортой хамааралтай эсэхийг тодорхойлоход ашиглагдана. Авторегрессийн лаг тархалттай загварын нэг онцлог шинж чанар нь хувьсагчдыг хэр сайн цуглуулснаас үл хамааран өгөгдөл нь бага түүвэр үед ч ашиглах боломжтой байдаг. Энэхүү судалгаа нь таван хэсэгт хуваагдаж эхний хэсэг удиртгал, хоёр дахь хэсэгт онолын үндэслэлийг гаргаж, судлагдсан байдлын талаар хэлэлцэж улмаар судалгааны загварыг тайлбарлана. Эцэст нь эмпирик дүн шинжилгээг хийж дүгнэнэ.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

Нилээд олон судалгаанд улс орнуудын худалдааны тэнцлийн алдагдлын ялгааг тайлбарлахын тулд уян хатан, шингээлтийн аргуудыг ашигласан байна.

Ихиеначо (2017) худалдааг либералчлах нь хөгжиж буй эдийн засагт үзүүлэх нөлөө ямар байхыг судалжээ. Энэхүү судалгаанд авторегрессив лаг тархсан загварыг ашигласан ба худалдааны нээлттэй байдлын индексийг бий болгоход худалдааг либералчлах хоёр үзүүлэлтийг ашигладаг бол санхүүгийн салбарын хөгжлийн гурван үзүүлэлтийг ашиглан санхүүгийн хөгжлийн индексийг бүрдүүлж үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээг хийсэн. Судалгааны үр дүнд худалдааг либералчлах нь Нигерийн эдийн засгийн өсөлтөд урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Худалдааг либералчлах нь эдийн засгийн өсөлтөнд ашигтай бөгөөд богино хугацаанд их нөлөө үзүүлсэн гэж дүгнэжээ.

Босняк нар (2018) Хорват улс дахь урсгал дансны динамикийн хүчин зүйлсийг валют, мөнгөний ба шингээлтийн аргыг ашиглан судалсан. Тэд үндсэн таамаглалдаа Хорват улсын урсгал данс нь валют ба шингээлтийн аргыг ашиглан төлбөрийн тэнцлийг тайлбарлах боломжтой гэж үзсэн. Мөн урсгал дансны шугаман бус байдал, тэдгээрийн шалтгааныг харгалзан үзэж шугаман бус авторегресс лаг тархсан загварчлалын аргыг ашиглажээ. Судалгаагаар мөнгөний хувьсагчдын дунд М4 мөнгөний агрегат хамгийн их тайлбарлах чадвартай байсан. Төсвийн бодлогын арга хэмжээ болон Хорват улсын экспортлогчдийн хөрвөх чадварын хязгаарлалтыг сулруулах нь гадаад тэнцвэрт байдалд хүрэх ёстой гэдгийг илтгэлийн гол дүгнэлт харуулж байна.

Кехо (2021) судалгаанаас харахад гадаад худалдааны тэнцэл нь дотоод болон гадаад орлогод сөргөөр нөлөөлдөг боловч ханшийн сулралт нь цаг хугацааны явцад худалдааны тэнцлийг сайжруулдаг. Гэсэн хэдий ч эдгээр өгөгдлөөр худалдааны тэнцэл богино хугацаандаа муудаж J муруйн дагуу оршихгүй байна. Худалдааны тэнцэл нь богино хугацаанд зөвхөн гадаад бодит орлогод хариу үйлдэл үзүүлдэг болохоос дотоодын бодит орлого, бодит ханшид нөлөөлдөггүй гэжээ.

Азнан, Маших (2018) нар Малайз улсын валютын ханш болон худалдааны тэнцлийн хоорондын хамаарлыг судлах зорилготой байв. Сар бүрийн хугацааны цувааны өгөгдлөөр ARDL, NARDL зэрэг загваруудыг ашиглан хийсэн судалгаа нь богино болон урт

хугацаандаа экспортлогч, импортлогч үйлдвэрүүдийн элэгдэл хорогдлын солилцоог харуулсан. Бодлого боловсруулагчид худалдааны тэнцлийг сайжруулахын тулд валютыг бага зэрэг сулруулж болох ч үүнээс үүдэн гарах зардлыг үр дүнтэй удирдах ёстой гэж дүгнэсэн.

Тассиван нар (2019) 1998-2018 оны улирлын мэдээллийг ашиглан Турк улсын ДНБ, зарим Европын орнуудын ДНБ, бодит ханш, газрын тосны үнэ зэргээр худалдааны тэнцлийн хүчин зүйлсийг судалсан. Тэдний үр дүнгээс харахад худалдааны тэнцэл ба түүний хөдөлгөгч хүч нь коинтеграцитай болохыг харуулсан. Турк улсын хувьд урт хугацаанд шингээх технологи бүхий аргачлал нь илүү гэдэг нь батлагдсан. Нефтийн үнэ өндөр, валютын ханш өндөр байгаа нь худалдааны тэнцвэргүй байдлыг мэдэгдэхүйц бууруулж байгаа нь тогтоогдсон. Авторегрессийн лаг тархалттай загварыг ашигласнаар Турк улсын ДНБ, зарим Европын холбооны улсын бодит ханш болон газрын тосны үнийн хоорондын урт хугацааны хамаарлыг олж тогтоосон. Иймд урт хугацаанд Турк болон Европын холбооны орнуудын ДНБ худалдааны тэнцэлд эерэг, их нөлөө үзүүлдэг бол бодит ханш болон газрын тосны үнийн өсөлт худалдааны тэнцэлд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг нь тогтоогджээ.

Дитта нар (2020) Финланд улсын худалдааны тэнцлийг тодорхойлогч хүчин зүйлсийн талаарх судалгааны эмпирик үр дүнгээс харахад бодит үр дүнтэй валютын ханш, хотжилт, инфляци нь Финландын худалдааны тэнцэлд богино болон урт хугацаанд мэдэгдэхүйц боловч сөрөг нөлөө үзүүлдэг. Нэг хүнд ногдох ДНБ болон ажилгүйдэл ихээхэн боловч эерэг нөлөө үзүүлдэг байна.

Весиних (2016) Этиоп улсын худалдааны тэнцлийн богино болон урт хугацааны хамаарлыг энэ судалгаанд судалж орлого, мөнгөний нийлүүлэлт, бодит ханш, төсвийн тэнцэл, гадаад орлого зэрэг зарим тайлбарлагч хүчин зүйлсээр авсан. Авторегрессив лаг тархсан загварын коинтеграци болон алдаа засах загваруудад хязгаар төстийн аргыг 1970-2011 он хүртэлх жилийн өгөгдөлд худалдааны тэнцэл болон худалдааны тэнцэл хоорондын хамаарал байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ашигласан. Судалгааны гол дүгнэлт нь худалдааны тэнцэл ба түүнийг тодорхойлогч хүчин зүйлс (бодит ханш, орлого, мөнгөний нийлүүлэлтийн төсвийн тэнцэл, гадаад орлого) хооронд тогтвортой коинтеграцийн хамаарал бий болсон гэсэн байна.

ЗАГВАРЫН ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь хоёр улсын худалдааны тэнцлийг ДНБ-д харьцуулсан харьцааг бодит ханш, мөнгөний нийлүүлэлтийн нөлөөгөөр үнэлэх явдал юм. Худалдааны тэнцлийн шалтгааныг илрүүлэхийн тулд гурван арга (мэдрэмж, шингээлт, санхүү) стратегиудыг Дуаса (2007), Киериме (2002)) авч үзье. Чөлөөт худалдааны худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөөг тодорхойлохын тулд бид дамми хувьсагчийг мөн оруулсан. Загварыг дараах байдлаар тодорхойлсон.

$$\log BT = c + \gamma_0 \log GDP + \gamma_1 \log REER + \gamma_2 \log MS + \delta_0 D + u$$

$\log BT$ нь худалдааны тэнцэл, c нь хувьсагчийн өөрчлөлтөөс хамаарахгүй тогтмол, $\log GDP$ нь ДНБ-ний логарифм хувьсагч, $\log REER$ нь төгрөгийг юаньтай харьцуулсан ханшийн логарифм хувьсагч, $\log MS$ нь мөнгөний нийлүүлэлтийн логарифм, D нь чөлөөт худалдааны

хэлэлцээр хүчин төгөлдөр бус үед 0-тэй тэнцэх дамми хувьсагч, хүчин төгөлдөр бол 1-тэй тэнцэнэ, u нь алдааны хэсэг, $\gamma_0, \gamma_1, \gamma_2, \delta_0$ – нь үл мэдэгдэх параметр

Песаран, Шин (1999,1995) нарын санал болгосон аргачлалыг ашиглан, хувьсагчдын хоорондын урт хугацааны хамаарлыг хэмжихийн тулд авторегрессийн лаг тархсан загварыг ашиглалаа. Энэ загвар нь хэд хэдэн давуу талтай бөгөөд урт хугацааны коинтеграцийг урьдчилан таамаглах чадвар нь бусад загваруудаас давуу байдаг. Мөн хувьсагчдыг хэр сайн бүрдүүлж байгаагаас үл хамааран бага түүвэрт ашиглах боломжтой юм. Урт хугацааны харилцан хамаарал байгаа эсэхийг шалгахын тулд коинтеграцийн тестийг (bound test) ашиглая.

(1) загварыг ашиглахын тулд авторегрессийн лаг тархсан загварын алдааг залруулсан хувилбар буюу (ECM)-ийг авч үзнэ.

$$\begin{aligned} \Delta \log EXP_t = & \alpha_0 + \alpha_1 \log TB_{t-1} + \alpha_2 \log REER_{t-1} + \alpha_3 \log GDP_{t-1} + \alpha_4 \log Ms_{t-1} + \\ & + \alpha_5 Ds_{t-1} + \sum_{i1=1}^m \beta_{1i} \Delta \log TB_{t-i1} + \sum_{i2=1}^n \beta_{2i} \Delta \log EX_{t-i2} + \\ & + \sum_{i3=1}^o \beta_{3i} \Delta \log R_{t-i3} + \sum_{i4=1}^p \beta_{4i} \Delta \log RES_{t-i4} + \sum_{i5=1}^q \beta_{5i} \Delta D_{t-i4} + \theta ECT_{t-1} + \varepsilon_t \quad (1) \end{aligned}$$

Энд Δ нь ялгавар оператор, m, n, o, p, q нь загвар дахь оновчтой хожимдол, α, β нь коэффициентууд, θ нь хурдыг тооцоолох алдаа засах хугацааны (ECT) коэффициент юм. тэнцвэрт тохируулга (θ нь 0-ээс -1 хооронд байна), ε_t нь цагаан шуугиан

Тус загварыг хэрэглэхээс өмнө бүх хувьсагчид $I(0), I(1)$ үед стационар байх ба ямар ч хүчин зүйлсийн хувьд (2) ба түүнээс дээш эрэмбийн интеграци байгаа эсэхийг шалгахын тулд хувьсагчдын стационар байдлыг үнэлнэ. Мөн авторегрессийн лаг тархсан загвараар хоёр үе шаттай үнэлгээ хийнэ. Эхлээд бид өгөгдлийг ашиглан коинтеграцийн тестийг хийж загвар дахь бүх хүчин зүйлийн урт хугацааны уялдаа холбоог шалгана. Дараа нь урт хугацааны уялдаа холбоог тодорхойлсны дараа загварын богино болон урт хугацааны коэффициентийг үнэлнэ. Загварынхаа найдвартай байдлыг шалгахын тулд оношилгооны тестүүд болох хетероскедастик нөхцөлтэй эсэхийг Вайт ба BPG тест, өгөгдлийн хэвийн тархалттай эсэхийг Жаркью-Бера тест, цувааны автокорреляцийн хамаарлыг Бреуш-Годфри LM тестээр шалгана. Мөн загвар дахь функцийн хэлбэр зөв эсэхийг шалгахын тулд Ramsey-ийн RESET тест, CUSUM болон CUSUMQ тестээр урт хугацааны шинж чанаруудын тогтвортой байдлыг тус тус шалгана.

ЭМПИРИК СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хүснэгт 1-д Шварцийн мэдээллийн шалгуурт (SIC) үндэслэсэн Дики Фуллер (ADF) болон Филлипс Перрон (PP) нэгж язгуурын шинжилгээний үнэлгээний үр дүнг үзүүлэв. Эндээс харахад худалдааны тэнцлийн логарифм $I(0)$ -ээс бусад бүх хувьсагчид зарим түвшинд стационар бус байна. $I(1)$ үед бүх хувьсагчид стационар байна. Тус аргачлалын давуу тал нь үндсэн регрессорууд $I(1), I(0)$ эсвэл хоёуланг нь хослуулсан эсэхээс үл хамааран урт хугацааны коэффициентүүд асимптот хэвийн тархалттай үед гаргадагт оршино. Менегак (2019)-ийн дагуу авторегрессийн лаг тархсан загварын таамаглалыг хангахын тулд хувьсагч бүр $I(0)$ эсвэл $I(1)$ эсвэл тэдгээрийн хослол байх ёстой. Диланчиев, Тактакишвили (2021) нар

I(0) түвшний суурин хувьсагч ба I(1) хослол нь авторегрессийн лаг тархсан загварын шинжилгээний үнэлгээний процедурт оновчтой болохыг тодорхойлсон байдаг.

Хүснэгт 1. Тогтвортой эсэхийг шалгах нэгжийн язгуурын тест

Хувьсагчид	ADF		PP	
	Level	First difference	Level	First difference
<i>logTB</i>	-2.8149*	-6.686	-2.8149*	-7.3255
<i>logREER</i>	-4.1713***	-2.1372	-2.1533	-5.1001
<i>logMS</i>	-1.2300	-4.0695***	-1.8718	-4.0484***
<i>logGDP</i>	-5.0262	-3.4673**	-8.4968	-19.4348***
1%	-4.284580	-4.296729	-4.284580	-4.296729
5%	-3.562882	-3.568379	-3.562882	-3.568379
10%	-2.5722900	-3.218382	-2.5722900	-3.218382

Эх сурвалж: Судлаачдын тооцсон программын үнэлгээ

*** 1% -д мэдэгдэхүйц, ** 5% -д чухал ач холбогдолтой, * 10% -д мэдэгдэхүйц статистик ач холбогдолтой

Авторегрессийн лаг тархсан загварын үр дүн

Тус загварыг ашиглан урт хугацааны хамаарлын коэффициентүүд болон харгалзах алдаа засах загварыг (ECM) үнэлэхийн тулд хувьсагчдын лаг тархсан цувааг Акаике мэдээллийн шалгуураар (AIC) сонгоно. Бидний загвар (1,1,1,0,3) боллоо.

Коинтеграцийн шинжилгээ

Параметруудийн хоорондын урт хугацааны коинтеграцийн хамаарлыг үнэлэхийн тулд хязгаарын тест нь коинтеграцитай байгаа эсэхийг харуулах ба үнэлээний параметруудийн хугацааны хожимдлын статистикийн ач холбогдлийг шалгахын тулд F шинжүүрийг ашигладаг. Волдийн тестийн үр дүнг (F статистик) Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. F статистик ба bound test

Загвар	k	M	F статистик	Ач холбогдлын түвшин	Доод босго	Дээд босго
ARDL (1,1,1,0,3)	4	4	18.44563	10%	1.9	3.01
				5%	2.26	3.48
				1%	3.07	4.44

Эх сурвалж: Судлаачдын тооцсон программын үнэлгээ

k нь тайлбарлагч хувьсагчийн тоог илэрхийлнэ. Аль ч ач холбогдлын түвшинд F шинжүүрийн тестийн утга нь статистик ач холбогдлыг харуулна. Хүснэгт 2- оос харахад худалдааны тэнцлийг тайлбарлах хувьсагчууд болон бодит ДНБ нь хоорондоо холбоо хамааралтай бөгөөд Хүснэгт 2-т гаргасан F статистик нь дээд босго хэмжээнээс их байгаа бөгөөд 1%-аас доош түвшинд статистикийн ач холбогдолтой байна. Авторегресс лаг тархсан загварыг тооцоолж коинтеграцийн холбоо хамаарал байгаа эсэхийг тодорхойлсон тул урт болон богино хугацааны хамаарлыг дахин шинжилнэ.

Богино болон урт хугацааны хамаарлын шинжилгээ

Урт хугацааны шинжилгээний үнэлгээний үр дүнг харуулсан урт хугацааны коэффициентүүдийг Хүснэгт 3-т нэгтгэлээ. Тус загвараар үнэлсэн урт хугацааны коэффициентийн утгууд:

Хүснэгт 3. Үнэлсэн ARDL (1,1,1,0,3) урт хугацааны загвар

Хувьсагч	Коэффициент	t-статистик	Магадлалын утга
<i>logREER</i>	1.306989	2.928373	0.0086
<i>logGDP</i>	-0.30	-1.052018	0.3060
<i>logMS</i>	0.160118	0.248002	0.8068
<i>D</i>	-0.191476	-0.536458	0.5979

Эх сурвалж: Судлаачдын тооцсон программын үнэлгээ

REER хувьсагчийн бүрэлдэхүүн хэсгүүд нь 1, 5, 10% - ийн ач холбогдлын түвшинд статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд энэ нь урт хугацаанд ханш 1%-иар өсөх нь гадаад худалдааны алдагдлыг 1.31%-иар нэмэгдүүлдэг гэсэн үг юм. Богино хугацаанд (Хүснэгт 4) харьцангуй ханш 1%-аар өсөхөд гадаад худалдааны тэнцэл 2.81%-аар буурдаг тул гадаад худалдааны тэнцэлд ханш ихээхэн нөлөөлдөг. Бусад бүх хувьсагч нь урт хугацаанд статистик ач холбогдолгүй болохыг харуулж байна. Ханш, мөнгөний нийлүүлэлт урт хугацаанд эерэг, ДНБ, дамми хувьсагч нь сөрөг нөлөөг үзүүлж байна.

Харин богино хугацаанд ханш болон дамми хувьсагчид 5%-аас дээш ач холбогдлын түвшинд статистик ач холбогдол бүхий коэффициентууд тооцогдсон бөгөөд хоёулаа гадаад худалдааны тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Эндээс хоёр улсын хоорондын богино болон урт хугацааны худалдааны тэнцлийг тайлбарлах гол хүчин зүйл нь төгрөг-юанийн ханшийн харьцаа болохыг харуулж байна. Судалгааны үр дүн нь урт хугацаанд төгрөгийн ханш өсөх нь Монгол улс дахь БНХАУ-ын бараа бүтээгдэхүүн болон үндэсний барааны БНХАУ-ын зах зээлийн үр нөлөөг нэмэгдүүлэх болно. Тиймээс энэ нь манай бүтээгдэхүүний БНХАУ дахь зах зээлийг бууруулж (Монгол улсын барааны үнийн өсөлтөөс шалтгаалж), импортын оронд БНХАУ-ын барааг орлуулахад хүргэж болзошгүй юм. Богино хугацаанд төгрөгийн юаньтай харьцах ханшийн өсөлт нь БНХАУ-ын барааны хэрэглээг нэмэгдүүлж, юанийн үнэ цэнийг бууруулж, улмаар үндэсний бүтээгдэхүүнээс БНХАУ-ын импортын барааны үнэ өсөх магадлалтай ба БНХАУ-аас импортлох бүтээгдэхүүний өртөг буурах болно.

Тооцооллоос харахад дамми хувьсагчийн (МУ, БНХАУ-ын худалдааны гэрээ) худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөө нь урт хугацаанд статистикийн хувьд ач холбогдолгүй байгааг харуулж байна. Энэ нь худалдааны гэрээ нь эдгээр улсын худалдааны тэнцэлд нөлөөлөх боломжгүй гэсэн үг юм. Энэхүү эерэг холбоо нь дэлхийн худалдааг либералчлах онолд нийцэж байна. ЕСТ нь богино хугацааны тэнцвэргүй байдлын улмаас тэгшитгэлийн засварын чиглэл, хурдыг тодорхойлдог. Сөрөг тэмдэгтэй, статистикийн ач холбогдолтой утга бүхий ЕСТ байгаа нь загварын хүчин зүйлүүдийн хооронд урт хугацааны хамаарал байгааг тодотгож, худалдааны тэнцлийн урт хугацааны тэнцвэрт эрэлтээс богино хугацааны хазайлтыг засч залруулах боломжтой гэсэн үг юм.

$$Cointeq(-1) = \log TB - (1.306989 \cdot \log REER + 0.160118 \cdot \log MS - 2.215248 \log GDP - 0.191476 \cdot D)$$

Хүснэгт 4. ARDL(1, 1, 1, 0, 3) богино хугацааны загвар

Хувьсагч	Коэффициент	t-статистик	Магадлалын утга
<i>logREER</i>	-2.819573	-2.7033	0.0141
<i>logGDP</i>	-0.309527	-1.3541	0.1916
<i>D</i>	-0.579431	-2.9638	0.0080

Эх сурвалж: Судлаачдын тооцсон программын үнэлгээ

Тогтвортой байдлын тест

ECT (Банержи, 1988) нь динамик загварт тэнцвэрийг сэргээхэд шаардагдах хурдны загварыг илэрхийлдэг. Манай загварын ECT нь -0.5409 сөрөг тэмдэгтэй гарсан бөгөөд тус загварын урт хугацаан дахь тохироцийг тодорхойлж параметрууд тэнцвэрт байдалд хэр хурдан нийлдэгийг харуулдаг. Харьцангуй их хэмжээний ECT нь урт хугацааны холбоо хамаарал нь тэнцвэртэй гэдгийг нотлох баримт болж өгдөг.

Авторегрессийн лаг тархсан загвар нь доорх хүснэгтэд үзүүлсэн шиг оношилгооны ердийн статистик шалгууруудыг хангадаг. Үлдэгдэл хэмжигдэхүүний хувьд хэвийн тархалттай эсэхийг шалгах тест нь Jarque-Bera тест бөгөөд үлдэгдэл хувьсагч нь хэвийн тархалттай байна гэж хэлэх статистик нотолгоо олдсон. Үлдэгдэл цуваа автокорреляци хамааралтай эсэхийг LM тестээр, мөн загвар хетероскедастик нөхцөлийг хангасан эсэхийг Брейш-Паган-Годфригийн тестээр тодорхойлсон. Ramsey RESET тест нь загварийн функцийг хэлбэр нь зөв тодорхойлогдсон эсэхийг тогтоох бөгөөд магадлалын утга нь 0.3540 болж загварын хэлбэр буруу гэж хэлэх үндэслэлгүй байна. CUSUM статистик болон CUSUM тогтвортой байдлын тест нь 5%-ийн ач холбогдлын түвшний завсарт оршин байгаа тул ARDL загвар тогтвортой (stability) болохыг харуулж байна.

Хүснэгт 5. Тест статистик

$\chi^2_{BG} = 0.2110 (0.8119)$	$\chi^2_{JB} = 1.5750 (0.4549)$
$\chi^2_{BG} = 1.1856 (0.1259)$	$\chi^2_{BG} = 0.9513 (0.3540)$

Эх сурвалж: Судлаачдын тооцсон программын үнэлгээ

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар бид 2015 оны 1-р сараас 2022 оны 12-р сар хүртэлх сар бүрийн өгөгдлийг ашиглан ашиглан хоёр улсын худалдааны тэнцлийн урт хугацааны хамаарлын загвар болон БНХАУ-тай хийсэн чөлөөт худалдааны гэрээний худалдааны тэнцэлд үзүүлэх нөлөөг шинжлэх зорилготой байсан. Судалгаанд хамааралтай болон үл хамаарах хувьсагчдын хоорондох урт хугацааны хамаарлыг үнэлэхийн тулд авторегрессийн лаг тархсан загварыг ашиглалаа. Бид худалдааны тэнцэлд нөлөөлөх хүчин зүйлсийг олохын тулд хэд хэдэн хувьсагчдыг авч үзсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд нөлөө үзүүлэх үр дүнтэй гэж тооцогдож буй валютын ханш нь урт хугацааны худалдааны тэнцэлд

статистикийн хувьд эерэг нөлөө үзүүлж, богино хугацааны худалдааны тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөнгөний нийлүүлэлт (M₃) болон GDP нь богино болон урт хугацаанд худалдааны тэнцэлд бага нөлөө үзүүлдэг нь хоёр улсын худалдааны тэнцвэргүй байдлын хоёр талын тэнцвэрийг тодорхойлоход мөнгөний хандлага бүхий аргачлал тохиромжгүй болохыг харуулж байна. Тооцооллын үр дүнгээс харахад чөлөөт худалдааны гэрээ нь урт хугацаанд худалдааны тэнцэлд бага нөлөө үзүүлж байгаа нь гэрээний үйл ажиллагааг цуцалсан орнуудын байр суурийг зөвтгөхөөр байна. Эдгээр эмпирик үр дүнгээс гаргаж болох бодлогын хамгийн чухал үр дүн нь төгрөгийг юанийн эсрэг үнэгүйдүүлэх нь худалдааны тэнцлийн тохиргоо хийгдэхэд ашиглагдаж магадгүй юм. Түүнчлэн бид чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж хэрэгжүүлснээр хоёр орны худалдааны эргэлт нэмэгдэнэ гэж үзэж байна. Чөлөөт худалдааны хэлэлцээрийн ачаар БНХАУ-ын өрх гэр Монголын гаралтай уул уурхайн бус хөдөө аж ахуйн хүнсний бараа бүтээгдэхүүн зэргийг худалдан авах боломжтой болох ба манай улсад зах зээлээ төрөлжүүлэх, экспортоо нэмэгдүүлэх шинэ боломж юм. Цаашлаад БНХАУ-ын зах зээлд нэвтрэх нь аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэлээ өргөжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт хийх чухал хөшүүрэг байх боломжтой. Үүний зэрэгцээ хоёр орны эдийн засгийн харилцааг бэхжүүлэх хүрээнд тус улсын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах боломж бүрдэнэ.

НОМ ЗҮЙ ЖАГСААЛТ

- [1] Adznan, S. and Masih, M. (2018, 12-р сарын 30). Валютын ханш ба худалдааны тэнцлийн уялдаа: ARDL болон NARDL [MPRA баримт бичиг] дээр үндэслэсэн Малайз улсын жишээ. <https://mpra.ub.uni-muenchen.de/91509/>
- [2] Ахад, М. (2017). Худалдааны тэнцэлд санхүүгийн хөгжлийн нөлөөлөл: Пакистан дахь ARDL-ийн коинтеграцичлал ба учир шалтгааны хандлага. *Global Business Review*, 18(5), 1199-1214. <https://doi.org/10.1177/0972150917710152>
- [3] Banerjee, A., Dolado, J. and Mestre, R. (1998). Нэг тэгшитгэлийн коинтеграцичлалын алдаа засах механизмыг турших. *Journal of Time Series Analysis*, 19(3), 267–283. <https://doi.org/10.1111/1467-9892.00091>
- [4] Bosnjak, M., Novak, I., and Kristo, A. (2018). Хорват улс дахь харилцах дансны мөнгөн тэмдэгт, шингээх аргыг тайлбарлах уу*. *Зборник Радова Экономског Факултета у Рижечи/Рижека эдийн засгийн сургуулийн сэтгүүл*, 36929-946. <https://doi.org/10.18045/zbefri.2018.2.929>
- [5] Диланчиев, А., Тактакишвили, Т. (2021). Валютын ханшийн уналт нь үндэсний экспортыг холбодог эсэх тухай нотолгоо. *Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн дэлхийн сэтгүүл*, 9(5), 1116-1124. <https://doi.org/10.13189/ujaf.2021.090521>
- [6] Песаран, М.Н. (1998). Коинтеграцийн шинжилгээнд зориулсан авторегрессив лаг тархсан загварчлалын арга. S. Strøm (ed.), 20-р зууны эконометрик ба эдийн засгийн онол:
- [7] Ч.Наранчимэг, Ч.Сумьяа, Ч.Даваасүрэн (2019). Чөлөөт Худалдааны Хэлэлцээр ба Монгол Улс, СЭЗИС сэтгүүл



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНД ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Цэлмэг

Магистр (M.Sc), Өвөрмонголын СЭЗИС



Түлхүүр үг:

Гадаад худалдаа,
логистик, ачаа
тээвэрлэлт

Хураангуй

Олон улсын зах зээлд эдийн засгийн хувьд хөгжсөн орнуудыг хөгжилтэй логистикийн салбар дэмждэг бөгөөд энэ нь тухайн улсын шинэчлэлийн түвшин, иж бүрэн хүч чадлыг харуулдаг бөгөөд судлаачид үндэсний эдийн засгийн хөгжлийн "артери" буюу "хөдөлгүүр" гэж үнэлдэг. Үндэсний эдийн засгийн хөгжлийн "артери" буюу "хөдөлгүүр" гэж эрдэмтэд ерөнхийд нь үздэг. Логистикийн салбар нь тээврийн салбар, тээвэр зуучийн салбар, мэдээллийн салбар ба агуулах гэх мэт бүх үйл ажиллагааг нэгтгэсэн үйлчилгээний салбар юм.


Тээвэр ба логистикийн үйлчилгээ нь олон улсын худалдааг хөнгөвчилж, орон нутгийн эдийн засгийн өсөлт, хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Логистикийн чанар болон үр ашигт байдал нь олон улсын худалдаанд чухал ач холбогдолтой тул логистикийн дэд бүтэц, үйл ажиллагааны сул тал нь дэлхийн худалдааны интеграцид томоохон саад болж болзошгүй юм (Devlin, 2005). Эсрэгээр, либералчлагдсан эдийн засгийн орчинтой хослуулсан худалдаа, үйлчилгээтэй холбоотой сайжруулсан логистик нь худалдааны хэмжээ, хуваарилалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх боломжтой юм (Lakshman, 2001).

2018 оноос хойш COVID-19 тахал, улмаар усан тээвэр, агаарын тээврийн тасалдал, ОХУ Украин дайн зэргээс шалтгаалан дэлхийн зах зээлд гарсан томоохон өөрчлөлтүүдийн үед логистикийн гүйцэтгэлийг хэмжих, түүнийг тодорхойлох хүчин зүйлсийг ойлгох нь улам чухал болж байна. Хятад улсын хойд хөршийн чухал орон, "Бүс ба Зам" стратегийн дагуух чухал зангилаа орны хувьд Монгол Улс сүүлийн жилүүдэд авто тээвэрт тулгуурласан хоёр орны худалдаа өргөжин хөгжиж, хамтын ажиллагаа эрчимжсэн зэрэг хүчин зүйлс нөлөөлж, хилийн боомтуудад логистикийн салбар олны анхаарлыг татаж байна. Хятад-Монголын боомтуудын логистикийн үр ашгийг судлах нь Монголын боомтуудын дэд бүтцийн бүтээн байгуулалтад ашигтай бөгөөд логистикийн салбарын үйлчилгээний түвшнийг дээшлүүлж, импорт экспортын худалдааны өндөр эрэлт хэрэгцээг хангахад тустай юм.

Гадаад худалдааны өнөөгийн байдал

Түүхийн аль ч цаг үеийг харсан далайд гарцгүй орнууд экспортын баримжаатай эдийн засаг, түүнтэй холбоотой хөгжлийн стратегийг бий болгох талаарх хандлагатай байсаар иржээ. Эдгээр орны ихэнх нь худалдааны хатуу бодлого, хилийн ээдрээтэй асуудлаас болж эдийн засгийн хөгжил нь удаашралтай болон буурай хөгжилтэй орнууд байна.


Зураг 1: Монгол Улсын хилийн боомтууд



Эх сурвалж: (ГЕГ, 2022)

Монгол Улс ОХУ-тай хиллэдэг 16 боомттой бөгөөд өнөөдрийн байдлаар 10 боомт ажиллаж, БНХАУ-тай хиллэдэг 17 боомт байгаагаас 3 нь түр горимоор ажиллаж байгаа бол 14 нь байнгын ажиллагаатай. Эдгээр боомтоор дамжуулан Монгол Улсын гадаад худалдаа явагддаг.

Зураг 2: Монгол Улсын гадаад худалдааны үндсэн үзүүлэлт



Эх сурвалж : (ҮСХ, 2020)

Монгол Улсын гадаад худалдааны хэмжээ сүүлийн 20 жилийн хугацаанд өсөх хандлагатай боловч өсөлт нь тогтворгүй, үүнд 2001-2008, 2009-2011, 2016-2019 жилүүдэд хурдацтай өсч байсан бол 2008-2009, 2011-2013, 2014-2016 зэрэг онуудад буурсан байна. 2020 оны гадаад

худалдааны нийт эргэлтийн хэмжээ өмнөхөноос 6%-аар буюу 872 сая ам.доллаароор буурч 12,875 сая ам.доллар байв. Үүнд экспорт 1%-аар буюу 43 сая ам.доллаароор, импорт 14%-аар буюу 829 сая ам.доллаароор тус тус буурсан нь нөлөөлөв. Худалдааны тэнцэл өнгөрсөн онтой харьцуулхад 785 сая ам.доллаароор өсч 2,277 сая ам.долларын ашигтай байна.

2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5,158 сая ам.доллаароор өсөж, 21,245 сая ам.долларт хүрснээс, экспорт 36%-аар буюу 3,299 сая ам.доллаароор, импорт 27%-аар буюу 1,859 сая ам.доллаароор тус тус өссөн нь нөлөөлөв. 2022 онд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,440 сая ам.доллаароор өсөж, 3,836 сая ам.долларын ашигтай гарлаа.

1.1 Экспортын өнөөгийн байдал

2022 онд өнгөрсөн оны мөн үеэс 36%-аар буюу 3,299 сая ам.доллаароор өсөж, 12,540 сая ам.долларт хүрчээ.

Хүснэгт 1.1 Экспортын задаргаа

Төрөл	2020	2021	2022	(2022/2021)	(2022/2021)
Уул уурхай	7,039	8,520	11,661	37%	▲
Мал аж ахуй	292	372	504	36%	▲
Газар тариалан	14	5	14	1.8%	▲
Аж үйлдвэрлэл	230	343	359	5%	▲
Бусад	1	1	1	-14%	▼

Эх сурвалж: (Монголбанк, 2022)

Уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт нь нийт экспортын өсөлтийг бүрдүүлж байна. Үүнийг тодруулбал:

Уул уурхайн экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж, 3,190 сая ам.доллаароор өсөж, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 49 сая ам.доллаароор буурсан, Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж, 252 сая ам.доллаароор буурч, харин үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 268 сая ам.доллаароор өссөн, Мал аж, ахуйн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж, 70 сая ам.доллаароор, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж, 63 сая ам.доллаароор тус тус өссөн байна.

Монголын уул уурхайн экспорт нийт экспортын 90 орчим хувийг эзэлжбуй. Үүнд нүүрс зонхилох нөлөөтэй. Монгол Улс 2019 онд 36 сая тонн нүүрс урд хөршийн зах зээлд экспортолсон нь түүхэн дээд амжилт байв. Монгол Улс өнөөдрийг хүртэл уул уурхайн экспортдоо авто тээврийг ашиглаж ирсэн нь экспортын хэмжээг огцом нэмэгдүүлэхэд хүндрэлтэй байгаа юм. Хүн хоорондын харилцаа их учраас хилийн хорио цээрийн дэглэмийн үед хоёр талын боомтыг хаахад томоохон эрсдэл дагуулсан байна. Улмаар Монголын нүүрсний экспорт 2021 онд энэ болон бусад хүчин зүйлээс шалтгаалан ердөө 16 сая тонн болж буурсан байна. Энэ нь Монголчуудын өмнө гаргасан түүхэн дээд хэмжээнээс хоёр дахин бага юм. Нүүрс олборлодог ажахуйн нэгжүүдийн 2021 оны экспортын хэмжээг боомтын хамт дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.2 Нүүрс олборлодог ААН-үүдийн 2021 оны экспорт

Боомт	ААН-н тоо	Экспорт (мян.тонн)	Эзлэх хувь
Гашуунсухайт	6	8482.1	53.22%
Шивээхүрэн	9	4018.9	25.22%
Ханги	5	1258.6	7.90%
Булган	1	1104.8	6.93%
Замын үүд	12	741.1	4.65%
бичигт	7	332.2	2.08%

Эх сурвалж: (МОУИТБС, 2021)

Нүүрсний экспорттой жишээтэйгээр уул уурхайн салбарын 90%-н бүтээгдэхүүнийг **Бичигт, Гашуунсухайт, Замын-Үүд, Ханги, Шивээхүрэн** зэрэг боомтуудаар дамждаг.

1.2 Импортын өнөөгийн байдал

2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27%-аар буюу 1,859 сая ам.доллараар өсөж 8,704 сая ам.долларт хүрчээ.

Хүснэгт 1.3 2022 оны импортын өөрчлөлт (салбараар)

Төрөл	2020	2021	2022	(2022/2021)	(2020/2019)
Хэрэглээний бүтээгдэхүүн	1542	2184	2686	23%	▲
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	2290	2757	3308	20%	▲
Аж үйлдвэрлэлийн орц	634	762	966	27%	▲
Нефтийн бүтээгдэхүүн	817	1132	1724	52%	▲
Бусад	18	11	21	95%	▲

Эх сурвалж: (Монголбанк, 2022)

Импорт 27 хувиар өсөхөд нефтийн бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 8 нэгж хувиар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 7 нэгж хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв. 2022 оны урьдчилсан гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт импорт 1,859 сая ам.доллараар өсжээ. Үүнд: Нефтийн бүтээгдэхүүний импорт 592 сая ам.доллараар, Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 551 сая ам.доллараар, Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 502 сая ам.доллараар, Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 204 сая ам.доллараар тус тус өссөн байна.

Монгол, Хятадын хилийн боомт Замын-Үүд-Эрээний төмөр замын боомтоор импортын барааны 70 гаруй хувийг авдаг бол экспортын барааны 90 гаруй хувь нь мөн Замын-Үүд-Эрээн, Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхэ боомтуудаар нэвтэрч байна. Хилийн боомтын ачаалал, нэвтрүүлэх хүчин чадлаас мөн дотоодын тээвэр логистикийн бүтээмж муугаас хамаарч импорт, экспортын барааны урсгал саатаж удааширсан нь эдийн засаг дахь цар тахлын хүндрэлийг улам нэмэгдүүлж байлаа.

1.3 Монгол Улсын ӨМӨЗО-той хиллэдэг боомтууд дахь гадаад худалдааны өнөөгийн байдал

2000-2022 он хүртэлх ӨМӨЗО-ны хилийн боомтуудын бараа эргэлтийн ерөнхий байдлыг үүднээс авч үзвэл, боомтуудын тоо нэмэгдэж, улирлын чанартай зарим боомтыг шинэчилж, хөгжүүлснээр, 2015 онд Хятадын нүүрсний зах зээлсуларч, орос рубль, монгол төгрөгийн ханш унасантай холбоотойгоор боомтуудаар дамжин өнгөрөх нийт ачаа бага зэрэг буурснаас гадна үлдсэн жилүүдэд боомтын ачааны хэмжээ тогтвортой өссөөр байна. ӨМӨЗО-ны хилийн боомтоор дамжин өнгөрөх ачааны дотор шилжүүлэн ачих ачааны хэмжээ өсөж, боомтоор дамжин өнгөрөх нийт ачаанд шилжүүлэн ачих ачааны хэмжээ, экспортын ачааны эзлэх хувь аажмаар нэмэгдэж байгаа хэдий ч импортын ачааны хэмжээ давамгайлсан хэвээр байна. Боомтоор дамжин өнгөрөх нийт ачааны өөрчлөлтийн хандлага нь импортын ачааны хэмжээ өөрчлөгдөх хандлагатай үндсэндээ нийцэж байна.


Хүснэгт 1.4 2010-2022 оны Монгол Улс, ӨМӨЗО-ны хилийн боомт дахь ачааны урсгалын статистик (мян.тонн)

Он	Шивээ хүрэн Цэгээ	Гашуун сухайт Ганцмод	Ханги Мандал	Замын-Үүд Эрээн		Бичигт Зүүн хатавч	Сүмбэр Рашаан	Баян хошуу Өвдөг	Хавирга Ар хашаат
				Авто зам	Төмөр зам				
2010	8659	8361	105	1182	7439	310	0	28	78
2011	10337	10679	169	1842	8461	501	0	40	130
2012	9028	12417	422	2228	9376	1050	0	54	148
2013	7525	10810	292	2904	10150	1070	0	42	133
2014	8098	12790	211	3038	10520	1212	0	278.4	116
2015	7623	7251	239.2	3239	10790	1252	0	571.7	115.7
2016	12580	13886.9	801.1	2041.1	12313	1270	0	685.8	96
2017	13343.8	18213	2261.2	1758.2	13272.9	1375.7	0.7	652.8	57.5
2018	14159	18941	3132	1914	14647.3	1503	7.3	445.4	33.5
2019	12400	21459.7	3121.7	3604.3		1521	1.4	567	25
2020	10761.4	15523.4	725.4	2811	16159	287.4	0	31.7	2.5

Эх сурвалж: (ЗТХЯ, 2021)

Хилийн боомт бүрийн эдийн засгийн хөгжлийн түвшин, боомтын өөрийнх нь хэмжээ, бодлого, орчин нөхцөл зэргээс шалтгаалан хилийн боомт тус бүрээр дамжин өнгөрөх ачааны хэмжээ ихээхэн ялгаатай байдаг. 2000-2017 он хүртэлх ӨМӨЗО-ны хилийн боомтуудын гаалийн бүрдүүлэлтийн байдлаас үзвэл, 10 сая тонноос дээш ачаа тээвэрлэх Ганцмод-Гашуунсухайт, Цэгээ-Шивээхүрэн авто замын боомт, ЭрээнЗамын-Үүд төмөр замын боомт зэрэг 3 боомт бий.Хятад-Монголын нүүрсний худалдаа хөгжихийн хэрээр байгалийн нөөцөд ойрхон байрладаг Цэгээ-Шивээхүрэнбоомт, Ганцмод-Гашуунсухайт боомт зэрэг боомтоор дамжин өнгөрөх ачааныхэмжээ ихээхэн нэмэгдэж, ӨМӨЗО-ны бүс нутгийн боомтоор дамжин өнгөрөх нийт ачааны эзлэх хувь нэмэгдэж байгаа хэдий ч Эрээн Замын-Үүд уламжлалт хилийн боомтоор дамжин өнгөрөх ачааны хэмжээ ӨМӨЗО дахь хилийн боомтоор дамжин өнгөрч буй нийт ачааны дийлэнх хувийг эзэлсээр байна.


Зураг 4: Боомт тус бүрийн ачааны урсгалын эзлэх хувь, 2020 он



Эх сурвалж: (ЗТХЯ, 2021)

Хилийн боомт тус бүрийн импорт, экспортын ачаа тээврийн хэмжээ, түүхий эдийн бүтцийн ялгаатай байдлаас шалтгаалан хилийн боомт тус бүрийн импорт, экспортын худалдааны хэмжээ ч өөр өөр байна. 2020 онд ӨМӨЗО-ны хилийн боомтуудаас Манжуур (авто, төмөр зам) боомт, Эрээн Замын-Үүд (авто, төмөрзам) боомт, Ганцмод-Гашуунсухайт авто замын боомт гэх 3 боомт импорт экспортын худалдаа хоёр тэрбум ам.доллороос давсан байна.

Зураг 5. Боомт тус бүрийн гадаад худалдааны хэмжээ, 2019 он




Эх сурвалж: (ЗТХЯ, 2021)

2. Монгол Улсын логистикийн төлөв байдал

Урд хилээрээ БНХАУ-тай 4709 км, хойд хилээрээ ОХУ-тай 3543км-ээр хиллэдэг, далайд гарцгүй, өргөн уудам тал нутагтай Монгол Улсын гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ий дунд хугацааны өсөлтөд их хэмжээний нөлөө үзүүлэхээр байна. Иймд эдийн засгийн тогтвортой өсөлтийг нэмэгдүүлэх хүрээнд экспорт, импортын хэмжээг зохицуулах гадаад худалдааны тав тухтай орчин байх нь тулгамдаж буй чухал асуудал болж байна.

2.1 Авто тээврийн ачаа тээвэрлэлт

Зураг 6: Авто тээврээр тээсэн нийт ачаа (мян.тонн)



Эх сурвалж: (ЗТХЯ, Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл, 2022)

Авто тээврээр 2022 онд 33.07 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс тээвэрлэсэн ачаа 15.1 сая тонн буюу +84%-аар өссөн байна. Үүнд Гашуунсухайт боомтын экспорт +149%, Ханги боомтын экспорт +93.83%, Шивээхүрэн боомтын экспорт +27%-аар тус тус өсөж, Бургастай, Булган боомтуудын нийт экспорт 3сая.тонн хүрсэн нь голлон нөлөөлсөн байна. Мөн уул, уурхайн бүтээгдэхүүнээр Газрын тос -36.69%, Зэсийн баяжмал -15.58%- аар буурсан ч, Нүүрс +105.59%, Төмрийн хүдэр +413.73% тус тус өссөн байна.

Хүснэгт 1.5 Авто тээврийн ачаа тээвэрлэлт (тонн)

Боомтын нэр	2021 он		2022 он		Харьцуулалт %	
	Импорт	Экспорт	Импорт	Экспорт	Импорт	Экспорт
Алтанбулаг	107,077	-	183,020.9	8,474.9	170.92%	-
Бичигт	-	521,571	10,854	111,676.7	-	21.41%
Баянхошуу-Өвдөг	-	398,676	23,554.5	346,013	-	86.79%
Бургастай	-	-	1,575.1	866,282	-	-
Гашуунсухайт	-	7,448,362	-	18,575,645.9	-	249.39%
Замын-Үүд	824,519	176,476	635,768	106242.7	77.11%	60.20%
Цагаан нуур	78,910	194	100,463.2	-	127.31%	-
Булган	-	-	86,355	2,210,695	-	-
Ханги	-	1,573,995	-	3,050,832.2	-	193.83%
Шивээ хүрэн	-	4,226,658	-	5,368,736.3	-	127.02%
Боршоо	-	1,056,951	29,085.6	1,063.2	-	0.10%
Нийт	1,010,506	16,959,803	1,070,676.3	32,004,924.7	105.95%	188.71%
		17,970,309		33,075,601		184.06%

Эх сурвалж: (ЗТХЯ, Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл, 2022)

Авто тээврээр ачааны импортын 59.3%-ийг Замын-Үүд боомт эзэлж байна. Харин экспортын 60.6%-ийг Гашуунсухайт, 17.5%-ийг Шивээхүрэн, 9.95%-ийг Ханги боомтууд тус тус эзэлж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2022 оны жилийн эцсээр 111,916.7км байгаагийн 100,354.73 км нь буюу 89.67% нь ердийн хөрсөн, 9,943.74 км буюу 8.88% нь хатуу хучилттай, 0.82% нь хайрган хучилттай, 0.62% нь сайжруулсан хөрсөн зам байна.

Хүснэгт 1.6 Авто замын төрөл


Авто замын төрлөөр	2021 он	2022 он	2021/2022
Ердийн хөрсөн зам	100,502.89	100,354.73	99.85%
Сайжруулсан хөрсөн	640	697.7	109.20%
Хайрган хучилттай	1,015.93	920.53	90.61%
Хатуу хучилттай	9,757.88	9,943.74	101.90%
1 Асфальт бетон	9,442.52	9,860.98	104.43%
2 Хөнгөвчилсөн хар	205.2	0	0%
3 Цемент бетон	110.16	82.76	75.13%

Эх сурвалж: (ЗТХЯ, Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл, 2022)

2.2 Төмөр замаар тээсэн ачаа тээвэрлэлт


Төмөр замаар тээвэрлэсэн нийт ачаа 2022 оны жилийн эцсийн байдлаар 27.68 сая.тонн болж өмнөх оны үеэс 3.58 сая.тонн буюу -11.45%-аар буурсан байна. Нийт ачааны 43%-ийг дотоодын ачаа, 31%-ийг экспортын ачаа, 14%-ийг импортын ачаа, 12%-ийг дамжин өнгөрсөн ачаа тус тус эзэлж байна. Төмөр замын ачааны бүтцээр импортын ачаа +16.27% өссөн ч, экспортын ачаа - 21.43%, дотоодын ачаа -5.56%, дамжин өнгөрсөн ачаа -25.1%-аар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Экспорт болон дамжин өнгөрөх ачаа буурсан нь ОХУ болон Украин улсын хооронд үүсээд буй нөхцөл байдал шууд нөлөөлсөн байна.

Зураг 7: Төмөр замаар тээсэн ачаа тээвэрлэлт 2022 он (мян.тонн)



Эх сурвалж: (ЗТХЯ, Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл, 2022)

Зураг 8: Уул уурхайн бүтээгдэхүүний төмөр замаар тээсэн ачаа тээвэрлэлт (мян.тонн)



Эх сурвалж: (ЗТХЯ, Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл, 2022)

3. Гадаад худалдааны логистикт оршиж буй асуудал

3.1 Монгол Улсын ложистикийн салбарын хөгжил харьцангуй хоцрогдсон.

Хятад, Монгол, Орос гурван улс нь газар зүйн хувьд ойрхон, хөрш улсууд боловч ложистикийн гүйцэтгэлийн хувьд асар их ялгаатай. Монгол Улс нь нэлээд үзүүлэлтүүдээрээ Хятад, ОХУ, ялангуяа БНХАУ-аас хоцорч байна. Монгол Улсын тээвэрт төмөр зам, авто зам голлодог бөгөөд Хятад, Орос хоёр улстай төмөр замаар холбогдсон төдийгүй Улаанбаатар хотын “Чингис хаан” олон улсын нисэ хонгоцны буудал нь Монгол Улсын цорын ганц олон улсын тээврийн зангилаа бөгөөд Хятад,

Орос, Япон, Өмнөд Солонгос, Герман болон бусад орны агаарын тээврийн зангилаагаар дамжуулан дэлхийн агаарын тээврийн сүлжээтэй холбогдсон байдаг.

Хүснэгт 2.1 2022 Монгол Улсын логистик гүйцэтгэлийн индекс

		Монгол	Хятад	Орос
LPI ерөнхий үзүүлэлт		2.5	3.7	2.6
LPI эзэлсэн байр		97	19	88
Гааль	Оноо	2.5	3.3	2.4
	Байр	84	31	90
дэд бүтэц	Оноо	2.3	4	2.7
	Байр	108	14	68
тээвэрлэлт	Оноо	2.5	3.6	2.3
	Байр	102	14	121
Логистикийн чадавхи	Оноо	2.3	3.8	2.6
	Байр	119	20	92
ачаа тээврийн мэдээлэл	Оноо	2.4	3.8	2.5
	Байр	105	23	98
цаг хугацаа	Оноо	2.7	3.7	2.9
	Байр	109	30	93

Эх сурвалж: (Дэлхийн банк, LPI, 2022)

Одоогийн байдлаар Хятад-Монголын худалдаа үндсэндээ хоёр тээврийн маршрутаар хязгаарлагдаж байна: Нэг нь Улаанбаатараас ӨМӨЗО-ны Эрээн хотоор дамжин Тяньжин боомт хүртэл 1200 миль, нөгөө нь Монголын зүүн хэсгийн Чойбалсан хотоос Өвөрмонголын Манжуураар дамжин Далянь боомт хүртэл 1400 миль үргэлжилнэ. Одоогийн байдлаар Хятад, Монгол хоёрыг хооронд холбосон өндөр хурдны төмөр зам болон авто зам барихаар төлөвлөж байгаа бөгөөд хоёр маршруттай. Эхнийх нь Бээжин, Тяньжин, Хэбэй зэрэг Бохай булангийн эдийн засгийн тойргийг холбосон, хоёр дахь Оросын Чита хотоор дамжин Далянь, Шэньян, Чанчунь, Харбин, Манжуур зэрэг хотуудтай холбогдоно. Эдгээр замуудыг барьчихвал Монголын бараа бүтээгдэхүүн БНХАУ-ын зүүн хойд гурван мужаар дамжин зүүн талаараа Владивосток хотод хүрэхээс гадна дэлхийн хамгийн том нүүрсний экспортын боомт болох Чинхуандао боомтоор нүүрсээ шууд экспортлох боломжтой. Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засгийн коридорын дэд бүтцийг барихад тулгамдаж буй нэг асуудал бол төмөр замын царигийн зөрүү юм. ОХУ-ын төмөр зам 1520 миллиметр, Хятадын төмөр зам 1435 миллиметр өргөн царигтай байгаа нь Хятад, Монгол болон Орос-Европын

хилийн бүс нутагуудад өндөр зардалтай, маш бохирдолтой дамжин өнгөрөх процесс явагдахыг харуулж байна. Иймд төмөр зам, автозамын харилцан холболтын бүтээн байгуулалтыг хурдавчлах нь гаалийн бүрдүүлэлт, тээвэрлэлтийг хөнгөвчлөх, олон улсын тээврийн хамтын ажиллагааг ахиулах нь Монгол Улсыг далайд гарцгүй улсуудтай холбох гол зангилаа болох юм.

3.2 Монголын боомтууд гаалийн нэвтрэлтийн түвшнийг үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай.

Хятад, Монгол хоёр орны эдийн засаг, худалдааны солилцоо улам бүр нэмэгдэж байгаа энэ үед хоёр орны хамтын ажиллагаа, солилцоог хэрэгжүүлэх эхний нөхцөл нь боомтуудын гаалийн нэвтрэлтийн түвшин юм. Хоёр орны эдийн засаг, худалдаанд ашигт малтмал, өдөр тутмын хэрэгцээний бараа бүтээгдэхүүн голлож байна. Энэ төрлийн бараа бүтээгдэхүүнийг үндсэндээ их хэмжээний тээврийн хэрэгсэл, төмөр замаар тээвэрлэх шаардлагатай байдаг. Гаалийн нэвтрэлтийн түвшин нь хоёр улсын эдийн засаг, худалдааг хөгжүүлэхэд шууд нөлөөлнө. Монголын боомтууд гаалийн нэвтрэлтийн түвшнийг үргэлжлүүлэн сайжруулах ёстой. Азийн орнууд Монголын хямд өртөгтэй транзит тээврийг сонирхдог ч цаг хугацаанаас шалтгаалан өөр маршрутыг сонгодог. Тиймээс хилийн төмөр замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Их хэмжээний экспортын барааг дан ганц төмөр замаар тээвэрлэх нь хангалтгүй байдаг тул заримыг нь авто замаар тээвэрлэхээс өөр аргагүй байдалд хүрдэг бөгөөд энэ нь тээврийн зардлыг ихээхэн нэмэгдүүлдэг. Монгол шиг далайд гарцгүй орны хувьд ашигт малтмалын нөөцөө гадагшаа гаргахад бэрхшээл их байдаг. Ашигт малтмалын олборлолтын зардал, тээврийн зардал нь ашигт малтмалын экспортын өртгийг маш өндөр болгодог.

Хүснэгт 2.2 Дотоодын логистикийн гүйцэтгэлийн индексийн харьцуулалт

Боомт, нисэх буудлын нийлүүлэлтийн хэлхээ 2 / Экспортын хугацаа/	Герман улс	Монгол улс	Хятад улс
Зай (километр)	259km	86km	130km
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	3 өдөр	4 өдөр	3 өдөр
Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ 4 / Экспортын хугацаа			
Зай (километр)	631km	1181km	402km
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	3 өдөр	16 өдөр	6 өдөр
Боомт, нисэх буудлын нийлүүлэлтийн хэлхээ 5 / Импортын хугацаа			
Зай (километр)	285km	75km	187km
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	3 өдөр	4 өдөр	5 өдөр
Импортын хугацаа / Хуурай газрын нийлүүлэлтийн хэлхээ			
Зай (километр)	1043km	772km	649km
Үргэлжлэх хугацаа (өдрөөр)	4 өдөр	12 өдөр	9 өдөр
аардлага хангасан тээвэрлэлт (%)	93.78%	88.42%	71.64%
Экспортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	2	3	3
Импортын үйл ажиллагаатай холбоотой агентлагуудын тоо	2	4	3
Экспортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	2	3	5
Импортын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын тоо	2	4	4

Биет үзлэг хийгдэхгүй гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	1 өдөр	1 өдөр	2 өдөр
Биет үзлэг хийгдэх гаалийн бүрдүүлэлт (өдрөөр)	2 өдөр	1 өдөр	3 өдөр
Биет үзлэг (%)	2.79%	26.89%	9.68%
Олон төрөлт үзлэг (%)	1.75%	8.80%	3.38%

Эх сурвалж: (Дэлхийн банк)

3.3 Боомтын удирдлагын тогтолцоонд учир дутагдалтай байна.

Эдийн засаг тасралтгүй хөгжихийн хэрээр улсаас аюулгүй байдлын менежментэд ихээхэн анхаарал хандуулж, барааны эргэлтийн түргэн шуурхай байдлыг хангахад ихээхэн анхаарч, хилээр орж ирж буй гадаадын бараа, бүтээгдэхүүний хяналтыг чангатгаж байна. Энэхүү процесс нь мөн илүү товч бөгөөд тодорхой чиглэлд хөгжиж, боомтуудын хяналт, шалгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажлын процессыг үр дүнтэй сайжруулсан байдаг. Гэвч боомтын үйл ажиллагааны явцад олон асуудлуудтай тулгарсан байна. Тухайлбал, боомтуудын хооронд мэдээллийн нэгдсэн байдал алдагдаж, хоорондоо таарахгүй байх нь ажлын явцад бие биедээ шуурхай хариу өгөх боломжгүй болох, ажлын бүтээмж муудах, нөөц бололцоог бүрэн ашиглаж чадахгүйд хүргэдэг.

4. Санал зөвлөмж

4.1 Дэд бүтцийн харилцан холбоог бэхжүүлэх

“Дэд бүтцийн харилцан холбоо” нь шууд утгаараа Хятад, Монголын тээвэр, ложистик, худалдааны байгууламжуудыг хооронд нь холбох бөгөөд гол зам, үндсэн зангилаа, гол төслүүдийн бүтээн байгуулалт болох төмөр зам, хурдны зам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтуудыг яаралтай хийх шаардлагатай байна. Одоогоор Монгол Улсын төв төмөр зам нь ОХУ-ыг БНХАУ-ын ӨМӨЗО-той холбодог бөгөөд энэ нь Хятад, Монголын бараа бүтээгдэхүүний худалдааны гол суваг юм. Хэдийгээр Хятад-Монгол хоёр улсын авто зам саадгүй нэвтэрдэг ч хилийн хоёр талын хөгжлийн түвшин тэс өөр бөгөөд Монголын тал нь элс, хайрга, шороон зам нь зам тээврийг хөгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байдаг. Энэ нь төв төмөр замын ачааллыг нэмэгдүүлж, Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор байгуулахад ачаа тээврийн хэрэгцээг хангах боломжгүй болгож байна. Иймд Хятад-Монголын төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, төмөр замын тээврийн хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлэхийн зэрэгцээ хилийн тээвэр, ложистикийн зангилаа газруудыг сонгон шалгаруулах, их хэмжээний тээвэрлэлт хийхэд тохиромжтой авто замын коридорыг хөгжүүлэх нь нэн тэргүүний зорилт болж байна. Хил дамнасан тээвэр, ложистикийн сувгийн бүтээн байгуулалт, Хятад, Монголын хилийн ложистикийн паркийн дэд бүтэц, боомтын худалдааны дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэг нь Хятад Монголын тээвэр ложистикт суурилсан харилцааны хөгжлийн загварыг бүрдүүлж, эдийн засаг худалдааны харилцан идэвхтэй хөгжлийг ахиуллаа.

4.2 Тээвэр ложистикийн зангилааг хамтран байгуулж, Монгол Улсын төмөр замын тээврийн сүлжээг сайжруулах

Хятад-Монголын олон улсын чингэлэг галт тэргээр дамжуулан тээвэр ложистикийн төвийг хамтран байгуулж, нэг талаас Монгол Улсыг олон улсын ложистик санхүүгийн төв байгуулахыг дэмжиж, нөгөө талаас Хятад-Орос, Хятад-Европыг холбосон нэмэлт зам

байгуулна. Их хэмжээний тээвэрлэлт хийх хүчин чадалтай төмөр замын сүлжээг хөгжүүлэхэд анхаарал хандуулж, Хятад Монголын хилийн худалдааны хил дамнасан авто тээврийн системийг хөгжүүлэх нь нэн чухал юм. Далайн тээврийн гарц нь төмөр замын тээврийн зардалтай харьцуулахад ихээхэн өрсөлдөөнийг бий болгодог. Гэвч Монгол Улсын хувьд төмөр замын сүлжээг хөгжүүлэх нь хуурай замын худалдааны эрэлт хэрэгцээг хангаад зогсохгүй далайд гарах гарцыг бий болгох юм. Харин Монгол Улс дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээ, дэлхийн худалдаанд нэгдэж, тодорхой хэмжээний үр дүнд хүрэхээс өмнө хил дамнасан ложистикийн тогтолцоог бий болгоход шаардагдах зардал харьцангуй өндөр байна. “Нэг бүс, нэг зам”-ын санаачилга болон бүс нутгийн стратег нь өртгийг бууруулж, бүтээн байгуулалтын хурдыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх юм.

4.3 Хятад-Монгол-Оросын аж үйлдвэрийн сүлжээ, нийлүүлэлтийн сүлжээний зохицуулалт, хамтын ажиллагааг оновчтой болгох

Хятад, Монгол, Хятад, Орос улсууд баялгаараа бие биеэ нөхөж, ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, хөдөө аж ахуй, мал аж ахуйн бүтээгдэхүүнээс үл хамааран тээвэр, ложистик, худалдааны дэд бүтцээс шалтгаалан нөөц бололцоогоо бүрэн чадахгүй байна. Иймд эрчим хүч, ашигт малтмалын нөөц, өндөр технологи, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, ой, мал аж ахуйн гурван талт хамтын ажиллагааг бэхжүүлж, хилийн болон чухал зангилаа хотуудад аж үйлдвэр, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны кластеруудыг байгуулж, бүс нутгийн үйлдвэрлэлийн нягт уялдаатай сүлжээ, бүснүтийн хангамжийг бий болгоно. Монгол бол Хятад, Орос хоёрын хооронд газар зүйн хувьд онцгой зуучлагч бөгөөд Хятад-Оросын түүхий газрын тос, байгалийн хийн хоолойг Монголоор дамжин өнгөрүүлэх хоолойг байгуулснаар Хятад, Орос хоёрын газрын тос, байгалийн хийн худалдааны зардлыг бууруулж, улмаар Монгол Улсын олон улс дахь ложистикийн байр суурийг дээшлүүлэх юм.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Salawu, Y. O. , & Ghadiri, S. M. . (2021). A meta-synthesis of trade logistics influence on international trade. *Academic Journals*(10).
- Gani, & Azmat. (2017). The logistics performance effect in international trade. *Asian Journal of Shipping and Logistics*, 33(4), 279-288.
- Shukla, N. , & Radhakrishnan, A. . (2019). Modelling trade logistics based on multi-method simulation approach: case-in-point: mongolia.
- Eldevochir, E. . (2016). Logistics and transport challenges in mongolia. *English-language papers*, 4.
- Ulziiochir, N. , & Vorshilov, E. . (2016). Study on the impact of a free trade agreement between mongolia and the eurasian economic union. *English-language papers*, 4.
- Boldbaatar, T. , & Yoon, D. W. . (2012). A study on logistics development in mongolia. *Journal of Navigation and Port Research*, 36(4), 313-319.
- Leautier, F. A. , Lakshmanan, T. R. , Subramanian, U. , & Anderson, W. P. . (2001). Integration of transport and trade facilitation: selected regional case studies.
- Devlin, J. , & Yee, P. . (2005). Trade logistics in developing countries: the case of the middle east and north africa. *The World Economy*.

Nyamdavaa Tsend.(2020).Research on the Forecast and Development Strategy of the Transportation Volume of China and Mongolia port., Master's dissertation,Changan university,Xi'an China.

Л.Даваажаргал, & О. Цолмон, & Б.Хүслэн, & Г.Мөнхбаяр, & Д.Ган-Очир.(2018.)Монгол улсын гадаад худалдааны бодлогын тулгамдсан асуудлууд. “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2018, 17-41.

Ochir Myagmarsuren, & Minrong Deng.(2014).The Research on the Current Logistics Situation and the Dry Port Development of Mongolia.Mongolian Journal of International Affairs,56-66

邓红星, Munkhtuul Jargalsaikhan, & 刘敏. (2021). 基于dea-malmquist的中蒙公路口岸物流效率分析. 重庆理工大学学报:自然科学.

Narantsatsral Sosorjav, & 胡志华. (2019). \"一带一路\"背景下蒙古国跨境物流系统及其发展策略研究. 商业经济(8), 4.

Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв

Азийн хөгжлийн банк



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

ON THE RELATIONSHIP BETWEEN INDUSTRIAL RESTRUCTURING
AND SUSTAINABLE GROWTH OF LOCAL FISCAL REVENUE IN
CHINA

Zhang Ke

Master, University of Finance and Economics, 792281909@qq.com



Keywords:

Industrial restructuring.

Local fiscal revenue.

Sustainable growth.

Abstract:

The relationship between industrial restructuring and sustainable growth of local fiscal revenue in China has always been a topic of academic interest and research. Theoretically, in economic development, we can see that resource-based cities are one of the important strategic targets for developing countries, the demographic dividend is gradually disappearing, and the construction of new rural areas requires a large number of labor force jobs. However, because of the lack of technological innovation capacity and the emergence of many problems in the urbanization process, this has led to a serious incongruous relationship between industrial restructuring and sustainable growth of local fiscal revenue in China. From the practical level. There is an interdependent relationship between industrial restructuring and sustainable growth of local fiscal revenue, but they affect each other. Therefore, this paper analyzes the contradictions arising between industrial restructuring and local economic development by studying the relevant data in China.

Introduction

Since the reform and opening up, China's industrial restructuring has made great achievements, but there are defects due to economic development and systems and policies. At present, the domestic market is not well developed and the prices of production factors are unstable. Under such circumstances, we are required to fundamentally change the traditional production methods to improve the utilization rate of labor resources; promote product upgrading through innovative technology so as to enhance the efficiency of enterprises; strengthen local governments to study the distribution of local residents' income and develop relevant tax incentives to guide consumption, increase fiscal revenue growth, and provide good financial security and policy support for China's economic development [1]. China's industrial structure is inseparable from the development of the local economy, and it is an important factor in the adjustment of social productivity, production methods and distribution relations. China is currently in a critical period of industrialization stage to service transformation, in this process, resource-based regions need to

be reasonably allocated according to the actual local situation, so as to achieve sustainable development pioneering. For labor-intensive regions, it is necessary to determine the industrial structure and local economic growth model and development direction based on market demand orientation, which can promote the local economy to move forward, enhance and coordinate development in a fast, smooth, healthy and stable manner [2].

2. Basic Definition about Sustainable Growth of Local Fiscal Revenues

2.1. The Scope of Finance in Sustainable Growth of Local Revenue

Through the analysis of China's industrial restructuring and the fiscal policy of local government revenue sources, we found that in recent years, the state has invested a lot of money in developing tertiary industries to promote economic growth, but since there are great disparities and inconsistencies among regions, how to reasonably allocate resources and improve the efficiency of each industry in the region has become one of the important factors affecting the sustainability of regional fiscal revenue [3]. Meanwhile, the speed and direction of industrial restructuring also have a direct impact on the growth of local government revenue. After analyzing the sustainable industrial growth and the current situation of local economic development in China, we found that there are positive correlation, interdependence and spontaneous characteristics between the two.

2.2. What is Sustainable Growth of Local Fiscal Revenue?

Sustainable growth of local fiscal revenue refers to the government's efforts to increase its revenue through various ways and means on the basis of ensuring economic development, thus promoting local residents' consumption ability and social wealth accumulation. It includes: first, improve the efficiency of resource allocation. The large difference in industrial structure among regions and the large gap between regions have led to the increasingly prominent contradiction between supply and demand in the market; At the same time, some enterprises over-exploit natural resources in order to maximize profits, causing the deterioration of the ecological environment, making it difficult for the local economy to continue to develop [4]. The second point is to improve the sustainable development ability of local residents and enterprises. Since the market mechanism plays a limited and unlimited role in economic development, we believe that social stability should be promoted through a reasonable and effective adjustment of the income distribution system so as to achieve common prosperity. In addition, the positive impact and significance of the optimization and upgrading of the relevant industrial structure brought by the growth of local fiscal revenue should not be ignored, and only the reasonable and effective use of the local industrial structure can promote economic growth.

2.3. Ownership Structure, Demand Structure and Sustainable Growth of Local Fiscal Revenue

China's economic growth is mainly based on the public ownership system, and other forms of multiple ownership systems develop together. Under the socialist market economy system, various types of entities, such as enterprises, institutions and the private sector, have assumed their share of responsibility. However, due to the defects of the property rights system and the government's excessive intervention in the market, the allocation of social resources is unreasonable, resulting in inefficient production and serious waste. At the same time, because of the monopoly characteristics

of state-owned enterprises, the state revenue cannot meet their needs, thus causing a shortfall in local fiscal expenditure or even a deficit. Rationalization of industrial structure is the key to promote the fairness of income distribution and improve the overall welfare level and economic efficiency of the society [5]. The relationship between the industrial structure and the sustainable growth of local revenue in China is discussed and analyzed, and it is concluded that there are positive and negative correlations between the two. It is only through the coordinated development, balance and stability of the two that the fundamental purpose of their common prosperity and strength can be achieved. Finally, corresponding policy recommendations and countermeasures are proposed to address the impact of this issue, providing a reference basis and guarantee for better government functions in further development, thus promoting a virtuous cycle and sustainable growth of the economy.

3. The Intrinsic Link Between Industrial Structure Adjustment and Sustainable Growth of Local Financial Revenue

In the relationship between industrial restructuring and sustainable growth of local fiscal revenue we should clarify that there is a positive or negative correlation between the two, that is, the economic development process is the first productive force, while the secondary and tertiary industries can provide more high value-added products. The third service industry has a larger proportion of GDP in terms of added value, but China has not really established a modern market-oriented service system yet, so fundamentally it is the lack of government-led strategic supply that leads to social demand not meeting the needs of the people for material and cultural life and spiritual and cultural aspects [6]. And due to the lack of effective guidance in the process of economic development, this has led to the incongruity of economic development and industrial restructuring. Only through reasonable and effective guidance of industrial structure transformation can we jointly create more wealth for our society.

4. Suggestions for Countermeasures

4.1. Increase the Adjustment of the Three Industrial Structures to Achieve Sustainable Growth of Local Fiscal Revenue

The adjustment of industrial structure refers to the optimization of the change of proportion and proportional relationship within each industry of the secondary and tertiary sectors so as to maintain their relative stability within a certain period of time, thus realizing economic growth and social progress. Firstly, promote the development of the third sector. According to the current situation in China, the service industry is a labor-intensive enterprise. Therefore, we should actively promote the transition from manufacturing to service units, and encourage enterprises to increase their technological research and development and improve the intensity of training of talents to promote the rapid growth of the service industry and the optimization and upgrading of the industrial structure. Secondly, the weak industrial base and backward technology seriously restrict the R&D capability and production efficiency of high-tech products, therefore, it is necessary to vigorously promote the transformation and upgrading of traditional industries and improve the overall competitiveness of enterprises must increase the adjustment of the structure of the three industries;

at the same time, we should also focus on the development of the service industry and expand employment, so that the tertiary industry becomes the most important support point for local economic growth [7].

4.2. Transformation of Economic Development Mode to Achieve Sustainable Growth of Local Fiscal Revenue

Industrial structure adjustment and transformation of economic development mode are the main factors to determine the sustainable growth ability of local fiscal revenue. First, we should adhere to the market-oriented, through the cultivation of new industries to improve product quality and increase technological content. Second, we should support the rapid development of modern service industry and the rising proportion of tertiary industry to promote the division of labor and increase the degree of specialization; Third, fundamentally change the traditional sloppy business model, accelerate the transformation and upgrading and innovation and reform efforts. Fourth, while maintaining stable economic growth, we should also focus on environmental resource protection and governance to strengthen management and improve the construction of ecological civilization.

4.3. Cultivate Diversified Fiscal Revenue Growth Points and Promote Sustainable Growth of Local Fiscal Revenue

At present, there are still many problems for Chinese local governments in the process of industrial restructuring and development, one of which is the lack of effective guidance for enterprises' independent innovation capability. Local government departments in China should actively encourage technological research and development activities and technological transformation projects in a conscious manner [8]. At the same time, through a variety of channels to introduce high-tech to improve product quality and expand market share, thereby enhancing economic efficiency. In addition, it can also increase the investment in high energy-consuming industries to promote local fiscal revenue. The growth points are many but slow, which requires the government to guide enterprises to carry out independent innovation through effective means, thus improving local fiscal revenue and providing a strong financial base for industrial restructuring and development.

Conclusion

Industrial restructuring is an important part of China's economic development and an essential condition for improving people's living standards and livelihood security. In the context of economic globalization, China's industrial structure has been continuously optimized and upgraded. This paper analyzes the relationship between how to achieve industrial transformation and sustainable growth of local fiscal revenue by studying domestic and foreign scholars and makes suggestions for reference. It also combines relevant literature and statistical results to demonstrate whether there is a mutual influence between the two and the effect produced by each one's role, and finally gives corresponding policy recommendations based on the above theoretical and empirical conclusions: improve economic strength and optimize industrial structure; increase the fiscal revenue of local governments to promote economic development.

BIBLIOGRAPHY

- [1] Zhao, J., Jiang, Q.Z., Dong, X.C., Dong, K.Y., and Jiang H.D. (2021). How does industrial structure adjustment reduce CO2 emissions? Spatial and mediation effects analysis for China[J]. *Energy Economics*, (2) pp.12-16.
- [2] Jing, L., Jia, W., and Bo, Z. (2021). Are Industrial Structure Adjustment and Technical Progress Conducive to Environmental Improvement? [J]. *Journal of Global Information Management (JGIM)*, (6) pp.30-33.
- [3] Viet T. Tran, Trung Thanh Nguyen, Nguyet T.M. Tran. Gender difference in access to local finance and firm performance: Evidence from a panel survey in Vietnam[J]. *Economic Analysis and Policy*, 2019(C) pp.63-65.
- [4] Zhu, W.W., Zhu, Y.Q., Lin, H.P., and Yu, Y. (2021). Technology progress bias, industrial structure adjustment, and regional industrial economic growth motivation —— Research on regional industrial transformation and upgrading based on the effect of learning by doing[J]. *Technological Forecasting & Social Change*, pp.170.
- [5] Lee, D. K., and Kim, J.B. (2019). A Preliminary Study for Improvement of Local Finance Adjustment System for a Unified Korea - A Case of Germany -[J]. *Crisis and Emergency Management: Theory and Praxis*, (2) pp.15-18.
- [6] 김철호. (2018). Analysis on Research Trends in the Field of Local Finance: Focusing on the Articles Published in Korean Journal of Local Government Studies (1989-2017) [J]. *Journal of Local Government Studis*, (2) pp.30-33.
- [7] Cui, Q., Hu, Y. X., and Yu, L. T. (2022). Can the aviation industry achieve carbon emission reduction and revenue growth simultaneously under the CNG2020 strategy? An empirical study with 25 benchmarking airlines[J]. *Energy*, (2) pp.245.
- [8] Hany, El Beshlawy, and Sinan Ardroumli. (2021). Ownership control intensity, corporate financial performance and revenue growth since the global financial crisis[J]. *Corporate Ownership & Control*, pp.18-20.



EXPANSION OF TRADE COOPERATION BETWEEN RUSSIA AND MONGOLIA: COMMODITY AND REGIONAL ASPECTS

SHINKAREVA Olga¹, ALEKSEICHEVA Elena²

¹*Cand. Sc. (Economics), Associate Professor, Moscow City University*

²*Doctor of Economics, Moscow City University*



Introduction.

An important condition for ensuring food security and maintaining the entrepreneurial activity of Russian producers is the development of trade relations with partner countries [4, 6]. Such interaction in the past was initiated by market participants themselves and did not always find support at the regional and federal levels of government. Now the authorities and the expert community recognize the need for more active support for collective action in the international market. Inter-regional cooperation is being reoriented to trade and economic partnership with Asian countries and Mongolia is one of the most important.

Materials and Methods. Authors used reports and operational economic statistics of the Federal Customs Service and the Federal Service for Veterinary and Phytosanitary Surveillance (Rosselkhozнадзор). The use of various sources, as well as scientific methods (grouping method, comparison method, tabular and graphic methods, analysis and synthesis, etc.), made it possible to collect information and verify and systematize it, identify certain trends and increase the reliability of the proposed recommendations.

Results and Discussion. An analysis of the current situation in Russian-Mongolian trade shows an uptrend. At the end of 2022, Russian-Mongolian trade increased by almost 42% and reached \$2.6 billion according to estimates by the Ministry of Economic Development of the Russian Federation. It is expected that by the end of 2023 the indicators could reach a historic maximum of \$3 billion. So far, there are no relevant statistical data on commodity groups, but already the data of 2021 demonstrate promising areas of cooperation.

Thus, imports from Mongolia amounted to \$43 million in 2021, an increase of 12.30% compared to 2020. Exports of Russian goods to Mongolia increased even more in 2021, by 31.29%, and amounted to \$1,816 million.

Analyzing Russia's imports from Mongolia in 2021 by commodity groups, it should be noted that the main share in the supply structure (as in 2020), accounted for the following types of goods:

- mineral products - 73.93% of the total import from Mongolia (in 2020 - 81.10%),
- textiles and footwear - 17.00% of the total import volume (in 2020 - 12.13%),
- machinery, equipment and vehicles - 5.12% (in 2020 - 4.84%),
- goods of the agro-industrial sector - 2.80% of the total volume of Russian imports from Mongolia (in 2020 - 1.47%) [6].

Russia's imports from Mongolia in 2021 for the fourteen largest commodity groups are presented in Figure 1.




Figure 1 – Imports of Russia from Mongolia in 2020-2021, by the largest commodity groups, \$ million

Source: by authors based on [6]

The largest segment of imports (salt, sulfur, lands and stone, plaster materials, lime and cement) is stable, and the second one - items of clothing and accessories, knitted machine or hand knitting - shows serious growth. Particularly noteworthy is the explosive dynamics in the category of ferrous metal products.

An analysis of the structure of Russia's exports to Mongolia by commodity groups shows that in 2021 the bulk of supplies accounted for mineral products - 52.26% of the total export to Mongolia (in 2020 - 54.11%), as well as food products and agricultural raw materials - 18.16% (in 2020 - 18.36%). Machinery, equipment and vehicles also took a noticeable place - 10.44% (in 2020 - 9.14%); products of the chemical industry - 7.88% (in 2020 - 7.41%); metals and products from them - 7.37% (in 2020 - 7.52%); wood and pulp and paper products - 1.52% (in 2020 - 0.96%) [6].

The structure of Russia's exports to Mongolia in 2021 is shown in Figure 2.




Figure 2 – Structure of Russia's exports to Mongolia, 2021

Source: by authors based on [6]

If we consider enlarged group of products of the agro-industrial complex, we can see that the export of livestock to Mongolia demonstrates the greatest dynamics. However, the export of livestock to Mongolia itself in absolute terms is not so significant - exports of meat products demonstrate much greater values. This situation should be assessed positively for the Russian economy, meat processing at domestic meat processing enterprises and an increase in the export of meat products is much more economically profitable both for economic entities and for the country as a whole [2]. In terms of grain, the picture is the opposite, the share of finished products from cereal grains and flour, flour confectionery in export is significantly lower than unprocessed cereals. This indicates the available reserves for improving the efficiency of trade turnover.

The growth of exports of meat processing industry products is a common trend for all regional export areas of the Russian Federation. After certain meeting the needs of the country's population for food, agro-industrial enterprises send food and agricultural raw materials for export in order to improve the financial results of management.

According to the Rosselkhoznadzor [3], the export of meat products from the Russian Federation in 2022 increased by 13% compared to 2021. At the same time, beef was exported to 24 countries and exports increased by 9% compared to 2021, pork - to 14 countries and exports increased by 18%. Such a significant increase in pork exports is primarily due to its high quality. Lamb exports were carried out in three countries and its volumes increased 5 times, poultry meat was supplied to 33 countries and exports increased by 24%, meat products were exported to 23 countries and the increase was 4%. These positive changes occurred because of an increase in the export of these products, in addition to Mongolia, to countries such as Vietnam, Iran, China, the United Arab

Emirates, Saudi Arabia, the Republic of Belarus (Figure 3).




Figure 3 - Export of main agricultural products from Russia to Mongolia, 2020-2021

Source: by authors based on [6]

Other processing sectors of the agro-industrial complex are also promising areas for the development of Russia's exports to Mongolia. For example, the intensification of trade relations with Asian and African countries is recorded in the structure of the mineral and drinking water export market. China has the leading position in the 10 months of 2022, 12.6 million liters of mineral and drinking water (17.4%), Turkey is in second place (11.0%), and Mongolia is in third (6.4%), followed by the Republic of Korea (5.7%), Egypt (4.9%), Azerbaijan (4.6%), India (3.6%), etc. [1].

In addition to trade operations, joint projects in promising industries as transport, energy and industrial engineering and tourism are of great importance in the development of cooperation between Mongolia and Russia.

Analyzing the regional aspect of the partnership between Russia and Mongolia, it should be noted that the basis of economic interaction between the two countries is the neighboring regions, with which Mongolia has close historical and geographical ties. For example, the government of Buryatia has a minister for interaction with Mongolia. Partners from Mongolia are invited to participate in the comprehensive investment project "Yenisei Siberia", which is being implemented in the Krasnoyarsk Territory, the republics of Tuva and Khakassia and unites more than 60

companies and 40 business initiatives with an investment portfolio worth over \$41 billion. Such contacts contribute to strengthening production, scientific and technical ties, solving issues of improving the standard of living of the population of both states.

One of the significant areas of partnership the Russian Government considers the creation of the economic corridor "Yenisei Siberia - Mongolia - China", which will contribute to the development of infrastructure for cross-border transportation between Russia, China and Mongolia.

Bulgantuya Khurelbaatar, head of the National Committee for the Restoration of Border Crossings of Mongolia, co-chairman of the subcommittee on regional and cross-border cooperation of the Russian-Mongolian intergovernmental commission on trade, economic, scientific and technical cooperation, positively assesses the development of ties between countries, including at the regional level. Mongolia is generally satisfied with the implementation of the medium-term Program of Action for the Development of Interregional Cooperation for 2021-2025. However, according to Mongolia, which positions itself as a Central Asian country with a convenient transport and logistics infrastructure for goods passing through its territory, border trade with Russia is largely hindered by high import tariffs of the Russian Federation

Conclusions.

In the emerging new realities, Russia needs new markets, in turn, Mongolia is ready to increase exports to Russia in the event of the elimination of tariff and non-tariff barriers to trade with neighboring friendly countries. One of the possible solutions to the problem may be a deeper interaction of states within the framework of the Shanghai Cooperation Organization.

REFERENCES

- Import and export of soft drinks. Results of 10 months of 2022. Russian food market. №1. 2023. Retrieved from: URL: <https://foodmarket.spb.ru/search/222655>
- Magomedov M.D. Conditions for increasing the export of meat and meat products of the Russian Federation. Meat industry. 2023. № 54.
- Rosselkhoznadzor. At the end of 2021, Russia exported record volumes of beef, pork, horse meat and finished meat products. Retrieved from: <https://fsvps.gov.ru/ru/fsvps/news/46802.html>
- Shinkareva O. V., Rakhmonov E. F., Erokhin S. G. [and others]. Risks of small and medium-sized businesses when countries join the Eurasian Economic Union (EAEU). Bulletin of the Catherine Institute. 2022. № 4(60). P. 119-124.
- Sokolova E. S., Leontieva L. S., Shkarina V. S. The prospects of Russia-China technology exchange partnership and digitalization: current trends and future prospects. Research Result. Economic Research. 2022. Vol. 8, No. 2. P. 13-22. – DOI 10.18413/2409-1634-2022-8-2-0-2.
- Trade between Russia and Mongolia in 2021. Federal customs service data. Retrieved from: <https://russian-trade.com/reports-and-reviews/2022-02/torgovlya-mezhdu-rossiy-i-mongoliev-v-2021-g/>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

THE EFFECT OF NATURAL RESOURCE ON ECONOMIC GROWTH
IN TRANSITION ECONOMIES

D.Enkh-Amgalan

Master, National University of Mongolia



Keywords:

transition economies,
corruption, institution,
natural resource

Abstract:

Natural resources did make some contribution to economic growth in transition economies. In this article, indicators are for countries with economies in transition, dividing them into FSU1, FSU2, Eastern Europe, Central Europe and the Baltics including Mongolia. Mongolia is just one democratic country sandwiched between China and Russia, two of the world's largest bureaucracies.

Our results reaffirm those of Brunschweiler (2009a, 2009b) and Aleexev et al (2010), as natural resource abundance promotes economic growth but reduces institutional quality for transition economies.

Introduction

Numerous literatures have investigated effect of different natural resources on economic growth. Using the share of primary exports to GDP as a measure of natural resources intensity, found a negative relationship between the abundance of natural resources and economic growth in a large cross-country study (Sachs et al. 1995). Point source countries and countries dependent on coffee/cocoa exports showed weak growth and were slower than resource-poor countries in cross-country assessments with institutional quality control, and its reliability was confirmed (Gylfason et al 1999, Leite et al. 1999, Sachs et al. 2001). Sala-i-Martin and Subramanian (2003) found that natural resources are not significantly related to economic growth when institutional quality is controlled. Fuel and mineral resources have a negative impact on institutions.

Brunnschweiler (2009a) used World Bank data on per capita natural resource wealth and found a positive empirical relationship between natural resource abundance and economic growth over the period 1970-2000 using institutional quality. In addition, Brunnschweiler (2009b) conducted group assessments and found that oil had a positive effect on economic growth during the period 1996–2006 in 27 transition countries. Alekseev et al. (2011) found an insignificant positive relationship between natural resources and economic growth in transition countries.

There have also been numerous studies on the influence of natural resources on institutional quality. Institutions are the main driver for natural resource management and growth. When institutions are "grabber-friendly", resources reduce income, while resources of "manufacturer-friendly" institutions increase income (Mehlum et al. 2006, Ploeg 2011). Natural resources are a

curse only in countries with poor institutions. The export of natural resources does not crowd out the manufacturing sector in post-Soviet countries with a sufficiently high institutional quality, then countries with a low institutional quality suffer from the curse of natural resources (Roman et al. 2016). Boschini et al (2012) assessed the negative relationship between natural resource intensity and economic growth, which can be reversed if institutional quality is high enough. They used four main components of primary exports: agricultural raw materials, food exports, fuels, ores and metals, and components of the total resource rent: forestry, fuels and minerals.

There are numerous papers examined the effects of natural resources on economic growth, then others examined the relationship between natural resources, institution and economic growth for particular countries. I re-examined the relationship for over all countries and for transition countries including Mongolia. Mongolia is only one democratic country sandwiched country between China and Russia, two biggest bureaucrat countries in World.

The primary and food exports in GDP are negative and statistically significant in resource abundant developing economies. However, we found that control of corruption had significantly negative mineral exports such as fuel and ores exports in GDP over the period 1996-2018 in transition economies. Fuel exports in GDP have a positive effect on economic growth, both in the least squares (OLS) and two-stage least squares (2SLS) methods.

This paper is organized as follows: Section 2 presents the data and the estimation approach; Section 3 shows the estimation results; Section 4 provides discussions, Section 5 provides conclusions, and Section 6 provides references.

Data and estimation approach

Our main focus is the transition 27 countries and we included 87 countries of developed and developing countries, which are used in the literature by Mehlum et al. 2006 due to improve results of estimations. The transition countries consist of twelve countries of the Commonwealth of Independent States (CIS) and Mongolia, three Baltic countries (BALT), five countries of Central Europe (CE) and six countries of Southeast Europe (SEE). CIS comprises FSU1, and FSU2. More detailed indicators are provided in the Appendix A.

Our resource variables are the primary exports in GDP, its decomposed data which are agricultural raw materials, food exports, fuels, and ores and metals. Figure 1 shows that between 1996 and 2018 the share of primary exports in GDP in transition countries and over the last 2 decades of transition, the share of primary exports in GDP has not changed significantly, with the exception of Mongolia and FSU2. However, agricultural and food exports as a share of GDP declined slightly in the former FSU2 and Mongolia, and increased slightly in other transition economies over the period.

Our institution variable is control of corruption for 1996, 2000, 2005, 2010, 2015. Figure 2 shows the time paths of corruption control in transition countries for 1996–2018, and over the past twenty years, corruption control in transition countries has evolved differently.

After 2010, the average level of control over corruption in the Baltic countries was the best, but, nevertheless, several countries of FSU2 still remain among the lowest among the countries in transition. Corruption control for 1996–2018 ranged from -1.54 in Turkmenistan to +1.51 in Estonia. Average corruption control scores in the countries of FSU2 (7 countries) fell to a low of -

1.17 in 2010 and then peaked at -0.90 in 2018. Overall, average corruption control scores in Central Europe and the Baltics are better than in the countries of FSU and Southeastern Europe. Between 1996 and 2018, the control of corruption in the Baltic countries increased from 0.22 to 0.77, in the countries of Southeast Europe it increased from -0.61 to -0.26, and in the countries of FSU it increased from -0.92 to -0.41. Georgia, for which corruption control changed from negative (-1.52) to positive (0.70), is the only country in FSU. In contrast, control of corruption changed from positive (0.11) to negative (-0.43) for Mongolia over the periods 1996–2018. Twenty-five years later, corruption control in Estonia was closer to that of Japan, while in Georgia and Poland it was similar to Spain. However, corruption control in Tajikistan, Turkmenistan and Uzbekistan was closer to the Congo, Dem. Republic and Chad and Cameroon respectively.

2.1. OLS estimation

$$g_i = \alpha_0 + \alpha_1 TR_i + \alpha_2 R_i + \alpha_3 TR_i \times R_i + \alpha_4 I_i + \varepsilon_i \quad (1)$$

Here g is the GDP per capita growth rate averaged over the period 1996-2018, i are different countries, TR is a dummy variable equal to one if the country is in transition, and zero otherwise. R is a natural resource, I is corruption control, and ε is a random error. All major regressions include GDP per capita in 1990 PPP (constant 2005 international dollars), and the transition from a planned to a market economy began in the early 1990s. A more detailed description and our sources of these variables are given in Appendix B.

Transition economies such as Belarus, Bosnia and Herzegovina, Tajikistan, Turkmenistan and Uzbekistan are excluded from the sample due to lack of data. We include the logarithm of initial GDP per capita in our regressions to control the convergence of GDP per capita. Tables 1 and 2 illustrate the results of the OLS evaluation.

Table 1. OLS regressions: natural resources, and institution

	Primary exports in GDP for 1996					Primary exports in GDP for 2000				
	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15	(6) con96	(7) con00	(8) con05	(9) con10	(10) con15
Primgdp	-3.53** (1.29)	-3.55** (1.30)	-3.45** (1.30)	-3.44** (1.28)	-3.44** (1.25)	-1.99* (0.99)	-1.95. (1.01)	-1.91. (1.01)	-1.88. (0.99)	-1.88. (0.98)
TR*primgdp	3.24 (2.94)	3.17 (2.99)	3.16 (3.10)	3.42 (3.12)	4.70 (3.10)	1.96 (1.94)	2.04 (2.01)	2.07 (2.18)	2.58 (2.26)	3.97. (2.12)
I	0.23 (0.20)	0.24 (0.20)	0.30 (0.22)	0.39. (0.20)	0.46* (0.19)	0.36. (0.19)	0.24 (0.20)	0.41. (0.21)	0.49* (0.20)	0.53** (0.19)
TR*I	-0.68. (0.38)	-0.54 (0.41)	-0.40 (0.45)	-0.31 (0.46)	0.08 (0.45)	-0.78. (0.40)	0.69 (0.44)	-0.62 (0.48)	-0.46 (0.50)	0.02 (0.46)
TR	1.75** (0.56)	1.83** (0.56)	1.93*** (0.56)	1.96*** (0.55)	1.82*** (0.55)	2.12*** (0.47)	2.16*** (0.48)	2.23*** (0.48)	2.22*** (0.48)	2.05*** (0.48)
initial income	-0.49** (0.16)	-0.51** (0.17)	-0.56** (0.18)	-0.63** (0.18)	-0.67*** (0.17)	-0.57** (0.16)	-0.59** (0.17)	-0.63*** (0.18)	-0.67*** (0.17)	-0.70*** (0.16)
number of countries	96	96	96	96	96	105	105	105	105	105
R ² -adj	0.40	0.39	0.39	0.40	0.42	0.44	0.44	0.44	0.45	0.46

Notes: Dependent variable is GDP per capita growth. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B.

Table 2. OLS regressions: natural resources, and institution

	Decomposed primary exports in GDP for 1996					Decomposed primary exports in GDP for 2000				
	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15	(6) con96	(7) con00	(8) con05	(9) con10	(10) con15
Fuelgdp	-2.73 (1.95)	-2.70 (1.96)	-2.40 (1.94)	-1.81 (1.92)	-1.70 (1.84)	-0.94 (1.53)	-0.82 (1.57)	-0.71 (1.55)	-0.42 (1.50)	-0.33 (1.44)
TR*fuelgdp	13.16. (7.45)	14.38. (7.41)	16.60* (7.71)	19.40* (8.00)	20.79** (7.42)	3.35 (2.98)	3.64 (3.04)	4.84 (3.29)	6.03. (3.38)	7.53* (3.13)
Oresgdp	-4.55 (4.42)	-4.96 (4.46)	-5.53 (4.47)	-6.26 (4.39)	-6.48 (4.28)	0.89 (4.24)	0.29 (4.28)	-0.12 (4.29)	-0.51 (4.21)	-0.46 (4.10)
TR*oresgdp	-6.39 (9.15)	-6.13 (9.31)	-3.96 (9.70)	-0.88 (9.72)	2.25 (9.60)	-5.04 (5.43)	-4.10 (5.50)	-2.75 (5.50)	-1.48 (5.44)	-0.35 (5.27)
Agrigdp	-3.77 (6.27)	-3.91 (6.30)	-3.85 (6.25)	-4.41 (6.13)	-5.21 (6.01)	-10.08. (5.42)	-10.29. (5.46)	-10.90* (5.48)	-11.19* (5.33)	-11.88* (5.22)
TR*agrigrdp	30.21 (15.78)	29.45. (15.91)	26.75. (15.91)	24.80 (15.57)	20.78 (15.55)	15.82 (9.92)	15.00 (9.91)	14.53 (9.76)	14.26 (9.58)	13.57 (9.37)
Food	-4.19. (2.24)	-4.14. (2.25)	-4.02. (2.24)	-4.44 (2.19)	-4.35* (2.14)	-2.63 (1.88)	-2.36 (1.89)	-2.13 (1.89)	-2.30 (1.85)	-2.38 (1.81)
TR*food	-5.06 (9.87)	-4.78 (9.94)	-5.53 (9.86)	-4.66 (9.65)	-3.40 (9.47)	-1.72 (4.80)	-1.90 (4.86)	-1.34 (4.99)	-0.38 (4.90)	1.83 (4.89)
TR	1.56* (0.71)	1.60* (0.72)	1.66* (0.71)	1.63* (0.70)	1.46* (0.68)	2.18*** (0.51)	2.25*** (0.51)	2.24*** (0.52)	2.22*** (0.50)	1.99*** (0.50)
I	0.29 (0.21)	0.31 (0.22)	0.41. (0.24)	0.55* (0.22)	0.60** (0.21)	0.49* (0.22)	0.52* (0.23)	0.59* (0.24)	0.69** (0.23)	0.73** (0.21)
TR*I	-0.55 (0.42)	-0.42 (0.45)	-0.16 (0.52)	0.08 (0.54)	0.33 (0.50)	-0.78. (0.43)	-0.67 (0.46)	-0.37 (0.54)	-0.11 (0.53)	0.29 (0.49)
Initial income	- 0.56** (0.19)	- 0.60** (0.21)	-0.69** (0.22)	- 0.81*** (0.21)	-0.83*** (0.19)	- 0.74*** (0.19)	- 0.79*** (0.21)	- 0.85*** (0.22)	- 0.93*** (0.20)	-0.95*** (0.18)
Number of countries	94	94	94	94	94	103	103	103	103	103
R ² -adj	0.41	0.41	0.41	0.44	0.46	0.46	0.46	0.46	0.48	0.50

Notes: Dependent variable is GDP per capita growth. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B

2.2. 2SLS estimation

Corruption control in OLS estimates can suffer from endogeneity and we use the instrumental variable method. Instrumental variables should be correlated with corruption control but not correlated with error. Tables 3 and 4 present the OLS regressions for Equation 2, which is our first step in control of corruption.

There are a number of research papers such as Beck et al. 2006, Brunnschweiler 2009, Arthur et al 2001, Boschini 2012, Acemoglu 2001, Sala-I-Martin, 2003, who used instruments such as the natural logarithm of the adult mortality rate in the early 19th century, latitude, state, mean annual temperature in degrees Celsius, the proportion of land within 100 km of the sea coast, a dummy variable of the 1960s–1980s war, which are also taken into account in our estimates. We ended up using exogenous components of corruption control explained only by latitude.

We have

$$I_i = \beta_0 + \beta_1 R_i + \beta_2 TR_i \times R_i + \beta_3 Z_i + \beta_4 X_i + v_i \quad (2)$$

where I is the control of corruption, now the dependent variable, R is the natural resource, Z is instrument such as latitude, X is control variable such as initial per capita GDP in purchasing power parity terms and TR is a dummy variable for transition countries, and zero otherwise and v is the random error term. This equation examines to test whether natural resources have a negative effect on institutions.

Table 3. First stage: Instrumenting for institution

Dep var is con	Primary exports in GDP, in 1996					Primary exports in GDP, in 2000				
	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15
Latitude	2.17*** (0.54)	2.08*** (0.52)	1.79*** (0.48)	1.96*** (0.52)	2.11*** (0.54)	2.07*** (0.50)	1.95*** (0.47)	1.69*** (0.44)	1.80*** (0.47)	1.93*** (0.50)
TR*lat	-0.12 (2.32)	-0.42 (2.20)	-0.05 (2.06)	-0.66 (2.19)	-0.23 (2.29)	-0.85 (1.99)	-0.82 (1.86)	-0.74 (1.78)	-1.21 (1.88)	-0.75 (1.96)
Primgdp	-0.51 (0.71)	-0.48 (0.68)	-0.63 (0.63)	-0.29 (0.67)	-0.09 (0.70)	-0.86 (0.59)	-0.91 (0.55)	-0.89 (0.53)	-0.74 (0.56)	-0.58 (0.59)
TR*primgdp	0.37 (1.60)	-0.05 (1.51)	-0.48 (1.42)	-1.15 (1.50)	-1.86 (1.57)	-0.39 (0.99)	-0.39 (0.93)	-0.73 (0.89)	-1.13 (0.93)	-1.14 (0.98)
TR	-1.22 (1.25)	-0.98 (1.19)	-0.87 (1.11)	-0.53 (1.18)	-0.53 (1.23)	-0.65 (1.10)	-0.66 (1.03)	-0.46 (0.98)	-0.20 (1.04)	-0.31 (1.09)
initial income	0.46*** (0.07)	0.51*** (0.07)	0.54*** (0.06)	0.52*** (0.07)	0.47*** (0.07)	0.44*** (0.06)	0.51*** (0.06)	0.53*** (0.06)	0.51*** (0.06)	0.46*** (0.06)
Number of countries	95	95	95	95	95	103	103	103	103	103
R ² -adj	0.64	0.68	0.71	0.68	0.64	0.66	0.72	0.73	0.70	0.66

Notes: Dependent variables in first stage are control of corruption for 1996, 2000, 2005, 2010 and 2015. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B.

Table 4. First stage: Instrumenting for control of corruption for 1996, 2000, 2005, 2010, and 2015

Decomposed primary exports in GDP, in 1996						Decomposed primary exports in GDP, in 2000				
Dep var is con	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15
Latitude	1.86*** (0.52)	1.76*** (0.50)	1.47** (0.46)	1.59** (0.48)	1.74** (0.51)	1.77*** (0.46)	1.63*** (0.42)	1.39*** (0.40)	1.50*** (0.42)	1.63** (0.45)
TR*latitude	-0.06 (2.36)	-0.94 (2.23)	-0.85 (2.08)	-1.49 (2.16)	-1.40 (2.31)	-2.11 (1.93)	-1.99 (1.75)	-1.45 (1.67)	-2.03 (1.77)	-1.58 (1.88)
Fuelgdp	-2.46* (0.95)	-2.42** (0.90)	-2.35** (0.84)	-2.51** (0.88)	-2.31* (0.93)	- (0.66)	- (0.60)	- (0.58)	- (0.61)	-2.23*** (0.65)
TR*fuelgdp	-6.14. (3.51)	-4.87 (3.31)	-4.61 (3.08)	-5.46. (3.21)	-4.76 (3.44)	-0.40 (1.25)	-0.17 (1.13)	-0.79 (1.08)	-1.17 (1.14)	-1.05 (4.59)
Oresgdp96	2.50 (2.20)	3.57. (2.08)	3.86* (1.94)	4.24* (2.02)	4.23. (2.16)	1.94 (2.16)	3.35. (1.96)	3.68. (1.87)	4.16* (1.97)	4.17. (2.10)
TR*oresgdp	-0.33 (4.72)	-3.72 (4.45)	-6.40 (4.14)	-7.85. (4.32)	-8.97. (4.62)	-4.12 (2.71)	-5.49* (4.46)	-5.14* (2.35)	-5.99* (2.48)	-5.89* (2.63)
Agrigdp96	1.96 (3.14)	2.20 (2.96)	1.43 (2.75)	2.11 (2.87)	3.26 (3.07)	4.62 (2.49)	4.78* (2.26)	5.10* (2.16)	4.58* (2.28)	5.11* (2.43)
TR*agrigrdp	1.73 (8.37)	3.46 (7.90)	5.17 (7.35)	4.90 (7.66)	6.51 (8.20)	2.33 (4.71)	1.46 (4.28)	-1.48 (4.09)	-0.94 (4.31)	-1.05 (4.59)
Food	0.47 (1.14)	0.18 (1.08)	-0.15 (1.00)	0.76 (1.04)	0.61 (1.12)	1.25 (1.10)	0.90 (1.00)	0.36 (0.95)	0.95 (1.01)	1.20 (1.07)
TR*food	-1.36 (4.98)	1.64 (4.69)	1.40 (4.37)	-0.98 (4.55)	-2.25 (4.87)	-1.99 (2.34)	-1.80 (2.12)	-1.77 (2.03)	-2.27 (2.14)	-3.55 (2.28)
TR	-0.92 (1.25)	-0.56 (1.18)	-0.34 (1.10)	0.11 (1.15)	0.22 (1.23)	0.12 (1.05)	0.09 (0.96)	0.07 (0.91)	0.39 (0.96)	0.32 (1.02)
initial income	0.55*** (0.07)	0.61*** (0.07)	0.64*** (0.06)	0.63*** (0.07)	0.58*** (0.08)	0.57*** (0.06)	0.64*** (0.06)	0.65*** (0.06)	0.64*** (0.06)	0.59*** (0.06)
Number of countries	93	93	93	93	93	101	101	101	101	101
R ² -adj	0.68	0.73	0.75	0.73	0.68	0.72	0.78	0.78	0.77	0.72

Notes: Dependent variables in first stage are control of corruption for 1996, 2000, 2005, 2010 and 2015. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B.

Estimation results

Tables 1 to 6 present the results of the OLS and 2SLS estimates.

3.1 Results of OLS

Table 1 shows the results of OLS where used primary exports in GDP. Primary exports in GDP are negative and statistically significant in countries other than those in transition. But the interaction between the transition dummy and primary exports in GDP is not statistically significant. In all

estimates, the coefficients of dummy transitions are positive. In all assessments, the variables of control of corruption were positive and statistically significant, but their interaction with the transition dummy was negative, weakly significant.

Coefficients of initial income were significantly negative, convergence applies in all countries, and the coefficients of convergence range from -0.49 percent to -0.70 percent.

Table 2 shows the results of the OLS, which used decomposed data on primary exports in GDP. Fuel exports to GDP were negative and statistically insignificant. But their interactions with the transition dummy are positive and statistically significant. Ore exports to GDP and their relationship to the transition dummy are negative and not statistically significant. Agricultural exports to GDP were negative and statistically significant. But their interactions with the transition dummy are positive and not statistically significant. Food exports to GDP were negative and statistically significant, and their interaction with the transition dummy was mostly negative and not statistically significant. In all assessments, the corruption control variables were not statistically significant. The coefficients of transition dummy in all regressions are positive. Initial income coefficients were significantly negative, with convergence rates ranging from -0.56 percent to -0.95 percent.

3.2 Results of 2SLS

The 2SLS results are presented in Table 5 using primary exports in GDP for 1996 and 2000, and Table 3 presents the corresponding first stage regressions for institutions. Primary exports in GDP was negative and statistically significant, but its interaction with the transition dummy is positive and not statistically significant in all regressions. Control of corruption for 1996, 2000, 2005, 2010 and 2015 was positive and not statistically significant in all regressions. Their interaction with the transition country dummy was negative and not statistically significant. The transition country's dummy coefficients are significant and positive in all regressions. Thus, average growth in transition countries was higher than in other countries. Initial income coefficients are negative and statistically insignificant in all regressions. As shown in Table 3, latitude and initial income are positive and significant in all regressions, and all other variables are not significant.

The results of 2SLS are presented in Table 6, which used decomposed primary exports in GDP for 1996 and 2000, and Table 4 presents the corresponding regressions of the first stage for control of corruption. Food exports in GDP were negative and statistically significant, but its interaction with the transition dummy is negative and not statistically significant in all regressions. All other decomposed primary export variables such as fuel exports, ore exports, and agricultural exports in GDP and their interaction with the transition dummy were not statistically significant in all regressions. The dummy variable for transition economies was positive and statistically significant. As shown in Table 4, latitude and initial income were both positive and significant in all regressions. Fuel and ore exports in GDP were significantly negative in the transition countries.

Table 5. 2SLS growth regressions

	Primary exports in GDP for 1996					Primary exports in GDP for 2000				
	(1) con96	(2) con00	(3) con05	(4) con10	(5) con15	(6) con96	(7) con00	(8) con05	(9) con10	(10) con15
Primgdp196	-3.64* (1.48)	-3.64* (1.48)	-3.60* (1.54)	-3.68* (1.42)	-3.72** (1.37)	-3.17* (1.36)	-3.16* (1.39)	-3.14* (1.42)	-3.18* (1.36)	-3.22* (1.30)

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

TR*primgdp196	3.75 (3.40)	3.78 (3.65)	3.80 (3.95)	3.94 (4.38)	3.98 (4.44)	3.55 (3.49)	3.54 (3.54)	3.46 (3.99)	3.35 (4.79)	3.50 (4.03)
I	0.18 (0.48)	0.19 (0.50)	0.22 (0.57)	0.21 (0.52)	0.19 (0.48)	0.20 (0.48)	0.21 (0.51)	0.23 (0.59)	0.22 (0.55)	0.21 (0.51)
TR*I	-0.11 (1.04)	-0.10 (1.07)	-0.11 (1.02)	-0.10 (1.16)	-0.11 (1.05)	-0.44 (1.26)	-0.42 (1.20)	-0.43 (1.23)	-0.47 (1.45)	-0.44 (1.24)
TR	1.84* (0.75)	1.85* (0.73)	1.85* (0.73)	1.82* (0.69)	1.79* (0.72)	1.92** (0.61)	1.94** (0.64)	1.98** (0.67)	1.97** (0.67)	1.97** (0.70)
Lngdp90wb	-0.48 (0.33)	-0.50 (0.36)	-0.51 (0.41)	-0.51 (0.38)	-0.48 (0.33)	-0.48 (0.32)	-0.49 (0.36)	-0.50 (0.42)	-0.50 (0.39)	-0.48 (0.34)
number of countries	94	94	94	94	94	103	103	103	103	103
R ² -adj	0.38	0.38	0.39	0.39	0.40	0.46	0.45	0.45	0.45	0.45

Notes: Dependent variable is per capita GDP growth. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B

Table 6. 2SLS growth regressions

	Decomposed primary exports in GDP for 1996					Decomposed primary exports in GDP for 2000				
	(1) Con96	(2) con00	(3) con05	(4) concor10	(5) concor15	(6) con96	(7) con00	(8) con05	(9) con10	(10) con15
Fuelgdp	-3.27 (2.77)	-3.27 (2.87)	-3.27 (3.10)	-3.21 (3.13)	-3.22 (2.92)	-1.96 (2.33)	-1.87 (2.49)	-1.82 (2.66)	-1.88 (2.50)	-1.92 (2.29)
TR*fuelgdp	9.91 (12.03)	9.79 (12.57)	9.95 (12.77)	8.02 (15.88)	8.90 (14.34)	3.61 (6.56)	3.89 (5.91)	3.92 (6.16)	3.59 (7.66)	3.84 (6.30)
Oresgdp	-4.16 (4.64)	-4.31 (4.69)	-4.38 (5.32)	-4.48 (5.40)	-4.52 (5.31)	-2.06 (4.71)	-2.50 (5.04)	-2.72 (5.35)	-2.82 (5.43)	-2.79 (5.27)
TR*oresgdp	-6.93 (9.44)	-8.69 (10.73)	-10.60 (13.52)	-11.95 (15.72)	-12.85 (16.87)	-2.51 (8.32)	-1.82 (8.58)	-1.21 (8.03)	-1.37 (8.90)	-1.31 (8.01)
Agrigdp	-3.47 (6.43)	-3.52 (6.53)	-3.40 (6.52)	-3.54 (6.66)	-3.75 (6.90)	-8.82 (6.13)	-8.97 (6.31)	-9.22 (6.80)	-9.01 (6.43)	-9.17 (6.38)
TR*agrigrdp	31.95. (16.65)	32.83 (17.40)	33.19. (18.34)	33.68. (18.62)	36.84. (21.39)	15.68 (12.06)	14.84 (10.85)	13.93 (9.84)	13.73 (9.81)	14.30 (9.95)
Food	-4.18. (2.28)	-4.14. (2.32)	-4.08. (2.37)	-4.24. (2.34)	-4.23. (2.37)	-5.02* (2.32)	-4.96* (2.35)	-4.81* (2.34)	-4.99* (2.37)	-5.08* (2.39)
TR*food	-5.51 (10.16)	-3.64 (10.39)	-4.19 (10.37)	-5.31 (10.40)	-6.56 (11.04)	0.27 (6.58)	0.25 (6.64)	0.06 (6.93)	0.08 (7.53)	-0.08 (8.04)
TR	1.48. (0.85)	1.46 (0.90)	1.62. (0.89)	1.71. (0.90)	1.80. (0.98)	1.88** (0.64)	1.93** (0.66)	2.01** (0.69)	1.99** (0.68)	2.00** (0.75)
I	0.15 (0.57)	0.15 (0.61)	0.16 (0.75)	0.16 (0.70)	0.17 (0.64)	0.25 (0.58)	0.27 (0.63)	0.31 (0.75)	0.30 (0.70)	0.29 (0.62)
TR*I	-0.83 (1.00)	-0.94 (1.19)	-0.95 (1.22)	-1.06 (1.43)	-1.07 (1.45)	-0.76 (1.67)	-0.68 (1.50)	-0.63 (1.34)	-0.70 (1.63)	-0.66 (1.37)
Initial income	-0.45 (0.43)	-0.46 (0.50)	-0.46 (0.60)	-0.48 (0.57)	-0.47 (0.50)	-0.61 (0.46)	-0.64 (0.53)	-0.66 (0.61)	-0.65 (0.57)	-0.64 (0.49)

Number of countries	92	92	92	92	92	100	100	100	100	100
R ² -adj	0.40	0.38	0.38	0.36	0.35	0.47	0.47	0.47	0.47	0.46

*Notes: Dependent variable is per capita GDP growth. Standard errors in parentheses. * ** *** statistically significant at 10%, 5%, and 1% levels, respectively. Variable sources and detailed descriptions are given in Appendix B.*

Discussions

A substantial number of articles such as Sachs, 1995, 1999, 2001, Auty (1997, 2001), Gylfason, 2001, Ross (2001), Stijns (2003), Kronenberg (2004), Collier and Hoeffler (2005), Mehlum, 2006, Boschini, 2009 present that resource abundance reduces long-term economic growth and quality institutions, at least in developing countries. According to our assessment, as in the papers cited above, primary exports in GDP are negative and statistically significant in other countries. However, the relationship between economic growth and primary exports in GDP is not statistically significant in transition economies using the OLS estimate. The relationship between economic growth and fuel exports in GDP is positive and statistically significant when using decomposed data on primary exports in GDP in transition economies.

Sala-i-Martin and Subramanian (2003) found that natural resources are not significantly related to economic growth, control of institutional quality and fuel and mineral resources negatively affects institutions. Brunnschweiler (2009) found a strong positive relationship between oil wealth and growth in transition economies using a panel of 27 countries. However, Brunnschweiler (2009) and Alexeev et al (2010) used new measures of natural resource abundance. Our findings on the impact of natural resources on economic growth are similar to those of Alexeev et al (2010) and Sala-i-Martin and Subramanian (2003, 2013).

We found that natural resource exports such as oil and minerals have a detrimental effect on the control of corruption when using 2SLS in transition economies. The relationship between control of corruption and natural resources such as oil and minerals were negative and statistically significant when using instrumental approach.

We have found that the export of natural resources, such as oil and minerals, has a detrimental effect on the control of corruption when using 2SLS in transition countries. The relationship between corruption control and natural resources such as oil and minerals was negative and statistically significant when using the instrumental approach.

Conclusions

We examined the effects of natural resources and control of corruption on economic growth using OLS and 2SLS. We did not find a significant negative impact of primary exports in GDP and institutions on economic growth, and fuel exports in GDP were positive and statistically significant over the period 1996–2018 using OLS in transition economies. In addition, we found that natural resources, such as fuel and ore exports in GDP, have a negative impact on control of corruption in transition economies. Our results show that poor institution has a negative effect on long-term growth in transition countries. The positive results of fuel exports in GDP are maintained both in the least squares (OLS) and two-stage least squares (2SLS) estimations.

REFERENCES

- Acemoglu, D., Johnson, S and Robinson, J., 2001. 'The colonial origins of comparative development: An empirical investigation', *American Economic Review*, 91(5): 1369-1401.
- Alexeev, M and Conrad, R., 2011. 'The natural resource curse and economic transition', *Economic Systems*, 35(4): 445-461
- Beck, T and Laeven, L., 2006. 'Institution building and growth in transition economies', *Journal of Economic Growth*, 11: 157-186
- Boschini, A., Pettersson, J and Roine, J., 2012. 'Resource Curse and its Potential Reversal', *World Development*, 43(1): 19-41.
- Brunnschweiler, C. N and Bulte, E, H., 2008. 'The resource curse revisited and revised: A tale of paradoxes and red herrings', *Journal of Environmental Economics and Management*, Elsevier, 55(3): 248-264
- Brunnschweiler, C. N., 2009. 'Cursing the Blessings? Natural Resource Abundance, Institutions, and Economic Growth', *World Development*, Elsevier, 36(3): 399-419
- Brunnschweiler, C., 2009. 'Oil and growth in transition countries', *Economics Working Paper Series*, No. 09/108, Center of Economic Research, Oxford
- Bulte, E. H, Damania, R and Deacon, R. T., 2005. 'Resource Intensity, Institutions, and Development', *World Development*, 33(7): 1029-1044
- Gylfason, T, Herbertsson, T. T and Zoega G., 1999. 'Natural Resources and Economic Growth', *Macroeconomic Dynamics*, 3: 204-225
- Gylfason, T., 2001. 'Natural resources, education, and economic development', *European economic review*, 45: 847-859
- Isham, J, Woolcock, M, Pritchett, L and Busby, G., 2005. 'The Varieties of Resource Experience: Natural Resource Export Structures and the Political Economy of Economic Growth', *World Bank Economic Review*, 19(2); 141-174
- Kronenberg, T., 2004. 'The curse of natural resources in the transition economics', *The Economics of Transition*, 12(3): 399-426, The European Bank for Reconstruction and Development
- Leite, C and Weidman, J., 1999. 'Does Mother Nature Corrupt? Natural Resources, Corruption, and Economic Growth', *Working Paper Series*, International Monetary Fund
- McArthur, J. W and Sachs, J. D., 2001. 'Institutions and Geography: Comment on Acemogly, J and Robinson (2000)', *Working Paper Series*, No. 8114, NBER
- Mehlum, H, Moene, K, O and Torvik, R., 2006. 'Cursed by Resources or Institutions?', *World economy*, 29(8): 1117-1131
- Ploeg, F., 2011. 'Natural Resources: Curse or Blessing?', *Journal of Economic Literature*, 49(2): 366-420
- Roman, H and Zeynalov, A., 2016. 'Natural resources, manufacturing and institutions in post-Soviet countries', *Resource Policy*, Elsevier, 50(C): 141-148
- Sachs, J. D and Warner, A. M., 1995. 'Natural Resource Abundance and Economic Growth', *Working Paper Series*, No. 5398, NBER
- Sachs, J. D and Warner, A. M., 2001. 'The curse of natural resources', *European Economic Review*, 45:827-838
- Sala-I-Martin, X and Sabramanian, A., 2003. 'Addressing the Natural Resource Curse: An Illustration from Nigeria', *Working Paper Series*, International Monetary Fund



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛ ДАХЬ ЦАХИМ БАНК ХЭРЭГЛЭГЧДИЙН ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА

Б.Тулга¹, Э.Тамир²

¹Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, tulga.b@ufe.edu.mn

²Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, tamir.e@ufe.edu.mn



Түлхүүр үг:

Дижитал шилжилт,
Цахим банк, Хэрэглэгчийн
хүртээмж

Хураангуй

Энэхүү өгүүлээр дижитал шилжилт, цахим банк, хэрэглэгчдийн хүртээмжийн холбоосыг ойлгохыг зорилоо. Дэлхий дахинд өрнөж буй аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалаас илүү өгөөж хүртэх нийгэм, эдийн засгийн хөгжлийг дараагийн шатанд гаргахын тулд дижитал шилжилтэд анхаарал тавьж буй ч шилжилтийн үр дүн улс орон бүрт харилцан адилгүй явагдаж байна. Монгол Улсын хувьд банкны салбарын өрсөлдөөнийг илүү хүчтэй болгож санхүүгийн үйлчилгээг технологийн дэвшилтэй хослуулан хэрэгжүүлж программ хангамжийн хөгжүүлэлтэд хамгийн их хөрөнгө оруулж байна. Технологи хөгжихийн хэрээр мэдлэг нэмэгдэж, санхүүгийн зуучлагч байгууллагууд харилцагчдынхаа технологийн болон дижитал мэдлэг, цахим банкны хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэрэглэгчид юу хүсэж байгааг болон хэрэглэхэд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг ойлгох шаардлагатай болж байна. Иймд судалгаагаар цахим банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжид нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох ба цахим банк хүртээмжийг нэмэгдүүлэх арга замыг тайлбарлахад чиглэсэн болно.

Удиртгал

Өсөн нэмэгдэж буй даяаршил, ширүүн өрсөлдөөн, технологийн хөгжлийг дагаад худалдаа, хөрөнгө оруулалтын орчин олон жилийн туршид эрс өөрчлөгдсөөр ирлээ. Өнөөдөр интернетийн үйлдэл бүх төрлийн үйл ажиллагаанд тархаж, мэдээллийн технологи сайжирч байгаатай холбоотойгоор цахим худалдаа арилжааны үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа банкны салбар дахь ашиг орлого, өсөлт хөгжилд технологийн хувьсал ихээхэн нөлөөлсөн байна.

Дэлхийн хүн амын гуравны хоёроос илүү хоёроос илүү нь (67.1 хувь) гар утас хэрэглэж байгаа бөгөөд 2022 оны эхэнд гар утас хэрэглэгчдийн тоо давтагдаагүй тоогоор 5.31 тэрбумд хүрчээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд дэлхий нийтээр гар утас хэрэглэгчдийн тоо 1.8% өсөж, 95 сая шинэ гар утас хэрэглэгчид нэмэгджээ. 2022 оны эхээр дэлхий

дээрх нийт интернет хэрэглэгчдийн тоо 4.95 тэрбум болж, нийт хүн амын 62.5%-тай тэнцэж байна. Аливаа улс оронд цахим банкны өсөлт нь интернетийн амжилт, онлайн банкны шинэ боломжууд, өрхийн интернетийн хэрэглээний өсөлт, хууль эрх зүйн орчин, зохицуулалт зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. (HOOTSUITE, 2022)

Цахим банк нь уламжлалт банкны мэдээллийн системээс харьцангуй сэтгэл ханамжтай байж болох хурдан шуурхай, найдвартай үйлчилгээг харилцагчдад санал болгодог. Цахим банкны систем нь зөвхөн хамгийн сүүлийн үеийн үр ашигтай өгөөжийг бий болгоод зогсохгүй харилцагчтай илүү сайн харьцах боломжтой. Энэхүү судалгааны үндэслэл нь Монгол дахь цахим банкны хөгжүүлэлт хэрэглэгчдийн хэрэглээнд хэрхэн нөлөөлж байгааг танин мэдэх судалгаа юм. Цахим банкны үйлчилгээ бол уламжлалт банкны системээс онлайн банкны системд шилжсэнээс хойш банкны салбарт шилжилтийн үе өнгөрч байна гэж ойлгож болно.

Банкны салбарын ашиг орлого, бизнес өргөжин тэлэх, амжилт гаргахад хэрэглэгчдийн хэрэглэх хандлагыг зайлшгүй судлах шаардлагатай юм. Өнөөгийн банкны салбар өдөр бүр шинэчлэгдэж, санхүүгийн янз бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэх үйл ажиллагаа өргөжүүлэн хөгжүүлсээр байна. Үүний зэрэгцээ банкны үйл явц илүү хурдан, хялбар үр ашигтай болсоор байна. Банкны салбарын өрсөлдөөнийн зах зээлд оршин тогтнохын тулд арилжааны банкууд харилцагчдаа илүү сайн үйлчилгээ үзүүлэх боломжийг эрэлхийлж байна.

Цахим банк нь гүйлгээ, хүргэлтийн зардлыг мэдэгдэхүйц бууруулж байгаа тул банкны бизнесийг өөрчлөх боломжтой. Цахим банк нь үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцэж чадах уу, үгүй юу гэдгийг олж мэдэхийн тулд энэхүү судалгааны ажлаар хүртээмжтэй байгаа эсэхийг хэрэглэгчдийн хэрэглэх хандлага, хэрэглэх мэдлэг чадварыг судалсан болно.

Дижитал шилжилт ба банкны салбар

Дижитал шилжилт нь өндөр технологийг ашиглан хаягдал багатай, өндөр бүтээмж, үр ашигтай эдийн засаг, нийгмийн гарцыг бий болгох тухай концепц юм. Дижитал шилжилтийн үр ашгийг дараах 3 бүлэгт хувааж авч үзэж болно. Дэвшилтэт мэдээллийн технологийг ашиглаж интернетэд холбогдсон бүхий л технологиудыг сайжруулж, инженерчлэлийн мэдлэгийг нэгтгэснээр үйлдвэрлэлийн сул зогсолтыг минимум байлгаж, илүү хурдан, жигд явуулж болно. Энэ тохиолдолд бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн системийн үр ашгийг дээшлүүлэх, зардал хэмнэлт, тогтворжуулалтыг илүү хялбар удирдана. (Cziesla, 2014)

Улс орны суурь салбар болох ХАА, эрүүл мэнд, аж үйлдвэр, тээврийн салбарт дижитал шилжилт явагдсанаар үнэ цэнэ бүтээлт нэмэгдэж, мэдлэг бүтээх боломжийг олгож улс орны эдийн засагт үлэмж өсөлтийг бий болгодог жишээ олон байна. Иймээс засгийн газрууд, хувийн хэвшлийн сектор технологийн трендийг дагаж, сүүлийн үеийн технологийг авч хэрэглэж байна. (Natalja Verina, Jelena Titko, 2019)

1.1 Дижитал шилжилтийн төлөвшлийг үнэлэх загвар

Байгууллагын дижитал шилжилтийн төлөвшлийн түвшнийг 3P загвараар хэмжив. Загвар нь 3P буюу People-Хүн, Process- Процесс, Preparedness-Бэлтгэлжилт юм. ХҮН буюу дижитал ноу-хоу, манлайлах чадвар, ажилчдын ур чадвар, тэдгээрийн авьяас, ҮЙЛ ЯВЦ буюу шинэлэг, хамтын ажиллагаа, хэрэглэгчийн үйлчилгээ, хэрэглэгчийн оролцоо, нээлттэй эх сурвалжийн хэрэглээ, БЭЛТГЭЖИЛТ буюу стратеги тодорхойлолт, дижитал чиг хандлагуудад хариу үйлдэл үзүүлэх, хөрөнгө оруулах, шилдэг туршлагыг нэвтрүүлэх чадамж зэргийг дэмжин ажиллах нөхцөл, суурийг бий болгохоор ажиллаж буй байдлаас шалтгаалан дижитал шилжилтийн төлөвшлийг үнэлэх боломжтой байдаг. (Kose, August, 2020)

Зураг 1.1 Дижитал шилжилтийн төлөвшлийн загвар



Эх сурвалж: *The Three P's Of Digital Transformation*

Базель III зохицуулалтын стандарт гарахаас өмнө банкууд дижитал шилжилтийг зохицуулалтын технологи (RegTech) гэх мэт шинэ технологийн стандартуудыг хэрэгжүүлэхээр зорьж байна. RegTech нь банкны зохицуулалтын удирдлагын үйл явцад ихээхэн тус болох мэдээллийн технологи, дижитал инновацийг хөшүүрэг болгон шинэчлэгдэж буй технологийн чиг хандлага юм. (Florian Diener, Miroslav Špaček, 2021)

Цахим банк ба банкны үйлчилгээ

Цахим банкны тухай ойлголтыг олон янзаар тодорхойлсон байдаг, банкны мэдээлэл, үйлчилгээг харилцагчдад хүргэх өөр өөр платформуудаар дамжуулан, тухайлбал хувийн компьютер болон программ хангамж, гар утас эсвэл дижитал платформуудыг хамруулан ойлгоно. (Daniel, 1999) Цахим банк гэдэг нь интернетээр дамжуулан банкны үйлчилгээг авна гэх үйл явцаас илүү том цар хүрээтэй ойлголт ба интернет нь цахим банкны үйлчилгээг хүргэх гол суваг бөгөөд түүний үйлчлүүлэгчид болон банкуудад үзүүлэх үнэ цэн нь тасралтгүй өссөөр байна. (Karjaluo, 2002)

Хүмүүс шинэ технологи, мэдээллийн системийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг ашиглахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох нь чухал юм. Үүнтэй холбогдуулан үндэслэлтэй үйлдлийн онол (Fishbein, M., Ajzen, I, 1975), Технологийг нэвтрүүлэх загвар (Davis, 1989), Төлөвлөсөн зан үйлийн онол (Ajzen, 1991) зэрэг хэд хэдэн онолыг судалсан болно. Хэрэглэгчдийн интернет банкны үйлчилгээг ашиглах хандлагыг судлах

зорилгоор эдгээр загваруудыг судалж боловсруулсан болно. Үндэслэлтэй үйлдлийн онол нь хүний зан үйлийг тайлбарлахад ашигладаг хамгийн чухал онолуудын нэг юм. (Pedersen, 2005) Технологийг ашиглах зан үйлдлийн хүсэл эрмэлзэл нь хүмүүсийн тухайн зан үйлд хандах хандлага, субъектив хэм хэмжээнүүдээр тайлбарлагддаг. Хэрэв зан үйлийг хувь хүн сайн дураараа удирддаг бол энэ нь технологийг нэвтрүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэн зөв тайлбарлаж чадна. (Laukkanen, T. and Cruz, P, 2009)

Хүснэгт 2.1 Цахим банкны үйлчилгээний чанарын хэмжээс ба шинж чанарууд

Цахим үйлчилгээний чанарын хэмжээс	Цахим үйлчилгээний шинж чанар
Цахим үйлчилгээний үр дүнгийн чанар	Үйл ажиллагаа, хувийн тохируулга, найдвартай байдал, цаг хэмнэх чадвар
Цахим үйлчилгээний үйл явцын чанар	Ашиглахад хялбар байдал, аюулгүй байдал, хандалт
Цахим үйлчилгээний системийн чанар	Веб сайт эсвэл программын бүтэц, дизайн
Цахим үйлчилгээний мэдээллийн чанар	Веб сайт эсвэл программын агуулгын чанар, мэдээллийн ашиг тустай байдал


Эх сурвалж: Zeithaml, Boyer (2002)

Технологийг хүлээн авах загварыг хэрэглэгчийн интернэт банкны үйлчилгээг ашиглахад хандах хандлагыг, хэргэлхэд хялбар байдал, хэрэглэгчийн хувийн зан чанар, өөрчлөгдөхгүй байх нөхцөлөөр хамааруулан тайлбарлаж байна. Хэрэглэгчийн хувь хүний онцлогийг нас, хүйс, гэр бүлийн байдал, ажил мэргэжил, боловсрол зэргээр төлөөлүүлэн тайлбарлаж байна. Өөрчлөлтөд дургүй байх нь шинэ технологи, эсвэл зах зээл дээрх бүтээгдэхүүнд хандах зан байдлын нэг чухал тал болдог байна. Өөрчлөлтийн эсэргүүцэл нь интернэтийн орчны хязгаарлагдмал хандалт, компьютер, интернэтийн өндөр өртөг зардал гэх мэт олон хүчин зүйлээс хамаардаг байна. Мөн харилцагчид мэдээллийн технологийн мэдлэггүй ба системийн аюулгүй байдлын асуудалд санаа зовдог байна. (Davis, 1989)

1.2 Үндэслэлтэй үйлдлийн онол

2010 онд хийгдсэн Фишбейн, Ажзен нарын үндэслэлтэй үйлдлийн онол нь хэрэглэгчийн зан төлөвөөс бий болсон олон нийтийн болон нийгмийн сэтгэлгээний үр дүн дүнд бүтээгдсэн загвар юм. Энэ онолын гол зорилго нь "хүний зан төлөвийг урьдчилан таамаглах, ойлгох" юм. (Ajzen I. a., 1980) Үндэслэлтэй үйлдлийн онолоор хүмүүс аливаа тодорхой зан авир гаргахаасаа өмнө үйл ажиллагаа, үйлдлийнхээ үр дагаврыг анхаарч үзэхийг анхааруулдаг байна. (Wetzels & Schepers, 2007)

Зураг 2.1 Учир шалтгаант зан үйлийн онол



Эх сурвалж: Theory of Reasoned Action – TRA (Fishbein & Ajzen)

Дээрх зурагт хүний үйлдэл дэх хандлага ба зан үйлийн хоорондын хамаарлыг харуулсан байна. (Wetzels & Schepers, 2007) хэлснээр ихэнх нийгмийн зан үйлийг гүйцэтгэхээс өмнө урьдчилан таамаглаж болохуйц үр дүнд хүрсэн гэж үндэслэлтэй үйлдлийн онолоор тайлбарладаг.

Үндэслэлтэй үйлдлийн загвар нь хэм хэмжээ, итгэл үнэмшил, төлөвлөсөн зан төлөв, хандлага, бодит зан үйлийн хоорондын харилцааг тодорхойлдог. Үндэслэлтэй үйлдлийн субъектив хэм хэмжээ, хандлага нь зан төлөвийг урьдчилан таамаглаж буй хүний хүсэлд нөлөөлдөг байна. (Ajzen I., Conceptual and methodological considerations., 2006)

Хүний сөрөг эсвэл эерэг зан авирыг хандлага гэж нэрлэдэг (Фишбейн & Ажзен, 2010), субъектив хэм хэмжээ нь нийгмийн дарамтаас үүдэлтэй өөрийн зан төлөвийн талаарх хүний үзэл бодол юм. (Schepers, 2007)

Үндэслэлтэй үйлдлийн онол нь субъектив хэм хэмжээ ба хандлага гэсэн хоёр үндсэн бүтцээс бүрдэнэ. (Yzer, 2007)

Мөн үндэслэлтэй үйлдлийн онол нь хувь хүний сайн дурын хяналт багатай нөхцөл байдлыг урьдчилан таамаглахад тохиромжгүй болохыг тогтоожээ.

1.3 Төлөвлөгдсөн зан төлөвийн онол


Үндэслэлтэй үйлдлийн онол (Ajzen I., Conceptual and methodological considerations., 2006) дээр хийгдсэн нэмэлт судалгаа бол төлөвлөгдсөн зан үйлийн онол юм. Үндэслэлтэй үйлдлийн онол нь хүмүүс өөрсдийн зан үйлийн хэв маягийг хянах чадваргүй нөхцөл байдалд хүмүүсийн зан төлөвийг судалжээ. Хувийн зан төлөвийн хяналт гэж нэрлэгддэг онол нь үндэслэлтэй үйлдлийн онол дээр нэмэлтээр хийгдсэн байна.

Энэхүү нэмэлт нь хувь хүмүүсийн дурын хувийн үзэл санаа буюу бүрэн хяналтгүй нөхцөл байдлыг засах зорилготой байв. Хувийн зан төлөвийн хяналт нь хувь хүний зан үйлийг гүйцэтгэхэд тулгардаг бэрхшээлийг багасгахад тусалсан (Ajzen & Sheikh, 2013).

Төлөвлөгдсөн зан төлөвийн онол нь нийгмийн сэтгэл зүйд суурилсан үзэл санааны загвар юм. Хандлага, субъектив хэм хэмжээ, хувийн зан төлөвийн хяналт зэрэг нь хүлээгдэж буй

болон үүсэх үр дүнд бий болох зан үйлийг тодорхойлж чадна.

Зураг 2.2 Төлөвлөгдсөн зан үйлийн онол



Эх сурвалж: *Theory of Planned Behaviour (Ajzen 1991)*

Төлөвлөгдсөн зан төлөвийн онолыг эрдэмтэн судлаачид бодит болон төлөвлөсөн зан үйлийг урьдчилан таамаглах зорилгоор ашиглав. Энэ нь хэрэглэгчийн шинэ мэдээллийн систем ашиглах гэсэн бодол (Mathieson, 1991) эсвэл ёс зүйгүй үйлдэл хийх (Chang, 2012) гэсэн бодлыг урьдачлан таамагладаг онолын арга байсан юм.

Төлөвлөгдсөн зан төлөвийн болон үндэслэлтэй үйлдлийн онолын тайлбар ухагдахууныг урьдчилан таамаглахтай харьцуулж болно. Ашиглах зорилго, бодит хэрэглээг хувийн зан төлөвийг хянах онолоор тайлбарлаж болно. (A.Brown, 2014) Хувийн зан төлөвийн хяналт нь "хүний хувийн зан үйлдлээр үйл ажиллагааг гүйцэтгэх нь тодорхой үр дүнд хүрэх магадлалаас илүүтэйгээр тухайн зан үйлийг гүйцэтгэх нь хэр хялбар, эсвэл хэцүү байх тухай ойлголт" гэж тодорхойлогддог бөгөөд үүнийг зан үйлийн гүйцэтгэлийг хянах гэж онолоор тайлбарлана. (Ajzen I. , 1991)


1.4 Технологи хүлээн авах онол

Дэвис 1989 онд технологийг хүлээн авах онолыг боловсруулсан байна. Хүмүүс шинэ технологиудыг хүлээн зөвшөөрч буйг тодорхойлоход энэ загварыг өнөөг хүртэл ашигласаар байна. Технологийг хүлээн авах онол нь мэдээллийн системийг хэрэглэх боломжит хэрэглэгчдийн хүлээн зөвшөөрөх загварчлалын үндсэн дээр боловсруулагдсан юм. Энэ онол нь хэрэглэгч мэдээллийн технологийг хүлээн зөвшөөрч буйг тайлбарлахад тусалдаг. (Chang M. C., 2013)

Технологийг хүлээн авах онол нь хүн шинэ системтэй танилцахдаа хэзээ, хэрхэн ашиглахыг тодорхойлоход туслах хоёр хувьсагчийг тайлбарладаг. Хүлээгдэж буй үр дүн нь тухайн хүн өөрийн ажлын гүйцэтгэлийг тодорхой систем ашиглан сайжруулж, өөрчилж болно гэдэгт итгэх түвшин гэж тодорхойлогддог эхний хувьсагч юм. (Davis F. a., 1995)

Цахим банкны хувьд эдгээр үйлчилгээг авах хүсэлтэй хүмүүс банкны шинэ хэлбэрт цахим үйлчилгээнд хамрагдах нь банкны үйл ажиллагааг илүү хялбар, ашиглахад илүү амар болгох болно гэж үздэг байна. Хоёр дахь хувьсагч нь хэрэглэхэд хялбар байдал юм.

Зураг 2.3 Технологийг хүлээн авах загвар



Эх сурвалж: Wixom ба Todd нарын боловсруулсан загвар, 2005. (Davis, Bagozzi ба Warshaw, 1989, х.985)

Технологийг хүлээн авах онол нь үндэслэлтэй үйлдлийн онолоос бий болгож боловсруулсан юм. Энэ нь хувь хүний шинэ технологийг хүлээн зөвшөөрөх эсвэл хүлээн авах хүсэл эрмэлзлийг тайлбарлахад хамгийн их хэрэглэгддэг загваруудын нэг юм. (Venkatesh & Davis, 2010).

(Chang Y. , 2003) ажил нь Солонгосын интернет банкинд төвлөрч, боловсрол, технологи зэрэг нийгмийн бүтцийн тал дээр илүү анхаарсан ба судалгааны үр дүнд хүйс, интернет банкинд хэр өртөж буй байдал, хүний нас, банкны бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой бусад шинж чанарууд дах хүчин зүйлүүд нь цахим банкны хүлээн авах байдалд нөлөөлж болохыг нотолсон байна.

Монгол дахь цахим банкны судалгаа

Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангаас харахад 2019 оноос 2022 оны хооронд нийт цахим банкны үйлчилгээг хэрэглэгчдийн тоо 3.7 саяас 6.4 сая хүртэл болж 73 хувь өсчээ. Нийт хэрэглэгчдийн тоонд интернэт банк, мобайл банк болон телефон банкны үйлчилгээг хэрэглэгчдийн тоог бүх банкаар хамтад нь оруулсан тул давхардсан тоо байх боломжтой.

Абсолют дүнгээр авч үзэхэд 2021 онд өссөн өсөлт нь бусад онуудын өсөлтөөс ойролцоогоор 60 хувиар их байгаа нь 2021 онд Ковидын хамгийн их хөл хорио тогтоосонтой холбоотой судлаачид таамаглаж байна. Цахим банкны нийт хэрэглэгчдийн өсөлтийг банкны үйлчилгээний төрлөөр авч үзвэл интернэт банкны хэрэглэгчийн тоо 2.1 саяас 3.7 болж 76 хувь өссөн бол мобайл банкны хэрэглэгчийн тоо 1.2 саяас 2.0 сая болж 62 хувь өсчээ. Цахим банкны хэрэглэгчдийн 58 хувь нь интернэт банкны хэрэглэгч бол 31 хувь нь мобайл банкны хэрэглэгч байна.

Хүснэгт 3.1 Цахим банкны хэрэглэгчдийн тоо /цахим банкны төрлөөр болон идэвхтэй хэрэглэгчийн тоо/

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2019	2020	2021	2022
	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй	Нийт хэрэглэгч	Нийт идэвхтэй
Нийт хөдөлгөөнт банкны хэрэглэгч	3,681,128	1,522,254	4,437,856	1,823,585	5,642,209	2,212,843	6,392,030	2,211,218
Интернэт хандалт	2,133,284	1,039,634	2,635,425	1,258,404	3,170,918	1,666,992	3,728,705	1,749,080
Мобайл хандалт	1,222,266	470,116	1,389,220	546,010	1,844,541	533,178	1,975,845	455,377
Телефон банк	325,578	12,504	413,211	19,171	626,750	12,673	687,480	6,761


Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

График 3-1 Цахим банкны хэрэглэгчдийн тоо /цахим банкны төрлөөр болон идэвхтэй хэрэглэгчийн тоо/



Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

График 3-2 Цахим банкны идэвхтэй хэрэглэгчдийн хувь /төрөл ангиллаар/



Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

Нийт цахим банкны хэрэглэгчийн 39 хувь нь идэвхтэй хэрэглэгч байгаа бол интернэт банкны хэрэглэгчдийн дунджаар 49 орчим хувь нь идэвхтэй, мобайл банкны хэрэглэгчдийн дунджаар 32 орчим хувь нь идэвхтэй хэрэглэгчид байгаа нь хэрэглэгчид нь бүртгэлтэй байгаа боловч идэвхтэй хэрэглэж байгаа хэрэглэгчид харьцангуй бага байгаа нь харагдаж байна. Интернэт банкны хэрэглээний идэвх хөл хориотой байсан үеүдэд нэмэгдсэн боловч 2022 онд буурсан байна. Харин мобайл банкны үйлчилгээний идэвх 2019 оноос 2022 оны хооронд байнгын буурчээ.

Хүснэгт 3.2 Цахим банкны үйлчилгээний гүйлгээний статистик /тоо, мөнгөн дүн/


Үзүүлэлт	2020		2021		2022	
	Тоо /мян/	Дүн /тэрбум төг/	Тоо /мян/	Дүн /тэрбум төг/	Тоо /мян/	Дүн /тэрбум төг/
Нийт хөдөлгөөнт банкны гүйлгээ	377,373	118,834	552,186	203,174	846,231	322,036
Гар утас апп - интернэт	229,950	59,598	368,555	93,095	635,228	171,729
Цахим хуудас - интернэт	28,278	48,991	45,320	94,489	66,701	134,497
Мобайл хандалт	118,182	10,062	137,413	15,344	143,459	15,574
Телефон банк	963	183	898	245	844	237

Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

Цахим банкны хэрэглээний статистик датанаас харахад нийт гүйлгээний тоо 2020 онд 377 сая ширхэг гүйлгээ хийгдэж байсан бол 2022 онд 846 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь 2.2 дахин өсчээ. Цахим банкны гүйлгээг хийж байгаа төрлөөр авч үзвэл банкны хэрэглэгчид гар утас дээрх интернэт банкны үйлчилгээг илүү сонгож хэрэглэж байгаа харагдана. Мобайл банкаар буюу мессежээр гүйлгээ хийх нь тогтмол тоотойгоор хийгддэг. Харин интернэтээр цахим

хуудсаар дамжин гүйлгээ хийх нь харьцангуй бага байна.


График 3-3 Цахим банкны гүйлгээний тооны өсөлт



Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

Монголбанкны хөдөлгөөнт банкны тайлангийн цахим банкны хэрэглээний статистик датанаас харахад нийт дүн нь 2020 онд 119 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдэж байсан бол 2022 онд 322 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь 2.7 дахин өссөн байна. Цахим банкны гүйлгээг хийж байгаа төрлөөр авч үзвэл банкны хэрэглэгчид ихэвчлэн гар утас дээрх интернэт банкны үйлчилгээ /нийт цахим гүйлгээний дүнгийн 53 хувь/ болон цахим хуудсаар дамжин интернэт банкны үйлчилгээгээр /нийт цахим гүйлгээний дүнгийн 42 хувь/ хэрэглэж байгаа нь харагдана. Мобайл банкаар буюу мессежээр гүйлгээ хийх нь тогтмол тоотойгоор хийгддэг боловч хамгийн бага эзлэх хувьтай. Тооны хувьд бага боловч дүнгийн хувьд их хувь эзэлж байгаа тул томоохон бизнесийн байгууллагууд цахим төлбөр тооцоогоо цахим хуудсаар дамжин хийдэг гэсэн таамаглалд хүргэлээ.

График 3-4 Цахим гүйлгээний өсөлт



Эх сурвалж: Хөдөлгөөнт банкны тайлан, МОНГОЛБАНК

Эмпирик шинжилгээ

Таамаглал: Онолын үндэслэлүүд болон судлагдсан байдлын судалгааны үндсэн дээр судлаачид бид дараах таамаглалуудыг гарган эмпирик судалгаа авав.

Хүснэгт 4.1 Суудлаачдын таамаглал

Н	Таамаглал
H1a	Хүйс хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H1b	Нас хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H1c	Боловсрол хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H1d	Орлого хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H2	Цахим банкны итгэл даахуйц байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H3	Цахим банкны хэрэглэх, ашиглах заавар ойлгомжтой байх нь хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H4	Мэдээллийн аюулгүй байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.
H5	Цахим банкны үйлчилгээний ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.

Эх сурвалж: Судлаачдын боловсруулснаар

Түүвэр: Эмпирик судалгааг бэлтгэсэн асуулгын хүрээнд Улаанбаатар хот, хөдөө орон нутгийн нийт 270 цахим банк хэрэглэгч иргэдээс авсан боловч зарим түүвэрт оролцогч нь судалгааны гол асуултуудад хариулаагүй байсан тул цэвэрлэн 260 оролцогчийн хариултыг шинжилгээнд авч үзлээ. Мөн цахим банкны үйлчилгээг авахгүйгээр салбараар байнга үйлчлүүлдэг 7 харилцагч сонгон ярилцлага хийв. Нийт судалгааны үндсэн асуулгыг 1-5 шкалтайгаар авсан ба эдгээр асуулгыг фактор шинжилгээ хийхэд нийт 8 асуултаас 1 асуулт хамааралгүй гарсан тул шинжилгээний үр дүнд оруулаагүй. Харин үлдсэн 7 асуултыг 3 бүлэгт ангилж болох нь шинжилгээний үр дүнд харагдаж байна.

Хүснэгт 4.2 Шинжилгээний үр дүн

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.964	.966	9

Rotated Component Matrixa			
	Component		
	1	2	3
Цахим банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх танд найдвартай итгэл даахуйц байдаг		.797	
Цахим банкны хэрэглэх заавар ойлгомжтой байдаг		.715	
Мэдээллийн аюулгүй байдал өндөр байдаг			.843
Цахим банкны мэдээллийн системийн үйлдлүүд ойлгомжтой тодорхой байж чаддаг	.755		
Цахим банкны үйлчилгээ танд маш тохиромжтой байдаг	.823		
Цахим банкны үйлчилгээг ашиглаж сурахад хялбар байдаг	.856		
Цахим банкны үйлчилгээг ашиглах маш хялбар	.865		

Extraction Method: Principal Component Analysis. Rotation Method: Varimax with Kaiser Normalization. Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

KMO and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.917
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	2272.770
	df	21
	Sig.	.000

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Судалгааны нийт асуулгыг 3 бүлэглэвэл: цахим банкны үйлчилгээний заавар ойлгомжтой бөгөөд итгэл даахуйц, цахим банкны үйлчилгээ мэдээллийн нууцлал сайн байхуйц, цахим банкны ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байхуйц байх гэсэн үндсэн бүлгүүд гарч байна. Цаашдын судалгаанд эдгээр нь цахим банкны хэрэглээг нэмэгдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх эсэхийг шинжилж үзэв.

Хүснэгт 4.3 Шинжилгээний үр дүн Таамаглал №1 – Хэрэглэгчийн хүйс, нас, гарын утасны марк, боловсрол, ажил эрхлэлт, өрхийн сарын дундаж орлого цахим банкны хэрэглээнд нөлөөлнө.

Coefficients^a

	Unstandardized Coefficients	Standardized Coefficients			
	B	Std. Error	Beta	t	Sig.
(Constant)	4.017	.534		7.525	.000
Хүйс	.022	.168	.008	.130	.897
Нас	-.226	.090	-.166	-2.502	.013
Таны гар утасны марк	.000	.075	.000	-.002	.998
Боловсрол	.034	.114	.019	.295	.768
Ажил эрхлэлт	.007	.029	.015	.244	.807
Өрхийн сарын дундаж орлого	.131	.061	.146	2.149	.033

a. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авсанаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Шинжилгээний үр дүнгээс авч үзвэл цахим банкны хэрэглээнд нас, өрхийн сарын дундаж орлого нөлөөлдөг нь харагдаж байна. Бусад хувьсагчууд ач холбогдолгүй гарсан байна. Нас цахим банкны хэрэглээнд сөрөг нөлөөтэй байгаа бол өрхийн сарын дундаж орлого эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, нас нэмэгдэх тусам цахим банкны хэрэглээ буурдаг бол орлого нэмэгдэх нь цахим банкны хэрэглээг нэмэгдүүлдэг.

Хүснэгт 4.4 Таамаглал №2 - Цахим банкны итгэл даахуйц байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ

Model Summary ^b					
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Durbin-Watson
1	.763 ^a	.583	.581	.621	1.953

a. Predictors: (Constant), Цахим банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх танд найдвартай итгэл даахуйц байдаг

b. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авсанаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 4.5 Шинжилгээний үр дүн Coefficients^a

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	1.213	.149		8.152	.000
	Цахим банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хэрэглэх танд найдвартай итгэл даахуйц	.704	.037	.763	18.985	.000

a. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авсанаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үр дүнгээс харвал цахим банкны итгэл даахуйц байдал нь цахим банкны үйлчилгээний хэрэглээнд эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, итгэл даахуйц байдал нь нэмэгдэх тусам цахим банкны хэрэглээ нэмэгдүүлдэг. Шинжилгээний коллинеар статистикийн үзүүлэлтүүдээс харахад мультиколлинеар нөхцөл үүсээгүй байв.

Хүснэгт 4.6 Таамаглал №3 – Цахим банкны хэрэглэх, ашиглах заавар ойлгомжтой байх нь хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.

Model Summary ^b					
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Durbin-Watson
1	.782 ^a	.611	.610	.599	2.167

a. Predictors: (Constant), Цахим банкны хэрэглэх заавар ойлгомжтой байдаг

b. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авсанаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 4.7 Шинжилгээний үр дүн

Coefficients^a

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	1.170	.143		8.209	.000
	Цахим банкны хэрэглэх заавар ойлгомжтой байдаг	.712	.035	.782	20.141	.000

a. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авсанаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үр дүнгээс харвал цахим банкны хэрэглэх зааврын ойлгомжтой байдал нь цахим банкны үйлчилгээний хэрэглээнд эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, цахим банкны хэрэглэх зааврын ойлгомжтой байдал нь нэмэгдэх тусам цахим банкны хэрэглээ нэмэгдүүлдэг. Шинжилгээний коллинеар статистикийн үзүүлэлтүүдээс харахад мультиколлинеар нөхцөл үүсээгүй байв.

Хүснэгт 4.8 Таамаглал №4 – Цахим банкны хэрэглэх, ашиглах заавар ойлгомжтой байх нь хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.

Model Summary ^b					
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Durbin-Watson
1	.742 ^a	.550	.549	.644	1.923

a. Predictors: (Constant), Мэдээллийн аюулгүй байдал өндөр байдаг

b. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авснаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Coefficients^a

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	1.421	.147		9.639	.000
	Мэдээллийн аюулгүй байдал өндөр байдаг	.701	.039	.742	17.775	.000

a. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авснаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үр дүнгээс харвал цахим банкны мэдээллийн аюулгүй байдал нь цахим банкны үйлчилгээний хэрэглээнд эерэг нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, цахим банкны мэдээллийн аюулгүй байдал нь нэмэгдэх тусам цахим банкны хэрэглээ нэмэгдүүлдэг. Шинжилгээний коллинеар статистикийн үзүүлэлтүүдээс харахад мультиколлинеар нөхцөл үүсээгүй байна.

Хүснэгт 4.9 Таамаглал №5 – Цахим банкны үйлчилгээний ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ

Model Summary ^b					
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Durbin-Watson
1	.951 ^a	.904	.902	.299	2.020

a. Predictors: (Constant), Цахим банкны үйлчилгээг ашиглаж сурахад хялбар байдаг, Цахим банкны мэдээллийн системийн үйлдлүүд ойлгомжтой тодорхой байж чаддаг, Цахим банкны үйлчилгээ танд маш тохиромжтой байдаг, Цахим банкны үйлчилгээг ашиглах маш хялбар

b. Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авснаар сэтгэл ханамж өндөр байдаг

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Coefficients^a

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	.256	.078		3.263	.001
	Цахим банкны мэдээллийн системийн үйлдлүүд ойлгомжтой тодорхой байж чаддаг	-.005	.038	-.006	-.140	.889

Цахим банкны үйлчилгээ танд маш тохиромжтой байдаг	.611	.058	.622	10.510	.000
Цахим банкны үйлчилгээг ашиглах маш хялбар	.206	.060	.218	3.459	.001
Цахим банкны үйлчилгээг ашиглаж сурахад хялбар байдаг	.132	.059	.136	2.221	.027

a. *Dependent Variable: Цахим банкны үйлчилгээг авснаар сэтгэл ханамж өндөр байдаг*

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үр дүнгээс харвал цахим банкны хэрэглэхэд хялбар байдал, ашиглаж сурахад амархан байх болон тохиромжтой байх нь цахим банкны үйлчилгээний хэрэглээнд эерэг нөлөөтэй байна. Харин цахим банкны системийн үйлдлүүд ойлгомжтой байх нь ач холбогдолгүй гарчээ. Өөрөөр хэлбэл, цахим банкны хэрэглэхэд хялбар байдал, ашиглаж сурахад амархан байх болон тохиромжтой байх байдал сайжрах нь цахим банкны хэрэглээ нэмэгдүүлдэг.

Шинжилгээний коллинеар статистикийн үзүүлэлтүүдээс харахад мультиколлинеар нөхцөл үүсээгүй байна.

Хүснэгт 4.10 Шинжилгээний үр дүн

Н	Таамаглал	Үр дүн
H1a	Хүйс хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдаагүй
H1b	Нас хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Сөрөг нөлөө
H1c	Боловсрол хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдаагүй
H1d	Орлого хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Эерэг нөлөө
H2	Цахим банкны итгэл даахуйц байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Эерэг нөлөө
H3	Цахим банкны хэрэглэх, ашиглах заавар ойлгомжтой байх нь хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Эерэг нөлөө
H4	Мэдээллийн аюулгүй байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Эерэг нөлөө
H5	Цахим банкны үйлчилгээний ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдал хэрэглэгчийн цахим банкны хэрэглээ, хүртээмжид нөлөөлөл үзүүлнэ.	Батлагдсан Эерэг нөлөө

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Хүснэгт 4.11 Ярилцлагын судалгаа: Цахим банкны үйлчилгээг авахгүйгээр салбараар байнга үйлчлүүлдэг 7 харилцагч сонгон ярилцлага хийв.

Ярилцлагын асуултын агуулга	Хариултын агуулга
Банкны ямар бүтээгдэхүүн үйлчилгээ авдаг вэ?	Карт, төлбөр гүйлгээ, харилцах данс
Банкаар хэр давтамжтай үйлчлүүлдэг вэ? Салбар дээр үйлчлүүлэхдээ хэр хугацаа зарцуулдаг вэ?	Бүх оролцогч сардаа 1-4 удаа банкны салбараар үйлчлүүлдэг. Багадаа 10 мин, дунджаар 30 минут, ихдээ 1 цаг орчим.

Цахим банкны үйлчилгээ авдаг бол үйлчилгээг нэрлэх. Авдаггүй бол шалтгаан.	Ихэнх нь цахим үйлчилгээг авдаггүй. Банкаар үйлчлүүлэх шаардлага бага. Картаа л ашигладаг. Банк ойрхон.
Цахим банкны талаарх мэдээ, зөвлөмж хаанаас авдаг. Цахим банкны хувьд санал.	Ихэнх оролцогч мэдээлэл, зөвлөмж банкны ажилтан, ойр тойрны хүмүүс, зар сурталчилгаанаас авдаг гэсэн бол код мартаx, зарим хэрэглэх заавраа мартдаг.
Ухаалаг утастай эсэх. Цаашид цахим банкны харилцагч болох эсэх.	Нийт оролцогчдын 6 оролцогч ухаалаг утастай байв. 6 оролцогч цаашид цахим банкны үйлчилгээ авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн бол харин 1 оролцогч авахгүй, итгэдэггүй гэж хариулжээ.
Ярилцагчийн нас болон харилцдаг банкны мэдээлэл	Нийт ярилцлагад оролцогчид 30-62 насных ба бүгд Хаан банкаар үйлчлүүлдэг. Мөн Хас, Төрийн банкны давхар харилцагчид байв.

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

Үр дүнгээс харахад ярилцагчид ихэнх нь карт, харилцах данс, төлбөр гүйлгээ хийдэг бөгөөд Хаан банкаар үйлчлүүлэх нь түгээмэл байна. Банкны талаарх мэдээллийг банкны ажилтан, орчин тойрны хүмүүс, зар сурталчилгаанаас авдаг. Харин цахим үйлчилгээг авахгүй байгаа нь код мартаx, хэрэглэх заавраа мартаx гэх мэт ашиглаж хэрэглэхэл төвөгтэй байдал, итгэдэггүй буюу итгэл даахуйц байдал, банк ойр байдаг, банкаар үйлчлүүлэх шаардлага бага гардаг гэх мэт хэрэгцээ шаардлагын байдлаас ихээхэн шалтгаалжээ. Харин цаашид цахим банкны үйлчилгээг авах хүсэлтэй байгаа нь харагдаж байлаа. Оролцогчдын нас 30-62 байсан. Үүнээс нас цахим хэрэглээнд нөлөөлдөг байх боломжтой гэдэг таамаглал гаргаж байна.

Дүгнэлт, санал зөвлөмж

Судалгааны үр дүнгээс тоймлон дүгнэвэл банкны цахим банкны хэрэглээнд нас, орлогын хэмжээ нөлөөллийн зэрэг багатайгаар нөлөөлж байсан бол цахим банкны үйлчилгээний найдвартай байдал, зааврын ойлгомжтой байдал, мэдээллийн нууцлал, хэрэглэж ашиглахад ойлгомжтой, хялбар байх нь нөлөөллийн зэрэг өндөртэйгээр нөлөөлдөг болох нь харагдлаа. Цахим банкны үйлчилгээг хэрэглэхгүй байгаа хүмүүсийн хариултаас нь эдгээр дүгнэлт батлагдаж байна. Иймд дараах санал, зөвлөмж судалгааны ажлын үр дүнд гарлаа.

- Цахим банкны үйлчилгээ найдвартай, итгэл даахуйц гэдгийг харуулсан, үйлчилгээг цахимаар авснаар ямар эрсдэлүүдээс зайлсхийх боломжтой вэ гэдгийг салбараар авахтай харьцуулж тусгасан мэдээллээр банкны харилцагчиддаа хүргэх нь цахим банкны үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэх боломжтой
- Мэдээллийн нууцлал сайн цахим банкны үйлчилгээнд сайн байдаг болохыг харилцагчдад харуулах нь их чухал нөлөөтэй.
- Цахим банкны үйлчилгээг хэрэглэж, ашиглахад маш хялбар, ойлгоход амар байх нь цахим банкны үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлэх нөлөө үзүүлэх боломжтой. Иймд банкны цахим банкны үйлчилгээг хэрэглэгчдээс хэрэглүүлэн үзэж, хэрэглэхэд хялбар байгаа эсэхийг нь судлан судалгаа явуулж үр дүнгээс тулгуурлан цахим банкны үйлчилгээний хэрэгслүүдийг дахин боловсруулах нь зүйтэй.

- Цахим банкны хэрэглээнд харилцагчийн нас, орлого нөлөөлдөг тул нас насны болон орлогын түвшин өөр өөр харилцагчдын хувьд цахим банкны үйлчилгээний хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийг нь үнэлэх судалгаа явуулах нь ач холбогдолтой.

Эдгээр арга хэмжээнг авснаар цахим банкны үйлчилгээний хэрэглээ өсч, тухайн хэрэгжүүлж ажилласан банкны цахим банкны хүрээмж нэмэгдэж, улмаар дижитал шилжилт түргэн хэрэгжих боломж бүрдэнэ гэж үзэж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Cziesla, T. (2014). A Literature Review on Digital Transformation in the Financial Service Industry. *BLED proceeding*, 4.
- Natalja Verina, Jelena Titko. (2019). Digital transformation: conceptual framework . *Contemporary Issues in Business, Management and Economics Engineering* (хууд. 13). RedearchGate.
- Kose, B. O. (August, 2020). Agile Business Analysis for Digital Transformation. L. R. Luísa Cagica Carvalho-Д, *Handbook of Research on Multidisciplinary Approaches to Entrepreneurship, Innovation, and ICTs* (хуудсд. 98-123).
- HOOTSUITE, W. A. (2022). *DIGITAL 2022 GLOBAL OVERVIEW REPORT*. УЛААНБААТАР: МАРКЕТИНГИЙН ЧИГ ХАНДЛАГА.
- Daniel, E. (1999). Provision of electronic banking in the UK and the Republic of Ireland. *International Journal of Bank Marketing*, 17(2), 72 – 83.
- Karjaluoto, H. (2002). Electronic banking in Finland. *Consumers beliefs, attitudes, intentions and behaviours*, хуудсд. Unpublished doctoral dissertation, University ofJyväskylä.
- Fishbein, M., Ajzen, I. (1975). Belief, attitudes, intention and behavior. *An Introduction totheory and research*, Reading, MA: Addison-Wesley.
- Davis, F. (1989). Perceived usefulness, perceived ease of use, and user acceptanceof computer technology. . *MIS Quarterly*, 13(3), 319-340.
- Ajzen, I. (1991). The theory of planned behavior. . *Organizational Behavior and HumanDecision Processes*, 50, 197-211.
- Pedersen. (2005). Adoption of mobile internet services: an exploratory study ofmobile commerce early adopters. . *Journal of Organizational Computing*, 15(2),203-22.
- Laukkanen, T. and Cruz, P. (2009). Comparing consumer resistance to mobile bankingin Finland and Portugal. in Filipe, J. and Obaidat, M.S. (Eds), e-Business and Telecommunications,. *Springer, Berlin*, 89-98.
- Florian Diener, Miroslav Špaček. (2021). Digital Transformation in Banking: A Managerial Perspective on Barriers to Change. *Sustainability*.
- Ajzen, I. a. (1980). Understanding attitudes and predicting social behavior. *Customers' Acceptance of Internet Banking*, хууд. An Empirical Study in Lebanon: Chapter 2.
- Wetzels, M., & Schepers, J. (2007). A meta-analysis of technology acceptance modeling: Investigating subjective norm and moderation effect', *Information and Management*, 44(1), pp. 90-103.
- Ajzen, I. (2006). Conceptual and methodological considerations. . *Working Paper, University of Massachusetts*. .

- Schepers, J. J. (2007). 'A meta-analysis of technology acceptance modeling: Investigating subjective norm and moderation effect', . *Information and Management*, 44(1), pp. 90-103.
- Yzer, M. (2007). Does perceived control moderate attitudinal and normative effects on intention? *A review of conceptual and methodological issues*.
- Mathieson, K. (1991). Predicting User Intentions: Comparing the Technology Acceptance Model with the Theory of Planned Behavior. *Information Systems Research*, 2, 173-191.
- Chang, M. K. (2012). Advances in Business Ethics Research. *Predicting Unethical Behavior: A Comparison of the Theory of Reasoned Action and the Theory of Planned Behavior* (хуудсд. book series (ABER, volume 2)).-Д
- A. Brown, S. (2014). Technology adoption decisions in the household: A seven-model comparison. *journal of the association for information science and technology*.
- Ajzen, I. (1991). The theory of planned behavior. *Organisational Behavior and Human Decision Process*, 50(2), pp. 179-211.
- Chang, M. C. (2013). Building trust online: Interactions among trust building mechanisms. *Information & management*, 50(7), pp. 439-445.
- Davis, F. a. (1995). Measuring user acceptance of emerging information technologies: An assessment of possible method biases. . *In 28th Annual Hawaii International Conference on System Sciences*. Hawaii, IEEE computer society press, Los Alamito.
- Chang, Y. (2003). Dynamics of banking technology adoption: an application to internet banking. *Working paper, University of Warwick, UK*.



MONGOLIAN REMOTE COMMUNITIES AND DIGITAL BANKING TRANSFORMATION

Bolitogtokh.D¹, Dashpil.Ya²

¹Assistant Professor, Financial Management Department of UFE, Mongolia

²Senior Lecturer, Financial Management Department of UFE, Mongolia



Keywords:

Remote communities, internet network, assessing the equality of banking services, Covid-19, digital banking transformation, fixed and random effect estimation

Abstract.

Although Mongolia has set up a nationwide Internet network as part of its goal of becoming a digital nation, remote communities were unable to have equal access to education, government services and other services due to inadequate infrastructure during the COVID-19 period.

When mobile communications and the Internet is expanding, customers have become available to use mobile banking and internet banking services. The uses of digital technology such as artificial intelligence and digital banking services based on big data have been increasing in recent year.

The benefits of this digital transformation for banks should be shared equally by all customers.

This paper describes assessing the equality of banking services based on reports on mobile banking transaction and reports on internet connection of citizens in Mongolian's remote communities and made a recommendation.

The methodology is based on a methodological approach using fixed and random effect estimation, panel analysis based on data from National statistics office of Mongolian, Mongol bank and Communication Regulatory Commission of Mongolia.

Introduction

The impact of the coronavirus has highlighted the need for electronic products and services in our daily lives and highlighted the shortcomings that have plagued service organizations and the financial sector in the past. The advantages of digital banking are well understood by both banks and customers. “Revolut”, Europe's largest digital bank, officially entered the US market last year. Barclays Bank's introduction of a digital center "From Home to Bank" in connection with the embargo, which allows it to meet its financial needs electronically, also sets the direction for the future. Foreign governments have also begun to regulate the digital revolution in the banking sector. Digitalizing traditional banking services will make it easier for people to work and deliver

services faster, regardless of space or time, and most importantly, reduce congestion, concentration, and movement, and thus reduce it to zero. It is expected that the digital transition will reduce inefficient costs and reduce interest rates.


According to the Economic Times, the disease has completely changed how people go about their daily lives, from shopping to working to banking. Several evolutionary changes are anticipated in the era of internet banking. Some consumers may expect completely autonomous banking operations due to a lack of time and competence, while others will demand high level interaction. As a result, the banking business in the future will be extremely adaptive. According to Deloitte, the rise of digital banking is putting customers at the center of every digital strategy, which institutions must undertake now to integrate successfully by 2030.

A new study by the deVere group on March 30, 2020 found that the use of fintech applications in European countries increased by 72% due to the coronavirus. The use of such applications has also risen sharply in Asia and the Middle East, with the number of online banking services doubling, according to a Philippine bank. This means that consumers prefer to use fintech applications and digital banking services in their daily services due to long-term quarantine restrictions.

Digital bank transformation and remote community

The term digital transformation is used in new digital trading channels such as e-banking, m-banking, and e-branch. Few have associated it with the degree to which the banks' staff accept it and describe the opportunities or threats it creates or influences. As digital transformation is a relatively new concept in the banking sector, the relevant reports focus mainly on the degree of acceptance and usage of new technologies by users of e-banking applications, whether they are customers or bank employees. (Fotis Kitsios, 2021)

Figure 1: Basic conceptional framework



Sources: (Ahmad, 2021)

According to the *Literature above*, the key factors of digital transformation of the organizations should be revisited and evaluated on a regular basis and make sure that the action plan for implementing phase of the digital transformation is on the right track

Figure 2: Examples of digital success measures across four categories

MEASUREMENT OF DIGITAL BUSINESS TRANSFORMATION	OPERATIONAL EFFICIENCY	CUSTOMER ENGAGEMENT	EMPLOYEE ENGAGEMENT	NEW SOURCES OF VALUE CREATION
	OPERATIONAL OBJECTIVES To save costs and improve operational speed and efficiency	To improve customer satisfaction and engagement	To improve employee satisfaction and productivity	To find new sources of revenue and profit
KPI EXAMPLES Time to market for digital products / services Employee hours saved due to digital tools Cost savings due to digital tools (i.e. predictive maintenance) Reduction in defects due to digital tools Percentage of operations handled by digital means	Customer NPS on use of digital tools Customer usage of digital tool (i.e. time on app or functions used) Percentage lead conversion across digital channels Click-through rates and other digital marketing measures Customer retention through digital channels Customer hours saved due to digital tools Percentage of customers who are active on a site or platform	Employee NPS on use of digital tools Employee satisfaction with remote work Employee usage of digital platforms (i.e. Intranet, internal social networks) New ideas generated via digital tools Degree of collaboration among employees across digital tools	Percentage of revenues from digital products / services Percentage of revenues from digital channels (i.e. web, app) Digital vs non-digital customer profitability New customer acquisition via digital channels	

Source: (Wade, 2022)

To better understand these challenges, a conceptual framework and digital metrics mapping represented by Figure 1 were created to collect specific information about the organization and its performance, the types of measures used in each digital transition phase, frequency of data analysis, and the types of analyses performed to address below propositions.

“Rural” refers generally to areas of open country and small settlements, but the definition of “rural areas” in both policy-oriented and scholarly literature are terms often taken for granted or left undefined, in a process of definition that is often fraught with difficulties. (Purnamita Dasgupta (India), 2015)

Literature Review

1. Dr.S.Amudhan, Dr. Sayantani Banerjee and Dr.J.Poornima, (2022), conducted a “Impact of digital transformation of banking sector in rural areas”, the objective of the research was to look at the socioeconomic characteristics of respondents who were chosen from the study area. The four main parts of digital transformation are technology, software, data, and organizational reorganization. In India's banking system, banks play a critical role. They oversee managing public finances and investing in the expansion of business and trade. In emerging countries like India, where other financial sectors are still in their infancy, the banking industry accounts for most of the financial sector. Banks' stability is vital since they act as trustees of public funds, mobilizers, and funders of various operations at the regional and international levels. The banking business has grown from a basic middleman to a vast commercial enterprise. Hence, the article concluded that the impact of the digital banking services on rural customers. (Dr.S.Amudhan, 2022)

2. **Nilutpal Neog**, (2019), conducted a “Usage Of Digital Banking Services By Rural Population: A Study In Sivasagar District Of Assam”, the objective of the research was carried out to study the adoption of digital banking services and other related issues among 100 rural people from Sivasagar district. (Neog, 2019)

3. Eneja Drobez, Valerija Rogelj, David Bogataj, conducted a “Planning Digital Transformation of Care in Rural Areas” was carried out to propose the multi-stage competing risk for control of event

leading to ill health and disabilities and show how to forecast the growth of these needs.

Digital bank transformation in Mongolia Urbanization of Mongolia's population

Because national definitions of urban and rural areas differ significantly from one country to another, it is difficult to compare these areas across national borders. To facilitate international comparisons, a coalition of six international organizations developed a new global definition of cities, towns and semi-dense areas, and rural areas. Although this is a relative concept, to describe an urban area, many countries utilize the smallest population. Therefore, the classification of urban and rural areas includes administrative decisions, employment, infrastructure, services, poverty, electricity, water, internet access, roads, and other infrastructure.

The total area of Mongolia is 1.5 million sq km with 21 province and 330 territorial administrative unit. It is one of the sparsely populated countries in the world with a population of 2 people per square kilometer. According to the 2015 urbanization rating of the European Union GHSL, 55.8% of the total population of our country is in urban areas, and 17.7% of the total population is in rural areas. /An urban centre consists of contiguous grid cells of 1 sq km with a density of at least 1500 inhabitants per sq km and a minimum total population of 50 000./, 23,8% /An urban cluster consists of contiguous grid cells of 1 sq km with a density of at least 300 inhabitants per sq km and a minimum total population of 5 000. / нь хөдөө, сууринд, 17,7% /Grid cells of 1 sq km with a density below 300 inhabitants per sq km and other grid cells outside urban clusters or centers/ нь хөдөө амьдардаг. In 2021, 1.5 million people of the total 3.2 million population live in the Ulaanbaatar, 0.9 million in territorial administrative unit, and 0.8 million in the rural areas. The territorial administrative unit with largest population is 136700, and the smallest population is over 18000. In recent years, The rural population density is declining significantly because of the migration from rural to urban areas is increasing. The population of 17 of the 330 territorial administrative unit is less than 1500. Accordingly, the territorial administrative unit with smallest population is 976. The most remote territorial administrative units from Ulaanbaatar are Bayan-Ulgii at 1710 km to the west, Tsengel area to the west is 80 km to the center of the province, Khalkhgol area to the east is 360 km to the center of the province and more than 1000 km to Ulaanbaatar.

Remoteness affects economy, business environment and infrastructure, which in turn affects the livelihoods, employment, education health, finance, technology, information and services of rural people in the territorial administrative unit.


The Rural development index /RDI/

The Rural Development Index is composed of five domains that are closely related to the quality of life of people living in rural areas. The domains are (1) economy, (2) health·welfare, (3) education, (4) environment (residential and natural environ- ment), and (5) culture·leisure.

In 2018, Mongolia approved the “Methodology for estimating the Local Development Index” and annually estimates the development index of 21 province and 330 territorial administrative units by education, health, economy, infrastructure, environment and others. This index is estimated on the basis of 5 groups of 65 indicators. As of 2021, Orkhon and Darkhan-uul provinces are leading in the Local Development Index in terms of economic capacity and infrasturcture, while Dornod

and Govi-Altai provinces have the lowest capacity.

Figure 3: Local development index, by some indicators by province



Source: (Development, 2022)

The Mongolian Economic Policy and Competitiveness Research center /EPCRC/ estimates the province's competitiveness index by 4 groups of 142 indicators and presents the annually report. To estimate competitiveness assessment, including infrastructure encompasses detailed technology infrastructure, including the use of digital devices, internet users, information organizations, access to information, landline points, telecommunications technology, total telecommunications, and mobile phone users.


The Human development index /HDI/

The Human Development Index, or HDI, is a metric compiled by the United Nations and used to quantify a country's "average achievement in three basic dimensions of human development: a long and healthy life, knowledge and a decent standard of living." The HDI was first launched in 1990 and has been released annually ever since, except in 2012.

Human Development Index value is determined by combining a country's scores in a vast and wide-ranging assortment of indicators including life expectancy, literacy rate, rural populations' access to electricity, GDP per capita, exports and imports, homicide rate, multidimensional poverty index, income inequality, internet availability, and many more. These indicators are compiled into a single number between 0 and 1.0, with 1.0 being the highest possible human development. HDI is divided into four tiers: very high human development (0.8-1.0), high human development (0.7-0.79), medium human development (0.55-.70), and low human development (below 0.55). According to the 2022 UNDP estimates, Mongolia is ranked 0.737 or 99th in the world.

As of 2021, Orkhon province leads in HDI, while Bayankhongor province has the lowest value.

Figure 4: Human Development index and poverty, by some indicators by province




Source: (Development, 2022)

Current situation of Mongolian telecommunication infrastructure

The 1992 transition from analogue system to digital has laid the foundation of fiber optic cable network in Mongolia, which facilitated connection of Mongolia to the world wide web in 1994. By 1996, Mongolia was officially connected to the internet via local firm Datacom. As of 2019, Mongolia ranked 57 in Network Readiness Index, 91 in Development of Information and Communication Technology (ICT), 101 in competitiveness index, and 92 in Utilization of Digital Development. Furthermore, as of 2019, 21 provinces and 310 districts were connected to the internet via fiber cables and 4G network was available for all districts.

Figure 5: Mongolian national fiber cable networks



Sources: (Mongolia, 2022)

Of 15 services currently operating in Information Communication sector in Mongolia, Cellular network services made up 55.4%, Internet and Data 10.3%, Internet Wholesale services 9.1% and the other 12 services accounted for 25.2%.

According to Mongolian Statistical Information Service 2015-2019 reports, Internet users in Mongolia are increasing. As of 2019, (including duplicates):

- Regular Internet Users : 5450610
- Fixed Internet Users: 303200

- 3G Users: 3190600

By payment method, 67.7% of all users are on prepaid plan, 25% are on monthly plan, 7.4% are on hybrid plans. Of all internet users, 93% are household whereas 6% are firms. Furthermore, 71% of all users are reported to be using 2Mbps to 5Mbps. As of 2021, excluding Ulan-Bator, Khuvsgul had the most cellular network users, whereas Govi-Altai had the least, Umnugovi had the highest number of regular internet users and Dundgovi had the least internet users.

Current situation of Digital Banking in Mongolia.

These days, everyone seems to be somewhere in the process of digital transformation. When the Pandemic changed life for everyone, the need for digital transformation became even more apparent as having more automated processes and work from home became even more important. Digital transformation involves redesigning business practices to incorporate digital technology within all facets of the business. Digital transformation will mean and require different things depending on the business. Digital transformation [DT] will look different for every company and enterprise. Digital transformation in banking requires a shift to online&digital services as well as a change in backend processes to promote digitization and automation. To compete with digital natives, banks should provide an end-to-end digital experience to their customers by integrating necessary technologies.

There are various issues and challenges in the implementation of digitalization to rural banking, they are:

- The literacy rate is low: It is evident that usage of digital banking services needs the education.
- Lack of infrastructural facilities: Digitalization of rural banking requires the availability of Infrastructural facilities, here we are considering mainly the Electricity and communication networks.
- Less number of people using smart phones: the number of people in rural area using smart phone is very less which is the big hindrance in implementation of digitalization of rural banking.
- Lack of banking habits among rural people: majority of the people in rural area do not have access to banking because of the lack of banking awareness and lack of financial literacy.
- Network issues in rural areas: there is a problem of communication networks because of which there is lesser digital payments in rural areas which needs to be addressed.
- Lack of financial literacy: the financial literacy among rural people is very less, because of which people are not aware of different kinds of making payments
- Cash economy: rural mainly depends on cash than digital cash to meet their daily needs as the transaction happens mainly with help of cash or barter form.
- Volume of transaction: the volume of transaction in rural area is very less because of lesser demand for the goods and low level of income.

- Customer resistance to new technology: the rural people do not change so easily in the case of usage of technology, as lack of awareness on usage of digital banking services.
- Cost of financial services: the cost of providing financial service is too high in rural area because of lack of infrastructural facilities and low volume of transaction in rural area.

l area.

The sudden outbreak of Coronavirus has further accelerated the rapid transformation in technological era. With Digital Transformation becoming a necessity for survival for many businesses, redesigning business structures and practices is imperative to facilitate successful digital transformation and how it's done is different for every business. Digital transformation in banking sector requires integration of necessary technologies to further promote digitalization and automation, thus providing end-to-end digital services to stay competitive.

The increasing number of Internet and Cellular network users has created both opportunities and challenges for traditional banks. According to Mongol bank 2021 digital banking report, internet bank has 1.66 million active users, mobile bank 530 thousand users, with 864 partners, which is a 4% increase from last year.

Of all digital transaction, 76.5% were intrabank, whereas other 14.7 were made up of other transfers such as interbank, international, wire transfer and credit payment etc.

Methodology and data collection

The study is basically based on primary data. For the required information individuals who were financially included mainly considered. Required information was collected through a structured questionnaire covering socio economic and demographic characteristics of sample respondents. The sample constitutes 424 rural respondents in 21 provinces of Mongolia, using Google Forms.

Table 1: Variable explanation

	Variables	Sign	Years	Sources
Dependent variable	Number of active mobile users, by province	Mob_bank_num	2015-2019	Mongolbank.mn
	Number of internet bank active users	Int_bank_num	2015-2019	Mongolbank.mn
Independent variable	Population density, by province	density	2010-2021	1212.mn
	GDP per capita, by province	Per_gdp	2010-2021	1212.mn
	Workers, by province	emp	2010-2021	1212.mn
	Spectrum of poverty, by province	poverty	2016,2018,2020	1212.mn
	Average salary of employees of enterprises and organizations, by province	sal	2010-2021	1212.mn

Analysis and results

The study was carried out during May, 2021. To study the factors that determines Access of digital banking services, logistic regression was models has been applied. The data were analyzed using Eviews10 software and estimated by fixed effect estimator approach.

$$INT_BANK_NUM = -24108.35 + 0.49 * PER_GDP + 13.08 * SAL + 2012.19 * DENSITY + [CX=F, PER=F, ESTSMPL="2015 2019"], R^2 = 0.86$$

$$MOB_BANK_NUM = 27336.02 - 15.04 * SAL + 1882.9 * DENSITY + [CX=F, PER=F, ESTSMPL="2015 2019"], R^2 = 0.94$$

GDP per capita, population density, and average salary rates were directly correlated with demand for digital banking. It is notable that Arkhangai, Bayan-Ulgi, Khenti provinces were lagging in a fore mentioned metrics, thus needs to increase them.

In this study, convenient sampling techniques were used to sample 424 customers in 15 provinces using Google Forms, which was intended to assess the effect of digital banking on rural users.

The questionnaire consisted of 3 sections of 18 questions, taken via the internet. Subjects were chosen by random sampling method and the data was processed using SPSS25 data processing software.

In section 1, We questioned: age, number of family members, household income per month, distance, internet, and mobile phone bills on average per month, education, and province.

The average age of respondents was 37, of all respondents, 60% were public servant, 18% ran their own businesses. The average family size was 4, and the average personal monthly income was \$290.32. Of all respondents, 23% were from Arkhangai and 81% had attained higher education. 21 respondents were at least 1600km away from Ulan-Bator, and on average, respondents were 600-800km away from Ulan-Bator and reported spending on average \$16.13 on internet bills.

Table 2: Section 1. Socio-Economic characteristics of the sample respondents

	Mean	Std.dev
Age	37	10
Number of family members	4.25	1.33
household income per month	USD 290.32	USD193.55
Distance	600-800 km	
internet and mobile phone bills on average per month	USD 12.9-19.35	USD 6.54

In section 2, We questioned: networks, devices and spendings for mobile phone bills.

Respondents reported to be extensively using 4G, 3G, Wifi and Local Area Network to connect to the internet. Unitel and Univision was the most used network, with cellular internet connection being the most used method of connection.

In section 3, We questioned: digital banking service types, purposes of use of the above digital banking services and frequencies, biggest concerns about digital banking services, and some improvements in your area to increase access to digital banking services.

Respondents reported to be extensively using 4G, 3G, Wifi and Local Area Network to connect to the internet. Unitel and Univision was the most used network, with cellular internet connection

being the most used method of connection.

Respondents' reports using internet, mobile banking, and ATMs to make transactions, pay bills, deposit and withdraw cash and wire transfers every day. Identity theft, phishing and technical difficulties were among the biggest concern for users of digital banking systems and internet speed and cost of services were challenges faced by rural customers. To conclude, increasing available internet speed, reducing cost of service in rural areas, more digital safeguards and information availability should be the first steps to encourage higher digital banking in rural areas.

Considering consumers, digital infrastructure, and digital banking consumption by province, the following results were obtained.

Table 3: Customers' digital infrastructure some improvements in your area, by province

	Indicators	Max	Min
1	Household income per month	Orkhon	Zavkhan, Sukhbaatar
2	Internet and mobile phone bills on average per month	Darkhan 21.7%	Sukhbaatar 16.7%
3	Networks		
	LAN	Darkhan 17%	GoviAltai 12%
	Wifi	Darkhan 25%	Zavkhan 11%
4	Difficulties		
	Poor equipment capacity	Dornod 10.3%	
	The cost of the service is high	Sukhbaatar 20%	
	It is difficult to open a digital banking service for the first time	Dundgovi 14%	
	Lack of information on digital banking services	Khovd, Dundgovi, Khuvsgul 14.3%	
	Some services are not available at all	Orkhon 20%	
5	Increase access		
	Increase the range of digital banking services	Khovd 45%	
	Increase citizens' knowledge of digital banking services	Orkhon 50%	
	Increase target-oriented projects and programs	Zavkhan, Dundgovi 20%	
	Reduce service costs and fees	Sukhbaatar 60%	

The questionnaire yielded the following results:

- Household income was the lowest in Zavkhan and Sukhbaatar
- Sukhbaatar province reported the lowest internet and cellular network usage
- Local Area Network and Fixed internet was used the least in Govi-Altai and Zavkhan
- Respondents reported the least equipment capacity in Dornod,
- Sukhbaatar had the highest cost of service,
- Respondents in Dundgovi reported the most difficulty opening first bank account

- Khovd, Dundgovi, Khuvsgul had the least available information about digital banking

As for suggestions to problems faced by digital banking in rural areas, respondents suggested:

- Increasing the availability of digital banking in Khovd,
- Increasing information availability in Orkhon
- Increasing target-oriented project and programs in Zavkhan, Dundgovi
- Reduction of service fees in Sukhbaatar

Furthermore, the distance from Ulan-Bator directly correlated with cellular network costs and inversely correlated with household income.

Conclusion

In the digital era, Mongolia desperately needs to transition to be a digital country. The disparity between Ulan-Bator and rural province's household income and internet availability is relatively high.

Mongolia has the least population density in the world and sees high amount of migration to urban areas, thus has vast infrastructure development gap, more apparent in whilst Mongolia ranks 99 out of 189 countries in Human Development Index, but rural provinces rank lower than the average.

Citizen at least 2000km away find it difficult to gain education and see health professionals, which increases the pressure to change to internet-based government services. Although 21 provinces and 310 districts are connected via Fiber cable, troubles like unreliability, cost of connection, monopoly in rural internet markets, lack of information impede fair distribution of information communication. Mongolian government has taken initiatives to better the infrastructures to increase the access to information communications in rural areas.

The surge of internet in Mongolia, has created favorable markets for digital transition of tradition banks, which would cut cost and time loss for both the bank and the customer. But it is still impeded in rural areas by the lack of internet access, cost of connection and poor quality of equipment.

The questionnaires concluded that to increase digital banking services in rural areas, it is crucial to decrease outward migration, develop infrastructure, decrease cost on connection, increase in living standards as first steps.

Cyber security of digital banks is still major concern for banks, as more sophisticated encryption, cyber-crime prevention is needed. Furthermore, customers demand varied service selection, access to information, fair pricing from digital banks.

Reference

Fotis Kitsios, I. G. (2021). *Digital Transformation and Strategy in the Banking Sector: Evaluating the Acceptance Rate of E-Services*. *Journal of Open Innovation: Technology, Market, and Complexity*, 14.

- Wade, M. (2022). *Covid-19 Has Accelerated Digital Transformation, but May Have Made it Harder Not Easier*. *MIS Quarterly*.
- Ahmad, A. A. (2021). *Digital transformation metrics: a conceptual view*. *Journal of management Information and Decision Sciences*.
- Dr.S.Amudhan, D. S. (2022). *IMPACT OF DIGITAL TRANSFORMATION OF BANKING SECTOR IN RURAL AREAS*. *Positive School Psychology*, 9.
- Neog, N. (2019). *Usage Of Digital Banking Services By Rural Population : A Study In Sivasagar District Of Assam*. *SCIENTIFIC & TECHNOLOGY RESEARCH VOLUME 8*, 4.
- Purnamita Dasgupta (India), J. F. (2015). *Rural Areas*. *researchgate*, 46.
- Development, M. o. (2022, 5 26). *Ministry of Economics and Development*. Retrieved from Ministry of Economics and Development: <http://ldi.nda.gov.mn>
- Mongolia, C. r. (2022, 5 26). *Communication regulatory commission of Mongolia*. Retrieved from Communication regulatory commission of Mongolia: <https://crc.gov.mn/en>
- Dhanraj N., Dr. R. Sai Kumar, “CHALLENGES AND ISSUES OF INDIAN RURAL BANKING INDUSTRY”, *AJRRRLJSM, VOLUME 1, ISSUE 4 (2016, May)*. Ahmad, A. A. (2021). *Digital transformation metrics: a conceptual view*. *Journal of management Information and Decision Sciences*.
- Kumari Nidhi, “E-BANKING IN INDIA: CHALLENGES AND OPPORTUNITIES”, *International journal of science technology and management, Vol. No. 5, Issue No. 8, August 2016*. Ahmad, A. A. (2021). *Digital transformation metrics: a conceptual view*. *Journal of management Information and Decision Sciences*.
- Raghavendra Nayak, “A Conceptual Study on Digitalization of Banking - Issues and Challenges in Rural India”, *International Journal of Management, IT & Engineering, Vol. 8 Issue 6, June 2018*.
- S. MD. SHAKIR ALI, MD. WASIM AKHTAR, S. K. SAFI UDDIN, “DIGITAL PAYMENTS FOR RURAL INDIA - CHALLENGES AND OPPORTUNITIES”, *International journal of Management and Applied Science, Volume-3, Issue-6, Jun.-2017*. Ahmad, A. A. (2021). *Digital transformation metrics: a conceptual view*. *Journal of management Information and Decision Sciences*.
- BCG Report on “Encasing on digital: Financial Services in 2020” Bhavesh J. Parmar, Darshan B. Ranpura, Chirag R.
- Patel, Nainesh kumar P. Patel, “Rural banking through internet: A study on use of internet banking among rural consumers”, *ASIAN JOURNAL OF MANAGEMENT RESEARCH, (2016)*



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ НЬ

Т.Оюунгэрэл¹, Ж.Эрдэнэчулуун²

¹Доктор (Ph.D), СЭЗИС, СУТ

²Магистр (MPM), СЭЗИС, СУТ



Хураангуй

Монголын хөрөнгийн зах зээлийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөлөл, хариу үйлдлийг VAR болон VEC загвараар үнэлэхэд урт хугацаандаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй байгаа бол арилжааны идэвх нь эергээр нөлөөлж байна. Харин богино хугацаанд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь эдийн засагт нөлөөлөл байхгүй ба арилжааны идэвх нь эергээр нөлөөлж байв.

Түлхүүр үг:

Зах зээлийн үнэлгээ,
Арилжааны идэвх, ДНБ,
VAR (вектор авторегесс)
загвар, VEC (вектор алдаа
засварлах) загвар

Удиртгал

Үнэт цаасны зах зээл ба эдийн засгийн өсөлт хоорондын хамаарлын талаар олон судалгааны ажлууд хийгдэж байсан боловч нэгдсэн нэг дүгнэлтэд хүрэлгүй өдий хүрсэн юм. Хөрөнгийн зах зээл хөгжих тусам хадгаламжийг хөдөлгөөнд оруулж, хөрөнгө оруулагчдыг шинээр зах зээлд оруулж ирэх өдөөлтийг өгөх, капиталыг тэгш хуваарилах, компаниудын хөгжлийг дэмжих, эрсдэлийг тараан байршуулах зэрэг нөлөө үзүүлнэ хэмээн таамаг дэвшүүлсний үндсэн дээр судалгааны ажлууд хийгдсэн байдаг боловч тухайн улс орны онцлог байдал, хөрөнгийн зах зээлийн төвлөрөл, засгийн газрын бодлого болон банкны салбарын хөгжил зэргээс хамаарч харилцан адилгүй дүгнэлтүүд гарсан байдаг²⁸. Levine and Zervos (1998), E.Nyanago болон D.Elly (2017), M.S.Nazir, M.M.Nawaz, U.J.Gilani (2010) нар нь бодит эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн хөгжил эерэг нөлөөтэй гэж дүгнэсэн байдаг боловч Harris (1997) нь эдийн засгийн өсөлт болон хөрөнгийн зах зээлийн хөгжил хоорондын хамаарал сулавтар байдаг гэж тайлбарлажээ. Мөн хөрөнгийн зах зээлийн хөгжил нь эсргээрээ хадгаламжийн хэмжээг бууруулж, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ хэмээн B.Wang болон D.Ajit (2015) нар баталсан байдаг. Мөн хэдэн хэдэн судалгааны ажлуудад хөгжингүй, эсвэл буурай хөгжилтэй орон эсэхээс хамаарч, хөрөнгийн зах зээл эдийн засагт харилцан адилгүй нөлөөлж байна хэмээн үзсэн учир онолын хувьд хөрөнгийн зах зээлийн хувьсагчдын тэмдэг тодорхой гэж үзэх нь учир дутагдалтай юм.

²⁸ Najeb M.H Masoud, The impact of stock market performance upon economic growth (2013)

Зах зээлийн мэргэжлийн шинжээчдийн үзэж байгаагаар хөрөнгийн зах зээл нь эдийн засгийн толин тусгал байдаг буюу хувьцааны үнэ өсөх нь ирээдүйн эдийн засгийн эерэг хүлээлтийг илэрхийлдэг гэсэн дүгнэлт зонхилдог²⁹.

Эсрэгээрээ хувьцааны үнэ буурч байвал ирээдүйд эдийн засгийн уналтыг хөрөнгийн зах зээл мэдэрч байна гэсэн үг. Хөрөнгийн зах зээлийн бууралтын үед хөрөнгө оруулагчид ирээдүйд бууралт удаан явагдаж магадгүй гэж үзэн алдагдлаа хаахын тулд хувьцаагаа зарахаар яаран хөрөнгөгүй болж, улмаар хэрэглээгээ хязгаарлахад хүрснээр худалдан авалт хийхээ багасгадаг байна. Ийнхүү борлуулалт буурч компаниуд зардлаа аль болох багасгахыг зорьдог бөгөөд энэхүү бодлого нь ажлын байр шинээр нэмэхгүйгээс гадна ихэнх тохиолдолд цомхотгол ч хийх шаардлагатай болгодог. Мөн хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах хэцүү болж, эх үүсвэрийн дутагдлаас үүдэн зээлийн дарамтад орох эрсдэл үүсэн эдийн засгийг агшаах хүчин зүйл болдог байна³⁰.

Зарим тохиолдолд эдийн засгаас үл хамааран хөрөнгийн зах зээлийн өсөлт бууралт явагддаг. Компанийн хувьцаа хэт өндөр үнэлэгдсэн байх, эсвэл тухайн компани болон салбарын талаарх таагүй мэдээ, мэдээлэл зэрэг нь ханшийн огцом уналтад нөлөөлдөг. Гэвч эдийн засгийн уналтын үед хөрөнгийн зах зээл өсдөг шалтгаан нь одоогийн эдийн засаг тасралтгүй олон жилээр унах магадлал бага буюу буурч л байгаа бол хэзээ нэгэн цагт өсөх нь тодорхой гэсэн найдлагыг хөрөнгө оруулагчид тээж байдаг³¹. Жишээлбэл 2020 оны 3-аас 4-р сарын хооронд хөл хорионоос шалтгаалан АНУ-ын ажилгүйдлийн түвшин 13-14 хувь болсон ч хөрөнгийн зах зээл харьцангуй тогтвортой байв. 33 хоног үргэлжилсэн баавгай зах зээлийн үед ажилгүйдэл, хямрал ихдээ л 6 сараас илүү үргэлжлэхгүй хэмээн тооцоолсон учраас буцаж хувьцааны үнэ өснө гэдэг хүлээлтээс үүдэн хөрөнгө оруулагчид бага үнэ дээр их хэмжээний хувьцаа авснаар хөрөнгийн зах зээл сэргэсэн гэж мэргэжилтнүүд үзсэн байдаг. Мөн өмнөх эдийн засгийн томоохон уналтуудыг харахад заримыг нь хөрөнгийн зах зээл мэдэрсэн жишээнүүд байгаа боловч хамааралгүй тохиолдол ч бий гэдгийг анзаарах хэрэгтэй.

Хөрөнгийн зах зээл өндөр хөгжсөн орнуудад урт хугацаандаа эдийн засгийн өсөлт болон үнэт цаасны зах зээлийн хөгжил нь харилцан уялдаатай, нэг нэгнийгээ дагах хөдөлгөөнтэй байдаг гэж ихэнх судлаачид үзсэн байдаг ч харьцангуй хөгжил буурай манай орны хувьд адилхан үр дүн гарахгүй байх магадлалтай юм. Монголын хөрөнгийн зах зээл нь төвлөрөл ихтэй буюу хөрөнгийн бирж дээрх нээлттэй хувьцааны ихэнх хувийг цөөн хэдэн хүн эзэмшдэг, том хөрөнгө оруулагчдын зүгээс үүсгэх зохиомол үнийн хөөрөгдөл, тоглолтоос үүдэн үнийн хэлбэлзэл явагдах бүрэн боломжтой тул жам ёсоор хөрөнгийн зах зээл тэлж эдийн засагт шууд эерэг нөлөө үзүүлж чадна гэж харахад хэцүү. Эсрэгээрээ эдийн засгийн үзүүлэлтүүд нь хөрөнгийн зах зээлд хүчтэй нөлөөтэй байж болох талтай³².

Сэдвийн судлагдсан байдал

Сүүлийн үеийн судалгаануудын гол суурь зарчим болгож буй хөрөнгийн зах зээл болон эдийн засгийн өсөлтийн хамаарлын талаарх анхдагч, нөлөө бүхий судалгаануудаас дурдвал

²⁹ Ashutosh Duda – A study of interlinkage between stock market and GDP growth (2020)

³⁰ Ross Levine – Finance and Development (March 1996)

³¹ BNY MELLON Asset Management - Stock market VS GDP growth: A Complicated Mixture (2012)

³² А.Гэлэгжамц – Монгол улсын үнэт цаасны зах зээлийн индекс ба макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал, TOP – 20IM загвар (2009)

Atje, Jovanovic (1993) нар нь 1980-1988 оны хоорондох хугацааг хамарсан 40 улсын тоон өгөгдөл дээр шинжилгээ хийж, зах зээлд арилжаалагдсан хувьцааны үнийн дүнгийн хэмжээ ДНБ-д хүчтэй нөлөө үзүүлнэ гэж үзсэн. Мөн Levine, Zervos (1998) нар нь 42 орны 1976-1993 оны хоорондох хугацааны мэдээллийг ашиглан 2 алхамт хамгийн бага квадратын аргаар үнэлсний эцэст хөрөнгийн зах зээлийн тодорхой үзүүлэлтүүд нь бодит эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй байна гэж дүгнэсэн байдаг. Гэвч Harris (1997) нийт 49 орны 1980-1991 оны хоорондох өгөгдөл дээр үнэлгээ хийж, хөрөнгийн зах зээлийн хувьсагчид эдийн засагт үзүүлэх нөлөө хөгжиж буй орнуудын хувьд ямар ч хамааралгүй бол өндөр хөгжилтэй орнуудын хувьд тодорхой хэмжээний нөлөө байгаа боловч статистикийн хувьд ач холбогдол сул байна хэмээжээ.

Сүүлийн үеийн хийгдсэн ажлуудаас авч үзвэл:

- E.Nyanaro, D.Elly (2017) - Хувьцааны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын харьцаа, хувьцааны үнийн хэлбэлзэл зэрэг хувьсагчдыг сонгон авч, VAR загвараар үнэлгээ хийхэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон ДНБ хооронд богино хугацаанд сөрөг хамаарал байгаа ч урт хугацаанд эерэг хамааралтай, харин хөрвөх чадвар эдийн засгийн өсөлт хооронд урт хугацааны эерэг хамааралтай;
- M.Khyareh, V.Oskou (2015) - Хувьцааны зах зээлийн үнэлгээ, хөрөнгө оруулалт, засгийн газрын зардал, M2 мөнгөний нийлүүлэлт, цэвэр экспорт зэрэг хувьсагчдыг ашиглан VEC загвараар үнэлгээ хийхэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон ДНБ харилцан бие биедээ нөлөөлж байна;
- B.Wang, D.Ajit (2015) –Хувьцааны зах зээлийн үнэлгээ, засгийн газрын зардал, M1 мөнгөний нийлүүлэлт зэрэг хувьсагчдаар VAR загвар үнэлгээ хийхэд засгийн газрын зардал, M1 мөнгө ДНБ-д эерэг нөлөөтэй бол хөрөнгийн зах зээлийн өсөлт нь сөрөг нөлөөтэй байна. Мөн хөгжиж буй орнуудын хувьд хөрөнгийн зах зээлийн өсөлт нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна;
- M.S.Nazir, M.M.Nawaz, U.J.Gilani (2010) - Хувьцааны зах зээлийн үнэлгээ, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хүний хөгжлийн индекс, хөрвөх чадварын харьцаа зэрэг хувьсагчдыг ашиглан хамгийн бага квадратын аргаар үнэлгээ хийсэн байна. Судалгааны үр дүнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь хөрвөх чадвараас илүү ДНБ-ий өсөлтөд эергээр нөлөөлж байгаа ба эдийн засагт хамгийн чухал нөлөөтэй нь хүний хөгжлийн индекс байна;
- Z.Jin, K.Guo (2021) - Thermal Optimal Path /TOP/ аргаар Хятадын хөрөнгийн зах зээл нь макро эдийн засгийг хэмжих гол хүчин зүйл болж чадах эсэхийг Америктай харьцуулах замаар судалгаа хийжээ. Судалгааны үр дүнд АНУ-ын хувьд 2013 оноос хойш хөрөнгийн зах зээлийн индексүүд нь макро эдийн засагт нөлөөлж эхэлсэн бол Хятадын хувьд индекс бүр өөр өөр байв. Хэрэглээний индекс нь жижиглэнгийн худалдаанд эерэг сөрөг янз бүрээр нөлөөлж байсан бол үл хөдлөх хөрөнгийн индекс нь харгалзах эдийн засгийн үзүүлэлтэд 2010 оноос хойш нөлөөтэй байна;
- Lenuta Carp (2012) - Зах зээлийн үнэлгээ, хувьцааны нийт арилжаа, хөрвөх чадварын харьцаа, хөрөнгө оруулалт зэрэг хувьсагчдын тоон мэдээллийг ашиглан VAR загвараар үнэлэхэд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны хэмжээ нь ДНБ-

д нөлөө үзүүлэхгүй байна. Харин хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар болон ДНБ нь харилцан бие биедээ нөлөөтэй байна;

- M.Alawin, A.T.Ali, E.Merza (2016) –Хувьцааны зах зээлийн үнэлгээ, хувьцааны нийт арилжаа, хөрвөх чадварын харьцаа зэрэг хувьсагчдаар VAR загвараар үнэлгээ хийж үзэхэд Арабын хувьд хөрөнгийн зах зээлийн бүх хувьсагчид ДНБ-д нөлөөлж байгаа бол Нигерийн хувьд зөвхөн зах зээлийн хөрвөх чадвар нь нөлөөлж байна.

1. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ОНОЛ АРГА ЗҮЙ

1.1. Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч үзүүлэлтүүд

Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлийг тодорхойлохдоо капитал болон хөдөлмөрөөс гадна технологийн дэвшил өндөр хувь нэмэртэй байдаг бөгөөд технологийн дэвшилд хүргэх хүчин зүйлүүдийг судлах шаардлагатай талаар өсөлтийн шинэ онолд дурдсан³³. Тэгвэл үйлдвэрлэлийн функцийг Кобб-Дугласын функц байна гэж үзье.

$$Y = AK^\alpha L^{1-\alpha} \Rightarrow \ln Y = \ln A + \alpha \ln K + (1-\alpha) \ln L \Rightarrow Y = \beta_1 + \beta_2 * K + \beta_3 * L$$

1. Капитал (K) - Биет болон санхүүгийн капитал хэлбэрээр орших ба судалгааны ажилд зөвхөн санхүүгийн капиталыг авч үзэх болно. Санхүүгийн зах зээл капиталыг дахин хуваарилах суваг болдог тул мөнгө болон хөрөнгийн зах зээлийн хувьсагчдыг нөлөөлөгч хүчин зүйлээр авах нь зүйтэй.
2. Бүтээмж (β_1) – Орлогоосоо хэрэглэн үлдсэн хэсгийг хадгалдаг ба хадгаламжаас хөрөнгө оруулалт хийж, капиталыг өсгөдөг. Солоугийн загварын дагуу хадгаламж хөрөнгө оруулалттай тэнцэх цэгт нэг хүнд ногдох капиталын урт хугацааны тэнцвэр оршино гэж үздэг. Гэвч бодит байдал дээр тэнцвэрийн цэгт оршилгүй эдийн засаг өсөж байдаг шалтгаан нь технологийн дэвшлээс үүдэлтэй бөгөөд технологид нөлөөлөгч хүчин зүйлээр дараах 2 үзүүлэлтийг сонгов. Үүнд:
 - *Гадаад худалдааны нээлттэй байдал буюу экспорт* - Экспорт нь эдийн засгийн хамгийн үр өгөөжтэй секторт төвлөрөх үндсийг тавьснаар бүтээмжийг нэмэгдүүлдэг. Экспортоос өндөр ашигтай ажилладаг салбарууд нь бусад салбараас илүүтэйгээр хөрөнгө оруулалт татаж, технологийн дэвшил болон менежментийн ур чадварыг (хөдөлмөр) нэмэгдүүлж, хэрэглээг өсгөдөг байна³⁴.
 - *Гадаадын хөрөнгө оруулалт* – Эмпирик судалгаануудад гадаадын хөрөнгө оруулалт нь технологи болон ноу-хау, менежментийн туршлага зэргийг тухайн оронд шинээр нутагшуулах суваг болдог төдийгүй ажилчдыг мэргэшүүлэн сургах, шинэ ажлын байр бий болгох замаар хүмүүн капиталыг нэмэгдүүлдэг гэж үздэг. Гаднаас хөрөнгө оруулалт татах нь санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлснээр капиталын хуримтлалд эергээр нөлөө үзүүлж, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжихээс гадна тухайн улсын экспортыг нэмэгдүүлэх үндэс

³³ Б.Алтанцэцэг, Б.Отгонтөгс – Макро эдийн засаг (2005)

³⁴ Emery, R.F - The Relation Of Exports And Economic Growth (1967)

болсноор эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй байдаг³⁵. Гэвч гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тухайн улс тэгш хуваарилахгүй бол томоохон корпорацуудын нийгмийн хариуцлага болон ёс зүйн хэм хэмжээ алдагдсанаас хүний нөөц болон байгалийн баялгийн мөлжлөгт өртөх аюул тулгарахад хүрдэг³⁶.

1.2. Эдийн засгийн өсөлтөд санхүүгийн зах зээл нөлөөлөх нь

Санхүүгийн капитал нь хадгаламж эсвэл хөрөнгө оруулалтын хэлбэрээр оршдог бөгөөд банкны салбар болон үнэт цаасны зэх зээл нь хоорондоо салшгүй холбоотой байдаг. Boyd болон Smith (1996) нарын үзэж байгаагаар хөрөнгийн зах зээл болон банкууд нь капиталын эх үүсвэрийн хувьд орлуулахаас илүүтэй хослох шинж чанартай болохыг харуулсан байдаг. Мөн Demircuc-Kunt болон Levine (1996) нарын үзсэнээр хөрөнгийн зах зээлийн хөгжил нь санхүүгийн зуучлалын хөгжилтэй эерэг хамааралтай болохыг харуулсан байна³⁷. Тиймээс мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг орхигдуулах нь учир дутагдалтай бөгөөд мөнгөний нийлүүлэлтийг олон судалгааны ажлуудад санхүүгийн салбарыг илтгэгч үзүүлэлт болгон ашигласан байдаг.

Мөнгөний бодлогын шилжих механизм³⁸

Мөнгөний бодлогын шийдвэр бодит эдийн засагт хэрхэн нөлөөлж байгаа үйл явцыг мөнгөний бодлогын шилжих механизм гэж нэрлэдэг. Төв банк бодлогын хэрэгслээр дамжин мөнгөний нийлүүлэлт, богино хугацааны зээлийн хүү зэрэг нэрлэсэн хувьсагчдыг өөрчилснөөр бодит хувьсагчдад нөлөөлөх бөгөөд хүүний, ханшийн, зээлийн, хөрөнгийн үнийн суваг зэрэг хэд хэдэн сувгаар дамжих боломжтой. Харин хөрөнгийн үнийн сувагт үнэт цаасны зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тайлбарласан байдаг. Үүнд:

- *Тобины q*: Тобины q-ийн онолоор мөнгөний бодлогын шилжих механизм нь үнэт цаасны үнэлгээгээр дамжин эдийн засагт нөлөөлдөг. Мөнгөний хатуу бодлогын үед мөнгөний нийлүүлэлт буурч, үнэт цаас худалдан авах зардал буурах бөгөөд үнэт цаасны эрэлт буурснаар үнэ нь буурна. Ингэснээр пүүсийн зах зээлийн үнэ цэнийг бууруулж, хөрөнгө оруулалтын зардлыг бууруулдаг байна.

$$\text{Тобины } q = \frac{\text{Фирмийн зах зээлийн үнэлгээ}}{\text{Фирмийн нийт хөрөнгийн үнэлгээ}} = \frac{\text{Эзний өмчийн зах зээлийн үнэ}}{\text{Эзний өмчийн дансны үнэ}}$$

- *Баялгийн нөлөө*: Баялгийн суваг нь Франко Модиглиани хэрэглээний амьдралын мөчлөгийн онолоор тайлбарлагддаг. Мөнгөний хатуу бодлогоор үнэт цаасны үнэ буурахад хэрэглэгчийн санхүүгийн баялаг буурах бөгөөд насан туршийнх нь орлогын эх үүсвэр буурч, улмаар хэрэглээг бууруулж, нийт үйлдвэрлэл буурна.

³⁵ Burcu Türkcan & Alper Duman & I. Hakan Yetkiner - How Does FDI and Economic Growth Affect Each Other? The OECD Case (2008)

³⁶ Bornschie, Volker, et al. "Cross-National Evidence of the Effects of Foreign Investment and Aid on Economic Growth and Inequality: A Survey of Findings and a Reanalysis (1978)

³⁷ Д.Батням, Д.Ган-Очир – Монголын хөрөнгийн зах зээлийн загвар (MSMM): Дэлхийн санхүүгийн хямралын эдийн засаг, хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөө (2010)

³⁸ Д.Энхзаяа – Банкны зээлийн суваг (2011)

Санхүүгийн зах зээлийн эдийн засагт нөлөөлөх онолын үндэслэл³⁹

Сэдвийн хүрээний онол, судалгааны ажлуудад ихэвчлэн санхүүгийн зах зээлийн эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах замаар үнэт цаасны зах зээлийн өсөлтөд нөлөөлөх сувгийг тодорхойлсон байдаг. Үүнд:

Мэдээллийн олдоц ба хөрөнгийн хуваарилалт

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын тулд компани болон зах зээлийг үнэлэхэд их хэмжээний зардал гардаг. Хадгаламж эзэмшигчид биеэ даан хамгийн сайн боломжит хөрөнгө оруулалтын хувилбарыг олно гэдэг хүндрэлтэй. Мэдээллийн олдоц муутай аливаа хөрөнгийг эзэмших сонирхолгүй байх ба нөгөө талаар цаг хугацаа, өртөг шаардсан мэдээлэл нь хамгийн сайн капиталд хөрөнгө оруулахгүй байх шалтгаан болдог. Санхүүгийн зуучлагчид мэдээллийг олж авах, боловсруулах зардлыг бууруулж, нөөцийн хуваарилалтыг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг өдөөдөг. Үүнээс гадна санхүүгийн зуучлагчид фирмүүдийн мэдээллийг цуглуулж, боловсруулах явцдаа технологийн хөгжилд хувь нэмэр оруулдаг гэж үздэг.

Фирмд хяналт тавьж, компанийн засаглалыг хэрэгжүүлэх

Компанийн засаглал нь хөрөнгө оруулагчид компанийн капиталын удирдлагыг хэр үр ашигтай хэрэгжүүлж байгааг хянах, шийдвэр гаргах төвшинд оролцох боломжоор хангадаг. Хөрөнгө оруулагчид болон гүйцэтгэх удирдлага нь фирмийн үнэ цэнийг хамгийн өндөр төвшинд барих зорилготой байдаг тул үйл ажиллагааг үр ашигтай байлгах үүднээс бүтээгдэхүүн болон инновацад анхаарах шаардлагатай болдог. Ийнхүү засаглалын нөлөөгөөр компани бүр хамгийн өндөр үр ашигтай түвшинд ажиллахыг зорьдог учир нийт улс орны хэмжээнд үйлдвэрлэлийн огцом өсөлтийг бий болгодог.

Эрсдэлийг тараан байршуулах

Санхүүгийн зах зээлийн зуучлагчдын тусламжтайгаар хедж хийх, тогтвортой өсөлттэй боловч эрсдэл бага байх хөрөнгийг авах боломжтой. Санхүүгийн системд байгаа бүх бүтээгдэхүүнүүд тодорхой эрсдэл дагуулж байдаг тул банк, хамтын сан, хөрөнгө оруулалтын сан зэрэг нь эрсдэлийг тараан байршуулах бодлого баримталдаг. Ингэснээр нөөцийн хуваарилалтыг оновчтой хийж, хадгаламжийн хүүгийн хэмжээнд нөлөөлөх замаар урт хугацааны эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө.

Хадгаламжийг нэгтгэх

Олон хадгаламж эзэмшигчээс хөрөнгө татах нь зардал ихтэй, цаг хугацаа үрсэн явдал юм. Мөн хадгаламж эзэмшигчдийг хөрөнгөө хүссэн үедээ захиран зарцуулах боломжтой гэдэг баталгаа өгөх нь жирийн фирмүүдийн хувьд хүндрэлтэй байдаг. Хувь хүн бүр дан дангаараа хөрөнгө оруулалт хийх нь олуулаа хийснээс үр ашиг муутай байдаг. Өөрөөр хэлбэл, технологийн шинэчлэл нь их хэмжээний капитал шаарддаг бөгөөд хөрөнгийн хязгаарлагдмал байдалд байх нь технологийн эдийн засагт үр өгөөжөө өгөхгүй байх нөхцөлд хүргэдэг.

³⁹ Ross Levine - Finance and Growth: Theory and Evidence, Handbook of Economic Growth (2005)

2. СУДАЛГААНЫ ЭКОНОМЕТРИК ЗАГВАР

2.1. Вектор авторегресс (VAR) загвар

VAR нь олон хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ хийхэд ашиглагддаг загвар бөгөөд тухайн хувьсагчийн өөрийнхөө хоцрогдлын утгууд болон бусад хувьсагчдын өмнөх үеийн утгуудаас хамаарах хамаарлыг шинжилдэг. Энгийн VAR загвар дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$Y_t = \Gamma_1 X_{t-1} + \varepsilon_t$$

Загварын параметруудийг (p) хамгийн их үнэний хувь бүхий (ХИҮХБ) үнэлгээний арга болон хамгийн бага квадратын арга (ХБКА)-аар тус тус тооцдог.

ХИҮХБ үнэлгээ :

Ажиглалтын нягтын функцийг доор харуулав.

$$f(y_t) = (2\pi)^{-m/2} |\Sigma^{-1}|^{1/2} \exp\left[-\frac{1}{2}(y - X\beta)^T \Sigma^{-1}(y - X\beta)\right]$$

y_1, y_2, \dots, y_n хүртэлх ажиглалтын утгын санамсаргүй түүврийн магадлалын функц нь доорх байдлаар илэрхийлэгдэнэ.

$$L(\beta, \Sigma) = \prod_{t=1}^n (2\pi)^{-m/2} |\Sigma^{-1}|^{1/2} \exp\left[-\frac{1}{2}(y - X\beta)^T \Sigma^{-1}(y - X\beta)\right]$$

Тэгвэл үнэний хувь бүхий функцийг бичвэл :

$$\log L(\beta, \Sigma) = -\left(\frac{nm}{2}\right) \log(2\pi) + \left(\frac{n}{2}\right) \log|\Sigma^{-1}| - \left(\frac{1}{2}\right) \sum_{t=1}^n [(y - X\beta)^T \Sigma^{-1}(y - X\beta)]$$

ХИҮХБ үнэлгээг ашиглан үнэний хувь бүхий параметрийн утга :

$$\hat{\beta} = \left[\sum_{t=1}^n x_t^T x_t \right]^{-1} \left[\sum_{t=1}^n x_t^T y_t \right]$$

Σ -ийн үнэлгээ :

$$\hat{\Sigma}^T = \frac{1}{n} \sum_{t=1}^n [\hat{\beta}_t^T \hat{\beta}_t]$$

2.2. Вектор алдаа засварлах загвар (VEC) загвар

Хуурмаг регресс үүсгэхгүйн тулд шинжилгээнд тогтвортой бус хугацаан цувааг ашиглахгүй байх ёстой байдаг ч ихэнх санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд өгөгдсөн төвшиндөө стационар байдаггүй. Хэрэв загварын бүх хувьсагчид тогтвортой бус боловч регрессийн шинжилгээнээс тооцсон алдааны илэрхийлэл нь тогтвортой байх тохиолдолд хувьсагчдыг коинтеграцилагдсан гэж үзнэ. VEC загвар нь стационар биш хувьсагчдын урт хугацааны шугаман хамаарлаар нэмж өргөтгөсөн VAR загварын нэг хэлбэр юм. Өөрөөр хэлбэл хувьсагчид урт хугацааны тэнцвэрт оршиж байвал богино хугацаанд тэнцвэрээс гажих учир

тэнцвэр сахиулагч буюу алдаа засах загварыг (ECM) оруулна. Хоёр хувьсагчийн VEC загварыг дараах байдлаар илэрхийлж болно.

$$\Delta y_t = \alpha_1 + \rho_1 e_1 + \sum_{i=0}^n \beta_i \Delta y_{t-i} + \sum_{i=0}^n \delta_i \Delta x_{t-i} + \sum_{i=0}^n \gamma_i z_{t-i}$$

$$\Delta x_t = \alpha_2 + \rho_2 e_{t-1} + \sum_{i=0}^n \beta_i \Delta y_{t-i} + \sum_{i=0}^n \delta_i \Delta x_{t-i} + \sum_{i=0}^n \gamma_i z_{t-i}$$

3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хүснэгт 1. Судалгаанд ашигласан тоон мэдээлэл

Хувьсагч	Тэмдэглэгээ	Тодорхойлолт	Тайлбар
Бодит ДНБ	RGDP_SA	Улирлын нөлөөг засварласан бодит ДНБ-ий логарифм утга	Эдийн засгийн өсөлтийг хэмжигч
Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	MCAP	Хаалтын ханш болон нийт эргэлтэнд байгаа хувьцааны үржвэрийн логарифм утга	Эмпирик судалгааны ажлуудад хөрөнгийн зах зээлийн хөгжлийг илэрхийлэгч хувьсагчаар авсан байдаг.
Хөрөнгийн зах зээлийн арилжаа	ARIL	МХБ дээрх үнэт цаасны арилжааны дүнгийн логарифм утга	Эмпирик судалгааны ажлуудад хөрөнгийн зах зээлийн хөгжлийг илэрхийлэгч хувьсагчаар авсан байдаг.
Гадаадын хөрөнгө оруулалт	FDI	Гадаадын хөрөнгө оруулалтын орох урсгалын мэдээг оны сүүлийн өдрийн ханшаар хөрвүүлсэн логарифм утга	Онолын хувьд эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч үзүүлэлт
M2 мөнгөний нийлүүлэлт	M2	Мөнгөний нийлүүлэлтийн логарифм утга	Мөнгөний бодлогын хувьсагч
Экспорт	X_SA	Улирлын нөлөөг засварласан нийт экспортын логарифм утга	Онолын хувьд эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч үзүүлэлт
Дамми /чанарын хувьсагч/	DUMMY	2021 онд хөрөнгийн зах зээлд бүтцийн өөрчлөлт үүссэн гэж үзсэн байна.	Загварын экзоген хувьсагч

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

Өнгөрсөн хугацаанд ДНБ-ий хэлбэлзэл харьцангуй бага байсан бөгөөд цар тахлын нөлөөгөөр 2020 онд эдийн засгийн өсөлт үзүүлж чадаагүй ч 2021 онд эдийн засаг бага багаар сэргэн 1.4 хувиар өсжээ. Хөрөнгийн зах зээлийн өсөлт өнгөрсөн жилүүдэд тогтвортой байсан боловч 2021 онд бодлогын хүүгийн бууралт, инфляц, хөл хорионоос болж хойшилсон байсан IPO-аас зэргээс үүдэн огцом өсөлтийг үзүүлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хувьд Оюу толгой төсөлтэй холбоотойгоор 2011 онд хамгийн өндөр

байсан бол 2013 оноос дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн уналт, манай улсын улс төр нийгмийн тогтворгүй байдлаас үүдэн хөрөнгө оруулалт буурч эхэлсэн байна.

Зураг 1. Хувьсагчдын тоон үзүүлэлтүүд



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Манай улсын хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжил тааруухан, зах зээлийн үнэлгээ багатай байснаас үүдэж 2009 он хүртэл хугацаанд эдийн засагт нөлөөлөхүйц хэмжээний байж чадаагүй гэж үзэж байгаа /2000-2022 оныг хамаарсан тоон мэдээллээр үнэлгээ хийхэд ихэнх хувьсагчид статистикийн хувьд ач холбогдол муутай байсан/ тул 2010 оноос хойш хугацааг

хамруулан шинжилгээ хийв. Хувьсагчдын суурийн эсэхийг Augmented Dickey–Fuller (ADF) тестээр шалгаж үзэхэд бүх хувьсагчид I(1) процесс болох нь харагдаж байна.

Хүснэгт 2. ADF тестийн үр дүн

Хувьсагч	ADF test statistic		Тайлбар
	Өгөгдсөн төвшинд	1-р эрэмбийн ялгавар авснаар	
ARIL	0.426922	-3.750685***	Тренд болон тогтмол тоон утгагүй
FDI	0.066065	-3.033677***	Тренд болон тогтмол тоон утгагүй
RGDP_SA	-0.732848	-10.73092***	Тренд болон тогтмол тоон утгатай
M2	-3.043301	-3.767627**	Тренд болон тогтмол тоон утгатай
MCAP	-1.219180	-6.114512***	Тренд болон тогтмол тоон утгатай
X_SA	-3.139084	-6.459021***	Тренд болон тогтмол тоон утгатай

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

3.1. Үнэт цаасны зах зээлийн үзүүлэлтүүд нь бусад хувьсагчдын хамт эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг үнэлэх

Гадаадын хөрөнгө оруулалт болон экспорт нь капитал болон бүтээмжийн хүчин зүйлд нөлөөлдөг талаар дээр дурдсан бөгөөд мөнгөний бодлогын шилжих механизмд мөнгөний нийлүүлэлтээр эдийн засагт нөлөөлөх сувгуудын талаар тайлбарласан байдаг. Тиймээс эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн үзүүлэх нөлөөллийг авч үзэхдээ гадаадын хөрөнгө оруулалт, экспорт, мөнгөний нийлүүлэлт зэрэг хувьсагчдын нөлөөг хамт авч үзэх нь зүйтэй юм.

Тохиромжтой хугацааны хоцрогдлын хэмжээг Akaike Information Criterion (AIC), Schwarz Information Criterion (SC), Hannan Quinn (HQ) шалгуурын дагуу 2 улирлаар сонгосон ба хувьсагчдын хооронд коинтеграцлагч векторын тоо 0-ээс илүү байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 3. Johansen-ий тестийн үр дүн

Unrestricted Cointegration Rank Test (Trace)				
Hypothesized		Trace	0.05	
No. of CE(s)	Eigenvalue	Statistic	Critical Value	Prob.**
None *	0.782752	172.5670	125.6154	0.0000
At most 1 *	0.541345	103.8648	95.75366	0.0123
At most 2	0.438524	68.78922	69.81889	0.0602
At most 3	0.364079	42.81586	47.85613	0.1371
At most 4	0.275638	22.44521	29.79707	0.2744
At most 5	0.144179	7.934341	15.49471	0.4724
At most 6	0.020413	0.928090	3.841465	0.3354
Trace test indicates 2 cointegrating eqn(s) at the 0.05 level				
Unrestricted Cointegration Rank Test (Maximum Eigenvalue)				
Hypothesized		Max-Eigen	0.05	
No. of CE(s)	Eigenvalue	Statistic	Critical Value	Prob.**
None *	0.782752	68.70222	46.23142	0.0001
At most 1	0.541345	35.07556	40.07757	0.1645
At most 2	0.438524	25.97336	33.87687	0.3224

At most 3	0.364079	20.37065	27.58434	0.3161
At most 4	0.275638	14.51087	21.13162	0.3246
At most 5	0.144179	7.006251	14.26460	0.4884
At most 6	0.020413	0.928090	3.841465	0.3354
Max-eigenvalue test indicates 1 cointegrating eqn(s) at the 0.05 level				

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хувьсагчид бүгд ижил эрэмбээр интеграцлагддаг бөгөөд урт хугацааны тэнцвэр оршиж байгаа учир VEC (2) загвараар үнэлгээ хийсэн ба загварын тавил дараах байдалтай байна.

$\Delta(RGDP_SA)$

$$\begin{aligned}
 &= b_0 + b_1\Delta(RGDP_{SA})_{t-1} + b_2\Delta(RGDP_{SA})_{t-2} + b_3\Delta(X_{SA})_{t-1} \\
 &+ b_4\Delta(X_{SA})_{t-2} + b_5\Delta(M2)_{t-1} + b_6\Delta(M2)_{t-2} + b_7\Delta(MCAP)_{t-1} \\
 &+ b_8\Delta(MCAP)_{t-2} + b_9\Delta(ARIL)_{t-1} + b_{10}\Delta(ARIL)_{t-2} + b_{11}\Delta(FDI)_{t-1} \\
 &+ b_{12}\Delta(FDI)_{t-2} - \lambda * (GDP_{SA_{t-1}} - a_0 - a_1 * X_{SA_{t-1}} - a_2 * M2_{t-1} \\
 &- a_3 * MCAP_{t-1} - a_4 * ARIL_{t-1} - a_5 * FDI_{t-1}) + b_{12} * DUMMY + u_t
 \end{aligned}$$

Урт хугацаандаа бүх нөлөөлөгч хувьсагчид болон алдаа засварлагч коэффициент ач холбогдолтой байгаа бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-д сөргөөр нөлөөлөх хандлагатай байгаа бол арилжааны идэвх сайжрах нь эерэг хамааралтай байна.

Хүснэгт 4. VEC (2) Загваруудын урт хугацааны хамаарал

Хувьсагчид	Кoeffициент
M2(-1)	0.601350*** (0.07335)
MCAP(-1)	-0.392825*** (0.05741)
ARIL(-1)	0.042247*** (0.01404)
FDI(-1)	-0.123760*** (0.04022)
X_SA(-1)	0.227812*** (0.06395)
Алдаа засварлагч коэффициент	-0.706395*** (0.20951)
Засварлагдсан R²	0.455146

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Зураг 2. VEC(2) Загвар дахь шокуудад үзүүлэх ДНБ-ий хариу үйлдэл

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний шок



Арилжааны идэвхийн шок



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Гаднаас үзүүлэх шокийн нөлөөгөөр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1 стандарт хазайлтаар өөрчлөгдөхөд ДНБ-д 2-р улирлаас эхлэн сөрөг нөлөө үзүүлэх ба 10-р улирлаас эхлэн нөлөө нь буурч байна. Харин арилжааны идэвх нь 2-р улирлаас эхлэн эергээр нөлөөлж байгаа бөгөөд энэ нөлөө нь арилахгүй хадгалагдсаар байна. Гэвч богино хугацааны хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүдийн коэффициентууд нь загварын үнэлгээгээр ач холбогдолгүй гарчээ.

Дараачийн улиралд ДНБ-ий хэлбэлзлийн 19 хувийг арилжааны идэвхийн өөрчлөлт тайлбарлаж байна. Арилжааны идэвхийн ДНБ-ий хэлбэлзлийг тайлбарлах хувь цаг хугацаа өнгөрөх тусам багасаж байгаа бол зах зээлийн үнэлгээ нь эхний улирлуудад ДНБ-ий хэлбэлзлийг тайлбарлаж чадахгүй байгаа бөгөөд дунд хугацаанд өөрчлөлтийн 7 хувийг тайлбарлаж байна.

Хүснэгт 5. VEC(2) Загваруудын вариацийн задаргаа

Хугацаа	MSAP	ARIL
1	0.000000	0.000000
2	0.603079	18.74830
3	0.480411	16.51694
4	1.966271	17.65243
5	2.930637	16.24697
6	4.612166	15.79085
7	5.777968	14.52713
8	6.548657	13.87264
9	7.039131	13.12263
10	7.158179	12.75135

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

3.2. Үнэт цаасны зах зээлийн үзүүлэлтүүд дангаараа эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөллийг үнэлэх

Дээр дурдсан загварт эдийн засгийн өсөлтөд үнэт цаасны зах зээлийн үзүүлэх нөлөөллийг тооцохдоо онолын хувьд нөлөөлөх бусад хүчин зүйлсийг хамт оруулав. Харин зөвхөн хөрөнгийн зах зээлийн хувьсагчид өсөлтөд хэрхэн нөлөөлөх талаар авч үзье. Хувьсагчдад коинтеграц хамаарал байхгүй учраас VAR (2) загвар үнэлэв. Хөрөнгийн зах зээлийн хувьсагчид хамтаараа бодит ДНБ-д үзүүлэх нөлөөллийг тооцсон загварыг VAR 1, зөвхөн арилжааны идэвхийн үзүүлэх нөлөөллийг тооцсон загварыг VAR 2, зөвхөн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ дангаараа ямар нөлөө үзүүлэхийг харуулсан загварыг VAR 3 гэж нэрлэвэл

загварын үнэлгээний коэффициентууд дараах байдалтай байна.

Хүснэгт 6. VAR (2) Загваруудын харьцуулалт


Хувьсагчид	VAR 1	VAR 2	VAR 3
D(MCAP(-1))	-0.037903 (0.07840)		-0.057114 (0.07576)
D(MCAP(-2))	0.069547 (0.07951)		0.007248 (0.07776)
D(ARIL(-1))	0.056567 (0.04477)	0.048026 (0.04261)	
D(ARIL(-2))	-0.109843** (0.04596)	-0.098777** (0.04271)	
Засварлагдсан R²	0.181614	0.201281	0.105648


Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний коэффициентууд ач холбогдолгүй, харин арилжааны идэвхийн 2 дахь хугацааны хоцрогдлын коэффициент ач холбогдолтой байгаа бөгөөд дан арилжааны идэвхээр үнэлсэн загварын детерминацийн коэффициент хамгийн өндөр байна. Гэвч өмнө үнэлсэн VEC загвартэй харьцуулахад VAR загваруудын үнэлгээ нь тайлбарлах чадвар харьцангуй муу байна.

Хариу үйлдлийн функцээс харвал хөрөнгийн зах зээлийн үнэлгээний хэлбэлзэл ДНБ-д нөлөөгүй байгаа бол арилжааны идэвх нь VEC загваруудтай харьцуулахад бага хэмжээгээр 2-р улиралд эерэг, 3-р улиралд сөрөг нөлөө үзүүлж байна.

Зураг 3. VAR(2) Загвар дахь шокуудад үзүүлэх ДНБ-ий хариу үйлдэл





Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Дараачийн улиралд ДНБ-ий хэлбэлзлийн 2.7-3.5 хувийг арилжааны идэвхийн өөрчлөлт тайлбарлаж байна.

Хүснэгт 7. VAR(2) Загваруудын вариацийн задаргаа

Хугацаа	VAR 1		VAR 2	VAR 3
	D(MCAP)	D(ARIL)	D(ARIL)	D(MCAP)
1	0.000000	0.000000	0.000000	0.000000
2	0.041598	3.501929	2.712756	0.973752
3	0.270632	12.54459	10.46763	1.036696
4	0.286572	12.26180	10.23284	1.239844
5	0.325859	13.32047	11.37556	1.263655
6	0.364635	13.27853	11.33275	1.291521
7	0.389930	13.43006	11.55290	1.294907
8	0.401204	13.42225	11.54384	1.297865
9	0.407436	13.45622	11.58977	1.298194
10	0.410258	13.45459	11.58796	1.298458

ДҮГНЭЛТ

Судалгааны ажлаар Монголын үнэт цаасны зах зээлийн үзүүлэлтүүд нь эдийн засгийн өсөлтөд үзүүлж байгаа нөлөөллийг тодорхойлохыг зорьсон бөгөөд эдийн засгийн өсөлтийг ДНБ-ээр төлөөлүүлэн авсан бол хөрөнгийн зах зээлийг илэрхийлэгч хувьсагчдаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг тус тус сонгон авав. Мөн эдийн засагт нөлөөлөх бусад хувьсагчууд болох экспорт, гадаадын хөрөнгө оруулалт, M2 мөнгөний нийлүүлэлт зэрэг үзүүлэлтүүдийг үнэлгээнд орууллаа.

VEC (2) загварын үнэлгээний үр дүнд ДНБ-ийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ сөргөөр, арилжааны идэвх эергээр нөлөөлөх хандлага ажиглагдаж байв. Богино хугацаанд арилжааны идэвхийн эерэг нөлөө хадгалагдаж байгаа бол хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нөлөөлөхгүй байна.

Бодит ДНБ-ийг хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон арилжааны идэвх зэрэг хувьсагчдаас хамааруулан VAR (2) загварууд үнэлсэн бөгөөд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-д нөлөөгүй байгаа бол арилжааны идэвх нь 2-р улиралд эерэг, 3-р улиралд сөрөг нөлөө үзүүлж байна. Гэвч VEC (2) загвартай харьцуулахад тайлбарлах чадамж муу байгаа ба ДНБ-ий хэлбэлзэлд нөлөөлж буй хэмжээ нь харьцангуй бага байв.

Загварын үнэлгээнүүдийг нэгтгэж харвал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь эдийн засгийн өсөлтөд богино хугацаанд нөлөө үзүүлэхгүй гэсэн дүгнэлт гарч байгаа нь Harris (1997); Lenuta Carp (2012) нарын судалгааны ажлын үр дүнтэй нийцэлтэй байна. Нөгөө талаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөх нь эдийн засгийн өсөлтийг урт хугацаандаа дэмжихгүй байна гэсэн дүгнэлтийг VEC (2) загваруудын үнэлгээнээс харж болох бөгөөд V.Wang, D.Ajit (2015) нарын судалгааны дүгнэлттэй таарч байна. Арилжааны идэвхийн хувьд эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлөх хандлагатай байгаа нь Atje, Jovanic (1993); M.Alavin, T.Ali, E.Merza (2016) нарын дэвшүүлсэн санаатай адил байна. Мөн арилжааны идэвх нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээнээс илүү эдийн засгийн өсөлтөд нөлөөтэй байгаа нь судалгааны үр дүнгээр батлагдлаа.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- R. Atje, B.Jovanovic. (1993). Stock markets and development. *European Economic Review*. vol. 37, issue 2-3, 632-640.
- R. Harris. (1997). Stock markets and development: A re-assessment. *European Economic Review*. vol. 41, issue 1, 139-146.
- Enock Nyanaro, Duncan Elly. (2017). The Relationship between Stock Market Performance and Economic Growth In the East African Community. *African development finance journal*. Vol 1, No.1, 110-132.
- Mohsen Mohammadi Khyareh, Vahid Oskou. (2015). The effect of Stock market on Economic Growth: The case of Iran. *International Journal of Academic Research in Economics and Management Sciences*. Vol. 4, No. 4, 52-61.
- Najeb Masoud. (2013). The Impact of Stock Market Performance upon Economic Growth. *International Journal of Economics and Financial Issues*. Vol. 3, No. 4, 788-798.
- Baotai Wang, D. Ajit. (2013). Stock Market and Economic Growth in China. *Economics Bulletin*. vol. 33, issue 1, 95-103.
- Mian Sajid Nazir, Muhammad Musarat Nawaz, Usman Javed Gilani. (2010). Relationship between economic growth and stock market development. *African Journal of Business Management*. Vol. 4(16), 3473-3479.
- Ashutosh Duda. (2020). A Study Of Interlinkage Between Stock Market And Gdp Growth. *European Journal of Molecular & Clinical Medicine*. Vol 7, Issue 10, 3860-3866.
- Zhenni Jin, Kun Guo. (2021). The Dynamic Relationship between Stock Market and Macroeconomy at Sectoral Level: Evidence from Chinese and US Stock Market. *Complexity*. vol. 2021, Article ID 6645570. 1-16.
- Ross Levine, Sara Zervos. (1997). Stock Market Development And Long-Run Growth. *The World Bank Economic Review*. Vol 10, No 2, 323-339.
- BNY MELLON Asset Management. (2012). Stock Market Vs Gdp Growth: A Complicated Mixture. *Viewpoint*. 1-9.
- Lenuta Carp. (2012). Can Stock Market Development Boost Economic Growth? Empirical Evidence from Emerging Markets in Central and Eastern Europe. *Procedia Economics and Finance*. Vol 3, 438-444.
- Mohammad Alawin, Adnan Tariq Ali, Ebrahim Merza. (2018). The relationship between Economic Growth and Stock Market. *International Journal of Advances in Management and Economics*. Vol.7,

- Ross Levine. (1996). Stock Markets: A spur to Economic growth. *Finance and Development*. Finance & Development. 0033, 7-10.
- А.Гэлэгжамц. (2009). Монгол улсын үнэт цаасны зах зээлийн индекс ба макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал, TOP-20IM загвар.
- Emery, R.F. (1967). The Relation Of Exports And Economic Growth. *Kyklos*, 20: 470- 486.
- Burcu Türkcan & Alper Duman & I. Hakan Yetkiner. (2008). How Does FDI and Economic Growth Affect Each Other? The OECD Case, *Proceedings of the Conference on Emerging Economic Issues in a Globalizing World*, pages 21-40.
- Bornschiefer, Volker, et al. (1978). Cross-National Evidence of the Effects of Foreign Investment and Aid on Economic Growth and Inequality: A Survey of Findings and a Reanalysis. *American Journal of Sociology*, vol. 84, no. 3, pp. 651–83.
- Б.Алтанцэцэг, Б.Отгонтөгс. (2005). Макро эдийн засаг, УБ хот.
- Д.Батням, Д.Ган-Очир. (2010). Монголын хөрөнгийн зах зээлийн загвар (MSMM): Дэлхийн санхүүгийн хямралын эдийн засаг, хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөө.
- Д.Энхзаяа. (2011). Банкны зээлийн суваг, Монголбанк судалгааны ажлын товхимол – 7, 159-174.
- Ross Levine. (2005). *Finance and Growth: Theory and Evidence*, Handbook of Economic Growth, Volume 1, Part A. Chapter 12.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ISBN: 978-9919-9906-1-9

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН I АНГИЛЛЫН ХУВЬЦААНЫ ӨГӨӨЖИЙН ХЭЛТИЙЛТ БОЛОН ОВОЙЛТЫН ЭМПИРИК СУДАЛГАА

Г.Ичинноров¹, Г.Цэлмэг²

¹Магистр (MBA), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

²Магистр (MBA), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль



Түлхүүр үг:

ТОП-20 индекс, KASE
индекс, I ангиллын хувьцаа

Хураангуй

Япон, АНУ зэрэг улсуудын хөрөнгийн бирж дээрх хувьцаануудын өгөөжийн тархалт нь хэвийн бус тархалттай байдаг нь өмнөх олон улсын судалгааны ажлуудаар батлагдсан байна. Хэрвээ хувьцааны өгөөжийн тархалт хэвийн бус байгаа тохиолдолд уламжлалт аргаар буюу өгөөжийн тархалтыг хэвийн тархалттай гэж үзэн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах нь оновчгүй байдаг. Энэхүү судалгааны ажлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн I ангиллын 23 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалтыг судаллаа.

Судалгааны үр дүнд Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 23 компанийн 22 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалтууд нь хэвийн бус тархалттай мэдэгдэхүйц хэлтийлтэй болон овойлттой байна. Иймд цаашид дотоодын хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтдаа энэхүү мэдэгдэхүйц хэвийн бус тархалтыг тусгаж байх нь зүйтэй. Мөн Монгол Улс болон Казакстан улсын хөрөнгийн биржийн индексийн сарын өгөөжийн тархалтуудыг харьцуулан судалсан бөгөөд судалгааны үр дүнд уг өгөөжүүд нь ижилхэн хэвийн бус тархалттай, баруун тал руугаа бага болон мэдэгдэхүйц хэлтийсэн байдалтай байна.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажил нь дараах үндсэн зорилготой. Үүнд:

- Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 23 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн хэвийн тархалт, хэлтийлт, овойлтыг тодорхойлох;
- Казахстаны KASE болон Монголын ТОП-20 индексийн хувьцааны сарын өгөөжийн хэвийн тархалт, хэлтийлт, овойлтын харьцуулсан судалгаа хийх.

Судлагдсан байдал

Ангел Леон, Гонзало Рубио, Грегорио Серна (Leon, Rubio, & Serna, 2005) нарын Авто регрессийн нөхцөлт хэлбэлзэл, хэлтийлт болон овойлт судалгааг GARCHSK болон NAGARCHSK загвараар ам.доллартай харьцах 4 ханш, таван хувьцааны индекс болон хөгжиж буй зах зээлийн индекс болох MEXBOL /Мексик/-ийн өдөр тутмын өгөөж дээр шинжилгээ хийсэн бөгөөд судалгааны үр дүнгээр мэдэгдэхүйц нөхцөлт хэлтийлт болон овойлт байгааг илрүүлсэн. Түүнээс гадна цаг хугацааны хувьд өөрчлөгддөг хэлтийлт болон овойлтын техникийн үзүүлэлтүүд нь тогтмол гурав болон дөрөв дэх үеийн техникийн үзүүлэлтүүдээс давж гардаг нь тогтоогдсон. Александрос Габриельсен (Gabrielsen, Kirchner, Liu, & Zagaglia, 2015) Экспоненциалаар жинлэсэн хөдөлгөөнт дунджаар хугацааны өөрчлөлттэй вариаци, хэлтийлт болон овойлттой VAR-ыг урьдчилан таамаглах сэдэвт судалгаагаар 1991-2011 оны S&P 500, NASDAQ, FTSE 100, DAX 30, CAC 40 индексийн өгөөжүүдэд хамгийн их магадлалын үнэлгээний аргаар шинжилгээ хийсэн бөгөөд хэлбэлзлийн үйл явцын уналтын хүчин зүйл нь Riskmetric-ийн өдөр тутмын өгөөжийн цувралд ашигладаг уналтын хүчин зүйлтэй харьцуулахад өссөн ба нийт хэлтийлт болон овойлтын уналтын хүчин зүйлтэй харьцуулахад их байгаа нь ажиглагдсан байна.

Маркус Хаас (Haas, 2009) Хэлтийсэн Гаусс-Лапласын нийлбэр тархалтаар хэлтийлт болон овойлтыг загварчлах нь сэдэвт судалгаагаар 1990-2007 оны DJIA, NASDAQ, S&P500 индексийн өдрийн өгөөжүүдийн хувьд шинжилгээ хийж судалгааны үр дүнд бүх тэгш бус тархалтын хувьд бүх тооцоолсон хэлтийлтийн параметрууд нь нэгдмэл байдлаас ихээхэн ялгаатай, SGLaS тархалтын хувьд стандартчилагдсан үлдэгдэл нь бүх гурван цувралын хувьд мэдэгдэхүйц хэлтийлт эсвэл илүүдэл овойлтыг харуулдаггүй бөгөөд бусад тархалтын хувьд эсрэг үр дүнг харуулж байгааг олж илрүүлжээ. Ричард Д.Ф. Харрисын (D.F. Harris, Küçüközmen, & Yilmaz, 2004) Хөрөнгийн өдрийн өгөөжийн нөхцөлт тархалтын хэлтийлт сэдэвт судалгаагаар хөрөнгийн зах зээлийн 5 индексийн 1969-1999 оны өдрийн өгөөжүүдийн хувьд шинжилгээ хийж судалгааны үр дүнд нөхцөлт SGT тархалтыг ашиглах нь GARCH болон EGARCH загваруудын тохирох байдлыг мэдэгдэхүйц сайжруулдаг болох нь тогтоогдсон. Мөн хоёр загварын хувьд хэвийн, Student-t болон хүчний экспоненциал тархалтаас үүдэлтэй SGT-ийн хязгаарлалтыг үгүйсгэсэн байна.

Маркку Ланнегийн (Lanne & Pentti, 2007) Хувьцааны өгөөжийн нөхцөлт хэлтийлтийг загварчлах сэдэвт судалгаагаар хувьцааны өгөөжийг загварчлахдаа нөхцөлт хэвийлтийг тооцох /оруулах/ нь чухал бөгөөд хэлтийсэн z тархалт дээр үндэслэн GARCH-M загвараар таамагласан нөхцөлт вариаци нь бодит вариацитай илүү ойр байсан ба таамагласан илүүдэл өгөөжийн бодит утгаас хазайх хазайлт нь гайхалтай бага байжээ. Хон-Шиан Лау (Lau & Wingender, 1989)-ийн Хувьцааны өгөөжийн хэлтийлт ба овойлтын интервалын нөлөөг задлан шинжлэх нь сэдэвт судалгаагаар зөрүүтэй интервал болон логарифм өгөөжийн хэлтийлт ба овойлтын зөв хамаарлыг харуулсан бөгөөд логарифм болон энгийн өгөөжийн интервалын нөлөө нь маш их ялгаатай ба эдгээр өгөөжүүдийг андуурч болохгүй талаар зөвлөмжийг өгчээ.

Дешиан Мей (Mei, Liu, Ma, & Chen, 2017)-ийн Хувьцааны зах зээлийн хэлбэлзлийг урьдчилан таамаглах: Хэрэгжсэн хэлтийлт болон овойлт нь тусалдаг эсэх сэдэвт судалгаагаар SSEC, S&P500 индексүүдийн 1996-2014 оны өдрийн өгөөжүүдийг ашигласан бөгөөд RSK /realized skewness/, RKU /realized kurtosis/-г HAR-RV загварт нэмэлт хувьсагч

болон нэмж тэдгээр хувьсагч нь таамаглалын нарийвчлалыг сайжруулж байгаа эсэхийг судалсан. Судалгааны үр дүнд RSK, RKU аль аль нь богино хугацааны таамаглалын нарийвчлалыг сайжруулж чадахгүй бөгөөд RSK нь дунд болон урт хугацааны таамаглалд ихээхэн тусалж чадна гэдгийг олж илрүүлжээ. Женнифер Конрад (Conrad, Dittmar, & Ghysels, 2013) Урьдчилсан хэлтийлт болон хүлээгдэж буй хувьцааны өгөөж сэдэвт судалгаагаар 1996-2005 оны опционы үнийн түүврийн хувьд Бакши (Bakshi, Kapadia, & Madan, 2003) нарын үнэт цаасны эрсдэл-саармаг нягтын функцийг ашигласан. Судалгааны үр дүнд хэлтийлт нь дараа үеийн өгөөжтэй хүчтэй сөрөг хамааралтай бөгөөд бага сөрөг болон эерэг хэлтийлттэй пүүсүүд бага өгөөж хүртдэг буюу хөрөнгө оруулагчид эерэг хэлтийлтийг илүүд үздэг бол овойлт болон өгөөж нь эерэг хамааралтайг тус тус илрүүлжээ.

Раж Аггарвал (Aggarwal, Rao, & Hiraki, 1989)-ын Японы хувьцааны өгөөжийн хэлтийлт болон овойлтын эмпирикал нотолгоо сэдэвт судалгаагаар Токиогийн I ангилалд бүртгэлтэй 488 хувьцааны 1965-1984 оны сарын өгөөжүүдийг ашигласан бөгөөд судалгааны үр дүнд Японы хувьцааны өгөөжийн тархалт нь мэдэгдэхүйц болон тогтвортой хэлтийлт болон овойлттой байсныг олж тогтоожээ. Жин-И Лай (Lai, 2012)-ын Хеджийн шийдвэр гаргалтад хэлтийлт болон овойлт нөлөөлөх нь: Эмпирик судалгаа сэдэвт судалгаагаар 2000-2008 оны Brentын газрын тосны фьючерс болон спот үнийн хаалтын ханшийг ашиглан өгөөжийг тооцож судалгаа хийсэн бөгөөд судалгааны үр дүнд газрын тосны өгөөжийг GARCH процесст ARCH төрлийн хэлтийлт болон овойлтын параметруудээр загварчлах замаар өгөөжийн цаг хугацааны өөрчлөлтийн дээд моментыг амжилттай олж болох бөгөөд шинжилгээгээр SU-normal model нь өгөгдөлд маш сайн нийцэж байгааг олж илрүүлсэн байна.

Бурчу Арациоглу (Bircu, Fatma, & Haluk, 2011)-ын Багцыг оновчтой болгох дундаж вариаци, хэлтийлт, овойлтын арга: Истанбулын хөрөнгийн биржийн жишээ сэдэвт судалгаагаар ISE-30 индексийн 30 хувьцааны сүүлийн 5 жилийн өдрийн өгөөжийн хувьд PGP загварыг ашиглан шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд хөрөнгө оруулагчийн үнэт цаасны сонголт нь багцын хөрөнгийн хуваарилалт болон хөрөнгийн өгөөжийн тодорхойлогч статистикт нөлөөлдөг болохыг илрүүлсэн. Петр Кристофферсен, Диего Амая (Amaya, Christoffersen, Jacobs, & Vasquez, 2011) нарын хэрэгжсэн хэлтийлт болон овойлт нь хувьцааны өгөөжийн хөндлөн огтлолыг урьдчилан таамаглах эсэх сэдэвт судалгаагаар Trade and Quote (TAQ)-д бүртгэлтэй бүх хувьцааны 1993-2008 хувьд шинжилгээ хийсэн ба судалгааны үр дүнд хэрэгжсэн хэлтийлт болон овойлт нь дараа долоо хоногийн хувьцааны өгөөжийн хөндлөн огтлолыг урьдчилан таамаглаж байсан бол хэрэгжсэн хэлбэлзэл нь таамаглаж чадахгүй байгааг олж илрүүлсэн. Мөн хэрэгжсэн хэлтийлт нь ирээдүйн хувьцааны өгөөжтэй сөрөг хамааралтай бол хэрэгжсэн овойлт нь ирээдүйн хувьцааны өгөөжтэй сөрөг хамааралтай бөгөөд хэрэгжсэн хэлтийлт болон хэлбэлзлийг давхар ангилах үед сөрөг хэлтийлттэй хувьцаанууд ирээдүйн өндөр өгөөжөөр нөхөгддөг болохыг олж мэджээ. Гэсэн хэдий ч хэлтийлт нэмэгдэж эерэг болох тусам хэлбэлзэл болон өгөөжийн эерэг хамаарал нь сөрөг хамаарал болон хувирдаг байна.

Гордон Танг (Tang, 1996) Долоо хоногийн өдөр нь хэлтийлт болон овойлтод үзүүлэх нөлөө: Шууд тест ба багцын нөлөө сэдэвт судалгаагаар 1981-1992 оны зургаан улсын индексийн өдрийн өгөөжийг ашигласан бөгөөд судалгааны АНУ-аас бусад бүх хувьцааны зах зээлийн хэлтийлт болон овойлтод долоо хоногийн өдөр нөлөө үзүүлдэг байна. Мөн хэлтийлтийг

зөвхөн мягмар гаригт тараан байршуулах замаар арилгах боломжтой бол пүрэв гаригаас бусад бүх ажлын өдрүүдэд овойлтыг төрөлжүүлэх боломжтой талаар олж мэдсэн бөгөөд хувьцааны өгөөж хэвийн тархаагүй үед олон улсын хэмжээнд тараан байршуулалт хийх нь үргэлж ашигтай байддаггүй талаар хөрөнгө оруулагчдад зөвлөжээ.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаагаар Монгол улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгаа I ангиллын нээлттэй 23 компаниудын хувьцаануудын нэг өдрийн өгөөжүүдийн тархалт нь хэр хэлтийлттэй (Skewness) болон овойлттой (Kurtosis) болохыг тодорхойлохыг зорьсон. Энэ зорилгодоо хүрэхийн тулд судалгаандаа Фишер-Пирсоны хэлтийлт болон овойлтын коэффициент тооцох арга, Жаркү-Берагийн хэвийн тархалтын коэффициент тооцоолох аргуудыг ашигласан.

1. Фишер-Пирсоны хэлтийлтийн коэффициент тооцоолох томъёо (Brooks, 2014):

$$\text{Хэлтийлт} = \frac{1}{N} * \sum_{1}^n \left(\frac{y_i - \bar{y}}{\sigma} \right)^3$$

σ – стандарт хазайлт, n – ажиглалтын тоо, \bar{y} – дундаж утга, y_i – ажиглалтуудын утга

2. Фишер-Пирсоны овойлтын коэффициент тооцоолох томъёо (Brooks, 2014):

$$\text{Овойлт} = \frac{1}{N} * \sum_{1}^n \left(\frac{y_i - \bar{y}}{\sigma} \right)^4$$

σ – стандарт хазайлт, n – ажиглалтын тоо, \bar{y} – дундаж утга, y_i – ажиглалтуудын утга

3. Жаркү-Берагийн хэвийн тархалтын коэффициент тооцоолох томъёо (Brooks, 2014):

$$\text{Жаркү – Бера} = \frac{N}{6} * \left(S^2 + \frac{(K - 3)^2}{4} \right)$$

n – ажиглалтын тоо, S – хэлтийлт, K – овойлт

Дээрх томъёонуудаар 24 компанийн өгөөжүүдийн хэлтийлт, овойлт, хэвийн тархалтыг тооцоолохдоо статистикийн Eviews програмыг ашиглалаа.

Судалгааны үр дүн


Судалгаанд Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 23 компанийн 2007-2023 хоорондох хувьцаануудын өдрийн өгөөжүүдийн өгөгдлийг ашиглалаа. 23 компанийн нийт 30,000 өдрийн өгөөжийн мэдээллийг судалгаандаа ашигласан болно. Нэг компанийн дунджаар 1,306 өдрийн өгөөжийн мэдээлэл дээр шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнгээс харахад 23 Компанийн хувьцааны өдрийн дундаж өгөөж нь 0.13 хувь боловч медиан өгөөж нь -0.02 хувь байсан байна. Мөн 23 компанийн хувьцааны 1 өдрийн өсөлтийн дээд хувь дунджаар 30.5 хувь харин 1 өдрийн бууралтын дээд хувь дунджаар -18.8 хувь байсан байна.

1. Хэлтийлт:

Нийт 23 компаниас 5 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн хэлтийлтийн коэффициент 0.5-аас бага гарсан буюу хэвийн хэлтийлттэй, 7 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн

тархалтын хэлтийлтийн коэффициент нь 0.5-1.0 хооронд гарсан буюу бага зэргийн хэлтийлттэй гарсан. Харин 11 компанийн хэлтийлтийн коэффициент 1.0-ээс их гарсан нь мэдэгдэхүйц хэлтийлттэй байна. Бага зэргийн болон мэдэгдэхүйц хэлтийлттэй компанийн тоо 18 байгаа нь I ангиллын компаниудын 82 хувийг эзэлж байна. Эдгээр 18 компаниас 17 компанийн хэлтийлтийн коэффициент нь эерэг 0.5-17.9 гарсан. Ганцхан “Голомт банк” ХК-ийн хувьцааны өдрийн өгөөжийн хэлтийлт нь сөрөг буюу -1.34 гарсан байна. Харин “Таван Толгой” ХК-ийн өдрийн өгөөжийн тархалт нь хамгийн өндөр хэлтийлттэй буюу 17.9 гарсан байна.

График. 1 I ангиллын 23 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалтын хэлтийлтийн коэффициент (2007-2023 он)




Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

2. Овойлт:

Нийт 23 компаниас 1-ээс бусад компанийн хувьцааны өдрийн өгөөжийн овойлтын коэффициент нь 5.6-715 байна. Энэ нь I ангиллын 23 компанийн 22 буюу 95 хувь нь өндөр овойлттой байна.

График. 2 I ангиллын 23 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалтын овойлтын коэффициент (2007-2023 он)



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

3. Хэвийн тархалт:

Ганцхан “Мик холдинг” ХК-ийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалт нь хэвийн тархалттай бусад 22 компанийн өдрийн өгөөжийн тархалт нь хэвийн бус тархалттай байна /Хавсралт 1-ээс Жаркү-Берагийн тест статистикийн утгыг харна уу/. Үлдсэн 22 компанийн өдрийн өгөөжийн тархалт хэвийн бус тархалттай буюу мэдэгдэхүйц хэлтийлт, овойлттой байна.


ТОП-20 болон KASE индексийн харьцуулсан судалгаа

Монгол Улсын ТОП-20 индекс болон Казакстан улсын KASE индексийн өгөөжийн тархалтыг харьцуулан судаллаа. Уг харьцуулсан шинжилгээгээр хоёр улсын хөрөнгийн биржийн индексийн сарын өгөөжийн тархалт нь хоёулаа хэвийн бус тархалттай, баруун тал руугаа хэлтийсэн хэлбэртэй байна. KASE индексийн сарын өгөөжийн тархалт нь бага зэрэг хэлтийлттэй бол ТОП-20 индексийн сарын өгөөж нь мэдэгдэхүйц баруун тал руугаа хэлтийсэн байдалтай байна. Хоёр улсын хөрөнгийн биржийн сарын өгөөжийн тархалтын статистик үзүүлэлтийг Хүснэгт 1-т харууллаа.

Хүснэгт. 1 ТОП-20 болон KASE индексийн харьцуулалт (2000-2023 он)

Үзүүлэлт	KASE	TOP-20
Дундаж	1.7%	2.3%
Медиан	1.1%	0.5%
Хамгийн их сарын өгөөж	54.8%	66.2%
Хамгийн бага сарын өгөөж	-36.7%	-19.2%
Стандарт хазайлт	9.1%	10.7%
Хэлтийлт	0.896762	2.458781
Овойлт	10.45361	13.86952
Жаркү-Бера тест	666.1	1,613
Хэвийн тархалттай байх магадлал	0.0000	0.0000
Ажиглалтын тоо	272	272

График. 3 ТОП-20 болон KASE индексийн харьцуулалт (2000-2023 он)



Судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй 23 компанийн 1 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалт нь хэвийн, 1 компанийн тархалт нь зүүн тал руугаа хэлтийсэн хэвийн бус тархалттай, 21 компани нь тархалт нь баруун тал руугаа хэлтийсэн хэвийн бус тархалттай байна. I ангиллын 23 компаниас 22 компанийн өдрийн өгөөжийн тархалт нь хэвийн бус тархалттай. Тус 22 компанийн 21 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалт нь баруун тал руугаа буюу эерэг өгөөж өгөх тал руугаа хэлтийсэн байдалтай байна. Баруун тал руугаа хэлтийсэн өгөөжийн тархалттай 21 компанийн хувьд өдрийн өгөөжийн хувь нь дунджаасаа доогуур байх магадлал нь дунджаасаа дээгүүр байх магадлалаас их байгааг харуулж байна. Мөн дундажтайгаа харьцуулахад огцом их хэмжээний өгөөж өгөх тохиолдол нь огцом бага өгөөж өгөхөөс олон тохиолдож байсан байна.

Ганцхан Голомт банкны өдрийн өгөөжийн тархалт нь зүүн тал руугаа хэлтийсэн байдалтай байгаа нь өдрийн дундаж өгөөжөөсөө илүү өгөөж өгөх магадлал нь өндөр байсан байна. Гэхдээ Голомт банкны хувьцааны өдрийн дундаж өгөөж -0.28 хувь, медиан өгөөж нь -0.17 хувь байсан байна. Мөн Монгол Улс болон Казакстан улсын хөрөнгийн биржийн индексийн сарын өгөөжийн тархалтууд нь ижилхэн хэвийн бус тархалттай, баруун тал руугаа бага болон мэдэгдэхүйц хэлтийсэн байдалтай байна.

Судалгааны санал, зөвлөмж

Нийт 21 компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалт нь хэвийн бус баруун тал руугаа хэлтийсэн байгаа нь судалгааны үр дүнгээр гарлаа. Цаашид энэхүү хэвийн бус тархалтын нөлөөг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, багц бүрдүүлэх, эрсдэлийг тооцоолохдоо авч тусгах нь зүйтэй байна. Хэвийн бус тархалтын үед дундаж өгөөжийн хэмжээгээр бус медиан өгөөжийн хэмжээгээр хүлээгдэж буй өгөөжийг тооцоолох нь илүү үр дүнтэй байдаг.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Aggarwal, R., Rao, R. P., & Hiraki, T. (1989). SKEWNESS AND KURTOSIS IN JAPANESE EQUITY RETURNS: EMPIRICAL EVIDENCE. *The Journal of Financial Research*, 253-260.
- Amaya, D., Christoffersen, P., Jacobs, K., & Vasquez, A. (2011). Do Realized Skewness and Kurtosis Predict the Cross-Section of Equity Returns? *Mathematical Finance Conference*, 1-47.
- Bakshi, G., Kapadia, N., & Madan, D. (2003). Stock return characteristics, skew laws, and the differential pricing of individual equity options. *Review of Financial Studies*, 101-143.
- Brooks, C. (2014). *Introductory Econometrics for Finance*. Cambridge: MPG Printgroup Ltd,.
- Burcu, A., Fatma, D., & Haluk, S. (2011). Mean-Variance-Skewness-Kurtosis Approach to Mean-Variance-Skewness-Kurtosis Approach to Stock Exchange. *Ege Academic Review*, 9-17.
- Conrad, J., Dittmar, R. F., & Ghysels, E. (2013). Ex Ante Skewness and Expected Stock Returns. *The Journal of Finance*, 85-124.


- D.F. Harris, R., Küçüközmen, C., & Yilmaz, F. (2004). Skewness in the conditional distribution of daily equity returns. *Applied Financial Economics*, 195-202.
- Gabrielsen, A., Kirchner, A., Liu, Z., & Zagaglia, P. (2015). FORECASTING VALUE-AT-RISK WITH TIME-VARYING VARIANCE, SKEWNESS AND KURTOSIS IN AN EXPONENTIAL WEIGHTED MOVING AVERAGE FRAMEWORK. *Annals of Financial Economics*, 1550005-1-29.
- Haas, M. (2009). Modelling skewness and kurtosis with the skewed Gauss–Laplace sum distribution. *Applied Economics Letters*, 1277-1283.
- Lai, J.-Y. (2012). An empirical study of the impact of skewness and kurtosis on hedging decisions. *Quantitative Finance*, 1827-1837.
- Lanne, M., & Pentti, S. (2007). Modeling Conditional Skewness in Stock Returns. *The European Journal of Finance*, 691-704.
- Lau, H.-S., & Wingender, J. (1989). The Analytics of the Intervaling Effect on Skewness and Kurtosis of Stock Returns. *The Financial Review*, 215-233.
- Leon, A., Rubio, G., & Serna, G. (2005). Autoregressive conditional volatility, skewness and kurtosis. *The Quarterly Review of Economics and Finance*, 599-618.
- Mei, D., Liu, J., Ma, F., & Chen, W. (2017). Forecasting stock market volatility: Do realized skewness? *Physica A*, 153-159.
- Tang, G. Y. (1996). Day-of-the-week effect on skewness and kurtosis: a direct test and portfolio effect. *The European Journal of Finance*, 333-351.

Хүснэгт. 2.23 Компанийн хэлтйлт, овойлт, хэвийн тархалт

№	Компанийн хувьцааны индекс	Дундаж	Медиан	Өдрийн дээд өгөөжийн хувь	Өдрийн доод өгөөжийн хувь	Стандарт хазайлт	Хэлтйлт	Овойлт	Жарку-Бера	Хэвийн тархалттай байх магадлал	Ажиглалтын тоо
1	AARD	0.06%	-0.05%	15.0%	-15.0%	0.03	1.28	8.86	1,729	0.00%	1,015
2	ADB	0.06%	-0.04%	15.0%	-15.0%	0.03	1.28	8.92	1,728	0.00%	996
3	AIC	0.03%	0.00%	14.9%	-14.2%	0.03	0.67	9.20	1,807	0.00%	1,079
4	APU	0.21%	0.00%	30.9%	-24.7%	0.03	1.21	15.67	24,841	0.00%	3,586
5	BDS	0.21%	0.00%	100.0%	-21.7%	0.05	5.43	103.88	558,098	0.00%	1,301
6	BODI	0.05%	0.00%	14.5%	-11.9%	0.03	0.52	5.60	197	0.00%	600
7	BOGD	-0.11%	-0.08%	14.7%	-8.5%	0.03	1.46	10.73	867	0.00%	305
8	GLMT	-0.28%	-0.17%	5.9%	-10.9%	0.02	(1.34)	8.14	115	0.00%	82
9	GOV	0.08%	0.00%	25.0%	-17.6%	0.03	0.68	13.47	14,513	0.00%	3,126
10	INV	0.15%	0.02%	13.7%	-11.2%	0.02	0.49	15.25	5,942	0.00%	945
11	LEND	0.05%	0.00%	15.0%	-15.0%	0.03	0.89	9.09	2,119	0.00%	1,262
12	MFC	0.07%	0.00%	11.6%	-10.3%	0.02	0.23	7.13	681	0.00%	945
13	MIK	0.30%	0.00%	15.0%	-15.0%	0.06	0.03	3.31	2	42.52%	417
14	MMX	0.18%	0.00%	20.0%	-15.0%	0.04	0.58	5.68	775	0.00%	2,179
15	MNDL	0.06%	0.00%	15.0%	-10.8%	0.02	1.24	12.40	4,332	0.00%	1,101
16	MNP	0.17%	0.00%	15.0%	-13.9%	0.04	0.50	6.28	673	0.00%	1,374
17	MSE	0.50%	-0.08%	15.0%	-7.3%	0.04	2.37	9.81	178	0.00%	62
18	NEH	0.21%	0.00%	19.8%	-27.5%	0.04	0.32	6.89	1,188	0.00%	1,833
19	SBM	0.02%	-0.04%	15.0%	-15.0%	0.04	0.56	9.73	240	0.00%	124
20	SUU	0.38%	0.00%	33.1%	-15.0%	0.04	1.82	15.60	13,777	0.00%	1,922
21	TTL	0.26%	0.00%	232.9%	-98.9%	0.06	17.90	715.71	58,159,052	0.00%	2,741
22	TCK	0.24%	0.00%	31.6%	-25.9%	0.04	0.33	8.11	2,230	0.00%	2,019
23	TUM	0.08%	-0.02%	14.8%	-11.5%	0.03	1.00	9.04	1,725	0.00%	1,020
	Дундаж	0.13%	-0.02%	30.58%	-18.76%	0.04	1.71	44.28	2,556,383	1.85%	1,306

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

График. 1 23 Компанийн хувьцааны өдрийн өгөөжийн тархалт 2007-2022 он



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ГАРЦАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Э.Төгсжаргал,

Магистр (МВА), СЭЗИС, СУТ, tugsjargal.e@ufe.edu.mn



Түлхүүр үг:

давхар даатгал, ашигт ажиллагаа, нийт хөрөнгө, андеррайтингийн эрсдэл, эрсдэлийн удирдлага, хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, панел өгөгдөл,

Хураангуй

Давхар даатгал нь ердийн даатгалын компаниудын хувьд томоохон эрсдэлээ шилжүүлэн хөрвөх чадвар болдог төлбөрийн чадварын эрсдэлээ бууруулж буй эрсдэлийн удирдлагын хэрэгсэл юм. Монголын ердийн даатгалын салбарын хувьд жил бүр нийт хураамжийн орлогын 33 орчим хувийг давхар даатгалд шилжүүлдэг бөгөөд энэ нь нэг талаасаа эрсдэлээ бууруулж байгаа боловч нөгөө талаасаа томоохон зардал гаргаж байгаа тул Монголын ердийн даатгалын компаниудын гарцад давхар даатгал нь хэрхэн нөлөөлж байгаа нөлөөллийг энэхүү судалгаагаар тодорхойлсон болно.

Судалгааны асуудал: Олон улсын хэмжээнд нийт хураамжийн орлогод эзлэх давхар даатгалын хураамжийн зардал 20-25% байдаг бол Монгол Улсын ердийн даатгагч нар жил бүр нийт хураамжийн орлогын 33 орчим хувийг давхар даатгалд шилжүүлдэг. Ердийн даатгагчид 2003-2022 оны хооронд 20 жилийн хугацаанд 273.15 сая долларыг давхар даатгагчид төлж 30.7 сая долларын нөхөн төлбөрийг давхар даатгагчаас олгосон байна. Төлсөн хураамж болон нөхөн төлбөрийн харьцаанаас харахад дунджаар 9%-ийг нь давхар даатгагчаас нөхөн төлбөр хэлбэрээр буцаан олгодог байна.

Судалгааны зорилго: Давхар даатгал нь нэг талаасаа эрсдэлээ бууруулах, шилжүүлэх эрсдэлийн удирдлагын нэг арга хэрэгсэл бөгөөд даатгалын компанид томоохон эрсдэл бий болоход төлбөрийн чадварыг хадгалж дампуурах эрсдэлээс сэргийлдэг боловч нөгөө талаасаа даатгалын компанид өндөр зардал болдог. Тиймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд Монголын ердийн даатгагчдын хувьд давхар даатгал нь даатгалын компанийн гарцад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой.

Судлагдсан байдал

МУИС болон СЭЗИС-ийн судалгааны сангаас харахад давхар даатгалын үйл ажиллагаа даатгалын компанийн гарцад хэрхэн нөлөөлж байгааг судалсан судалгаа дотоодод хийгдэж байгаагүй бөгөөд салбарын гарцад сонгосон хувьсагч нь хэрхэн нөлөөлж байгааг судалсан судалгааны ажлуудаас дурдвал:

Хүснэгт 2 Дотоодод судлагдсан байдал

№	Нэр	Судалгааны ажлын нэр	Товч хураангуй
1	(Э.Алунгуа, 2023)	Банкны салбарын барилгын салбарын гарцад үзүүлэх нөлөөллийн судалгаа	Банкны салбар зээл олголтоор дамжуулан барилгын салбарын гарцад хэрхэн нөлөөлж байгааг судалсан бөгөөд шугаман регрессийн загвар ашиглан барилгын салбарын ДНБ болон барилгын салбарт олгосон нийт зээлийн үлдэгдлийн хамаарлыг тогтоожээ. Судалгааны үр дүнд банкны зээлийн үлдэгдэл нь барилгын гарцад эерэг нөлөө үзүүлдэг болох нь харагдав. Гэвч, барилгын гарцад дан барилгын салбарт олгосон зээлийн үлдэгдэл нөлөөлөхгүй, бусад макро, микро, дам хүчин зүйлүүд нөлөөлж байна гэж үзсэн байна.
2	(Г.Золзаяа, 2023)	Ковид-19 цар тахлын нөлөөллийн судалгаа: даатгалын салбарын жишээн дээр	Энэхүү судалгааны ажлаар Ковид-19 цар тахлын нөлөөлөл нь даатгалын салбарын гарцад хэрхэн нөлөөлж байгааг судалсан бөгөөд панел тоон өгөгдөл ашиглан шугаман регрессээр даатгалын салбарын гарцын үзүүлэлт болох ROA болон ковидын нөлөөллийг дамми хувьсагчаар нэмж нөлөөллийг тодорхойлсон байна.

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

Хүснэгт 3 Гадаадад судлагдсан байдал

№	Нэр	Судалгааны ажлын нэр	Товч хураангуй
1	(Hsu-Hua, 2012)	An Analysis of Reinsurance and Firm Performance: Evidence from the Taiwan Property-Liability Insurance Industry	Судалгааны үр дүнд давхар даатгал нь компанийн гүйцэтгэлтэй урвуу хамааралтай бөгөөд энэ нь давхар даатгалын зардалтай холбоотой. Өндөр ROA-тай даатгагчид давхар даатгал бага худалдан авах хандлагатай байдаг бол давхар даатгалын хамаарал өндөртэй даатгагчид гүйцэтгэлийн түвшин доогуур байдаг байна. Мөн төлбөрийн чадваргүй болох магадлал өндөртэй даатгагчид илүү их давхар даатгал худалдаж авдаг гэсэн дүгнэлтийг хийжээ.
2	(Amarasena, 2021)	Effect of Reinsurance on Performance of General Insurance Companies: Evidence from Sri Lanka	Нэхэмжлэлийн цэвэр харьцаа нь ердийн даатгалын компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгааг регрессийн шинжилгээгээр тодорхойлсон. Үүний эсрэгээр давхар даатгалын харьцаа нь ердийн даатгалын компаниудын үйл ажиллагаанд ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг. Цаашилбал, цэвэр шимтгэлийн харьцаа эерэг нөлөө үзүүлдэг бол хадгалах харьцаа нь ерөнхий даатгалын компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс, энэхүү судалгаагаар ерөнхий даатгалын компаниуд андеррайтерийн журмын чанараа үр

		дүнтэй удирдаж, гүйцэтгэлээ нэмэгдүүлэхийн тулд зардлаа нэхэмжлэх ёстой гэж дүгнэжээ.
3	(Ogunlami, 2021) The Effect of Reinsurance on the Development of Insurance Industry and the Nigeria Economy	Давхар даатгал нь даатгалын компаниудын үйл ажиллагааны үндэс суурь болдог. Давхар даатгал нь даатгалын компаниудын хөрөнгийн удирдлагын хэрэгсэл болдог; Даатгагчид үүнийг капиталаар орлуулдаг бөгөөд бага хөрөнгө эзэмшиж томоохон эрсдэлийг даатгах боломжийг олгож, улмаар төлбөрийн чадваргүй болох магадлалыг нэмэгдүүлдэг. Энэхүү аргументийн гол санаа нь давхар даатгалын хараат байдал нь урт хугацаанд даатгалын компаниудын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй, зардал ихтэй, даатгагчийн үр ашгийг бууруулж, өр төлбөрөө барагдуулах хангалттай хөрөнгөгүй, урт хугацаандаа даатгагчийн үйл ажиллагааг бууруулж болзошгүйд чиглэж байна. Нигерийн ерөнхий даатгалын компаниудын ашигт ажиллагааг бууруулж байна.
4	(M.Buckle, 2003) The determinants of corporate financial performance in the Bermuda insurance market	Бермудийн даатгалын зах зээл дэх корпорацийн санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг (жишээ нь андеррайтинг болон хөрөнгө оруулалттай холбоотой) судалсан болно. 1993-1997 оны даатгалын компаниудын панел өгөгдлийг ашигласнаар хүлээгдэж буйгаар өндөр хөшүүрэгтэй, хөрвөх чадвар багатай компаниуд бага хөшүүрэгтэй, өндөр хөрвөх чадвартай компаниудаас илүү үйл ажиллагааны гүйцэтгэлтэй байгааг олж тогтоосон. Мөн даатгалын компанийн гүйцэтгэл нь андеррайтерийн эрсдэлтэй эерэг холбоотой байсан бол компаниудын хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ нь чухал тайлбарлагч хүчин зүйл болж чадаагүй байна.
5	(Jadi, 2015) An empirical analysis of determinants of financial performance of insurance companies in the United Kingdom	Энэхүү судалгаа нь даатгалын компаниудын санхүүгийн чадавхын зэрэглэлд тулгуурлан санхүүгийн гүйцэтгэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлах зорилготой юм. Эмпирик өгөгдлийг Их Британи улсын 57 даатгагчийн тайлангийн 2006-2010 оны үзүүлэлтүүдэд регрессийн загваруудыг ашигласан болно. Шинжилгээнд хөшүүрэг, ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, компанийн хэмжээ, давхар даатгал, өсөлт, бизнесийн төрөл, зохион байгуулалтын хэлбэр гэсэн 8 хамаарах хувьсагчдыг хамруулсан. Үр дүн нь ашигт ажиллагаа, хөрвөх чадвар, хэмжээ, зохион байгуулалтын хэлбэр нь Их Британи улсын даатгалын компаниудын санхүүгийн гүйцэтгэлд статистикийн чухал хүчин зүйл болохыг тогтоожээ.

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

Давхар даатгалын ач холбогдол, эрэлт

Даатгалын компаниуд давхар даатгалыг худалдан авах замаар эрсдэлээ удирддаг, учир нь даатгагчийн сөрөг эрсдэлийг (өөрөөр хэлбэл дампуурлын эрсдэл) бууруулдаг. Давхар даатгал нь өндөр өртөгтэй учраас (Smith, 1990) давхар даатгалын худалдан авалт нь эзэмшигчдийн багцыг төрөлжүүлэхтэй сөрөг нөлөөтэй байх ёстой гэж үздэг. Даатгалын компаниудын давхар даатгалын шийдвэрийг тайлбарлахын тулд судлаачид хэд хэдэн тайлбарыг дэвшүүлсэн байдаг боловч үйл ажиллагааны эрсдэлээс үр дүнтэй хамгаалах чадвараас шалтгаалж давхар даатгалыг худалдан авдаг гэсэн таамаглалыг голчлон авч үздэг. Компанийн эрсдэл даах чадвар нь капиталын бүтэц, пүүсийн хэмжээ зэрэг байгууллагын хүчин зүйлээс хамаардаг тул давхар даатгалын хэмжээ нь даатгалын компаниудын онцлогоос хамаарч өөр өөр байх ёстой. Давхар даатгал нь жижиг, илүү өндөр хөшүүрэг, андеррайтерийн эрсдэл өндөртэй компаниудтай холбоотой буюу эдгээр даатгалын компаниуд нь давхар даатгалын эрэлт өндөртэй байдаг. (Adams, 1996)

Давхар даатгалын үйл ажиллагаа даатгалын компанийн гарцын нөлөөлөл

Давхар даатгалын хураамж буюу зардал нь андеррайтерийн эрсдэл, компанийн чадавхтай холбоотой бөгөөд даатгагчдын гүйцэтгэл болон компанийн өсөлтөд нөлөөлдөг. Өмнөх судалгаануудын үр дүнд давхар даатгал болон компанийн гарцын хоорондын уялдаа холбоог зэрэг болон сөргөөр ялгаатай тодорхойлсон нь тухайн зах зээлийн онцлогоос хамаарч байна. Давхар даатгалын зардал нь анхдагч зах зээлийн ашигт нөлөөлж, давхар даатгалд эрсдэлээ шилжүүлснээр одоогийн ашигт ажиллагаа сайжирч байгааг харуулсан бөгөөд давхар даатгалыг илүү худалдан авч буй компаниуд илүү тогтвортой гүйцэтгэлтэй байдаг нь эрсдэлийг тохируулж, өгөөжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулдаг болохыг харуулж байна. (B. Elango, 2008) Давхар даатгалд эрсдэлээ их шилжүүлсэн даатгагчид бага шилжүүлсэн буюу давхар даатгалын зардал багатай компаниудтай харьцуулахад удаан өсдөг бөгөөд давхар даатгалын ашиглалт нь орлогын үр ашигт сөрөг нөлөөтэй, цаашлаад энэ нь даатгалын компаниуд ашгаа давхар даатгагчидтай хуваалцах шаардлагатай болж, улмаар үйл ажиллагааны ашиг буурах нөлөөтэй гэж үзсэн. (Elyasiani, 2009) Давхар даатгал нь даатгуулагчдын дунд эрсдэлийн төрөлжилтийг сайжруулдаг боловч давхар даатгал болон даатгалын компанийн гүйцэтгэлийн хоорондын сөрөг хамаарал нь давхар даатгалын үйл ажиллагаа нь зардлыг нэмэгдүүлж болзошгүйг харуулж байна. Даатгагчид давхар даатгалын хараат байдал өндөр бол цэвэр хураамжийн орлого буурч ашигт ажиллагааг бууруулдаг.

Монголын даатгалын салбарын өнөөгийн байдал


Даатгалын зах зээлд 2022 оны байдлаар 2 урт хугацаат даатгалын компани, 1 давхар даатгалын компани, 15 ердийн даатгалын компани үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 4 Монгол Улсын даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

Ерөнхий мэдээлэл	2021	2022
Ердийн даатгалын компани	15	15
Урт хугацааны даатгалын компани	1	2
Давхар даатгалын компани	1	1
Нийт	17	18

Даатгалын салбарын бүтцийг сүүлийн 5 жилийн байдлаар харвал ердийн даатгалын хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 98%-ийг бүрдүүлдэг бол урт болон давхар даатгалын хураамжийн орлого үлдсэн 2%-ийг бүрдүүлж байна.

График 1 Даатгалын салбарын бүтэц



Эх сурвалж: (хороо, 2022)

Ердийн даатгалын салбарын хувьд жил бүр нийт хураамжийн орлогын 33 орчим хувийг гадаадын давхар даатгагчид шилжүүлдэг бөгөөд хураамжийн орлогын хэмжээ нэмэгдэх тусам гадагш шилжүүлж буй давхар даатгалын хураамжийн хэмжээ өссөөр байна.


Хүснэгт 5 Даатгалын салбарын давхар даатгалын хураамжийн хэмжээ, тэрбум төгрөгөөр

Он	Ердийн болон урт хугацааны даатгалын хураамж	Гадагш шилжүүлсэн давхар даатгалын хураамж	Эзлэх хувь	Дотоодын давхар даатгалын хураамж	Эзлэх хувь
2015	113.9	42	37%	0.4	1.0%
2016	112.9	37.2	33%	1.6	4.3%
2017	142.5	45.8	32%	1.9	4.1%
2018	177.0	54.5	31%	1.7	3.1%
2019	196.6	57.3	29%	2.1	3.7%
2020	201.5	66.8	33%	3.6	5.4%
2021	243.3	84.4	35%	4.2	5.0%
2022	300.7	99.94	33%	4.08	4.1%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын нэгдсэн тайлан, 2022

Дотоодын давхар даатгалын компанид нийт давхар даатгалд шилжүүлж буй хураамжийн 3.8 орчим хувийг даатгаж байгаа бөгөөд дотоодын давхар даатгагч компани өөрсдийн боломжит эрсдэлийг авч үлдээд үлдсэн хэсгийг дахин давхар даатгалд шилжүүлдэг.


График 2 Даатгалын эрсдэлийг шилжүүлж буй зураглал



Эх сурвалж: (С.Будханд, 2022)

Монгол Улсын хувьд даатгалын эрсдэлийг шилжүүлж буй зураглалаас харахад даатгуулагч эрсдэлээ ердийн даатгалын компанид шилжүүлэн даатгалын компанийн хувьд эрсдэлийн өөрт ногдох тодорхой хэсгийг авч дотоодын эсвэл гадаадын давхар даатгагчид шилжүүлж байна.

График 3 Давхар даатгалын хураамж болон төлсөн нөхөн төлбөрийн хэмжээ /сая.доллаар/



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл СЗХ-ийн тайланд үндэслэсэн

Давхар даатгагчид төлсөн хураамж болон нөхөн төлбөрийн хэмжээнээс харахад 2003-2022 оны хооронд 20 жилийн хугацаанд 273.15 сая долларыг давхар даатгагчид төлж 30.7 сая долларын нөхөн төлбөрийг давхар даатгагчаас олгосон байна. Төлсөн хураамж болон нөхөн төлбөрийн харьцаанаас харахад дунджаар 9%-ийг нь давхар даатгагчаас нөхөн төлбөр хэлбэрээр буцаан олгодог байна.

2003-2022 оны хооронд хураамжийн хэмжээ 15.1 дахин өссөн бол 2003-2008 оны хооронд давхар даатгагчаас нөхөн төлбөр авах тохиолдол гараагүй бөгөөд томоохон нөхөн төлбөрийн тохиолдлуудтай холбоотой 2017-2019 онуудад давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөрийн хэмжээ өссөн байна. Үүнд:

- 2014 оны 9-р сард Шангрила барилга угсралтын даатгалын нөхөн төлбөр 2015, 2016 онд олгогджээ.
- 2017 оны 6-р сард Говь ХК-ийн үйлдвэрийн барилга шатсантай холбоотой давхар даатгагчаас нөхөн төлбөрийг олгосон байна.
- 2019 оны 6-р сард И-март худалдааны төвд гал гарсантай холбоотой давхар даатгагчаас нөхөн төлбөрийг олгожээ.
- 2020 оны 6-р сард Улсын их дэлгүүр шатсантай холбоотой давхар даатгагчаас нөхөн төлбөрийг олгосон байна.

Дээрхээс харахад ердийн даатгалын компани томоохон эрсдэлээ давхар даатгалд шилжүүлснээр төлбөрийн чадварын эрсдэлээс зайлсхийж байгаа эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл боловч бүх эрсдэлийг давхар даатгагчид шилжүүлэх нь зардал өндөртэй буюу даатгагчдын ашигт ажиллагаанд нөлөөлөх боломжтойг харуулж байна.

Судалгааны арга, өгөгдөл

1. Судалгааны өгөгдөл

Судалгаанд нийт 10 ердийн даатгалын компанийн 2016 оноос 2022 он хүртэлх санхүүгийн тайлан баланс, орлогын тайланд тусгагдсан тоон өгөгдлүүдийг ашигласан болно. Шинжилгээг Eviews-8 version программ ашиглан гүйцэтгэв.

Судалгааны хязгаарлалт: Нийт 15 ердийн даатгалын компаниас 5 даатгалын компани давхар даатгалд эрсдэлээ шилжүүлдэггүй буюу ихэвчлэн иргэдийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд байсан тул судалгаанд давхар даатгалтай 10 ердийн даатгалын компаниудын панел өгөгдлийг боловсруулан ашиглалаа.

2. Судалгааны арга зүй

Судалгааг 10 даатгалын компанийн 6 жилийн панел тоон мэдээлэлд үндэслэн дараах тэгшитгэлүүдээр давхар даатгал болон даатгалын компанийн гарцын нөлөөллийг үнэлнэ.

$$reinsurance = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 IL_{it} + \beta_3 FL_{it} + \beta_4 ROA_{it} + \beta_5 RP_{it} + \beta_6 UR_{it} + \beta_7 GP_{it} + \beta_8 LR_{it} + \beta_9 ROI_{it} + \beta_{10} LBS_{it} + \beta_{11} FHD_{it} + E_{it} \quad (1)$$

$$ROA = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 FL_{it} + \beta_3 REINS_{it} + \beta_4 RP_{it} + \beta_5 UR_{it} + \beta_6 GP_{it} + \beta_7 LR_{it} + \beta_8 ROI_{it} + \beta_9 MS_{it} + \beta_{10} LBS_{it} + \beta_{11} FHD_{it} + \beta_{12} LD_{it} + E_{it} \quad (2)$$

Тэгшитгэлийн бүтцийн загварыг (Hsu-Hua, 2012) нарын судалгааны дээрх үндсэн тэгшитгэлийн загварыг ашиглан Монголын даатгалын компаниудын боломжит тоон мэдээлэлд тохируулан тооцоолох боломжгүй хувьсагчдыг хасч дараах тэгшитгэлийг ашиглан тооцоолохын тулд хоёр үе шаттай хамгийн бага квадрат (2SLS) регрессийг ашиглана.

$$reinsurance = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 Inslev_{it} + \beta_3 Finlev_{it} + \beta_4 ROA_{it} + \beta_5 Reratio_{it} + \beta_6 Und_R_{it} + \beta_7 GoP_{it} + \beta_8 ROI_{it} + \beta_9 FHD_{it} + E_{it} \quad (1)$$

$$ROA = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 Finlev_{it} + \beta_3 REINS_{it} + \beta_4 Reratio_{it} + \beta_5 Und_R_{it} + \beta_6 LR_{it} + \beta_7 ROI_{it} + \beta_8 M_Share_{it} + \beta_9 D_listed_{it} + E_{it} (2)$$

Шинжилгээнд хамрагдах хувьсагчуудыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 6 Хувьсагчуудын нэгтгэл

	Хувьсагчид	Тэмдэглэгээ	Тайлбар
Хамаарах хувьсагчид	Давхар даатгалын зардал /хураамж/	REINS	Нийт хураамжийн орлого/ Давхар даатгалын хураамж
	Нийт хөрөнгийн өгөөж	ROA	Цэвэр ашиг/Нийт хөрөнгө
Үл хамаарах хувьсагчид	Компанийн хэмжээ	FS	ln Нийт хөрөнгө
	Даатгалын хөшүүрэг	INSLEV	Цэвэр хураамжийн орлого/Өр төлбөр
	Санхүүгийн хөшүүрэг	FINLEV	Нийт өр төлбөр/Нийт хөрөнгө
	Андеррайтингийн эрсдэл	UND_R	Хохирлын харьцаа= Орлогод тооцсон хураамж/нийт нөхөн төлбөр
	Давхар даатгалын нөхөн төлөлтийн харьцаа	Re_ratio	Давхар даатгалын хариуцсан нөхөн төлбөр/Давхар даатгалын зардал
	Хураамжийн өсөлтийн хувь	GOP	Тайлант үеийн хураамжийн орлого/Өмнөх жилийн хураамжийн орлого-1
	Хөрвөх чадварын харьцаа	LIQR	Эргэлтийн хөрөнгө/Эргэлтийн эх үүсвэр
	Хөрөнгө оруулалтын өгөөж	ROI	Хөрөнгө оруулалтын орлого/Хөрөнгө оруулалт
	Зах зээлд эзлэх хувь	MS	Тухайн компанийн нийт хураамжийн орлого/Салбарын нийт хураамжийн орлого
	Санхүүгийн нэгдэл дамми хувьсагч	D_FH	1;0
Нээлттэй хувьцаат компани дамми хувьсагч	D_LISTED	1;0	

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Судалгааны үр дүн

1. Хувьсагчдын дискриминал статистик

Хүснэгт 7 Хувьсагчдын статистик үзүүлэлтүүд

	MEAN	MEDIAN	MAXIMUM	MINIMUM	STD. DEV.
D_FHD	0.4	0	1	0	0.493435
D_LISTED	0.228571	0	1	0	0.422944
FINLEV	0.010663	0.007645	0.044613	0.000164	0.009021
GOP	0.054704	0.039694	0.202984	0.000387	0.043722
FS	0.81319	0.821791	2.263343	0.020868	0.47526
INSLEV	0.991965	0.896879	2.544339	0.378787	0.412479
LIQR	0.230539	0.172339	1.420733	0.001739	0.231459
M_SHARE	0.09485	0.082893	0.248638	0	0.058968
REINS	0.242155	0.239339	0.662113	0	0.190992
RERATIO	0.360703	0.038848	6.885295	0	1.164624
ROA	0.072325	0.056265	0.303848	-0.07229	0.079818

ROI	0.130161	0.123374	0.608679	0	0.09578
UND_R	0.524186	0.474587	1.790163	0.25727	0.215646

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Үнэлгээг хийхдээ давхар даатгал болон даатгалын компанийн гарцын үзүүлэлтийн 2 тэгшитгэлийг 2SLS модель ашиглан санамсаргүй нөлөөний загвараар үнэлэхэд дараах үр дүн гарсан. Тэгшитгэл тус бүрийн үр дүнгээ Хаузмений тестээр шалгахад $prob > 0.05$ гарсан учир энэхүү загвар маань санамсаргүй нөлөөтэй гэж үзсэн. Хавсралт2 болон 4-т Хаузмений тестийн үр дүнг хавсаргав.

2. Давхар даатгалын хураамжийн зардалд нөлөөлж буй хүчин зүйлс

Даатгалын компанийн нийт хураамжийн орлого болон давхар даатгалд шилжүүлж хураамжийн орлогын харьцаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг дараах тэгшитгэлээр тодорхойлсон бөгөөд тэгшитгэлийн нэмэлт /instrument/ хувьсагчдаар үл хамаарах хувьсагчдаас гадна /ROA-г хассан/ хөрвөх чадварын харьцаа, зах зээлд эзлэх хувь, нээлттэй хувьцаат компанийн дамми хувьсагчдыг авсан.

$$reinsurance = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 Inslev_{it} + \beta_3 Finlev_{it} + \beta_4 ROA_{it} + \beta_5 Reratio_{it} + \beta_6 Und_R_{it} + \beta_7 GoP_{it} + \beta_8 ROI_{it} + \beta_9 FHD_{it} + E_{it} \quad (1)$$

Үр дүн:

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	0.145526	0.088397	1.646285	0.1049***
FS	0.028009	0.041051	0.682296	0.4977
GOP	0.428357	0.648769	0.660261	0.5116
INSLEV	-0.181052	0.055784	-3.245601	0.0019*
FINLEV	3.2395	3.589508	0.902492	0.3704
ROA	-0.004648	1.247689	-0.003725	0.9997***
RERATIO	-0.03177	0.016252	-1.954803	0.0553**
ROI	0.074679	0.218382	0.341963	0.7336
UND_R	0.227219	0.135141	1.681349	0.0979***
D_FHD	0.196109	0.049517	3.960468	0.0002*

Тайлбар: * - p value is < 0.001 , ** - p is < 0.05 , ***- p value is > 0.1 , Cross-section random

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Загварын R^2 нь 62% гарсан бөгөөд давхар даатгалын хураамжийг дараах хувьсагчид тайлбарлаж байгааг илэрхийлж байна. Ач холбогдолтой хувьсагчдыг авч үзвэл даатгалын хөшүүрэг, давхар даатгалын нөхөн төлбөрийн харьцаа, нийт хөрөнгийн өгөөж нь сөрөг нөлөөтэй, андеррайтингийн эрсдэл болон санхүүгийн нэгдэл байх нь давхар даатгалын хураамжид эерэгээр нөлөөлж байна.

Андеррайтингийн эрсдэл /хохирлын харьцаа/ нь давхар даатгалын хураамжийн зардалд эерэгээр нөлөөлж байгаа буюу компанийн авч буй эрсдэл, хохирлын хэмжээ нэмэгдэх тусам давхар даатгалд эрсдэлээ шилжүүлэх хандлагатай байна. Мөн санхүүгийн нэгдэл компани байх нь давхар даатгалын хураамжийг нэмэгдүүлж байгаа нь тухайн компанийн найдвартай байдал, групп компаниудын томоохон даатгалуудтай холбоотой гэж үзэж байна.

Харин даатгалын хөшүүрэг болон нийт хөрөнгийн өгөөж, давхар даатгалын нөхөн төлбөрийн харьцаа нь давхар даатгалын хэмжээнд сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд цэвэр хураамжийн орлого өндөртэй буюу иргэдийн даатгалын зах зээлд голчлон ажилладаг, нийт хөрөнгө бага ашигт ажиллагаа өндөртэй даатгагчдын хувьд давхар даатгалд даатгуулах их хэмжээний эрсдэлийг даатгадаггүй учир давхар даатгалын хураамжид сөргөөр нөлөөлж байна.

3. Даатгалын компанийн гарцад давхар даатгалын үзүүлэх нөлөөлөл

Даатгалын компанийн гарцад давхар даатгалын үзүүлэх нөлөөллийг дараах тэгшитгэлээр тодорхойлсон бөгөөд нэмэлт /instrument/ хувьсагчдаар тэгшитгэлийн үл хамаарах хувьсагчдаас /давхар даатгалыг хассан/ гадна хураамжийн орлогын өсөлт, даатгалын хөшүүрэг, санхүүгийн нэгдэл дамми хувьсагчдыг авав.

$$ROA = \alpha + \beta_1 FS_{it} + \beta_2 Finlev_{it} + \beta_3 REINS_{it} + \beta_4 Reratio_{it} + \beta_5 Und_R_{it} + \beta_6 LR_{it} + \beta_7 ROI_{it} + \beta_8 M_Share_{it} + \beta_9 D_listed_{it} + E_{it} \quad (2)$$

Үр дүн:

VARIABLE	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	0.072022	0.018153	3.967446	0.0002
FS	-0.00478	0.013207	-0.36225	0.7186
FINLEV	-2.64843	0.846095	-3.13018	0.0028**
REINS	0.14286	0.070111	2.037638	0.0465***
RERATIO	0.005477	0.005085	1.07715	0.2862
UND_R	-0.03356	0.032182	-1.04282	0.3017
LIQR	0.074571	0.032193	2.316387	0.0244***
ROI	0.24107	0.067265	3.583903	0.0007*
M_SHARE	-0.34447	0.196795	-1.7504	0.0857
D_LISTED	-0.01068	0.014373	-0.74283	0.4608

Тайлбар: * - p value is <0.001, ** - p is <0.05, ***- p value is 0.1, Cross-section random (dummy variables), Period random (dummy variables)

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Загварын R^2 нь 73% гарсан бөгөөд даатгалын компанийн гарцад дараах хувьсагчид нөлөөлж байна. Ач холбогдолтой хувьсагчдыг авч үзвэл санхүүгийн хөшүүрэг нь гарцад сөрөг нөлөөтэй, давхар даатгалын хураамжийн харьцаа, хөрвөх чадварын харьцаа, хөрөнгө оруулалтын өгөөж нь даатгалын компанийн гарцад эергээр нөлөөлж байна.

Хөрөнгө оруулалтын өгөөж нь даатгалын компанийн үндсэн үйл ажиллагааны бус орлого бөгөөд даатгалын компаниудын хувьд андеррайтингийн алдагдалтай ажилласан ч хөрөнгө оруулалтын өгөөжөөрөө алдагдлаа нөхдөг зарчимтай. Харин хөрвөх чадварын харьцаа өндөртэй байх нь гарцад эерэгээр нөлөөлж байгаа нь компанийн эрсдэлийг бууруулахаас гадна санхүүгийн байгууллагуудад байршуулж буй харилцах, хадгаламжаар дамжуулан борлуулалтын орлого өсдөгтэй холбоотой. Давхар даатгалын хураамжийн харьцаа нь гарцад эерэгээр нөлөөлж байгаа нь ердийн даатгалын компаниудын хувьд томоохон эрсдэлээ шилжүүлж байгаа нь компани их хэмжээний нөхөн төлбөр төлөх эрсдэлийг бууруулж, андеррайтингийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулж байгаатай холбоотой.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын ердийн даатгалын даатгалын компаниудын гарцад давхар даатгал хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох энэхүү судалгааны хүрээнд ердийн даатгалын 10 компанийн 2016-2022 оны панел тоон өгөгдөлд үндэслэн 2 шатлалт хамгийн бага регрессийн загварыг ашиглан тодорхойллоо. Судалгааны үр дүнд даатгалын компанийн гарцад давхар даатгал нь эерэгээр нөлөөлж байгаа нь Монгол Улсын ердийн даатгалын компаниудын хувьд эрсдэл даах чадамж бага байгаатай холбоотой. Өндөр ROA-тай даатгагчид давхар даатгал бага худалдан авах хандлагатай байдаг бол ROA багатай даатгагчид давхар даатгалын хамаарал өндөртэй байдаг бөгөөд гүйцэтгэлийн түвшин буюу гарцын үзүүлэлт доогуур байдаг байна. Иймээс даатгагчид төлбөрийн чадваргүй болох эрсдэлийг бууруулах, боломжит ашгийг бууруулах хоёрын хооронд тэнцвэртэй байх ёстой бөгөөд эрсдэл даах чадамжаа нэмэгдүүлэхэд анхаарах нь зүйтэй.

НОМЗҮЙН ЖАГСААЛТ

Adams, M. (1996). THE REINSURANCE DECISION IN LIFE INSURANCE FIRMS: AN EMPIRICAL TEST OF THE RISK-BEARING HYPOTHESIS. *Accounting & Finance*.

Amarasena, B. W. (2021). Effect of Reinsurance on Performance of General Insurance Companies: *International Journal of Scientific and Management Research*.

B. Elango, Y.-L. M. (2008). An Investigation Into the Diversification–Performance Relationship in the U.S. Property–Liability Insurance Industry. *Journal of Risk and Insurance*.

Elyasiani, B. P. (2009). Foreign-owned insurer performance in the US property-liability markets. *Applied Economic*.

Hsu-Hua, L.-Y. L. (2012). An Analysis of Reinsurance and Firm Performance: Evidence from the Taiwan Property-Liability Insurance Industry. *Springer*.

Jadi, D. M. (2015). An empirical analysis of determinants of financial performance of insurance companies in the United Kingdom. *University of Bradford*.

M.Buckle, M. &. (2003). The determinants of corporate financial performance in the Bermuda insurance market. *Applied Financial Economics*.

Ogunlami, K. (2021). The Effect of Reinsurance on the Development of Insurance Industry and the Nigeria Economy. *International Journal of Social Relevance & Concern*.

Smith, M. &. (1990). On the corporate demand for insurance: Evidence from the reinsurance market. *Journal of Business*, 63:19-40.

Г.Золзаяа. (2023). *Ковид-19 цар тахлын нөлөөллийн судалгаа: даатгалын салбарын жишээн дээр*. Санхүүгийн зах зээлийн сургалт, судалгааны хүрээлэн.

С.Будханд. (2022). *Даатгалын компанийн уламжлалт бус эрсдэлийн удирдлагын арга хэрэгсэл*. Санхүүгийн зохицуулах хороо.

хороо, С. З. (2022). *Даатгалын салбарын тайлан*. Санхүүгийн Зохицуулах хороо.

Э.Алунгуа, Ө. (2023). *Банкны салбарын барилгын салбарын гарцад үзүүлэх нөлөөллийн судалгаа*. Санхүүгийн зах зээлийн сургалт, судалгааны хүрээлэн.



THE IMPACT OF CLIMATE RISK ON FINANCIAL PERFORMANCE IN MONGOLIAN MINING COMPANIES

Bolitogtokh Demberel¹, Enkh-Otgon Gankhuyag²

¹ University of Finance and Economics, Ulaanbaatar, Mongolia. bolitogtokh.d@ufe.edu.mn

² Mandakh University, Ulaanbaatar, Mongolia. enkhhotgon@mandakh.edu.mn



Keywords

Climate change, ROA, mining firms, CRI score

Abstract

Increasing global climate change has had potential impacts on business operations and gets uncertainty and the mining industry is highly dependent on the climate. The purpose of this study is to estimate the impact of climate change risk on the financial performance of Mongolian mining companies. The study sample includes 16 Mongolian companies in the mining industry in the period of 2011-2021. Climate change was assessed using the Climate Risk Index (CRI). The panel least square regression and panel structure VAR models were used to examine the impacts of climate risks on the company's financial performance. Empirical results show that an increase in the CRI score by 1 increases the ROA by 0.2, and the one-time shock is expected to stabilize after one year. There is a statistically significant positive relationship between climate risk and the financial performance of mining companies. An increase in extreme weather events will have a negative impact on the financial performance of Mongolian mining companies after 2 years. As mining activity increases, climate risk increases, and businesses need to consider climate risk assessment. Furthermore, it could add climate events to the model, which include storms, floods, and drought.

INTRODUCTION

In the last decades, accelerated expansion of industrialization and urbanization is increasing global climate change through greenhouse gas emissions[1][2]. Greenhouse gas emissions from human activities is increasing about 250 times faster than it did from natural sources after the last Ice Age (NASA, n.d.). Global temperature has risen by 1.1°C since pre-industrial (1880-1900) period, and that increase is mainly owing to human activities on the sixth assessment report of the Intergovernmental Panel on Climate Change [3]. The above statistics show that climate change risk mitigation measures are recognized as essential globally. The World Economic Forum has identified the highest global risks in the next decade. Climate action failure, extreme weather and


biodiversity loss risks are primarily prioritized on the list according to the sustainable development goals[4]. Furthermore, the impact of climate change on the socio-economy of countries is expanding. The world bank has announced that it will work to finance climate measures by mitigating the risks associated with climate change in developing countries.

The main opportunity to mitigate climate risk is declining energy-intensive, material convention industries which include heavy manufacturing industries [5]. Increasing evidence of the detrimental effects of climate change on the mining industry has emerged in recent years. According to Lukas Rüttinger and Adelphi report that due to extreme climate events impact major mining regions such as Mongolia, Chile, and Australia are facing difficulties[6]. The mining sector is sensitive to climate change due to the dependence of operations and materials on suitable climatic conditions. Studies results showed that the mining industry and the raw materials used in mining are vulnerable to climate change[6],[7],[8]. According to Marshall, Dale Pearce, Tristan Ford, James D 35-48% of the mining companies that climate change has affected their operations[9]. In addition, some studies have reported that the characteristics of the region where mining company is located is a reason for sensitivity to climate change. Instances A reported that those located in the permafrost region mining companies are at higher risk [10]. Climate change events have an indirect negative impact on the argue between mining companies and citizens. The mining industry will be impacted by changing climatic conditions in both direct and indirect ways [7], [4].

There is a general understanding that enterprises that operate in areas with severe weather conditions or whose operations depend on natural conditions are directly affected by extreme weather events. These events create significant financial risks and opportunities related to climate change and may affect the Company's revenues, expenses, assets, and liabilities, as well as its financing [10]. As markets are interconnected, if climate change risks impact the industry, the associated upstream and downstream industries will also be indirectly Measuring the impact of climate change on company operation will help to mitigate uncertainty due to climate change.

The Mongolian mining sector accounts for 24% of the gross domestic product in 2022 implicated. Mongolia is a country with abundant natural resources and a mining sector that has played a major role in economic growth. Last decade increasing percentage of the mining industry in GDP by around 40% (NSO, 2023). Mongolia's spending on environmental restoration in 2020 is 70 percent of its total mining production in GDP. Ranking Mongolia has a strongly continental climate, with large-scale fluctuations of temperature in a year. Weather is extremely changing and has four seasons in Mongolia and it ranges between -30°C from +30°C yearly. Average annual climate change and declining precipitation. The average annual rainfall of 2022 for Mongolia was 200.6 mm, which was the 19th year with the lowest rainfall since 1940 [11].

Fig I Average temperature anomaly, Global



Source: Met office Hadley Centre (HadCRUTS)

Mongolian has important degree Celsius of average temperature, which is 2°C with warming higher than that global average Fig I. Rainfall declines reported between 1940 and 2015 from Asian Development Bank report [12]. Few studies that specifically examine the impact of climate risk on mining companies in the Mongolian context Davaajaragal, Anand.B, Khosbayar.E has identified impact of climate change on Mongolian socio-economy. According to study an increase in temperature by 1 degree reduces the growth of the Gross Domestic Product by 0.48 percent, and the one-time shock is expected to stabilize after 3 years^[13]. However, the mining sector is highly vulnerable to climate change, which may pose a risk to the financial operations of mining companies. Purevjav and Narantsetseg (2018) analyzed the environmental risks faced by mining companies in Mongolia, such as water scarcity, land degradation, and pollution. Research has shown that these risks have a significant impact on the financial performance of mining companies, and that companies that take measures to manage these risks improve their profitability and stability. But the scientific evidence is still weak.

On how climate change might affect mining operations and the extractives industry, there is comparatively little information. Although some initiatives are underway to acknowledge and address the susceptibility of the mining industry to climate change, comprehensive evidence-based knowledge that covers the full spectrum of causal interactions and links between the two is still scarce. Therefore, provide the evaluation of the impact of climate change risk on the financial performance of top mining companies operating in Mongolia.

I. Literature review and hypothesis development

Climate change is an ample issue faced globally, and cannot be affiliated separately by the country. The impact of climate change affects companies' operations despite of location. Expanding the impact of climate change effect various sectors, especially the mining industry. Climate change risks affect global economic, geopolitical, social and technological risks, and these impacts can directly or indirectly affect a company's financial performance. Thus, climate change risks impact getting a variety of production processes, for example, infrastructure getting unexpected weather could be having difficulties with the distribution channel. As global temperatures continue to rise, it is increasingly important to understand and predict the impact of climate change risks on economic activity [14].

Climate change risks are reshaping the business environment and facing systematic risks for firms of each country [15]. Climate change affects through gross domestic product and gross national product of the economy depending on a country's level of growth in the longstanding [16]. Climate change can have both direct and indirect impacts on a company's financial performance. Extreme weather and climate risk indirectly affect core business activities [4]. Several studies have examined the relationship between climate risk and financial performance in the mining industry. CDP has published a report on the impact of climate change on the mining sector, including a study covering the Asia-Pacific region. The report shows that the mining sector in the Asia-Pacific region is highly exposed to climate risks such as water scarcity, extreme weather events and regulatory changes. In addition, research shows that companies that manage climate risks effectively can improve their competitiveness and improve their financial performance.

II. Effect climate change risk on financial performance

Studies focus mainly inform that climate change directly and indirectly affects organizations' financial performance. Many types of climate change are related to financial performance indicators of organizations. For example, despite the poor quality of information on climate change and the positive attitude of customers towards climate change information, companies' financial indicators have increased [17]. Reference [18] shows diversified global stock portfolio will permanent reduction between 5% and 20% of its value if warming reaches 4°C or more. Erdenebat and Altansukh highlighted the impact of climate change on the mining industry in Mongolia based on the example of a gold mining company. Research has shown that climate risks such as droughts and extreme weather events significantly affect the production and profitability of mining companies. This study highlights the importance of developing adaptive strategies to manage climate change related risks.

Climate change: The Climate Risk Index (CRI) describes the level of exposure and vulnerability to extreme events, which should be understood as a warning for countries to prepare for more severe events in the future. That index is based on indicators as follows:

- the number of deaths,
- the number of deaths per 100,000 inhabitants,
- the sum of losses in US\$ in purchasing power parity (PPP) as well as
- losses per unit of gross domestic product for each country.

That index is calculated by Germanwatch. Mongolia has ranked top 10 most affected countries to global climate change 2 times in the last decade. This means we have to increase our action against climate change and its casualty such as footprint.

Financial performance: The company's financial performance is measured as market-based and accounting based. Market-based financial measurements are suitable for available to measure their market value such as listed companies. Accounting-based measurements grounded on backward-looking performance and used for available on unlisted companies [19]. Return on asset (ROA) is one of the measurements of accounting based financial performance. ROA indicates the company

how efficiently uses its' assets during an accounting period, which determined profitability. Return on assets is calculated as net income divided by total assets.

There are few studies that identified climate change negative impact on financial performance. Ben Edvard, Matthew gray, Boyd Hunter have addressed the problem about sunburnt country the economic and financial impacts of drought in Australia. This study discussed extreme weather such as drought has significant negatively effects on financial position [20]. Henry He, Joseph Kerstein, Chong Wang studied the impact of climate change in 55 countries on firm financial performance. This finding reported constant the timing of financial crisis climate change adverse effects different countries at different periods [21].

Also, studies research with companies' financial distress. Faisal Alshahrani, Baban eulawi, Lien Duong has studied relationship between climate change disclosure performance and financial distress through moderator values which includes litigation, Existence of a risk committee, level of audit fees. As result climate change development performance related to financial distress [22].

In highlight of previous research papers, our first hypothesis determined as follows:

H1: Climate risk index Granger-causes changes in financial performance

H2: Climate risk index is negatively associated with financial performance.

III. Methodology and data

3.1. Data analysis

Granger causality test to measure bidirectional causality between ROA and CRIS. A Granger-causality test developed by Granger in 1969 is used. Granger-causality tests are widely used to establish causal relationships between variables. This approach is commonly used to examine the relationship between climate change and financial performance. Because Granger causality tests use time lags, time lags are an effective way to deal with reverse causality and endogeneity problems. The basic Granger causality model can be written as follows.

$$ROA = \alpha_0 + \sum_{i=1}^n \alpha_i ROA_{t-i} + \sum_{j=1}^n \beta_j CRIS_{t-j} + e_{1t} \quad (1)$$

$$CRIS = \theta_0 + \sum_{i=1}^n \theta_i ROA_{t-i} + \sum_{j=1}^n \mu_j CRIS_{t-j} + e_{2t} \quad (2)$$

Recently main studies have been conducted to examine the effects of climate change on financial performance, but no established and commonly used methodology has yet been identified. The main research methods are Panel Econometrics, Integrated Assessment Models, Cross Sectional Econometrics and General method of moments [6],[21],[22]. For this study, the panel data, VAR analysis was selected in order to keep the data limited and the calculations simple and not too cumbersome. Panel data

3.1.2 Panel regression model

Random effects panel regression, assumes that individual-specific characteristics are randomly distributed and estimates the effects of changes in the explanatory variables across individuals over time. We used Hausman test to determine the best method between fixed effect or random effect. Checking Hausman test in each model, result shows in Table.1. Structural VAR models show the dynamic effects between economic variables and are mainly used by researchers in their empirical

studies, but require sufficient time series data in some cases. To estimate the PVAR model in this instance, we use the Eviews application. We used the measure of climate risk index score and return on assets to investigate the interrelation between climate change events and financial performance. The next section will explain the data that were utilized in the analysis.

The effect of climate risk on financial performance of Mongolian mining companies, in this paper on using the change of elements of accounting and firm size.

$$ROA_{i,t} = \beta_0 + \beta_1 CRIS_{i,t} + \beta_2 ASSET_{i,t} + \beta_3 LIABILITY_{i,t} + \beta_4 SIZE_{i,t} + e_{i,t} \quad (3)$$

i is the effect of the cross-sectional variable (top mining companies in Mongolia) and t is the time series data (2011-2021 years). The e is the error terms. Dependent variable determined by return on asset (ROA), the comprehensive climate change risk index independent variables include climate score (CRIS) (Table 1).

3.2. Data

3.2.1 Climate risk variable

Following the prior literature [21], dependent variable determined as climate risk index score. We measured climate change by Climate risk index score (CRIS). Utilizing the Mongolian climate risk index data for the recent 11 years from Germanwatch.org open database.

3.2.2 Financial Performance variables

Studies have attempted to measure financial performance using financial ratios such as return on asset, return on equity, cash flow from operation [23]. Mainly used measurement was return on asset. We start with the top 22 mining firms, which are included in the top 100 enterprises announced by the Mongolian National Chamber of Commerce and Industry in 2021. There are key indicators based on the income of the year, state budget contributions of their tax payments, number of employees paying social insurance, and net profit and total assets to rank.

Table 1 Variables description in regression analysis

Variables type	Variables code	Variables name	Variables description
Dependent variable	ROA	Return on asset	Net profit/Total asset
Independent variable	CRIS	Climate risk index score	Index, which determined by Germanwatch, yearly (2 year lagged)
	ASSET	Asset growth rate	Annual change in total asset
	LIABILITY	Total liability	Percentage of total liability in total asset
	SIZE	Firm size	The natural logarithm of asset at the beginning of the year

IV. Results

4.1. Descriptive analysis

Descriptive Statistics Table. 2, shows the descriptive statistics for the sample used for testing for the effect of climate risk on firm performance. The required data to be included in these tests are

available for a total of 16 companies. The mean and median annual climate risks are 50.57 and 58.17 score. Our sample firms have a median ROA of 0.010, asset growth rate of 0.040, total liability of 75% of assets. The natural log of their assets (Size) median was 19.7.

Table 2 Descriptive statistics

	Mean	SD	P25	Median	P75	No. of companies	No. of obs.
Return on asset	0.052	0.17	-0.440	0.010	0.760	16	176
Climate risk index score	50.57	14.599	31.00	58.17	68.670	*	176
Asset growth rate	0.068	0.209	-0.650	0.040	0.850	16	176
Total liability	0.736	0.454	0.010	0.750	2.640	16	176
Firm size	20.063	1.686	16.860	19.700	24.400	16	176

* - Mongolian climate risk index score, 2011-2021

4.2. Regression model results

We evaluated the causal relationship between the dependent variable and the independent variable using the Granger test. The results are shown in Table 2. Climate change is an impact on the financial performance of mining companies (F=6.95, p=0.0002).

Table 3 Granger-causality test results

Granger causality	Lag	Obs.	F	P value
CRIS to ROA	3	128	6.95	0.0002
ROA to CRIS	3	128	5.17	0.0021
ASSET to ROA	3	128	10.13	0.0005
Liability to ROA	1	128	7.15	0.0012
Size to ROA	2	128	1.28	0.2403

$$ROA = 0.486 * ROA(-1) + 0.176 * ROA(-2) - 0.002 * CRIS(-1) + 0.003 * CRIS(-2) - 0.041 \quad (4)$$


$$CRIS = 13.57 * ROA(-1) - 14.435 * ROA(-2) + 0.869 * CRIS(-1) - 0.134 * CRIS(-2) + 16.268 \quad (5)$$

Table 4 Variables variance

Variance Decomposition of ROA			
Period	S.E	ROA	CRIS
1	0.143	100	0.000
2	0.159	99.57	0.429
3	0.169	99.49	0.503
Variance Decomposition of CRIS:			
Period	S.E	ROA	CRIS
1	6.634	0.002	99.997
2	9.006	4.769	95.231
3	9.862	4.328	95.672

The variance decomposition table shows the impact of the climate risk index on the company's financial performance after a year. This can be explained by the fact that changes in the climate in 2021 will affect the return on capital of mining companies in 2022. As you can see in table 4 the return on assets of Mongolian mining companies in 2023 can be calculated based on the return on capital of the previous year. Looking at detailed company effects, the climate risk index had a negative effect on financial performance for 56 percent of all companies in the randomly selected panel regression.

Fig. II Response of CRIS to ROA



The impulse response effect findings are explained in Fig. II. The impact of CRIS on financial performance is stabilizing after 2 years.

Table 2 presented the panel regression results. We evaluated four-panel regression models. In the first model, without control variables, there was a positive correlation between CRIS and the financial performance of the organization (B=0.001; p=0.054).

Table 5 Panel regression results

Independent variables	Panel regression models			
	PR (1) B (p value)	PR (2) B (p value)	PR (3) B (p value)	PR (4) B (p value)
C	-0.02 (0.623)	-0.056 (0.187)	0.106** (0.013)	0.002*** (0.001)
CRIS	0.001* (0.054)	0.002*** (0.002)	0.001** (0.026)	0.002*** (0.001)
ASSET		0.251*** (0.000)	0.280*** (0.000)	0.266*** (0.000)
LIABILITY			-0.198*** (0.000)	-0.229*** (0.000)
SIZE				-0.026*** (0.007)
Sample size	176	176	176	176
R ²	0.021	0.127	0.339	0.363
Hausman test	Random preferred	Random preferred	Random preferred	Random preferred

PR- Panel regression models, * - p value is <0.1, ** - p is <0.05, ***- p value is 0.001, B – Regression coefficients, C – Regression constant,

Table 4 illustrates the result of panel regression model. Climate risk index score (2 years lagged) has positive effect on return on asset on Mongolian mining companies (p=0.001). This could be

explained by rehabilitation costs. A mining company will be profitable for a certain period of time with the minerals of the deposit, and after the mining resources are exhausted, the natural environment must be restored. The higher the company's profitability, the better the environmental remediation can be.

CONCLUSION

Climate risk index score affects a company's financial performance. This study creates a panel data model based on the top mining corporations in Mongolia to validate the correlation and method. The financial performance of top mining companies is positively influenced by climate risk index scores. In panel regression, climate change had a positive effect on financial performance. These variables were identified as interrelated variables and their causality was tested by Granger causality test. Also, the positive relationship may be related to the support policy of Mongolia's mining industry. The positive effect of the growth of the company's capital on financial performance can be observed through the variable of capital growth. The negative effect of company size on financial performance may be due to the fact that the mining industry is part of the heavy manufacturing sector. When a company expands its operations, it requires a large amount of investment and the operating costs increase.

The negative impact of liability on financial performance can result in insufficient utilization of the additional loans received by mining companies. It is also possible to include the effect of time lag on the liability variable. - Leading mining firms must abandon their outdated ideas and acknowledge how crucial climate change concerns are to the advancement of humankind. Establishing functional divisions to deal with climate change and incorporating climate change risks into the organization's risk management system are both important at the same time. - Top mining companies should actively fulfill their emission reduction responsibilities to avoid high fines from the competent authorities

Furthermore, it is necessary to consider climate indicators in more detail and to consider extreme weather phenomena by region in the model. This study measures climate change in terms of the Climate risk index score (CRIS) at the country level.

REFERENCES

- Chen PY, Chen ST, Hsu CS, Chen CC. Modeling the global relationships among economic growth, energy consumption and CO2 emissions. *Renew Sustain Energy Rev.* 2016;65:420-431.
- Liobikienė G, Butkus M. Scale, composition, and technique effects through which the economic growth, foreign direct investment, urbanization, and trade affect greenhouse gas emissions. *Renew Energy.* 2019;132:1310-1322.
- Garza-Reyes JA. Table of Contents Table of Contents اى ر تكدده بحاصمزا يپااثر بسزا. *Eur Univ Inst.* 2012;(2):2-5. <https://eur-lex.europa.eu/legal-content/PT/TXT/PDF/?uri=CELEX:32016R0679&from=PT%0Ahttp://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CELEX:52012PC0011:pt:NOT>
- Sun Y, Yang Y, Huang N, Zou X. The impacts of climate change risks on financial performance of mining industry: Evidence from listed companies in China. *Resour Policy.* 2020;69(July):101828.

- Group WB. World Bank Group. *World Bank Gr A to Z 2016*. Published online 2015:189a - 190.
- Rüttinger L, Sharma V. Climate Change and mining A Foreign Policy Perspective legal notice. *Guideb Eval Min Proj EIAs*. 2016;63(2):45.
- Applestein C, Caughlin T, Germino MJ. Final report Final report. *Rev 3D Print potential red meat Appl*. 2021;2019(23 February 2021):1-61.
- Arent D, Pless J, Mai T, et al. Implications of high renewable electricity penetration in the U.S. for water use, greenhouse gas emissions, land-use, and materials supply. *Appl Energy*. 2014;123:368-377.
- Marshall D, Pearce T, Ford JD, et al. climate change and Canadian mining A summary for decision-makers Climate Change and Canadian Mining: Opportunities for Adaptation Summary for Decision-Makers. 2009;(August 2009):8.
- Volz U, Beirne J, Preudhomme NA, et al. Climate Change and Sovereign Risk. *SOAS Cent Sustain Financ*. 2020;(October):133.
- Information and research of meteorology hydrology and environment. Spatial distribution of average annual air temperature in Mongolia in 2022. Published online 2022:8-14.
- The World Bank Group, The Asian Development Bank. Climate Risk Country: Mongolia. Published online 2021. <https://www.adb.org/sites/default/files/publication/709901/climate-risk-country-profile-mongolia.pdf>
- Davaajargal, L Anand, B, Khosbayar E. Possible impacts and risks of climate change on the society and economy: The example of Mongolia.
- Zhong S, Huang C. *Climate Change and Human Health: Risks and Responses*. Vol 64.; 2019.
- Begg Kathryn, Frans Van Der Woerd LD. The business of climate change corporate responses to kyoto. *Angew Chemie Int Ed* 6(11), 951–952. Published online 2017:2013-2015.
- Kahn ME, Mohaddes K, Ng RNC, Pesaran MH, Raissi M, Yang J-C. Long-term macroeconomic effects of climate change: A cross-country analysis. *Energy Econ*. 2021;104:105624.
- Iriyadi I, Antonio Y. Climate Change Disclosure Impact on Indonesian Corporate Financial Performance. *J Din Akunt dan Bisnis*. 2021;8(2):117-127.
- Suarez LYT. The Case for Forceful Stewardship Part 1: The Financial Risk from Global Warming. 2015;2015(1):1-27.
- Devie D, Liman LP, Tarigan J, Jie F. Corporate social responsibility, financial performance and risk in Indonesian natural resources industry. *Soc Responsib J*. 2020;16(1):73-90. doi:10.1108/SRJ-06-2018-0155
- Edwards B, Gray M, Hunter B. A Sunburnt Country: The Economic and Financial Impact of Drought on Rural and Regional Families in Australia in an Era of Climate Change. *Aust J Labour Econ*. 2009;12(1):109-131.
- Huang HH, Kerstein J, Wang C. The impact of climate risk on firm performance and financing choices: An international comparison. *J Int Bus Stud*. 2018;49(5):633-656.
- Alshahrani F, Eulaiwi B, Duong L, Taylor G. Climate change performance and financial distress. *Bus Strateg Environ*. 2022;(October):1-23.
- Abban AR, Hasan MZ. The causality direction between environmental performance and financial performance in Australian mining companies - A panel data analysis. *Resour Policy*. 2021;70(May):101894.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ, ШИМТГЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БА БАНКНЫ ҮР АШГИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА

З.Оюунцацрал¹, Г.Намуужин², Г.Ариун-Эрдэнэ³

¹Доктор (Ph.D), СЭЗИС-ийн Ахисан түвшний сургуулийн профессор

²Магистр (MBA), СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч

³Магистр (MBA), СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш



Хураангуй

Энэхүү судалгаагаар ипотекийн зээл, зээлийн хүү, зээлийн үйл ажиллагааны шимтгэлийн талаарх суурь ойлголтыг судалж, тэдгээрийн эдийн засаг болон банкны салбарын ашигт ажиллагаа, үр ашигт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлов.

Түлхүүр үг:

Зээлийн бодит өртөг, орон сууцны үнэ, үр ашиг, суурь ойлголт, нөлөөлөл

УДИРТГАЛ

Судалгааг хийх болсон үндэслэл нь Монгол улсад үүсээд буй арилжааны банкууд болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн газрын хоорондын зөрчилдөөн буюу арилжааны банкууд ипотекийн зээлийн шимтгэл авах нь буруу гэсэн шүүхийн маргаанаас үүдэлтэйгээр судлаачдын зүгээс онол аргазүйн судалгаанд үндэслэн энэхүү асуудалд дүгнэлт өгөхөд чиглэсэн. Судалгааны хүрээд ипотекийн зээлийн хүү болон шимтгэлийн талаарх суурь ойлголтууд, эдгээрийн хоорондын хамаарлаас эхлээд ипотекийн зээлийн шимтгэл нь арилжааны банкуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөг талаар судалж дараах үр дүнгүүдийг гаргасан. Үүнд арилжааны банкны эх үүсвэрээр олгож буй ипотекийн зээлийн хувь хэмжээ нэмэгдэх тусам банкны салбарын эздийн өмчийн өгөөж тухайн зээл олгосон сардаа 0.145%-аар, 3 сарын дараах эздийн өмчийн өгөөжийг 0.172%-аар бууруулах улирлын нөлөөтэй байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Ипотекийн зээлийн хүү, шимтгэлийн тухай ойлголт

1.1 Ипотекийн зээлийн хүү

Ипотекийн зээлийн хүүгийн талаарх дэлгэрэнгүй ойлголтыг дурдахаас өмнө хүүгийн тухай ойлголт, хүүгийн түвшний суурь бүрдлийг авч үзвэл, хүүг олон улсад 3 төрлийн ойлголтоор тодорхойлдог (CFA Institute, 2022). Үүнд:

1. *Шаардлагатай өгөөжийн түвшин.* Энэ нь санхүүгийн байгууллагын хувьд зээлдэгчид зээл олгосны төлөө шаардаж буй хамгийн бага өгөөжийн түвшин юм.
2. *Хорогдуулалтын хувь.* Энэ нь мөнгө үнэ цэнээ алдаж байдаг гэсэн санхүүгийн суурь ойлголт дээр тулгуурлан өнөөдрийн нэг төгрөг ирээдүйд үнэ цэнээ хэдэн хувиар алдаж буйг харуулах хувь хэмжээ.
3. *Алдагдсан боломжийн зардал.* Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын боломжуудаас сонголт хийх явцад алдсан өөр нэг боломжоос олж болох байсан орлого, ашиг юм.

Зээлийн хүүг нэрлэсэн хүү (interest rate) болон бодит хүү буюу өртөг (annual percentage rate) гэж ангилдаг. Аливаа зээлийн нэрлэсэн хүүд эх үүсвэрийн өртөг, эрсдэлийн зардлаас гадна орон сууцны зээлийн хүүд бондын зах зээл, зохицуулагч байгууллагаас үзүүлэх аливаа нөлөө, тухайн улсын эдийн засгийн нөхцөл байдал болон хувь хүмүүсийн хүчин зүйлс нөлөөлдөг гэж үздэг. Зээлийн бодит өртгийг олон улсад зээлийн нэрлэсэн хүүгээс гадна тухайн зээлд төлж буй аливаа шимтгэл, хураамж зэргийг шингээсэн тоон үзүүлэлт гэж тодорхойлсон байдаг (USA, 2022).

Харин Монголбанкны “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн байдлын журам”-д зээлийн бодит өртөг гэж зээлдэгчээр төлүүлж буй зээлийн зарласан хүү, шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн хувиар илэрхийлсэн үзүүлэлтийг хэлнэ гэж тодорхойлсон байна. Зээлийн бодит өртгийн задаргааг харуулбал:

$$\text{Зээлийн бодит өртөг (APR)} = \text{Ипотекийн зээлийн нэрлэсэн хүү} + \text{Зээлийн үйл ажиллагааны шимтгэл} + \text{Бусад шимтгэл, хураамж}$$

Дээрх томъёоллоос харахад зээлдэгч орон сууцны зээл авахдаа зээлийн хүүгээс гадна нэмэлтээр аливаа шимтгэл, зардал (зээлийн үйл ажиллагааны шимтгэл, даатгалын хураамж, хаалтын зардал, орон сууцны брокерын шимтгэл)-ыг төлдөг. Энэ нь банкны үйлчилгээндээ тогтоож буй өртгийн бүрэлдэхүүн хэсэг ба манай улсад төдийгүй олон улсад ч тогтсон нийтлэг ойлголт юм.

АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас гаргасан “Зээл олгох тухай” журам (Truth in Lending Act)-д зээлийн бодит өртөг нь зээлтэй холбогдох зардал, шимтгэл, хураамж зэргээс шалтгаалан хоорондоо харилцан адилгүй, ялгаатай байх боломжтой. Зээлийн бодит өртөг нь зээлийн нэрлэсэн хүүгээс ялгаатай байж болно гэсэн үзэл баримтлалд тулгуурлан холбогдох хууль, журамд тусгасан байдаг.

Зээлийн бодит өртөг нь мөнгөний цаг хугацааны өнөөгийн үнэ цэнд үндэслэдэг бөгөөд энэ нь эргэн төлөгдөж буй зээлийн төлөлт нь зээлийн хүү болон үндсэн төлбөр, бусад зардлуудыг бүрэн нөхөх тооцоололд суурилдаг. Зээлээр орон сууц худалдаж авах нь бэлэн мөнгөөр орон сууц худалдаж авахаас зардал ихтэй (банк зээлийг судалж олгох, хяналт

тавихад зардал гардаг тул) гэж үздэг бөгөөд тэрхүү нэмэлт зардлыг нь шимтгэл хэлбэрээр санхүүгийн байгууллагууд хүлээж авдаг. Шимтгэл, хураамж байснаар орон сууцны зээлийн хүү бага байх боломжтой гэдгийг Холбооны нөөцийн банкны судлаач Daniel J. McDonald and Daniel L. Thornton нарын 2008 оны судалгаанд үндэслэлтэйгээр тайлбарласан байдаг (Daniel J. McDonald., 2008).

Банкуудын ипотекийн зээлийн бодит өртөгт хүү, үйлчилгээний шимтгэл, брокерын шимтгэл, даатгалын хураамж, хөнгөлөлтийн оноо зэрэг хэд хэдэн шимтгэлүүд багтдаг бөгөөд зээлийн бодит өртөг нь бүх санхүүгийн байгууллагуудын хувьд ижил байх боломжгүй. Учир нь банк бүрийн зээл олгох процесс харилцан адилгүй ялгаатай байдгийг 3.2 хэсэгт тоймлон харууллаа.

1.2 Ипотекийн зээлийн шимтгэлийн тухай

2022 оны 12 сард Forbes сэтгүүлээс зээлийн шимтгэлийн талаар хийсэн судалгаанд origination fee буюу зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг “Зээлдэгч тал таны баримт бичгийг бүрдүүлж, боловсруулж, зээл судлах, хугацаа сунгахтай холбоотой аливаа үйлчилгээг үзүүлж буйтай холбоотой олон үйлчилгээг багтаасан шимтгэл юм” гэж тодорхойлсон байна. Мөн зээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллага үйлчилгээний шимтгэл авахгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд бусад шимтгэл, хураамжаар эсвэл хүүгийн төвшнөөр дамжуулан авдаг болохыг онцолжээ (Campisi, 2022).

Зээл олголтын шимтгэл нь дараах зүйлсээс бүрддэг болохыг дэлхийн хамгийн том аудитын компаниудын нэг болох PwC 2022 оны тайландаа дурджээ (PwC, 2022). Үүнд:

1. Зээлдэгч хугацааны өмнө зээлийг хаах, зээлийн хүүг урьдчилж төлөх эсвэл зээлийн нэрлэсэн хүүг бууруулах зорилгоор авч байгаа шимтгэл
2. Зээлдүүлэгчийн үйл ажиллагааны нөхөн төлбөр
3. Зээл олгохтой шууд холбоотой зээлдэгчээс авах бусад хураамж (жишээлбэл, нарийн шинжилгээ хийж зээл олгох эсвэл богино хугацаанд зээл олгохыг зөвшөөрсний нөхөн төлбөр болгон зээлдүүлэгчид төлсөн шимтгэл)
4. Зээл олгох, дахин санхүүжүүлэх, гэрээнд бүтцийн өөрчлөлт хийх зэрэг үйл явцтай холбогдуулан зээлдэгчээс авдаг шимтгэл. Энэ нэр томъёо нь зээл, лизингийн гүйлгээний дагуу зээлдэгчийг оноожуулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгийн байршуулалт хийх, өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх, андеррайтинг болон бусад хураамжийг багтаасан бөгөөд үүгээр ч хязгаарладаггүй болохыг дурджээ.


1.3 Ипотекийн зээлийн шимтгэлийн талаар ижил төстэй улсуудын харьцуулалт

Дараах хэсэгт нэг хүнд ногдох ДНБ нь Монгол улстай ойролцоо улсуудын зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг харьцуулан нэгтгэсэн судалгааны үр дүнг харуулав (Монголын банкуудын холбоо, 2022). Уг судалгаанд сонгон судалсан орнуудын банкны хууль, эрх зүйн орчин тухайн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран зээлийн шимтгэлийг харилцан адилгүй авдаг. Тажикстан болон Узбекистан улсуудын хувьд зээлийн шимтгэл авдаггүй. Харин энэ 2 улсын хувьд зээлийн хүү бусад улстай харьцуулахад өндөр байгаа нь

зээлийн хүүд зээлийн бүхий л төрлийн шимтгэлийг шингээсэн байх магадлалтай хэмээн дүгнэжээ.

Сонгон судалсан орнуудын банкууд зээл олгоходоо зээлдэгчийг оноолуулах аргачлалыг ашиглан харилцагчийн авах боломжтой зээлийн хэмжээг тооцоолдог. Зээлдэгчийн онооноос хамааран шимтгэлийн хэмжээ нь 0.1-1 хүртэл хувь байдаг. Филиппин, Мьянмар улсуудын хувьд зээлийн шимтгэл нь 0.5 хувь хэдий ч зээлийн шийдвэр гарсан тохиолдол харилцагчаас тэмдэгтийн хураамж хэмээн зээлийн дүнгээс үл хамааран 4\$ тутамд 0.02\$-ийг суутган авдаг бол Вьетнам улсын хувьд зээлийг хугацаанаас өмнө хаахыг хүсвэл зээлийн дүнгийн 4 хүртэлх хувийг шимтгэлд төлдөг байна.

Зураг 1. Азийн банкуудын зээлийн хүү, зээлийн шимтгэлийн харьцуулалт



Эх сурвалж: Монголын банкуудын холбоо, 2022

Мөн дээрх улсуудад зээлийн шимтгэлийг үндсэн зээлээс суутган авах тохиолдол их байна. Өөрөөр хэлбэл, тухайн арилжааны банк нь зээл олгосны шимтгэлийг тухайн зээлийн дүнгээс тооцоолон харилцан адилгүй байдлаар шууд суутган авдаг байна. Английн судлаач Matteo Benetton, Alessandro Gavazza, Paolo Surico нарын 2021 онд хийсэн “Ипотекийн зээлийн үнэ тогтолт болон мөнгөний бодлогын хамаарлын судалгаа”-нд Английн засгийн газраас хэрэгжүүлсэн орон сууцны зээлийн хөтөлбөрийн нөлөөг судалжээ (Matteo Benetton, 2021).


Зураг 2. Бага хүү, өндөр шимтгэл ба Өндөр хүү, бага шимтгэл

Mortgages available	Maximum loan to value	Initial rate	Differential to Bank of England base rate (currently 0.25%)	Then changing to Santander's Standard Variable Rate	The overall cost for comparison is (APR)	Product fee	Additional benefits	Early repayment charge (ERC)	Monthly cost	Compare up to three rates
2 year fixed rate	80%	1.64%				£999	Free valuation and £250 cashback	3% + Repay £250 cashback	£813	<input type="checkbox"/>
2 year fixed rate	85%	1.74%	n/a	4.49%	4.1%	£999	Free valuation and £250 cashback	3% + Repay £250 cashback	£823	<input checked="" type="checkbox"/>
2 year fixed rate	85%	2.14%	n/a	4.49%	4.2%	£0	Free valuation and £250 cashback	3% + Repay £250 cashback	£861	<input checked="" type="checkbox"/>
2 year fixed rate First Time Buyer Exclusive	90%	2.24%				£999	Free valuation and £250 cashback	3% + Repay £250 cashback	£871	<input type="checkbox"/>
5 year fixed rate	80%	2.44%	n/a	4.49%	4.0%	£999	Free valuation and £250 cashback	5% + Repay £250 cashback	£891	<input type="checkbox"/>

Судалгаанаас шимтгэл бага үед хүү өндөр буюу 0 шимтгэлтэй үед 2.14 хувийн хүүтэй байгаа бол шимтгэл өндөр үед хүү бага буюу 999 фунт стерлингийн шимтгэл (хураамж)-тэй үед хүүгийн түвшин 1.74 хувьтай байгааг харж болно. Эндээс санхүүгийн байгууллагууд үйл ажиллагааныхаа зардлыг нөхөхийн тулд хүү болон шимтгэлийн аль нэгд нь зардлаа

шингээдэг болохыг зураг 2-т харуулав. Судлаачид судалгааны үр дүнгээ батлахдаа хүүгийн түвшин болон үйл ажиллагааны шимтгэлийн хамаарлыг тооцсон байна. Шимтгэлийн хэмжээ тасралтгүй үргэлжлэх болон тэг шимтгэлтэй үеийн хувьсагчдыг ашиглан панел үнэлэхэд хүснэгт 1-д харуулсан үр дүн гарсан байна.

Зураг 3. Зээлийн хүү ба шимтгэлийн хамаарал



Үйл ажиллагааны шимтгэлгүй үеийн хүүгийн түвшин, шимтгэлтэй үеийнхээс өндөр байгаа бөгөөд хэрэв үйл ажиллагааны шимтгэлийг 0 болговол зээлийн нэрлэсэн хүүгийн түвшин өсөх магадлалтай болохыг харуулж байна.

Эндээс зээлийн үйл ажиллагааны шимтгэл болон нэрлэсэн хүүгийн түвшин хоорондоо урвуу хамааралтай болохыг харж болно.

1.4 Зээлийн шимтгэлийн нягтлан бодох бүртгэл

Монголбанкны ерөнхийлөгч, сангийн сайдын хамтарсан А-294/340 тоот тушаалаар 2017.11.24-нд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг шинэчлэн батлах тухай” НББ-ийн багц материалд шимтгэлтэй холбогдох бүртгэл, тайлбарыг баталсан байдаг. НББ-ийн багц материалын зээл бүлгийн “Хэмжилт ба үнэлгээ” хэсэг нь СТОУС 7, СТОУС 9, НББОУС 1, НББОУС 32, НББОУС 39-тэй шууд холбогддог байна. Зээлийг анх удаа хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь үнэлнэ. Зээлийн бодит үнэ цэнд зээл олгохтой шууд холбоотой орлого, зардал шингэнэ. Шууд холбогдох орлого, зардалд **шимтгэл, хураамж, урамшуулал** гэх мэт уг зээлийг олгохтой шууд холбоотой гарсан ажил гүйлгээний орлого, зардал багтана.

НББОУС 18-ын дагуу санхүүгийн үйлчилгээний шимтгэлийн орлогын бүртгэл нь түүний зориулалт, холбогдох санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн суурь зэргээс шалтгаалан тодорхойлогдоно. Санхүүгийн үйлчилгээний шимтгэл нь уг ажил үйлчилгээний онцлог шинж, мөн чанарыг агуулахгүй байх тохиолдол гарч болно. Иймээс санхүүгийн хэрэгслийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон шимтгэл, үйлчилгээний шимтгэл, тодорхой үйлчилгээ үзүүлсний төлөө авсан хураамж зэргийг ялгаатай авч үзнэ гэж тус журамд заасан бөгөөд үйл ажиллагааны шимтгэлтэй холбогдох тайлбар болон бүртгэлийг дэлгэрүүлэн авч үзье.

Санхүүгийн хэрэгслийн шимтгэлийг хойшлуулан бүртгэж, үр ашигт хүүгийн аргаар хорогдуулах бөгөөд энэхүү шимтгэлд Санхүүгийн хөрөнгийг анх гаргах, эсвэл худалдан авахтай холбоотойгоор төлөгдсөн шимтгэл (origination fees) багтдаг (Зураг 4-ийг харна уу).

Origination fee буюу үйл ажиллагааны шимтгэлд зээлдэгчийн санхүүгийн байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа хөрөнгө, үнэт цаасны хэлцлийг үнэлж, бүртгэх, санхүүгийн хэрэгслийн нөхцөлийг харилцан тохиролцох, холбогдох баримтыг бүрдүүлж, боловсруулах, арилжааг хаах зэрэг үйл ажиллагаанд хамаарах хураамж багтана гэж тусгажээ.

Үйлчилгээний шимтгэлийг тайлант үеийн орлогод бүртгэх ба үүнд зээлийн үйлчилгээний шимтгэл орох ба зээлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх үед төлөгдсөн шимтгэлийг үйлчилгээг үзүүлсэн даруйд орлогод бүртгэхээр тусгасан байна.

Хүснэгт 4. Шимтгэлийн төрөл, онцлог




Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материалын орлого бүлгийн “Хүлээн зөвшөөрөлт” хэсэг нь НББОУС 1, НББОУС 18, НББОУС 21-тэй нийцсэн байдаг. Орлого нь банкны үйл ажиллагааны явцад үүсдэг бөгөөд төлбөр, шимтгэл, хураамж, хүү болон ногдол ашиг зэргийг хамруулна. **Банкны үндсэн орлого нь хүүгийн орлого ба хураамж, шимтгэлийн орлого юм.** Хүүгийн орлого нь тодорхой гэрээний үндсэн дээр зээлдэгчдэд олгосон зээл, бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгийг ашиглуулсны төлөө авч буй төлбөр хэмээн тодорхойлсон ба шимтгэл, хураамжийн орлогыг бүртгэхдээ **холбогдох шимтгэл, хураамжийн орлого** дансанд бүртгэхээр тусгажээ. СТОУС, НББОУС, Монголбанкны НББ-ын багц материалын журамд заасны дагуу арилжааны банкууд шимтгэлийн орлогыг бүртгэхдээ хураамж, шимтгэлийн орлого гэсэн дансанд бүртгэх бөгөөд харилцагч бүрийн нэр дээр тусад нь шимтгэлийн орлогод бүртгэж, зарцуулалтыг мөн тус бүрчлэн зарлагаар бүртгэх зохицуулалт, бүртгэлийн стандарт, журам байдаггүй.

2. Ипотекийн зээлийн банкны үр ашигт үзүүлэх нөлөө

2.1 Орон сууцны үнэ болон ипотекийн зээлийн хамаарал (Олон улсад)

2001 онд Испани улсад ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасны нийт дүн эрчимтэй өсөж байсан бөгөөд үүнээс хойш ипотекийн зээлийн тогтолцоонд оруулсан өөрчлөлтүүд нь орон сууцны үнэ нэмэгдэхэд шууд нөлөө үзүүлсэн гэж шинжээчид дүгнэсэн байна (Valverde & Fernández, 2009). Ирландын ипотекийн зээл болон орон сууцны үнийн хоорондын харилцан хамаарлыг судалсан ажлуудад мөн эдгээр нь шууд хамааралтай байгааг тодорхойлжээ (Fitzpatrick & McQuinn, 2007). Доорх зурагт АНУ-ын орон сууцны үнийн индекс болон ипотекийн зээлийн хүүгийн түвшний хоорондын хамаарлыг харууллаа. Эндээс хугацаа өнгөрөх тусам эдийн засгийг дэмжих зорилго бүхий ипотекийн зээлийн хүүгийн түвшин болон орон сууцны үнэ нь хоорондоо сөрөг хамааралтай байгааг харж болохоор байна.

Зураг 5. АНУ-ын орон сууцны үнийн индекс болон Ипотекийн зээлийн хүүгийн түвшний хамаарал



Эх сурвалж: (S&P Dow Jones Indices LLC, 2022)

Ипотекийн зээлийн хүү буурч, орон сууцны үнэ өсөх хөдөлгөөн судалгааны нийт хугацааны 53%-д тохиолдсон бөгөөд ипотекийн зээлийн хүүгийн өсөлт, бууралтаас хамааран нийт хугацааны 85%-д орон сууцны үнэ өссөн статистик үзүүлэлттэй байна. Эндээс ипотекийн зээлийн хөтөлбөр нь орон сууцны үнэ өсөхөд нөлөөлөх нэг чухал хүчин зүйл болж байгааг харуулж байна. Харин хөтөлбөрийг хэрэгжүүлж буй банкуудын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг дараагийн хэсэгт судалгааны үр дүнгээс харья.

2.2 Ипотекийн зээлийн арилжааны банкны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

Кенийн судлаачид 2009–2013 оны санхүүгийн өгөгдөл дээр үндэслэсэн Кени улсын олон нийтэд нээлттэй 11 арилжааны банк дээр хийсэн судалгаанд ипотекийн зээлийн санхүүжилт арилжааны банкуудын санхүүгийн үзүүлэлтэд хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байгаа үр дүнг харуулжээ (Ojiambo, 2014). Мөн Dondi болон Ouma нарын судалгаанд корреляцийн шинжилгээг ашиглан арилжааны банкны санхүүгийн гүйцэтгэлийн хувьсагчид (ROE, ROA болон NIM) болон үндсэн бие даасан хувьсагч (Ипотекийн зээлийн хэмжээ) хооронд 95%-ийн интервалын түвшинд мэдэгдэхүйц сөрөг хамаарал байгааг дүгнэн харуулжээ (Dondi & Ouma, 2017). Арилжааны банкуудын иргэдэд олгож буй ипотекийн зээл нийт дүнгээрээ өсөхөд тухайн банкны хөрөнгө оруулагчдын өгөөж (Return on equity) болон нийт хөрөнгөө ашиглан олж буй өгөөжүүд (Return on asset) тус тус буурахад нөлөөлж байгааг харуулжээ. Монголын банкуудад үзүүлэх нөлөөллийг дараагийн хэсэгт харууллаа.

2.3 Ипотекийн зээл, шимтгэл болон арилжааны банкуудын ашигт ажиллагаа хоорондын хамаарал

Дээрх олон улсын онолын судалгаануудад үндэслэн Монгол улсын арилжааны банкнуудын ашигт ажиллагаа болон ипотекийн зээл, шимтгэл хоорондын хамаарлыг Монголбанкнаас гаргадаг “Банкуудын нэгдсэн тайлан тэнцэл”-ийн 2017 оны 5 сараас 2022 оны 11 сарын хоёрдогч тоон өгөгдөлд үндэслэн тодорхойлов. Шинжилгээнд “Хамгийн бага квадратын арга”-аар регрессийн шинжилгээ хийж үнэлэв. Үүнд:

Тайлбарлагдагч хувьсагчдаар:

- ROE – Эздийн өмчийн өгөөж
- ROA – Нийт хөрөнгийн өгөөж

Тайлбарлагч хувьсагчдаар:

- **BANK** – Ипотекийн нийт зээлд эзлэх банкны эх үүсвэрээр олгосон зээлийн хувь
- **M_VOL** – Ипотекийн нийт зээлийн өсөлтийн хувь

Хяналтын хувьсагчдаар:

- **USD** – Төгрөгийн ам доллартой харьцах ханш
- **L_GROWTH** – Банкны салбарын нийт зээлийн өсөлт
- **S_GROWTH** – Банкны салбарын нийт хадгаламжийн өсөлт
- **S_RATE** – Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
- **L_RATE** – Зээлийн жигнэсэн дундаж хүү

Үр дүн 1: Ипотекийн нийт зээл олголт 1%-аар өсөх нь 1-ээс 2 сарын хугацааны туршид банкны салбарын эздийн өмчийн өгөөжийг харгалзан 0.037%, 0.025%-аар бууруулах нөлөө үзүүлдэг.

$$ROE = -0.212 - 0.021 * M_VOL - 0.145 * BANK + 0.00016 * USD - 0.172 * BANK(-3) - 0.037 * M_VOL(-1) - 0.025 * M_VOL(-2)$$

Мөн арилжааны банкны эх үүсвэрээр олгож буй ипотекийн зээлийн хувь хэмжээ нэмэгдэх тусам банкны салбарын эздийн өмчийн өгөөж тухайн зээл олгосон сардаа 0.145%-аар, 3 сарын дараах эздийн өмчийн өгөөжийг 0.172%-аар бууруулах улирлын нөлөөтэй байна.

Үр дүн 2: Ипотекийн нийт зээл олголт 1%-аар өсөх нь 1-ээс 2 сарын хугацааны туршид банкны салбарын нийт хөрөнгийн өгөөжийг харгалзан 0.0035%, 0.0025%-аар бууруулах нөлөө үзүүлдэг.

$$ROA = -0.020 - 0.002 * M_VOL - 0.012 * BANK - 0.014 * BANK(-3) - 0.0035 * M_VOL(-1) - 0.0025 * M_VOL(-2) + 1.414 * USD$$

Мөн арилжааны банкны эх үүсвэрээр олгож буй ипотекийн зээлийн хувь хэмжээ нэмэгдэх тусам банкны салбарын нийт хөрөнгийн өгөөжийг тухайн зээл олгосон сардаа 0.012%-аар, 3 сарын дараа 0.014%-аар бууруулах улирлын нөлөөтэй байна.

Үр дүн 3: Ипотекийн зээл олголтын шимтгэлийн нийт дүн өсөх нь банкны ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг.

Монголын арилжааны банкуудаар дамжуулан олгосон ипотекийн зээлийн нийт дүнгээс 1%-аар тооцож гаргасан зээл олголтын шимтгэлийн дүнг арилжааны банкуудын ашигт ажиллагаатай уялдуулан хамаарлыг тооцоход эдгээр нь сөрөг хамааралтай байна. Ипотекийн зээлийн шимтгэл нь тухайн зээл олгосон хугацаандаа болон 3 сарын хоцрогдолтойгоор арилжааны банкуудын эздийн өмчийн өгөөж болон нийт хөрөнгийн өгөөжийг бууруулах нөлөө үзүүлж байна.

Шинжилгээний үр дүнгээс харахад ипотекийн зээлийн хөтөлбөр нь Монголын арилжааны банкуудад үр ашиггүй байхыг үгүйсгэхгүй бөгөөд энэ хөтөлбөр хэнд үр ашигтай байна вэ? гэсэн асуулт гарч ирж байна.

ДҮГНЭЛТ

Бид ипотекийн зээл, зээлийн хүү, зээлийн үйл ажиллагааны шимтгэлийн талаарх суурь ойлголтыг судалж, тэдгээрийн эдийн засаг болон банкны салбарын ашигт ажиллагаа, үр ашигт хэрхэн нөлөөлж байгааг олж тогтоох зорилготой судалгаа хийлээ. Судалгааны үр дүнг нэгтгэн харуулбал. Үүнд:

1. Зээлийн бодит хүүгийн хувь буюу өртгийг олон улсад зээлийн нэрлэсэн хүүгээс гадна тухайн зээлд төлж буй аливаа шимтгэл, хураамж зэргийг шингээсэн тоон үзүүлэлт гэж тодорхойлдог. Манай улсын хувьд зээлийн бодит өртгийг зээлдэгчээр төлүүлж буй зээлийн зарласан хүү шимтгэл, хураамж, бусад нэмэлт зардлыг багтаасан дүнг жилийн хувиар илэрхийлсэн үзүүлэлт хэмээн тодорхойлсон байдаг. Зээлдэгч орон сууцны зээл авахдаа зээлийн хүүгээс гадна нэмэлтээр аливаа шимтгэл, хураамжийг төлдөг. Энэ нь банкны үйлчилгээндээ тогтоож буй өртгийн бүрэлдэхүүн хэсэг ба манай улсад төдийгүй олон улсад ч тогтсон нийтлэг ойлголт юм.
2. Гадаадын судалгаануудаас харахад ипотекийн зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг зээлдэгчийн бүрдүүлсэн баримт бичгийг боловсруулж, зээл судлахтай холбоотой аливаа үйлчилгээг багтаасан шимтгэл гэж үздэг. Манай улсын хувьд “Ипотекийн зээлийн үйл ажиллагааны журам”-д ипотекийн зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх үүднээс зээл үүсгэх харилцаа, зээлийн өргөдөл, баримт бичгийн судалгаа хийх, шийдвэр гаргах, барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх, тайлан гаргах, зээлийн түүхийн судалгаа, шуудан холбоо, нэмэлт судалгаа, хяналт шалгалт, хугацаа сунгасны шимтгэл гэх мэт зардлыг шингээсэн шимтгэлийг зээлдэгчээр төлүүлэхээр тусгасан байна. Шимтгэл, хураамжийг тусад нь авснаар ипотекийн зээлийн нэрлэсэн хүүг бага байлгах боломжтой гэдгийг судалгаанууд харуулж байна.
3. Нэг хүнд ногдох ДНБ нь Монгол улстай ойролцоо улсуудын ипотекийн зээлийн үйл ажиллагааны шимтгэлийг харьцуулахад зээлийн процессоосоо хамааран ялгаатай алхмуудтай байна. Алхам бүрийн цаана үйл ажиллагааны зардал гарна, үйл ажиллагааны зардлаа шимтгэлийн орлогоороо санхүүжүүлэх шаардлагатай болно. Санхүүгийн байгууллагууд үйл ажиллагааныхаа зардлыг нөхөхийн тулд хүү болон шимтгэлийн аль нэгд нь зардлаа шингээдэг. Мөн үйл ажиллагааны шимтгэл болон хүүгийн түвшин хоорондоо сөрөг хамааралтай болохыг олон судалгаанууд харуулж байна.
4. СТОУС, НББОУС, Монголбанкны НББ-ын багц материалын журамд заасны дагуу арилжааны банкууд шимтгэлийн орлогыг бүртгэхдээ хураамж, шимтгэлийн орлого гэсэн нэгдсэн дансанд бүртгэдэг. Харин харилцагч бүрийн нэр дээр тусад нь шимтгэлийн орлогод бүртгэж, зарцуулалтыг мөн тус бүрчлэн зарлагаар бүртгэх зохицуулалт, бүртгэлийн стандарт, журам байдаггүй.
5. Олон улсад хийгдсэн ипотекийн зээл болон орон сууцны үнийн хоорондын харилцан хамаарлыг судалсан судалгааны ажлуудад ипотекийн зээл олголт болон орон сууцны үнийн хооронд шууд хамаарал байгааг нийтлэг тодорхойлжээ. Ипотекийн зээл олголт, хүүгийн түвшний бууралт нь эдийн засагт орон сууцны үнийн хөөргөдөл бий болгох шууд хамааралтай байгааг харуулж байна.
6. Ипотекийн зээл олголт, зээлийн шимтгэлийн арилжааны банкуудын ашигт ажиллагаанд үзүүлж байгаа нөлөөлөл нь эерэг болон сөрөг үр дүнгүүдийг үзүүлж байгаа нь харагдаж

байна. Харин манай улсын хувьд хийсэн шинжилгээгээр ипотекийн нийт зээл олголт 1%-аар өсөх нь 1-ээс 2 сарын туршид банкны салбарын эздийн өмчийн өгөөжийг болон нийт хөрөнгийн өгөөжийг бууруулах нөлөө үзүүлдэг. Ипотекийн зээл олголтын шимтгэлийн нийт дүн өсөх нь банкны ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн үр дүнгүүдийг тус тус харуулжээ.


7. Нэг талаас зээлийн хүүг арилжааны банкууд тогтоодоггүй, нөгөө талаас ЗГ-аас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр учир бодлогоор дэмжих шаардлагатай болдог. Энэхүү хөтөлбөр нь олон талын оролцоонд суурилсан, ажиллагаа ихээхэн шаарддаг болох нь ОУ-ын хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд болон манай улсад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагаа, процессын зураглалаас харагдаж байна.

НОМЗҮЙ ЖАГСААЛТ

- Campisi, N. (2022, November 30). Retrieved from Forbes advisor: <https://www.forbes.com/advisor/mortgages/best-mortgage-lenders-no-origination-fee/>
- CFA Institute. (2022). *Quantitative methods Volume 1*.
- Daniel J. McDonald., a. D. (2008). A primer on the Mortgage Market and Mortgage Finance. *Federal Reserve Bank of St. Louis Review*, 90(1), 31-45.
- Dondi, D. O., & Ouma, J. O. (2017). *Relationship Between Volume of Mortgage Lending and Financial Performance of Commercial Banks*. Kenya: International Journal of Business and Management Invention.
- Fitzpatrick, T., & McQuinn, K. (2007). House prices and mortgage credit: Empirical evidence for Ireland. *The Manchester School*, Vol. 75, No. 1, pp. 82-103.
- Karanjia, A. W. (2013). *Mortgage financing and profitability of commercial banks in Kenya*. Kenya.
- Korea housing finance corporaion. (2023). *KOREA HOUSING FINANCE CORPORATION ACT*.
- Matteo Benetton, A. G. (2021). *Mortgage pricing and Monetary policy*.
- Miles, D. (2004). *The UK Mortgage Market: Taking a Longer-Term View*. United Kingdom: Imperial College London.
- Ojiambo, L. (2014). *THE EFFECT OF REAL ESTATE FINANCE ON FINANCIAL PERFORMANCE OF COMMERCIAL BANKS LISTED ON THE NAIROBI SECURITIES EXCHANGE*. Kenya: University of Nairobi.
- Rajapakse, P. J. (2006). *Issuance of residential mortgage-backed securities in Australia - legal and regulatory aspects*. Australia: The University of New South Wales law journal.
- Ross, J. (2022, 9 7). *How Closely Related Are Historical Mortgage Rates and Housing Prices?* Retrieved from MARKETS IN A MINUTE: <https://advisor.visualcapitalist.com/historical-mortgage-rates-vs-housing-prices/>
- S&P Dow Jones Indices LLC. (2022, 12 23). *S&P/Case-Shiller U.S. National Home Price Index*. Retrieved from Federal Reserve Bank of St. Louis: <https://fred.stlouisfed.org/series/CSUSHPINSA>


- USA, U. S. (2022, 12). *Consumer Financial Protection Bureau*. Retrieved from <http://www.consumerfinance.gov/>: <https://www.consumerfinance.gov/ask-cfpb/what-are-discount-points-and-lender-credits-and-how-do-they-work-en-136/>
- Valverde, S. C., & Fernández, F. R. (2009). *THE RELATIONSHIP BETWEEN MORTGAGE MARKETS AND HOUSE PRICES: DOES FINANCIAL INSTABILITY MAKE THE DIFFERENCE?* Spain: Santiago Carbo Valverde, Departamento de Teoría e Historia.
- Монголбанк. (2023, 01 03). *Түгээмэл асуулт, хариулт*. Retrieved from <https://www.mongolbank.mn/repoipotek.aspx?id=3>
- Монголын банкуудын холбоо. (2022). *Банкны зээлийн шимтгэлийн талаарх судалгаа*. Улаанбаатар хот: Монголын банкуудын холбоо.
- Тэнхлэг зууч. (2023, 01 02). *Хуучин орон сууцны дундаж үнийн мэдээлэл*. Retrieved from <https://tz.mn/mn/p/152>

Хавсралт 1 Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй процесс




Эх сурвалж: (Монголбанк, 2023)

Хавсралт 2 Австрали улсын ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй процесс



Эх сурвалж: (Rajapakse, 2006)

Хавсралт 3. Их Британи улсын ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй процесс



Эх сурвалж: (Miles, 2004)

Хавсралт 4 Улс орнуудын эрх зүйн актуудын хүрээнд ипотекийн зээл олгох процессийн харьцуулалт

N	Энэтхэг улс	N	Вьетнам улс	N	Монгол улс
1	Зээлдэгч зээл хүсэх анкетыг бөглөж, шаардлагатай баримт бичгийг хүргүүлэх	1	Зээл авах урьдчилсан шалгуур. Зээлдүүлэгч нь орлого, өр гэх мэт санхүүгийн үндсэн мэдээлэлтэй танилцах ба зээлдэгч хэдэн төгрөгийн байр авах боломжтойг тодорхойлно.	1	Зээлийн хүсэлт хүлээн авах (3 алхам)
2	Зээл хүсэгчийн мэдээлэл, бичиг баримт дээр судалгаа хийх	2	Ипотекийн зээлийн хөтөлбөр ба хүү. Зээлдэгчид хамгийн тохиромжтой ипотекийн хөтөлбөр, хүүг санал болгох.	2	Ипотекийн зээлийн баримт бичиг бүрдүүлэх (3-4 алхам)
3	Банкны хурлаар зээлдэгчийн хүсэлтийг хэлэлцэх	3	Бичиг баримт. Зээлдэгч зээл хүсэх өргөдлийг бөглөж, шаардлагатай материалыг бүрдүүлнэ.	3	Ипотекийн зээлийн судалгаа хийх (3 алхам)
4	Баримт бичгийг үнэлэх	4	Зээлийн тооцоо. Зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээлийн хүү, зээлийн үндсэн төлбөр, даатгал, шимтгэл зэргийг багтаасан бүхий л тооцооллыг хийх.	4	Зээлийн эрсдэлийн иж бүрэн үнэлгээ хийх (13 алхам)

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

5	Зээл олгох эсэх шийдвэр гаргах	5	Шийдвэр гаргах. Зээлийг олгох эсвэл татгалзах эсэх шийдвэрийг гаргана	5	Барьцаа хөрөнгийн үнэлгээ, тайлан (3-4 алхам)
6	Зээл олгох шийдвэр гарсны дараагаар банк зээлийг үнэт цаасжуулах хүсэлтийг илгээнэ	6	Боловсруулалт. Ипотекийн зээлийг зээлдэгчид олгох процесс эхлэх.	6	Зээлийг шийдвэрлэх (13 алхам)
7	Хуулийн дагуу үл хөдлөх хөрөнгийн бичиг баримтыг боловсруулах	7	Шаардлагатай баримт бичиг. Зээлдэгч шаардлагатай нэмэлт бүх бичиг баримтуудыг бүрдүүлж өгөх.	7	Даатгалын нөхцөл (5 алхам)
8	Мэргэжлийн үл хөдлөх хөрөнгийн шинжээчдээр барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгөд шинжилгээ хийлгэх	8	Зээлийн бүртгэл. Зээлдэгчийн өмнөх зээлийн эргэн төлөлттэй холбоотой бүхий л мэдээллийг хянах.	8	Зээлийн хувийн хэрэг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах (3 алхам)
9	Зээлийн хэлэлцээрийг хийх	9	Үнэлгээ. Зээлдэгчийн зээлийн барьцаа хөрөнгө болох орон сууцыг үнэлэх.	9	Ипотекийн зээлийн үйлчилгээ, хяналт шалгалт хийх (8-14 алхам)
10	Зээлийн гэрээнд гарын үсэг зурах	10	Андеррайтинг. Зээлийг санхүүжүүлэгч байгууллага руу илгээж, зөвшөөрсөн эсэх хариуг авна.		
11	Зээл олголт хийгдэх	11	Хаалтын тодруулга хийх.		
		12	Хаалт. Зээлийг хүлээн зөвшөөрсний дараагаар зээл нь хаалтын болон санхүүжилтийн хэлтэс рүү шилждэг.		
		13	Зээл олгох		



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ЗАЛУУ АЖИЛТНУУДЫН АЖЛЫН БАЙРНЫ ҮНЭТ ЗҮЙЛИЙН СУДАЛГАА: Z үеийнхний жишээн дээр

Б.Баярсайхан¹, С.Сайн-Од², Б.Идэрцогт³

¹Магистр (МВА), СЭЗИС, Бизнесийн Удирдлагын Тэнхим, Bayarsaikhan.b@ufe.edu.mn

²Магистр (МВА), СЭЗИС, Бизнесийн Удирдлагын Тэнхим, Sain-od.s@ufe.edu.mn

³Магистр (МВА), СЭЗИС, Бизнесийн Удирдлагын Тэнхим, Idertsogt.b@ufe.edu.mn



Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь залуу ажилтнуудын ажлын байран дахь үнэт зүйлийн ач холбогдлыг тодорхойлоход оршино. Z үе бол хамгийн залуу, хамгийн сонирхолтой бүлэг бөгөөд хөдөлмөрийн зах зээл дээр бүх салбарт онцгой нөлөөлөл үзүүлж байгаа учраас судлаачдын анхаарлыг ихээр татаж байна. Шинэ эринд өсч байгаа энэхүү үеийн залуу ажилтнууд нь технологийн хөгжлийн орчинд төрөл бүрийн хэрэгслээр ядах зүйлгүй мэдээллийг олж авч байгаа онцлогтой ба нийгэм, эдийн засаг, түүхийн замналаас шалтгаалан хувь хүний зан чанарын хувьд эрхэмлэх үнэт зүйл, ажлын байранд ирээдүйдээ хувийн хөгжлийн төлөвлөгөөндөө анхаарч ач холбогдол өгч буй үнэт зүйлүүд нь их онцлогтой байгааг бусад судалгааны ажлаас харж болох юм. Энэ судалгааны зорилгод хүрэхийн тулд, санал асуулгын аргаар одоо ажил эрхэлж байгаа, өнгөрсөн хугацаанд ажил эрхэлж байсан, ажилгүй ба ажил хийж байгаагүй хүмүүсийг хамруулсан болно. Судалгаанд нийт 200 оролцогчид хамрагдсан бөгөөд хүчин зүйлсийн шинжилгээ хийж өгөгдлийг боловсрууллаа.

Судалгааны үр дүнд хамгийн өндөр үнэлэгдсэн үнэт зүйлд тухайн ажлаа чанартай хийх, өөрөө өөртэйгөө ажиллах, үнэнч шударга байдал, үүрэг хариуцлага, өөрийгөө харуулах боломжтой байх зэргээр эрэмбэлэв.

Түлхүүр үг:

Z үе, Залуу ажилтнууд,
Paired samples T test,
Зөрүүний шинжилгээ

ОРШИЛ

Z үеийн залуу ажилтны талаар цөөнгүй судлаачид судалгааны ажлаа хийж байгаагаас дэвшилтэт технологи болон инновацтай холбоотой ойр өссөн гэдэг таамаглалд үнэдэслэсэн ажилд илүү ихээр анхаарлаа хандуулж байна (Quintanilha, 2019). Харин хөдөлмөрийн зах

зээл дээр Z үеийнхний эрхэмлэж буй үнэт зүйлтэй хэрхэн уялдаж, нийцэж байгааг судалсан судлаачид ховор байна (Bejtkovsky, 2013).

Хөдөлмөрийн зах зээл дээр оюутнуудын өрсөлдөх ур чадварыг дэмжсэн мэдлэгийг өгөх зорилготой дээд боловсролын салбар ажиллаж байгааг харгалзан үзвэл, тэдний чухалчилж байгаа үнэт зүйлийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай байна. Судалгааны гол асуудал нь тэдний үнэт зүйлэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэж байна уу? гэдэгт оршино. Тиймээс судалгааны зорилго нь хувь хүний үнэт зүйл болон зан төлөвийн ялгаатай ойлголтууд залуу ажилтнуудын хувьд ямар байгааг тодорхойлоход оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд 50 ялгаатай үнэт зүйлийн тодорхойлолтыг боловсруулж, залуу үеийн төлөөллүүдээр бөглүүлж, Z үеийн залуусын талаарх судалгааны ажлын санд хувь нэмэр болох ач холбогдолтой.

ОНОЛЫН СУДАЛГАА

Куппершмидтийн тодорхойлсноор “үе” гэдэг нэр томъёог “төрсөн он, цаг хугацааны явцад туршлагаа хуваалцдаг, амьдралын туршид тохиолдох төрөл бүрийн хүчин зүйлсэд нөлөөлөх болон нөлөөнд автах бүлэг хүмүүс” гэж тодорхойлсон байна (Kupperschmidt, 2000). Судлаачдын одоогийн байдлаар 6 ялгаатай үе байгааг тодорхойлсон байна (Becton JB, 2014). Үүнд: 1) ахмад үе; 2) baby boomer үе; 3) X үе; 4) Y үе; 5) Z үе ; 6) Alpha үеийнхэн (Facebook generation/digital natives).

Үе үеийн төлөөллийн ажлын үнэт зүйлийн шинж чанарууд:

- Baby boomers үеийнхэн 1946-1964 оны хооронд төрсөн бөгөөд тэд сорилтод дуртай, хэт ажилсаг, шүүмжлэгчид болон сэтгэгчид байх нь элбэг (Dries N. P., 2008).
- X үеийн төлөөллүүд 1961-1981 оны хооронд төрсөн ба суралцах хүсэлтэй, сониуч, материаллаг, тэнцвэртэй гэж тодорхойлсон байна (Dries N. &., 2008).
- Y үеийн төлөөллүүд 1980 оны эхэн үеэс 1990 оны сүүл хүртэл онуудад төрсөн ба тэд тэнцвэртэй байдал, суралцах, найдвартай байдал, бэлэн байдал зэргийг чухалчилдаг байна. (Gayeski, 2015).
- Z үеийн залуучууд нь 20-25 насны залуучуул байх ба цахим, интернэт орчин гэдгээр хаяглагдсан бүлэг хүмүүс юм (Gale, 2015).

Эцэг эхийн хэт их хамгаалалтанд байх соёл нь амьдралын ухаанд суралцах боломжийг санамсаргүйгээр алга болгодог гэж Z үеийн залуучууд үздэг (Lukianoff, 2019). Энэ нь тэдний биеэ даасан насанд хүрсэн хүн болоход, ажил, амьдралын аливаа сорилтыг даван туулахад, нөлөөлж, нийгмийн, сэтгэл хөдлөл, хувь хүний хөгжлийн явцад муугаар нөлөөлж байна гэсэн үг. Бие даана гэдэг нь тодорхойгүй нөхцөл байдалд хариуцлагатай шийдвэр гаргахад суралцах үйл явц юм. Z үеийнхний ажлын байранд манлайллын дүрүүдийг авах дургүй байх шалтгаан нь манлайлж чадахгүй гэсэн айдас, өөртөө итгэх итгэл дутуу байдагтай холбоотойг судлаач онцлон тэмдэглэсэн байна (Schroth, 2019).

Судлаач Dose (1997) ажлын үнэт зүйлийн тодорхойлолтыг олон талаас нь тайлбарласнаар үнэт зүйлийг тодорхойлогч хүчин зүйлсийн зарим эргэлзээг багасгасан байна. Тэрээр “ажлын үнэт зүйлэ нь ажил болон ажлын байран дээр юуг чухалчилж байгааг үнэлэх

стандартууд” гэж тодорхойлсон (Dose, 1997). Ялгаатай үе үеийн төлөөллийн хүмүүсийн үнэт зүйл, ур чадвар, шинж чанарууд нь шууд удирдлагад сорилт болон боломжуудыг бий болгож байдаг (Gursoy, 2008).

Хүний нөөцийн удирдлагын ниймгэмлэгийн 2009 оны судалгаагаар ажилтнуудын ялгаатай үнэт зүйл нь ажлын байран дээр зөрчлүүдийг үүсгэдэг эх үүсвэр гэж тайлбарласан байдаг хэдий ч ихэнх судалгаа хэрвээ тэр зөрчлийг сайнаар эргүүлж удирдаж чадвал онцгүй давуу тал болон боломжуудыг бас бүтээнэ гэж үзсэн байна. (Lancaster, 2002).

Ажлын үнэт зүйлийн талаар маш олон ялгаатай тайлбарууд байдаг бөгөөд өнгөрсөн цаг хугацаанд 3 бүлэг үнэт зүйлийг тодорхойлсон байна. Нэгдүгээрт: дотоод үнэт зүйл – сэтгэл ханамж, ажлын сорилт бэрхшээл, оюун санааны мэдрэмж, хоёрдугаарт: гадаад үнэт зүйл – ажлын материаллаг зүйлс, цалин хангамж, ажлын байрны баталгаа, гуравдугаарт: нийгмийн үнэт зүйл – хамтран ажиллагсдын болон удирдах хүний харилцаа, бусдад болон нийгэмд туслах хувь нэмэр гэх мэтийг багтаасан (Ng, 2010).

Дотоод үнэт зүйл нь өрсөлдөх чадвар болон бие даах байдал зэрэг сэтгэл зүйн хэрэгцээгээ хангах амбицаар дамжин бие сэтгэлийн эрүүл мэндтэй мөн холбогддог байна (Deci, 2000). Ажлын явцад хамгийн ихээр бий болдог биет бус нөлөөллийн шинж чанартай үнэт зүйлүүд дотоод үнэт зүйлд багтдаг байна. Тухайлбал: Ажилдаа сонирхолтой байх, суралцах хүсэлтэй байх зэрэгт богино хугацааны үр дүн болон урамших үйл явц чухал нөлөөлдөг (Ryan, 2000). Гадаад үнэт зүйлийн хувьд ихэнх судлаачид карьер өсөлт, эрх мэдэл, ажлын статус зэргийг чухалчилдаг. Энэ нь өөртөө итгэх итгэлийг би болгодог гэсэн бол зарим судлаач зөвхөн их хэмжээний орлоготой байх нь илүү их сэтгэл ханамжийг бий болгодог гэсэн байр суурийг илэрхийлдэг (Malka, 2003).

Судлаач Lyons ба Twenge нар нийгмийн үнэт зүйлийг хэрхэн хамтран ажиллагсадтайгаа тогтоож байгаа харилцаа холбооноос гадна чөлөөт цаг, хөгжилтэй байх зэргийг мөн багтааж тайлбарласан байна (Lyons, 2010). Ажил дээрээ хөгжилтэй байх, хошин шогийн мэдрэмжтэй байх зэрэг нь ажилтнуудын эрч хүч, мотивацийг нэмэгдүүлдэг. Шинэ мянганы үеийнхнийг судалсан судалгааны ажлын дүгнэлтээс харахад ажлын байран дээр үнэт зүйл нь гадаад үнэт зүйлийг хамгийн эхэнд чухалчилж, дараа нь дотоод үнэт зүйл болон нийгмийн үнэт зүйл эрэмбэлэгдсэн байна (Kuron, 2015).

Харин Z үеийнхэн ажлын байран дээр харьцангуй шинэ байгаа учраас системтэй үнэлгээ хийгдээгүй боловч багагүй үр дүн гарсан байна. Z үеийн төлөөлөл нь 2000 оноос хойш төрсөн бүлгийг хамруулж байгаа бөгөөд шинэ мянганы үеийн дараагийн үе болж судлаачдын эрчимтэй судлах судалгааны сэдэв болсон юм. Тоймлон хэлэхэд Z үеийнхэн нь төрөлхийн технологид ээлтэй, дуртай гэсэн ерөнхий дүр төрхүүдээр тайлбарлагддаг ч үнэт зүйл талаасаа шударга, ил тод байдал, өөртөө найдах зэрэг шинж чанаруудыг ажлын байранд түлхүү эрхэмлэж байна (Mileski M, 2016). Гэсэн хэдий ч, энэ үе нь технологид суурилсан ур чадваруудтай, бие даасан / багаар ажиллахын эсрэг / хувийн, мэргэжлийн, хүрээлэн буй орчны гэсэн хүчин зүйлсэд анхаарлаа түлхүү хандуулах зэрэг ерөнхий байдлаар судлагдсан бөгөөд асуултын тэмдэг хэвээр байсаар байна (West M, 2014).

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Ямар үнэт зүйл залуу ажилтнуудын хувьд чухал байгааг олж илрүүлэхийн тулд 1995 оноос хойш төрсөн оюутан болон залуу ажилтнуудаас судалгааг авсан болно. Судалгаандаа санал асуулгын арга хэрэглэсэн бөгөөд Barret Value Center - ийн үнэлгээ мониторингийн албанаас гаргасан судалгаанд үндэслэлээ. Уг судалгаа нь нийт 100 гаруй хувь хүний болон байгууллагын үнэт зүйлийг 7 бүлэгт хуваасан байдаг. Харин энэхүү судалгааны ажил нь “Z” үеийг төлөөлж буй залуу ажилтнуудын чухалчилж буй үнэт зүйлсийг тодорхойлох зорилгоор нэгдүгээрт: судалгаанд оролцогчийн хувийн мэдээлэл, хоёрдугаарт: үнэт зүйлийн чухалчилсан байдлыг тодруулах 50 асуулттай хэсгүүдтэй.

Судалгааны санал асуулгын дагуу үнэт зүйлийг үнэлүүлэхдээ нийгмийн шинжлэх ухааны судалгааны ажилд түгээмэл ашигладаг 5 хэмжээст хэмжигдэхүүнийг сонгосон бөгөөд “1” – нь огт чухал биш, “5” – нь маш чухал болохыг харуулна. Бүх асуулт тухайн судалгаанд оролцогчийн хувьд болон байгууллагын хувьд гэсэн 2 ялгаатай байр сууринаас хэрхэн үнэт зүйлийг чухалчилж байгааг үнэлүүлж, үнэт зүйл хоорондын зөрүү буюу ялгаатай байдлыг тодруулах юм. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогч 50 асуулт бүхий үнэт зүйлийг Таны хувьд хэр чухал вэ?, Байгууллагын хувьд хэр чухал гэж та бодож байна вэ? асуултад харицлах зарчмаар үнэлнэ гэсэн үг юм. Санал асуулга нь нээлттэй болон хаалттай асуултуудаас бүрдсэн бөгөөд судалгааны санал асуулгын цаасан хуудас, цахим хэлбэрээр “google form” ашиглан мэдээлэл цуглуулсан болно.

Судалгаанд оролцогчдоор 4 бүлгийн 50 ялгаатай үнэт зүйлсийг үнэлүүлсэн дундаж утгууд дээр “Paired sample T-test” (A. Ross, 2017)-ээр ялгааг тестэлнэ.

ЭМПИРИК СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын хувийн мэдээлэл буюу түүврийн тархалт.

Хүснэгт 1 Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Хүйс	эрэгтэй	эмэгтэй	
	44%	56%	
Нас	Дундаж	Интервал	
	22	14-28	
Төрсөн газар	УБ	Орон нутаг ба гадаад улс	
	70%	30%	
Ажил эрхлэлт	Ажилтай	Ажиллаж байсан	Ажилгүй
	53%	27%	20%

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Нийт судалгаанд 206 Z үеийн төлөөлөл болох 14-28 насны залуучууд хамрагдсан бөгөөд Дэлхийн банкны Баррет үнэт зүйлсийн төв байгууллагын тодорхойлсон 50 ялгаатай үнэт зүйлсээр чухалчлах байдлыг хувь хүн болон байгууллагын гэсэн хоёр талаас үнэлүүлээ. Үүнээс 22 үнэт зүйлс бүхий хүчин зүйлс нь байгууллага болон хувь хүний хувьд хоорондоо зөрүүтэй, статистик ялгаатай байв.

Z-үеийн ажлын байран дээрх үнэт зүйлсийг хувь хүний хувьд болон ажил олгогчийн хувьд хэр чухал байгааг хэрхэн хүртэж байгаагаар хоорондын ялгааг Paired Samples T-test-ээр шалгав. Үр дүнг хүснэгт 2-т дэлгэрэнгүй харууллаа.


Зураг 1 Paired samples T test-ийн үр дүн

№	Зөрүү үүсч буй үнэт зүйлс	Paired sample T-test			t	df	Sig. (2-tailed)
		Дундаж утга					
		Хувь хүн	Байгууллага	Зөрүү			
Pair 1	X5 Ажил амьдрал, чөлөөт цагийн тэнцвэрийг хангах	4.6039	4.1208	0.48309	6.471	206	0
Pair 2	X8 Өөрийгөө харуулах боломжтой байх	4.3913	4.0966	0.29469	4.209	206	0
Pair 3	X9 Биений, сэтгэлзүйн, оюуны, дотоод мэдрэмжийн тэнцвэр	4.3961	3.8164	0.57971	6.861	206	0
Pair 4	X11 Шахалт шаардлагатай байх	3.2802	3.744	-0.46377	-5.749	206	0
Pair 5	X12 Олон төрлийн ажлуудтай байх	3.3478	3.6812	-0.33333	-3.824	206	0
Pair 6	X13 Мэргэших, туршлагажих боломжтой байх	4.4589	4.2802	0.17874	2.779	206	0.006
Pair 7	X14 Өрсөлдөөнт орчинтой байх	3.7246	3.9082	-0.18357	-2.66	206	0.008
Pair 8	X15 Хараат бус байдал	4.1159	3.7536	0.36232	4.278	206	0
Pair 9	X19 Ажилдаа гаршсан байх	4.087	4.3527	-0.2657	-4.019	206	0
Pair 10	X21 Санхүүгийн тогтвортой байдал	4.372	4.2271	0.14493	2.173	206	0.031
Pair 11	X22 Хэгийн төлвийг тодорхойлох	4.0773	4.2995	-0.22222	-3.522	206	0.001
Pair 12	X23 Харилцан бие биедээ тусалдаг байх	4.5266	4.314	0.21256	3.463	206	0.001
Pair 13	X26 Багаар ажилладаг байх	4.4396	4.5845	-0.14493	-2.968	206	0.003
Pair 14	X27 Үр дүнд чиглэсэн байх	4.3478	4.5459	-0.19807	-3.398	206	0.001
Pair 15	X29 Практик туршлагатай байх	3.7295	4.2415	-0.51208	-6.887	206	0
Pair 16	X30 Тодорхой бус нөхцөлд үйлдэл хийх чадвар	4.0821	4.3092	-0.22705	-3.658	206	0
Pair 17	X32 Зорилго тодорхойлох чадвартай	4.2512	4.4058	-0.15459	-2.372	206	0.019
Pair 18	X33 Төлөвлөгөөний дагуу ажилладаг байх	4.3285	4.5459	-0.21739	-3.603	206	0
Pair 19	X36 Амжилт гаргах	3.913	4.1691	-0.25604	-3.671	206	0
Pair 20	X40 Имидж ба нэр хүнд	3.715	4.0338	-0.31884	-4.173	206	0
Pair 21	X46 Аливааг урт хугацаанд хардаг байх	4.2464	4.5072	-0.26087	-4.062	206	0
Pair 22	X49 Өөрөө өөртэйгөө ажилладаг байх	4.4155	4.1787	0.23671	3.801	206	0

Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Зураг 1 дээр гарсан зөрүү утгууд тулгуурлан Z үеийнхний үнэт зүйлс нь байгууллагын хүлээлтээс өндөр байгааг улаан өнгөөр, байгууллагын хүлээлт нь хувь хүний үнэлгээнээс өндөр байгааг цэнхэр өнгөөр тус тус илэрхийлж зөрүүтэй байдлын шинжилгээг зураг 2-оор харууллаа.


Зураг 2. Зөрүүтэй байдлын шинжилгээ



Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Ажлын байрны 22 зөрүүтэй үнэт зүйлсийн 14 буюу 64% нь байгууллагын хувьд хүлээлт өндөртэй үнэт зүйлс байгаа бол 8 буюу 36% нь хувь хүний хувьд хүлээлт өндөртэй үнэт зүйлс байна. Тухайлбал:

Зураг 3. Ажлын үнэт зүйлс /төрлөөр/



Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт

Судалгааны Paired Samples T-test-ээр тодорхойлогдсон нийт 22 зөрүүтэй ажлын үнэт зүйлсийг судлаачдын ангилан хуваасан 4 төрөлд багцалж үзвэл дотоод үнэт зүйлийг чухалчилж байгаа хувь дийлэнх буюу 55%-ийг, гадаад болон ажлын статустай холбоотой үнэт зүйлэ тус бүр 18%-ийг, нийгмийн үнэт зүйл 9%-ийг эзэлж байна.

ДҮГНЭЛТ

Z үеийн залуу ажилтнуудын эхний үе нь ажлын байран дээр гараад 6 жил болсон байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээрх идэвхтэй ажиллах хүчний гол хэсэг болж эхэлж байна. Ажлын байран дээр чухалчилж байгаа үнэт зүйлсийг үе үеийн төлөөллүүд ялгаатай хүртэж, ойлгож байгаа нь ажил олгогч нарт удирдлагын арга барилаа тодорхой байлгах, тэдэнтэй хэрхэн харилцах, хэрхэн урамшуулах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааны сорилт болон боломжуудыг гаргаж байдаг. Иймээс энэ үеийн төлөөллийн залуу ажилтнуудад ямар үнэт зүйлсээр дамжуулан манлайлах, удирдах, гүйцэтгэлийг нэмэгдүүлэх нь шууд удирдлагад зайлшгүй тулгамдсан асуудал хэвээр байна. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад залуу ажилтнуудын биеийн, сэтгэл зүйн, оюун санааны, дотоод мэдрэмжийн тэнцвэрийг хангах нь хамгийн чухал үнэт зүйлд тооцогдож байна. Үүнээс гадна ажил амьдрал, чөлөөт цагийн тэнцвэрийг хангах нь мөн Z үеийнхний хувьд чухал эрэмбэлэгдэж байна. Иймээс ажил олгогчийн зүгээс залуу ажилтнууддаа бие даасан байдалтай ажиллах ажлын орчноос илүүтэй өөрийгөө харуулах боломжийг бүрдүүлэх буюу сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хүчин зүйлсийг олгож чадахгүй байна. Нөгөө талаасаа ажилтны хувьд илүү чухал байхаасаа илүүтэй ажил олгогч байгууллагын хувьд чухал байх үнэт зүйлсийг залуу үеийнхэн урт хугацааны төлөвлөлттэй, хийж гүйцэтгэх ажлуудыг тодорхой байлгах, аливааг урт хугацаанд хардаг байхыг хүсдэг байна. Үүнээс харахад өөрийгөө танин мэдэх, ойлгох,

дотоод мэдрэмжтэй холбоотой сэтгэл ханамж зэрэг хүчин зүйлс нь Z үеийн залуу ажилтнуудын хувьд их ач холбогдолтой байна. Санхүүгийн болон материаллаг үнэт зүйлийг дотоод үнэт зүйлээс илүү чухалчлахгүй байгаа нь 1995 оноос хойш төрсөн төлөөллийн залуусын онцлогийг тодотгож байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Байгууллагын зүгээс ажлын байран дээрх ажлын зорилго, үүрэг даалгавар, харилцааны хувьд тодорхой бус байдлыг бууруулахад чиглэсэн нөхцөл байдлыг бүрдүүлэх нь чухал байна.

Энэ үеийн залуучуудын шинэ зүйлд суралцах хандлага, үйл явц нь богино хугацааны шинж чанартай болж байгаа учраас тодорхой чиглэлд мэргэших, дадлага туршлагыг хуримтлуулах байдал нь чухал бус болж байгаа тул шинэ ажилтнуудыг бүрдүүлэх, сонгон шалгаруулалтын үйл явц дахь шаардлагуудыг бууруулах боломжуудыг эрэлхийлэх нь зүйтэй.

Судалгааны үр дүнд ажил олгогчид энэ үеийн төлөөллүүдийг удирдахад хяналт, шахалт шаардлагатай байдлыг чухалчлахаас илүүтэйгээр хувийн дэмжлэг үзүүлэх, туслан зөвлөх байдлаар гүйцэтгэлийг сайжруулахад чиглэх хэрэгтэй.

Энэ үеийнхэнд ажлын төрөл, агуулга нь ямар байх нь чухал биш учраас тэдэнд илүү утга учиртай, өөрсдөд нь тохирсон, хийх дуртай байх ажлыг харгалзан үзэх нь зөв оновчтой удирдах боломжийг бүрдүүлж чадна.

Тэдний хувьд ажлын байран дээр заавал нэр хүндтэй байх, бусдын дунд хүлээн зөвшөөрөгдөх, амжилтын хэрэгцээ их биш байгаа учраас байгууллага нь үнэт зүйлийн амлалтуудтай холбож тэднийг татах нь үр дүнтэй биш байх магадлалтай.

Дээрх бүгдээс нэгтгэн үзвэл ажил олгогч байгууллагууд нь залуу ажилтнуудад чиглэсэн хүний нөөцийн бодлогоо эргэн харах, шууд удирдлагууд нь манлайллын арга барилаа өдөр тутмын ажил үүрэг, харилцаанд хөтөч болох арга замуудыг ашиглах хэрэгцээ үүсч байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

A. Ross, V. L. (2017). Paired Samples T-Test In: Basic and Advanced Statistical Tests. *SensePublishers*, 17-19.

Becton JB, W. H.-F. (2014). Generational differences in workplace behavior. *Journal of Applied Social Psychology*, 175-189.

Bejtkovsky. (2013). Age management concept. *IBIMA*, 805-813.

Deci, E. L. (2000). The ‘what’ and ‘why’ of goal pursuits: Human needs and the self-determination of behavior. *Psychological Inquiry*, 227-268.

Dose, J. J. (1997). Work values: An integrative framework and illustrative application to organizational socialization. *Journal of Occupational and Organizational Psychology*, 219-240.

Dries, N. &. (2008). Exploring four generations beliefs about career Is “satisfied” the new “successful”? *Journal of Managerial Psychology*, 907-928.

- Dries, N. P. (2008). Exploring four generations beliefs about career Is “satisfied” the new “successful”? *Journal of Managerial* , 907-928.
- Gale, S. (2015). Forget Millennials: are you ready for Generation Z? *Workforce solution review*, 9-11.
- Gayeski, D. (2015). Will Gen Z care about HR technology? *Workforce Solution Review*, 9-11.
- Gursoy, D. M. (2008). Generational differences: An examination of work values and generational gaps in the hospitality workforce. *International Journal of hospitality management*, 455-488.
- Kupperschmidt, B. (2000). Multigenerational employees: Strategies for Effective Management. *Health Care Management*, 65-76.
- Kuron, L. L. (2015). Millennials’ work values: differences across the school to work transition. *Personnel Review*, 991-1009.
- Lancaster, L. C. (2002). *When generations collide: Traditionalists, baby boomers, Generation Xers, millennials: Who they are, why they clash, how to solve the enerational puzzle at work*. New York, NY: : Harper Collins.
- Lukianoff, G. &. (2019). . *The coddling of the American How good intentions and bad ideas are setting up a generation for failure*. London.
- Lyons, S. D. (2010). A Comparison of the Values and Commitment of Private.
- Malka, A. a. (2003). Intrinsic and extrinsic work orientations as moderators of the effect of annual income on subjective well-being: A longitudinal analysis. *Personality and Social Psychology Bulletin*, 737–746.
- Mileski M, S. K. (2016). Perceptions of the value of professional networking by undergraduate students in a school of health administration: a pilot study. *The Journal of Health Administration Education*, 461-474.
- Ng, E. S. (2010). New Generation, Great Expectations: A Field Study of the Millennial Generation. *Journal of Business and Psychology*, 281-292.
- Quintanilha, R. V. (2019). *Kybernetes*, 91-107.
- Ryan, R. M. (2000). The ‘what’ and ‘why’ of goal pursuits: Human needs and the self-determination of behavior. *Psychological Inquiry*, 227-268.
- Schroth, H. (2019). Are You Ready for Gen Z in the Workplace? *California Management Review*, 5-18.
- West M. (2014). What manufacturers need to know about generation Z. *Manufacturing Engineering*, 168-168.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

КЛИНИК ЭМНЭЛГИЙН ЭМНЭЛ ЗҮЙН ЗАСАГЛАЛЫГ ҮНЭЛЭХ СУДАЛГАА (ОНОЛ АРГА ЗҮЙН СУДАЛГАА)

Б. Урэлцэцэг¹, Д. Гэрэлмаа²

¹Магистр (MBA). (СЭЗИС),

²Доктор (Ph.D), профессор. (СЭЗИС)



Хураангуй

Эмнэл зүйн засаглалын асуудал нь олон судлаачийн сонирхлыг татсан, эрэлт хэрэгцээ ихтэй асуудал боловч МУ-д энэ талаар хийгдсэн эмпирик судалгаа цөөн байна.

Түлхүүр үг:

засаглал, эмнэл зүйн
засаглал, клиник эмнэлэг,
эмнэл зүйн засаглалын
үнэлгээ, эрүүл мэндийн
систем тогтолцоо,

УДИРТГАЛ

Эрүүл мэндийн салбар хурдацтай хөгжиж, улмаар хүний дундаж наслалт нэмэгдэхийн хэрээр дэлхий даяар хүн амын тоо огцом нэмэгдэж байна. Хүн амын тоо ийнхүү нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн байгууллагууд хүн амын өсөлтийн хэрэгцээг хангахын тулд зөвхөн нөхөн үржихүйн цогц үйлчилгээнээс гадна эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх оношилгооны арга хэлбэрүүдийг нээн хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Үүний зэрэгцээ дэлхийн хүн амын дунд төрөл бүрийн халдварт болон халдварт бус өвчнөөр өвчлөх явдал буураагүйгээр барахгүй урьд өмнө гарч байгаагүй шинэ төрлийн өвчний тархалт нэмэгдэж байгаа нь эмнэлгийн байгууллага, эмнэлгийн ажилтнуудаас эмчилгээний арга, аргачлал, ур чадвараа сайжруулах, эмчилгээний чанар, хүртээмж, эмчилгээ, үйлчилгээнд мөрдөгддөг стандартуудыг хатуу мөрдөж ажиллахыг шаардах боллоо. Энэ нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа эрүүл мэндийн байгууллагуудад тулгарч буй асуудал боловч улс орнуудын хөгжлийн түвшин, онцлогоос шалтгаалан өөр өөр арга замаар шийдэгдэх нь тодорхой. Монгол Улсын эрүүл мэндийн салбарт сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн үсрэнгүй өөрчлөлт, хөгжил явагдаж, Төрөөс эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого, Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарыг

сайжруулахад чиглэсэн ихээхэн өөрчлөлт хийгдэж байгаа ч эмнэлгийн үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх асуудалд доголдол байсаар байгаа нь эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж буй улсын клиник эмнэлгүүдийн шийдлээ хүлээсэн чухал асуудал байсаар байна. Эмнэлгийн байгууллага, эмнэлгийн ажилтнуудын ур чадвар, хариуцлага, хандлага, институцийг удирдах арга барил ялгаатай байгаатай холбоотойгоор дараах дутагдлууд байсаар байна. Тухайлбал:

- ✓ Эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн үнэлгээ сул, тааруу үзүүлэлттэй байна. (ЭМХТ 2019, 2020), (WHO., 2019, 2020)
- ✓ Эмнэлгийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, зорилго, баримтлах стратеги тодорхой бус, түүнийг дэмжсэн удирдлагын бүтэц, байгууллагын соёл хангалттай бүрдээгүй.
- ✓ Эмнэлгийн байгууллагын үйлчилгээний чанар хангалтгүй, тэгш хүртээмжтэй бус.
- ✓ Эмнэлгийн байгууллагуудын ажилтнуудын дунд хээл хахууль их.
- ✓ Сайн засаглалыг тогтолцоо дутмаг гэх мэт. (Mickan and Boyce, 2018)

Засаглал гэсэн нэр томъёог орчин үеийн бизнест 40 –өөд жилийн өмнөөс хэрэглэж иржээ. Түүнээс хойш энэхүү томъёоллыг эрдэмтэн судлаачид гүнзгийрүүлэн судалж, шинэ үзэл баримтлалаар баяжуулан өөрсдийн бүтээлд өргөн хэрэглэх болсон байдаг. Компанийн засаглалыг Adrian “Менежмент бол бизнес эрхлэх тухай, засаглал бол түүнийг зөв удирдах чиглүүлэх явдал юм” гэж тодорхойлсон байна. (Adrian, 2000) “*Засаглал*” гэсэн нэр томъёог ямар асуудал, ямар салбар ямар цар хүрээнд авч үзэж байгаагаас хамааруулан компанийн засаглал, клиник засаглал, соёлын засаглал, эмнэлгийн засаглал, нийгмийн засаглал, цахим засаглал, засгийн газрын засаглал гэх мэтээр ангилдаг.

Бид, энэхүү судалгааны ажлын хүрээнд эмнэл зүйн засаглалын асуудлыг эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулдаг клиник эмнэлгүүдийн жишээн дээр судлах зорилго тавьсан юм. Эмнэл зүйн засаглалын асуудал нь олон судлаачийн сонирхлыг татсан, эрэлт хэрэгцээ ихтэй асуудал боловч энэ талаар хийгдсэн эмпирик судалгаанууд цөөн байна.

Эмнэл зүйн засаглал гэдэг нь: Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмнэл зүйн эрсдэл, удирдлагын системчилсэн хандлага, дутагдалтай асуудлыг илрүүлж, засаж залруулах, стандартыг мөрдүүлэхэд чиглэсэн хариуцлагын тодорхой чиг үүргийг бий болгох үйл явцуудыг багтаасан ойлголт юм. Тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний гүйцэтгэлийн болон үр дүнгийн аудит хийх, шинжлэх ухаанд суурилсан эм, эмнэл зүйн стандартчилагдсан үйлчилгээг хэрэглэх, мэргэжлийн байгууллагын удирдамж зөвлөгөөний дагуу эмчилгээний чиглэлийг боловсруулах замаар үр дүнг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хуульчлан мөрддөг захиргааны удирдлагын хэлбэр юм. (NHS, 1998)

Эрүүл мэндийн салбарын засаглалын хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд засгийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд болон бусад институц байгууллагууд клиникийн засаглалд илүү их хөрөнгө оруулалт хийж, ялангуяа хөгжиж буй орнуудын эрүүл мэндийн байгууллагууд, эмч ажилчдын дунд эрэлт хэрэгцээ ихтэй хөгжиж байна. (Frenk & Moon, 2013). (Nmai, Mensah, & Delle, 2015)

Эмнэл зүйн засаглалын нэр томъёо болон судлаачдын судалгааны ажлуудад өгсөн тодорхойлолтуудаас харахад эмнэл зүйн засаглалыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулахын тулд хяналт үнэлгээ хийх, бүтэц зохион байгуулалт, эрүүл

мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн нэгдмэл цогц үйл ажиллагаа хэмээн үзэж байна. (Mickan and Boyce, 2018) .

Эрүүл мэндийн салбарын засаглалын хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд засгийн газрууд, эрүүл мэндийн байгууллагууд болон бусад институц байгууллага клиникийн засаглалд илүү их хөрөнгө оруулалт хийж, ялангуяа хөгжиж буй орнуудын эрүүл мэндийн байгууллагууд, эмч ажилчдын дунд эрэлт хэрэгцээ ихтэй хөгжиж байна. (Frenk & Moon, 2013). (Nmai, Mensah, & Delle, 2015)

Эмнэл зүйн засаглалын нэр томьёо болон судлаачдын судалгааны ажлуудад өгсөн тодорхойлолтуудаас харахад эмнэл зүйн засаглалыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг тогтмол сайжруулахын тулд хяналт үнэлгээ хийх, бүтэц зохион байгуулалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн нэгдмэл цогц үйл ажиллагаа хэмээн үзэж байна. (Mickan and Boyce, 2018)

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судлагдсан байдал

Засаглал тухай ойлголт онол арга зүйн үндэс нь юу болох, бусад салбар шинжлэх ухаануудтай хэрхэн холбогдох, засаглалын зарчим, түүнийг хэмжих арга зүй, гол тулгамдсан асуудал нь хаана байгааг судлагдсан байдлын судалгаагаар судлахыг зорьсон болно. Европын холбооны эрүүл мэндийн системийн засаглалын зарчим, арга хэрэгсэл, түүний нөлөөлөл стандартууд болон ОУ-ын хэмжээнд судлагдсан байдал, засаглалын зарчим, улс орнуудын эмнэлзүйн засаглалын түвшин судлаач нарын нэг сэдэвт бүтээл, судалгаануудыг судлаж үзлээ. Англи улсын үндэсний эрүүл мэндийн үйлчилгээг (NHS) сайжруулах үйл явцын үр дүнд эмнэлзүйн засаглал бий болсон. 1948 онд байгуулагдсан NHS бол Английн төрийн санхүүжүүлдэг үндэсний эрүүл мэндийн систем юм. *Эмнэл зүйн засаглал гэдэг нэр томьёо нь:* Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмнэлзүйн эрсдлийн удирдлагын системчилсэн хандлага, тааруу үзүүлэлтүүдийг тодорхойлох, залруулах, стандартын хариуцлагын тодорхой шугамыг бий болгох үйл явцыг багтаасан нэр томьёо юм. (NHS, 1998) Эмнэлзүйн засаглал нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, сайжруулах системтэй арга юм. Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарт гарсан алдаа, сөрөг үйл явдлууд нь ОУ-ын хэмжээнд эрүүл мэндийн тогтолцооны хамгийн чухал асуудал гэж хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд өвчтөний аюулгүй байдлыг дэлхий нийтийн тэргүүлэх чиглэл болгон онцолж байна. (WHO., 2008)

Орчин үед эмнэл зүйн засаглал нь хэд хэдэн оронд илүү танил болсон ч ихэнх оронд нь зохих ёсоор хэрэгждэггүй. 1970-аад онд чанарын бүрэлдэхүүн хэсгүүдийг (шалгуур, стандарт, норм гэх мэт) тодорхойлсон байдаг (Донабедиан нар, 1982). 1980-аад онд чанар нь өөрийн удирдлагын хувьд тусдаа биш байсан ч менежерүүд үйлдвэрлэлийн бүх хэмжүүрийг үргэлж хариуцдаг байсан бөгөөд чанарыг байгууллагын гүйцэтгэл гэсэн гарчигтай авч үздэг байв. Дараа нь шинэчлэл, засаглалын үйл явцад эмч нарын оролцоо эрүүл мэнд, чанарын менежментэд чухал ач холбогдолтой. (Брайтвейт ба Травагиа, 2008).1990-ээд онд эрүүл мэндийн технологи хурдацтай хөгжиж, эмнэл зүйн менежментийн аргуудыг сайжруулснаар удирдлагын тогтолцооны нарийн төвөгтэй байдал улам бүр нэмэгдэв. Энэхүү нарийн

төвөгтэй байдал нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тодорхой бөгөөд тогтвортой чанарыг шаарддаг. Эрүүл мэндийн тогтолцоонд аюулгүй байдал, чанарын арга хэмжээ дутмагтай холбоотой эмнэл зүйн асуудлууд ихсэх тусам эмнэл зүйн тусламж үйлчилгээний чанар, хариуцлагыг сайжруулах шаардлага гарч байна. Mannion and Davies (2002: 68)-ийн хэлснээр, “эмнэл зүйн засаглал нь мэргэжлийн зохицуулалт, хяналт тавих, чанарыг сайжруулах илүү тодорхой хүрээ рүү шилжихийг тусгадаг” ба “эмнэл зүйн засаглалын хөтөлбөрт үндсэн төлөөлөгчийн тогтолцоог ашиглан дүн шинжилгээ хийдэг”. Skok and Macmillan (2000) нар Австралийн эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг сайжруулахын тулд илүү сайн, шинэ нээлт, шинэлэг санаануудыг боловсруулсан талаар дурджээ. Жишээ нь: Эмнэлгийн байгууллагын салбарыг дэмжих тогтолцоо бол ямар нэгэн байгууллагад эрх мэдэл, гэрчилгээ олгоход чиглэсэн магадлан итгэмжлэлийн чанартай үйл ажиллагаа бус харин тухайн байгууллагын соёл, дүр төрхийг өөрчлөхөд чиглэсэн системтэй, олон талт үйл ажиллагааг хамарсан, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй дээшлүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ байхыг чухалчилсан байна. Мөн түүнчлэн Австралийн Баруун хэсэгт эмнэлгийн байгууллагын аудит, хяналт шалгалт, эмнэлгийн байгууллагын эрсдэлийн удирдлага, мэргэжлийн боловсрол, болон мэргэжил дээшлүүлсэн байдал зэрэг дээр үндэслэн эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд эмнэлгийн байгууллагын засаглалын шинэ загварыг гаргасан байна. (Introduction to clinical governance n.d, p. 2). Энэхүү шинэ загвар нь өвчтөний сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх, эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн үйл ажиллагааг илүү сайн хийж гүйцэтгэх, эмнэлгийн байгууллагын дэмжлэгт орчныг бүрдүүлэхэд чиглэсэн юм. Эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүд эмнэлгийн байгууллагын засаглалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь тэд тусламж үйлчилгээний чанарын хэмжигдэхүүн, чанарын баталгаатай байдал, чанарыг дээшлүүлэх асуудал эргээд эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүд, эмч нарыг буруутгах гол зүйл болно гэж боддогтой холбоотой ажээ. Эмнэлгийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах асуудлыг эрүүл мэндийн салбарт өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагаас гадна, тусдаа зүйл хэмээн хүлээн авдаг бөгөөд түүнд оролцох нь эргээд ажлын ачаалал, цаг хугацааны хувьд дарамттай нэмэлт үүрэг болно гэж үздэг байна. Тэгээд ч бодит практикт хэрэгжсэн жишээ болгон харчихаар төгс загварчлал өнөөг хүртэл байхгүй байгаа нь тэдний хувьд эргэлзэх, эсэргүүцэх үндсэн шалтгаануудын нэг болж байна. (Shekelle 2002, p.6) Энэхүү загварчлал байхгүй нөхцөлд Английн Үндэсний Эрүүл Мэндийн үйлчилгээний газраас санхүүжүүлэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж буй багийнхантай хамтран үнэлгээ өгөх боломж бүхий загварчлалыг боловсруулсан байна. Campbell et al (2002) Англи улсад дээрх загварыг бий болгох үүднээс эрүүл мэндийн анхан шатны тусламжийн түвшинд эмнэлгийн байгууллагын засаглалын чиглэлээр судалгаа хийсэн бөгөөд уг эмнэлгийн байгууллагын засаглалын загварыг хэрэгжүүлэхэд хамгийн чухал нь байгууллагын соёл, дүр төрхийг өөрчлөх, ялангуяа бодит амьдрал дээр тохиолдож буй туршлагауудыг харгалзан үзэж нэгтгэн ажиллах хэрэгтэйг санал болгожээ. Английн үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний эмнэлгийн байгууллагын засаглалын дарга, эрүүл мэндийн хэлтсийн орлогч дарга Aidan Halligan хэлэхдээ “Итгэл үнэмшлийг хүчин чармайлттай нэгтгэхэд бид маш их ажиллах шаардлагатай бөгөөд хамгийн гол нь шинэ соёл, дүр төрхийг хэвшүүлэхэд саад их байгаа гэж бодож байна. Тасралтгүй суралцах нь эмнэлгийн байгууллагын засаглалын гол зүрх

болсон асуудал бөгөөд үүнийг бид үндэсний бодлогын түвшинд ч, тухайн орон нутгийн, байгууллагын амжилттай хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчид болон өвчтөнүүдэд илүү бодитой үр өгөөжийг өгөх болно гэдэгт миний бие найдаж байна” гэжээ (UK Government 2003, p.1).

Эмнэлгийн байгууллагын сургалт, семинар, хурал зөвлөлгөөн зэргийг хөтөлбөр, төлөвлөгөөнд нэвтрүүлэхийн сацуу эмнэлгийн байгууллагын засаглалыг хөгжүүлэх, дэмжихийн төлөө бүх хүмүүс хамтран ажиллах хэрэгтэй юм. Практикт, эмнэлгийн байгууллагын салбарт ажиллаж буй хүний хувьд мэдээлэл, шинэлэг зүйлүүдийн талаар бусадтай ил тодоор хуваалцан, хамтран суралцаж өөрийн болон бусдын ажлыг үнэлэх нь маш чухал билээ.

Spath (1997) тэмдэглэхдээ эмнэлгийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар үйл ажиллагаа нь эмнэлгийн байгууллагын салбарын нотолгоонд суурилсан үйл ажиллагаа, түүний ил тод байдлыг дээшлүүлэх, үнэлэх, асуудлын нэгэн хэсэг болох ёстой. Эмнэлгийн байгууллагын засаглалын гол хандлага, чиг үүрэг нь эмнэлгийн байгууллагын салбар болон түүний түүний дэмжлэгт орчны ил тод, нээлттэй байдлын үр дүн, эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээний гүйцэтгэл зэргийг мэргэжлийн хүмүүс дүгнэх, үнэлэх, эргэцүүлэн бодоход тустай юм. Мөн түүнчлэн тусламж үйлчилгээний үр дүнтэй байдлыг хэмжих, шинээр арга аргачлал боловсруулах хэрэгтэй байна. Эдгээр саад бэрхшээл, стратегиудаас харахад эмнэлгийн байгууллагын засаглалыг амжилттай хэрэгжүүлэхэд хамгийн гол нь цаашдын тууштай судалгаануудыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай юм. Эмнэлгийн байгууллагын мэргэжлийн хүмүүс бүгд хүчин чадлаа нэгтгэн хамтран ажилласны үндсэн дээр эмнэлгийн байгууллагын тусламж үйлчилгээний чанар сайжирч эмнэлгийн байгууллагын засаглал амжилттай хэрэгжих болно гэдгийг ухаарч ойлгох хэрэгтэй.

Монгол Улс 1990-ээд оныг хүртэл эмнэлэг, эмч нарын тоог нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний тогтоцооны янз бүрийн хэлбэрийг сонгон хөгжүүлэх бодлогыг баримталж иржээ.⁴⁰ ДЭМБ-ын “Монголын эрүүл мэндийн тогтолцоо салаа замын уулзвар дээр Семашкогийн дараах загварын бүрэн бус шилжилт” (2006) тайланд эмнэлгийн салбарын дэд бүтэц, үйлчилгээг нийлүүлэх, нэгтгэх замаар зохистой болгох, эмчилгээнд хэвтүүлэхээс өөр аргуудын ашиглалтыг нэмэгдүүлэх тухай дурдсан байна. ЗГ-аас баталсан “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө” (2005), тус төлөвлөгөөнд эмнэлгийн хүчин чадал, үйлчилгээг зохистой болгож тусламж үйлчилгээний үр ашгийг сайжруулах талаар маш тодорхой оруулсан байна. Эмнэлгийн салбарыг хөгжүүлэх энэхүү бодлогын баримт бичигт засаглалтай холбоотой шийдэл, стратегиудыг тодорхой санал болгосон байна.

Судалгааны арга зүй

Арга зүйн хувьд судалгааны асуулга, ярилцлага, фокус бүлгийн уулзалт хийж анхдагч мэдээлэл цуглуулахаас гадна хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглана. Мэдээллийг боловсруулахад задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, судалгааны тоон болон чанарын шинжилгээний аргуудыг ашиглав. Эмнэл зүйн засаглалыг үнэлэх, засаглалын уур амьсгалын судалгаа хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахад урьдчилан боловсруулсан анкетийн асуулгыг ашиглана. Анкетийн судалгаанд оролцогчдыг

⁴⁰ Эрүүл мэндийн яамны түүхэн замнал УБ.2010


санамсаргүй түүврийн аргаар сонгов Түүвэрийн хэмжээг тодорхойлохдоо түүврийн төлөөлөх чадварын хувь 10% -аас багагүй байхаар тооцлоо. Засаглалд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд, тэдгээрийн хамаарлыг судлахад корреляци, регрессийн аргыг ашиглалаа.

Судалгааны хувьсагчид: Чанарын хувьсагчаар компанийн хамтын засаглалын үзүүлэлтүүдийг (ил тод, нээлттэй байдал, аудит болон хяналт, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон хороодын үйл ажиллагаа), тоон хувьсагчаар эрүүл мэндийн үйлчилгээний үр дүнгийн үзүүлэлтүүдийг авч үзлээ. Эдгээрээс хамааран хувьсагч нь засаглалын үзүүлэлтүүд, үл хамаарах хувьсагч нь гүйцэтгэлийг хэмжих үзүүлэлтүүд байна.

Эмнэлзүйн засаглалын үнэлгээний загвар, судалгааны арга зүй

Эмнэл зүйн засаглал нь хариуцлага, нээлттэй ил тод байдал, харилцан суралцах замаар тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг тасралтгүй сайжруулах тогтолцоо юм. Эмнэл зүйн засаглал нь үйлчлүүлэгчдийнхээ эрүүл мэнд амь насанд аюулгүй байдлыг хангаж эрсдэлийг бууруулж, жигд хүртээмжтэй хүргэж мэргэжлийн хариуцлага, нээлттэй ил тод байдал, харилцан суралцах замаар тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг тасралтгүй сайжруулах тогтолцоо юм.⁴¹

Зураг 1-1 Эмнэл зүйн засаглалын үнэлгээний загвар



Эх сурвалж: NHS, 1998

Эмнэл зүйн засаглал гэдэг нь удирдах байгууллагын удирдлага, менежерүүд, клиникч ажилтнууд, тусламж үйлчилгээний чанар, тасралтгүй сайжруулж, эрсдэлийг багасгах, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээнд онцгой орчин бүрдүүлэх үүрэг хариуцлага, хариуцлага тооцдог тогтолцоо юм. Эмнэл зүйн засаглалын загварыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанарын зорилтууд үндэслэн баталж, үр дүн нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн загвар юм. Эмнэл зүйн засаглалын хамрах хүрээ нь нэлээд өргөн бөгөөд тусламж

⁴¹ Pool, Robert & Wenzel Geissler. (2005). Medical anthropology (Series: Understanding Public Health). Maidenhead: McGraw-Hill Education.

үйлчилгээний стандартыг дэмжих, сайжруулах, ахиулахад туслах олон үйл ажиллагааг хамардаг. Эмнэл зүйн засаглал нь эдгээр бүх үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохын тулд тэдгээрийг хооронд нь холбохыг хичээдэг. Эмнэлгийн байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарыг ерөнхийд нь авч үзэх үндэс суурь, тогтолцоог бүрдүүлдэг. Эмнэл зүйн засаглалын зарчим, эмнэл зүйн засаглал гэж юу болох талаар илүү сайн ойлголттой болохын зэрэгцээ үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар судалдаг. *Эх сурвалж: (NHS 1998., WHO 2008.)*

Судалгааны үр дүн:

Эмнэл зүйн засаглалын уур амьсгалын судалгааг (CGCQ) ашиглан эмпирик судалгааг улсын төрөлжсөн нарийн мэргэшлийн гуравдугаар шатлалын I, II, III-р эмнэлэгт хийв. Эмнэлгийн ажилтнуудын бөглөсөн нийт цахимаар 300, цаасан хэлбэрээ 550 судалгаа нийт 880 асуулгыг цуглууллаа. Үзүүлэлтүүд тус бүрийг нь оролцогчдын өөрийнх нь үгээр илэрхийлсэн эерэг ба сөрөг мэдэгдлүүдээс бүрдсэн бөгөөд оролцогчид мэдэгдэл тус бүртэй санал нийлж буй эсвэл санал нийлэхгүй байгаа эсэхээ Эмнэлгийн уур амьсгал нь КЗ -ийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь тогтоогдсон бөгөөд анхаарал хандуулах шаардлагатай байна. Эмнэлгийн хууль эрх зүйн байдал нь өвчтөний эрүүл мэндийн байдал, үйлчилгээний чанарт нөлөөлдөг.

ДҮГНЭЛТ

Эмнэлгийн засаглал, бие даасан байдлыг шийдвэрлэнэ гэдэг бол эмнэлгийг хувьчлах асуудал биш, зах зээлийн хямралын үед төрөөс төсвийг захиран зарцуулах эрх мэдэл, хариуцлагыг хамтад нь эрүүл мэндийн байгууллага, удирдах зөвлөлд өгч, санхүүжилтийг бие даасан байдал руу шилжүүлэн хуульчилж, тусламж үйлчилгээг сайжруулан цаашид эрүүл мэндийн байгууллагын бие даан хөгжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх төрийн бодлого юм. Эмнэлгийн үйлчилгээ нь зохих түвшинд үзүүлэх тусламж үйлчилгээ нь улсын эмнэлгүүдийн дунд хэт ачаалалтай хүний нөөц болоод, санхүү, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн ор, техник, технологийн хүрэлцээ нь хангалтгүй байгаа бөгөөд Монгол Улсын эрүүл мэндийн тогтолцоонд тулгамдсан асуудал байсаар байна. Судалгааны сэдвийн хүрээнд эх олонлогоос Клиник эмнэлгийн засаглалыг үнэлэх арга зүй дээр үндэслэн онолын судалгаа, эмч ажиллагсдаас клиник засаглалын загварын судалгаа, клиник засаглалын уур амьсгалын судалгааг их олонлогоос түүврийн төлөөлөх чадварыг 10% -аас багагүй хэмээн тооцож, түүвэр судалгааг улсын төрөлжсөн нарийн мэргэшлийн гуравдугаар шатлалын I, II, III эмнэлгээс түүвэр болгон судалгаа хийлээ. Цаашид илүү нарийвчилсан судалгаа хийж бусад улс орны нарийн мэргэшсэн эмнэлгийн эмнэл зүйн засаглал, болон эмнэл зүйн гүйцэтгэлтэй харьцуулсан судалгаа хийж, үр дүнд шинжилгээ хийх нь зүйтэй байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Англи хэл дээр:

Saltman RB, Elke Jakubowski eds. (2013). *Governing public hospitals: Reform strategies and the movement towards institutional autonomy*. Copenhagen, WHO Regional Office for Europe on behalf of the European Observatory on Health Systems and Policies (Observatory Studies Series 29).

- Guy Hougston & David Wall “ *GP Unit, West Midlands Region; University of Birmingham and West Midlands Region*
- Bolormaa T, Natsagdorj Ts et al. (2007). *Health systems in transition: Mongolia*. Copenhagen, WHO Regional Office for Europe on behalf of the European Observatory on Health Systems and Policies.
- Introduction to clinical governance n.d, p. 2
- Blandford and Smyth (n.d cited in Harris 2002, p.394)
- Berger A. Why doesn't audit work? *Br Med J* 1998; 318: 875–876.
- Al Assaf.A.E ‘Health care quality:past and present.’ *Health care quality an international perspective* 2001.p 7-14
- Pool, Robert & Wenzel Geissler. (2005). *Medical anthropology* (Series: Understanding Public Health). Maidenhead: McGraw-Hill Education.
- IFC (2008) “Corporate governance” Manual Belgrade.
- IFC (2013) “Corporate governance scorecard”.
- Edward Freeman, *Strategic management: A Stakeholder Approach*. (1984).
- Phillips, R.Robert; Edward Freeman. *Stakeholder Theory and Organizationl Ethics*, (2003)
- John W.Meyer; *Organization Theory paper* (2003)
- Adam Smith. *The Wealth of Nations*, 99-117 (1766)
- Some Questions about the Governance of auditing firms, Prem Sikka University of Essex, UK
- Evaluating and Improving Governance in Organizations, 2009, International Good Practice Guidance, International Federations of Accountants
- Thidar Pyone, Helen Smith and Nynke van den Broek “Frameworks to assess health systems governance,a systematic review ” *Health Policy and Planning*, 2017, Vol. 32, No. 5 Published by Oxford University Press in association with The London School of Hygiene and Tropical Medicine.
- Berman, S. L., et al. 1999. Does stakeholder orientation matter? The relationship between stakeholder management models and firm financial performance. *Academy of management Journal, Mississippi State* 42 (5):488-506.
- Donaldson, T., et al. 1995. The stakeholder theory of the corporation: Concepts, evidence. *The Academy of Management Review, Mississippi State* 20 (1):65-91.
- Freeman, R. E. 1984. *Strategic management: A stakeholder approach*. Boston: Pitman.
- Freeman, R. E. 1984. *Strategic management: A stakeholder approach*. Boston: Pitman.
- Hallandvik, J.-E. 1998. *Helsetjeneste og helsepolitikk*. 2nd edition ed. Oslo: Universitetsforlaget.
- Aoki, M. 1984. *The co-operative game theory of the firm*. London: Oxford University Press.
- 25.Christensen, T. 1994. *Politisk styring og faglig uavhengighet*. Oslo: Tano.
- Christensen, T., et al. 2001. New Public Management i norsk statsforvaltning. In *Den fragmenterte staten. Reformer, makt og styring*, edited by B. Tranøy, Sofus and Ø. Østerud. Oslo: Gyldendal Akademisk.
- Cyert, R., M., et al. 1963. *A behavioral theory of the firm*. New Jersey: Prentice-Hall Inc. 1992. *A behavioral theory of the firm*. 2nd ed. New Jersey: Prentice- Hall.
- Golledge, R. G. 1999. Human wayfinding and cognitive maps. In *Wayfinding behavior. Cognitive mapping and other spatial processes*, edited by R. G. Golledge. Baltimore: The John Hopkins University Press.
- Kuhn, T. S. 1962. *The structure of scientific revolutions*. 3rd ed. Chicago: The University of Chicago Press.

- Kumar, N., et al. 1993. Conducting interorganizational research using key informants. *Academy of Management Journal* 36 (6):1633-1651.
- March, J. G., et al. 1984. The new Institutionalism: Organizational factors in political life. *American Political Science Review* 78:734-749.
- . 1989. *Rediscovering institutions. The organizational basis of politics*. New York: The Free Press.
32. Weber, M. 1947. *The theory of social and economic organization*. London: Free Press.

Ном, сэтгүүл, өгүүлэл:

- Saltman RB, Elke Jakubowski eds. (2013). *Governing public hospitals: Reform strategies and the movement towards institutional autonomy*. Copenhagen, WHO Regional Office for Europe on behalf of the European Observatory on Health Systems and Policies (Observatory Studies Series 29).
- Guy Hougston & David Wall “ GP Unit, West Midlands Region; University of Birmingham and West Midlands Region
- Bolormaa T, Natsagdorj Ts et al. (2007). *Health systems in transition: Mongolia*. Copenhagen, WHO Regional Office for Europe on behalf of the European Observatory on Health Systems and Policies.
- Introduction to clinical governance n.d, p. 2
- Blandford and Smyth (n.d cited in Harris 2002, p.394)
- Berger A. Why doesn't audit work? *Br Med J* 1998; 318: 875–876.
- Al Assaf.A.E “Health care quality:past and present.” Health care quality an international perspective 2001.p 7-14
- Pool, Robert & Wenzel Geissler. (2005). *Medical anthropology* (Series: Understanding Public Health). Maidenhead: McGraw-Hill Education.
- IFC (2008) “Corporate governance” Manual Belgrade.
- IFC (2013) “Corporate governance scorecard”.
- Edward Freeman, Strategic management: A Stakeholder Approach. (1984).
- Phillips, R.Robert; Edward Freeman. Stakeholder Theory and Organizationl Ethics, (2003)
- John W.Meyer; Organization Theory paper (2003)
- Adam Smith. The Wealth of Nations, 99-117 (1766)

Монгол хэл дээр:

- Цэнд-Аюуш Т. Компанийн засаглал (2010): Гарын авлага /Ред. Амаржаргал Р., Батжаргал Д., Дүгэржав Д., УБ
- Цэнд-Аюуш Т., Монголын компанийн засаглалыг сайжруулах арга замууд, докторын диссертац, УБ.,2012 х.25.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ХЭРЭГЛЭГЧИЙН ХУДАЛДАН АВАХ ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ ДЭЛГҮҮРИЙН ОРЧНЫ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Б.Мөнхжаргал^{1а}, Б.Оюунтунгалаг^{2б}, Т.Сүмжидмаа^{3с}

¹Докторант, СЭЗИС, Баланскарт ХХК

²Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Бизнесийн Ахисан Түвшиний Сургууль

³Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль, Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль

^аbcmongolia8@gmail.com, ^бoyuntungalag@must.edu.mn, ^сsumjidmaa@must.edu.mn.



Хураангуй

Энэхүү судалгаанд Монгол хэрэглэгчийн худалдан авах хандлагад нөлөөлөгч дэлгүүрийн орчны хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлсон. Дэлгүүрээр үйлчлүүлэгчид нь дэлгүүрийн таатай орчин нөхцөл, түүнээс бий болох таатай мэдрэмж дээр тулгуурлан худалдан авалт хийх шийдвэр гаргах хандлагатай. Судалгааны хүрээнд Улаанбаатар хотод байгаа томоохон сүлжээ дэлгүүрүүд болох Номин, Имарт, Оргил, Сансар, Миний Сүлжээ, Эфэс дэлгүүрүүдээр үйлчлүүлж буй 352 үйлчлүүлэгчийг хамруулсан. Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн таамаглалуудыг шалгаж үзэхэд үйлчлүүлэгчийн худалдан авах хандлагад дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө, үнэр болон зохион байгуулалт нь эерэг шууд нөлөөтэй байна. Үйлчлүүлэгчдийн 2/3 нь гэрэлтүүлгийн нөлөөнд автдаг гэж судлаачдын зүгээс баталсан байдаг. Энэ нь мөн манай судалгааны үр дүнгээр батлагдаж байна.

Түлхүүр үг:

ажиллагсад, өнгө, гэрэлтүүлэг, үнэр, зохион байгуулалт, хөгжим

Удиртгал

Өнөөгийн нийгэмд хэрэглэгчид илүү их цаг хугацааны дарамтыг туулж, ачаалал ихтэй, стресстэй өдрүүдээс зугтах шаардлагатай болсон (Chronicle 2011), (Ogden-Barnes 2011). Тиймээс жижиглэнгийн худалдаачид амьдралын хэв маягийг ухамсарлаж, “завгүй, яарч байна” гэж сануулахгүй, хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж, тааламжтай туршлагаар хангахын тулд дэлгүүрийн орчинг аль болох таатай болгох нь чухал байх талтай гэж дүгнэсэн байна (Gobé 2009). Хүмүүс аливаа зүйлийг тодорхой шалтгаан, зорилгоор хийдэг бөгөөд жишээ нь бие махбодоо хүйтэн цаг агаараас хамгаалах, амар тайван дэлгүүр хэсэх гэх мэт ямар нэг зүйлийн тодорхой хэрэгцээнд сэдэлтэй байдаг. Хүн бүр, цаг хугацаа, газар нутгаас хамаарч өөр өөр байдаг ч худалдан авагчийн хувьд худалдан авах хүсэл эрмэлзэл, догдоллыг тохирох, зохисгүй байх, эсвэл худалдан авахдаа зөв, буруу байх тухай бодлоор нь хязгаарлаж, тохируулж болно (Rook 1995). Байгууллагууд хэрэглэгчдийнхээ амьдралын хэв маяг, зан үйлийн талаар илүү гүнзгий ойлголттой болохын тулд тэдний цагийг хэрхэн

өнгөрөөж, хүрээлэн буй орчны янз бүрийн элементүүдийн талаар юу гэж бодож байгааг нь харах нь чухал юм (Evans 2010). Үйлчлүүлэгч дэлгүүрийн талаарх төсөөлөл нь таатай байвал дэлгүүрт илүү их цаг зарцуулах хүсэлтэй (В. Е. Berman 2018). Худалдан авагчдын мэдрэмжийг төрүүлдэг хөгжим, үнэр, гэрэлтүүлэг, өнгө, шал зэрэг янз бүрийн элементүүдэд анхаарлаа төвлөрүүлснээр дэлгүүрийн эерэг, тааламжтай орчин бий болно (Berman, В. & Evans, J.R. 1995). Тэр дундаа харах, сонсох болон үнэрлэх элементүүд илүү их нөлөөлөх боломжтой юм (Connections 2011). Үүнийг худалдан авагч дэлгүүрт орсноос хойш 5 минутын дараа тухайн дэлгүүрт өнгөрүүлэх цаг, авах таашаал ханамжийн хэмжээг урьдчилан таамаглаж байсныг тогтоож тодорхойлсон (Solomon R. 2006).

Дэлгүүрийн орчин нь сэтгэл хөдлөл, итгэл үнэмшил, физиологийн мэдрэмжид нөлөөлж, хэрэглэгч болон ажилчдын зан үйлийг тодорхойлдог. Дотоод орчны элементүүдийн өөр өөр хослол нь хувь хүнд өөр өөр байдлаар нөлөөлсөнийг судласан байна (Gobo 2014) Тухайлбал Тёрлэй судалгаандаа хүрээлэн буй орчны өдөөлтөд өсвөр насныхан эерэг хариу үйлдэл үзүүлдэг байхад ахимаг насны худалдан авагчид сөрөг хариу үйлдэл үзүүлж байсныг тодорхойлсон байна (Turley 2000). (Мошис 1987) нас ахих тусам хэрэглэгчид гадны өдөөлтөд (жишээ нь, гэрэл, өнгө) бага мэдрэмтгий болж, эдгээр өдөөлтийг ялгах чадвар багасдаг, 70 наснаас хойш анхилуун үнэрийн мэдрэмжгүй болдгийг бусад судлаачид тогтоосон байна (Correia 2016). Зарим судалгаагаар эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү харааны чиг баримжаатай, дотоод хүсэл эрмэлзэлтэй, романтик бөгөөд худалдан авалт хийх хандлага илүү байдаг байна. Мөн дэлгүүрийн орчны цочромтгой хүчин зүйлсийн судалгаагаар эмэгтэйчүүд зохисгүй тасалгааны хэм, дэлгүүрийн хэмжээ ("хэтэрхий жижиг") эсвэл бөөгнөрөл (d' Astous 2000) зэргээс илүү их цочромтгой байдгийг тогтоожээ. Эмэгтэйчүүд нь өдөөлт ихтэй зүйлд татагддаг олон хэсгүүдэд очиж үзэж, харьцуулж, сонгож авах дуртай байдаг бол эрэгтэйчүүд харин шийдэмгий байж, худалдан авалтаа хурдан бөгөөд үр дүнтэй дуусгадаг (Hart 2007) болохыг судлагаагаар баталгаажуулсан байна. Түүнчилэн Sommer нар эмэгтэйчүүд дэлгүүрт эрэгтэйчүүдээс илүү их цаг зарцуулдаг болохыг тогтоожээ. Дээрхи бүгдээс үзвэл дэлгүүрийн орчин нь хэрэглэгчийн худалдан авах шийдвэр гаргах хандлагад нөлөөтэй гэдгийг олон эрдэмтэн судлаачид судалсан боловч тухайн сегментэд чухам ямар хүчин зүйлс түлхэц өгдөгийг нарийвчлан судлах шаардлагатайг дурьджээ. Манай улсын эрдэмтэн судлаачдын зүгээс хэрэглэгчийн зан үйлийн талаар цөөнгүй судалгаа байгаа хэдий ч дэлгүүрийн орчны хүчин зүйлсийн нөлөөллийг нарийвчлан судлаагүй байна. Мөн худалдааны салбарт бизнес эрхлэгчид дэлгүүрийн орчноо хэрхэн бий болгох тал дээр мэдлэг, туршлага дутмаг зэргээс шалтгаалан бусдыг дагаж орчноо өөрчлөх ажлыг хийдэг практик ажиглагдаж байна. Дэлгүүрийн сэтгэл хөдөлгөм орчинг бий болгосноор худалдан авах шийдвэрт нөлөөлөх магадлалтай юм. Иймээс хэрэглэгчдийн худалдан авах хандлагад дэлгүүрийн орчин нөлөөлж буй эсэхийг тодорхойлох шаардлага үүсч байна.

Сэдвийн судлагдсан байдал

Дэлгүүрийн орчны хүчин зүйлс ба хэрэглэгчийн худалдан авах хандлага

Энэхүү судалгаанд дэлгүүрийн орчин ба хэрэглэгчийн худалдан авах хандлагын хамаарлыг тайлбарлах Вүүдворф, Мехрабиан, Рассел (Mehrabian 1974) нарын санал болгосон S-O-R (*stimulus-organizm-response*) буюу өдөөгч-организм-хариу үйлдэлийн онолыг судалгааны суурь хүрээ болгон ашигласан. Энэхүү онолын гол үндэс нь худалдааны байгууллагын орчны бүрэлдэхүүн хэсгүүд хэрэглэгчдэд хэрхэн нөлөө үзүүлдэг талаар тайлбарласан. S-O-R загварын дагуу дэлгүүрийн орчин нь хэрэглэгчдийн сэтгэл хөдлөл түүгээр дамжуулан шийдвэр гаргах хандлагад нөлөөлдөг өдөөгч (S) юм. Дэлгүүрийн орчны нөлөөлөлд өртсөн

үйлчлүүлэгчийн дотоод төлөв байдал (O) нь тэдний ойртох эсвэл холдох хариу үйлдэл (R)-ийг үүсгэдэг.

Зураг 1. SOR онолын загвар



Хэрэглэгчид тодорхой зураг, объектыг харах, үнэрлэх, амтлах, сонсох агшинд өнгөрсөн дурсамжууд тэр даруйдаа эргэн дурсагдаж, дахин мэдрэгддэг тул баяр баясгалантай эсвэл гунигтай гэх мэт тодорхой сэтгэл хөдлөлийг хэрэглэгчдийн оюун санаанд бий болгодог. Хэрэглэгчдийн сэтгэл хөдлөл нь худалдан авалтын зан байдал эсвэл хариу үйлдэлд нөлөөлдөг байх магадлалтайг судлаачид дурьдсан байна. Өөрөөр хэлбэл SOR загварын хүрээнд дэлгүүрийн орчин нь сэтгэл хөдлөлөөр дамжин худалдан авалтын шийдвэр гаргах хандлагад нөлөөлж байгааг тайлбарлах боломжтой онол юм.

Хэрэглэгч гэж бараа, ажил үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад захиалж, худалдан авч үйлчлүүлж байгаа эсвэл хэрэглэж байгаа хувь хүнийг хэлнэ. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахын тулд дэлгүүр нь тэдний зан төлөвт нөлөөлөх дэлгүүрийн орчны хүчин зүйлсийг зөв зохицуулах шаардлагатай болдог. Дэлгүүр гэдэг нь хэрэглэгчид бүтээгдэхүүн худалдан авдаг газар бөгөөд дэлгүүрийн орчин нь хэрэглэгчийн худалдан авах магадлалыг нэмэгдүүлэхийн тулд тэдний мэдрэхүйгээр (харах, сонсох, үнэрлэх, хүрэлцэх) дамжуулан худалдан авах тодорхой сэтгэл хөдлөлийг үүсгэдэг гэж үзэж болно. Дэлгүүрийн орчин нь үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлд ихээхэн эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөл өндөр байх тусам худалдан авах хандлага өндөр илэрдэг байна. Сэтгэл хөдлөл гэдэг нь тэдний доторх тодорхой мэдрэмжийн идэвхжлийг илэрхийлсэн үйлчлүүлэгчийн үйлдлийг илэрхийлдэг. Худалдан авагчийн сэтгэл хөдлөл нь худалдан авах хандлагад зуучлах үүрэг гүйцэтгэдэг болохыг дээрх судлаачдын судалгаануудаас харж болно.

Судлаачид дэлгүүрийн таатай орчин нь хэрэглэгчдэд дэлгүүрт очих, үйлчлүүлэх таатай мэдрэмж төрүүлэхэд тусалдаг гэж онцолжээ. Орчныг бүрэн шинэчлэх нь төвөгтэй боловч дэлгүүрийн талаарх хэрэглэгчийн ойлголтыг мэдэгдэхүйц өөрчлөх чадвартай. Таван мэдрэхүйгээр дамжин мэдрэгддэг дуу чимээ, өнгө, гэрэлтүүлэг, үнэр, амт зэрэг хүчин зүйлүүд нь дангаараа эсвэл хамтдаа хэрэглэгчийн сэтгэл хөдлөлд тодорхой хэмжээгээр өдөөх, тайвшруулах нөлөө үзүүлдэг. Сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл нь эсрэг тэсрэг хоёр зан үйлийг бий болгодог. Дэлгүүрийн орчинд эерэг сэтгэл хөдлөлтэй үйлчлүүлэгчид худалдан авах шийдвэр гаргах хандлагатай болдог. Үйлчлүүлэгчид дэлгүүрийн талаарх төсөөлөл нь таатай байвал дэлгүүрт илүү их цаг зарцуулах хүсэлтэй байдаг. Өнгө нь хэрэглэгчдийн хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрдөг зүйлсийн нэг бөгөөд хэрэглэгчидтэйгээ харилцахад ашигладаг чухал хэрэгслүүдийн нэг юм. Өнгө нь гэрэлтүүлгээс ихээхэн хамаардаг бөгөөд нэг дор олон мэдээлэл өгөх боломжийг олгодог. Харин зохион байгуулалтгүй тавиурууд, нарийхан, жигд бус хонгилууд нь хэрэглэгчдэд сэтгэл зүйн дарамт үүсгэн зан үйлийн хариу үйлдлийн гажуудалд хүргэдэг байна. Гобе, Котлер нар харааны мэдрэмжид өнгө, гэрэлтүүлэг, сүүдэр, хэлбэр дүрс, эд хогшил, дэлгэц зэрэг элементүүд нөлөөлнө гэдгийг онцолсон байна.

Дэлгүүрийн орчны үзүүлэлтүүд: Дэлгүүрийн орчныг тодорхойлогч үзүүлэлтүүдийг судлаачид олон янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, үнэр, орчны хэм, гэрэлтүүлэг, өнгө, тоглож буй хөгжим зэргийг судлаачид түлхүү онцолсон байна. Мөн дэлгүүрийн зохион байгуулалтын үзүүлэлтүүд болох цэвэр байдал, дэлгүүр, барааны зохион байгуулалт, чимэглэл зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг нэмж судалсан байна. Зарим судлаачид дэлгүүрийн гаднах байдал, ерөнхий дотоод засал, зохион байгуулалт, дизайн, худалдан авах цэг ба гоёл чимэглэлийн үзүүлэлтүүдийг дэлгэрүүлэн оруулсан байдаг. Түрлэй ба Миллиман нар эдгээр элементүүд дээр хүний хувьсагчийг нэмж таван төрөл болгон өргөжүүлсэн. Дэлгүүрийн орчныг дэлгүүрийн гадна тал, дотоод засал, зохион байгуулалт, дотор чимэглэл гэсэн дөрвөн хувьсагчид хувааж үзсэний дотор дотоод хувьсагч нь дэлгүүрийн ерөнхий дотоод байдлыг илэрхийлэх шал, өнгө, гэрэлтүүлэг, хөгжим, үнэр, хонгилын өргөн, хананы бүтэц, бараа бүтээгдэхүүн, орчны хэм ба цэвэр байдал гэдгийг зарим судлаачид онцолж өгсөн.

Гэрэлтүүлэг. Нүдний харааг идэвхжүүлж, юмсыг харагдахуйц болгодог байгалийн орчин (Kotler 2001), харах боломжтой болгодог гэрэлтүүлгийн хэрэгсэл” (Collins, 2012) гэж тодорхойлсон байна. Хүний нүдийг татах нь дэлгүүрийн гэрэлтүүлгийн хамгийн чухал үүрэг гэж олон хүн үздэг (Karlen 2011). Учир нь хүний тархины дөрөвний нэг нь бусад мэдрэхүйгээс илүү харааны боловсруулалтанд оролцдог байна. Мэргэжилтэнүүд гэрэлтүүлэг нь дэлгүүрийн дүр төрхийг сайжруулдаг бол тасалгааны хэм нь худалдан авалт хийх үед хэрэглэгчийн тав тухыг мэдрэхэд нөлөөлдөг гэж үздэг. Хэд хэдэн эрдэмтэд гэрэлтүүлэг нь сэтгэл хөдлөлд (Kuller.R 2006); (McCloughan C.L.B. 1998) болон ойлголтод (Fleischer.S 2001), барааг үзэхэд зарцуулсан цаг хугацаанд нөлөөлдөг (Areni 1994), түүнчилэн хэрэглэгчдийн ойлголтод илүү эерэг сэтгэгдэл төрүүлдэг болохыг (Moys 2002) тогтоожээ. Зарим судлаачид нэмэлт гэрэлтүүлэг эсвэл тод гэрэл нь худалдан авагчдыг бараа бүтээгдэхүүн рүү ойртож шалгаж, харьцах зүйлсийн тоо, дэлгүүр эсвэл үзмэрт зарцуулсан цаг хугацаа зэрэгт нөлөөлдөг (Areni 1994); (Summers 2001). Худалдан авах шийдвэрийн гуравны хоёр нь гэрэлтүүлгийн нөлөөнд автдаг (Kutlu 2013) гэсэн байна.

Таамаглал 1. Гэрэлтүүлэг нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Тасалгааны хэм. Жижиглэн худалдааны дэлгүүрийн зөвшөөрөгдөх дулааны түвшин (B. & Berman 2013); (Beukes 2010). Нийгмийн сэтгэл судлалын судалгаагаар тасалгааны хэм нь хувь хүмүүст нөлөөлдөг болохыг тогтоожээ. Тасалгааны хэмийн зөвшөөрөгдөх түвшнийг үйлчлүүлэгчид анзаардаггүй ч хэт өндөр эсвэл бага түвшин нь зайлсхийх зан үйлийн магадлалыг нэмэгдүүлдэг (J. Baker 1987). Тасалгааны хэм хэт их, хэт бага үед түрэмгий зан авир, үймээн самуун, сөрөг нөлөөлөл, нийгмийн эсрэг зан үйл (Anderson 1989) нэмэгддэг (<62°F: (Bell 1977) байна. Эндээс харвал "тайтгарлын хүрээ" гэж байна (Baker, Cameron 1996). Бүх хүмүүст тохирсон тасалгааны хэмийн түвшинг тодорхойлох боломжгүй боловч (Fanger 1970) дулааны мэдрэмжийг таамаглахад ашигладаг урьдчилан таамагласан дундаж санал (PMV) загварыг боловсруулсан. Дулааны тав тух ба PMV нь дулааны нөхцлөөс гадна хүмүүсийн өмсөж буй хувцас, үйл ажиллагааны түвшингээс хамаарна. Дотор дулааны ая тухыг мэдрэх нь 68°F-ээс 74°F хооронд хэлбэлзэж, дулаан хувцастай бол 66°F, хөнгөн хувцастай бол 78°F хүртэл болж тэлдэг. (Moys 2002) нарын судалгаагаар дэлгүүрийн тасалгааны хэм нь хувцасны дэлгүүрийн худалдан авалтад эерэгээр нөлөөлдөг болохыг баталгаажуулсан байна. Зарим судалгаанд дэлгүүр доторхи хөдөлгөөн дэлгүүрийн 66°F-ээс 78°F хэмтэй эерэг хамааралтай болохыг тогтоожээ.

Таамаглал 2. Тасалгааны хэм нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Өнгө. Өнгө гэж нүдэнд төрөл бүрийн мэдрэмж төрүүлдэг бараа бүтээгдэхүүн эсвэл эд хогшил (өнгө, будаг эсвэл сүүдэр) (Boone 2012); (Stone 2010); (Soars 2009) юм. Өнгө нь худалдан авалт хийх явцад тааламжтай мэдрэмжийг төрүүлэн (J. A. Bellizzi 1983); (J. A. Bellizzi 1992) хэрэглэгчдийн бүтээгдэхүүний талаарх ойлголтод нөлөөлдөг (Middlestadt

1990); (Crowley 1993) байна. Өнгөний сонголтоор дамжуулан үйлчлүүлэгчид үйл явдлыг санахад, тодорхой бодол санаа, туршлагыг өдөөхөд түлхэц болно (Dash 2018). (Lee Feb 2002) өнгө нь аливаа асуудлыг нэг талаас харах бус олон тайлбар хийх боломжийг олгодог гэж тэмдэглэжээ. Мөн бүтээгдэхүүнтэй мэдрэхүйн харилцаатай байдаг тул барааг өнгөний дагуу цэгцлэх нь чухал бөгөөд энэ нь худалдан авагчдад хялбар худалдан авалт хийх боломжийг олгодог. Хүйсийн үүднээс авч үзвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь цэнхэр өнгөнд дуртай боловч (Hallock 2003). эмэгтэйчүүд шар өнгийг илүүд үзэх талтай байна (Lange 2007). Бүх өнгө нь ямар ч төрлийн гэрэлтүүлгээс ихээхэн хамаардаг ([n.d.] 2012), (Pegler 2010) болохыг судласан байна.

Таамаглал 3. Өнгө нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Хөгжим. (Hultén 2009) хэрвээ жижиглэн худалдааны дэлгүүр хөгжим ашиглах замаар дэлгүүрийн зөв уур амьсгалыг бүрдүүлж чадвал хэрэглэгчид илүү их урам зориг өгөх магадлалтай. Зарим судалгаанаас харахад хөгжим нь ресторан дахь хоолны хэрэглээний түвшин (Milliman 1986) дэлгүүрийн талаархи хэрэглэгчийн ойлголт (Hui L 1997), хэрэглэгчдэд дэлгүүр хэсэх хэрэгцээгээ хангах, хэрэглэгчдийн зан төлөв (Herrington 1994) зэрэгт шууд нөлөөлдөг болохыг тогтоожээ. Ялангуяа хөгжим нь сэтгэл хөдлөлийн болон зан үйлийн хариу үйлдлийг бий болгодог (Bruner 1990); (Milliman 1982); (Milliman (1986)); (R. F. Yalch 1990) бөгөөд удаан хэмнэлтэй хөгжимтэй бол дэлгүүрийн замын хөдөлгөөний хурд мэдэгдэхүйц удааширч, борлуулалт мэдэгдэхүйц өндөр байгааг нотолсон байдаг. Мөн рестораны үйлчлүүлэгчид удаан хэмнэлтэй хөгжмөөр удаан хүлээхэд бэлэн (Milliman (1986)) байхад сонгодог, жааз, алдартай хөгжим тоглох үед ресторанд үйлчлүүлэгчид үндсэн хоолондоо илүү их мөнгө зарцуулах хүсэлтэй байдаг (Wilson 2003) байна. Түүнчлэн (R. & Yalch 1988) нар залуу худалдан авагчид арын хөгжмийн нөхцөлөөр дэлгүүр хэсэхдээ илүү их цаг зарцуулдаг, харин ахимаг насны худалдан авагчид дэлгүүрийн радио системээр дамжуулан урд талын хөгжим тоглох үед дэлгүүрт илүү их цаг зарцуулдаг болохыг тогтоожээ. (Smith 1966) нар хөгжим чанга байхад худалдан авагчид дэлгүүрт илүү бага цаг зарцуулдаг бол (R. a. Yalch 1990) нар хөгжимтэй нөхцөлд эрэгтэй худалдан авагчид төлөвлөснөөс илүү их цаг зарцуулдаг болохыг судласан байна. Үүнээс гадна дэлгүүр дотор сонгодог рок хөгжим тоглож байх үед baby boomers-ын үеийнхэн илүү өндөр үнээр худалдаж авдаг байсан бөгөөд энэ төрлийн хөгжим нь ахимаг насны хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлсөн байна.

Таамаглал 4. Хөгжим нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Үнэр. Үнэр гэдэг нь тааламжтай үнэр, муу үнэр гэх мэт тодорхой үнэрийг хэлдэг (Dictionary 2012). (Gobé 2009) Үнэр нь хэрэглэгчийн сэтгэл хөдлөлийг хамгийн сайн өдөөх чадвартай учраас таван мэдрэхүйн дотроос хамгийн хүчтэй нь бөгөөд өнгөрсөн дурсамжаа санахад тусалдаг (Rodrigues.S 2011). Мөн үнэр нь худалдан авагчдын зан төлөв (D. J. Mitchell 1995) хандлагад (Holland 2005) нөлөөлдөг, тааламжтай үнэр нь эерэг нөлөөлөл эсвэл зан үйлийн хариу үйлдэл үзүүлэхэд хүргэдэг ба хэрэглэгч дэлгүүрт илүү их цаг зарцуулдаг (E. C. Spangenberg 1996), (Parsons 2009). Харин тааламжгүй үнэр нь зан үйлийн сөрөг хариу урвалыг үүсгэдэг байна (D. J. Mitchell 1995), Dunkin' Donuts нь үйлчлүүлэгчдийг татахад шинэхэн кофены үнэр чухал болохыг хүлээн зөвшөөрсөн. Starbucks кофены сүлжээ, Mrs. Field Cookies гэх мэт бусад компаниуд ч үүнийг дагаж мөрддөг (Hunter BT 1995). (Schifferstein 2002) нараас ялгаатай нь шоколадны үнэр нь дэлгүүрийн борлуулалтад эерэгээр нөлөөлдөг бөгөөд худалдан авагчид дэлгүүрт удаан хугацаагаар байж, авсан бүтээгдэхүүнээ удаан шалгадаг (Vinitzky 2011) байна. Сүүлийн үед хүйс ба үнэр хоорондын хамаарлын судалгаанууд ихээр хийгдэж байна (Fleischer.S 2001), (E. S. Spangenberg 2006).

Таамаглал 5. Үнэр нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Дэлгүүрийн зохион байгуулалт гэдэг нь бараа бүтээгдэхүүн, лангуу тавиур, бүтээгдэхүүний

дэлгэцийг хуваарилах гэсэн ойлголт юм. Үүнээс гадна дэлгүүрийн давхрын төлөвлөгөө, орц, гарц, кассын цэгүүд, хонгил, гарцын өргөн, уртыг хэлнэ. Дэлгүүрийн зохион байгуулалт нь борлуулалтад шууд бус нөлөө үзүүлдэг. (Huddleston 2004) нарын үзэж байгаагаар барааны нэр төрөл, дэлгүүрийн байрлал, үнэ зэрэг нь эерэг сэтгэл хөдлөл бий болгох талтай. (Yoo 1998) ачаалал багатай сайн зохион байгуулсан дэлгүүр нь үйлчлүүлэгчдэд эерэг сэтгэл хөдлөлийг төрүүлдэг бөгөөд энэ нь дэлгүүрт хандах хандлагад эерэгээр нөлөөлж, үнэнч байдлыг бий болгодог талтай. (Sorensen 2003) дэлгүүрийн зохион байгуулалтын худалдааны зан үйлийн ач холбогдлын талаар сонирхолтой ажиглалт хийж, дундаж худалдааны аялал нь дэлгүүрийн ердөө 25 орчим хувийг эзэлдэг бөгөөд худалдааны туршлагын 85 хувь нь байршлаас шалтгаалдаг гэж тэмдэглэжээ. (D. N. Bellenger 1978) 18-19 насны залуучууд шууд худалдан авалт хийх хандлагатай байдаг, 18-39 наснаас худалдан авалт сайжирч, харин нас ахих тусам худалдан авагчид хэрэгцээтэй зүйлээ олж чадахгүй, муухай үнэр, цэвэр цэмцгэр байдал, худалдагчид хууртагдах, өндөр ачаалалтай борлуулалт зэрэгт бухимдах нь нэмэгдэж (d' Astous 2000) худалдан авалт аажмаар буурч байгааг судласан байна.

Таамаглал 6. Зохион байгуулалт нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Дэлгэц. Бүтээгдэхүүнийг харуулах олон янзын арга байдаг. Ихэнх загварын ордонууд бүтээгдэхүүнийг танилцуулахдаа нээлттэй дэлгэцийг ашигладаг. Хэрэглэгчид тухайн барааг худалдан авахаар төлөвлөж байгаа эсэхээс үл хамааран дэлгэцэнд харуулсан бараа бүтээгдэхүүний талаар нэмэлт мэдээлэл авах, дэлгэц дээр зарласан хямдралын талаар илүү ихийг мэдэх эсвэл давуу талыг ашиглахын тулд тухайн барааны тасагт зочилдог бөгөөд бүтээгдэхүүний дэлгэцийг бүх зүйл харагдахуйц, тодорхой тэмдэглэгээтэй чимэглэсэнээр худалдан авагчдыг төөрөгдлөөс сэргийлдэг. Худалдан авагчид мэдээллээр хангагдсанаар бүтээгдэхүүний чанарыг таних, шинэ бараа болон барааны мэдээлэл, ямар бараа хаана байрлаж байгаа зэрэг дэлгүүр болон бараа бүтээгдэхүүнтэй холбоотой бүх мэдээллийг цаг тухайд нь авсанаар худалдан авалтын шийдвэрээ зөв гаргахад нь тусладаг (De Nisco 2013). Цонхны дэлгэцийг эрэгтэй хэрэглэгчид эмэгтэй хэрэглэгчдээс илүү эерэг ханддаг гэж үздэг. (Babin 1995) нар өмнө тодорхой зорилго тавьсан худалдан авагчид сэтгэл хөдлөлөөр удирдагддаг хүмүүстэй харьцуулахад дэлгэцийн нөлөөгөөр худалдан авалт хийх магадлал бага байсан гэж үзсэн байна. Зарим эрдэмтэд дэлгүүрийн дэлгэцийн үр дүнтэй байдлыг нотолсон байна. Жишээлбэл, (Inman 2004) нарын судалгаагаар бүтээгдэхүүнийг 2 байршилд байршуулснаар борлуулалт 77% -иас 243% хүртэл өссөн болохыг тайлбарласан. (Inman 2004) нарын нэмэлт дүгнэлтүүд нь дэлгэцийн байршлыг харуулсан бөгөөд гэнэтийн худалдан авалтад чухал нөлөө үзүүлдэг болохыг харуулж байна. Учир нь дэлгэц нь коридорын төгсгөлд (61.2%), эсвэл кассын лангуун дээр (63.5%) байх үед коридорт байх үеийнхээс (58.0%) илүү төлөвлөгдөөгүй худалдан авалт хийсэн байна.

Таамаглал 7. Дэлгэц нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Цэвэр байдал. Цэвэрлэгээ гэдэг нь тухайн дэлгүүрийн өнгө үзэмж, хэр нямбай, зохион байгуулалттай байхаас хамаарна. Цэвэрхэн худалдааны цэг нь үйлчлүүлэгчдэд эерэг мэдрэмж, сэтгэл санааг өдөөж болох бөгөөд энэ нь тэдний туршлагаас шалтгаалж үйлчлүүлэгчдэд түгээх худалдааны цэгийн талаарх эерэг эсвэл сөрөг аман ярианд нөлөөлнө (Choi 2019). Цэвэрхэн, сайн зохион байгуулалттай дэлгүүр нь илүү сонирхол татахуйц байдаг бөгөөд үйлчлүүлэгчид худалдан авалтаа нэмэгдүүлж, илүү их цаг зарцуулж, цэвэрхэн дэлгүүрт дахин зочлох магадлал өндөр байдаг (Manuahe 2017), (Choi 2019). (Huddleston 2004) ерөнхий цэвэр ариун байдал, бага түгжрэл, тогтмол зохион байгуулалт нь эерэг сэтгэл хөдлөлийг төрүүлдэг. Дэлгүүр нь бага, дунд, өндөр орлоготой хүмүүст үйлчилдэг эсэхээс үл хамааран дэлгүүрийн цэвэр байдлыг алдагдуулах ёсгүй.

Таамаглал 8. Цэвэр байдал нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Ажиллагчид. Дэлгүүрийн орчны нөлөөлөл нь ажиллагсдын ойлголтоор дамждаг бөгөөд (J. P. Baker 2002) , ажилчдын тоо (J. L. Baker 1992) болон борлуулалтын ажилтнуудын үзүүлж буй үйлчилгээ нь үйлчлүүлэгчдийн дэлгүүрийн сонголт, ялангуяа гэрт хүргэх үйлчилгээтэй холбоотой бизнесийг сонгоход ихээхэн нөлөөлдөг (Teller 2006). (Gable 2008) дэлгүүрийн сайн бэлтгэгдсэн, мэдлэгтэй, найрсаг, чадварлаг боловсон хүчин нь үйлчлүүлэгчдэд хамгийн их хамааралтай шинж чанарууд гэдгийг тэмдэглэжээ. Маркес (2016), үйлчлүүлэгчид дэлгүүрээр үйлчлүүлэхдээ борлуулалтын ажилтануудын найрсаг байдал, эелдэг байдал, хувийн анхаарал, шуурхай үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг олох боломжийг чухалчилдаг болохыг харуулсан.

Таамаглал 9. Ажиллагсад нь худалдан авах хандлагад нөлөөлнө.

Судалгааны арга зүй, үр дүн

Монгол хэрэглэгчийн худалдан авах хандлагад нөлөөлөгч дэлгүүрийн орчны хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох, мөн дэвшүүлсэн таамаглалуудыг шалгахын тулд бид Улаанбаатар хотод байгаа томоохон сүлжээ дэлгүүрүүд болох Номин, Имарт, Оргил, Сансар, Миний Сүлжээ, Эфэс дэлгүүрүүдээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчийг судалсан. Энэхүү судалгаанд тоон буюу асуулгын аргыг ашигласан бөгөөд асуултуудыг эрдэмтэн судлаачдын бүтээлүүдээс хөрвүүлэн авч монгол хэрэглэгчдэд тохируулан найруулсан.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл: Судалгаанд 352 үйлчлүүлэгч оролцсон бөгөөд судалгаанд оролцогчдын 64.2 хувь нь эмэгтэй, 81.8 хувь нь 6 хүртэл тооны ам бүлтэй, 87.5 хувь нь 49 хүртэл насны, 61.4 хувь нь төрийн болон хувийн байгууллагад ажилладаг, 48.3 хувь нь 1 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой байна. Боловсролын түвшний хувьд 93.2 хувь нь бүрэн дундаас дээш боловсролтой байна. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 85.8 хувь нь дэлгүүрт 2 хүртэл цагийг зарцуулж, 80.1 хувь нь 1 сард 9 хүртэл удаагийн давтамжтайгаар худалдан авалт хийдэг бөгөөд 79.5 хувь нь 201 мянган төгрөг хүртэлх худалдан авалтыг хийдэг байна.

Судалгааны үндсэн үзүүлэлтүүдийг Ликертийн хэмжүүр (5 хэмжээст) бүхий багц асуултуудаар судалсан. Асуулгын найдвартай байдлыг илтгэх Кронбах альфа нь зохист түвшинд (*ажиллагчид – 0.971; зохион байгуулалт – 0.958; дэлгэц – 0.948; үнэр – 0.929; өнгө – 0.907; худалдан авах үйлдэл – 0.819; гэрэлтүүлэг -0.938*) гарсан нь хувьсагчид хоорондын дотоод нийцэлтэй байдал хүлээн зөвшөөрөгдөж байгаа бөгөөд уг асуулга судалгааны үр дүнг ашиглан цаашид загварын үнэлгээ, шинжилгээ хийх боломжтой гэж үзсэн.

Фактор сорих шинжилгээний үр дүн: Хэрэглэгчийн худалдан авах зан үйлд дэлгүүрийн орчны үзүүлэх нөлөөллийг тооцохдоо хүчин зүйлийг сорих шинжилгээг хийсэн. Тус шинжилгээнд Эйген утга 1-ээс их, хувьсагчийн абсолют утга 0.6-с их байхаар авч тооцсон. Энд, түүврийн хэмжээ хангалттай эсэхийг харуулах КМО үзүүлэлт 0.928 гарсан нь түүвэр хангалттайг илэрхийлж байна.

Хүснэгт 1. Фактор сорих шинжилгээний үр дүн

	Rotated Component Matrix ^a						
	Component						
	1	2	3	4	5	6	7
Ажилтнууд асуултанд ойлгомжтой хариулт өгдөг.	.782						
Ажилтнууд маш сайн бэлтгэгдсэн	.767						
Ажилтнуудтай харилцахад хялбар.	.756						
Дэлгүүр хангалттай тооны борлуулагчтай	.756						
Ажилтнууд үйлчлүүлэгчдэд туслах хангалттай туршлагатай.	.753						
Ажилтнууд туршлагатай, найлбартай.	.753						
Дэлгүүрийн борлуулалтын ажилтнууд үйлчлүүлэгчдэд анхаарал хандуулдаг.	.750						
Худалдагч нар ямар ч үед туслахад бэлэн байдаг.	.747						
Ажилтнууд зөлдөг, хүндэтгэлтэй ханддаг.	.745						
Дэлгүүрийн ажилтнууд миний худалдан авалтад нөлөөлдөг	.734						
Дэлгүүрийн ажилчид хангалттай хамтран ажилладаг	.731						
Би энэ дэлгүүрийн ажилтнуудаас шурусай үйлчилгээ авдаг.	.727						
Ажилтнууд дэлгүүрийн бүтээгдэхүүний талаар маш сайн мэддэг.	.723						
Ажилтнууд үйлчлүүлэгчдэд санаа тавьдаг.	.710						
Дэлгүүрийн ажилчид сайхан хувцасласан, эмх цэгцтэй байсан	.695						
Ажилчдын үйлчилгээ найрсаг, чин сэтгэлээсээ.	.693						
Ажилтнууд миний хэрэгцээг ойлгохыг хичээдэг.	.672						
Бараа руу очиход хялбар, суд чөлөөтэй		.755					
Дэлгүүр дотор хөдөлгөөн хийхэд хялбар		.738					
Бүтээгдэхүүний зохион байгуулалт нь сонголт хийхэд тусалдаг		.711					
Дэлгүүрийн барааны харагдах байдал нь маш сайн		.704					
Бараа руу очиход тодорхой, ойлгомжтой		.687					
Дэлгүүрийн таниурууд нэвэрхэн		.656					
Дэлгүүрийн барааны нэр төрөл олон		.654					
Дэлгүүрийн барааны ангилал сайн		.651					
Дэлгүүрийн орчин нэвэр		.645					
Дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнүүд найлбартай		.645					
Дэлгүүрийн орчин зүүл ажуйн шаардлага хангасан		.637					
Дэлгүүрийн уур амьсгал тухтай		.631					
Бүтээгдэхүүний зохион байгуулалт нь системчилсэн, сонголт хийхэд тусалдаг		.630					
Дэлгүүрийн зохион байгуулалтын ойлгоход хялбар		.626					
Дэлгүүрийг зөв зохион байгуулсан.		.611					
Дэлгүүрийн дэлгэц дээрх мэдээлэл хангалттай			.764				
Бүтээгдэхүүний дэлгэцүүд ойлгомжтой			.762				
Дэлгүүрийн хэсгүүдийг зохих самбараар илэрхийлсэн			.748				
Дэлгэц нь үзүүж буй бүтээгдэхүүнийг тодорхой харах боломжийг олгодог			.721				
Дэлгүүрт байгаа дэлгэцийн самбараар дамжуулан аливаа мэдээллийг хайсад тохиромжтой			.719				
Дэлгэц нь бүтээгдэхүүнийг илүү тунгаахад тусалдаг			.717				
Сэтгэл тагам сонирхолтой дэлгэц нь илүү их зүйл худалдаж авахад хүргэдэг			.706				
Дэлгүүрийн температур улирлын нөхцөл байдалд тохирсон байдаг			.653				
Дэлгүүрийн температур нь тав тухтай байдалыг үүсгэдэг			.610				
Дэлгүүрийн аюулгүй үнэр дэлгүүрт илүү их цаг зарцуулахад хүргэдэг.				.731			
Дэлгүүрийн үнэр тааламжтай байсан				.683			
Дэлгүүрийн аюулгүй үнэр нь дэлгүүрээр дахин зочлоход хүргэдэг.				.655			
Дэлгүүрийн үнэр намайг илүү их зүйл худалдаж авахад идэвхижүүлдэг.				.654			
Дэлгүүрт байгаа үнэр тохиромжтой байсан				.638			
Дэлгүүрийн үнэр зөөлөн таатай байсан				.623			
Дэлгүүр загварлаг өнгөтэй					.755		
Дэлгүүрийн хана өнгөлөг.					.751		
Дэлгүүрийн өнгө аятайсан.					.684		
Дэлгүүрийн өнгө миний сэтгэлд хоногшсон.					.682		
Дэлгүүр өөрийн онцлогт тохирсон өнгөний хослолтой.					.681		
Дэлгүүрийн орчин нь дэлгүүрт илүү их цаг зарцуулахад хүргэдэг.						.780	
Дэлгүүрийн орчин нь илүү их худалдан авалт хийхэд нөлөөлдөг.						.723	
Дэлгүүрийн гэрэлтүүлэг хангалттай байсан							.930
Дэлгүүр гэрэлтүүлэгтэй байсан							.921

Extraction Method: Principal Component Analysis.
 Rotation Method: Varimax with Kaiser Normalization.
 a. Rotation converged in 7 iterations.

Дэлгүүрээр үйлчлүүлэгчийн худалдан авах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг дэлгүүрийн ажиллагсад, гэрэлтүүлэг, өнгө, үнэр, зохион байгуулалт, барааны өрөлт, хөгжим, дэлгэц зэрэг хүчин зүйлсээс хамааруулан авч үзсэн. Хүчин зүйлийн шинжилгээгээр худалдан авах хандлага, дэлгүүрийн ажиллагсад, гэрэлтүүлэг, өнгө, үнэр, зохион байгуулалт дэлгэц гэсэн нийт 7 бүлэг 56 асуулт бүлэглэгдэн тодорхойлогдсон. Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн таамаглалуудыг шалгаж үзэхэд үйлчлүүлэгчийн худалдан авах хандлагад дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө, үнэр болон зохион байгуулалт нь эерэг шууд нөлөөтэй байна.

$$RA = 0.784 + 0.163\text{Гэрэл} + 0.253\text{Өнгө} + 0.191\text{Үнэр} + 0.2443\text{Б}$$

$$(2.765) (2.523) (3.181) (2.386) (2.554)$$

Энд: RA-худалдан авах хандлага, ЗБ-Зохион байгуулалт

Үйлчлүүлэгчийн нас, хүйс, орлого, дэлгүүрт зарцуулах хугацаа зэргээр худалдан авах хандлагад ялгаа байгаа эсэхийг Levene’s тестээр шалгасан. Тестийн үр дүнгээр худалдан авах хандлага нь дээрх хүчин зүйлсээс хамаарч ялгаатай байна. Дэлгэрэнгүйг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Худалдан авах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн ялгааны шинжилгээний үр дүн

Хүчин зүйлс	Дэлгүүрээр үйлчлүүлэгчийн үзүүлэлт			
	Нас	Хүйс	Өрхийн орлого	Дэлгүүрт зарцуулах хугацаа
Дэлгүүрийн гэрэлтүүлэг	+	+	+	+
Дэлгүүрийн өнгө	+	+	-	+
Дэлгүүрийн үнэр	+	+	+	+
Мэдээллийн дэлгэц	-	-	+	-
Дэлгүүрийн зохион байгуулалт	+	+	+	+
Дэлгүүрийн ажиллагчид	-	+	+	-

+ ялгаатай - ялгаагүй

1. Насны бүлгээр худалдан авах хандлага ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийсэн. Дэлгүүрээр үйлчлүүлж буй 49 ба түүнээс доош насны хүмүүсийн хувьд дэлгүүрийн өнгө үнэр зохион байгуулалт нь нөлөөлж байгаа ба эдгээр хүчин зүйлс нь худалдан хандлагын 24.7%-ийг ($R^2 = 0.247$) тайлбарлаж байна.

$$PA(49 \text{ ба түүнээс доош насны}) = 1.077 + 0.209\text{Өнгө} + 0.214\text{Үнэр} + 0.2143\text{Б}$$

$$(3.219) (2.423) (2.429) (2.075)$$

Харин 50 ба түүнээс дээш насныханд зохион байгуулалт болон гэрэлтүүлэг чухал нөлөөтэй болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, 50 ба түүнээс дээш насны үйлчлүүлэгчдийн худалдан авах хандлагын 79.4%-ийг ($R^2 = 0.794$) эдгээр хүчин зүйлс тайлбарлаж байна.

$$PA(50 \text{ ба түүнээс дээш насны}) = 0.341\text{Гэрэл} + 0.7703\text{Б}$$

$$(3.221) (2.523)$$

2. Худалдан авах хандлага дахь хүйсийн ялгаатай байдлыг авч үзэхэд дэлгүүрийн ажиллагчдын нөлөө илүү их мэдрэгдэж байна. Эрэгтэй эмэгтэй үйлчлүүлэгчдийн худалдан авах хандлага дан ганц ажиллагсдаас шалтгаалдаггүй болох нь дараах тэгшитгэлээс харагдаж байна.

Эмэгтэй үйлчлүүлэгчдийн хувьд ажиллагсдаас гадна дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө, үнэр чухал нөлөөтэй байгаа ба эдгээр хүчин зүйлс эмэгтэйчүүдийн худалдан авах хандлагыг 46.5%-тайгаар ($R^2 = 0.465$) тайлбарлаж байна.

$$PA(\text{эмэгтэй}) = 2.291\text{Гэрэл} + 0.255\text{Өнгө} + 0.291\text{Үнэр} + 0.179\text{Аж}$$

$$(4.446) (2.878) (3.350) (2.000)$$

Харин эрэгтэй үйлчлүүлэгчдийн хувьд дэлгүүрийн ажиллагсад ба зохион байгуулалт нь худалдан авах хандлагыг 21.3%-иар ($R^2 = 0.213$) тайлбарлаж байна.

$$PA(\text{эрэгтэй}) = 1.871 + 0.6753\text{Б} + 0.405\text{Аж}$$

$$(2.983) (2.678) (3.479)$$

3. Сарын орлого нь 1 сая төгрөг хүртэлх өрхийн хувьд дэлгүүрийн ажиллагсад, гэрэлтүүлэг, үнэр, дэлгэц болон зохион байгуулалт гэсэн үзүүлэлтүүд нь худалдан авах хандлагын 56.6% -ийг ($R^2 = 0.566$) тайлбарлаж байна.

$$PA(1 \text{ сая төгрөгөөс доош}) = 0.961 + 0.321\text{Гэрэл} + 0.264\text{Аж}$$

$$(3.158) (2.992) (4.683)$$

Харин сарын 1 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн худалдан хандлагын 36% -ийг ($R^2 = 0.360$) өнгө, үнэр болон дэлгэц гэсэн үзүүлэлтүүд тайлбарлаж байна.

$$PA(1 \text{ сая төгрөгөөс дээш}) = 0.669\text{Өнгө} + 0.476\text{Үнэр} + 0.651\text{Дэлгэц} \\ (5.189) (3.685) (5.358)$$

4. Үйлчлүүлэгчдийн дэлгүүрт зарцуулах цаг хугацааны хувьд ялгаатай байдал үүссэн. 2 цагаас доош хугацааг дэлгүүрт зарцуулдаг үйлчлүүлэгчдийн хувьд дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө, үнэр нь худалдан авах хандлагыг 32.5%-иар ($R^2 = 0.325$) тайлбарлаж байна.

$$PA(2 \text{ цаг хүртэл}) = 0.708 + 0.281\text{Өнгө} + 0.271\text{Үнэр} + 0.191\text{Гэрэл} \\ (2.342) (3.395) (3.237) (2.771)$$

Харин 2 ба түүнээс дээш хугацааг дэлгүүрт зарцуулдаг үйлчлүүлэгчдийн хувьд зохион байгуулалт чухал нөлөөтэй болох нь харагдаж байна ($R^2 = 0.525$).

$$PA(2 \text{ ба түүнээс дээш}) = 1.468 + 1.3613B \\ (2.191) (4.867)$$

Дүгнэлт

Дэлгүүрийн орчин таатай байвал худалдан авалтад хандах хандлага эерэг болдог тухай судалгаануудад дурьдсан байна. Дэлгүүрээр үйлчлүүлэгчид нь дэлгүүрийн таатай орчин нөхцөл, түүнээс бий болох таатай мэдрэмж дээр тулгуурлан худалдан авалт хийх шийдвэр гаргах хандлагатай. Эрдэмтэн судлаачид зохион байгуулалт, гэрэлтүүлэг, өнгө, хөгжим, үнэр, тасалгааны хэм, дэлгэц, ажиллагсад, барааны өрөлт болон цэвэр цэмцгэр байдал зэрэг нь дэлгүүрийн орчныг илэрхийлэх хүчин зүйлс болно гэж тодорхойлсон байдаг. Энэхүү судалгааны зорилго нь дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн худалдан авах хандлагад дэлгүүрийн ажиллагсад, гэрэлтүүлэг, өнгө, үнэр, зохион байгуулалт, барааны өрөлт, хөгжим, дэлгэц зэрэг дэлгүүрийн орчинг илэрхийлэх хүчин зүйлсийг хэрхэн нөлөө үзүүлэхийг судлах юм. Судалгааны хүрээнд Улаанбаатар хотод байгаа томоохон сүлжээ дэлгүүрүүд болох Номин, Имарт, Оргил, Сансар, Миний Сүлжээ, Эфэс дэлгүүрүүдээр үйлчлүүлж буй 352 үйлчлүүлэгчийг хамруулсан.

Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн таамаглалуудыг шалгаж үзэхэд үйлчлүүлэгчийн худалдан авах хандлагад дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө, үнэр болон зохион байгуулалт нь эерэг шууд нөлөөтэй байна. Үйлчлүүлэгчдийн 2/3 нь гэрэлтүүлгийн нөлөөнд автдаг гэж судлаачдын зүгээс баталсан байдаг. Энэ нь мөн манай судалгааны үр дүнгээр батлагдаж байна.

Харин нас, хүйс, өрхийн орлого, дэлгүүрт зарцуулах цаг хугацаа зэргээс хамааран үйлчлүүлэгчид дэлгүүрийн орчны өөр өөр хүчин зүйлсэд анхаарал хандуулдаг байна. Тухайлбал, эрэгтэй үйлчлүүлэгчдийн хувьд дэлгүүрийн зохион байгуулалт болон ажиллагсдын харилцаа нь худалдан авах хандлагыг нэмэгдүүлэх хүчин болдог бол эмэгтэй үйлчлүүлэгчдийн хувьд дэлгүүрийн гэрэлтүүлэг, өнгө үзэмж, үнэр зэрэг нь чухал ач холбогдолтой байдаг байна. Мөн 1 сая хүртэлх төгрөгийн орлоготой гэж хариулсан судалгаанд оролцогчдын хувьд дэлгүүрийн үнэр, зохион байгуулалт, гэрэлтүүлэг, ажиллагчдын харилцаа, мэдээллийн дэлгэц зэрэгт өндөр ач холбогдол өгдөг бол 1 сая төгрөгөөс дээш орлоготой судалгаанд оролцогчдын хувьд дэлгүүрийн үнэ дэлгэцээс гадна өнгө чухал нөлөөтэй байдаг байна.

Эндээс үзвэл дэлгүүрийн зорилтот үйлчлүүлэгчдийн амьдралын хэв маяг, зан үйл, эерэг мэдрэмжтэй байлгах хүчин зүйлсийг гүнзгийрүүлэн судалснаар дэлгүүрийн орчныг илүү таатай болгох боломж нэмэгдэх юм. Ингэснээр үйлчлүүлэгчдийн худалдан авах хандлагад нөлөөлөх боломжтой гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Anderson, Craig A. 1989. «Temperature and Aggression: Ubiquitous Effects of Heat on Occurrence of Human Violence.» *Psychological Bulletin*, 106, July.
- Areni, Charles S. and David Kim. 1994. «The Influence of In- Store Lighting on Consumers' Examination of Merchandise in a Wine Store.» *International Journal of Research in Marketing*, 11 (March).
- Babin, B.J. & Darden, W.R. 1995. «Consumer self-regulation in a retail environment.» *Journal of Retailing* 71 (1).
- Baker, J. 1987. «The role of the environment in marketing services: the consumer perspective In J. Czepiel, C. A. Congram, & J. Shanahan, eds.» *The Services Challenge: Integrating for Competitive Advantage*.
- Baker, J., Levy, M. & Grewal, D. 1992. «An experimental approach to making retail store environmental decisions.» *Journal of Retailing* vol. 68, no. 4.
- Baker, Julie and Michaelle Cameron. 1996. «The Effects of the Service Environment on Affect and Consumer Perception of Waiting Time: An Integrative Review and Research Propositions.» *Journal of the Academy of Marketing Science*, 24 (September).
- Baker, John, Parasuraman, A., Grewal, Dhruv, & Voss, Glenn. 2002. «The influence of multiple store environment cues on perceived merchandise value and patronage intentions.» *Journal of Marketing* 66(April).
- Bell, Paul A. and Robert A. Baron. 1977. «Aggression and Ambient Temperature: The Facilitating and Inhibiting Effects of Hot and Cold Environments.» *Bulletin of the Psychonomic Society*. 9 June.
- Bellenger. D. N., D. H. Robertson and E. C. Hirshman. 1978. «Impulsive Buying Varies By Product.» *Journal of Advertising Research* vol. 18.
- Bellizzi, J. A., Crowley, A. E., Hasty, R. W. 1983. «The Effects of Color in Store Design.» *Journal of Retailing* Vol. 59, No. 1.
- Bellizzi, J. A., Hite, R. E. 1992. «Environmental Color, Consumer Feelings, and Purchase Likelihood.» *Psychology and Marketing* Vol. 9, No. 1.
- Berman, B. & Evans, J.R. 1995. *Retail management: a strategic approach 6th ed.* Macmillan Publishing Co., ed., Englewood Cliffs, NJ.: Prentice-Hall Inc.
- Berman, B., & Evans, J. R. 2013. «Retail management: a strategic approach (Twelfth ed.)» *Upper Saddle River, NJ: Palgrave Macmillan*.
- Berman, B., Evans, J. R., & Chatterjee, P. 2018. *Retail management: a strategic approach (13th ed.)*. Harlow, UK: Pearson Education.
- Beukes, M. 2010. *The importance of, and satisfaction with, store attributes when buying casual wear: a study among black Generation X consumers*. Potchefstroom: NWU. (Thesis – Master's).
- Boone, L.E. & Kurtz, D.L. 2012. *Contemporary marketing. 15th ed.* Baltimore, Md.: Cengage Learning.
- Bruner, Gordon II. 1990. «Music, mood and marketing.» *Journal of Marketing* 54(4).
- Choi, J. 2019. «Is Cleanliness Really a Reason for Consumers to Revisit a Hotel?» *Journal of Environmental Health* 82(5).
- Chronicle, Deccan. 2011. *Busy lifestyles making us forget five things every day*. 08 11. <http://www.deccanchronicle.com/channels/lifestyle/stress/busy-lifestyles-making-us-forget-five-things-every-day-535> .
- Connections, ACP. 2011. *Music and consumer behaviour*. 11 10. [http://www.queenslandnewsagents.com.au/assets/images/MusicConsumer Behaviour.pdf](http://www.queenslandnewsagents.com.au/assets/images/MusicConsumerBehaviour.pdf) .
- Correia, Camil, Kevin J. Lopez, Kristen E. Wroblewski, Megan Huisingsh-Scheetz, David W. Kern, and Rachel C. Chen. 2016. «Global Sensory Impairment in Older Adults in the United States.» *Journal of the American Geriatrics Society* 64 (2).

- Crowley, A. E. 1993. *The Two-Dimensional Impact of Color on Shopping*. Marketing Letters, Vol. 4, No. 1.
- d' Astous, A. 2000. «Irritating aspects of the shopping environment.» *Journal of Business Research* vol. 49, no. 2.
- Dash, S. K. 2018. «Role and Importance of Color in Marketing.» *The XIMB Journal of Management* 15(1).
- De Nisco, A. & Warnaby, G. 2013. «Shopping in downtown: The effect of urban environment on service quality perception and behavioural intentions.» *International Journal of Retail & Distribution Management* 41(9).
- Effect of brightness distribution and light colours on office staff Results of the "Lighting Harmony" project.» *The 9th European Lighting Conference „Lux Europa 2001”*. Reykjavik; 18.
- Eicar. 2012. *Glossary: Lighting*. 05 12. <http://www.eicar-international.com/definition-lighting.html> .
- Evans, M., Jamal, A. & Foxall, G. 2010. *Consumer behaviour. 2nd ed.* . England: John Wiley and Sons.
- Eze. 2014 . «Temporal and Spatial Temperature Trends and Their Implications on Health Conditions in Port Harcourt and Warri in Niger Delta Gobo.» *Journal of Environment and Earth Science* Vol.4, No.8,.
- Fanger, Ole. 1970. *Fanger, Ole (1970), Thermal Comfort Analysis and Applications in Environmental Engineering*. Copenhagen, Danish : Technical Press.
- Fleischer.S, Krueger.H, Schierz.C. 2001. «Effect of brightness distribution and light colours on office staff Results of the "Lighting Harmony" project.» *The 9th European Lighting Conference „Lux Europa 2001”*. Reykjavik; 18 .
- Gable, Myron, Martin T. Topol, Vishal Lala, and Susan S. Fiorito. 2008. «Differing perceptions of category killers and discount stores.» *International Journal of Retail & Distribution Management* 36.
- George, M., Kumar, V., & Grewal, D. 2013. «Maximizing profits for a multi-category catalog retailer.» *Journal of Retailing* 89
- Gobé, M. 2009. *Emotional branding: The new paradigm for connecting brands to people*. New York: Allworth Press.
- Gobo, A. E. and Eze, M. 2014. « Temporal and Spatial Temperature Trends and Their Implications on Health Conditions in Port Harcourt and Warri in Niger Delta .» *Environment and Earth Science*.
- Hallock, J. 2003. *Color assignment*. Дата обращения: 08 02 2014 г. <http://www.joehallock.com/edu/COM498/index>.
- Hart, C., Farrell, A.M., Stachow, G., Reed, G. & Cadogan, J.W. 2007. «Enjoyment of the shopping experience: impact on customers' repatronage intentions and gender influence.» *The Service Industries Journal* vol. 27, no. 5.
- Herrington, J.D. and Capella, L.M. 1994. «Practical applications of music in service settings.» *Journal of Services Marketing* Vol. 8 No. 3,.
- Holland, R. W., Hendriks, M., & Aarts, H. 2005. « Smells like clean spirit: Nonconscious effects of scent on cognition and behavior.» *Psychological Science* 16(9).
- Huddleston, P., Whipple, J. & VanAuken, A. 2004. «Food Store Loyalty: Application of a Consumer Loyalty Framework.» *Journal of Targeting, Measurement and Analysis for Marketing* 12 (3).
- Hui L, Dube L, Chebat JC. 1997. «The impact of music on consumers' reactions to waiting for service experience.» *Retailing* 73(1).
- Hultén, B., Broweus, N. & Van Dijk, M. 2009. *Sensory marketing*. London: Palgrave Macmillan.
- Hunter BT. 1995. «The sales appeal of scents (using synthetic food scents to increase sales.» *Consum Res Mag* 78(10).
- Inman, J. J. & Winer, R. S. 2004. «Where the Rubber Meets the Road: A Model of In-Store Consumer Decision-Making.» *Marketing Science Institute, Working Paper* No. 98.

- Karlen, M., Benya, J. 2011 . «Lighting Design Basics.» *New Jersey: John Wiley & Sons.*
- Knasko, S. C. 1995. « Pleasant odors and congruency Effects on approach behavior.» *Chemical Senses* 20.
- Kotler, P. 2001. «Atmospherics as a marketing tool.» *Journal of Retailing* 49(4).
- Kuller,R, Ballal,S, Laike,T, Mikellides,B, Tonello,G. 2006. «The impact of light and colour on psychological mood: a cross-cultural study of indoor work environments .» () Pages 1496-1507 .
- Kutlu, R., Manav, B., & Klanc, R. 2013. «Retail Design: Color-Light Influence on Brand Identity Image Perception.» *World Applied Sciences Journal* 23(5).
- Lange, R., Rentfrow, J. 2007. «Color and personality: Strong’s interest inventory and Cattell’s 16PF.» *North American Journal of Psychology* Vol. 9, No. 3.
- Lee, N. R. Feb 2002. «Color as a tool for e-branding.» *MA Design Futures.*
- Macmillan. Dictionary, 2012. *Scent.* 31 5.
http://www.macmillandictionary.com/thesaurus/british/scent#scent_10 .
- Manuahe, F., Lapian, S. J., & Tumbuan, W. A. 2017. « Analyzing the store atmosphere of Centro department store in Manado town square using importance- performance analysis (IPA).» *Jurnal EMBA: Jurnal Riset Ekonomi, Manajemen, Bisnis dan Akuntansi* 5(3).
- McCloughan C.L.B., Aspinall, P.A. & Webb, R.S. 1998. «The impact of lighting on mood. Lighting .» *Research and Technology* 31 (3).
- Mehrabian, A. & Russell, J.A. 1974. *An approach to environmental psychology.* Cambridge: MA: MIT Press.
- Middlestadt, S. E. 1990. *The Effect of Background and Ambient Color on Product Attitudes and Beliefs.* Advances in Consumer Research, Vol. 17, No. 1.
- Milliman, Ronald E. 1982. «Using background music to affect the behavior of supermarket shoppers.» *Journal of Marketing* 46(2).
- Milliman, Ronald E. 1986, 13 (September),. «The Influence of Background Music on the Behavior of Restaurant Patrons.» *Journal of Consumer Research.*
- Mitchell, Deborah J., Barbara E. Kahn and Susan C. Knasko. 1995. «There’s Something in the Air: Effects of Ambient Odor on Consumer Decision Making.» *Journal of Consumer Research* 22 (September).
- Moschis, G.P. 1987. *Consumer Socialization: A Life-cycle Perspective.* Lexington MA: Lexington Books.
- Moye, L.N. and Giddings, V.L. 2002. «An examination of the retail approach-avoidance behavior of older apparel consumers.» *Journal of Fashion Marketing and Management* Vol. 6 No. 3.
- Ogden-Barnes, S. & Barclay, D. 2011. «Store sense: Reclaiming the four walls with sensory engagement.» *The retail acumen series.* 11 10. <http://www.deakin.edu.au/buslaw/gsb/retail> .
- Parsons, A. G. 2009. «Use of Scent in a Naturally Odourless store.» *International Journal of Retail & Distribution Management* 37 (5).
- Pegler, M.M. 2010. *Visual merchandising and display. 5th ed.* China: Fairchild.
- Rodrigues.C, Hultén,.B, Brito.C. 2011. «Multi-sensory brand-experience: towards a strategic sensorial approach.» *Conference 7th Thought Leaders International Conference in Brand Management . .*
- Rook, D.W., & Fisher, R. J. 1995. «Normative Influences on Impulsive Buying Behavior.» *Journal of Consumer Research.*
- Schifferstein, H. N. J., & Blok, S. T. 2002. «The signal function of thematically (in) congruent ambient scents in a retail environment.» *Chemical Senses* 27.
- Smith, Patricia, and Curnow, Ross. 1966. «Arousal Hypothesis” and The Effects of Music on Purchasing Behavior.» *Journal of Applied Psychology* 50.

- Soars, B. 2009. «Retail insight: driving sales through shopper's sense of sound, sight, smell and touch.» *International Journal of Retail & Distribution Management* 37(3).
- Solomon R., Michael. 2006. «Consumer Behaviour – buying, having and being.» *Upper Saddle River, New Jersey: Pearson Prentice Hall*.
- Sorensen, H. 2003. « The Science of Shopping.» *Marketing Research* 15 (3).
- Spangenberg, E.R., Sprott, D.E., Grohmann, B. & Tracy,. 2006. «Gender-congruent ambient scent influences on approach and avoidance behaviors in a retail store.» *Journal of Business Research* vol. 59, no. 12.
- Spangenberg, E., Crowley, A. E., & Henderson, P. W. 1996. «Improving the store environment: do olfactory cues affect evaluations and behaviors?» *Journal of Marketing* 60(2).
- Stone, E. 2010. *The dynamics of fashion. 3rd ed.* . N.Y.: Fairchild.
- Summers, Teresa A. and Paulette R. Hebert (2001). 2001. «Shedding Some Light on Store Atmospherics Influence of Illumination on Consumer Behavior.» *Journal of Business Research*, 54 (November).
- Teller, C., Kotzab, H. & Grant, D.B. 2006. «The consumer direct services revolution in grocery retailing: an exploratory investigation.» *Managing Service Quality*, 16(1).
- Turley, L.W. & Milliman, R.E. 2000. «Atmospheric effects on shopping behavior: a review of the experimental evidence.» *Journal of Business Research*, vol. 49, no. 1990.
- Vinitzky, G., & Mazursky, D. 2011. «The effects of cognitive thinking style and ambient scent on online consumer approach behavior, experience approach behavior, and search motivation.» *Psychology & Marketing* 28(5).
- Wilson, S. 2003. «The Effect of Music on Perceived Atmosphere and Purchase Intentions in a Restaurant.» *Psychology of Music* 31(1).
- Yalch, R.F. & Spangenberg, E.R. 1988. «An environmental psychological study of foreground and background music as retail atmospheric factors In A. W. Walle, ed.» *AMA Educators' Conference Proceedings*. Chicago: American Marketing Association.
- Yalch, Richard F. and Eric Spangenberg. 1990. «Effects of Store Music on Shopping Behavior.» *Journal of Consumer Marketing* 7 (Spring).
- Yoo, C., Park, J., & MacInnis, D. J. 1998. « Effects of store characteristics and in-store emotional experiences on store attitude.» *Journal of Business Research* 42(3).



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮТЭЭМЖИЙН ХЭМЖИЛТЭД ГАРЦЫН ИНДЕКС ЧУХАЛ БОЛОХ НЬ

Д.Отгонтуяа

Доктор (Ph.D), Шинэ Монгол сургууль



Хураангуй

Эмчилгээний үр нөлөөг үнийн өсөлтөөр биш, үйлчилгээний чанараар хэмжих нь үйлчилгээний бүтээмжийн хэмжилтийн бодит байдлыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг:

Бүтээмж, төрийн
үйлчилгээний бүтээмж,
бүтээмжийн хэмжилт,
чанарын тохируулга

УДИРТГАЛ

Улс орны хөгжил дэвшил, бүтээх чадварт голлон нөлөөлдөг бүтээмжийн тухай сэдэв ямагт анхаарлын төвд байдаг билээ (Singh, H., Motwani, J. and Kumar, A. , 2000), (Tangen, 2005). Бүтээмжийн тухай ойлголт нийтлэг боловч (A.Ghobadian & T.Husband, 1990) эдийн засагч, бодлого боловсруулагч, инженер, менежер, нягтлан бодогч зэрэг өөр салбарын мэргэжилтнүүд өөрсдийн үйл ажиллагааны онцлог, хэтийн төлвөөс хамааруулан (Grunberg, 2004), (Susan, 2007) бүтээмжийг ялгаатай (Mohanty, R. P. & Rastogi, S. C. , 1986) тодорхойлдог.

Бүтээмжийн үзэл баримтлал, тодорхойлолт бий болоход үйлдвэрлэл (Chew, 1986), эдийн засгийн шинжлэх ухаан чухал нөлөөтэй. Бүтээмжийн ихэнхи тодорхойлолт нь үйлдвэрлэлийн үйл явцын үр ашгийг эсвэл орц гарцын хамаарлыг (Craig C.E and Harris C.R, 1973), (C. Ammer and Ammer D.S., 1984) илэрхийлдэг. Бүтээмжийн судалгаанд чухал хувь нэмэр оруулсан гол төлөөлөгч, эрдэмтэн С.Синк бүтээмжийг “Бүтээмж гэдэг нь хамгийн энгийнээр, системийн бий болгосон гарц бөгөөд тэдгээр гарцыг бий болгоход оруулсан орцын харилцан хамаарал юм. Хөдөлмөр (хүний нөөц), капитал (санхүүгийн хөрөнгө), эрчим хүч, материал, тоон өгөгдөл нь системийн орц юм. орцууд нь бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу гарц болж хувирдаг” хэмээн тодорхойлсон нь өнөөг хүртэл ач холбогдолтой хэвээр байна.

Бүтээмжийн хэмжилтийг 1990 он хүртэл эдийн засгийн ойлголтын хүрээнд судалж байсан бөгөөд 1992 онд дэлхийн 178 улс нэгдэн “Тогтвортой хөгжлийн тунхаглал”-ыг баталснаар

бүтээмжийн талаарх ойлголт эрс өөрчлөгдсөн. Эдийн засгийн өсөлт, нийгмийн амьдралын чанарын дэвшил, байгаль, экологийн тэнцвэртэй байдал, уур амьсгалын өөрчлөлт, технологийн хөгжил зэрэг асуудлууд бүтээмжийг чанарын үзүүлэлттэй уялдуулах хэрэгцээг бий болгосон.

Эдгээр шаардлагуудад үндэслэн аливаа улсын эрүүл мэнд, боловсролын бүтээмжийг хэмжихдээ нийгмийн амьдралын чанарт гарч буй өөрчлөлтийг хэрхэн тусгаж, хэмжих нь оновчтой вэ гэсэн асуултанд хариулах хэрэгцээ үүссэн. Бүтээмжийг өсгөх уламжлалт арга нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн (эмч, эмнэлэгийн ажилтан гэх мэт) нэрлэсэн зардлыг (nominal expenditure) үнийн индексээр бууруулж тодорхойлдог. Онолоор бол тухайн цаг хугацаанд үзүүлсэн үйлчилгээний гарцыг хэмжих ёстой. Гэвч, эрүүл мэндийн үйлчилгээний үнийг хассан тохиолдолд гарц, бүтээмжийн хэмжилт л үлдэнэ. Тиймээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний *үнийг хэмжих* асуудал нь бүтээмжийг хэмжихэд тулгарч буй гол бэрхшээлүүдийн нэг юм (Malinovskaya A, Sheiner L, 2016).

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь олон технологи, арга ба горимоор явагддаг, ялангуяа эмчилгээ хийх үйл явцын сонголт, яаралтай тусламжийн тасаг, өвчтөнд үргэлжлүүлэн тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэгт бий болгож буй үнэ цэнэ зэрэг нь энэ салбарын бүтээмжийн хэмжилтийг өөрөөр ойлгоход хүргэдэг (el, Rosen A. Cutler D. at, 2017). Бүтээмжийн хэмжилтэд орц, гарц, үйл ажиллагаа, үр нөлөө зэрэг ойлголтууд шууд нөлөөтэй учир эхлээд эдгээр үзүүлэлтийг товч авч үзье.

Орц

Орцын арга нь ажиллагчдыг нэмж ажиллуулахгүйгээр төрийн үйлчилгээг хоёр дахин ихэсгэх нь хоёр дахин их үр ашиг бий болгон гэсэн үзэлд тулгуурладаг. Энэ аргын давуу тал нь өгөгдөл бэлэн, хэрэглэхэд хялбар боловч сүүлийн үеийн тоног төхөөрөмж, технологийн хэрэглээнээс шалтгаалсан бүтээмжийн бүх өөрчлөлтийг илэрхийлж чаддаггүй сул талтай. Тиймээс орцын хэмжүүр нь бүтээмжийн өөрчлөлтөд оруулсан нэмэлт өөрчлөлтийг илэрхийлдэг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, орцын чанарын өөрчлөлтийг (жишээ нь хөдөлмөр) харгалзан үзсэний дараа бүтээмжийн өөрчлөлтийг хэмжих нь бүтээмжийн хэмжилтэнд чухал ач холбогдолтой хэдий ч үүнийг төрийн бүтээмжийг тооцоход ашигласан олон улсын туршлага байхгүй хэвээр байна.

Үйл ажиллагаа

Үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь зах зээлийн бус үйлдвэрлэгчид орцыг ашигласнаар юу бүтээснийг харуулдаг учир (мэс засал хийлгэсэн хүний тоо) үүгээр гарцыг илэрхийлэх боломжтой. Сайжруулсан аргуудыг эмчилгээнд ашигласнаар мэс заслын тоо буурсан гэж төсөөлөн, үйл ажиллагааны тоог гарцын үзүүлэлт гэвэл энэ тохиолдолд бүтээмж буурах учир уг үзүүлэлтийг ашиглах нь тохиромжгүй юм. Харин, зарим нийтлэг үйлчилгээний (элэгний өвчнөөс урьдчилан сэргийлэх) хувьд үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт нь цорын ганц гарцын үзүүлэлт байж болно.

Гарц

Төрийн бүтээмжийн хэмжилтэд гарцын үзүүлэлтийг чухалчилдаг хандлага давамгайлдаг боловч гарцын нэгжийг оновчтой тодорхойлох нь ихээхэн бэрхшээлтэй байдаг. Хувь хүний гарц нь үйлдвэрлэгчээс хэрэглэгч рүү бодитоор хүргэгддэг учир бараа,

үйлчилгээний гарцыг тодорхойлох боломжтой. Тухайлбал, эмнэлгийн тусламж үйлчилгээний хувьд гарц нь өвчтөний хүлээн авсан тусламжийн тоо хэмжээ юм.

Үр нөлөө

Үр нөлөө нь хүн амын боловсролын түвшин, дундаж наслалт гэх мэт аливаа зүйлсийн түвшин, хэм хэмжээг илэрхийлсэн шалгуур үзүүлэлтүүд юм. Энгийнээр хэлбэл, үйл ажиллагааны үр дүнд иргэдийн амьдралын чанарт гарсан өөрчлөлтийг үр нөлөөгөөр илэрхийлдэг.

Чанарын өөрчлөлт

Зах зээлийн бус гарцын хувьд зах зээлийн үнэ байхгүй тул чанарын өөрчлөлтийг тохируулах шаардлагатай. Гарцын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглахдаа эдгээр үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, ялангуяа нэгжийн өртгийн хувьд оношийн бүлгээр (зурх, бөөр г.м), үйл ажиллагааны чиглэлээр (хэвтэн, өдрийн эмчилгээ г. м) нэг төрөл болгон ангилна. Дээрх ангилалд түшиглэн онош тус бүрийн эзлэх хувийн жинг өртгөөр илэрхийлнэ. Жишээлбэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнг олон тооны эмчилгээнд хувааж үзвэл эмчилгээний хоорондох шилжилтийг тоо хэмжээгээр илэрхийлэх хэсэгт оруулна. Гэхдээ, энэ тохиолдолд илүү өндөр өртөгтэй эмчилгээг чанартай эмчилгээ гэж тооцохгүй.

Чанарын өөрчлөлтийг тохируулах гурван хандлага бий (Statistics, 2012).

- Гарцын чанарыг хэмжих. Төрийн үйлчилгээний чанарыг цаг хугацааны явц дахь чанарын өөрчлөлтөөр илэрхийлж болох ч мэдээлэл нь субъектив шинж чанартай учир гарцын чанараас илүү үйлдвэрлэлийн үйл явцын чанарыг үнэлэх шаардлага тулгарч болно.
- Орцын чанарыг хэмжих. Хэмжилтийн бүрэлдэхүүнд ажлын байрны чанарын өөрчлөлтийг оруулсан тохиолдолд орцын чанарыг ажилчдын цалин хөлсөөр тооцож болно. Орцын чанарын өөрчлөлт гарцын чанарын өөрчлөлтөд нөлөөлөх боломжтой учир энэ аргыг гарцын чанарыг зөв хэмжсэн тохиолдолд хэрэглэх боломжтой.
- Үр өгөөжийг ашиглах. Гарцын чанар нь түүний үр дүнд гарч буй өөрчлөлт буюу үр нөлөөгөөр илэрдэг. Жишээлбэл, нас баралт буурсан нь эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө сайжирсныг илэрхийлнэ. Түүнчлэн, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь өвчлөлийн хэмжээг бууруулж, энэхүү өөрчлөлт нь үйлчлүүлэгчийн амьдралын чанарт эерэгээр нөлөөлнө.

Эмнэлгийн бүтээмж

Бүтээмжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гарцын нийт дүнг гарцыг үйлдвэрлэхэд ашигласан орцын нийт хэмжээтэй харьцуулж хэмждэг. (Томъёо1.)

$$h \text{ эмнэлгийн бүтээмж} = \frac{\text{Гарца}}{\text{Орца}} \quad (\text{Томъёо1.})$$

Гарц нь h эмнэлгийн өвчтөнүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ (амбулатори, хэвтүүлэн эмчлэх) ($h = 1 \dots H$), орц нь өвчтөнүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд оролцдог ажилтан, хөрөнгө болон засварын хэрэглээнээс бүрдэнэ.

Эмнэлгийн үйл ажиллагааны үр дүнг харьцуулах, тайлбарлах ажлыг хөнгөвчлөхийн тулд эмнэлэгийн (h) тухайн жилийн стандарт⁴² (P_h) бүтээмжийг дараах томъёогоор тооцдог.

$$P_h = \left\{ \left[\left(\frac{X_h}{Z_h} \right) / \frac{1}{H} \sum_h \frac{X_h}{Z_h} \right] - 1 \right\} \times 100, \quad (\text{Томъёо2.})$$

Энд,

X_h үйлдвэрлэсэн гарцын хэмжээ

Z_h ашигласан орцын хэмжээ

Эмнэлэгийн стандарт бүтээмжийг эмнэлгийн гарц/орцын харьцааг улсын дундаж гарц/орцын харьцаанд хувааж, хувиудын зөрүүг 1 гэсэн тоогоор илэрхийлэв. Өөрөөр хэлбэл, h эмнэлэгийн стандарт бүтээмж нь 10 гэвэл энэ эмнэлэгийн бүтээмж нь улсын дунджаас 10% илүү байна гэсэн үг юм.

Эрүүл мэндийн гарцад чанарын тохиргоо хийх арга зүй

Урьдчилсан тандалтын судалгаагаар чанарын хэмжилтийг доорх аргуудаар тооцоход шаардлагатай суурь мэдээлэл байгаа хэдий ч зарим мэдээлэл хангалтгүй учир дахин боловсруулалт хийн өгөгдлийг тодорхой болгох шаардлага тулгарсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг хэмжих аргууд нь ДЭМБ, эрүүл мэндийн үндэсний тооцооны тайлан, эрүүл мэндийн статистик мэдээ, эрүүл мэндийн үзүүлэлтийн тайлан зэрэгт тусгагдсан мэдээллүүдэд үндэслэдэг. Манай улсын эрүүл мэндийн үндэсний тооцоог 2003-2014 оны мэдээллийг хамруулан 2017 онд боловсруулсан гаргасан ба үүнээс хойш жил бүрийн мэдээллийг ДЭМБ-аар баталгаажуулдаг (ЭМХТ, 2017). Тиймээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гарцыг олон улсын арга зүйгээр тооцох боломжтой. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хэмжих дараах аргуудыг судалгаанд ашиглах тул нарийвчлан судалсан. Үүнд:

- Чанартай амьдралыг тооцсон жил
- Дундаж наслалтын арга
- Хүлээлтийн хугацаа тооцох арга багтана.

Чанартай амьдралыг тооцсон жилийн арга (QALY, Quality adjusted life year): “Чанартай амьдралыг тооцсон жил” (ЧАТЖ) гэсэн үзүүлэлт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга бөгөөд үүнийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт болгон ашигладаг. “Чанартай амьдралыг тооцсон жил” (ЧАТЖ) гэдэг нь өвчтөн эмчилгээний үр дүнд ямар хугацаанд (хэдэн сар, жил) боломжийн түвшинд чанартай амьдрахыг илэрхийлнэ. Амьдралын чанарын үнэлгээ 0-ээс доош буюу сөрөг утга (эрүүл мэндийн байдал хамгийн муу) эсвэл 1 хүртэлх (эрүүл мэнд байдал хамгийн сайн) утга авч болно. Эрүүл мэнд нь маш сайн байгаа нэг жилийг “Чанартай амьдралыг тооцсон жил” (ЧАТЖ) гэж үзнэ.

Үйл ажиллагааны чанарын өөрчлөлтийг хэмжих энгийн арга нь цаг хугацааны явцад ЧАТЖ үйл ажиллагааны өөрчлөлттэй хэрхэн хамаарахыг тооцно. Аргыг илүү ойлгомжтой болгох үүднээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг болох ихээхэн хэмжээний хөрөнгө, шинэ мэдлэг, ур чадвар, өндөр технологи шаарддаг мэс заслыг жишээ болгон авч үзье. Мэс

⁴² a measure of standardised productivity

ажилбарыг хөрөнгө оруулалт гэж үзэж болох бөгөөд түүний өгөөжийг практикт ирээдүйд бий болох (одоо өвдсөн ч гэсэн ирээдүйд амьдралын чанар сайжран ажиллаж амьдрах хугацаа) өгөөжийг ашиглан ирээдүйн үнэ цэнийг тооцдог.

Амь насанд аюул учруулахгүй өвчний нөхцөлд q_{jt} дэх t хугацаан дахь j ажилбарын хувьд

$$q_{jt} = a_{jt}q_{jt}^* - q_{jt}^0 \quad (\text{Томьёо 3. Амьдрах хугацаа}) \text{ болно.}$$

a_{jt} - t хугацаан дахь j ажилбарын мэс заслын дараах амьдрах хугацаа

q_{jt}^* - эмчлэгдсэн тохиолдлын ЧАТЖ-н дундаж хугацаа

q_{jt}^0 - эмчлүүлээгүй тохиолдлын ЧАТЖ-н дундаж хугацаа

Тэгшитгэлийн баруун гар талын эхний томьёо нь мэс ажилбарыг амжилттай давсан хүмүүсийн эрүүл мэндийн үр ашгийг илэрхийлж байна. Мэс ажилбарын дагуу ЧАТЖ - үүдийн хоёр q_{jt+1}/q_{jt} хугацааны хоорондын пропорциональ өөрчлөлтийг Томьёо3-г ашиглан дараах хэлбэрээр бичнэ.

$$\frac{a_{jt+1}q_{jt+1}^* - q_{jt+1}^0}{a_{jt}q_{jt}^* - q_{jt}^0} \quad (\text{Томьёо4.})$$

Мэс засал хийснээс хойш 30 хоногийн дараах өгөгдлөөр t хугацаан дахь j ажилбарын мэс заслын дараах амьдрах магадлал a_{jt} -ыг тодорхойлно.

Монгол улсын эрүүл мэндийн статистикт эрүүл мэндийн нөөцийн бүлэг түүний дэд бүлгүүдээр өвчтөний эмчилгээний үр дүнгийн мэдээллийг тогтмол цуглуулдаг. Иймд дээр дурдсан судалгаануудын эрүүл мэндийн үр ашгийн "зураглал"-д үндэслэн, эмчилгээ хийсний дараах эрүүл мэндийн байдал нь өвчтөний амьдралын бусад хугацаанд тогтмол байна гэж үзвэл $\frac{h_{jt}^0}{h_{jt}^*} = k_j$ -ийг (Томьёо 5. Эрүүл мэндийн байдал) ойролцоогоор тооцоолох боломжтой болно. Эмчилгээ хийлгээгүй үед эрүүл мэндийн байдал тогтвортой бөгөөд эмчилгээний үр ашиг цаг хугацааны явцад өөрчлөгддөггүй гэж үзсэн тохиолдолд дээрх тооцооллыг хийнэ.

Зарим мэс ажилбарын хувьд k_j -ыг тооцоолох өгөгдөл хангалтгүй үед бусад өөр хагалгааны k_{jt} дундаж үзүүлэлтэд тулгуурлаж тооцож болно. Жишээлбэл, хагалгаа хийлгэхээс өмнөх өвчтөний эрүүл мэндийн байдал, хагалгаа хийлгэсний дараах биеийн байдалтай харьцуулахад 80 хувь сайжирсан байдаг гэж үзвэл $k_{jt} = k_j = 0.8$ байж болно.

Гэхдээ цаг хугацааны хувьд ялгаатай ажилбаруудын тоон өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн өгөөжийг тооцоолох боломж нэмэгдэнэ.

Эрүүл мэндийн өгөөжийг тодорхойлохдоо томьёо 5-ыг хялбаршуулан $k_j = \frac{h_{jt}^0}{h_{jt}^*}$ үед дараах байдлаар бичиж болно.

$$\frac{a_{jt+1} - k}{a_{jt} - k_j} \quad (\text{Томьёо 6. Эрүүл мэндийн байдал})$$

k_j нь a_{jt} эсвэл a_{jt+1} -тэй ойролцоо утгатай байх нь тооцоололд сөргөөр нөлөөлнө. Өөрөөр хэлбэл, $(a_{jt+1} - k_j)$ ба $(a_{jt} - k_j)$ нь тэг эсвэл сөрөг утгатай байж болох ба мэс заслын дараах амьдрах багахан өөрчлөлтөд мэдрэмтгий байна гэсэн үг юм.

“Мэс ажилбар нь нийгмийн ач холбогдолгүй”, “мэс ажилбарын эрсдэлийг даван туулахад эрүүл мэндийн өгөөж хангалтгүй” зэрэг ойлголт нь дараах гурван шалтгаантай.

- Эмчилгээний дараах нас баралтын тохиолдол. Өвчтөн нас барсан нь түүнд анхаарал халамж тавиагүй гэсэн үг биш бөгөөд харин, мэс заслын дараа амьдрах нь мэс ажилбараас хамаарахгүй тохиолдолд эрүүл мэндийн өгөөжийг тухайн өвчтөний амьдрах хугацаанд гарсан өөрчлөлтөөр илэрхийлнэ.
- Хоёр дахь шалтгаан нь k -г дунджаар хэрэглэх нь амьдрах магадлал нь өндөр биш ч тодорхой өгөөжтэй зарим нэг мэс заслын (жишээлбэл эмчлүүлээгүй үлдсэн тохиолдолд ойрын ирээдүйд нас барах эсвэл хөгжлийн бэрхшээлтэй болох магадлалтай өвчин) эрүүл мэндэд үзүүлэх өгөөжийг дутуу үнэлдэг.
- Мэс ажилбарын эрсдэл нь үр өгөөжөөсөө их байх тохиолдол байх ба ийм үед мэс ажилбар хийгддэггүй гэж үзэж болно. Эдгээр тохиолдлуудыг шийдвэрлэхийн тулд $(a_{jt+1} - k_j)$ ба $(a_{jt} - k_j)$ -ийн утга сөрөг, эсвэл өсөлтийн хурд 10 хувиас давсан тохиолдолд л чанарын тохируулгыг ашиглана.

Үйл ажиллагаа бүрт ноогдох зардлын хувийн жин зөв үнэлэгдсэн гэсэн төсөөлөлд үндэслэн үйл ажиллагааны зардлын жингийн индекст чанарын тохируулгыг ашиглан ерөнхий индексийг дараах байдлаар тодорхойлж болно:

$$\frac{\sum_j x_{jt+1}^c \frac{a_{jt+1}-k_{jt}}{a_{jt}-k_{jt}}}{\sum_j x_{jt}^c} \quad (\text{Томьёо 7.Чанарын индекс})$$

Дундаж наслалтын арга: Эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн дундаж наслалтыг чанарын үзүүлэлт болгон ашиглах нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодит үр дүнг илэрхийлнэ. Өвчтөнүүд нас, хүйсээр ялгаатай учир дундаж наслалтыг өвчтөний дундаж нас, хүйс дээр үндэслэн тооцоолно. Хэрэв эмчилгээ хийлгэсэн хүмүүс урт насалдаг бол тэдний дундаж наслалтаас илүү амьдарсан жилүүдийг эрүүл мэндийн гарцын нэг хэсэг гэж тооцно. Дундаж наслалт өөрчлөгдөж байгаагийн гол шалтгаан нь эрүүл мэндийн нөөцийн бүлэг дэх эмчлүүлж байгаа хүмүүсийн насны өөрчлөлттэй холбоотой. Өвчтөний эрүүл мэндийн байдал эмчилгээ хийсэн хийгээгүй аль ч тохиолдолд өвчтөний үлдсэн амьдралын туршид тогтмол гэвэл t хугацаан дахь j эмчилгээний хүлээгдэж буй өгөөж нь:

$$(a_{jt}h_j^* - h_j^0) \left(\frac{1-e^{-rL_{jt}}}{r} \right) \text{ болно. (Томьёо 8.Хүлээгдэж буй өгөөж)}$$

Томьёоны эхний хэсэг нь эмчилгээний өмнөх болон дараах үеийн эрүүл мэндийн байдлыг, хоёр дахь нь эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн үлдсэн хугацааны турш дахь хүлээгдэж буй үр өгөөж “ L_{jt} ” -ийг “ r ” буюу эрүүл мэндийн нөлөөллийг хэмжих нэгжид суурилан тооцсон тохируулга юм. Практикт хүлээгдэж буй үр өгөөжийг ихэвчлэн эмчлүүлсэн хүмүүсийн насаар тооцоолдог. Тиймээс дараалсан хоёр жилийн чанарын үзүүлэлтийг ашиглах ба энэ нь:

$$\frac{q_{jt+1}}{q_{jt}} = \frac{(a_{jt+1} h_j^* - h_j^0)(1 - e^{-rL_{jt+1}})}{(a_{jt} h_j^* - h_j^0)(1 - e^{-rL_{jt}})}$$
 болно. (Томьёо 9.Чанарын үзүүлэлт)

Эмчилгээ хийлгэж буй өвчтөнүүдийн үлдсэн хугацаа $L_{jt+1} = L_{jt}$ нь хугацааны хооронд өөрчлөгддөггүй бол дээрх илэрхийлэл нь эрүүл мэндийн өгөөжийг тооцоонд ашиглах томьёотой ижил байна.

Иймд нийт зардлын хувийн жин ба чанарын тохируулгатай индекс нь дараах байдалтай байна:

$$\sum_j \frac{x_{jt+1} c_{jt} (a_{jt+1} h_j^* - h_j^0)(1 - e^{-rL_{jt+1}})}{\frac{(a_{jt} h_j^* - h_j^0)(1 - e^{-rL_{jt}})}{\sum_j x_{jt} c_{jt}}} \text{ (Томьёо 10.Чанарын тохируулгатай индекс)}$$

Тодорхой эрүүл мэндийн нөөцийн бүлэг (ЭМНБ)-т эмчлүүлсэн хүмүүсийн дундаж наслалт өөрчлөгдвөл энэ индекс өөрчлөгдөнө. Хэрэв эрүүл мэндийн нөөцийн бүлэг (ЭМНБ) өөрчлөгдөөгүй бол индекс нь эрүүл мэндийн өртгийн нэмэгдсэн тохируулгатай индекстэй ижил байна. Энэ нь эрүүл мэндийн нөөцийн бүлэг (ЭМНБ)-ийн дунджаас дээш настай өвчтөнүүд мэс ажилбар руу шилжсэн тохиолдолд ч үнэн гэдэг нь батлагдана. Өөрөөр хэлбэл энэхүү шилжилтийн үнэ цэний аливаа зөрүүг зардлын жинг бүрэн тооцоолсон гэж үзнэ. Хэрэв энэ шилжилт нь илүү их өртгийн жинтэй үйл ажиллагаанд чиглэвэл гарц өөрчлөгдөнө.

Эндээс, h байгууллагын j гарцад хамаарах үйлчилгээний чанарыг дараах байдлаар томьёолж болно. (Томьёо 11.ЧАТЖ)

$$\bar{q}_{jh} = \left(\frac{a_{jh} - k_j}{\widehat{a_{jh} - k_j}} \right) \frac{\left[\frac{(1 - e^{-r_Q L E_{jh}})}{r_Q} - \frac{(e^{r_W W_{jh}} - 1)}{r_W} \right]}{\left[\frac{(1 - e^{-r_Q \widehat{L E}_j})}{r_Q} - \frac{(e^{r_W \widehat{W}_j} - 1)}{r_W} \right]}$$

q_{jh} h эмнэлгийн j гарцад хамаарах үйлчилгээний чанар

a_{jh} h хугацаан дахь j ажилбарын дараах амьдрах магадлал

W_{jh} h эмнэлгийн j үйлчилгээний хүлээлтийн хугацаа

\widehat{W}_j j үйлчилгээг хүлээлтийн хугацаа

$L E_{jh}$ h эмнэлгийн j үйлчилгээг авсан үйлчлүүлэгчийн дундаж нас

$L E_j$ j үйлчилгээг авсан үйлчлүүлэгчийн дундаж нас

r_Q чанарын тохируулгын хувь

r_W хүлээлтийн хугацааны тохируулгын хувь

Томьёо 11-ийн урвуу экспоненциал функц нь өвчтөний дундаж насанд нөлөөлөх чанарын үзүүлэлтийг бодит болгохын тулд бууруулах хувь, хэмжээг хэрэглэдэг. Бууруулах хувь хэмжээ буюу r нь эрүүл мэндийн болон бусад салбарт ирээдүйд бий болох өгөөжийг тохируулах зорилгоор ашиглагддаг. Ихэнх судалгаанд эрүүл мэндийн бууруулах хувь, хэмжээг 0% (судалгааны 35%) эсвэл 5% (судалгааны 47%), 10% (York, 2000) тус тус тооцсон

байгаагаас дүгнэхэд дээрх тохируулга нь улс бүрд оношийн бүлгээс хамааран ялгаатай байгааг дурдах нь зүйтэй. Энэхүү судалгаанд оношийн бүлгийн эрсдэлт хүчин зүйл, эмчилгээний техник технологийн хөгжлийн түвшин, зонхилох шалтгаант өвчний эзлэх хувийн жин өндөр зэргээс шалтгаалж тохируулгын хувийг 15 хувиар тооцсон болно.


Өвчтөний амьдрах магадлал гэдэг нь эмнэлгээс гарснаас хойш 30 хоногийн хугацаанд эсэн мэнд байх хугацаа юм. Хүлээлтийн хугацааны хувьд, эмчилгээг хойшлуулах нь өвчтөний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг бөгөөд хүлээгдэж буй үр ашиггүй байдал нь экспоненциал функц болон хөнгөлөлтийн хувь хэмжээгээр (r_w) тодорхойлогддог. LE_j буюу j үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн дундаж насыг өвчтөний нас, хүйсийн мэдээлэлд үндэслэн тооцдог.

Хүлээлтийн хугацаа тооцох арга. Хөгжлөөр тэргүүлэгч улсуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хэмжихэд өргөн ашигладаг аргуудын нэг нь хүлээлтийн хугацааг тооцох арга юм. Оношилгоо, эмчилгээ хийлгэхээр хүлээх нь хувь хүмүүст хоёр янзаар нөлөөлдөг.

- ✓ Нэгдүгээрт, үйлчлүүлэгчид эмчилгээний үр дүн болон чанарын тохируулгатай амьдралын жилийн дүн (qjt)-ээс үл хамааран хүлээх хүсэлгүй байдаг. Тиймээс хүлээлтийн хугацаа нь эрүүл мэндэд үзүүлэх нөлөөгөөрөө эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс ялгаатай.
- ✓ Хоёрдугаарт, удаан хүлээх нь эмчилгээний үр дүнг бууруулдаг бол, хүлээлтийн тохируулга нь эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх хүлээлтийн хүчин зүйлтэй (scaling factor) ижил юм.

Бүтээмж хэмжилтийн дээрх томъёоллыг ашиглан Монгол улсын “А” төв эмнэлгийн⁴³ хэвтүүлэн эмчлэх тасгийн бүтээмжийг 2016-2019 оны тоон мэдээллийг ашиглан чанарын тохируулгатай болон тохируулгагүй аргаар тооцлоо.

Хүснэгт 1. Хэвтэн эмчлүүлэгчдийн бүтээмж, чанарын тохируулгагүй




2016 онд 75.7 нэгж байсан бүтээмж 2017 онд 104.8 нэгж болж 29.1 нэгжээр нэмэгдсэн нь гарцын хэмжээ 84.2 нэгжээс 108.6 нэгж болж нэмэгдсэнтэй холбоотой. Хэдийгээр орцын тоо хэмжээ 2017 онд өмнөх оныхоос -8.3 нэгжээр буурсан хэдий ч бууралтын хэмжээ

⁴³ Нууцын зэрэглэлтэй тоон мэдээлэл ашигласан учир байгууллагын нэрийг дурьдаагүй болно.


бүтээмжийн өсөлтөд сөргөөр нөлөөлөөгүй нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, “А” төв эмнэлэг 2017 онд өмнөх оныхтой харьцуулахад бага орцоор илүү гарц үйлдвэрлэж, бүтээмжтэй ажиллаж чаджээ. Харин, 2018 онд орцын хэмжээ өмнөх оноос -10.3 нэгжээр буурсан ч, бүтээмж ердөө 3.9 нэгжээр буурсан нь орцын тоо хэмжээний бууралт бүтээмжийн бууралтад эрс өөрчлөлт оруулаагүй нь бүтээмжийн тухай үзэл, хандлага нь төлөвшиж буйг нотолж байна. 2016 оноос 2018 он хүртэлхи хугацаанд орцын тоо хэмжээ дунджаар 9.3 нэгжээр буурсан боловч энэхүү бууралт нь гарц болон бүтээмжийн өөрчлөлтөд төдийлөн сөргөөр нөлөөлж чадаагүй нь “А” төв эмнэлгийн бүтээмжийн удирдлагын тухай ойлголт болон удирдлага, зохион байгуулалт үр ашигтай, оновчтой байсныг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, бага орцоор өмнөхөөс илүү гарц үйлдвэрлэж байгаа нь орцыг бүтээмжтэй, үр ашигтай зарцуулсныг нотлохын зэрэгцээ бүтээмжийн үндсэн агуулга, үзэл баримтлалыг практикт нотолсон сайн жишээ юм.

Хүснэгт 2. Хэвтэн эмчлүүлэгчдийн бүтээмжийн харьцуулалт



Хэвтэн эмчлүүлэгчдийн бүтээмжийг чанарын тохируулгатай тооцоход, 2016 оноос эхлэн 2018 он хүртэл орцын тоо хэмжээ буурсан боловч эсрэгээр гарц, бүтээмжийн тоо хэмжээ нэмэгдсэн байгаа нь сонирхолтой дүр зураг юм. Чанарын тохируулгагүй хэмжилтийн үед 2016-2018 онд орц дунджаар 9.3 нэгжээр буурсан ч гарц 2017 онд өсөлттэй, 2018 онд бууралттай байсан үр дүнг гарцыг чанараар тохируулан тооцоход бүтээмж нэмэгдсэн нь чанарын тохируулгатай тооцооллын ач холбогдолтойг нотолж байна. Чанарын тохируулгатай тооцооллын графикаас харахад, 2019 онд орцын тоо хэмжээ өмнөх оноос 18.4 нэгжээр өссөн боловч, гарцын тоо хэмжээ 2019 онд өмнөх оноос -6.6 нэгжээр, бүтээмж -25.6 нэгжээр огцом буурсан нь орцыг үр ашиггүй, оновчгүй зарцуулсан нь нөлөөлжээ. Чанарын тохируулгагүй тооцооллын үед, 2019 онд орц, гарцын тоо хэмжээ аль аль нь нэмэгдсэн ч бүтээмж буурсан нь чанараар тохируулах шаардлагатайг нотолж байна. Өөрөөр хэлбэл, бүтээмжийг тоон үзүүлэлтийг харьцаагаар хэмжих нь үр дүнгийн бодит илэрхийлэл болж чадахгүй бөгөөд бүтээмжийг хэмжихдээ чанарын тохируулгыг ашиглах нь орц, гарцын нөлөөг тоон харьцаанаас илүү бодитой тооцоолох боломжийг олгодог.

Хүснэгт 3. Хэвтэн эмчлүүлэгчдийн бүтээмжийн харьцуулалт



2015 оныг суурь болгон тооцсон графикаас харахад, чанарын тохиргоотой тооцоололд 2017 онд бүтээмж өмнөх оноос 6.3 нэгжээр өссөн байхад, чанарын тохиргоогүй үед бүтээмж 29.1 нэгжээр өссөн нь бодитой өсөлт гэж тооцоход эргэлзээтэй юм. Өөрөөр хэлбэл, орцын тоо хэмжээ ижил байхад чанарын тохируулгатай болон тохируулгагүй тооцооллын үед бүтээмжийн тоо хэмжээ эрс ялгаатай байгаа нь бүтээмжийг чанарын тохируулгатай хэмжих нь бодит үр дүнг илэрхийлэхээс гадна хэмжилтэнд чухал ач холбогдолтойг нотолж байна. 2019 онд чанарын тохируулгагүй тооцоход, орцын тоо хэмжээ нэмэгдсэн байхад, гарцын хэмжээ буурсан, чанарын тохируулгатай хэмжилтийн үед, орцын хэмжээ нэмэгдсэн ч гарц буурсан нь орцын зарцуулалт үр ашиггүй, оновчгүй байсныг нотолж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын эрүүл мэндийн салбарын бүтээмжийг үйл ажиллагааны нэг чиглэл буюу хэвтэн эмчлүүлэгчдийн тоо болон зардлыг ашиглан, салбарын онцлогт тохируулан олон улсад ашиглаж буй орчин үеийн арга зүйгээр хэмжих боломжтойг судалгааны үр дүн нотолж байна.

Бүтээмжийг хэмжихдээ зөвхөн тоон үзүүлэлтийн харьцаанаас гадна, чанарын үзүүлэлтээр хэмжих нь бүтээмжийн хэмжилтийг илүү нарийвчлалтай, бодитой тооцдогыг судалгааны үр дүн нотолсон нь энэ судалгааны ач холбогдлыг нэмэгдүүлж байна.

Тоон өгөгдлийн тасралтгүй, найдвартай байдал нь судалгааны явцад туларсан гол асуудал байв. Тиймээс цаашид эрүүл мэндийн салбарын бүтээмжийг одоогийнхоос илүү олон үзүүлэлтээр, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргаар тооцоолохын тулд тоон өгөгдөл, мэдээллийн баазыг сайжруулах, статистикийн өгөгдлийн чанар, тасралтгүй байдал, цар хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- A.Ghobadian & T.Husband. (1990). Measuring Total Productivity using Production Functions. *International Journal of Production Research*, 1435.
- Bradley, R. (2013). Feasible methods to estimate disease based price indexes. *Journal of Health Economics*, 32(3), 504-514.
- C. Ammer and Ammer D.S. (1984). *Dictionary of Business and Economics*. Macmillan.
- C.Schultze C.Mackie. (2002). *At What Price?: Conceptualizing and Measuring Cost-of-Living and Price Indexes*. Washington, D.C: National Academies Press.
- Chew, W. B. (1986). Productivity and Change: The Short-Term Effects of Investment on Factory Level Productivity. *Harvard University, PhD dissertation thesis, University Microfilms International*, , 161.
- Craig C.E and Harris C.R. (1973). *Total Productivity*.
- Diane Dawson, Huge Gravelle, et all. (2005). *Developing new approaches to measuring NHS outputs and productivity*. Centre for Health Economics, University of York.
- Dunn, A. Eli L., Sarah P., A.H. Shapiro. (2013). Medical Care Price Indexes for Patients with Employer-Provided Insurance: Nationally Representative Estimates from MarketScan Data. *Health Services Research*, 48(3), 1173-1190.
- el, Rosen A. Cutler D. at. (2017). Strengthening national data to better measure what we are buying in health care: reconciling national health expenditures with detailed survey data. *NBER*.
- Fenton, E. H. (1985). Company Productivity Measurement and Usage in Theory and Practice. *Pace University, PhD dissertation thesis, University Microfilms International*, 296 .
- Grunberg, T. (2004). Performance Improvement towards a Method for Finding and Prioritizing Potential Performance Improvement Areas in Manufacturing Operations. *International Journal of Productivity and Performance Management*, 53(1), 52-71.
- Malinovskaya A, Sheiner L. (2016). Measuring productivity in healthcare: an analysis of the literature. *Hutchins Center on Fiscal and Monetary Policy at Brookings*, 4.
- Mohanty, R. P. & Rastogi, S. C. . (1986). An Action Research Approach to Productivity Measurement . *International Journal of Operations & Production Management*, 6(2) , 47 - 61.
- OECD. (2001). Measuring Productivity. *OECD Manual*, 25-65.
- Schreyer, P Matilde M . (2013). An International Perspective.” In Measuring and Modeling Health Care Costs. *Measuring Health Services in the National Accounts*.-Д University of Chicago Press.
- Schreyer, P. (2010). Towards Measuring the Volume Output of Education and Health Services. *OECD Statistics Working Papers 2010/02*.
- Singh, H., Motwani, J. and Kumar, A. . (2000). A review and analysis of the state-of-the-art research on productivity measurement. *Industrial Management and Data Systems* 100(5), 234-41.
- Statistics, O. f. (2012). *Quality adjustment of public service output: current method*. London: Office for National Statistics.
- Sumanth, D. (1984). *Productivity Engineering and Management*. New York: McGraw-Hill Book.
- Susan, H. W. (2007). Outsourcing, Offshoring, and Productivity Measurement in U.S. Manufacturing. . *International Labour Review*, 146(1-2), 61-80.
- Tangen, S. (2005). Demystifying productivity and performance. *International Journal of Productivity and Performance Management* 54(1), 34-46.
- Triplett, Jack E. (2011). Health System Productivity. *Oxford Handbook of Health Economic* (хуудсд. 707-32).-Д New York: Oxford University Press.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ БА ГҮЙЦЭТГЭЛД МЭДЛЭГ ХУВААЛЦАХ ХҮСЭЛ, БАЙГУУЛЛАГЫН ИРГЭНШЛИЙН ЗАН ТӨЛӨВИЙН НӨЛӨӨЛӨЛ

Ц.Азбаяр

Магистр (МВА), Хан Голомт Консалтинг



Түлхүүр үг:

Суралцагч байгууллагын соёл, мэдлэг хуваалцах, байгууллагын иргэншлийн зан төлөв, байгууллагын гүйцэтгэл

Хураангуй

Хүчтэй суралцагч байгууллагын соёл нь бизнесийн амжилтыг хадгалах зайлиггүй нөхцөл юм. Ажилчдад мэдлэг олж авах, хуваалцах боломжийг олгодог соёлыг бий болгох нь эцэстээ шинэ санаа, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх шинэлэг арга зам болдог.

Энэхүү судалгаагаар суралцагч байгууллагын соёл нь байгууллагын гүйцэтгэлтэй холбоотой талаарх ном зохиолуудыг судалж, мэдлэг хуваалцах хүсэл болон байгууллагын иргэншлийн зан төлөв нь үүнд хэрхэн нөлөөлдөг талаар цаашидын судалгаанд чиглэл өгөхөд шаардлагатай дутагдаж буй мэдлэгийг тодруулахыг эрэлхийлсэн.

Энэхүү судалгаа нь байгууллагын соёл, суралцагч байгууллага, түүний соёл, мэдлэгийн менежмент, мэдлэг хуваалцах хүсэл, байгууллагын иргэншлийн зан төлвийн талаархи үзэл баримтлал, онолын ном зохиолуудыг тоймлон авч үзэхэд чиглэв.

Оршил:

Аж үйлдвэрийн 4-р хувьсгал, дижитал шилжилт нь бизнесийн ертөнцийг үндсээр өөрчилж, дэлхийн эдийн засгийн чиг хандлага аж үйлдвэрлэлд чиглэсэн хүрэн эдийн засгаас мэдлэгт суурилсан ногоон эдийн засаг руу шилжиж байна.

Өнөө үед мэдлэгээ хуваалцах зан төлвийг төлөвшүүлэх нь байгууллагын иргэншлийн зан төлөвт гол үүрэг гүйцэтгэх төдийгүй, суралцагч байгууллагын соёл ба гүйцэтгэлд гол ач холбогдол бүхий хүчин зүйлс хэмээн үзэж байна.

Байгууллагын мэдлэг нь өрсөлдөөний давуу талын гол эх үүсвэр гэдгийг онолчид, практик дээр ч улам бүр баталж байгаа тул байгууллагууд мэдлэгийн менежментийг эрэлхийлсээр байна (De Long & Fahey, 2000). Мөн хувь хүмүүсийн эзэмшсэн мэдлэгийг бусадтай хуваалцахаас нааш байгууллагын мэдлэг болгон хувиргах боломжгүй гэсэн таамаглал дээр

үндэслэн сүүлийн 20 жилийн хугацаанд мэдлэг хуваалцах нь ихээхэн анхаарал татаж байна. Мэдлэг хуваалцах нь тухайн байгууллагын нийгмийн капиталын хуримтлалын үзүүлэлт гэж ойлгогддог, учир нь тухайн байгууллагын нэг гишүүний эзэмшсэн мэдлэгийг нийгмийн капитал хангалттай байгаа тохиолдолд хялбар, үр дүнтэй хуваалцах боломжтой байдаг (Collins & Hitt, 2006).

Бизнесийн тогтворгүй орчинд тэсэж үлдэхэд туслах нэг гол хүчин зүйл бол суралцагч байгууллагын соёл бөгөөд энэхүү сэдэв нь сүүлийн жилүүдэд олон судлаачдын анхаарлыг татаж байна.

Нам, Парк (2019)-ийн хэлснээр суралцагч байгууллага гэдэг нь шинэ мэдлэг, ойлголтыг тусгахын тулд мэдлэгийг бий болгох, олж авах, шилжүүлэх, түүнчлэн зан төлвөө өөрчлөх чадвартай байгууллагыг хэлнэ. Суралцагч байгууллагууд мэдлэгийг ур чадвар болгон хувиргах, өөрийгөө байнга өөрчлөхийн тулд санал санаачлагуудыг хүлээн авч ашигладаг (Гула нар, 2021).

Суралцагч байгууллагын соёлын тухай нэр томъёоны тодорхойлолт нь судлаачдын хувьд харилцан адилгүй байдаг. Зарим эрдэмтэд үүнийг нийтлэг үнэт зүйлс, хэм хэмжээ, итгэл үнэмшил гэж үздэг бол зарим нь бүрэн тайлбар нь зан төлөв, багаар ажиллах зэрэг олон янзын хэмжигдэхүүнийг багтаасан байх ёстой гэж үздэг. Тиймээс байгууллагын соёлыг ойлгож, түүний компанийн гүйцэтгэлтэй уялдаа холбоог тогтоохын тулд илүү их судалгаа хийх шаардлагатай. Цаашилбал, бусад хувьсагчид нь энэ харилцааг зуучилж, зохицуулах боломжтой байж болно (Mahmood & Iqbal, 2021).

Иймээс мэдлэг хуваалцах хүсэл болон байгууллагын иргэншлийн зан төлөв нь байгууллагын соёл ба гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөх талаар онцлон авч үзлээ.

Эцсийн зорилго нь ирээдүйн эмпирик судалгаанд гарын авлага болох судалгааны загварыг боловсруулах явдал юм.

Тодруулбал, судалгааны гол асуулт бол:

- Суралцагч байгууллагын соёл ба гүйцэтгэл нь байгууллагын иргэншлийн зан төлөв болон ажилтнуудын мэдлэг хуваалцах хүсэлтэй ямар холбоотой вэ?

Онолын хүрээ ба таамаглал

- Суралцагч байгууллагын соёл, мэдлэг хуваалцах, байгууллагын иргэншлийн зан төлөв зэрэг ойлголтууд болон эдгээр бүтцийн хоорондын харилцааг авч үзсэн болно. Мэдлэг хуваалцах үйл явцыг хөнгөвчлөх эсвэл саад болж буй чухал хүчин зүйлсийг илрүүлэхийг оролдсон.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь:

Суралцагч байгууллагын соёл, Мэдлэг хуваалцах хүсэл, байгууллагын иргэншлийн зан төлвийг онолын түвшинд судлах бөгөөд эрдэмтэн судлаачдын энэ чиглэлийн бүтээлүүдтэй танилцаж, хүлээн зөвшөөрөгдсөн загварууд дээр үндэслэсэн судалгааны зураглал гаргах хэлбэрээр бичигдсэн болно.

I. СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БА СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ

Суралцагч байгууллага болохыг эрмэлзэж буй байгууллагууд нь байгууллагын хэмжээнд суралцах практикийг хөнгөвчлөхийн тулд зохих шинж чанаруудыг хөгжүүлэх хэрэгтэй.

- Суралцагч байгууллага нь урт хугацааны үр ашгийн төлөө чадвараа тасралтгүй хөгжүүлэх чадвартай байгууллага юм (Сэнгэ, 1990).
- Суралцагч байгууллагын соёлыг аливаа байгууллагын үйл ажиллагааг сайжруулж чадах арга хэрэгсэл гэж тодорхойлсон. Педлер, Бургойн, Бойделл нар (1997)
- Суралцагч байгууллагын үзэл баримтлал бол байнгын сайжруулалт хийж, тасралтгүй сурч хөгжиж, өөрийгөө өөрчлөх чадвараар тодорхойлогддог байгууллага юм. Марсик (1993), Ян, Уоткинс, Марсик (2004)


Эдгээр тодорхололтуудад тусгагдсан нийтлэг 3 ойлголт нь:

- 1) Орчны өөрчлөлтийг ойлгож, хариу үйлдэл үзүүлэх замаар ажилладаг
- 2) Илүү уян хатан, шинэлэг, илүү оролцоотой ажлын орчинг бүрдүүлэх
- 3) Тасралтгүй сурч, хөгжих чадвартай байгууллага юм байна.

Уоткинс ба Марсик (1997)-ийн суралцагч байгууллагын тогтолцоо:

Суралцагч байгууллагын хэмжүүрийн асуулгын (DLOQ) хэрэглүүр нь байгууллагын бүтцийн түвшин ба хүмүүсийн хамтын суралцах түвшин гэсэн хоёр түвшний динамик сургалтын үйл явцыг дэмжих суралцагч байгууллагуудын эерэг шинж чанар, соёлын талуудыг агуулдаг (Song, Joo, & Chermack, 2009). DLOQ-ийн дэд хэмжигдэхүүнүүд нь суралцагч байгууллагын долоон үндсэн шинж чанарыг харуулдаг: **1) Тасралтгүй суралцах:** Боловсрол, өсөлт хөгжлийг хангах боломжийг бүрдүүлэх; Хүмүүс ажил дээрээ суралцах боломжтой байхын тулд сургалт зохион байгуулдаг. **2) Харилцан яриа ба судалгаа:** Байгууллагын соёл нь асуулт, санал хүсэлт, туршилтыг дэмждэг; Хүмүүс өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, бусдын санаа бодлыг сонсох, асуух, өөрийгөө илэрхийлэх ур чадвар эзэмшдэг. **3) Багаар суралцах:** Ажил нь баг бүлгийн сэтгэлгээний янз бүрийн хэлбэрт нэвтрэхийг уриалахад чиглэгдсэн бөгөөд бүлгүүд хамтран суралцаж, хамтран ажиллах, хамтын ажиллагааг үнэлж урамшуулах **4) Систем бүтээх:** Суралцах, хуваалцах шаардлагатай системийг бий болгох, хадгалах, ажилтай нь нэгтгэх; ажилтнууд эдгээр өндөр, бага технологийн системд нэвтрэх. **5) Хүмүүст эрх мэдэл өгөх:** Хүмүүс хамтын алсын харааг бий болгох, хэрэгжүүлэхэд оролцдог; хариуцлага нь шийдвэр гаргахтай хамт хуваарилагддаг тул хүмүүс өөрсдөө хариуцлага хүлээх зүйлээ сурч мэдэх хүсэл эрмэлзэлтэй байдаг **6) Системийн холболт:** Хүмүүс ажлынхаа үр дүнг байгууллагад бүхэлд нь нөлөөлж, системтэй сэтгэхэд нь тусалдаг. Хүмүүс хүрээлэн буй орчныг судалж, ажлын дадлыг тохируулахын тулд мэдээллийг ашигладаг; байгууллага нь олон нийттэйгээ холбоотой байдаг **7) Стратегийн манлайлал:** Манлайлал нь бизнесийн үр дүнд суралцах, удирдах загварчлах, аварга болох, суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор стратегийн аргаар суралцдаг.


Суралцагч байгууллагын соёл



Gerald Kanyango Githuku, Godfrey Kinyua, PhD, Anne Muchemi, PhD (2022)-ийн суралцагч байгууллагын соёл ба байгууллагын гүйцэтгэлийн загвар нь 1) Ажилтнуудыг чадавхижуулах /Нөөцөө хянах боломжийг олгох, Тооцоолсон эрсдэлийг дэмжих, Үүрэг хариуцлагыг хуваарилах, Алсын хараанд оруулж буй хувь нэмэр, Санал санаачлагыг хүлээн зөвшөөрөх/ 2) Асуулга / харилцан яриа /Бусдын үзэл бодлыг сонсох, Нээлттэй санал хүсэлт өгөх, Бие биедээ хүндэтгэлтэй хандах, Итгэлцлийг бий болгох/ 3) Тасралтгүй суралцах /Ур чадвараа тодорхойлох, Бие биенээ суралцахад туслах, Суралцахыг дэмжих эх сурвалж, Асуудлыг суралцах боломж гэж үзэх, Суралцсаны төлөө шагнуулах 4) Хамтран суралцах / мэдлэг хуваалцах систем /Хэмжилтийн системийг бий болгох, Сурсан мэдсэнээ хүртээмжтэй болгох, Сургалтын үр дүнг хэмжих, Глобал хэтийн төлвийг дэмжих, Олон талын хэтийн төлвийг дэмжих 5) Хамтран ажиллах, багаар суралцах /Мэдээ мэдээлэлтэй сэтгэн бодох, дахин боловсруулах, Туршлага хуваалцах, Зорилгодоо дасан зохицох эрх чөлөө, Бүлгийн ажилд анхаарлаа төвлөрүүлэх, Амжилттай багуудыг урамшуулах, Мэдээлэл хуваалцах/

Байгууллагын гүйцэтгэлийг дараахь хүчин зүйлсээр хэмжсэн байна. /Санхүүгийн хэтийн төлөв, Хэрэглэгчийн хэтийн төлөв, Бизнесийн дотоод процесс, Суралцах ба өсөлт хөгжил/

Суралцагч байгууллагын соёл



II. МЭДЛЭГИЙН МЕНЕЖМЕНТ БА МЭДЛЭГ ХУВААЛЦАХ ХҮСЭЛ

2.1 Мэдлэгийн менежмент

Мэдлэгт түшиглэсэн эдийн засаг нь мэдлэгийн шингээц ихтэй, бүтээгдэхүүн үйлчилгээ асар хурдтай шинэчлэгддэг гэдгээрээ капитал, хүний нөөцөд голлон түшиж ирсэн уламжлалт эдийн засгаас ялгаатай.

Өдгөө байгууллагуудын нийт хөрөнгийн 70 гаруй хувь нь мэдлэг гэсэн биет бус хөрөнгөөс бүрдэж байгаа (Kulkarni, U., & Freeze, R., 2005) бөгөөд байгууллагууд бүтээгдэхүүн, үйлчилгээ болгондоо мэдлэгийн капиталыг шингээж, үнэ цэнийг бүтээх замаар хэрэглэгчдийн хүсэл сонирхолд нийцүүлж, өрсөлдөх чадвартай болгож байна. Энэ нь хэрэглэгч бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг байгууллагын мэдлэгийн хамт худалдаж авдаг гэсэн үг юм (Brian Lehane et al, 2004).

Т.Давенпорт, Л.Прусак (1998) нар “Өрсөлдөгчид шинэ бүтээгдэхүүнийг амархан хуулбарладаг тул давуу байдлыг тогтвортой хадгалах нь улам бэрхшээлтэй болж байна. Ийм нөхцөлд ажлын байран дахь мэдлэг л давуу байдлыг тогтвортой бий болгож чадна... Мэдлэгээр баялаг бүтээж, мэдлэгийг удирддаг байгууллага л чанар, бүтээлч байдал, үр ашгийн шинэ түвшинд хүрнэ” гэж үздэг. Иймд байгууллагын мэдлэг нь “үнэ цэнийг бий болгоход байгууллагад зайлшгүй хэрэгтэй түүний онцлог нөөц, хөрөнгийн нэг” (Nonaka, I., Toyama, R., & Konno, N., 2000) юм.

Байгууллагын мэдлэгийн менежментийн онолоор үйлдвэрлэлд мэдлэгийг газар, хөдөлмөр, капиталас илүү ач холбогдол бүхий хөгжлийн гол уг сурвалж гэж үздэг (Drucker, 1993; Kogut, B. & Zander, U., 1992; Nonaka, I, 1991; Prahalad, C.K. & Hamel, G., 1990; Spender, 1996; Шумпетер).

Хүн төрөлхтөн өөрийн тархины потенциалыг бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүйн адил байгууллагууд ч мөн өөрт байгаа мэдлэгийг бүрэн ашиглаж чаддаггүй байна. Тиймээс байгууллагууд гүйцэтгэлээ сайжруулахын тулд хэрэгцээт мэдлэгийг бий болгох, эзэмших, шаардлагатай үед бусад хүмүүс авч ашиглах боломжтой газар хадгалах зэргээр мэдлэгийн менежментийг хэрэгжүүлдэг байна (King, 2008).

Мэдлэгийн менежмент нь маш энгийнээр хэлбэл далд мэдлэгийг ил болгон, түүнийг байгууллага дотроо хуваалцах гэж тайлбарлаж болох юм.

Мэдлэгийн менежментэд хүнийг удирдах, мэдээллийг удирдах гэсэн хоёр хүчин зүйлийг хамруулдаг. Энэ утгаараа нэг талаас хүнийг, нөгөө талдаа мэдээллийг удирдах ухаан гэж үзэж болох юм.

Байгууллагын мэдлэгийн менежмент нь мэдлэг чадвар, сэтгэл зүтгэлийн аль алиныг нь дэмждэгээрээ байгууллагад чухал ач холбогдолтой. Ажиллагчдын мэдлэг ажил, мэргэжлийн ноу-хау, туршлага, бүтээмж, тасралтгүй суралцах чадварт төвлөрдөг тул байгууллагын мэдлэгийн менежмент нь хүний нөөцийн менежмент ба суралцагч байгууллагын онолыг дэмждэг (Brian Lahaney et al, 2004).

Мэдлэгийн менежментийн үйл явцын цикл

Мэдлэгийн менежментийн үйл явцын циклийн загварыг янз бүрээр тайлбарласан байдаг ба Davenport and Pursak-ийн (2000) гурван үе шаттай загвар болох “Бүтээх, Кодчлох/ Зохицуулах, Дамжуулах”, (Ward, Aurum, 2004) гаргасан долоон үе шаттай загвар (“Бүтээх, Эзэмших, Тодруулах, Суурьшуулах, Зохион байгуулах, Түгээх, Хэрэглэх), АСЕАН-ы сангийн дөрвөн үе шаттай буюу элементтэй гэж үзсэн загваруудыг тус тус дурдаж болох юм. Эдгээрээс АСЕАН-ы сангаас тодорхойлсон загварыг сонгоё.

Мэдлэгийн менежментийн цогц систем дараах 4 элементийг агуулж байх ёстой:

- Мэдлэгийг бүтээх, эзэмших
- Мэдлэгийг хуваалцах, баяжуулах
- Мэдээллийг хадгалах, эргэн сэргээх
- Мэдлэгийг түгээх

Мэдлэгийг хуваалцах болон баяжуулах: Мэдлэгийн менежментийн хоёр дахь элемент нь бөгөөд энэ нь уг дөрвөн элементээс хамгийн чухал ач холбогдолтой нь болно.

Мэдлэгийг дараах байдлаар хуваалцаж болдог:

- Байгууллага ажилтнууддаа мэдлэгийг хуваалцах (санамж, зааварчилгаа зэргээр дамжуулж)
- Байгууллагын ажилтнууд хоорондоо мэдлэгээ хуваалцах (групп хэлэлцүүлэг, дотоод хурал зэргээр дамжуулж)
- Гадны байгууллагын хүмүүстэй мэдлэгээ хуваалцах (семинар, сургалт зэрэгт оролцож)

Байгууллага дотор явагддаг их хэмжээний мэдлэг хуваалцах процессийн дүнд байгууллагын өрсөлдөөнд давуу байх чадвар нэмэгддэг ч мэдлэг хуваалцах процессийг урамшуулж, дэмжихгүйгээр өөрөө автоматаар явагддаг үйл явц биш юм. Тиймээс мэдлэгээ хуваалцдаг уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд байгууллага дотроо зөв соёлыг бүрдүүлэх, харилцаа холбоог бий болгох хэрэгтэй. Хүн өөрийн мэдлэгээ бусадтай хуваалцаснаар өөрийн байгууллага дахь үнэ цэнээ алдах вий гэсэн айдас, нөгөө талаас одоо миний гаргаж буй бүтээмж хангалттай учир бусдаас суралцах шаардлагагүй гэж бодох бодол байдаг тул байгууллагадаа мэдлэгийн менежментийн систем бүрдүүлэхдээ энэ талаар анхаарах нь зүй.

К.Вонг, Аспинвол нар (2005) мэдлэгийн менежментэд нөлөөлдөг хүчин зүйлсэд төвлөрсөн онолын ба эмпирик судалгаануудыг хянан шүүж, нийтлэг байгаа хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг тус салбарын эрдэмтэд ба практик хэрэгжүүлэгчдээр үнэлүүлж, зэрэглүүлсэн. Тэд судалгаандаа түшиглэн байгууллагын мэдлэгийн менежментэд чиглэсэн: 1) удирдлагын манлайлал ба дэмжлэг, 2) **байгууллагын соёл**, 3) мэдээллийн технологи, 4) стратеги, 5) мотивац, 6) хэмжилт, 7) байгууллагын дэд бүтэц, 8) нөөцүүдийн хүртээмж, 9) сургалт боловсрол, 10) хүний нөөцийн менежмент зэрэг байгууллагын дотоод орчны хүчин зүйлс мэдлэгийн үр дүнтэй менежмент, хүчин чармайлтуудад нөлөөлөх нь нийтлэг байгаа тул тэдгээрийг бүх төрлийн байгууллагад хэрэглэхийг санал болгосон байна.

Байгууллагын соёлын зэрэг ба сөрөг нөлөөлөл: Байгууллагын соёлын бүх хэв маягууд амжилтанд хөтөлж чадахаас (Д.Ганбаатар нар, 2017) гадна бас аливаа өөрчлөлт сайжруулалтын саад бэрхшээлийн гол хүчин зүйл болдог. Байгууллагын мэдлэгийн менежментийг сорилттой болгосон шалтгаануудыг хайсан бүх судалгаанууд (жишээ нь, KPMG Consulting, 2000; Barth 2000) байгууллагын соёлыг “мэдлэгийн менежментийг үр дүнгийн гол саад бэрхшээл буюу чухал урьдчилсан нөхцөл мөн” гэсэн нэг дүгнэлтэнд хүрчээ. Байгууллагын дотоод соёлд мэдлэгт түшиглэсэн тогтолцоог нэвтрүүлж, мэдлэгийг үр дүнтэй удирдахад тулгарч буй гол саад бэрхшээлүүдийг арилгаж, удирдах ажилтнууд ба ажилтнуудын зан төлвийг өөрчлөх шаардлагатай байдгийг байгууллагын мэдлэгийн менежментийг хэрэгжүүлсэн байгууллагуудын удирдах ажилтан, ажилтнууд онцлон тэмдэглэж байгааг олон судалгаанууд илрүүлжээ.

2.2 Мэдлэг хуваалцах үйл явц

Мэдлэг хуваалцах гэдэг нь мэдлэг буюу ур чадвар, туршлага, ойлголтоо бусадтай солилцох гэсэн үг юм (Lyly Tsui, 2006).

Ямар нэгэн саадгүйгээр мэдлэгийг хамтдаа суралцаж эзэмших, хоорондоо хуваалцсанаар ажилтнууд ажлаа илүү хялбар гүйцэтгэх боломжтой болдог нь мэдээлэл хуваалцах урсгалыг бий болгосны нэг илрэл юм (O Dell, 2011).

Мэдлэг хуваалцах үйл явцын үе шат

Байгууллагын мэдлэг хуваалцах процессийг хэд хэдэн үе шатад хувааж үздэг. (Gephart, Marsick, Van Buren, Spiro 1996) нар байгууллага мэдлэг хуваалцах бүх үе шатыг дамжсан тохиолдолд мэдлэг хуваалцах үйл явц нь зорилтот бус, хувь хүнээс хамааралтай, цогц бус байдлаас албан ёсны, илүү өргөн цар хүрээг хамарсан, уялдаа холбоотой болж өөрчлөгдөх төдийгүй хамтач чанартай, маш сайн уялдаа холбоотой, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болдог аж.

Мэдлэг хуваалцах үе шат нь: 1) Тодорхой бус, 2) Мэдлэгийн сан бүрдүүлэх, 3) Мэдлэгийг баримжаалах, 4) Хамтарч ажиллах, 5) Байгууллагын суралцах

Мэдлэг хуваалцахыг дэмждэг нөхцлүүд

Мэдлэг хуваалцахад хүн хоорондын нийгмийн харилцаа, байгууллагын холбогдолтой аливаа асуудлаас ирэх үр нөлөө, мэдээлэл харилцааны техник технологи зэрэг нь чухал нөлөөтэй (Brink, 2001) ба тэдгээр нь мэдлэг хуваалцахад нөлөөлөгч хүчин зүйлс юм.

Мэдлэгээ хуваалцахад нөлөөлөгч гол хүчин зүйлс

- Хүмүүс
- Технологи
- Байгууллага

Мэдлэг хуваалцах соёлын тухай ойлголт

Байгууллагын мэдлэг, мэдлэгийн нөөцөд тухайн байгууллагын хуримтлуулсан ил мэдлэгээс гадна ажилтнуудынх нь далд мэдлэг мөн ордог. Далд мэдлэг нь байгууллагын өрсөлдөх чадварт эерэгээр нөлөөлдөг ч тухайн ажилтан ажлаасаа гарлаа гэхэд уг ажилтанд байсан үнэ цэнэ бүхий далд мэдлэг алдагдах эрсдэл байдаг тул мэдлэг хуваалцах соёлыг байгууллагадаа төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой. Байгууллага дахь оюуны капиталын ач холбогдол, мэдлэгийн менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага улам бүр өсч байгаа учир мэдлэг хуваалцах соёлын тухай ойлголт чухлаар тавигдаж байна (Gupta, 2000).

Мэдлэг хуваалцдаг байхын тулд технологийн хүчин зүйлээс гадна хамгийн чухал нь мэдлэг хуваалцах соёлыг бүрдүүлэх явдал юм (Thompson, Rohit, Mark, Sameer, 2011).

Мэдлэг хуваалцах соёлыг бий болгоно гэдэг нь мэдлэг хуваалцах үйл явцыг хэвшил болгоно гэсэн үг юм. Мэдлэгээ хуваалцдаг соёлыг бий болгохын тулд хүмүүсийг илүү их үр дүнтэйгээр хамтарч ажиллах, байгууллагын мэдлэгийг илүү үр өгөөжтэй болгох үүднээс мэдлэгээ хуваалцахыг тус тус дэмжих хэрэгтэй.

Мэдлэгээ хуваалцахыг идэвхжүүлэх нь хүмүүсийг мэдлэгээ хуваалцах сонирхолтой болгох явдал юм. Өмнө нь “Мэдлэг бол хүч” гэсэн парадигм үйлчилдэг байсан бол өнөө үед “Мэдлэгээ хуваалцах нь хүч” гэж ойлгох хэрэгтэй болж байна. Хэрэв хүмүүс мэдлэгээ хуваалцах нь ажлаа илүү үр дүнтэй хийхэд, ажлын байраа хадгалахад, хувийн хөгжил болон карьер өсөхөд нь тусалдаг төдийгүй хийсэн зүйлсийнх нь төлөө шагнаж урамшуулдаг, өөрийгөө бусдад харуулах, таниулах боломж гэж ойлгодог болбол мэдлэгээ хуваалцах нь бодит байдлаар хэрэгжиж эхэлнэ.

Мэдлэг хуваалцах соёлыг бий болгоход нөлөөлдөг хүчин зүйлст

- хүний (нийгмийн),
- байгууллагын (удирдлагын),
- техникийн гэсэн хүчин зүйлс ордог.

Эдгээрийн харилцан уялдаан дунд мэдлэг хуваалцах таатай орчин бүрддэг.

Мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэхэд нэг чухал хэсэг нь мэдлэг хуваалцах соёлыг бүрдүүлэх явдал юм.

Мэдлэг хуваалцах соёлыг хэмжих тухай

Мэдлэг хуваалцах соёлыг дөнгөж бүрэлдэж байгаагаас бүрэн төлөвшсөн хүртэл нийт таван шкалаар үнэлсэн Robert Hoss, Art Schlüssel нарын загвар байдаг.

Мэдлэгийн менежментийн соёл дөнгөж бүрэлдэж байгаа			Мэдлэгийн менежментийн соёл бүрэн төлөвшсөн		
Мэдлэгээ маш бага хуваалцдаг. Мэдлэгтэй байх нь өөрөө хүч, эрх мэдлийг дагуулдаг тул бусадтай хуваалцах нь миний ажил /рейтинг/ цалинд муугаар нөлөөлнө. Байгууллага дотор хамтын ажиллагаа гэж бараг байдаггүй. Ихэнх ажилтнууд ганцаарчилж ажилладаг бөгөөд үүнийг нь байгууллагаас дэмжиж урамшуулдаг.			Ажилтнууд сурсан мэдсэн, хийсэн бүтээснээ бусадтай байнга хуваалцдаг. Тэд үргэлж "Үүнийг өөр хэн мэдэх хэрэгтэй вэ?" гэж асуудаг. Мэдлэгийн менежментийн мэдлэгээ хуваалцах соёл, орчин байгууллагад бүрэлдсэн бөгөөд ажлын гүйцэтгэлийн нэг үзүүлэлт болдог. Хамтран ажиллах, мэдлэгээ дамжуулах, мэдлэг алдагдахаас сэргийлэх зэрэг нь хүн бүрийн хариуцлага гэсэн ойлголт байдаг тул мэдлэгээ хуваалцахыг дэмждэг, шагнаж урамшуулдаг.		
1	2	3	4	5	Жин:
Хэмжүүр: Байгууллага <ul style="list-style-type: none"> • Мэдлэг хуваалцахыг дэмжсэн суралцах орчин бүрдсэн эсэх • Удирдлагын дэмжлэг, манлайлал байгаа эсэх Хүмүүс <ul style="list-style-type: none"> • Мэдлэгээ хуваалцдаг ажилтнуудын эзлэх хувь Мэдээллийн технологи <ul style="list-style-type: none"> • Технологийн нэвтэрсэн байдал ба түүний хэрэглээ 					

III. БАЙГУУЛЛАГЫН ИРГЭНШЛИЙН ЗАН ТӨЛӨВ

Байгууллагын иргэншлийн зан төлөв чухал ач холбогдолтой болохыг анх гаргаж ирсэн хүн бол Katz юм. Тэрээр анх 1964 онд ажилтнуудын сайн дурын, ажлыг шинэ арга барилаар гүйцэтгэх санаачлагын байгууллагад үзүүлэх эерэг нөлөөний талаар онцолж байжээ. Хожим 1983 онд С. А. Smitt, Organ, Near нарын эрдэмтэд ажилтнуудын иймэрхүү төрлийн зан төлвүүдийг байгууллагын иргэншлийн зан төлвүүд гэж нэрлэсэн байна.

Иргэншлийн зан төлвүүд нь 2 талт харилцаа үүсэх замыг нээж өгдөг. Учир нь иргэншлийн зан төлвүүд нь ажил үүргийн хуваарь болон албан ёсны нөхөн олговрын системд тусгагдаагүй хувь хүний сайн дурын үйлдэл байдлаар илэрдэг (Organ 1988) бөгөөд

удирдлагатайгаа сайн харилцаатай ажилтнууд иргэншлийн зан төлөв гаргах замаар хариу барьдаг гэж үздэг байна. Ажилтны зүгээс илрэх иргэншлийн зан төлөв нь зөвхөн удирдагчид төдийгүй ажлын байран дахь бусад хүмүүст ч бас ашиг тусаа өгдөг байна. (Liden et al., 1997; Settoon, Bennet & Liden, 1996)

Katz-ын 1964 онд суурийг нь тавьсан БИЗТ-ийн судалгааг цааш цогц хэлбэрээр баяжуулан хөгжүүлсэн хүн бол Dennis Organ юм. Ийм ч учраас түүнийг БИЗТ-ийг үндэслэгч нь гэж үздэг. Organ-ы 1988 онд тодорхойлсноор БИЗТ гэдэг нь “Байгууллагын албан ёсны нөхөн олговрын системд шууд буюу тодорхой байдлаар тусгагдаагүй боловч байгууллагын нийт гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг хувь хүний сайн дурын зан авир” юм.

БИЗТ-ийн талаар өгсөн Organ-ы тодорхойлолт нь энэхүү конструкцын 3 гол бүрэлдэхүүнийг тодорхойлж өгсөн байна. Үүнд:

- 1) БИЗТ нь ажилтан хүн хэний ч шахалт шаардлагагүй үйлддэг, ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй сайн дурын үйлдэл юм.
- 2) БИЗТ нь ажлын байрны тодорхойлолтод заасан хийвэл зохих үүргүүдээс цааш хальж гардаг.
- 3) БИЗТ нь байгууллагын нийт гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг.

1997 онд Organ “Гүйцэтгэлийн харилцаа”-ны онолд тулгуурлан БИЗТ-т утгад өөрчлөлт оруулсан. Organ БИЗТ-ийг шинээр тодорхойлохдоо, “туслалцааг дэмжих, гүйцэтгэлийн түвшинг сайжруулах нийгмийн болон сэтгэлзүйн зан төлөв” гэжээ. Энэ тодорхойлсон байдал нь олон судлаачдад хүлээн зөвшөөрөгджээ.

Байгууллага үүсгэн байгуулагдаад оршин тогтохтой холбоотой хамгийн шаардлагатай хүчин зүйлсийг үүргийн хувьд байгууллагын ажилтнууд ажил гүйцэтгэхэд зайлшгүй хийх даалгаврын дагуу үйлдэл болон даалгавраас гадуурх үйлдэл гэж ангилдаг (Williams & Anderson, 1991).

БИЗТ-ийн хэмжээсүүд:

БИЗТ-ийг томъёологчид нь энэ конструкцыг бүр анхнаасаа л олон хэмжээстэй гэж үзсэн байдаг. Smith, Organ, Near нар анх 1983 онд БИЗТ-ийг хэмжихийн тулд нүнжиг (altruism) буюу бусдад туслах сэтгэл болон general compliance буюу нийцэл гэсэн 2 хэмжээсийг санал болгосон байна. Энэ 2 хэмжээс нь байгууллагын үр ашигт байдлыг дээшлүүлэхэд янз бүрээр нөлөөлдөг байна.

Нүнжиг (Altruism) нь ажлын байран дахь бусдад туслах зан төлвүүдээс тогтдог. Эдгээр зан төлвүүдийг байгууллагын дотор болон байгууллагаас гадуур чиглүүлж болдог. Нүнжиг (altruism)-ийн хүрээнд багтах зан төлөв бүр байгууллагад ямар нэг онцгой ашиг болж бууна гэсэн шууд холбоо байхгүй. Үндсэн санаа нь, цаг хугацаа өнгөрөхийн хирээр ажилтнуудын бусаддаа туслах үйлдлүүд нь нийлээд байгууллагын тусын тулд л үйлчилнэ гэдэгт оршино. (Organ et al., 2006).

Нийцэл (general compliance)-ийн хүрээний зан төлвүүд нь байгууллагад олон янзаар ашиг тусаа өгдөг. Ажил таслалт буурч, дүрэм журмын биелэлт сайжирснаар байгууллагын үр ашигтай ажиллах нөхцөлийг хангаж өгдөг. Нийцтэй ажилтан хэрээс хэтэрсэн завсарлага

авах, ажлын цагаар хувийн ажлаа хийх зэрэг үйлдэл гаргадаггүй. Иймэрхүү зан авир буурснаар ажиллах хүчний бүтээмж нэмэгддэг.

Хожим 1988 онд Organ general compliance гэдэг хэмжээсийг задалж БИЗТ-т өөр хэмжээсүүдийг нэмж оруулсан байна. Ингэснээр БИЗТ нь **нүнжиг (altruism)**, **анхаарамж (courtesy)**, **ухамсар (conscientiousness)**, **нийгмийн идэвх (civic virtue)**, **мэргэжлийн хандлага (sportsmanship)** гэсэн 5 хэмжээсээс тогтсон загвар болж хувирсан байна.

Түүнээс хойш БИЗТ-ийн төрлийн судалгаанууд улам бүр гүнзгийрч, 1998 онд профессор Fan Jing Li хятадын соёлд үндэслэн БИЗТ-ийг 11 хэмжээсээр хэмжсэн ба сайн дураараа суралцах зэрэг 6 төрлийн хэмжээс нь хятадын соёл уламжлалтай уялдсан байна. Үүнээс үүдэн өөр өөр соёл, ёс заншлаас үүдэн БИЗТ нь өөр хоорондоо ялгаатай байж болно гэсэн санааг дэвшүүлсэн байна.

БИЗТ-ийн төрлүүд

Williams, Anderson нар 1991 онд БИЗТ-ийн конструкцуудыг арай өөрөөр зохион байгуулах санал гаргасан. Тэд БИЗТ-ийн хэмжээсүүдийг хэнд хандсан гэдгээр нь 2 ялгаатай БИЗТ болгож хуваасан байна.

- Ажлын байран дахь бусад хүмүүсрүү чиглэсэн зан төлөв буюу ХБИЗТ,
- Байгууллагыг бүхэлд нь онилсон зан төлөв буюу ББИЗТ.

Нүнжиг (Altruism) болон **Анхаарамж (courtesy)** нь бусад ажилтнууд руу хандсан шинжтэй тул ХБИЗТ, харин **Ухамсар (conscientiousness)**, **Нийгмийн идэвх (civic virtue)**, болон **мэргэжлийн хандлага (sportsmanship)** зэрэг нь байгууллагын сайн сайхны төлөө чиглэсэн байдаг тул ББИЗТ гэж тооцож болно.

БИЗТ-ийн хэмжүүрүүд:

Судлаачид БИЗТ-ийн олон янзын хэмжүүрийг хөгжүүлж бий болгосон.

Betaman, Organ (1983) нар БИЗТ-ийн хэмжүүрийг тогтоох гэж оролдсон анхны оролдлого байсан юм. Тэдний тодорхойлсноор БИЗТ нь хамтын ажиллагаа, нүнжиг, нийц, цаг барилт, ажлын арга барил сайжруулалт, компанийн өмчийг хамгаалах, компаний дүрэм журмыг шударгаар дагаж мөрдөх, итгэл даах чадвар зэргийг хэмжих 30 зүйлтэй БИЗТ-ийн хэмжүүр боловсруулсан. Энэхүү хэмжүүрийн зарчим нь оролцогч бүрээр 30 зүйл нэг бүрийн тухай санал нийлж байгаа болон нийлэхгүй байгаа түвшингээс хамааран -3-аас + 3-ын хооронд 7 баллаар үнэлнэ.

Smith. (1983) хийсэн илүү хандлагаар шаталсан байдлаар боловсруулсан хэмжүүр гаргаж ирсэн судалгаа юм. Энэ 16 зүйлтэй хэмжүүрийг гаргаж ирэхийн тулд судлаачид үйлдвэрүүдийн менежерүүдтэй ярилцлага хийсэн бөгөөд тэднээс тустай боловч зайлшгүй хэрэгтэй бус зан төлвүүдийг тодорхойлохыг хүссэн байна. Smith (1983)-ын судалгааны зарим зүйлийг дурдвал:

- Байхгүй байж байгаад ирсэн нөхөддөө туслах
- Хэрэв ажилдаа ирж чадахааргүй бол урдаас мэдэгдэх
- Даргадаа ажлаараа туслах
- Оролцох албагүй боловч байгууллагын имижийг дээшлүүлэх ач холбогдолтой арга хэмжээнд оролцох гэх мэт.


Podsakoff, MacKenzie, Moorman, Fetter (1990) нар БИЗТ-ийн 5 хэмжээсийг ашиглан 24 асуултаас бүрдсэн шалгуур гаргаж ирсэн байна. Оролцогчдод “Огт санал нийлэхгүй байна” буюу “Бүрэн дүүрэн санал нийлж байна” гэсэн хоёр туйлын хооронд орших 7 хэмжээт хэмжүүрээр үнэлгээ хийх заавар өгсөн байна. Энэхүү 5 хүчин зүйлээс тогтсон бүтэц нь хожмын БИЗТ-тэй холбоотой олон тооны судалгааны үндэс болсон байна. Podsakoff (1990)-ын хэмжүүрийн зүйлүүдээс зарим нэг жишээ татвал:

- Хэн ч харахгүй байсан гэсэн байгууллагын дүрэм журмыг дагаж мөрдөх
- Оролцох албагүй боловч чухал гэж тооцогдох хурлуудад оролцох
- Өөрийнх нь гаргаж байгаа зан авир бусад хүмүүсийн ажилд хэрхэн нөлөөлж болохыг марталгүй санах байх
- Ажлын холбоотой асуудалтай тулгарсан бусад хүмүүст сайн дураараа туслах г.м.

IV. СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ БА МЭДЛЭГ ХУВААЛЦАХ ХҮСЭЛ, БАЙГУУЛЛАГЫН ИРГЭНШЛИЙН ЗАН ТӨЛВИЙН ХАМААРАЛ, ТЭДГЭЭРИЙН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛД НӨЛӨӨЛЖ БУЙ БАЙДАЛ

Sung Jun Jo and Baek-Kyoo Jo (2011) нарын Суралцагч байгууллагын соёл, байгууллагын коммитмент, байгууллагын иргэншлийн зан төлөв нь байгууллагын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийн судалгаагаар Ажилтнуудын мэдлэгээ хуваалцах хүсэл эрмэлзэлд


- Соёлын (суралцагч байгууллагын соёл),
- Сэтгэл зүйн (байгууллагын коммитмент),
- Зан төлвийн (байгууллагын иргэншлийн зан төлөв) хүчин зүйлс нөлөөлөх талаар авч үзсэн.



Судалгааны үр дүнгээс харахад: 1-рт суралцагч байгууллагын соёлыг илүү өндөр түвшинд хүлээн зөвшөөрч, ОСВ-ийн өндөр түвшнийг харуулсан үед мэдлэг хуваалцах хүсэл эрмэлзэл өндөр байгааг харуулсан. **2-рт**, байгууллагын коммитмент ба мэдлэг хуваалцах хүсэл хоёрын хоорондох шууд холбоо нь ач холбогдолгүй байсан. **3-рт**, суралцагч байгууллагын

соёл нь байгууллагын коммитмент, ОСВ, мэдлэг хуваалцах зорилготой холбоотой болохыг олж тогтоосон.

Байгууллагын соёл нь тухайн байгууллагад мэдлэгийг бий болгох, хуваалцах, түгээх, ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг нь тодорхой юм (De Long & Fahey, 2000).



ДҮГНЭЛТ

Өнөөгийн мэдлэгт суурилсан эдийн засгийн орчинд байгууллагын тогтвортой өрсөлдөх давуу талыг бий болгох гол эх үүсвэрийн нэг нь мэдлэг болж байна. Хувь хүний эзэмшиж буй мэдлэгийг байгууллага даяар түгээхээс нааш байгууллагын мэдлэг болж чадахгүй тул Мэдлэгээ хуваалцах нь чухал ач холбогдолтой. Иймээс мэдлэг хуваалцах нь байгууллагыг тасралтгүй суралцах, өөрчлөх чиглэлд шилжүүлэхийн тулд хүмүүс болон байгууллагын бүтцийг нэгтгэсэн байгууллагын хэмжээнд соёлыг шаарддаг (Egan, Yang, & Bartlett, 2004).

Байгууллагууд мэдлэг хуваалцах хүслийг сайжруулахын тулд ялангуяа байгууллагын иргэншлийн зан төлвийг хөгжүүлэх нь зайлшгүй чухал юм. Үүний тулд суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлэх нь чухал юм. Энэхүү судалгаа нь байгууллагын соёл нь нийгэмд чиглэсэн хандлага, зан төлвийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг болохыг харуулж байна.

Энэ нийтлэлд бид: суралцагч байгууллагын соёл, мэдлэг хуваалцах хүсэл, байгууллагын иргэншлийн зан төлвийг онолын түвшинд судалж, эрдэмтэн судлаачдын энэ чиглэлийн бүтээлүүдтэй танилцаж, суралцагч байгууллагын соёл нь байгууллагын гүйцэтгэлд нөлөөлөх талаар онолын загвар дээр үндэслэсэн мэдлэг хуваалцах хүсэл ба байгууллагын иргэншлийн зан төлөв нь үүнд хэрхэн нөлөөлөх зураглалыг гаргахыг зорьсон.

Дээрх судалгаанаас үзэхэд нь **The theory of reasoned action** - Бок нар. (2005) онолын дагуу “Хувь хүний мэдлэгийг хуваалцах хүсэлд түүний хандлага, субъектив хэм хэмжээ (мөн байгууллагын уур амьсгал) нөлөөлдөг байна. Мөн **Social exchange theory** онолын дагуу болон байгууллага нь өөрсдийг нь дэмжиж байгаа гэж боддог ажилчид иргэншлийн зан төлвийн хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдаг бөгөөд энэ нь мэдлэгийг хуваалцах хандлагад нөлөөлдөг болохыг харуулж байна. Энэ ч үүднээсээ “Мэдлэг бол хүч” гэсэн парадигм өмнө нь үйлчилдэг байсан бол өнөө үед “Мэдлэгээ хуваалцах нь хүч” гэж ойлгох хэрэгтэй болж байна.

Хөдөлмөрийн оролцоо ихтэй аж үйлдвэрлэлийн загвараас оюун ухаанд суурилсан мэдлэг бүтээх загвар луу шилжиж буйтай холбоотойгоор байгууллагын зан төлөв, гүйцэтгэл, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлэх гол хүчин зүйл нь байгууллагын соёл болдог учраас суралцагч байгууллагын соёл ба гүйцэтгэл, мэдлэг хуваалцах хүсэл ба байгууллагын иргэншлийн зан төлвийн хамаарал, нөлөөллийн талаар шинэ судалгаа шинжилгээ шаардлагатай байгааг харуулж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Б.Содбаяр (2013) “Байгууллага дахь шудрага ёс нь байгууллагын иргэншлийн зан төлөвт нөлөөлөх нь” /Интернэт үйлчилгээ үзүүлэгч компаниудын жишээн дээр/
- Б.Санчир (2015) “Ажилтны байгууллагаас ирж буй дэмжлэгийг ухамсарлах байдал нь байгууллагын иргэншлийн зан төлөвт нөлөөлөх нь” /Шингэн хүнсний салбарын жишээн дээр/
- Б.Баяржаргал (2016) “Уул уурхайн олборлолтын салбар дахь мэдлэг хуваалцах соёлыг үнэлэх нь” /Уул уурхайн олборлолтын компаниудын жишээн дээр/
- Г.Нансалмаа (2017) “Байгууллагын иргэншлийн зан төлөвт ажлын шинж чанар нөлөөлөх нь” /Олон Улсын онгоцны тийз борлуулагч компаниудын жишээн дээр/
- А.Хонгорзул (2017) “Мэдлэг хуваалцах үйл явц болон бүтээлч сэтгэлгээнд хамтач соёлын үүргийн хамаарлыг тодорхойлох” /Хэвлэх компаниудын жишээн дээр/
- Д.Болормаа (2018) “Дээд боловсролын байгууллагуудын мэдлэгийн менежментийн чадавхад нөлөөтэй хүчин зүйлсийн шинжилгээ” /Бизнес, менежментийн их дээд сургуулиудын жишээн дээр/
- Organ, D. W. (1988). *Organizational citizenship behavior: The good soldier syndrome*. Lexington, MA: Lexington Books.
- Garvin, A. (1993). Building a learning organization. *Harvard Business Review*, 71(4), 78-84.
- Senge, P. M. 1990a. *The Fifth Discipline: The Art and Practice of the Learning Organization*. New York: Doubleday.
- Senge, P. M. 1990b. “The Leader’s New Work: Building Learning Organizations.” *Sloan Management Review* 32: 7–23.
- Podsakoff, P. M., MacKenzie, S. B., Moorman, R. H., & Fetter, R. (1990). Transformational leader behaviors and their effects on followers’ trust in leader, satisfaction, and organizational citizenship behaviors. *Leadership Quarterly*, 1, 107-142.
- Robertson, M., & Hammersley, G. (2000). Knowledge management practices within a knowledge-intensive firm: The significance of the people management dimension. *Journal of European Industrial Training*, 24, 241-253.
- Williams, L. J., & Anderson, S. E. (1991). Job satisfaction and organizational commitment as predictors of organizational citizenship and in-role behaviors. *Journal of Management*, 17, 601-617.
- Nonaka, I. 1994. “A Dynamic Theory of Organizational Knowledge Creation.” *Organization Science* 5 (1): 14–37.
- Nonaka, I., & Takeuchi, H. (1995). *The knowledge-creating company: How Japanese companies create the dynamics of innovation*. New York, NY: Oxford University Press.

- Watkins, K. E., & Marsick, V. J. (1997). *Dimensions of the learning organization*. Warwick, RI: Partners for the Learning Organization.
- Davenport, T., and L. Prusak. 2000. *Working Knowledge: How Organizations Manage What They Know*. Boston, MA: Harvard Business School Press.
- Watson, G. W., & Papamarcos, S. D. (2002). Social capital and organizational commitment. *Journal of Business and Psychology*, 16, 537-552.
- Marsick, V. J., & Watkins, K. E. (2003). Demonstrating the value of an organization's learning culture: The Dimensions of the Learning Organization Questionnaire. *Advances in Developing Human Resources*, 5, 132-151.
- Podsakoff, P. M., MacKenzie, S. B., Lee, J., & Podsakoff, N. (2003). Common method biases in behavioral research: A critical review of the literature and recommended remedies. *Journal of Applied Psychology*, 88, 879-903.
- Yang, B., Watkins, K. E., & Marsick, V. J. (2004). The construct of the learning organization: Dimensions, measurement, and validation. *Human Resource Development Quarterly*, 15, 31-55.
- Sung Jun Jo and Baek-Kyoo Joo (2011) The Influences of Learning Organization Culture, Organizational Commitment, and Organizational Citizenship Behaviors
- Gerald Kanyango Githuku, Godfrey Kinyua, PhD, Anne Muchemi, PhD (2022) Learning Organization Culture and Firm Performance: A Review of Literature



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ПИГМАЛИОН ЭФФЕКТИЙН НӨЛӨӨЛӨЛ

С.Эрхэмбаяр¹, Б.Идэрцогт²

¹Магистр (МВА), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

²Магистр (МВА), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль



Түлхүүр үг:

Удирдлагын хүлээлт,
манлайлах чадвар,
ажилтны өөрийн хүлээлт

Хураангуй

Энэхүү судалгаанд байгууллагын удирдлага болон ажилчдын хоорондын үр дүнтэй харилцаа, ажлын гүйцэтгэлийг сайжруулах асуудлын талаар судлах бөгөөд удирдлагын хүлээлт, ажилчдын хүлээлттэй хамааралтай эсэхийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, удирдлагын хүлээлт, манлайлах чадвар нь ажилтны өөрийн хүлээлтэд хэрхэн нөлөөлдгийг судлах юм. Уг судалгааг хийхдээ нэг байгууллагын удирдлагыг бүхэлд нь болон зарим ажилтнууд, мэргэжилтнүүдийн хамт судалгаанд хамруулав. Ингэснээр удирдлага болон ажилтан хоорондын харилцаанд хүлээлтийн нөлөөлөл байгаа эсэх талаар судлахад илүү бодитой судалгааны түүвэр бүрдэнэ гэж үзсэн болно. Сонгосон байгууллагын удирдлага, ажилтнуудыг хамруулан нийт 26 хүнээс асуулгын хуудсаар судалгааны өгөгдөлөө цуглуулав. Үүнээс дээд түвшиний удирдлага 1, дунд түвшиний удирдлага 13, анхан шатны удирдлага 2, мэргэжилтэн 3, гүйцэтгэх түвшиний ажилтан 7 хүн хамрагдсан болно. Судалгааны асуулгын хувьд 3 бүлэг 30 асуулттай ба нэгдүгээр бүлгийн удирдлагын манлайлал хэсэг 9 асуулттай, хоёрдугаар бүлгийн ажилтны хүлээлт хэсэг 14 асуулттай, гуравдугаар бүлгийн удирдлагын хүлээлт хэсэг 7 асуулттай. Байгууллагын удирдлагын хүлээлтийг үл хамаарах хувьсагч, удирдлагын манлайлах чадварыг зуучлагч хувьсагч харин ажилтны хүлээлтийг хамаарах хувьсагч гэж үзэн ажилтны хүлээлт болон удирдлагын хүлээлт хооронд зуучлагч хувьсагч нь удирдлагын манлайлал гэж таамаглан шинжилгээг хийв. Өгөгдлийн шинжилгээг SPSS Statistic программ ашигласан бөгөөд зуучлалын шинжилгээг хийхдээ “Baron, R.M., болон Kenny, D.A” аргыг ашиглан регрессийн шинжилгээ хийж үр дүнг тайлбарлалаа. Энэхүү судалгааны үр дүнд судалгаанд хамрагдсан байгууллагын хувьд санал зөвлөмж боловсруулан ажиллав.

Сэдвийн үндэслэл

Байгууллагын удирдлагын аль ч түвшинд тулгардаг ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнд эерэг нөлөө үзүүлэх, удирдлагын хүлээлтийн талаар судлах хэрэгцээ байдаг.

“Пигмалион эффект”-ийн нөлөөллийг удирдлага болон ажилчид, багш болон сурагчид, эмч болон өвчтөн зэрэг олон салбарт судлан судалгааны ажилдаа хүлээлтийн үр нөлөөг тайлбарласан байна.

Судалгааны хувьсагч хүчин зүйлс

Судалгааны зорилгын хүрээнд удирдлагын хүлээлт (Pygmalion effect)-ийг бие даасан хувьсагч, удирдлагын ажлын байран дахьманлайлах чадвар (Leadership skills)-ийг зуучлагч хувьсагч, ажилтны хүлээлт (Subordinate Self-Expectancy)-ийг хараат хувьсагч гэж үзэн хүчин зүйлсүүдийн хамааралтай эсэхийг судаллаа.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгаа нь удирдлагын хүлээлт нь ажилтны гүйцэтгэлд нөлөөтэй эсэхийг судлах, мөн удирдлагын хүлээлтээс хамаарсан манлайлал нь ажилтны ажлын гүйцэтгэлд хамааралтай эсэхийг олж илрүүлэх, хэр зэрэг ач холбогдолтойг тодорхойлох зорилготой юм.

Судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд:

1. Удирдлагын хүлээлт, удирдлагын манлайлал хоорондын ач холбогдлыг тодорхойлох
2. Удирдлагын хүлээлт, ажилтны хүлээлт хоорондын ач холбогдлыг тодорхойлох
3. Удирдлагын хүлээлт, удирдлагын манлайлал болон ажилтны хүлээлт хоорондын ач холбогдлыг шинжлэх

БҮЛЭГ 1. ОНОЛЫН СУДАЛГАА

Бид хэн нэгэн хүний харилцаа, хандлагатай холбоотой түүний талаарх тодорхой төсөөлөлд автдаг. Тэр хэзээ, хаана, хэрхэн биеэ авч явах тухай бодож хүлээлтийг мөн үүсгэдэг байна. Хүлээлт нь заримдаа "зан үйлийн хандлага"-тай холбоотой байдаг бол зарим үед хувь хүний тухай бодох таны төсөөлөлтэй холбоотой байж болно. Өөрөөр хэлбэл, өмнө нь түрэмгий зан гаргаж байсан хүн ижил төстэй нөхцөлд яг ийм байдлаар хандана гэж бид хүлээж байдаг. Тиймээс бидний хүлээлт нь тодорхой зан үйл ижил төстэй нөхцөлд давтагдана гэсэн төсөөлөлтэй холбоотой (Demirtas, 2004). Хэн нэгний талаарх таны төсөөлөл бодол санаа нь хүлээгдэж буй зан үйлийг бий болгодог. Ихэнхдээ амжилтад хүрнэ гэж найдаж байсан хүн гайхалтай үр дүнг үзүүлж байдаг. "Чамайг хамгийн сайнаараа хийх болно гэдгийг би мэдэж байна", эсвэл "Энэ чамд хэцүү байж магадгүй гэхдээ чи чадна." гэх хүлээлт нь хүлээгдэж буй зан үйлийг гүйцэлдүүлдэг. Хэн нэгний өөр хүний талаарх хүлээлт, бодол нь урт хугацаанд тухайн хүний бодолд, үйлдэлд нөлөөлж болзошгүй юм (Loftus, 1995).

Хүлээлтийн үр нөлөөг сэтгэл судлалд "Pygmalion effect" гэж нэрлэдэг бөгөөд энэ нэр томьёо нь Грекийн домогт анх өгүүлэгдсэн юм. Эмэгтэйчүүдийг үздэггүй, хэзээ ч гэрлэхгүй гэж боддог Киприйн хунтайж, уран барималч Пигмалион нь бүх эмэгтэйчүүдийг үл ойшоож,

хамгийн сайхан эмэгтэйг өөрөө баримал хэлбэрээр хийхийг оролдсон байдаг. Баримал нь үнэхээр үзэсгэлэн төгс, гайхамшигтай болсон тул Галатея гэж нэрлэсэн энэхүү урлагийн бүтээлдээ Пигмалион өөрөө дурладаг. Тэрээр Венусийг дуудаж, Галатеяг амилуулж өгөхийг гуйх ба Венус ч үзэсгэлэн төгс барималыг харан энэ хүслийг нь биелүүлж өгдөг. Ингээд ханхүү Пигмалион, Галатея гэрлэн аз жаргалтай амьдарсан гэх домог бий (Senlen, 2008).

Сүүлийн жилүүдэд хүлээлтийн үр нөлөөг судлах эрдэмтэд нэмэгдэж, салбар бүрийн судлаачдын анхаарлыг татах боллоо. Тиймээс хүлээлтийн үр нөлөөний талаар олон төрлийн туршилт, судалгааны ажлууд нийгмийн шинжлэх ухааны салбар бүрд хийгдэх болсон байна. Бид ямар нэг зүйлийг хүсэн хүлээх үед бидний үйлдэл итгэл үнэмшилдээ хөтлөгддөг. Тиймээс хүлээлтийн үр нөлөө нь хүлээлт үүсгэх хоромд тохиолддог хариу үйлдэл биш, харин итгэл төрүүлэхтэй холбоотой сэдэл, үйлдэл, хандлага зэргийн цогц нийлбэр байж болно (Gunduzalp O. , 2019). Хүлээлтийн талаарх сэтгэлзүйн судалгаануудад хүлээлтийн үр нөлөөг пигмалионы нөлөө гэж тодорхойлдог (Wang L. , 2000). Энэ нөлөөг харгалзан Жорж Бернард Шоу "Миний шударга хатагтай" нэртэй мюзиклээ бичсэн байдаг. Энэ мюзикл 1914 онд Лондонд анх удаа тоглогдсон байдаг (Shaw, 2004) (Prasad, 2013). Жорж Бернард Шоугийн "Pygmalion" зохиолд хатагтай Элиза Дулитл, цэцэгчин охин хоёрын харилцаанд пигмалионы нөлөөллийг тодорхой дүрсэлсэн байна. Хатагтай Элиза Дулитлийн биеэ авч явах байдлаас илүү, цэцэгчин охинд хэрхэн хандаж байгаагаар хүлээлтийн нөлөөллийг дүрсэлсэн байдаг. Профессор Хиггинсийн хувьд “би үргэлж цэцэгчин охин байх болно, учир нь хүмүүс үргэлж цэцэгчин охин шиг байхыг надаас хүсдэг. Хэрвээ чи надад хатагтай Элиза Дулитл мэт хандвал би чиний хувьд үргэлж цэцэгчин охин байж чадна гэдгээ мэдэж байна” (Murphy, 1999). Пигмалион эффект нь үндсэндээ биелдэг нөлөөллийн үр дүн юм. Энэ нөлөөллийг өөрийгөө дутуу үнэлдэг хэн нэгэн хүчирхэг нэгний хүлээлтэд нийцүүлэн зан төлөвөө өөрчилж байгаагаар харах боломжтой (Wang L. , 2000).

“Пигмалион эффект”-ийн гол зарчим нь бидний тархи хүссэн зүйлээ бодит нөхцөл байдлаас ялгах чадваргүйд оршдогт байдаг. Социологич: Роберт Мертоны үзсэнээр “Пигмалион эффект”-ийг санаснаар гүйцэлдүүлэх зөн буюу нэгэн төрлийн гипноз гэж тодорхойлсон байна. Бид өөртөө болон бусдын талаар өндөр хүлээлттэй байснаар бодит байдалд нөлөөлж, аливаа ажлын гүйцэтгэлийг сайжруулдаг. Энэхүү үзэгдэл нь хүмүүс хоорондын харилцаанд үүсэх тул зорилготой эсвэл санамсаргүй байдлаар үүсэх боломжтой юм.

Зураг 1.1 Пигмалион эффект



Эх сурвалж: *Pygmalion effect* (Kashen, 2011)

“Пигмалион эффект”-ийн нөлөөг Жон Стерлинг Ливингстон өөрийн судалгааны ажилдаа “*Байгууллагын харилцаанд удирдлагын хүлээлт, манлайлах чадвар болон ажилчдын хүлээлт, урам зориг, гүйцэтгэл хоёр хоорондоо уялдаатай гэж үзэн менежерүүд өөрсдийн шууд удирдлагад байгаа хүмүүстээ тодорхой хүлээлт үүсгэх нь бүтээмж болон гүйцэтгэлд эерэг нөлөөтэй байгааг тайлбарласан.*”

- Менежерүүд өөрийн ажилчдаасаа юу хүсэн хүлээж, тэдэнд хэрхэн хандах нь ажилчдын өсөлт хөгжилтөд ихээхэн нөлөөлдөг.
- Амжилттай, үр дүнтэй менежерүүдийн өвөрмөц чанар бол ажилчдынхаа биелүүлж чадах шаардлагыг хэрэгжүүлж байдаг.
- Ажлын үр дүн сул байдаг менежерүүд хүлээлтийг үүсгэж чаддаггүй учраас ажилчид нь бүтээмжгүй болдог.

Ер нь ажилтнууд өөрсдөөс нь хүсэн хүлээдэг зүйлийн дагуу үйл хөдлөлөө өөрчилж байдаг (Livingston, 1969).

“Пигмалион эффект” амьдралд элбэг тохиолдох нь олон бөгөөд дараах туршилтаас харах боломжтой. 1968 онд Харвардын их сургуулийн Роберт Розентал, Ленор Жейкобсон нар туршилт явуулсан ба уг туршилтад оюутнуудыг оролцуулсан байна. Тэднийг 2 бүлэгт хуваан эхний бүлэгт оюуны чадамж өндөртэй оюутнуудыг, дараагийн бүлэгт оюуны чадамж доогуур оюутнууд байгаа гэж хичээл заах багш нарт ойлгуулсан. Хэсэг хугацааны дараа тухайн оюутнуудаас оюуны чадамжийн шалгалтыг дахин авахад эхний бүлгийн хүүхдүүдийн шалгалтын үр дүн 2-р бүлгийн хүүхдүүдээс нэлээдгүй өндөр гарсан байдаг. Үнэндээ анх энэ бүлгийг хуваахад санамсаргүй байдлаар хүүхдүүдийг хуваарилсан, мөн хичээлийн хөтөлбөрт ямар нэгэн ялгаа байгаагүй, эхний шалгалтын үр дүнд ямар нэг онцлох ялгаа ч байгаагүйг судлаач нар онцолсон байдаг. (Robert Rosenthal & Lenore Jacobson, 1992)

Роберт Розентал, Ленор Жейкобсон нарын үзсэнээр эхний бүлгийн оюутнуудын оюуны чадамжид итгэсэн багш нар илүү их анхаарал хандуулж, өөрсдөө манлайлан өндөр хүлээлттэй байгаагаа оюутнууддаа ойлгуулсан. Оюутнууд ч эргээд багш нарын өндөр

хүлээлтэд тохируулан үйлдэл, хандлага нь өөрчлөгдсөн байна. Харин 2-р бүлгийн сурагчид багш нарын хандлагаас сул хүлээлт мэдэрсэн тул сурлагын идэвх, гүйцэтгэл нь өсөөгүй гэж дүгнэлт хийжээ. Үүнтэй адил өөр хүний талаарх хэн нэгний хүлээлт, бодол санаа нь эцэстээ тэр хүний зан төлөвт нөлөөлж болно гэж Лофтус өөрийн судалгааны ажилдаа үзсэн байдаг. Мөн дээрх туршилт, судалгааны үр дүнгүүдэд үндэслэн байгууллагын удирдлага болон ажилтнуудын хооронд ч ижил нөлөөтэй байна гэж үзсэн. Гүйцэтгэл сайтай ажилтан болон гүйцэтгэл сул ажилтны ялгаа нь цалин хөлсний зөрүүгээр биш, тэдэнд удирдлага нь хэрхэн хандаж, ямар хэмжээнд хүлээлт үүсгэж байгаагаас хамаарч гүйцэтгэлд зөрүү үүсдэг. (Bezuijen, 2009)

Удирдлагаас хүлээх хүлээлт нь ажилчдын бүтээлч байдалд нөлөөлөхөөс гадна тэдний зан төлөв, гүйцэтгэлийг сайжруулах урам зориг, ажилдаа манлайлах сэдлийг өдөөж өгөх суурь болно хэмээн үзсэн байна. (Tierney, 2004).

Зураг 1.2 Удирдлагын хүлээлтийн процесс



Эх сурвалж: Pygmalion effect (Tierney, 2004)

Судалгааны таамаглал:

1. Бие даасан хувьсагч, зуучлагч хувьсагч нар хоорондоо ач холбогдолтой.
2. Бие даасан хувьсагч хараат хувьсагч хоорондоо шууд бус ач холбогдолтой.
3. Бие даасан хувьсагч, зуучлагч хувьсагч, хараат хувьсагч хоорондоо ач холбогдолтой.

Зураг 1.3 Судалгааны дизайн



Эх сурвалж: *Pygmalion effect* (Tierney, 2004)

Нийт 3 хүчин зүйлийн 30 асуулттай асуулгыг судалгаанд оролцогчдоос авсан ба судалгааны асуултуудыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.1 Судалгааны агуулга болон жишээ асуулт

Судлаачид	Асуултын төрөл	Жишээ асуулт		Хэмжүүр
Eden, D., Ravid, G	Ажилтны хүлээлт	1	Манай удирдлага миний ур чадварыг үл тоодог. Энэ нь миний ажлын гүйцэтгэлд сөрөг нөлөөлдөг.	1 - огт санал нийлэхгүй байна, 5 - бүрэн санал нийлнэ.
		2	Би карьерынхаа туршид байгууллагадаа ажиллахдаа баяртай байх болно	
		3	Ажил дээрээ би эрч хүчээр дүүрэн байгаагаа мэдэрдэг	
Seda Gunduzalp, Mukadder Boydak Ozan	Удирдлагын манлайлал	1	Би удирдлагатай дандаа өөрийнхөөрөө харилцдаг. Удирдлагатай хамт ажиллахад түшигтэй байдаг.	
		2	Манай удирдлагын удирдах арга барил их таалагддаг. Биднийг байнга чиглүүлж, зөвлөмж өгч, хамтарч ажиллаж чаддаг.	
	Удирдлагын хүлээлт	1	Би ажилдаа чухал зорилго тавиад түүндээ хүрэх нь ховор. Удирдлага надад бие дааж ажиллах боломж өгдөггүй.	
		2	Би ажилдаа сонирхолтой ч миний саналыг удирдлага үргэлж үл ойшоох хандлагатай байдаг.	

Эх сурвалж: (Gunduzalp & Ozan, 2019)

БҮЛЭГ 2. ҮР ДҮН, ШИНЖИЛГЭЭ

2.1 Найдвартай байдлын шинжилгээ

Scale: ALL VARIABLES

Case Processing Summary			Reliability Statistics	
	N	%	Cronbach's Alpha	N of Items
Valid	24	92.3	.792	40
Cases Excluded ^a	2	7.7		
Total	26	100.0		

a. Listwise deletion based on all variables in the procedure.

KMO and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.619
	Approx. Chi-Square	23.387
Bartlett's Test of Sphericity	df	3
	Sig.	.000

Энэхүү судалгааг гурван хүчин зүйлээс бүрдсэн асуулгаар авсан ба судалгаанд оролцогчдоос удирдлагын хүлээлт, удирдлагын манлайлал, ажилтнуудын өөрийн хүлээлт зэргийг асуулгаар хамруулан авав. Дээрх үзүүлэлтүүдээс харахад Bartlett's test 0.61, харин Cronbach's alpha 0.79 гарсан нь найдвартай байдлыг хангаж байна хэмээн үзсэн.

Scale: АЖИЛТНЫ ӨӨРИЙН ХҮЛЭЭЛТ

Case Processing Summary			Reliability Statistics	
	N	%	Cronbach's Alpha	N of Items
Valid	26	100.0	.748	14
Cases Excluded ^a	0	.0		
Total	26	100.0		

a. Listwise deletion based on all variables in the procedure.

2.2 Регрессийн шинжилгээ

Scale: УДИРДЛАГЫН ХҮЛЭЭЛТ

Case Processing Summary			Reliability Statistics	
	N	%	Cronbach's Alpha	N of Items
Valid	25	96.2	.732	7
Cases Excluded ^a	1	3.8		
Total	26	100.0		

a. Listwise deletion based on all variables in the procedure.

Бие даасан хувьсагч болон хараат хувьсагчийн найдвартай байдлыг шинжлэн “Baron, R.M., and Kenny, D.A” аргыг ашиглан регрессийн шинжилгээ хийж зуучлагч хүчин зүйл болох “удирдлагын манлайлал” ач холбогдолтой байгаа эсэхэд шинжилгээ хийж үр дүнг тайлбарласан байна.

• Зуучлагч хүчин зүйлийн регрессийн шинжилгээ 1

Model	Variables Entered	Variables Removed	Method
1	udirdlagiin huleelt ^b	.	Enter

a. Dependent Variable: udirdlagiin manlailal
 b. All requested variables entered.

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Regression	1.142	1	1.142	4.426	.046 ^b
	Residual	6.192	24	.258		
	Total	7.334	25			

a. Dependent Variable: udirdlagiin manlailal
 b. Predictors: (Constant), udirdlagiin huleelt
 F- 4.42

Signature буюу P утга нь 0.046 гарсанаар ач холбогдолтой загвар байгааг харуулж байна.

Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	2.192	.434		5.051	.000
	udirdlagiin huleelt	.312	.148	.395	2.104	.046

a. Dependent Variable: udirdlagiin manlailal

Regression Coefficients утгын хувьд $0.05 > 0.046$ гарсанаар model-1 нь ач холбогдолтой загвар мөн болохыг баталж байна. Өөрөөр хэлбэл удирдлагын хүлээлтийн ач холбогдолтой зуучлагч хувьсагч нь удирдлагын манлайлал байна гэсэн утгыг илэрхийлнэ.

• Зуучлагч хүчин зүйлийн регрессийн шинжилгээ 2

Model	Variables Entered	Variables Removed	Method
1	udirdlagiin huleelt ^b	.	Enter
2	udirdlagiin manlailal ^b	.	Enter

a. Dependent Variable: ajiltanii huleelt
 b. All requested variables entered.

R Square утгын хувьд удирдлагын хүлээлт болон ажилтны өөрийн хүлээлт шууд бус хамааралтай байгааг илтгэж байна. Тиймээс удирдлагын хүлээлт болон ажилтны өөрийн хүлээлтэд тодорхой зуучлагч хүчин зүйл байх ёстой гэдгийг илтгэсэн байдаг.

Model		Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
1	Regression	.954	1	.954	4.826	.038 ^b
	Residual	4.745	24	.198		
	Total	5.699	25			
2	Regression	3.239	2	1.620	15.145	.000 ^c
	Residual	2.460	23	.107		
	Total	5.699	25			

a. Dependent Variable: ajiltanii huleelt
 b. Predictors: (Constant), udirdlagiin huleelt
 c. Predictors: (Constant), udirdlagiin huleelt, udirdlagiin manlailal

Signature буюу P1 утга нь - 0.03, Signature буюу P2 утга нь - 0.00 арсан нь Модел 1 болон Модел 2 ач холбогдолтойгоор хамааралтай загвар мөн болохыг харуулж байна.

Coefficients ^a						
Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	2.399	.380		6.317	.000
	udirdlagiin huleelt	.285	.130	.409	2.197	.038
	(Constant)	1.068	.401		2.662	.014
2	udirdlagiin huleelt	.096	.104	.137	.920	.367
	udirdlagiin manlaial	.607	.131	.689	4.623	.000

a. Dependent Variable: aйлтнii huleelt

Beta утгын хувьд модел 2 нь модел 1-с их байгааг харж байна тиймээс удирдлагын манлайлах ур чадвар нь ач холбогдолтой зуучлагч хүчин зүйл мөн байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, удирдлагын хүлээлтийн зуучлагч хүчин зүйл болох удирдлагын манлайлал нь ажилтны өөрийн хүлээлтэд ач холбогдолтойгоор зуучлагч хүчин зүйл болохыг илтгэж байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд бизнесийн байгууллагын удирдлагын хүлээлт нь удирдлагын өөрийн манлайлах зан төлөвт нөлөөлдөг. Манлайлах зан төлөв нь удирдлага тухайн ажилтны зан төлөв, хандлага, ажил гүйцэтгэх чадамж зэрэгт үндэслэн хүлээлтийг ажилтан болгонд ялгаатай байдлаар үүсгэдэг байна. Ингэснээр удирдлагаас тодорхой хүлээлтийг мэдэрч буй ажилтан өөрийн хүлээлтийг ч мөн адил түвшинд үүсгэх хандлагатай байдаг. Энэ нь тухайн ажилтын ажлын гүйцэтгэл, урам зориг, сэтгэл ханамж зэрэгт нөлөөлдөг байна.

Энэхүү судалгааны зорилгод нийцүүлэн удирдлагын хүлээлтийг зуучлагч хүчин зүйлээр удирдлагын манлайлал ач холбогдолтой байгааг нотолсноор ажилтны өөрийн хүлээлтэд буюу өөртөө итгэлтэй, бүтээмжтэй, урам зоригтой ажиллахад нь удирдлагын манлайлах чадвар мөн түүнд нөлөөлж буй удирдлагын хүлээлт чухал хамааралтай болохыг баталлаа. Тиймээс аливаа бизнесийн байгууллагын удирдлагын хүлээлт төсөөлөл нь ажилтнуудын өөрийн хүлээлтэд нөлөөлж болзошгүй тул энэ талаарх ойлголт, мэдлэгтэй байх нь өндөр ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн судалгааны үр дүнд таамаглалууд бүгд батлагдсан гэж үзэж болохоор байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Роберт Розентал, Л. Ж. (огноо байхгүй).

Robert Rosenthal, P., & Lenore Jacobson, E. (1992). *Pygmalion in the Classroom*. The New Yorker.

Gunduzalp, S., & Ozan, M. B. (2019 оны 1 29). *The power of Expectations in School Management: Pygmalion effect*. *Journal of Education and Future*, хууд. 49.

Demirtas. (2004). *The Power of Expectations in School Management*. хууд. 4.

Loftus, P. (1995 оны 5 1). *The Pygmalion effect*. хуудсд. 17-20.

Senlen, S. (2008). *Pygmalion" Adli Oyununda Dil, Eđitim ve Toplumsal Sinif İliřkisi*. хууд. 23.

Wang, L. (2000). *The Upward Pygmalion Effect in the Organization*. хууд. 707. Prasad.

(2013). *The Central Theme of Education in Shaw's Pygmalion*. хууд. 5. Shaw, G. B. (2004). *Pygmalion Musical*.

Murphy. (1999). *The Pygmalion effect reconsidered*. хуудсд. 238-250.

Wang, L. (2000). *The upward pygmalion effect in the organization*. хууд. 707.

Livingston, J. S. (1969). *Pygmalion in Management*. хууд. 35.

Bezuijen. (2009). *Pygmalion and Employee Learning: The Role of Leader Behaviors*. хууд. 9. Tierney, P.

F. (2004). *The Pygmalion Process and Employee Creativity*. хуудсд. 413-432. Gunduzalp, O. (2019). *The Power of Expectations in School Management: Pygmalion Effect*. хууд. 18.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ФАКТОРЫ РАЗВИТИЯ ТРУДОВОГО ПОТЕНЦИАЛА РЕГИОНАЛЬНОГО АПК

О.А. Каурова¹, Е.Б. Дондокова², Митюхин Д.С.³, Имидеева И.В.⁴

¹Восточно-Сибирский государственный университет технологий и управления,

г. Улан-Удэ, Российская Федерация

²Восточно-Сибирский государственный университет технологий и управления,

г. Улан-Удэ, Российская Федерация

³Восточно-Сибирский государственный университет технологий и управления,

г. Улан-Удэ, Российская Федерация

⁴Финансово-Экономический университет, г. Улан-Батор, Монголия



Аннотация

Ключевые слова:

трудовой потенциал
регионального АПК;
факторы, влияющие на
развитие трудового
потенциала; система
контроллинга.

В статье выявлены факторы, влияющие на использование и развитие трудового потенциала. Авторами расширена представленная классификация факторов трудового потенциала такими факторами регионального регулирования как уровень жизни, благосостояние, уровень доходов конкретной территории; имеющаяся инфраструктура: детские сады, школы, возможность обучаться в СПО или вузах, не покидая территории; наличие действующих организаций и рабочих мест; регулирование отношений между работодателями и работниками; наличие социальных программ финансируемых государством; наличие социальной инфраструктуры и т.д. Разработаны перспективы развития трудового потенциала регионального АПК, такие как: цифровизация экономики, в результате которой изменены базовые принципы во взаимоотношениях работников и работодателей; внедрены новые цифровые платформы в кадровый документооборот; изменены условия труда и занятости в организациях регионального АПК. Предложено внедрение системы контроллинга в организации регионального АПК, которая позволит создать определенную систему подходов, методик, технологий по управлению изменениями во всех подсистемах организации.

FACTORS OF DEVELOPMENT OF THE LABOR POTENTIAL OF THE REGIONAL AGRO-INDUSTRIAL COMPLEX

Annotation

The article identifies the factors influencing the use and development of labor potential. The authors expanded the presented classification of factors of labor potential by such factors of regional regulation as the standard of living, well-being, income level of a particular territory; existing infrastructure: kindergartens, schools, the opportunity to study in vocational schools or universities without leaving the territory; the presence of operating organizations and workplaces; regulation of relations between employers and employees; the availability of state-funded social programs; availability of social infrastructure, etc. Prospects for the development of the labor potential of the regional agro-industrial complex have been developed, such as: digitalization of the economy, as a result of which the basic principles in the relationship between employees and employers have been changed; new digital platforms have been introduced into the personnel document flow; working and employment conditions in the organizations of the regional agro-industrial complex have been changed. It is proposed to introduce a controlling system in the organization of the regional agro-industrial complex, which will create a certain system of approaches, techniques, technologies for managing changes in all subsystems of the organization.

Keywords: labor potential of the regional agro-industrial complex; factors influencing the development of labor potential; controlling system.

Введение

В настоящее время, с учетом сложившейся ситуации в нашей стране, аграрная политика должна играть доминирующую роль и заключаться в совершенствовании процессов обеспечения продовольствием, в развитии и поддержке российских производителей собственной сельскохозяйственной продукцией. При этом особое внимание необходимо уделить привлечению трудоспособного населения в сельскую местность, обеспечить уровень занятости, мотивацию и повышение доходов.

К основным проблемам развития региональных АПК, необходимо отнести, на наш взгляд: миграцию трудоспособного населения в городские территории, недостаточное количество высококвалифицированных кадров для внедрения инноваций, в связи с отсутствием на местах условий для повышения квалификации; использование устаревших технологий, устаревшей техники; использование несовершенных методов организации и управления производством, отсутствие, в большинстве случаев, внедрения инноваций в производственный процесс. Для решения проблем необходимо обеспечить организации сельской местности притоком высококвалифицированных кадров с предпринимательской и инновационной активностью.

Исходные данные и методы исследования

На основе статистических данных Минсельхоза России, отчетов о финансово-экономическом состоянии товаропроизводителей агропромышленного комплекса проведен ретроспективный анализ основных экономических показателей сельскохозяйственных организаций за 2016-2020 гг. Количество сельскохозяйственных организаций в 2020 составило 16300 организаций различных форм собственности, производящих более 70% потребительских товаров для населения и треть валового продукта [1].

Прежде следует определиться, что относим к сельскохозяйственным организациям. Согласно Федеральной службе государственной статистики, к ним относятся хозяйственные товарищества, общества и партнерства, производственные кооперативы, унитарные предприятия, подсобные хозяйства несельскохозяйственных организаций и учреждений. К малым предприятиям (включая микропредприятия) относятся юридические лица – коммерческие организации, внесенные в единый государственный реестр юридических лиц и соответствующие условиям, установленным Федеральным законом от 24 июля 2007 г. № 209-ФЗ (с изменениями) "О развитии малого и среднего предпринимательства в Российской Федерации"; индивидуальные предприниматели по сельскохозяйственной деятельности, занимающиеся предпринимательской деятельностью без образования юридического лица с момента его государственной регистрации в соответствии с Гражданским кодексом Российской Федерации. К хозяйствам населения относятся личные подсобные и другие индивидуальные хозяйства граждан в сельских и городских поселениях, а также хозяйства граждан, имеющих земельные участки в садоводческих и огороднических некоммерческих объединениях.

Личные подсобные хозяйства - это форма непредпринимательской деятельности по производству и переработке сельскохозяйственной продукции, осуществляемой личным трудом гражданина и членов его семьи в целях удовлетворения личных потребностей на земельном участке, предоставленном или приобретенном для ведения личного подсобного хозяйства. Землепользование хозяйств может состоять из приусадебных и полевых участков.

К садоводческим, огородническим некоммерческим объединением граждан относятся некоммерческие организации, учрежденные гражданами на добровольных началах для содействия ее членам в решении общих социально-хозяйственных задач ведения садоводства, огородничества. К крестьянским (фермерским) хозяйствам относятся объединение граждан, связанных родством и (или) свойством, имеющих в общей собственности имущество и совместно осуществляющих производственную и иную хозяйственную деятельность (производство, переработку, хранение, транспортировку и реализацию сельскохозяйственной продукции), основанную на их личном участии [1].

Таблица 1. Основные экономические показатели сельскохозяйственных организаций

	2016	2017	2018	2019	2020
Среднегодовая численность занятых по виду экономической деятельности «Растениеводство и животноводство, охота и предоставление соответствующих услуг в этих областях»:					
тыс. человек	4890	4481	4346	4212	4011
в процентах к предыдущему году	99,8	91,6	97,0	96,9	95,2
Удельный вес занятых по виду экономической деятельности «Растениеводство и животноводство, охота и предоставление соответствующих услуг в этих областях» в общей численности занятых, в процентах	6,8	6,2	6,1	5,9	5,8
Количество рабочих мест по виду экономической деятельности «Растениеводство и животноводство,					

охота и предоставление соответствующих услуг в этих областях»: тыс. единиц в процентах к предыдущему году	21902 100	20923 95,5	21711 103,8	21415 98,6	23144 108,1
Количество фактически отработанного времени на всех видах работ по виду экономической деятельности «Растениеводство и животноводство, охота и предоставление соответствующих услуг в этих областях»: млн. человеко-часов в процентах к предыдущему году	19933 99,7	19098 95,8	19032 99,7	18565 97,6	18731 100,9
Среднемесячная номинальная начисленная заработная плата работников занятых в организациях по виду экономической деятельности «Растениеводство и животноводство, охота и предоставление соответствующих услуг в этих областях»: руб. в процентах к предыдущему году	21268 110,6	23529 110,6	25820 109,7	28396 110,0	31058 109,4
Индекс производительности труда по отрасли «Сельское, лесное хозяйство, охота»), процентов к предыдущему году	102,6	105,7	103,3	106,6	99,8

Согласно методике Росстата, производительность труда характеризует эффективность использования затрат труда в процессе производства. Индекс производительности труда отражает динамику производительности труда и рассчитывается путем деления индекса физического объема валовой добавленной стоимости отрасли на индекс изменения совокупных затрат труда.

В качестве основных методов исследования были использованы методы ретроспективного анализа и методы экономико-статистического анализа.

Проведенный анализ основных экономических показателей сельскохозяйственных организаций показал, что за 2016-2020 гг. среднегодовая численность занятых сократилась на 18%, количество фактически отработанного времени – почти на 6%, тогда как количество рабочих мест увеличилось на 5,67%. Хотя за этот же период среднемесячная номинальная начисленная заработная плата и увеличилась на 46%, но в целом уровень заработной платы в организациях сельской местности остается все таким же низким (табл.1). Все это свидетельствует о наличии ряда проблем с трудовым потенциалом в сельской местности. Для повышения эффективности трудового потенциала организаций сельской местности необходим анализ факторов, влияющих на его использование и развитие.

Результаты.

При изучении факторов, влияющих на использование и развитие трудового потенциала, многие авторы предлагали различные классификации (табл.2). Так, в работах Юдиной Л.Н. выделены такие факторы, как научно-технические, социально-экономические и культурные [2].

Таблица 2. Краткий обзор классификаций факторов влияния на трудовой потенциал

Автор	Факторы
Юдина Л.Н.	Научно-технические, социально-экономические и культурные [2].
Маскаев М.И.	Факторы внешней и внутренней среды [2].
Волков И.В., Афанасьева И.В., Горохов В.А.	Выделяют оптимальные факторы влияния на эффективность трудовых ресурсов: трудовая миграция, организация ярмарок вакансий, повышение заработной платы [3].
Генкин Б.Н.	Факторы, действующие со стороны работника и факторы, действующие со стороны окружающей среды [4].
Алиева П.Р.	Негативные и позитивные факторы, влияющие на развитие трудового потенциала [5].

Существует множество классификаций, влияющих на формирование, использование и развитие трудового потенциала, но за основу нами принята классификация факторов, предложенная М.И. Маскаевым [2].

В данной классификации выделены факторы внешней среды, включающие глобализацию, миграцию, развитие инноваций, демографические, экономические, политические факторы. В данную группировку, на наш взгляд, можно добавить военно-стратегическую обстановку, которая в настоящее время оказывает большое влияние на формирование, использование и развитие трудового потенциала на всех уровнях управления.

В число факторов государственного регулирования включены государственное субсидирование, увеличение госзаказов, система налогообложения, развитие системы образования, государственная поддержка.

Непосредственное влияние на формирование и развитие трудового потенциала оказывают факторы регионального регулирования, особенно в сельской местности. В сельской местности условия деятельности организаций сильно отличаются от городских условий. Особое влияние оказывают природно-климатические условия, месторасположение, развитие регионов, отдаленность от центральной территории, исторические и национальные особенности.

К основным факторам регионального регулирования, влияющим на формирование и развитие трудового потенциала, необходимо, по нашему мнению, отнести: уровень жизни, благосостояние, уровень доходов конкретной территории; наличие инфраструктуры: детские сады, школы, возможность обучаться в СПО или в вузах, не покидая территории; наличие действующих организаций и рабочих мест; регулирование отношений между работодателями и работниками, наличие социальных программ финансируемых государством и т.д.

В следующую группу выделяются факторы внутренней среды организации, которые, безусловно, зависят от вышеперечисленных групп. К ним можно отнести мотивацию и формы оплаты труда персонала, регулирование состава и численности персонала, возможность обучения и карьерного роста, условия труда, стиль управления, имидж организации, организационная и корпоративная культура, социально-психологический климат и др.

Для более глубокого изучения трудового потенциала классификация по М.И. Маскаеву расширена авторами за счет добавления таких факторов как цифровизация экономики, вызванная пандемией и режимом удаленной занятости, усиление роли контроллинга.

По итогам совещания о состоянии рынка труда были разработаны предложения по внесению поправок в действующее трудовое законодательство об использовании цифровых технологий в трудовых отношениях и законодательному переходу на удаленный режим работы. Удаленный режим работы, по мнению Президента РФ Путина В.В., обеспечит возможности трудовой деятельности таким категориям граждан как люди с ограниченными возможностями, молодые мамы, малый бизнес, люди в удаленных местностях и др. [6].

Ускоренная цифровизация обеспечит переход на электронные трудовые книжки, электронный документооборот, предоставление и получение государственных и муниципальных услуг, расширит возможности обмена юридически значимыми документами посредством электронного документооборота, подписание и передачу налоговой и бухгалтерской (финансовой) отчетности субъектами малого и среднего бизнеса путем применения электронных цифровых подписей и специализированных цифровых комплексов и программ отечественного производства и т.д. [6].

Обобщая мнения ученых и специалистов в различных сферах деятельности, авторы пришли к выводу, что цифровизация обусловила внедрение современных цифровых технологий в кадровый документооборот, условий труда и занятости, появление новых цифровых платформ, внедрение новых должностей, что требует от работников постоянного совершенствования и развития компетенций. Все это изменило базовые принципы во взаимоотношениях работников и работодателей. Использование современных цифровых технологий в организации позволяет сократить время для получения результатов: поиск и подбор персонала, виртуальное оформление отпусков, командировок, дистанционного повышения квалификации и т.д. В этой связи, каждая организация, освоившая цифровизацию, должна стать инновационной.

Однако с масштабным внедрением цифровых технологий и удаленной занятости во многих организациях появилось множество проблем, в частности, в сельских организациях регионального АПК. Так, на основании проведенного авторами анализа организаций регионального АПК, были выявлены определенные проблемы, которые препятствовали развитию цифровых технологий. К ним можно отнести:

- несовершенная нормативно-правовая база;
- отсутствие межведомственного взаимодействия по вопросам внедрения цифровой экономики;
- отсутствие финансовой поддержки;
- низкая квалификация;
- низкий уровень правовой, информационной и компьютерной грамотности населения.

Острой проблемой являются недостаточные знания и принятие самими сотрудниками цифровых инноваций. Для успешного внедрения цифровых технологий стоит, на наш взгляд, создать необходимый потенциал самой организации для ее оптимизации, вовлечь сотрудников в процессы цифровизации, поощрять, мотивировать их и предоставлять необходимые обучающие материалы, проводить инструктажи и семинары.

Для решения более глобальных проблем по внедрению цифровой экономики в регионе необходимо, по нашему мнению, создать Региональный Координационный Совет при Правительстве Республики Бурятия, в состав которого должны войти представители всех региональных министерств и ведомств, общественники, политики, представители бизнес-сообщества и профсоюзных объединений [7].

В настоящее время, наряду с цифровизацией, важным фактором, влияющим на формирование и развитие трудового потенциала в организациях регионального АПК, по нашему мнению, является усиление роли контроллинга. Развитие системы контроллинга персонала в организации обеспечит непрерывное совершенствование форм, методов и приемов работы с кадрами, позволит успешно перенимать и применять разработки отечественной и зарубежной науки, а также передовые достижения производственного опыта.

Контролинг персонала, по нашему мнению, объединяет комплекс мер информационно-аналитической и методической поддержки принятия управленческих решений в деятельности организации, содействует систематизации больших информационных потоков, своевременному и качественному предоставлению необходимой информации на различных уровнях управления, совершенствованию методов обработки и анализа экономической информации с применением последних достижений в области компьютерной техники [8].

Особую значимость контролинг персонала приобретает в сельскохозяйственных организациях регионального АПК. Как уже отмечалось выше, данные организации имеют проблемы в своем развитии, такие как сезонный характер сельскохозяйственного производства, высокая трудоемкость, слабый уровень ключевых компетенций сотрудников, низкий уровень мотивации сотрудников и оплаты труда, стагнация кадровой системы, деятельность в различных климатических условиях, существенно различающейся по территориям региона (северные и южные районы).

Все это требует от руководителей сельскохозяйственных организаций умения видеть перспективы, принимать обоснованные стратегические решения. Поэтому, в данном случае, контролинг персонала позволяет выстроить согласованную систему подходов, методик, технологий по управлению изменениями во всех подсистемах организации, так как в практическом применении система контроллинга содействует установлению организационно-экономических, социально-психологических и правовых отношений субъекта и объекта управления, в основе которых лежат принципы, методы и формы воздействия на интересы, поведение и деятельность работников в целях максимального их использования.

Вышеуказанные положения подчеркивают актуальность развития теоретико-методологических положений и практики внедрения системы контроллинга персонала в сельскохозяйственных организациях, так как внедрение и развитие системы контроллинга персонала на сельскохозяйственном предприятии позволит эффективно использовать и развивать трудовой потенциал; служить инструментом повышения ответственности руководителей и мотивации персонала за результативность их деятельности, в установленные планом сроки намеченных заданий.

Внедрение совершенной системы контроллинга позволит обеспечить систематический и квалифицированный контроль над функционированием всех звеньев организации сельского

хозяйства в их взаимодействии и взаимозависимости, относительно реализации мероприятий, намеченных планом; позволит вскрывать недостатки практики планирования, оптимизировать их посредством своевременного внесения необходимых коррективов.

В настоящее время, с учетом сложившейся ситуации в стране (удаленная занятость, цифровизация экономики, сокращение рабочих мест, последствия пандемии), условия жесткой конкуренции наложили отпечаток на деятельность организаций в сельской местности: удаленность от центральных районов, нехватка средств на обучение сотрудников, проблемы с внедрением новых IT технологий и т.д.

Выводы

Анализируя факторы, влияющие на формирование трудового потенциала, следует отметить такую группу как социально-демографическая, которая отражает состояние физического и психического здоровья трудового потенциала работника организации.

Не менее значимыми факторами, влияющими на формирование, использование и развитие трудового потенциала, являются такие как цифровизация экономики и удаленная система занятости. Цифровизация изменила базовые принципы во взаимоотношениях работников и работодателей: внедрение современных цифровых технологий в кадровый документооборот, условий труда и занятости, появление новых цифровых платформ, внедрение новых должностей, что требует от работников постоянного совершенствования и развитие компетенций.

Внедрение системы контроллинга в организации регионального АПК позволит, в свою очередь, создать определенную систему подходов, методик, технологий по управлению изменениями во всех подсистемах организации. В практическом применении система контроллинга позволит установить организационно-экономические, социально-психологические и правовые отношения между работниками.

БИБЛИОГРАФИЯ

- Федеральная служба государственной статистики (Росстат) Сельское хозяйство в России 2021. Статистический сборник. Москва. 2021
- Маскаев М. И. Система и механизм управления трудовым потенциалом современной организации. Дис. на соиск. уч. ст. к.э.н. Пенза. 2014
- Волков И.В., Афанасьева И.В., Горохов В.А. Факторы эффективного использования трудового потенциала [Электронный ресурс] //Вестник НГИЭИ. – №5 (60). – 2016. – С.18-25. – Режим доступа: <https://cyberleninka.ru/article/n/factory-effektivnogo-ispolzovaniya-trudovogo-potentsiala/viewer> (дата обращения 17.03.2022 г.).
- Генкин Б. М. Экономика и социология труда : учеб. для вузов /Б. М. Генкин. — 7-е изд., доп. — М. : Норма, 2007. — 448 с.
- Алиева П.Р. Факторы развития национального трудового потенциала //Современные проблемы науки и образования. – 2014. – №5. – Режим доступа: <https://science-education.ru/ru/article/view?id=14994> (дата обращения 17.03.2022 г.).
- Путин поручил цифровизировать трудовое законодательство - CNews <https://cnews.ru> 15 Дек 2020 Интернет Плюс
- Каурова О.А., Кушнарева И.Г. Имедеева И.В. Место цифровой экономики в системе управления

персоналом в международных организациях, промышленных предприятиях Материалы международной научно-исследовательской конференции: Развитие монгольской рыночной демократической экономики: выход и решения №11, Улаан Баатар, 2020.

Каурова О.А., Дондокова Е.Б., Слепнева Л.Р. Особенности контроллинга персонала на сельскохозяйственных предприятиях //Международный научно-исследовательский журнал. №5 (95). Ч. 2. Май. 2020. С.49-56.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЗАСАГЛАЛ, МЕНЕЖМЕНТ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ ХӨДЛӨЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, ЧИГ ХАНДЛАГА (БНСУ-ын ХНУЯ-ны жишээн дээр)

Б.Цацралт

Доктор (Ph.D.), СЭЗИС, Салбар дундын судлалын тэнхим, ахлах багш, tsatsralt.b@ufe.edu.mn



Түлхүүр үг

Төрийн албаны төв байгууллага, бие даасан байдал, шударга байдал, төвлөрсөн удирдлага, хүний нөөцийн чиг үүргүүд, удирдлага зохион байгуулалт, төрийн албаны тухай хууль

Хураангуй

Төрийн албаны төв байгууллага нь тухайн улс орны төрийн албаны тогтолцоо дахь хүний нөөцийн удирдлагын чиг үүргүүдийг нэгтгэн удирддаг байгууллага тул аль ч улс оронд бүтэц зохион байгуулалтын аль нэг хэлбэрээр үйл ажиллагааг явуулж байдаг. Ингэхдээ удирдлага, зохион байгуулалтын хувьд ямар бүтэцтэй, мөн ямар статустай байх, улмаар хүний нөөцийн удирдлагын ямар чиг үүрэгт төвлөрөн үйл ажиллагаа явуулахаас хамаарч төрийн албаны тогтолцоонд хэсэгчилсэн болон бүхэлд нь нөлөөлж байдаг.

Тус судалгаа нь БНСУ-ын төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ-ны бие даасан байдал, үйл ажиллагааны шударга байдал, хүний нөөцийн чиг үүргүүдийн төвлөрсөн байдал зэргийг шинжилж авч үзлээ. Судалгааны үр дүнд БНСУ-ын ХНУЯ-ны бие даасан байдал буюу улс төрөөс хараат бус байдал хэсэгчилсэн байдлаар хангагдсан болох, түүнчлэн үйл ажиллагааны “шударга байдал” ХНУЯ-ны харьяа байнгын, байнгын бус үйл ажиллагаатай 9 Хороо нь хамтын удирдлагын зарчимд суурилсан, шийдвэр гаргах үйл явц зөвшилцөлд суурилсан болох, улмаар төрийн албаны хүний нөөцийн маргаантай шийдвэрийг шалган тогтоох, шударга бус шийдвэрийг цуцлах, эсвэл засвар өөрчлөлт оруулах эрх бүхий Төрийн албан хаагчдын Маргаан зохицуулах Хороотой болох, ХНУЯ нь олгогдсон мандат болон чиг үүргийн хүрээнд төрийн албаны тогтолцоог нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангадаг гэж үзэж байна.

1. Удиртгал

Төрийн албаны төв байгууллага нь тухайн улс орны төрийн албан хаагчдад чиглэсэн хүний нөөцийн удирдлагын чиг үүргүүдийг нэгтгэн удирдаж, түүний хэрэгжилтэд нь хяналт тавьдаг байгууллага юм. Эхэн үедээ төрийн албаны тогтолцоог улс төрөөс ангид байлгах, шийдвэр гаргах үйл явц хамтын удирдлагын зарчмаар зөвшилцөлд хүрсний үр дүнд гардаг


байх, улмаар хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд шударга байдлыг сахиулахад (Pendleton Civil Service Reform Act, 1883) чиглэгдэж байсан. Харин өнөө цагт төрийн албаны төв байгууллага нь өмнөх цаг үеийн уламжлалт суурь зарчмаа баримтлахын зэрэгцээ төрийн байгууллагад хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх явцад үүсдэг хуваагдмал нөхцөл байдал, захиргааны үр ашиггүй байдлыг бууруулахад чиглэх болсон байна.

Төрийн албаны төв байгууллага нь зөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, шүүн шалгах, дүрэм журам батлах чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг. Чиг үүрэг бүрээр нарийвчлан авч үзвэл ① зөвлөх чиг үүрэгт эрх бүхий этгээд буюу шийдвэр гаргагчдад төрийн албаны тогтолцоонд баримтлах хүний нөөцийн бодлого, эрх зүйн орчны талаар чиглэл, зөвлөмж өгөх тухай асуудал ② хэрэгжүүлэх чиг үүрэг нь төрийн албаны тогтолцоонд хүний нөөцийн бодлого, холбогдох хууль тогтоомж, хүний нөөцийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулах тухай асуудал, ③ хяналт тавих чиг үүрэг нь төрийн албан хаагчдын өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, улмаар төрийн байгууллага дахь хүний нөөцийн үйл ажиллагаанд аудит хийх тухай асуудал, ④ шалган тогтоох буюу шүүн шалгах чиг үүрэг нь эрх бүхий албан тушаалтан, эсвэл төрийн байгууллагын шийдвэр төрийн албан хаагчийн эрхийг зөрчих, хууль бус шийдвэр гарсан тохиолдолд цуцлах, засвар өөрчлөлт оруулах хагас шүүх эрхтэй холбоотой үйл ажиллагааг, ⑤ дүрэм журам батлах чиг үүрэг нь төрийн албаны төв байгууллагын бие даасан шинжийг хамгийн хүчтэй илэрхийлдэг бөгөөд энэ нь төрийн албаны тогтолцоонд хүний нөөцтэй холбоотой дүрэм журам батлах, нийтэд тунхаглаж мөрдлөг болгох хагас хууль тогтоох эрхтэй чиг үүрэг юм.

Төрийн албаны төв байгууллагын үйл ажиллагааг бусад төрийн байгууллагуудтай харилцах ажил үүргийн харилцаанд тулгуурлан 1) бие даасан байдал, 2) шударга байдал, 3) төвлөрсөн байдал гэсэн шалгуураар тодорхойлж байдаг. Энэ нь улс төрөөс ангид харилцаа буюу бие даасан байдал; төрийн албаны төв байгууллагын бие даан шийдвэр гаргах хэлбэр; төрийн яамдын хүний нөөцийн алба нэгжид эрх шилжүүлсэн (итгэмжилсэн) хүний нөөцийн чиг үүргүүдийн харьцааг тус тус илэрхийлж байдаг.

Түүнчлэн төрийн албаны төв байгууллагын удирдлага, зохион байгуулалт улс орнуудад ихэвчлэн **үндсэн хоёр хэв шинж буюу** Хороо болон Яамны хэлбэрээр бүтэцлэгдэн үйл ажиллагаа явуулж байдаг. Өөрөөр хэлбэл төрийн албаны төв байгууллага нь үйл ажиллагаандаа дээр нэг бүрчлэн дурдсан улс төрөөс хараат бус байдал, шударга байдал, төвлөрсөн байдлыг бүрэн хадгалж чадсан Хороо, дээрх гурван шинжийг хэсэгчилсэн байдлаар хадгалж чадсан Яамны хэлбэрээр бүтэцлэгдэн үйл ажиллагаа явуулдаг. Сүүлийн үед улс орнууд төрийн албаны төв байгууллагаа дээрх хоёр хэлбэрийн давуу талуудыг нэгтгэж Хороог ямар нэг байдлаар Яамны зохион байгуулалтын хэлбэртэй холимог байдлаар бүтэцлэх болсон бөгөөд энэхүү бүтэц зохион байгуулалтын хэлбэрийг “экетик” буюу “хосолсон” хэлбэр гэж нэрлэдэг. Өнөөдөр дэлхийн ихэнх улс орнууд “хосолсон хэлбэрт” төрийн албаны төв байгууллагаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 1. Төрийн албаны төв байгууллагын харилцаа (Tobin Im, Yu Minbong, 2019)



Эх үүсвэр : Tobin Im ▪ Minbong Yu, *Personnel Management Theory : From the perspective of Government Competitiveness*, 2012, pp.132

2. Үндсэн хэсэг

Төрийн албаны төв байгууллага урт, дунд, богино хугацаанд хэрэгжиж ирсэн олон арван төрийн албаны шинэчлэлүүдийн гол тулгуур нь болж ирэхдээ амжилт ололт, алдаа оноо, туршлагыг хангалттай хуримтлуулж ирсэн байдаг. Тус судалгаанд БНСУ-ын төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ-ыг дээр дурдсан онолын үзэл баримтлалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд судалгааны субъект болгож сонгосон шалтгаан нь **нэгт**, БНСУ бол Монгол улстай яг ижил гараанаас буюу хөгжиж буй улс орны түвшнээс хөгжингүй улс орны түвшинд богино хугацаанд хүрч чадсан улс юм. Өөрөөр хэлбэл хөгжлийн хамтын ажиллагааны хандив тусламжийг “хүлээн авагч улс орон”-оос “хандивлагч улс орон” болж чадсан, тэр ч утгаараа Азийн нэлээдгүй улс орнуудад “хөгжлийн загвар” болгон суралцах, туршлага судлах улс орнуудын жагсаалтыг тэргүүлж байдаг.

Хоёрт, тухайн улс орны хөгжлийг түүчээлэх, үндэсний өрсөлдөх чадварыг бий болгоход төрийн онч мэргэн бодлого, түүний хэрэгжилтийг хангах төрийн захиргаа, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдал юу юунаас илүү чухал байдаг. Энэ нь тухайн улс орны төрийн албаны төв байгууллага хэр сайн ажиллаж чадсан эсэхээс шууд хамааралтай байдаг. БНСУ-ын ХНУЯ нь төрийн албаны үнэт зүйлсэд суурилсан хүний нөөцийн бодлогоо тодорхойлж, үндэсний төвшинд хэрэгжилтийг хангах явцдаа хөдөлмөрийн зах зээлээс чадварлаг ажиллах хүчнийг өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж төрийн албаа бүрдүүлж, албан тушаалын шатлал бүрд мэргэшүүлэх богино, дунд хугацааны кредит сургалтаар чадавхжуулж, түүнчлэн төрийн албан хаагчдад карьерын зорилгодоо хүрч чадах урам зориг, төрд ажиллах сэдэл, сэтгэл ханамжийг системтэй бий болгох замаар улс орныхоо төрийн албаны тогтолцоог нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар мэргэшсэн тогтвортой байдалд туштай чиглүүлж чадсан төрийн албаны төв байгууллага юм. Энэ нь Монгол төдийгүй аль ч улс орнууд бенчмаркинг гэхээс илүүтэйгээр авах гээхийн ухаанаар

ажиглалтад тулгуурлан өөрийн улс орны нийгмийн болон орчны өгөгдөлтэй уялдуулж эргэцүүлэл, дүгнэлт хийх хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн болно.

БНСУ-ын төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ нь 2014 оноос бие даасан хэлбэрээр үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Түүхэн хөгжлөөр нь авч үзвэл хараат бус буюу бие даасан байдлаар хамгийн анх 1999 онд Төрийн албаны Комисс байгуулагдсан ч 2008 онд татан буугдсан байдаг. Улмаар 1999 оныг хүртэл, мөн 2008~2013 оныг хүртэл БНСУ-ын төрийн албаны хүний нөөцийн асуудлыг Засаг захиргаа, Аюулгүй байдлын яам дахь Боловсон хүчний газраас төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага дахь хүний нөөцийн алба нэгжүүдийг нэгтгэн удирдах замаар төвлөрүүлэн удирддаг байсан.

БНСУ-ын нийт төрийн албан хаагчдын тоо 1,156,326 бөгөөд үүнээс 4,801 төрийн албан хаагч хууль тогтоох засаглалд, 18,429 төрийн албан хаагч шүүх засаглалд, харин 1,129,545 төрийн албан хаагч гүйцэтгэх засаглалд тус тус ажиллаж байна (ХНУЯ, 2022)⁴⁴. Төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ-нд 539 төрийн албан хаагчид ажилладаг бөгөөд бүтэц зохион байгуулалтын хувьд 4 алба, 4 газар, 27 хэлтэс, түүнчлэн 2 харьяа агентлаг (Хүний нөөцийн хөгжлийн Үндэсний Хүрээлэн, Төрийн албан хаагчдын Маргаан Зохицуулах Хороо), 1 харьяа байгууллага (Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж хариуцсан газар) гэсэн бүрэлдэхүүнээр үйл ажиллагаа явуулдаг. Чиг үүргийн хувьд ① төрийн албаны хүний нөөцийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх; ② төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн системийг нэгтгэн удирдах; ③ төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн үйл ажиллагаанд инновацыг нэвтрүүлэх; ④ төрийн удирдах албан тушаалд нэр дэвшигчдийн судалгаа хийх, санал болгох; ⑤ төрийн албан хаагчдын ҮЭХ-той хэлэлцээр хийх, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх; ⑥ төрийн албанд элсүүлэх, сонгон шалгаруулах; ⑦ төрийн албан хаагчийн сургалт хөгжил; ⑧ төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлага; ⑨ төрийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмж (нөхөн олговор)-ийн асуудал; ⑩ төрийн албан хаагчдын өргөдөл гомдол хянах гэх зэрэг үйл ажиллагааг хариуцан эрхэлдэг.

Онолын хэсэгт дурдсанчлан төрийн албаны төв байгууллагыг бусад төрийн байгууллагуудтай харилцах ажил үүргийн харилцаанд тулгуурлан 1) бие даасан байдал, 2) шударга байдал, 3) төвлөрсөн байдал гэсэн шалгуураар тодорхойлж авч үздэг.

Эхний шалгуур болох “бие даасан байдал”-ийг 1) улс төрөөс ангид байдал, 2) удирдах албан тушаалтны томилгоо, мөн 3) төсөв санхүүгийн бие даасан байдал зэргийг шинжилж дүгнэдэг. Улс төрөөс ангид байдал гэдэг нь төрийн тэргүүн (Ерөнхийлөгч) болон улс төрийн намаас хэр ангид байхыг илэрхийлдэг бөгөөд төрийн албаны хүний нөөцийн үйл ажиллагаанд улс төрийн хүрээнийхэн хөндлөнгөөс оролцохыг хориглох, улс төрийн нөлөөллөөр төрийн албанд шударга бус шийдвэр гаргахгүй байх, төрийн албан хаагчид тогтвортой ажиллах баталгааг бүрэн хангаж чадсан түвшинд байхыг илэрхийлдэг. Төрийн албаны төв байгууллагын улс төрөөс ангид байдлыг “удирдлагын баг бүрдүүлэлт (томилгоо)” болон тэдний тогтвортой ажиллах нөхцөлөөр хэр хангагдсан байдлыг нягтлан авч үздэг.

⁴⁴ <https://www.mpm.go.kr/mpm/ebook/2022stat/ecatalog5.html>

БНСУ нь ерөнхийлөгчийн засаглалтай улс бөгөөд Үндсэн хууль, Парламентын тухай хууль тогтоомжид үндэслэн Үндэсний Ассамблейн зөвшөөрөл авах ёстой 17 албан тушаал⁴⁵ мөн Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид үндэслэн нэр заагдсан 42 албан тушаалыг⁴⁶ Үндэсний Ассамблейн зөвшөөрөлд үндэслэн томилдог.

ХНУЯ-ны сайд болон дэд сайд нь дээрх нэр заагдсан албан тушаалын жагсаалтад багтдаггүй тул бүрэн эрхийн хугацаа заагдахгүйгээр Ерөнхийлөгчөөс тус тус шууд томилогддог. ХНУЯ-ны сайд нь улс төрийн албан тушаалтан, харин дэд сайд нь Удирдах албан тушаалтны бүлгэм (Senior Civil Service)-ээс томилогддог ерөнхий албаны “А” зэрэглэлийн төрийн албан хаагч⁴⁷ байдаг. ХНУЯ-ны сайд тогтвортой ажиллах нөхцөл хэр зэрэг хангагдсан болохыг өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа (2017~2022)-нд авч үзвэл нийт 3 удаагийн томилгоо хийгдсэнээс хамгийн урт хугацаанд ажилласан нь 2 жил 3 сар, хамгийн богино ажилласан нь 10 сар байсан бөгөөд тус албан тушаалыг эрхлэх дундаж хугацаа нь 1.5 жил байна. Дээрх хоёр үндэслэл, үүнд төрийн албаны төв байгууллагын удирдлагын томилгоо, тухайн албан тушаалд тогтвортой ажилласан хугацааг авч үзэхэд засаглалын онцлогоос хамаарч төрийн тэргүүн (Ерөнхийлөгч) шууд томилох эрх олгогдсон байдаг нь тухайн албан тушаалд ажиллах мөчлөгт шууд нөлөөлөх боломжийг бүрдүүлж, энэ нь төрийн албаны төв байгууллагын удирдлага улс төрөөс шууд хамааралтай болох нь харагдаж байна.

Хоёрт, БНСУ-ын ХНУЯ нь төрийн албан хаагчдын томилгоо, тэр дундаа удирдах албан тушаалтны томилгоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал удирдах албан тушаалтны томилгоонд хоёр арга замаар, ① Удирдах албан тушаалтны бүлгэм (Senior Civil Service)⁴⁸-д элсүүлэх, улмаар эрх бүхий албан тушаалтны санал болгосон нэр дэвшигч тухайн албан тушаалын шаардлага хангасан эсэхийг шалган тогтоох, ② нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулалт зохион байгуулах зэргээр чадварлаг удирдах албан тушаалтныг улс төрөөс хараат бус байдлаар томилогдох боломж, баталгааг хангаж өгдөг.

Эхний арга зам болох Удирдах албан тушаалтны бүлгэм (Senior Civil Service)-д элсүүлэх үйл явцыг ХНУЯ-ны сайдаар ахлуулсан Төрийн удирдах албан тушаалтныг шалгаруулах ШАЛГАЛТЫН ХОРОО зохион байгуулдаг. Тус хорооны бүрэлдэхүүн нь ХНУЯ-ны сайд, дэд сайдаас гадна иргэдийн төлөөллөөр итгэмжилж томилсон 7 гишүүн, нийт 9 гишүүнтэй,

⁴⁵ Үндсэн хуулийн 86-р зүйл, 98-р зүйл, 104-р зүйл, 111-р зүйлд үндэслэн Үндэсний Ассамблейн зөвшөөрлөөр томилогдох ёстой 17 албан тушаал, үүнд Ерөнхий сайд, УАГ-ын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, УХЦ-ийн дарга тус тус багтана.

⁴⁶ Төрийн зөвлөлийн гишүүн 18 хүн (* Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүний нэр заасан Ерөнхий сайд ба Төрийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчид), УХЦ-ийн 5 гишүүн (* 3 гишүүн нь ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ санал болгох), СЕХ-ны 6 гишүүн (*3 гишүүн нь Дээд шүүхийн Ерөнхий шүүгч санал болгох), ҮНДЭСНИЙ ТАГНУУЛЫН ГАЗРЫН ДАРГА, ТЕЛЕВИЗ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХОРООНЫ ДАРГА, Шударга өрсөлдөөний Хорооны дарга, СЗХ-ны дарга, ХЭҮК-ийн дарга, Ерөнхий прокурор, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ЦЕГ-ын дарга, ШТАБЫН ДАРГА НАРЫН НЭГДСЭН ХОРООНЫ дарга, БНСУ-ын Банкны ерөнхийлөгч, БНСУ-ын Өргөн нэвтрүүлгийн корпорацын ерөнхийлөгч, Улсын тусгай байцаагч, Төрийн өндөр албан тушаалтны гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга тус тус багтана.

⁴⁷ Ерөнхий сайдын 2022 оны 1864-р тушаал, “ХНУЯ ба түүний харьяа байгууллагуудын зохицуулалт ба хэрэгжилтийг хангах журам”, 2-р зүйл

⁴⁸ Удирдах албан тушаалтны бүлгэм нь төрийн бодлого тодорхойлох, боловсруулахад гол чухал үүрэг гүйцэтгэдэг Алба • Газрын удирдах албан тушаалтныг төрийн албанд тохирох хэрэгцээ шаардлага нь бий болсон газар буюу ажлын байранд хэрэгтэй цаг мөчид буюу зөв цаг үед мэдлэг ур чадвараар нь нээлттэй өрсөлдүүлэх зарчмаар сонгон шалгаруулж, томилох, тэдний гүйцэтгэл, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх замаар чадамжтай төрийг бий болгох зорилгоор улс орнууд төрийн албаны тогтолцоондоо нэвтрүүлж, мөн хэрэгжүүлдэг.

долоо хоногт 1 удаа, шаардлагатай гэж үзвэл тухай тухайн үед нь зохицуулалт хийж хуралддаг байна.

Төрийн яамдаас удирдах албан тушаалтны бүлгэмд элсүүлэхдээ юун түрүүн “Нэр дэвшигчийн ур чадварын сургалт”-д урьдчилж хамруулсаны дараа Төрийн удирдах албан тушаалтныг шалгаруулах ШАЛГАЛТЫН ХОРОО нь 1) Ур чадварын үнэлгээ (төрийн удирдах албан тушаалтны мэдлэг чадварын үнэлгээ); 2) Удирдах албан тушаалын шаардлага хангаж буй эсэхийг хянан хэлэлцэх гэсэн хоёр үе шаттай арга хэмжээ зохион байгуулдаг. Дээрх хоёр шалгалтад тэнцсэн төрийн албан хаагчдыг “Удирдах албан тушаалтны бүлгэм”-д бүртгэж, хүлээлэгт оруулдаг.

** БНСУ нь төрийн удирдах албан тушаалтны хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор карьерын системийн үндэс сууриа хадгалангаа хөгжингүй улс орнуудад амжилттай хэрэгжсэн Удирдах албан тушаалтны бүлгэм (Senior Civil Service)-ийн тогтолцоог 2006 оноос төрийн албаны тогтолцоондоо нэвтрүүлж эхэлсэн. БНСУ-ын Удирдах албан тушаалтны бүлгэм нь төрийн захиргааны төв байгууллагын “газрын дарга”-аас дээш албан тушаалын 1,500 орчим удирдах албан тушаалтнаас бүрддэг бөгөөд Засаг даргын орлогч, Боловсролын газрын орлогч дарга зэрэг нутгийн захиргааны байгууллагад томилогддог удирдах албан тушаалтнууд мөн энэ бүлгэмд хамаардаг.

Хоёр дахь арга зам болох “нээлттэй өрсөлдөөний зарчмаар удирдах албан тушаалд сонгон шалгаруулах” үйл ажиллагааны хувьд БНСУ-ын төрийн захиргааны төв байгууллага нь нийт удирдах албан тушаалын 30%-ийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар хувийн хэвшилд ажилладаг чадварлаг боловсон хүчин, бусад төрийн яамдад ажилладаг төрийн албан хаагчдаас сонгон шалгарсан иргэнийг томилох үүрэг хүлээсэн байдаг. Дээрх үндэслэлээр сонгон шалгаруулах ажиллагааг ХНУЯ тус тус зохион байгуулдаг бөгөөд хэрэв төрийн яамдын сайд нар бусад төрийн яамдаас шалгаруулж авах тохиолдолд “Удирдах албан тушаалтны бүлгэм”-д бүртгэлтэй байгаа удирдах албан тушаалтнаас харьяалал харгалзахгүйгээр тохирох хүнээ сонгон ажиллуулах боломжтой.

Хэрэв гаднаас буюу хувийн хэвшилд ажиллаж буй чадварлаг хүний нөөцөөс удирдах албан тушаалтны сул орон тоог бүрдүүлэх тохиолдолд Ур чадварын үнэлгээ (төрийн удирдах албан тушаалтны мэдлэг чадварын үнэлгээ)-нд тулгуурлан нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, тэнцсэн иргэнийг “тухайн албан тушаалд тавигдах хууль ёсны шаардлага” хангаж буй эсэхийг хянан хэлэлцэх хоёр дахь шатны хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. Хэрэв хувийн хэвشلээс өрсөлдөж буй энгийн иргэн “нэр дэвшигчийн ур чадварын сургалт”-д хамрагдах хүсэлт гаргавал ХНУЯ зохион байгуулалтыг хариуцдаг.

Төрийн яамд “Төрийн удирдах албан тушаалтныг шалгаруулах ШАЛГАЛТЫН ХОРОО”-ны үр дүнг дагаж мөрдөх боломжгүй хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ талаар дэлгэрэнгүй тайлбарыг хавсаргаж, ХНУЯ-ны дахин хянан хэлэлцэх хүсэлт гаргаж болдог (Ministry of Personnel Administration., 2016)⁴⁹ байна.

Төрийн яамдын сайд нар удирдах албан тушаалтны сул орон тоонд ажиллуулах хүсэлтэй төрийн албан хаагчийг юун түрүүн ХНУЯ-ны сайдтай зөвшилцөх, улмаар Ерөнхий сайдаар

⁴⁹ Төрийн удирдах албан тушаалтныг томилох журам 15.2

дамжуулан Ерөнхийлөгч эцэслэн томилох (Ministry of Personnel Administration, 2022)⁵⁰ байдлаар үйл явц өрнөдөг байна.

Дээрх үндэслэлүүд, тухайлбал Удирдах албан тушаалтны бүлгэм (Senior Civil Service)-д элсүүлэх, хувийн хэвшилд ажилладаг чадварлаг боловсон хүчнийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар удирдах албан тушаалд сонгон шалгаруулах болон тэнцсэн төрийн албан хаагч болон иргэнийг “Удирдах албан тушаалын шаардлага хангаж буй эсэхийг хянан хэлэлцэхдээ ХНУЯ-ны сайдаар ахлуулсан Төрийн удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах ШАЛГАЛТЫН ХОРОО ажлуулдаг болох, төрийн яамдын сайд нар удирдах албан тушаалтны сул орон тоонд ажиллуулах хүсэлтэй төрийн албан хаагчийг юун түүрүүн ХНУЯ-ны сайдтай зөвшилцөх зэргээр ХНУЯ голлох үүрэг оролцоотой байж, энэ нь “удирдах албан тушаалын томилгоо”-нд нээлттэй өрсөлдөөний зарчмаар шударга байдал, мөн хөндлөнгийн оролцооноос сэргийлсэн эрх ашгийг хамгаалж буй байдал зэрэгт үндэслэн улс төрөөс хараат бус байдлыг бүрэн хангасан үйл ажиллагаа явуулдаг гэж дүгнэж болох юм.

Гуравт, төрийн албаны төв байгууллагын төсөв санхүүгийн бие даасан байдал нь улсын төсвөөс тодорхой төсөв хуваарилуулах, эсвэл төрийн байгууллагаас тодорхой үнийн дүнгээр төсөв төвлөрүүлэх хэлбэрээр төсвийг бүрдүүлж бие даасан төсвийн хараат бус байдал нь хангагддаг. БНСУ-ын ХНУЯ-ны татварын орлого төвлөрүүлэх төсөв ба хөрөнгө оруулалтын төсвийн харьцаанд дүн шинжилгээ хийхэд эзлэх жингээр бага байж болох ч бие даасан төсвийн эх үүсвэр байна гэж харж байна. Тухайлбал 2022 оны төсвийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд ХНУЯ-ны нийт орлого нь 19,189.715 тэрбум вон төвлөрүүлэх, үүнээс 6.813 тэрбум вон нь ерөнхий нягтлан бодох бүртгэлийн данснаас, 19,182.902 тэрбум нь Төрийн албан хаагчдын тэтгэврийн сангийн орлогоос тус тус бүрдэж байна. Харин төсвийн нийт зарлага нь нийт 22,460.460 тэрбум вон, үүнээс 204.518 тэрбум вон нь ерөнхий нягтлан бодох бүртгэлээр, 22,255.942 тэрбум вон нь төрийн албан хаагчдын тэтгэврийн сангийн зарлагаас тус тус үүсэж байна (National Assambley Budget Office, 2022)⁵¹.

Түүнчлэн ХНУЯ-ны татварын орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийхэд 2022 оны татварын орлогын төсөв 60.758 тэрбум вон, харин татварын зарлагын төсөв 4,278.118 тэрбум вон байна. Эндээс татварын зарлагад татварын орлогын эзлэх жин 1.4% болж байна. Гэхдээ ерөнхий нягтлан бодох бүртгэлийн татварын орлого 60.758 тэрбум вон, зарлагын 4,278.112 тэрбум воны нийлбэрээс 4,073.600 тэрбум вон төрийн албан хаагчдын тэтгэврийн сангийн зарлагаар шилжүүлэгдэж энэ нь 26,795.066 тэрбум воны үнийн дүнтэй нийт зарлагад эзлэх жин нь 15.2% болж байна⁵².

Дээрх тооцоолол буюу ХНУЯ-ны төсвийн төлөвлөгөө болон татварын орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөнд үндэслэн авч үзэхэд үнийн дүнгийн хувьд харьцангуй бага хувь эзэлж байгаа ч төсөв санхүүгийн хувьд төрөөс 100% хамааралтай биш төрийн албаны төв байгууллага гэж дүгнэж болох юм.

Хоёр дахь шалгуур болох “шударга байдал” нь төрийн албаны хүний нөөцийн бодлого болон чиг үүрэгт хамаарах тодорхой чухал шийдвэр хэн нэгэнд онцгойлон давуу болон сул

⁵⁰ <https://www.mpm.go.kr/mpm/info/infoBiz/hrSystemInfo/hrSystemInfo03/>

⁵¹ 2022년 예산안 위원회별 분석 [행정안전위원회] : 인사혁신처 115~117쪽, 국회예산정책처 (National Assambley Budget Office)

⁵² мөн тэнд

тал үүсгэхгүй байхаар төвийг сахисан хэр хэмжээг илэрхийлж байдаг. Шударга байдлыг баталгаажуулах хамгийн сайн арга хэлбэр нь “зөвшилцөл” бөгөөд энэ нь аливаа шийдвэр гишүүдийн олонхын саналд тулгуурлан шийдвэрлэгдэх, ингэхдээ хагас шүүхийн чиг үүргийн хэрэгжилтийг ихэвчлэн илэрхийлдэг тул төрийн албаны төв байгууллага дахь шударга байдлыг 1) шийдвэр гаргах үйл явц зөвшилцөлд тулгуурладаг эсэх, 2) төрийн албан хаагчийн эрхийг зөрчсөн шийдвэр гарсан тохиолдолд шүүн шалгаж, шударга бус шийдвэрт засвар, өөрчлөлт оруулсан эсэх зэргээр хэмжигддэг.

БНСУ-ын төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ-ны шударга байдлыг дээрх хоёр шалгуурт тулгуурлан авч үзье. 2023 оны байдлаар ХНУЯ-нд төрийн албаны хүний нөөцийн тодорхой чиг үүргүүд, үүнд төрийн албанд сонгон шалгаруулж томилох, түүнчлэн төрийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмж, гэнэтийн ослын нөхөн төлбөр олгох, төрийн албан хаагчийн ёс суртахууны хэм хэмжээ, сахилга хариуцлагын асуудал, хүний нөөцийн шударга бус шийдвэр гарсан эсэхийг шалган тогтоох гэх мэт асуудлыг хянан хэлэлцэх, шийдвэрлэх зорилгоор байнгын болон байнгын бус үйл ажиллагаатай 9 Хороо (Ministry of Personnel Administration, 인사혁신처 위원회별 설치현황 및 활동내역서, 2023)⁵³-нд төрийн албан хаагч болон иргэний нийгмийн төлөөллөөс томилогдсон нийт 230 орчим гишүүд ажиллаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ХНУЯ-ны харьяа Байнгын Хороодын үйл ажиллагааны тойм

	Хорооны нэр	Эрх зүйн үндэслэл	Гишүүдийн тоо			Хуралдааны тоо (2022*)
			Хорооны дарга	Төрийн албан хаагч	Иргэний төлөөлөл	
1	Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөр олгох Хороо	Төрийн албан хаагчийн гэнэтийн ослын нөхөн төлбөрийн тухай хууль, 52-р зүйл	<p><u>Нийт гишүүдийн тоо</u> : 45</p> <p>Хорооны дарга : ХНУЯ-ны сайд санал болгож Ерөнхийлөгч томилоно.</p> <p>Төрийн албан хаагч (8 гишүүн): <u>Албан ёсны 5 гишүүн</u>: СЭЗЯ, ТЗАБЯ, ХЭХЯ, Эх орончид, ахмад дайчдын хэрэг эрхлэх Яам, ХНУЯ-ны ХНУ-ын газар</p> <p><u>Итгэмжлэн томилох (2 гишүүн)</u>: Гуанжү Хот Галын аюулгүй байдлын штабын дарга, Захиргаа, Аюулгүй байдлын Хорооны ахлах эксперт</p> <p><u>Байнгын гишүүн</u>: Гамшгийн нөхөн төлбөрийн бодлого хариуцсан ажилтан</p> <p>Иргэний төлөөлөл (36 гишүүн) : Өмнө нь төрийн албанд ажиллаж байсан 4 гишүүн, Хуулийн салбарын 4 гишүүн, Эрүүл мэндийн салбарын 16 гишүүн, бусад мэргэжилтэн 5 гишүүн</p>			10 удаа
2	Төрийн албан хаагчдын маргаан хянан	Төрийн албан хаагчийн тухай хууль,	<p><u>Нийт гишүүдийн тоо</u> : 11</p> <p>Хорооны дарга : ХНУЯ-ны сайд санал болгож Ерөнхийлөгч томилоно.</p>			90 удаа

⁵³ Нээлттэй ажлын байранд Сонгон шалгаруулах Хороо, Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөрийн Хороо, Засгийн газрын Ёс зүйн Хороо, Сахилгын Хороо, Төрийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн Хороо, Төрийн албан хаагчдын хувьцаа эзэмшилтийг шалган тогтоох Хороо, Төрийн албан хаагчдын маргаан зохицуулах Хороо, Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөрийг хэлэлцэх Хороо гэх мэт

	шийдвэрлэх Хороо	9-р зүйл	Төрийн албан хаагч (4 гишүүн) : Хорооны дарга + <u>Байнгын 3 гишүүн</u> Иргэний төлөөлөл (7 гишүүн) : Сурган хүмүүжүүлэгч (3 гишүүн) + Мэргэжлийн талбарын хүн (4 гишүүн)	
3	Ёс зүйн Хороо	Төрийн албан тушаалтны ёс суртахууны хууль, 9-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо</u> : 12 (9+3) Хорооны дарга : Ерөнхийлөгч томилно. Төрийн албан хаагч (4 гишүүн) : <u>Албан ёсны гишүүн</u> : ХНУЯ-ны сайд + Засгийн газрын ТАХ (3 гишүүн) Иргэний төлөөлөл (8 гишүүн) : Сурган хүмүүжүүлэгч (4 гишүүн) + Мэргэжлийн талбарын хүн (4 гишүүн : Хорооны дарга багтана) + Сул орон тоо *шүүгч, прокурор, өмгөөлөгч, сурган хүмүүжүүлэгчээс Иргэний нийгмийн байгууллага санал болгох, Ерөнхийлөгч шууд томилох **Үндэсний Ассамблей, Дээд шүүх, ҮХЦ, СЕХ, Төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн захиргааны байгууллага, Аймаг-Нийслэл-Хотын Боловсролын газар ЁС ЗҮЙН ХОРОО-той байх	19 удаа (Төв Хороо-13, Салбар Хороо-3)
4	Сахилгын Хороо	Ерөнхийлөгч-ийн зарлиг, Төрийн албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулах тушаал, 3-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо</u> : 33 Хорооны дарга : ХНУЯ-ны сайд Төрийн албан хаагч (6 гишүүн) : Хаалттай мэдээлэл (Төрийн албан хаагчид сахилын шийтгэл оноох журам 20-р зүйл) *Байнгын гишүүний тоо : тоо заагаагүй Иргэний төлөөлөл (26 гишүүн) : Сурган хүмүүжүүлэгч (12 гишүүн) + Эдийн засагч ▪ Бизнесмен ▪ Санхүүч (3 гишүүн) + Мэргэжлийн талбарын хүн (8 гишүүн) + Тэтгэвэрт гарсан ТАХ (3 гишүүн)	2023 оны эхний 2 сарын байдлаар 3 удаа хуралдсан
5	Тэтгэврийн үйл ажиллагаа хариуцсан Хороо	Төрийн албан хаагчдын тэтгэврийн тухай хууль, 79-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо</u> : 17 Хорооны дарга : ХНУЯ-ны сайд Төрийн албан хаагч (8 гишүүн) : <u>Албан ёсны 7 гишүүн</u> : СЭЗЯ, Боловсролын яам, БХЯ, ЭМНХЯ, ХНУЯ-ны УАТБ (Удирдах албан тушаалтны бүлгэм)-д харьяалах төрийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмж, гэнэтийн ослын нөхөн төлбөртэй холбоотой ажил хариуцсан удирдах албан тушаалтан <u>Итгэмжлэн томилогдох (2 гишүүн)</u> : * Төрийн албан хаагчдын нийгэмлэгээс 2 гишүүн Иргэний төлөөлөл (9 гишүүн) : <u>Албан ёсны (1 гишүүн)</u> : Төрийн корпорацад санхүүгийн удирдлага хариуцсан гүйцэтгэх захирал, <u>Итгэмжлэн томилогдох (8 гишүүн)</u> : Сурган хүмүүжүүлэгч (4 гишүүн) + Иргэний нийгмийн байгууллага (4 гишүүн) + Тэтгэвэр авагч (2 гишүүн)	4 удаа

6	Хувьцаа эзэмшилтийг шалган тогтоох Хороо	Төрийн албан тушаалтны ёс суртахууны хууль, 14.5-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо : 9</u> Хорооны дарга : Ерөнхийлөгч томилно. Төрийн албан хаагч (2 гишүүн) : 2 гишүүн / Байнгын гишүүний тоо : 0 Иргэний төлөөлөл (7 гишүүн) : Сурган хүмүүжүүлэгч (2 гишүүн) + Эдийн засагч ▪ Бизнесмен ▪ Санхүүч (1 гишүүн) + Мэргэжлийн талбарын хүн (4 гишүүн)	12 удаа
7	Төрийн удирдах албан тушаалтныг шалгаруулах, хянан хэлэлцэх Хороо	Төрийн албан хаагчийн тухай хууль, 28.6-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо : 9</u> Хорооны дарга : ХНУЯ-ны сайд Төрийн албан хаагч (2 гишүүн) : ХНУЯ-ны сайд + Дэд сайд Иргэний төлөөлөл (7 гишүүн) : Гадаад харилцаа (1 гишүүн) + Анагаахын салбар (1 гишүүн) + Эдийн засгийн салбар (1 гишүүн) + Төрийн захиргааны салбар (1 гишүүн) + ШУ инженерчлэл (1 гишүүн) + Соёлын салбар (1 гишүүн) +Хуулийн салбар(1 гишүүн)	29 удаа
8	Нээлттэй албан тушаалд сонгон шалгаруулах Хороо	Ерөнхийлөгч-ийн зарлиг, Нээлттэй албан тушаал, нээлттэй сул орон тоог нөхөх журам	<u>Нийт гишүүдийн тоо : 5</u> Хорооны дарга : Санал хураалтаар сонгох, итгэмжлэн томилох Иргэний төлөөлөл (5 гишүүн) : Сурган хүмүүжүүлэгч (4 гишүүн) + Нийтийн алба (1 гишүүн)	202 удаа
9	Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөрийг хэлэлцэх Хороо	Төрийн албан хаагчийн гэнэтийн ослын нөхөн төлбөрийн тухай хууль, 6-р зүйл	<u>Нийт гишүүдийн тоо : 88</u> Хорооны дарга : Тухайн хэлэлцүүлэг бүрд шинээр томилох, итгэмжлэн томилох Төрийн албан хаагч (6 гишүүн) : СЭЗЯ, ТЗАБЯ, ХЭХЯ, Эх орончид, ахмад дайчдын хэрэг эрхлэх Яам, ХНУЯ-нд харьяалан хариуцсан хэлтсийн дарга <u>Итгэмжлэн томилогдох (1 гишүүн)</u> : Төрийн албан хаагч (1 гишүүн) Иргэний төлөөлөл (82 гишүүн) : Эрүүл мэндийн салбар (59 гишүүн) + Хуулийн салбар (9 гишүүн) + өмнө нь төрийн албан хаагчаар ажиллаж байсан иргэн (7 гишүүн) + Бусад (7 гишүүн)	113 удаа

Эх үүсвэр :

https://www.mpm.go.kr/mpm/open/referDataList/?boardId=bbs_000000000000042&mode=view&cntId=917&category=&pageIdx -д тусгагдсан дэлгэрэнгүй агуулгыг хураангуйлан нэгтгэв.

Шударга байдлын эхний шалгуур болох “шийдвэр гаргах үйл явц зөвшилцөлд тулгуурладаг эсэх”-ийг Хүснэгт 1-г нарийвчлан харуулснаар авч үзвэл Хороодын бүтэц зохион байгуулалт нь хамтын удирдлагын зарчимд суурилсан болох нь харагдаж байна. Илүү тодорхой шинжилж харах үүднээс дээрх 9 Хороодоос “Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын хохирлыг барагдуулах Хороо”-г санамсаргүй түүврийн аргаар сонгож үйл

ажиллагааны эрх зүйн үндэслэл, бүрэлдэхүүн, хуралдааны тоонд харьцуулалт хийж авч үзье. Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөр олгох тухай хууль (Public officials' accident compensation act, 2018)-ийн 6-р зүйлд “Төрийн албан хаагчийн гэнэтийн осолд нөхөн төлбөр олгохтой холбоотой асуудлууд, албан үүргээ гүйцэтгэх явцад нас барсан болохыг хүлээн зөвшөөрөх тухай асуудал, гэнэтийн ослын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ, тахир дутуугийн тэтгэвэр тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон нөхөн олговор, эрсдэлтэй хүнд албан үүрэг гүйцэтгэж яваад амиа алдагсдад олгох тэтгэвэр болон нөхөн олговор, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлтэй холбоотой асуудлууд, Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөрийн тогтолцоотой холбоотой бусад асуудлуудыг хэлэлцэх зорилгоор ХНУЯ-нд Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын хохирлыг барагдуулах Хороог байгуулах, нийт 100 хүртэлх гишүүдтэй байх, Хорооны даргыг гишүүд дундаас ХНУЯ сайд томилох, эсвэл итгэмжилж болно” гэж тус тус нарийвчлан заасан байна. Дээрх эрх зүйн үндэслэлд тулгуурлан Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын хохирлыг барагдуулах Хороо нь нийт 88 гишүүдтэй, үүнээс 6 гишүүн нь төрийн албан хаагчдын төлөөлөл, үүнд СЭЗЯ, ТЗАБЯ, ХЭХЯ, Эх орончид, ахмад дайчдын хэрэг эрхлэх Яам, ХНУЯ-нд тус асуудлыг хариуцсан хэлтсийн дарга тус тус багтдаг. Иргэний нийгмийн төлөөллөөс салбар салбарын төлөөллийн оролцоог хангасан нийт 82 гишүүд байдгаас эрүүл мэндийн салбараас 59 гишүүн, хуулийн салбараас 9 гишүүн, өмнө нь төрийн албан хаагчаар ажиллаж байсан иргэдээс 7 гишүүн, бусад 7 гишүүнээс тус тус бүрдэж байна. Мөн тус Хорооны хуралдааны тоо 2022 оны байдлаар нийт 113 удаа хуралдсан (Ministry of Personnel Administration, Civil Servants' Accident Compensation Deliberative Committee, 2023)⁵⁴ гэж бүртгэгдсэн байна. Дээрх дүн шинжилгээнд үндэслэн БНСУ-ын төрийн албаны тогтолцоонд Төрийн албан хаагчдын гэнэтийн ослын нөхөн төлбөртэй холбоотой асуудал нь “хамтын удирдлагын зарчимд суурилсан Хороо”-оос шийдэгддэг болох, түүнчлэн шийдвэр гаргах үйл явц хэт нэг талыг барьсан шийдвэр гаргахгүй байх талаас оролцогч талуудын зохих төлөөллийг хангаж, “зөвшилцөл”-д суурилах боломжийг бүрэн хангаж шийдвэрлэгддэг гэж дүгнэж болохоор байна.

Шударга байдлыг бататгах хоёр дахь шалгуур болох төрийн албан хаагчийн эрхийг зөрчсөн шийдвэр гарсан тохиолдолд үүнийг шалгаж тогтоох, шударга бус шийдвэрт өөрчлөлт оруулдаг эсэхийг Төрийн албан хаагчдын Маргаан Зохицуулах Хорооны үйл ажиллагаанд тулгуурлан авч үзье. Түүхэн хөгжлөөр нь авч үзвэл тус Хороо Хүснэгт 1-т нэг бүрчлэн танилцуулагдсан 9 Хорооноос хамгийн эрт буюу 1963 оноос үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд Төрийн албаны тухай хууль (State Public Officials act : 1949)-ийн 9-р зүйлд “Төрийн захиргааны байгууллагад ажиллаж буй төрийн албан хаагчидтай холбоотой сахилгын шийтгэл хууль бус, үндэслэлгүй оноогдсон эсэх, энэ нь тухайн төрийн албан хаагчийн үзэл бодол, байр суурийн эсрэгээр шийдэгдсэн эсэхийг шалган тогтоох, хянан шийдвэрлэх зорилгоор ХНУЯ-нд Төрийн албан хаагчдын Маргаан зохицуулах Хороог байгуулах (State Public Officials act, 1949), нийт 5~7 гишүүдтэй байх ба байнгын бус гишүүд нь байнгын гишүүдийн хоёрны нэгээс дээш байх, хорооны дарга нь улс төрийн албан тушаалтан байх” гэж тус тус нарийвчлан заасан байдаг. Дээрх эрх зүйн үндэслэлд тулгуурлан Төрийн албан

⁵⁴https://www.mpm.go.kr/mpm/open/referDataList/?boardId=bbs_000000000000042&mode=view&cntId=917&category=&pageIdx=

хаагчдын Маргаан зохицуулах Хороо нийт 10 гишүүдтэй, үүнээс 4 гишүүн нь төрийн албан хаагчдын төлөөллөөс томилогдсон байнгын гишүүд бөгөөд тус ажлын байранд тавигдах шаардлага нь 3-р зэрэглэлээс дээш, Удирдах албан тушаалтны бүлгэмд 3 жилээс дээш ажилласан Төрийн албан хаагчийг ХНУЯ-ны сайд санал болгож Ерөнхийлөгч томилдог. Тус албан тушаалыг эрхлэх явцад өөр албан тушаал хавсарч эрхлэхийг хориглож, бүрэн эрхийн хугацаа нь 3 жил, дахин сонгогдох эрхгүйгээр томилогддог байна.

Иргэний нийгмийн төлөөллөөс нийт 7 гишүүд, үүнээс 3 гишүүн нь сурган хүмүүжүүлэгч, 4 гишүүн нь мэргэжлийн талбарт ажилладаг байнгын бус гишүүд байх, ингэхдээ шүүгч, прокурор өмгөөлөгчөөр 5-аас доогүй жил ажилласан байх, түүнчлэн их дээд сургуульд төрийн удирдлага, бодлого судлал, хууль эрх зүйн хичээл заадаг дэд профессороос дээш зэрэглэлд 5-аас доошгүй жил ажилласан байх шаардлага тус тус тавигддаг. Чиг үүргийн хувьд сахилгын шийтгэлтэй холбоотой гомдол давж заалдах асуудал мөн эсэхийг шалган тогтоох, түүнчлэн өргөдөл гомдлын хүрээнд Төрийн албан хаагчтай холбоотой хүний нөөц ▪ ажиллах нөхцөл болон байгууллагын бүтэц, зохион байгуулалтаас хамааралтай хууль бус шийдвэрүүд, түүнчлэн бэлгийн дарамт болон шударга бус үйлдлийг шалган тогтоох асуудлыг хянаж хэлэлцдэг.

Тус Хороо 2022 оны байдлаар нийт 90 удаа хуралдсан бөгөөд сахилгын шийтгэлтэй холбоотой 850 өргөдөл гомдол хүлээн авснаас 821 асуудлыг шалган тогтоохдоо Төрийн албан хаагчдын эрх ашгийг зөрчсөн хуульд нийцээгүй 40 шийдвэрийг цуцлах, 149 шийдвэрт өөрчлөлт оруулах, 632 шийдвэрт үл хэрэгсэх болон өргөдөл гомдлыг буцаах гэж тус тус шийдвэрлэсэн байна (Appeals Commission, 2023)⁵⁵.

Маргаан зохицуулах Хороонд хандсан төрийн албан хаагчдыг эрхэлсэн ажил үүргийн байдлаар ангилан авч үзвэл 305 цагдаагийн офицер, 100 гал сөнөөгч, 30 засан хүмүүжүүлэгч, 13 татварын ажилтан, 373 ерөнхий албаны төрийн албан хаагчид бөгөөд сахилгын зөрчлөөр нь төрөлжүүлэн авч үзэхэд Төрийн албан хаагчийн нэр төрийг сахих үүргээ зөрчсөн 312 зөрчил, шударга байх үүргээ зөрчсөн 27 зөрчил, үнэнч байх үүргээ зөрчсөн 202 зөрчил, дүрэм зөрчсөн 68 зөрчил, хохирол учруулсан 175 зөрчил, сахилгын торгуультай холбоотой 37 зөрчлийн шийдвэрийг хянан хэлэлцсэн байна. Улмаар дээрх сахилгын зөрчлүүдэд үндэслэн төрийн албанаас бүрэн чөлөөлөх 14 шийдвэр, төрийн албан тушаалаас халах 96 шийдвэр, албан тушаал бууруулах 44 шийдвэр, тодорхой хугацаанд төрийн албанд ажиллахыг хориглох 143 шийдвэр, албан тушаалын цалин бууруулах 129 шийдвэр, сануулга өгөх 183 шийдвэр, бусад 178 шийдвэр, сахилгын торгууль 37 шийдвэр тус тус эзэлж байна.

Дээрх тоон баримтад тулгуурлан Маргаан зохицуулах Хороо нь төрийн албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэсэн байдал, сахилгын зөрчлийн хэлбэр болон шийтгэлтэй холбоотой шийдвэрийн үр дүнг нэгтгэн авч үзэхэд төрийн албан хаагчдын эрх ашгийг зөрчсөн, хүний нөөцийн шударга бус маргаантай асуудлыг шалган тогтоох, улмаар шударга бус шийдвэрийг цуцлах, мөн засвар өөрчлөлт оруулах зэргээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилладаг болох нь харагдаж байна. Энэ нь БНСУ-ын төрийн албаны тогтолцоонд ХНУЯ-ны үйл ажиллагаа, тэр дундаа хүний нөөцийн чиг үүргүүд

⁵⁵ https://sochung.mpm.go.kr/home/page/sub7_3.do

“шударга байдал”-ыг хангаж хэрэгжих боломж нөхцөлийг бүрдүүлдэг болохыг олж харж болох юм.

Гурав дахь шалгуур болох “төвлөрсөн байдал” нь төрийн албаны хүний нөөцийн чиг үүрэг төрийн албаны төв байгууллага ба төрийн яамдын хооронд хэрхэн хуваарилагдаж байгааг илэрхийлж байдаг. Төвлөрөл нь “байгууллагын ерөнхий онол”-оор тайлбарлагддаг “төвлөрөл”, “төвлөрлийг сааруулах” зүй тогтлыг хүний нөөцийн эрх мэдлийн хуваарилалтад мөн адил хэрэгжүүлдэг. Тухайлбал төрийн албанд баримтлах хүний нөөцийн удирдлагын нэгдсэн зарчмыг боловсруулж, хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн албаны төв байгууллагыг байгуулж, төрийн яамд (байгууллага) бүрд салангид хэрэгжиж ирсэн хүний нөөцийн эрх мэдлийг энд төвлөрүүлэн удирдах явдал юм.

ХНУЯ нь төрийн албаны хүний нөөцийн бодлого боловсруулж, хэрэг жилтийг хангах; төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн системийг нэгтгэн удирдах; төрийн албанд элсүүлэх, сонгон шалгаруулах; төрийн албан хаагчийн сургалт хөгжил; төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлага; төрийн албан хаагчдын тэтгэвэр тэтгэмж (нөхөн олговор)-ийн асуудал; төрийн албан хаагчдын маргааныг шалган тогтоож, хянаж хэлэлцэх гэсэн чиг үүргүүдийг төрийн албаны тогтолцоонд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар төвлөрүүлэн удирддаг. Чиг үүрэг бүрээр нарийвчлан авч үзэх боломжгүй тул дараах байдлаар тодорхой чиг үүргүүдэд тулгуурлан дүн шинжилгээ хийж байна.

Тухайлбал ХНУЯ-аас 2011 оноос хойш жил бүр PUBLIC JOB FAIR (Ministry of Personnel Administration, *공직박람회*, 2022)⁵⁶ зохион байгуулдаг бөгөөд энэ нь төрийн албанд ажиллах хүсэл сонирхолтой чадварлаг иргэдийг төрийн албанд татах буюу нөөц бүрдүүлэх арга хэмжээг үндэсний түвшинд төрийн яамд болон төрийн байгууллагуудыг татан оролцуулж нэгдсэн удирдлагаар хангадаг байна. 2022 оны хувьд тус арга хэмжээнд нийт 66 төрийн байгууллага, үүнээс төрийн захиргааны төв байгууллага 45, нутгийн захиргааны 13 байгууллага, УАГ, СЕХ, Үндэсний Ассамблейн ажлын алба, түүнчлэн 5 төрийн байгууллага тус тус оролцож төрийн албаны сонгон шалгаруулалттай холбоотой танилцуулга, онлайн зөвлөгөө, ярилцлага, түүнчлэн захиргааны үйл явцад гарсан шилдэг ололт амжилтуудыг танилцуулах зэрэг олон талт арга хэмжээг хүүхэд залуучууд, оюутнууд, энгийн иргэд, төрийн албанд ажиллах хүсэл сонирхолтой иргэдэд чиглүүлж зохион байгуулсан байна.

Түүнчлэн төрийн албанд сонгон шалгаруулах, томилох ажиллагааг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд, мөн нийтийн албан байгууллагаас ирүүлсэн орон тооны захиалгад үндэслэн календарчилсан төлөвлөгөөгөөр үндэсний төвшинд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар явуулдаг. Тухайлбал төрийн албаны гүйцэтгэх болон удирдах албан тушаалд нээлттэй, өрсөлдүүлэх зарчмаар сонгон шалгаруулалтыг ХНУЯ-ны Төрийн албанд сонгон шалгаруулах ШАЛГАЛТЫН ХОРОО бие даан зохион байгуулдаг байна.

Мөн төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалт, хөгжлийн нэгдсэн тогтолцоог ХНУЯ-нд төвлөрүүлэн удирддаг. Энэ нь Хүний нөөцийн хөгжлийн Үндэсний Хүрээлэн (National Human Resources Development Institute)-ээс төрийн захиргааны төв байгууллага дахь бүх төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн асуудлыг танхимын болон

⁵⁶ <https://www.mpm.go.kr/mpm/info/fair/publicFair/expo2022/overview/overview03/>

танхимын бус, богино болон дунд хугацааны, түүнчлэн албан тушаалын зэрэглэл бүрээр квот тогтоосон кредит сургалтуудад хамрагдахад нэгдсэн удирдлагаар чиглүүлж, зохион байгуулалтыг хангаж ажилладаг байна.

Түүнчлэн ХНУЯ нь админы эрхтэй хүний нөөцийн стандарчлагдсан цахим систем болох “e-SARAM”-аар төрийн албаны ХНМС-ийг нэгтгэн удирддаг. БНСУ-ын Засгийн газрын харьяа бүх төрийн байгууллагад ажиллагсадтай холбоотой цахим бүртгэл, үүнд төрийн албанд ажилд авахаас эхлээд тэтгэвэрт гарах бүх үйл явц болох цалин хөлс, амралтын хуваарь, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, сургалт хөгжлийн байдал зэрэг бүх мэдээллийг цахимжуулж мэдээллийн сангийн баяжуулалт хийх, өгөгдөл солилцох, хамгаалах, ашиглалтыг хангаснаар төрийн байгууллага дахь хүний нөөцийн аливаа шийдвэр оновчтой гарах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлэх, нөгөөтээгүүр төрийн албаны тогтолцоог нэгдмэл удирдлагаар хангах ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО боловсруулалт, шийдвэр гаргагчид, оролцогч талуудыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах үйл ажиллагааг дэмждэг. Нэмж дурдахад “e-SARAM” нь нийт 59 цахим сантай мэдээлэл харилцан шейрэлдэг байна.

ХНУЯ-ны дэргэд байнгын болон байнгын бус хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг 9 Хороо нь төрийн албаны тогтолцоонд “шударга байдлыг хангах” хүрээнд бүх төрийн албан хаагчдад чиглэсэн сахилга хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, төрийн албан хаагчдын гэнэтийн осолд нөхөн төлбөр олгох тогтолцоо, тэтгэвэр тэтгэмжийн тогтолцоо, маргаан зохицуулах ажиллагаа, хөрөнгө орлогын мэдүүлэг, хувьцаа эзэмшилтийг тогтоох зэрэг хүний нөөцийн чиг үүргүүдийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж үйл ажиллагаа явуулдаг.

Дээрх чиг үүргүүдэд нарийвчлан авч үзсэнээр өмнө нь төрийн яамд (байгууллага) бүрд салангид байдлаар хэрэгжиж ирсэн төрийн албаны хүний нөөцийн эрх мэдэл, чиг үүргүүдийг төрийн албаны төв байгууллага болох ХНУЯ-нд нэгтгэн төвлөрүүлж, улмаар нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж байна гэж дүгнэж болох юм.

Дүгнэлт хэсэг

Төрийн албаны төв байгууллагыг улс төрөөс ангид бие даасан байдал, үйл ажиллагааны шударга байдал, төрийн албаны хүний нөөцийн чиг үүргүүдийн төвлөрсөн байдал гэсэн гурван шалгуураар, шалгуур бүрд холбогдох дэд элементүүдэд уялдуулан БНСУ-ын ХНУЯ-ыг шинжилж авч үзлээ.

Судалгааны үр дүнд эхний шалгуур болох улс төрөөс ангид бие даасан байдал нь “удирдлагын томилгоо” буюу ХНУЯ-ны сайдын томилгоо, тогтвортой ажиллах нөхцөлд хараат бус байдлын шалгуур хангагдахгүй байсан хэдий ч 1) төрийн албан хаагчдын томилгоо, тэр дундаа “удирдах албан тушаалтны томилгоо”-нд улс төрөөс хараат бус байдлаас бүрэн хангаж ажилладаг болох, мөн 2) төсвийн хараат бус байдал нь ХНУЯ-ны төсвийн төлөвлөгөө болон татварын орлого, зарлагын төсвийн төлөвлөгөөнд үндэслэн авч үзэхэд төсөв санхүүгийн бие даасан байдал харьцангуй бага түвшинд байна гэж дүгнэж болохоор байна.

Хоёр дахь шалгуур болох төрийн албаны үйл ажиллагаанд “шударга байдал” хэр зэрэг хангагдаж байгааг 1) шийдвэр гаргах үйл явц зөвшилцөлд тулгуурладаг эсэх, 2) төрийн

албан хаагчийн эрх зөрчсөн шийдвэрийг шалгаж тогтоож шударга бус шийдвэрт засвар, өөрчлөлт оруулдаг эсэхийг нягтлан авч үзэхэд ХНУЯ-ны харьяа байнгын болон байнгын бус үйл ажиллагаатай хамтын удирдлагын зарчимд суурилсан нийт 9 Хороо нь “хэт нэг талыг барьсан шийдвэр гаргахгүй байх талаас оролцогч талуудын төлөөллийг хангаж, зөвшилцөлд суурилсан шийдвэрийг гаргадаг байна. Түүнчлэн төрийн албаны хүний нөөцийн шударга бус маргаантай шийдвэрийн асуудлыг шалган тогтоох, улмаар шударга бус шийдвэрийг цуцлах, эсвэл засвар өөрчлөлт оруулалт хийхэд Төрийн албан хаагчдын Маргаан зохицуулах Хорооны үйл ажиллагаа идэвхтэй чиглэгддэг байна.

Гурав дахь шалгуур болох **төвлөрсөн байдлыг** төрийн албаны хүний нөөцийн чиг үүргүүд төрийн албаны төв байгууллага болон төрийн яамдын хооронд хэрхэн хуваарилагдсан байдлыг шинжлэн авч үзэхэд ХНУЯ нь өөрт олгогдсон мандат болон чиг үүргийн хүрээнд, тухайлбал харьяа 9 Хороод, түүнчлэн хүний нөөцийн стандарчлагдсан “e-SARAM” цахим систем, Хүний нөөцийн хөгжлийн Үндэсний Хүрээлэн (National Human Resources Development Institute)-ийн чиг үүргийн онцлог бүрд тулгуурлан БНСУ-ын төрийн албаны тогтолцоог нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангадаг болохыг илрүүллээ.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Tobin Im, Yu Minbong. (2019). Personnel Administration. Seoul: Parkyeongsa Printing Co.,Ltd.

Appeals Commission (2023). 소청심사위원회 설치 현황 및 활동내역서

MPM, Statistical Yearbook (2022)., Republic of Korea.

National Assambley Budget Office (2022) 예산안 위원회별 분석 [행정안전위원회 : 인사혁신처 115~117쪽.

MPM (2023). 인사혁신처 위원회별 설치현황 및 활동내역서

Civil Servants' Accident Compensation Deliberative Committee (2023).

MPM (2022), 공직박람회. www.PublicServiceFair.kr

Pendleton Civil Service Reform Act. (1883)

State Public Officials act (1949)

Regulations on the Personnel management of the Senior Civil Service Corps*(2016)

<https://sochung.mpm.go.kr/home/page/eng/index.do>

<https://www.mpm.go.kr/mpm/info/infoBiz/hrSystemInfo/hrSystemInfo03/>

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=444&lang=ENG

<https://www.pybook.co.kr/mall/book/field?goodsno=471&ssort=&category=0504&ppt=&sword=&page=>

<https://www.mpm.go.kr/mpm/ebook/2022stat/ecatalog5.html>

https://en.wikipedia.org/wiki/Pendleton_Civil_Service_Reform_Act:

<https://www.archives.gov/milestone-documents/pendleton-act#:~:text=The%20Pendleton%20Act%20provided%20that,were%20covered%20by%20the%20law>

<https://www.mpm.go.kr/mpm/info/compens/compens04/>

<https://www.mpm.go.kr/mpm/open/referDataList/>

<https://www.law.go.kr/LSW//lsInfoP.do?lsiSeq=195984&chrClsCd=010203&urlMode=engLsInfoR&viewCls=engLsInfoR#0000>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ,
ТҮҮНИЙ АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Т.Туяа¹, Я.Дашпил²

¹ Доктор Ph.D, СЭЗИС-ийн СУТ-ийн багш, tuuya.t@ufe.edu.mn

² Магистр (MBA), СЭЗИС-ийн СУТ-ийн багш, dashpil.y@ufe.edu.mn



Хураангуй

Цар тахлын дараагаас санхүүгийн зах зээл ба тогтвортой байдал хоорондын хамаарлын асуудал хурдацтай нэмэгдэж байгаа ба хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалт хийх шалгуурын нэг нь Байгаль орчин, нийгэм засаглал (БОНЗ)-ын шалгуур үзүүлэлтүүд болоод байна. Энэхүү судалгааны ажлаар тогтвортой санхүү, нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт, БОНЗ-ын зэрэглэлт, тайлагналын үзүүлэлт нь бизнесийн үнэлгээнд үзүүлэх нөлөөллийн талаарх онол аргазүйн харьцуулах замаар цаашид хөгжүүлэн, практикт ашиглах боломжийн талаар судлах юм.

Түлхүүр үг:

Байгаль орчин, нийгэм, засаглал, Компанийн зах зээлийн үнэлгээ, Хувьцааны үнэлгээ, Тогтвортой байдал, Тогтвортой хөгжил

ҮНДСЭН ХЭСЭГ

1.1 Тогтвортой хөгжлийн үндсэн ойлголтууд

21-р зуунд тогтвортой байдал гэдэг үгийг илүү өргөн утгаар хэрэглэх болсон. Тогтвортой байдлыг хангах нь өнөөгийн нийгмийн шийдвэрлэх хамгийн чухал асуудлын нэг болж байна. 1980-аад оны үед хүний үйл ажиллагааны байгаль орчинд учруулах сөрөг нөлөө улам бүр нэмэгдсэнтэй холбоотойгоор үүсэж, тогтвортой байдалд хүргэхэд чиглэсэн цогц арга хэмжээ, үйл явцыг илэрхийлэх “Тогтвортой хөгжил” гэсэн ойлголт үүссэн. Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүйн хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангахыг хэлнэ. (Brundtland, Khalid, Al-Athel, & Chidzero, 1987) Дэлхийн байгалийн нөөцийг үр ашиггүй, үрэлгэн байдлаар ашиглаж зөвхөн эдийн засгийн өсөлтөд анхаарах нь агаарын чанар буурах, нийт уур амьсгалын өөрчлөлт зэрэг аюултай үр дагаварт хүргэж байна. Ерөнхийдөө тогтвортой хөгжил нь манай гараг болон түүн дээр амьдарч буй хүн төрөлхтөнд ойрын болон урт хугацааны үр өгөөжийг

харгалзан нөөцийг илүү үр ашигтай ашиглахын зэрэгцээ өсөлтийг хангах нарийн төлөвлөсөн стратеги юм. Одоо болон ирээдүйд хүн төрөлхтөн, эх дэлхийгээ энх тайван, хөгжил цэцэглэлтэд хүргэх хамтын төлөвлөгөөг НҮБ-ын бүх гишүүн улс 2015 онд баталсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөртөө тусгасан бөгөөд 17 зорилгоос бүрдэнэ.

Зураг 2 Тогтвортой хөгжлийн зорилгууд



Эх сурвалж: НҮБ 2015 <https://mongolia.un.org/mn/sdgs>

Тогтвортой хөгжлийн зарчимд үндэслэн бий болсон БОНЗ хэмээх ойлголт нь байгаль орчин, нийгэм, засаглал гэсэн үгнүүдийн товчлол бөгөөд компани үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, санхүүгийн нэмэлт мэдээлэлдээ багтаан авч үздэг. Дараах хүснэгтээр уг шалгуурын ангилал тус бүрийн хүрээнд авч хэлэлцдэг хамгийн түгээмэл асуудлуудыг харуулав.

Зураг 3 БОНЗ-ын түгээмэл асуудлууд

Байгаль орчны асуудлууд	Нийгмийн асуудлууд	Засаглалын асуудлууд
Цаг уурын өөрчлөлт	Хэрэглэгчдийн сэтгэл хангамж	Удирдлагын цалин, урамшуулал
Агаар, ус, хөрсний бохирдол	Мэдээллийн аюулгүй байдал	Сонирхлын зөрчилдөөн
Хүлэмжийн хий	Хүйсийн эрх тэгш байдал	Ил тод, нээлттэй байдал
Эрчим хүч	Ажилчдын оролцоо	Эрсдэлийн удирдлага,
Цөлжилт	Хөдөлмөрийн журам, стандарт	Менежментийн багийн бүтэц
Хог хаягдал	Хүний эрх	Авлигын эсрэг бодлого
Бүтээгдэхүүн болон үйл ажиллагааны үр ашигт байдал	Бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдал	ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн
Бүтээгдэхүүний чанар, инноваци	Ажилчдын сургалт, хөгжлийн программ	Татвар
Нөөцийн үр ашигтай байдал	Хүний нөөцийн бодлого	Санал хураалтын бодлого
Биологийн төрөл зүйл	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нөлөө	Улс төрийн оролцоо хамаарал
Аюултай химийн бодис ашиглалт	Соёлын өв	Байгаль орчин, нийгмийн удирдлагын бодлого
Хамгаалалттай газар	Орон нутгийн иргэд	Онц байдлын үеийн бэлтгэл

Эх сурвалж: (Bersagel, Juillard, & Siri Storaker, 2020)

2019 онд хэвлэгдсэн “Тогтвортой санхүү” гарын авлагад бизнесийн байгууллага тогтвортой санхүүг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн авч үзсэнээр тохиолдож болох түгээмэл эрсдэлүүдээс гадна байгаль орчин, нийгмийн асуудлуудаас үүсэж болзошгүй томоохон эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх эрсдэлийн системийг бий болгодог болохыг дурьджээ. Тогтвортой санхүүг хэрэгжүүлснээр компани санхүүжилтийн

хямд эх үүсвэр татах, эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо сайжруулах, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх замаар зах зээлээ тэлэх, нэр хүндээ өсгөх давуу талыг үүсгэн, үнэ цэнээ нэмэгдүүлэх боломжтой болдог байна. (С.Дашдорж, et al., 2019)

БОНЗ-ын хөрөнгө оруулалт гэдэг нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцын урт хугацааны өгөөжийг харгалзан БОНЗ-ын хүчин зүйлсийг хөрөнгө оруулалтын шийдвэртээ тодорхой тусгадаг хөрөнгийн менежментийн арга юм. (Simonek & Verhagen, 2021) БОНЗ шалгуурын хөгжлийн үйл явцаас товч дурдвал, 1998 онд “SustainAbility” нэртэй бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанийг хамтран үүсгэн байгуулагч Жон Экингтон нь “21-р зуунд бизнесийн гурвалсан шугам” нэртэй өгүүллийг олонд нийтэлсэн байна. Тус өгүүлэлд санхүүгийн бус асуудлуудыг компанийн үнэлгээнд тусгах тухай ойлголтыг анх удаа хөндсөн байна. Энэ үеэс “БОНЗ-ын шалгуур үзүүлэлт” хэмээх ойлголт нь санхүүгийн салбарт анх танигдаж, хөгжлийн үе шат нь эхэлсэн байна. Үүнээс хойш БОНЗ-ыг тооцсон хөрөнгө оруулалтын зах зээлийг дэлхийн олон олон томоохон банк, хөрөнгө оруулалтын байгууллагууд сонирхох болсон байна.

СФА институцийн гаргасан тайлангаас харахад СФА цол эзэмшигчдийн 86% нь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтанд БОНЗ-ын хамгийн багадаа 1 үзүүлэлтийг харгалзан үздэг, институционал хөрөнгө оруулагчдын 75%, хувь хөрөнгө оруулагчдын 69% нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад БОНЗ-ын хөрөнгө оруулалтыг сонирхдог гэсэн үр дүн гарсан байна. Хөрөнгө удирдлагын салбарт БОНЗ-ын шалгуур үзүүлэлт, зэрэглэлийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна. (CFA Institute, 2020)

1.2 БОНЗ-ын шалгуур үзүүлэлт компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөө

БОНЗ-ын шалгуур бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэн тогтвортой хөгжлийн зорилгууд руу тэмүүлснээр компани давамгайл байдлыг үүсгэж үнэ цэнээ хэрхэн нэмэгдүүлэх боломж нэмэгддэг байна. Компани БОНЗ-ын шалгуурыг үйл ажиллагаандаа харгалзаж үзсэнээр тогтвортой хөгжлийн инновациас өгөөж хүртэх болон хэрэглэгчдийг татах, түүхий эдийн хувьд төрөөс татаас авах зэргээр өрсөлдөөний давуу талыг бий болгох боломжтой болдог. Цаашлаад БОНЗ нь эрсдэлийн удирдлагыг сайжруулдаг учир санхүүжилтийн хямд эх үүсвэр авах боломжтой болно. Олон улсын байгууллага, засгийн газар, агентлагууд тогтвортой хөгжлийг эрхэмлэгч компаниудын нэр хүндийг өсгөхөд дэмжлэг үзүүлдэг байна. (С.Дашдорж, et al., 2019) Компаний зорилго нь тогтвортой өгөөж, тогтвортой ашигт ажиллагаа, цаашлаад хувьцааны үнэ цэнээ нэмэгдүүлэх байдаг буюу хамгийн бага өртөгтэй эх үүсвэрийг ашиглаж үнэ цэнийг хамгийн их байлгах гэж үздэг. Байгаль орчин, нийгмийн шалгуур сайн байх нь үйл ажиллагаа явуулж буй компанид зардал учруулж, ашигт ажиллагаа, өгөөж үнэ цэнийг бууруулах боломжтой эрсдэлүүдээс зайлсхийн хамтын үнэ цэнийг бий болгодог байна. (Kramer, 2011)

Судлаачдын үзсэнээр БОНЗ-ын үзүүлэлт болон компанийн үнэлгээ хоорондын харилцан хамаарал тодорхойгүй, мөн түвэгтэй боловч шууд бус замаар энэхүү хүчин зүйлийн нөлөөлөл байдаг болохыг тогтоожээ. Компанийн БОНЗ-ын үзүүлэлт сайн байх нь компанийн үнэ цэнийг бий болгож, түүнийг нэмэгдүүлдэг хэд хэдэн сувагт эерэгээр нөлөөлдөг байна. Үүнд борлуулалтаас орж ирэх мөнгөн урсгал, компанийн ашигт ажиллагаа, нөөцийн зарцуулалт, санхүүжилтийн өртөг зэрэг багтах юм. (Schramde, 2016) Компани тогтвортой санхүүг баримталж, БОНЗ-ын үзүүлэлтээ сайн байлгаснаар ямар

сувгаар дамжин компанийн үнэ цэнийг нэмэгдүүлж, үнэлгээнд нөлөөлдөг болохыг дараах бүдүүвчээр тоймлон харуулав.

Зураг 4 Компанийн санхүүгийн удирдлагын зорилго ба арга хэрэгсэл

КОМПАНИЙН ЗОРИЛГО	ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН ӨСӨЛТ		
	<ul style="list-style-type: none"> • Урт хугацааны тогтвортой өсөлттэй ногдол ашиг • Капиталын үнэ цэнийн өсөлт (Хувьцааны үнэ өсөх) 		
ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭГЧ	Борлуулалтын өсөлт	Зардлын хэмнэлт	Капиталын өртөг буурах
ШИЙДВЭР ГАРГАЛТ	Бүтээгдэхүүний удирдлага <ul style="list-style-type: none"> • Маркетинг • Бүтээгдэхүүний шийдэл 	Үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> • Бүтээмж • Үйл ажиллагааны үр ашигт байдал 	Өрийн санхүүжилт <ul style="list-style-type: none"> • Өртөг • Санхүүгийн хөшүүрэг
			Хувьцаат капиталын санхүүжилт <ul style="list-style-type: none"> • Өртөг • Санхүүгийн хөшүүрэг
			Капитал хөрөнгө <ul style="list-style-type: none"> • Ажлын капитал • Үндсэн капитал
			Санхүү <ul style="list-style-type: none"> • Нэмэгдэх капитал

Эх сурвалж: (Даидорж, et al., 2019)

1.3 БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын ашиг тус

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтын дагуу БОНЗ нь байгууллагын үнэ цэн харин тогтвортой байдлыг компанийн гүйцэтгэл болон түүний оролцогч талуудад нөлөөлж болох байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын өргөн хүрээний асуудал хэмээн тодорхойлсон. (хороо, 2021)

Компаниуд нь тогтвортой байдлыг удирдах, тайлагнах сайн туршлагыг нэвтрүүлснээр дараах шинэ боломжуудийг нэмэгдүүлэх боломжтой. Үүнд:


- Хөрөнгө оруулагчдын чиг хандлагад нийцүүлэх:
- Санхүүгийн хүртээмж
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах
- Харилцагчийн тоог нэмэгдүүлэх
- Зах зээлийн шинэ боломжууд
- Мэдээллийн урсгалын сайжруулах зэрэг давуу талуудыг дурьдсан байна. (хороо, 2021)

1.4 БОНЗ-ын шалгуур, үзүүлэлт ба тайлагналын өнөөгийн байдлын судалгаа

Санхүүгийн зохицуулах хороо

СЗХ-ноос бүртгэлийн компаниуд санхүүгийн тайланд 2021 оны 4-р сард БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын өнөөгийн байдалд суурь үнэлгээ хийсэн. Үнэлгээнд нийт 42 компани (бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын 25% орчим) хамрагдсан бөгөөд үнэлгээний дүнгээс дүгнэхэд хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын тогтвортой байдлын тайлагнал харьцангуй хязгаарлагдмал байгаа бөгөөд засаглалтай холбоотой үзүүлэлтүүд харьцангуй ил тод болж байгаа хэдий ч компаниуд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл гэх зэрэг байгаль орчин, нийгмийн асуудлаар тайлагнах талаар мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутмаг байна. Гэсэн хэдий ч, судалгаанд оролцогч компаниуд тогтвортой байдлын тайлан гаргах хүсэл эрмэлзэлтэй бөгөөд тодорхой удирдамж заавраар ханган, чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх аваас холбогдох мэдээллийг цуглуулж, ил тод тайлагнах боломжтой гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Зураг 4. БОНЗ-ын үзүүлэлтийн өнөөгийн байдал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо, 2021

СЗХ нь 2022 оны 3-р сарын 23-нд Компанийн засаглалын кодексийг (Шинэчилсэн Хувилбар) (Кодекс) баталж, мөн Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) 2022 оны 5-р сарын 10-нд Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмыг баталснаар Монгол улсад байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын талаарх зохицуулалт бий болсон байна. Түүнчлэн 2022 оны 8-р сард СЗХ, МХБ болон бусад байгууллагууд хамтран “БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийг” боловсруулжээ. Ийнхүү БОНЗ-ын талаар нийтэд мэдээлэх, тайлагнахыг шаардах болсон нь Монгол дахь бизнесийн практикийг олон улсын стандартад нийцүүлэх, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдэд болон олон нийтэд мэдээллийг илүү ил тод нээлттэй байдлаар хүргэх зорилготой юм.

Уг стандарт удирдамжид тайлагналын стандарт, удирдамжид бүртгэлтэй компаниудын БОНЗ, тогтвортой байдлын үзүүлэлтийг хэрхэн тайлагнах талаарх олон улсын стандартын дагуу, бүх компанийг заавал тайлагнах үзүүлэлт, нэмэлтээр буюу салбарын ангиллаас хамаарч тайлагнах үзүүлэлтийг жишиг болон оруулж өгсөн байна.

Кодекст тусгаснаар БОНЗ-ын талаар тайлагнах үүрэг нь харьцангуй хялбар бөгөөд нээлттэй хувьцаат компаниуд болон бусад тодорхой компаниуд өөрсдийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл, түүнийг хэрхэн удирдаж буйгаа нийтэд мэдээлж, тайлбарлах үүргийг хүлээсэн байна. Түүнчлэн, тус үүрэг болон Кодекс заасан бусад үүргийн хэрэгжилтийг МХБ-д жил бүр тайлагнаж, жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулах үүрэгтэй болсон байна. Цаашлаад, БОНЗ-ын талаар тогтвортой байдлын тайланг тусад нь гаргах боломжтой бөгөөд хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх тухай Кодекс онцолсон байна. (PwC, 2022)

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

2.1 БОНЗ-ын шалгуур үзүүлэлт нь компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөөллийн онол аргазүй

Компанийн үнэлгээний уламжлалт 3 аргаар үнэлгээг хийх боломжтой ба үүнд Хөрөнгийн арга, орлого хорогдуулалтын арга болон зах зээлийн үржүүлэгчийн арга орно. БОНЗ-ын


шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд авч үзэхдээ орлого болон зах зээлийн аргын үед авч үзвэл илүү тохиромжтой.

БОНЗ-ын зэрэглэлийн компанийн үнэлгээний зах зээлийн үржүүлэгчдэд үзүүлэх нөлөөлөл

Зах зээлийн арга нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанийн санхүүгийн үзүүлэлт, зах зээлийн үнийн мэдээллийг ашиглан үнэлгээг тооцдог.

- Нээлттэй компанийн үнэлгээ - Хонконгийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй 60 компанийн БОНЗ, P/E харьцаа үзүүлэлт нь эерэг хамааралтай үр дүн гарсан. БОНЗ-ын зэрэглэл өндөртэй компаниудад хөрөнгө оруулагчид өндөр үнэ төлөд бэлэн байдаг. ҮХХ-ийн салбарын компаниулын хувьд БОНЗ-ын зэрэглэл 20 оноогоор өсөхөд P/B харьцаа 0.13 нэгжээр өсж байна.
- EV/EBITDA үржүүлэгч ашиглан компанийн үнэлгээг тооцсон тохиолдолд Refinitiv компаниас гаргасан аргачлалын БОНЗ-ын зэрэглэл тогтоосон тохиолдолд БОНЗ-ын зэрэглэл 10 оноогоор өсөхөд EV/EBITDA харьцаа 1.2 нэгжээр өсөж байна. (Deloitte, 2022) Уг судалгаанд 4 салбарын 300 компанийн мэдээллийг хамруулсан.
- Хаалттай компанийн үнэлгээ - Биржид бүртгэлгүй компаниудын хувьд БОНЗ-ын зэрэглэл, тайлагналын талаар хуулийн зохицуулалт харьцангуй багатай тул зээлийн эрсдэлээр дамжуулан эрсдэлийн урамшуулалт нэмэгддэг. Зах зээлийн хөрвөх чадварыг эрсдэлийн урамшуулалт бууруулдаг тул үржүүлэгчийг хямдруулалт хийх замаар тохируулдаг.

Зураг 5. БОНЗ-ын зэрэглэлийн зах зээлийн үржүүлэгчид үзүүлэх нөлөөлөл



Эх сурвалж: (Jonhes Lang La Salle, 2022)

Компанийн үнэлгээний орлогын арга


Орлогын арга нь тухайн компанийн ирээдүйд үүсч бий болох мөнгөн урсгал, ногдол ашигт үндэслэн үнэлгээг тооцож буй аргачлал юм. БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийн орлогын аргаар тооцсон үнэлгээнд оруулж үзэх 2 арга байдаг нь мөнгөн урсгал ба хорогдуулалтын хувь юм.

БОНЗ-ын зэрэглэлийн ирээдүйн мөнгөн урсгалд үзүүлэх нөлөөлөл

БОНЗ-ын зэрэглэлийн үнэлгээ нь тухайн салбараас хамаарч харгалзан үзэх хүчин зүйл, байгаль орчин, засаглал ба нийгмийн шалгуур үзүүлэлтийн хувийн жингүүд мөн ялгаатай

авч үздэг. Үнэлгээний мөнгөн урсгалын төсөвлөлтөд дараах замаар нөлөө үзүүлэх боломжтой.

Зураг 6. БОНЗ-ын зэрэглэлийн үзүүлэлт нь хүлээгдэж буй мөнгөн урсгалд үзүүлэх нөлөөлөл




Эх сурвалж: (Deloitte, 2022)

БОНЗ-ын зэрэглэлийн капиталын өртөгт үзүүлэх нөлөөлөл

Eccles, Ioannou ба Serafeim (2014); El Ghoul (2011); болон Gregory, Tharyan, Whittaker (2014) нарын судалгааны үр дүнд БОНЗ-ын зэрэглэл өндөртэй компаниудын дараах процессоор дамжуулан компанийн үнэлгээ өндөртэй байх нөхцөл болдог.

Зураг 7. БОНЗ зэрэглэл ба компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөөлөл



Эх сурвалж: (Guido Giese, 2019)

БОНЗ-ын компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөөлөл нь дараах урсгалаар дамжин нөлөөлөх боломжтой.

- БОНЗ-ын зэрэглэл өндөртэй компаниуд хувьд системийн зах зээлийн шоконд өртөмтхий байдал бага байдаг тул системийн эрсдэл багатай байдаг.
- Капитал хөрөнгийн үнэлгээний CAPM загвар нь 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд: бета коэффициент буюу системийн эрсдэл болон тухайн компанийн эрсдэлийн урамшуулал юм. Системийн эрсдэл багатай компаниуд бета коэффициентоор дамжуулан капиталын өртгийг бууруулах боломжтой, хөрөнгө оруулагчид бага өгөөж шаарддаг. БОНЗ-ын зэрэглэл багатай компаниудын хувьд зах зээлийн эрсдэлийн урамшууллаар дамжуулан капиталын өртөг урамшуулал тооцно.
- Капиталын өртөг бага байх нь хорогдуулсан мөнгөн урсгалын загвараар дамжуулах компанийн үнэлгээг өндөр байх боломжийг олгодог.

2.2 БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийг компанийн үнэлгээнд үзүүлэх нөлөөллийн харьцуулсан судалгаа

Хүснэгт 1. Компанийн үнэлгээний аргачлалын харьцуулсан судалгаа

Д/д	Үнэлгээний аргачлал	Үнэлгээний онцлог	Хязгаарлалт
1	P/E	<ul style="list-style-type: none"> Салбарын онцлогын маш сайн харуулж өгдөг. Зах зээлийн нөхцөл байдлыг маш сайн тусгаж өгдөг. 	Алдагдалтай ажиллаж буй компани дээр тооцох боломжгүй.
2	P/B	<ul style="list-style-type: none"> Ижил төстэй компанийн мэдээлэл олдохуйц байх Тооцоолоход хялбар 	Үйл ажиллагааны онцлог, ирээдүйн стратеги төлөвлөгөөг үнэлгээнд оруулж үздэггүй.
3	EV/EBITDA	Үйл ажиллагааны онцлогийг маш сайн тусгаж өгдөг.	
4	Ирээдүйн мөнгөн урсгал	Салбарын мөчлөг, стратеги төлөвлөлт, ирэх жилүүдийн үйл ажиллагааны төлөвлөлтийг илүү сайн тооцоололд оруулж өгдөг. БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээг ирээдүйн төлөвлөлтөд илүү сайн тусгаж өгдөг.	Маш олон таамаглал дэвшүүлдэг тул компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгцээтэй болдог. Ирээдүйн төлөвлөлтийн мэдээллийн хэрэгцээ өндөр.
5	Хорогдуулалтын хувь	БОНЗ-ын шалгуурын тухайн цаг үеийн үзүүлэлтийг илүү тусгаж өгдөг. Практик түгээмэл ашигладаг.	

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Практикт БОНЗ-ын шалгуур үзүүлэлт нь компанийн үнэлгээнд нөлөөллийг оруулж үзэхдээ P/E, P/B, EV/EBITDA болон хорогдуулалтын хувиар дамжуулан тооцох нь илүү үр дүнтэй хэмээн үзлээ. Учир нь ирээдүйн мөнгөн урсгалд БОНЗ-ын шалгуур үзүүлэлтийг оруулж тооцоолоход шаардлагатай мэдээлэл манай улсын бүртгэлтэй компаниудын хувьд одоогоор дутмаг байна.

2023 оноос эхлэн биржид бүртгэлтэй компаниуд шинэ журмын дагуу БОНЗ, Тогтвортой байдлын тайланг жил бүр МХБ дээр тайлагнах, компанийн цахим хуудсанд тайлагнах үүрэг хүлээгээд байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс нь НҮБ-аас баталсан тогтвортой хөгжлийн зорилт 2030 хүрээнд компаниуд тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хандлага нэмэгдээд байна. Компанийн зүгээс БОНЗ-ын тайлан, тогтвортой байдлын тайлан гаргах

хүсэлт эрмэлзэл МХБ-д бүртгэлтэй компаниудын хувьд ихээхэн байгааг 2021 онд хийсэн судалгааны тайланд дурьдсан байна. Монголын Улсын СЗХ-ноос 2022 оны 4-р сард БОНЗ-ын тайлан, тогтвортой байдлын тайлагналыг биржид бүртгэлтэй бүх компаниуд МХБ болон компанийн цахим хуудсанд жил бүр тайлагнах журам батлагдсан байна.

БОНЗ-ын зэрэглэлийн компанийн үнэлгээнд орлогын арга, зах зээлийн аргаар үнэлэх үед нөлөөллийг оруулах боломжтой. Зах зээлийн аргын үед P/E, P/B болон EV/EBITDA үржүүлэгч ашиглан БОНЗ-ын зэрэглэлийг үнэлгээнд оруулах боломжтой байна. Орлогын аргын үед ирээдүйн чөлөөт мөнгөн урсгал, хорогдуулалтын аргаар дамжуулан БОНЗ-ын зэрэглэлийг үнэлгээнд оруулах боломжтой байна. Ирээдүйн чөлөөт мөнгөн урсгалд БОНЗ-ын зэрэглэлийг оруулж тооцоолох нь компанийн онцлог, БОНЗ-ын чиглэлээр ирээдүйд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг компанийн үнэлгээнд оруулж тооцдоогоороо давуу талтай байна. Гэвч одоогоор Монгол Улсын БОНЗ-ын тайлагналын системийн зохицуулалтын үндэс суурь дөнгөж тавигдаж байгаа энэ үед хангалттай хэмжээний мэдээлэл олдохгүй байх эрсдэлтэй байна. Иймд орлогын аргын үед хорогдуулалтын хувьд БОНЗ-ын зэрэглэлийн оруулж үнэлэх нь илүү тохиромжтой байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Brundtland, G. H., Khalid, M., Al-Athel, S. A., & Chidzero, B. (1987). *Our common future*. New York: Oxford University Press.

хороо, С. з. (2021). *Санхүүгийн зохицуулах хороо*. Улаанбаатар хот: СЗХ. Retrieved from frc.mn: http://www.frc.mn/resource/frc/File/2022/04/15/h7pxzdd60hzn1yf/%D0%91%D0%9E%D0%9D%D0%97_%D1%82%D0%BE%D0%B3%D1%82%D0%B2%D0%BE%D1%80%D1%82%D0%BE%D0%B9_%D0%B1%D0%B0%D0%B9%D0%B4%D0%BB%D1%8B%D0%BD_%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%B3%D0%BD%D0%B0%D0%BB%D1%8B%D

Pwc. (2022, 10). *Pwc*. Retrieved from Pwc: ПрайсуотэрхаусКүүпэрс Легал

Guido Giese, L.-E. L. (2019). *How ESG Affects Equity Valuation, Risk, and Performance*. London: MSCI.

Jonhes Lang La Salle. (2022). *Explore How ESG impacts Business Value*. London: JLL.

CFA Institute . (2020). *Future of Sustainable Investment Management From Ideas to Reality* . London: CFA Institute.

Deloitte. (2022). *Does a company's ESG score have a mesaruble impact on its market value?* London: Deloitte



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ,
ТҮҮНИЙ АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

ТОЙРОГ ЭДИЙН ЗАСГИЙН ТУРШЛАГЫН ЗӨРҮҮТЭЙ БАЙДЛЫН СУДАЛГАА

Г.Сайнбилэг¹, Т.Оюунгэрэл², Б.Баярсайхан³

¹ Магистр (MBA), СЭЗИС, Бизнес Удирдлагын Тэнхим, sainbileg.g@ufe.edu.mn

² Доктор (PhD), СЭЗИС, Бизнес Удирдлагын Тэнхим, oyungerel.t@ufe.edu.mn

³ Магистр (MBA), СЭЗИС, Бизнес Удирдлагын Тэнхим, bayarsaikhan.b@ufe.edu.mn



Түлхүүр үг:

тойрог эдийн засаг, ногоон гэрчилгээ, тойрог эдийн засгийн зөрүү, CE, CE gap

Хураангуй

Хүрээлэн буй орчиндоо ээлтэй үйлдвэрлэл явуулж тойрог эдийн засаг (ТЭЗ) хөгжүүлэх нь Монгол улсын эдийн засгийн урт хугацааны зорилтуудын нэг төдийгүй нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудал болох талаар бизнесийн байгууллагуудын дунд өргөн цар хүрээнд яригдах болсон. Монгол Улсын хөдөө аж ахуй, хүнсний салбар нь улсын нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувь, хөдөлмөр эрхлэлтийн 30 хувийг бүрдүүлдэг хэдий ч хог хаягдал, хүлэмжийн хийн ялгарлаар байгаль орчинд сөрөг нөлөө ихээхэн үзүүлж байна. Судлаач нарын үзэж буйгаар салбарын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд жижиг дунд үйлдвэрлэгч нарын үйл ажиллагаанд тойрог эдийн засгийн туршилууудыг нутагшуулах шаардлага үүссэн байна. Энэхүү судалгааны зорилго нь монголын бизнесийн байгууллагуудын ТЭЗ-ийн туршилагыг хэрэгжүүлж байгаа түвшин, ТЭЗ-ийн туршилагын зөрүүтэй байдлыг тодорхойлоход оршино.

Судалгаанд хөдөө аж ахуйн гаралтай хүнс, ус, ундаа үйлдвэрлэлийн салбарын бичил, жижиг, дунд хэмжээний бизнесийн байгууллагуудыг хамруулсан бөгөөд ТЭЗ-ийн онолын 7R зарчимд үндэслэсэн болно. Уламжлалт 3R зарчим 5R болж өргөжиж, улам боловсронгуй болсоор хүрээлэн буй орчинд ээлгүй үйлдвэрлэлээс татгалзах (refuse), дахин бодох, загварчлах (rethink-redesign), бууруулах (reduce), дахин хэрэглэх (reuse), засах (repair), дахин үйлдвэрлэх (recover), дахин боловсруулах (recycle) гэсэн долоон бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна. Газар тариаланч, зөгийн аж ахуй эрхлэгч, хоол хүнс үйлдвэрлэгч, жижиглэн худалдаачид, үйлчилгээ үзүүлэгчид ТЭЗ-ийн туршилагын үндсэн зарчим болох хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаагаа явуулах дадлын

талаар мэдлэгтэй боловч тэрхүү дадлыг хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй болох нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

УДИРТГАЛ

Хүнсний хог хаягдлын тогтвортой менежментийн асуудал нь нийгэм, байгаль орчин, эдийн засгийн аль ч үүднээс зайлшгүй анхаарах зүйл юм. Дэлхий даяар хүний хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний гуравны нэг орчим нь (жилд ойролцоогоор 1.3 тэрбум тонн) хаягдаж (SOFA, 2019) байхад 1 тэрбум орчим хүн өлсгөлөнд нэрвэгдэж байдаг (FAO, 2022) байна. Хүнс үйлдвэрлэлийн сүлжээ нь зөвхөн нийгэм, ёс суртахууны асуудал бус байгаль орчныг хамгаалахад мөн чухал ач холбогдолтой. Хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хадгалалтад байгалийн асар их нөөцийг ашигладаг ба хүнсний хог хаягдал дангаараа хүлэмжийн хийн ялгарлын 8 орчим хувийг бүрдүүлдэг зэргээр уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлсөөр байна.

Олон улсын Дэлхийн нөлөөллийн байгууллагаас 2022 онд 176 орны нийгэм болон байгаль орчинд ээлтэй байх үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд Монгол улс жагсаалтын сүүлийн байр эзэлж байна (Global Impact Organization, 2022). Тайланд дурдсанаар хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэлийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэхэд засгийн газрын дэмжлэг, бага хүүтэй, урт хугацаатай зээлийн санхүүжилтийн хэрэгцээ, санхүүжилтийн хязгаарлагдмал боломж зэрэг бэрхшээлүүд тулгарч байна. Мөн салбарын хувьд мэргэшсэн хүний нөөцийн олдоц тааруу байгаа явдал зайлшгүй анхаарлаа хандуулах тулгамдаж буй асуудал болоод байгаа бөгөөд, үүнийг дагаад ажиллах хүчнийг мэдлэг мэдээллээр хангах сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлага өндөр байна.

Монгол улсын хувьд хөдөө аж ахуйн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарт (ХААХУУҮС) газар тариалан, зөгийн аж ахуй, хүнс, ус ундаа үйлдвэрлэл, жижиглэнгийн худалдаа үйлчилгээний гэсэн дэд салбарууд багтаж байна. Газар тариалангийн дийлэнх хэсгийг үр тариа эзэлдэг бөгөөд хүн амын хоногийн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 63 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн эзэлж (ХХААХҮЯ, 2022) байгаагаас харахад энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээний хөгжил бусад дэд салбаруудтай харьцуулахад өрсөлдөхүйц давуу талтай байна. Харин төмс, хүнсний ногоо, нарийн ногоо, жимсний тариалалт нь улсын хэмжээнд тариалсан талбайн 10 хүрэхгүй хувийг эзэлдэг (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2022) ба тэдгээрийг боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, тариаланчдын чадавх хязгаарлагдмал, ижил төрлийн импортын бүтээгдэхүүний үнэ хямд байдаг зэргээс шалтгаалан өрсөлдөх чадвар нь сул байна. Дэд салбаруудын хөгжил болон өрсөлдөөний давуу талууд нь харилцан адилгүй байгаа бөгөөд үүнээсээ хамаараад хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах, хэмнэлттэй эдийн засгийн загварыг хөгжүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдах зэрэг үйл ажиллагаанууд хангалтгүй түвшинд байна.

Энэхүү судалгаа нь монголын бизнесийн байгууллагуудын ТЭЗ-ийн туршлагыг хэрэгжүүлж байгаа түвшин, ТЭЗ-ийн туршлагын зөрүүтэй байдлыг тодорхойлох зорилготой ба судалгааны ач холбогдол нь хэмнэлттэй, тойрог эдийн засгийн талаар ойлголтыг үйл ажиллагааны хэрэгжүүлэлтийн түвшинд нарийвчлан судалснаар нөхцөл байдлыг тодруулах, дэлхийн дахинтай хөл нийлүүлэн алхах боломжийг эрэлхийлэхэд оршино.

ҮНДСЭН ХЭСЭГ

Судлагдсан байдал:


Сүүлийн 10 жилийн хугацаанд ТЭЗ-ийн үзэл баримтлал нь чухал судлагдахууны нэг хэсэг болж, тогтвортой нийгмийг бий болгох зорилготой Европын Холбооны судалгааны байгууллагуудын анхаарлыг татаж байна. ТЭЗ-ийн судалгааны үүсэл хөгжил, үндсэн зарчмууд нь системийн онол, экологи болон хүрээлэн буй орчны эдийн засаг, үйлдвэрлэлийн экологийн онолтой шууд холбоотой бөгөөд (M. Geissdoerfer, 2017) ба цоо шинэ судлагдахуун бол биш юм (Reike et al, 2018). Тодорхойлолтуудаас харвал ТЭЗ-ийг нөөцийг үйлдвэрлэлийн системд аль болох удаан байлгахад чиглэсэн үйлдвэрлэл болон хэрэглээний систем гэж тайлбарладаг. ТЭЗ гэдэг нэр томъёо нь үйлдвэрлэлийн бүх шат дамжлагад түүхий эд материалын хэрэглээг багасгах (түүхий эдийн хамгийн бага ашиглалт), дахин хэрэглэх (бүтээгдэхүүн, эд ангиудыг олон дахин ашиглах), дахин боловсруулах зэргийг агуулсан ерөнхий ойлголт юм (Korhonen, 2017). Өнөөгийн шугаман эдийн засгийн тогтолцооны зорилго нь үйлдвэрлэх, хэрэглэх, устгахад чиглэсэн байдаг бол эрдэмтэд ТЭЗ-ийг байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх буюу дахин сэргээх систем гэж үздэг бөгөөд (M. Geissdoerfer, 2017), материалын урсгалыг эргэлтэд оруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах замаар бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн төгсгөлийг дахин үргэлжлүүлэх зорилготой байдаг (J. Korhonen, 2018).

Шугаман эдийн засгийн загварт үйлдвэрлэл эсвэл хэрэглээний дараа бүтээгдэхүүний шууд хаягдал болдог бол ТЭЗ нь бүтээгдэхүүн, түүхий эдийг дахин ашиглах, хог хаягдлыг бууруулах, хөрс, ус, агаарт бий болох хорт хийн ялгаруулалтаас аль болох урьдчилан сэргийлэхэд төвлөрдөг. Тойрог эдийн засагт техникийн болон биологийн гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэг байдаг. Техникийн цикл нь хязгаарлагдмал нөөцийг удирдахад чиглэдэг. Биологийн цикл нь сэргээгдэх боломжтой түүхий эд материалын урсгалыг багтаасан ойлголт юм. Хэрэглээ зөвхөн биологийн циклд бий болдог. Иймээс сэргээгдэх (биологийн) шим тэжээл нь мөн биологийн циклд нөхөн сэргээгддэг.

Экологийн хувьд тогтвортой хөгжлийн төлөөх байгууллагууд болон паркууд ногоон үйлдвэрлэлийн төлөвлөгдөх, ажиллах, бүтээмжтэй байх нь тойрог эдийн засгийн зорилго юм (Heshmati, 2015). **Тойрог эдийн засгийн зөрүүтэй** байдал гэдэг нь нөөц авах, ашиглах үйл явцыг багасгах, хүн амын хэрэглээний түвшинд хэмнэх, хуваалцах, бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж дуусаад хаях биш, дахин боловсруулах, дахин өөр зорилгоор үйлдвэрлэлд нэвтрүүлж амьдралын мөчлөгийг уртасгах боломжуудыг ашиглаж, үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаа эсэхээр тодорхойлно.

Энэхүү орон зайг нөхөхийн тулд үйлдвэрлэлийн болон хэрэглээний явцад хаана нь анхаарлаа хандуулах, хөгжүүлэх шаардлагатай байгаа тойрог эдийн засгийн циклийн зураглалаас /зураг 1/ харж болно.


Зураг 1. Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдал



Эх үүсвэр: (Ellen MacArthur Foundation, 2015)

ТЭЗ нь зөвхөн дахин боловсруулах тухай ойлголт биш юм (PBL, 2019). Үндсэндээ хүн төрөлхтний эдийн засгийн харилцааг 3R, 5R, 7R зарчимд нийцүүлж байгаа экологийн эдийн засгийн тухай ойлголт юм (Xing, 2017). Нидерландын хүрээлэн буй орчны үнэлгээний агентлаг нь тойрог эдийн засгийг "R" зарчмын дагуу *дахин бодох, дахин төлөвлөх, дахин ашиглах, засах, дахин үйлдвэрлэх, дахин боловсруулах, сэргээх* үйл явц гэж тодорхойлсон байна. Энэ нь хүрээлэн буй орчны хамгаалал, байгалийн нөөц баялаг зэргийг бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоонд аль болох хэмнэлттэй байлгахад чиглэсэн стратегийн хэрэгжүүлэлтийн дэмжлэгээр бий болдог гэсэн үг юм.


Зураг 2. Тойрог эдийн элемент ба стратегиуд



Эх үүсвэр: (PBL, 2019)

3R, 5R зарчмуудын түүхий эд материалын урсгал эргэлт, ашигт ажиллагаа, хог хаягдлыг бууруулах зэрэг зорилтууд нь хангалтгүй болсон учраас 7R зарчим болон хөгжсөн байна. Бид эх дэлхийг аврах, ТЭЗ-ийг биежүүлэхийн тулд 7R зарчимд суурилах үзэл баримтлал өнөө цагт хамгийн чухал болсон байна (Stockholm Environment Institute, 2022).

Зураг 3. 7R зарчим



Эх үүсвэр: (PBL, 2019)

Тус бүрчлэн дараах зарчмуудыг жишээтэй холбон тайлбарлавал:

1. Хувилбаруудыг нээж, дахин бодож үзэж, асуудлыг шийдвэрлэх зорилгоор бараа бүтээгдэхүүнийг дундаа хэрэглэх нь байгалийн баялаг, түүхий эд материалыг бага хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ.
2. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг сунгах, илүү хэмнэлттэй үйлдвэрлэлийн жишиг тогтоох нь нөөцийг бууруулах гол нөхцөл болно.
3. Бүтээгдэхүүн үйлчилгээний бүрэлдэхүүн хэсэг, эд ангиудыг засварлах нь нэг хэрэглэгч дээр тухайн бүтээгдэхүүн удаан хугацаанд хэрэглэгдэх боломжтой.
4. Бүтээгдэхүүнийг байгаагаар нь эсвэл өөрчлөлт хийснээр дараагийн хэрэглэгчид шилжүүлэх боломж бүрдэнэ.
5. Бүтээгдэхүүний үндсэн үүргээ гүйцэтгэх бүрдэл хэсгийг өөрчлөх, шинэ сэлбэгээр дахин сэргээх нь дахин хэрэглээг бий болгоно.
6. Дахин боловсруулалтанд оруулах нь түүхий эд материалын томоохон нөөц болно.
7. Дахин үйлдвэрлэлд оруулан хувиргах нь шинэ эх үүсвэрийг бий болгоно

Судалгааны арга зүй:

Судалгаа нь бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ТЭЗ-ийн хэрэгжилтэд иж бүрэн дүн шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд чиглэсэн. Үүний тулд ХААХУУҮС бизнес эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх байдлаар Өөрийн үнэлгээний асуулгыг боловсруулсан. Өөрийн үнэлгээний асуулгыг олон улсын байгууллагуудын зөвлөмж, дотоодын дүрэм журам, зохицуулалт, олон улсын болон дотоодын судалгааны ажлуудад суурилан боловсруулсан. Асуулгын загварыг монгол хэл дээр боловсруулж, найруулга үг үсгийн алдааг хянаж, ойлголтын зөрүү, үнэлгээний алдаа үүсэж байгаа эсэхийг шалгах зорилгоор туршилтаар бөглүүлж засваруудыг хийсэн.

Тойрог эдийн засгийг 3 түвшинд хуваан судлах боломжтой. Үүнд: а). Микро түвшинд хэрэглэгч, үйлдвэрлэгч, бүтээгдэхүүний хувьд, б). Мэсо түвшинд орон нутгийн экосистем, эко аж үйлдвэрийн паркуудын хувьд, в). Макро түвшинд хот, бүс нутаг, үндэстнийг хамарсан ойлголтууд багтаж байна (P. Ghisellini, 2016). Тус судалгаа нь микро түвшинд

хийгдсэн болно. Улсын хэмжээнд ХААХУУҮС-т нийт 42,233 байгууллага болон хувь хүн үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээрт 58 гурилын үйлдвэр, 870 гурилан бүтээгдэхүүний үйлдвэр, 162 ус ундааны үйлдвэр, 14,078 хүнсний жижиглэнгийн худалдаа үйлчилгээ, 8,467 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, зөгийн аж ахуй эрхлэгч 680 өрх ба 36 аж ахуйн нэгж (ААН), газар тариалан эрхлэгч 17,459 өрх ба 423 ААН, тус тус бүртгэлтэй байна. Судалгаанд Улаанбаатар, Сэлэнгэ, Эрдэнэт, Өмнөговь аймгийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй нийт 742 бизнес эрхлэгчдийг хамруулсан бөгөөд Үүнээс 444 үйлдвэрлэл, 298 жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ, тээвэр, агуулахын үйлчилгээ эрхлэгчид болно.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ

Дэд салбар	Улаанбаатар хот	Сэлэнгэ аймаг	Эрдэнэт хот	Өмнөговь аймаг	Нийт
Газар тариалан	136	57	33	3	229
Зөгийн аж ахуй	3	42	10	0	55
Хүнс, ус ундаа үйлдвэрлэл	106	21	27	6	160
Жижиглэнгийн худалдаа үйлчилгээ	94	21	19	6	140
Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ	68	18	24	4	114
Агуулах	4	13	3	0	20
Тээвэрлэлт	7	8	9	0	24
Нийт	418	180	125	19	742

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Сонгон авсан бүс нутгийн хэмжээнд түүврийн эх олонлогийг 18,943, түүврийн итгэх түвшин 99% гэж үзээд тооцоолоход түүврийн хүлээн зөвшөөрөгдөх доод хэмжээ 644 байгаа тул тус судалгаанд оролцсон нийт 742 өгөгдөл нь эх олонлогийг бүрэн төлөөлж чадна, түүврийн найдвартай байдлыг хангаж, үр дүнг хүлээн зөвшөөрч болохыг илтгэж байна.

Судалгааны үр дүн:

Тойрог эдийн засгийн зөрүүтэй байдлыг тодорхойлохдоо ТЭЗ-ийн 7R зарчим тус бүрийн хэрэгжилтийг дэд салбар тус бүрээр үнэлж, хэрэгжихгүй байгаа орон зайг тодорхойлсон. Үр дүнг хүнс үйлдвэрлэлийн дэд салбар тус бүрээр нэгтгэн гаргасан.

1. Газар тариалангийн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Газар тариалан эрхлэгчдийн тойрог эдийн засгийн туршлага **зөвхөн нөөцөд анхаарлаа хандуулсан хэв маягтай** байна. Судалгааны үр дүнгээс харахад хөрсийг биологийн хувьд идэвхтэй, үржилт шимтэй байлгахад чиглэсэн хөрсний менежментийг хэрэгжүүлэх үзүүлэлт сайн байна. Тариаланчид хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх зорилгоор байгалийн гаралтай бордоо, малын өтөг бууцыг ашигладаг, тариалангийн бүсэд ойр мод ургамлыг нөхөн сэргээдэг, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг тогтмол хийдэг байна.

Хүснэгт 2. Газар тариалангийн салбарын ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

Туршлагауд	ТЭЗ-ийн элемент						
	Тагталзах	Дахин бодох /загварчлах	Бууруулах	Дахин хэрэглэх	Засах	Дахин үйлдвэрлэх	Дахин боловсруулах
Байгалийн органик ба био бордоо ашигладаг.	+						
Байгалийн органик ба био үр тариа ашигладаг.	+						
Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх органик бордоо ашигладаг.	+						
Амьтны өтөг бууц хөрсөнд ашигладаг.	+						
Хортон шавж ургамал, өвчний эсрэг байгалийн гаралтай бэлдмэл ашигладаг.	+						
Хөрсөнд задрах боломжтой бортого ашигладаг.	+						
Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг.					+		
Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг					+		
Борооны ус, саарал ус ашигладаг.			+				

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Бүтээгдэхүүний бүртгэх, агуулахад тэмдэг тэмдэглэгээ хийх, түлш бага зарцуулдаг эрчим хүчний хэмнэлттэй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах, хортон шавж, хогийн ургамлын эсрэг физик арга технологийг ашиглах зэргийг үйл ажиллагаандаа тусгасан байдаг. Дахин боловсруулах эсвэл олон дахин ашиглах боломжтой, хөрсөнд задрах боломжтой бортого, дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодлын ашиглалт бага хувьтай байна. Харин саарал ус, сэргээгдэх эрчим хүч ашиглах ажлуудыг огт хэвшүүлээгүй, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, эко үйлдвэрлэл, хог хаягдлын менежментийн сургалтыг ажилтнуудад тогтмол зохион байгуулдаггүй зэрэг нь тогтоогдсон.

2. Зөгийн аж ахуйн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Зөгийн аж ахуй (ЗАА) эрхлэгчдийн тоо өссөн нэмэгдэж тус салбар сүүлийн 5 жилийн дотор эрчимтэй хөгжиж, хүн амын дунд эко бүтээгдэхүүн, эко туршлагын тухай ойлголтыг төлөвшүүлэхэд оруулж буй хувь нэмэх өндөр юм. Зөгийн аж ахуй мөн адил **нөөцөд түлхүү анхаарлаа хандуулдаг, үйл ажиллагааны явцад эко туршлагаудыг хэвшүүлж** эхэлж байна.

Хүснэгт 3. ЗАА эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

Туршлагаууд	ТЭЗ-ийн элемент						
	Таггалзах	Дахин бодох /загварчлах	Бууруулах	Дахин хэрэглэх	Засах	Дахин үйлдвэрлэх	Дахин боловсруулах
Тэсвэр хатуужилтай зөгийн үүлдэртэй	+						
Өвчин эсэргүүцэх, халдвараас урьдчилан сэргийлэх тохиромжтой арга хэрэгсэлтэй	+	+					
Органик зөгийн бал, чихрийн сироп зэрэг органик гэжээл ашигладаг	+						
Органик газар тариалантай 3км-н радиуст ойр байрладаг	+						
Ургамлын гаралтай эмчилгээний бүтээгдэхүүн ашигладаг	+						
Зөгийн үүрийг хийхдээ байгалийн гаралтай материал ашигладаг	+						
Малын бууц зэрэг байгалийн гаралтай утааны материал ашигладаг	+						
ЗАА эрхлэх, боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд тогтмол бүртгэл, хяналтын оновчтой системтэй	+						
Дахин боловсруулсан материалаар хийгдсэн сав, баглаа боодол ашигладаг				+			
Дахин боловсруулах боломжтой сав, баглаа боодол ашигладаг				+			
Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг					+		
Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг					+		
Ажилтнуудад бүтээгдэхүүнийг ангилах, хадгалах, ашиглах талаар сургалт тогтмол хийдэг		+					+

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

ЗАА эрхлэгчид тэсвэр хатуужилтай зөгийн үүлдэртэй, зөгийн өвчин, халдвараас урьдчилсан сэргийлэх тохиромжтой арга хэрэгсэлтэй, ургамлын гаралтай эмчилгээний бүтээгдэхүүн ашигладаг байна. Мөн зөгийн үүр хийхдээ байгалийн гаралтай материал ашигладаг, малын бууцыг утаа гаргахад ашигладаг, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийх дадлуудыг бий болгожээ. Гэвч зөгийчид орц буюу нөөцөд түлхүү анхаарлаа хандуулж, үйлдвэрлэлийн үйл явц, хэрэглээний үе шатуудад эко туршлага дутагдалтай хэвээр байгааг дээрх хүснэгтээс харж болно.

3. Үйлдвэрлэлийн дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Үйлдвэрлэгчдийн хувьд бүтээгдэхүүний үндсэн түүхий эд материалын худалдан авалтад өндөр шаардлага тавьдаг боловч үйл ажиллагаандаа эко туршлага хэвшүүлсэн байдал хангалтгүй байна. Тэд хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй үйл ажиллагаа

явуулснаар байгууллагын үйл ажиллагаа сайжирч, гадаад орчноос боломж нээгддэг гэдэгт итгэл муу байна.

Хүснэгт 4. Үйлдвэрлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

Туршлагауд	ТЭЗ-ийн элемент						
	Тагталзах	Дахин бодох /загварчлах	Бууруулах	Дахин хэрэглэх	Засах	Дахин үйлдвэрлэх	Дахин боловруулах
Манай компани хэрэглээний усаа хэмнэдэг.			+				
Манай байгууллага бүтээгдэхүүнийхээ орц найрлагын гарал үүсэл, баталгаажилт, тээвэрлэлтийг байнга шалгаж, үйлдвэрлэлд оруулдаг.	+						
Багцалсан эсвэл сав баглаа нь материалын хэмнэлттэй байх.	+		+				
Боловсруулах тоног төхөөрөмж, технологи нь эрчим хүч бага зарцуулдаг байх.	+						
Хэрэглээний явцад гарах нэмэлт зардал гардаггүй байх.	+						
Түүхий эд материалын лабораторийн чанарын баталгааны бичигтэй байх.	+						
Манай компани эрчим хүч бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаг.			+				
Шөнийн хөнгөлөлттэй цагаар ашигладаг.			+				
Бид тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээгээ өөрсдөө хийдэг.					+		
Манай компани хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, дахин боловсруулах систем нэвтрүүлсэн.							+
Манай компани хадгалалт, тээвэрлэлтийн явцад бүтээгдэхүүний зохих бүртгэлийг хийж, зориулалтын тээврийн хэрэгсэл ашигладаг.		+					

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Харин бүтээгдэхүүний орц, найрлагын гарал, үүсэл, баталгаажуулалт, тээвэрлэлтийг байнга шалгаж, хадгалалт, тээвэрлэлтийн бүртгэлийг хөтөлж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэж, бүтээгдэхүүний чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж чадсан байна. Хэрэглээний усаа хэмнэж хэвшсэн байдал хамгийн өндөр буюу 96 хувьтай байна. Мөн эрчим хүч бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаг, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах сургалтыг тогтмол явуулдаг туршлагауд өндөр үзүүлэлттэй байна. Гэвч тусгай зориулалтын тоног төхөөрөмж болон технологийг бусад байгууллагуудтай хамтран дундаа хэрэглэх, цахилгаан эсвэл түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгсэл ашиглах тал дээр учир дутагдалтай байна.

4. Жижиглэн худалдаа үйлчилгээний дэд салбарын 7R зарчмын үнэлгээ

Жижиглэнгийн худалдаа, тээвэрлэлт, хадгалах агуулах үйлчилгээний хувьд үйл ажиллагаандаа эко туршлага хэвшүүлсэн байдал хангалтгүй байна. Тэдний хувьд тоног

төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийдэг, цэвэрлэгээг тогтмол хийдэг, хэрэглээний усаа байнга хэмнэж, хэвшсэн гэдэг нь хамгийн өндөр үзүүлэлтүүдтэй туршлага байсан.

Хүснэгт 58. Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

Туршлагауд	ТЭЗ-ийн элемент						
	Татгалзах	Дахин бодох /загварчлах	Бууруулах	Дахин хэрэглэх	Засах	Дахин үйлдвэрлэх	Дахин боловсруулах
Манай компани хэрэглээний усаа хэмнэдэг.			+				
Тоног төхөөрөмжийн тогтмол цэвэрлэгээ хийдэг.					+		
Тоног төхөөрөмжийн тогтмол засвар үйлчилгээ хийдэг.					+		

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Жижиглэнгийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн ТЭЗ-ийн туршлагын өнөөгийн нөхцөл байдал болон өдөр тутмын үйл ажиллагааны дадлуудад хийсэн шинжилгээний дээрх үр дүнгүүдээс харвал түүхий эд материал худалдан авахдаа бэлтгэн нийлүүлэгчид тавих шаардлага өндөр тавьдаг нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй, эдийн засгийн хэмнэлтгүй зүйлсээс татгалзах хандлага өндөр байгаа, 7R-ийн **татгалзах** /refuse/ дадал сайн байгааг илтгэж байна.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ

Судалгааны үр дүнд үндэслэн дэд салбаруудын тойрог эдийн засгийн туршлагыг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчид хэрхэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байгааг дараах үзүүлэлтүүдээр үнэлж, нэгтгэн харууллаа. Үүнд:

- Монгол улсад хэрэгжиж буй стандартууд
- Хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай байдал
- Хүрээлэн буй орчиндоо ээлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт
- Хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх зорилгыг хэмжих үзүүлэлт / индикатор
- Хамтын ажиллагаа

Хүснэгт 6. ТЭЗ-ийн зөрүүтэй байдал

№	Тойрог эдийн засгийн туршлагын элементүүд	Газар тариалан	Зөгийн аж ахуй	Хүнс, ус ундаа үйлдвэрлэгч	Жижиглэн худалдаа, үйлчилгээ
1.	Үндэсний стандартууд, засгийн газрын бодлогын хэрэгжилт	+	-	+	+
2.	Хүрээлэн буй орчны хариуцлагатай байдал	-	-	+	+
3.	Хүрээлэн буй орчиндоо ээлтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлогын бичиг баримт	+	+	-	-

4.	Хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх зорилтуудыг хэмжих үзүүлэлтүүд	-	-	-	-
5.	Хамтын ажиллагаа	-	+	N/A	+

Эх үүсвэр: Судалгааны үр дүн

Газар тариалангийн салбарт санхүүжилт болон хөнгөлөлттэй зээлийн боломжууд бусад салбартай харьцуулахад илүү байгаа тул энэ чиглэлийн байгууллагууд байгаль орчинд ээлтэй тариаланг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бодлогын бичиг баримт, төсөл төлөвлөгөө сайтай байна. Газар тариалан төдийгүй хүнс, ус ундаа үйлдвэрлэгч болон жижиглэнгийн худалдааны байгууллагууд үндэсний хэмжээний стандартуудыг дагаж мөрддөг, хүрээлэн буй орчиндоо ээлтэй байх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна. Зөгийн аж ахуй эрхлэгчдийн хувьд онцлог нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтран ажилладаг туршлага бусад дэд салбаруудаас илүү байна.

Гэвч дээрх 4 дэд салбарын аль нь ч байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагааны зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт ашигладаггүй байна.

Үр дүнгийн хэлэлцүүлэг:

Газар тариалан эрхлэгчдийн хамгийн ихээр анхаарлаа хандуулж байгаа ТЭЗ-ийн элемент нь байгалийн нөөц ашиглалт болон түүний нөхөн сэргээлт бөгөөд органик түүхий эд материалаар хөрсийг бордож, байгаль орчинд хор хөнөөлтэй сонголтуудаас татгалздаг. Байгалийн болон капитал нөөцөд анхаарлаа хандуулж, тариалалт, ургац хураалтын үйл явцад техник технологийн шийдэл бага ашиглаж байгаа нь сул тал болж байна. Тариаланчид ургац хураалтын явцад бий болсон хог хаягдлыг бордоо болгон ашиглах, малын тэжээл болгож, үлдсэн хувийг газар дүүргэлтэд ашиглаж байгаа нь нэг давуу тал юм. Харамсалтай нь хамтын эдийн засгийг хөгжүүлэх, дундаа нөөцөө ашиглах, эсвэл техникийн тусламж үйлчилгээ авах, сургалт зөвлөгөөнд хамрагдах үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Газар тариалан эрхлэгчид тариалалт болон хураах үйл явцад ашиглагдаж буй нөөцийг үр ашигтай хэрэглэх, тариалах болон ургац хураах үйл явцаа ухаалаг болгох, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн ажиллах бизнесийн загвар, хэв маягаа өөрчилж чаддаггүй. Дахин загварчлах зорилгоор нөөцийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлдэггүй. Дахин хэрэглэгдэх болон дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодлын туршлага муу. Цахилгаан эрчим хүч болон түлш бага зарцуулдаг тоног төхөөрөмж ашигладаггүй.

Зөгийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай түүхий эд материалын ухаалаг сонголтыг хийж, аль болох химийн гаралтай бодис оролцсон түүхий эдээс татгалздаг тэргүүн туршлагатай байна. Мөн тоног төхөөрөмжийн урсгал засвар, цэвэрлэгээ болон эвдрэл гэмтлийг дотооддоо засварлах туршлагыг хэвшүүлсэн. Зарим хэсэг нь тогтмол бүртгэл хөтлөн явуулдаг, дахин боловсруулах боломжтой сав, баглаа боодол ашигладаг. Харин бүтээгдэхүүний дахин боловсруулсан болон шинэ сав баглаа, боодлыг буцаан авах тогтолцоо, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж ашиглах, цахилгаан машин, борооны ус саарал усны ашиглалт, химийн болон органик бүтээгдэхүүнийг тусад нь хадгалах, химийн бодис байгаа тухай анхааруулга тэмдэглэгээг байршуулах зэрэг туршлагууд дутмаг байна.

Эдийн засгийн хэмнэлттэй байх зарчмын хүрээнд үйлдвэрлэгчдийн хэрэгжүүлж буй хамгийн түгээмэл туршлагаас дурдвал шөнийн хөнгөлөлттэй цагаар ажиллах, усны хэрэглээнд хяналт тавих хандлага сайн байна. Ус болон цахилгааны зохистой хэрэглээг хянах, хэмнэх тогтолцоо бий болгож, тоног төхөөрөмжийн урсгал засвар, цэвэрлэгээ болон эвдрэл гэмтлийг дотооддоо засварлах туршлагыг хэвшүүлж чадсан байна. ТЭМ-ын худалдан авалтын явцад лабораторийн чанарын баталгааны бичигтэй байх, багцалсан эсвэл сав баглаа нь материалын хэмнэлттэй байх шаардлагыг бэлтгэн нийлүүлэгчээс шаарддаг. Гэвч худалдан авч буй тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашигладаг байх, бүтээгдэхүүнээс гарах хог хаягдал, сав баглааг буцааж авах тогтолцоотой байх, олон удаа хэрэглэгддэг байх зэрэг шаардлагуудыг чухалчилдаггүй. Мөн дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол ашиглах, сав баглаа боодлыг эргүүлэн авах тогтолцоогүй, сэргээгдэх эрчим хүч ашигладаггүй сул тал ажиглагдсан

ДҮГНЭЛТ

7R зарчмын хүрээнд бизнесийн байгууллагуудын хэрэгжүүлж буй өнөөгийн туршлагыг үнэлж, нэгтгэн дүгнэлээ. Тойрог эдийн засаг, эко үйлдвэрлэлийн туршлагыг судалснаар Монгол улсад эдийн засгийн хэмнэлттэй, хүрээлэн буй орчинд ээлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж ямар түвшинд байгаа болон аль хэсэгт туршлага хангалтгүй, зөрүү ихтэй байгааг харах боломж бүрдэж байна. "7R" зарчим гэдэгт *дахин бодох, дахин төлөвлөх, дахин ашиглах, засах, дахин үйлдвэрлэх, дахин боловсруулах, сэргээх* үйл явц орно.

- Нийгэм хүрээлэн буй орчин, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, дасан зохицох зорилгоор үйлдвэрлэлийн явцыг дахин бодох, бүтээгдэхүүнээ дахин загварчлах чадвар /rethink, redesign/ судалгаанд оролцогчдод хангалтгүй түвшинд байна.
- Харин өөрсдийн боломж бололцоонд тулгуурлан усаа хэмнэх, оройн цагаар цахилгаан хэрэглэх зэрэг арга хэмжээ авч бууруулах дадал /reduce/ дадлыг хэрэгжүүлж байна. Гэхдээ гадны үйл ажиллагаа, байгууллага, оролцогч талуудын дэмжлэгтэй хэмнэх процесс байхгүй байна.
- Нөөцийг дахин хэрэглэх, эсвэл хэрэглээг өөрчлөх зэргээр тухайн бараа бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгах Дахин хэрэглэх /reuse/ сэтгэлгээ бизнес эрхлэгчдэд тогтоогүй байна.
- Дотоод үйл ажиллагааны явцад гарсан эвдрэл гэмтлийг засах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмолжуулах тал дээр байгууллагуудын туршлага сайн байдаг.
- Дахин үйлдвэрлэх туршлага дэд салбаруудын хувьд тогтоогүй гэж дүгнэж болно. Дахин боловсруулах туршлага нь нийгэмд хамгийн ихээр яригддаг сэдэв болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа боловч хэрэгжүүлэх үйл явц дутмаг бөгөөд зөвхөн сургалт, судалгааны түвшинд байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд (i) түүхий эд материалын ухаалаг сонголт, эко худалдан авалт хийх, (ii) үйлдвэрлэлийн явцыг үр ашигтай байлгах, (iii) эцэст нь орц, хувиргалт, гарц гэсэн 3 алхам бүрд бий 7R зарчмыг хэвшүүлэх шаардлагатай байна.

Байгууллагууд тоног төхөөрөмжүүд цахилгаан бага зарцуулдаг, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах сургалт явуулаад хэвшсэн байна. Гэвч тусгай зориулалтын тоног

төхөөрөмж болон технологийг бусад байгууллагуудтай дундаа хэрэглэх, цахилгаан эсвэл түлш бага зарцуулдаг тээврийн хэрэгсэл ашиглах, дахин боловсруулсан материалаар хийсэн сав баглаа боодол ашиглах, сав баглаа боодлыг эргүүлэн худалдаж авах, сэргээгдэх эрчим хүч ашиглах гэсэн туршлагауд нийтлэгээр хэвшээгүй байна.

Бизнес загвар, бүтээгдэхүүний үйлчилгээ, технологийг байгальд ээлтэй болгож өөрчлөхийн (Rethinking/Redesign) тулд байгууллагын удирдлага болон ажилтнуудын хандлагыг өөрчлөх төдийгүй хамтран ажиллах, тууштай байх нөхцөлийг бүрдүүлэх, урамшуулж дэмжих нь чухал болохыг олон улсын туршлагаас харж болно. Судалгааны үр дүнд тойрог эдийн засгийн туршлагауд сул байгаа нь харагдсан. Гэтэл тойрог эдийн засгийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд цогц, өргөн хүрээний идэвхтэй хамтын ажиллагааг шаарддаг. Түүнчлэн бизнесийн шинэ орлогын эх үүсвэр бий болгох, бүтээгдэхүүн үйлчилгээний дизайныг шинэчлэх, сэргээгдэх эрчим хүч зэрэг байгалийн нөөцийг ухаалгаар хамтран хэрэглэх сорилт тулгарч байна.

Цаашид ТЭЗ-ийн тухай ойлголтыг тодорхойлох судалгааны хэрэгцээтэй ба ТЭЗ-ийн туршлагаудаас дор хаяж нэгийг хэрэгжүүлэх, ойлголтыг нэмэгдүүлэх, байгууллагын стратеги, зорилго зорилтыг ТЭЗ-рүү чиглүүлэх, бизнесийн загварыг эргэн харах зэрэг үйл ажиллагаанд чиглэгдсэн сургалт, зөвлөх үйлчилгээний хэрэгцээ шаардлагатай. Мөн түүнчлэн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгч болон олон нийтийн мэдлэг, ойлголтыг тодорхойлох, ТЭЗ-ийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах оновчтой арга хэрэгслүүдийг санал болгох зэрэг судалгаа шинжилгээний хэрэгцээ байна.

НОМЗҮЙН ЖАГСААЛТ

Global Impact Organization. (2022). The Circularity Gap Report.

Ellen MacArthur Foundation. (2015). Towards a circular economy: Business rationale for an accelerated transitions.

Ellen MacArthur Foundation and McKinsey Center for Business and Environment . (огноо байхгүй).
GROWTH WITHIN: A CIRCULAR ECONOMY VISION FOR A COMPETITIVE EUROPE.

FAO. (2009). Global agriculture towards 2050.

http://www.fao.org/fileadmin/templates/wsfs/docs/Issues_papers/HLEF2050_Global_Agriculture.pdf-ээс Гаргасан

FAO. (2022). <http://www.fao.org/food-loss-and-food-waste/en/> -ээс Гаргасан

FAO. (2022). European Commission preparatory study on food waste.

<https://www.eea.europa.eu/media/infographics/wasting-food-1>-ээс Гаргасан

FAO. (2022). Technical Platform on the Measurement and Reduction of Food Loss and Waste.

<https://www.fao.org/platform-food-loss-waste/en/>-ээс Гаргасан

Heshmati, A. (2015). A Review of the Circular Economy and its Implementation.

J. Korhonen, A. H. (2018). Circular economy: the concept and its limitations. *Ecol. Econ.*, 143, pp. 37-46.

Korhonen, J. (2017). Circular economy as an essentially contested concept .

M. Geissdoerfer, e. a. (2017). The circular economy - a new sustainability paradigm? *J. Clean. Prod.*, 143, pp. 757-768.

- P. Ghisellini, C. C. (2016). A review on circular economy: the expected transition to a balanced interplay of environmental and economic systems. *J. Clean. Prod.*, 114, pp. 11-32.
- PBL. (2019). Opportunities for a circular economy.
- SOFA. (2019). Food waste refers to the decrease in the quantity or quality of food resulting from decisions and actions by retailers, food service providers and consumers.
- Stockholm Environment Institute. (2022). Accelerating the transition to a circular economy through impactful and actionable research. *SEI Report*.
- Xing, J. &. (2017). A New Conceptual Perspective on Circular Economy: preliminarily confirmation of the 7R Principle by a descriptive Case Study in Eastern China. .
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2022). 1212.mn-ээс Гаргасан
- ХХААХҮЯ. (2022). Хүн амын хүнсний хэрэглээ. <https://mofa.gov.mn/exp/blog/10/82-ээс> Гаргасан



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ,
ТҮҮНИЙ АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ОЙЛГОЛТЫГ ЭРХЭМЛЭХ ЗҮЙЛЭЭР ТОДРУУЛАХ НЬ (СЭЗИС-ийн оюутнуудын жишээн дээр)

Г.Дагвасүрэн¹, Ц.Мөнх-Өлзий², Ц.Гэрэл³

¹ Магистр (MSc & MBA), СЭЗИС, dagvasuren.g@ufe.edu.mn

² Магистр, СЭЗИС, munkhulzii.ts@ufe.edu.mn

³ Магистр (MBA), СЭЗИС, gerel.ts@ufe.edu.mn



Түлхүүр үг:

Тогтвортой хэрэглээ,
тогтвортой хэрэглээний
ойлголт, эрхэмлэх зүйл

Хураангуй

Их дээд сургуулиуд мэргэжлийн мэдлэг, чадвартай, зөв хандлагатай мэргэжилтнийг бэлтгэн гаргах нь нийгмийн өмнө хүлээсэн үүрэг учир тэдэнд даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, тэр дундаа тогтвортой хэрэглээний талаар таниулж, тогтвортой хэрэглээг дэмждэг, өөрийн амьдралд хэрэгжүүлдэг байхад чиглүүлсэн оюутны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой боловсруулахад нэн тэргүүнд тэдний тогтвортой хэрэглээний ойлголтыг тодруулах нь чухал юм. Иймээс уг судалгаагаар оюутнуудын тогтвортой хэрэглээний ойлголтыг хүрээлэн буй орчинд хандах хандлага, тогтвортой хэрэглээний мэдлэг, үйлдэхүй, тулгарах саад бэрхшээл болон тогтвортой хэрэглээг дэмжих гэсэн 5 багц ойлголтод хурааж, хүний эрхэмлэх зүйлийн нөлөөллөөр статистик хамаарлыг тодрууллаа. Судалгааг СЭЗИС-ийн 177 оюутнаас асуулгын аргаар авч, факторын шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, регрессийн шинжилгээ хийж, үр дүнг боловсруулав. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал болон өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маягийг эрхэмлэдэг бол хүрээлэн буй орчинд хандах хандлагад эерэг нөлөөтэй, нийгмийн тэгш, шударга байдлыг эрхэмлэдэг бол тогтвортой хэрэглээний үйлдэх, дэмжих байдал эерэг нөлөөтэй байна. Харин тухайн хүний эрхэмлэх зүйл ямар байхаас үл хамааран тогтвортой хэрэглээтэй байхад тодорхой саад бэрхшээл тулгарч байна гэсэн үр дүн гарлаа.

I. Удиртгал

Дэлхийн хүрээлэн орчин ба хөгжлийн хорооны (WCED) 1987 онд гаргасан “Бидний хамтын ирээдүй” илтгэлд (WCED, 1987) өмнөд нутгуудийг хамарсан ядуурал, хойд хагас дахь тогтвортой бус үйлдвэрлэлээс үүдэн дэлхий нийтийг хамарсан хүрээлэн буй орчны үлэмж хэмжээний доройтолд хүрч буйг томъёолж, хамтын хөгжлийн асуудлыг хөндсөн нь өдгөө

тогтвортой хөгжлийн үзэл санааны үндэс болжээ. Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2015 онд хойч ирээдүйдээ илүү сайхан, тогтвортой хөгжсөн дэлхийг өвлүүлэхийн тулд дэлхийн улс орнууд хамтдаа 17 зорилтыг томъёолж, дэвшүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030” нь түүнийг хэрэгжүүлж, улс орны ирээдүй, цаашлаад дэлхий нийтийн ирээдүйг сайн сайхан болгоход хөл нийлүүлэн алхах зорилт байв. Уг үзэл баримтлалын “Байгаль орчны багц үзүүлэлт”-ээр Монгол Улс 2014 онд 111 дүгээр байранд жагсаж байсан бол 2030 онд 90 дүгээр байранд жагсах зорилт тавьсан бөгөөд “байгаль орчны тогтвортой хөгжлийг хангахад нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангах болон байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх” зарчим баримтална гэж заажээ. Санхүү Эдийн Засгийн Их Сургууль нь 2021-2031 стратегийн төлөвлөгөөндөө алсын харааг “Даян дэлхийн тогтвортой хөгжил, эх орныхоо өрсөлдөх чадварт үнэ цэнтэй хувь нэмэр оруулах манлайлагчдыг бэлтгэнэ” хэмээн тодорхойлсон юм. Иймд, Монгол Улсаас анх удаагаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрхэн биелүүлж буйг үнэлэх цор ганц глобал жагсаалт болох “Times Higher Education Impact ranking” жагсаалтад орж, дэлхий ертөнцийн ирээдүйн төлөөх нөлөөллөөрөө дэлхийн 106 орны 1406 их сургуультай зэрэг үнэлүүлж, нийт үнэлгээгээр 2022 онд 867-р байранд жагссан байна.

Дэлхий нийтийн хандлага тогтвортой хөгжлийн цогц зорилтуудад чиглэж, хүн төрөлхтөн “дараа үеийнхнийхээ хэрэгцээгээ хангах боломжийг алдагдуулахгүйгээр” аж төрөх соёлд суралцах шаардлага үүсээд байгаа юм. Шинэ үеийн залуус хэрэгцээнээс давсан их хэмжээний үйлдвэрлэлийн хажуугаар хариуцлагатай амьдрахыг шаардаж буй завсрын/шилжилтийн үед (Ziesemer et al., 2021) амьдарч байна. Иймээс, их, дээд сургуулиуд мэргэжлийн мэдлэг, чадвартай, зөв хандлагатай мэргэжилтнийг бэлтгэн гаргах үүргийг нийгмийн өмнө хүлээдэг учир оюутнуудад даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, тэр дундаа тогтвортой хэрэглээний талаар таниулж, тогтвортой хэрэглээг дэмжин хэрэгжүүлдэг байхад чиглүүлсэн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой боловсруулах нь чухал ач холбогдолтой юм. Тогтвортой хэрэглээний мэдлэг, боловсрол нь боловсролын салбарын бодлого хийгээд тэтгэлэгтэй дүйцэхүйц хэмжээнд хөндөгдөж эхэлсэн ба хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого зохицуулалтад тогтвортой хөгжил, тогтвортой хэрэглээний агуулгыг шингээхийг (Stanzus et al., 2017) зорих болжээ. Тиймээс тогтвортой хэрэглээг дэмжих оюутны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахаас өмнө нэн тэргүүнд тэдний ойлголтын түвшинг тодруулах шаардлага үүсч байна.

II. Үндсэн хэсэг

Судлагдсан байдал

Өргөн цар хүрээ болон урт хугацаанд хэрэглээний нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тусгасан хэрэглэгчийн үйлдэхүйг илэрхийлэхийн тулд тогтвортой хэрэглээний нэр томъёог ашиглаж эхэлсэн (Schäfer et al., 2011) байна. 1994 онд НҮБ-ийн хүрээлэн буй орчны бодлого төлөвлөлтийн “Тогтвортой хэрэглээний бодлогын хүчин зүйл” тайланд дурдсан тогтвортой хэрэглээний ойлголтыг тодорхойлохдоо “хүний үндсэн хэрэгцээг хангаж, амьдралын чанарыг дээшлүүлэхийн хамт үйлчилгээ болон бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж, байгалийн нөөц болон хорт бодисын хэрэглээг бууруулж, хэрэглээнээс үүдсэн

хог хаягдал, бохирдлыг багасгах юм” хэмээжээ. Ерөнхий утгаар авч үзвэл үндсэн хэрэгцээг хангаж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд төвлөрч, өнөө үеийн төдийгүй дараа үеийн хэрэгцээнд нийцэх, байгаль орчинд ээлтэй хэрэглээг тогтвортой хэрэглээ гэнэ. (Quoquab et al., 2019) Тогтвортой хэрэглээ бол эдийн засгийн, хувь хүний, нийгмийн болон байгаль орчны сайн сайхантай холбогдуулан удаан эдэлгээтэй, чанартай бүтээгдэхүүнийг худалдан авах, хэрэглэх, хаях, боловсруулах тухай ойлголт юм. Үүний адилаар тогтвортой хэрэглээтэй хэрэглэгч гэдэг нь эдийн засгийн, хувь хүний, нийгмийн болон байгаль орчны сайн сайханд анхаарч, хэрэглээнээс үүдэлтэй нөлөөлөлд санаа зовниж, түүнийгээ бусадтай хуваалцдаг хүмүүсийг хэлнэ (Sheth et al.2011). Тэгэхээр тогтвортой хэрэглээнд суралцаж, өөрийн амьдралд дадал зуршил болгох үйл явц нь амьдралын хэв маяг, хүн ам зүйн суурь үзүүлэлт, зан төлөв, төлөвшил, соёлоос хамааран амьдралын турш үргэлжилэхээс гадна нас болон хүйс тодорхой хэмжээнд нөлөөлөх боломжтой юм.

Сүүлийн жилүүдэд хүрээлэн буй орчинд ээлтэйгээр амьдрах хандлага чухал болохыг ойлгож, улс орон бүр өөрийн бодлогоор дэмжиж байгаа ч нэгэнт тогтсон хүн төвт үзлээс үүдсэн үйлдвэржилтийн эрин үеийн нөлөөг шууд бууруулах боломжгүй юм. Иймд хэрэглээ өндөр, үйлдвэрлэл нь хэрэглээнээс давсан цаг үед төрж өссөн залуу үеийнхний талаар судалж, тогтвортой хэрэглээний өнөөгийн ойлголтыг, тэдэнд тулгарч буй саад бэрхшээл, үйлдэхүйд хөтлөх эрхэмлэх зүйлийг тодруулах нь чухал байна. Учир нь, залуу үе нь хүрээлэн буй орчныг хамгаалах нэн чухал бүлэг (Caruana & Vassallo, 2003) болохоос гадна өмнөх үеийн судалгаануудтай харьцуулахад тогтвортой хэрэглээний зан төлөв, үйлдэхүйд залуу үеийнхний нас эерэг хамааралтай (Dimitrova et al., 2022) байна. Хэрэв, бие хүний амьдралын зөв, таатай хэв маяг, хувийн санхүүд эергээр нөлөөлж байвал залуу үеийнхэн тогтвортой хэрэглээг дэмжихэд бэлэн (Ziesemer et al., 2021) байгаа нь тогтвортой хэрэглээний ойлголтыг олон төрлийн сувгаар байнга хүлээн авч (Dimitrova et al., 2022), ерөнхий ойлголттой болсныг илтгэнэ. Техник, технологийн эрин үе бидэнд олон төрлийн мэдээллийг хязгааргүйгээр авах боломжийг олгож эхэлсэн нь мэдээллээс хоцрохгүй байж, дэлхий нийтийн чиг хандлагыг мэдэх, өөрийн амьдралдаа тусгах, даган дуурайх сонголтыг бий болгож байна.

Тогтвортой хэрэглээ нэр томъёог дагалдаж, эко бүтээгдэхүүн, сав, баглаа боодол гэх ойлголт бидний өдөр тутмын сонголтод нөлөөлж эхэллээ. Теста нарын (Testa et al., 2021) судлаачид ногоон бүтээгдэхүүн, түүний хэрэглээний талаар 2000-2018 онд хэвлэгдэн гарсан 113 хянан магадлалтай хэвлэгдсэн өгүүлэлд анализ хийхэд хүн ам зүйн үзүүлэлтүүдээс зөвхөн хүйс, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг худалдан авахад эерэг хамааралтай байгааг тогтоожээ.

Ш. Судалгааны арга зүй

Судалгааны асуулга

Судалгааны асуулгыг хүн ам зүйн үзүүлэлт (хүйс, төгссөн газар, мэргэжлийн чиглэл), судалгаанд оролчогчийн эрхэмлэх зүйлс (хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал, нийгмийн тэгш, шударга байдал, өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг, мөнгө санхүү, хадгаламж), болон тогтвортой хэрэглээний талаарх 5 багц (хүрээлэн буй орчинд хандах хандлага, тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг, тогтвортой хэрэглээний үйлдэхүй,

тогтвортой хэрэглээтэй байхад тулгарах саад бэрхшээл, тогтвортой хэрэглээг дэмжих) ойлголтыг тодруулах 19 асуулт бүхий 3 хэсэгтэйгээр боловсруулав. Асуултуудад таван утгат Лайкертын шкалаар хариулна.

Найдвартай байдал ба факторын шинжилгээ

Тогтвортой хэрэглээний талаарх 5 багц ойлголтыг хэмжиж буй загварын найдвартай байдлыг шалгахын тулд баталгаажуулах факторын шинжилгээ хийж хэмжилтийн зүйл тус бүрийн факторын ачаалал, Кронбахын альфа коэффициент, нийлмэл найдвартай байдал (CR), олборлосон дундаж вариацийн (AVE) оноог ашиглана. 1951 онд Ли Кронбахийн боловсруулсан Кронбахын альфа, α нь найдвартай байдал буюу дотоод тогтвортой байдлыг хэмждэг. Нийлмэл найдвартай байдал (заримдаа бүтцийн найдвартай байдал гэж нэрлэдэг) нь Кронбахын альфа шиг хэмжилтийн зүйлсийн дотоод нийцлийн хэмжүүр юм (Netemeyer, 2003). Нийлмэл найдвартай байдал нь Кронбахын альфатай төстэй далд хувьсагчийг (буюу бүтцийг) хэмжихэд ашигладаг багц зүйлийн дотоод нийцлийн хэмжүүр юм. Гэсэн хэдий ч, Кронбахын альфа нь τ -эквивалент (жишээ нь, бүх зүйлсийн факторын ачаалал тэнцүү) гэж үздэг бол, түүнээс ялгаатай нь нийлмэл найдвартай байдал нь хүчин зүйлийн ачаалал өөр өөр байж болно гэж үздэг. Найдвартай байдлын нийлмэл коэффициент нь 0-1 хооронд хэлбэлздэг бөгөөд өндөр утга нь зүйлүүдийн хоорондын дотоод нийцтэй байдлыг харуулдаг. Далд хувьсагчид дахь зүйлүүд нь ялгаатай факторын ачаалалтай байх үед үүнийг Кронбах альфагаас илүүд үздэг. Олборлосон дундаж вариация (AVE) нь хэмжилтийн алдаа буюу бусад хэлбэлзлийн эх үүсвэрээс үүдэлтэй вариацийн хэмжээтэй холбоотой далд хувьсагчаар тогтоогдсон хэлбэлзлийн хэмжээ юм. AVE нь 0-1 хооронд хэлбэлздэг бөгөөд 1-тэй ойртсон утга нь факторууд болон түүнийг илэрхийлэх зүйлсийн хооронд илүү хүчтэй хамааралтай болохыг харуулна.

Хувьсагчдын хоорондын хамаарал факторын шинжилгээ хийхэд хангалттай эсэхийг тодорхойлоход КМО тестийг хэрэглэлээ. Хэрэв КМО-ийн утга бага байвал энэ нь хувьсагчид хоорондын нийтлэг вариация хангалтгүй байгааг харуулах бөгөөд энэ нь өгөгдөл хүчин зүйлийн шинжилгээнд тохиромжгүй гэсэн үг юм. Харин эсрэгээрээ, КМО-ийн утга өндөр байвал энэ нь хувьсагчдын дунд хангалттай нийтлэг хэлбэлзэл байгааг харуулах буюу өгөгдөл нь факторын шинжилгээнд тохиромжтой. Мөн өгөгдлийн бүрдэл дэх хувьсагчдын бүрдэл нь тохиромжтой эсэхийг Бартлеттын тест ашиглан шалгалаа. Тус тестийн тэг таамаглал нь хувьсагчид корреляцтай бөгөөд цөөн тооны факторууд болгон бууруулж болно гэсэн таамаглал байдаг.

Баталгаажуулах факторын шинжилгээний дараагаар, эрхэмлэх зүйлс болон тогтвортой хэрэглээний талаарх 5 багц ойлголтын үнэлгээг дескриптив статистикийн тусламжтайгаар тоймлох бөгөөд цаашлаад эдгээрийг хүйсээр статистик ач холбогдол бүхий ялгаатай эсэхийг үл хамаарах хоёр эх олонлогийн дунджийг харьцуулах t тест ашиглан шалгана. Түүнчлэн, хувь хүний эрхэмлэх зүйлс нь тэдний тогтвортой хэрэглээний талаарх ойлголтод нөлөөлж буй эсэхийг олон хувьсагчийн регрессийн шинжилгээний тусламжтайгаар шалгана. Эдгээр дүн шинжилгээг гүйцэтгэхэд SPSS 25 программ ашиглана.

IV. Судалгааны үр дүн

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд СЭЗИС-ийн 177 оюутан хамрагдсанаас 65 хувь нь эмэгтэй оюутан байна. Түүвэрт хамрагдсан оюутнуудын 73.8 хувь нь Улаанбаатар хотод, 18.4 хувь нь орон нутагт (Дархан-Уул, Орхон аймгийг эс тооцвол) ерөнхий боловсрол эзэмшсэн байна. Мэргэжлийн байдлаар нь авч үзвэл, 40.3 хувь нь санхүүгийн менежмент, 14.6 хувь нь нягтлан бодох бүртгэл, 14.3 хувь нь мэдээллийн системийн менежмент хөтөлбөрөөр суралцагчид байна.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

		Тоо	Хувь
Хүйс	Эмэгтэй	115	65.0%
	Эрэгтэй	62	35.0%
Ерөнхий боловсрол	Улаанбаатар хот	131	73.6%
	Хөдөө, орон нутаг	33	18.5%
	Дархан-Уул, Эрдэнэт	12	6.7%
	Гадаад улсад	2	1.1%
Мэргэжил	Санхүүгийн менежмент	71	40.3%
	Нягтлан бодох бүртгэл	26	14.8%
	Мэдээллийн системийн менежмент	25	14.2%
	Бизнесийн менежмент	15	8.5%
	Банкны менежмент	10	5.7%
	Бусад	10	5.7%
	Даатгал	8	4.5%
	Маркетингийн менежмент	7	4.0%
	Худалдаа	4	2.3%

2. Найдвартай байдал ба факторын шинжилгээ

Ялгаатай далд хувьсагчдын найдвартай байдал болон хүчин төгөлдөр байдлыг шинжиллээ. Бид холбогдох далд хувьсагч бүрийн хувьд Кронбахын альфа коэффициент 0.6-гаас дээш бол хүлээн зөвшөөрч болохуйц, CR коэффициент 0.7-оос дээш бол далд хувьсагчдын дотоод нийцтэй байдал нь тогтвортой бөгөөд хэмжигдэхүүний загвар найдвартай, AVE нь 0.5-аас дээгүүр бол хэмжигдэхүүний загварын таарамжийн хүчин төгөлдөр байдал нь сайн гэж үзнэ (Хүснэгт 2). Мөн факторын ачааллын коэффициент 0.5-д хүрээгүй зүйлсийг далд хувьсагчийн багцаас хассан болно. Тодруулбал, хүрээлэн буй орчинд хандах хандлагын тухайд “Би, өөрийн хийж буй үйлдлээрээ хүрээлэн буй орчныг хамгаалахад хувь нэмэр оруулж чадна гэдэгт итгэдэг” гэсэн зүйлийг, тогтвортой хэрэглээний үйлдэхүйн тухайд “Нийтийн тээвэр, унадаг дугуй, эсвэл явганаар явахыг автомашин унахаас илүүд үздэг” болон “Гэртээ эрчим хүч, ус хэмнэхийг эрхэмлэдэг” гэсэн зүйлүүдийг тус тус хассан болно. Мөн далд хувьсагч тус бүрийн AVE утгын язгуур нь, тэдгээрийн корреляцын коэффициентоос өндөр байгаа тул дискриминант хүчин төгөлдөр байдал хангагдсан гэж дүгнэж болохоор байна (Хүснэгт 3).

Хүснэгт 2. Найдвартай байдал ба факторын шинжилгээний үр дүн

Бүтэц ба зүйлс	Ачаалал
Хүрээлэн буй орчинд хандах хандлага (Кронбахын $\alpha = 0.556$, CR = 0.708, AVE = 0.551)	
2-1. Би, хүрээлэн буй орчны асуудалд бие хүний хувьд хариуцлага хүлээх ёстойгоо ухамсарладаг.	0.808
2-3. Би, хүрээлэн буй орчинд ээлгүй хэрэглээнээс үүдэх үр дагаварт сэтгэл зовнидог.	0.670
Тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг (Кронбахын $\alpha = 0.705$, CR = 0.874, AVE = 0.569)	
3-1. Би, тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл сайтай.	0.802
3-2. Би, өөрийн хэрэглээнийхээ хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг ойлгодог.	0.791
3-3. Би, эко шошго гэж юу болох, яагаад сонгох ёстойг мэддэг.	0.661
Тогтвортой хэрэглээний үйлдэхүй (Кронбахын $\alpha = 0.627$, CR = 0.819, AVE = 0.471)	
4-1. Байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн худалдан авдаг.	0.655
4-2. Нийтийн тээвэр, унадаг дугуй, эсвэл явганаар явахыг автомашин унахаас илүүд үздэг.	0.761
4-4. Хөдөө орон нутгийн, органик бүтээгдэхүүн хэрэглэхийг эрмэлздэг.	0.636
Тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл (Кронбахын $\alpha = 0.617$, CR = 0.864 AVE = 0.451)	
5-1. Тогтвортой бүтээгдэхүүний өндөр өртөг нь намайг тогтвортой хэрэглээтэй байхад саад болдог.	0.655
5-2. Тогтвортой хэрэглээний хязгаарлагдмал сонголт намайг тогтвортой хэрэглээтэй байхад саад болдог.	0.663
5-3. Тогтвортой хэрэглээний талаарх мэдээлэл, ойлголтын дутмаг байдал намайг тогтвортой хэрэглээтэй байхад саад болдог.	0.681
5-4. Тогтвортой хэрэглээнээс үүдэн миний тав тух, таатай байдал алдагдана гэдгээс айдаг.	0.688
Тогтвортой хэрэглээг дэмжих (Кронбахын $\alpha = 0.723$, CR = 0.881 AVE = 0.509)	
6-1. Би, тогтвортой бүтээгдэхүүн, практик туршлагын талаар илүү их мэдээлэл авах сонирхолтой байна.	0.759
6-2. Би, байгальд ээлтэй бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ төлбөрийг төлөхөд бэлэн байна.	0.777
6-3. Би хүрээлэн буй орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай компаниудыг дэмжихийг илүүд үздэг.	0.787
6-4. Би тогтвортой хэрэглээг дэмжих төрийн бодлого, зохицуулалтыг дэмждэг.	0.807

Хүснэгт 3. Форнелл Ларкерийн шалгуур

	1	2	3	4	5
Хүрээлэн буй орчинд хандах хандлага	0.742				
Тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг	.225**	0.754			
Тогтвортой хэрэглээний үйлдэхүй	.305**	.294**	0.686		
Тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл	.226**	0.063	.198**	0.671	
Тогтвортой хэрэглээг дэмжих	.274**	.347**	.349**	0.127	0.713

Факторын шинжилгээнд КМО 0.6-аас дээш байвал хүлээн зөвшөөрөгддөг ба судалгаанд КМО нь 0.711 байгаа тул хангалттай гэж үзэв. Өгөгдлийн бүрдэл дэх хувьсагчдын бүрдэл нь тохиромжтой эсэхийг Бартлеттын тест ашиглан шалгалаа. Тус тестийн тэг таамаглал нь хувьсагчид корреляцтай бөгөөд цөөн тооны факторууд болгон бууруулж болно гэсэн таамаглал байдаг. Судалгаанд тестийн статистик, $\chi^2 = 717.2$ буюу тэг таамаглалыг няцаасан байна ($p < 0.001$). Өөрөөр хэлбэл, хувьсагчид факторын шинжилгээ хийхэд тохиромжтой байсныг харуулж байна.

3. Дескриптив статистик

Бие хүний эрхэмлэх зүйл нь хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал (4.70 ± 0.57), нийгмийн тэгш, шударга байдал (4.72 ± 0.65), өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг (4.69 ± 0.60), мөнгө санхүү, хадгаламж (4.53 ± 0.66) тус бүрийг чухалчлах байдал нь дунджаар ойролцоо байна. Тогтвортой хэрэглээний талаарх ойлголтын тухайд, хүрээлэн буй орчинд хандах хандлага (4.36 ± 0.61), тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал (4.03 ± 0.64) өндөр, харин тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг (3.60 ± 0.76), тогтвортой хэрэглээний үйлдэхүй (3.54 ± 0.78), тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл (3.62 ± 0.69) нь дунджаар ялимгүй бага байна.

Хүснэгт 4. Дескриптив статистик

	N	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Стандарт хазайлт
Бие хүний эрхэмлэх зүйлс					
Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал	177	2.00	5.00	4.70	0.57
Нийгмийн тэгш, шударга байдал	177	2.00	5.00	4.72	0.65
Өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг	177	2.00	5.00	4.69	0.60
Мөнгө санхүү, хадгаламж	177	2.00	5.00	4.53	0.66
Тогтвортой хэрэглээний талаарх ойлголт					
Хүрээлэн буй орчинд хандах хандлага	177	2.50	5.00	4.36	0.61
Тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг	177	1.33	5.00	3.60	0.76
Тогтвортой хэрэглээний үйлдэхүй	177	1.33	5.00	3.54	0.78
Тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл	177	2.25	5.00	3.62	0.69
Тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал	177	1.50	5.00	4.03	0.64

4. Харьцуулалтын шинжилгээ

Эрхэмлэх зүйлс, тогтвортой хэрэглээний талаарх ойлголт нь хүйсээр ялгаатай эсэхийг тодорхойлохын тулд үл хамаарах түүврүүдийн t тест ашиглалаа (Хүснэгт 4).

Бие хүний эрхэмлэх зүйлсийн тухайд, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал, нийгмийн тэгш, шударга байдал, өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл мэнд, зөв хэв маяг зэрэг нь эмэгтэй оюутнуудын хувьд дунджаар статистик ач холбогдол бүхий өндөр байна. Тогтвортой хэрэглээний талаарх ойлголтын тухайд, тогтвортой хэрэглээний үйлдэхүй болон

тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал нь эмэгтэй оюутнуудын хувьд мөн дунджаар статистик ач холбогдол бүхий өндөр байна.

Хүснэгт 4. Хүйсээр харьцуулсан t тестийн үр дүн

Хувьсагчид	Хүйс	N	Дунда ж	Стандарт хазайлт	p-утга
<i>Бие хүний эрхэмлэх зүйлс</i>					
1-1. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал	Эрэгтэй	62	4.59	0.72	0.097
	Эмэгтэй	115	4.76	0.47	
1-2. Нийгмийн тэгш, шударга байдал	Эрэгтэй	62	4.54	0.86	0.023
	Эмэгтэй	115	4.82	0.48	
1-3. Өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг	Эрэгтэй	62	4.52	0.75	0.017
	Эмэгтэй	115	4.78	0.49	
1-4. Мөнгө санхүү, хадгаламж	Эрэгтэй	62	4.50	0.72	0.686
	Эмэгтэй	115	4.54	0.62	
<i>Тогтвортой хэрэглээний талаарх ойлголт</i>					
Хүрээлэн буй орчинд хандах хандлага	Эрэгтэй	62	4.26	0.69	0.149
	Эмэгтэй	115	4.41	0.56	
Тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг	Эрэгтэй	62	3.47	0.71	0.105
	Эмэгтэй	115	3.66	0.77	
Тогтвортой хэрэглээний үйлдэхүй	Эрэгтэй	62	3.36	0.87	0.020
	Эмэгтэй	115	3.64	0.71	
Тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл	Эрэгтэй	62	3.61	0.70	0.901
	Эмэгтэй	115	3.62	0.68	
	Эрэгтэй	62	3.81	0.74	
Тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал	Эмэгтэй	115	4.15	0.54	

5. Регрессийн шинжилгээ

Бие хүний эрхэмлэх зүйлс (хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал, нийгмийн тэгш, шударга байдал, өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг) нь тогтвортой хэрэглээний талаарх ойлголтод (хүрээлэн буй орчинд хандах хандлага, тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг, тогтвортой хэрэглээний үйлдэхүй, Тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй саад бэрхшээл, тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал) үзүүлэх нөлөөг олон хувьсагчийн регрессийн шинжилгээний тусламжтайгаар шинжиллээ. Олон хувьсагчийн регрессийн шинжилгээнд хүйс (эмэгтэй бол 1, үгүй бол 0 гэсэн утга бүхий хуурмаг хувьсагч), боловсрол эзэмшсэн газар (Улаанбаатар болон гадаадад бол 1, үгүй бол 0 гэсэн утга бүхий хуурмаг хувьсагч) болон мэргэжил (Санхүү хөтөлбөрөөр суралцдаг бол 1, үгүй бол 0 гэсэн утга бүхий хуурмаг хувьсагч) зэргийг хяналтын хувьсагчаар авч үзсэн болно.

Бие хүний эрхэмлэх зүйлс нь хүрээлэн буй орчинд хандах хандлагад нөлөөтэй эсэхийг шалгасан олон хувьсагчийн регрессийн шинжилгээний үр дүнгээс (1 дүгээр багана) харахад хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал болон өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маягийг илүү чухалчилдаг бол хүрээлэн буй орчинд хандах хандлага сайн байх төлөвтэй буюу эерэг нөлөөтэй. Тодруулбал, бусад хүчин зүйлс тогтмол үед, хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгааллыг чухалчлах байдлын үнэлгээ нь 1 стандарт хазайлтаар

өндөр байх нь хүрээлэн буй орчинд хандах хандлагын үнэлгээг 0.286 стандарт хазайлтаар нэмэгдүүлдэг байна ($t=3.46, p<0.001$). Өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маягийг чухалчлах байдлын үнэлгээ нь 1 стандарт хазайлтаар өндөр байх нь хүрээлэн буй орчинд хандах хандлагын үнэлгээг 0.146 стандарт хазайлтаар нэмэгдүүлдэг байна ($t=1.86, p<0.001$).

Бие хүний эрхэмлэх зүйлс нь тогтвортой хэрэглээний үйлдэхүйд нөлөөтэй эсэхийг шалгасан олон хувьсагчийн регрессийн шинжилгээний үр дүнгээс (3 дугаар багана) харахад нийгмийн тэгш, шударга байдлыг илүү чухалчилдаг бол тогтвортой хэрэглээний үйлдэхүй өндөр байх төлөвтэй буюу эерэг нөлөөтэй. Тодруулбал, бусад хүчин зүйлс тогтмол үед, нийгмийн тэгш, шударга байдлыг чухалчлах байдлын үнэлгээ нь 1 стандарт хазайлтаар өндөр байх нь хүрээлэн буй орчинд хандах хандлагын үнэлгээг 0.172 стандарт хазайлтаар нэмэгдүүлдэг байна ($t=2.27, p<0.05$).

Бие хүний эрхэмлэх зүйлс нь тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдалд нөлөөтэй эсэхийг шалгасан олон хувьсагчийн регрессийн шинжилгээний үр дүнгээс (5 дугаар багана) харахад нийгмийн тэгш, шударга байдлыг илүү чухалчилдаг бол тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдал өндөр байх төлөвтэй буюу эерэг нөлөөтэй. Тодруулбал, бусад хүчин зүйлс тогтмол үед, нийгмийн тэгш, шударга байдлыг чухалчлах байдлын үнэлгээ нь 1 стандарт хазайлтаар өндөр байх нь тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдлын үнэлгээг 0.240 стандарт хазайлтаар нэмэгдүүлдэг байна ($t=3.26, p<0.01$).

Бие хүний эрхэмлэх зүйлс нь тогтвортой хэрэглээний талаарх мэдлэг болон тогтвортой хэрэглээтэй байхад тулгамдаж буй бэрхшээлд статистик ач холбогдол бүхий нөлөө үзүүлээгүй байна (2 ба 4 дүгээр багана).

Хүснэгт 5. Регрессийн шинжилгээний үр дүн

	(1)	(2)	(3)	(4)	(5)
(Constant)	2.000*** (0.480)	2.920*** (0.676)	2.294*** (0.524)	2.485*** (0.613)	2.578*** (0.422)
Хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал	0.306*** (0.084)	0.056 (0.127)		0.046 (0.115)	
Нийгмийн тэгш, шударга байдал		0.114 (0.109)	0.206** (0.091)	-0.069 (0.098)	0.237*** (0.073)
Өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маяг	0.148* (0.084)	-0.050 (0.112)		0.136 (0.102)	
Мөнгө санхүү, хадгаламж		-0.035 (0.096)		-0.035 (0.096)	
Эмэгтэй	0.078 (0.094)	0.179 (0.125)	0.249** (0.124)	0.019 (0.114)	0.299*** (0.099)
УБ болон гадаад ЕБ эзэмшсэн	0.093 (0.102)	0.116 (0.136)	0.005 (0.135)	0.189 (0.124)	0.058 (0.109)
Санхүүгийн менежмент	0.038 (0.089)	-0.117 (0.118)	0.256** (0.117)	-0.033 (0.107)	0.097 (0.094)
Ажиглалтын тоо	177	177	177	177	177
R-квадрат	0.145	0.039	0.079	0.037	0.123

Дүгнэлт

Уг судалгаагаар бид тогтвортой хэрэглээний ойлголтыг оюутны эрхэмлэх зүйлээр тодруулж, хамаарлыг гаргах замаар оюутнуудын тогтвортой хэрэглээний талаарх ойлголтыг тодруулахаар зорив. Ингэснээр, хүрээлэн буй орчныг хамгаалах нэн чухал бүлэг (Caruana & Vassallo, 2003) болох оюутан залууст даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, тэр дундаа тогтвортой хэрэглээний талаар таниулж, тогтвортой хэрэглээг өөрийн амьдралд дэмжин хэрэгжүүлэхэд чиглүүлсэн оюутны хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг оновчтой боловсруулахад бидний судалгааны ач холбогдол оршино.

Судалгаанд СЭЗИС-ийн 177 оюутан хамрагдсанаас 65 хувь нь эмэгтэй оюутан байна. Түүвэрт хамрагдсан оюутнуудын 73.8 хувь нь Улаанбаатар хотод, 18.4 хувь нь орон нутагт (Дархан-Уул, Орхон аймгийг эс тооцвол) ерөнхий боловсрол эзэмшсэн байна. Судалгааны үр дүнгээс харвал, судалгааны 5 багц 16 асуултын дотоод хамаарал өндөр байгаа нь хүрээлэн буй орчны хандлага, тогтвортой хэрэглээний талаарх ойлголт, үйлдэхүй, саад бэрхшээл болон дэмжлэгийн хооронд боломжит хамаарал байгааг илтгэж байна. Мөн, судалгаанд оролцогчдын хүйс тодорхой үүрэг гүйцэтгэж байна. Эрэгтэй оюутнуудтай харьцуулахад эмэгтэй оюутнууд нийгмийн тэгш шударга байдал, өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маягийг илүү чухалчлан авч үзэж эрхэмлэх зүйлээр сонгосон бол тогтвортой хэрэглээний ойлголтын хувьд хүрээлэн буй орчинд хандах хандлага, тогтвортой хэрэглээг дэмжиж буй байдлыг чухалчилсан үзүүлэлттэй байна. Хвангийн судалгаанд (Hwang, 2021) эмэгтэй хүйсийн нөөцийг дахин ашиглах, байгальд ээлтэй бүтээгдэхүүн сонгох, эрчим хүчийг хэмнэх зэрэг тогтвортой хэрэглээг хэрэгжүүлэх байдал эрэгтэй хүйстэй харьцуулахад илүү үзүүлттэй гарсан байна.

Регрессийн шинжилгээгээр хүрээлэн буй орчны аюулгүй байдал, хамгаалал болон өөрийн эрүүл мэнд, амьдралын эрүүл, зөв хэв маягийг эрхэмлэдэг бол хүрээлэн буй орчинд хандах хандлагад эерэг нөлөөтэй, нийгмийн тэгш, шударга байдлыг эрхэмлэдэг бол тогтвортой хэрэглээний үйлдэхүй болон тогтвортой хэрэглээг дэмжихэд эерэг нөлөөтэй байна. Харин тухайн хүний эрхэмлэх зүйл ямар байхаас үл хамааран оюутнууд тогтвортой хэрэглээний талаар ойлголттой байгаа нь тогтвортой хэрэглээг дадал зуршил болгон төлөвшүүлэх боломжийг харуулж байна. Тогтвортой хэрэглээтэй байхад тулгарах саад бэрхшээл нь оюутны ойлголт болон эрхэмлэх зүйлээс үл хамааралтай байгаа нь тогтвортой хэрэглээтэй байхад нөлөөлөх хүчин зүйлийг олж тодруулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Иймээс бид тогтвортой хэрэглээний талаарх ойлголтыг хүрээлэн буй орчин болон амьдралын эрүүл, зөв хэв маяг, тогтвортой хэрэглээний үйлдэхүйд нөлөөлөх цогц ойлголт гэдгийг харуулсан зорилтот агуулгыг үе шаттайгаар оюутны хөгжлийн хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагаандаа тусгах замаар нөлөөлөх боломжтой юм. Тогтвортой хэрэглээний ойлголтыг оюутны эрхэмлэх зүйлээр тодруулж, хамаарлыг гаргахдаа 177 оюутныг төлөөлөл болгон судалгааг авсан тул цаашид хийх судалгаанд оролцогчдыг нэмэгдүүлж, судалгааны үр дүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийн буюу курсийн ялгаа, хүйсийн ялгаа, бие даасан орлоготой эсэх зэргээр илүү нарийвчлан магадлах нь зүйтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Balderjahn, I., & Hüttel, A. (2019). Why Consumers Buy Sustainably: The Role of Personal Values. *Marketing*, 41(1), 24-38.
- Caruana, A., & Vassallo, R. (2003). Children's perception of their influence over purchases: the role of parental communication patterns. *Journal of Consumer Marketing*.
- Dangelico, R. M., Nonino, F., & Pompei, A. (2021). Which are the determinants of green purchase behaviour? A study of Italian consumers. *Business strategy and the environment*, 30, 2600-2620. DOI: 10.1002/bse.2766
- Dimitrova, T., Ilieva, I., & Angelova, M. (2022). Exploring Factors Affecting Sustainable Consumption Behaviour. *Administrative sciences*, 12(155), 1-22. <https://doi.org/10.3390/admsci12040155>
- Hawkes, J. (2001). *The fourth pillar of sustainability*. Common Ground Publishing Pty.
- Hwang, M. J. (2021, 2 2021). Longitudinal trends and implications of consumers' sustainable consumption behavior as measured by the Consumer Life Index. *소비자정책동향*, 110(129), 1-27. <https://www.dbpia.co.kr/journal/articleDetail?nodeId=NODE10547037>
- Lundbald, L., & Davies, I. A. (2016). The values and motivations behind sustainable fashion consumption. *Consumer Behaviour*, 15, 149-162. DOI: 10.1002/cb.1559
- Paavola, J. (2001). Towards Sustainable Consumption: Economics and Ethical Concerns for the Environment in Consumer Choices. *Review of social economy*, 59(2), 227-248.
- Prakash, N., & Thakur, A. (2023). Relationship among Consumer Values, Green Brand Equity and Green Purchase Intention: A Conceptual Framework. *International Management Review*, 19(special issue), 49-59.
- Roos, D., & Hahn, R. (n.d.). Understanding Collaborative Consumption: An Extension of the Theory of Planned Behavior with Value-Based Personal Norms. *Business ethics*, 158, 679-697. DOI 10.1007/s10551-017-3675-3
- Sener, A., & Hazer, O. (2008). Values and Sustainable Consumption Behavior of Women: a Turkish Sample. *Sustainable Development*, 16, 291-300. DOI: 10.1002/sd.329
- Stanzus, L., Fischer, D., Bohme, T., Frank, P., Fritzsche, J., Geiger, S., Harfensteller, J., Grossman, P., & Schrader, U. (2017). Education for Sustainable Consumption through Mindfulness Training: Development of a Consumption-Specific Intervention. *Teacher Education for Sustainability*, 19(1), 5-21. DOI: 10.1515/jtes-2017-0001
- Testa, F. (2021). Drivers to green consumption: a systematic review. *Environment, Development and Sustainability*, 23, 4826-4880. <https://doi.org/10.1007/s10668-020-00844-5>
- WCED. (1987). *Report of the World Commission on Environment and Development: Our Common Future*.
- Young, W., Hwang, K., McDonald, S., & Oates, C. J. (2010). Sustainable Consumption: Green Consumer Behaviour when Purchasing Products. *Sustainable Development*, 18, 20-31. DOI: 10.1002/sd.394
- Yuksel, C. U., & Kaya, C. (2021). Traces of cultural and personal values on sustainable consumption: An analysis of a small local swap event in Izmir, Turkey. *Consumer behavior*, 20, 231-241. DOI: 10.1002/cb.1843
- Ziesemer, F., Hüttel, A., & Balderjahn, I. (2021). Young People as Drivers or Inhibitors of the Sustainability Movement: The Case of Anti-Consumption. *Consumer Policy*, 44, 427-453. <https://doi.org/10.1007/s10603-021-09489-x>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ,
ТҮҮНИЙ АСУУДЛУУД

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛЧУУДЫН ГАДААДЫН ЖУУЛЧИНД ХАНДАХ ХАНДЛАГА

Б.Мөнхзул

Бакалавр, Монгол Улсын Их Сургууль



Түлхүүр үг:

Аялал жуулчлал, гадаадын жуулчид, жуулчинд хандах хандлага гэсэн түлхүүр үг оруулах

Хураангуй

Улс бүрийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогод жуулчин ихээр татах, өөрийн улс орны онцлогийг шингээсэн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх, ажилгүйдлийг арилгах, салбарын ажлын байрыг хадгалах, аялал жуулчлалыг тогтвортой хөгжлийн бодлогод нийцүүлэхтэй холбогдсон төрөл бүрийн судалгаанууд ихээхэн хийгддэг. Аялал жуулчлалыг хөгжүүлэх гэдэг зөвхөн засгийн газрын бодлого, хүлээн авагч тур оператор, жуулчин гэх талуудаас илүү жуулчин хүлээн авч буй оршин суугчдын хандлага чухал байр суурь үзүүлдэг бөгөөд дахин тухайн оронд жуулчин ирэх шийдвэрт шууд хамааралтай байдгийг тус салбарын судлаач, мэргэжилтнүүд тодорхойлсон байдаг. Эдгээрээс Монголын аялал жуулчлалын монголчуудын Гадаадын жуулчинд хандах хандлага /Attitudes toward tourism/ ямар байгааг судлах нь ихээхэн ач холбогдолтой юм. Тиймээс аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, аюулгүй байдлыг хангах, чанарыг бодитой үнэлэхэд түлхэц болохуйц асуудал бол оршин суугч, жуулчин хүлээн авч буй иргэд, тухайн газрын дүр төрх, тэдний үзүүлж буй хоорондын нөлөөлөл юм.

Удиртгал

Нүүдэлчин соёлыг тээгч нь монгол хүн юм. Монгол улс 1950-аад оноос аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг тодорхойлж, судалгаа идэвхтэй хийж эхэлсэн цагаас өнөөг хүртэл нүүдэлчин соёл дээр тулгуурлан аялал жуулчлалаа хөгжүүлэх хүн төвтэй бодлого баримталж ирсэн байдаг. Хотжилт хөгжиж, амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр олон улсад гаднын оронд аялж амарна гэдэг ялангуяа хотод амьдардаг хүмүүсийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх салшгүй чухал зүйл болжээ. Аялал жуулчлалын газруудыг сонгохдоо хүмүүс ихэвчлэн уул, нуур болон бусад зэрлэг газрууд бүхий жижиг хот, тосгон, тосгоныг чухалчлан үздэг бөгөөд эдгээр нь "сэтгэл хөдөлгөм, өдөөлт, адал явдал, шинэ санааг бий болгодог" (Beedie and Hudson, 2003, p. 625). Жуулчид аялах хугацаандаа эерэг ба сөргөөр, шууд болон шууд бусаар нөлөөлдөг орон нутгийн оршин суугчидтай зайлшгүй харилцах

болдог (Yoon et al., 2001). Аялал жуулчлалын оролцогч талуудын нэг болохын хувьд орон нутгийн оршин суугчид жуулчдын очих газарт чухал ач холбогдолтой болж байгаа бөгөөд тэдний эерэг хандлага нь тухайн орны аялал жуулчлалыг тогтвортой байлгах чухал урьдчилсан нөхцөл гэж үздэг (Agarito et al., 2010; Sinclair-Maragh and Gursoy, 2016; Ribeiro et al., 2017). Нункоо нар. (2013, х. 6) хүртэл “оршин суугчдын оролцоо, хамтын ажиллагаа нь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх чухал ач холбогдолтой” гэж үзжээ. Хэдийгээр зарим эмпирик судалгаагаар оршин суугчдын орон нутгийн аялал жуулчлалын хөгжилд хандах хандлага, хариу үйлдлийг судалж үзсэн боловч цөөн хүн оршин суугчдын газар нутгийн дүр төрх, газар нутгийн хамаарлыг урьдал зүйл гэж үздэг (Stylidis, 2015; Eusebio et al., 2018).

Монголын үзэсгэлэнт байгаль, түүнд дасан зохицсон нүүдлийн амьдрал нь гадаадын жуулчин татах гол шалтгаан юм. Тиймээс тухайн аялал жуулчлалын голлох аймаг, сум, багт амьдарч буй иргэдийг судлах нь бид аялал жуулчлалын хөгжих эхлэл цэгт очиж байгаатай ижил. Бид аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ олон улсын жишигт нийцсэн гэдэг нэрийдлээр гадаад жуулчдад таалагдах талаас өмнөх үеийн түүх, ёс заншлыг эвдэх нь цөөнгүй.

Аялал жуулчлалд хандах хандлага, хүлээн авагч жуулчдын харилцан үйлчлэл нь тэдний аялал жуулчлалыг дэмжих зан төлөвт эергээр нөлөөлдөг болохыг дээрх судалгаануудын үр дүн харуулж байна.

Энэхүү судалгааг хийснээр бид өөрөө өөрсдийгөө ойлгох, аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэхэд бид бэлэн байгаа эсэх холбоо хамаарлыг дэлгэрэнгүй харах боломжтой.

Судалгааны зорилго, зорилтууд

Энэхүү судалгааны гол зорилго нь гадаадын жуулчин хүлээж авч буй монголын ард иргэдийн жуулчинд хандах хандлагыг олон улсын загвар ашиглан судлан, Монгол Улсад оршин суугаа иргэдийн гадаадын жуулчинд хандах хандлагыг дүгнэхэд оршино. Үүнд:

- Жуулчинд хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйлс, түүний үр дагаврыг судлах,
- Оршин суугч иргэдийн аялал жуулчлал, гадаадын жуулчинд хандах хандлагын талаарх судлагдсан байдлын судалгааг хийх,
- Монголчуудын аялал жуулчлал, гадаадын жуулчинд хандах хандлагыг хүчин зүйл бүрээр нь хуваан хамаарлыг тодорхойлох,
- Судалгааны үр дүнд шинжилгээ хийж, санал зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Онолын үндэслэл, дэвшүүлсэн таамаглал

Хүлээн авагч орон нутгийн оршин суугчдын аялал жуулчлалд хандах хандлага, зан байдал нь аялал жуулчлалын салбарын амжилтад чухал нөлөө үзүүлдэг. Эерэг хандлага, зан үйл нь зочдыг хүлээн авч, дэмжих таатай орчин бүрдүүлдэг бол сөрөг хандлага, зан үйл нь жуулчдын урмыг хугалж, очих газрын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг.

Оршин суугчдын аялал жуулчлалын талаар үзүүлж болох нийтлэг хандлага, зан үйлийн дунд:

Дэмжих хандлага /Supportive Attitudes/: Дэмжих хандлагатай оршин суугчид аялал жуулчлалыг илүүтэй хүлээн авч, орон нутагтаа эерэг хүч гэж үздэг. Тэд аялал жуулчлалтай

холбоотой бизнест хөрөнгө оруулалт хийх, зочдод туслах сайн дурын ажил хийх, орон нутгаа аялал жуулчлалын газар болгон сурталчлахад бэлэн байж болно.

Хоёрдмол хандлага / Ambivalent Attitudes/: Зарим оршин суугчид аялал жуулчлалын талаар хоёрдмол хандлагатай байж болох бөгөөд энэ нь тэд үүнийг эрс дэмждэггүй, эрс эсэргүүцдэггүй гэсэн үг юм. Тэд энэ салбарт хайхрамжгүй ханддаг, эсвэл тэдний нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовж магадгүй юм.

Дайсагнасан хандлага /Hostile Attitudes/: Дайсагнасан хандлагатай оршин суугчид аялал жуулчлалыг нийгэмд заналхийлж байна гэж үзэж болно. Тэд аялал жуулчлалыг хөгжүүлэхийг эсэргүүцэж, зочдыг нутагтаа ирэхийг хориглохын тулд идэвхтэй ажиллаж магадгүй юм.

Зан үйлийн хувьд оршин суугчид өөрсдийн орон нутагтаа аялал жуулчлалын амжилтыг дэмжих, эсвэл сааруулах олон төрлийн үйлдлүүдийг үзүүлж болно.

Эерэг зан үйл / Positive Behaviors/: Оршин суугчид үйлчлүүлэгчдэд маш сайн үйлчилгээ үзүүлэх, зочдод заавар, зөвлөмж өгөх, хамт олноо цэвэр, сэтгэл татам байлгах, зочдод хүндэтгэлтэй хандах зэрэг эерэг зан үйлийг гаргаж чадна.

Сөрөг зан үйл/ Negative Behaviors/: Оршин суугчдын сөрөг зан үйлд хог хаях, зочдод бүдүүлэг, дайсагналцах, гэмт хэрэг үйлдэх, аялал жуулчлалын салбарыг дэмжихгүй байх зэрэг орно.

Оршин суугчдын аялал жуулчлалд хандах хандлага, зан төлөвт эдийн засгийн үр ашиг, соёлын ялгаа, байгаль орчны асуудал зэрэг олон хүчин зүйл нөлөөлж болохыг анхаарах нь чухал юм. Аялал жуулчлалын үр дүнтэй менежмент, олон нийтийн оролцоо нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тусалж, оршин суугчид энэ салбарын амжилтад хөрөнгө оруулалт хийх болно. Оршин суугчид АЖ-ын идэвхтэй газар нутгууддаа илүү мэдрэг ханддаг.

J Travel Res эрдэмтний хийсэн судалгаанд Грекийн Kavala бүсийн 481 оршин суугч дээр хийсэн судалгааны үр дүнд одоо ашиглаж буй хэмжилтийн аргууд нь очиж буй газартаа илүү төвлөрсөн бөгөөд тухайн бүс нутгийн иргэдтэй холбоотой хүчин зүйлсийг бага судалсныг нотолж харуулсан байна. Энэхүү судалгаа нь бодит харагдах байдал, нийтийн үйлчилгээ, нийгмийн орчин, зугаа цэнгэлийн төрлүүд гэсэн 4 чиглэлийн хувьд тухайн газар орон нутгийн дүр төрхийн судалгааг сайжруулах зөвлөмжүүдийг санал болгосон байв⁵⁷

Celeste Eusébio, Armando Luís Vieira & Sara Lima нарын хийсэн судалгаанд оршин суугчдын хандлагад хүн болон орчны холбоо, аялагч болон хүлээн авагчийн харилцаа болон аялал жуулчлалд хандах хандлага эерэг нөлөө үзүүлдэг ба тодорхой сөрөг нөлөө нь аялал жуулчлалд хандах хандлагатай холбоотой байгааг мөн гаргасан байв.⁵⁸

Ma Mar García de los Salmones Sánchez and Ángel Herrero нарын хийсэн судалгаанд харах өнцөг – хандлага – зан төлөв гэсэн дарааллыг судалсан бөгөөд аялал жуулчлалын тухайн орон нутагт үзүүлэх нөлөөлөл нь жуулчдад хандах хандлагад нөлөөлдөг болохыг

⁵⁷ An Exploratory Study of Residents' Perception of Place Image 2014

<https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC5897881/>

⁵⁸ Place attachment, host–tourist interactions, and residents' attitudes towards tourism development: the case of Boa Vista Island in Cape Verde 2016

тайлбарласан байна. Судалгааны үр дүнд оршин суугчдын эдийн засаг болон соёлын эерэг нөлөөллийн ажиглалт нь аялал жуулчлал болон аялагчдад хандах хандлагад нөлөөлөх гол хувьсагч болохыг харуулав. Мөн уг судалгаанд “behavioural support” гэх шинэ төрлийн нөлөөлөх хувьсагчийг танилцуулсан байна.⁵⁹

Salvatore Vimonte, Lionello F. Punzo нарын хийсэн судалгаанд оршин суугчдын харах өнцгийг судалсан бөгөөд аялагч болон хүлээн авагчийн хоорондын харилцаа болон туршлага нь тэдгээрийн хандлага болон бодолд нь нөлөөлдөг. Энэ нь оршин суугчдын аялал жуулчлал болон аялагчийг харах өнцөгт бүтцийн хувьд нөлөө үзүүлдэг.⁶⁰

Судалгааны загвар, арга зүй, боловсруулалт

Оршин суугчдын нутгийн харагдах байдал / Residents' Place Image /

PI-ийг үнэлэхийн тулд гадаад төрх (physical appearance PHA), олон нийтийн үйлчилгээ (community services CS), нийгмийн орчин (social environment SE) болон зугаа цэнгэлийн үйлчилгээ (entertainment services ES) гэсэн дөрвөн хэмжүүр бүхий хэмжилтийг баталсан⁶¹ байна.

CS-ийн нэг зүйл хүчин зүйлийн ачаалал багатай тул устгасан болно.

- Зочин, хүлээн авагч хоёр талын харилцаа / Host–Tourist Interaction /⁶² Зочин, хүлээн авагч хоёр талын харилцаа НТИ-г үнэлэх гурван зүйлээр үнэлэв.
- Оршин суугчдын аялал жуулчлал, жуулчдад хандах хандлага / Residents' Attitudes to Tourism and Tourists /⁶³ АТТТ-ийг 4 үнэлэх, АТТ-ийг үнэлэхийн тулд дөрвөн зүйлээр үнэлэв.
- Монголын уламжлалт байдал / Mongolian Traditionality /

Монголын уламжлалт байдалыг Ван, Жан (2020) тохируулсан таван зүйлээр үнэлэв.

- Оршин суугчдын аялал жуулчлалыг дэмжих зан үйл / Residents' Pro-tourism Behaviours /

Оролцогчид болон зан үйлийн ижил төстэй байдлыг харгалзан Рибейрогийн онол/2017/ дөрвөн зүйлийн тодорхойлолтоор РВИ-ийг үнэлэхэд ашиглав.

⁵⁹ Residents' attitudes and behavioural support for tourism in host communities 2017


⁶⁰ Tourist development and host–guest interaction: An economic exchange theory 2016

⁶¹ (Stylidis et al., 2014, 2016; Stylidis, 2016).

⁶² Eusébio et al. (2018)

⁶³ Palmer et al. (2013) and Martín et al. (2018)

Зураг 1. PI болон PA хамаарлыг PLS-SEM ашиглан SmartPLS version 3.2.8 судалсан судалгаа



Судалгааны таамаглал:

H1: Монголчуудын аялал жуулчлалд хандах хандлага тэдний аялал жуулчлалыг дэмжих зан төлөвт эергээр нөлөөлдөг.

H2: Монголчуудын аялагчид хандах хандлага нь тэдний аялал жуулчлалыг дэмжих зан төлөв-д эергээр нөлөөлдөг.

H3: Монголчуудын аялагчид хандах хандлага нь тэдний аялал жуулчлалд хандах хандлага-д эергээр нөлөөлдөг.

H3а: Монголчуудын аялал жуулчлалд хандах хандлага нь тэдний аялагчид хандах хандлага болон аялал жуулчлалыг дэмжих зан төлөв хоорондын харилцааг эергээр зуучилдаг.

H4: Монголчуудын зочин хүлээн авагчийн харилцаа тэдний аялал жуулчлалд хандах хандлага-д эергээр нөлөөлдөг.

H5: Бүс нутгийн оршин суугчид, зочин хүлээн авагч хоорондын харилцаа нь тэдний аялагчид хандах хандлага-д эергээр нөлөөлдөг.

H6: Монголчууд болон тур оператор харилцаа нь тэдний аялал жуулчлалыг дэмжих зан төлөв-д эергээр нөлөөлдөг.

H6а: Монголчуудын аялал жуулчлалд хандах хандлага нь тэдний зочин хүлээн авагчийн харилцаа болон аялал жуулчлалыг дэмжих зан төлөв хоорондын харилцаанд эергээр нөлөөлдөг.

H7: Монголчуудын нутгийн харагдах байдал нь тэдний аялагчид хандах хандлага-д эергээр нөлөөлдөг.

H8: Монгол нутгийн харагдах байдал нь иргэдийн аялал жуулчлалд хандах хандлага-д эергээр нөлөөлдөг.

H9: Монголчуудын нутгийн харагдах байдал нь иргэдийн аялал жуулчлалыг дэмжих зан төлөв-д эергээр нөлөөлдөг.

Н9а: Монголчуудын аялал жуулчлалд хандах хандлага нь иргэдийн нутгийн харагдах байдал болон аялал жуулчлалыг дэмжих зан төлөв хоорондын харилцааг эергээр зуучилдаг.

Н10: Монголчуудын ёс заншил нь иргэдийн аялал жуулчлалд хандах хандлага болон аялал жуулчлалыг дэмжих зан төлөв хоорондын харилцааг зохицуулдаг.

Н11: Монголчуудын ёс заншил нь иргэдийн аялагчид хандах хандлага болон аялал жуулчлалыг дэмжих зан төлөв хоорондын харилцааг зохицуулдаг.

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн болон найдвартай байдлын шинжилгээ

Монголчуудын гадаадын жуулчинд хандах хандлага тодорхойлох дээрх бүлэг асуулгууд нь хувьсагчуудаа төлөөлөх чадвар болон найдвартай байдал зэргийг шалгаж үзэхэд КМО шалгуурын үр дүн 0,786 байгаа нь түүврийн тоо хангалттай хүрэлцээтэй статистик ач холбогдолтой гарсан нь хүчин зүйлийн шинжилгээ үр дүнтэй болохыг илэрхийлж байна. Асуултын найдвартай байдлыг илэрхийлэх

- Аялал жуулчдад хандах хандлага нь 4 хувьсагчаас АТТ2 хувьсагч хасагдаж 3 хувьсагчаар
- Жуулчинд хандах хандлага нь 3 хувьсагчаас АТТТ1 хувьсагч хасагдаж 2 хувьсагчаар
- Зочин хүлээн авагч хоёрын харилцааны хандлага нь 3 хувьсагчаас үр дүнтэй 3 хувьсагчаар
- Нийтийн үйлчилгээний хандлага нь 3 хувьсагчаас үр дүнтэй 3 хувьсагчаар
- Нийтийн орчны хандлага нь 3 хувьсагчаас үр дүнтэй 3 хувьсагчаар
- Хүрээлэн буй биет орны хандлага нь 4 хувьсагчаас РНА1,РНА4 хувьсагчийг хасаж 2 хувьсагчаар
- Жуулчдад хандах зан төлөвийг 4 хувьсагчаас РИ1,РИ2 хувьсагчийг хасаж 2 хувьсагчаар
- Монгол ёс заншилд хандах хандлагыг 3 хувьсагчаас МТ2 хувьсагч хасагдаж 2 хувьсагчаар

Кронбах альфа коэффициент 1-д их ойрхон буюу 0,7-с их гарсан тул судалгааны асуулга оновчтой гэж дүгнэн дараах 9 бүлэг 30 асуулгуудаар санал асуулга авч боловсруулалт хийн үндэслэлтэй бөгөөд найдвартай 23 асуулгыг хүчин зүйлийн шинжилгээ болон найдвартай байдлын шинжилгээнд хамрууллаа.

Хүснэгт 1 - Хүчин зүйлийн шинжилгээ болон найдвартай байдлын шинжилгээ

Асуулгын утга	Бүрдэл хэсгүүд								
	НТИ	CS	ES	АТТ	АТТТ	РНА	PI	MT	SE
АТТ1 - Аялал жуулчлал Монгол Улсад эерэг нөлөө үзүүлдэг гэж боддог.				.792					
АТТ3 - Монгол улсад аялал жуулчлалын салбар томоохон үүрэг гүйцэтгэх боломжтой.				.789					
АТТ4 - Аялал жуулчлалыг Монгол Улсад идэвхтэй хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.				.717					

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

АТТТ2 - Зочилж ирсэн гадаадын жуулчдад Монгол Улс таалагдаж, таатай байдаг.						.594			
АТТТ3 - Миний амьдарч буй газар зочилж ирсэн гадаадын жуулчинтай харилцахаас төвөгшөөдөггүй						.732			
НТ11 - Бид Монголд ирсэн гадаад жуулчидтай найрсаг харилцаа тогтоож чаддаг	.778								
НТ12 - Бидний гадаад жуулчидтай харилцах харилцаа эерэг байдаг.	.766								
НТ13 - Бид гадаад жуулчидтай харилцах дуртай.	.766								
CS1 - Манай улсад нийтэд үйлчлэх үйлчилгээ сайн хөгжсөн.		.758							
CS2 - Манай улсын засгийн газрын бодлого, хэрэгжүүлж буй аялал жуулчлалын хөтөлбөрүүд гада		.862							
CS3 - Манай улсын нийтийн тээвэр сайн хөгжсөн.		.730							
ES1 - Гадаадын жуулчинд үйлчилдэг ресторан, зоогийн газруудын үйлчилгээ сайн.			.794						
ES2 - Гадаадын жуулчинд үйлчлэх үзвэр, үйлчилгээ, цэнгээний газар сайн хөгжсөн			.710						
ES3 - Миний оршин суугаа газар гадаад жуулчдад санал болгох дэлгүүр олон байдаг.			.760						
SE1 - Миний оршин суугаа газар гадаад жуулчин хүлээн авахад эрүүл, аюулгүй, тайван газар.									.780
SE2 - Манай улсын хотууд, аймгийн төв, сумдуудын амьдрах орчин их цэвэрхэн.									.607
SE3 - Монголчууд их нөхөрсөг ард түмэн.									.787
РНА2 - Манай улс их үзэсгэлэнтэй байгальтай						.831			
РНА3 - Монгол улсад гадаадын жуулчинд санал болгох сонирхолтой түүхэн дурсгалт газрууд олон						.835			
PI3 - Хэрвээ би гадаадын жуулчинтай таарвал мэдээлэл өгч, туслахдаа татгалзахгүй.							.734		
PI4 - Монгол улсын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд							.819		

шаардлагатай тохиолдолд өөрийн хувь нэмрээ									
MT1 - Монголчууд гадаад жуулчдыг найрсгаар хүлээн авдаг.								.555	
MT3 - Монголчууд өөрсдийн зан заншлын хэм хэмжээгээ жуулчдад таниулахыг хүсдэг.								.853	

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд аялал жуулчлалын салбарт идэвхтэй оролцох боломжтой 18 нас хүрсэн нийт 460 иргэнийг хамруулсан. Нийт судалгаанд хамрагсдын

- Оршин суугаа газраар нь 79.1% нь Улаанбаатар хотод, 20.9% нь орон нутагт амьдардаг байна.
- Оршин суугаа харьяаллын бүсчлэн авч үзвэл төвийн бүсийн 84%, баруун бүсийн 13%, хангайн бүсийн 3% иргэд
- Боловсролын зэргээр нь авч үзвэл: Ахисан түвшний боловсролтой 21%, дээд боловсролтой 49%, бүрэн дунд боловсролтой 28%, дунд боловсролтой 2% тус тус хамрагдав.


Хүснэгт 3 - Хамаарлын шинжилгээ

		ATT	ATTT	HTI	CS	ES	SE	PHА	PTB	MT
ATT	Pearson Correlation	1	.263**	.317**	-.146**	.054	.130**	.352**	.472**	.246**
	Sig. (2-tailed)		.000	.000	.002	.244	.005	.000	.000	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
ATTT	Pearson Correlation	.263**	1	.589**	.233**	.330**	.330**	.463**	.149**	.393**
	Sig. (2-tailed)	.000		.000	.000	.000	.000	.000	.001	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
HTI	Pearson Correlation	.317**	.589**	1	.438**	.421**	.452**	.231**	.224**	.531**
	Sig. (2-tailed)	.000	.000		.000	.000	.000	.000	.000	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
CS	Pearson Correlation	-.146**	.233**	.438**	1	.612**	.574**	-.015	-.184**	.246**
	Sig. (2-tailed)	.002	.000	.000		.000	.000	.745	.000	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
ES	Pearson Correlation	.054	.330**	.421**	.612**	1	.626**	.102*	-.017	.353**
	Sig. (2-tailed)	.244	.000	.000	.000		.000	.029	.717	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
SE	Pearson Correlation	.130**	.330**	.452**	.574**	.626**	1	.311**	-.053	.486**

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

	Sig. (2-tailed)	.005	.000	.000	.000	.000	.000	.000	.252	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
PHА	Pearson Correlation	.352**	.463**	.231**	-.015	.102*	.311**	1	.227**	.381**
	Sig. (2-tailed)	.000	.000	.000	.745	.029	.000		.000	.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
РТВ	Pearson Correlation	.472**	.149**	.224**	-.184**	-.017	-.053	.227**	1	.310**
	Sig. (2-tailed)	.000	.001	.000	.000	.717	.252	.000		.000
	N	460	460	460	460	460	460	460	460	460
MT	Pearson Correlation	.246**	.393**	.531**	.246**	.353**	.486**	.381**	.310**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	.000	.000	.000	.000	.000	.000	
	N	460	460	460	460	460	460	460	460	460
**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).										
*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).										

Дээрх хамаарлын шинжилгээний үр дүнд доорх загвар батлагдав.



Дүгнэлт

Тогтвортой Оршин суугчдын жуулчдад хандах хандлагад нөлөөлөх 11 хүчин зүйлийг авч үзэн таамаглал дэвшүүлэв. Уг хандлагыг хэмжихдээ Оршин суугчдын газрын дүр төрх, Зочин, хүлээн авагч хоёр талын харилцаа, Оршин суугчдын аялал жуулчлал, жуулчдад хандах хандлага, Монголын уламжлалт байдал, Оршин суугчдын аялал жуулчлалыг дэмжих зан үйл гэсэн үндсэн 5 үндсэн бүлэгт хуваан хамаарлын шинжлэв. PLS – SEM (Partial Least Square – Structural Equation Model), Хамаарлын шинжилгээний үр дүнд дэвшүүлсэн таамаглалуудыг шалгаж үзсэн болно.

Дээрх шинжилгээг хийхэд Монгол Улсын иргэдийн гадаад иргэдэд хандах хандлага нь аялагчид хандах хандлагад шууд хамгийн өндөр эерэг хамааралтай бөгөөд монгол хүн, тэр дундаа Улаанбаатар хотын иргэд монгол улсыг зорин ирж буй гадаадын жуулчдыг хүлээн авахдаа төвөгшөөдөггүй, найрсаг дотноор хүлээн авах хандлагатай. Энэ нь гадаадын жуулчдыг дахин айлчлахад эерэг нөлөө үзүүлдэг байна.

Монголчуудын аялагчид хандах хандлага, монголчууд болон тур оператордын гадаад жуулчин хүлээн авах хандлага нь АЖ-ыг дэмжих зан төлөвт эерэг ач холбогдолтой боловч тийм ч өндөр хамаарал үзүүлдэггүй.

Харин монголын газар нутгийн байгаль, цаг уур, нөөц боломжийг үнэлэх монголчуудын үнэлэмж нь аялагчид хандах хандлагад өндөр хамааралтай. Мөн иргэдийн аялал жуулчлалын салбарт хандах хандлагад ч өндөр эерэг нөлөө үзүүлдэг байна.

Монголчуудын аялагчид хандах хандлага, монголчууд болон тур операторын гадаад жуулчин хүлээн авах хандлага, Монголын газар нутгийн байгаль, цаг уур, нөөц боломжийг үнэлэх монголчуудын үнэлэмж нь аялагчид хандах хандлага нь үндэсний уламжлалт зан заншлын өвөөр баяжигдан аялал жуулчлалын салбарт хандах хандлагад эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд хамаарал өндөр байна. Үүнээс монголчуудын аялал жуулчлалын салбарыг дэмжих зан төлөвт эерэг хамааралтай гэдэг нь батлагдаж байгаа юм.

Монголчуудын онгон дагшин байгаль, эрс тэс уур амьсгал, нутгийн өвөрмөц тогтоц, түүх соёлын үнэт олдворыг үнэлэх монголчуудын үнэлэмж, түүнд хандах хандлага сул бөгөөд аялал жуулчлалын салбарыг, гадаад жуулчны эргэлтийг үүгээр дамжуулан сайжруулах тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хийгдэж буй зорилтууд нь уг судалгаанаас иргэдийн дэмжих зан төлөв сул гэдэг нь харагдаж байгаа юм.

Тиймээс хандлага харилцан хамаарлыг сайжруулж , түүх соёл, ёс уламжлал дээр тулгуурласан АЖ-ын бүтээгдэхүүн хөгжүүлэхээс илүүтгээгээр бид олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, зам тээвэр, үйлчилгээний соёлыг сайжруулах нь нэн тэргүүний шаардлага болно.

Санал зөвлөмж

Монголчуудын ёс заншил түүгээр дамжих нүүдлийн ёс заншил ахуйг харуулсан гадаадын жуулчдыг татах үзвэр үйлчилгээ нь төдийлөн аялагчид хандах хандлага, АЖ-ийн зан төлөвт өндөр хамаарал үзүүлж чадахгүй байгааг харгалзан үзэж дараах зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Нийтийн үзвэр үйлчилгээ, түүнд дагалдах тайлбар, санамж, зөвлөмжийг гадаад хэлээр хүргэх,
- Тухайн жилийн соёлын үзвэр үйлчилгээний батлагдсан хуваарийг олон улсад зарладаг, тухайн жилийн товлогдсон хугацаандаа зохион байгуулдаг байх,
- Нийтийн тээврийг сайжруулах,
- Гадаад жуулчинд үйлчлэх ресторан зоогийн газрын нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх,
- Гадаадын жуулчдад үйлчилгээ үзүүлэх хөтөч тайлбарлагчдыг мэргэжлийн түвшинд бэлтгэх, тэдэнд үндэсний ахуй соёлыг таниулан мэдүүлэх, системтэй боловсрол олгох эдгээр болно.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Ном, сурах бичиг

Монголын аялал жуулчлалын түүхийн товчоон Нэргүй.Ш. Дэлгэрсүрэн.Б, Доржнамжим.Д. УБ 2014 он

“Боловсролын удирдлага” Н.Наранчимэг, Э.Төгөлдөр 2010. 9-р тал

"Боловсролын үндэс" Ц.Содов Л.Жамц 2009 9-р тал

Coltman Micheal M, Introduction to travel and Tourism

Д.Гантомор "Аялал жуулчлалын үндэс" 2003. 87-р тал

Гадаад хэлээр

Host–Tourist Interaction Stylidis et al., 2014, 2016; Stylidis, 2016

Residents' Attitudes to Tourism and Tourists Palmer et al. (2013) and Martín et al. (2018).

Azjen I. (1980). *Understanding Attitudes and Predicting Social Behavior*. Englewood cliffs, NJ: Prentice-Hall.

Bimonte S., Punzo L. F. (2016). Tourist development and host–guest interaction: an economic exchange theory. *Ann. Tourism Res.* 58, 128–139. 10.1016/j.annals.2016.03.004

Binder J., Zagefka H., Brown R., Funke F., Kessler T., Mummendey A., et al.. (2009). Does contact reduce prejudice or does prejudice reduce contact? A longitudinal test of the contact hypothesis among majority and minority groups in three European countries. *J. Pers. Soc. Psychol.* 96:843. 10.1037/a0013470

Carmichael B. A. (2000). A matrix model for resident attitudes and behaviours in a rapidly changing tourist area. *Tourism Manage.* 21, 601–611. 10.1016/S0261-5177(00)00007-8

Carneiro M. J., Eusébio C., Caldeira A. (2018). The influence of social contact in residents' perceptions of the tourism impact on their quality of life: a structural equation model. *J. Qual. Assur. Hosp. Tour.* 19, 1–30. 10.1080/1528008X.2017.1314798

Woosnam K. M. (2011). Testing a model of Durkheim's theory of emotional solidarity among residents of a tourism community. *J. Travel Res.* 50, 546–558. 10.1177/0047287510379163

Zaman U., Aktan M. (2021). Examining residents' cultural intelligence, place image and foreign tourist attractiveness: a mediated-moderation model of support for tourism development in Cappadocia (Turkey). *J. Hosp. Tour. Manag.* 46, 393–404. 10.1016/j.jhtm.2021.01.017

Zhang J., Xu H.-g., Xing W. (2017). The host–guest interactions in ethnic tourism, Lijiang, China. *Curr. Issues Tour.* 20, 724–739.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

“СУУРЬ БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ АХИУЛАХАД МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИЙГ ОНОВЧТОЙ АШИГЛАХ НЬ” ТӨСЛИЙН ЗАРИМ ҮР ДҮН

Ж.Сүхбаатар¹, Шинобу Юмэ Ямагучи²

¹ Доктор, профессор /Санхүү, Эдийн Засгийн Их Сургуулийн Зөвлөх профессор/

² Доктор, профессор /НҮБ-ийн Их Сургуулийн Тогтвортой Хөгжлийн Судалгааны Хүрээлэнгийн Захирал/



Түлхүүр үг:

Суурь боловсрол, Мэдээлэл харилцааны технологи боловсролд, Багшийн хөгжил

Хураангуй

Японы Токиогийн Технологийн Дээд Сургууль нь Монгол Улсын Боловсролын Их Сургуультай хамтран “Суурь боловсролын чанарыг ахиулахад Мэдээлэл, харилцааны технологи-(МХТ)-ийг оновчтой ашиглах нь” гэж нэрлэгдсэн төслийг 2018-2022 онд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг – (ЯОУХАА)-ын санхүүжилтээр хэрэгжүүлсэн юм. Энэхүү төслийн зорилго нь суурь боловсролын багш нар МХТ-ийн тусламжтайгаар багшийн хөгжлийн цахим хэрэглэгдэхүүн орон нутагтаа боловсруулан үр дүнтэй ашиглах замаар хичээл заах ур чадвар, чадамжаа дээшлүүлэхэд чиглэгдсэн байна. Төсөл хэрэгжиж эхэлсэн эхний жил 2018 онд суурь судалгаа, төслийн сүүлийн жил 2022 онд үр дүнгийн судалгаа явуулсан байна. Судалгааны түүвэр нь сургуулийн удирдах ажилтан болон суурь боловсролын нийт багш нарын 10 гаруй хувийг хамарсан байна. Хоёр судалгааны үр дүнг харьцуулсан дүн шинжилгээ хийгдсэн бөгөөд энэхүү өгүүлэлд харьцуулсан судалгааны зарим гол үр дүнг багтаасан болно. МХТ-ийн нөөц нэмэгдсэн, суурь боловсролын багш нарын МХТ ашиглах ур чадвар, чадамж дээшилсэн, хосмог сургалтын арга, технологи дэлгэрч байгаа зэрэг олон эерэг сайн өөрчлөлт харьцуулсан дүн шинжилгээгээр тодорхой болсон бөгөөд эдгээрийг төслийн үр дүн гэж үзэх боломжтой юм.

УДИРТГАЛ

Японы Токиогийн Технологийн Дээд сургууль нь 2012-2017 онд Монголын бага боловсролын багш нарын мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлж сайн үр дүнд

хүрсэн туршлагадаа тулгуурлан МХТ ашиглан багш нарт зориулсан сургалтын материал боловсруулах замаар суурь боловсролын чанарыг ахиулах зорилготой төсөл боловсруулсан юм. Төслийн санхүүжилтийг ЯОУХАА гаргасан бөгөөд төслийг таван жилийн хугацаанд 2018-2022 онд хэрэгжүүлэхээр болсон байна.

Энэхүү төсөл нь суурь боловсролын багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн, чухал хэрэгцээтэй сургалтын материал боловсруулан сургалт явуулах замаар суурь боловсролын чанарыг ахиулах зорилготой.

Төслийн зорилгод бүлэг нь Монголын хөдөөгийн суурь боловсролын сургуулиуд юм. Төслийн үр дүнг шууд хүртэгч нь Монгол улсын Боловсролын Их сургууль (МУБИС) –ийн 25 профессор багш, аймаг, хотын Боловсрол, Шинжлэх Ухааны Газар – (БШУГ)-ын арга зүйчид 124, суурь боловсролын багш 2,320, нийт 2469 хүн болох бөгөөд шууд бусаар Монголын суурь боловсролын бүх багш нар үр ашиг хүртэхээр тооцсон байна.

Төслийн үйл ажиллагаа:

Чадавхи бэхжүүлэх: 1) Багш нарт зориулсан сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах мэргэжлийн баг бүрдүүлэх, чадавхижуулах; 2) Япон улсад судалгааны аялал зохиох 3) Сургалтын материал боловсруулах багуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх.

Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах сургалт: 1) Арга зүйч нарт зориулсан сургалтын агуулга боловсруулах; 2) Нийт 124 арга зүйчдэд 5 хоногийн сургалт явуулах; 3) Бэлтгэгдсэн сургагч багш нар аймаг, дүүрэгт сургалт явуулах.

Цахим хэрэглэгдэхүүн боловсруулах: 1) Багшид зориулсан сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах нийт 30 багц;

2) Боловсруулсан материалыг 4 аймаг болон нэг дүүрэгт турших, сайжруулах; 3) Эцэслэн боловсруулсан материалыг CD, BCD (VCDs/DVDs) хэлбэрээр олшруулах; 4) Багшийн гарын авлага боловсруулах, хэвлүүлэх; 5) Боловсруулсан материалыг түгээн хүргэх, сургалт явуулах.

Багшийн сургалт: 1) Шаталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, агуулга бэлтгэх; 2) Арга зүйчид, сургалтын менежер, захирал, багш нарт сургалт явуулах; 3) Сургууль дээрх сургалтанд хяналт тавих; 4) Боловсруулсан материалыг хүргэх цахим талбар бий болгох (аймаг, дүүргийн хэмжээнд); 5) “Багшийн Хөгжил” болон бусад вебсайтад боловсруулсан материал байршуулах.

Түшиц сургуулиудад сургалтын материал боловсруулах: 1. Түшиц сургууль сонгох; 2. Япон улсад судалгааны аялал зохиох; 3. Түшиц сургуульд дэмжлэг үзүүлэх; 4. Сургалтын материал түгээн дэлгэрүүлэх.

Эдгээр болон бусад бүх үйл ажиллагааг 2018 оны 4 сараас 2022 оны 12 сар хүртэл таван жилийн хугацаанд хэрэгжүүлсэн байна. Суурь судалгааг 2018 оны 9-11 сард явуулж төсөл хэрэгжихийн өмнөх нөхуөл байдлыг тодорхойлсон болно. Үр дүнгийн судалгааг 2022 оны 10-12 сард явуулж төсөл хэрэгжиж дуусах үеийн мэдээлэл цуглуулсан болно.

Үр дүнгийн судалгааны зорилтууд:

- i) Үр ашиг хүртэгчдэд төсөл ямар нөлөө үзүүлсэнийг тоо болон чанарын судалгааны аргаар тодорхойлох

- ii) Багшийн хөгжилд гарсан өөрчлөлтийг суурь болон үр дүнгийн судалгааны харьцуулалтаар тодорхойлох,
- iii) Төслийн үр дүнг тооцох матрицийн тоон үзүүлэлтүүд цуглуулж тавьсан зорилтуудын биелэлтэнд үнэлгээ өгөх,
- iv) Төсөл хэрэгжсэн аймгуудад мониторинг үнэлгээ хийх, чанарын баримт цуглуулах, японы төслүүд хэрэгжсэн нийт 10 жилийн үр дүнгийн үнэлгээ хийх зэрэг даалгавар өгөдсөн байна.

СУДАЛГААНЫ АСУУДАЛ

Сүүлийн жилүүдэд Монголын боловсролын чанар, хүртээмж доголдож, ялангуяа хөдөөгийн хүн ам, нийгмийн эмзэг бүлгийнхний боловсрол эзэмших боломжийг ихээхэн нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байгааг харуулах тоо баримт, судалгаа тайлан олон тоогоор байна. Боловсролын чанарын судалгаагаар суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд суралцагчид танин мэдэхүйн энгийн түвшний даалгаврыг гүйцэтгэж дадсан боловч дээд түвшний буюу шаардлагатай мэдээлэл олж авах, боловсруулах, үр дүнг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэглэх, өгсөн загвар ашиглан зохиомж бичих зэрэг чадвар сул, хэл зүйн дүрэм, үгийн сангийн мэдлэг, эхийн бүтцийг тодорхойлох чадвар сул байсан. Багшийн мэргэжлийн бэлтгэл, мэргэжил дээшлүүлэх сургалт Засгийн газрын дэмжлэгтэйгээр системтэй зохион байгуулагдаж байгаа хэдий ч үр дүн, чанар сул байгааг судалгаа харуулжээ (АХБ, БШУЯ 2019). Монгол улсын Засгийн газрын 2006 оны 192-р тогтоолоор батлагдсан “Монголын боловсролыг 2005-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-нд бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх, бага боловсролыг мэргэжлийн багшаар 100% хангах зэрэг олон тооны арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан байна (Монгол улсын Засгийн газар, 2007). Багшийн хөгжлийг дэмжих тухай тусгайлсан хуулийг Монгол улсын Их хурлаас батлан гаргасан нь (УИХ, 2018) багшийн хөгжлийн асуудал Монгол улсад хэр их ач холбогдолтой, чухал болохыг харуулах нэгэн баримт юм. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030” хэмээн нэрлэгдсэн шинэ мастер төлөвлөгөөнд “Бага, дунд боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах” зорилт тавьж 2030 он гэхэд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, хот, хөдөөгийн сурагчдын үнэлгээний гүйцэтгэлийн ялгаа багассан байна гэж төлөвлөсөн байна (МУЗГ 2020).

Японы улсын санхүүжилтээр 2004-2006 онд хэрэгжүүлсэн “Зуд” төсөл, 2010-2011 онд хэрэгжүүлсэн “МХТ ашиглан багшийн мэргэжил дээшлүүлэх материал боловсруулах нь” төслийн явцад багш нарын мэргэжлийг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага Монголд ихээхэн байгаа Японы талд тодорхой болсон байна. Нөгөө талаас эдгээр төслийн явцад багшийн мэргэжил боловсролыг дээшлүүлэхэд МХТ-ыг ашиглах нь ихээхэн үр дүнтэй болох нь батлагдсан байна (TokyoTech and MSUE, 2012).

МХТ-ийг боловсролд нэвтрүүлэхэд хоёр үндсэн хандлага ажиглагдаж байна. МХТ-ийг сургалтанд нэвтрүүлэн сургалтыг илүү сонирхолтой, сурагч төвтэй, илүү чанар, өгөөжтэй явуулах нь чухал болохыг аль хэдийн нийтээр хүлээн зөвшөөрчээ. Харин МХТ-ийг ашиглан багшид ажлын байран дээрээ хөгжих нөөц, боломжийг бий болгох нь олон улсад төдийлөн дэлгэрээгүй хэдий ч Монголын нөхцөлд илүү нийцэх чиг хандлага юм. ЯОУХАА-

ийн санхүүжилтээр 2000-аад оноос хойш Монголын ерөнхий боловсролд хэрэгжүүлсэн төслүүд үндсэндээ энэхүү чиг хандлагыг баримталсан байна.

ОНОЛЫН КОНЦЕПЦ

МХТ-ийг хүлээн зөвшөөрөх, хэрэглэхэд бэлэн байх ашиглах талаар хийж буй олон судалгаанд хэрэглэгддэг онолын гол концепц бол ТАМ (Technology Acceptance Model) гэж нэрлэгдсэн Технологи хүлээн авах (ТХА) загвар юм.

Энэ концепцийн дагуу аливаа технологийн хэрэглэхэд хялбар байдал, хэрэглэх нь ашигтай байх нь тухайн технологийг хүлээн зөвшөөрөх, цаашдаа ашиглахад хүргэнэ гэж үздэг (Davis, 1989). Ерөнхий боловсролын багш нарын хувьд МХТ-ийг судлан ашиглах нь юуны өмнө тэдэнд өөрсдийн мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, улмаар заах хичээл, сургалтаа илүү чанартай сайн явуулна гэсэн үзэл баримтлал дээр энэхүү төслийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Төслийн үр дүнг тодорхойлохын тулд суурь болон үр дүнгийн гэсэн хоёр судалгааг хооронд нь таван жилийн зайтай явуулж гарсан үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулах замаар багшийн хөгжилд гарсан ахиц өөрчлөлтийг тодорхойлохоор судалгааны дизайныг боловсруулсан болно. Суурь болон үр дүнгийн судалгааг явуулахдаа тоон болон чанарын судалгааг хослуулан хэрэглэсэн болно. Тоон судалгаанд асуулгын арга, чанарын судалгаанд ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, ажиглалт зэрэг арга хэрэглэсэн болно. Хүснэгт 1-д төслийн аймаг, дүүргийн нийт сургуулийн удирдлага, багш нар болон судалгаанд хамрагдсан удирдлага, багш нарын тоог харуулав.

Хүснэгт 1: Төслийн аймаг, дүүргийн нийт сургуулийн удирдлага, багш нар болон судалгаанд хамрагдсан удирдлага, багш нарын тоо

№	Аймаг	Сургуулийн удирдлагын тоо	Судалгаанд хамрагдсан тоо	Хамрагдалтын %	Суурь боловсролын нийт багшийн тоо	Судалгаанд хамрагдсан багшийн тоо	Хамрагдалтын %
1	Баянхонгор	60	42	70	435	392	90.1
2	Ховд	60	38	63.3	473	326	68.9
3	Сэлэнгэ	80	66	82.5	750	660	88.0
4	Хэнтий	50	53	106	521	303	58.1
5	Сонгинохайрхан дүүрэг УБ хот	80	37	46.2	825	735	89.1
	Нийт	300	236*	78.7	3004	2425**	80.7

*Тэмдэглэл: Цэвэрлэгээний дараа ашиглаж болох судалгааны тоо 231 болсон.

**Тэмдэглэл: Цэвэрлэгээний дараа ашиглаж болох судалгааны тоо 2255 болсон.

Хүснэгт 2. Зорилтот олонлог болон судалгааны хамарсан байдал

	Хүн ам	Суурь судалгаа	Үр дүнгийн судалгаа	Хамарсан %
Сургуулийн удирдлага	2,493	239	236	9.5
Суурь боловсролын багш	15,399	2,023	2,425	14.6

Хүснэгт 2-оос харахад судалгаанд Монгол улсын нийт ерөнхий боловсролын сургуулийн удирдлага- (захирал болон сургалтын менежер)-ын 9.5%, суурь боловсролын багш нарын 14.6%-ийг хамруулсан байна.

Судалгаанд хоёр янзын асуулга боловсруулж ашигласан. Багшийн асуулгад ерөнхий мэдээлэл, МХТ-ийн төсөл, сургуулийн МХТ дэд бүтэц гэсэн 3 хэсэгтэй 50 асуулт 143 дэд асуулт орсон бол сургуулийн захирал, сургалтын менежерийн асуулгад мөн 3 хэсэг 38 асуулт 115 дэд асуулт орсон болно. Асуулгын 3 дахь хэсгийг Норвеги улсын ерөнхий боловсролын сургуульд 2 жил тутам нэг удаа явуулдаг МХТ-ийн асуулгаас түүвэрлэж авсан бөгөөд асуулгыг туршилтын үндсэн дээр эцэслэн боловсруулсан. Мөн эдгээр асуулгыг 2012 болон 2017 онд явуулсан бага боловсролын багшийг хөгжүүлэх төслийн судалгаанд тохируулан хэрэглэсэн юм. 2017 оны суурь судалгааг мөн ийм асуулгаар явуулсан. Үр дүнгийн судалгаанд төслийн үр дүнтэй холбоотой зарим асуулт нэмж оруулсанаас бусдаар суурь судалгаатай адилхан асуулга байсан юм.

СУДАЛГААГААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ҮР ДҮН:

1) МХТ-ийн нөөц ба багш нарын хэрэглээ

Үр дүн 1.1: Багш нар сургалтандаа компьютер ашиглах, бусад багш нартай харилцахдаа компьютер ашиглах явдал нэмэгдсэн байна.

Багш нарын компьютер ашиглалтын тухай асуултын дундаж оноо хичээл заахад компьютер ашиглах нь 9.16%-иар, хичээл бэлтгэх эсвэл захиргааны үйл ажиллагаанд компьютер ашиглах нь 2.73%-иар, бусад багш нартай харилцахад компьютер ашиглах нь 10.43%-иар, багш нарын компьютерын хэрэглээ 37 хувиас 43 хувь болж тус тус нэмэгдсэн байна. Үүнийг хүснэгт 3-аас харж болно.

Хүснэгт 3. Багш нар сургалтандаа компьютер ашиглах, хичээл бэлтгэх эсвэл захиргааны үйл ажиллагаанд компьютер ашигладаг хугацаа /долоо хоногт/

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Та хичээл заахад долоо хоногт хэдэн цаг компьютер ашигладаг вэ?	4.74	5.47	0.73	9.16%
Та хичээл бэлтгэх, удирдах ажил зохион байгуулахад долоо хоногт хэдэн цаг компьютер ашигладаг вэ?	5.65	5.87	0.22	2.73%
Та бусад багш нартай харилцахад компьютерийг хэр их ашигладаг вэ?	3.84	4.24	0.40	10.43%

Үр дүн 1.2 Багш нарын МХТ-ийн сургалтад зарцуулах санхүүжилт эрс нэмэгдсэн байна.

Энэ нь сургалтын бүх шатлалын тухай сургуулийн удирдлагын өгсөн хариулт өссөн, цар тахлын үед бүх хичээлийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах шаардлагатай болсон, төслийн хүрээнд багш нарт зориулсан МХТ-ийн сургалтыг нэмэгдүүлсэн зэргээс үүдэлтэй байна.

Хүснэгт 4. Багш нарын МХТ-ийн сургалтад зориулсан санхүүжилт

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Багш нарын МХТ-ийн үндсэн чадварыг (оффисын программ, интернет, цахим шуудан, цахим сургалтын платформ ашиглах гэх мэт) сайжруулах сургалт	2.24	2.69	0.45	20.1%
МХТ-ийг төрөл бүрийн сургалтын арга зүйд нэвтрүүлэх сургалт	2.26	2.67	0.40	17.8%
МХТ-ийг төрөл бүрийн судлагдахуунд нэвтрүүлэх сургалт	2.22	2.59	0.38	16.9%

Үр дүн 1.3: Багш нар МХТ-ийн төрөл бүрийн хэрэгсэл ашиглах санхүүжилт нэмэгдэж байгааг сургуулийн удирдлагууд хүлээн зөвшөөрч байна

Сургуулийн удирдлагууд эдгээр зардлыг багш нарын хэрэглээнд зориулсан санхүүжилт хэмээн үздэг бөгөөд багш нарын дунд Facebook болон бусад цахим сүлжээ, цахим шуудан /имэйл/-г ажлын хэрэгцээнд ашиглах, ажлын хэрэгцээнд төрөл бүрийн интернэт чат хэрэглэх зэрэг нь эрс нэмэгдсэн байна. Үүнийг хүснэгт 5-аас харж болно.

Хүснэгт 5. Багш нар МХТ-ийн хэрэгслийг ашиглахад хуваарилсан санхүүжилт

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Ажлын хэрэгцээнд (yahoo messenger, Skype, Viber, WhatsApp, Facetime facebook messenger зэрэг) чат ашиглах	2.79	3.05	0.26	9.35%
Цахим шуудан /имэйл/-г ажлын хэрэгцээнд ашиглах	2.94	3.16	0.22	7.51%
Facebook болон бусад цахим сүлжээг ажлын хэрэгцээнд ашиглах	2.94	3.25	0.31	10.47%
Сургуулийн цахим хуудас, сургалтын порталыг ажлын хэрэгцээнд ашиглах	2.71	2.86	0.15	5.41%

Үр дүн 1.4: Сургууль түшиглэсэн сургалт, Боловсрол шинжлэх ухааны газарт зохион байгуулсан орон нутгийн түвшний сургалт, бусад багш нартай туршлага хуваалцах зэрэг сургалтын олон төрлийн үйл ажиллагаа багш нарын МХТ-ийн мэдлэг чадварыг хөгжүүлэхэд нөлөөлсөн.

Орон нутгийн сургалтын ач холбогдлын талаарх багш нарын ойлголт сайжирсан, БШУГ-ын сургалт 4.35%-иар өссөн, сургуульд суурилсан сургалт 7.33%-иар өссөн, хамт олон/ бусад багш нараас суралцах явдал 3.66%-иар өссөн байгааг хүснэгт 6 харуулж байна.

Хүснэгт 6. Сургалтын үйл ажиллагаанууд багш нарын МХТ-ийн мэдлэгт үзүүлсэн нөлөө

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
УБ дахь сургалт	2.61	2.53	-0.09	-3.36%
Боловсрол Шинжлэх ухааны газрууд дахь сургалт	2.52	2.63	0.11	4.35%
Сургуульд суурилсан сургалт	2.68	2.88	0.20	7.33%
Хамт олон/ бусад багш нар	2.81	2.91	0.10	3.66%
Бие даан суралцах	3.18	3.09	-0.09	-2.89%

2) Багш нарын МХТ-ийн ур чадвар, сургалтын талаар

Үр дүн 2.1: Сургуулийн удирдлагууд багш нар мэргэжлээ дээшлүүлэх, цахим агуулгыг хөгжүүлэх ур чадвартай болсныг хүлээн зөвшөөрч байна

Хүснэгт 7-оос харахад багш нарын талаарх сургуулийн удирдлагын үзэл бодол ихээхэн эерэг болсон байна. Тухайлбал, багш нарын МХТ-ийн ур чадвар, ажлын үзүүлэлт ихээхэн дээшилсэн гэж тэд үзэж байна.


Хүснэгт 7. Багш нарын МХТ-ийн ур чадвар, мэргэжил дээшлүүлэх боломж, цахим агуулгыг хичээлд ашиглах чадварын талаарх сургуулийн удирдлагын үзэл бодол

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Манай багш нар цахим агуулга боловсруулах ур чадвартай	3.18	3.25	0.07	2.35%
Манай багш нар мэргэжил дээшлүүлэх боломж илүү бий	3.23	3.29	0.07	2.13%
Манай багш нар хичээл заахдаа цахим агуулга ашигладаг	3.21	3.33	0.12	3.69%
Манай багш нарын үйл ажиллагааны үзүүлэлт сайжирч байна	3.39	3.46	0.07	2.16%

Үр дүн 2.2: Багш нарын цахим сургалтын хэрэглэгдэхүүн, орон нутгийн нөхцөл байдалд нийцсэн хэрэглэгдэхүүн ашиглах ур чадвар, чадамжийн талаарх сургуулийн удирдлагын ойлголт нэмэгдсэн.

Суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад сургуулийн удирдлагын ойлголт 7.4%-иар нэмэгдэж багш нарын 75 гаруй хувь нь цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ашиглах мэдлэг, ур чадвартай болсон гэж нотолж байна.

Зураг 3. Цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад багш нарын ур чадвар, чадамжийн талаарх сургуулийн удирдлагын ойлголт (суурь болон үр дүнгийн судалгааны харьцуулалт)



3) Багшийн ур чадвар, сэтгэл ханамж, нэр хүндийн талаар

Үр дүн 3.1: Сургуулийн зүгээс үзүүлсэн дэмжлэг нь багш нарын ур чадвар, ажилдаа сэтгэл ханамжтай байхад сайнаар нөлөөлсөн

Хүснэгт 8-аас харахад суурь судалгааны үр дүнтэй харьцуулахад багш нарын мэргэжлийн ур чадвар, ажлын сэтгэл ханамжийн талаарх ойлголт эрс нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Багш нарын мэргэжлийн ур чадвар, ажлын сэтгэл ханамж

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Сургуулийн зүгээс сурган хүмүүжүүлэх ажилд дэмжлэг үзүүлдэг учраас багшийн хувьд мэргэжлийн ур чадвартай гэж боддог	2.92	2.96	0.04	1.37%
Мэргэжил дээшлүүлэх боломж байгаа учраас ажилдаа сэтгэл хангалуун байдаг	2.75	2.76	0.01	0.37%
Сургуулийн зүгээс сурган хүмүүжүүлэх ажилд дэмжлэг үзүүлдэг учраас ажилдаа сэтгэл хангалуун байдаг	2.78	2.86	0.08	2.75%

Үр дүн 3.2: Сургуулийн удирдлагуудын МХТ-ийг ашиглах зорилгын талаарх ойлголт нэмэгдэж, МХТ-ийн алсын харааг тодорхойлоход багш нарын оролцоо нэмэгдэж байна.

МХТ-ийн тодорхой зорилтуудыг сургуулийн эрхэм зорилго, зорилтуудыг нэгэн хэсэг болгон мөрдөж байгааг сургуулийн удирдлагууд илэрхийлж байна.

Хүснэгт 9. МХТ-ийн төлөвлөгөөнд багш нарын оролцооны талаарх сургуулийн удирдлагын үзэл бодол

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Манай сургуульд МХХТ-ийг сургуулийн эрхэм зорилго, зорилгын нэг хэсэг болгон ашиглах тодорхой зорилтуудыг тавьсан	2.97	3.09	0.13	4.24%
Багш нарын дийлэнх нь сургуулийн МХХТ-ийн төлөвлөгөөг боловсруулахад оролцсон	2.83	3.04	0.22	7.66%
Сургуулийн МХХТ-ийн төлөвлөгөөг багш нар сайн мэддэг бөгөөд тэдгээрийг тодорхой системийн дагуу тогтмол шинэчилдэг	2.69	2.92	0.23	8.60%
Багш нарын МХХТ-ийн ур чадвар, сургалтын хэрэгцээг тодорхой системийн дагуу тогтмол үнэлдэг	2.73	2.84	0.11	3.89%

Үр дүн 3.3: Олон төрлийн арга, хэлбэрүүдээр дамжуулан МХТ-ийн мэдлэгийг хуваалцах нь нэмэгдсэнийг сургуулийн удирдлагууд хүлээн зөвшөөрч байна

Сургуулийн хүрээнд МХТ-ийн хэрэглээний талаарх мэдлэг, туршлагыг өргөнөөр хуваалцдаг болжээ гэж дүгнэж болохоор байна. Мэдлэг, туршлагаа солилцоход албан ёсны уулзалт, семинар, сургуульд суурилсан сургалт зонхилж байна..

Хүснэгт 10. МХТ-ийн хэрэглээний талаарх мэдлэг, туршлага хуваалцах арга замууд

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Албан ёсны уулзалт, семинараар дамжуулан	2.93	3.10	0.18	6.11%
МХХТ-ийг хариуцдаг хүнээр дамжуулан	2.63	2.70	0.08	3.00%
Сургуульд суурилсан сургалтаар дамжуулан	2.79	2.97	0.18	6.31%
Хичээлийн төлөвлөгөөг хуваалцах замаар	2.79	2.91	0.12	4.26%
Гадны сургалтаар дамжуулан	2.65	2.76	0.11	4.16%

Үр дүн 3.4: Сургуулийн удирдлагын манлайллын хэв маяг нь багш нарыг дэмжих, урамшуулахад чиглэсэн байна

Сургуулийн удирдлагууд багш нарын идэвх, урам зоригийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол өгдөг нь тэд урьд өмнө багшийн ажил эрхэлдэг байсантай холбоотой байж болох юм.

Хүснэгт 11. Сургуулийн удирдлагын манлайллын хэв маяг

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Миний манлайллын арга барил бол итгэлцлийг бий болгож, боловсролын алсын хараагаар багш нарт урам зориг өгөх явдал юм	3.31	3.42	0.11	3.19%
Миний манлайллын арга бол багш нарын гаргасан амжилтыг урамшуулах явдал юм	3.22	3.45	0.23	7.16%
Сургуулийн удирдлагын хувьд миний үүрэг бол багш нарт анхаарал хандуулж, зөвлөгөө өгөх явдал юм	3.30	3.46	0.16	4.99%

4) Сургуулийн удирдлага болон багш нарын хоорондын харилцаа

Үр дүн 4.1: Сургуулийн удирдлага МХТ ашигласан сургалтын арга зүй, хичээл төлөвлөлтийн талаарх яриа хэлэлцээ хийх нь нэмэгдсэн

Хүснэгт 12-оос харахад багш нар МХТ-д суурилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, МХТ-ийн сурган хүмүүжүүлэх хэрэглээний талаар санал солилцож, тогтмол уулзалт зохион байгуулдаг гэдэгт сургуулийн удирдлагууд итгэлтэй байна. Мөн ийм төрлийн туршлага солилцох арга хэмжээг санхүүжүүлэх төсөв нэмэгдэж байна.

Хүснэгт 12. Сургуулийн удирдлагын зүгээс МХТ-д суурилсан сурган хүмүүжүүлэх арга зүйн талаар багш нартай хийсэн хэлэлцүүлэг

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Сургуулийн багш нар МХТ-д суурилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах зорилгоор тогтмол уулзалт зохион байгуулдаг	2.95	3.15	0.21	7.03%
Бид багш нартай МХТ-ийн сурган хүмүүжүүлэх хэрэглээний талаар яриа хэлэлцээ хийдэг	3.30	3.40	0.10	3.04%
Бид багш нар хооронд туршлага солилцох үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүжилтийг шийддэг	2.44	2.70	0.26	10.62%

5) Төслийн гол үр дүн

Үр дүн 5.1: Сургуулийн удирдлагууд анги танхимд МХТ-ийг ашиглахад сурагч төвтэй хандлага нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрч байна

МХТ-ийг сургалтад нэвтрүүлснээр уламжлалт сурагч төвтэй сургалтын арга хэлбэр өөрчлөгдөж байна. МХТ ашиглан явуулдаг хичээл нь бусад хичээлээс илүү сурагч төвтэй байдаг.

Хүснэгт 13. Багш нар МХТ-д суурилсан хичээл заахад сурагчдын оролцоо

Асуулт	Суурь /дундаж/	Үр дүн /дундаж/	Зөрүү /дундаж/	Нэмэгдсэн %
Багш нар МХТ-д суурилсан хичээл заахад сурагчдын МХТ-ийн мэдлэг чухал үүрэг гүйцэтгэдэг	2.81	2.91	0.10	3.60%

Үр дүн 5.2: Мэргэжил дээшлүүлэх, багшийн ур чадвар, бүтээлч байдал, санаачлага, сургалтын үйл ажиллагаанд МХТ-ийг үр ашигтай ашиглах чадвар нэмэгдсэн

Хүснэгт 14-өөс харахад багш нарын дийлэнх хувь нь төсөлд хамрагдсанаар дараах үр дүнд хүрсэн хэмээн үзэж байна. Үүнд: Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах боломж нэмэгдсэн (68%); Багшийн ур чадвар эрс нэмэгдсэн (69%); Багш нар цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад илүү бүтээлч, санаачлагатай болсон (71%).

Хүснэгт 14. Төслийн багш нарт үзүүлсэн шууд нөлөө

ЖАЙКА төслийн үр дүнд	Санал нийлж байна	Тодорхой хэмжээнд санал нийлэхгүй байна	Тодорхой хэмжээнд санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Санал нийлсэн %
Миний мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах боломж нэмэгдсэн	3.6	17.0	46.6	21.5	68.1%
Багшийн хувьд миний ур чадвар эрс нэмэгдсэн	2.7	15.1	50.6	18.7	69.3%
Би цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахдаа илүү бүтээлч, санаачлагатай болсон	3.0	15.4	52.8	17.9	70.7%
Би МХХТ-ийг илүү ихээр, үр дүнтэй ашигладаг болсон	2.6	16.1	52.7	18.3	71.0%
Би багшийн хувьд МХХТ-ийг илүү ихээр, үр дүнтэй ашигладаг болсон	2.5	15.8	53.0	18.1	71.1%

Үр дүн 5.3: Төслийн үйл ажиллагаа, хэрэглэгдэхүүн нь багш нарын хэрэгцээнд нийцсэн

Хүснэгт 15-аас харахад төслийн бүх үйл ажиллагаа нь дунд боловсролын багш нарын ажилд тустай байвв Тухайлбал: цахим сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, багшийн удирдамжийн талаарх сургалт (77%); багш нарын боловсруулсан DVD/VCD (70%); холимог сургалтын туршилт (70%).

Хүснэгт 15. Төслийн үйл ажиллагаа багш нарын хэрэгцээнд нийцсэн байдал

	Санал нийлж байна	Тодорхой хэмжээнд санал нийлэхгүй байна	Тодорхой хэмжээнд санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Санал нийлсэн %
Багш нарын мэргэжил дээшлүүлэх зорилгоор харилцан адилгүй судлагдахууны хүрээнд багш нарын бүтээсэн DVD, VCD	3.4	14.9	49.6	20.0	69.6%
Багшийн гарын авлага/удирдамж	1.9	10.6	53.2	23.3	76.5%
Цахим хэрэглэхүүн боловсруулах сургалтын үйл ажиллагаа	2.0	10.5	51.3	25.2	76.5%
Зарим сургуулиудад туршилтын хэлбэрээр зохион байгуулсан хосолсон сургалт	2.9	13.6	49.7	19.2	68.9%

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хөдөө орон нутгийн сургуулиудын сургалтын чанарыг сайжруулснаар дунд ангийн сурагчдад сурагч төвтэй боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэхэд энэ төсөл чиглэгдсэн гэж хэлж болно. Төсөл тавьсан зорилгодоо хүрсэн болохыг нотлох олон тооны баримтууд байна.

Үр дүнгийн судалгааны үр дүнгээс харахад төслийн явцад сургуулиудад МХТ-ийг ашигласнаар сургалтын чанар сайжирч байгааг сургуулийн удирдлагууд хүлээн зөвшөөрч байна.

Сургуулийн удирдлагуудын дараах асуултад санал нийлсэн хариулт өгсөн дундаж оноо суурь судалгааны түвшингээс нэмэгдсэн байна. Үүнд:

“Сургууль дахь МХТ-ийн хэрэглээ нь сургалтын чанарыг сайжруулахад нөлөөлдөг”

“Сургууль дахь МХТ-ийн хэрэглээ нь сурагчдыг илүү үр бүтээлтэй суралцахад нөлөөлдөг”

Багш нартай хийсэн ярилцлага, судалгаагаар МХТ ашиглан заадаг хичээл нь энгийн хичээлээс илүү сурагч төвтэй болохыг тогтоосон.

Төслийн үр дүнд цар тахал сайн болон муу талаар нөлөөлсөн гэж үзэж болно. Төслийн үйл ажиллагаа, гол сургалтууд яг цар тахлын өмнөхөн болсон нь сургууль, багш нарт цар тахлын үеийн онлайн сургалт явуулах бэлтгэл болж өгсөн байна. Нөгөө талаар цар тахлаас болоод багш нарт зориулсан зарим сургалтууд онлайн хэлбэрээр зохион байгуулагдсан юм.

Суурь судалгааг төслийн эхний сургалтууд явагдсаны дараа авсан болохоор суурь үзүүлэлтүүд нэлээд өндөр авагдсан, мөн үр дүнгийн судалгаа цар тахлын дараа, эдийн засгийн байдал хүндэрсэн, хүмүүсийн санаа бодол нэлээд сөрөг, пессимист болсон үед авсан учир энд дурьдсан үзүүлэлтүүд илүү сайн байх боломжтой байсан гэж судлаачид үзэж байгаа болно.

Дараагийн төслүүдийг бүх сургуулийг хамрахаар, цар тахлын үед хичээл хоцорсон сурагчдад чиглэсэн, эсвэл ахлах ангийн багш нарыг хамрахаар төлөвлөж хэрэгжүүлэх санал зөвлөмж олон гарч байсныг энд тэмдэглэх нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Азийн Хөгжлийн Банк, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

Davis, F. D. "Perceived Usefulness, Perceived Ease of Use, and User Acceptance of Information Technology," MIS Quarterly (13:3), 1989, pp. 319-339

Монгол улсын Засгийн газар (2020) Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030.

Монгол улсын Засгийн газар (2007) Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө. https://www.num.edu.mn/files/ZHSHUA/3.4.EDU_MP_mon.pdf -ээс үзэж болно.

Tokyo Institute of Technology & Mongolian State University of Education 2012. Final Report of Project: "SUSTAINABLE USE OF ICT FOR DEVELOPING TEACHER TRAINING MATERIAL"

Монгол Улсын Их Хурал (2018) Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail/13532> -ээс үзэж болно.



ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Л.Хаш¹, Б.Мөнгөннахиа²

¹ Доктор Ph.D. (СЭЗИС ЭЗТэнхимийн ахлах багш, хуульч, өмгөөлөгч)

² Магистр (СЭЗИС ЭЗТэнхимийн ахлах багш, хуульч, өмгөөлөгч)

(Khash.l@ufe.edu.mn, mungunnakhia.b@ufe.edu.mn)



Түлхүүр үг:

цахим гэмт хэрэг,
харьцуулсан судалгаа

Хураангуй

1990 он гарч, зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас хойш Монгол Улсын иргэдийн интернэтийн хэрэглээ, олон улстай холбогдох мэдээллийн гарц цоо шинэ түвшинд гарсан гэхэд хилсдэхгүй. Ялангуяа 2000-аад оноос хойш интернэт хэрэглэгчдийн тоо, сошиал хаягуудын идэвхтэй хэрэглээ асар хурдтайгаар нэмэгдсээр байна.

2023 оны 3 дугаар сарын байдлаар, Монгол Улсад цахим хөгжлийг дэмжих, цахим гэмт хэргээс сэргийлэх, хувь хүний мэдээллийг хадгалах тухай зэрэг холбоо хамаарал бүхий нийт 5 нэр төрлийн хууль батлагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Техник технологи хөгжихийн хэрээр, түүнийг ашиглан үйлдэгдэх гэмт хэргийн тоо ч мөн адил өссөөр байгаа нь Цагдаагийн Ерөнхий газрын Дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тайланд дурдсанаар, Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 35340 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үүний 8563 нь буюу 24 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг байжээ. Эдгээр гэмт хэргээс 90 орчим хувь нь залилангийн гэмт хэрэг байсан ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 99 хувиар өссөн байдалтай байна.

Ковид-19 цар тахалтай холбогдуулан 2 жил орчим хөл хорионд байж, эдийн засаг болон нийгмийн тодорхой шаардлага, хэрэгцээний улмаас энэхүү гэмт хэргийн хохирогчдын тоо өдрөөс өдөрт өссөөр байна. Иймд Америкийн Нэгдсэн Улсын цахим гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин болон Монгол Улсын өнөөгийн байдлыг харьцуулан шинжилж, дүгнэлт гаргахыг зорилоо.

1. Цахим гэмт хэргийн тухай ойлголт

АНУ-ын Хууль зүйн яам (DOJ) - Компьютерын гэмт хэрэг, оюуны өмчийн хэлтэс (CCIPS) нь кибер гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл, нөөцөөр ханган ажилладаг. CCIPS нь кибер гэмт хэргийг “компьютерын систем, сүлжээ, төхөөрөмж, программ хангамж зэрэг компьютерын

технологийн нэг буюу хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой аливаа хууль бус үйл ажиллагаа⁶⁴” гэж тодорхойлсон байдаг.

Үүнээс харахад, кибер гэмт хэрэг гэдэг нь компьютер, сүлжээ болон бусад дижитал төхөөрөмж ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн үйл ажиллагааг хэлнэ. Цахим гэмт хэргийн тодорхойлолт нь харьяаллаас хамаарч өөр өөр байж болох ч ерөнхийдөө гэмт хэрэг үйлдэхийн тулд технологи ашиглахтай холбоотой аливаа хууль бус үйл ажиллагааг багтаадаг. Үүнд хакердах, фишинг хийх, хортой программ түгээх, хувийн мэдээллийг хулгайлах, кибер дээрэлхэх гэх мэт үйлдэл багтаж болно.

Цахим гэмт хэргийн нийтлэг төрлүүдийг дурдвал:

- Хакердах - компьютерын систем, эсвэл сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтрэх;
- Фишинг - халдагчид хохирогчдыг хууран мэхэлж, хэрэглэгчийн нэр, нууц үг, зээлийн картны дугаар зэрэг нууц мэдээллийг задруулдаг нийгмийн инженерчлэлийн нэг төрөл;
- Хортой программ хангамжийн түгээлт – вирус, эсвэл ransomware зэрэг хортой программ хангамжийг интернэт, эсвэл бусад дижитал сувгаар түгээх;
- Хувийн мэдээллийг хулгайлах - хэн нэгний нэр, хаяг, нийгмийн даатгалын дугаар, зээлийн картны дугаар зэрэг хувийн мэдээллийг хулгайлж, залилан болон бусад гэмт хэрэг үйлдэх;
- Кибер дээрэлхэх - технологийг ашиглан хэн нэгнийг дарамтлах, айлган сүрдүүлэх, доромжлох;
- Онлайн залилан - мөнгө эсвэл нууц мэдээллийг бусдад өгөхийн тулд хүмүүсийг хууран мэхлэхийн тулд интернэт ашиглах;
- Хүүхдийн мөлжлөг - интернэтийг ашиглан хүүхдийн садар самууныг сурталчлах, түгээх, эзэмших, эсвэл хүүхдийг бэлгийн зорилгоор мөлжлөг болгох, ашиглах;

Харин Кибер гэмт хэргийн Олон улсад кибер гэмт хэрэг гэдэгт кибер халдлага, пишинг, онлайн мөрдлөгө болон залилан, заналхийлэл, скиминг буюу картны гэмт хэрэг, садар самуун дүрс бичлэг тараах болон интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг багтаадаг бөгөөд дараах ерөнхий байдлаар дараах 4 төрөлд ангилдаг байна. Үүнд:

1. Компьютерын мэдээлэл, сүлжээний бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлын эсрэг гэмт хэрэг
2. Компьютер ашиглаж үйлдэх гэмт хэрэг
3. Интернэт дэх зохистой агуулгын эсрэг гэмт хэрэг
4. Интернэт дэх оюуны өмчийн эсрэг гэмт хэрэг⁶⁵

⁶⁴ АНУ-ын Хууль зүйн яам. (n.d.). Кибер гэмт хэрэг. <https://www.justice.gov/criminal-ccips/cybercrime>

⁶⁵ <https://schollufsin.ru/mn/razvod/kiberprestupleniya-v-rf-cto-takoe-kiberprestupnost-pod-odin/>

2. Монгол Улс дахь цахим гэмт хэргийн эрх зүйн орчин, өнөөгийн байдал

Цахим гэмт хэрэг гэх ойлголтыг 2021 оноос өмнө судлаачид өөр өөрсдийнхөөрөө кибер гэмт хэрэг, цахим гэмт хэрэг, компьютерын гэмт хэрэг зэргээр нэршиж байсан бөгөөд олон улсад цахим гэмт хэргийн тухай ойлголтыг дараах байдлаар тодорхойлдог. Тухайлбал, *Цахим гэмт хэрэг гэдэг нь компьютер, сүлжээнд холбогдсон төхөөрөмж, эсвэл сүлжээтэй холбоотой аливаа хууль бус үйлдлийг хэлнэ. Ихэнхдээ цахим гэмт хэрэг нь онлайн залилан, хувийн мэдээллийг хулгайлах, фишинг хийх, хортой программ түгээх зэрэг онлайн гэмт хэргийн үйлдлүүдийг хэлдэг. Гэсэн хэдий цахим хэрэгсэл ашиглан тагнах, мөрдөх, онлайнар дарамт учруулах зэрэг дижитал төхөөрөмж ашиглан үйлдэгдсэн гэмт хэрэг ч мөн адил багтана*⁶⁶ хэмээн тусгажээ.

Харин Монгол Улсын хувьд 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аюулгүй байдлыг үзэл баримтлал, хөтөлбөртөө “мэдээллийн аюулгүй байдал” нь үндэсний аюулгүй байдал баталгаажих цогц бодлогын нэг хэсэг юм гэдгийг тусгаж өгсөн байна. Тухайн ойлголт, хөтөлбөрийг хангахын тулд кибер орчин дахь гэмт явдалтай тэмцэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн орчинд сөргөлдөх аюулаас сэргийлэх чиглэлд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлэн гэж заасан байдаг.

Мөн түүнчлэн Монгол Улсын хувьд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Кибер Аюулгүй байдлын тухай хуулийг баталсан байдаг. Үүнтэй холбогдуулан, Монгол Улсын Эрүүгийн хууль дахь кибер гэмт хэргийн зохицуулалтыг тус хуулийн 26 дугаар бүлгийг “Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” хэмээн өөрчлөн баталжээ.

Хүснэгт 1. Монгол Улсын Эрүүгийн хуулиар тодорхойлсон кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг

№	26.1.Кибер орчинд хууль бусаар халдах
1	Кибер орчинд зөвшөөрөлгүйгээр хандаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2	Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, нуусан, нэмж оруулсан, хуулбарлаж авсан, ашиглах боломжгүй болгосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3	Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, хандалтад хязгаарлалт тогтоосон, ноцтой саад учруулсан бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁶⁶ НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба. (2021). Кибер гэмт хэрэг. <https://www.unodc.org/cybercrime/en/cybercrime.html>

4	Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн бол хоёр жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5	Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
6	Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:
	6.1.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;
	6.2.төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд; төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний албан болон тусгай хэрэглээний сүлжээнд; онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
№	26.2.Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах
1	Энэ хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ, техник хэрэгслийг бэлтгэсэн, борлуулсан; программ хангамжийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2	2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг:
	зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;
	төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа мэдээллийн системд; төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний албан болон тусгай хэрэглээний сүлжээнд; онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын Кибер Аюулгүй байдлын тухай хуулийн зорилго нь ...кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино хэмээн тусгагдсан байдаг. Тэгэхээр энэхүү хуулийн цар хүрээ нь интернэт болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, тэдгээрийн ажиллагааг хангах мэдээллийн дэд бүтцийн харилцан хамааралтай цогцоос бүрдсэн биет болон биет бус талбарт мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал хангагдсан байхтай холбоотой бүхий л төрлийн харилцааг зохицуулахад орших ажээ.

Одоогийн байдлаар GSMA олон улсын судалгааны байгууллагаас гаргасан дүгнэлтээр, Монгол Улсын интернэт хэрэглэгчдийн тоо 2022 оны 1 сарын байдлаар 2.6 саяд хүрсэн⁶⁷ бөгөөд сошиал платформын хэрэглэгчдийн тоо 96 мянгаар өссөн гэх мэдээлэл бий. Энэхүү үр дүнгээс харахад, Монгол Улсын нийт хүн амын 73 хувь нь интернэтийг идэвхтэй хэрэглэж, 10 хүн тутмын 7 нь цахим орчинд байнгын хандалтыг үүсгэдэг байна. Мөн түүнчлэн энэхүү цахимын хэрэглээ нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ихээхэн идэвхжиж, иргэд олон нийтийн хувьд цар тахлын хөл хорионд байх хугацаанд бүхий л үйлчилгээг хүргэлтээр захиалан авах, интернэтээр дамжуулан ажил, үйлчилгээ явуулах зэргээр өөрсдийн зарим хувийн мэдээллийг бусдад задруулсан байдаг. Үүний хор уршгаар цахимыг ашиглан залилан хийх, бага насны хүүхдийг уруу татах, хүүхдийн хулгай ихсэх зэрэг гэмт хэргийн гаралтын тоо мөн адил өссөн байдаг.

2022 оны Улсын Ерөнхий Прокурорын газраас хийсэн цахим гэмт хэргийн тухай судалгаагаар, Кибер орчинд цахим хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан үйлдэж байгаа гэмт хэргүүд ихэвчлэн зохион байгуулалтад шилжсэн, дэлхийн аль ч улс орноос интернэтийн сүлжээ ашиглан үйлдэгдэж байна. Манай улсын иргэд фэйсбүүк, инстаграм, жи-мэйл зэрэг хилийн чанадад сервертэй вэб сайтуудыг хэрэглээндээ ашигладаг. Дийлэнх гэмт хэрэг хуурамч хаягнаас хандалт хийгддэг. Судалгаанаас харахад цахим хэрэгсэл, цахим сүлжээ ашиглан үйлдэж буй хэргийн дийлэнх буюу 30 орчим хувийг “фэйсбүүк” мэдээллийн сүлжээ ашиглаж үйлдсэн, үүнээс 95.6 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байна.⁶⁸

Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэгт заасан “цахим мэдээлэл”, “цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах” хэмээн тодорхойлсон байсныг “цахим орчинд” гэж Кибер аюулгүй байдлын тухай хуульд үгийн хэрэглээний хувьд өөрчилж, “цахим” гэх нэр томъёог цаашид кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг хэмээн ашиглахаар зохицуулсан байна.

Мөн түүнчлэн Эрүүгийн хуулийн дараах зохицуулалтуудад цахим хэрэгсэл ашиглаж үйлдэх нөхцөлийг тусгаж өгчээ. Үүнд,

- 17 дугаар зүйлийн 17.3-т тусгагдсан Залилах гэмт хэргүүд;
- 13 дугаар зүйлийн 13.10-т тусгагдсан. Хувь хүний нууцад халдах гэмт хэргүүд;

Харин тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-ийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу Хүүхэд оролцуулж, садар самууныг сурталчлах гэмт хэргийг “кибер орчныг ашиглаж” үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулахаар зүйлчилжээ.

Эрүүгийн салбар эрх зүйн онцлог нь хүний жам ёсны эрхтэй шууд холбогддог учраас үг хэллэгийн хувьд тодорхой байх шаардлагатай ба аливаа гэмт хэргийн хувьд хуулинд заасан тохиолдолд л хариуцлага ногдуулахаар тусгагдсан байх тул аливаа гэмт хэргийг цахим гэмт хэрэгт оруулах эсэх нь тухайн хэрэгт ажиллаж буй хуульчийн мэргэжлийн ур чадвараас хамааралтай байна.

Манай улсын салбарын зохицуулагч байгууллагын хувьд Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Тагнуулын байгууллага нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд захиргааны хэм хэмжээний акт болон журам батлан мэдээллийн аюулгүй байдлыг

⁶⁷ <https://datareportal.com/reports/digital-2022-mongolia>

⁶⁸ <https://www.arslan.mn/social/news/636026.shtml>

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

ханган ажилладаг. Тухайлбал, дээрх байгууллагууд нь дараах журам, хэм хэмжээний актыг салбарын хууль батлагдсанаас хойш батлан ажиллаж байна.

№	Хууль	Журам	Батлагдсан огноо
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	2022.07.06 №А/35
2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам	2022.05.18 №201
3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Хязгаарлалттай мэдээлийг ашиглах бол мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах, мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам	2022.05.31 №211
4	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Хүн хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам	2022.05.25 №206
5	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам	2022.05.31 №219
6	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нээлттэй өгөгдлийн жагсаалт гаргах	2022.06.15 №232
7	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журам	2022.08.26 №А/288, А/44
8	Цахим гарын үсгийн тухай хууль	/Шинэчилсэн найруулга/	2021.12.17
9	Цахим гарын үсгийн тухай хууль	Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журам	2022.06.23 А/28
10	Цахим гарын үсгийн тухай хууль	Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журам	2022.06.29 А/30
11	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нээлттэй өгөгдөлтэй холбоотой журмууд	2022.05.18 №200
12	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал	2022.05.18 №202
13	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам	2022.05.11 №196
14	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам	2022.05.02 №А/18

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

15	Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль	Мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдлийг устгах үйл ажиллагааг зохицуулах журам	2022.04.13 №55
16	Кибер аюулгүй байдлын тухай хууль	Онц чухал дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт	2022.05.25 №207
17	Кибер аюулгүй байдлын тухай хууль	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам	2022.05.11 №197


Цагдаагийн Ерөнхий газраас эрхлэн гаргасан Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, нөхцөл байдал - 2022 тайланд⁶⁹ тусгагдсанаар, цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн гаралтын тоо өмнөх онтой харьцуулахад 77.5 хувиар өссөн үзүүлэлттэй байж, нийт 8563 хэрэг бүртгэгдсэн байна. Үүний 80.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 19.6 хувь нь орон нутагт, 0.04 хувь нь хилийн чанадад үйлдэгджээ.

Тус гэмт хэргийн дийлэнх хувь буюу 90 хувийг Залилах гэмт хэрэг, 1.4 хувийг худал мэдээлэл тараах гэмт хэрэг, 3 хувийг кибер орчинд халдах гэмт хэрэг, 1.5 хувийг хулгайлах гэмт хэрэг, 0.5 хувийг заналхийлэх гэмт хэрэг, 0.8 хувийг мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг эзэлсэн байна.

- Гэмт хэрэгт холбогдогсад

Нийт 8563 цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгт 5664 хүн холбогдон шалгагдаж, тэдний 3798 буюу 67.1 хувь нь эрэгтэй, 1866 буюу 32.9 хувь нь эмэгтэй, 402 буюу 7.1 хувь нь 14-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал холбогдон шалгагдсан хүн 2805 буюу 98.1 хувиар, эмэгтэй хүн 1152 буюу 2.6 дахин, хүүхэд 298 буюу 3.9 дахин тус тус өссөн.

Гэмт хэрэгт холбогдогсдыг нас, хүйс, нийгмийн байдлаар авч үзвэл,




Эх сурвалж: Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, нөхцөл байдал - 2022 тайлан

⁶⁹ <https://police.gov.mn/resource/policienew/File/2023/02/08/j54prlrtohmj3i8q/2022%20nom%20N.pdf>

● Гэмт хэргийн хохирогчид

Гэмт хэргийн улмаас 8438 хүн хохирсны 3224 буюу 38.2 хувь нь эрэгтэй, 5214 буюу 61.8 хувь нь эмэгтэй, 83 буюу 1.0 хувь нь 11-17 насны хүүхэд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 4103 буюу 94.6 хувь, эрэгтэй хүн 1639 буюу 2.0 дахин, эмэгтэй хүн 2464 буюу 89.6 хувь, хүүхэд 39 буюу 88.6 хувиар тус тус өссөн байна.



Эх сурвалж: Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, нөхцөл байдал - 2022 тайлан

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 32662.6 сая төгрөгийн хохирлын 10413.8 сая төгрөг буюу 31.9 хувийг нөхөн төлүүлж, 275.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 14153.9 сая төгрөг буюу 76.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 241.3 сая төгрөг буюу 8.0 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1185.0 сая төгрөг буюу 12.8 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байдлаар 2022 оны 1 сарын 1-нээс 2023 оны 4 сарын 5 хүртэл хугацаанд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26.1-ийн дагуу шийдвэрлэгдсэн нийт 23 бүртгэлтэй хэрэг нийтлэгджээ.

Эдгээр нээлттэй хэргийг шүүж үзэхэд дийлэнх нь цахимаар үйлдсэн залилангийн хэрэг эзлэх бөгөөд 2022 оны 10 сарын байдлаар, Цагдаагийн байгууллагад бүртгэгдэж байгаа нийт гэмт хэргийн 30 гаруй хувийг кибер орон зайд үйлдэж байгаа гэсэн судалгаа байна. Үүнээс, нийт гэмт хэргийн 24 орчим хувийг цахимаар залилах гэмт хэрэг эзэлдэг. Үлдсэн зургаа орчим хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлдэг. Энэ оны эхний арван сарын байдлаар 30 гаруй мянган гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгджээ. Үүнээс 8000 орчим нь цахимаар залилах төрлийн гэмт хэрэг байна. Цахимаар залилах гэмт хэргийн 15 орчим хувь нь бусдын цахим хэрэгсэл, хаяг руу хууль бусаар нэвтэрч залилах хэлбэрээр үйлдэгдэж байна.

3. Америкийн Нэгдсэн Улсын цахим гэмт хэргийн эрх зүйн орчин

АНУ-ын кибер гэмт хэргийн хууль эрх зүйн орчин нь нарийн төвөгтэй бөгөөд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг. Холбооны, муж, орон нутгийн янз бүрийн төрлийн кибер гэмт хэрэгт үйлчилдэг олон төрлийн хууль байдаг бөгөөд технологи, эрүүгийн тактик хөгжихийн хэрээр хууль тогтоомж, шийтгэл нь өөрчлөгддөг онцлогтой.

Холбооны түвшинд компьютерын залилан, урвуулан ашиглах тухай хууль (CFAA), Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA), Кибер аюулгүй байдлын мэдээлэл хуваалцах тухай хууль (CISA) зэрэг цахим гэмт хэрэгт хамааралтай хэд хэдэн хууль байдаг. Эдгээр хуульд цахим гэмт хэргийн төрөл бүрийн хэлбэрийг тодорхойлж, үйлдсэн этгээдэд оногдуулах шийтгэл ногдуулдаг.

Мөн цахим гэмт хэргийн эрх зүйн орчинд муж улсын хууль тогтоомж ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Муж бүр цахим гэмт хэрэгтэй холбоотой өөрийн гэсэн хууль тогтоомж, шийтгэлтэй байдаг бөгөөд эдгээр хууль нь тухайн мужаас хамаарч өөр өөр байж болно. Зарим муж цахим дээрэлхэх, онлайн дарамтын бусад хэлбэрт тусгайлан чиглэсэн хууль тогтоомж гаргасан байна.

Цахим гэмт хэрэгт чиглэсэн хуулиас гадна кибер гэмт хэргийн хууль эрх зүйн орчинд нөлөөлөхүйц нууцлал, мэдээллийн хамгаалалттай холбоотой олон төрлийн хууль байдаг. Жишээлбэл, Мэдээллийн Хамгаалалтын Ерөнхий журам (GDPR) нь Европын Холбооны дүрэм бөгөөд тус компани хаана байрлаж байгаагаас үл хамааран Европын Холбооны иргэдийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулдаг аливаа компанид үйлчилдэг.

Эдгээр мэдээллийг нэгтгэн дүгнэж, эрх зүйн эх сурвалжийг ангилбал,

- Холбооны хууль: АНУ-д кибер гэмт хэргийг зохицуулах хэд хэдэн холбооны хууль байдаг. Тухайлбал,
 1. Компьютерын залилан болон урвуулан ашиглах тухай хууль (CFAA)⁷⁰: Энэхүү хууль нь зөвшөөрөлгүйгээр компьютер эсвэл компьютерын сүлжээнд нэвтрэх, зөвшөөрөлгүй нэвтрэхийг хууль бус болгодог. CFAA-г зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулахаас эхлээд 20 жил хүртэл хугацаагаар хорих хүртэл шийтгэл ногдуулдаг.
 2. Цахим харилцааны нууцлалын тухай хууль (ECPA)⁷¹: Энэхүү хууль нь цахим харилцааг таслан зогсоох, задруулах асуудлыг зохицуулдаг. Энэ нь зарим тохиолдолд цахим харилцаа холбоог таслан зогсоохыг хориглож, зөрчил гаргасан тохиолдолд торгууль ногдуулдаг.
 3. Кибер аюулгүй байдлын мэдээлэл хуваалцах тухай хууль (CISA)⁷²: Энэхүү хууль нь кибер аюулгүй байдлын аюулын талаарх мэдээллийг засгийн газар болон хувийн хэвшлийн байгууллагууд хооронд хуваалцахыг заасан бөгөөд ийм мэдээллийг хуваалцсаны хариуцлагыг багтаасан болно.

⁷⁰ (<https://www.law.cornell.edu/uscode/text/18/1030>)

⁷¹ (<https://www.law.cornell.edu/uscode/text/18/part-I/chapter-119>)

⁷² (<https://www.congress.gov/bill/114th-congress/senate-bill/754>)

4. Дижитал мянганы зохиогчийн эрхийн тухай хууль (DMCA)⁷³: Энэхүү хууль нь дижитал эрхийн менежментийн (DRM) технологийг тойрч гарах, DRM-ийг тойрч гарах зорилготой технологийг үйлдвэрлэх, түгээх үйлдлийг гэмт хэрэгт тооцдог.
- Төрийн хууль: АНУ-ын муж бүр цахим гэмт хэрэгтэй холбоотой өөрийн гэсэн хууль тогтоомж, шийтгэлтэй байдаг. Мужийн хууль тогтоомж нь янз бүр байж болох ч ихэнхдээ холбооны хуулиудыг тусгаж, кибер гэмт хэргийн хохирогчдыг нэмэлт хамгаалалтаар хангадаг. Жишээлбэл:
 1. Калифорни муж нь кибер дээрэлхэх, онлайн дарамтад чиглэсэн хуулиудыг баталсны дотор хохирогчдод дарамтлагчдын эсрэг таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжийг олгодог хууль⁷⁴ батлагдсан байна.
 2. Нью-Йорк хотод бэлгийн дур хүслээ илэрхийлсэн зургийг цахим орчинд зөвшөөрөлгүй хуваалцахад чиглэсэн хууль⁷⁵ баталсан байна.
- Нууцлал ба мэдээлэл хамгаалах хууль: Кибер гэмт хэрэгт тусгайлан чиглэсэн хуулиас гадна кибер гэмт хэргийн хууль эрх зүйн орчинд нөлөөлөхүйц нууцлал, мэдээллийн хамгаалалттай холбоотой олон төрлийн хууль байдаг. Жишээлбэл:
 1. Мэдээллийг хамгаалах ерөнхий журам (GDPR)⁷⁶ нь Европын Холбооны дүрэм бөгөөд тус компани хаана байрлаж байгаагаас үл хамааран ЕХ-ны иргэдийн хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулдаг аливаа компанид үйлчилдэг.
 2. Калифорнийн Хэрэглэгчийн Нууцлалын тухай хууль (CCPA) нь Калифорнийн оршин суугчдад бизнесүүд хувийн мэдээллээ цуглуулах, ашиглахтай холбоотой тодорхой эрхийг олгодог.

АНУ-д кибер гэмт хэргийн хууль ёсны шийтгэл нь үйлдсэн цахим гэмт хэргийн тодорхой төрөл, гэмт хэргийн хүнд байдлаас хамаарч өөр өөр байж болно. Зарим цахим гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэж үзэж байхад заримыг нь маш хүнд гэмт хэрэг гэж үзэж болно.

Жишээлбэл, компьютер, сүлжээнд зөвшөөрөлгүй нэвтэрсэн, хакердах гэж нэрлэгддэг шийтгэл нь анх удаа үйлдсэн тохиолдолд торгууль болон/эсвэл 10 жил хүртэл, давтан гэмт хэрэг үйлдсэн бол 20 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэдэг. Вирус, тагнуул гэх мэт программыг тараасан тохиолдолд торгууль эсвэл анх удаа үйлдсэн тохиолдолд 10 хүртэл жил, давтан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 20 жил хүртэл хугацаагаар хорих ял оноож болно.

Цахим гэмт хэргийн нийтлэг хэлбэр болох хувийн мэдээллийг хулгайлах нь зарим тохиолдолд торгууль эсвэл 30 хүртэлх жилийн хорих ял зэрэг хүнд шийтгэл ногдуулдаг. Хүүхдийн садар самууныг сурталчлах, түгээх зэрэг хүүхдийн мөлжлөг нь торгууль, эсвэл 20 жил хүртэл хорихоос эхлээд бүх насаар нь хорих хүртэл шийтгэл ногдуулдаг.

⁷³ (<https://www.law.cornell.edu/uscode/text/17/chapter-12>)

⁷⁴ (https://leginfo.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=1.6.&part=2.&chapter=1.5.&article= and https://leginfo.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?sectionNum=646.9.&lawCode=PEN)

⁷⁵ (<https://www.nysenate.gov/legislation/laws/PEN/250.45>)

⁷⁶ (https://leginfo.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=1.81.5.&part=4.&chapter=3.&article=)

АНУ-д кибер гэмт хэргийн тодорхой хууль ёсны шийтгэл нь муж бүрийн хууль тогтоомж, тохиолдол бүрийн нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байж болохыг анхаарах нь чухал.

Ерөнхийдөө АНУ-д кибер гэмт хэргийг маш нухацтай авч үздэг бөгөөд холбооны, муж, орон нутгийн түвшний хууль сахиулах байгууллагууд эдгээр гэмт хэргийг хуулийн хүрээнд мөрдөн шалгаж, илрүүлэхээр ажилладаг.

Мөн түүнчлэн, АНУ-ийн хувьд манай орноос ялгаатай эрх зүйн бүл бөгөөд шүүхийн жишигийг өөрсдийн эх сурвалжаар ашигладгийг тодотгох ёстой. Энэ нь тухайн муж, улсад үйлдэгдсэн гэмт хэрэгт шударга шийтгэл оногдуулах, хохирогчийн хохирлыг бүрэн барагдуулахад чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Кибер гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн зарим онцлох жишээг дурдвал:

- АНУ-ын эсрэг Моррис (1990): Энэ нь Компьютерын залилан, урвуулан ашиглах тухай хуулийн (CFAA) дагуу анх удаа мөрдөн байцаалтын ажиллагаа байсан бөгөөд компьютерын системд ихээхэн хохирол учруулсан өөрийгөө хуулбарлах чадвартай компьютерын вирус бүтээж, гаргасан төгсөгч оюутан оролцсон байна.
- АНУ-ын эсрэг Сварц (2013): Энэ хэрэгт МПТ-ийн компьютерын сүлжээг ашиглан эрдэм шинжилгээний сэтгүүлийн нийтлэлүүдийг зөвшөөрөлгүйгээр татан авч, тараасан интернэт идэвхтнийг ялласан явдал юм. Сварцыг CFAA болон бусад хуулийн дагуу хэд хэдэн хэрэгт буруутгаж, шүүх хурал дуусахаас өмнө амиа хорлосон байдаг.
- АНУ-ын эсрэг Ауернхаймер (2014): Энэ хэрэгт iPad хэрэглэгчдийн хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүйгээр нэвтэрч, нийтэлсэн компьютерын хакерыг ялласан байна. Auernheimer CFAA-ийн дагуу шийтгэгдсэн боловч дараа нь давж заалдах шатны шүүхээс ялыг нь суллажээ.
- Facebook, Inc.-ийн эсрэг Power Ventures, Inc. (2016): Энэ хэрэг нь хэрэглэгчдэд сошиал медиа дансаа нэг дор нэгтгэх боломжийг олгодог үйлчилгээг санал болгосон компанитай холбоотой юм. Фэйсбүүк компанийг үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн, Facebook-ийн сүлжээнд зөвшөөрөлгүйгээр нэвтэрсэн гэж шүүхэд өгчээ. Шүүхээс Facebook-ийн талд шийдвэр гаргаж, тус компанид учирсан хохирлыг барагдуулах шийдвэр гаргажээ.
- АНУ-ын эсрэг Hutchins (2017): Энэ хэрэг нь компьютерын аюулгүй байдлын судлаачийг хорлонтой програм бүтээж, худалдсан хэрэгт буруутгаж ялласан явдал юм. Эцэст нь Хатчинс өөрт нь тулгасан хэргүүдийг цагаатгасан байна.

Эдгээр нь АНУ-д кибер гэмт хэрэгтэй холбоотой шүүхийн олон жишээний цөөн хэдэн жишээ юм. Технологи үргэлжлэн хөгжихийн хэрээр хууль эрх зүйн орчин ч мөн адил хувьсан өөрчлөгдөж, шинээр гарч ирж буй аюул занал, сорилтуудыг шийдвэрлэх шинэ хууль тогтоомж, шүүхийн өмнөх жишээнүүд бий болохоор харагдаж байна.

Дүгнэлт

Монгол Улсын хувьд цахим гэмт хэрэг, кибер гэмт хэрэгтэй сүүлийн үед эрчимтэй тэмцэж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, хэм хэмжээний акт, журмууд мөн түүнчлэн

батлагдсаар байна. Үүнтэй холбогдуулан цахим гэмт хэргийн өнөөгийн байдлын тухай судалгааг хийн дараах дүгнэлтэд хүрэв.

- Бусад улс орны хууль тогтоомж, эрх зүйн орчинтой харьцуулан судлахад, салбар хуулийн уялдаа холбоо дутмаг, үүсч болох нөхцөл байдлын цар хүрээ илүү багасгасан байдалтай байна. Хуульч, судлаачдын зүгээс дараа дараагийн судалгааг илүүтэйгээр хийж, хуулийн зүйл заалтыг нарийвчлах, үүсч болох нөхцөл байдлыг бусад орны жишигтэй харьцуулан нарийвчлан хуульчлах зэрэг шаардлагууд үүсч байна.
- Олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь нэн тэргүүний хийх ёстой ажлын нэг бөгөөд кибер гэмт хэргийн хувьд хил дамнан үйлдэгддэг тул илрүүлэхэд төвөгтэй байх магадлалтай байна.
- Цахим орчныг ашиглан үйлдсэн гэмт хэргүүдийг судлахад ихэвчлэн залилангийн шинж чанартай гэмт хэргүүд тэргүүн эгнээнд бичигдсэн байх бөгөөд үүнтэй холбогдуулан иргэдийн идэвх оролцоо, мэдлэгийг тэлэх, мэдээллийг цаг тухай бүрт нь хүргэх, сэрэмжлүүлэх нөлөөллийн ажлыг явуулах нь зүйтэй байна.

НОМ ЗҮЙ ЖАГСААЛТ

Хууль эрх зүй.

Монгол Улсын эрүүгийн хууль 2015 он

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2021 он
НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба. (2021). Кибер гэмт хэрэг.

Цахим гарын үсгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2021 он

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2021 он

Кибер аюулгүй байдлын тухай хууль 2021 он

Судалгаа тайлан:

Цагдаагийн байгууллагын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, нөхцөл байдал - 2022 тайлан

<https://datareportal.com/reports/digital-2022-mongolia>

Цахим эх сурвалж:

АНУ-ын Хууль зүйн яам. (n.d.). Кибер гэмт хэрэг. <https://www.justice.gov/criminal-ccips/cybercrime>

<https://schollufsin.ru/mn/razvod/kiberprestupleniya-v-rf-chto-takoe-kiberprestupnost-pod-odin/>

<https://www.unodc.org/cybercrime/en/cybercrime.html>

<https://www.arслан.mn/social/news/636026.shtml>

<https://police.gov.mn/resource/policenew/File/2023/02/08/j54prlrtohmj3i8q/2022%20nom%20N.pdf>

<https://www.law.cornell.edu/uscode/text/18/1030>

<https://www.law.cornell.edu/uscode/text/18/part-I/chapter-119>

<https://www.congress.gov/bill/114th-congress/senate-bill/754>

<https://www.law.cornell.edu/uscode/text/17/chapter-12>

https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=1.6.&part=2.&chapter=1.5.&article=

https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?sectionNum=646.9.&lawCode=PEN

<https://www.nysenate.gov/legislation/laws/PEN/250.45>

https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=CIV&division=3.&title=1.81.5.&part=4.&chapter=3.&article=



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛ УЛСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН СУУРЬ ТАВИГДСАН НЬ (1911-1950 ОН)

Б.Дэлгэрмаа¹, Ж.Хулан²

¹ Магистр (LLM), дэд профессор /СЭЗИС/

² Магистр (LLM), дэд профессор Ж.Хулан /СЭЗИС/



Хураангуй

Монгол Улсад орчин цагийн хууль цаазны боловсрол олгож эхэлсэн түүхэн үйл явцыг эрх зүйн түүхийн он дарааллын дагуу судалсан болно.

Түлхүүр үг:

Оюутны сургууль, хууль
цаазны анги, шүүх яам, түр
сургалт, архивын баримт,
багш.

Удиртгал

ХХ зуун бол Монгол орныг орчин үеийн соёл иргэншилд шилжүүлсэн түүхэн цаг үе юм.

Монголын төр улс орноо хөгжүүлэхдээ мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх улс орны хэрэгцээ шаардлагын дагуу зөвхөн уламжлалт сургалтдаа тулгуурлах бус хууль цаазын боловсролтой мэргэжилтэн бэлдэх ирсэн түр курс, сургуулиудыг нээсэн төдийгүй эрх зүйн боловсролын ач холбогдолд анхааран эх орондоо хууль цаазны дээд мэргэжилтэн бэлтгэх хүртэл хэрхэн хууль цаазны мэргэжилтэн бэлтгэж ирсэн үйл явцыг судалсан юм.

Үндсэн хэсэг

1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар сэргэн мандсан Монгол Улс, улс төрийн статусаа бэхжүүлж, эдийн засгийн орчин цагийн хэв шинжит бүтцийг буй болгоод зогсохгүй нийгэм, соёлын хүрээнд шинэтгэл хийсний нэг чиглэл нь боловсролын салбар байв.

Тухайн үеийн Монгол Улсад мэдлэг, мэргэжил олгох зорилготой гурван хэв шинжийн сургууль байжээ. Үүнд:

1. Үндэсний хэл бичгээр уншиж бичих, тоо бодох, зурах, хүмүүжүүлэх зорилготой гэрийн сургууль,
2. Төвөд хэл бичиг зааж шашны боловсрол эзэмшүүлэх шашны сургууль,

3. Хууль цааз, төр захиргааны боловсрол олгож, төрийн түшээ, тамгын ажилтныг бэлтгэх төрийн сургууль байжээ. Дээрх сургуулиуд бүтэц, зохион байгуулалт, сургах үүрэг зорилго, сургалтын агуулга, арга хэлбэрээрээ адилгүй, тусдаа бие даасан, өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүхий байв. (Болдбаатар ба бус, 2020. х.36)

Бид уг судалгаагаар зөвхөн хууль цаазны боловсролыг хэрхэн олгож байсан түүхийг өгүүлэх тул нэг ба хоёрдугаар хэлбэрийн хэв шинжийн сургуулийг цааш дэлгэрүүлэн судлаагүй болно.

Төрийн сургуулиар төрд алба хаших түшмэл, тамгын ажилтнуудыг бэлтгэдэг учраас тэдний үзэж судлах хичээлийн гол төрөл нь төрийн хууль цааз, төрт ёсны сургаал, хэв ёс, бичгийн боловсрол (албан бичиг үйлдэх, төрөл бүрийн бичгийн эх зохиох зэрэг), мөн манж, хятад хэл бичиг зэрэг болно. Төрийн монгол сургууль нь Манж Чин улсын үед Хүрээ сайдын яаманд байгуулагдан, төрийн албан хаагчдыг бэлтгэн сургаж, суралцагчдаас зургаан хүүхдийг сонгон, өдөр бүр Оросын консулын сайдын яамны сургуулийн гэрт илгээж орос бичиг хэл сургаж байжээ. (Болдбаатар ба бус, 2020. х.39)

Монгол Улс төрийн тусгаар тогтнолоо тогтоосны дараа ч тэдгээр монгол хөвгүүдийг тэр хэвээр нь өдөр бүр илгээн үргэлжлүүлэн сургаж, сар бүр хүн тутамд хүнс мөнгө арваад лан, оросын сургагч нарт гучин лан, бас бийр цаасны зэрэг үнэ ба хөтөл (багшийн унах морь бэлтгэгч) нэгийн хэрэглэлийг тавин олгож хоёр жил шахам болсон боловч, тэдний төсөөлсөн нь маш өчүүхэн, сурч төгсөх цаггүй, улсын мөнгийг талаар сүйтгэж байжээ. Тиймээс Гадаад яамны дотор хэдэн өрөө тасалгааг цэвэрлэн засч сургуулийн гэр болгоод, сургагч хүнийг тусгайлан гаргаж өгнө үү хэмээн Орос улсын консулаас хүсэхэд тус улсын эрдэмт буриад Жамсрановыг илгээж болно хэмээсэн тул, түүнийг урин авчирч орос үсгийн сургууль нээн, бас тус яамны дэс түшмэл тойн Лувсанжамбааг томилон монгол бичиг үсгийг хавсран орохоор төлөвлөж, хөвгүүдийн тоо цөөхөн тул дахин 4 хүн нэмж бүгд 10 болгоод, сар бүр хүн тутам хүнс мөнгө арван лан, бийр цаас, бэх зэрэг хэрэглэл, сургуулийн гэрт түлэх түлээ, нүүрс ба хөтлийн хүн хоёрын хэрэглэлийг цөм Сангийн яамнаа хадгалан буй сургуулийн хэрэглэл, мөнгөнөөс тавин олгож байжээ. (*Монголын автономит үеийн сургууль*, 1966. х.29)

Уригдан ирсэн буриад эрдэмтэн Цэвээн Монголд төрийн сургууль байгуулах тухай төсөл бичиж 1912 оны 3 дугаар сарын 30-ы өдөр Гадаад яаманд өргөсөн байна. Төслийн бичигт гадаадын олон хүчирхэг улсын хамаг чадал нь элдэв ухааны эрдэмд дээд, доод, эр, эм ялгахгүй цөм бага наснаас эхлэн, бага, дунд, их гурван зэргийн сургуульд явсны үр дүн болохыг гаргаад, таван зүйлийн саналыг дэвшүүлжээ. Үүнд: Нийслэл хүрээ олон түмний төв газар тул энд дав дээр бага сургууль нэгийг байгуулж, хожмоо дунд сургууль нэмэхээр сууриа тавих, орос, хятад хэлийг судлах дөрвөн аймаг, дагаар орсон аймгууд бүр нэг нэг сургууль байгуулах, хот орчмын сүү тос хийх мал аж ахуйн сургууль нэгийг байгуулах, сургуулийн багш нар болон эрдэмтдээр ухаан бүрийн дэвтрүүдийг монголоор зохиолгох, эрдэмд шавь ялгаагүй, жинстэн, харцуулыг хамт сургах зэрэг санаануудыг тусгажээ. (*Монголын автономит үеийн сургууль*, 1966. х.12) Ийнхүү хүн бүрийн сурч боловсрох эрхийг дээдлэх санааг тусгаж байсан байна.

Үүнээс гадна Монголын тэргүүний үзэлтэй хүмүүс тухайлбал Гомбосүрэн, Цэрэндорж нараас сургууль байгуулахын ач холбогдол, үйл ажиллагааны талаар удаа дараа Богд

Жибзундамба хутагт болон Гадаад Яаманд өргөх бичиг барьж айлтгаж байжээ. (*Монголын автономит үеийн сургууль*, 1966. х.8-12) Эдгээр санал, санаачилгууд төрөөс сургууль боловсролын хэргийг явуулах үндэслэл болж, улмаар 1912 оны 3 дугаар сарын эхээр сургууль байгуулах тухай Богд Жибзундамба хааны зарлиг гарч дөрвөн аймгийн чуулган дарга, жанжин нарт зарлан мэдэгджээ.

Монголд анхны төрийн, орчин цагийн сургуулийг 1912 оны 3 дугаар сарын 24-д Гадаад яамны байранд Нийслэл Хүрээ, Сэцэн хан, Түшээт хан хоёр аймгаас ирсэн нийт 47 хүүхэдтэйгээр нээжээ. Сургуулийн хэргийг анхлан Дотоод яам хавсран эрхэлж, сайд да лам Г.Цэрэнчимэд сургууль байгуулах үйлст идэвхийлэн оролцож байжээ. (Болдбаатар ба бус, 2020. х.40)

Нийслэл Хүрээ ба олон хошуу, шавийн газар бага, дунд, дээд зэргийн сургуулийн танхим байгуулж, олон хан, ван, гүнгийн хөвгүүд, дүү нараас эхлэн аливаа 10 наснаас дээш 15 наснаас доош ухаан сэргэлэн хөвгүүдийг цөм сургуульд оруулж, тогтоосон дүрэм хэмжээг даган явуулах, олон хошуудын бага сургуулийн хөвгүүдэд тогтоосон тоогүй, хошууны хүн амын байдалд тэнцүүлэн заах, Нийслэл Хүрээний бага, дунд хоёр сургуулийн хөвгүүд бүгд 80 хүн байх бөгөөд энэ тоонд Маймаа хотын сургуулийн танхимд явах хөвгүүдийг оруулан төлөвлөжээ.

Манай судлаачид сэргэн мандсан Монгол Улсын боловсролын хөгжлийн асуудалд анхаарал хандуулж, үнэлж дүгнэсэн байдаг. Тухайлбал, Ш.Бира*, Ш.Шагдар*, Ж.Урангуа*, Н.Хишигт* нарын судалгааны бүтээл, өгүүллүүдийг дурдаж болно. Дээрх бүтээлүүдэд сэргэн мандсан болон автономитын үед тус орны амьдралд гарсан нэгэн чухал шинэ дэвшилт үзэгдэл бол иргэний боловсролыг чухалчлан үзэж орчин үеийн иргэний сургуулийн ажлыг үүсгэн байгуулсныг чухалчлан дүгнэжээ.

Судлаач Б.Пунсалдулам “ХХ зууны монгол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны боловсрол” бүтээлдээ “Бидний хувьд дээрх дүгнэлт, үзэл бодлыг дэмжиж буй боловч, үзэгдэл, онцгой үйл явдлаас илүү түвшинд хүрсэн тодруулбал, нийгмийн бие даасан салбарын хувьд анхны суурь үндсээ тавьсан хэмээн үзжээ.

Академич С.Нарангэрэл Монгол Улс дахь хууль зүйн мэргэжлийн боловсролын орчин цагийн хөгжлийг улс орны тухайн цаг үеийн онцлог нөхцөл байдал, боломж зэргээс шалтгаалан дараах 3 зурвас хэсэгт ангилж болно хэмээгээд,

1. Гадаадад бэлтгэж байсан үе
2. Эрх зүйчдийг эх орондоо бэлтгэж байсан үе
3. Эрх зүйчдийг бэлтгэхэд төрийн болон хувийн хэвшил хослох болсон үе гэж ангилжээ.

Бидний судалгаа хүрээний хувьд энэхүү ангиллын нэгдүгээр үе буюу ХХ зууны эхэн үеийг хамрах юм. Түүнчлэн 1911-1940 он хүртэлх үеийг энэхүү судалгаагаараа тодруулахыг

* Ш.Бира. Монголын автономит засгийн үед төрийн сургуулийн хэргийг хөгжүүлэх талаар авч явуулсан зарим дэвшилт арга хэмжээний тухай. УБ., 1958. т.6

* Ш.Шагдар. Монгол улсын боловсролын түүхэн товчоон. УБ., 2000. х.50

* Ж.Урангуа. ХХ зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919). УБ., х.225-232

* Н.Хишигт. Хаант Монгол улсын төрийн сургууль. Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудал. УБ., 2002. х.141-148

зорилоо. Учир нь, академич С.Нарангэрэлийн судалгааны эхний хоёр үе нь 1940-1992 оныг хамарч байгаа билээ. Иймээс энэхүү судалгааг цаг хугацааны хувьд урагшлуулах зорилго агуулсан болно.

Академич С.Нарангэрэл, **Нэгдүгээр үеийн тухайд** 1940-өөд оны сүүлчээс эхлэн манай улс хуучин ЗХУ болон социалист бусад улсуудын хууль зүйн их, дээд сургуулиудад оюутан илгээж суралцуулж, Монгол Улсын анхны дээд боловсролтой мэргэжлийн эрх зүйчид бэлтгэгдсэн гэж үзжээ.

Хоёрдугаар үеийн хувьд 1950-иад оноос эхлэн тэр үеийн худалдааны техникумын дэргэд нэг жилийн хугацаатай курс байгуулж хичээллүүлж эхэлснээр эрх зүйчдээ эх орондоо бэлтгэх үйлсийн тулгын чулуу тавигдсан юм. Дараа нь энэ курсийн үндэс суурьт тулгуурлан хууль цаазын дунд сургууль байгуулагдаж, түүгээр тулгуурлан тусгай дунд боловсролтой эрх зүйчид бэлтгэгджээ. Тэдгээр нь манай орны хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагын ажил, ачааллын хүндийг нуруундаа үүрч, тэдгээрийн боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх шаардлага нь МУИС-д хууль зүйн анги нээхэд ихээхэн түлхэц өгчээ. Улс орных нь хамгийн том, нэр хүндтэй их сургуульд хуулийн салбар заавал байдаг дэлхий нийтийн жишгийн дагуу чухамхүү МУИС-д хууль зүйн ангийг анх 1960 онд нээсэн түүхтэй хэмээжээ.

Гуравдугаар үеийн хувьд Монгол Улсад хувийн хэвшлийн хууль зүйн их дээд сургуулиар эрх зүйчдийг бэлтгэж эхэлсэн 1992 оноос хойших үеийг хамруулжээ. (С.Нарангэрэл,) Ийнхүү хууль зүйн мэргэжлийн боловсролын хувьд хуульч мэргэжилтнийг бэлтгэснийг түүхэн цаг үеэр хуваасан нь өмнөх үеийн буюу 1911-1940-өөд он хүртэлх хууль, эрх зүйн боловсролыг хэрхэн олгож байсан эсэх судалгаа дутагдалтай байсныг илтгэнэ.

Ийнхүү бид судалгаагаа 1921 оноос 1940 он хүртэлх хугацааны үеийн хууль, эрх зүйн боловсролыг хэрхэн олгож байсанд түлхүү анхаарав.

Үүний тулд холбогдох эрх зүйн баримт бичгүүд, түүх, боловсрол, эрх зүйн салбаруудын судалгааны сүүлийн үеийн үр дүн, түүх архивын сан хөмрөг, дурдатгал, дурсамж, аман түүхийн баримт сэлтэд тулгуурлан гүйцэтгэхийг зорив.

Юуны түрүүн 1921 оны эцсээр цэргийн дарга нарын сургуулийг, 1922 оноос эхлэн багш нарыг бэлтгэх, давтан бэлтгэх курсийг байгуулж түүнийгээ 1924 онд оюутны сургууль, 1928 онд багшийн сургууль болгон өөрчилжээ. Энэ нь тухайн үедээ манай орны томоохон сургуулийн нэг байсан бөгөөд тус улсад тусгай мэргэжлийн дунд боловсролыг хөгжүүлэх эх үүсвэр болов. (Жамьянжав, 1987)

Дээрх үйл явдлыг баримтаар тодруулан авч үзье.

Ардын Засгийн Дотоод Явдлын яамнаас Ардын Засгийн зэрэг долоон газрын нэр бүхий сайд түшмэл дарга нарт хуудсаар илгээсэн сургуулийн хэлтсийн бичигт:

“Байцааваас ноднин жил арван сарын хорин найман бөгөөд европын арван хоёр сарын арван зургааны (энэ нь 1922 оны 12 сарын 16) өдөр Засгийн газрын зэрэг хэдэн газрын төлөөлөгчдийг урин ирүүлж хэлэлцсэн нь: Бидний монголчууд бага насны хүүхдийн бага, дунд сургууль нээн байгуулж бүхий боловч долоо, найман жилээс нааш тэдгээрийн тус илэрч чадах үгүй тул даруй бичиг үсэгт боловсронгуй хүмүүсийг хуралдуулан авч, элдэв ухааны сургууль нээн байгуулж, сурган боловсруулбаас улсын тулгуур хэрэгт тустай болмой хэмээсэн учир эл хэрэгсэх зүйлийг төсөвлөн, зохих газраа өгөхөөр явуулсан бөлгөө.

Одоо энэ сургуулийн хэргийг завдан шийтгэхүүд урьдаар хэлэлцэн тогтвоос зохих зүйл зургааг сүүлээр томруун бичиж Эрхэм сайд түшмэл дарга гишүүн танд явуулан, толилон үзэж, энэ цагаан сарын гучин бөгөөд европын гурван сарын арван долооны өдрийн арван цагт дунд сургуулийн газраа нэгэн дэсээр морилон ирцгээж уг хэргийг хэлэлцэн тогтвоос болох ажааму хэмээн урин ирүүлэх сайд түшмэлүүдийн нэрсийг сүүлд бичсүгэй хэмээмүй хэмээн өргөжээ.”

Үүний тул илгээв.

Арван гуравдугаар он, цагаан сарын хорин есөн, европын гурван сарын арван зургаан (1923 он, 3 сарын 16)

Тус сургуульд хэлэлцэх зүйл нь:

1. Заан сургах зүйлүүдийг тогтоон батлах, анги салааг тодорхойлох
2. Эрдэмтэн багш нарыг сонгож урих
3. Мөн сургуулийн дүрмийн үндсэн зүйлийг төлөвлөн тогтоох
4. Сурган боловсруулах хүмүүсийг томилон ирүүлэх
5. Орон байшинг олж нийлүүлэх
6. Ямар газруудаас хичнээн тусламж үзүүлбэл зохих (МУҮТА, ТБА, Х.4, Д.1, ХН.651, х.33-34)

Ийнхүү архивын баримтад зааснаар элдэв ухааны сургуулийг нээн байгуулахын тулд дээрх зургаан зүйлийг хэлэлцсэн байна. Ийнхүү оюутны сургууль хэмээн нэрлэгдсэн сургууль байгуулагдсан нь архивын баримтад тэмдэглэгдэн үлджээ. Тус баримтад зааснаар,

“Ардын эрхтэй хэмжээт засаг байгуулагдсанаас хойш сургууль хэрхэн дэлгэрсний учрыг тодорхойлж өргөх дэвтэрт “Гадаад, дотоодын байдал төлөв үзвээс зохих олон улсын сургуульд заадаг бичиг эрдмийн ерөнхий зүйлүүдийг заан таниулж, олон ард ба бага насны хөвгүүдэд нэвтрүүлэн, сургуульд бэлтгэхийг хүсэж, арван гуравдугаар онд Оюутны сургууль байгуулахаар төлөвлөснийг Засгийн газраас энэ он, хоёр сарын шинийн долоон, европын гурван сарын хорин дөрвөн (1923 оны 3 дугаар сарын 24) 135 дугаар хуудсаар зөвшөөрчээ. Үүнд Дотоод явдлын яамнаас аймаг, шавь таван газраас бичиг үсэгт боловсронгуй хүмүүс гучийг дуудаж, хорин хүмүүнийг ардын нам ба сурган боловруулах хэлтэс, худалдаа хоршооноос томилж, дөрвөн сарын нэгнээ (1923 оны 4 дүгээр сарын 16) сургууль нээхээр төлөвлөөд, орон байшинг олж бэлтгэх ба боловсорсон багш хоёр хүмүүнийг Оюутны сургуулийн жинхэнэ сургагчид урин ирүүлэх, эл сургуульд заах зүйлүүдийг тодорхойлон, дүрэм зохиох зэргээр оролдож буй. Эдгээр нээн байгуулсан олон сургуульд үзүүлэн заах бичиг судар зохион хэвлүүлж тараан үзүүлэх нь маш чухал. Манай Монголын урьдын эрдэмтэн мэргэдийн зохиосон сургуульд зааваас зохих бичиг судар олон боловч тэдгээрийг хэвлэх хороо манай улсад ганцхан төдий болох тул хэвлэж огт завдах үгүйд хүрчээ.”(МУҮТА, ТБА, Х.4, Д.1, ХН.645, х.7)

Ийнхүү Оюутны сургууль (архивын баримтад “Оюутны сургууль” хэмээн бичсэн бөгөөд зарим ном бүтээлд 4 сарын хугацаатай хичээллэснийг үндэслэн “Оюутны түр сургууль” хэмээн нэрлэсэн нь бий) нь билгийн тооллоор 1923 оны 4 сарын 12-оос 1923 оны 8 сарын 12 хүртэл 4 сар хичээллэж дуусаад, сурагчдаас шалгалт авч, тэнцсэнийг нь хот, хөдөөгийн бага

сургуулийн дарга сургагч (захирал), сургагч (багш)-д тус тус тохоон томилсон байна. (Дэлгэрсайхан, 2022. х.114)

Оюутны сургуулийн анхны төгсөгч Монгол Улсын гавьяат багш Л.Жүрмэд дуртгалдаа: “...1923 оны 4-р сараас эхлэн эрэгтэй, эмэгтэй, лам хар гэх ялгаваргүй цөм бичиг үсгийн боловсрол бүхий идэр залуу 40-өөд сурагчидтайгаар сургууль маань нээгдэж хичээллээд, 2 сар болсны дараа **багшийн анги, дансны ба нягтлан бодохын анги** хэмээн хоёр хэсэг болон хуваагдсан юм. Багш нарыг дурдвал, одоогийн Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат, хуучин манж, монгол бичгийн эрдэмтэн Магсар, Зөвлөлт Холбоот Улсын Буриад Монголын эрдэмтэн Цэвээн Жамсрандорж, Ишдорж, Эрдэнэбатхан нар байсан юм.” (Лхаасүрэнгийн Жүрмэд багшийн дуртгал гар бичмэл, 1973. х.2)

Бид архивын баримтаас 1923 оны Оюутны сургуулийн сургалтын төлөвлөгөө, агуулга буюу “Оюутны сургуульд заан сургах зүйлийн дүрэм” (МУҮТА, УТНОНББА, Х.4, Д.2, ХН.33, х.1-4)-ийг үзэхэд дүрмийн төгсгөлд “Олноо өргөгдсөний арван гуравдугаар он, арван сарын хорин хоёр, европын арван нэгэн сарын гучин” (1923 оны 11 сарын 30) хэмээсэн байна.

Монгол Улсын дээд зэргийн Оюутны сургуульд заан сургах зүйлүүдийг жагсаан бичсэн нь, Нэгдүгээр бүлэг 6 сар буюу 720 цаг заан сургах ерөнхий зүйлүүд нь:

1. Монгол хэл бичиг (Элдэв бичиг шаштирын утгыг тайлбарлан үзэх, үсгийн үндсэн хувь ба утга, мөн үсгийг хувьсган хэрэглэх ёс, үсэг найруулж, утга болгохын дүрэм, тогтсон дүрмийн ёсоор үсэг утгыг бичих сургах арга, эх зохиох, Монгол бичгийн эрдэм хэрхэн дэлгэрсээр ирсэн түүх)
2. Тооны ухаан (Бүхэл ба бутархай тоо бодлого, үнэн тоо ба хийсвэр тоо, монгол орос хятадын аливаа хэмжээ бас олон улсын метр хэмээх хэмжээнүүдийг үзүүлэн таниулж хэрэглүүлж сургах, геометр хэмээх хэмжихүйн ухаан)
3. Түмэн бодисыг шинжлэх нь (Хүмүүний биеийн эрхтэн ба мах ясыг шинжлэн үзэх бас мөнхүү бие бялдрын байдал дүрсийг үзэх, ургамал ба адгуусан амьтны аймаг бас амь үгүй бодисын байдал, амьд бодисын уг гарлын түүх, физик ба хими хэмээх амь үгүй бодисын аймгийн ёсны шинжлэл)
4. Дэлхийн байдал (Газар усны ерөнхий байдал, Олон улсын байдал, Сав ертөнцийн байдал төлөв (балын харандаагаар “сав” гэдгийг дарж, хажууд нь гараар “олон” гэж бичжээ))
5. Хүмүүн төрөлхтөн эрт урьдаас нааш хэрхэн боловсорсоор ирсэн товч түүх
6. Монгол угсаатан эртний цагаас нааш хэрхэн боловсорсоор ирсэн түүх
7. Монгол Улсын түүхийн дэлгэрэнгүй оршил
8. Монгол Улсын түүх
9. Олон улсын хуучин ба дунд шинэ үесийн товч түүх
10. Улсын эрх ба ардын нам эвлэлийн түүх
11. Монгол Ардын Засгийн газрын эдийн засгийн үндсэн бодлого гэх судалжээ.

4 сар буюу 480 цагт заах тусгай зүйлүүд нь:

Дэс дараалсан тоо	Заах зүйлүүдийн нэр	7 хоног бүр заах цагийн тоо	Сард заах цагийн тоо	6 сард заах цагийн тоо	10 сард заах цагийн тоо
	Нутгийн захиргаа ба харилцан туслах хоршооны анги				
	1. Монгол Улсын Үндсэн ба ардын засгийн газраас тогтоон зарласан чухал холбогдолтой хууль дүрмийн учир утгыг тайлбарлан хэлэх	6	24	96	
	2. Монгол Улсын нутгийн захиргаа түүний явуулбаас зохих хэргүүд	3	12	48	
	3. Харилцан туслалцах хоршоо	9	36	144	
	4. Нутгийн захиргаа бөгөөд харилцан туслах хоршооны нягтлан ба тайлан бодох хийгээд аливаа юмын үнэ тоо авах арга	12	48	192	
	Бүгд		720 цаг		

Нутгийн захиргааны ангид Монгол Улсын Үндсэн хууль ба бусад ардын засгийн газраас тогтоон зарласан чухал холбогдолтой хууль дүрмийн учрыг тайлбарлан хэлдэг хичээл долоо хоногт 6 цаг, сард 24 цаг, 4 сард 96 цагаар зааж тухайн цаг үед хууль цаазны боловсролыг олгож байсан байна.

Монгол Улсын Үндэсний Төв Архивын сан хөмрөгт хадгалагдаж буй 1924 оны “Дунд ба Оюутны сургуульд орохыг хүссэн хүүхдийн нэр зэргийг тодорхойлсон данс нь” (МУУТА, ТБА, X.6, Д.1, ХН.18, х.1-4) баримт бичигт Хан Хэнтий уулын аймаг, Баян түмэн Хан уулын хошуу, Өндөр Хан уулын хошууны бага сургуулийн 25 сурагчийг нэр, нас, эцэг, эхийн нэр, аль хошуу, хичээлийн оролдлого, зан байдал, аль зэрэг шалгагдсан байдлаар нь тодорхойлжээ. Ийнхүү бага сургуулийг төгссөн сурагчдыг өөрийнх нь нэр, нас, эцэг, эхийн нэр, аль хошууны болохыг тодорхойлон бичихийн зэрэгцээ “хичээл оролдлого, зан байдал, аль зэрэг шалгагдсан” гэсэн 3 шалгуураар үнэлж дүгнэжээ. (Дэлгэрсайхан, 2022. х.146) Эдгээр үнэлгээний дагуу оюутны сургуульдаа элсүүлдэг байсан байна.

15 (1925) оны 8 дугаар сарын 28-ны Бүх Монгол Улсын олон сургуулийн дарга, багш нарын хоёрдугаар хурлын тогтоолд зааснаар, бүх монгол улсын олон сургуулийн дарга багш нарын хоёрдугаар хурлын тогтоолд дурдсанаар энэ жил Оюутны сургуульд 60 хүнийг зарлан хуралдуулж, сургуулийг үйлдүүлэхээр багш нар ба хууль цаазны зүйлд боловсруулахыг гол болгох бөгөөд хойшид жил бүр 200 хүнийг нэмж оруулах бодолтой байна гээд манай Монгол угаас европ ёсны эрдмийг сурсан багш цөөхөн тул оюутан, дунд сургуулийн 5-6 хүнийг Буриад Монголоос урьж ирүүлсэн. Одоо сургагч багш нар 20-оос Оюутны Багшийн сургууль төгсгөсөн нь 16 байна хэмээжээ. (Дэлгэрсайхан, 2022. х.149)

Оюутны сургуулийн сургагч багш нарын хуралдааны 1-р хурлын тогтоолын нэгдүгээр зүйлд, АГЯ-аас тушаасан ёсоор 16-р (1926) онд Оюутны сургуульд 40 хүнийг нэмж аваад сургаж боловсруулсугай хэмээснийг хэлэлцээд одоо хянаваас:

1-д. Орон байшин багталцахгүй. 2-д. Багш нар хүрэлцэхгүй тул даруй 40 хүнийг нэмж өгөхийг энэ оны намар цаг хүртэл түр түтгэлзэнэ. Тоосгоор байшин барьж амжихгүй бол тухайн үед эсгий гэр барьж гүйцэтгэнэ гэж хэлэлцэн тогтжээ. Харин долоодугаар зүйлээр, Оюутны сургуулийн дэргэд байгуулах бага насны бичээч түшмэлийн түр сургуульд заах зүйлүүдэд, Монгол Улсын хэв журам, Монгол Улсын түүх, эдийн засгийн бодлого эдгээр гурав болох ба эдгээрийг Цэвээнээр нэг хоёр сар өнгөрсөн хойно заалгана гэж хэлэлцэн тогтжээ. Хуралдсан багш нар Цэвээн, Батхан, Абашеев, Канаев, Ишдорж, Дашням, захирал Абашеев (Дэлгэрсайхан, 2022. х.150) нар байна.

Академич Ш.Лувсанвандан гуай дурдатгалдаа. Намайг дунд сургуульд сурч байсан 1927-1928 оны үед буюу одоогоос 45 жилийн өмнө Монгол Улсад орчин цагийн дээд сургуультай хүн гэвэл оросын дээд сургуультай Цэвээн Жамсранов, Баярт Вампилов, Даш Сампилов, японы дээд сургуультай Нүннээжав гэж хэлэлцдэг байж билээ. Манай дунд сургуулийн бусад багш нараас Дашеев Цэвэгжав, Будадарь хоёрыг оросын дунд сургуультай, Хажид Бадрах, Дууран аа, Соёлтой гурвыг хятадын дунд сургуультай гэдэг байсан.

Тэр үеийн дунд сургуулийн багш нар дотор харь хэл мэддэг хүн олон байв. Жишээлбэл, Будадарь орос, англи, герман хэлтэй, Нүннээжав япон, хятад, англи хэлтэй, Цэвэгжав орос хэлтэй, Бадрах, Соёлтой, Дууран-аа гурав хятад хэлтэй, Бат-Очир, Авирмэд хоёр манж хэлтэй гэдэг байсан” (Базар, Гомбосүрэн, 1973. х.37-38)

Энд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд тухайн үед боловсон хүчин дутмаг байсан болохоор эдгээр багш нар нь анхны дунд сургуулиас гадна Оюутны сургууль, Бүх цэргийн ерөнхий сургууль, Намын төв сургууль, Хоршооны сургуульд багшлахаас гадна Судар бичгийн хүрээлэн, Ардын цэнгэлдэх хүрээлэн гээд улс орны аль л хэрэгцээ шаардлагатай газруудад давхар давхар ажиллаж байсныг түүхэн баримт эх сурвалжууд нотолдог билээ. (Дэлгэрсайхан, 2022. х.162)

Улсын анхдугаар Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, Засгийн газраас шүүх таслах албаны боловсон хүчин бэлтгэх, тэдний ажлын дадлага туршлагыг дээшлүүлэх анхны арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ. 1926 оны сүүлээр Ардыг гэгээрүүлэх яамтай хамтарч оюутаны сургуулийн төсөв тоонд багтаан 20 хүнийг томилон 6 сарын хугацаагаар Цааз хуулийн түр сургуулийг нээн байгуулж хичээллэжээ. 1928 оны эцсээр мөн сургуулийн дэргэд 30 хүнийг мөн хугацаагаар сургах хэмээсэн авч, 6 хүн суралцжээ. 1929 оноос эхлэн 4 удаа хууль, цаазын түр сургуулийг байгуулж, төгсгөсөн хүн 68, үүнээс эрэгтэй 60, эмэгтэй 8, намын гишүүн 43, эвлэлийн гишүүн 25 байжээ. (МУҮТА, ТБА, Х.284, Д.1, ХН.655)

1928 оны аравдугаар сарын 23-аас арван хоёрдугаар сарын 11-ий хооронд хуралдсан МАХН-ын долоодугаар их хурлын товч тогтоолын дөрөвдүгээр бүлгийн “Шүүх таслах хэрэг” гэсэн хэргийн 18-д “Шүүх таслах хэргийг жинхэнэ хувьсгалын бодлого ба ардын ёсонд нийлүүлж явуулах ба төв ба орон нутгийн шүүх таслах хэргийг эрхлэгчдэд хувьсгалын бодлоготой танилцан ардын этгээдээс бүрнээ оруулах хийгээд нэгэнтээ эл хэрэгт танилцуулах боловсруулах тухай түр хуралдаан ба сургуулийг төв газарт байгуулбал зохино” (МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд, 1-р боть, 1920-1928 он, 1981, х.422) гэснийг үндэслэж, 1928 оны эцэст 1929 оны эхээр хуралдсан Улсын тавдугаар Их хурлын тогтоолд “Цааз хуулийг таниулан боловсруулах дамжаа болон сургууль байгуулах”-ыг заасан байна.

Шүүхийн байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор 1930-1932 онд хууль цаазны түр курсийг 3 удаа байгуулан 70 суралцагч төгсжээ. 1933 онд орон нутгийн шүүхүүдийн дэргэд хууль цаазны бүлгэмүүдийг нээн ажиллуулжээ. Цаг үеийн нөхцөл байдал, санхүүгийн боломжоос шалтгаалсны сацуу багшийн хүрэлцээ, хүмүүсийн сурах хүсэл зэргээс хамааран хуулийн байгууллагад ажиллах боловсон хүчнийг богино хугацааны түр курс (дамжаа)-ээр сургаж аргацаасаар 1940-өөд онтой золгожээ.

1926 онд Ардын гэгээрлийн яамны сургуулийн хэлтсээс Монгол Ард Улсын Шүүх явдлын яаманд илгээсэн баримтад дурдсанаар “... Ноднин жил манай яамнаас оюутны сургуулийн хүмүүсийг 60 болгож нэмэгдүүлэн байгуулахад олон аймаг хошуунаас заалгах бичиг үсэг боловсронгуй хүмүүсийг хуралдуулан 2 жилийн хугацаагаар сургах бага сургуулийн багш нарыг яаран бэлтгэсүгэй хэмээн зарлан тушаасан боловч олон харьяа газраас томилогдон ирэх хүмүүс их төлөв бичиг үсэгт сайнгүй унших ба муухан бичих төдий хүмүүс ирэхээр үл барам, харин ч тэнцэх хүн үгүй хэмээн хөгшин, эмгэг өвчин бүхий бичиг үсэг ухааж мэдэхгүйг ирүүлэх зэргээр үл бүтэхийг үзвээс, аливаа олон газруудад тийнхүү нас залуу идэр бичиг үсэгт боловсон хүн маш ховор ямагт хүрэлцэхгүй доор бүр албан давхацсанд ийм болсон байдал төрх илэрхий бөгөөд хөдөөгөөс ирсэн сургуулийн хүмүүсийн зарим нь сургууль завсарлах чөлөөнд нутагт буцаж өвчин эмгэг учир шалтгаан тохиолдсоныг харьяат газраас тодорхойлон ирэх, зарим нь байшин чийг, газар ус зохилдохгүй гэх зэргээр чөлөө, зарим нь зүй бус хэрэг өдүүлэх зэргийн төвөгтэй учир уламжлан бүхий нь угаас боловсон бус тул шинэ олон ухааныг сургах нь удаан бөгөөд дэв дув боловсон хүн болж гарах нь хэрхэвч нэгэн хэдэн сар дотор болохгүй бөгөөд одоо энэхүү оюутны сургуулиас энэ 16-р онд 2 жилийн хугацаагаа гүйцвээс тус сургуулийг төгсгөх 10 хэдэн хүн байх нь” хэмээн тоочсоноос үзэхэд янз бүрийн шалтаг, шалтгааны улмаас 60 элсэгчээс 2 жилийн дараа арван хэдхэн хүн л төгсөж байсан байна. Цааш үргэлжлүүлэн тус баримтад дурдахдаа “ Шалгаран гаргах авах тухайд мөн энэ жил намраас эхлэн шинэ нэмж байгуулахаар баталсан 10 илүү жинхэнэ бага сургуулийн тэнхимийн сургагч болгох ба бусад нь шалгарч гарах аваас мөн л 17р оноос эхлэн нэмэгдэх танхимын багш болгоход бэлтгэхээс гадна басч шинэ боловсролын олон ухааныг манай монголд заах боловсон багш нар үгүй гадаадаас эрдэмтэн хүмүүс олныг урин ирүүлэхэд чирэгдэл үлэмжхэн болохын дээр монгол хэл бичиг мэдэх хүн олдохгүй завсарт хэлмэрч туслах хүмүүс хэрэгтэй болох зэргийн явдал бүхий нь нэн бэрх болох тул энэ удаа УБ хотноо алба хааж буй гадаад дотоодын хүмүүсээс аль болох тэнцэх чадахуйц хүмүүсээс сонгон ээлж буюу цагаар заалгаж аргацаан дараа буй орон байшин, сав хэрэглэлийг хүчин төгөлдөр болгон сан зузаарах зэргийг харгалзан тохирох эрдэмтэнийг урин ирүүлж олон хүмүүсийг заалгаж сургуулилан явуулбаас дараа дараагаар боловсон хүмүүсийг үргэлжлүүлэн гаргаж болох мэт боловч энэхүү сургуулийг оюутны сургуульд хавсаргах ба нийлэн байгуулах явдлыг цөм улсын их хурлаар тогтоосон болохын дээр эдүгээ даруй хэрэглэгдэх хүмүүсийг бэлтгэх нь чухал бөгөөд маш яаравчилбаас зохих. Үүнд хэргийн дэв дувыг бодож энэ жил оюутны сургуульд нэмэн авах дөчин хүнд суух ба сургуульд үйлтгэх ихээхэн эсгий гэр хэд хэдийг гэрэл түши хэрэглэлтэй тусгай төсөвлөн худалдан авч бэлтгэн олон яамны идэр залуу бичээч нараас томилон авч оюутны сургуульд хавсарган оруулж, нэгэн жилийн хугацаанд боловсруулах буюу эсвэл хот хөдөөгийн олон бага сургуулийг энэ жил төгсөх ба нас хэтэрсэн хүүхдийг оруулж уг 40 тоонд хүргэн 2-3 жил хүртэл заан сургахад энэ жил намар цагаас эхлэн хууль цааз ба орон нутгийн захиргааны явдлыг тус бүр 20-оод хүмүүсийг ангилан сурган зааж гаргаваас болох мэт боловч зүй нь

урьдаар лавлан тогтоолговоос зохихын тулд үүнийг МАУ-ын засгийн газар өргөн явуулаад байцаан тогтоон шийтгэж ирүүлэх ажамуй. Үүний учир нэгэн зэрэг МАУ-ын Дотоод, Шүүх яам, МАХН-ын төв хорооноо мэдэгдэн явуулсугай, үүний тул илгээв.16.2.25” (МУУТА, ТБА, Х.284, Д.1, ХН.264, х.3) гэжээ. Дээрх баримтаас харахад, шинээр төгсөгчдийг шууд багш болгохын сацуу нэмэн бэлдэх хэрэгцээ их, түүнчлэн гадаадаас эрдэмтэн урихад зардал, сүйтгэл ихтэй тул дотоодын нөөц бололцоогоо сайн ашиглахаар шийдвэрлэсэн байна.

Энэ байдал цаашид ч нэлээд хугацаагаар үргэлжилсэн байдаг юм. Тухайлбал, 1941 онд Шүүх явдлын яам, Улсын прокурорын дэргэд хууль цаазын түр курсийг нээж, түүнийг төгссөн 17 хүнээс 2 хүнийг шүүхийн даргаар, 15 хүнийг шүүхийн орлогчоор томилсон байна. Мөн Нам ба улсын төв сургуулийн хууль цаазын ангид суралцаж төгссөн хүмүүсийг ч ажилд томилсон байна. (Бадарчи ба бус, 2007, х.142) Ер нь тэр үеийн шүүх явдлын яам, шүүх таслах газруудад ажиллаж байсан хүмүүсийн ихэнх нь мэргэжил, боловсролын хувьд ямар хүмүүс байсан нь дараах баримтаас тодорхой харагдана. Энэ тухай: “Боловсон хүчний хувьд 1948 онд конторны ажилтан нар Шүүх яаманд 12, Дээд шүүхэд 13, аймгийн шүүхүүдэд 83, ангийн шүүхүүдэд 17, бүгд 242 хүн ажилласан байна. Эдгээрийн дотор бага боловсролтой 14, дунд боловсролтой 25, дээд боловсролтой 6, хуулийн мэргэжлийн курс хийсэн 33, огт боловсролгүй практикаар ажиллаж байгаа 30 хүн байна. Урьд Алма-Атад 2 хүн сурч төгссөн, одоо эрэгтэй 2, эмэгтэй 1 хүн гадаадад сурч байгаа гэсэн мэдээлэл байна” гэж зарим судлаач тэмдэглэсэн байна. (Бадарчи нар, 2007, х.150)

Шүүх явдлын яамнаас 1948 онд Шинэ хүчний дээд сургуулийн дэргэд 3 дугаар сарын 1-ээс 6 дугаар сарын 25 хүртэл 4 сарын хугацаатай хуулийн түр курс нээж, тус яамнаас 13 хүнийг сургажээ. Эдгээрээс шүүхийн даргаар 2, зааварлагчаар 3, шүүхийн орлогчоор 7, нарийн бичгийн даргаар 1 хүнийг тус тус томилсон байна. Ийм байдлаар хууль зүйн албаны байгууллагын ажилтнуудын мэргэжил, дадлагыг дээшлүүлэх ажлыг жил жилд тодорхой хэмжээгээр ахиулсаар байсан боловч байнгын ажиллагаатай сургууль байгуулж, хуульч мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх шаардлага зүй ёсоор тавигдаж иржээ. Тиймээс Сайд нарын Зөвлөлийн 1950 оны “Шүүх, прокурорын ажилтныг бэлтгэх хууль цаазны сургуулийг байгуулах тухай” 124 дүгээр тогтоолоор байнгын ажиллагаатай хуулийн мэргэжлийн сургууль байгуулагдах үндэс суурь нь тавигдсан юм. (Хууль, дүрэм, тогтоолын эмхэтгэл, 1950, №1, х.131) Уг тогтоолоор тухайн сургуульд суралцах хугацаа, хамрагдах хүний тоо, цалингийн хэмжээ, байрлах газрыг нэг бүрчлэн зааж, тогтоож өгсөн байдаг. Тухайлбал, тогтоолын 1-д “Шүүх, прокурорын мэргэжилтэй шинэ хүчнийг бэлтгэхийн тулд нэгэн жилийн хугацаатай байнга ажиллах Хууль цаазны сургууль байгуулахыг Улсын прокурор, Шүүх яаманд зөвшөөрсүгэй”, 2-т “Хууль цаазны сургуульд шүүх, прокурорын практиктай ажилтны дотроос элсүүлэн суралцуулах сурагчдын тоог 30 хүнээр тогтоож, тэдний цалинг тус сургуульд суралцаж буй хугацаанд урьд ажиллаж байсан газраар нь хэвээр олгож байсугай” гэж тус тус заасан байдаг. Түүнээс гадна хууль цаазны сургуулийн 1950 оны зардалд хэрэглэгдэх 101100 төгрөгийг улсын төсвөөр энэ зүйлд зориулагдсан хөрөнгөнөөс гаргаж санхүүжүүлэх, уг сургуулийг Худалдааны техникумын байранд байгуулж, түүний сурагчдын ахуй байдлын хэрэгцээг мөнхүү техникумын захиргаанаас хангаж байхыг зохицуулжээ. Мөн Хууль цаазны сургуулийн ажиллагааг удирдах ба хариуцах явдлыг Шүүх

яамны сайд Н.Дамбадаржаад үүрэг болгож, түүнд уг сургуулийн санхүүжүүлэхээр олгосон хөрөнгийг барьж байх эрхийг олгосон байна.

Шүүх яамнаас МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоонд тавих “Шүүх яамнаас 1951 онд хийж гүйцэтгэсэн ажлын тухай” илтгэлдээ: “Нэгдүгээрт тус улсын доторх бүх шүүх таслах байгууллагуудыг зохион байгуулах ба тодорхой удирдаж тэдний ажиллагааг одоогийн шаардлагад зориулж сайжруулах, хоёрдугаарт шүүхийн боловсон хүчнийг бэлтгэн төрүүлэх ба ажиллаж байгаа хүний онолын ба ерөнхий боловсролын хэмжээг нэмэгдүүлэх, гуравдугаарт элдэв төрлийн гэмт хэргийг яллан шийтгэх, хувьсгалт хуулийн улс төрийн бодлогыг ёсчлон биелүүлж, ард иргэдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, дөрөвдүгээрт шүүхийн тогтоол шийдвэрийг зөв бөгөөд хөнгөн гавшгай биелүүлэх үндсэн зорилтуудыг өөрийн тодорхой зорилго болгож байна.” (ҮТА, Ф-284, Т.1, ХН.850) гэж тэмдэглэсэн байна. Энд онцлон тэмдэглэсэнээр хууль зүйн албаны байгууллагуудад ажиллах хуульч мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчин сургаж бэлтгэх явдал Шүүх яамны үндсэн зорилгын нэг даруй мөн билээ. (Цэвээн, Б., Удвал. 2011, х114)

Шүүгчийн мэдлэг мэргэжил, ажлын дадлага чадварыг дээшлүүлэх, шинээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх чиглэлээр байгуулагдсан тус сургуулийн ажлыг сайжруулахын тулд шалган зааварлах, захирлын илтгэлийг сонгож хэлэлцэх зэргээр Шүүх яам анхаарч иржээ. Тухайлбал, Шүүх яамны сайдын 1952 оны 54-р тушаалаар тус яамны дэргэдэх Хууль цаазны курсийн ажиллагааны тухай захирал Н.Доржсүрэнгийн илтгэлийг коллежийн хурлаар авч хэлэлцэн тогтоолын баталж, оршиж байгаа дутагдалыг заан нэрлэж, цаашид хэрхэн ажиллах талаар үүрэг өгсөн байна. Уг тушаалд багш нар хичээл таслах, бэлтгэл муутай хичээлд орох, хичээлийн хуваарь, программаа баримтлахгүй байх, захиргаанаас багш, сурагчдын сахилга батын асуудалд муу анхаардаг, яамны шинэ хүчний эрхлэгчээс курсийн ажилд тодорхой ордоггүй ба гүйцэтгэлийн хяналт шалгалт муу хийж байсныг тэмдэглэж, цаашид тэдгээрийг засаж залруулах, хичээлийг 9 дүгээр сарын 1-ээс эхлүүлж, 6 дугаар сарын 20-д дуусгаж байх, 1952-1953 оны хичээлийн жилд практиктай бөгөөд чадвар, найдвар бүхий хүмүүсийг сонгон олж 8 дугаар сарын 1-ий дотор бэлтгэх үүрэг өгсөн байна. (Цэвээн, Б., Удвал. 2011, х115)

Шүүх яамны 1952 оны ажлын байдал ба 1953 оны зорилтын тухай илтгэлд Монгол Улсын Их сургуулийн дэргэд 20 хүнтэй Хууль цаазын факультет байгуулах талаар бодлого тавихыг, МАХН-ы Төв Хорооны Улс төрийн Товчоонд Шүүх яамны ажлын тухай тавих илтгэлд ЗХУ-ын Хууль цаазын дээд сургуульд 3-аас доошгүй хүнийг жил тутам явуулж, одоогийн курсийн орон тоог 50 хүн болгож хууль цаазын мэргэжилтнүүдийг төрүүлэх талаар авч үзэхийг (ҮТА, Ф-284, Т№1, ХН№862) тус тус дээд байгууллагад хүсэлт болгон тавьсан байдаг. Энэ мэтээр Хууль цаазны сургуулийг цаашид улам бэхжүүлэх, суралцагчдын ахуй хангамжийг сайжруулах асуудлыг Шүүх яам удирдах байгууллагад тавьж, тэр ёсоор төр, засгаас холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирсэн байна. Жишээ нь Сайд нарын Зөвлөлийн 1952 оны “Шүүх яамны харьяа Хууль цаазны сургуулийн сурагчдын цалинг тогтоох тухай 459 дүгээр тогтоолоор аймаг, хотын прокурорууд ба аймаг, хотын шүүхийн дарга нарт сар тутам 350 төгрөгийн, бусад сурагчдад сар тутам 250 төгрөгийн цалинг 1953.01.01-ээс эхлэн олгохоор болжээ. Мөн түүнчлэн Хууль цаазны сургуулийн сурагчдад цалин тогтоосон явдалтай холбогдуулж, мөнхүү сурагчдын хоолны үнийг тэдний цалингаас гаргуулж байхаар зохицуулжээ. (Цэвээн, Б., Удвал. 2011, х115)

МАХН-ын Төв хороонд 1954 оны 9 дүгээр сард хүргүүлсэн “БНМАУ-ын Шүүх яамнаам МАХН-ын 11 дүгээр их хурлаас хойш хийсэн ажил ба түүний цаашдын зорилтын тухай” илтгэлд: “Одоогийн хууль цаазны нэг жилийн курсыг 1956 оноос эхлэн 2 жилийн хугацаатай сургууль болгож өгөх, ЗХУ-ын Хууль цаазны дээд сургуульд жил бүр 5-аас доошгүй хүнийг явуулан суралцуулах, ЗХУ-д Хууль цаазны аспирантурт нэгээс доошгүй үндэстний мэргэжилтнийг 1955 оноос хэтрүүлэхгүйгээр явуулж өгөх” хүсэлт тус тус тавьсан байна.

Дүгнэлт

1924 оноос Багшийн сургуульд багш нараас гадна мөн нягтан бодогч, гааль түүнчлэн хууль цаазны мэргэжилтэн бэлтгэх нэг жилийн хугацаатай оюутны сургууль болгон өргөтгөж анги нээсэн байна. Ийнхүү хууль зүйн мэргэжлийн боловсролын эхлэл бусад мэргэжлийн нэгэн адил шинэ хүчин бэлтгэснээр эхэлсэн билээ. Үүний зэрэгцээ хууль зүйн боловсролыг уламжлалт түшмэлийн дэг сургуульд үндэслэн “Тэрээр суралцах хууль цаазын сургууль”, “Шинэ хүчний дээд сургууль”, “Хууль цаазын дунд сургууль” гэх шат дараалалтайгаар өнөө цагийн хуульчид бэлтгэгдсэнийг судлаачид мэдэх билээ.

Энэ үед эрх зүйн шинэтгэлийн нэг хэсэг буюу хууль зүйн эрдэм шинжилгээний ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх анхны эхлэл мөн тавигдсан юм.

Тухайлбал, 1924 оны 3 дугаар сарын 24-д Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд нэр томьёоны арван салбар комисс байгуулагдсаны нэг нь цааз хуулийн комисс бөгөөд даргаар нь Э.Д.Ринчино, гишүүдээр нь Дугаржав, Цэрэндорж, Найдансүрэн нарыг томилсон байна. Иймээс цаашид энэ салбар комисс хэрхэн ажилласан талаарх судалгааг хийвэл зохистой юм.

Эрх зүйн боловсрол нь ерөнхийдөө онолын болон практикийн хэд хэдэн зорилготой байдаг билээ. Бүх зорилгоо нэгэн зэрэг хэрэгжүүлэх боломжгүй тул Монгол Улсад ХХ зууны эхэн үеэс зөвхөн практикийн зорилгыг хэрэгжүүлж эрх зүйн боловсролын суурь тавигдсан гэж дүгнэж байна. Түүнчлэн эрх зүйн боловсролыг олгох зорилгод тухайн цаг үе, түүхэн нөхцөл, багшлах боловсон хүчин, төсөв, зардал, хүмүүсийн хүсэл зорилго хүртэл хамааралтай буйг дурдах нь зүйтэй.

Уламжлал ёсоор эрх зүйн боловсролын түүх нь аливаа боловсролтой хуульчийн сургалтын салшгүй хэсэг бөгөөд эрх зүйн түүхийн судалгаанд багтаадаг. Гэхдээ салбар эрх зүй бүрийн хувьд судлаачид, багш нар өөрийн салбар эрх зүйн хувьсал, өөрчлөлт, түүхийг судлах, мэдэх шаардлага тавигдаж, сэдвийн хүрээнд заагдаж байгаа билээ.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

МУУТА, ТБА, Х.4, Д.1, ХН.651, х.33-34

МУУТА, ТБА, Х.4, Д.1, ХН.645, х.7

МУУТА, УТНОНББА, Х.4, Д.2, ХН.33, х.1-4

МУУТА, ТБА, Х.6, Д.1, ХН.18, х.1-4

МУУТА, ТБА, Х.284, Д.1, ХН. 850.

МУУТА, ТБА, Х.284, Д.1, ХН. 862,

МУУТА, ТБА, Х.284, Д.1, ХН.264, х.3

МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд, 1-р боть, 1920-1928 он, Улаанбаатар хот, 1981 он.

Монголын автономит үеийн сургууль (1911-1920) Баримт бичгийн эмхэтгэл (1966). Улаанбаатар, Монгол

С.Бадарчи нар, Монгол Улсын хууль зүйн албаны түүхийн товчоон, Улаанбаатар хот, 2007 он.

Хууль, дүрэм, тогтоолын эмхэтгэл, 1950 он, №1.

Болдбаатар, Ж., Хишигт, Н., Пунсалдулам, Б., Эрдэнэбат, Д., Өлзий, Ц., Батдорж, Ч., (2020). *XX зууны монгол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн түүх*. Улаанбаатар, Монгол: “Удам соёл”.

Базар, Д., Гомбосүрэн, Ж.(1973) *Багш нарын дуртгал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн комбинат

Дэлгэрсайхан, Ц. (2022). *Багшийн сургууль-100 жил Тэргүүн боть 1912-1942он*. Улаанбаатар, Монгол: “Адмон принт

Лхаасүрэнгийн Жүрмэд багшийн дуртгал гар бичмэл. (1973)

Нарангэрэл, С. (2009). Монгол Улс дахь эрх зүйн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. *Хууль дээдлэх ёс* 3(26), 9

Жамьяанжав, Т. (1987) *Ардын боловсролын системийг боловсронгуй болгох талаар МАХН-аас явуулсан бодлого*. Улаанбаатар, Монгол: Улсын хэвлэлийн газар.

Цэвээн, Б., Удвал, В.(2011) Монгол Улсын хууль зүйн алба. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар, Монгол: Мөнхийн үсэг.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТААС ҮҮССЭН ГЭМ ХОРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЛЭЭ

Ж.Хулан¹, Ц.Даваасүрэн²

¹ Магистр (LLM), дэд профессор /СЭЗИС/

² Магистр (LLM), /СЭЗИС/



Хураангуй

Монгол Улсын Иргэний хуулийн 499 дүгээр зүйл буюу тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн эдийн болон эдийн бус гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын талаар шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж, түүний хэрэгжилтийг судлахыг зорилоо.

Түлхүүр үг:

Тээврийн хэрэгсэл
эзэмшигч, эд хөрөнгөд
учирсан гэм хор, эрүүл
мэндэд учирсан гэм хор,
сэтгэл санааны хохирол.

Удиртгал

Иргэд ослоос үүдэлтэй гэм хорын хохирлоо иргэний шүүхэд хандан гаргуулах боломжийг нээлттэй байлгах үүднээс хууль тогтоогчид тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй гэм хорыг Иргэний хуулийн 499 дүгээр зүйлээр тусгайлан зохицуулжээ. Судлаач бидний зүгээс тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорын маргааныг шийдсэн 2020-2023 оны шүүхийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтын хэрэглээнээс хамаарсан онолын болон практик судалгааг хийж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Үндсэн хэсэг

Судлагдсан байдал. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын талаар сүүлийн жилүүдэд олон талын судалгаа хийгдсэн байна. Хуульч эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, эрх зүйн шүүмж зэрэг бүтээлүүдэд энэхүү асуудлыг хөнджээ. Эдгээрээс Хууль зүйн ухааны доктор Ж.Оюунтунгалаг “Гэм хорын тусгай төрөл: эзэмшигчийн хариуцлага”, “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, “Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага”, судлаач Н.Норовсамбуу, Р.Пүрэвбаатар нар “Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг

арилгах зохицуулалтын талаар судалгаа шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн дүн шинжилгээ” зэрэг бүтээлүүддээ тусгажээ.

Судалгааны үр дүн. Судлаачид Иргэний хуулийн 499 дүгээр зүйл тээврийн хэрэгсэл эзэмшигч, ашиглагчийн хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл зэрэг асуудлуудыг бусад орны хууль тогтоомжтой харьцуулж, онолын болон хууль хэрэглээний судалгаа хийжээ. Бидний зүгээс энэ өгүүлэлдээ тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй гадаадад эмчлүүлсэн эрүүл мэндийн зардлыг тооцож гаргуулах, сэтгэл санааны буюу эдийн бус хохирлыг хэрхэн шийдвэрлэх, мөн эд хөрөнгөд учруулсан гэм хорыг арилгах асуудлын талаар БНХАУ-ын Иргэний хуулийн зохицуулалтыг судалж оруулсан юм.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, сэтгэцэд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэйгээр зохицуулсан байна.

- Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.1 дэх хэсэгт “Зорчигч болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн бол тухайн тээврийн хэрэгслийг эзэмшигч учирсан гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй”
- Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.3 дэх хэсэгт “Хэн нэг этгээд өмчлөгч буюу эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг ашигласнаас бусдад хохирол учирсан бол гэм хорыг тухайн этгээд хариуцах боловч өөрийн буруугаас тээврийн хэрэгслийг ашиглах боломж олгосон өмчлөгч буюу эзэмшигч хариуцлагаас чөлөөлөгдөхгүй”
- Иргэний хуулийн 499-р зүйлийн 499.4 дэх хэсэгт “Тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг өмчлөгч буюу эзэмшигч хариуцан арилгах үүрэгтэй” хэмээн тус тус заажээ.

ИХ-ийн 499 дүгээр зүйлд гэм хорын хохирол тухайлбал, тээврийн хэрэгслийн ашиглалтаас учирсан эрүүл мэндийн хохирол, эвдэрч, устаж, гэмтсэн эд юмсын хохирол болон сэтгэл санааны хохирол зэргийг нөхөн төлүүлэх эрхтэй. Иймд 2020-2023 оны иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд дараах үндсэн асуудлууд гарч байна.

1. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй эрүүл мэндийн хохирлыг гадаадад эмчлүүлэх эрхийн асуудал. Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн дагуу нэхэмжлэгчид тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн эрүүл мэндийн хохирлоо хариуцагчаас нэхэмжилдэг. Ингэхдээ нэхэмжлэгчид өөрийн эрүүл мэндийн хохирлыг гадаад улсад эмчлүүлсэн байх тохиолдол олон байна. Гэтэл үүнийг зарим хуульчдын зүгээс заавал гадаадад эмчлүүлэх шаардлагагүй дотоодод эмчлүүлэх боломжтой гэж үздэг байна. Нэгэн тохиолдлоос дурдвал, хариуцагчийн унаж явсан машин нэхэмжлэгчийн машиныг мөргөн зам, тээврийн осол гаргажээ. Анхан шатны шүүхээс нэхэмжлэгчийн гадаадад эмчлүүлэх эрхийг нээлттэй гэж дүгнэсэн бол давж заалдах шатны шүүхээс дотооддоо эмчлүүлэх боломжтой байсан гэх хариуцагчийн тайлбарыг үндэслэлтэй гэж үзэж хэргийг анхан шатанд буцаасан байна.

Гэтэл энэхүү маргаантай холбоотой 2017 оны 09 дүгээр сарын 21-ий өдрийн Эрүүл мэндийн сайдын А/370 дугаар “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”, Засгийн газрын 2011 оны 226 дугаар “Зайлшгүй шаардлагатай гадаад улсад эмчлүүлэх иргэнд санхүүжилт олгох журам” тус тус батлагдсан байдаг. Тус эрүүл мэндийн сайдын тушаал болон Засгийн газрын тогтоолын агуулгаас үзвэл иргэнийг заавал улсдаа эмчилгээ хийлгэх ёстой гэж хуульчлаагүй бөгөөд гагцхүү хэрэв иргэн эх орондоо эмчлүүлэх боломжгүй өвчний жагсаалтад багтсан өвчин эмгэг туссан бол улсаас санхүүжилтийг нь олгож болно гэж заасан байна.

Өөрөөр хэлбэл хуулийн аль ч зохицуулалтаар ИХ-ийн 499 дүгээр зүйл, 505 дугаар зүйл болон Засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаалаар нэхэмжлэгчийн гадаадад эмчлүүлэх эрхийг хязгаарлаагүй байна. Гэвч практик дээр хариуцагчид энэхүү үндэслэлийг барьж маргадаг, шүүхээс ч мөн тус үндэслэлээр хохирлын хэмжээг багасгаж байгаа нь иргэдийн дунд тэр тусмаа нэхэмжлэгчдийн дунд тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй гэм хорын эрх зүйн зохицуулалтад итгэх итгэлийг бууруулдаг байна.

Мөн шүүхүүд нотлох баримт тэр дундаа гадаадад эмчлүүлсэн нотлох баримтыг үнэлэхдээ хэт хатуу ханддагаас хохирлын хэмжээг багасгах тохиолдол олон гарч байна. Тухайлбал, хариуцагч нь зам тээврийн осол гарган нэхэмжлэгчийн эрүүл мэндэд хохирол учруулсан байна. Нэхэмжлэгчийн зүгээс шүүхэд гадаадад эмчлүүлсэн баримтыг эх хувиар болон түүний монгол орчуулгын хамт гаргаж өгсөн байна. Анхан шатны шүүх уг эмчилгээний баримтыг нотлох баримтын шаардлага хангахгүй гэж үзсэн бол давж заалдах шатны шүүхээс хэргийн нотлох баримтыг дутуу үнэлсэн, дахин үнэлэх шаардлагатай гэж үзэж хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Практик дээр гадаадын эмнэлэг өвчтөнд төлбөрийн эх баримтыг өгч, иргэд уг баримтыг орчуулгын хамт шүүхэд ирүүлдэг. Учир нь, иргэдийн хувьд гадаадад эмчлүүлсэн нь үнэн, зардал гарсан нь үнэн байх тул түүнийг шүүх гадаад дотоод гэж ялгалгүй адил хүчин төгөлдөр үзнэ гэдэгт итгэнэ. Гэвч ихэнх тохиолдолд шүүх нотлох баримтыг үнэлэлгүй орхидог байна. Дээрх маргааны хувьд ч нэхэмжлэгчийн өгсөн эмчилгээний нотлох баримтын эх хувь болон орчуулгыг анхан болон давж заалдах шатны шүүх өөр өөрөөр үзэж байв.

2. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн эдийн бус хохирлыг тодорхой болгох асуудал.

Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорын нэхэмжлэгчид тээврийн хэрэгслийн ослын үеийн цочрол, олон удаагийн эмчилгээнээс хамааралтай хямрал, хариуцагчийн хандлага зэргээс сэтгэл санааны хямралд ордог. Тэгвэл Иргэний хуулийн тайлбарт энэхүү хямралыг “бие эрхтний болон сэтгэцийн хохирол, амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна” гэж тайлбарлажээ. (Кают, Шпанглер, 2010. х.458)

Гэвч бодит практик дээр шүүхүүд сэтгэл санааны буюу эдийн бус хохирлыг нэхэмжлэлийн шаардлагаас хасаж тооцдог байна. Сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулахад хууль хэрэглээний хувьд Иргэний хуулийн тусгай ангид заасан 497 дугаар зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.1 дэх зохицуулалтыг хэрэглэх бөгөөд хохирлыг барагдуулахдаа Иргэний хуулийн 228-230 дахь зохицуулалтыг хэрэглэх юм. (Түвшинтөгс, Ганхүрэл, Золзаяа, 2022.

х.31). Гэхдээ иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дэх хэсэгт “Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд бусад эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана” гэж, мөн хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсэгт “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” гэж тус тус хуульчилсан нь манай улсын хувьд зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн гаргуулж дээрхээс бусад эдийн бус эрхэд халдсан тохиолдолд сэтгэл санааны хохирол гаргуулах боломжгүй байгаа юм. Иймд шүүх сэтгэл санааны хохирлыг энэ зүйлд хуульчлаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагаас хасаж тооцдог байна.

Мөн иргэний сэтгэл санааны хохирлыг ямар аргачлалын дагуу хэрхэн тооцож олгох нь манай улсын хувьд одоог хүртэл шийдвэрлэгдээгүй ба одоогоор хуулийн төсөл боловсруулах шатандаа байна. ХЗДХЯ-ын Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг iToim-д өгсөн ярилцлагадаа “Сэтгэл санааны хохирлын тодорхой аргачлалыг ХЗДХЯ болон ЭМЯ-аас баталж, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгээс сэтгэл зүйд учраад буй хямралын зэрэглэлийг тогтоож, шүүх нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тодорхойлно. Хүний амь насыг хохироосон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлэх хэмжээгээр төгрөгөөр үнэлж болох эсхүл мөнгөл хүний дундаж наслалтаас тухайн гэмт хэргийн хохирогч болсон иргэний насны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлж, зөрүү үүссэн жилээр нь тооцож үнэлэх ийм асуудал байгаа. Хүний амь нас хохирсны улмаас ар гэрт нь учирч буй сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудлыг энэ аргачлалаар томъёолж болох юм. Гэхдээ энэ бол доод жишиг гэдгийг дахин хэлье. Шүүхээс өөрөөр үнэлэх жишиг тогтоох асуудал нээлттэй буюу хуулийн төсөлд энэ асуудлыг нээлттэй хуульчилж байгаа. Одоогийн байдлаар хуулийн төсөлд мөнгөн дүн нь 63 сая төгрөг байхаар тусгаад байна” гэжээ. (Сайнзориг, 2021)

3. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн эд хөрөнгөд учирсан гэм хорыг арилгах асуудал

2020 оноос 2023 он хүртэл шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 44 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд гарч буй маргаантай асуудлуудыг доорх жишээнүүдээр авч үзлээ.

Шүүхийн шийдвэр-1

Улсын ..-16 УНП дугаартай Ланд круйзер 200 загварын автомашин “эсрэг урсгал”-д орж, улсын ..-15 УБК дугаартай автомашиныг мөргөж зам тээврийн осол гаргасан. Ослын гол шалтгаан нь Ланд-200 маркийн ..-16 УНП улсын дугаартай автомашины жолоочийн буруутай үйлдлээс болсон ба уг жолооч нас барсан байна. Улсын бүртгэлд осол гаргагчийн өмчлөгчөөр ... банк байх тул гэм хорын асуудлыг хариуцан арилгах үүрэгтэй. Иймд хохирлыг “... банк” ХХК-иас гаргуулж өгнө үү гэжээ.

Хариуцагч тайлбартаа: ЗГ201742962553 дугаар бүхий барьцаат зээлийн гэрээ байгуулан Тоёота Ланд круйзер 200 маркийн тээврийн хэрэгслийг лизингийн зээлээр авсан болно. Тухайн барьцаат зээлийн гэрээ байгуулсан өдөр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө шилжүүлэх фидуцийн гэрээ байгуулсан байна. Фидуцийн гэрээний дагуу хохирлыг

зээлдэгч нар хариуцахаар тохирчээ. Иймд нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү гэжээ.

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 183/ШШ2019/00459 дүгээр шийдвэр гаргаж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.4, 510 дугаар зүйлийн 510.1-д заасныг баримтлан ... банк ХХК-с 32,280,000 төгрөг гаргуулж М.Б-д олгож шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхээс зөвхөн “Эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ”-г нэхэмжлэлийг хангах үндэслэл болгосон нь буруу байна. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл, 2018-08-04-ий өдөр зам тээврийн осол болох үед Ланд Круйзер 200 маркийн улсын ..-16 УНП дугаартай автомашин хариуцагчийн эзэмшилд байгаагүй нь тогтоогдсон байх тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

Дүгнэлт: Хяналтын шатны шүүхийн тогтоолтой санал нэг байна. ИХ-ийн 499 дүгээр зүйл нь хэдийгээр гэм буруугүйгээр тээврийн хэрэгсэл эзэмшигчид хариуцлага хүлээлгэх зохицуулалт боловч хуульд энэ хэсгийн эзэмшигчийг хэн байх талаар тайлбарлаагүй нь

Банкийг хариуцагч мөн гэж үзэх үндэслэл болжээ. Зарим судлаачийн үзсэнээр эзэмшил гэдгийг иргэний хуулийн 89.2 дугаар хэсэг болон 89.3 дугаар хэсгийн дагуу орчин тойрондоо аюултай зүйлийг эзэмшигчид уул зүйлийг хууль буюу гэрээнд заасны дагуу байнга буюу түр хугацаагаар өөрийн эзэмших эрхийн үндсэн дээр ашиглаж байгаа хуулийн этгээд, иргэнийг хамруулж ойлгож байна.

Харин дийлэнх судлаачид нь хууль тогтоогчид тээврийн хэрэгслийн нийгэмд үзүүлэх аюултай шинж чанар, түүнийг удирдах чадвар, эрсдэлийг арилгах нөхцөл боломжийг харгалзан ИХ-ийн 499 дүгээр зүйлд өмчлөгчийг хариуцлага хүлээх бус эзэмшигчийг хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан гэдэгтэй санал нийлдэг байна. Иймд анхан шатны шүүхээс ИХ-ийн 499.1 дэх хэсгийг хэрэглэхдээ зөвхөн Фидуцийн гэрээг үндэслэн тээврийн хэрэгслийн өмчлөгч нь банк байгаа тул гэм буруугүйгээр хариуцлага хүлээх хатуу зохицуулалтын дагуу банкийг хариуцлага хүлээлгэхээр шийдвэрлэсэн нь өрөөсгөл ойлголт болсон байна.

Шүүхийн шийдвэр-2

Нэхэмжлэгч О.А нь 81-78 УБД улсын дугаартай Тоёота Королла аксео маркийн машиныг жолоодож явсан жолооч Б.М-д мөргүүлж авто машины осолд орсон. Иймд уг зам тээврийн ослын улмаас надад учирсан гэм хорын хохирол болох нийт 2 798 205 төгрөгийг хариуцагч Б.М, Ш.Б нараас гаргуулж өгнө үү гэжээ. Хариуцагч Б.М нь О.Аийн нэхэмжилсэн гэм хорын хохирлыг үндэслэлгүй гэж үзэж байгаа тул мөнгийг өгөх боломжгүй болно гэжээ. ***Б.М-ийн жолоодож явсан автомашин өвөг эцэг Ш.Бийн эзэмшлийнх болох нь хэрэгт цугларсан баримтаар тогтоогджээ.***

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 182/ШШ2019/00469 дүгээр шийдвэрээр: Иргэний хуулийн 499 дүгээр зүйлийн 499.1, 505 дугаар зүйлийн 505.1-д заасны дагуу хариуцагч Б.М-өөс 100 000 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгч О.А-г олгон түүнд холбогдох нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх хэсгийг, хариуцагч Ш.Б-д холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь тус тус хэрэгсэхгүй болгосон байна.

Харин хяналтын шатны шатны шүүх Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага нь хариуцагчийн гэм буруугийн үйлдэлтэй шалтгаант холбоотой тул хариуцагч нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1., 505 дугаар зүйлийн 505.1., 510 дугаар зүйлийн 510.1.-д зааснаар эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан гэм хорын хохирлыг нөхөн төлнө гэж үзэж Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд хууль хэрэглээний өөрчлөлт оруулжээ.

Дүгнэлт: Хяналтын шатны шүүхийн шийдвэртэй санал нийлэхгүй байна. Судлаачид нарын үзэж байгаагаар “тээврийн хэрэгслийн жолооч нь эзэмшигч байгаа тохиолдолд ИХ-ийн 497.1 дэх хэсгийг шаардах эрхийн үндэслэл болгох нь нэхэмжлэгчийг нотлох үүргээс чөлөөлөх, тээврийн хэрэгсэл эзэмшигчид гэм буруугүйгээр хариуцлага хүлээлгэх 499 дүгээр зүйлийн зорилго хэрэгжихгүй болгох юм” гэж үзсэн байна.

Өөрөөр хэлбэл, ИХ-ийн 497.1 дэх хэсэг нь гэм хорын харилцааг ерөнхийлөн заасан зохицуулалт бол 499.1 дэх хэсэг нь тээврийн хэрэгслийн гэм хорыг тусгайлан зохицуулсан зохицуулалт болно. Иймд зөвхөн хариуцагч нь гэм буруугийн үйлдэлдээ шалтгаант холбоотой гэх үндэслэлээр ИХ-ийн 497.1 дэх хэсгийг хэрэглэх нь хэт явцуу ойлголт болсон байна.

Түүнчлэн хяналтын шатны шүүхээс Б.М-ийн жолоодож явсан машиныг Ш.Б-ийн эзэмшлийн машин гэж тодорхойлсон боловч Б.М нь уг машиныг эрх зүйн ямар үндэслэлээр жолоодож явсныг тодруулаагүй байна. ИХ-ийн 499.1 дэх хэсэгт хариуцлага хүлээх этгээдийг тээврийн хэрэгслийн эзэмшигч гэж тодорхойлсон байдаг. Энэ тохиолдолд Б.М нь уг машиныг Ш.Б-ийн зөвшөөрлийн дагуу, түүний ашиг сонирхлын тулд эзэмшиж байсан эсэх, Ш.Б тээврийн хэрэгслийг эзэмших боломж олгосон эсэх, эсвэл машины эзэмшлийг хараахан шилжүүлж амжаагүй байсан эсэхийг тодруулах нь хууль хэрэглээний хувьд буюу 499.1 эсвэл 499.3-ийг хэрэглэхийг тодорхойлоход чухал нөлөөтэй байсан байна.

Шүүхийн шийдвэр-3

Нэхэмжлэгч “Б.Гансүх нь ГАҮ 74-85 улсын дугаартай авто машинаар явж байтал Э.Уранчимэгийн жолоодож явсан 39-77 УНА улсын дугаартай машин ирж мөргөсөн. Иймд хохирол нийт 1,380,000 төгрөгийг гаргуулахаар нэхэмжилжээ. Хариуцагч нь нэхэмжлэгчийн буруутай үйлдэл мөн байсан тул хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.

Хариуцагч Э.У нь Тоёота спринтер маркийн 3977УНА улсын дугаартай тээврийн хэрэгслийн өмчлөгч биш, уг тээврийн хэрэгсэл нь Энхтуяа гэх найзын автомашин байсан гэсэн тайлбарыг шүүх хуралдаанд гаргасан бөгөөд уг тээврийн хэрэгслийг өмчлөгчийн зөвшөөрөлтэй ашиглаж байсныг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй байна.

Ингээд анхан шатны шүүхээс Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 499 дүгээр зүйлийн 499.3, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1-д заасныг тус тус баримтлан хариуцагч Э.У-ээс 690,000 төгрөгийг гаргуулан нэхэмжлэгч Ч.С-д олгож шийдвэрлэсэн байна.

Дүгнэлт: ИХ-ийн 499.3 нь харьцангуй тодорхой заалт бөгөөд энэхүү заалтын хэрэглээтэй холбоотой гарсан маргаан бусад зүйлтэй харьцуулахад бага байдаг байна. Энэхүү шүүхийн шийдвэрийн хувьд бидний зүгээс харьцангуй санал нэг байгаа хэдий ч шүүхийн зүгээс уг

тээврийн хэрэгслийг өмчлөгчийн зөвшөөрөлтэй ашиглаж байсныг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй гэдэг үндэслэлээр 499.3 дугаар хэсгийг хэрэглэх нь өрөөсгөл гэж үзэж байна.

Учир нь практик дээр хувь хүмүүс хооронд тээврийн хэрэгслийг нэр дээр шилжүүлэлгүй хэлцэл хийх тохиолдол олон байдаг бөгөөд энэ тохиолдолд шүүхийн үндэслэл болгох хуулийн заалт нь ИХ-ийн 499.3 дугаар зүйлээс ИХ-ийн 499.1 болж өөрчлөгдөх боломжтой болно. Иймд хэдийгээр хариуцагчийн унаж байсан тээврийн хэрэгсэл нь өөр этгээдийн нэр байсан хэдий ч хариуцагч болон тээврийн хэрэгслийн өмчлөгч нарын хооронд ямар харилцаа үүссэнийг тодорхой болгох шаардлагатай байсан байна.

Шүүхийн шийдвэр-4

Нэхэмжлэгч шүүхэд гаргасан тайлбартаа: Ч.Ганбаяр нь Landcruiser 120 Prado маркийн 0059УНК улсын дугаартай авто машинаар Өвөрхангай аймгаас Улаанбаатар хот орохоор явж байхад О.Эрдэнэдалай МТЗ-80 маркийн авто машинд өвс хаддаг тармуур зүүж замын хөдөлгөөнд оролцож замын хөдөлгөөн зөрчсөний улмаас зам тээврийн осол гаргасан.

Хариуцагч О.Эрдэнэдалай шүүхэд гаргасан хариу тайлбартаа: МТЗ-80 маркийн авто машин миний эзэмшлийн тээврийн хэрэгсэл биш Ш.Бямбанямын трактор, Ш.Бямбаням тариалангийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Би намрын улиралд тухайн тракторыг барьж тариа хураах ажил хийж Ш.Бямбанямаас цалин авдаг байсан. Ажлын хөлс 1 сая төгрөгийг осол гарсны дараа Ц.Норжинжавт өгсөн. Нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэжээ.

Хяналтын шатны шүүх хэргийг ИХ-ийн 499 дүгээр зүйлийн 499.4, 510 дугаар зүйлийн 510.1. зүйлийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний хувьд өөрчлөлт оруулсан байна.

Дүгнэлт: Хяналтын шатны шүүхийн шийдвэртэй санал нэгтэй байна. Зарим тохиолдолд үүнтэй төсөөтэй маргааныг шүүх шийдвэрлэхдээ ИХ-ийн 498 дугаар зүйлийг 498.1 дэх хэсгийг удирдлага болгон шийдвэрлэсэн байна.

Үүнээс ИХ-ийн 498.1 болон ИХ-ийн 499.4 дүгээр зүйлийн хэрэглээний өрсөлдөөн гарч ирж байна. Энэ тохиолдолд судлаачдын үзэж байгаагаар хоёр зүйлийн урьдчилсан нөхцөлийг анхаарах шаардлагатай гэж үзсэн байна. 498.1 дэх хэсгийг хэрэглэхэд урьдчилсан нөхцөл нь хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүргээ гүйцэтгэж явахад гэм хор учирсан байхыг шаарддаг бол 499.4-ийн хувьд томилсон, шилжүүлэн өгсөн тээврийн хэрэгслийг ашиглах явцад байхыг шаарддаг байна.

Иймд шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ дээрх нөхцөлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ бусдад учруулсан гэм хорыг арилгахад ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.1 дэх хэсгийг удирдлага болгох нь зүйтэй бол тээврийн хэрэгсэл ашиглагчийг өмчлөгч буюу эзэмшигч өөрөө томилсон буюу өөрөө түүнд уг хэрэгслийг шилжүүлэн өгсөн бол бусдад учирсан гэм хорыг арилгахад ИХ-ийн 499 дүгээр зүйлийн 499.4 дэх хэсгийг удирдлага болгох нь зүйтэй байна.

Шүүхийн шийдвэр-5

Миний бие 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас 58 км-г засмал зам дээр 49-9 ДГА улсын дугаартай автомашинаар З.Д, Г.Дэлгэрмаа нартай зорчин явж байхдаа онхолдож Г.Дэлгэрмаагийн биед хүндэвтэр гэмтэл учирсан билээ. Замын цагдаагийн шинжээчийн 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 22 тоотдүгнэлтээр З.Д-г Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасныг зөрчсөний улмаас уг зам тээврийн осол хэрэг гарсан гэж дүгнэсэн Хариуцагч З.Д нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй гэж маргажээ.

Хяналтын шатны шүүх А.А нь Замын хөдөлгөөний дүрмийн 2.3 б-д заасан хамгаалах бүсээр тоноглогдсон автомашин жолоодоходоо хамгаалах бүс хэрэглэх, хамгаалах бүс хэрэглээгүй зорчигч тээвэрлэхгүй байх гэснийг, З.Д нь ...Замын хөдөлгөөний дүрмийн 4.2 в-д заасан хөдөлгөөний үед жолоочийн анхаарлыг сарниулах, түүний үйлдэлд саад болохгүй байх гэсэн заалтыг тус тус зөрчсөн, гэм хор учрахад аль алины гэм буруу байна. Иймд давж заалдах шатны шүүхийн дүгнэлт Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1, 514 дүгээр зүйлийн 514.1-т заасан зохицуулалтыг зөрчөөгүй байна гэж үзжээ. Ингэхдээ ИХ-ийн 514.1-т заасны дагуу нийт нэхэмжилсэн 12,814,000 төгрөгөөс 7,800,300-ийг гаргаж шийдвэрлэжээ.

Дүгнэлт: Хяналтын шатны шүүхийн тогтоолтой санал нэгтэй байна. Зарим тохиолдолд үүнтэй адил маргаан дээр шүүхээс хэргийг ИХ-ийн 499 дүгээр зүйлийг баримтлан шийдвэрлэх тохиолдолд байдаг. Гэтэл 499.1-ийг хэрэглэх урьдчилсан нөхцөл нь тээврийн хэрэгслийг ашиглах явцад бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан буюу эд юмс нь эвдэрч, устаж, гэмтсэн тохиолдолд байдаг. Өөрөөр хэлбэл энэхүү маргаанд машины эзэмшигч нь өөрийн тээврийн хэрэгсэлд учирсан хохирлыг нэхэж байгаа нь ИХ-499.1 дэх хэсэгт заасан бусдын гэсэн шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна.

Түүнчлэн тээврийн хэрэгслийн гэм хорын эрх зүйтэй холбоотойгоор шүүхүүд ИХ-ийн 514 дүгээр зүйлд “Гэм хор учрах буюу түүнээс үүдэн гарах хохирлын хэмжээ нэмэгдэхэд хохирогчийн хэтэрхий болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл нөлөөлсөн бол уг нөхцөл байдлыг харгалзан хариуцах гэм хорын хэмжээг багасгаж болно” гэж заасны дагуу хохирлын хэмжээг багасгах тохиолдол байдаг байна. Гэхдээ энэ хэсгийг хэрэглэхдээ шүүх хохирлын хэмжээг хэргийн оролцогчдын буруутай үйлдэлтэй холбоотойгоор хэдий хэмжээгээр багасгах нь тодорхойгүй байдаг байна.

Ийнхүү шүүхийн шийдвэрүүдээс харахад Монгол Улсын Иргэний хууль 499 дүгээр зүйлийн зохицуулалтыг иргэний эрх зүйн маргаанд хэрэглэхэд хуульчдын дунд нэгдүгээрт, уг зүйлд заасан тээврийн хэрэгсэл эзэмшигч гэдгийг хэрхэн ойлгох асуудал, хоёрдугаарт, гэм хор учруулсан этгээд, тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хэн нь гэм хорыг шууд хариуцах этгээд болох асуудлаар зөрүүтэй ойлголтууд байсаар байна. Иймд уг харилцааг гадаад орнууд тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг хэрхэн зохицуулж, тайлбарладаг болохыг авч үзье.

Харьцуулсан зүйл	Судалгаанд харьцуулагдсан орон		
	ОХУ	ХБНГУ	БНХАУ
Хариуцах этгээд	Иргэний хуулийн 1079 дүгээр зүйлд “Өндөржүүлсэн аюултай эх сурвалж”-аас үүдэлтэй хохирлыг уг эх сурвалж эзэмшигч нь хариуцан арилгах үүрэгтэй гэж заасан байна.	Замын хөдөлгөөний тухай хууль 7 дугаар зүйл 1 дэх хэсэгт Тээврийн хэрэгслийн ашиглалтын явцад хүнд болон хөрөнгөд учирсан хохирлыг уг тээврийн хэрэгслийн бүртгэлтэй эзэмшигч эсхүл арчлан хамгаалагч нь хариуцан арилгахаар заасан байна	Иргэний хуулийн 1209 дүгээр зүйл Тээврийн хэрэгслийн өмчлөгч, ашиглагч, эзэмшигч нь нэг хүн биш байх үед зам тээврийн ослын улмаас хохирол учруулсан тохиолдолд тээврийн хэрэгсэл эзэмшигч хохирлыг барагдуулна. Хэрэв Өмчлөгч, ашиглагч бүрүүтэй тохиолдолд
Тээврийн хэрэгслийг тодорхойлох журам	“Өндөржүүлсэн аюултай эх сурвалж” гэдгийг хүний зүгээс бүрэн хянах боломжгүй, орчин тойрондоо аюул учруулах магадлалтай эд зүйлс болон эдгээрийг ашиглан,	Тээврийн хэрэгсэл гэдгийг механик хүчээр жолоодогддог төмөр замд хамааралгүй, хуурай газрын бүх тээврийн	БНХАУ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 119 дүгээр зүйлд дараах байдлаар тодорхойлсон байна.
	аж ахуйн бусад зориулалтаар ашиглах үйл ажиллагаа гэж тодорхойлсон байна.	хэрэгслийг ойлгохоор заасан.	<ul style="list-style-type: none"> • "Тээврийн хэрэгсэл" гэж моторт болон моторт бус тээврийн хэрэгслийг хэлнэ. • "Моторт тээврийн хэрэгсэл" гэж эрчим хүчний нэгжээр жолооддог, чирэгддэг, зорчигчдод зориулан зам дээр явах, эд зүйл зөөх, инженерийн тусгай ажиллагаа эрхлэхэд ашигладаг дугуйтай тээврийн хэрэгслийг хэлнэ.

<p>Тээврийн хэрэгслийн эзэмшигч</p>	<p>Аюултай эх сурвалж эзэмшигч гэдгийг</p> <ul style="list-style-type: none"> • бодит байдал дээр эзэмшиж байгаа (Тээврийн хэрэгслийг түрээслүүлсэн тохиолдолд түрээсэлсэн этгээд хохирлыг хариуцна) • эд зүйлсийг тодорхой эрхэд үндэслэн эзэмшилдээ байлгах эрх мэдэлтэй этгээд (Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа этгээдийн хувьд Ажил олгогч хохирлыг хариуцна) 	<p>Автомашин эзэмшигч гэдгийг тухайн авто машиныг өөрийн зардлаар ашиглаж, ийнхүү ашиглахтай холбоотойгоор захиран зарцуулах, эрх мэдэл бүхий этгээд гэж тодорхойлжээ. (Автомашинь богино хугацаагаар хөлслөх гэрээгээр ашиглаж байгаа тохиолдолд эзэмшигч гэж үзэхгүй бөгөөд урт хугацааны хөлслөх гэрээний хувьд автомашиныг ашиглаж байгаа этгээд нь түүнтэй холбоотой гарах бүх зардал, эрсдэлийг хариуцаж байгаа тохиолдолд эзэмшигч гэж тооцогдоно.)</p>	<p>Автомашин эзэмшигч гэдгийг тухайн авто машиныг хуулийн дагуу буюу гэрээ, хэлцлийн үндсэн дээр эзэмшилдээ авсан этгээдийн ойлгож байна.</p> <ul style="list-style-type: none"> • Автотээврийн хэрэгслийг худалдах болон бусад аргаар шилжүүлж, хүлээлгэн өгсөн боловч тээврийн хэрэгслийг хараахан бүртгүүлээгүй байхад зам тээврийн ослын улмаас хохирол учруулсан тохиолдолд нь тухайн тээврийн хэрэгслийг шилжүүлэн авсан этгээд нөхөн төлбөрийг хариуцна. • Зам тээврийн осол нь зөвшөөрөлгүй бусдын тээврийн хэрэгслийг жолоодож хохирол учруулсан бол тухайн тээврийн хэрэгслийн эзэмшигч нь хохирлыг барагдуулна.
<p>Хариуцлагаас чөлөөлөх үндэслэл</p>	<p>Давагдашгүй хүчин зүйл, хохирогчийн гэм буруу, гуравдагч этгээдийн гэм буруу байгааг нотолсон тохиолдолд болно.</p>	<p>Давагдашгүй хүчин зүйлийн нөлөө, гуравдагч этгээдийн үйлдлийн улмаас эсхүл тухайн нөхцөл байдалд эзэмшигч нь анхаарал болгоомжтой байх, зохих арга хэмжээг бүрэн авснаа нотолсон тохиолдолд зайлшгүй тохиолдолд тээврийн хэрэгслийн эзэмшигч</p>	<p>Үйлчилгээний бус зориулалттай тээврийн хэрэгсэл нь зам тээврийн ослын улмаас төлбөргүй зорчигчид хохирол учруулсан тохиолдолд хохирлын хэмжээг багасгаж болно. Гэхдээ эзэмшигч нь ослыг санаатай үйлдсэн тохиолдолд энэ зүйлийг хэрэглэхгүй.</p>

Манай улсын хувьд Иргэний хуулийн 497 дугаар заалтаар гэм хор учруулснаас үүсэх хариуцлагыг гэм хор учруулсан этгээд хариуцахаар заасан бол гэм буруугүйгээр хариуцлага хүлээж болох зохицуулалтыг 499 дүгээр зүйлд тусгасан нь Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалт юм. Энэ заалт нь бусад гэм хорын

зүйлээс тээврийн хэрэгслийн гэм хорын харилцааг нарийвчлан зохицуулснаараа онцлогтой. Иргэний хуулийн 499 дүгээр заалтад тээврийн хэрэгслийн эзэмшигч нь учирсан гэм хорыг нөхөн төлөхөөр зохицуулсан. Гэхдээ тээврийн хэрэгслийн эзэмшигч гэдгийг зөвхөн Улсын бүртгэлд бүртгэгдсэн өмчлөгч эзэмшигчээр тооцож хариуцлагыг хүлээлгэдэггүй байна.

Харин Иргэний хуулийн 89 дүгээр зүйл 89.2 дахь хэсэгт “Өөр этгээдээс бүрэн эрх олгогдсоны дагуу түүний ашиг сонирхлын үүднээс эд хөрөнгийг тухайн үед өөрийн мэдэлд байлгаж байгаа этгээдийг эзэмшигч гэж үзэхгүй. Энэ тохиолдолд бүрэн эрх олгосон этгээд эзэмшигч байна” мөн зүйлийн 89.3 дахь хэсэгт “Өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын дагуу хууль буюу хэлцлийн үндсэн дээр тодорхой хугацаагаар эд хөрөнгийг эзэмших эрх олж авсан буюу үүрэг хүлээсэн этгээд нь шууд эзэмшигч, эрх буюу үүргээ шилжүүлсэн этгээд нь шууд бус эзэмшигч байна” гэж зааснаар тайлбарлан хэрэглэдэг байна.

89.2 дахь хэсгийг Тээврийн хэрэгслийн эзэмшилтэй холбон тайлбарлавал, тээврийн хэрэгслийг аливаа этгээдийн эрх олгосны дагуу, түүний ашиг сонирхлын дагуу (жишээ нь байгууллагын машин техник хариуцсан ажилтан, хөдөлмөрийн гэрээгээр ажил үүргээ гүйцэтгэж яваа этгээдийг хамруулж ойлгож болохоор байна) ашиглах явцад бусдад хохирол учруулсан тохиолдолд тээврийн хэрэгслийг эзэмших эрх олгосон этгээд гэм хорыг хариуцахаар байна.

Харин 89.3 дугаар хэсгийг 499.1 дэх хэсгийн эзэмшилтэй холбон тайлбарлавал, энэ хэсгийн урьдчилсан нөхцөл нь хууль болон хэлцлийн үндсэн дээр эзэмших эрх олж авсан этгээд байхыг шаардаж байгаа бөгөөд ийнхүү олж авсан тохиолдолд тээврийн хэрэгслийн шууд эзэмшигч хариуцлага хүлээхээр, харин шууд бус эзэмшигч нь хариуцлагаас чөлөөлөгдөхөөр зохицуулсан гэж ойлгогдож байна.

Судлаачдын зүгээс Иргэний хуулийн эзэмших эрх үүсэх зохицуулалт нь тээврийн хэрэгслийн гэм хорыг арилгах зохицуулалт дахь эзэмшигч гэдгийг тодорхойлоход хэт явцуу ойлголт болох бөгөөд ийнхүү тайлбарлах нь тодорхой нийтлэг гардаг асуудлууд болох 1) тээврийн хэрэгслээ бусдад өөрийн эрх ашиг сонирхлын дагуу ашиглуулах, 2) өөрийн буруугаас ашиглах эрх олгох, 3) гэрээ хэлцлийн үндсэн дээр эзэмших эрхийг шилжүүлэх зэргийг зохицуулах боломжтой боловч өмчлөх эрхийг хуулийн дагуу бусдад шилжүүлсэн хэдий ч эзэмшил, ашиглалт нь өөрт байгаагаас гардаг тохиолдлуудыг ийнхүү тайлбарлан хэрэглэх нь учир дутагдалтай гэж үзсэн байна.

Санал: Дээрх улсуудын тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтаас үзэхэд улс орон бүр өөрийн онцлогоос хамаарч тээврийн хэрэгслийг тодорхойлох тодорхойлолт, гэм хорын хохирлыг хариуцах этгээд, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл зэрэг нь өөрийн онцлогуудтай байна.

Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорын хариуцагчийн хувьд ОХУ нь тээврийн хэрэгслийг нийгмийн аюул, эрсдэлээс нь хамааруулан “аюултай эх сурвалж” хэмээх ойлголтод оруулсан бөгөөд түүний эзэмшигчийг тодорхойлохдоо бодит байдал дээр эзэмшилдээ байлгаж байгаа болон эд зүйлсийг тодорхой эрхэд үндэслэн эзэмшилдээ байлгах эрх мэдэлтэй байх шинжийг нь харгалзан үздэг байна.

БНХАУ-ын хувьд тээврийн хэрэгслийн эзэмшигч гэдэгт хуулийн дагуу буюу гэрээ, хэлцлийн үндсэн дээр эзэмшилдээ авсан этгээдийн оруулдаг бөгөөд хэрэв бодит байдал дээр

эзэмшил, өмчлөлийг шилжүүлсэн боловч хараахан улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж амжаагүй байгаа бол МУ-ын Иргэний хуулийн 111 дүгээр зүйлд заасантай адил буюу хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэхтэй төсөөтэй зохицуулалт үйлчилдэг байна.

Харин ХБНГУ-ын хувьд автомашины эзэмшигчийг тодорхойлохдоо уг эд зүйлсийг өөрийн ашиг тусын тулд хяналт, удирдлага ашиглалтдаа байлгаж байгаа эсэх бодит нөхцөл байдлыг харгалздаг байна. Тодруулбал, автомашины эзэмшигч гэдгийг тухайн авто машиныг өөрийн зардлаар ашиглаж, ийнхүү ашиглахтай холбоотойгоор захиран зарцуулах, эрх мэдэл бүхий этгээд гэж тодорхойлжээ. Жишээлбэл, автомашиныг богино хугацаагаар хөлслөх гэрээгээр ашиглаж байгаа тохиолдолд эзэмшигч гэж үзэхгүй бөгөөд урт хугацааны хөлслөх гэрээний хувьд автомашиныг ашиглаж байгаа этгээд нь түүнтэй холбоотой гарах бүх зардал, эрсдэлийг хариуцаж байгаа тохиолдолд эзэмшигч гэж тооцогдоно.

Харьцуулсан судалгааны дүнд ХБНГУ-ын эзэмшигчийн тодорхойлолттой төсөөтэйгөөр тээврийн хэрэгслийг өөрийн ашиг тусын тулд хяналт, удирдлага, ашиглалтдаа хууль болон гэрээнд заасны дагуу байлгахыг 499 дүгээр хэсэгт заасан эзэмшигч гэж үзсэнээр манай улсад гардаг өмчлөх эрхийг хуулийн дагуу бусдад шилжүүлсэн хэдий ч эзэмшил, ашиглалт нь өөрт байгаагаас үүдсэн маргааныг зохицуулах боломжтой гэж үзлээ.

Мөн судалгаанд дурдагдаагүй хэдий ч гадаад орнууд тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй гэм хорыг арилгах зохицуулалтыг практик дээр илүү боловсронгуй болгохын тулд даатгалын системийг хөгжүүлж байгаа нь зүйтэй санагдлаа. Жишээ нь: БНХАУ-ын Иргэний хуульд автотээврийн хэрэгслийн жолооч зам тээврийн ослын дараа оргон зайлсан бол, тээврийн хэрэгсэл заавал даатгуулах даатгалд хамрагдсан бол даатгагч нь тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын хариуцлагын хүрээнд нөхөн төлбөр төлөх; тээврийн хэрэгсэл алга болсон, тухайн тээврийн хэрэгсэл албан журмын даатгалд даатгагдаагүй эсвэл яаралтай ажиллагааны зардал нь тээврийн хэрэгслийн албан журмын даатгалын хариуцлагын хэмжээнээс хэтэрсэн бөгөөд гэмтсэн хүний амь нас хохирсон тохиолдолд аврах, оршуулах болон бусад зардлыг төлөх шаардлагатай бол “Зам тээврийн ослын нийгмийн тусламжийн сан” төлбөрийг урьдчилж төлнө. Зам тээврийн ослын нийгмийн тусламжийн сан нь хохирлыг урьдчилж төлсний дараа хохирлыг зам тээврийн осолд холбогдсон этгээдээс нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй байхаар зохицуулжээ.

Дүгнэлт

Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэн гэм хорыг арилгах асуудлыг шийдвэрлэхдээ нэхэмжлэгчийн гадаадад эмчлүүлэх эрхийг хязгаарлаагүй тул шүүх хууль хэрэглээний хувьд нэгдмэл байх үүднээс энэхүү хохирлыг хүлээн авч шийдвэрлэх бүрэн боломжтой.

Иргэний хуулийн 230.2 дахь хэсэгт “Сэтгэцэд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгах бөгөөд эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр арилгана” гэж заасан нь тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн эдийн бус гэм хорыг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Практик дээр зам тээврийн осол гаргасан этгээд тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгч бус тухайн үед эзэмшиж байсан этгээд байх тохиолдол олон. Судлаачдын зүгээс хууль тогтоогчид тээврийн хэрэгслийн нийгэмд үзүүлэх аюултай шинж чанар, түүнийг удирдах

чадвар, эрсдэлийг арилгах нөхцөл боломжийг харгалзан ИХ-ийн 499 дүгээр зүйлд өмчлөгчийг хариуцлага хүлээх бус эзэмшигчийг хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан гэдэгтэй санал нийлдэг байна. Тээврийн хэрэгсэл эзэмшигч гэдгийг зөвхөн гэрчилгээн дээр нэр нь дурдсан этгээдээр ойлгох боломжгүй гэж үзжээ. Иймд бусад судлаачдын дүгнэлттэй саналтай нэг байгаа бөгөөд эзэмшигчийн ойлголтыг нэг мөр болгох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь ХБНГУ-ын жишгээр түүнтэй төсөөтэйгөөр ИХ-ийн 499 дүгээр зүйлийн эзэмшигчийн ойлголтыг улсын бүртгэлд бүртгэгдсэн шинжээр нь бус тээврийн хэрэгслийн зардлыг хариуцаж, эрсдэлийг удирдах боломжтой этгээдийнх нь хувьд тодорхойлох нь боломжтой юм.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын Иргэний хууль, 2002 он.

Кают, Ё., Шпанглер, Э. (2010). Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. 458-р тал.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 13-ний өдөр, 001/ХТ2022/01256.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, 001/ХТ2022/01198.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, 001/ХТ2022/01186.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 15-ний өдөр, 001/ХТ2022/01093.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр, 001/ХТ2022/00610.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр, 001/ХТ2021/01255.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр, 001/ХТ2021/00073.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр, 001/ХТ2020/00695.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 7 дугаар сарын 02-ний өдөр, 001/ХТ2020/00322.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 7 дугаар сарын 02-ний өдөр, 001/ХТ2020/00334.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 7 дугаар сарын 02-ний өдөр, 001/ХТ2020/00330.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 5 дугаар сарын 08-ны өдөр, 001/ХТ2020/00208.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, 001/ХТ2020/00183.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр, 001/ХТ2020/00183.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны тогтоол, 2020 оны 4 дүгээр сарын 02-ний өдөр, 001/ХТ2020/00151.

- Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр, 181/ШШ2021/00296.
- Оюунтунгалаг, Ж. (2018). *Иргэний эрх зүйн онолын асуудал*. Улаанбаатар. Монгол.
- Норовсамбуу, Н., Пүрэвбаатар, Р., (2020). *Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн гэм хорыг арилгах зохицуулалтын талаар судалгаа шүүхийн шийдвэрт хийх хөндлөнгийн дүн шинжилгээ*. Улаанбаатар. Монгол: Legaldata.mn
- Оюунтунгалаг, Ж. (2019). Гэм хорын эрх зүйн зорилго: Эрх зүй, эдийн засгийн хандлага. Улаанбаатар. Монгол. Хууль дээдлэх ёс №1 (71), 9 дэх тал.
- Хүний эрхийн Үндэсний комисс. (2013). *Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт: Суурин дүн шинжилгээ. 2 дахь тал*. Улаанбаатар. Монгол.
- Түвшинтөгс, А., Ганхүрэл, Д., Золзаяа, Н., нар. (2022). *Шүүхийн шийдвэрийн судалгаа цуврал, 4*.
- Сайнзориг, П. (2021). *Сэтгэл санааны хохирлыг тодорхойлоход ярвигтай ч асуудлыг орхигдуулж болохгүй*. www.itoim.mn.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ (Уул уурхайн салбарын жишээн дээр)

М.Түвшинжаргал

Хууль зүйн доктор (Ph.D), University of Erciyes-Turkey



Түлхүүр үг:

Төрийн өмчит компани,
төрийн өмчийн оролцоотой
компани, төлөөлөн удирдах
зөвлөл

Хураангуй

Зах зээлийн харилцаан дахь төрийн өмчийн оролцоо нь эдийн засгийг бэхжүүлэх үүднээс хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд цахилгаан холбооноос эхлээд уул уурхайн салбар хүртэл өргөн хүрээнд төрийн өмчит компани (цаашид ТӨК гэх) болон төрийн өмчийн оролцоотой компаниуд (цаашид ТӨОК гэх) үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, баялгийг хуваарилах, нийтийн эрх ашгийг хангах зэрэг үзэл санаанд суурилсан байх нь олонтаа. Өндөр хөгжилтэй улсуудад ТӨК болон ТӨОК-ууд олноор орших бөгөөд хөгжиж буй улсуудын хувьд ч эдийн засгийг хөгжүүлэх эсхүл зах зээл дэх хувийн хэвшлийн хоосон орон зайг нөхөх хүрээнд багтаасан төрийн өмчит хуулийн этгээд (цаашид ТӨХЭ гэх) чухал байр суурь эзэлсэн хэвээр байна.

Манай улсын хувьд ТӨК болон ТӨОК дахь төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх)-ийн гишүүд нь яам, агентлагын дарга нараас бүрддэг жишиг манай улсад нийтлэг болсон. Ийнхүү ТУЗ-ийн механизм бэхжээгүй, олон нийтийн хяналт бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас компанийн удирдлагын болон хяналтыг чиг үүргээ бүрэн гүйцэтгэж чадахгүй байгаа нь шүүмжлэлийг дагуулж байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ТӨК болон ТӨОК-той компаниудын удирдлагын хэлбэр, ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлан тулгарч буй асуудлыг тодорхойлох, улмаар зарим улс орнуудын засаглалын туршилага, олон улсын чиг хандлагыг судлах замаар тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьлоо.

I. ОРШИЛ

Монгол Улсын хувьд уул уурхайн салбарт газрын баялгийн үр өгөөжийг тэгш хуваарилах хүрээнд төрийн өмчийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Сүүлийн жилүүдэд иргэдийн баян, хоосны ялгаа улам нэмэгдэх болсноор баялгийг тэгш хуваарилах асуудал хүчтэй тавигдаж, энэхүү нөхцөл байдлыг харгалзан Улсын Их Хурлаас 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр түүний 6.2 дахь хэсэгт “байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь ... газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн зарчмыг тусгаж өгсөн.

Баялгийн үр өгөөжийг бий болгох, улмаар хөрөнгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх зохион байгуулалтын томоохон хэлбэр нь төрийн өмчит болон төрийн оролцоотой компани, бусад арилжааны хуулийн этгээд байх нь тодорхой юм.

Манай улсын хувьд ТӨК болон ТӨОК дахь төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх)-ийн гишүүд нь яам, агентлагын дарга нараас бүрддэг жишиг манай улсад нийтлэг болжээ. Ийнхүү ТУЗ-ийн механизм бэхжээгүй, олон нийтийн хяналт бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас компанийн удирдлагын болон хяналтыг чиг үүргээ бүрэн гүйцэтгэж чадахгүй байгаа нь шүүмжлэлийг дагуулж байна.

Үүнээс үүдэн ТӨК болон ТӨОК-ийн засаглалыг сайжруулах хүрээнд ТУЗ-ийн бүрэн эрх, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдэд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх үйл явц, томилгоо, үүрэг хариуцлага, ажлын үнэлгээ зэргийг тодорхой болгож, эрх зүйн орчныг нь сайжруулах, ТӨК болон ТӨОК-ийн засаглалын зарчмууд, олон улсын чиг хандлага, бусад улсны туршлагыг судлах, суралцах хэрэгцээ шаардлага зүй ёсоор урган гарч байгаа билээ.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд уул уурхай салбарт үйл ажиллагаа явуулдаг ТӨК болон ТӨОК-ийн ТУЗ-ын харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, өнөөгийн нөхцөл байдлын хүрээнд судалгааг хийсэн ба харьцуулсан судалгааны хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (цаашид ЭЗХАХБ гэх)-ын зарчмууд болон олон улсын сайн туршлага зарим орнуудын төрийн өмчит уул уурхайн компанийн туршлагыг судалсан болно.

II. ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

A. Төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

ЭЗХАХБ-аас 2013 онд “Төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд: Үндэсний туршлага” сэдэвт ТӨХЭ-ийн засаглалын удирдамжийг хэрэгжүүлэхэд дэлхийн улс орнуудад тулгарч буй нийтлэг асуудал, сайн туршлагыг нэгтгэсэн зөвлөмж гаргасан⁷⁷. Улмаар ЭЗХАХБ-ын зүгээс дээрх зөвлөмжийг 2018 онд шинэчилж улс

⁷⁷ OECD, Board of Directors of State-Owned Enterprises: An Overview of National Practices, OECD Publishing (2013) p. 1.

орнуудын хэрэгжүүлж буй сайн туршлагыг багтасан “Төрийн өмчит хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн мэргэшсэн байдал: Үндэсний туршлагын судалгаа” сэдэвт зөвлөмжийг гаргажээ.⁷⁸ Тус зөвлөмжийн хүрээнд ТУЗ-ын бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хүрээнд дараах зөвлөмжийг боловсруулсан байдаг.

i) ТУЗ-ийн бүрэлдэхүүн: ТУЗ-ийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй хүчин зүйлийн нэг нь түүний бүтэц бүрэлдэхүүн болохыг онцлосон байдаг. Тухайлбал, ТУЗ-ийг ур чадвар, туршлага, засаглалын шаардлагын дагуу сайн удирдагчийн (good director) шалгуур хангасан гишүүдээр бүрдүүлэх нь чухал. Иймд ихэнхи улсад ТУЗ-ийн гишүүнд боловсрол (боловсролын түвшин) болон ажлын туршлагыг (мэргэжлийн ур чадвар) хослуулсан нийтлэг шалгуур, шаардлагыг тавьдаг.

ЭЗХАХБ-ын зөвлөмж:⁷⁹

ТУЗ-ийг “хөндлөнгийн байр сууриас бие даан шийдвэр гаргах” чадамжтай гишүүдээс бүрдүүлэх нь зүйтэй. Үүний тулд ТУЗ-ийн гишүүдийг улс төрийн нөлөөллөөс хамгаалах механизмыг бүрдүүлэх шаардлагатай. ТУЗ-ийн гишүүн нь гүйцэтгэх засаглалын байгууллагатай (сайд болон түүний хамаарал бүхий этгээд) шууд холбоотой хүн байж болохгүй.

ЭЗХАХБ-ын ихэнхи гишүүн улсуудад ТУЗ-ийг хараат бус гишүүнтэй байлгах ба зарим улсад эмэгтэйчүүд, жижиг хувьцаа эзэмшигчид, ажилтны төлөөллийг багтаахыг шаарддаг байна. Мөн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ТӨХЭ-ийн ТУЗ-д хувийн хэвшлийн төлөөлөл оруулахыг шаарддаг.

ii) ТУЗ-ийн хөндлөнгийн байр суурь (objectivity), хараат бус байдал (independence): ТӨХЭ-ийн нэг онцлог нь ТУЗ-д төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгч байдаг явдал байдаг. Иймд ТӨХЭ-тэй холбоотой онолын маргааны цөм нь ТУЗ-д төр ба хувийн хэвшлийн төлөөллийг хэрхэн тэнцвэртэйгээр хангах тухай асуудал байдаг.

Ихэнхи улсад төрийн өмчийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгчийг төрийн албанаас шууд томилох явдал нийтлэг байна. Энэ нь ТУЗ-ийг хараат бусаар бие даан шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлдөг.

Төрийн төлөөллийн томилгоо ТУЗ-ийн бие даасан, хараат бус байдлын хамаарлыг дор үзүүлэв.⁸⁰

- **Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгч:** Төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч төлөөлөгчийг шууд томилох (хяналтаа бүрэн тогтоох) хэлбэр.
- **Бусад төлөөлөгч:** Хууль болон журамд тусгагдсан шаардлагыг хангасан, төрийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гишүүн. Зарим улсад ийм гишүүнийг хувийн хэвшил, академик салбараас томилж, төрийг төлөөлөн хувьцаа

⁷⁸ OECD, Professionalising BOARD of Directors of State-Owned Enterprises: Stocktaking National Practices OECD Publishing (2018);

⁷⁹ OECD, supra note. 1, at 48.

⁸⁰ OECD, Corporate Governance Board of State-Owned Enterprises: An Overview of National Practices (2013)

эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээлгэдэг. Гэвч төрийн албанаас томилох явдал илүү түгээмэл байна.

- **Холбоо хамаарал бүхий төлөөлөгч:** Сайд болон эрх бүхий албан тушаалтнаас нэр дэвшүүлэн томилдогдсон гишүүд. Гэхдээ нь төрийг төлөөлөх үүргийг шууд хүлээдэггүй. (зарим улс оронд улс төрийн байгууллага, намаас томилдог)
- **Хараат бус гишүүн:** Тухайн улсын хууль тогтоомж дахь ТӨХЭ-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүний шалгуурыг хангасан гишүүн.

Хараат байдал ←-----► **Хараат бус байдал**

Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгч	Бусад төлөөлөгч	Холбоо хамаарал бүхий төлөөлөгч	Хараат бус гишүүн Төрийн оролцоогүй
---	-----------------	------------------------------------	--

ЭЗХАХБ-ын гишүүн улсууд ТУЗ-ийн хараат бус байдлыг сайжруулах чиглэлээр харилцан адилгүй арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаа (ихэвчлэн 3-5 жил), ажлаас чөлөөлөх нөхцлүүдийг хууль тогтоомжид тодорхой тусгадаг. Ингэснээр албан тушаалтан өөрийн хамаарал бүхий этгээдийг томилох боломжийг хязгаарлаж, ТУЗ-ийн гишүүн тодорхой ашиг сонирхлын нөлөөнд автахгүйгээр тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлдэг.

Мөн ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох үйл явцад холбогдох төрийн байгууллага, яам гэх мэт олон талын төлөөллийг оролцуулах эсвэл бие даасан тусгай нэгж байгуулах замаар сонгон шалгаруулалтыг хийдэг байна. Үр дүнд нь эрх бүхий албан тушаалтны ашиг сонирхлыг хэрэгжүүлэх гишүүн сонгогдох магадлал бага гэж үздэг байна.

iii) Төрийн алба ба хувийн салбарын зохицол (public versus private): ЭЗХАХБ-ын гишүүн улсуудад ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 1) төрийн алба болон хувийн хэвшлээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх, 2) төрийн албанаас бүрдүүлэх, 3) төрийн албанаас огт бүрдүүлэх шаардлагагүй гэсэн гурван үндсэн хандлага тогтсон байна.

Сайн туршлага:

Гүйцэтгэх засаглалын байгууллагатай шууд хамаарал бүхий этгээдийг ТУЗ-ийн бүрэлдэхүүнд оруулахгүй байх хэрэгтэй. Бусад төлөөлөгчийг ч хувь хүний ур чадвар, ажлын туршлагыг шалгуур болгон нэр дэвшүүлэ сонгох хэрэгтэй.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг төрийн албанаас бүрдүүлэх нь тохиромжтой гэх хандлага нь олон нийтэд үйлчлэх зорилготой (төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий) ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг ТӨХЭ-д илүү тохиромжтой юм.

ТУЗ-ийн гишүүнийг төрөөс томилохтой холбоотойгоор а) шууд хориглох, б) тоон хязгаарлалт тогтоох, в) ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой шалгуур тогтоох гэсэн үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Ийнхүү ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад ТУЗ-ийн гишүүдийг төрийн алба болон хувийн хэвшлээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх, сайд, эрх бүхий төрийн албан тушаалтанаас нэр дэвшүүлсэн эсвэл гүйцэтгэх засаглалын байгууллагатай шууд хамаарал бүхий этгээдийг ТУЗ-ийн бүрэлдэхүүнд багтаахыг дэмждэггүй практик нийтлэг байна.

iv) Хараат бус гишүүний үр нөлөө: ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнд тавигдах хамгийн түгээмэл шалгуурын нэг бол өндөр түвшний мэдлэг, ажлын туршлага бүхий хараат бус гишүүнийг хувийн хэвшлээс сонгон ТУЗ-ийн бүрэлдэхүүнд оруулах юм.

Компанийн засаглалын зарчмын хүрээнд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь компанийн бие даасан, хараат бус байдлыг бий хангахад чухал үүрэгтэй гэж үздэг. Улс орнууд хууль тогтоомж болон тусгайлан журам гаргах байдлаар нээлттэй хувьцаат компани болон ТӨХЭ-ийн ТУЗ-д хараат бус гишүүнийг заавал ажиллуулах шаардлагыг тогтоосон байдаг. Тухайлбал, Скандинавын орнууд болон БНАУ (цаашид Австри улс гэх), ХБНГУ (цаашид Герман улс гэх), НВУ (цаашид Голланд улс гэх), Шинэ Зеланд гэх мэт улсад ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийг хувийн салбараас сонгогдсон хараат бус гишүүдээс бүрдүүлдэг.

Сайн туршлага:

Хараат бус гишүүн нь гүйцэтгэх удирдлага, засгийн газраас үйл ажиллагааны хувьд бүрэн хараат бус байх ёстой. Үүний тул тохиромжтой нэр дэвшигчийг сонгон шалгаруулах оновчтой механизмыг бүрдүүлэх ёстой.

Хараат бус байх гэдэг нь ТӨХЭ-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор төр, гүйцэтгэх удирдлагатай ямар нэг хамааралгүй байхыг ойлгоно. Гэхдээ улс орнуудад хараат бус байдалд харилцан адилгүй шалгуур тогтоосон байдаг. Тухайлбал, АХУ (цаашид Австрали улс гэх) болон НВУ (цаашид Норвеги улс гэх)-д хувийн хэвшлээс сонгогдсон хараат бус гишүүн нь тухайн хуулийн этгээдтэй ямар нэг ажил хэргийн харилцаа холбоогүй байхаас гадна адил салбарт өрсөлдөх хэлбэрээр үйл ажиллагаа явуулахыг хориглодог. АХУ (цаашид Австрали улс гэх) болон НВУ (цаашид Норвеги улс гэх)-

Харин БНГУ (цаашид Грек улс гэх) ТУЗ-ийн хараат бус гишүүнд: 1) гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн даргын албан тушаалд давхар ажиллахгүй байх, 2) тухайн компанитай бизнесийн болон бусад хэлбэрээр харилцан хамааралгүй байх, 3) ТУЗ-ийн бусад гишүүд болон гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй ашиг сонирхлын зөрчил, гэр бүлийн харилцаа холбоогүй байх; 4) тухайн хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэггүй байх гэсэн шалгуурыг тогтоож өгчээ.⁸¹

v) ТУЗ дахь ажилтны төлөөлөл (employee representatives): Зарим улсад ТӨХЭ-ийн ТУЗ-д ажилтны төлөөллийг багтаах бодлогыг баримталдаг.

ТУЗ-д ажилтны төлөөллийг багтаах нь: 1) ТУЗ нь ажилтнууддаа бусад хувьцаа эзэмшигчдийн адил үйл ажиллагаагаа тайлагнах, улмаар хариуцлага хүлээх, 2) ТУЗ нь шийдвэр гаргахдаа зөвхөн ажилтны үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэддэг нарийн мэдээллүүдийг ашиглах, 3) хүний нөөцийн бодлого, ажилтны нийгмийн асуудлын тухай

⁸¹ OECD, supra note 1, at 53.

мэдээллийг илүү ойроос авах, 4) ажилчдын дэмжлэгтэйгээр ТУЗ-ийн шийдвэр хурдан шуурхай хэрэгжих зэрэг давуу талуудыг бий болгодог.

Ихэнхи улсад ТУЗ-д ажилтны төлөөлөл байх нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад эерэг нөлөөтэй гэж үздэг. Харин ТУЗ дахь ажилтны төлөөлөл нь ТУЗ-ийн бусад гишүүдийн нэгэн адил үүрэг, хариуцлага хүлээх тул хангалттай мэдлэг, ур чадвар, туршлагатай байх ёстой. Мөн ашиг сонирхол, нөлөөллөөс хамгаалах механизмыг бүрдүүлэх шаардлагатай байдаг. Ажилтны төлөөллийг сонгох үйл явцыг бүх ажилтны оролцоог хангасан нээлттэй ил тод хэлбэрээр явуулахад анхаарах ёстой.⁸²

Сайн туршлага:

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажилтны төлөөлөл байх нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл явц, хэлэлцүүлгийг улам баяжуулдаг. Гэвч ажилтны төлөөлөгч нь хангалттай мэдлэг, ур чадвар мэргэшсэн байх, ажилтнуудын эрх ашгийг төлөөлөх статусыг хэрэгжүүлэх чадвартай байх зэрэг шалгуурыг хангах ёстой.

Австри, БНЧУ (цаашид Чех улс гэх), БНФУ (цаашид Финланд улс гэх), Норвеги, ДВУ (цаашид Дани улс гэх) болон Герман улсын хувьд ТУЗ-д ажилтны төлөөллийг багтаах нь нийтлэг жишиг болж хэвшсэн байдаг бол БНФУ-д (цаашид Франц улс гэх) ажилтны төлөөлөлд квот (хоёр гишүүн, эсвэл гуравны нэг гэх мэт) тогтоосон байдаг.

vi) ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага буюу ур чадварт суурилсан шалгуур (skill based qualifications): ТУЗ-ийн гишүүнийг сонгох үйл ажиллагааны гол цөм нь нэр дэвшигчийн мэдлэг, ур чадварыг бодитойгоор үнэлэх боломжтой шалгуур тогтоон, сонгон шалгаруулалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах явдал юм. ЭЗХАХБ-ын гишүүн улсууд ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадварын шаардлагыг харилцан адилгүйгээр тогтоосон (гол төлөв боловсролын түвшин, ажлын туршлагад тулгуурласан) боловч ур чадвар, хувь хүний зан төлөв, онцлог шинжинд суурилсан шалгуурыг тогтоох хандлага (outcomes-oriented approach) давамгайлж байна.

Зарим улсад ТУЗ-ийн гишүүнд тавигдах нийтлэг шалгуурыг хуулиар хатуу тогтоохоос татгалзаж, сул орон тоон дээр тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаатай уялдсан тусгай шалгуурыг тухай бүрт тогтоон сонгон шалгаруулах (case by case approach) хандлага мөн түгээмэл байна.

Сайн туршлага:

ТУЗ-ийн гишүүнд тавигдах үндсэн шаардлагыг хуулиар тогтоож өгөх хэрэгтэй. Гэхдээ ур чадвар, ажлын туршлага болон хувь хүний зан төлөвийг хослуулан үнэлэх боломжтой шалгуурыг тогтоох нь зүйтэй.

Ийнхүү ТУЗ-ийн гишүүнд тавих шаардлага улс орнуудад харилцан адилгүй байх боловч нийтлэг байдлаар ТУЗ-д төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгчид тавигдах шаардлагыг хуулиар тодорхойлох нь зөв гэж үздэг.⁸³ Тухайлбал Австрали Улс ТУЗ-ийн гишүүнд байх ёстой олон талт ур чадварыг хослуулан дүгнэх

⁸² Id. at 54.

⁸³ Id. at 55.

боломжтой шалгуур тогтоожээ. Энэ нь ТУЗ-ийн гишүүнд бизнес, санхүү, нятлан бодох бүртгэл, хуулийн мэдлэг, туршлага, худалдааны болон харилцаа, удирдлагын ур чадвар зэрэг олон чадварыг хослуулан эзэмшсэн нэр дэвшигчийг шалгаруулж авахад тусалдаг. Израйл Улс нь хууль тогтоомждоо ТУЗ-ийн гишүүнд тавигдах нийтлэг шаардлагыг (өндөр түвшний академик мэдлэгтэй, 5 жил хүртэл ажилласан туршлагатай гэх мэт) тогтоосон байх ба томоохон ТӨХЭ-ийн ТУЗ-д тавих тусгай шаардлагыг ТӨХЭ-ийн газраас (Government Companies Authority) нэмж тодорхойлжээ.

vii) ТУЗ-ийн бүтэц: ЭЭЗХАХБ-ын гишүүн улсуудад ТУЗ нь ихэвчлэн төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэх төлөөлөгч (ихэнхи тохиолдолд төрөөс томилогддог) болон хараат бус гишүүдээс бүрдсэн байдаг. Ингэхдээ тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл болон төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээнээс хамааран ТУЗ-ийн бүрэлдэхүүн харилцан адилгүй байна. Тухайлбал,

- ТӨК – төр хувьцааг нь 100 хувь эзэмшдэг
- ТӨОК – хувьцааных нь 20-75 хувийг төр эзэмшдэг гэж ангилж байна.

Гол төлөв хувьцааг нь 100 хувь төр эзэмшдэг ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийг төрөөс томилогдсон гишүүд бүрдүүлдэг бол ТӨОК-ний хувьд ТУЗ-ийн гишүүнийг томилох бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн хурал хэрэгжүүлдэг байна.

Мөн ТӨХЭ-ийг үйл ажиллагааны чиглэлээс нь хамааран:

- Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зориулалт бүхий (нийтэд үйлчлэх тусгай зориулалт) ТӨХЭ
- Төрийн стратеги бодлогыг хэрэгжүүлэх (үндэсний баялгийн сан, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулдаг гэх мэт) чиг үүрэг бүхий ТӨХЭ
- Ашгийн төлөө буюу арилжааны үйл ажиллагаа явуулдаг ТӨХЭ хэмээн ангилж болно.

ТӨХЭ нь нийтэд үйлчлэх зорилготой эсвэл төрийн стратегийн чухал бодлогыг хэрэгжүүлэх тохиолдолд ТУЗ-ийг нь төрөөс бүрдүүлэх нь илүү тохиромжтой байдаг.⁸⁴

Гэхдээ ТУЗ-ийг улс төрийн нөлөөллөөс хараат бус байлгахын тулд зарим улс оронд ТУЗ дахь төрийг төлөөллийн тоо (квот) эсхүл дээд хязгаарыг нь тогтоох, тодорхой нөхцөл шаардлага тавих замаар төрийн оролцоог хязгаарладаг. Мөн ТУЗ-ийн хараат бус, мэргэшсэн байдлыг хангахын тулд ихэнх улсад ТУЗ-ийн гишүүнд тодорхой шалгуур тогтоож, ажиллах хугацааг (ихэвчлэн 3-5 жил) нь хязгаарлаж өгдөг байна. тодорхой болгох зэрэг шалгуурыг тогтоож өгсөн байдаг.

Үүнээс гадна хөрөнгө оруулалт ихтэй томоохон ТӨХЭ-ийн ТУЗ-д хувийн хэвшлийн компанийн ТУЗ-тэй адил шаардлага тавьж, заавал хараат бус гишүүн байхыг шаарддаг.

⁸⁴ OECD, Owner and Governance of State-Owned Enterprises: A Compendium of National Practices, OECD Publishing (2018) 64.

Хүснэгт. Зарим улс дахь ТӨХЭ-ийн ТУЗ-ийн бүтэц

	Хараат бус гишүүн (дээд, доод хязгаар)	Төрөөс томилогдсон төлөөлөгч	Төрөөс томилогдох төлөөлөгчийн тооны хязгаар	Ажилтны төлөөлөл	Жендэрийн квот	
					Хууль, журамд тусгасан	Шалгуур хангасан тохиолдолд
Австрали	Бүх гишүүн	Байхгүй	-	Байхгүй	-	-
Чили	-	-	5	-	-	40 хүртэлх хувь нь эмэгтэй байх
Дани	Бүх гишүүн (ихэнх тохиолдол)	Байхгүй	-	1-3 гишүүн	-	Жендэрийн тэнцвэрт байдлыг дэмждэг
Финланд	Бүх гишүүн (ихэнх тохиолдол)	2 хүртэлх гишүүн		хамгийн багадаа тавны нэг		40/40 хувь эмэгтэй, эрэгтэй
Франц	1-3 гишүүн	1-3 гишүүн		1-3 гишүүн	40 хувь хүртэл эмэгтэй	
Герман	Бүх гишүүн (ихэнх тохиолдол)	2 хүртэлх гишүүн		гуравны нэг эсвэл 50 хувь хүртэл	30 хувь хүртэл эмэгтэй	
Голланд	Байгаа	Байхгүй	Байхгүй	гуравны нэг		Албан бус (30 хувь хүртэл эмэгтэй)
Испани	Байгаа (50 хувь хүртэлх)	Байгаа		Байгаа (2-3 гишүүн)		Жендэрийн тэнцвэрийг бий болгох зорилттой
Шинэ Зеланд	Бүх гишүүн (ихэнх тохиолдол)	Байхгүй		Байхгүй	Сонголттой. (Үндэстний цөөнхийг багтаах)	
Норвеги	Байгаа (ихэнх)	Байхгүй	Байхгүй	гурваны нэг хүртэл	40 хувь хүртэл эмэгтэй	
Швед	Байгаа (90 хувь хүртэлх)	Байхгүй (Зөвхөн хөрөнгө оруулалтын чиг үүргийг хариуцсан ТУЗ-ийн	Байхгүй	Байгаа 2 гишүүн, эсхүл 50 хувь хүртэл, эсхүл 1000 ажилтантай	40 хувь хүртэл эмэгтэй гишүүн	

		гишүүний чиг үүргийг төрөөс томилогдсон гишүүн хэрэгжүүлнэ)		тохиолдолд 3 гишүүн, ТУЗ-ийн гишүүдийн 50 хувиас хэтрэхгүй байх)		
Турк	Байхгүй (нээлттэй ХК-д заавал ажиллах)	Байгаа		Байхгүй	Тусгайлан заагаагүй	Тусгайлан заагаагүй
Өмнөд Солонгос	Байгаа (1.8 тэрбум доллараас дээш хөрөнгө оруулалттай бол ТУЗ-ийн олонх нь хараат бус гишүүдээс бүрдэх)	Байгаа (1.8 тэрбум доллараас доош хөрөнгө оруулалттай ТӨК-ийн ТУЗ-ийн дөрөвний нэг нь хараат бус гишүүдээс бүрдэх)				

Мөн зарим улсад ТУЗ-ийн бүрэлдэхүүн дэх эмэгтэй гишүүний тоонд квот тогтоох хандлага гарч эхэлсэн ч албан ёсоор хуульчилсан нь харьцангуй цөөн байна.⁸⁵ Үүнээс гадна зарим улс оронд төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг хэрэгжүүлэх төлөөлөгчийг хувийн хэвшил, академик салбар, мэргэжлийн байгууллага, холбоодоос сонгон шалгаруулах хандлага гарч эхэлж байна.⁸⁶

Б. ТУЗ-ийн гишүүнийг томилох

ТӨХЭ-ийн ТУЗ-д төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэхээр томилогдсон төлөөлөгч нь бизнес, санхүүгийн мэдлэг туршлагын хувьд дутмаг бөгөөд эрх баригч намын удирдлага, улс төрийн лидер, эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд байх нь элбэг. Ийм байдлаар томилогдсон төлөөлөгч нь ТУЗ-ийн гишүүний чиг үүргийг (эрсдлийн удирдлага, дотоод хяналт, аудит, гүйцэтгэх удирдлагын хяналт, стратеги бодлого тодорхойлох гэх мэт) үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж сул байдаг. Өөрөөр хэлбэл ТУЗ-ийн гишүүний мэргэшсэн байх шалгуурыг хангаж чаддаггүй гэсэн үг юм.

Мэргэшсэн байх шалгуурыг хангаагүй хүмүүсээр ТУЗ-ийг бүрдүүлэх нь түүний ажлын гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлдөг. Улмаар тухайн төлөөлөгч шийдвэр гаргахдаа ТӨХЭ-ийн ашиг сонирхлоос илүүтэй түүнийг өөрийг нь томилсон албан тушаалтны ашиг сонирхлыг дээгүүр тавих магадлал өндөр. Энэ нь ТӨХЭ-ийг алдагдалтай ажиллахад хүргэдэг гол хүчин зүйлсийн нэг билээ.

⁸⁵Toolkit, supra note 18, at 166.

⁸⁶ Id.

Харин ийм нөхцөл байдал үүсэхэд хүргэх хүчин зүйлсийн нэг нь ТӨХЭ-ийн ТУЗ-д нарийн мэргэшил, өндөр мэдлэг, ур чадвар бүхий хүнийг сонгон шалгаруулж авахад чигилэсэн нээлттэй бодлого, дүрэм, журам байхгүй явдал юм.

Зөвлөмж⁸⁷

ТУЗ-ийг компанийн ашиг сонирхлын тулд зөв, оновчтой шийдвэр гаргах чадвартай, ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй, хувийн хэвшлийн тэнцвэртэй төлөөлөл бүхий мэргэшсэн, туршлагатай гишүүдээр ТУЗ-ийг бүрдүүлэх хэрэгтэй.

Зарим улсад бараг уламжлал болж тогтсон нийтлэг жишиг бол төрийн өмчийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэх төлөөлөгчийг зөвхөн төрийн албанаас сонгон томилох хандлага юм. Гэхдээ ТУЗ-ийг төрийн албанаас бүрдүүлэх энэ хандлага нь олон нийтэд үйлчлэх зорилготой (төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий) арилжааны бус ТӨК-д илүү тохиромжтой. Тухайлбал, Швед Улс нийтэд үйлчлэх тусгай зорилго бүхий арилжааны бус ТӨК-д энэхүү чиг үүргээ тогтвортой хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд харилцан уялдаатай, хурдан шуурхай ажиллах боломжийг нэмэгдүүлэх үүднээс ТУЗ-ийг төрийн албанаас бүрдүүлдэг байна.⁸⁸

Гэхдээ сүүлийн үед ЭЗХАХБ-ын гишүүн болон гишүүн бус улс орнуудад ч ТУЗ дахь төрийн төлөөллийн тоог багасгаж, хараат бус гишүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх хандлага давамгайлж байна. Өөрөөр хэлбэл, ТУЗ-ийн бие даасан, мэргэшсэн байдлыг хадгалах зорилгоор а) ТУЗ-д төрийн төлөөллийг хориглох, б) тоон хязгаарлалт тогтоох, в) ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тодорхой шалгуур тогтоох гэсэн арга хэмжээг авч эхэлжээ. Үүнд:

- Сайд болон бусад эрх бүхий албан тушаалтны томилгоо хийх эрхийг хязгаарлах;
- Сайд болон бусад эрх бүхий албан тушаалтан ТУЗ-д ажиллахыг хориглох. Тухайлбал, Норвеги Улсад парламентийн гишүүн, сайд, төрийн нарийн бичгийн дарга нарыг өөрийн харьяалах салбарт ТӨХЭ-ийн ТУЗ-д ажиллахыг хориглодог. Мөн чиг үүргийн хувьд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаатай шууд холбогдох ажил эрхэлдэг төрийн албан хаагч, улс төрчдийг ч ТУЗ-д ажиллахыг хязгаарладаг.
- Хувийн хэвшлээс сонгогдсон гишүүдийн тоог нэмэх байдлаар төрийн төлөөллийг тоог хязгаарлах. Энэтхэг Улсад салбарын яамнаас ТӨХЭ-ийн ТУЗ-д дээд тал нь 2 албан хаагчийг нэр дэвшүүлж болно.
- ТУЗ-д зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан хаагч ажиллахыг хориглох. Малайз Улсад ТӨОК-ийн улс төрөөс хараат бус чадвар, бизнесийн үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын албан тушаалтан ТУЗ-д нь ажиллахыг хориглодог.⁸⁹
- Өмнөд Солонгост ТУЗ-ийн гишүүнийг төрөөс томилж болох боловч гагцхүү академик салбар, хувийн хэвшлээс сонгон шалгаруулалт хийж томилоно.⁹⁰

⁸⁷ The World Bank, A Toolkit: Corporate Governance of State-Owned Enterprises, (2014)

⁸⁸ OECD, supra note, at 52;

⁸⁹ Toolkit, supra note 18, at 166.

⁹⁰ OECD, supra note, at 52;

- Тоон хязгаар тогтоох. Финланд Улсад ТУЗ-ийн зөвхөн нэг гишүүн нь төрийн албаны төлөөлөл байж болно.
- Шалгуур тогтоох. Австрали Улсад төрийн байгууллагын албан хаагчдыг зөвхөн хуульд заасан нөхцөл, шалгуурыг хангасан (*ажлын ур чадвар, туршлага, ашиг сонирхлын зөрчилгүй байх гэх мэт*) тохиолдолд ТУЗ-д ажиллахыг зөвшөөрдөг байна⁹¹.

Израйл Улсад сайдын албан тушаал хашиж буй этгээдтэй бизнесийн болон улс төрийн хамааралтай хүнийг ТӨХЭ-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилохыг зөвшөөрдөг байна. Гэхдээ хуулиар тусгайлан олон шалгуур тогтоосон тавьдаг. Томилгооны хяналтын хороо нь нэр дэвшигчийг тухайн шалгуур нэг бүрээр судлан дүгнэлт гаргадаг.

Зарим улсад ТУЗ-д төрөөс томилогдох гишүүний тоог хязгаарлах зорилгоор дараах шалгуурыг тогтоож өгсөн байдаг. Үүнд:

- Тухайн томилгоо нь ТУЗ-д ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх;
- Томилгоо нь мэдлэг, ур чадварыг үнэлэх зарчимд тулгуурласан байх;
- Томилогдсон гишүүн нь ажил үүргээ өөрөө биечлэн гүйцэтгэх буюу ямар нэг байдлаар бусдад шилжүүлэхийг хориглох;
- Тухайн гишүүнд ТУЗ-ын бусад гишүүдтэй нэгэн адил шалгуур тавьж, ажлын гүйцэтгэлийг нь адилхан үнэлэх, шаардлагатай тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлөх;
- Томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн бусад гишүүдийн адил хариуцлага болон ажил хэргийн нэр хүнд унах эрсдэлийг (reputational risk) хүлээх;
- Томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн бусад гишүүний адил ур чадвар, ялангуяа удирдан чиглүүлэх чадвартай байх ёстой;
- Төрийн төлөөлөгч нь ТУЗ-ийн дарга болон орлогч даргын албан тушаал хашихгүй байх.

III. МОНГОЛ УЛС ДАХЬ ТӨХЭ-ИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

A. Монгол Улсын төрийн өмчит уул уурхайн компани

Монгол Улсын уул уурхайн салбар нь эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг бөгөөд ОУИТБС-ийн 2019 оны тайлангаас үзэхэд ДНБ-ний 23.7 хувийг дангаар бүрдүүлж байна. Уул уурхайн салбарт голлох ашигт малтмалыг нүүрс, зэс, алт, мөнгө, төмөр эзэлдэг. Мөн уул уурхайн салбарт 20 гаруй томоохон ТӨХЭ үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрийн тал хувийг ТӨК болон ТӨОК-иуд эзэлж байна.

⁹¹Id.

Хүснэгт. Уул уурхайн салбар дахь ТӨК болон ТӨОК

д/д	Хуулийн этгээдийн нэр	Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч	Аж ахуйн нэгжийн төрөл	Үйл ажиллагаа	Төрийн эзэмшил
1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (цаашид ТӨБЗГ гэх)	ТӨҮГ "ААТ"	Зэс	100%
2	"Монголросцветмет" ТӨҮГ		ТӨҮГ "ААТ"	Жонш, төмөр, алт, хайрга, элс	100%
3	"Эрдэнэс монгол" ХХК	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	ТӨХХК	Хувьцаа	100%
4	"Оюу толгой" ХХК	"Эрдэнэс Оюу Толгой" ХХК	ТӨОХХК	Зэс	34%
5	"Эрдэнэс Таван Толгой" ХК	"Эрдэнэс Монгол" ХХК	ТӨОХК	Нүүрс	85.5%
6	"Эрдэнэс Оюу Толгой" ХХК		ТӨХХК	Хувьцаа	100%
7	"Мон Атом" ХХК		ТӨХХК	Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, олборлолт	100%
8	"Эрдэнэс алт ресурс" ХХК		ТӨХХК	Алт	100%
9	"Эрдэнэс метан" ХХК		ТӨХХК	Метан	100%
10	"Багануур" ХК		ТӨОХК	Нүүрс	75%
11	"Шивээ овоо" ХК		ТӨОХК	Нүүрс	90%
	Нийт дүн		ТӨҮГ – 2 ТӨОХХК – 1 ТӨХХК – 5 ТӨОХК – 3 Нийт - 105		

Уул уурхайн салбарт ажилладаг хуулийн этгээд нь аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон компанийн хэлбэрээр зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Харин уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг 1) ТӨБЗГ, 2) Засгийн газрын хэрэг эрхлэх газар, 3) Эрдэнэс Монгол ХХК хэрэгжүүлж байна. 2020 оны байдлаар ТӨК болон ТӨОК нийлсэн нийт 105 компанид 629-н ТУЗ-ийн гишүүн ажиллаж байна.⁹² Үүнд:

- ТӨХК - 423 гишүүн
- ТӨХХК – 130 гишүүн
- ТӨОК - 76 гишүүн тус тус байна.

⁹² Дэд ажлын хэсгийн тайлан, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга” тайлан 47 тал (2020).

Үүний 288 нь Эрдэнэс Монгол ХХК-ийн охин болон хараат компаниудын ТУЗ-ийн гишүүд байна.

Б. ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн

Монгол Улсын хувьд ТӨК-ийн ТУЗ-ийн бүтцийг Компанийн тухай хуулиар тодорхойлдог ба энэ нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-иудад ч нэгэн адил хамаарна.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т “...төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна” хэмээн заажээ.

Эндээс дараах хоёр дүгнэлтийг хийж болохоор байна.

- ТӨК-ийн ТУЗ нь доод тал нь 9-н гишүүтэй байх;
- ТӨК-ийн ТУЗ нь ердийн болон хараат бус гишүүнээс бүрдэх бөгөөд хараат бус гишүүний тоо нь нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй байх.

Улмаар уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-иудын ТУЗ-ийн бүтцийн өнөөгийн байдлын тодруулах үүднээс “Эрдэнэс Монгол” ХХК болон түүний ТУЗ бүхий охин компаниудын ТУЗ-ийн бүтцийг авч үзлээ.

Хүснэгт 15. ТӨК болон ТӨОК-ний ТУЗ-ийн бүрэлдэхүүн

№	Компанийн нэр	Үйл ажиллагаа	ТУЗ-ийн гишүүдийн тоо	Хараат бус гишүүдийн тоо	Төрийн эзэмшил
1	“Эрдэнэс Монгол” ХХК	Уул уурхай салбарт үйл ажиллагаа явуулж ТӨК болон ТӨОК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх	9	3	100 хувь
	“Эрдэнэс Таван Толгой” ХК	Коксжих нүүрс	9	3	80 хувь
2	“Багануур” ХК	Нүүрс олборлох	12	4	75 хувь
3	“Шивээ Овоо” ХК	Нүүрс олборлох	9	3	90 хувь
4	“Эрдэнэс Оюу” ХХК	“Оюу Толгой” ХХК-ын төрийн эзэмшлийн хувьцааны эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх	-	-	100 хувь
5	“Оюу Толгой”	Зэс олборлох	9	-	34 хувь
6	“Мон Атом” ХХК	Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаа	-	-	100 хувь
7	“Эрдэнэс Метан” ХХК	Нүүрсний давхаргын метан хийн эрэл судалгаа болон бусад	-	-	100 хувь

8	“Эрдэнэ Шивээ Энержи” ХХК	Эрчим хүчний экспортын Шивээ Энержи цогцолбор төсөл”-ийг нүүрсээр хангах	-	-	50 хувь
9	“Гашуун Сухайт Автозам” ХХК	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн замын хариуцагч	-	-	100 хувь
10	“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК	Ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах	-	-	100 хувь
11	“Эрдэнэс Алт” ХХК	Үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах	-	-	100 хувь
12	“Эрдэнэс Ашид” ХХК	Геологийн хайгуул, судалгаа	-	-	50 хувь
13	“Эрдэнэс Стийл” ХХК	Кокс, ган төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх	-	-	50 хувь

Эндээс үзэхэд Эрдэнэс Монгол ХХК-ийн охин, хараат компаниудын дотор ТУЗ бүхий компани 4 байх бөгөөд хараат бус гишүүдийн тоо Компанийн тухай хуульд заасан 1/3-ийн квотоор хязгаарлагдаж байна.

Мөн Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компанийн хувьд Компанийн тухай хуульд заасан ТӨК-д хамаарахгүй хэмээн үздэг тул заавал ТУЗ байгуулах, хараат бус гишүүнтэй байх хуулийн шаардлага үйлчлэхгүй байна.⁹³ ТУЗ байгуулах нь Эрдэнэс Монгол ХХК-ийн жижиг хэмжээний охин компаниудын хувьд ихээхэн хэмжээний зардал шаардах тул энэ нь оновчтой байж болох юм.

IV. ДҮГНЭЛТ

ТУЗ-ийн бүтцийн хүрээнд тухайн ТӨК-ийн үйл ажиллагааны зорилгыг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, арилжааны бус ТӨК-ийн хувьд түүний ТУЗ дэх төрийн албан хаагчийн оролцоог зөвтгөх хандлага байна. Ингэснээр зохицуулах байгууллагын бодлого болон ТӨК-ийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирна гэж үздэг.

Харин арилжааны ТӨК-ийн хувьд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тэнцвэртэй байх зарчмыг нийтлэг баримталдаг. ТУЗ-ийн гишүүд тэнцвэртэй байх гэдэг нь 1) гүйцэтгэх удирдлага, түүний багт давхар ажилладаг ТУЗ-ийн гишүүн, 2) гүйцэтгэх удирдлага, түүний багт ажилладаггүй ТУЗ-ийн гишүүн, 3) хараат бус гишүүн, 4) ажилчдын төлөөлөл гэх мэт олон талын төлөөллийн тэнцэртэй хангасан байхыг ойлгоно.⁹⁴ Сүүлийн жилүүдэд ТУЗ-ийн бүтцэд хараат бус гишүүд, ажилчдын оролцоог нэмэгдүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах асуудал хүчтэй яригдаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын хувьд дараах гурван хандлагыг хэрэгхэн хэрэгжүүлж байгаа авч үзье.

⁹³ Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнтэй хийсэн ярилцлага. 2021.07.21

⁹⁴ Toolkit, supra note 18, at 163.

Хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх

Манайд ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлагыг тавих боловч хараат бус гишүүний бие даасан байдал, чадварын дутмаг хэвээр байна. Тухайлбал, ТӨК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд улс төрийн холбоо бүхий этгээд эсхүл тухайн ажил үүргийг гүйцэтгэх чадваргүй хүн томилогдох тохиолдол гарч байна.⁹⁵

Мөн “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-д ТӨК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг төрийн захиргааны албан хаагчдаас бүрдүүлэхээр заажээ. Тухайлбал, Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний 2/3 нь төрийн захиргааны албан хаагчдаас бүрдэж байна. Энэ нь ТӨК болон ТӨОК-ийн ТУЗ-ийн хараат бус байдлыг сулруулахаас гадна ур чадварын хувьд ТУЗ-ийн чиг үүргийг гүйцэтгэхэд хангалтгүй байдаг тул компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө.

Нөгөө талаар “Эрдэнэс Монгол” ХХК-ний нэгдлийн жишиг загвар харж буй Сингапур улсын “Тэмасек” ХХК-ний нэгдлийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг авч үзвэл гишүүдийн дийлэнх олонх нь хувийн хэвшлээс гаралтай хараат бус гишүүд байгааг анхаарах нь зүйтэй.

Ажилчдын төлөөллийг оролцуулах

Монгол Улсын хувьд ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажилтны төлөөллийн оролцоог хангах зохицуулалт байхгүй, гэхдээ бас хуулиар хориглоогүй юм. Бодит байдал дээр ч уул уурхайн салбар дахь ТӨХЭ-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажилтны төлөөлөл орсон тохиолдолд гараагүй байна.

Харин зарим улсад ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд ажилтны төлөөллийг оруулах механизм хэрэгжиж байна. Тухайлбал, Чили Улсын төрийн өмчит уул уурхайн компани болох ҮЗК-ийн ТУЗ-ийн 9 гишүүний 2 нь, ҮГТК-ийн хувьд ТУЗ-ийн 7 гишүүний 1 нь ажилчдын төлөөлөл байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах

Монгол Улсын хувьд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд жендэрийн тэгш байдлыг хангах асуудал чухал байна. Тухайлбал, Эрдэнэс Монгол ХХК болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн гишүүд нь 100 хувь эрэгтэй байна.

Олон улсад ч ТУЗ-ийн бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах асуудал чухлаар тавигдаж байна. Тухайлбал, Чили Улс нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ТӨК-ийн удирдлагад жендэрийн тэгш байдлыг хангах бодлого хэрэгжүүлснээр БЗС-ын харьяа компаниудын ТУЗ-ийн гишүүдийн наад зах нь 40 хувь нь эмэгтэй гишүүд болсон байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас жендэрийн тэгш байдлыг хангах үүднээс ТӨК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад манлайлал үзүүлэх шаардлагатай.

⁹⁵ Эрдэнэс Тавантолгой ХХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнтэй хийсэн ярилцлага /2021.07.21/.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

I. Монгол эх сурвалж

Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, 2021

“Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-д Монгол Улсыг төлөөлөх гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтын зар, <https://montsame.mn/mn/read/236431>

“Эрдэнэс Монгол” ХХК-д хийсэн үнэлгээ, <https://resourcegovernance.org/sites/default/files/documents/erdenes-mongol-mongolian.pdf>

Г.Давааням, Үндэсний баялгийн сангийн засаглал: Сингапур улсын Темасек загварын туршлага, 78 Хууль дээдлэх ёс, №3 97, (2020);

Д.Байлхүү, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын засаглалын үнэлгээ, 2014;

Д.Байлхүү, Төрийн өмчит эрчим хүчний компаниудын засаглалын үнэлгээ, 2014;

О.Отгонбаяр, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд хамаарах эрх зүйн тулгамдсан асуудал, МУИС-ХЗС-ийн Магистрын ажил, 2020 ;

Үндэсний аудитын газар, “Эрдэнэс монгол ХХК-ийн үйл ажиллагаа үндсэн зорилго чиглэлийн дагуу явагдаагүй байна” гүйцэтгэлийн аудитын тайлан. 2019

Ц.Одмаа, Төрийн өмчийг удирдах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал, 47 Эрх зүй №3 49, 2019;

Эрдэнэс Монгол ХХК-ийн вэб хуудас <http://erdenesmongol.mn/index.php?view=article&type=item&val=211> ;

Эрдэнэс Тавантолгой ХК санхүүгийн тайлангийн аудит <https://ett.mn/mon/184/file1> ;

II. Гадаад эх сурвалж

A Toolkit, Corporate Governance of State-Owned Enterprises, The World Bank (2014);

ЭЗХАХБ, Accountability and Transparency – A Guide for State Ownership, ЭЗХАХБ Publishing (2010) ;

B Motshegwa, K Mooketsane and K Bodilenyane, The Slip-Ups of Corporate Governance in Botswana Public Enterprises, The 2nd Annual International Conference on Public Administration and Development Alternatives 26 - 28 July 2017, Tlotlo Hotel, Gaborone, Botswana, (2007);

Bernier, Luc; Florio, Massimo; Bance, Phillippe, The Routledge Handbook of State-Owned Enterprises., New York, Routledge, 2020 https://www.researchgate.net/publication/341742354_State-owned_enterprises_and_industrial_development_in_Latin_America

Christopher Chen, Solving the Puzzle of Corporate Governance of State-Owned Enterprises: The Path of the Temasek Model in Singapore and Lessons for China, 36 Nw. J. Int'l L. & Bus. 303 (2016);

Dan W. Puchniak and Luh Lan, *Independent Directors in Singapore: Puzzling Compliance Requiring Explanation*, NUS Law Working Paper No. 2015/006 (2015);

Dan W. Puchniak and Luh Lan, *Independent Directors in Singapore: Puzzling Compliance Requiring Explanation*, NUS Law Working Paper No. 2015/006 (2015);

Donald C. Clarke, The Independent Director in Chinese Corporate Governance, 31 Del. J. Corp. L. 125 (2006);

- Gakpo, M. D. Y., Ashigbey, K. K., Kwakye, M. Corporate governance and performance of state-owned enterprises in Ghana. *International Academic Journal of Economics and Finance*, 3(6), 333 (2021)x;
- Growing Temasek into A Distinct and Unique Enterprises, STRAITS TIMES, July 24, 2013;
- Press Release, Temasek, Transcript: Remarks by Chairman of Temasek, Mr. S. Dhanabalan, to Singapore Media (July 23, 2013);
- Information on De Beers' involvement in Botswana is sourced from <http://www.debeersgroup.com/botswana/en/who-we-are/de-beers-in-botswana.html> ;
- Investment Climate Statements (2018): Chile8 <https://www.state.gov/reports/2018-investment-climate-statements/chile/>;
- Kgotla M. Ramaphane, Public Enterprises In Botswana: Ownership And Governance, *Public enterprise*, 2011, Vol. 18, Nos. 1-4, (2011) ;
- Ministry of Finance and Economic Development, Peoples' guide to the 2020/2021 BUDGET, Republic of Botswana, (2020) 2, https://www.cabri-sbo.org/uploads/bia/Botswana_2020_Approval_External_CitizensBudget_MinEcosFin_SADC_English.pdf
- Ministry of Finance, 2018 State Ownership Report https://www.mofep.gov.gh/sites/default/files/reports/economic/2018_State_Ownership_Report_v3.pdf ;
- Ministry of Finance, Final Report for 2017&2018 Mining Sector, 47, https://eiti.org/files/documents/final_2017_and_2018_mining_reportab_1.pdf ;
- Ministry of Finance, ТЭХЗН to Change Narrative of doing Business in Ghana-Prez Assures, <https://www.mofep.gov.gh/news-and-events/2019-08-23/ТЭХЗН-to-change-narrative-of-doing-business-in-ghana-prez-assures> ;
- OECD, Board Practices and Financing for Latin American State Owned Enterprises, OECD Publishing (2015);
- OECD, Organising The State Ownership Function-implementing the OECD Guidelines on Corporate Governance of State Owned Enterprises, OECD Publishing (Paris., 2020);
- OECD, Owner and Governance of State-Owned Enterprises: A Compendium of National Practices, OECD Publishing (2018) ;
- OECD, Professionalising BOARD of Directors of State-Owned Enterprises: Stocktaking National Practices OECD Publishing (2018);
- OECD, Board of Directors of State-Owned Enterprises: An Overview of National Practices, OECD Publishing (2013);
- PEEPA, Нэр дэвшүүлэх процессын зорилго, <https://www.peepa.co.bw/about-11/> ;
- Shome A. Singapore's state-guided entrepreneurship: a model for transitional economies? *New Zealand Journal of Asian Studies* 11, 1 (June 2009);
- State Owned Enterprises Catalysts for Public Value Creation? (2015);
- Tebogo Israel Magang & Koketso Bafana Kube, Compliance with Best Practice Governance Principles by State Owned Enterprises in Botswana, *13 International Journal of Business and Management* 2, 149, 150 (2018);

The Act on the Management of Public Institutions;

The World Bank, Corporate Governance of State-Owned Enterprises in Latin America Current Trends and Country Cases, (2014) 16
<https://documents1.worldbank.org/curated/en/634451468088457556/pdf/894680WP00P1260orate0Governance0LAC.pdf> ;

Türkiye ve Dünya Kamu İşletmeleri, Karşılaştırmalı Araştırma, İnceleme Raporu ve Siyasa Önerileri, (2015);

US Geological Survey, “Mineral Commodity Summaries 2019;

Word Bank Group, Botswana Mining Investment and Governance Review, The Mining investment and governance review (MInGov) (2016);

Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн үнэлэх, хувьчлах агентлагийн вэб хуудас,
<https://www.peepa.co.bw/about-2-2/> ;

Шинэ Зеланд Улс, Crown Ownership Monitoring Unit (COMU)-ийн албан ёсны цахим хуудас
www.comu.govt.nz ;

Хятад Улс, State-owned Assets Supervision and Administration Commission of the State Council (SASAC)-ийн албан ёсны цахим хуудас, <http://en.sasac.gov.cn/>,
<http://en.sasac.gov.cn/aboutus.html> ;

Энэтхэг Улс, Department of Public Enterprises (DEP)-ийн албан ёсны цахим хуудас,
<https://dpe.gov.in/about-us/about-department> ;

Филиппин Улс, Government-owned and controlled corporation-ийн танилцуулга, мэдээлэл,
<https://ogcc.gov.ph/gocc> ;

Турк Улс, Kamu sermayeli kuruluş ve işletmeler genel müdürlüğü-ийн албан ёсны цахим хуудас,
<https://www.hmb.gov.tr/kamu-sermayeli-kurulus-ve-isletmeler-genel-mudurlugu-hakkinda> ;

Чили Улс, Sistema de Empresas Council (БЗС)-ийн албан ёсны цахим хуудас,
https://www.БЗСchile.cl/nuestra-organizacion/quienes-somos/?no_cache=1 ;

Бельги Улс, Federal Holding and Investment Company (FPIM)-ийн албан ёсны цахим хуудас,
<https://www.sfpi-fpim.be/en> ;

Тэмасек вэб хуудас https://www.temasek.com.sg/en/who-we-are/our-leadership#item-content-temasek-corporate-en-who-we-are-our-leadership-jcr:content-par-tabbed_content-tabbed_content_item-tabpar-gridtabs-item11 (2020.04.29.);

中村美幸「政府系ファンド (SWFs) における投資戦略 —シンガポール・テマセク持株会社の事例を中心に」創価経営論集 第35巻1・2・3号57頁 (2010年) 72;

楊永良「中国国有企業ガバナンス改革の視点：シンガポール・テマセクモデルを参考に」六甲台論集、法学政治学編64巻1号91頁 (2017年) 109頁;

III. Эрх зүйн эх сурвалж

6102 sayılı Türk Ticaret Kanunu (2012);

Botswana Code of Corporate Governance (BCCG) - Code of Best Practice on Corporate; Governance
<https://www.governance.co.bw/images/BotswanaCodeofCorporateGovernanceV4.pdf> ;

Botswana Companies Act CAP 42-01, <https://www.cipa.co.bw/cipa-acts> ;

Constitution of the Republic of Singapore (1999);

Monetary Auth. of Singapore, Code of Corporate Governance (2012) § 2.2, https://www.mas.gov.sg//media/MAS/resource/fin_development/corporate_governance/CGCRevisedCodeofCorporateGovernance3May2012.pdf

Singapore Companies Act, (1967);

Temasek charter, (2009), https://www.temasek.com.sg/content/dam/temasek-corporate/news-and-views/news/files/Charter_2009_-_Background_and_Context.pdf;

Дэд ажлын хэсгийн тайлан, “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн танилцуулга” тайлан (2020) ;

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын хавсралт. **Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам;**

Монгол Улсын Засгийн газрын тогтоол №266, Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай, 2006;

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын Хавсралт № 20, Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, 2016;

Монгол Улсын Засгийн газрын тогтоолын Хавсралт №104, “Эрдэнэс Монгол” Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, 2016;

Монгол Улсын Их Хурлын тогтоол №27, Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай, 2007;

Монгол улсын Компанийн тухай хууль, 2011;

Санхүүгийн зохицуулах хороо 2014 оны 162 дугаар тоот тогтоол;

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 34 дугаар тоот тогтоол Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам;

Төрийн эрх ашиг, засаглалыг удирдах байгууллагын хууль <https://ТЭХЗН.gov.gh/ТЭХЗН/wp-content/uploads/2019/08/STATE-INTERESTS-AND-GOV.-ACT-9903362.pdf> ;

Эрдэнэс Монгол ХХК-ний ТУЗ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолын хавсралт Эрдэнэс Монгол ХХК-ний ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам;

Эрдэнэс Монгол ХХК-ний ТУЗ-ийн 2017 оны 23 дугаар тогтоолын хавсралт "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ-ийн ажиллах журам;

Эрдэнэс Тавантолгой ХК-ний ТУЗ-ийн 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралт “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

Vietnam Law on State Owned Enterprises (2003);

Botswana Code of Corporate Governance (2013);

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн харьцуулалт

№	Улс	Хараат бус гишүүн	Ажилчдын төлөөлөл	Жендерийн тэгш байдал	Төрийн албан хаагчийн тоо
1	Ботсвана (Дэвсвана)	Хараат бус гишүүн байхгүй. ТУЗ-ийн гишүүдийн 50 хувийг бусад хувьцаа эзэмшигчдээс томилдог.	Ажилтны төлөөлөл багтдаггүй	Жендерийн квот байхгүй	ТУЗ-ийн гишүүдийн 50 хувийг төрөөс томилдог
2	Чили (ҮЗК/ҮГТК)	ҮЗК, ҮГТК зэрэг томоохон компанид хараат бус гишүүн байхгүй	ҮГТК- 1 гишүүн ҮЗК- 2 гишүүн	БЗС нь харьяа ТӨК-д 40 хувь нь эмэгтэй гишүүн байна ҮГТК-д 1 эмэгтэй гишүүн ҮЗК-д жендерийн квот байхгүй	ҮГТК-д 4 гишүүн ҮЗК-д 4 гишүүн
3	Монгол (Эрдэнэс Монгол ХХК)	ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна	Ажилтны төлөөлөл багтдаггүй	Жендерийн квот байхгүй	Тоон хязгаар байхгүй
4	ЭЗХАХБ-ын орнуудын туршлага	Томоохонд ТӨХЭ болон ашгийн төлөө арилжааны үйл ажиллагаа явуулдаг ТӨХЭ-ний ТУЗ-д заавал хараат бус гишүүн байлгах шаардлагыг тавьдаг байна. (Хүснэгт 3-ыг харна уу)	Франц, Грек, Израил, Словени, Испани, Швед, Швейцарь зэрэг улсад ТУЗ-д ажилтны төлөөллийг заавал багтаахыг хуулиар шаарддаг.	Дани, Финланд, Голланд, Испани улсуудад жендерийн тэгш байдлыг дэмждэг (Хүснэгт 3-ыг харна уу)	ТУЗ-ийн гишүүдийн тэнцвэрийг хадгалах үүднээс ТУЗ дахь төрийн албан хаагчийн томилгоог хязгаарлах арга хэмжээ авч буй улсуудын тоо нэмэгдсээр байна.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

**НИЙТИЙН АШИГ СОНИРХЛЫГ ТӨЛӨӨЛӨН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ШҮҮХЭД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ, ЗХШХШТХ-ийн 18.3.1,
18.3.2 ДАХЬ ЗААЛТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Б.Мөнгөннахиа¹, Л.Хаш²

¹ СЭЗИС-Эрх зүйн тэнхимийн ахлах багш. Mungunnakhia.b@ufe.edu.mn,

² Доктор (Ph.D) СЭЗИС-Эрх зүйн тэнхимийн ахлах багш. Khash.L@ufe.edu.mn



Хураангуй

2016 оны 2 дугаар сарын 4-ий өдөр Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй ...” хэмээн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулж өгсөн байна. Энэхүү хуулийн зохицуулалтаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах хүрээ хязгаарыг тогтоож өгсөн бөгөөд нэхэмжлэгчийн хувьд нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх, дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хуульд тавьсан байдаг. Тус шаардлагыг шүүхээс харилцан адилгүй байдлаар үнэлж, хэргийг шийдвэрлэж байгаа нь хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл маргаантай асуудал хэвээр байсаар байна. Тиймээс шүүх хуулийг нэг мөр хэрэглэж, энэ төрлийн хэрэг маргааныг шүүхүүд харилцан адил байдлаар шийдвэрлэхэд хуулийн зохицуулалтыг бий болгох, хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг хөндсөн болно.

Түлхүүр үг:

Захиргааны эрх зүй,
нийтийн эрх ашиг, нийтэд
үйлчилдэг төрийн бус
байгууллага.

Удиртгал:

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэл гэдэгт “иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг” хамааруулан ойлгодог байсан бөгөөд нийтлэг эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дангаараа болон хамтарч нэхэмжлэл гаргах зохицуулалттай байв. Уг хуулийн 22

дугаар зүйлд нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах зохицуулалттай байжээ. Үүнд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж байгаа нэхэмжлэлд төлөөлөгчөө дундаасаа сонгох боломжийг хуулиар олгосон байв. Харин 2016 онд шинэчлэн баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нэхэмжлэл гэдэгт “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэсэн шинэ ойлголтыг оруулж өгснөөрөө онцлог зохицуулалт бий болсон юм.

Энэхүү хуулийн зохицуулалтаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах хүрээ хязгаарыг тогтоож өгсөн бөгөөд нэхэмжлэгчийн хувьд нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх, дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хуульд тавьсан байдаг. Тус шаардлагыг шүүхээс харилцан адилгүй байдлаар үнэлж, хэргийг шийдвэрлэж байгаа нь хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл маргаантай асуудал хэвээр байсаар байна. Тиймээс шүүх хуулийг нэг мөр хэрэглэж, энэ төрлийн хэрэг маргааныг шүүхүүд харилцан адил байдлаар шийдвэрлэхэд хуулийн зохицуулалтыг өөрчлөх, хууль тогтоомжийг шинэчлэх асуудлыг хөндсөн болно. Ингэхдээ дараах зорилтын хүрээнд судалгаа хийлээ.

- Онолын судалгааны хүрээнд нийтийн ашиг сонирхлын талаар судлах
- Шүүхүүд хуулийг нэг мөр хэрэглэж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх
- Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргахад практикт тулгамдаад буй асуудлыг шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийн судлах
- Дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох онол, арга зүйн үндэс

Нийтийн ашиг сонирхлыг үгийн үндсээс нь авч үзвэл, “Нийт” гэдэг нь монгол хэлний их тайлбар толинд “Нэг төрлийн буюу ижил утга агуулгыг илтгэх олон тоог хамран заах төлөөний үг; бүгд” гэсэн утгыг илэрхийлэх бол “ашиг сонирхол” гэдэг нь “хүсэл зорилго, эрх ашиг” буюу ямарваа нэгэн зүйлийг хийх хүсэл сонирхолтой байхын сацуу түүнээс өөрийн эрх ашигт нийцсэн үр дүнг хүсэх гэсэн утгыг илэрхийлж байна. “Нийтийн ашиг сонирхол” хэмээх ойлголт нь улс төрийн үзэл баримтлал, төрийн онолын янз бүрийн чиг урсгалуудаас хамаарч тодорхойлогддог гэж барууны хууль зүйн шинжлэх ухааны бүтээлүүдэд үздэг бөгөөд Германы Бийлефелдийн их сургуулиас явуулсан судалгааны үндсэн дээр нийтийн ашиг сонирхол хэмээх ойлголтын агуулга, мөн чанарыг авч үзэхэд тэргүүлэх байр сууринд тавигддаг онолын гурван концепци байдаг байна.

- Нийтийн ашиг сонирхлын либерал концепци
- Нийтийн ашиг сонирхлын төр төвтэй концепци
- Нийтийн ашиг сонирхлын ардчилсан ёсны концепци

Эх сурвалж: Нээлттэй Нийгэм Форум. (2018). Шүүхийн шийдвэрийн шинжилгээ. Улаанбаатар

ХБНГУ-ын захиргааны эрх зүйн нэрт эрдэмтэн, доктор Хартмут Маурэр: “... Захиргааны үйл ажиллагаа нийтийн ашиг сонирхол дээр суурилсан байх ёстой. “Нийтийн ашиг

сонирхол” гэх ойлголт нь бүх тохиолдолд нэг мөр агуулгыг илэрхийлдэггүй бөгөөд тухайн цаг үеийн өөрчлөлтийн нөлөөнд өртөж, улмаар цаг үе бүрт ихэвчлэн маргаантай байдаг. Юуны өмнө олон ургальч үзэл хандлагын хамааралд оршин буй төрийн үед нийтийн ашиг сонирхол гэдэгт юу хамаарах, ашиг сонирхлын зөрчилдөөн дунд нийтийн ашиг сонирхлын эзлэх байр суурь ямар байх вэ гэдэг нь байнгын асуулт дагуулж байдаг” хэмээжээ. (Мөнх-Эрдэнэ, Баттулга, 2018. х.19-20)

Түүнчлэн, ХБНГУ-ын нэр хүндтэй эрх зүйн толь бичигт: “Нийтийн ашиг сонирхол гэх ухагдахуун нь а) хуулийн хэлэнд (ялангуяа, захиргааны эрх зүй болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд) ихэвчлэн хэрэглэгддэг ойлголт бөгөөд нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт (ХБНГУ-ын Захиргааны шүүхийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2.4 дэх заалтанд “нийтийн ашиг сонирхлын үүднээс захиргааны актыг яаралтай гүйцэтгэх” тухай заасан байна); б) нийтийн ашиг сонирхол гэдгийг тодорхойлох урьдчилсан нөхцлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг бүхэллэг байдлаар тайлбарлах замаар тогтооно; в) нийтийн ашиг сонирхол гэх ухагдахуун нь эрх зүйн тодорхойгүй ойлголт (хуулиар шууд тодорхойлох байдлаар заах боломжгүй ойлголт) бөгөөд үндсэндээ түүний урьдчилсан нөхцлийг эрх зүйн тодорхой маргаанд шүүхээс шалгах замаар тайлбарлана” хэмээн тэмдэглэжээ. (Мөнх-Эрдэнэ, Баттулга, 2018. х.20)

“Нийтийн ашиг сонирхол” гэдгийг үе үеийн маш олон эрдэмтэд олон янзаар тайлбарласан байдаг ч тухайлсан нэг ойлголт байхгүй бөгөөд юун түрүүнд нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлын эсрэг авч үзэн ямагт нийтийн ашиг сонирхол хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдана гэсэн ойлголт урган гарч байна.

Дээрхээс дүгнэн үзвэл, ард иргэд өөрсдийн ашиг сонирхлоо нэгтгэн, түүндээ дасан зохицож амьдрах аваас бүх нийтийн эрх ашиг зөрчилдөхгүй нийтийн сайн сайхан бий болсноор төрийн үндсэн чиглэл биелэгдэх боломжтой. Мөн нийтийн ашиг сонирхол бол төрийн эцсийн зорилго бөгөөд нийтийн сайн сайхан байдал нь төрийн ашиг сонирхол хэмээн дэлхийн суут эрдэмтэд үзжээ. Харин зарим нь ард иргэд өөрсдийн эрх ашгаа нэгтгэн төрөөр хамгаалуулан амьдарснаар эрх ашгийг зөрчил үүсэхгүй бөгөөд энэ нь ард иргэдийн нийтийн сайн сайханд дагуулна гэж үзсэн байна. Нийгмийн гэрээний онолыг үндэслэгч Ж.Ж.Руссогийн гол үзэл баримтлал бол ард түмэн өөрийн эрх мэдлээ төртэй байгуулсан гэрээний үндсэн дээр “төр”-д шилжүүлэн өөрсдийгөө хамгаалуулах, засаглах эрх мэдлийг олж авч байгаа нь нийтийн сайн сайхныг бий болгох үүргийг төрд оногдуулж буй хэрэг билээ. Нийтийн ашиг сонирхлыг хуульд шууд тодорхойлох боломжгүй бөгөөд хуульд тоочин тодорхойлох аваас урьдчилан тогтоож чадаагүй үнэт зүйлс хамгаалалтад орж чадахгүй байх эрсдэлтэй юм.

2. Монгол Улсад нийтийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн механизм


2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны шүүхэд гаргах нэхэмжлэл гэдэгт “иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд хандаж гаргасан өргөдлийг” хамааруулан ойлгодог байсан бөгөөд нийтлэг эрх нь зөрчигдсөн гэж үзвэл дангаараа болон хамтарч нэхэмжлэл гаргах зохицуулалттай байсан. Тухайлбал, тус

хуулийн 22 дугаар зүйлд нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргах зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Үүнд нэгэн адил шаардлага бүхий нэхэмжлэлийг хэд хэдэн нэхэмжлэгч хамтран гаргаж байгаа нэхэмжлэлд төлөөлөгчөө дундаасаа сонгох боломжийг хуулиар олгожээ. Харин 2016 онд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нэхэмжлэл гэдэгт “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд” гэсэн шинэ ойлголтыг оруулж өгснөөрөө онцлог зохицуулалт бий болсон юм. Ингэхдээ тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” болохыг хуульчилснаас гадна тус этгээдийг тавих шаардлагыг тодорхойлж өгсөн байна. Үүнд:

- нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх;
- дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх.


Уг судалгааны ажилдаа ЗХШХШТХ-ийн 18-р зүйлийн 18.3 дахь заалтыг шүүх хэрхэн хэрэглэж ойлгож байгаад дүгнэлт хийхийн тулд нийт 19 нэхэмжлэгчийн бие даасан 15 нэхэмжлэлийг сонгон авч дүгнэлт хийлээ.

Зураг 1. Нэхэмжлэл гаргасан оноор нь авч үзвэл:



ЗХШХШТХ нь 2016 оны 02 дугаар сарын 04-ий өдөр батлагдаж, мөн оны 07 дугаар сарын 01-ий өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн байна. Хууль батлагдсан онд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүхэд хандсан нэхэмжлэл цөөн байсан бол жил ирэх тусам тус зорилгын хүрээнд шүүхэд хандсан нэхэмжлэлийн тоо өссөн байна.

Зураг 2. Нэхэмжлэлийг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан нийтийн ашиг сонирхлын хүрээнд авч үзвэл:



ЗХШХШтХ-ийн 18.3-т хамааралтай 15 нэхэмжлэлийг Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас сонгон авсан бөгөөд үүнээс 43% буюу 6 нэхэмжлэл нь хүрээлэн буй орчин, 36% буюу 5 нэхэмжлэл нь нийтийн өмч, 14% буюу 2 нэхэмжлэл нь нийтийн эрүүл мэнд, үлдсэн 7% буюу 1 нэхэмжлэл нь хүүхдийн эрхийг хамгаалах ашиг сонирхол дор тус тус нэхэмжлэл гарган хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байна.

ЗХШХШтХ-ийн 18.3-т хамааралтай 15 нэхэмжлэлд хэрэг үүсгэж, хэргийг шийдвэрлэсэн захиргааны хэргийн 15 анхан шатны шүүхийн шийдвэр, 11 давж заалдах шатны шүүхийн магадлал, 8 Улсын Дээд Шүүхийн тогтоол гарсан байдаг. Эдгээр 15 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан 10, зарим хэсгийг хангасан 1, шүүх хуралдаанаар хэргийг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгосон 3, нэхэмжлэгчийн шаардлагыг хариуцагч хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон 1 хэрэг байна.

Зураг 3. Хэргийг шийдвэрлэсэн байдал



Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй этгээд нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх хэсэгт “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх” хэмээн заасан шаардлагын хүрээнд нэхэмжлэл гаргана. Өөрөөр хэлбэл, тухайн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй ТББ-ын дүрмийн зорилгодоо хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах талаар тусгасан байх ёстой.

3. ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалтын хэрэглээ

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.9-д заасны дагуу захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэж хуулиар эрх олгогдсон этгээд, ЗХШХШтХ-ийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг ойлгоно. Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар нэхэмжлэл гаргаж буй ТББ нь ЗХШХШтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1 “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, “18.3.2.дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэсэн шаардлагыг хангасан байна. Энэхүү хуулийн зүйл заалтын агуулга нь тухайн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй ТББ нь тухайн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ талаар шүүхэд нийтийг ашиг сонирхлыг хамгаалах эрх бүхий этгээд мөн болохоо илэрхийлэхэд чиглэгдсэн зохицуулалт юм.

Гэтэл энэхүү зохицуулалт хэрхэн хэрэгжиж буйд сонгон авсан шүүхийн шийдвэрүүдэд судалгаа хийхэд.

Шүүхийн зарим шийдвэрт нэхэмжлэгч нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх талаар дүгнэсэн байхад зарим шийдвэрт огт дүгнээгүй болох тухайд

Сонгогдсон нийт шүүхийн шийдвэрүүдээс нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх тухай 10 шийдвэрт шүүхээс нэхэмжлэгч нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй талаар дүгнэлт өгсөн бол үлдэх 5 шийдвэрт огт дүгнэлт өгөөгүй байна.

Шүүхийн шийдвэрт нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхтэй талаар дүгнэлт өгөх тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй боловч тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд нэхэмжлэгч 18.3.1, 18.3.2-т заасан шалгуурыг хэрхэн хангасан талаар шүүхийн шийдвэрт тусгах нь ач холбогдолтой юм.

Нэхэмжлэгчийг ямар үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж үзсэн талаар шүүхийн шийдвэрт дүгнээгүй нөхцөлд хэргийн оролцогч хийгээд олон нийтэд тодорхойгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй. Тиймээс шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргаж буй нэхэмжлэгчид тавигдах шаардлага нь хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллагын гаргаж буй нэхэмжлэгчид тавигдах шаардлагаас онцлог учраас шүүх ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 заалтад хамааруулан гаргасан нэхэмжлэлийг чухалчлан авч үзэн, зохих дүгнэлт өгч байвал зохистой.

ТББ нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх тухай нотлох баримтыг шүүхээс үнэлсэн байдал

Шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх хувьд нэхэмжлэгч ТББ нь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөл эрхтэй болохыг дүгнэхдээ шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт ТББ-ын дүрмийн зорилго болон байгуулагдсан огноо, дүрэмд өөрчлөлт оруулсан огноог дурдсанаас өөр нэмэлт тайлбар өгөөгүй байна. Энэ нь нэхэмжлэгч ТББ-ын дүрмийн зорилго нь нэхэмжлэлийн шаардлагатай хэрхэн нийцэж байгаа, ТББ байгуулагдаад 3 жил болоогүй, дүрмийн зорилгод нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой өөрчлөлт ороод гурван жил болоогүй байхад нэхэмжлэлийг хүлээж авч шийдвэрлэсэн нь тодорхойгүй, шүүхээс хуулийг нэг мөр хэрэглэхгүй байгааг илтгэж байна. Жишээлбэл, доорх шүүхийн шийдвэрээс харвал “Амьд хууль” НҮТББ нь нийтийн өмчийг хамгаалах талаар 2018 онд дүрмийн зорилгодоо оруулсан байхад 2020 онд буюу дүрмийн зорилгод өөрчлөлт оруулаад 3 жил болоогүй байхад нийтийн өмчийг хамгаалах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхээс хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан гэж дүгнэжээ. (эх сурвалж: https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Шийдвэрээс харахад ТББ нь ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.2 дахь зүйл заалтыг хангаагүй буюу дүрмийн зорилгодоо нэмэлт өөрчлөлт оруулаад гурван жил болоогүй болох нь харагдаж байна. Гэсэн хэдий ч шүүхээс нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд гэж үзсэн бөгөөд тусгайлсан дүгнэлт өгөөгүй байна. Нэхэмжлэл гаргах эрхийг хуульд заасан шалгуураар бус

тодорхойгүй байдлаар тогтоож шийдвэрлэсэн нь ТББ-уудын дунд төөрөгдөл үүсгэх, цаашид энэ талаар буруу жишиг тогтоох эрсдэлтэй юм.

Нөгөө талаас нэгэнт хуулиар ТББ-д нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх, дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлуудыг тавьсан байхад шүүхээс ийнхүү шийдвэрлэснээр хариуцагчийн зүгээс давж заалдах гомдол гаргах үндэслэл болж байна. Тухайлбал, “Амьд хууль” ТББ-ын нэхэмжлэлтэй анхан шатны шүүхийн шийдвэрт Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмгөөлөгч Б.Т Нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан хэмээн давж заалдах шатны шүүхэд хандсан байдаг. Нэхэмжлэгчийн зүгээс шүүхэд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх “нийтийн өмч” гэдэгт аймгийн төрийн захиргааны барилга хамаарах эсэх, орон нутгийн өмчийг хассан шийдвэр нь нийтийн өмчид халдаж буй шийдвэр мөн эсэх талаар дүгнэлт хийгээгүйгээс гадна “нийтийн өмчийг хамгаалах” үйл ажиллагааны чиглэлийг 2018 оны 05 дугаар сарын 21-ий өдөр нэмүүлж дүрэмдээ тусгасан уг этгээд нь гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хангасан эсэх талаар үндэслэл бүхий дүгнэлтийг хийгээгүй. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл 2018 оны 05 дугаар сарын 21-ий өдрөөс нийтийн өмчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн этгээд нь 2021 оны 05 дугаар сарын 21-ий өдрийг хүртэл энэ чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулснаар нэхэмжлэл гаргах эрх үүсэхээр байна. Зарим онуудын үйл ажиллагааны тайлан хэрэгт авагдсан байх боловч уг тайланд нийтийн өмчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан зүйл тусгагдаагүй байдаг.

Иймд нийтийн өмчийг хамгаалах чиглэлээр нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл бүрдсэн байхад шүүх хэрэгт авагдсан баримтыг буруу үнэлж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3 дахь заалтыг буруу хэрэглэж хэргийг шийдвэрлэсэн байна. (Хавсралт 1-ээс шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Дээрх маргаантай холбоотойгоор давж заалдах шатны шүүхийн магадлалд:

“... хэрэгт авагдсан “АХТ” НҮТББ-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгдсэнээр нэхэмжлэгч нь хүний эрх хамгаалах, байгаль орчноо хамгаалах үйлчилгээ эрхлэх чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан болох нь 2016 оны үйл ажиллагааны тайлангаар нотлогдож байх ба Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д заасан улсын бүртгэл үнэн зөв байх зарчмын дагуу нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн шаардлагад тусгагдсан нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нийтийн өмчийг хамгаалах асуудлаар үйл ажиллагаа явуулж байгаагүй болох нь тогтоогдож байх тул энэ асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд гэж үзэх боломжгүй.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нь 2019 оны 11 дүгээр сарын 29-ий өдөр шүүхэд дээрх нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан бөгөөд цаг хугацааны хувьд хуульд тусгайлан заасан дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хангахгүй байна.

Иймд дээрх үндэслэлүүдээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ. (эх сурвалж: https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Энд шүүх тухайн ТББ-ын гаргасан нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилготой нийцэхгүй байгаа буюу дүрмийн зорилгодоо нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудлаар нэмэлт өөрчлөлт хийсэн нь хуульд заасан шаардлагыг хангахгүй байгаа тухай дүгнэлт хийжээ. Хэдийгээр хуулинд гурван жил гэсэн цаг хугацааг зааж өгсөн хэдий ч хугацааг хэзээнээс тоолох тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Тус хуулийн шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснээр тухайн нэхэмжлэлийн үндсэн шаардлага болох маргаан бүхий асуудал буюу төрийн албан тушаалтны хууль бус үйлдлээс үүдсэн нийтийн ашиг сонирхол зөрчигдсөөр байх болно гэдгийг аль ч талаас харгалзахгүй орхиж болохгүй. Энэ талаар “Амьд хууль” ТББ-ын нэхэмжлэлтэй захиргааны хэргийн маргааныг хянан шийдвэрлэсэн Улсын Дээд Шүүхийн тогтоолоос харж болохоор байна. “Амьд хууль” ТББ Хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

“Манай байгууллага үүсгэн байгуулагдсанаас хойш Захиргааны ерөнхий хууль батлагдаж улмаар нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах ойлголтыг тусгаж улмаар байгаль орчны хамгаалал, хүүхдийн эрх хамгаалал, нийтийн өмчийг хамгаалах” агуулгыг тусгасны дагуу зохих өөрчлөлтийг дүрмийн агуулгадаа нэмж, хуулийн дагуу өөрчилсөн. Манай байгууллага нь дүрмийн зорилгын дагуу гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан гэдэг нь байгууллагын тайлан болон үйл ажиллагаа явуулж байсан талаарх бусад баримтуудаар нотлогдон тогтоогдоно. Гэтэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх нь манай байгууллагыг зөвхөн байгаль орчин хамгааллаар үйл ажиллагаа явуулж байсан гэж үзэн “хүний эрх хамгаалал” үүний дотор “нийтийн өмчийг хамгаалах” ойлголт хамт байдаг талаар дүгнэлт хийгээгүй.

“А х т” ТББ нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “М к” болон “Н н ф” олон улсын байгууллагуудтай тасралтгүй хамтран ажиллаж хүний эрх хамгаалал, нийтийн өмчийн хамгаалал, байгаль орчны хамгааллын чиглэлээр тасралтгүй 7, 8 жил үйл ажиллагаа явуулсан байхад энэ чиглэлээр гурван жил тасралтгүй үйл ажиллагаа явуулаагүй, нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэж үзэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байгааг хүлээн зөвшөөрөхгүй.

Манай байгууллага үүсгэн байгуулагдаж байхад энэ ойлголт хуулинд байгаагүй, Захиргааны ерөнхий хууль батлагдсаны дагуу дүрэмдээ өөрчлөлт оруулсан, энэ хугацаанаас хойш ч, өмнө ч үйл ажиллагаа явуулж байсан гэдэг нь татварын тайлан, бусад баримтаар тогтоогддог. Байгууллага тогтвортой үйл ажиллагаа явуулсан, энэ талаар баримтаа өгсөөр байхад шүүх буруу дүгнэлт өгсөн байгаа нь хууль буруу хэрэглэсэн гэж үзэх үндэслэл юм” гэх гомдол. (эх сурвалж: https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Дээрх маргаантай холбоотойгоор Улсын Дээд Шүүхийн тогтоолд:

“А х т” НҮТББ нь 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдөр “хууль тогтоомж сурталчлах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, төсөл боловсруулах” чиглэлээр үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн, 2017 онд “хүний эрх хамгаалах, байгаль орчноо хамгаалах үйлчилгээ”, 2018 онд “хууль эрх зүйн сургалт, хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч хөрөнгийг хамгаалах, нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах, нөлөөллийн болон мониторинг төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, төсөл хөтөлбөр санаачлах ажил” гэж үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг өргөжүүлснээс үзвэл тус байгууллагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1. “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, 18.3.2. “дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэсэн шаардлагыг хангаагүй гэж үзэхээргүй байна.

Дээрх хуулийн зорилго нь “нийтийн эрх ашгийг хамгаалах” нэрийн дор явцуу ашиг сонирхлын үүднээс /улс төр, эдийн засаг, хувийн гэх мэт/ ямар ч шалгуургүйгээр хэн дуртай этгээдээс нэхэмжлэл гаргах боломжийг хязгаарлах, шүүхийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх, эрх зүйн хамгаалалтын үр нөлөөг бууруулах, шүүхийг өөр зорилгод ашиглах зэрэг сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн зохицуулалт юм. Харин нэхэмжлэгчийн хувьд 2013 оноос хойш өнөөдрийг хүртэл /нэхэмжлэл гаргах үеийн байдлаар/ нийгэмд үйлчлэх чиглэлээр 6 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, дүрмийн зорилгодоо “нийтийн өмч хөрөнгийг хамгаалах” гэж тодорхой заасан байх бөгөөд хариуцагч захиргааны байгууллагын нийтийн буюу орон нутгийн өмчийг хууль бусаар хассан асуудлаар нийтийн эрх ашгийг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасныг “цаг хугацааны хувьд хуульд тусгайлан заасан дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хангахгүй байна” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь энэхүү хуулийн зорилгод нийцэхгүй.” хэмээн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байдаг. (эх сурвалж:

https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Энэ тохиолдолд шүүхээс төрийн албан тушаалтны үйл ажиллагаа ямар хуулийн, ямар зүйл заалтад үндэслэн шийдвэр гаргасан нь тодорхойгүй буюу тухайн шийдвэр нь агуулгаараа эрх зүйн үндэслэлгүй болохыг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй үйлдлийг хууль бус болохыг тогтоохдоо хуулийн шаардлага, зорилгыг тодорхой тайлбарлаж боломжит бүхий л баримтад тулгуурлан нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэгчийн хувьд бус нийтийн ашиг сонирхлын маргааны хувьд шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрийг зөв, буруу гэж дүгнэх боломжгүй юм. Учир нь, дээрх харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь хэт ерөнхий учраас, хуулийг нэг мөр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, ТББ-д тавьж буй шаардлагуудыг эргэн харах шаардлагатай байна.

ТББ дүрмийн зорилгын дагуу гурваас доошгүй жил тогтвортой ажилласан тухай нотлох баримтыг шүүхээс үнэлсэн байдал

Нэхэмжлэгч сүүлийн 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх тухайд мөн хуулийн нэг мөр ойлголт байхгүй байна. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон ТББ-ын зүгээс гаргасан нэхэмжлэлийг судлан үзэхэд дийлэнх тохиолдолд шүүхээс тогтвортой үйл ажиллагаа явуулсан болохоо нотлох зорилгоор дараах баримт бичгүүдийг хавтаст хэрэгт хавсаргажээ.

- ТББ-ын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- Төрийн бус байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан тогтоол
- ТББ-ын үйл ажиллагааны тайлан
- Үйл ажиллагааны тайлангаа улсын бүртгэлийн байгууллагад заавал хүргүүлсэн байх
- Санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг нэхэмжлэлд хавсаргасан байх
- Татвар төлсөн тайлан /Татварын байгууллагын лавлагаа/ ирүүлэх гэх мэт.

Шүүхээс ТББ-ыг дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх шаардлагыг хэрхэн үнэлж буй талаар доорх шүүхийн шийдвэрээс харж болохоор байна.

“Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д ...захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд гэж хуулиар эрх олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг хэлнэ... ,Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т ...Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь, хүрээлэн байгаа орчин хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй... гэж тус тус зааснаар нэхэмжлэгч Байдраг нутаг усаа хайрлан хамгаалъя Төрийн бус байгууллага нь нэхэмжлэл гаргах эрхтэй. Энэ нь Байдраг нутаг усаа хайрлан хамгаалъя Төрийн бус байгууллагын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 000059086 бүхий 0371001075 дугаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Байдраг нутаг усаа хайрлан хамгаалъя Төрийн бус байгууллагын 2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 2 дугаар Дүрэмд өөрчлөлт оруулсан тогтоолоор тогтоогдож байна.” . (эх сурвалж: https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Тухайн ТББ-ын дүрмийн зорилгод ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шаардлага нийцээгүй буюу дүрмийн зорилгодоо нийцээгүй агуулгаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан тохиолдолд шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэж байна.

“Нэхэмжлэгч “...” НҮТББ-ын дүрмийн Зургаад тус төрийн бус байгууллагын зорилгыг “Хүн амын тодорхой бүлэг давхаргын эрх ашгийг хамгаалах, Байгаль орчин нийтийн эрүүл мэнд нийтийн эрх ашгийг хамгаалах, Нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд туслах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, халуун сэтгэлийн аян, соёл урлаг, спортын

арга хэмжээ зохион байгуулах, дэмжих” гэж тодорхойлноос үзэхэд тус байгууллагын үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд нийтийн өмчийг хамгаалах чиглэл тусгагдаагүй, тус байгууллагыг “нийтийн өмч”-ийн асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх зорилготой, түүний гаргасан нэхэмжлэл дүрмийнх нь зорилгод нийцсэн гэж үзэх үндэслэлгүй” гэх. (эх сурвалж: https://shuukh.mn/single_case/6736?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1 шүүхийн шийдвэртэй танилцана уу)

Дээрхээс харвал ЗХШШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалтын шаардлагын хүрээнд дараах асуудлууд тулгарч байна.

- ТББ үүсгэн байгуулагдаад 3 жил болоогүй байхдаа гаргасан нэхэмжлэл
- ТББ-ын дүрэмд өөрчлөлд оруулснаас хойш 3 жилийн хугацааг тооцох эсэх
- Нэхэмжлэлийн шаардлага тухайн ТББ-ын дүрмийн зорилгод нийцээгүй

Зарим тохиолдолд шүүхүүд харилцан адилгүй байдлаар буюу нэхэмжлэгчид үйл ажиллагааны тайлангаа улсын бүртгэлийн байгууллагад заавал хүргүүлсэн байх, санхүүгийн тайланг нэхэмжлэлд хавсаргасан байх, татвар төлсөн тайланг нэхэмжлэлд хавсаргах гэх мэт шаардлагыг шаардаагүй байна. ТББ-ууд дүрмийн зорилгын дагуу 3 жилийн хугацаанд тогтвортой ажилласан болохоо харилцан адилгүй байдлаар нотолж байгааг үгүйсгэх аргагүй юм. Энэ нь мөн ТББ дүрмийн зорилгын дагуу тогтвортой үйл ажиллагаа явуулсан талаар хуулинд нарийвчилсан зохицуулалт байхгүйтэй холбоотой. Тиймээс тус хуулийн шаардлагыг хэрхэн нотлох талаар хуулийн зохицуулалтыг нарийвчлан нэг мөр болгох шаардлагатай. Хуулийн зохицуулалтыг нарийвчлан нэг мөр болгох аваас шүүхүүд хуулийг нэг мөр хэрэглэж, нэг тохиолдолд өөр өөр байдлаар нотлох баримтыг үнэлж, адил тохиолдолд өөр өөр шийдвэр гаргахгүй байх болно.

Үүнээс гадна нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад хуулийн шаардлагыг хангаагүй үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг буцааснаар нийтийн ашиг сонирхол зөрчигдсөөр байх эрсдэлтэй. Тиймээс нэхэмжлэлийн шаардлагад дурдсан асуудлаар, нэхэмжлэл гаргаж буй эрх бүхий этгээдээс шалтгаалж нэхэмжлэлийг хангахгүй орхиж буй нь явдал нь хуульд заасан журмын дагуу нэхэмжлэл гаргахад саад болохгүй болохыг шүүхийн шийдвэрт дурдах нь зүйтэй юм.

ДҮГНЭЛТ

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх, эрх бүхий этгээд” гэж хуулиар олгогдсон этгээд, энэ хуулийн 18.3-д заасан шаардлага хангасан төрийн бус байгууллагыг” ойлгоно гэж, 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтад “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд уг этгээд дараах шаардлагыг хангасан байна.” гээд 18.3.1-д “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, 18.3.2-т “Дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх”, 20 дугаар зүйлийн 20.3-т “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл

гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглох”-оор гэж тус тус заасан байна. Энэхүү нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн тухай эрх зүйн зохицуулалт нь ЗХШХШТХ-д шинэ зохицуулалт болж орсон бөгөөд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагад тавигдах шаардлагыг зааж өгсөн байдаг.

ЗХШХШТХ-ийн 18.3.1, 18.3.2 дахь заалтад заасан шаардлагыг шүүхүүд харилцан адилгүй байдлаар хэрэглэж байна. Хэдийгээр хуулинд сүүлийн гурваас доошгүй жил гэсэн цаг хугацааг зааж өгсөн хэдий ч хугацааг хэзээнээс тоолох тухай нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Тус хуулийн шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэснээр тухайн нэхэмжлэлийн үндсэн шаардлага болох маргаан бүхий асуудал буюу төрийн албан тушаалтны хууль бус үйлдлээс үүдсэн нийтийн ашиг сонирхол зөрчигдсөөр байх болно гэдгийг аль ч талаас харгалзахгүй орхиж болохгүй. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсэн, эсхүл зөрчигдөж болзошгүй талаар шүүхээс хуулийн шаардлага, зорилгыг тодорхой тайлбарлаж боломжит бүхий л баримтад тулгуурлан нийтийн ашиг сонирхлын нэхэмжлэгчийн хувьд бус нийтийн ашиг сонирхлын маргааны хувьд шийдвэрлэх хэрэгтэй. Одоо үйлчилж буй хууль тогтоомж хэт ерөнхий учраас, хуулийг нэг мөр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж өгөх нь зүйтэй юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Дээд шүүхийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг баталгаажуулж өгсөн байдаг. Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулинд заасны дагуу “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” эрхтэй. Тиймээс Монгол Улсын Дээд Шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.2 дахь заалтыг нэг мөр ойлгохоор албан ёсны тайлбар гаргах,
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтын зорилго нь “нийтийн эрх ашгийг хамгаалах” нэрийн дор явцуу ашиг сонирхлын үүднээс ямар ч шалгуургүйгээр хэн дуртай этгээдээс нэхэмжлэл гаргах боломжийг хязгаарлах, шүүхийн ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх, эрх зүйн хамгаалалтын үр нөлөөг бууруулах, шүүхийг өөр зорилгод ашиглах зэрэг сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн байдаг. Энэ ч утгаараа манай улсад шийдвэрлэсэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалт буюу нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотой шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд дийлэнх тохиолдолд хуулийн 18.3.2-т заасан дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх гэсэн шаардлагын гурваас доошгүй жил гэсэн цаг хугацаанд ач холбогдол өгөхөөс илүү тогтвортой үйл ажиллагаа явуулсан байдлыг шаардлага хангасан гэж үзэж хэргийг шийдвэрлэж байна. Тиймээс тухайн байгууллагыг тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа шалгуурыг харгалзан үзэж хэргийг шийдвэрлэх буюу гурваас доошгүй жил гэсэн шалгуурыг хуулиас хасах,

- Нөгөөтээгүүр Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах тоо нэмэгдэж байгаа бөгөөд шүүхээс тогтвортой үйл ажиллагаа явуулсан гэдэгт ямар шалгуур тавьж хэрэг маргааныг шийдвэрлэх талаар эрх зүйн нарийн зохицуулалт, шүүхийн жишиг, практикийг тогтоож өгөх,
- ТББ-ын зүгээс гаргасан нэхэмжлэл болгон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нэхэмжлэлд хамаарахгүй бөгөөд тухайн харилцаанд нийтийн ашиг сонирхол хөндөгдөж, зөрчигдсөн буюу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хуулийн шаардлага гарсан тохиолдлыг ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт хамааруулан авч үзнэ. Тиймээс ТББ-ын субъектив эрхийг хангуулах зорилгоор гаргасан нэхэмжлэл нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх” агуулгад хамааралгүй тул шүүхээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ маргааны төрлийг зөв тодорхойлох шаардлагатай байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж, хэм хэмжээний акт

Монгол Улсын Үндсэн хууль, Тавьдугаар бүлэг, 1 дүгээр зүйл (1992).

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нэгдүгээр бүлэг, 1 дүгээр зүйл (2016).

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нэгдүгээр бүлэг, 3 дугаар зүйл (2016).

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гуравдугаар бүлэг, 18 дугаар зүйл (2016).

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гуравдугаар бүлэг, 20 дугаар зүйл (2016).

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/, Зургадугаар бүлэг, 52 дугаар зүйл (2016).

Ном сурах бичиг, судалгааны ажил

Одгэрэл, П. (2016). Захиргааны эрх зүйн ерөнхий анги. Улаанбаатар.

Цогтоо, Ш. (2021). Монгол Улсын захиргааны эрх зүй: Ерөнхий, тусгай анги. Улаанбаатар.

Банзрагч, Г. (2019). Захиргааны процессын эрх зүй. Улаанбаатар.

Баярцэцэг, Ж. (2006). Стратегийн өмгөөлөл “Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах нь”. Улаанбаатар.

Амарбат, Б. (2018). Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох онолын зарим асуудал. Улаанбаатар.

Төртогтох, Ж. Ганболд, Ц. Фурманн, Й. Ганзаяа, С. (2018). Монгол Улсад Ардчиллын бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ. Улаанбаатар.

Хууль зүйн судалгааны хүрээлэн. (2013). Нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Улаанбаатар.

- Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо. (2017). Захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг нээх нь” бодлогын судалгаа. Улаанбаатар.
- Нээлттэй нийгэм форум. (2020). Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик. Улаанбаатар.
- Мөнх-Эрдэнэ, Т. (2017). Нийтийн ашиг сонирхлыг тодорхойлох нь. Улаанбаатар.
- Хууль зүйн судалгааны төв. (2018). Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. Улаанбаатар.
- Нээлттэй нийгэм форум. (2020). Нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Шүүхийн практик. Улаанбаатар.
- Баттулга, П. Мөнх-Эрдэнэ, Т. (2018). Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Улаанбаатар
- Баттулга, П. (2016). Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх. Улаанбаатар



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛД НИЙЦҮҮЛЭН ХЯНАХ ЧИГ ХАНДЛАГА

Д.Отгонбаяр

МУИС-ийн ХЗС-ийн магистрант, эрх зүйч, судлаач, dansranotgonbaar@gmail.com



Түлхүүр үг:

Үндсэн хууль, Үндсэн хуулийн
цэц, үүрдийн баталгаа,
мөнхийн заалт, eternity clause,
үндсэн эрх, нэмэлт өөрчлөлт

Хураангуй

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд нэмэлт өөрчлөлтөөр орсон Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно" гэсэн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэсэн мэдээллийг иргэдээс гаргасны дагуу Монгол Улсын Үндсэн Хуулийн цэц их суудлын хуралдаанаараа 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцэж, 02 тоот дугаартай тогтоолыг гаргасан билээ. Уг тогтоолтой холбоотойгоор Үндсэн хуулийн мөнхийн заалтад нийцүүлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянах эрхтэй эсэх асуудлын талаар онолын болон харьцуулсан судалгаа хийж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дахин Үндсэн хуулийн Цэц хянах эрхтэй эсэх асуудлыг авч үзэж, дүгнэлт өгөхийг зорилоо.

I. Оршил хэсэг

Эрх зүйн шатлалын логикийн хүрээнд хууль, хуульчилсан акт нь Үндсэн хуульд харшлах боломжтой. Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуульд бусад хууль, хуульчилсан акт нийцэж буй эсэхийг хянах хандлагаас гадна Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцэж байгаа эсэхийг хянах хандлага байдаг байна. Тухайлбал, Ваймарын Бүгд найрамдах улсын үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульдаа нийцээгүй талаар авч хэлэлцэж байсан⁹⁶ байна. Ингэхдээ Үндсэн хууль дах мөнхийн заалт буюу Eternity clauses гэх ойлголт байх бөгөөд энэ онолын талаар авч үзэх болно.

Мөн Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд нэмэлт өөрчлөлтөөр орсон Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Ерөнхий сайд болон Засгийн газрын

⁹⁶ Dimitry Gegenava "Unconstitutional constitutional amendments: Three Judgements from the practice of the Constitutional court of Georgia". SCLJ 5/2014, p.396

дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг⁹⁷ зөрчсөн гэсэн мэдээллийг иргэдээс гаргасны дагуу Монгол Улсын Үндсэн Хуулийн цэц их суудлын хуралдаанаараа 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцэж, 02 тоот дугаартай тогтоолыг гаргасан билээ. Уг тогтоолтой холбоотойгоор Үндсэн хуулийн мөнхийн заалтад нийцүүлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн цэц хянах эрхтэй эсэх асуудлын талаар онолын судалгаа хийж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дахин Үндсэн хуулийн Цэц хянах эрхтэй эсэх асуудлыг авч үзэж, дүгнэлт өгөхийг зорилоо.

II. Судалгааны онолын үзэл баримтлал

A. Үндсэн хууль дах мөнхийн заалт буюу “Eternity clauses” ойлголтын тухай

Үндсэн хуулийн мөнхийн заалт нь нийгэмд үнэт зүйлээ үүрд мөнхөд хадгалах боломжийг олгодог эрх зүйн хэрэгсэл⁹⁸ гэж үздэг. Мөнхийн заалтын зорилго нь хууль тогтоох байгууллагад хэт их эрх мэдэл олгохыг хязгаарлах, Үндсэн хуулийн мөн чанар, тогтолцоо, эх бичвэрийг хадгалж, Үндсэн хуулийг тогтвортой байлгадаг. Үүрдийн баталгаа нь “мөнхийн баталгаа”, “мөнхийн заалт”, “хөдөлшгүй заалт”, “eternity clause”, “unamended clause”, “immutable clause” зэрэг утгаар илэрхийлэгддэг байна.

Гари Ж.Жейкобсон Үндсэн хуулийн мөнхийн заалтыг тухайн улсын баримталж буй төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг⁹⁹ хамгаалах зохицуулалт гэж тодорхойлж, мөнхийн заалтууд нь үндсэн зарчмуудыг өргөжүүлэн тайлбарлах орон зайг бий болгодог гэж тэмдэглэжээ¹⁰⁰. Өөрөөр хэлбэл, мөнхийн заалт нь Үндсэн хуулийн тодорхой зарчим, үнэт зүйл буюу зарим заалтыг өөрчлөх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн заалт¹⁰¹ юм. Мөн үндсэн хууль тогтоогч Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчимд харшилсан нэмэлт, өөрчлөлтийг хийх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, Үндсэн хуулийн үнэт зүйлийг хамгаалахад чиглэгдэж, хэрэв өөрчлөгдвөл хуулийн шинж чанар алдагддаг. Уг заалтын үүрэг нь улс төрийн тогтолцоог тогтворжуулах, хадгалах явдал юм. Иймээс мөнхийн заалт нь нэг талаас Үндсэн хуулийн үнэт зүйл алдагдахаас урьдчилан сэргийлэх, нөгөө талаас төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн өөрчилж болохгүй баталгаа болдог¹⁰² гэж үзжээ.

⁹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал, Нэгдүгээр зүйлийн 2 дах хэсгийн "Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэнтэй нийцэхгүй байна гэж үзжээ.

⁹⁸ Ondřej Preuss “The Eternity Clause as a Smart Instrument – Lessons from the Czech Case Law”, *Hungarian Journal of Legal Studies* 57, No 3, pp. 289 (2016)

⁹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”

¹⁰⁰ Jacobsohn, G.I. *Constitutional Identity*, Cambridge: Cambridge University Press (2010) p.136

¹⁰¹ Zbigniew Witkowski, Maciej Serowaniec “Eternity clause – a realistic or merely an illusory way of protecting the state’s constitutional identity?” (2021) p.175

¹⁰² Preuss, O. (2016a). The Eternity Clause as a Smart Instrument – Lessons from the Czech Case Law, in *Hungarian Journal of Legal Studies*, No. 3 (57), p. 289–304

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулах гэдэг нь Үндсэн хуулийн үндсэн зарчмуудыг задлах, засаж сайжруулах гэсэн утгатай¹⁰³. Нэмэлт өөрчлөлт нь эхний ээлжид Үндсэн хуулийнхаа эх бичвэрт нийцсэн байж Үндсэн хуулийнхаа нэгэн адил үйлчилнэ. Эс тэгвээс хэм хэмжээнүүдийн уялдаа алдагдаж үүнээс сөрөг үр дагавар гарах эрсдэл бий¹⁰⁴. Тухайлбал, Үндсэн хуульд амьд явах үндсэн эрхийг тусгасан байхад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр цаазаар авах ялыг эрүүгийн эрх зүйн үндсэн хуулийн хэм хэмжээний элемент болгон тогтоовол Үндсэн хуульд тусгагдсан агуулгатайгаа зөрчилдсөн өөрчлөлт оруулахыг хориглосон үндэслэлээр уг нэмэлт, өөрчлөлт оруулах акт нь хүчингүй болно¹⁰⁵.

Үндсэн хуулийн заалтууд нь үндсэн хуулийн үнэт зүйлсийг илэрхийлэх талбар болдог бөгөөд үүнээс засаж залруулах боломжгүй буюу мөнхийн заалтууд нь үндсэн хууль судлаачдын анхаарлыг татаж байна¹⁰⁶. Мөнхийн заалт (Герман “Ewigkeitsgarantie”)-ын шинж чанар нь зарим зарчим, үнэт зүйл, Үндсэн хуулийн тодорхой заалтыг өөрчлөх боломжгүй гэж тунхагласан ойлголт бөгөөд Үндсэн хуульд оруулсан зарим нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн суурь зарчмыг хөндөх эрхийг хязгаарласан ерөнхий ойлголт юм. Мөнхийн заалтын түүх нь 1798 оны Швейцарын Бүгд найрамдах Хельветика улсаас үүдэлтэй бөгөөд уг заалтыг Үндсэн хуульдаа тусгаж, 2 дугаар зүйлд Засгийн газрын хэлбэр нь өөрчлөгдөж болох ч төлөөллийн ардчилал хэвээр байх ёстой гэж тунхаглажээ.

Мөн 1814 онд батлагдаж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр байгаа Норвегийн Үндсэн хуулийн мөнхийн заалт бөгөөд түүний төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг өөрчлөхийг хориглодог¹⁰⁷ байна.

Орчин үед Үндсэн хуулийн мөнхийн заалтууд нь 1884 оны Францын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс үндэслэгдэж, Бүгд найрамдах засаглалын хэлбэрийг өөрчлөх боломжгүй гэдгээс үүдэлтэй. 1946 оны Үндсэн хуулийн 95, 36 дугаар зүйл, 1958 оны Үндсэн хуулийн 89 дүгээр зүйлд “Бүгд найрамдах засаглалын хэлбэр нь аливаа нэмэлт, өөрчлөлтийн объект байж болохгүй”¹⁰⁸ гэжээ. Холбооны Бүгд найрамдах Герман улс (*цаашид “ХБНГУ” гэх*) холбооны улс, ард түмний бүрэн эрхт байдал, эрх мэдлийг хуваах, хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хязгаарладаггүй. Уг ХБНГУ-ын шинжлэх ухааны онолын үзэл баримтлалаас Энэтхэг улсад мөнхийн заалтын хандлага үүссэн байна¹⁰⁹.

1787 оны АНУ-ын Үндсэн хуульд “ямар ч муж өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр Сенатад тэгш сонгох эрхээ хасуулахгүй”¹¹⁰ гэж заажээ. Бүгд найрамдах Чех улсад ардчилсан эрх зүйт

¹⁰³ Walter F. Murphy, *Merlin’s Memory: The Past and Future Imperfect of the Once and Future Polity*, in *RESPONDING TO IMPERFECTION: THE THEORY AND PRACTICE OF CONSTITUTIONAL AMENDMENT* 163, p.177 (Sanford Levinson ed., 1995).

¹⁰⁴ Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал” (2022), 2 дах тал.

¹⁰⁵ Ulrich K. Preuss. “The implications of “eternity clauses”: the german experience” *Israel law review*. Vol 44., 2011, p.431 / [THE-IMPLICATIONS-OF-“ETERNITY-CLAUSES”:-THE-GERMAN-EXPERIENCE \(danielturnpqc.org/\)](http://THE-IMPLICATIONS-OF-“ETERNITY-CLAUSES”:-THE-GERMAN-EXPERIENCE-(danielturnpqc.org/))

¹⁰⁶ Silvia Suteu “Eternity clauses in post-conflict and post-authoritarian constitution-making: promise and limits” p.1 [Suteu Eternity Clauses in Post-conflict and Post-authoritarian Constitution-Making.pdf \(ucl.ac.uk\)](http://Suteu_Eternity-Clauses-in-Post-conflict-and-Post-authoritarian-Constitution-Making.pdf(ucl.ac.uk))

¹⁰⁷ The Constitution, as laid down on 17 May 1814 by the Constituent Assembly at Eidsvoll, subsequently amended, most recently by Resolution of 12 January 2023. [The Constitution of the Kingdom of Norway - Lovdata](http://The-Constitution-of-the-Kingdom-of-Norway-Lovdata) accessed 20 January 2023

¹⁰⁸ Yaniv Roznai “Unconstitutional Constitutional Amendments—The Migration and Success of a Constitutional Idea”, 2013, p.692, *The American Journal of Comparative Law* [Vol. 61]

¹⁰⁹ Мөн тэнд 692

¹¹⁰ Art. V of the US Constitution- 17th September 1787, [United States of America 1789 \(rev. 1992\) Constitution -](http://United-States-of-America-1789-(rev.-1992)-Constitution-)

төрийн нэн чухал шаардлагад өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхгүй гэдгийг тодорхойлсон энгийн дүрэм бий. Бүгд найрамдах Чех улсын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн өөрчлөлтийг үгүйсгэсэн үндсэн шийдвэрээ гаргахад мөнхийн заалтыг ашигладаг. Мөн Иран улсад бүгд найрамдах улс болон исламын шашнаас гарахыг хориглодог бол Португали улсад Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг нарийвчлан тодорхойлж, уг заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглодог. 1924 оны Мексикийн Үндсэн хуулиар Мексик үндэстэн нь католик шашинтай бөгөөд мөнхөд байх болно¹¹¹ гэж тодорхойлсон байна. Афганистаны Үндсэн хуульд¹¹² Исламын ариун шашин, түүнчлэн Исламын Бүгд найрамдах намын баримтлах зарчмыг зааж, өөрчлөлт оруулахыг хориглодог. Бразил улсын Үндсэн хуульд шууд, нууц, бүх нийтийн сонгох эрх, эрх мэдлийн хуваарилалтыг устгахад чиглэгдсэн нэмэлт өөрчлөлт, оруулахыг хориглодог¹¹³.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр мөнхийн заалтыг хамгаалах арга Америк болон Европт түгээмэл болж¹¹⁴ байна. Франц улс бүгд найрамдах засаглалын хэлбэрт өөрчлөлт оруулахыг хориглохоос өмнө 19-р зууны эхний хагаст Латин Америкийн мужууд АНУ-ын Үндсэн хууль болон Францын хувьсгалын үзэл санааны нөлөөнд автаж, зарим зарчмуудыг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан хамгаалахын тулд өөрчлөх боломжгүй заалтуудыг тунхагласан байна. 2015 оны байдлаар 193 улсад Үндсэн хуулиа тунхаглаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд 59 улсын Үндсэн хуульд мөнхийн заалт (30.6%), 71 улсад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хязгаарласан заалтууд (36.8%), 12 улс 6.2% нь мөнхийн заалт болон нэмэлт, өөрчлөлт оруулахыг хязгаарлалт тавьдаг бол 51 улс буюу 26.4% нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа ямар нэгэн байдлаар хязгаарлалт тавьдаггүй¹¹⁵ байна.

Үндсэн хуулийн мөнхийн заалтын жишээ бол ХБНГУ-ын Үндсэн хуулийн 79 дүгээр зүйлийн 3 дах хэсэг буюу “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Холбоог мужид хуваах асуудлыг хөндөх, хууль тогтоох ажиллагаан дах тэдний оролцооны зарчим, 1 болон 20 дугаар зүйлд заасан зарчимд өөрчлөлт оруулахыг хориглоно” гэсэн байна.

ХБНГУ-ын 1-р зүйлд заасан үндсэн эрхэд өөрчлөлт, оруулахыг хориглодог байна. Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд 1) “Хүний нэр төр, алдар хүнд халдашгүй дархан байна. Үүнийг хүндэтгэх, хамгаалах нь улсын үүрэг мөн”, 2) “Хүний халдашгүй бөгөөд салшгүй эрх нь дэлхийн энх тайван, эв нэгдэл, шударга ёсны үндэс суурь болохыг Германы ард түмэн хүлээн зөвшөөрч байна”, 3) “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь хүний үндсэн эрхийг хуулиар хамгаалах үүрэгтэй” гэж заажээ.

Мөн хуулийн 20 дугаар зүйлд 1) “Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь ардчилсан, социаль, холбооны улс байна”, 2) “Улсын бүх эрх мэдэл ард түмнээс эх үндэстэй байна. Энэ эрх мэдэл нь ард түмний санал хураалт, сонгуулийн үндсэн дээр байгуулагдсан хууль

[Constitute \(constituteproject.org\)](https://www.constituteproject.org) accessed 20 january 2023

¹¹¹ Mexico Const. (1824), art. 3

¹¹² Art. 149 of the Constitution of Afghanistan. The role of Islam as the religion of the State is unamendable also in Algeria or Morocco

¹¹³ Constitution of Brazil, Art. 60/4 (1988, rev. 2015)

¹¹⁴ Claude Klein, On the Eternal Constitution: Contrasting Kelsen and Schmitt, in HANS KELSEN AND CARL SCHMITT: A JUXTAPOSITION (Dan Diner & Michael Stolleis eds., 1999). P.62

¹¹⁵ Hein, M., ‘Never say never’ Katapult magazin (2015) (8) [Never say never! On Entrenchment and Eternity Clauses in Modern Constitutions.](https://www.katapultmagazin.com/never-say-never-on-entrenchment-and-eternity-clauses-in-modern-constitutions/) | Michael Hein - Academia.edu

тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлээр дамжин хэрэгжинэ”, 3) “Хууль тогтоох эрх мэдэл нь үндсэн хуулийн дэг журам, гүйцэтгэх болон шүүх эрх мэдэл нь хууль, шударга ёсонд захирагдана”, 4) “Хэрэв засах боломжгүй тохиолдолд, энэхүү үндсэн хуулийн дэг журмыг үгүйсгэх гэсэн аливаа этгээдийг Герман хүн бүр эсэргүүцэх эрхтэй”, мөн 20а дугаар зүйлд “Үндсэн хуулийн журмын бүхий л хүрээнд төр нь ирээдүй үеийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан амьдралын баталгааг хууль тогтоох замаар ханган, хуульд нийцсэн гүйцэтгэх болон шүүхийн үйл ажиллагаагаар хамгаална” гэж заажээ.

Үндсэн хуульд өөрчлөлт оруулж болохгүй мөнхийн заалт байх нь нэг талаас нэмэлт, өөрчлөлт оруулах хязгаарлалт, хориглолт нь Үндсэн хуулийг өөрчлөхөд хэцүү, цаашлаад эрх зүйн хувьд боломжгүй болгох замаар улсын Үндсэн хуулийг хамгаалах бэлгэдлийн шинж чанартай¹¹⁶ гэж үздэг. Нөгөө талаас Үндсэн хуулийн зүйл, заалт, нь бэлгэдлээр хязгаарлагдахгүй, иргэдийн үндсэн эрхэд тулгуурладаг. Тухайлбал, Үндсэн хуулиар олгосон үндсэн эрхийг хамгаалахад чиглэгддэг. Энэ нь Үндсэн хуулийн шинэчлэлтэй холбоотой зөрчилдөөн гарах үед илэрдэг. Тухайлбал, 2014 онд Румын улсад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн мөнхийн заалтыг зөрчсөн гэж Үндсэн хуулийн шүүх тогтоосноор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглосон¹¹⁷ байна.

2008 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Туркийн Үндсэн хуулийн шүүх парламентаас боловсрол эзэмших эрх, тэгш байдлын зарчмын талаар Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосон¹¹⁸. Хууль тогтоогчийн зорилго нь их, дээд сургуулиудад байдаг толгойн алчуурыг хориглох явдал байв. Туркийн Үндсэн хуулийн шүүх уг нэмэлт, өөрчлөлтийг шашин шүтэх эрхийг хөндсөн, өөрчлөгддөггүй зарчмыг зөрчсөн тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзжээ¹¹⁹. Энэ нь нэг талаас Үндсэн хуультай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт зөрчилдөх явдал, нөгөө талаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчих боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. Энэ талаарх судалгааг Лондоны эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны сургуулийн докторант Янив Рознай дэлхийн улс орнуудын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн шүүх хянаж, хүчингүй болгосон талаар харьцуулан судалсан байна.

Ш. Дэвшүүлж буй асуудал

А. Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцүүлэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн Цэц хянах асуудал

Үндсэн хууль тогтоогч үндсэн хуулийнхаа эх бичвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болохгүй заалтын талаар заагаагүй. Ердийн хуульд “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа нь дур зоргын шинжтэй байж болохгүй; Үндсэн хуульд оруулах

¹¹⁶ (8) [Never say never! On Entrenchment and Eternity Clauses in Modern Constitutions. | Michael Hein - Academia.edu](https://www.academia.edu) accessed 20 january 2023

¹¹⁷ [Romania: a constitutional reform fiasco? | OSW Centre for Eastern Studies](https://www.osw.ac.uk) accessed 20 january 2023

¹¹⁸ Turkish Constitutional Court, June 5, 2008, No. 2008/16; 2008/116.

¹¹⁹ Ergun Ozbudun, “Judicial Review of Constitutional Amendments in Turkey”, 15(4) EUR. PUB. L. 533 (2009); Yaniv Roznai & Serkan Yolcu, An Unconstitutional Constitutional Amendment—The Turkish Perspective: A Comment on the Turkish Constitutional Court’s Headscarf, 10(1) INT’L J. CONST. L. 175 (2012); Abdurrahman Saygili, What is Behind the Headscarf Ruling of the Turkish Constitutional Court? 11(2) TURKISH STUD. 127 (2010).

нэмэлт, өөрчлөлт нь улс төрийн аль нэгэн нам, бүлэг, давхаргын ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалсан байж болохгүй; Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулсан, төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчмыг үгүйсгэсэн байж болохгүй”¹²⁰ гэжээ. Хүний эрх, эрх чөлөө, бүгд найрамдах засаг, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим, бүрэн эрхт байдал, нэгдмэл төр, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хуульд захирагдах, тусгай шүүхийг хориглох, шүүгчийн хараат бус байдал зэрэг үнэт зүйлсэд халдсан нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн бүлэг, зүйл, хэсэг, заалтад байхгүй шинэ томъёоллоор зохих бүлэгт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтыг Үндсэн хуулийн нэмэлт гэх бөгөөд тэр нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн байна. Үндсэн хуулийн зохих бүлэг, зүйл, хэсэгт байгаа заалтын нэр томъёог тодруулах, найруулгыг сайжруулахаар оруулж байгаа заалтыг Үндсэн хуулийн өөрчлөлт гэх бөгөөд тэрхүү өөрчлөлт нь Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцсэн шаардлагыг хангасан байх¹²¹ ёстой. 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Үндсэн хууль батлагдсанаас хойш 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр¹²², 2000 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр, 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр тус тус дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Мөн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах бодитой, ил тод байх зарчмын хүрээнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилга, үйл ажиллагаа нь дур зоргын шинжтэй байж болохгүй, улс төрийн аль нэгэн нам, бүлэг, давхаргын ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалсан байж болохгүй, Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хүний үндсэн эрх, эрх чөлөөг дордуулсан, төрийн эрх мэдлийг хуваарилсан зарчмыг үгүйсгэсэн байж болохгүй¹²³ билээ. Үүнтэй холбоотойгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа түүний үндсэн бүтэц ба суурь үзэл баримтлалыг нь хөндөхгүй гэж тусгайлан заажээ¹²⁴.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан¹²⁵ бөгөөд нэмэлт өөрчлөлтөөр орсон Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн заалт нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэсэн мэдээллийг иргэдээс гаргасны дагуу ҮХЦ их суудлын хуралдаанаараа 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцэж №2 дугаартай тогтоол¹²⁶ гарсан билээ.

¹²⁰ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1; 5.4.2; 5.4.3

¹²¹ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг

¹²² Уг нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн Цэцийн 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон

¹²³ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.3 дах хэсэг

¹²⁴ Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал” (2022), 3 дах тал. <https://legaldata.mn/b/1387>

¹²⁵ Эрх зүйн акт дэлгэрэнгүй (legalinfo.mn) accessed 21 january 2023

¹²⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2022.08.15-ны өдрийн 2 дугаартай тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай (legalinfo.mn) accessed 21 january 2023

Тогтоох хэсэгтээ “... Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал, Нэгдүгээр зүйлийн 2 дах хэсгийн “Ардчилсан ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэнтэй нийцэхгүй байх тул хүчингүй болгосугай гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй зүйл, заалт байхгүй¹²⁷ бөгөөд ҮХЦ Үндсэн хууль дах мөнхийн заалтад үндэслэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянах боломжгүй тул 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт, өөрчлөлтийг хянахдаа үндсэн бүтцийн онолыг хэрэглэсэн байна. Гэвч үндсэн бүтцийн онолд үндэслэн агуулгын хяналт хэрэгжүүлэх тохиолдолд Үндсэн хуулийн суурь зарчмыг л хамгаалах ёстой¹²⁸ байдаг байна. Эндээс Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.” гэсэн заалт нь Үндсэн хуулийн суурь зарчимд хамаарахгүй тул үндсэн бүтцийн онолыг хэтрүүлэн хэрэглэсэн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуульд¹²⁹ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэр нь зөвхөн хууль байна¹³⁰ гэж заажээ. Энэ нь аливаа парламентын батлан гаргах эрх бүхий хамгийн дээд хүчин чадалтай шийдвэр нь хууль байдагтай холбоотой¹³¹.

Үндсэн хуулийн Цэцийн 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн №2 дугаартай тогтоол гарсантай холбогдуулан, Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэсэн заалт нь хүчингүй болж, УИХ ээлжит бус чуулган зарласан¹³² билээ. УИХ-ын ээлжит бус чуулган хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн Цэц хянахаар нэмэлт оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Үндсэн хуулийн Цэц дахин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчсөн гэх маргааныг хянахгүй болж байна. Улсын Их Хурал хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд¹³³ Үндсэн хуульд

¹²⁷ Д.Гангабаатар “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”.УБ.,2019, 116 дах тал

¹²⁸ Б.Ариунзаяа “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн хянах асуудал: харьцуулсан судалгаа” (2022), 6 дах тал.

¹²⁹ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2011 он, №3

¹³⁰ Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4 дэх хэсэг

¹³¹ Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал” (2022), 4 дэх тал./ <https://legaldata.mn/b/1387/> Last visited on 28.12.2022

¹³² Улсын Их Хурлын ээлжит бус чуулганыг 2022 оны 08 дугаар сарын 22-ноос 26-ны өдрүүдэд товлон зарлалаа (parliament.mn)

¹³³ Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1.1 дэх хэсэг /МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН

нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд Улсын Их Хурлаас баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд харшлах боломжтой юм.

Мөн Иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий албан тушаалтны хүсэлтээр Үндсэн хуулийн маргааныг анхлан хянан хэлэлцэж дүгнэлт гаргадаг нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн, манай Үндсэн хуулийн хяналтын нэг томоохон онцлог, ялгаатай шинж юм¹³⁴. Бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн гаргаж буй шийдвэр шууд эцсийн шийдвэр хэмээн тооцогддог¹³⁵ бол Монгол Улсын хувьд Цэцийн дунд суудлын хуралдаанаас гарах дүгнэлтийг Улсын Их Хуралд уламжилдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлийн 2-т заасны дагуу Үндсэн хуулийн маргаан нэгэнт үүсгэсэн бол түүнийг дунд суудлын хуралдаанаар шийдвэрлэх ёстой байсан ч Үндсэн хуулийн цэц 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэхдээ шууд их суудлын хуралдаанаараа хянан хэлэлцсэн байна.

Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэсэн нь 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн №2 тогтоолдоо дээрх асуудлын талаар хөндөөгүй бөгөөд энэ нь Үндсэн хуулийн Цэц Үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлийн 2 дах хэсгийг зөрчсөн нь харагдаж байна.

Дүгнэлт

Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлт Үндсэн хууль зөрчсөн эсэх хандлага дэлхий нийтэд аль хэдийн бий болсон бөгөөд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцүүлж, мөнхийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох, нэмэлт, өөрчлөлт нь өөрөө уг заалтад нийцэж буй эсэхийг хянах хандлага түгээмэл гарч байна.

Дэлхийн улс орнуудын Үндсэн хуульд ихэвчлэн Үндсэн хуулийн удиртгал, тухайн ард түмний бүрэн эрхт байдал, үндсэн эрх, шашин шүтэх эрх, уламжлал, соёл зэргийг мөнхийн заалт гэж үздэг. 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуульд орсон 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн зарим нэмэлт, өөрчлөлтүүд Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн Цэц агуулга талаас нь хянахдаа Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэсэн нь үндэслэлгүй, харин Үндсэн хуулийн удиртгал, суурь зарчимд нийцүүлэн хянах боломжтой байсан. Мөн Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянахдаа процессын хэд хэдэн ноцтой алдааг гаргасан байна. Тухайлбал, Үндсэн хуулийн жаран зургаадугаар зүйлийн 2, 3 дах хэсэг, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дах хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

[ХУУЛЬ \(legalinfo.mn\)/](http://legalinfo.mn/)

¹³⁴ Ц.Сарантуяа “Үндсэн хуулийн процессын эрх зүй” хоёр дахь хэвлэл.УБ.,2021, 168 дахь тал

¹³⁵ Тухайлбал, Constitutional Court decisions together with the reasons and some resolutions shall be published in the State Gazette within fifteen days of their adoption. The decisions shall enter into force three days after their publishing. The constitutional court of the Republic of Bulgaria. София, 2004, p.13

Монгол Улсын Их Хурал 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг Цэц хянах эрхтэй болсон бөгөөд хууль тогтоогчоос баталсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дахин Үндсэн хуулийн эх бичвэрт харшлах магадлалтай тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хууль хэмээн үзэж, Үндсэн хуулийн Цэц хянах нь зүйтэй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн үндсэн бүтэц, суурь үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг Цэц хянах нь олон улсын жишигт нийцэж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Монгол эх сурвалж

Гангабаатар Д, “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”.УБ.,2019 он
Сарантуяа Ц, “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуулийн шүүх (Цэц) хянах эсэх асуудал”
(2022)

“Эрх зүй- Num Law review” сэтгүүл., 2023 №1, цуврал 61

Монгол Улсын Үндсэн хууль.,УБ., 1992 он

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль.УБ.,2010 он

Төрийн мэдээлэл эмхэтгэл.1992 №1

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022.08.15-ны өдрийн №2 дугаартай тогтоол

Гадаад эх сурвалж

Claude Klein, On the Eternal Constitution: Contrasting Kelsen and Schmitt, in HANS KELSEN AND CARL SCHMITT: A JUXTAPOSITION (Dan Diner & Michael Stolleis eds., 1999)

Ergun Ozbudun, “ Judicial Review of Constitutional Amendments in Turkey, 15(4) EUR. PUB. L. 533 (2009); Yaniv Roznai & Serkan Yolcu, An Unconstitutional Constitutional Amendment—The Turkish Perspective: A Comment on the Turkish Constitutional Court’s Headscarf, 10(1) INT’L J. CONST. L. 175 (2012); Abdurrahman Saygili, What is Behind the Headscarf Ruling of the Turkish Constitutional Court? 11(2) TURKISH STUD. 127 (2010).

Hein, M., ‘Never say never’ Katapult magazin (2015) (8) Never say never! On Entrenchment and Eternity Clauses in Modern Constitutions. | Michael Hein - Academia.edu

Jacobsohn, G.I. Constitutional Identity, Cambridge: Cambridge University Press (2010)

Ondřej Preuss “The Eternity Clause as a Smart Instrument – Lessons from the Czech Case Law”., Hungarian Journal of Legal Studies 57, No 3, (2016)

Preuss, O. (2016a). The Eternity Clause as a Smart Instrument – Lessons from the Czech Case Law, in Hungarian Journal of Legal Studies, No. 3 (57)

Silvia Suteu “Eternity clauses in post-conflict and post-authoritarian constitution-making: promise and limits” p.1 Suteu _Eternity Clauses in Post-conflict and Post-authoritarian Constitution-Making.pdf (ucl.ac.uk)

Ulrich K. Preuss. “The implications of “eternity clauses”: the german experience” Israel law review. Vol 44., 2011 / THE IMPLICATIONS OF “ETERNITY CLAUSES”: THE GERMAN EXPERIENCE (danielturpqc.org)/

Walter F. Murphy, Merlin’s Memory: The Past and Future Imperfect of the Once and Future Polity, in RESPONDING TO IMPERFECTION: THE THEORY AND PRACTICE OF CONSTITUTIONAL

AMENDMENT (Sanford Levinson ed., 1995).

Yaniv Roznai “Unconstitutional Constitutional Amendments—The Migration and Success of a Constitutional Idea”, 2013, The American Journal of Comparative Law [Vol. 61]

Zbigniew Witkowski, Maciej Serowaniec “Eternity clause – a realistic or merely an illusory way of protecting the state’s constitutional identity?” (2021)

Mexico Constitution. (1824), art. 3

Constitution of Afghanistan

Constitution of Brazil, (1988, rev. 2015)

Romania: a constitutional reform fiasco? | OSW Centre for Eastern Studies

Turkish Constitutional Court, June 5, 2008, No. 2008/16; 2008/116.

US Constitution- 17th September 1787, United States of America 1789 (rev. 1992) Constitution - Constitute
(constituteproject.org)



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

ИХ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН СУДАЛГАА

Б.Түвшинжаргал

Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, Салбар Дундын Судлалын Тэнхмийн Ахлах багш



Түлхүүр үг:

Их сургууль, их сургуулийн нийгмийн хариуцлага, оролцогч талууд

Хураангуй

Орчин үеийн их сургуулиуд сургалтын үйл ажиллагаа эрхлэх, судалгаа хийхээс илүү өргөн хүрээнд ажиллах шаардлагатай тулгарч, урт хугацааны амжилт, давуу тал нь нийгэмтэй тогтоосон харилцаанаас ихээхэн хамаарах шинжтэй болж, стратегийн түвшинд нийгмийн хариуцлагыг авч үзэх, урт хугацааны бодлого боловсруулах, оролцогч талуудтай тогтвортой харилцаа тогтоох, хамтран ажиллах, үйл ажиллагаандаа татан оролцуулах асуудал чухал болсон. Энэхүү судалгааны өгүүлэлд их сургууль ба оролцогч талууд хоорондын харилцааны онцлог, их сургуулийн нийгмийн хариуцлага нь оролцогч талуудтай тогтоосон үр дүнтэй харилцаанаас ихээхэн хамаарах тухай онолын судалгааны үр дүнг тоймлон танилцуулж байна.

Судалгааны үндэслэл

Их сургуулиудын өрсөлдөх чадвар, тогтвортой байдалд нөлөөлж буй чухал хүчин зүйл бол их сургуулийн нийгмийн хариуцлагын асуудал юм. Орчин үеийн их сургуулиуд зөвхөн сургалтын үйл ажиллагаа эрхлэх, судалгаа шинжилгээ хийхээс илүү өргөн хүрээнд ажиллах шаардлагатай тулгарч, урт хугацааны амжилт, давуу тал нь нийгмийн янз бүрийн харилцан адилгүй хүсэл сонирхол, зорилготой бүлгүүдтэй тогтоосон тогтвортой урт хугацааны харилцаанаас ихээхэн хамаарах шинжтэй болж байна. Нийгэмтэй сайн харилцаа тогтооно гэдэг нь их сургуулиуд стратегийн түвшинд нийгмийн хариуцлагыг авч үзэх, урт хугацааны бодлого боловсруулах, оролцогч талуудтай тогтвортой харилцаа тогтоож хамтран ажиллах, үйл ажиллагаандаа татан оролцуулах тухай асуудал юм. Нийгэмтэй харилцаа тогтоох гол гүүр бол их сургуулийн хувьд түүний оролцогч талууд бөгөөд оролцогч тал тус бүрийн онцлог, ялгаатай байдлыг судалж, янз бүрийн харилцан адилгүй харилцааны арга хэрэгслийг ашиглан хамтран ажиллах шаардлагатай болно.

Их дээд сургуулиуд зөвхөн сургалт, эрдэм шинжилгээний үйлчилгээ үзүүлэхээс гадна эх орон, дэлхийн нийтийн өмнө өндөр хариуцлага хүлээсэн оюутнуудыг асуудалд шүүмжлэлтэй байр сууринаас ханддаг, ухамсартай иргэн болгон төлөвшүүлэх томоохон

үүрэг хүлээдэг. Иймээс бизнесийн байгууллагуудын нэгэн адил их дээд сургуулиуд ч нийгмийн хариуцлага хүлээх шаардлагатай болж байна. Нийгмийн хариуцлагын талаарх судалгааны бүтээлүүдийг судалж байх явцад, бизнесийн байгууллагын янз бүрийн түвшинд нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх, бодлого боловсруулах талаарх судалгаа голлож, их сургуулиуд, төрийн болон ашгийн бус байгууллагын нийгмийн хариуцлагын судалгааны бүтээлүүд харьцангуй цөөн байгаа нь цаашид гүнзгийрүүлэн судлах бас нэг шалтгаан болсон. Их сургууль нь үйл ажиллагааны хувьд аж ахуйн нэгжээс ялгаатай, онцгой төрлийн байгууллага хэдий ч оролцогч талуудын (төгссөн болон одоо сурч буй оюутнууд, ирээдүйн оюутнууд, оролцогч талууд, дэмжигчид, гэх мэт) хүлээлтийг хангахуйц нийгмийн хариуцлагын стратеги боловсруулах шаардлага чухлаар тавигдах болсон байна (Vasilescu et al., 2010).

Монгол улсын хувьд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-ын 7.13-д Монгол Улсын 4 - өөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 сургуулийн эгнээнд хүргэх зорилго тавьжээ. Түүнчлэн олон их сургуулиуд “бүс нутгийн их сургууль болон хөгжих” зорилго тавьж, сургуулийнхаа алсын харааны нэг хэсэг болгон тодорхойлсон. Олон улсын түвшинд их сургуулиуд зөвхөн сургалт, судалгааны амжилтаас гадна нийгэмд үзүүлсэн үйлчилгээний амжилтаар өрсөлдөж буй энэ цаг үед манай их сургуулиуд үйл ажиллагаагаа өргөн хүрээнд харах шаардлагатай тулгарч байгаа нь судлаачийн хувьд их сургуулийн нийгмийн хариуцлагыг оролцогч талуудтай тогтоосон харилцааны өнцгөөс судлах шаардлагыг бий болгосон.

Энэхүү судалгааны өгүүлэлд их сургууль ба оролцогч талууд хоорондын харилцааны онцлог шинж чанар, их сургуулийн нийгмийн хариуцлага нь оролцогч талуудтай тогтоосон үр дүнтэй харилцаанаас ихээхэн хамаарах тухай онолын судалгааны үр дүнг танилцуулна. Нэгдүгээрт; их сургуулийн оролцогч талуудыг тодорхойлж, тэдгээрийн онцлог шинж чанаруудыг тайлбарлах, хоёрдугаарт; их сургууль ба оролцогч талуудын хоорондын харилцаа, их сургуулийн нийгмийн хариуцлага нь оролцогч талуудаас хэрхэн хамаарах тухай асуудлыг хөндсөн. Мөн түүнчлэн их сургуулийн нийгмийн хариуцлагын үзэл баримтлалын талаарх судалгааны үр дүнг нэмж тайлбарлахыг зорьсон.

Их сургууль түүний оролцогч талууд

Их сургууль нь “дээд боловсролын байгууллага” бөгөөд бакалавр, магистр, докторын зэрэг олгохоос гадна насан туршийн тасралтгүй боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг боловсролын байгууллага юм. Орчин үеийн их дээд сургуулиудын үндсэн чиг үүргүүдэд сургалт явуулах, судалгаа шинжилгээ хийх, нийгэмд үйлчилгээ үзүүлэх гэсэн гурван төрлийн үүрэг оногдож байна. Энэхүү судалгааны зорилго нь үндсэндээ их сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээ, нийгэмтэй тогтоож буй харилцаанд анхаарал хандуулна.

Олон улсын хөгжлийн байгууллагуудын тайлангаас харахад, 20 – р зууны сүүлийн хагаст хүн төрөлхтөнд нийгэм, эдийн засаг технологийн дэвшил үсрэнгүй гарсан хэдий ч нийгмийн шударга бус байдал ихэсч, тэгш бус байдал газар авсан, авлига хүнд суртал ихтэй, орлого багатай улс орнуудад иргэдийнх нь нийгэм эдийн засгийн амьдралд оролцох оролцоо нь бага байгааг тэмдэглэсэн байдаг. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд улс орныхоо нийгмийн үнэт зүйлсийн элементүүдийг иргэддээ тайлбарлах ойлгуулах, боловсролын

систем нь ёс зүй, хариуцлага, үнэт зүйлсийн талаар хэрхэн авч үзсэн байдал, энэ асуудлыг шат шатны боловсрол олгох сургалтын хөтөлбөрт тусгасан уу, үр дүнг хэмжиж байна уу, шат шатны хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж чадаж байна уу, сургалтын хөтөлбөрүүд нь ирээдүйн удирдагчид, хариуцлагатай төгсөгчдийг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байна уу гэх мэтээр шат шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагаатай дээрх асуудлыг холбон тайлбарласан байна. Мөн түүнчлэн их сургуулийн нийгмийн хариуцлагаар дамжуулан иргэдийн оролцоонд анхаарал тавих тухай асуудлыг хөндсөн ба их сургуулиуд өөрөө байгууллага болохынхоо хувьд гадаад болон дотоод оролцогч талуудын харилцаанд баримтлах байр суурь стратегиа тодорхойлж, оролцогч талуудаар дамжуулан улс орны нийгэм эдийн засгийн амьдралд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарал тавьж, харилцан хамтран ажиллаж болох тухай тэмдэглэсэн байна.

Эндээс харахад их сургуулиуд оролцогч талуудаар дамжуулан улс орон, дэлхий нийтийн нийгэм эдийн засгийн асуудалд шууд ба шууд бусаар оролцох, оролцогч талуудыг сургах, дэмжих, хамтран ажиллах зэргээр нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч болж, нийгмийн манлайлал үзүүлэх замаар хамтран хөгжих боломжтой ба энэ нь их сургуулийн нийгмийн хариуцлагын үзэл баримтлалд нийцэж байгаа юм. Оролцогч талууд гэдэг нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд эерэг болон сөрөг нөлөө үзүүлдэг, эсвэл түүнтэй харилцах шаардлагатай хүмүүсийн бүлэг юм (Ebner and Baumgartner, 2008).

Их сургуулиуд нь бодлого боловсруулагч ба хэрэгжүүлэгч шат шатны удирдах ажилтнууд, багш нар, оюутнууд, сургалтын үйл ажиллагааны чиглүүлэгч болон туслах ажилтнууд, эрдэм шинжилгээний ажилтнууд, оюутны өөрөө удирдах байгууллагууд, төгсөгчид, төгсөгчдийн холбоо, тэдний эцэг эхчүүд ба орон нутгийн иргэд, оршин суугаа газрын холбогдох нийгмийн бүлгүүд, өрсөлдөгчид ба нийлүүлэгчид, хамтрагчид, хувь хүмүүс, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх сонирхолтой гадаад болон дотоодын байгууллагууд, үйл ажиллагаанд хяналт тавьж зөвшөөрөл олгох төрийн болон төрийн бус байгууллагууд, ирээдүйн болон өнөөдрийн ажил олгогч бизнесийн байгууллагууд, бусад их сургуулиуд гэх мэт янз бүрийн нийгмийн бүлгүүд ба оролцогч талуудтай тогтоосон харилцаанд тулгуурлаж, үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлдэг. Их сургуулийн үйл ажиллагааны түлхүүр буюу шууд оролцогч бол багш, оюутан, ажилтнууд бөгөөд тэдгээр нь бусад оролцогч талуудтай амжилттай харилцаа тогтоож, их сургуулийн хөгжлийг тодорхойлно. Оролцогч талууд нь байгууллагын зорилго болон нийгмийн хүлээлт хоёрын хоорондох холбоосыг бүрдүүлдэг (Whetten et al., 2002).

Байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талуудын талаарх судалгаа ихэвчлэн бизнесийн байгууллагууд дээр хийгдсэн байгаа ба их сургуулийн оролцогч талуудын судалгаа хангалттай биш байна. Судлаач Василески нарын 2010 онд оролцогч талуудын хандлагад үндэслэн их сургуулийн нийгмийн хариуцлагыг боловсруулах талаар хийсэн судалгаанаас харахад, тухайн байгууллага оролцогч талуудын хандлага, хүлээлтийг байнга судлах, үнэлэх шаардлагатай бөгөөд оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, сэтгэл ханамжийг дутуу үнэлэх нь урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэх тухай дурьдсан байдаг. Оролцогч талууд нь тухайн байгууллагад өөр өөр ач холбогдолтой байдаг ба байгууллагын хөгжилд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг учраас оролцогч талуудад хандах хандлага болон нөөцийн харилцан адилгүй бие даасан стратеги ашиглаж, удирдлагын хүчин чармайлтын зардал болон санхүүгийн бусад зардлуудыг янз бүрээр төлөвлөх зарцуулах тухай анхаарч үзэх талаар

судлаачид бичсэн байна. Иймд их сургуулиуд оролцогч тал тус бүртэй харилцан адилгүй арга барилаар ажиллаж, нийгэмтэй тогтвортой харилцаа тогтоох шаардлагатай болж байна.

Их сургуулийн оролцогч талууд ба их сургуулийн нийгмийн хариуцлагын харилцан хамаарал

Аливаа байгууллага ашгийн төлөө юу, ашгийн бус зорилготой юу гэдгээс үл хамааран үйл ажиллагаандаа оролцогч талуудын өмнө хамгийн эхэнд хариуцлага хүлээх ёстой юм. Орчин үеийн байгууллагууд оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэж, тэдний өмнө хариуцлага хүлээх ёстой (Фадун, 2014). Эдийн засгийн субъект бүр өөрийн хүрээлэн буй орчны амьд ба амьгүй элементүүдээр хүрээлэгдсэн, оролцогч талууд гэж нэрлэгддэг бодит орчинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь нэг талаас хүрээлэн буй орчны нөлөөнд автдаг бол нөгөө талаас түүнд нөлөөлдөг. Нийгмийн хариуцлагын тухай ойлголт нь тухайн улс орны хөгжлөөс үл хамааран нийгмийн харилцан хамаарлыг нэгтгэдэг ойлголт юм. Тиймээс төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагууд орчин тойрныхоо эерэг хөгжилд хувь нэмрээ оруулахыг хичээх хэрэгтэй. Энэ нь өөрсдийн зорилгоо биелүүлэх цорын ганц арга зам учраас нийгмийн хариуцлагатай байх ёстой(Европын комиссын тайлан).

Адриан, Николета нарын судалгаанд “Компанийн нийгмийн хариуцлага нь нийгэмд болон хэрэгжүүлэгч байгууллагуудад ашиг тусаа өгөх өнөө үеийн хамгийн ашигтай бизнесийн стратеги гэж үзэж болно гээд ...тиймээс компаниуд бүх оролцогч талуудын эрх ашгийг бодолцох ёстой” гэж дурьдсан байдаг.

Ерөнхийдөө, компанийн нийгмийн хариуцлагад нийгмийн хариуцлагын анхдагч ойлголтууд үндэслэгддэг бөгөөд нийгмийн хөгжлийн явцад бусад байгууллагуудын нийгмийн хариуцлагын ойлголт, хэрэглээ гарч ирсэн. Мөн компанийн нийгмийн хариуцлагын асуудал нь байгууллагын нийгмийн хариуцлагын онолыг суурь болгох ба энэ утгаараа бусад байгууллагуудын хувьд огт өөр үндэслэл ярих боломжгүй юм. Иймээс их сургуулиуд, төр болон ашгийн бус байгууллагууд нь байгууллагын онол, байгууллагын нийгмийн хариуцлагын онолыг иш үндэс болгох ба их сургуулийн нийгмийн хариуцлагыг энэ үүднээс тайлбарлах боломжтой болдог.

Орчин үеийн байгууллагууд тогтвортой өрсөлдөх давуу талаа бий болгохын тулд үйл ажиллагааныхаа нийгэмд үзүүлэх нөлөөлөлд ихээхэн анхаарал хандуулж байна. Энэ дагуу, их дээд сургуулиуд ч оролцогч талуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор компанийн нийгмийн хариуцлагын стратегийг улам бүр хэрэгжүүлэх шинжтэй болж байна. Гэсэн хэдий ч нийгмийн хариуцлагад зарцуулагдах нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, харилцан адилгүй үр дүнд хүрч байна. Иймд нийгмийн хариуцлагыг амжилттай төлөвлөж хэрэгжүүлэх, нөөцийг үр дүнтэй төлөвлөж хуваарилах, оролцогч талуудтай амжилттай харилцаа тогтоох, тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх гол арга хэрэгсэл бол оролцогч тал тус бүрийн хэрэгцээ, хандлага, онцлогийг судалж, тэдгээртэй харилцан адилгүй арга барилаар ажиллах явдал юм.

Их сургуулийн нийгмийн хариуцлага оролцогч талуудаас ихээхэн хамааралтай бөгөөд тухайн их сургуулийн нийгмийн хариуцлагаас оролцогч тал тус бүрийн хүлээх хүлээлт нь

харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Судлаач Васкиүз, Тавизон нарын 2021 онд Мексикийн дээд боловсролын байгууллагуудын үр нөлөөг сайжруулах зорилгоор хийсэн “Их сургуулийн нийгмийн хариуцлагын удирдлагын загвар” судалгаанд; “...их сургуулиуд оюутнуудад зөвхөн сургалт, эрдэм шинжилгээ судалгааны үйлчилгээ үзүүлэхээс гадна эх орон, нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг, ухамсартай иргэн болон төлөвшихөд хамгийн томоохон үүрэг хариуцлагыг урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр хүлээх шаардлагатай болж байгаа талаар дурьдаад, их сургуулийн нийгмийн хариуцлагын үзүүлэлтүүд оюутны гүйцэтгэл, идэвх оролцоо, сурлагын амжилт, дүрэм журмаа сахих байдалд эерэгээр нөлөөлж байгаа бөгөөд цаашид ирээдүйн хөдөлмөрийн талбарт бие даан ажиллах, нийгмийн асуудлыг танин мэдэж, нийгэмдээ хувь нэмрээ оруулдаг бие хүн болон төлөвших, тогтвортой байдал, хүрээлэн буй орчны төслүүдийг ойлгож, хэрэгжүүлэх ухамсартай иргэн болоход нөлөөлөгч хүчин зүйл нь болно” гэж дүгнэсэн байдаг.

Эндээс харахад, их сургуулиуд ирээдүйд зөвхөн академик боловсролоор тогтохгүй ёс суртахуунлаг, дүрэм журмаа чанд сахидаг, нийгмийн асуудлыг ухаалгаар танин мэдэх чадвартай, нийгмийн асуудалд оролцдог, шийдэл хайдаг, хариуцлагатай иргэдийг бэлтгэхэд чиглэсэн стратеги боловсруулах шаардлагатай болж байна.

Murray, Vogel (1997) нар нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөрүүдийн хэрэглэгч, олон нийтэд үзүүлэх нөлөөллийг судалж, энэ нь тухайн бизнест хандах хандлага, үнэнч шударга үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх итгэл үнэмшил, хэрэглэгчийн хариу үйлдлийн эерэг байдал зэргийг нэмэгдүүлсэн байна гэх дүгнэлтэнд хүрсэн байдгаас харахад, ямар ч байгууллага нийгмийн хариуцлагад анхаарал хандуулж, тодорхой хэмжээний нөөц зарцуулж, урт хугацаанд хэрэгжүүлэх нь амжилтанд нөлөөлөх боломжтойг харуулж байгаа юм. Иймээс их сургуулиуд нийгмийн хариуцлагын стратеги боловсруулж, өнөөдрийн багш, оюутнуудаар дамжуулан хэрэгжүүлж, бусад оролцогч талуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулж, хамтран ажиллаж, тэдгээр оролцогч талуудыг манлайлан чиглүүлэх замаар нийгмийн хариуцлага хэрэгжүүлэх нь урт хугацаанд тухайн их сургуулийн өрсөлдөх чадварыг сайжруулна. Байгууллагууд нэр хүндээ бэхжүүлэх, оролцогч талуудтай харилцах харилцаагаа сайжруулах, өрсөлдөх давуу талтай болохын тулд нөөцийг нийгмийн хариуцлагын стратегид зарцуулж байна (МакДональд ба Рандл-Тиеле, 2007). Мөн бизнесийн байгууллагууд өөрсдийн бодлого, үйл ажиллагаанд нийгмийн бүлгүүдийг татан оролцуулах сонирхол улам ихээр нэмэгдэж, нийгэмдээ учруулж болзошгүй сөрөг үр дагаварт хариуцлагатай хандах, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, зөвхөн санхүүгийн асуудал, ашиг орлогын гэхээсээ илүү нийгмийн анхаарал татахыг эрмэлзэж байна.

Судлаачид энэ талаар нийгмийн хариуцлага үзэл баримтлалын шинжтэй байхаа больж, бодит байдалтай илүү уялдаатай болж байгаа тухай хэлэлцэж эхэлсэн ба одоо боловсролын байгууллагууд илүү манлайлал үзүүлж, оролцогч талуудтайгаа тогтвортой харилцаа тогтоож, нийгмийг хөгжүүлэхэд оролцох шаардлагатай гэж үзэж байна. “Нийгмийн хариуцлага нь ... зөвхөн төлөвшүүлэх зорилгоос гадна тэгш байдал, харилцан хүндэтгэл, хариуцлага, ёс суртахууныг төлөвшүүлж, нийгэм байгаль орчны асуудалд нөлөөлөх чхуал хүчин зүйл байх ёстой(Ahumada Tello, Ravina Ripoll, & López Regalado, 2018).

Нийгмийн хариуцлагын онолын үзэл баримтлалд томоохон байр суурь эзэлдэг оролцогч талуудын онолын чиг хандлагад суурилан их сургуулиуд оролцогч талуудын сонирхол хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн, ирээдүйд оролцогч талуудаас харилцан хүндэтгэл хүлээх

боломжтой, харилцан хамааралтай нийгмийн хариуцлагын стратеги хэрэгжүүлэх нь их сургуулиудын өнөөдөр анхаарах чухал асуудлын нэг болсон байна.

Дүгнэлт

Их сургуулиудын өрсөлдөх чадварт нөлөөлж буй нийгмийн хариуцлагыг төлөвлөж хэрэгжүүлэхдээ их сургуулиудын оролцогч талууд тус бүрийн харилцан адилгүй онцлог шинж чанарт үндэслэх нь чухал гэдгийг энэ нийтлэлийн хүрээнд тэмдэглээд, энэхүү нийтлэлээр цаашид үргэлжлэн хийгдэж байгаа судалгааны нэгээхэн хэсгийг тоймлосон төдий гэдгийг хэлэх байна. (Vásquez-Torres & Tavizón-Salazar, 2021)

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Atakan, M. G. S., & Eker, T. (2007). Corporate Identity of a Socially Responsible University – A Case from the Turkish Higher Education Sector. *Journal of Business Ethics* (2007), 55–68. <https://doi.org/10.1007/s10551-006-9274-3>
- Badat, S. (2009). The role of higher education in society: valuing higher education. *HERS-SA Academy*, (September), 1–14. <https://doi.org/10.1080/03004279.2014.931545>
- Dahan, G. S., Senol, I., & Assistant, T. (2012). Corporate Social Responsibility in Higher Education Institutions : Istanbul Bilgi, 2(3), 95–103.
- Galbreath, J. (2009). Building corporate social responsibility into strategy. *European Business Review*, 21(2), 109–127. <https://doi.org/10.1108/09555340910940123>
- Gomez, L. (2014). The Importance of University Social Responsibility in Hispanic America: A Responsible Trend in Developing Countries, 8, 241–268. <https://doi.org/10.1108/S2043-905920140000008013>
- Mongolia, I. (n.d.). *Монгол дахь нийгмийн хариуцлагын нөхцөл байдлыг үнэлэх зураглал судалгаа*.
- Studiu privind implicarea instituțiilor de învățământ superior din România în acțiuni și activități de responsabilitate socială. (n.d.).
- Vasilescu R, Bana C, Epure M, Baicu V. (2010) Developing university social responsibility; A model for the challenges of the new civil society
- Vasquez M, Tavizon A. (2021) A Management model of University social responsibility from the stakeholders perspective
- Libena T, Veronika S. (2019) University Stakeholder Management and University Social Responsibility
- МИДСК, БСШУЯ. (2010). Дээд боловсролын чанар – бидний оролцоо, хамтын ажиллагаа” зөвлөгөөний эмхтгэл
- НҮБ –ын хөгжлийн хөтөлбөр. (2003). Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжил” төсөл
- Х.Цэцэгжаргал, Р.Нурбек. (2017) “Монголын дээд боловсролын өнөөгийн байдал ба менежментийн зохицуулалтын зарим асуудал
- Б. Түвшинжаргал (2018) Байгууллагын нийгмийн хариуцлагыг хөгжүүлэхэд төрийн үүрэг “



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

МОНГОЛ УЛС ДАХЬ ЛГБТ ХҮМҮҮСИЙН ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.Оюун¹, Ж.Хулан²

¹ Магистр (LLM), дэд профессор /СЭЗИС/

² Магистр (LLM), дэд профессор /СЭЗИС/



Хураангуй

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, бэлгийн ба хүйсийн баримжаа, хүйс, гэрлэлтийн байдал, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглодог. Хүйсийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл нь олон янз байдлаар илэрхийлэгддэг нь биологийн хувьд ялгаатай. Манай улсад 2000 оны эхэн үеэс бусад улс орнуудын нэгэн адил бэлгийн чиг хандлагад суурилсан ялгаварлалтаас сэргийлэхэд анхаарч эхэлсэн боловч энэ төрлийн ялгаварлалтад өртөж буй хүмүүс байсаар байна. Энэ өгүүлэлд бэлгийн чиг хандлагад суурилсан ялгаварлан гадуурхалтад өртдөг ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалтыг гадаад орнуудын зохицуулалттай харьцуулан авч үзэж, дүгнэлт хийлээ.

Түлхүүр үг:

Бэлгийн чиг баримжаа,
хүйсийн чиг баримжаа,
ЛГБТ, бисексуал,
трансжэндэр, бэлгийн
цөөнх, ялгаварлан
гадуурхах, тэгш эрх.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалтад зааснаар “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан бөгөөд Монгол Улс хүний эрхийн талаарх дөч гаруй гэрээ конвенцид нэгдсэн билээ. Монгол Улс Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг Төр иргэнийхээ өмнө хариуцдаг хэдий өнөөгийн байдлаар дээрх хүмүүсийн эрхийг хамгаалсан, сэргээн эдлүүлэх, тэгш эрхийн талаарх асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа нь төр иргэнийхээ өмнө хариуцсан үүргээ биелүүлэхгүй байгаагийн илрэл юм.

Үндсэн хэсэг

Судлагдсан байдал. Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн тухай асуудлыг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний

байдлын талаарх 12, 15 дахь илтгэл”, НҮБХХ-ийн Азид ЛГБТ байх нь: Монгол Улсын тайланд лесбиян, гей, бисексуал, трансжендэр хүмүүс, иргэний нийгмийн хууль эрх зүй, нийгмийн орчны оролцоонд суурилсан үнэлгээ, шинжилгээг хийсэн байна. Түүнчлэн судлаач Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж нарын “ЛГБТ - хүний эрх” гарын авлагад энэ асуудлыг тус тус түлхүү хөндсөн дотоодын эх сурвалжууд байна.

Судалгааны үр дүн. Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалтын орчинд дүгнэлт хийж, Герман, Япон орнуудын ЛГБТ хүмүүсийн эрхийн хамгаалалт, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан болно.

Бэлгийн цөөнх буюу ЛГБТ гэж лесбиян, гей, бисексуал, трансжендэр хүмүүсийг хэлэх ба нийгэм судлалын онолоор зуун хувь эмэгтэйлэг шинж бүхий эмэгтэй, зуун хувь эрэгтэйлэг шинж бүхий эр хүн гэдэг нь харьцангуй, хийсвэр ойлголт болохыг хүлээн зөвшөөрөх болсон байна. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн чиг баримжаа нь төрөлхийн бөгөөд өөрчлөгдөхгүй зүйл гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрөх болжээ. Ингэж хүлээн зөвшөөрөхөд 1973 онд АНУ-ын сэтгэц, эмгэг судлалын холбоо¹³⁶ ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчний ангиллаас албан ёсоор хасч, улмаар 1974 онд ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн үзэж, сэтгэцийн өвчин биш гэдгийг зарласан нь нөлөөлжээ. Мөн 1990 оны 5-р сарын 17-ы өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг хүний төрөлхийн ба салгаж болшгүй мөн чанар хэмээн хүлээн зөвшөөрч, сэтгэцийн өвчнөөс албан ёсоор хасч байгаагаар зарлажээ¹³⁷. Улмаар Англи 1994, ОХУ 1999, БНХАУ 2001 онд ЛГБТ байх нь сэтгэцийн өвчин биш гэдгийг хүлээн зөвшөөрсөн нь эдгээр хүмүүс нийгмийн харилцаанд бусдын нэгэн адил оролцох боломжийг бүрдүүлснээрээ ач холбогдолтой юм.

Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалт:

Монгол Улсад ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалтын асуудал ардчилсан хувьсгал ялж, хүний эрхийг дээдлэх болсон 1990 оноос хойш ярьж эхэлжээ. 1992 оны ардчилсан Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” хоёрдугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан нь бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар гадуурхаж үл болно гэсэн утгыг агуулж байна. Үндсэн хуулиас гадна нийгмийн харилцааг зохицуулж буй гол хуулиудад дээрх асуудлыг дараах байдлаар зохицуулжээ.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйлийн 3.2-т “Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй”, 10 дугаар зүйлийн 2.14-т “Үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ”, 14 дүгээр зүйлийн 14.1-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө

¹³⁶ American Psychiatric Association, APA

¹³⁷ <https://www.closebrothers.com/pride-month-2021/1990s-world-health-organisation-declassifies-same-sex-attraction-mental-illne>

чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заажээ.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6-д “Үрчилсний, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний, хүйс өөрчлөгдсөний, шилжилт хөдөлгөөний, Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоосны бүртгэлээс бусад иргэний улсын бүртгэлийг засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй бүртгэнэ” гэжээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно” гэж заажээ. Тэгвэл бусад өндөр хөгжилтэй орнуудад ЛГБТ хүмүүсийн эрх зүйн байдлыг хэрхэн зохицуулсныг ХБНГУ болон Япон улсын жишээн дээр авч үзье.

ХБНГУ-ын ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалт:

Германд лесбиян, гей, бисексуал, трансжендер хүмүүсийн (ЛГБТ) эрх дэлхийн хамгийн өндөрт тооцогддог бөгөөд сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд ихээхэн хувьсан өөрчлөгдөж байна¹³⁸. 1920-оос 1930-аад онд Берлин хотод лесбиян, гей хүмүүсийг нийгэм ерөнхийдөө хүлээн зөвшөөрч, гей эрчүүдийн үйлчлүүлж болох олон тооны баар цэнгээний газрууд нээгдсэн түүхтэй¹³⁹.

2001 онд Ижил хүйстнүүдийн хамтран амьдрах тухай хууль үйлчилж эхэлсэн ба ижил хүйстэн хосуудад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрлэлтээс үүсэх эрхүүдийг бүрэн олгоогүй 2 хамтын амьдралыг нь хүлээн зөвшөөрч, зохицуулж байжээ. Мөн Бундестаг 2017 оны 6-р сарын 30-д ижил хүйстэн хосуудын гэрлэх, хүүхэд үрчлэн авах бүрэн эрхийг Гэр бүлийн тухай хуульд нэмэлтээр оруулжээ. Ийнхүү Гэр бүлийн тухай хуулинд өөрчлөлт оруулснаар Ижил хүйстнүүдийн хамтран амьдрах тухай хууль хүчин төгөлдөр бус болсон. ХБНГУ-ын Гэр бүлийн тухай хуулиар ЛГБТ хүмүүсийн гэрлэлтийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн юм. Энэ хуулиар өв залгамжлал, тэтгэлэг, өмч хуваах, эрүүл мэндийн даатгал зэрэг асуудлыг шийдсэн бөгөөд хосуудын эрх, үүргийг нарийвчлан зохицуулсан байдаг. Гэрлэлтээ батлуулсан хосууд хүүхэд үрчилж авах шалгуурыг хангаж, хүүхэд үрчилж авсан бол Гэр бүлийн тухай хуулийн дагуу бусад эцэг, эх нартай адилхан үүрэгтэй байдаг. Мөн

¹³⁸ (Staff (1 January 2023). "LGBT Equality Index: The Most LGBT-Friendly Countries in the World". Equaldex. Retrieved 6 March 2023.)

¹³⁹ Ginn, H. Lucas (12 October 1995). "Gay Culture Flourished in Pre-Nazi Germany". Update, Southern California's gay and lesbian weekly newspaper. Retrieved 8 October 2017.

ижил хүйстэн дагавар хүүхэд үрчлэн авах, хамтрагчийнхаа аль хэдийн үрчилж авсан хүүхдийг үрчилж авах боломжийг олгосон байдаг¹⁴⁰.

Герман улс нь бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг нийгмийн бүхий л салбарт хамгаалах механизмыг бий болгосон байна. Түүнчлэн 2005 оны 8 дугаар сарын 18-д батлагдсан Тэгш эрхийн тухай хуулиар Германы бүх иргэд түүний дотор ЛГБТ хүмүүс ажил эрхлэлт, төрийн болон бусад үйлчилгээ авах зэрэг бүхий л харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хуульчилжээ.

Мөн бэлгийн хэвийн бус анатомитой төрсөн нярайн төрсний гэрчилгээн дээр хүйсийг хоосон үлдээдэг байна. Интерсекс хүмүүс бичиг баримтдаа гуравдагч хүйсээр тэмдэглүүлэх эрхтэй байна.

Герман улс насанд хүрээгүй хүмүүст хүйс солих ямар нэгэн эмчилгээ хийлгэхийг хориглосон дэлхийн тав дахь улс юм. Мөн эдгээр хүмүүс цэргийн алба хаах эрхтэй ба бэлгийн чиг баримжаа нь цэргийн цол хэргэм хүртэхэд хамааралгүй. Хэрэв олон нийтийн газарт ЛГБТ хүмүүсийг гадуурхаж, дарамталсан бол буруутай тал нь нөхөн төлбөр төлөх зохицуулалт бий.

2020 оны 9 дүгээр сард Германы засгийн газар өмнө нь цэрэгт ижил хүйстнүүдийг ялгаварлан гадуурхдаг байсандаа албан ёсоор уучлалт гуйсан¹⁴¹ ба мөн оны 11 дүгээр сард Германы Засгийн газар ЛГБТ хүмүүст нөхөн төлбөр олгох тухай хуулийг баталсан байна.

2021 оны 3 дугаар сард трансжендер болон интерсекс хүмүүсийн аль аль нь Германд цэрэг, цагдаагийн алба хаах боломжтой гэж мэдээлжээ.

Эрх зүйн зохицуулалт болон практикт хэрэгждэг байдлаараа ХБНГУ нь бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүмүүсийн амьдрах таатай эхний 10 орны жагсаалтад ордог байна.

Япон улсын ЛГБТ хүмүүсийн эрх зүйн зохицуулалт

1872 оноос 1880 оны хооронд Япон улсын түүхэнд ижил хүйстний бэлгийн харилцааг гэмт хэрэгт тооцдог байжээ¹⁴². 2015 оноос хойш ижил хүйстэн хосууд харилцаагаа хуулиар хүлээн зөвшөөрүүлэх бэлгэдлийн “түншлэлийн гэрээ” байгуулдаг байв. Тус түншлэлийн гэрээгээр ижил хүйстэн хосуудын эмнэлэгт үзүүлэх, орон сууц түрээслэх зэрэг амьдралын тодорхой асуудлуудыг шийдэж өгчээ. Энэ гэрээ нь лесбиян болон гей хосуудын эрхийн төлөөх чухал алхамд тооцогддог. 2015 оны эхэн үед зөвхөн Токио хот түншлэлийн гэрээг зөвшөөрсөн бол 2015 оны 7 дугаар сараас эхлэн хүн ам ихтэй Йокомо, Осака, Саппоро зэрэг хотууд хүлээн зөвшөөрчээ¹⁴³. Япон улс ижил хүйстнүүдийн харилцаа, тэдгээрийн төрийн бус байгууллага, холбоог хуулиараа албан ёсоор зөвшөөрдөггүй. 2019 онд Японы иргэдийн дунд явуулсан судалгаагаар дийлэнх хувь буюу 68 хувь нь ижил хүйстнүүдийг нийгэм хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзсэн байдаг бол 22 хувь нь эсэргүүцсэн санал өгчээ. Жил ирэх тутам ЛГБТ хүмүүсийг иргэд хүлээн зөвшөөрч, энэ нь илүү нээлттэй сэдэв болжээ.

¹⁴⁰ "German court expands adoption rights of gay couples". Reuters. 19 February 2013. Retrieved 8 October 2017.

¹⁴¹ Moulson, Geir (17 September 2020). "Germany apologizes for past military anti-gay discrimination". ABC News

¹⁴² Furukawa, Makoto. The Changing Nature of Sexuality: The Three Codes Framing Homosexuality in Modern Japan. pp. 99, 100, 108, 112.

¹⁴³ Tokyo's Setagaya Ward to begin legally recognizing same-sex partnerships". En.riocketnews24.com. 30 July 2015. Retrieved

Хэдийгээр олон улс төрийн намууд ЛГБТ эрхийг илт дэмждэггүй ч, бас эсэргүүцдэггүй байна.

Мөн 2012 оноос хойш “Tokyo rainbow” цуглааныг жил бүр зохион байгуулж, оролцогчдын тоо нэмэгдсээр байна. 2015 оны Японы иргэдийн дунд явуулсан судалгаагаар иргэдийн дийлэнх хувь нь ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзжээ. Японы иргэд бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүмүүсийн эрхийг дэмждэг ч, ЛГБТ хүмүүсийн дунд явуулсан судалгаагаар тэдний 38 хувь нь тодорхой хэмжээний дарамт, хүчирхийлэлд өртдөг гэж хариулсан байна¹⁴⁴.

Японы Үндсэн хуулийн 24 дүгээр зүйлийн 1-т “Гэрлэлт нь зөвхөн хоёр хүйсийн харилцан зөвшөөрлөөр, эхнэр, нөхөр хоёр тэгш эрхтэй байх үндсэн дээр уг харилцаа хадгалагдана” гэж заасан байна. Японы Иргэний хуулийн 731 дүгээр зүйлд зөвхөн өөр хүйсийн хүмүүсийн гэрлэлтийг зөвшөөрснөөрөө Япон улс ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуулиараа хүлээн зөвшөөрдөггүй улсуудын нэг юм. Ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хуулиар хүлээн зөвшөөрдөггүй учраас ижил хүйстэн хосууд хүүхэд үрчлэх эрхгүй ба лесби хосууд эмнэлзүйн аргаар үр тогтоох, хүүхэдтэй болох боломжгүй юм¹⁴⁵.

2018 оны 10 дугаар сард Бэлгийн чиг хандлага болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглосон хуулийг баталсан бөгөөд 2019 оны 4 дүгээр сараас хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлжээ. Тус хуулийн дагуу Нийслэлийн засаг захиргаанд ЛГБТ хүмүүсийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийн үнэт зүйлс хотын өнцөг булан бүрт хэрэгжих арга хэмжээг авах үүрэг хүлээлгэсэн байна.

Мөн ажил эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль нь ажлын байран дахь хүйсээр ялгаварлан гадуурхах, дарамтлах асуудлыг шийдвэрлэхийг зорьж хэд хэдэн удаа шинэчлэгдсэн боловч Засгийн газар хүйсийн эсрэг ялгаварлан гадуурхах асуудлаар хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаас татгалзсаар ирсэн байна.

2017 онд Японы Боловсролын яам бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар дээрэлхэх, ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. Сургуулийн багш, сурагч нарт бэлгийн болон хүйсийн чиг баримжааны талаар зөв ойлголт өгөх, ингэснээр сурагчдыг бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар нь дээрэлхэх, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлжээ¹⁴⁶.

Япон улсад 22 ба түүнээс дээш настай, гэрлээгүй, хүүхэдгүй хүн хүйсээ солиулах мэс ажиллаварт орж болох ба бичиг баримтдаа хүйсийн тэмдэглэгээг өөрчлөх эрх хуулиар олгогдсон байна.

Тус хуулийн дагуу Хөдөлмөр нийгэм хамгааллын яам болон Эрүүл мэндийн яамнаас трансжендэр хүмүүс эрүүл мэнд болон нийгмийн даатгалын дэвтэртээ өөрийн хоёрдогч хүйсийн нэрээ ашиглаж болохыг хуульчилсан. 2018 оны 10 дугаар сард батлагдсан Бэлгийн

¹⁴⁴ Justin McCurry (30 October 2020). "Japan's 'love hotels' accused of anti-gay discrimination". The Guardian.

¹⁴⁵ "Japan court finds same-sex marriage ban unconstitutional". BBC News. 17 March 2021. Retrieved 18 March 2021.

¹⁴⁶ Tokyo: New Law Bars LGBT Discrimination. Human Rights Watch, 5 October 2018

чиг хандлага болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхахыг хориглосон хуулийн дагуу трансжендэр хүмүүс ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхтэй байдаг байна.¹²¹⁴⁷.

Дүгнэлт

Монгол Улсад ЛГБТ хүмүүсийн асуудлыг 1990 оноос хойш ярьж эхэлсэн ба Монгол Улсын соёл, түүхэнд уламжлалт бус бэлгийн харилцааны мэдээлэл төдийлөн байдаггүй. Энэ нь ЛГБТ хүмүүсийг хүлээн авч, ойлгоход хүндрэл бэрхшээлтэй байгааг илэрхийлж байна. Мөн олон нийт Үндсэн хууль болон Эрүүгийн хуулиар “...бэлгийн болон хүйсийн чиг баримжаагаар ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг төдийлөн мэддэггүйн улмаас ЛГБТ хүмүүсийг нийгмийн харилцаанд ялгаварлан гадуурхах, тэдний эрхийг зөрчих, халдах үндэслэл болж байна. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын 12 дахь илтгэлд дурдсанаар ЛГБТ хүний хувьд ажил хөдөлмөр эрхлэх эрх нь хангагдахгүй байгаа нь ажлын байранд ялгаварлан гадуурхалтад өртөж байгаа холбоотой гэж үзжээ.

Дэлхийн ихэнх улс орон ижил хүйстний гэрлэлтийг хүлээн зөвшөөрөх эсвэл ижил хүйстэн хосууд гэрээ байгуулах замаар тэдний харилцааг зохицуулдаг байна. Өөрөөр хэлбэл, улс орон бүр бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүмүүст зориулсан хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосоор байна. Харин Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.1-т: “гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ” гэж заасан нь ЛГБТ хүмүүсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэж болохоор байна.

Монгол Улс нь эмнэл зүйн магадалгаанд үндэслэн хүйсийн тэмдэглэгээг бүх баримт, бичигт өөрчлөлт оруулахыг хуулиараа зөвшөөрдөг юм. Монгол Улс нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийг хуульчлан, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа өөр хүмүүсийн эрхийг хамгаалах механизмыг бий болгосон боловч, зарим талаараа учир дутагдалтай байгаа нь гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна. Иймд тухайн хүмүүсийг нийгмийн харилцаанд тэгш оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он

Иргэний хууль, 2002 он

Гэр бүлийн тухай хууль, 1999 он

Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, 2015 он

ХБНГУ-ын иргэний хууль Bürgerliches Gesetzbuch

“ЛГБТ төв” ТББ (2012 он), Бэлгийн цөөнхийн эрхийн хэрэгжилт судалгаа, Улаанбаатар, Монгол

Нийгмийн тухай мэдлэг сургалтын модуль, (2002 он), Улаанбаатар, Монгол

¹⁴⁷ "Japan's social security net for transgender people improving but obstacles loom for seniors". 14 June 2018. Retrieved 25 June 2019

- Ижил хүйсийн бэлгийн чиг баримжаа ба сэтгэл санааны эрүүл мэндийн тухай баримтууд:
<https://lgbtqa.ucdavis.edu/>
- НҮБХХ, Азид ЛГБТ байх нь: Монгол улсын тайлан, (2014 он), Улаанбаатар, Монгол
- Чимид, Б (2008 он), Үндсэн хуулийн мэдлэг, Улаанбаатар, Монгол
- Жогжакартын зарчимууд, (2012 он), Улаанбаатар, Монгол
- Хүний эрхийн комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл,
Улаанбаатар, Монгол
- Хүний эрхийн комисс, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл,
Улаанбаатар, Монгол
- ЛГБТ Төвийн баримтжуулалт, (2011 он), Улаанбаатар, Монгол
- Alonso-Zaldvar, Rcardo (May 10, 2021). "Reversng Trump, U.S. Restores Transgender Health Protectons"
Online, FOCUS. "Wr haben ene sehr free Beziehung". FOCUS Online (n German). Retreved 30 January 2019.
- Rebecca Bard-Remba (23 March 2013). "World's Most Gay Frenly Countres". Busness nsder. "Germany
ant-gay law: Plan to rehabltate convcted men". BBC News. 13 May 2016. Retreved 8 October 2017.
- "Same-Sex Marrage Ctzens n 16 Countres Assess Ther Vews on Same-Sex Marrage for a Total Global
Perspective".
- "Germany ant-gay law: Plan to rehabltate convcted men". BBC News. 13 May 2016. Retreved 8 October
2017.
- Justn McCurry (30 October 2020). "Japan's 'love hotels' accused of ant-gay dscrmnaton". The Guardan.
- "Japan court fnds same-sex marrage ban unconsttutonal". BBC News. 17 March 2021. Retreved 18 March
2021. Tokyo: New Law Bars LGBT Dscrmnaton. Human Rghts Watch, 5 October 2018
- "Japan's socal securty net for transgender people mprovng but obstacles loom for senors". 14 June 2018.
Retreved 25 June 2019



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

**ОЮУТНЫ ДҮН БОЛОН БАГШ СОНГОЛТЫГ НЭЙВИ БАЙЕСИЙН
АНГИЛАГЧ АШИГЛАН ТААМАГЛАХ НЬ**
/СЭВИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутнуудын үнэлгээний
жишээн дээр/

П.Гантөмөр¹, Г.Авирмэд², Н.Аргилсан³

¹ Доктор (Ph.D), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, gantumur.p@ufe.edu.mn

² Магистр (MSA), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, avirmed.g@ufe.edu.mn

³ Магистр (MS), Санхүү Эдийн Засгийн Их Сургууль, argilsan.n@ufe.edu.mn



Хураангуй

Өгөгдөл олборлох Нэйви Байесийн ангилагчийн алгоритм ашиглан оюутны сурлагын амжилт болон хичээлийн багш сонголтын магадлалын таамаглалын хүрээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргалаа.

Түлхүүр үг:

Приор болон постериор
магадлал, Нэйви Байесийн
ангилагч, сурлагын
амжилт, хичээлийн багш
сонголт

Удиртгал

Өгөгдөл олборлолт бол машин сургалт, статистик, мэдээллийн баазын системийн огтлолцолд хамаарах аргуудыг багтаасан их өгөгдлийн олонлогийн ерөнхий хэв маягыг илрүүлэх, задлан шинжлэх үйл явц юм. Өөрөөр хэлбэл, **өгөгдөл олборлолт** нь өгөгдлийн шинжилгээгээр дамжуулан бизнесийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор өгөгдлийн бүтэц, хамаарлыг тодорхойлохын тулд их өгөгдлийн олонлогийг ангилах үйл ажиллагаа юм. Өгөгдөл олборлолтын арга хэрэгслүүд нь бизнес эрхлэгчдийн ирээдүйн чиг хандлагыг урьдчилан таамаглах, илүү их мэдээлэлд тулгуурлан бизнесийн шийдвэр гаргах боломжийг олгодог тул өнөө үед эрдэмтэд, судлаачид түгээмэл ашигладаг болсон билээ. Хүснэгт 1-д өгөгдөл олборлолтын аргуудын талаар тодорхой харуулав.

Хүснэгт 1. Өгөгдлийн хэлбэрээс хамааруулан ашиглах алгоритмууд

Өгөгдлийн хэлбэр	Шийдвэрлэх асуудлууд	Ашиглах алгоритмууд
Дискрет өгөгдөл ашиглан шинж чанарыг урьдчилан таамаглах	<ul style="list-style-type: none"> - Боломжит худалдан авагчдын жагсаалтад байгаа үйлчлүүлэгчдийн сайн эсвэл муу төлөв байдлыг тодорхойлох - Дараагийн 6 сарын дотор сервэр ажиллахгүй байх магадлалыг тооцоолох - Өвчтөний эдгэрэлтийн үр дүнг ангилж, холбогдох хүчин зүйлсийг судлах 	Шийдвэрийн модны алгоритм Нейви Байесийн алгоритм Кластер алгоритм Мэдрэлийн сүлжээний алгоритм
Тасралтгүй өгөгдөл ашиглан шинж чанарыг урьдчилан таамаглах	<ul style="list-style-type: none"> - Ирэх жилийн борлуулалтыг таамаглах - Өнгөрсөн түүхэн болон улирлын чиг хандлагыг харгалзан сайтын зочдыг урьдчилан таамаглах - Хүн ам зүйн хүрээнд эрсдэлийн оноо (risk score)-г гаргах 	Шийдвэрийн модны алгоритм Хугацааны цувааны алгоритм Шугаман регрессийн алгоритм
Дарааллыг урьдчилан таамаглах	<ul style="list-style-type: none"> - Компанийн вебсайт дахь тандалтын шинжилгээ хийх - Серверийг доголдолд хүргэж буй хүчин зүйлсийг шинжлэх - Амбулаторийн үзлэгийн үеэр дарааллын хүрээнд түүвэр бүрдүүлэх замаар дүн шинжилгээ хийн үйл ажиллагааны талаарх нийтлэг шилдэг туршлагыг боловсруулах 	Дарааллын кластерийн алгоритм
Үйл ажиллагаан дахь нийтлэг зүйлсийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Бүтээгдэхүүний байршлыг тодорхойлохын тулд зах зээлийн сагсны шинжилгээг ашиглах - Худалдан авагчид нэмэлт бүтээгдэхүүн санал болгох - Арга хэмжээнд оролцогчдын мэдээллийн судалгаанд дүн шинжилгээ хийж, ямар үйл ажиллагаа хамааралтай болохыг илрүүлэх замаар цаашдын үйл ажиллагааг төлөвлөх 	Хамаарал (association) алгоритм Шийдвэрийн модны алгоритм
Ижил төстэй зүйлсийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Хүн ам зүй, зан байдал зэрэг шинж чанарууд дээр үндэслэн өвчтөний эрсдэлийн товч намтрын бүлгийг үүсгэх - Хэрэглэгчдийн сонголт болон худалдан авалтад дүн шинжилгээ хийх - Ашиглалтын ижил төстэй шинж чанартай серверүүдийг тодорхойлох 	Кластерын алгоритм Дарааллын кластерын алгоритм

Эх сурвалж: <https://learn.microsoft.com/en-us/analysis-services/data-mining/data-mining-algorithms-analysis-services-data-mining?view=asallproducts-allversions>

Нэйви Байесийн ангилагчийн хувьд ангиллууд нь харилцан онцгой шинж чанартай, өгөгдсөн ангиллын хүрээнд шинж чанарууд нь **үл хамаарах** гэсэн урьдач нөхцөлүүд тавигддаг. Эдгээр таамаглалууд туршилтаар батлагдсан, маш сайн масштабтай учраас “Нэйви” ангилагч гэж нэрлэгддэг. Олон тооны хэрэглээнүүдэд шинж чанаруудын олонлог

болон ангиллын хувьсагчуудын хоорондын хамаарал нь детерминистик шинж чанартай байдаг. Өөрөөр хэлбэл, тест нь тодорхой категориудад ангилж чадахгүй. Ийм тохиолдолд ангиллыг магадлалаар нь авч үзэхэд ач холбогдолтой байдаг.

Нэйви Байесийн ангилагч нь шинж чанаруудын олонлог болон ангиллын хувьсагчуудын магадлалт хамаарлыг загварчилдаг арга юм. Илүү нарийвчилбал, Нэйви Байесийн ангилагч нь Байесийн магадлалын теоремыг ангилалдаа ашигладаг.

Үндсэн хэсэг

Судлагдсан байдал:

Нэйви Байесийн ангилагчийн аргачлалын аргыг ашиглан олон улсад болон монголд дараах судалгааны ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1. Hong Chen, Songhua Hu, Rui Hua, Huiju Zhao нарын “Нэйви Байесийн ангилагчийн алгоритм ашиглан замын хөдөлгөөний менежментийг сайжруулах нь”, EURASIP Journal on Advances in Signal Processing, 2021 он.

2. Aida Krichene, Department of Accounting, IHEC Carthage, “Зээлийн эрсдэлийг үнэлэхэд Нэйви Байесийн ангилагчийн аргачлалыг ашиглах нь: Тунис улсын арилжааны банкны жишээн дээр”, 2017 он.

3. Christos Troussas (University of West Attica), Jaime D.L Caro (University of the Philippines), Maria Virvou (University of Piraeus), “Фэйсбүүк хэрэглэгчдийн гадаад хэл сурах мэдрэмжийн шинжилгээг Нэйви Байесийн ангилагч ашиглан тодорхойлох нь”, 2013 он.

4. Allsela Meiriza, Endang Lestari, Pacu Putra, Ayu Monaputri, and Dini Ayu Lestari Sriwijaya International Conference on Information Technology and Its Applications (SICONIAN 2019), “Нэйви Байесийн ангилагчийг ашиглан оюутны төгсөлтийг урьдчилан таамаглах”, 2019 он.

5. D R Prehanto^{1,*}, A D Indriyanti¹, K D Nuryana¹, S Soeryanto¹ and A S Mubarak²

1- Faculty of Engineering, Universitas Negeri Surabaya, Surabaya, Indonesia

2-Faculty of Engineering, Universitas Hasyim Asy'ari Jombang, Jombang, Indonesia,

“Нэйви Байесийн ангилагчийн алгоритм ашиглан интернет токен худалдан авах сонирхолтой хэрэглэгчдийг илрүүлэх”, 2019 он

6. Shafayat Bin Shabbir Mugdha, Lubaba Salsabil, Marian Binte Mohammed, Afra Anika, “Бенгаль хэл дээрх хуурамч мэдээллийг илрүүлэхэд Гауссын Нэйви Байесийг ашиглах нь”, 2021 он.

7. Д.Эрдэнэтөгөлдөр “Төгсөгдчийн хөдөлмөр эрхлэлтийг өгөгдөл олборлолт дахь ангиллын алгоритмд үндэслэн таамаглах нь”, 2022 он

Судалгааны арга зүй

Байесын ангилагчийн талаар ярихаас өмнө магадлалын тодорхойлолт болон Байесийн теоремыг зайлшгүй авч үзэх шаардлагатай.

Магадлалын тодорхойлолт:

Хэрэв санамсаргүй туршилттай холбоотой n үзэгдэл байдаг бол эдгээр n үзэгдлээс m нь A үйл явдалтай хамааралтай бол A үйл явдал тохиолдох магадлалыг дараах байдлаар тодорхойлдог.

$$P(A) = \frac{m}{n}$$

Хамтын магадлал:

A ба B нь дурын хоёр үзэгдэл бөгөөд $P(A), P(B)$ нь A ба B үзэгдлүүд явагдах магадлалыг тодорхойлдог гэе. Хоёр үзэгдлийн хамтын магадлал дараах хэлбэрт бичигдэнэ.

$$P(A \cup B) = P(A) + P(B) - P(A \cap B)$$

A, B үзэгдлүүд үл хамаарах бол

$$P(A \cap B) = P(A) \cdot P(B)$$

Нөхцөлт магадлал:

Үзэгдлүүд нь хамааралтай бол тэдгээрийн магадлал нь нөхцөлт магадлалаар илэрхийлэгддэг. B өгөгдсөн нөхцөлд A үзэгдлийн тохиох магадлалыг $P(A|B)$ гэж тэмдэглэдэг.

A ба B нь санамсаргүй туршилтын хувьд хамааралтай хоёр үзэгдэл бөгөөд $P(B) \neq 0$ байхад B үзэгдэл тохиолдсон нөхцөлд A -ийн магадлал нь дараах байдлаар өгөгддөг.

$$P(A|B) = \frac{P(A \cap B)}{P(B)}$$

Бүтэн магадлалын томъёо:

E_1, E_2, \dots, E_n нь үзэгдлүүдийн бүтэн бүлэг буюу туршилтын үр дүнд эдгээр n үзэгдлийн зөвхөн нэг нь явагддаг байг. Хэрэв A үзэгдэл нь E_1, E_2, \dots, E_n бүтэн бүлгийн аль ч үзэгдэлтэй нь хамтран явагдах боломжтой бол A үзэгдлийн явагдах магадлал

$$P(A) = P(E_1) \cdot P(A|E_1) + P(E_2) \cdot P(A|E_2) + \dots + P(E_n) \cdot P(A|E_n)$$

Байесийн томъёо:

Хэрэв A үзэгдэл явагдсан нөхцөлд E_i үзэгдэл явагдсан байх магадлал нь

$$P(E_i|A) = \frac{P(E_i) \cdot P(A|E_i)}{\sum_{i=1}^n P(E_i) \cdot P(A|E_i)}$$

Алгоритм: Нэйви Байесийн ангилагч

Орц: харилцан хамааралгүй, бүтэн бүлэг $C = \{c_1, c_2, \dots, c_k\}$ анги нь k элементээс бүрддэг гэе. Тэдгээрийн приор магадлалууд нь $P(C_1), P(C_2), \dots, P(C_k)$ болно. Шинж чанаруудын олонлог A бөгөөд $A = \{A_1, A_2, \dots, A_n\}$ байг. $A_1 = a_1, A_2 = a_2, \dots, A_n = a_n$ гэсэн утгаа авах үед $c_i \in C, i = 1, 2, \dots, k$ бүрийн хувьд нөхцөлт магадлал нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$p_i = P(C_i) \times \prod_{j=1}^n P(A_j = a_j | C_i)$$

$$p_x = \max\{p_1, p_2, \dots, p_k\}$$

Гарц: C_x нь ангилалын болно.

Судалгааны үр дүн

Энэ судалгааны ажлаар өгөгдөл олборлох Нэйви Байесийн ангилагчийн алгоритм дээр тулгуурлан СЭЗИС-ийн өдрийн хөтөлбөрийн оюутнуудын МАТ111, МАТ112, ЕСN221, ЕСN222 хичээлүүд дээрх сурлагын амжилт болон хичээлийн багш сонголтын талаарх таамаглалыг дараах шинж чанарын хувьсагчуудаас хамааруулан хийлээ. Үүнд: багшийн хүйс, оюутны хүйс, хаанаас элссэн, ЭЕШ-ын дундаж оноо болон хичээлийн ангилал.

Таамаглалыг хийхдээ СЭЗИС-ийн өгөгдлийн сангаас 2017-2022 оны 4762 оюутны мэдээллийг ашигласан болно.

Судалгааны ажлыг хоёр хэсэгт хуваан гүйцэтгэв. Үүнд:

СУДАЛГААНЫ ХЭСЭГ I-д 7 шинж чанарын хувьсагч болон 5 ангиллын хүрээнд шинжилгээг гүйцэтгэж үнэлэлт, дүгнэлт өгөв.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ II-т 3 шинж чанарын хувьсагч болон 6 ангиллын хүрээнд шинжилгээг гүйцэтгэх замаар дүгнэлт өгөв.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ I

Энэ хэсэгт ангиллын хувьсагч болгон оюутнуудын үсгэн үнэлгээг авсан ба шинж чанарын хувьсагчуудын зарим нөхцөлүүдэд харгалзах ангиллын хувьсагч тус бүрийн илрэх магадлалыг Нэйви Бэйесийн ангилагч ашиглан тооцооллоо.

Ангиллын хувьсагчийн олонлог нь оюутнуудын дүнгийн ангиллаар илэрхийлэгдсэн ба дараах хэлбэрт бичиж болно.

$$Y = \{y_1 = A, y_2 = B, y_3 = C, y_4 = D, y_5 = F\}$$

Шинж чанарын хувьсагчуудад дараах хувьсагчууд хамаарна. Шинж чанарын хувьсагчуудыг вектор хэлбэрт дараах байдлаар бичиж болно. Үүнд:

$$X = \{X_1, X_2, X_3, X_4, X_5, X_6, X_7\}$$

Энд:

X_1 – хичээл заасан багшийн хүйс

$$X_1 = \{x_{11} = \text{эр}, x_{12} = \text{эм}\}$$

X_2 – оюутны хүйс

$$X_2 = \{x_{21} = \text{эр}, x_{22} = \text{эм}\}$$

X_3 – оюутны элссэн газар

$$X_3 = \{x_{31} = \text{Улаанбаатар}, x_{32} = \text{Орон нутаг}, x_{33} = \text{Дархан, Орхон}\}$$

X_4 –Математик, англи хэлний хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо

$$X_4 = \{x_{41} = 620 - \text{оос бага}, x_{42} = [620,650[, x_{43} = [650,700[, x_{44} = [700,800] \}$$

X_5 – Математикийн хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо

$$X_5 = \{x_{51} = 620 - \text{оос бага}, x_{52} = [620,650[, x_{53} = [650,700[, x_{54} = [700,800] \}$$

X_6 –хичээл төрөл

$$X_6 = \{x_{61} = \text{Ерөнхий суурь}, x_{62} = \text{Мэргэжлийн суурь}\}$$


X_7 –хичээл заасан багшийн тоо

$$X_7 = \{x_{71} = \text{Багш 1}, x_{72} = \text{Багш 2}, x_{73} = \text{Багш 3}, x_{74} = \text{Багш 4}, x_{75} = \text{Багш 5}, x_{76} = \text{Багш 6}\}$$

Элсэлтийн ерөнхий шалгалтын оноонд харгалзах оюутнуудын үнэлгээний тархалтаас харахад 620-оос доош, 620-650, 650-700, 700-аас дээш оноотой оюутнуудын хувьд мэдэгдэхүйц ялгаа байсан тул ЭЭШ-ын оноог дээрх интервалуудад хуваах замаар дүгнэлт өгсөн болно. Ерөнхий суурь хичээлийн хувьд Хэрэглээний математик 1, 2, мэргэжлийн суурь хичээлийн хувьд Бизнесийн статистик болон Эконометрикийн үндэс хичээлүүдийг тус тус авсан болно.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын үнэлгээ тус бүрийн магадлалыг элссэн газраар нь ангилан тооцсон үр дүнг График 1-т харуулав.

График 1. Оюутнуудын үнэлгээ, элссэн газрын ангиллаар




Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотуудаас элссэн элсэгчдийн хувьд үнэлгээ тус бүрийн магадлал ойролцоо байгаа бол орон нутгаас элсэгчдийн хувьд А суралцах магадлал 7%-8%-иар их байна.

Энэ диаграммд харуулаагүй боловч оюутны хүйсээр ангилан авч үзсэн шинжилгээгээр А сурах магадлал эмэгтэй оюутнуудын хувьд Орон нутаг болон Дархан, Эрдэнэт хотоос элссэн элсэгчдийн хувьд ижил

байсан хэдий ч Улаанбаатар хотын элсэгчдийн А сурах магадлалаас 6%-иар их гарсан. Эрэгтэй оюутнуудын хувьд орон нутгаас элссэн элсэгчийн А сурах магадлал Улаанбаатар хотоос элссэн элсэгчдийн магадлалаас 8%-аар, Эрдэнэт, Дарханы элсэгчдийн үнэлгээнээс 14%-иар өндөр гэсэн үр дүнг гарсан.


График 2. Оюутнуудын үнэлгээ, хүйсийн ангиллаар



Эмэгтэй оюутнуудын А сурах магадлал эрэгтэй оюутнуудаас 14%-аар өндөр байгаа бол бусад үнэлгээний хувьд магадлал ойролцоо түвшинд байна. Хичээлийн төрлөөр нь авч үзвэл ерөнхий суурь хичээлийн хувьд эмэгтэй оюутнуудын А сурах магадлал эрэгтэй оюутнуудаас 13%-иар их гэж үнэлэгдсэн бол мэргэжлийн суурь хичээлүүдийн хувьд 16% болж өссөн.

Судалгаанд хамрагдсан оюутнуудын элсэлтийн ерөнхий шалгалтын онооны интервалаар үнэлгээ тус бүрийг харьцуулсаныг График 3-т харуулав.

График 3. Оюутны үнэлгээ, ЭЕШ-ын дундаж онооны ангиллаар




Математик, англи хэлний элсэлтийн шалгалтын дундаж оноо 620-оос доош элсэгчдийн хувьд 62% нь 80%-аас дээш үнэлгээтэй суралцаж байгаа бол 620-650 оноотой элсэгчдийн 71%, 650-700 оноотой элсэгчдийн 78%, 700-оос дээш оноотой элсэгчдийн 87% нь тус тус 80%-иас дээш үнэлгээтэй суралцдаг байна.

Шинж чанарын хувьсагчууд болох X_4, X_7 хувьсагчийн бүх утгуудын хүрээнд ангиллын хувьсагчийн утга бүрийн илрэх магадлалыг дараах томъёогоор тооцсон бөгөөд үр дүнг график 4-т харуулав.

$$P(Y = y_i | X_4 = x_{4j}, X_7 = x_{7j}) = \frac{P(Y = y_i) \cdot P(X_4 = x_{4j} | y_i) \cdot P(X_7 = x_{7j} | y_i)}{\sum_{i=1}^5 P(Y = y_i) \cdot P(X_4 = x_{4j} | y_i) \cdot P(X_7 = x_{7j} | y_i)}$$


График 4. Оюутны үнэлгээ, багш бүрийн ангилал, дундаж оноо 620-оос доош



ЭЕШ-ын дундаж оноог илэрхийлэх шинж чанарын хувьсагч $X_4 = x_{41}$ үед 620-оос доош оноотой элсэгч 80%-аас дээш үнэлгээтэй дүгнэгдэх магадлал 1-р багшийн хувьд 74%, 2-р багшийн хувьд 61%, 3-р багшийн хувьд 47%, 4-р багшийн хувьд 69%, 5-р багшийн хувьд 52%, 6-р багшийн хувьд 54% байна.

ЭЕШ-ын дундаж оноог илэрхийлэх шинж чанарын хувьсагч $X_4 = x_{42}$ үед 620-650 оноотой элсэгч 80%-аас дээш үнэлгээтэй дүгнэгдэх магадлалыг График 5-д харуулсан бөгөөд үр дүнгээс үзвэл 1-р багшийн хувьд 81%, 2-р багшийн хувьд 71%, 3-р багшийн хувьд 59%, 4-р багшийн хувьд 78%, 5-р багшийн хувьд 62%, 6-р багшийн хувьд 64% байна.


График 5. Оюутны үнэлгээ, багш бүрийн ангилал, дундаж оноо 620-650



ЭЕШ-ын дундаж оноог илэрхийлэх шинж чанарын хувьсагч $X_4 = x_{43}$ үед 650-700 оноотой элсэгч 80%-аас дээш үнэлгээтэй дүгнэгдэх магадлалыг График 6-д харуулсан ба дараах байдлаар магадлалууд нь үнэлэгдэв. Үүнд:

1-р багшийн хувьд 87%, 2-р багшийн хувьд 78%, 3-р багшийн хувьд 68%, 4-р багшийн хувьд 84%, 5-р багшийн хувьд 70%, 6-р багшийн хувьд 72% байна.


График 6. Оюутны үнэлгээ, багш бүрийн ангилал, дундаж оноо 650-700



ЭЕШ-ын дундаж оноог илэрхийлэх шинж чанарын хувьсагч $X_4 = x_{44}$ байх тохиолдолд 700-800 оноотой элсэгч 80%-аас дээш үнэлгээтэй дүгнэгдэх магадлалыг График 7-д харуулав. Тухайн багшийн хувьд 80-аас дээш үнэлгээтэй суралцах магадлалууд дараах байдлаар үнэлэгдэв. Үүнд:

1-р багшийн хувьд 92%, 2-р багшийн хувьд 86%, 3-р багшийн хувьд 82%, 4-р багшийн хувьд 90%, 5-р багшийн хувьд 81%, 6-р багшийн хувьд 82% байна.

График 7. Оюутны үнэлгээ, багш бүрийн ангилал, дундаж оноо 700-800



Нэмэлт шинж чанарын хувьсагчийг оруулсан үеийн ангиллын хувьсагчийн илрэх магадлалууд

Дараах хоёр тохиолдолд үнэлэгдсэн магадлалууд нь шинж чанарын хувьсагч болох багшийн хүйс ялгаатай, бусад шинж чанарын хувьсагчууд ижил утгаа авч байх тохиолдлуудад хамаарна.

Шинж чанарын хувьсагч $X_1 = x_{11}, X_2 = x_{21}, X_3 = x_{31}, X_4 = x_{41}, X_6 = x_{61}$ утгаа тус тус авч байх үеийн ангиллын хувьсагчийн утга бүрийн илрэх магадлалууд дараах байдлаар тодорхойлогдож байна.

$$P(Y = y_1|X) = 12\%, P(Y = y_2|X) = 21\%, P(Y = y_3|X) = 31\%, P(Y = y_4|X) = 24\%$$

Шинж чанарын хувьсагч $X_1 = x_{12}, X_2 = x_{21}, X_3 = x_{31}, X_4 = x_{41}, X_6 = x_{61}$ утгаа тус тус авч байхад ангиллын хувьсагчийн утга бүрийн илрэх магадлалууд дараах байдлаар үнэлэгдэв.

$$P(Y = y_1|X) = 17\%, P(Y = y_2|X) = 35\%, P(Y = y_3|X) = 28\%, P(Y = y_4|X) = 14\%$$

СУДАЛГААНЫ ХЭСЭГ II

Энэ хэсэгт ангилалын хувьсагчаар багшийг авч шинж чанарын хувьсагчуудын зарим нөхцлүүдэд харгалзах ангиллын хувьсагч тус бүрийн илрэх магадлалыг Нэйви Байесийн ангилагч ашиглан тооцооллоо.

Ангиллын хувьсагчийн олонлог нь дараах вектороор илэрхийлэгдэнэ.

$$Y = \{y_1 = \text{Багш 1}, y_2 = \text{Багш 2}, y_3 = \text{Багш 3}, y_4 = \text{Багш 4}, y_5 = \text{Багш 5}, y_6 = \text{Багш 6}\}$$

Шинж чанарын хувьсагчийн вектор:

$$X = \{X_2, X_3, X_4\}$$

Энд:

X_2 –оюутны хүйс

$$X_2 = \{x_{21} = \text{эр}, x_{22} = \text{эм}\}$$

X_3 –оюутны элссэн газар

$$X_3 = \{x_{31} = \text{Улаанбаатар}, x_{32} = \text{Орон нутаг}, x_{33} = \text{Дархан, Орхон}\}$$

X_4 –Математик, англи хэлний хичээлүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо

$$X_4 = \{x_{41} = 620 - \text{оос бага}, x_{42} = [620, 650[, x_{43} = [650, 700[, x_{44} = [700, 800]\}$$

Оюутнууд хичээл сонголт хийхдээ тухайн багшийг сонгох магадлалыг дээрх шинж чанарын хувьсагчдын хүрээнд тооцоолж үр дүнг хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Улаанбаатар хотоос элссэн оюутнуудын багш сонголт, хүйс, ЭЕШ-ын дундаж онооны ангиллаар

	Хүйс							
	Эр				Эм			
	620-оос бага	620-650	650-700	700-800	620-оос бага	620-650	650-700	700-800
Багш-1	42%	40%	32%	34%	37%	35%	27%	29%
Багш-2	6%	7%	7%	6%	4%	5%	5%	4%
Багш-3	14%	16%	23%	25%	18%	20%	28%	31%
Багш-4	21%	16%	14%	12%	24%	18%	15%	13%
Багш-5	8%	9%	10%	10%	6%	7%	7%	7%
Багш-6	8%	12%	15%	13%	11%	15%	18%	16%

Элссэн оюутнууд нь хүснэгтэд харуулсан Улаанбаатар хотоос элссэн байх, хүйс нь эрэгтэй болон эмэгтэй байх, ЭЕШ-ын дундаж оноонуудын ангиллаар авч үзэхэд 1-р багшийг сонгох магадлал хамгийн өндөр үнэлэгдлээ.

Хүснэгт 3. Орон нутгаас элссэн оюутнуудын багш сонголт, хүйс, ЭЕШ-ын дундаж онооны ангиллаар

	Хүйс							
	Эр				Эм			
	620-оос бага	620-650	650-700	700-800	620-оос бага	620-650	650-700	700-800
Багш-1	36%	34%	26%	27%	31%	28%	21%	22%
Багш-2	5%	6%	5%	4%	3%	4%	4%	3%
Багш-3	18%	20%	27%	30%	22%	24%	32%	36%
Багш-4	21%	15%	13%	11%	23%	17%	13%	12%
Багш-5	8%	10%	9%	10%	6%	7%	6%	7%
Багш-6	12%	16%	19%	17%	15%	20%	23%	20%

Харин орон нутгаас элссэн оюутнуудын хувьд 1 болон 3-р багшийг сонгох магадлалууд бусад багш нартай харьцуулбал харьцангуй өндөр гарсан гэдгийг хүснэгт 3-аас нэг утгатай харах боломжтой.

Дархан, Эрдэнэт хотоос элсэгчдийн багш сонголтын магадлалыг тооцож Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Дархан, Эрдэнэт хотоос элссэн оюутнуудын багш сонголт, хүйс, ЭЕШ-ын дундаж онооны ангиллаар

	Хүйс							
	Эр				Эм			
	620-оос бага	620-650	650-700	700-800	620-оос бага	620-650	650-700	700-800
Багш-1	35%	32%	25%	26%	30%	27%	21%	22%
Багш-2	7%	7%	7%	6%	5%	5%	5%	4%
Багш-3	16%	18%	24%	27%	20%	22%	29%	32%
Багш-4	20%	15%	12%	11%	22%	16%	13%	12%
Багш-5	10%	12%	12%	12%	8%	9%	8%	9%
Багш-6	12%	16%	20%	17%	15%	21%	24%	21%

Хүснэгт 4-өөс үзэхэд 1-р багшийг сонгох магадлал эрэгтэй элсэгчдийн хувьд бусад багш нартай харьцуулбал харьцангуй өндөр байгаа бол 650-800 оноотой эмэгтэй элсэгчид 3, 6-р багшийг сонгох магадлал бусад багш нартай харьцуулбал харьцангуй өндөр байна.

Дүгнэлт:

Нэйви Байесийн ангиллын алгоритм ашиглан оюутнуудын үнэлгээг тодорхой шинж чанарын хувьсагчуудаар дамжуулан шинжлэх боломжтой гэдгийг судалгааны үр дүн харуулав. Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтүүдийг өгч байна.

- Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт хотуудаас элссэн элсэгчдийн хувьд үнэлгээ тус бүрийн магадлал ойролцоо байсан бол орон нутгаас элсэгчдийн хувьд А суралцах магадлал хотуудаас элсэгчдийн магадлалаас өндөр үнэлэгдэв.
- Орон нутгаас элссэн эрэгтэй оюутнуудын хувьд А сурах магадлал Улаанбаатар хотоос элссэн элсэгчдийн А сурах магадлалаас 8%-иар, Эрдэнэт, Дарханы элсэгчдийн А сурах магадлалаас 14%-иар тус тус өндөр үнэлэгдэв.
- Улаанбаатар хотоос элсэгчдийг үл харгалзвал эмэгтэй оюутнуудын А сурах магадлал аль ч газраас элсэгч эмэгтэй оюутнуудын хувьд ижил бөгөөд Улаанбаатар хотын элсэгчидтэй харьцуулахад А сурах магадлал 6 хувиар өндөр байв.
- ЭЕШ-ын дундаж онооны ангиллаар авч үзвэл багш бүрийн хувьд А, В сурах магадлал 5-10%-ийн өсөлттэйгөөр үнэлэгдэж байв.
- ЭЕШ-ын дундаж онооны ангилал бүрт 1-р багшийн хувьд оюутан А, В сурах магадлал өндөр, мөн багш сонголтын хүрээнд бусад багш нартай харьцуулбал уг багшийг сонгох магадлал харьцангуй өндөр үнэлэгдэв.

Дараах агуулгын хүрээнд уг судалгааны ажлыг өргөтгөх боломжтой. Үүнд:

Шинж чанарын хувьсагчуудын сонголтууд:

Курс, хэдэн хичээл сонгодог, долоо хоногт ямар ямар гарагуудад хичээлээ судалдаг, хэддүгээр цаг дээр сонголтоо хийдэг,

Хичээл: Ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх

Мэргэжил:

Хичээл заагч багшийн тоо

Хичээлийн үргэлжлэх хугацаа: 90 ба 150 минут

Хичээлийн хэлбэр: Танхим, цахим, танхим болон цахим хосолсон

Үр дүнгийн хувьсагчийн сонголтууд

Сурч буй мэргэжлээр төгсөх магадлал

Шийдвэр гаргалтад ашиглах боломжууд

- Ямар гарагийн хэддүгээр цаг дээр ямар хичээл оруулах
- Багшийн группын саналын тоо
- Нэг багшийн өдөрт хичээл заах зохимжит хичээлийн тоо
- Оюутны нэг өдөрт хичээл үзэх зохимжтой хичээлийн тоо
- Нэг багш тухайн улиралд хэдэн хичээл орох нь зохимжтой болох
- Элсэлтийн бодлого: орон нутаг, хот, суурин газраас элсэгчдийн зохимжит харьцаа
- Дүрэм, журмын өөрчлөлтийг судалгааны үр дүнд суурилан хийх

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Data Mining: Concepts and Techniques, (3rd Edn.), Jiawei Han, Micheline Kamber, Morgan Kaufmann, 2015.

Introduction to Data Mining, Pang-Ning Tan, Michael Steinbach, and Vipin Kumar, Addison-Wesley, 2014

Le mingming, research and application of data mining classification algorithm [D]. Chengdu university of electronic science and technology, 2017: 12-16.

Dong liyan, sui peng, sun peng, li yongli, a new naive bayesian algorithm based on semi-supervised learning [J]. Journal of Jilin University (engineering science edition), 2016, 46(3): 884-889.

Zhang bin, zhuang chijie, hu jun, et al. Power load curve integrated clustering algorithm combined with dimension reduction technology [J]. Chinese journal of electrical engineering. 2015. 35(15): 3741-3749.

Zhu cuiling, research on text classification methods based on unsupervised clustering and naive bayes classification [D]. Jinan: Shandong University, 2005: 33-39.

Интернетийн эх сурвалжууд:

<https://asp-urasipjournals.springeropen.com/>

<https://www.researchgate.net/publication/351348550>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДАЙ ХАМТАРСАН ЛИЦЕЙ АНГИУДЫН ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТУУДЫН ҮР ДҮН, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Ш.Ганболд¹, Г.Авирмэд²

¹ Багш, дэд профессор, МСМТ, ganbold.sh@ufe.edu.mn

² Багш, СШУТ, avirmed.g@ufe.edu.mn



Хураангуй

Энэхүү өгүүлэлд Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Ерөнхий Боловсролын сургуулиудтай хамтарсан гүнзгийрүүлсэн сургалттай ангиудын сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын сүүлийн 5 жилийн үр дүнг Улаанбаатар, Дархан-Уул болон Төв аймгуудын төгсөгчдийн үр дүнтэй харьцуулсан болно.

Түлхүүр үг:

элсэлтийн ерөнхий
шалгалтын гүйцэтгэл,
хэмжээст оноо.


Удиртгал

СЭЗИС-ийн Ерөнхий Боловсролын сургуулиудтай хамтарсан гүнзгийрүүлсэн сургалттай ангиудыг 2011-2012 оны хичээлийн жилээс эхлэн нийслэлийн зургаан дүүрэгт тус бүр нэг ангийг байгуулж, анхны элсэлтээ авч 157 сурагчийг элсүүлсэн байна.

Тухайн хамтарсан лицей ангийн хувьд гэрээний дагуу математик болон англи хэлний хичээллийг гүнзгийрүүлэн судлах, СЭЗИС дээр мэргэжлийн тэнхимүүдийн багш нараар “Бизнес, эдийн засгийн үндэс”, “Төлөвшил ёс зүйн” хичээллүүдийг оруулах, ерөнхий эрдмийн бусад хичээлүүдийг ЕБ сургуулийн хөтөлбөрөөр тухайн сургуулийн тэргүүний багш нараар заалгахаар шийдвэрлэсэн байдаг. Одоогоор уг ангийг Төв аймаг, Дархан хотуудад хичээллүүлж байна.

2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн хамтарсан ангиудын сурагчид ЭЕШ-ын оноогоор СЭЗИС-д элсэн суралцаж эхэлсэн байдаг. Төгсөгчдөөс СЭЗИС-д элссэн байдлыг жил жилээр нь харьцуулсаныг График 1-т харуулав.

График 1. Лицей ангийн төгсөгчид болон лицей ангиас СЭЗИС-д элссэн сурагчдын тоо



Эхний 3 жилийн хугацаанд нийт төгсөгчдийн 30% орчим нь СЭЗИС-д элсэн суралцсан бол 2019, 2020 онд 50%, 2021 онд 25%, 2022 онд 59% тус тус элсэн суралцжээ.

Үндсэн хэсэг

2018-2022 оны хооронд Улаанбаатар, Дархан хотууд болон Төв аймгаас математик, англи хэлний хичээлээр хоёулангаар нь элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн 48684 оюутны гүйцэтгэлийн хувь болон хэмжээст оноон дээр харьцуулсан шинжилгээг хийв. Ингэхдээ математик болон англи хэлний хичээл тус бүрийн хувьд зарим тодорхойлогч статистикуудыг тооцож, авч үзэж буй ангиллуудын ЭЕШ-ын онооны дунджууд ялгатай эсэх, мөн тархалтуудыг авч үзсэн болно.

1. Математикийн хичээл

Математикийн хичээлийн сүүлийн 5 жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дунжийг Хүснэгт 1-т харуулав. Математикийн хичээлийн хэмжээст онооны дундаж Улаанбаатар хотын хувьд 2020 оноос бусад жилүүдэд 505 онооны орчимд, Дархан хотын хувьд 2019 оноос бусад жилүүдэд 510-520 оны орчимд, Төв аймгийн хувьд сүүлийн 2 жилд өмнөх жилүүдээс бага зэрэг өсөлттэй гарсан бол Лицей сургуулийн хувьд аль ч жилүүдэд 540 онооноос дээш үнэлэгджээ. Улаанбаатарын хотын шалгуулагчдын хэмжээст онооны дундаж 2020 онд огцом өссөн байна.

Хүснэгт 1. Математикийн хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны дундаж

Аймаг, хот	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	506	509	564	505	503
Төв	494	480	-	508	517
Дархан	513	494	518	507	524
Лицей	607	544	601	580	549

Хүснэгт 2-оос харахад Лицей сургуулийн шалгуулагчдын 50% нь 2018 онд 624 онооноос дээш үнэлэгдсэн бол сүүлийн жил 546 онооноос дээш үнэлэгджээ. 2020 оноос бусад жилүүдэд Улаанбаатарын хотын шалгуулагчдын 50% нь 508 онооноос дээш үнэлэгдсэн бол Төв аймгийн хувьд сүүлийн 2 жилийн медиан оноо тогтмол 516, Дархан хотын хувьд 2022 онд шалгуулагчдын 50% нь 524 онооноос дээш оноо авсан байна.

Хүснэгт 2. Математикийн хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны медиан

Аймаг, хот	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	507	508	571	507	508
Төв	498	487		516	516
Дархан	515	487	520	507	524
Лицей	624	561	597	583	546


Дээд квартил оноог Хүснэгт 3-аар харуулав. Уг хүснэгтээс харахад Улаанбаатар хотын шалгуулагчдын 25% нь ойролцоогоор 570 онооноос дээш дүгнэгддэг бол Дархан хотын шалгуулагчдын хувьд 2022 онд 25% нь 597 онооноос дээш дүгнэгджээ. Төв аймгийн шалгуулагчдын сүүлийн 2 жилийн дээд квартил оноо хотын элсэгчдийн үнэлгээтэй ойролцоо түвшинд үнэлэгдсэн байна. Харин Лицей ангийн 2018 оны шалгуулагчдын 25% нь 669 онооноос дээш дүгнэгдэж байсан бол 2022 онд 618 онооноос дээш дүгнэгджээ.

Хүснэгт 3. Математикийн хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны дээд квартил

Аймаг, хот	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	576	579	628	574	572
Төв	556	541		573	578
Дархан	576	561	581	574	597
Лицей	669	607	651	628	618

Математикийн хичээлийн оноог тухайн шалгуулагчийн авсан оноогоор буюу гүйцэтгэлээр нь авч үзсэнийг дараах хүснэгт, графикуудаар харууллаа. Гүйцэтгэлийн дунжийг авч үзвэл Улаанбаатар болон Дархан хотуудын шалгуулагчдын хувьд ихэнх жилийн гүйцэтгэлийн дундаж 20%-30% байгаа бол Лицей сургуулийн шалгуулагчдын гүйцэтгэлийн дундаж 30%-аас дээш түвшинд үнэлэгджээ. Авч үзэж буй ангиллуудын хувьд жил бүрийн гүйцэтгэлийн дундаж статистик ач холбогдол бүхий ялгаатай эсэхийг t тест ашиглан шалгахад Улаанбаатар болон Дархан хотуудын хувьд 2018, 2021 оны гүйцэтгэлийн дунджуудаас бусад хугацааны гүйцэтгэлийн дунджууд статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. Харин Улаанбаатар болон Төв аймгуудын хувьд сүүлийн 2 жилийн дунджуудаас бусад жилүүдийн гүйцэтгэлийн дунджууд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Дархан болон Төв аймгийн хувьд 2018 оноос бусад жилүүдийн дунджууд ялгаагүй гарсан. Лицей ангийн хувьд 2019 онд Улаанбаатар хотын шалгуулагчдын гүйцэтгэлийн дундажтай, 2022 онд бүх ангиллын гүйцэтгэлийн дундажтай тус тус ялгаагүй байсан бол бусад жилүүдийн хувьд ангилал бүрийн гүйцэтгэлийн дундаж статистик ач холбогдол бүхий ялгаатай дээгүүр түвшинд үнэлэгдсэн байна.

График 2. Математикийн хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн дундаж / хувиар/



Хүснэгт 4-өөс харахад аймаг хотуудын хувьд гүйцэтгэлийн медиан оноо 20%-30% байгаа бол Лицей ангийн хувьд 30%-40% байна. 2018 онд Лицей ангийн шалгуулагчдын гүйцэтгэлийн медиан оноо 49% байсан бол 2022 онд 29% болж буурсан.

Хүснэгт 4. Математикийн хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн медиан

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	26	25	34	23	24
Төв	25	23		24	25
Дархан	27	23	26	23	26
Лицей	49	32	40	35	29

Дээд квартил оноо аймаг хотуудын хувьд 30%-40% байгаа бол лицей ангийн хувьд шалгуулагчдын 25% нь 40%-аас дээш дүгнэгддэг. Лицей ангийн шалгуулагчдын хувьд 2018 онд шалгуулагчдын 25% нь 63%-аас дээш үнэлэгдэж байсан бол 2022 оны шалгуулагчдын 25% нь 43%-аас дээш гүйцэтгэлтэй болж буурсан байна.

Хүснэгт 5. Математикийн хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн дээд квартил

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	37	35	48	33	33
Төв	33	29		33	34
Дархан	37	32	36	33	38
Лицей	63	41	55	48	43

Математикийн хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын гүйцэтгэлийн тархалтыг доорх графикуудад харууллаа. Математикийн хичээл дээр нийт шалгуулагчдын дийлэнх хэсгийн гүйцэтгэл 10%-30%-ийн орчимд тархсан байгаа бол Лицей ангийн шалгуулагчдын хувьд баруун далийлт бага зэрэг багассан байна.

График 3. Математикийн хичээлийн гүйцэтгэлийн тархалт





График 4. Лицей ангийн Математикийн хичээлийн гүйцэтгэлийн тархалт



2. Англи хэлний хичээл

Англи хэлний хичээлийн хэмжээст онооны дундаж Улаанбаатар хотын шалгуулагчдын хувьд 2020 оноос бусад жилүүдэд 520 онооны орчимд байгаа бол 2020 онд 616 болж огцом өссөн байна. Төв аймгийн хувьд хотуудтай харьцуулахад хэмжээст онооны дундаж доогуур түвшинд буюу 480 онооны орчимд байна. Дархан хотын шалгуулагчдын хэмжээст онооны дундаж 2019, 2020 онуудаас бусад жилүүдэд Улаанбаатар хотын шалгуулагчдын дундажтай

ойролцоо түвшинд байгаа бол Лицей ангийн шалгуулагчдын хэмжээст онооны дундаж 550 онооноос дээш түвшинд үнэлэгджээ.

Хүснэгт 6. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны дундаж

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	520	525	616	515	516
Төв	477	479		481	483
Дархан	514	491	510	508	520
Лицей	591	552	610	574	577

Хүснэгт 7-оос харахад Лицей сургуулийн шалгуулагчдын 50% нь 2018 онд 600 онооноос дээш үнэлэгдсэн бол сүүлийн жил 563 онооноос дээш үнэлэгджээ. 2020 оноос бусад жилүүдэд Улаанбаатарын хотын шалгуулагчдын 50% нь 520 орчим онооноос дээш үнэлэгдсэн бол Төв аймгийн хувьд медиан оноо 490 онооноос доош түвшин байна. 2022 онд Дархан хотын шалгуулагчдын 50% нь 524 онооноос дээш оноо авсан байна. Улаанбаатарын хотын шалгуулагчдын хэмжээст онооны медиан 2020 онд 604 болж огцом өссөн байна.

Хүснэгт 7. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны медиан

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	515	526	604	516	520
Төв	480	490		484	487
Дархан	515	487	512	507	524
лицей	600	579	593	584	563

Англи хэлний хичээлийн хэмжээст онооны дээд квартил оноог Хүснэгт 8-аар харуулав. Уг хүснэгтээс харахад Улаанбаатар хотын шалгуулагчдын 25% нь ойролцоогоор 590 онооноос дээш дүгнэгддэг бол Дархан хотын шалгуулагчдын хувьд 580-590 онооны орчимд жил ирэх тусам өмнөх жилээсээ бага зэрэг өсөлттэй байна. Төв аймгийн шалгуулагчдын квартил оноог хотын түвшинтэй харьцуулахад доогуур түвшинд бөгөөд ерөнхийдөө 25% нь жил бүр ойролцоогоор 540 онооноос дээш оноо авдаг байдал ажигдагдлаа. Харин Лицей ангийн жил бүрийн шалгуулагчдын 25% нь 610 болон түүнээс дээш түвшинд дүгнэгджээ.


Хүснэгт 8. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын хэмжээст онооны дээд квартил

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	595	596	650	587	586
Төв	528	537		537	538
Дархан	581	558	577	578	588
лицей	654	610	658	616	646

Шалгуулагчдын англи хэлний хичээлийн гүйцэтгэлийн үр дүнг дараах хүснэгт, графикуудаар харууллаа. Гүйцэтгэлийн дунджийг авч үзвэл Улаанбаатар хотын шалгуулагчдын хувьд ихэнх жилийн гүйцэтгэлийн дундаж 40%-50% байгаа бол Дархан болон Төв аймгийн хувьд ойролцоо түвшинд буюу 30%-40%-ийн хооронд байна. Лицей сургуулийн шалгуулагчдын гүйцэтгэлийн дундаж 50%-аас дээш түвшинд үнэлэгджээ. Авч үзэж буй ангиллуудын хувьд жил бүрийн гүйцэтгэлийн дундаж статистик ач холбогдол бүхийг ялгаатай эсэхийг t тест ашиглан шалгахад Улаанбаатар болон Дархан хотуудын хувьд авч үзэж буй бүх хугацааны гүйцэтгэлийн дунджууд статистик ач холбогдол бүхий

ялгаатай байв. Мөн Улаанбаатар болон Төв аймгуудын хувьд бүх жилүүдийн гүйцэтгэлийн дунджууд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Дархан болон Төв аймгийн хувьд 2019 оноос бусад жилүүдийн дунджууд ялгаатай гарсан байна. Лицей ангийн хувьд 2019 болон 2020 онд Улаанбаатар хотын шалгуулагчдын гүйцэтгэлийн дунджаас ялгаагүй байсан бол бусад жилүүдийн хувьд ангилал бүрийн гүйцэтгэлийн дунджаас статистик ач холбогдол бүхий ялгаатай дээгүүр түвшинд үнэлэгдсэн байна.

График 5. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн дундаж



Хүснэгт 9-өөс харахад аймаг хотуудын хувьд гүйцэтгэлийн медиан оноо 25%-40% байна. 2018-2021 онуудад Лицей ангийн шалгуулагчдын гүйцэтгэлийн медиан оноо 50%-60% байсан бол 2022 онд 42% болж буурсан.

Хүснэгт 9. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн медиан

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	30	35	64	39	31
Төв	25	29	-	32	26
Дархан	34	26	28	28	28
лицей	50	50	59	62	42

Дээд квартил оноо Улаанбаатарын шалгуулагчдын хувьд 50%-80% байгаа бол Дархан болон Төв аймгуудын хувьд 30%-50% байна. Харин Лицей ангийн шалгуулагчдын хувьд 2018 онд шалгуулагчдын 25% нь 74%-аас дээш үнэлэгдэж байсан бол 2020 онд шалгуулагчдын 25% нь 81%-аас дээш гүйцэтгэлтэй болж өссөн байна.

Хүснэгт 10. Англи хэлний хичээлийн ЭЕШ-ын гүйцэтгэлийн квартил

Аймаг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Улаанбаатар	49	57	79	63	50
Төв	32	37	-	45	35
Дархан	53	35	45	43	41
лицей	74	63	81	74	73

Англи хэлний хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын гүйцэтгэлийн тархалтыг доорх графикуудад харууллаа. Англи хэлний хичээл дээр нийт шалгуулагчдын дийлэнх хэсгийн гүйцэтгэл 20%-40%-ийн орчимд тархсан байгаа бол Лицей ангийн шалгуулагчдын хувьд дунджийнхаа хувьд тэгш хэмтэйгээр тархсан байна.

График 6. Англи хэлний хичээлийн гүйцэтгэлийн тархалт






График 7. Лицей ангийн Математикийн хичээлийн гүйцэтгэлийн тархалт




Математик болон англи хэлний хэмжээст онооны нийлбэрийн дунджийг 620-оос доош, 620-650, 650-700, 700-800 гэсэн дөрвөн интервалд хувааж ангилал тус бүрээр дараах графикуудаар харууллаа. Улаанбаатар хотын шалгуулагчдын хувьд 12%-15% нь СЭЗИС-ийн босгыг хангадаг бол 2020 оны огцом өсөлт ажиглагдсан жил энэ тоо 31% болж өссөн байна. Жил бүр Улаанбаатар хотын шалгуулагчдын 2% нь 700-оос дээш дүгнэгддэг бол 10%-12% нь 620-700 онооны хооронд дүгнэгдэж байна.

График 8. Улаанбаатар хотын шалгуулагчдын математик англи хэлний хэмжээст онооны нийлбэрийн дундаж / % /




Дархан хотын шалгуулагчдын хувьд 10%-15% нь СЭЗИС-ийн босгыг хангадаг байдал ажиглагдаж байна. Жил бүр Дархан хотын шалгуулагчдын 1%-2% нь 700-оос дээш дүгнэгддэг бол 4%-7% нь 620-650 онооны хооронд, 4%-6% нь 650-700 онооны хооронд тус тус дүгнэгдэж байна.

График 9. Дархан хотын шалгуулагчдын математик болон англи хэлний хэмжээст онооны нийлбэрийн дундаж / % /




Төв аймгийн шалгуулагчдын хувьд 2%-6% нь СЭЗИС-ийн босгыг хангасан байгаа бол 1%-3% нь 620-650 онооны хооронд, мөн 1%-3% нь 650-700 онооны хооронд тус тус дүгнэгдэж байна.

График 10. Төв аймгийн шалгуулагчдын математик болон англи хэлний хэмжээст онооны нийлбэрийн дундаж / % /



Лицей ангийн шалгуулагчдын хувьд 2018 оны шалгуулагчдын 50%, 2019 онд 13%, 2020 онд 39%, 2021 онд 21%, 2022 онд 16% нь тус тус СЭЗИС-ийн босгыг хангасан байна.

График 11. Лицей ангийн шалгуулагчдын математик болон англи хэлний хэмжээст онооны нийлбэрийн дундаж / % /



Дүгнэлт:

Сүүлийн жилүүдийн элсэлтийн ерөнхий шалгалтын материал, уг материал дээр дүгнэгдсэн сурагчдын дээрх зарим статистик үр дүнгээс харахад ЕБС төгсөгчдийн математикийн хичээлийн мэдлэг маш хангалтгүй түвшинд байгаа нь харагдаж байна. Англи хэлний хичээлийн хувьд статистик үр дүнгүүд нь математикийн хичээлийн үр дүнгүүдээс 10%-20%-

аар дээш түвшинд, мөн сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын элсэгчдийн англи хэлний мэдлэг бусад ангиллуудын хувь дахь харгалзах түвшнээс дээгүүр түвшинд байгаа байдал ажиглагдлаа.

Математикийн хичээлийн хэмжээст онооны ерөнхий дундаж 511 байгаа бол англи хэлний хичээлийн хэмжээст онооны дундаж 524% байна. Математикийн хичээлийн хэмжээст онооны медиан болон квартил оноо харгалзан 515 оноо, 581 оноо байгаа бол англи хэлний хичээлийн хувьд медиан 527 оноо, квартил 595 оноо байна.

Гүйцэтгэлийн хувьд математикийн дундаж гүйцэтгэл 30% байгаа бол англи хэлний хичээлийн хувьд 42% байна. Математикийн хичээлийн гүйцэтгэлийн медиан болон квартил харгалзан 25%, 36% бол англи хэлний хувьд гүйцэтгэлийн медиан 34%, квартил 57% байгаа нь нэг хэсэг сурагчдын хэлний мэдлэг чадвар бусад сурагчтай харьцуулахад дээгүүр түвшинд болж байгаа байдал ажиглагдлаа.

Лицей сургуулийн хувьд ерөнхий болон жил бүрийн үр дүнгүүд ангиллуудын жил бүрийн үзүүлэлтээс харьцангуй дээгүүр түвшинд дүгнэгджээ. Лицей ангийн математикийн хичээлийн хэмжээст онооны ерөнхий дундаж 590, медиан 600, квартил 650 байгаа бол англи хэлний хичээлийн хувьд хэмжээст онооны дундаж 586, медиан 592, квартил 643 оноо байна. Лицей анги төгсөгчдийн математикийн хичээлийн ерөнхий гүйцэтгэлийн дундаж 43%, медиан 40%, 55% бол англи хэлний хувьд гүйцэтгэлийн дундаж 55%, медиан 55%, квартил 74% байна.

Санал зөвлөмж:

Цаашид ЕБС-тай хамтарсан лицей ангиудын тоог ихэсгэж, тухайн ангиудаар дамжуулан гүйцэтгэл сайтай элсэгчдээр элсэлтийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ:

Badamjav, G., Jeon, Y. (2022). *Survey of Mongolian Secondary School Student's Attitude Toward Statistical Topic*. Cit.05/03/2023. Retrieved from <http://www.koreascience.or.kr/journal/OGSHB2/v4n1.do>

Анхбаяр, Ж., Амарзаяа, А. (2021). *Суралцагчийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор их сургуулийн сурлагын амжилтыг таамаглах*. Cit.05/03/2023. Retrieved from Cit.05/03/2023. Retrieved from <https://shorturl.at/dKMS7>

Боловсролын үнэлгээний төв. Retrieved from <http://stat.eec.mn/>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

БАКАЛАВРЫН ДИПЛОМЫН АЖИЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Т.Туяа¹, С.Норжинлхам²

¹Доктор(Ph.D) СЭЗИС-ийн СУТ-ийн багш tuya.t@ufe.edu.mn

²Доктор (Ph.D) СЭЗИС-ийн СШУТ-ийн багш, norjinkham.s@ufe.edu.mn



Түлхүүр үг:

Найруулгын алдаа, Зөв
бичих дүрмийн алдаа,
Алдаа шалгах программ,
Толь бичгийн хэрэглээ

Хураангуй

Аливаа бичмэл эхүүд хоорондоо бичлэгийн арга барил, үг сонголтын хувьд ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл бичлэгийн төрөл зүйл бүхэн найруулгаас шалтгаална. Эрдэмтэн Ц.Сүхбаатар "...найруулга бол түүхийн явцад бүрэлдэн тогтсон, нийт ард түмэн үг ярианы харилцуурын хэрэглүүрийг шилжэж сонгох, хэрэглэх арга барилыг ухамсарлан мэдсэн, өнгө аяс болон хэлний нарийн ялгамжааг илтгэсэн хэлний нэгжүүдийг аль болох зохистой хэрэглэсэн, дотоод нэгдэл бүхий хэлний тогтолцоо юм" (Ц.Сүхбаатар, 2004) гэж тодорхойлсон байна. Найруулга гэдэг нь үг хэллэг хэрэглэх, өгүүлбэрийг зохион байгуулах, өөрийн онцлогийг агуулсан арга барил юм. Энэхүү арга барилыг эзэмшихийн тулд хөдөлмөрч эрмэлзэлтэй байх, эргэн тойрноо байнга ажиглах, зорилго чиглэлтэй уйгагүй унших, бүтээлч дуурайл авах, бичих сэдвээ зөв сонгож, ойлгох, сонгож авсан сэдвээ төлөвлөх, үгийг оновчтой сонгох, бичсэн зүйлээ ахин дахин засахыг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Оюутан суралцагчид бол ирээдүйн судлаачид төдийгүй хэлний дархлааг хамгаалан, орчин цагийн бичгийн хэлний хөгжлийг түүчээлэгч болохын хувьд өмнөх эрдэмтдээсээ бичгийн хэлний чадварт суралцан, ялангуяа шинжлэх ухааны найруулгын хэрэглээг хөгжүүлэхэд хамгийн ихээр хувь нэмэр оруулах үеийнхэн мөн билээ. Түүнчлэн цахим эриний үед бичгийн хэлний алдаа засах тусгай программ бий болохын зэрэгцээ хэрэглэгчдийн санал, хэрэгцээгээр хөгжих үндэстэй тул найруулан бичсэн эрдмийн ажлаа алдаа шалгагчаар засан сайжруулж, түүнээсээ суралцан, улмаар программ хөгжүүлэгчдэд санал хүргүүлж, бие биеэ дэмжин ажилласнаар дараа дараагийн үеийнхэн маань бичгийн хэлнээ төвөггүй суралцах боломж бүрдэх билээ. Тиймээс энэхүү асуудлыг авч үзэн, 2015 оноос хойш сургуулийн цахим санд орсон бакалаврын дипломын ажлуудад ажиглалт, шинжилгээ хийв. Ингэхдээ дипломын ажлуудад гарч буй нийтлэг алдааг илрүүлэхийг зорьж, хөтөлбөр тус бүрээр болон нийт тоон статистикийг гаргаж дүгнэв.

УДИРТГАЛ

Найруулгын чадвар эзэмшээгүйгээс болон найруулгад тавих шаардлагыг зөрчсөнөөс алдаа гарч, мөн зөв бичих дүрмээ баримтлахгүй байх зэргээс улбаалан аливаа бичвэрийн утга санаа бүдгэрэх, алдагдах, стандарт найруулгын хэм хэмжээ зөрчигдөх нь цөөнгүй тохиолдох болсноор эрдмийн ажил чанаргүйдэх, улмаар хэл бичгийн хөгжил соёлд сөргөөр нөлөөлөх болжээ.

Найруулгын алдаа гэж тухайн яриа, бичвэрийг сонсогч, уншигч хүлээн авч ойлгоход ямар нэг хэмжээгээр саад, хүндрэл учруулж байгаа нэг эсвэл хэд хэдэн үгийг хэлдэг. Аман ярианд найруулгын алдаа үүсэхэд ярилцагч хүнээс лавлан асуух боломж байдаг бол бичмэл материалыг уншиж буй хүнд ийм боломж үгүй тул юм бичиж буй хүн анхнаасаа найруулгын алдаа гаргахгүй байхыг хичээх хэрэгтэй юм. Үүний тулд найруулгын алдааны талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Найруулгын алдааг найруулга зүйч, доктор профессор Ц.Сүхбаатар найруулгын болоод найруулгын бус алдаа гэж ангилсан авч үзсэн. Найруулгын алдааг үг сонгохтой холбоотой, найруулгын бус алдааг тухайн бичигчийн ерөнхий мэдлэг дутсанаас үүдэлтэй гэж хэлж болно. Доктор профессор Д.Отгонсүрэн “Найруулга зүйн үндсэн шаардлага, хэл найруулгын дүрэм горимыг зөрчсөний үр дагаврыг найруулгын алдаа гэдэг. Найруулга зүйн шинжлэх ухаан нь санаа бодлоо илэрхийлэхдээ тохируулан хэлний аль нэг арга хэрэглүүрийг төгс төгөлдөр сонгон найруулж чадсан эсэхийг тодруулан судалдаг. Ер нь найруулгын алдааг олно гэдэг нь үгийг онож сонгоогүй, үгийн сангийн давхаргын үгийг зөв хэрэглээгүй, илүүц үгээр нуршсан, хэлний зүйн дүрмээр буруу хэлбэржүүлсэн, утга санаа, учир шалтгааны холбоог алдсан зэргийг тодруулна гэсэн үг юм” гэж тодорхойлоод “найруулгын алдааг чухам юуг алдсаныг харгалзан үгийн сангийн, хэлний зүйн, утгын, учир шалтгааны баримт сэлтийн гэж” (Д.Отгонсүрэн, 1998) хуваасан байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Аливаа хэлний дархлааг бий болгож, хөгжлийг нь тогтвортой хадгалдаг нэг чухал хүчин зүйл бол бичгийн хэл юм. Монголчуудын хэрэглэж ирсэн бичиг үсгийн дотроос оюуны болон эдийн соёлын хамгийн баялаг сан хөмрөгийг тээж ирсэн болон тээж байгаа бичиг үсэг бол үндэсний буюу монгол бичиг, кирилл буюу монгол кирилл бичиг хоёр юм. Энэ хоёр бичгийн үнэ цэн, ач холбогдлыг нэгийг нь дээр нөгөөг нь тавих боломжгүй.

Монгол кирилл бичиг нь хэрэглэсэн цаг хугацааны хувьд богино боловч хэрэглээний цар хүрээ, гүйцэтгэсэн үүрэг, тээж дамжуулсан баримтын хувьд асар өргөн юм.

1941 онд Ц.Дамдинсүрэнгийн зохиосон зөв бичих дүрмийг дахин нягталж, зарим нэмэлт тайлбар хийж боловсруулаад, түүндээ тулгуурласан журамласан толь шинээр зохиох шаардлагын улмаас Монгол хэлний тухай хуулийн дагуу Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дарга 2016 оны 9-р сарын 8-ны өдрийн 05 дугаар тогтоол гаргаж, уг тогтоолоор толь зохиох ажлын хэсэг байгуулагдан, тус Зөвлөлийн Ажлын албаны дэргэд ШУА-ын Хэл зохиолын хүрээлэн, МУИС, МУБИС-ийн эрдэмтэн судлаачдын баг бүрдүүлж, “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2017)-ийг боловсруулсан байна.

Энэхүү журамласан толийг зохиохдоо 1941 онд Ц. Дамдинсүрэн зохиож 1983 онд нэмэн

засварлаж хэвлэсэн дүрэм (Ц.Дамдинсүрэн, 1983)-ийг баримтлан, Ц.Дамдинсүрэнгийн дүрэмд ямар нэг өөрчлөлт оруулалгүй, зарим нэг нэмэлт тайлбар, тодруулга хийсэн байна.

Нийгмийн аль ч салбарт бичгийн хэлний үүрэг асар их бөгөөд нийтээрээ мөрдөх хэлний хууль дүрэм, дэгийг дагахгүйгээр хэл соёлоо хөгжүүлэх, хүүхэд залуучуудынхаа мэдлэг оюуныг тэлэх, аливаа соёлын эх суурийг гүн гүнзгий эзэмшүүлэх, монгол үндэстнийхээ эрх ашигт нийцүүлэн дэлхийн хүн ардтай хөл нийлүүлэн хөгжих боломжгүй юм. Улс үндэстнүүд өөр өөрийн гэсэн түүхээ бичиг үсгээрээ, түүх соёлоороо өвлүүлэн үлдээдэг жамтай. Тиймээс ч бичгийн соёл, тэр дундаа судлаачид, эрдэмтдийнхээ бүтээл туурвилаар хөгжлөө түүчээлэх, үндэстнийхээ онцлогийг түгээх нь зүй ёсны хэрэг билээ. Ирээдүйн судлаачдаа бэлтгэж буй орчин үед оюутан суралцагчдын судалгааны ажлын чанар чансаа, бичгийн соёл, цаашлаад академик соёлын орчин бүрдүүлэх үүргээ профессор багш нар, эрдмийн ажлын удирдагчид анхаарах зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Орчин цагийн монгол хэлнээ бичгийн хэлний тогтворжсон хэд хэдэн төрөл хөгжиж ирснийг дурдвал, албан бичгийн найруулга, шинжлэх ухааны (эрдэм шинжилгээний) найруулга, сонин сэтгүүлийн найруулга, уран зохиолын найруулга юм. Мөн зах зээлийн үеэс бизнесийн байгууллага олноор бий болж, бараа бүтээгдэхүүн, бусад зүйлийг сурталчлах хэрэгцээний үүднээс зар сурталчилгааны найруулга ч биеэ даасан төрөл болохуйц хөгжиж байна. Эдгээрээс шинжлэх ухааны найруулга бол стандарт найруулгын төрөлд хамаарах бөгөөд өөрийн гэсэн хэл зүй, үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сангийн онцлогтойгоор бие даасан төрөл болон хөгжиж ирсэн уламжлалтай. Шинжлэх ухааны найруулгыг доктор, профессор М.Базаррагчаа (М.Базаррагчаа, 2005) дараах жанруудад ангилсан байна. Үүнд:

1. Шинжлэх ухааны мэдээллийн найруулга /нэвтэрхий толь, гарын авлагын өгүүлэл, сэтгүүл, эмхэтгэл, лавлах, гарын авлага/
2. Шинжлэх ухааны зохиолын найруулга /өгүүлэл, нэг сэдвт зохиол, шүүмжит горилсон бүтээл, хураангуй/
3. Сурах бичгийн найруулга /сурах бичиг, гарын авлага, хөтөлбөр /хэмжих ба орчих хөтөлбөр/, бодлого дасгалын хураамж, ажиллах заавар/
4. Шинжлэх ухааны хялбарчилсан найруулга /шинжлэх ухааны нээлтийн түүх, эрдэмтний намтар, хялбарчилсан өгүүлэл, хэрэглэх заавар/ эдгээр болно.

Оюутан суралцагчдын бакалаврын дипломын ажил нь шинжлэх ухааны зохиолын найруулга (Б.Бямбадорж, 2014) буюу горилсон бүтээлд хамаарагдана.

СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Бид, энэхүү өгүүллээрээ бакалаврын дипломын ажлуудад ажиглалт хийж, тэдгээрт гарч буй түгээмэл алдааг илрүүлэхийг зорилоо. СЭЗИС-ийн багш, оюутны эрдмийн ажлууд нь 2015 оноос эхлэн бүтээлийн санд электрон хэлбэрээр хадгалагдаж ирсэн байна. Бүтээлийн санд 2022 оны эцсийн байдлаар 6 мэргэжлийн хөтөлбөрийн нийт 1615 бакалаврын дипломын ажил байна. Бакалаврын дипломын ажлыг хөтөлбөр тус бүрээр Хүснэгт 1-д харуулав.


Хүснэгт 1 Бүтээлийн санд орсон дипломын ажил

Огноо	Бизнесийн эдийн засаг	Бизнесийн удирдлага	Бизнесийн эрх зүй	Нягтлан бодох бүртгэл	Мэдээллийн системийн менежмент	Санхүүгийн удирдлага	Нийт
2015	9	4				8	21
2016	8	82		1	7	14	112
2017	14	74		8	7	26	129
2018	21	110	13	14	5	52	215
2019	22	86	14	27	4	53	206
2020	25	87	29	26	10	61	238
2021	46	99	45	61	9	84	344
2022	27	85	37	79	17	105	350
Нийт	172	627	138	216	59	403	1615
Эзлэх хувь	10.7%	38.8%	8.5%	13.4%	3.7%	25%	100%

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Дээрх хүснэгтээс харахад хамгийн их хувийг Бизнесийн удирдлагын мэргэжил, хамгийн бага хувийг Мэдээллийн системийн менежментийн мэргэжлийн диплом тус тус эзэлж байна. Түүвэрт хамрагдах дипломын ажлуудыг хөтөлбөр тус бүрээр нэгтгэн График 1-ээр харуулав.

График 1 Хөтөлбөр тус бүрээр түүврийн тоо



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Хөтөлбөр тус бүрийн нийт түүвэрт хамрагдах тоо хэмжээнд үндэслэн 2015 оноос 2022 оныг дуусталх хугацаанд харгалзах онуудад хуваарилалтыг хийж, нийт түүвэрт хамрагдах дипломын ажил тус бүрийг тодорхойллоо. Дэлгэрэнгүйг Хүснэгт 2-оор харуулав.

Хүснэгт 2 Түүврийн тоо

Огноо	Бизнесийн эдийн засаг	Бизнесийн удирдлага	Бизнесийн эрх зүй	Нягтлан бодох бүртгэл	Мэдээллийн системийн менежмент	Санхүүгийн удирдлага
2015	1	0	0	0	0	1
2016	1	8	0	0	1	1
2017	1	7	0	1	1	3

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

2018	2	11	1	1	0	5
2019	2	9	1	3	0	5
2020	3	9	3	3	1	6
2021	5	10	5	6	1	8
2022	2	9	4	8	2	11
Нийт	17	63	14	22	6	40

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Дипломын ажлуудыг 2 үндсэн зарчмаар найруулга болон найруулгын бус алдааг илрүүлэв. Нэгдүгээрт, алдааг шалгах программ буюу “Болор спелл”-ээр алдааг шалгав. Уг программыг 2013 онд Болорсофт ХХК үг зүйн судалгаанд үндэслэн алдаа хянах программ хангамжийг зохиосон байна. Тус программ “Болор толь”-той холбогдсон ба анх 40 сая үгийн сантай байсан бол одоо 140 сая гаруй үгийн сантай болсон байна. Уг программаар үгийн алдааг шалгахад чиглэгдсэн учраас бусад найруулгын бус алдаануудыг шалгах боломжгүй нөхцөл үүссэн болно. Энэ программаар зөвхөн үгийн алдааг илрүүлдэг учраас учир дутагдалтай байв. Програмаар хянагдаж чадахгүй бусад алдааг гар аргаар тулган шалгасан болно. Мөн “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” буюу монгол хэлний онлайн тайлбар толь бичгийг суурь болгон авлаа. Нийт түүврийн хэмжээнд алдаануудыг шалгаж, хөтөлбөр тус бүрээр нэгтгэн харууллаа.

Хүснэгт 3 Нийт алдааны тоо хэмжээ (хувиар)

№	Хөтөлбөр	Тийн ялгалыг зөв залгаагүй	Дагавар буруу залгасан	Цэг, тэмдэгт зөв аваагүй	Үг давтсан	Үг үсгийн алдаа	Үг буруу сонгосон	Үг хооронд зөв зай аваагүй
1	Бизнесийн эдийн засаг	39%	6%	4%	6%	44%	0%	1%
2	Бизнесийн удирдлага	36%	10%	3%	0%	47%	2%	2%
3	Бизнесийн эрх зүй	40%	0%	1%	0%	58%	1%	1%
4	Нягтлан бодох бүртгэл	36%	0%	1%	0%	59%	0%	4%
5	Мэдээллийн системийн менежмент	38%	0%	0%	0%	56%	3%	4%
6	Санхүүгийн удирдлага	48%	15%	4%	0%	30%	0%	4%

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр


Судалгааны үр дүнгээс харахад тийн ялгалыг зөв залгаагүй болон үг үсгийг буруу бичиж алдаа гаргасан хувь хэмжээ нийт алдааны 84% эзэлж байна. Зөв бичих дүрмийн алдаа буюу дагавар нөхцөлийг буруу залгах алдаа хамгийн түгээмэл байна. Үүнд, гээгдэх гээгдэхгүй эгшгийн дүрэм, үйл үг бүтээх дагаврыг залгах дүрэм, харьяалах, өгөх орших, заахын тийн ялгалын нөхцөлийг залгах дүрмийн зөрчил олонтоо давтагдаж байгаа нь ажиглагдлаа. Зарим тийн ялгалын нөхцөлийг бичих тухай өгүүлбэл:¹⁴⁸

¹⁴⁸ Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь (2017)

1. Үгийг тийн ялгалаар хувилгахдаа тогтворгүй н үсгийг уг үгийн төгсгөлийн гийгүүлэгч гэж үзэхгүй, харин үгийн үндэс ба залгаврын жийрэг гэж үзнэ. Жишээлбэл: тэрэг-тэрэгний, төлөг-төлөгний, үндэс-үндэсний гэх мэт.
2. Тогтворгүй н-тэй үгийг тийн ялгалаар хувилгахдаа н үсгийг гаргаж бичнэ. Энэхүү тогтворгүй н үсэг ихэвчлэн харьяалах, өгөх орших, гарах гурван тийн ялгалд нэгэн адил гарна. Жишээлбэл: модны, модонд, модноос, морины, моринд, мориноос, унины, унинд, унинаас гэх мэт. Гэтэл номны сан гэдэггүй учир номонд гэж бичихгүй номд; асуултны, амжилтны гэдэггүй учир асуултад, амжилтад гэж бичнэ.
3. Харьяалахын тийн ялгалын –ы, -ий нөхцөлийг тогтвортой ба тогтворгүй н үсгээр төгссөн үгэнд эгшиг зохицох ёсоор залгана. Жишээлбэл: модны, түмний, усны гэх мэт. Харьяалахын тийн ялгалын –н нөхцөлийг хос эгшиг ба урт ий эгшгээр төгссөн үгэнд залгана. Жишээлбэл: толгойн, дэлхийн гэх мэт.
4. Өгөх оршихын тийн ялгалын нөхцөл –д, -т: -Т нөхцөлийг г ба өмнөө эгшигтэй с гийгүүлэгчээр төгссөн тогтворгүй “н” -гүй үгэнд залгана. Жишээлбэл: худагт, Нацагт, нутагт, хэлтэст гэх мэт. Бас р, в гийгүүлэгчээр төгссөн зарим үгэнд уламжлал баримтлан бичнэ. Жишээлбэл: гарт, Дэндэвт гэх мэт. -Д нөхцөлийг дээрхээс бусад үсгээр төгссөн үгэнд бичнэ. Жишээлбэл: ахад, шилд, сард, хүн бүрд гэх мэт.
5. Заахын тийн ялгалын –г нөхцөлийг урт, хос эгшиг, хэлний угийн н үсгээр төгссөн үгэнд залгана. Жишээлбэл: дүнг, шороог, тахиаг, гахайг, Галсанг гэх мэт. Биеийн хамаатуулах минь, чинь, нь-ийн өмнөх заахын тийн ялгалын –ыг, -ийг; харьяалахын тийн ялгалын –ын, ийн, нөхцөлийн г, н үсэг, сонстохгүй боловч энэхүү н, г үсгийг гээхгүй бичнэ. Жишээлбэл: ахыг нь, гарыг минь, үзгийг чинь, гарын нь гэх мэт (ахы нь, гары минь, үзгий чинь, гары нь гэж бичвэл буруу).
6. Зарим нэр үг хоёр өөр утгыг илтгэх болоод тийн ялгалаар хувилахдаа ч ялгавартай болжээ. Жишээлбэл: Шөнө од (нэрлэхийн тийн ялгал) гялалзана. Алтан гадас одон Лувсангийн энгэр дээр гялалзана. Ард Насангийн соёолон насны морь наадамд түрүүлэв. Өвлийн эхэн сарын (харьяалах) арван тавны шөнө сарны гэрэл тооноор орно. Сард авах цалин, саранд нисэж очих гэх мэт. Зарим үг тийн ялгалаар хоёр өөр хувирч хоёр өөр утгыг илтгэх явдал байна. Жишээлбэл: адуугаар баян нэгдэл, танай адуунаар миний морь явчлаа гэх мэт.

Нийт алдааны төрлүүдийн дэлгэрэнгүйг График 2-оор харууллаа.

График 2 Нийт алдааны төрлүүд



Эх сурвалж: Судлаачийн нэгтгэлээр

Ихэнх алдаа бичигчийн хайхрамжгүй байдал, дахин дахин нягтлаагүй, цаг зарцуулаагүй, үл тоох хандлага зэргээс үүдэн гарсан гэлтэй ажиглагдлаа. Тухайлбал, механик алдаа буюу үсэг давхар, дутуу дарагдах (*талархлалаа, суртанхууны, энэнхүү, авдагаа, эрслэлүүдэд, шаардлагтай, Зургаадугаат, байгууллагууд*), үг хооронд зай авахгүй байх (*санхүүгийнтүрээс, лизингнь, Түрээслэгчи йн, Үзүүлэлтүү дийн*), нэг үгийг нэг нүүрэнд өөр өөр хэлбэрээр бичих (*түвшинг, түвшинийг, дараахь, дараах, үүсчээ, үүсжээ, банкинд, банканд, санхүүжилтийн, санхүүжилтын, эрсдлийн, эрсэдлийн, эрсдэлийн, эзлэхүүн, эзэлхүүн*) зэрэг ийм төрлийн алдаа нийт алдааны тал хувийг эзэлж байгаа нь бичигчийн хариуцлагатай шууд холбоотой. Нөгөө талаар академик ёс зүй, соёлын хэм хэмжээг дагаж мөрдөх зайлшгүй хэрэгцээ төдийгүй шаардлага байгааг бэлхнээ харуулж байна.

Харин зөв бичих дүрмийн алдаанууд нь толь бичиг ашиглаагүй, мэдлэг дутмагаас үүдэн гардаг. Тухайлбал,

1. Толь бичиг ашиглаагүйгээс: *монопол-монополь, инновац-инноваци, дурдаж-дурьдаж, программ-програм, объект-объект, цэнтэй-цэнэтэй, нэлээд-нилээд, түвшин-төвшин, нөгөөтээгүүр-нөгөөтэйгүүр, томъёо-томъёо, идэвх-идэвхи, дээрх-дээрхи, чадавх-чадавхи, индукц-индукци, хойших-хойши, авлигал-авилгал, талаарх-талаархи, ойрх-ойрхи;*
2. Гээгдэх эгшгийн дүрэм зөрчсөн: *стандарчлалын-стандартчилалын, газраас-газараас, байдлыг-байдалыг, орчны-орчины, хэрэгслийг-хэрэгсэлийг, өрнүүлсний-өрнүүлсэний, бохирдуулсны-бохирдуулсэний, ялгарлыг-ялгаралыг, дунджаар-дундажаар, баялгийн-баялагийн, алхмын-алхамын, хэрэглэгчдэд-хэрэглэгчидэд, өндгийг-өндөгийг, оруулагчдын-оруюлагчидын, зөрчлийг-зөрчилийг, шийдүүлсний-шийдүүлсэний, мэдэгдлийг-мэдэгдэлийг, нөхцөлөөр-нөхцлөөр, төлөвийн-төлвийн,*
3. Тийн ялгалын нөхцөл буруу залгасан: *хэрэгжилтийн-хэрэгжилтын, одоогийн-*

одоогын, номд-номонд, дүгнэлтэд-дүгнэлтэнд, тайлангийн-тайлангын, компанийн-компаний, асуудлыг-асуудлийг, цагийн-цагын, доллароор-доллараар, оролцогчдын-оролцогчдийн, зурагт-зурганд, компьютерын-компьютерийн, шокийн-шокийн, инфляцын-инфляцийн, хяналтад-хяналтанд, вирусний-вирусын, орчныг-орчинг, дунджийг-дунджыг, жагсаалтад-жагсаалтанд, хооллолтод-хооллолтонд, эргэлтэд-эргэлтэнд, хүүгээс-хүүнээс, гаднын-гадны, удирдамжид-удирдамжинд, хүүхдэдээ-хүүхэддээ, авагчдадаа-авагчиддаа, сургалтад-сургалтанд;

4. Товчилсон үгийн нөхцөл буруу бичсэн: *АНУ-аас/АНУ-с, НББ-ийн/НББ-н, ДНБ-ий/ДНБ-ы, 4.27%-аар/4.27%-иар, 20-оор/20-иор, 01.01-ээс/01.01-нээс, ...эрхлэхүй"-ээс/...эрхлэхүй"-гээс, ХХК-ийн/ХХК-ын,*
5. Үйл үг бүтээх “-л” дагаврыг буруу залгасан: *судаллаа-судлалаа, судалж-судлаж, баримталж-баримтлаж, түрээслэнэ-түрээслэнэ, нэрлэж-нэрэлж, баталсан-батласан, судалсан-судласан, онцолсон-онцолсон, оношилгоо-оношлогоо* ГЭХ МЭТ.

ДҮГНЭЛТ

Шинжлэх ухааны зохиолын хэл нь найруулгын загварт төрөлд хамаарах бөгөөд тухайн нэг шинжлэх ухааны чиглэлийн бүтээл нь нэр томьёо, тогтсон үг хэллэгээс гадна тогтсон өгүүлбэр, цогцолборын хэв маягаар илрэх нь энэхүү төрлийн хэл найруулгын нэг онцлог шинж болно. Бичгийн хэл, тэр тусмаа шинжлэх ухааны зохиолын хэл найруулгад түгээмэл тохиолдож буй алдаа эндүүрлийг тухай бүр засаж залруулах нь мэдээ мэдээллийн шугамаар хэлэнд нөлөөлж байгаа алдаа, гажуудлаас зайлсхийх, мэргэжилтэн, судлаачдын мэдлэг, чадварыг ахиулах, “Хэлний хэм хэмжээг хэл зүйн ном сурах бичиг, хэм хэмжээний толь бичигт журамлан тусгах нь тухайн хэлээр хэлэлцэгч залуу үеийг зорилготойгоор сургах зайлшгүй алхам болно. Харин хэлэнд гарч болох бүтээлч бус буруу хэрэглээг анхаарахгүй орхих нь хэлний хэвшин тогтсон хэм хэмжээг зөрчихөд хүргэх тул аливаа алдааг багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, ахмад үе засах нь зүйтэй.” (Н.Нансалмаа, 2012) гэсэн олон улсын нийтлэг үзэл баримтлал, “Төрийн албан ёсны хэлний тухай хууль” (2003), “Монгол хэлний тухай хууль” (2015) зэргийг үндэслэн, монгол үндэстний утга зохиолын хэлний хэм хэмжээг бүх нийтээр дагаж мөрдөх зарчимд нийцүүлэн, шинжлэх ухааны бичиг зохиолын хэлний хөгжилд судлаачийн зүгээс хувь нэмрээ оруулах, бичгийн хэлний тогтолцоог дараагийн үед уламжлуулан үлдээх, эрдэмтэн судлаач-багш хүний хувьд нийгмийн үүрэг, хариуцлагаа ухамсарлан, зэрэг горилогчийн судалгааны ажилд зөвлөн туслахдаа бичгийн хэлний найруулгын шаардлага, үсгийн дүрмийн хэрэглээг албан ёсоор хянах үүрэгтэй байх нь зүйд нийцнэ. Тийм ч учраас шинжлэх ухааны хэл найруулгын хөгжилд, байгууллагын судалгаа шинжилгээний ажилтнууд, боловсролын байгууллага, ялангуяа дээд боловсролын байгууллагын багш нар ихээхэн үүрэг, оролцоотойг ухамсарлах асуудал чухал юм. Энэ тухай “Судлаачид судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэхийн зэрэгцээ өөрийн орчинд академик соёлыг бий болгож, түүнийг бусад судлаач болон оюутнуудад дамжуулж байдаг.” хэмээн судлаач, доктор Н.Оюунцэцэг тэмдэглэжээ. (Н.Оюунцэцэг, 2015)

Утга зохиолын бичгийн хэлний найруулгад монгол хэлний үсгийн дүрмийн хэрэглээнээс гадна дагавар, нөхцөлүүдийн утга, үүргийг чухалчлан, судалгааны ажлынхаа хэл найруулгаар дамжуулан хойч үедээ бичгийн хэлний боловсрол, соёлыг уламжлуулан

үлдээж, залгамжлуулах нь зөвхөн хэлний мэргэжилтний бус аль ч салбарын судалгаа шинжилгээний ажилтан, боловсролын бүх түвшний сургалтын байгууллагын багш, ажилтнуудын нийгмийн өмнө хүлээх хариуцлага гэдгийг ухамсарлах нь зүйтэй юм. Хариуцлагаа үл ухамсарлаваас монгол үндэстний бичиг зохиолын хэлний хөгжиж ирсэн уламжлал алдагдаж, тогтсон бичгийн хэлний хэлбэр, загвар эргээд ярианы хэлний найруулга болон суларч, задрах магадлалтай.

Хэдийгээр орчин цагийн утга зохиолын аман болон бичгийн хэлнээ гадаад үг хэллэгийн хэрэглээ, үсгийн дүрмийн эргэлзээ, алдаа эндүүрэл, хэл найруулгын ташаарал олонтоо байгаад эрдэмтэн судлаачдын зүгээс энэ асуудалд анхаарлаа хандуулан, дүгнэлт хийж, үндэстний хэлнийхээ тогтвортой байдал, хэрэглээ, соёлыг хадгалан өвлүүлэх явдал чухал юм. Дараах асуудлуудыг анхааран хэлэлцэж хэвшүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Бичгийн хэлний найруулгад тавих шаардлагуудыг дагаж мөрдөх хэрэгцээ, шаардлага байна.
2. “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2017) дагаж мөрдөх, ашиглаж дадах хэрэгцээ байна. Үг толийг утсан дээрээ үнэгүй суулгаж, байнгын хэрэглээ болгох нь дээрх мэтийн алдаа гарахгүй байх төдийгүй бичгийн хэлний соёл эзэмшүүлэх, дадал болгоход тийм ч төвөгтэй биш гэдэг нь илт байна.
3. Шинжлэх ухааны найруулгын төрөл, жанруудын ялгааг таньж, нийцүүлэн бичиж хэвших нь судлаачийн үүрэг төдийгүй “жинхэнэ судлаач” болохыг харуулах нэгэн ноиолгоо гэхэд хэтийдэхгүй буй за.
4. “СЭЗДС-ийн эрдмийн ажлын бичилт хийх стандарт” (2010) мөрдөж хэвшихэд багш, ажилтан, оюутан судлаач хэн хүний оролцоо чухал юм.
5. <https://spellcheck.mn/> программыг ашиглаж хэвших, улмаар бусдад түгээн сурталчлах, сургуулийн соёлыг бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой төдийгүй боловсролын тогтвортой хөгжлийг дэмжихэд хувь нэмрээ оруулах юм.
6. Бакалаврын ажлын үнэлгээний шалгуурыг шинэчлэн тогтоож, цахим санд хяналт шүүлттэйгээр байршуулах ажлыг тогтмолжуулах хэрэгцээ байна.

НОМЗҮЙН ЖАГСААЛТ

- Н.Нансалмаа. (2012). *Ерөнхий хэл шинжлэл*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- М.Базаррагчаа. (2005). *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Ц.Дамдинсүрэн. (1983). *Монгол үсгийн дүрмийн толь*. Улаанбаатар.
- Б.Бямбадорж. (2014). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар.
- Н.Оюунцэцэг. (2015). *Академик соёл ба эрдэм шинжилгээний өгүүлэлд нийтлэг шаардлагууд*.
www.ikon.mn-ээс гаргасан
- Д.Отгонсүрэн. (1998). *Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй*. Улаанбаатар.
- Ц.Сүхбаатар. (2004). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

БНХАУ-ЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ БАТЛАХ¹⁴⁹
АРГЫН СУДАЛГАА

Буянтогтох (BAOYINTAOGETAO¹, Д.Гэрэлмаа²

¹ СЭЗИС-ийн докторант, 470882528@qq.com

² Доктор (ScD), проф. СЭЗИС, Бизнесийн удирдлагын тэнхим-ийн ахисан түвшний профессор, gerelmaa.d@ufe.edu.mn



Хураангуй

Уг өгүүлэлд БНХАУ-ын дээд боловсролын сүүлийн хоёр жилийн чанарын үзүүлэлтэд нэгдсэн дүгнэлт хийн, сургалтын байдал, чиг хандлагыг тайлбарласан болно.

Түлхүүр үг:

Дээд боловсрол; чанарын
батлах;
технологигжуулалт

Удиртгал

Дээд боловсрол нь хөгжлийн явцдаа зөвхөн хөгжлийн хурдыг анхаарах ёсгүй ба чанарыг гол цөмөө болгох нь зөв юм. Дээд боловсролын чанарыг баталгаажуулах тогтолцоог байгуулснаар сургалтын түвшинг цогцоор нь үр дүнтэй дээшлүүлж, цаг үеийн хөгжилтэйгөө нийцэх сургалтын загварыг бий болгосноор БНХАУ-ын дээд боловсролын шинэчлэлд хүчтэй түлхэц болно. Дээд боловсролын чанарыг батлах, сайжруулах явцад дээд боловсролын удирдлагын түвшинг дээшлүүлж, хөгжлийг түргэсгэх, чанаржуулах ба Шинжлэх ухаан, боловсролоор улс орноо сэргээх¹⁵⁰ бодлогыг хэрэгжүүлж чадах юм.

1. БНХАУ-ын дээд боловсролын салбарын үндсэн мэдээлэл


Ойрын жилүүдэд, их дээд сургууль байгуулах ажлууд үргэлжилж, холбогдох санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. БНХАУ-ын боловсролын яамны статистик мэдээллийн дагуу 2015-2020 онд үндэсний боловсролын санд оруулсан нийт хөрөнгө оруулалт 3619.2 тэрбум юаниас 5301.4 тэрбум болж өссөн ба жилийн нийт өсөлт нь 7.97% байна^[1]. Үүнээс дээд боловсролд оруулсан хөрөнгө оруулалт 951.8 тэрбумаас 1399.9 тэрбум болж өссөн буюу жилийн нийт өсөлт нь 8.02% байна. Жил ирэх тусам Хятадын их дээд сургуулиудын тооны өсөлт удаашрах чиг хандлагатай байна^[2]. 2020 онд Хятадад дээд боловсролын 3003

¹⁴⁹ Одоо байгаа чанарыг барих, бууруулахгүй байх, чанаржуулах

¹⁵⁰ 20 дугаар зууны эхэн үеэс БНХАУ-ын засгийн газрын баримталж байгаа бодлого.

байгууллага бүртгэлтэй байсан. 2021 он болоход энэ тоо ердөө 9-өөр л нэмэгдэж нийт 3012 болсон буюу 0.3% өсөлттэй байна.

График 1. Их, дээд сургуулийн элсэгчдийн тоо, түвшингээр



Үүнд бакалаврын түвшний¹⁵¹ 1238, бакалаврын түвшний коллеж 32, мэргэжлийн коллеж 1486, насанд хүрэгчдийн¹⁵² 256 их сургууль хамрагдана^[3]. Их дээд сургуулиудад 44.3 сая оюутан суралцаж байсан бөгөөд 2021 онд 10,000,320 суралцагч элсүүлэн 1.18 сая орчим магистрант, 130 мянган докторант, 1.885 сая профессортой болсон нь өмнөх жилээс 1.79%-иар өссөн болно^[4].

2. БНХАУ-ын дээд боловсролын чанарыг батлан сайжруулах арга хэмжээ

2.1. Дээд боловсролын чанарыг сайжруулах арга зам

2022 онд БНХАУ-ын хэмжээнд их дээд сургуульд шинээр нэмэгдсэн мэргэжлийн тоо 1961, хүчингүй болсон мэргэжлийн тоо 804 байна. Үүнд “Их дээд сургуулийн бакалаврын мэргэжлийн каталог”-т 31 мэргэжил нэмэгдсэн ба олон их сургуулийг хамарсан болно. Эдгээр 31 мэргэжил нь нүүрстөрөгчийг нөөцлөх шинжлэх ухаан ба инженерчлэл, намгархаг газрын хамгаалал ба нөхөн сэргээлт, биологийн үржүүлгийн шинжлэх ухаан зэрэг өндөр нарийвчлал бүхий мэргэжлүүд юм^[5]. Дээд боловсролын мэргэжлийн байгуулга нь зохион байгуулалтаа сайжруулж, байрлаж буй бүсийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегид үйлчлэх ёстой. Боловсролын байгууллагын чанарын үзүүлэлтийн түвшин нь сургалтын чанартай шууд хамааралтай учир тус бүсийн үйлдвэрүүдийн хөгжилд тодорхой хэмжээгээр нөлөөлнө.

¹⁵¹ Элсэгчид нь ахлах сургуулиа төгсөөд шууд ордог, энгийн мэргэжлүүдээр бакалаврын түвшний мэдлэг олгодог сургуулиуд

¹⁵² Элсэгчид нь ажлын туршлагаараа мэргэжил дээшлүүлэх зорилготой, хичээлийн хуваарь нь уян хатан чанартай сургуулиуд

"Давхар арван мянгатын төлөвлөгөө"¹⁵³-ний тайлангийн хурлаар дээд боловсролын чанартай системийг бий болгоход зургаан¹⁵⁴ том ажлыг хийж гүйцэтгэн, их сургууль дахь инженерийн мэргэжлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн. Үүнээс гадна эрэлт бүхий мэргэжлийг шинээр бий болгох нь сургуулийн зорилго болон үйлчилгээний чиг баримжаанаас гажаагүй, нийгмийн хөгжлийн хэрэгцээ болон суралцагчдын хэрэгцээний дагуу, шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөлт, ангилсан удирдлага, динамик удирдлага зэрэг шаардлагуудыг хангасан байх ёстой.

Боловсролын гурван үе шат¹⁵⁵-ын иж бүрэн шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжихийн тулд шинээр мэргэжил бий болгож буй үзэл баримтлалыг өөрчилж, тогтолцоо, механизмыг шинэчилж, бүх боловсон хүчээ дайчлан, хүн бүр үүргээ биелүүлэх шаардлагатай. Өндөр түвшний бакалаврын сургалтаар чиг баримжаа болгон сургууль болон удирдагчдад үүргийг нь ухамсарлуулж, мэргэжлийн бүтээн байгуулалт болон боловсон хүчийг бэлтгэх ажлыг тодорхой болгож, "хүн рүү чиглэх" бодлогыг хэрэгжүүлэн, улс даяар мэргэжлийн стандартыг хангасан үйлдвэрлэл, анагаах ухаан, либерал урлаг /liberal art/ босгож, мэргэжлийн үнэлгээний шалгуурыг дээшлүүлэн нийгэм дэх өндөр чанартай мэргэжилтний эрэлтийг хангах нь зүйтэй гэж үзсэн байна^[6].

"Сургуулиуд, суралцагчид, цаг хугацааг бүрэн хамруулах" зарчмын дагуу "боловсрол, удирдлага, үйлчилгээг нэгтгэсэн ухаалаг, үзэл суртлын боловсролын платформ" бий болгох шаардлагатай байна. Үүнээс гадна, социал медиа болон дээд боловсролыг хослуулан, онлайн болон танхимын загвараар хичээлээ явуулж, виртуал симуляцийн туршилтын сургалтын төслүүдийг хэрэгжүүлж, сургалтын материалыг зохиох, хянах, сонгох явдлыг сайжруулж; танхимын болон хичээлээс гадуурх, онлайн сургалтын хөтөлбөрийг нэмэгдүүлэх, сургуулийн хамтын боловсролын нөөцийг өргөжүүлэх, өндөр чанартай хичээлүүдийг хуваалцах, сургалтын хөтөлбөр боловсруулах түвшинг дээшлүүлэх зорилготой ажиллаж байна^[8].

2.2. Боловсролын системийг технологижуулах

Их дээд сургуулиуд мэргэжлийн ур чадвар, практикийн ур чадварыг сургалтын зарчим болгон авч, танхимын сургалтад анхаарч, боловсролын үзэл баримтлал, заах арга барилыг сайжруулж, дээд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцооны хөгжүүлэлтийг эрчимжүүлж, ерөнхий шинэчлэл, инновацыг эхлүүлэх хэрэгтэй. Ингэхдээ, 1) танхимын сургалтад орчин үеийн мэдээллийн технологийг идэвхтэй ашиглаж, ухаалаг анги танхимын ажлыг идэвхтэй хэрэгжүүлж, сурагчдад тухтай суралцах орчинг бүрдүүлэх 2) боловсрол сургалтын талаарх судалгаан дээр тулгуурлан, судалгааны үр дүнг сургалтын явцад хэрэгжүүлж, заах аргыг тасралтгүй хөгжүүлж, багш нарыг олон хэв загварын заах аргыг идэвхтэй судлахыг дэмжих 3) сурагчдын багаар ажиллах чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаан, эмнэлгийн тусламжийн үйлчилгээ зэрэг сургалтын материалд нэгдсэн төлөвлөлт хийж, мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрт компанит ажил, бодит төсөл, өгөгдөл,

¹⁵³ БНХАУ-ын засгийн газраас туайн үеийн ерөнхий сайд Ли Кэчяны санаачлагаар 2015 оны 3 сард баталсан хувийн ААН-ын дэмжих талаар хөгжлийн төлөвлөгөө. Уг төлөвлөгөөнд эрэлт бүхий мэргэжлүүдэд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх, 10 мянган шилдэг инженер бэлтгэх зорилтуудыг тусгасан байдаг.

¹⁵⁴ Сургалтын чанар сайжруулах, мэргэжлийн судалгааг дэмжих, сургууль болоод ААН-ын харилцааг сайжруулах, дээд боловсролын нийгэмд үйлчлэх чадамжийг ахиулах, гадаадын сургуулиудтай харилцаа холбоогоо сайжруулах, удирдлагын тогтолцоог шинэчлэх.


¹⁵⁵ Суурь боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол

элементүүдийг багтаах шаардлагатай. Ингэснээр "Боловсролын гурван үе шат"-ын сүүлчийн үе болох дээд боловсролын шатанд гарцад чиглэсэн, оюутан төвтэй, тасралтгүй сайжруулалт бүхий боловсон хүчин бэлтгэх үйл явцыг босгож чадна.

2021 оны байдлаар дээд боловсролын үндсэн багш нарын тоо 1.8852 сая байна. Үүнээс энгийн бакалаврын сургуульд 1.2697 сая, бакалаврын түвшний боловсрол олгодог коллежид 25600, мэргэжлийн коллежид 570200, насанд хүрэгчдийн коллеж, их дээд сургуульд 19,700 үндсэн багш, профессор ажиллаж байна^[9]. Дээд боловсролын багшлах мэргэжлийн баг хамт олныг сайжруулан, боловсон хүчинг дэмжих механизмыг байгуулж, өндөр зэрэглэлийн мэргэжилтнийг бэлтгэх ажилд шинэ ололт болно. Бүсүүдийн их дээд сургуулиудад өндөр технологи эзэмшсэн боловсон хүчинг урих, их дээд сургуулийн залуу багш нарыг гадаадад сургах хөтөлбөрийг хэрэгжүүлж, өндөр түвшний мэдлэгтэй багийг бүрдүүлэх үйл явцыг хурдасгана. Холбогдох тэнхимүүд шинжлэх ухааны суурь судалгааны баг байгуулах ажлыг эрчимтэй дэмжиж, шинжлэх ухааны салбарыг байгуулах явцад, чадварлаг оюутнуудыг урамшуулах, хүндэт профессоруудад үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Ойрын жилүүдэд, боловсролын системийг технологижуулах зах зээлийн орлогын жилийн нийлмэл өсөлт нь 10.45% -д хүрж, 2022 онд 527.7 тэрбум юань болсон. Үүнээс дээд боловсролыг технологижуулах зах зээлийн хэмжээ 139.4 тэрбум юанийг эзэлнэ. Боловсролын яамны Хятадын Боловсролыг технологижуулах стратегийн судалгааны баазаас гаргасан тайланд дурдсан тоо баримтаас харахад их дээд сургуулиудыг технологижуулах сангийн 48.14%-ийг шугам сүлжээ, тоног төхөөрөмж худалдан авахад, 31.46%-ийг дижитал нөөц, платформ хөгжүүлэхэд, 14.33%-ийг бусад судалгаа шинжилгээнд, 4.97%-ийг ашиглалт, засвар үйлчилгээнд зарцуулсан байна^[10].

График 2. Их, дээд сургуулиудыг технологижуулах сангийн зарцуулалт



Технологижсон сургалтын системийн ач холбогдлыг бүрэн ойлгож, тусгай сан байгуулж, тасралтгүй хөгжүүлэх нь чанартай боловсон хүчин бэлтгэхэд оруулах хамгийн том хувь нэмэр юм. Ухаалаг анги танхим, шууд дамжуулах анги зэрэг сургалтын орчны өөрчлөлт, техник хангамжийн бүтээн байгуулалтыг хөгжүүлж, сургалтын янз бүрийн хувилбаруудад технологийн дэмжлэг үзүүлэн; онлайн сургалтын платформ, онлайн сургалтын курсуудыг нээж, "Сюетонг", "Үйкетанг" зэрэг ухаалаг сургалтын программ хангамжийг сурталчлах

зэргээр мэдээллийн технологи нь сургалтын шинэчлэлд тус нэмэр болох болно. Ингэснээр хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, шинжлэх ухааны мэргэжлүүдийн өөрчлөлтийн хөгжилд түлхэц өгч, үйлдвэрлэлийн менежментийг гол цөм болгосон, олон салбар хамтран ажилласан, программчлагдсан, технологижсон, шинжлэх ухаанч сургалтын орчин бий болно.

3. Дүгнэлт

Одоогийн байдлаар БНХАУ-ын улс төр, эдийн засаг, соёл урлаг зэрэг салбарууд хурдацтай хөгжиж байна. Дээд боловсролын сургууль нь чадварлаг боловсон хүчин бэлтгэх чухал байгууллага гэдгээрээ цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах шаардлагатай. Энэ чвцад мэргэжлийн төрлүүдэд өөрчлөлт орж болох ба маш тодорхой шалгууртай байх нь зүйтэй. Шинжлэх ухааны салбартай уялдсан заах аргад зогсолтгүй шинэчлэл хийх нь зүйтэй бөгөөд дээд боловсролын чанарыг сайжруулахын тулд боловсролын системийг технологижуулах ажлыг эрчимтэй хийж байна. Үр дүнд нь БНХАУ-ын дээд боловсролын түвшин дээшилж, олон салбарын чанартай боловсон хүчээр хангагдана.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- [1] Shine Wong. Өртгийн сүлжээний онолын үүднээс Хятадын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох нь [J]. Хятадын цахилгаан эрчим хүчний боловсрол, 2012, (14): 1-2+20
- [2] Ли Баопин. Хятадын алсын зайн дээд боловсролын чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны хэрэгжилтийн сэдвийн судалгаа [J]. Орчин үеийн алсын зайн боловсролын судалгаа, 2011, (03): 30-34.
- [3] Ву Сүмэй, Сүн Кайпин. Хятадын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцооны төлөв байдал болон авах арга хэмжээний дүн шинжилгээ [J]. Хил хязгаар, 2010, (14): 182-184.
- [4] Жоу Шиачин, Гу Линган. Хятадын дээд боловсролын мэдээллийн тэгш бус байдал ба чанарын баталгааны судалгаа [J]. Нинбо их сургуулийн сэтгүүл (Боловсролын шинжлэх ухааны хэвлэл), 2010, (04):56-60.
- [5] Гуо Пин, Тянь Ляньжин. Манай улсын дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцооны өнөөгийн байдал, эсрэг арга хэмжээ[C]// Дээд боловсролын олон улсын форум.2011 он.
- [6] Жан Лигуо.Хятад болон Их Британийн орчин үеийн алсын зайн дээд боловсролын гадаад чанарын баталгаажуулалтын тогтолцооны харьцуулсан судалгаа[J]. Хятадын алсын зайн боловсрол, 2006.
- [7] Ян Шиули, Зян Шоусү. Манай улсын ихэнх насанд хүрэгчдийн дээд боловсролын чанарын баталгаажуулалтын арга хэмжээний тухай ярих нь[C]// Дээд боловсролын шинэчлэлийн судалгаа ба практик (2-р боть)—Хармөрөн мужийн дээд боловсролын нийгэмлэгийн 2003 оны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2003 он. .
- [8] Жэн Хайронг. Хятад дахь үндэстэн дамнасан дээд боловсролын чанарын баталгаажуулалтын тогтолцооны судалгаа[D].Хуажун Шинжлэх ухаан технологийн их сургууль.
- [9] Ли Жинхуй. 21-р зууны эхэн үеийн манай улсын их дээд боловсролын чанарын судалгаа[D].Шанси боловсролын их сургууль, 2004 он.
- [10] Жэн Фанфан. Элсэгчдийг өргөжүүлэх үндсэн дээр манай улсын дээд боловсролын чанарын удирдлагын бодлогын судалгаа[D]. Хуайбэй боловсролын их сургууль.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
ЭРХ ЗҮЙ, НИЙГЭМ БА БОЛОВСРОЛ

ISBN: 978-9919-9906-1-9

НОМЫН САНГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ НЬ ОЮУТНЫ СУРЛАГЫН АМЖИЛТАНД НӨЛӨӨЛӨХ НЬ

Г.Гантулга¹, Ч.Өнөржаргал², Ц.Хатанхангай³

¹ СЭЗИС-ийн НББ-ийн тэнхмийн эрхлэгч доктор (Ph.D)

² СЭЗИС-ийн НББ-ийн тэнхмийн ахлах багш

³ СЭЗИС-ийн НББ-ийн тэнхмийн ахлах багш



Түлхүүр үг:

Номын сан, Оюутан

Хураангуй

Суралцахуйн үр дүнд олон хүчин зүйл нөлөөлдөг билээ. Оюутны үр дүнтэй, амжилттай суралцах үндэс нь тухайн хичээл, сэдэвтэй холбоотой нэмэлт материалуудыг уншиж судлах явдал юм. Бид сургалтын үйл ажиллагааны нэг хэсэг болох оюутнуудын номын сангаар үйлчлүүлэх байдал оюутны сурлагын дүнд хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорилоо. Судалгааны үр дүнгээс харахад номын сангаар үйлчлүүлдэг оюутны сурлагын дүн номын сангаар үйлчлүүлдэггүй оюутны дүнгээс илүү өндөр байх хандлагатай байна. АССА хөтөлбөрийн оюутнуудын номын сангаар үйлчлүүлэх давтамж бага байгаа ч сурлагын дүн өндөр байгаагийн шалтгаан нь тэдний ашигладаг сурах бичиг, гарын авлагууд номын санд байдаггүй бөгөөд хөтөлбөрөөс тавьж олгодогт оршино. Оюутан номын сангаар үйлчлүүлэх байдал, давтамжийн тооноос оюутны сурлагын амжилт хамааралтай болж байна.

Бид судалгаандаа 2021-2022 он болон 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улирлын бакалаврын хөтөлбөрийн оюутнуудын дүн болон номын сангаар үйлчлүүлсэн оюутнуудын мэдээллийг авч ашиглан Microsoft Excel-ийн Pivot Table, Microsoft Access, Microsoft PowerBI програмуудын тусламжтайгаар шинжилгээ хийж үзсэн болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Номын сангаар үйлчлүүлэх нь оюутны сурлагын амжилтанд хэр зэрэг нөлөөлж байгааг судлахын тулд СЭЗИС-ийн номын сан болон оюутны дүнгийн мэдээллийн баазыг ашиглалаа. Судалгааг сүүлийн 3 улирал буюу 2021-2022 оны хичээлийн жилийн 1,2-р улирал, 2022-2023 оны 1-р улирлын мэдээллийн хүрээнд хийв. Сүүлийн 3 улиралд номын сангаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн мэдээлэл болон оюутны дүнгийн мэдээлэлд MS

Excel-ийн Pivot Table ашиглан шинжилгээ хийлээ. Номын сангаар үйлчлүүлэгчдийн мэдээлэл нь 27 багана, 44310 мөр, оюутны дүнгийн мэдээлэл нь 6 багана 100784 мөрөөс бүрдсэн байв. Номын сангаар үйлчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдээс үйлчлүүлсэн оюутны мэдээллийг ялган авах, нийт оюутны дүнгийн мэдээлэлд үндэслэн номын сангаар үйлчлүүлээгүй оюутнуудын мэдээллийг ялган авахад Microsoft Access-ийн Simple Query, Find Unmatched Query-ийг тус тус ашиглалаа. Microsoft Access, Microsoft Power BI програмуудын тусламжтайгаар номын сангаар үйлчлүүлсэн болон үйлчлүүлээгүй оюутны дүнгийн мэдээлэлд шинжилгээ хийлээ.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Оюутны дүнгийн мэдээлэлд хийсэн шинжилгээ

СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн оюутнуудын 2021-2022 оны хичээлийн жилийн 1,2-р улирал, 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улирлын дүнгийн мэдээлэлд шинжилгээ хийлээ. Өдөр орой, эчнээ хөтөлбөрийн нийт 5685 оюутны 630 хичээлийн дүнгийн мэдээллийг хамруулан авч үзсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

№	Хичээлийн жил, улирал	Оюутны тоо	Хичээлийн тоо	Дундаж дүн
1	2021-2022 оны 1-р улирал	3,510	493	82.07%
2	2021-2022 оны 2-р улирал	3,581	496	78.53%
3	2022-2023 оны 1-р улирал	3,318	391	73.51%
Нийт		5,685	630	78.74%


2021-2022 оны хичээлийн жилийн 1-р улирлын дундаж дүн хамгийн өндөр байгаа бөгөөд цаашид буурсан үзүүлэлттэй гарчээ. Ковидын дараа сургалтын үйл ажиллагааг танхимд шилжүүлж эхэлсэн хугацаанд оюутны дундаж дүн буурсан байна. Гурван улирлын нийт хичээлийн ерөнхий дундаж дүн 78.74% байна. Оюутны дүнг хөтөлбөр тус бүрээр гаргаж Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2

Хөтөлбөрийн нэр	2021-2022-1	2021-2022-2	2022-2023-1	Ерөнхий
АССА	84.38	82.93	78.54	82.52
АССА бямба бэлтгэл	68.23	74.34	88.84	73.73
ВРР/2+2/ Нябо хамтарсан хөтөлбөр	80.38	84.67	79.88	81.97
Бакалаврын бямба гаригийн эчнээ анги	83.13	81.86	79.96	81.86
Бакалаврын оройн анги	84.72	79.31	59.88	80.04
Бакалаврын өдрийн анги	82.17	78.30	73.12	78.63
Бакалаврын эчнээ анги	84.40	84.35	81.22	83.94
Бакалаврын эчнээ анги/цахим ухаалаг/	77.20	76.54	72.48	76.08
БНХАУ-ын Дунбэй	72.68	76.35	74.21	74.95
БНХАУ-ын Шандонг коллежтай хамтарсан хөтөлбөр	86.44	73.79	68.05	79.16
Далиан политехникийн их сургууль	90.84	74.23	67.86	73.61
Далиантай хамтарсан анги	83.81	83.86	76.92	82.18
Зочлохуйн үйлчилгээний менежментийн	90.00	14.80		36.29

хөтөлбөр				
Канадтай хамтарсан анги	69.99	72.72	66.18	69.89
ОХУ, Дорнод Сибирийн ИС-тай хамтарсан хөтөлбөр	76.67	66.75	70.47	68.91
ОХУ, Ирниту хамтарсан хөтөлбөр			70.08	70.08
ОХУ, Москвагийн ИС-тай хамтарсан хөтөлбөр			34.17	34.17
Солбридж	81.01	78.36	68.24	74.43
Тайваньтай хамтарсан анги	81.01	74.83	69.78	74.45
Үндэсний батлан хамгаалахын их сургуультай хамтарсан анги	84.60			84.60
Хандонтой хамтарсан анги	82.54	76.48	61.94	71.38
Шаталсан бакалаврын оройн хөтөлбөр	76.92	73.81	72.33	75.92
Шаталсан бакалаврын өдрийн хөтөлбөр	80.61	76.31	67.67	78.50
Эрх зүй + Санхүү		79.17	93.50	82.75
Японтой хамтарсан анги	87.80	78.64	73.26	79.42
Ерөнхий дундаж	82.07	78.53	73.51	78.74

Зураг 1. Оюутны дүн



Оюутны дүнг үсгэн үнэлгээ тус бүрээр ангилж үзэхэд А- үнэлгээ авсан оюутны тоо 23475 буюу хамгийн олон байна. Харин D+ гэсэн үнэлгээг хамгийн цөөн авчээ. Гурван улирлын дүнгээр оюутны дүнгийн амжилт 91%, чанар 66% байна. Амжилтгүй дүн буюу F үнэлгээ авсан оюутны тоо 9330 байгаа бөгөөд энэ нь нийт дүгнэгдсэн оюутны 9%-ийг эзлэж байна.

Номын сангийн мэдээлэлд хийсэн шинжилгээ

СЭЗИС-ийн номын сангаар 2021-2022 оны хичээлийн жилийн 1,2-р улирал, 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улиралд 2,940 уншигч давхардсан тоогоор 44,310 удаа үйлчлүүлсэн байна. (Хүснэгт 3) Уншигчдын тоо улирлаас улиралд өссөн байгаа нь ковидын дараа танхимаар хичээллэх болсноор уншигчид хэвлэмэл ном ашиглахыг чухалд үзсэнийг илтгэж байж болох юм..

Хүснэгт 3

№	Хичээлийн жил, улирал	Уншигчийн тоо	Үйлчлүүлсэн тоо	Дундаж
1	2021-2022 оны 1-р улирал	1,341	10,310	7.69
2	2021-2022 оны 2-р улирал	1,728	16,370	9.47
3	2022-2023 оны 1-р улирал	1,800	17,630	9.79
Нийт		2,940	44,310	


Гурван улирлын хугацаанд оюутан М.Ц хамгийн олон удаа үйлчлүүлсэн байна. Тэрээр 410 удаа үйлчлүүлж 287 ном, бүтээлийг номын сангаас авч ашиглажээ.

Хүснэгт 4

№	Уншигчийн код	Уншигчийн нэр	Үйлчлүүлсэн тоо	Материалын тоо
1	1057	М.Ц	410	287
2	B20...	А. Л.	274	15
3	b21fj...	Э. Д.	239	107
4	B20F...	С.Б.	231	49
5	1011...	Х.Н.	225	167

Номын сангаар үйлчлүүлэгчдийн дийлэнх хэсэг буюу 77% нь бакалаврын өдрийн хөтөлбөрийн оюутнууд байна. Бакалаврын хөтөлбөрийн оюутнууд Микроэкономикс номыг хамгийн олон удаа буюу 2317 удаа авч ашиглажээ. Үүний дараа Нягтлан бодох бүртгэлийн үндэс номыг 2080 удаа, Үйлдвэрлэл үйл ажиллагааны менежмент номыг 2008 удаа авч ашигласан байна. B20FA... кодтой оюутан А Л. Санхүүгийн бүртгэл /онол, стандарт, тест, бодлого, дасгал/ номыг 48 удаа авч ашигласан байгаа нь нэг номыг хамгийн олон удаа авсан тохиолдол болсон байна.

Зураг 2. Номын сангаар үйлчлүүлэгчдийн бүтэц



Номын сангаар үйлчлүүлсэн оюутны дүнд хийсэн шинжилгээ

СЭЗИС-ийн бакалаврын хөтөлбөрийн оюутнуудын 2021-2022 оны хичээлийн жилийн 1,2-р улирал, 2022-2023 оны хичээлийн жилийн 1-р улирлын дүнгийн мэдээллийг номын сангаар

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

үйлчлүүлсэн оюутны мэдээлэлтэй уялдуулан шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүнгүүд гарсан байна.

2021 оны 09-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний хооронд номын сангаар 2423 оюутан үйлчлүүлжээ. Харин 3262 оюутан номын сангаар огт үйлчлүүлээгүй байна. Номын сангаар үйлчлүүлдэггүй 673 оюутан өөрийн судласан хичээлүүд дээрээ хангалтгүй үнэлгээ авчээ. (Хүснэгт 5) Энэ нь номын сангаар үйлчлүүлдэггүй оюутнуудын 20.63%-ийг эзлэж байна.

Хүснэгт 5.

Хөтөлбөрийн нэр	Оюутны тоо	Дундаж дүн
Бакалаврын өдрийн анги	369	39.71
Бакалаврын бямба гаригийн эчнээ анги	99	30.52
Бакалаврын эчнээ анги/цахим ухаалаг/	43	30.84
Шаталсан бакалаврын өдрийн хөтөлбөр	29	34.20
Тайваньтай хамтарсан анги	25	42.54
Солбридж	20	34.10
АССА	17	38.74
БНХАУ-ын Дунбэй	12	42.61
АССА бямба бэлтгэл	10	30.37
Канадтай хамтарсан анги	10	34.60
Бакалаврын оройн анги	9	14.77
Далиантай хамтарсан анги	7	38.89
Японтой хамтарсан анги	7	54.91
Хандонтой хамтарсан анги	6	42.98
Далиан политехникийн их сургууль	5	44.72
ОХУ, Москвагийн ИС-тай хамтарсан хөтөлбөр	2	20.26
БНХАУ-ын Шандонг коллежтай хамтарсан хөтөлбөр	2	43.84
Зочлохуйн үйлчилгээний менежментийн хөтөлбөр	1	14.80
	673	

Номын сангаар үйлчлүүлдэг оюутнуудаас 147 оюутан буюу 6.06% нь хангалтгүй үнэлгээ авсан байна. (Хүснэгт 6)

Хүснэгт 6.

Хөтөлбөрийн нэр	Оюутны тоо	Дундаж дүн
Бакалаврын өдрийн анги	96	51.73
Тайваньтай хамтарсан анги	9	52.09
Солбридж	8	51.22
Шаталсан бакалаврын өдрийн хөтөлбөр	6	47.00
Канадтай хамтарсан анги	4	55.99
Хандонтой хамтарсан анги	4	41.70
БНХАУ-ын Дунбэй	4	55.41
Бакалаврын бямба гаригийн эчнээ анги	2	51.90
Бакалаврын эчнээ анги/цахим ухаалаг/	2	58.76
БНХАУ-ын Шандонг коллежтай хамтарсан хөтөлбөр	2	36.82
Далиан политехникийн их сургууль	2	56.40


АССА	2	45.21
Далиантай хамтарсан анги	2	53.32
Японтой хамтарсан анги	1	55.50
ОХУ, Ирниту хамтарсан хөтөлбөр	1	39.50
Шаталсан бакалаврын оройн хөтөлбөр	1	54.05
ОХУ, Дорнод Сибирийн ИС-тай хамтарсан хөтөлбөр	1	54.25
	147	51.34

Зураг 3. Номын сангаар үйлчлүүлдэг, үйлчлүүлдэггүй оюутнуудын дундаж дүнгийн харьцуулалт



Номын сангаар үйлчлүүлдэг оюутнуудын дундаж дүн, үйлчлүүлдэггүй оюутнуудынхаас 10-13 орчим хувиар илүү гарсан байна. Номын сангаар үйлчлүүлдэг оюутан хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд 60%-тай ойролцоо дүн авч байгаа бол үйлчлүүлдэггүй оюутан түүнээс 14 орчим хувиар бага дүн авч байна.


Зураг 4.



Номын сангаар үйлчлүүлдэг оюутнууд нь үйлчлүүлдэггүй оюутнуудаас илүү өндөр дүн авч байгааг А, В үнэлгээний тооны харьцуулалтаас харж болно. Харин номын сангаар үйлчлүүлдэггүй оюутнууд, үйлчлүүлдэг оюутнуудаас илүү олон F үнэлгээ авчээ. (Хүснэгт 7)


	A	A-	B+	B	B-	C+	C	C-	D+	D	D-	F
Номын сангаар үйлчлүүлдэг	7799	13770	6627	5031	5190	3231	2261	2603	1573	1778	1163	3240
Номын сангаар үйлчлүүлдэггүй	5397	9705	4927	4343	3751	2776	2394	1954	1653	2381	1139	6048

Зураг 5.



Номын сангаар үйлчлүүлдэг оюутнуудын амжилт нь үйлчлүүлдэггүй оюутнуудынхаас 7%-иар илүү байна. Мөн номын сангаар үйлчлүүлдэг оюутнуудын сурлагын чанар нь 10%-иар илүү байна.

Зураг 6. А болон F үнэлгээ авсан оюутны эзлэх хувийн харьцуулалт



А үнэлгээ авсан оюутнуудын 59% нь номын сангаар үйлчлүүлдэг бол F үнэлгээ авсан оюутнуудын 65% нь номын сангаар үйлчлүүлдэггүй болохыг Зураг 6-аас харж болно.

Сүүлийн гурван улиралд номын сангаар үйлчлүүлэх оюутны тоо өсөлттэй гарсан байна. Дэлхий нийтийг хамарсан ковидын цар тахлын улмаас хичээл сургалтын үйл ажиллагаа цахимаар зохион байгуулагдах болсонтой холбоотой номын сангийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон билээ. Ковидын дараа буюу танхим, цахим хосолсон хэлбэрээр

хичээл сургалтын үйл ажиллагаа зохион байгуулагдсан 2021-2022 оны хичээлийн жилийн 1-р улиралд номын сангаар 3713 оюутан давхардсан тоогоор үйлчлүүлжээ. Дараагийн 2 улиралд номын сангаар үйлчлүүлсэн оюутны тоо эрс өссөн байна. (Зураг 7)

Зураг 7.




Зураг 8.



Номын сангаар үйлчлүүлж буй тоо нь оюутны дүнд хэрхэн нөлөөлснийг Зураг 8-д харууллаа. Эндээс харахад номын сангаар үйлчлүүлэх тоо нь өсөх тусам тухайн оюутны дүн өссөн хамаарал илт харагдаж байна.

Хүснэгт 8. Номын сангаар үйлчлүүлсэн байдлын оюутны дүнд үзүүлэх нөлөө

№	Үнэлгээ	Оюутны тоо	Номын сангаар үйлчлүүлсэн тоо	Үйлчлүүлсэн тооны дундаж
1	60-аас бага үнэлгээ авсан	215	918	4.27
2	60-70	332	1559	4.70
3	70-70	748	4652	6.22
4	80-90	1649	11013	6.68
5	90-100	746	5895	7.90



Оюутны дундаж дүн нь номын сангаар үйлчлүүлсэн тооны дундажтай хэр зэрэг хамааралтай байгааг тогтоох зорилгоор корреляцийн коэффициентийг нь тодорхойлоход 0.99 гарсан байгаа нь энэхүү хоёр үзүүлэлт хоорондоо шууд хамааралтай болохыг илтгэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

- Судалгааны ажлын гол зорилго нь номын сангаар үйлчлүүлэх байдал ба сурлагын дүнгийн хамаарлыг гаргах явдал байлаа. Судалгааны үр дүнгээс харвал оюутны дүн номын сангаар үйлчлүүлэх хандлагаас шууд хамаарч байна.
- Номын сангаар олон удаа үйлчлүүлдэг оюутны сурлагын амжилт өндөр байгаа нь судалгааны үр дүнгээр нотлогдсон учир номын сангаар үйлчлүүлэх нөхцөл боломж, номын тоо, хүртээмжийг улам сайжруулах замаар төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх боломжтой юм.
- Оюутны номын сангаар үйлчлүүлэх хандлага сүүлийн 3 улирлын судалгаанаас харвал нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь сургалтын үйл ажиллагааг танхимаар

зохион байгуулж багш оюутантай нүүр тулж харилцах болон лекцийн хичээлийг цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотойгоор оюутнууд тухайн хичээлийн агуулгыг ном, сурах бичгээс авах шаардлагатай болсон байж болох юм.

- Нэгэнт оюутны сурлагын амжилтад номын сангаар үйлчлүүлэх давтамж эерэгээр нөлөөлж байгаа тул багш нар оюутнуудад сурах бичгээс агуулгыг дэлгэрүүлж унших, тэмдэглэл хөтлөх, оюуны зураглал хийх гэх мэт даалгавар өгөх гэх мэтээр ном, сурах бичиг, нэмэлт материалуудыг унших хандлагад нөлөө үзүүлбэл суралцагчдын сурлагын чанар, мэдлэг чадварт улам сайн нөлөө үзүүлж болх юм.
- Дараагийн ээлжинд номын сангийн ном, сурах бичиг, унших материалын хүртээмжийн судалгааг оролцогч талуудаас авч, шинжилгээ хийж, үр дүнд нь суурилсан зохих арга хэмжээг авах нь зүйтэй юм.
- Бид оюутны дүнг номын сангаар үйлчлүүлэх байдалтай нь холбон судлахдаа ашиглах ном сурах бичгийг нь хөтөлбөрөөс нь өгчихдөг АССА хөтөлбөр болон ном сурах бичиг худалдан авсан оюутнууд, цахим ном сурах бичиг ашигладаг оюутнуудын нөлөөллийг авч үзээгүй юм. Эдгээр оюутнууд нь бидний судалгаагаар номын сангаар үйлчлүүлдэггүй гэсэн ангилалд багтсан учир цаашид судалгааны ажлыг улам нарийвчлан хийх шаардлагатай байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

СЭЗИС-ийн номын сангийн мэдээллийн сан

СЭЗИС-ийн оюутны дүнгийн мэдээллийн сан

<https://support.microsoft.com/en-us>



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

TOURISM TO MONGOLIA FROM RUSSIA: DEVELOPMENT PROSPECTS

SHINKAREVA Olga¹, ALEKSEICHEVA Elena², KULOMZINA Elena³

¹ *Cand. Sc. (Economics), Associate Professor, Moscow City University, Moscow, Russia*

e-mail: shinkareva_ol@mail.ru

² *Doctor of Economics, Moscow City University, Moscow, Russia*

e-mail: alexeitcheva@yandex.ru

³ *Cand. Sc. (Economics), Associate Professor, Moscow City University, Moscow, Russia*

e-mail: tomlena.mk@mail.ru



Summary.

The study is devoted to the analysis of the prospects for the development of inbound tourism of Russian citizens to Mongolia. It was noted that Mongolia has a significant potential for growing tourist flow from Russia, promising tourism destinations and measures that must be implemented to attract Russian tourists are analyzed.

Key words:

Tourism, Russian Federation, Mongolia, development, ethical tourism

1. Introduction.

In recent years, the global travel industry market has existed in conditions of uncertainty. The stability and development of tourism was negatively influenced by many factors to the main ones: coronavirus, tense geopolitical situation, the closeness of individual countries and tourism destinations. All of these phenomena negatively affected the tourism industry - if in 2019 the industry brought the global economy almost \$9.2 trillion, then in 2020, due to the pandemic, there was a drop of 49.1%, as a result, the figure was only \$4.5 trillion. At the same time, tourism is one of the fastest recovering industries from shocks - for example, by 2023, world tourism has recovered by 63% compared to pre-pandemic 2019 (BBT, 2022; World Tourism Organization, 2023; Ministry of Economic Development of the RF, 2023).

2. Materials and Methods.


Authors used reports and operational economic statistics of the Ministry of Economic Development of the Russian Federation and open data. The use of various sources, as well as scientific methods (grouping method, comparison method, tabular and graphic methods, analysis and synthesis, etc.),

made it possible to collect information and verify and systematize it, identify certain trends and increase the reliability of the proposed recommendations.

3. Results and Discussion.

It should be noted that the current difficult geopolitical situation has significantly affected not only the volume of tourist flow of Russian citizens, but also the redistribution of tourist flow directions. Due to the fact that travel to a number of countries, mostly European, associated with significant difficulties, then the Russians began to seek new areas of tourism for themselves - so, domestic tourism began to actively develop, new countries began to gain popularity in terms of outbound tourism, and cooperation between Russia and Mongolia in this direction has great prospects - already in 2022 out foreigners who went in Mongolia, the majority were Russians (Fig. 1).

Figure 3.1 – The structure of foreigners who entered Mongolia in 2022



Source: by authors based on (ARD, 2023a)

According to official data, in 2022 the number of tourists in Mongolia increased significantly and reached 300.5 thousand people, which indicates the restoration of the country's tourism sector. It can be noted that not only the number of Russians who visited Mongolia has grown, but also other foreigners (Table 1).

Table 3.1 – Increase in the number of tourists entering Mongolia in 2022

№	Country	Increase in the number of tourists, people	Growth rate, 2022-2021%
1	Russia	140 637	11 200%
2	South Korea	51 070	22 100%
3	Kazakhstan	16 828	23 100%
4	China	5 423	90%

Source: by authors based on (ARD, 2023a)

A significant increase in the outbound tourist flow to Mongolia from Russia is largely due to the removal of covid restrictions, as well as the lack of proposals for traditional markets - for example, for a long time, China (which was one of the centers of attraction for residents of Siberia and the Far East) was closed for residents of Russia, significant difficulties arose with trips to Europe. In addition, the authorities of the Siberian regions made significant efforts to develop a tourist exchange with Mongolia - in May 2022, a meeting was organized between representatives of the authorities of Buryatia, the tourist business and representatives of Mongolia. As a result tour operators from Buryatia and the Irkutsk region began to offer excursion tours to Mongolia, among which the most popular were bus tours lasting 4-6 days. At the same time, the average cost of a tour to Ulan Bator from Ulan-Ude starts at 16,000 rubles (slightly less than 200 US dollars at the exchange rate at the end of April 2023), which is considered cheap for Russians (Profi and Travel, 2023). The advantage is the visa-free regime when entering for up to 30 days.

In December 2022, Mongolia launched the state program Visit Mongolia, aimed at developing the country as a tourist destination. The seriousness of Mongolia's plans to attract Russian tourists is demonstrated by the large-scale Mongolian-Russian tourist forum held at the end of winter in Ulan Bator. It attracted 18 leading Russian tour operators, including such large federal tour operators as ANEX Tour and FUN&SUN. The Minister for Border Crossings noted that at the end of this 2023, Mongolia set itself the goal of attracting from 200 to 250 thousand tourists from Russia to the country, in total, it is planned to attract up to 1 million foreign tourists to the country annually (ATOR, 2023).

The great limitation for the development of the tourism sector of Mongolia is the lack of access to the sea, therefore, this direction of tourism, which is in high demand among Russians, has no development prospects. Other restrictions on the development of cooperation in the field of tourism can also be highlighted.

1. Political - cultural gap between countries, positioning countries in the world information space.
2. Technology - related to both providing physical access to several regions and related to obtaining information.
3. Environmental - related to guarantees of preservation of integrity of natural objects.
4. Financial - the level of wealth of travelers, allowing you to purchase tours and related services.
5. Social, caused by lack of subsidies, other measures of state support to those segments of the population who cannot pay for tourist services (Alekseicheva E., Kulomzina E., Shinkareva O., 2022).
6. Informational - insufficient knowledge of potential tourists about the existing possibilities of the destination.

However, at the same time, the tourist potential of Mongolia is certainly present, and in other directions Mongolia can be very attractive for Russians. The following promising areas of development can be identified, primarily for residents of the Asian part of the country of the Russian Federation.

The first direction is shopping. It should be noted that the trips of Russians to China began from shopping. After that our citizens began to master other areas of recreation in the country.

Considering the current geopolitical situation, Mongolia can repeat this path by providing the visitors not only with shopping, but also by introducing the visitors to culture, customs, cuisine, etc.

The second direction is authentic tourism. In recent decades, authenticity and commodification of historical and cultural products have become increasingly important in the tourism industry. It is important that cultural resources are the basis of cultural tourism, as well as part of other types of tourism.

The correctly accents in the formation of an authentic tourist environment allow attracting tourists not only to the capital of Mongolia - Ulan Bator, but also to other regions of the country, primarily to the Gobi Desert. Mongolia has a few advantages in this area - primarily the possibility of nomadic tourism. So, tourists can live in a real nomadic town, where they offer traditional nomadic dishes, acquaint themselves with life and customs. Authentic tourism is an important reserve that contributes to the sustainable socio-economic development of the territory.

The third direction is gastronomic (culinary) tourism, which can attract tourists with the opportunity to get new unique and memorable experiences from food and drinks. The main directions of gastronomic tourism are the tourist's acquaintance with the cuisine of region, traditions and recipes for the preparation and consumption of traditional national dishes. The culinary component in Mongolia is very rich and diverse. Mongolia is famous for lamb dishes, primarily buuz, which, against the background of the love of Russians for this type of product, is its advantage.

We can also note such a direction of possible tourism development for Russians in Mongolia as ethical tourism, the purpose of which is to realize the ethical needs and intentions of tourists, including limiting the impact of tourist activities on the natural and cultural environment, the living culture of the local community. The term first appeared in the Global Code of Ethics for Tourism, year 1999. This type of tourism is based on the following postulates:

- tourism should promote respect and understanding between the peoples of the Earth and their inhabitants,
- tourism should promote tolerance, equality and respect and offer travelers the opportunity to develop their identity and broaden their horizons,
- tourism should promote sustainable development rather than destroy nature,
- humanity's heritage should be promoted through tourism.
- the host country should benefit from tourism through new jobs and social, cultural and economic growth,
- travel industry members have responsibilities and must fulfill them,
- a person has the right to tourism,
- tourists must enjoy freedom of movement in accordance with national legislation,
- fundamental rights of industry workers must be guaranteed,
- public and private tourism development actors must respect and follow these principles.

Mongolia is among the top 10 best regions in the world for ethical tourism, according to a 2023 report compiled by Ethical Traveler, an international research organization. The study evaluated factors such as human rights, social welfare, animal welfare and the environment. Among the

advantages of Mongolia, untouched nature, a diverse landscape, and wild animals were noted. The efforts of the country, which it has recently applied to the development of environmental protection programs in the mining and agricultural sectors, the fight against air pollution, policies aimed at ending and preventing human rights violations, were also considered.

Mining remains a challenging issue for tourism development, accounting for nearly a quarter of Mongolia's gross domestic product. But at the same time, significant progress has been noted in this direction - the Gobi Desert has excellent conditions for creating renewable energy sources. Solar and wind farms are emerging in some aimaks, reflecting Mongolia's desire to reduce its dependence on coal under the 2015-2030 State Energy Policy. The recommendations of The Nature Conservancy (TNC) were incorporated into the Environmental Impact Assessment Act, and TNC developed a national mitigation design tool to determine how to offset the impact of mining and oil field development. By 2030, Mongolia will establish a national mining mitigation system while funding conservation and sustainable management of critical lands. Another problem - air pollution - is very acute in the capital of the country - Ulan Bator. Mongolia is also moving towards environmental protection - with the assistance of the Asian Development Bank, funding was approved for the installation of the world's largest battery-based energy storage system, which should be completed in 2024. The project will supply clean energy charged by renewable electricity and integrate additional renewable energy strategies (ARD, 2023b).

Mongolia is beginning to actively develop tourism in various regions of the country, not only in the capital, which, thanks to a number of outstanding historical attractions, is the center of attraction. The Asian Development Bank approved the allocation of US \$32 million in a loan and grant for a tourism project aimed at strengthening and diversifying the sustainable development of tourism in Mongolia, which will support the development of tourism in three regions of the west of the country, focusing on the benefits for communities, the preservation of wildlife and heritage values, as well as recovery from coronavirus (COVID-19) and sustainability (Shinkareva O., Alexeitcheva E., Kulomzina E., 2022). It is expected that more than 16 thousand residents will increase their skills and income in the field of tourism. These events will diversify the economy of the regions and create new jobs through the creation of tourist complexes. As part of the project, the first two tourist centers in Western Mongolia will be built - the center of rock art and nomadic culture in the Khovd aimak and the Uvs tourist complex in the Uvs aimak. The Hovd Center will include Mongolia's first digital museum dedicated to the cultural heritage of rock art, and will include an online platform to promote local tourist goods and services. The project began in 2022 and is scheduled to be completed in 2027 (Central Asia Media, 2023).

The Mongolian government pays great attention to measures to attract tourists to the country. The strategy for the development of the country and tourism has plans to increase the number of tourists to 1 million people per year. One of the solutions aimed at implementing this goal is to ease visa conditions for visiting the country. Currently, between Russia and Mongolia there is a 30-day visa-free regime of entry into the country for the purpose of tourism. On April 07, 2023, at a meeting of the Great State Khural, Mongolian Foreign Minister Batmunkhiin Battsetseg noted that currently residents of 61 countries, including Russia, are exempt from visa requirements for short-term visits to the country and this list will expand in the near future.

Conclusions.

It can be noted that Mongolia as a country for inbound tourism of Russians has prospects, especially in the areas of ethical, gastronomic, and authentic tourism. At the same time, a several events can be highlighted that will facilitate the attraction of Russian tourists to Mongolia:

1. Solving the issue of direct flights from various cities of Russia.
2. Establishing partnerships between travel firms in Russia and Mongolia and their joint promotion of the Mongolian direction to form a sustainable demand for vacations in the country. It will also create cross-border routes that will combine rest in Russia and travel in Mongolia.
3. To provide the opportunity to pay in Mongolia with a MIR card, which will significantly facilitate payment methods and reduce the cost for Russian tourists. It means that it will increase not only the number of vacationers, but also make it possible to more easily spend money, including on the purchase, first of all, cashmere and other products of local crafts. Head of the Department for Coordination of Tourism Policy of the Ministry of Environment and Tourism of Mongolia Tuksgrlin Munkh-Od noted this spring that significant work has already been carried out in this direction with Mongolian banks (ATOR, 2023).

REFERENCES

- Alekseicheva E., Kulomzina E., Shinkareva O. (2022). Tourist cashback program as a factor in the development of gastronomic tourism. *Aktual'nye problemy razvitija jekonomiki Rossii v uslovijah novyh vyzovov. Sbornik nauchnyh trudov po itogam nauchnoj konferencii. (Actual problems of the development of the Russian economy in the context of new challenges. A collection of scientific works based on the results of a scientific conference)*, Moscow, 2022, 16-21.
- ARD (2023a). *The number of foreign tourists in Mongolia increased 3.1 times*. Retrieved from <https://asiarussia.ru/news/35053/> (in Russ.)
- ARD (2023b). *Ethical Traveler names Mongolia as one of top 10 regions of ethical tourism in 2023*. Retrieved from <https://asiarussia.ru/news/35750> (in Russ.)
- ATOR (2023). *Direct flights and Mir cards: Mongolia wants to increase Russian tourist flow*. Retrieved from <https://www.atorus.ru/node/51443?ysclid=lgxb1cjdb1615752284> (in Russ.)
- BBT (2022). *Tourism revenues in the world can reach \$8.6 trillion*. Retrieved from <https://buyingbusinesstravel.com.ru/news/mice/44368-dokhody-sfery-turizma-v-mire-mogut-dostich-8-6-trln/?ysclid=lgx9hzbww9829034529> (in Russ.)
- Central Asia Media (2023). *Asian Development Bank allocates \$32 for Mongolia's second sustainable tourism development project*. Retrieved from <https://centralasia.media/news:1739795?ysclid=lgz8b4k549728504528> (in Russ.)
- Ministry of Economic Development of the RF (2023). *National Project "Tourism and Hospitality Industry"*. Retrieved from <https://www.economy.gov.ru/?ysclid=lgxt7c2upg976743014> (in Russ.)
- Profi and Travel (2023). *Mongolia significantly increased tourist flow from Russia*. Retrieved from <https://profi.travel/news/56575/details> (in Russ.)

- World Tourism Organization (2023). *UNWTO: in a number of areas, revenues from international tourism exceeded the pre-pandemic level in 2022*. Retrieved from <https://travelvesti.ru/news/unwto-naryade-napravlenij-dokhody-ot-mezhdunarodnogo-turizma-prevysili-v-2022-godu-dopandemijnyj-uroven.html?ysclid=lgx9lhc56h545707959> (in Russ.)
- Shinkareva O., Alexeitcheva E., Kulomzina E. (2022). Socio-economic descriptors of the post-covid era in Russia. *Global economic trends – challenges and opportunities*, 2022, 33-35.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

Т.Намуун¹, Б.Гэрэлмаа^{2*}

¹Докторант, Эдийн засаг бизнес удирдлагын тэнхим, Мандах Их Сургууль

²Ахлах багш (Ph.D), Эдийн засаг бизнес удирдлагын тэнхим, Мандах Их Сургууль
t.namuun@mandakh.edu.mn¹, gerelmaa.b@mandakh.edu.mn²



Түлхүүр үг:

Хүргэлт, үйлчилгээний чанар, үнэнч хэрэглэгч, сэтгэл ханамж

Хураангуй

Орчин үеийн технологийн хурдацтай хөгжил, даяаршлын нөлөөгөөр хэрэглэгчид цахим худалдаа хийх сонирхол улам ихэсч байна. Үүнтэй зэрэгцээд цахим худалдаанд хамгийн их асуудалтай хэсэг нь хүргэлт байдаг. Монгол Улсын хүргэлтийн ер гаруй хувийг төрийн өмчит компани бүрдүүлж байгаа бөгөөд цахим худалдааны нөлөөгөөр хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ зайлиггүй шаардлагатай байна. Энэхүү судалгааны зорилго нь Монголын хүргэлтийн үйлчилгээний чанарыг судлах, үнэнч хэрэглэгчийг тогтоон барихад нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа юм. Судалгааг 2022 оны 7-р сарын 20-оос 9-р сарын 17-ы хооронд явуулсан бөгөөд 358 анкет цуглуулснаас 290-ийг SPSS 21.0 болон AMOS 26.0 статистикийн багц программыг ашиглан боловсруулалт хийв.

Энэхүү судалгааны үр дүн дараах байдалтай байна. Нэгдүгээрт, хүргэлтийн үйлчилгээний чанарын хувьсагчууд (эмпати, хүртээмжтэй байдал, гомдол шийдвэрлэлт) нь хэрэглэгчийн итгэлтэй байдалд нийцсэн бөгөөд бодит байдал хувьсагч батлаагдаагүй болно. Хоёрдугаарт, хүргэлтийн үйлчилгээний чанарын хувьсагчууд (хүртээмжтэй байдал, гомдол шийдвэрлэлт) нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцсэн бөгөөд эмпати, бодит байдлын хувьсагч батлагдаагүй. Итгэлтэй байдал нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид, итгэлтэй байдал нь үнэнч байдалд, хэрэглэгчийн сэтгэл ханамж үнэнч байдалд тус тус батлагдаж байна.

ОРШИЛ

Технологийн дэвшил ба дижитал хувьсгал нь бизнесийн өрсөлдөөнийг бий болгож хэрэглэгчийг татах гол зүйл юм (Орука, 2019). Тиймээс байнга өөрчлөгдөж байгаа зах зээлийн нөхцөлд шинэ технологи, инновациар шинэчлэж байнгын хэрэглэгчээ хадгалах

шаардлагатай. Одоогийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хэмжиж чанартай үйлчилгээ үзүүлэхгүй бол алдагдсан хэрэглэгчийн 68% нь ахин үйлчлүүлэх магадлалтай. Үнэнч хэрэглэгч нь орлогын ихэнх хэсгийг бүрдүүлдэг бөгөөд нийт үйлчлүүлэгчийн 20% нь нийт орлогын 80% орлогыг бүрдүүлдэг.

“Монгол Шуудан” ХК нь 2016 оноос төр, хувийн өмчийн оролцоотой нээлттэй компани болж менежментийн хувьд өөрчлөлтүүд хийгдэж эхэлжээ. Өнгөрсөн 2022 онд Монгол Улс төдийгүй дэлхийн улс орнуудын төр засаг, нийгэм, тээвэр логистик зэрэгт цах тахлын хүндрэл бэрхшээлүүд тулгарч, өөрчлөлт, шинэчлэлтүүд өрнөсөн байна. Өнгөрсөн онд буухиа илгээмж 7028, илгээлт 3978, бичиг захидал 7001, алга болсон 31, гаалиас аваагүй буцсан 91 нийт хүргэгдээгүй 1702 ширхэг байна. Хамтран ажиллаж буй байгууллагууд дийлэнх төрийн үйлчилгээ бөгөөд цөөхөн хувийн компанитай хамтран ажиллаж байгаа хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ харахан хүрээгүй байна. Хот доторх хүргэлт нь уламжлалт явган хүргэлт, ялгалт боловсруулалт зэрэг нь хүргэлтийн хугацаа нь b2c үйлчилгээ хөгжүүлэхэд төдийлэн нийцэхгүй байна.

Судалгааны зорилго нь хүргэлтийн үйлчилгээний чанар (бодит байдал, эмпати, хүртээмж, гомдол шийдвэрлэлт) хэрэглэгчийн итгэлтэй байдалд нөлөөлөх эсэх, (бодит байдал, эмпати, хүртээмж, гомдол шийдвэрлэлт) нь хэрэглэгчийн сэтгэл ханамжинд нөлөөлөх эсэх, итгэлтэй байдал нь үнэнч байдалд нөлөөлөх эсэх, сэтгэл ханамж нь үнэнч байдалд эерэг нөлөөтэй эсэхийг батлахыг зорив. Судалгааны ач холбогдол нь өссөн нэмэгдэж байгаа цахим худалдааны нөлөөгөөр хүргэлтийн салбарын компаниудын тоо мөн хурдацтай нэмэгдэж байна. Хүргэлтийн компаниудад үйлчилгээний чанарт аль асуудал төвлөрч ажиллах практик ач холбогдолтой.

II. ОНОЛЫН СУДЛАГДАХУУН

2.1 Хүргэлтийн үйлчилгээний чанар ба итгэлтэй байдал

Аж ахуй нэгж байгууллагууд хэрэглэгчдэд хариуцлагатай, тууштай үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. Маш сайн үйлчилгээний чанар нь хэрэглэгчдийг аз жаргалтай байнгын үйлчлүүлэгч болгоно. (Arora and Arora, 2015) Шинэ хэрэглэгчдийг авчрахаас анхаарахаас илүү үнэнч хэрэглэгчдээ төвлөрсөн бизнесийн үндсэн бодлого гаргах шаардлагатай. (Чоу ба Ким, 2009) Ваходи (2021) итгэл үнэмшил, үйлчилгээний чанар, сэтгэл ханамж үнэнч байдалд шууд нөлөөлдөг. Ратовик (2017) шуудангийн үйлчилгээний чанар нь илүү мэдрэгдэхгүй, харилцаа шаарддаг нь мөн хамгийн хүчтэй хэмжигдэхүүнүүдийн нэг юм шинж чанарын хэмжүүр, энэ нь өөрөө зөрчилддөг. Биет байдал нь хэмжүүр юм. Хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг үйлчилгээ (Парасураман нар, 1988). Вилсон (2016) хэрэглэгчдийн төсөөллийг судалсан найдвартай байдал гэх мэт засварын тодорхой харьцаа, хариуцлага, баталгаа, сэтгэл ханамж, үйлчилгээ үйлчилгээний талаарх ойлголтод нөлөөлж болох чанар. Эмпати бол анхаарал төвлөрүүлэх явдал юм.

H2-1: Хүргэлтийн үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн итгэлтэй байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

2.2 Хүргэлтийн үйлчилгээний чанар ба хэрэглэгчийн сэтгэл ханамж

Lykogiannis (2014), хүргэх хугацаа, хүргэлт давтамж, үйлчилгээний хүртээмж хэрэглэгчийн шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Делафраоз (2013) үйлчилгээний чанарын бүх хандлага байгааг харуулсан хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх. Эмпати хамгийн их биелэлтийг хангасан. Mulyono and Pasaribu (2021) нар гар утасны үйлчилгээний чанар болон хоорондын хамаарал брэндийн дүр төрх, тэдний үр дүн сайн нөлөө үзүүлсэн байдаг. Цахим үйлчилгээний чанар ба цахим хэрэглэгчийн таашаал хоёрын хоорондын хамаарал (Рахматау, 2021). Цахим үнэнч байдлын үр дүнд анхаарлаа хандуулж ба цахим үйлчилгээний чанар эерэг ба цахим хэрэглэгчийн сэтгэл ханамжид ихээхэн нөлөө үзүүлдэг.

H2-2: Хүргэлтийн үйлчилгээний чанар нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

2.3 Итгэлтэй байдал ба Хэрэглэгчийн сэтгэл ханамж

Судлаачид энэ үйлчилгээг илрүүлсэн чанар нь итгэлцэлд ихээхэн нөлөөлдөг бөгөөд итгэлцэл ч бий үнэнч байдалд үзүүлэх үр дагавар (Шин, 2020) юм. Судалгааны үр дүн нь хэрэглэгчдэд харьцангуй нөлөө үзүүлсэн биелэлт ба хэрэглэгчийн үнэнч байдал. Судлаачид итгэл үнэмшил хоорондын хамаарлыг олж тогтоосон хэрэглэгчийн зөвшөөрөл, ялангуяа хүргэлттэй холбоотой үйлчилгээ (Шин, 2020) харилцаа тогтоохыг санал болгосон байна. Үйлчилгээний тал нь мэдэгдэхүйц эерэг талтай үр дагавар нь хэрэглэгчийн хүлээлт, гэхдээ зөвхөн хоолны чанар нь үйлчлүүлэгчдэд ихээхэн нөлөөлдөг.

H2-3: Хүргэлтийн үйлчилгээний итгэлтэй байдал нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлнэ.

2.4 Хэрэглэгчийн сэтгэл ханамж ба Үнэнч байдал

Үнэнч байдал цаг хугацааны төрөл юм уу, үйлдвэрлэл гэдгийг харуулж боломжит маркетингийн хүчин чармайлтыг үл харгалзан худалдан авсан өрсөлдөгчид (Аедин, 2015). Брэнд үнэнч байдал ба брэндийн тэнцвэрт байдлын хооронд брэндийн итгэлээр төлөөлнө. Цахим сургалтын харилцаанд анхаарлаа хандуулж, Дора (2017) үнэнч байдлыг тайлбарлах загварыг боловсруулав. Үнэнч байдал нь мөн хооронд эерэг харилцаатай байдаг оюутны сэтгэл ханамж. хоорондын эерэг харилцааг тодорхойлов. Мөн оюутнуудын сэтгэл ханамж, итгэл, үнэнч байдал өмнөх талаар судалсан болно. (Latif et al., 2021)


H2-4: Хүргэлтийн хэрэглэгчийн сэтгэл ханамж нь үнэнч байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны загвар

Энэхүү судалгааны ажлын загварыг нэхүү судалгаа нь хэрэглэгчийн түүвэр судалгаа юм. Нэгдүгээрт, үйлчилгээний чанарын шинж чанаруудын хувьсагчийг өмнөх судалгаанаас (Мүүн, 2021; Эстимали, 2021; Валенсия ба Лайман, 2021; Мухарам нарбусад, 2021) боловсруулсан байна.

Зураг 1: Судалгааны загвар



IV. ҮР ДҮН

4.1 Хүн ам зүйн шинжилгээ

Судалгаанд оролцогчдын хүйсийн хувьд 77.52 хувь нь эрэгтэй, 19.80 хувь нь эмэгтэй оролцогч байв. Хүснэгт 1-ээс харахад 30-39 насны хүмүүс нийт судалгаанд оролцогчдын 43.96 хувийг бүрдүүлж байна. Боловсролын хувьд их, дээд сургууль төгссөн оролцогчид 53.02 хувийг хамарсан ба бүрэн дунд боловсрол эзэмшсэн оролцогчдын тоо 10.07 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Хүн ам зүйн шинжилгээ

Ангилал	Оролцогчдын мэдээлэл	Тоо	Хувь %
Хүйс	Эрэгтэй	231	77.52
	Эмэгтэй	59	19.80
Нас	20-29	76	25.50
	30-39	131	43.96
	40-49	62	20.80
	50-59	21	7.04
Боловсрол	Бүрэн дунд боловсрол	30	10.07
	Техник мэргэжил	11	3.69
	Их дээд сургууль	158	53.02
	Магистр болон түүнээс дээш	97	32.55
	Бусад	1	0.6
Давтамж	Өдөр бүр	23	7.72
	Долоо хоног бүр	22	7.38
	Сар бүр	55	18.46
	Улирал бүр	52	17.46
	Жилд нэг удаа	77	25.84
	Бусад	69	23.15

4.2 Найдвартай байдлын шинжилгээ

Найдвартай байдлын шинжилгээ нь хувьсагч бүрийн асуулга хоорондын уялдаа холбоог илэрхийлдэг. Найдвартай байдлын шинжилгээ нь асуултуудын бүлэг бүрийн хоорондын хамаарлыг судалдаг. Энэ хэмжилт нь Кронбах Альфа-ийн түвшин .70-аас одээш байвал зөвшөөрөгдөх бүтцийн дотоод нийцтэй нийцэж байна. Хүснэгт 2-оос харахад Кронбах Альфа коэффициентүүд санал болгож буй утгууд (.847-.955) хооронд байна. Эдгээр тоон дүгнэлтээс харахад манай объектууд нь хэмжээс бүрээрээ өндөр чанартай дотоод нягтралтай байгаа бөгөөд статистик үзүүлэлтүүд ач холбогдолтой ба шаардлагатай найдвартай байдлыг хангаж байна.

Хүснэгт II. Найдвартай байдлын шинжилгээ

Хувьсагч	Тоо	Кронбах Алфа
Биет байдал	3	.847
Эмпати	4	.954
Хүртээмж	3	.839
Гомдол шийдвэрлэлт	4	.940
Итгэлцэл	4	.897
Сэтгэл ханамж	4	.903
Үнэнч байдал	3	.955

4.3 Баталгаажуулах тест

Хэмжилтийн загварыг үнэлэхийн тулд AMOS 26.0 ашиглан ковариацийн матрицын баталгаажуулалтын хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Загварын хэрэглээг сайжруулахын тулд 0.6-тай тэнцүү буюу түүнээс бага стандарт ачааллын утга бүхий $me4$ хэмжигдэхүүнүүдийг устгасан байна. Тохиромжтой өгөгдлийн хувьд сайн таарсан загваруудын хувьд $\chi^2=169.504$ (p -утга=.005), (чөлөөний зэрэг-df)=125, (GFI)=.851($\geq .80$), (AGFI)=.851($\geq .80$), (RMR)=.042($\leq .05$).. Санал болгож буй босго нь хосолсон хүчин төгөлдөр байдал (CR) болон дисперсийн дундаж (AVE) дараа нь хосолсон хүчин төгөлдөр байдлыг шалгах үед CR-ийн хувьд 0.70, AVE-ийн хувьд 0.50-аас их байна. Шинжилгээгээр CR утга нь бүх хувьсагчийн хувьд 0.70 (0.766~0.874), AVE утга 0.5(0.589~0.849)-аас дээш гарсан байна. Иймээс шинжилгээг найдвартай, хүчинтэй байхаар тооцож байна.

Хүснэгт III. Факторын болон хүчин зүйлийн шинжилгээ

Хувьсагч	Item	Std.	S.E	t-Value	CR	AVE
Биет байдал	TA3	.882				
	TA2	.764	.060	14.130	0.846	0.648
	TA1	.765	.062	14.155		
Эмпати	EM4	.724			0.903	0.701
	EM3	.870	.095	14.758		
	EM2	.909	.099	15.438		
	EM1	.842	.096	14.276		
Хүртээмж	AC1	.693			0.819	0.604
	AC2	.865	.095	13.560		
	AC3	.856	.099	13.436		
Гомдол	CO1	.806				

шийдвэрлэлт	CO2	.933	.058	19.961	0.941	0.801
	CO3	.928	.059	19.792		
	CO4	.908	.059	19.108		
Сэтгэл ханамж	CS4	.857			0.907	0.710
	CS3	.724	.066	14.825		
	CS2	.874	.051	20.330		
	CS1	.906	.045	21.878		
Итгэлцэл	TR4	.920	.034	27.576	0.931	0.772
	TR3	.896	.036	25.430		
	TR2	.903	.038	26.013		
	TR1	.791	.051	18.878		
Үнэнч хэрэглэгч	LO3	.938			0.955	0.876
	LO2	.931	.031	30.546		
	LO1	.940	.029	31.573		

Notes: $\chi^2 = 495,687$, d.f.=328, $p=.000$, GFI=.920, AGFI=.870, RMR=0.92, RMSEA=.041

Хүснэгт IV. Хамаарлын шинжилгээ

Хувьсагч	1.	2.	3.	4.	5.	6.	7.
Биет байдал	.648						
Эмпати	.257	.701					
Хүртээмж	.268	.454	.604				
Гомдол шийдвэрлэлт	.260	.457	.379	.801			
Сэтгэл ханамж	.248	.442	.366	.496	.710		
Итгэлцэл	.238	.451	.402	.549	.462	.772	
Үнэнч	.248	.447	.388	.521	.452	.582	0.876

* $p < 0.05$, ** $p < 0.01$

Хувьсагчдын хоорондын хамааралд дүн шинжилгээ хийв. Бүх хоёр хувьсагчийн хамаарлыг харьцуулж, AVE-ийн язгуур утгыг квадрат болгосны үр дүнд корреляцийн утга нь бүх AVE-ийн квадрат язгуур утгаас бага байна. Үүнээс гадна 0.9-ээс их хамаарал бүхий хос хэмжүүр олдоогүй бөгөөд бүтцэд олон шугаман хамаарал байхгүй байгааг харуулж байна.

4.4 Таамаглал шалгах тест

Энэхүү судалгааны баримт бичигт бий болсон таамаглалыг шалгахын тулд шинжилгээ хийж үр дүнг хүснэгт 5-д үзүүлэв. Үр дүнд тохирох загваруудын хувьд: CMIN=172.799, CMIN/df=473.799, $p=.000$, GFI =.904, AGFI=.874, RMR=.87, RMSEA=.038. Индексийн дийлэнх нь суурь үзүүлэлтээс дээгүүр байгааг харуулж байна. Таамаглалын туршилтын үр дүн дараах байдалтай байна. Биет байдал нь хэрэглэгчийн итгэлцэлд нөлөөгүй (H1-1, $p=.609$). Эмпати нь хэрэглэгчийн итгэлцэлд эерэг нөлөө үзүүлсэн байна (H1-2, $p=.075$). Хүртээмжтэй байдал хэрэглэгчийн итгэлцэлд эерэг нөлөө үзүүлжээ (H1-3, $p=.000$). Гомдол шийдвэрлэлт нь хэрэглэгчийн итгэлцэлд эерэг нөлөөтэй гэж батлагдлаа (H1-4, $p=.000$). Биет байдал нь хэрэглэгчийн сэтгэл ханамжинд нөлөөгүй (H2-1, $p=.126$). Эмпати нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид сөрөг нөлөө үзүүлсэн байна (H2-2, $p=.364$). Хүртээмжтэй байдал хэрэглэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлжээ (H2-3, $p=.000$). Гомдол шийдвэрлэлт нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөөтэй гэж батлагдсан байна (H2-4, $p=.000$). Итгэлцэл нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлсэн байна (H3, $p=.000$).

Итгэлцэл нь хэрэглэгчийн үнэнч байдалд эерэг нөлөөтэй гэж батлагджээ (H4, $p=.000$). Сэтгэл ханамж нь хэрэглэгчийн үнэнч байдалд эерэг нөлөөтэй гэж батлагдсан байна (H6, $p=.066$).

Хүснэгт V. Таамаглал шалгасан үр дүн

Нур.	Path	Std. Estimate	S.E	T-value	Sig	Үр дүн
H1-1	Биет байдал → Итгэлцэл	.027	.055	.512	.609	Няцаагдсан
H1-2	Эмпати → Итгэлцэл	.170	.087	1.782	.075	Батлагдсан
H1-3	Хүртээмж → Итгэлцэл	.424	.258	3.547	.000	Батлагдсан
H1-4	Гомдол шийдвэрлэлт → Итгэлцэл	.324	.087	3.685	.000	Батлагдсан
H2-1	Биет → Сэтгэл ханамж	-.054	.038	-1.529	.126	Няцаагдсан
H2-2	Эмпати → Сэтгэл ханамж	.059	.059	.908	.364	Няцаагдсан
H2-3	Хүртээмж → Сэтгэл ханамж	.299	.200	3.270	.001	Батлагдсан
H2-4	Гомдол шийдвэрлэлт → Сэтгэл ханамж	.267	.064	4.153	.000	Батлагдсан
H3	Итгэлцэл → Сэтгэл ханамж	.425	.075	5.674	.000	Батлагдсан
H4	Итгэлцэл → Үнэнч	1.157	.151	9.228	.000	Батлагдсан
H5	Сэтгэл ханамж → Үнэнч хэрэглэгч	.217	.143	1.837	.066	Батлагдсан

Notes: $\chi^2 = 473.799$, d.f.=331, $p=.000$, GFI=.904, AGFI=.874, RMR=.87, RMSEA=.038

ҮР ДҮН

Судалгааны үр дүнгээс харахад биет байдалд хамаарах шуудангийн тохижилт, албан ёсны хувцаслалт, дотоод орчны цэвэр цэмцгэр байдал нь хэрэглэгчийн итгэл төрүүлэх, сэтгэл ханамжид нийцахгүй байна. Шуудангийн ажилчид эелдэг, найрсаг харьцаа, харилцааны сэтгэл хангалуун байдал, үйлчлүүлэгчдээ туслах, нэмэл мэдээлэл өгөх зэрэгт хэрэглэгч итгэл төрүүлэхүйц байгаа боловч сэтгэл ханамжгүй байна. Вэбсайтаас илгээмжийн байршлыг олох нь ойлгомжтой бөгөөд ойлгомжтой хялбар байдал, шуудангийн ажилтны мэргэжлийн мэдлэг, чадвар, утсаар лавлагаа асуух байдал, хайлтын систем зэрэг нь хэрэглэгчийн итгэлцэл болон сэтгэл ханамжид нийцсэн байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

Агога Н ба Агога Р (2015). Үйлчилгээний чанарын хэмжүүр: Энэтхэг дэх арилжааны банкуудын эмпирик судалгаа, SERVQUAL. Олон улсын үйлчилгээ, үйл ажиллагааны сэтгүүл, Менежмент, 21(1): 50-72.

Жиёон, С., Ро, М., Хешмати, А., Ким, С. (2020). Өмнөд Солонгос дахь суудлын автомашины түлшний хэмнэлтийн дундаж стандартын үнэлгээ. *Энержи*, 13(17), 4533.

Макдермотт, М. (1995). Өмнөд Солонгосын автомашины үйлдвэрлэлийн хөгжил, олон улсын байдал: Европын хэмжээс. *Ази Номхон далайн бизнесийн тойм*, 2(2), 23-47.

Макетт, Р.Л. (2003). Хүмүүс яагаад богино аялалд машинаа ашигладаг вэ?. *Тээврийн бодлого*, 30, 329-349.

- Буйс, Л., Миллер, Э. (2011). Тав тухтай байдлын үзэл баримтлал: Австралийн Брисбэн хотын өндөр нягтаршилтай оршин суугчдын тээврийн туршлага, ойлголт. *Тээврийн бодлого*, 18(1), 289-297.
- Жаханшахи, А.А., Гашти, М.А.Х., Мирдамади, С.А., Навасэр, К., Хаксар, С.М.С. (2011). Хэрэглэгчийн үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үнэнч байдалд хэрхэн нөлөөлж байгааг судлах нь. *Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны олон улсын сэтгүүл*, 1(7), 253-260.
- Жажае, S. M., & Ahmad, F. B. S. (2012). Австралийн автомашины даатгалын салбарын үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хоорондын хамаарлыг үнэлэх судалгаа. *Олон улсын эдийн засаг, бизнесийн инноваци бага хурал* (Боть 38, №1, 219-223 хуудас).
- Ли, Б.С. (2002), “Солонгос, Америк, Японы хэрэглэгчдийн талаарх эмпирик судалгаа– Сонголт, Жижиг ба дунд оврын тээврийн хэрэгсэл, *Олон улсын худалдааны сэтгүүл*, 27(2), 289-306
- Ким, В.С. (2013), “ Хятад дахь Hyundai компанийн хэрэглэгчийн судалгаа,” *Бизнесийн судалгаа*, 11(4), 147-164.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

БАНКНЫ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ХАРИЛЦАХ БАНКАА СОЛИХ ЗАН ТӨЛӨВИЙН СУДАЛГАА

Б.Ганишагай¹, Б.Амарсанаа²

¹ СЭЗИС-ийн ахлах багш, МВА

² Доктор (Ph.D) СЭЗИС-ийн дэд профессор



Түлхүүр үг:

иргэдийн банкны үйлчилгээ, хэрэглэгчийн солих зан төлөв, солих зардал, нэр хүнд, үнэ, үйлчилгээний чанар

Хураангуй

2021 оны байдлаар нийт 11 арилжааны банк үйл ажиллагаагаа явуулж байгаагаас төрийн өмчийн /Төрийн банк/ нэг банк байна. Эдгээр банкны 1500 салбар, нэгжээр дамжуулан Монгол Улсын бүх аймаг, хот, сум, суурин газруудад үйлчилж, тэдгээрт 13,564 ажиллагсад ажиллаж, манай улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд банкны үйлчилгээг хүргэж байна. Банкны салбарын зохицуулалтай нээлттэй компани байгуулахтай холбоотойгоор санхүүгийн зах зээлд шинэ хөрөнгө оруулагчид орж ирж байгаа нь энэ салбарын өрсөлдөөн орон зай нэлээн өргөжин тэлж байна. Үр дүнд нь, одоогийн үйлчлүүлэгчид илүү олон сонголттой болсон энэ нь үйлчлүүлэгч шилжихэд илт нөлөөлөж байна. Тиймээс банкууд эдгээр хүлээлтийг хангаж чадахгүй, эсвэл үйлчилгээгээ өргөн хүрээнд санал болгож чадахгүй нь улмаас үйлчлүүлэгчид хэрэгцээ, хүсэлээ хангах боломжтой хувилбаруудыг хайж байдаг. Тус салбар дахь харилцагчийн солих хүчин зүйлийг судлан ойлгох хэрэгцээ шаардлага үүсэж байна. Хэрэв солих асуудлыг үр дүнтэй ойлгож, удирдаж чадахгүй бол ихэнх банк зах зээлд эзлэх хувиа өрсөлдөгчдөө алдах эрсдэлтэй. Энэхүү судалгаа нь яагаад чухал болохыг энэхүү судалгаагаар тайлбарлах болно.

Судалгааны дизайн ба арга аргачлал. Банкаа үйлчлүүлэх солих зан төлөвийг судлах онолын загварыг судлан, банкны үйлчлүүлэгчээс асуулгын судалгааны аргыг ашиглан, биечилсэн хэлбэрээр дөхөмтэй түүврээс өгөгдөл цуглуулав. Цуглуулсан өгөгдлийг SPSS Statistics 23.0 программ дээр шинжилгээ хийж, төв хандлагын статистикийг тооцож, шкал хэмжигдэхүүнүүдийн найдвартай байдлыг Кронбахын альфа (Cronbach's alpha) коэффициентээр шалгалаа. Хүчин зүйлийн шинжилгээ (Factor analysis) шинжилгээг хийсэн болно.

Судалгааны хязгаарлалт. Нэгдүгээрт, бидний боловсруулсан судалгааны дизайн нь зөвхөн бидний түүвэрлэн судалсан судалгааны хоёрдогч эх үүсвэр дээр тулгуурласан тул хязгаарлагдмал байх талтай. Хоёрдугаарт, Монгол Улсын хэмжээнд бус зөвхөн Улаанбаатар хотын хэмжээнд дөхөмтэй түүврийн аргаар өгөгдөл цуглуулсан тул дараа дараагийн судлаачид судалгааны цар хүрээ болон түүврийн тоог нэмэгдүүлэх талаар анхаарах хэрэгтэй юм.

Судалгааны практик ач холбогдол. Хөгжиж буй орнуудын иргэдийн банкны харилцагчид банкаа солих зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийн тухай эмпирик судалгаа хязгаарлагдмал судалсан байдаг. Тиймээс, Монголын иргэдийн банкны салбар дахь банкаа солих үйл явц нэмэгдэж, хөгжиж буй эдийн засагт энэ нь хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгааг илүү гүнзгий ойлгох шаардлага үүссэн байна. Тиймээс энэхүү судалгаа нь банкны харилцагчийн солих зан зан төлөвийн талаарх судалгаа хийж, иргэдийн банкны салбарт яагаад үйлчлүүлэгчид банкаа сольж байгааг тайлбарлах болно. Мөн судалгаа нь Монголын хөгжиж буй эдийн засагт байгаа иргэдийн банкны салбарын одоогийн дүр төрх, үзэгдлийн талаар илүү гүнзгий ойлголттой болох боломжийг олгох мэдлэгт хувь нэмэр оруулж байна.

ОРШИЛ

Ирээдүйн ашгийг бий болгох зорилгоор аль ч компанийн хувьд хэрэглэгчдийг үнэнч болон солих зан төлөвтэй гэж хоёр хуваан авч үздэг. Хэрэглэгчийн солих үйлдэл нь хэрэглэгчийг алдаж, ирээдүйд бизнест сөрөг нөлөөлдөг бол үнэнч байдал нь бизнесийг үйл ажиллагааг тогтвортой байдлыг бий болгодог (Zeithaml, et al, 1996). Солих зан зан төлөв гэдэг нь хэрэглэгч биш болох шийдвэрээр тодорхойлдог гэж тайлбарласан байна. (Stewart, 1994) Солих зан төлөвийн санаачилга нь үйлчилгээгээ худалдан авахыг зогсоох буюу худалдан авагчийг тодорхой үйлчилгээгээ зогсоох шийдвэр гаргах үйл явц юм. (Bolton and Bronkhurst 1995). Банкны салбард, үйлчлүүлэгч солих /шилжих/ үйл ажиллагаа гэдэг нь үйлчлүүлэгчид нэг банкнаас шилжихийг хэлнэ. Энэ нь үйлчлүүлэгч өөрийн үйлчилгээг авахын тулд бусад банкныг сонгоно гэсэн ойлголт юм. (Garland 2002)

1990 онд улс төр, нийгэм, эдийн засагт шинэчлэл хийгдэж, 1990 онд "Аж ахуйн банк байгуулах болон түүний үйл ажиллагааны нийтлэг дүрэм", 1991 онд "Банкны тухай хууль" батлагдсанаар Монгол Улсад 2 шатлалт банкны тогтолцооны хөрс суурь тавигдаж, анхны Арилжааны банкууд үүссэн байдаг. Банкны 2 шатлалтай тогтолцоонд шилжсэнээс хойш өдгөөг хүртэл арилжааны 31 банк байгуулагдаж, үйл ажиллагаа явуулснаас 20 банк нь өөрийн үйл ажиллагааны алдаа, эндэгдлээс шалтгаалан санхүү, төлбөрийн чадваргүй болон дампуурч, дүрмийн санг тогтоосон хэмжээнд хүргээгүй, бусад банктай нэгдэх, татан буугдах зэргээр үйл ажиллагаагаа зогсоож, Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Санхүүгийн салбарын тойм:

Монгол Улсын санхүүгийн салбарт 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 банк, 534 банк бус санхүүгийн байгууллага, 209 хадгаламж зээлийн хоршоо, 17 даатгалын компани, 57 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 25 компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж

буй боловч нийт санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлсэн хэвээр байгаа юм. Банкны салбар тайлант оны эцсийн байдлаар нийт 11 банк, 15,958 ажилтан, 1,393 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.0 сая, нийт зээлдэгчдийн тоо 946.4 мянгад хүрлээ. Банкны системийн нийт актив 2021 онд өмнөх оноос 4.5 их наяд төгрөгийн буюу 12.5 хувийн өсөлт үзүүлж, 40.8 их наяд төгрөгт хүрлээ.

Банкны салбарын нийт орлого 4.7 их наяд төгрөгт хүрсний 69.1 хувийг хүүгийн орлого, 29.0 хувийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Хүүгийн орлогын 71.3 хувийг зээлийн хүүгийн орлого, 23.6 хувийг үнэт цаасны хүүгийн орлого, үлдэх 5.1 хувийг харилцах, хадгаламжид төлөгдсөн хүүгийн орлого бүрдүүлж байна. Харин нийт зардал тайлант онд 4.3 их наяд төгрөгт хүрсний 41.3 хувийг хүүгийн, 54.5 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн зардлын 73.8 хувийг харилцах, хадгаламжийн хүүгийн зардал, 18.2 хувийг зээл, үнэт цаасны хүүгийн зардал, 8.0 хувийг бусад хүүгийн зардал бүрдүүлж байна. 2021 онд банкны салбарын ашиг 371.6 тэрбум төгрөг, активын өгөөж 1.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 9.6 хувьд хүрлээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Үйлчлүүлэгчийн солих зан төлөвийн судалгаа нь шинэ ойлголт биш юм бөгөөд харилцааны маркетингийн хөгжлийн явцад хэрэглэгчийн үнэнч байдал, эсрэг ойлголт нь солих зан төлөвийн ойлголтын хөгжүүлэлт сүүлийн үед хурдастай хөгжиж байна. Хөгжиж буй эдийн засагтай улс оронүүдын хувьд харилцагчийн зан төлөвийн бүхий л өөрчлөлтийг сайтар шийдэж чадаагүй байгаа нь одоогийн асуудал болж байгаа юм. Энэ асуудал нь иргэдийн банкны үйл ажиллагаанд ч нөлөөлдөг. Тиймээс энэхүү судалгаа нь эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилготой юм.

Nasrut Sharmin (2017), Dongmei Zhang (2009) загварыг ашиглан сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд хэрэглэгчийн үйлчилгээгээ солих зан төлөвийг ойлгох, олон эрдэмтэд үүнийг янз бүрийн үйлчилгээний салбарт үйлчлүүлэгч солих зан төлөвийн судалгаанд ашигласан байдаг. Монгол хувьд иргэдийн банкны салбарт солих зан төлөвийн судалгаа одоогоор ашиглаагүй байна.

Үнэ бол чухал. Үнэнч байдал болон солих зан төлөвийн хувьд арилжаа хийх үнийн тухай ойлгоц нь өөрчлөгдөж болно (Varki & Colgate, 2001). Аливаа үнийн өсөлт нь шударга бус гэж тооцогддог үйлчлүүлэгч нь солих үйл ажиллагаанд хүргэж болзошгүй (Campbell, 1999). Банкны салбарт үнэ нь үйлчилгээний алдаа, таагүй байдал зэргээс хамааран хэрэглэгчид үйлчилгээг харьцуулах чухал хэрэгсэл болдог (Gerrard & Cunningham (2004).

Нэр хүнд. Санхүүгийн үйлчилгээний салбарт эерэг нэр хүнд нь үйлчлүүлэгчдийн итгэлийг нэмэгдүүлдэн хэрэглэгчдийг илүү сайн бүтэгдэхүүнийг ойлгох боломжийг олгодог (Berry, 2000). Нэр хүнд нь компаниудын хувьд үнэ цэнтэй хөрөнгө болж байдаг, ялгарах гол хэрэгсэл болдог, хуулбарлан дуурайхад хүндрэлтэй, өрсөлдөөний тогтвортой давуу талыг бий болгодог (Wang et al., 2003). Сайн нэр хүнд нь банканд итгэх хэрэглэгчийн итгэлийг нэмж, банкны найдвартай байгаа харуулдаг бол, нэр хүндгүй байдал нь хэрэглэгчдийн магадгүй банкаа солих шийдвэр хүргэдэг Yue & Tom (1995).

Үйлчилгээний чанар. Үйлчилгээний чанарыг хэрэглэгчийн хүлээлт, үйлчилгээний талаархи ойлголтын зөрүүгээр чанарыг тодорхойлно (Gronroos, 1984). Үйлчилгээний чанар илүү өндөр стандарт байх тусам хэрэглэгчдийг хүлээлтээс илүүтэйгээр сэтгэл хангалуун болгож байдаг бөгөөд банкны зүгээс хэрэглэгчийг татах нэгэн хэрэгсэл байж чаддаг Lewis & Soureli (2006). Адилхан чанартай боловч харьцангуй хямд үнээр авдаг бүтээгдэхүүн нь хэрэглэгчдэдээ илүү өндөр үнэ цэнийг өгөх болно. Хэрэв үйлчлүүлэгч сэтгэл хангалуун байвал буцаж ирэх боломжийг өгнө. Сэтгэл хангалуун үйлчлүүлэгчид нь бусад хүмүүст зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар сайн лавлагаа өгөх боломжтой байдаг. Сэтгэл дундуур байгаа үйлчлүүлэгчдийн хувьд тийм биш юм. Сэтгэл дундуур байгаа үйлчлүүлэгчид бүтээгдэхүүнийг буцааж авах арга хэмжээ авах, эсвэл өмгөөлөгчөөр дамжуулан компаний эсрэг шүүхэд хандаж болно.

Зар сурталчилгааны өрсөлдөөний үр дүнтэй байдал. Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс зар сурталчилгааг харилцааны хэрэгслийг ашиглах нь хэвээр байна гэж нэлээн маргаантай асуудал болж байна (Barchard, 1990). Гэсэн хэдий ч өмнөх судалгааны үр дүн нь үр ашигтай зар сурталчилгаанд үндэслэсэн үйлчлүүлэгчдийн анхаарлыг татаж, харилцагчдынхаа үнэнч байдлыг дээшлүүлж чадна (Hite & Fraster, 1988). Үр ашигтай зар сурталчилгаа нь банкны харилцагчийн үнэнч байх, харилцагчдыг хадгалахад туслаж чаддаг (Cengiz et al, 2007).

Өөрийн мэдэлгүй солих. Харилцагч, бизнес эрхлэгчдэд хянах боломжгүй хүчин зүйлс нь (тухайлбал, өвчитэй болох, байшингийн байршил өөрчлөгдөх, ажлын байр солих, салбараа хаах гэх мэт) солих шаардалга бий болсон байдаг үүнийг сайн дураар солих гэж нэрлэдэг (Barchard, 1990). Үйлчилгээ үзүүлэгчид нь ойролцоогоор 6% нь сайн дураа буюу зайлшгүй шалтгааны улмаас солисон байдаг. Хэдийгээр төгс үйлчилгээ, хэрэглэгчийн шаардлагыг бүрэн хангасан үйлчилгээ санал болгосон ч компаниуд үйлчилүүлэгчээ алдаж байдаг (Keaveney 1995).


Зай. Зай нь хэрэглэгч банкаа сонгох чиглүүлэгч чухал хүчин зүйл юм. Банкууд хязгаарлагдмал газарзүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байдаг нь өрхийн амьдарч буй байршилд хүрч чаддаггүй (Kiser 2002). Байршил нь санхүүгийн үйлчилгээний салбарт онцгой утга учиртай байдаг. Энэ нь үйлчлүүлэгчид данстай байна гэдэг харилцагчийн холбогдсон салбар, эсвэл оффис байна гэсэн үг (Peppard, 2000). Тав тухтай байдал нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж байдаг (Levesque and McDougall 1996) байна.

Солих зардал. Солих зардал нь өндөр байвал сэтгэл дундуур үйлчлүүлэгчид үлдэж болно. Өөр үйлчилгээ солих үед хөрөнгө, цаг хугацаа, мөнгө шилжихэд саад болж байна (Gronhaug & Gilly, 1991). Солих 3 төрлийн зардал байдаг. Бүрдүүлэлтийн зардал нь зарцуулсан цаг хугацаа, хүчин чармайлт, эдийн засгийн эрсдэл, үнэлгээ, суралцах, бий болгосон зардлаас бүрдэнэ. Санхүүгийн зардал нь санхүүгийн алдагдлын зардал ба үр ашиг. Оролцооны зардал нь сэтгэл зүйн, эсвэл сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг алдах эсвэл таагүй байдал (Lee et al. 2001) юм.

Судалгааны арга зүй

Бид, онолын хүрээнд хийсэн судалгаа дээрээ үндэслэн үйлчлүүлэгчдийн банк солих зан төлөвийг тодорхойлох судалгаа нь Nasrut Sharmin (2017), Dongmei Zhang (2009) судалгааны загварыг хөгжүүлэн судалгааны загвараа боловсруулав.

Зураг 1. Судалгааны загвар



Эх сурвалж: судлаачдын тодорхойлсон

Дээрх загварын хүрээнд доорх 7 таамаглалыг дэвшүүлж, шалгасан. Үүнд:

- H1:** Тааламжгүй үнийн тухай ойлгоц нь банкаа солих үйл явцад нь эерэг хамааралтай байна.
- H2:** Нэр хүндгүй банк байх нь банкаа солих үйл явцад нь эерэг хамааралтай байна.
- H3:** Үйлчилгээний чанар сайн байх нь банкаа солих үйл явцад сөрөг харилцаа байдаг.
- H4:** Зар сурталчилгааны өрсөлдөөний үр дүнгүй байдал нь банкаа солих үйл явц нь сөрөг харилцаатай байдаг.
- H5:** Өөрийн мэдэлгүй солих нь банкаа солих үйл явцад нөлөөлдөг.
- H6:** Зайны талаархи ойлгоц, банкаа солих үйл явц нь хоёрын хоорондоо сөрөг харилцаа байдаг.
- H7:** Солих зардал өндөр байх банкаа солих үйл явцад сөрөг нөлөөлдөг.

Судалгааны анкет нь банкаар үйлчлүүлэгчдийн банк солих зан төлөвийг тодорхойлох судалгаа нь Nasrut Sharmin (2017), Dongmei Zhang (2009) банкны солих зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах 38 шкал асуулт болон хувийн мэдээллийн 7 асуултаас тус тус бүрдэж байна.

Туршилтын тест /pilot test/. Дээр дурдсан асуултууд бүхий анкетыг найруулга зүйн хувьд, монгол хэл рүү үндсэн санаагаа хэр оновчтой хадгалж хөрвүүлэгдсэн болон худалдан авагчийн зан төлөвийг тодорхойлох асуултуудын хариулуудын сонголт хэр оновчтой бүтэцлэгдсэн зэргийг шалгах зорилгоор СЭЗИС-ийн эчнээ хөтөлбөрийн (n=30) оюутнуудыг хамруулан шалгав. Туршилтын тестийг хийж байх явцад судалгаанд хамрагдагсдаас

ойлгохгүй асуулт байгаа эсэх, ойлгоход бэрхшээлтэй асуултыг хэрхэн засварлавал илүү тохиромжтой байх зэргийг тодруулж байв. Мөн статистик үр дүнг гаргаж, олон сонголтот асуултуудын хариултуудын байрыг солих өөрчлөлт орууллаа.

Өгөгдөл цуглуулсан үйл явц. Судалгааны нийт өгөгдлийг биечилсэн хэлбэрээр цуглууллаа. Судалгааны түүврийг бүрдүүлэхдээ дөхөмтэй түүврийн аргыг ашиглан, өнгөрсөн 3 жилийн хугацаанд ядаж 1 удаа банкаа сольсон, шалгуурыг зэрэг хангах зорилтот бүлгээс бүрдүүлсэн болно. Өгөгдөл цуглуулах ажилд СЭЗИС-ийн бизнесийн болон маркетингийн менежментийн мэргэжлийн 3, 4-р курсийн 30 орчим оюутан 30 хоногийн турш ажиллалаа.

Шинжилгээ. Судалгааны өгөгдлийг SPSS Statistics 23.0 программд оруулж, холбогдох шинжилгээнүүдийг хийв. Хамгийн түрүүнд судалгаанд хамрагдагсдын хувийн мэдээллийг ашиглан, банкаар үйлчлүүлэгчдийн ерөнхий мэдээлэл /generic profile/-г тодорхойлсон. Дараа нь үйлчлүүлэх авах зан төлөвийг тодорхойлох асуултуудын давтамж, төв хандлагын статистикуудыг гаргасан.

Мөн дэвшүүлсэн загварын хүрээнд банкаа солих үйлчлүүлэх зан төлөвт нөлөөлөх 7 хүчин зүйлийг илэрхийлэх 38 хувьсагчдын найдвартай байдлыг Кронбахын альфа (Cronbach's alpha) коэффициентээр шалгасан. Ингэхэд үнийн хувьд PR (0.775), нэр хүнд RP (0.839), үйлчилгээний чанар SQ (0.838), Зар сурталчилгааны өрсөлдөөний үр дүнгүй байдал EAC (0.624), өөрийн мэдэлгүй солих IC(0.795), зай D (0.720), солих зардал SC (0.832) тус тус гарсан нь шкал хэмжигдэхүүнийг хүчин зүйлийн шинжилгээнд ашиглах бүрэн боломжтойг харуулсан.

Үүний дараа дээрх 25 хувьсагчдыг ашиглан хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Kaiser Meyer Olkin – КМО коэффициент нь 0.910, Principal Component шинжилгээний хэлбэрээр вариаци нь хамгийн их байх (varimax rotation) сонголт сонгон, Eigenvalue утга нь 1-с дээш байхаар хүчин зүйлийн шинжилгээг хийсэн.

Судалгааны үр дүн

Судалгаанд хамрагдагсдын мэдээлэл. Бид нийтдээ 450 хүнийг хамруулан судалгааны өгөгдлөө цуглуулж, чанарын шаардлага хангахуйц 392 хүний өгөгдлийг шинжилгээний хэсэгтээ ашиглалаа. Нийт судалгаанд хамрагдагсдын 58% нь эмэгтэй, 42% нь эрэгтэй байсан. Насны хувьд 20 хүртэлх насны залуучууд 14%, 21-25 насныхан 28.8%, 26-30 насныхан 23.3%, 31-40 насныхан 16.4%, 41-50 насныхан 11.6%, 51-60 насныхан 5.5%, үлдсэн 0.3% нь 61 болон түүнээс дээш насныхан байсан байна.

Ажил эрхлэлтийн хувьд 22.6% нь бизнесийн байгууллагад, 18.2% нь хувиараа бизнес эрхэлдэг, 13.4% нь төрийн албанд, 11.3% нь төрийн бус байгууллагад, үлдсэн 34.6 орчим хувь нь оюутан болон бусад төрлийн ажил эрхлэлтийн статустай хүмүүс байсан.

Өрхийн сарын дундаж орлогын хувьд авч үзвэл 10.3% нь 0.5 сая төгрөг хүртэл, 19.2% нь 0.5-1.5 сая төгрөг, 39.4% нь 1.5-2.5 сая төгрөг, 17.5% нь 2.5-3.5 сая төгрөг үлдсэн 13.7 орчим хувь нь 3.5-с дээш сая төгрөгний өрхийн сарын дундаж орлоготой Улаанбаатар хотын иргэд байсан байна.

Ам бүлийн тооны хувьд ганц бие 12.3%, 2-3 ам бүлтэй 36%, 4-5 ам бүлтэй 44.2%, 6-7 ам бүлтэй 6.8% 8 болон түүнээс олон ам бүлийн гишүүдтэй судалгаанд хамрагдагсад 0.9 орчим хувийг тус тус эзэлсэн. Оршин суугаа дүүргийг мөн тодруулсан бөгөөд нийт түүврийн 39% нь БЗД, 22.3% нь БГД, 13% нь ХУД, 8.2% нь СБД, 3.8% нь ЧД, үлдсэн 9.2 орчим хувь нь СХД дүүргээс тус тус хамрагджээ.

Банкаар үйлчлүүлэх зан төлөв. Судалгаанд хамрагдагсдын 32,8% нь Хаан банкинд, 19,9% нь Голомт банкинд, 16,1% нь Худалдаа хөгжлийн банкинд, 19,6 хувь нь Хас банкинд, 8,7% нь Төрийн банкинд, үлдсэн 2,9 хувь нь бусад банкинд хадгаламжтай байна. Харин харилцах дансны хувьд 43,1% нь Хаан банкинд, 19,4% нь Голомт банкинд, 13,7% нь Худалдаа хөгжлийн банкинд, 9,6% нь Төрийн банкинд, 11,5% нь Хас банкинд, үлдсэн 2,7 хувь нь бусад банкинд харилцах данстай байна.

Судалгаанд хамрагдагсад банкаар биечилж үйлчлүүлдэг хүмүүсийн 33,8% нь орлого, зарлагын гүйлгээ хийх, 26,6% нь төлбөр төлөх, 21,2% нь данснаас бэлэн мөнгө авах, 7,4% нь гадаад гүйлгээ хийх, 3,1 % нь валют солиулах зэрэг үйлчилгээг авдаг байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь буюу 41,1 орчим хувь мобайл банк ашигладаг бол 34,9% нь интернэт банк хэрэглэдэг, 14,4% нь АТМ машин ашигладаг, 8,9 хувь нь банкинд очиж үйлчилгээ хийдэг байна.

Банкаа солих зан төлөв. Та сүүлийн 3 жилийн хугацаанд үйлчлүүлдэг банкаа сольсон уу? гэсэн асуултанд 51% тийм буюу сольсон харин 49% үгүй буюу одоо үйлчлүүлдэг банкаараа л үйлчлүүлж байгаа гэж хариулсан байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 30,2% нь үйлчлүүлж байсан банкаа би өөрийн хүслээрээ сольсон, 13,5% нь үйлчлүүлж байсан банкны үйлчилгээ нь хоцрогдмол, бусад банкууд шинэ үйлчилгээ нэвтрүүлсэн учир сольсон, 12,7% нь манай байгууллага өөр банктай харилцаж, дансаа байрлуулах болсон тул сольсон, 12,3 хувь нь үйлчлүүлж байсан банкны үйлчилгээний чанар буурсан тул сольсон, 12,3 хувь нь үйлчлүүлж байсан банкны байршил нь очиж үйлчлүүлэхэд хол, төвөгтэй байсан учир сольсон, 6,3% нь үйлчлүүлж байсан банкны нэр хүнд буурсан, 6% нь үйлчлүүлж байсан банкны хадгаламжийн хүү буурсан, 6,7% нь бусад шалтгааны улмаас банкаа сольсон гэж хариулжээ.

Харилцах банкаа солих зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ.


Банкаа солих зан төлөвт нөлөөлөх 7 хүчин зүйлийг олон хүчин зүйлийн шинжилгээ хийж үр дүнг гаргасан.

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Rotated Component Matrix ¹							
	Component						
	1	2	3	4	5	6	7
SQ3_ Миний үйлчлүүлдэг банк олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг.	.720						
SQ4_ Миний банкаар үйлчлүүлэх хэрэгцээг одоогийн банк маань бүрэн хангадаг.	.716						
SQ1_ Миний үйлчлүүлдэг банкны ажилтнууд эелдэг харилддаг.	.696						
SQ2_ Миний үйлчлүүлдэг банкны ажилтнууд мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлдэг.	.694						
SQ5_ Би үйлчлүүлдэг банкныхаа өгдөг зөвлөгөөнд сэтгэл ханамжтай байдаг.	.645						
RP1_ Миний үйлчлүүлдэг банкны онлайн систем найдвартай.		.730					
RP2_ Би үйлчлүүлдэг банкиндаа бүрэн итгэдэг.		.709					
RP4_ Миний дансыг банк оновчтой удирддаг.		.706					
RP3_ Миний үйлчлүүлдэг банк санхүүгийн хувьд тогтвортой.		.685					
RP5_ Миний үйлчлүүлдэг банк амласан үйлчилгээгээ үзүүлдэг.		0.631					
SC4_ Банкаа солиход харилцагчийн анкет бөглөхөд маш их хугацаа зарцуулах хэрэгтэй болно.			.819				
SC3_ Банкаа сольсон тохиолдолд тус банкны бодлогод дасах гэж их цаг зарцуулах хэрэгтэй болно.			.814				
SC2_ Банкаа солиход маш их зардал гарах хэрэгтэй болно.			.784				
SC1_ Банкаа солиход маш их цаг зарцуулах хэрэгтэй болно.			.701				
SC5_ Надад банкаа сольсноор ямар нэгэн нэмэлт үр ашиг хүртэнэ гэж бодогдохгүй байна.			.664				
EAC3_ Өрсөлдөгч банкны картны дизайн нь намайг банкаа солиход нөлөөлдөггүй.				.800			
EAC4_ Өрсөлдөгч банкны идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүд нь миний банкаа солих шийдвэрт нөлөөлдөггүй.				.775			
EAC2_ Өрсөлдөгч банкны гадаах самбарын сурталчилгаа нь намайг банкаа солиход нөлөөлдөггүй.				.759			
EAC1_ Өрсөлдөгч банкны зар сурталчилгаа нь намайг банкаа солиход нөлөөлдөггүй.				.639			
D2_ Миний үйлчлүүлдэг банкны салбар манай ажлын газартай ойрхон байдаг.					.748		
D3_ Миний үйлчлүүлдэг банкны салбар бизнес төв болон худалдааны төвтэй ойрхон байдаг.					.747		
D1_ Миний үйлчлүүлдэг банкны салбар манай гэртээ ойрхон байдаг.					.724		
IS1_ Миний үйлчлүүлдэг банкны салбарууд нь хүртээмж сайтай, энд тэнд байрласан байдаг.						0.721	
IS3_ Би цалингаа одоо үйлчлүүлдэг банкны дансаар авдаг тул тус банкыг солихгүй.						0.689	
IS2_ Би үйлчлүүлдэг банкныхаа салбараас өөр гийшээ явдаггүй.						0.632	
PR2_ Миний үйлчлүүлдэг банк зээлийн хүү багатай.							.833
PR3_ Миний үйлчлүүлдэг банк орон сууцны зээлийн хүү багатай.							.804
PR1_ Миний үйлчлүүлдэг банк бага хураамж авдаг.							.780
PR4_ Миний үйлчлүүлдэг банк хадгаламжийн хүү өндөртэй.							.533

Банк тус бүрээр нь харьцуулж солих зураглал гаргасныг Зураг 2-г харуулав.


Зураг 2. Банк тус бүрийн шилжсэн хүмүүсийн хувь, бусад банкнаас шилжин ирсэн хувь



Дээрх графикуудаас банк1 нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 25,15 %, харин бусад банкнаас шилжин ирсэн 25,15 %, банк2 нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 19,8%, харин бусад банкнаас шилжин ирсэн 20,74 %, банк3 нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 24,97%, харин бусад банкнаас шилжин ирсэн 19,04 %, банк4 нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 25%, харин бусад банкнаас шилжин ирсэн 28,02 %, банк5 нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 22,15%, харин бусад банкнаас шилжин ирсэн 38,84 % тус тус сольсон байна. Банкны дундаж нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 23,41%, харин бусад банкнаас шилжин ирсэн 23,33 % бол нийт сольсон 46,74 % байна.

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд суурилан 7 хүчин зүйл нь солих зан төлөв хэрхэн нөлөөлдөг гэдгийг 95 хувийн итгэх магадлалын түвшинд, Пийрсоны корреляцийн (Pearson correlation) коэффициент ашиглан тодорхойлж, Зураг 3-т засварлагдсан судалгааны загварыг харууллаа.

Зураг 3. Судалгааны загвар



Банкны үйлчилгээний чанар муудах үед SQ (0.70) солих зан төлөвт эерэг хамааралтай, өөрийн мэдэлгүй солих IC(0.70) солих зан төлөвт эерэг хүчтэй хамааралтай тус бүр байна. Харин солих зардал SC (0.43), үнийн хувьд PR (0.48) солих зан төлөвт сул хамааралтай байна. Харин нэр хүнд RP (0.48), зар сурталчилгааны өрсөлдөөний үр дүнгүй байдал EAC (0.56), зай D (0.63) солих зан төлөвтэй тус бүр эерэг хамааралтай байдаг гэсэн үр дүн гарлаа.

Дээрх үр дүндээ суурилан судлаач бидний дэвшүүлсэн таамаглалуудын биелэлт дараах байдал байна гэж үзлээ.

Таамаглалууд	Биелэлт	
	Нотлогдсон	Няцаагдсан
H1: үнэ => солих зан төлөв	+	
H2: нэр хүнд => солих зан төлөв	+	
H3: үйлчилгээний чанар => солих зан төлөв	+	
H4: Зар сурталчилгааны үр дүн => солих зан төлөв	+	
H5: өөрийн мэдэлгүй солих=> солих зан төлөв	+	
H6: зай => солих зан төлөв	+	

ДҮГНЭЛТ

Бид банкаа үйлчлүүлэгчдийн солих зан төлөвийг судлаж, судалгааны үр дүндээ суурилан дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Судалгаанд хамрагдагсад банкаар биечилж үйлчлүүлдэг хүмүүсийн 33,8% нь орлого, зарлагын гүйлгээ хийх, 26,6% нь төлбөр төлөх, 21,2% нь данснаас бэлэн мөнгө авах, 7,4% нь гадаад гүйлгээ хийх, 3,1 % нь валют солиулах зэрэг үйлчилгээг авдаг байна. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь буюу 41,1 орчим хувь мобайл банк ашигладаг бол 34,9% нь интернэт банк хэрэглэдэг, 14,4% нь АТМ машин ашигладаг, 8,9 хувь нь банкинд очиж үйлчилгээ хийдэг байна.
- Та сүүлийн 3 жилийн хугацаанд үйлчлүүлдэг банкаа сольсон уу? гэсэн асуултанд 51% тийм буюу сольсон харин 49% үгүй буюу одоо үйлчлүүлдэг банкаараа л үйлчлүүлж байгаа гэж хариулсан байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 30,2% нь үйлчлүүлж байсан банкаа би өөрийн хүслээрээ сольсон, 13,5% нь үйлчлүүлж байсан банкны үйлчилгээ нь хоцрогдмол, бусад банкууд шинэ үйлчилгээ нэвтрүүлсэн учир сольсон, 12,7% нь манай байгууллага өөр банктай харилцаж, дансаа байрлуулах болсон тул сольсон, 12,3 хувь нь үйлчлүүлж байсан банкны үйлчилгээний чанар буурсан тул сольсон, 12,3 хувь нь үйлчлүүлж байсан банкны байршил нь очиж үйлчлүүлэхэд хол, төвөгтэй байсан учир сольсон, 6,3% нь үйлчлүүлж байсан банкны нэр хүнд буурсан, 6% нь үйлчлүүлж байсан банкны хадгаламжийн хүү буурсан, 6,7% нь бусад шалтгааны улмаас банкаа сольсон гэж хариулжээ.
- Банкны дундаж нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 23,41%, харин бусад банкнаас шилжин ирсэн 23,33 % бол нийт сольсон 46,74 % байна. Энэ 2021 тайлант жилд банкны салбарын ашиг 371.6 тэрбум төгрөг буюу 46,74 хувь болох 173.7 тэрбум төгрөг эсрдэлтэй байгаа нь солих зан төлөвийг судлах үндэслэл болж байна.
- Банкны үйлчилгээний чанар муудах үед SQ (0.70), өөрийн мэдэлгүй солих IC (0.70) солих зан төлөвт эерэг хүчтэй хамааралтай тус бүр байна.
- Харин солих зардал SC (0.43), үнийн хувьд PR (0.48) солих зан төлөвт сул хамааралтай байна.
- Нэр хүнд RP (0.48), зар сурталчилгааны өрсөлдөөний үр дүнгүй байдал EAC (0.56), зай D (0.63) солих зан төлөвтэй тус бүр эерэг хамааралтай байдаг гэсэн үр дүн гарлаа.

Эдгээр дүгнэлтүүд дээрээ суурилан бид дараах зөвлөмжийг боловсрууллаа.

ЗӨВЛӨМЖ

Нийт банкуудын хувьд:

1. Банкны дундаж нь тус банк шилжсэн хүмүүсийн хувь нь дундаж 23,41% зах зээлээ хамгаалах стратеги буюу өөрийн банкны сул талаа засаж сайжируулах.
2. Харин бусад банкнаас шилжин ирсэн 23,33 % буюу өрсөдөлгчийн хувийг булаах стратеги чиглүүлж үр өгөөжөөр ялгарах стратеги хэрэгжүүлэх.

3. Нийт сольсон 46,74 % байгаа хэрэглэгч хөдөлгөөнтэй байгаа нь зах зээлийг шинэчлэх стратеги тулгуурлан үйлчилгээ болон процес шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх буюу банкаар үйлчлүүлэгчдийн хувьд ялгаатай сегмент байгааг анхаарч, сегмент бүрт тохирсон шийдлийг санал болгох хэрэгтэй.
4. Банкны үйлчилгээний чанар муудах буюу үйлчилгээний стандарт хэрэгжүүлэх системийн чанарын хувьд хаана ч хэрэглэх боломжтой, гацдаггүй, түргэн шуурхай ажилладаг буюу ашиглах боломжтой байх тал дээр анхаарах хэрэгтэй.
5. Нэр хүндийн хувьд нийгмийн нөлөөллийг сайжруулах буюу ам дамжсан яриа, вирал маркетинг зэрэгт анхаарал хандуулах. Хэрэглэгчид бие биедээ тус банкны талаар мэдээлэл дамжуулах, хэрэглэхийг уриалах гэх мэт үйлдлүүд хийлгэхэд анхаарах.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Michael D. Cledes, Christopher Gan, Li Yan Zheng (2007) Customer switching behavior in the New Zealand banking industry. *Bank and bank systems*
- Philip Gerrard J. Barton Cunningham, (2004) Consumer switching behavior in the Asian banking market. *Journal of Services Marketing*
- Simon Gyasi Nimako, (2016). Consumer Switching Behaviour: A Theoretical Review and Research agenda. *Research Journal of Social Science and Management.*
- Susan M. Keaveney (1995). Customer Switching Behavior in Service Industries: An Exploratory Study. *Journal of Marketing*
- Vishal Vyas and Sonika Raitani, (2014). Drivers of customers' switching behaviour in Indian banking industry. *International Journal of Bank Marketing.*



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛД ИННОВАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Цэцэнтана (Siqintana)¹, Л. Оюунцэцэг²

¹ СЭЗИС-ийн докторант, siqintanamgl@126.com

² Доктор (Sc.D.), проф. ШУТИС, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль (БухС)-ийн зөвлөх профессор, l.ouyuntsetseg@must.edu.mn



Түлхүүр үг:

үйлдвэрийн салбар,
инноваци, инновацийн
үүрэг, инновацийн хөгжил

Хураангуй

Өнөө үед инноваци нь улс орнуудын нийгэм- эдийн засгийн хөгжлийн нэг гол хүчин зүйл болж байгаа бөгөөд ялангуяа аж үйлдвэрийн салбарын хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон. Аж үйлдвэрийн салбар, үйлдвэр аж ахуйн газруудын хувьд хэрэглэгч, зах зээлийн байнга өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг хангахын тулд бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи болон үйл ажиллагаагаа тасралтгүй шинэчилж сайжруулах, шинжлэх ухаан технологи (ШУТ)-ийн ололт, инновацийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна. Судалгаанаас үзэхэд Хятад болон Монгол Улсад аж үйлдвэрийн салбар, үйлдвэрийн газруудын инновацийн туршилагыг судалсан байдал дутмаг, энэ талын судалгаа бүтээлүүд хомс байгаа юм. Иймээс бид аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжлийн туршилагыг Өвөр Монголын аж үйлдвэрийн салбар, тэр дундаа текстилийн үйлдвэрлэлийн жишээн дээр судалж байгаа бөгөөд энэхүү бүтээлд аж үйлдвэрийн салбарын хөгжилд инновацийн гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлагын талаар судалсан үр дүнг тусган авч үзсэн болно.

Удиртгал

Орчин үеийн даяаршил, нийгэм-эдийн засгийн эрчимтэй хөгжлийн нөхцөлд шинжлэх ухаан технологийн дэвшил, инноваци нь аж үйлдвэрийн салбар, үйлдвэр аж ахуйн газруудын хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. Учир нь, үйлдвэр аж ахуйн газар, бизнесийн байгууллагууд багагүй хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулан, ихээхэн хэмжээний ашиг орлого олж, зах зээлд танигдан, тодорхой байр суурь эзэлсэн хэдий ч гарц үр дүн нь буурч, үйл ажиллагаа нь доголдон, олсон амжилт, байр сууриа алдаж, улмаар “үүд хаалгаа барих” явдал практикт цөөнгүй тохиолддог. Энэ бүхний гол

шалтгаан нь байнга хувьсан өөрчлөгдөх нийгэм-эдийн засгийн орчинд зохицуулан үйл ажиллагаагаа шинэчилж, инновацийг цаг алдалгүй түргэн шуурхай нэвтрүүлж чадаагүйтэй холбоотой гэж үзэж болно.

Эдийн засгийн онол, практикт бүр 1950-иад оноос аливаа байгууллагын хөгжилд инновацийн гүйцэтгэх үүрэг чухал болох талаар судлаачид судалгаа бүтээлдээ дурдаж байжээ. Тухайлбал, орчин үеийн менежментийн онолын томоохон төлөөлөгч П. Друкер аж ахуйн нэгж, байгууллагууд маркетинг болон инноваци гэсэн хоёр чухал чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой бөгөөд ялангуяа үйл ажиллагаагаа цаг алдалгүй шинэчилж, инновацийг нэвтрүүлэхгүйгээр урт хугацаанд оршин тогтнох боломжгүй гэж үзсэн байдаг [1].

Өнөө үед Хятадын болон дэлхийн улс орнуудын эдийн засаг, аж үйлдвэр, технологийн хөгжил эрчимжиж, эдийн засаг, худалдаа болон нийгэм улс төрийн орчин бүхэлдээ тогтворгүй, байнга хувьсан өөрчлөгдөх хандлагатай байгаа нь олон салбар, байгууллагуудад өөрчлөлт шинэчлэлт хийх, инновацийг нэвтрүүлэх гол шалтгаан нөхцөл болж байна.

Иймээс өнөө үед инноваци нь хэрхэн хөгжиж, үйлдвэр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ямар үүрэг гүйцэтгэж байгааг судлах нь чухал юм.

Судалгааны арга зүйн чиг баримтлал, аргачлал

Судалгааг явуулахдаа аж үйлдвэрийн инновацийн хөгжлийн талаарх эрдэмтэн судлаачдын судалгааны бүтээлүүд, улс орнууд болон олон улсын холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны болон судалгааны тайлан мэдээлэл, бодлого эрх зүйн баримт бичгүүд зэргээс бүрдэх хоёрдогч мэдээллийн эх сурвалжуудыг цуглуулан, дүн шинжилгээ хийсэн ба кейс судалгааны арга (case study method), баримт бичгийн судалгааны арга (document analysis method), агуулгын шинжилгээний арга (content analysis method) зэрэг чанарын судалгааны аргуудыг ашигласан.

Инновацийн онол, практикийн хөгжлийн чиг хандлага

Инновацийн онолыг үндэслэгч нь Австрийн эдийн засагч Й. Шумпетер юм. Тэрээр судалгаа бүтээлдээ “инноваци” гэсэн ойлголтыг орчин үеийн агуулгаар анхлан томъёолсон ба эдийн засгийн өсөлт, хөгжилд ШУТ-ийн дэвшил, инновацийн гүйцэтгэх үүргийг ул суурьтай авч үзсэн байдаг [2].

Инновацийн онолын хөгжлийн чиг хандлагыг цөөнгүй судлаач, эрдэмтэд судалсан ба


Монгол улсын эрдэмтэн судлаач Л. Оюунцэцэг¹⁵⁶ судалгаа бүтээлдээ түүнийг дараах 5 үе шатаар авч үзжээ. Үүнд:

- **I үе шат.** XIX зууны сүүлч- 1930-аад он. Инновацийн онолын суурь тавигдсан үе;
- **II үе шат.** 1930 -1950-иад он. Инновацийн онолын хөгжлийн эхэн үе;
- **III үе шат.** 1950-1980-аад он. Инноваци, инновацийн менежментийн онолын бие даасан хандлага болж хөгжсөн үе:
 - 1950-1960-аад он. Нийлүүлэлтийн чиг хандлага (Technology push approach);

¹⁵⁶ Л.Оюунцэцэг. (2019). Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол, арга зүйн үндэс. Монограф, ШУТИС.

- 1960-1970-аад он. Эрэлтийн чиг хандлага (Demand pull approach);
- 1970-1980-аад он. Хосолмол чиг хандлага (Integreted approach);
- **IY үе шат.** 1980-2000-аад он. Инноваци, инновацийн менежмент интеграци, системийн хандлагаар хөгжсөн үе:
 - 1980-1990-ээд он. Интеграцчиллын буюу инновацийн системийн чиг хандлага (Integration, innovation system approach);
 - 1990-ээд он 2000-аад он. Сүлжээ интеграцийн буюу үндэсний инновацийн тогтолцооны чиг хандлага (Network Integration, National innovation system approach);
- **Y үе шат.** 2000-аад оноос хойш. Инноваци, инновацийн менежментийн хөгжлийн шинэ үе:
 - 2000-аад он- 2010-аад он. Нээлттэй инноваци, нийгэм соёлын инновацийн чиг хандлага (Open innovation, social-cultural innovation approach);
 - 2010-д оноос хойш: Инновацийн экосистемийн чиг хандлага (Innovation Ecosystem approach) зэрэг болно.

Зураг 1. Инновацийн онолын хөгжлийн үе шат



Харин Хятадын судлаач Дун Жинжүн (Dong Jin Jun), Вү Жинши (Wu Jin Xi) нар инновацийн онолыг ерөнхийд нь дараах 4 үе шатанд хуваан авч үзсэн байна¹⁵⁷. Тухайлбал:

- **1-р үе шат:** Шугаман чиг хандлага. Энэ үе шат нь Ванневар Бушийн 1945 онд "Шинжлэх ухаан: Төгсгөлгүй хил" хэмээх илтгэлээ Ерөнхийлөгч Рузвельтэд өргөн барьснаар, АНУ шинжлэх ухаан, ялангуяа суурь шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлэхийг санал болгосон байна. Үүнээс шинжлэх ухаан, технологид суурилсан инновацийн онолын үе шат эхэлсэн ба үүний суурин дээр "Суурь судалгаа→ Хэрэглээний судалгаа→ Бүтээн байгуулалт→ Үйлдвэрлэлийн менежмент ба инноваци" хэмээх инновацийн онолын шугаман чиг хандлага бий болон хөгжсөн болно.


¹⁵⁷ Дун Жинжүн (Dong Jin Jun), Вү Жинши (Wu Jin Xi) нар.Инновацийн онолын хөгжлийн дөрвөн үе шат: тойм ба тайлбар[J].Байгалийн диалектик, 2018,34(02):6065.

- **2-р үе шат:** Системд суурилсан чиг хандлага. Энэ үе шат нь Фриманы Японы тухай монографид тэмдэглэгдсэн. Учир нь 1987 онд Фриман "Технологийн бодлого ба эдийн засгийн гүйцэтгэл: Японы үндэсний инновацийн тогтолцооны туршлага" хэмээх сэдвээр санал дэвшүүлсэн ба тэр нь үндэсний хэмжээнд төрийн төв байгууллагын тэргүүлэх үүрэг, ялангуяа Олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яамны үүрэг, аж ахуйн нэгжийн түвшинд томоохон аж ахуйн нэгжийн бүлгүүдийн үүргийг, боловсролын түвшинд боловсрол, сургалт, нийгмийн шинэчлэл зэргийг тодорхойлсон. Үүнд энэ үе шатны гол чухал ололт нь инновацийн тогтолцоог бүс нутгийн инновацийн тогтолцоо, аж үйлдвэрийн инновацийн тогтолцоо, аж ахуйн нэгжийн инновацийн тогтолцоо гэх үндсэн гурван төрөлд хуваан үзсэн ба аж ахуйн нэгжийг инновацийн тогтолцооны гол цөм болгож, захын бусад оролцогч элементүүдийг багтаасан "төв-захын" инновацийн тогтолцооны загварыг бий болгосон явдал болно.
- **3-р үе шат:** Олон системийн чиг хандлага. Энэ үе шат нь мэдлэгийн инновацийн судалгааны өсөлттэй нягт холбоотой байж, 1995 онд молекул биологи, талстографийн бичил сансар огторгуйн спираль бүтцээс санаа авч, Ллойд Реудидофф, Хенри Эзковак нар "их дээд сургууль - аж үйлдвэр - засгийн газрын" харилцан үйлчлэлийн механизмын хоорондын харилцаанд дүн шинжилгээ хийх гурвалсан спираль загварыг нэвтрүүлсэн байна.
- **4-р үе шат:** Экосистемд тулгуурласан инновацийн онолын чиг хандлага.

Инновацийн экосистемийн парадигм нь ерөнхийдөө тодорхой нэг дэд системд төвлөрөх бус, харин олон органик дэд системүүдийн харилцан үйлчлэл, дасан зохицох, шинэчлэх явдал болно. Энэ нь бүх оролцогч, бүрэлдэхүүн хэсгүүдийг инновацийн хөгжилд тэгшээр оролцуулан, томоохон инновацид том аж ахуйн нэгжийн бүлгүүд болон жижиг, дунд үйлдвэрүүдийн бүлгүүдэд адил тэгш хандаж, бүх төрлийн аж ахуйн нэгжүүд зэрэгцэн оршин, хамтын хөгжихийг шаарддаг байна [4].

Энэ нь аж ахуйн нэгжүүдийн ганцаар оролцсон бие даасан үйл ажиллагаа биш, харин засгийн газар, шинжлэх ухааны судалгааны байгууллагуудын санаачлагаар зах зээл, хэрэглэгчид зэрэг нь бүгд дэмжигч хүч, дэд систем болон оролцох бөгөөд эдийн засгийн янз бүрийн холбоосуудын урсгалын зохицуулалт нь хүрээлэн буй орчинтойгоо дасан зохицож, тасралтгүй тогтвортой хөгжлийг буй болгох явдал болно (Зураг 2).

Зураг 2. Инновацийн экосистемийн онолын хөгжлийн үйл явц



Тэрчлэн инноваци бий болох гол үндэс нь нийгмийн эрэлт хэрэгцээ байдаг тул инновацийн салбар/хүрээ нь үндсэндээ үйлдвэрлэгчид, хэрэглэгчдийн үйл ажиллагааны талбар болдог ба шинжлэх ухаан болон бизнесийг хамарч, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны бүтээл, материаллаг үйлдвэрлэлийн салбарт шилжин нэвтрэх боломжийг бүрдүүлдэг. Уг салбар нь эдийн засгийн өсөлт ба аж ахуй эрхлэлттэй салшгүй холбоотой байж, үйлдвэрлэлийн газар, аж ахуйн нэгжүүд нь инновацийн үйл ажиллагаа ба инновацийн практик хөгжил буй болж хөгжих чухал талбар болдог.

Иймээс энэхүү инновацийн онолын хөгжлийн чиг хандлага нь салбар, үйлдвэр аж ахуйн нэгжийн түвшинд инновацийн практик хөгжил хэрхэн явагдаж байгаа туршлагыг судлахад гол суурь болох тул ихээхэн чухал ач холбогдолтой.


Хятадын аж үйлдвэрийн салбарын өнөөгийн төлөв байдал

Улс орны эдийн засгийн бүтцийн хувьд, ерөнхийдөө гурван том салбарт хуваадаг, даруй хөдөө аж ахуйн салбар, аж үйлдвэрийн салбар, үйлчилгээний салбар болно. Үүнд Хятад Улсын аж үйлдвэрийн салбар нь тус улсын эдийн засагт голлох байр суурь эзэлдэг, улс орны хөгжлийн гол тулгуур болдог бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна.

Өнөөгийн байдлаар тус салбар нь Хятад Улсын ДНБ-ний 40% шахам хувийг бий болгож байна. 2022 оны байдлаар, ДНБ-ий 7.3 хувийг хөдөө аж ахуйн салбар, 39.9 хувийг аж үйлдвэрийн салбар, 52.8 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна(Зураг 3). Үүнд, хөдөө аж ахуйн салбарын нэмэгдсэн өртөг 8834.5 тэрбум юань байж, өмнөх оныхоос 4.1%-иар, аж үйлдвэрийн салбарын нэмэгдсэн өртөг 48316.4 тэрбум юань болж, 3.8%-иар нэмэгдсэн, үйлчилгээний салбарын нэмэгдсэн өртөг 63869.8 тэрбум юань болж, 2.3%-иар тус тус өссөн байна. Үүнээс аж үйлдвэрийн салбарын өсөлт мөн нилээд хурдацтай байгааг мэдэж болхоор байна.

Зураг 3. 2018-2022 оны Гурван том салбарын нэмүү өртгийн ДНБ-д эзлэх хувь

(нэгж: тэрбум юань)



Эх сурвалж: Үндэсний статистикийн мэдээ 2022

Үүнээс харахад, аж үйлдвэрийн салбар нь Хятад улсын үндэсний эдийн засагт чухал байр суурь эзэлж байна. Иймд аж үйлдвэрийн хөгжилд инновацийн гүйцэтгээх үүрэг, хөгжлийн чиг хандлагын талаарх судалгаа нь аж үйлдвэрийн инновацийн хөгжлийн туршлагыг цааш судлахад чухал ач холбогдолтой юм.

Аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжил, гүйцэтгэх үүрэг, чиг хандлага

Аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжил

Инноваци нь аж үйлдвэрийн эрчимтэй хөгжлийг буй болгох дотоод хөдөлгөгч хүч болдог. Аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүдийн чанарыг сайжруулахад инновацийн үйл ажиллагааны хөгжлийг тасралтгүй бэхжүүлэхтэй болгож байдаг.

Сүүлийн жилүүдэд Хятад улс инновацид тулгуурласан хөгжлийн стратегийг бүрэн хэрэгжүүлж, аж үйлдвэрийн инноваци, хөгжлийн стратегийг улам ахиулж, аж үйлдвэрийн инновацийн орчныг тасралтгүй оновчтой болгож, инновацийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, судалгаа ба туршилт хөгжил (R&D)-ийн санхүүжилт зэрэг инновацийн хөгжлийг батлах үйл ажиллагааг үйлдвэр аж ахуйн нэгждээ хэрэгжүүлж ирснээр, инновацийн үйлдвэрлэлийн хүчин чадал сайжирч, инновацийн хөгжил улам үр дүнтэй явагдаж байна.

Хятадын үндэсний статистикийн газар, Шинжлэх ухаан, технологийн яам, Сангийн яамнаас хамтран гаргасан "Шинжлэх ухаан, технологийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 2021 оны үндэсний статистикийн эмхэтгэл"-д дурдсанаар, Хятад улсын судалгаа ба туршилт хөгжил (R&D)-ийн бүтээн байгуулалтын нийт хөрөнгө оруулалт 2021 онд 2.8 их наяд юаньд хүрч, өмнөх оныхоос 14.6%-иар өссөн нь шинэ дээд үзүүлэлт болсон.

Хөрөнгө оруулалтын цар хүрээний хувьд, манай улсын нийт судалгаа ба туршилт хөгжил (R&D)-ийн бүтээн байгуулалтын зардалын нийт дүнгээр дэлхийд хоёрдугаарт ордог.

Судалгаа, хөгжлийн үйл ажиллагааны үүднээс авч үзвэл, 2021 онд аж ахуйн нэгж, төрийн судалгааны байгууллага, коллеж, их, дээд сургуулийн санхүүжилтийн эзлэх хувь тус бүр 76.9%, 13.3%, 7.8%-ийн үзүүлэлттэй байна. Аж ахуйн нэгжийн судалгаа, боловсруулалтын зардлын хэмжээ 2 их наяд юаниас давж, өмнөх оныхоос 9.3%-иар, өсөлтийн хурд нь өмнөх

оныхоос 1.1 пунктээр, судалгаа шинжилгээний хөрөнгө оруулалтын эрч 0.94%-д хүрч, өмнөх оноос 0.04 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.

Тогтоосон хэмжээнээс дээш аж ахуйн нэгжүүд нийт 361 мянган R&D төсөл боловсруулсан нь өмнөх оныхоос 16.5%-иар өссөн үзүүлэлттэй. 2020 оны байдлаар, тогтоосон хэмжээнээс дээш аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүдээс судалгаа, хөгжлийн үйл ажиллагаа явуулдаг 147 мянган аж ахуйн нэгж байгаа бөгөөд энэ нь нийт аж ахуйн нэгжийн 36.7%-ийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, ААН-үүдийн 60 гаруй хувь нь судалгаа шинжилгээний ажил хийгээгүй байна. Тиймээс Хятадын аж ахуйн нэгжүүдэд ашиглах асар их нөөц боломж байсаар байна.

Судалгаа, хөгжүүлэлт, ялангуяа суурь судалгааны ажилд “төлбөр төлөх” нь аж ахуйн нэгжүүдийн үндсэн өрсөлдөх чадварыг хөгжүүлж, хөгжлийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд тустай байдаг. Жишээлээд авч хэлбэл, 2021 онд "HUAWEI" корпораци-ийн судалгаа, хөгжлийн хөрөнгө оруулалт 142.7 тэрбум юаньд хүрч, энэ нь жилийн нийт орлогын 22.4%-ийг эзэлсэн ба үүнээс асар их шинэ инноваци болон шинэ мэдлэгийг бий болгодог байна.

Түүнчлэн 2018 оны байдлаар, судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулсан аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүдийн дундажаар нэг хүнд ноогдох үйлдвэрлэлийн хэмжээ болон орлогын ашгийн хэмжээ нь тус бүр 1.352 сая юань, буюу 6.37%-иар өссөн нь судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулаагүй аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад, нэг хүн тутамд 146 мянган юань буюу 0.33 пунктээр илүү байдаг байна. Эдгээрийг харангуйлан авч үзвэл(Хүснэгт 1):

Хүснэгт 1. Аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжлийн үйл ажиллагаа ба үр дүн

№	Аж үйлдвэрийн инновацийн хөгжлийн үйл ажиллагаа	Үр дүн
1	"Шинжлэх ухаан, технологийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 2021 үндэсний статистикийн эмхэтгэл" гаргасан	(R&D)-ийн хөрөнгө оруулалт 2.8 их наяд юань, өмнөх оныхоос 14.6%-иар өссөн
2	Хөрөнгө оруулалтын цар хүрээний хувьд	(R&D)-ийн бүтээн байгуулалтын зардалын нийт дүнгээр дэлхийд хоёрдугаарт
3	Судалгаа, хөгжлийн үйл ажиллагааны үүднээс	Аж ахуйн нэгж, төрийн судалгааны байгууллага, их дээд сургуулийн санхүүжилтийн хувь 76.9%,13.3%,7.8%
4	Тогтоосон хэмжээнээс дээш аж ахуйн нэгжүүд	361000 R&D төсөл боловсруулсан; үйл ажиллагаа явуулдаг 147000 аж ахуйн нэгж, нийтийн 36.7%-ийг эзэлнэ
5	Суурь судалгааны ажилд “төлбөр төлөх” нь аж ахуйн нэгжүүдийн үндсэн өрсөлдөх чадварыг хөгжүүлжнэ	"HUAWEI" корпораци-ийн (R&D)-ийнхөрөнгө оруулалт 142.7 тэрбум юань,жилийн нийт орлогын 22.4%-ийг эзэлсэн
6	Судалгаа, боловсруулалтын үйл ажиллагаа явуулсан аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүд	Үйл ажиллагаа явуулаагүйтэй харьцуулахад, үйлдвэрлэлийн хэмжээ болон орлогын ашгийн хэмжээ нь146 мянган юань буюу 0.33 пунктээр илүү

Иймээс аж үйлдвэрийн аж ахуйн нэгжүүдийн судалгаа шинжилгээний үйл ажиллагаа нь инноваийг буй болгон, энэ нь аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн үр ашгийг үр дүнтэй

нэмэгдүүлж сайжруулдаг байна. Үүнээс аж үйлдвэрийн эдийн засгийг хөгжүүлэхэд инноваци, R&D үйл ажиллагаа, санхүүжилт зэрэг нь чухал бөгөөд эерэг үүрэг гүйцэтгэдэг болохыг олж харах боломжтой.

Аж үйлдвэрийн салбар дахь инновацийн гүйцэтгэх үүрэг

Аж үйлдвэрийн хөгжилд инновацийн гүйцэтгэх үүргийн талаар, Хятадын судлаач эрдэмтэн Ван Чи (Wang Qi) нарын судалгаагаас, дараах байдлаар харангуйлан тодорхойлсон. Тухайлбал:

1. Инноваци нь аж үйлдвэрийн өртгийн сүлжээний шинэчлэлийг бий болгодог.

Аж үйлдвэрийн өртгийн сүлжээг шинэчлэх нь аж үйлдвэрийг хөгжүүлэх арга зам болох бөгөөд аж үйлдвэрийн хүчин зүйлийн өөрчлөлт нь инновацид тулгуурладаг байна. Инновацид суурилсан аж үйлдвэрийн гинжин хэлхээний шинэчлэл нь дараах байдлаар голчлон хэрэгждэг байна. Тухайлбал: Нэгдүгээрт, үйлдвэрлэлийн технологийн шинэчлэл, үйлдвэрлэлийн шинэ технологи, үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмж, бүтцийн өөрчлөлт зэргийг судлаж, хөгжүүлэх замаар хэрэгждэг. Хоёрдугаарт, аж үйлдвэрийн хөгжлийн үзэл баримтлал, менежментийн инновациар дамжин, аж үйлдвэрийн анхны байгууллагыг өөрчлөн байгуулах, сэргээн босгох, аж үйлдвэрийн хөгжлийн анхны загварыг шинэчлэх, шинэ үйлдвэрлэлийн гинжин хэлхээний шинэчлэлийг хэрэгжүүлэх зэрэг болно. Гуравдугаарт, технологи, менежментийн инновациар дамжин хэрэгждэг байна. Үүнээс аж үйлдвэрийн бусад хүчин зүйлийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн анхны хүчин зүйлийн бүтцийг өөрчлөх, аж үйлдвэрийн чиг үүргийг баяжуулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ зах зээлийг өргөжүүлэх, аж үйлдвэрийн сүлжээний босоо ба хэвтээ хөгжлийн чиглэл, өргөтгөлийн орон зайг өөрчлөх болно.

2. Инноваци нь аж үйлдвэрийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг хөтөлдөг.

Аж үйлдвэрийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт нь аажмаар явагдаж байдаг үйлдвэрлэлийн хувьсалын загвар юм. Үүнд үйлдвэрийн өөрчлөлт, шинэчлэлт нь ихэвчлэн анхны аж үйлдвэрийн салбарын хувьсал, өрсөлдөөний доод түвшингээс өндөр өрсөлдөөн рүү, бага бүтээмжээс өндөр бүтээмж рүү, өргөн үйлдвэрлэлийн горимоос эрчимтэй үйлдвэрлэлийн горим рүү, чанаргүй хөгжлийн горимоос өндөр чанарын хөгжлийн горимд шилжих хувьсал өөрчлөлтийг заадаг юм. Уламжлалт үйлдвэрлэлийн хөгжил нь нөөцийг ашиглах, хүрээлэн буй орчныг золиослоход суурилдаг байсан ба нөөц баялаг болон хүрээлэн буй орчны хязгаарлалт нэмэгдсэн тохиолдолд, үйлдвэрлэлийн өөрчлөлт, хөгжилт, шинэчлэлт нь инновацид тулгуурлах болсон байна. Үүний гол илрэл нь: Нэгдүгээрт, үйлдвэрлэлийн технологийн инновациар дамжуулан үйлдвэрлэлийн анхны технологийг өөрчлөн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлдэг. Хоёрдугаарт, үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулахын тулд үйлдвэрлэлийн менежментийн инновациар дамжуулан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны анхны зохион байгуулалт, менежментийн загварыг оновчтой болгодог. Гуравдугаарт, аж үйлдвэрийн технологийн инноваци, менежментийн инновациар дамжуулан өндөр хөгжилд хүрэх буюу аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин зүйлийг оновчтой болгох, үйлдвэрлэлийн анхны арга хэлбэрийг өөрчлөн сайжруулах, аж үйлдвэрийн үнэ цэнэ, зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг болно.

3. Инноваци нь тухайн салбарт шинээр гарч ирж буй салбаруудын хөгжлийг жолоодон чиглүүлдэг.

Аж үйлдвэрийн салбарт шинээр хөгжиж буй салбарууд нь аж үйлдвэрүүдийн үндсэн суурь дээр шинээр хөгжин гарч ирсэн буюу зах зээлийн хөгжлийн хэтийн төлөв сайтай аж ахуйн нэгжүүд болох бөгөөд эдгээр нь үйлдвэрлэлийн чиг үүргийн өргөтгөл, бүтээлүүд болдог байна. Үүнд шинээр хөгжин гарч буй салбаруудыг хөгжүүлэхэд инноваци нь голчлон дараах хэдэн талаар үүрэг гүйцэтгэдэг байна: Нэгдүгээрт, үзэл баримтлал, бүтээлч сэтгэлгээ, менежментийн инновациар дамжуулан салбарын хөгжлийн орон зай, аж үйлдвэрийн чиг үүргийг өргөжүүлж, аж үйлдвэрийн салбарын өндөр чанартай хөгжлийг ахиулж, дэлхийн зах зээл дахь хүлээн зөвшөөрлийг нэмэгдүүлэх. Хоёрдугаарт, үзэл баримтлал, технологийн шинэчлэл хийх замаар аж үйлдвэрийг хөгжүүлэн, үнэ цэний шинэ талбаруудыг бий болгох. Гуравдугаарт, технологийн инноваци, шинэ бүтээлээр дамжуулан аж үйлдвэрийн үр ашгийг нэмэгдүүлэн хөгжүүлэх болно.

Үүнээс инноваци нь аж үйлдвэрийн хөгжлийн үе шат, холбоос бүрд чухал үүрэг гүйцэтгэж байгааг танин мэдэх боломжтой бөгөөд цаашид аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжлийн туршлагын судалгаа хийхэд суурь онол болж хөгжинө.

Хятад Улсын аж үйлдвэрийн салбар дахь инновацийн хөгжлийн чиг хандлага

Хятадын аж үйлдвэрийн хөгжил дахь инновацийн практик хөгжлийн чиг хандлагыг харахад, Хятадын аж үйлдвэрийн инновацийн судалгаа нь 1990-ээд оноос голчлон эмпирик судалгаанаас эхэлсэн ба эхэндээ аж үйлдвэрийн технологийн инновацид анхаарлаа хандуулах хандлагатай байсан. Түүнчлэн "аж үйлдвэрийн инноваци" хэмэх түлхүүр үгтэй судалгааны ажлыг Хятадын судалгааны вэбсайтаас хайхад, судлаач Шие Чи (Xie Chi) -гийн 1997 онд нийтэлсэн судалгаанд хамаг анхн дурдагдсан ба цаашид хөгжүүлж ирсэн байна¹⁵⁸.

Үүнд Хятадын аж үйлдвэрийн салбар дахь инновацийн практик хөгжлийн үе шат нь ерөнхийдээ дараах 4 үе шатаар хөгжиж ирсэн хэмээн харангуйлан тодорхойлсон. Тухайлбал:

- Эхний үе шат: (гарааны үе шат) 1949(шинэ Хятад улс байгуулагдсанаас хойших)-1978 -аад он. Энэ үе шатанд аж үйлдвэр эрхлэгчид анх инновацийн тал дээр олголтой болж, өртийн аж үйлдвэрийн үйл ажиллагаандаа ашиглан хэрэглэхээр оролдож эхэлсэн байна.
- Хоёр дахь шат: (анхны хөгжлийн үе шат) 1979-1991 -ээд он. Энэ үе шатанд аж үйлдвэр эрхлэгчид инновацийн талаар нэлээд их олголтой болж, инновацийг өрийн үйлдвэр аж ахуй буюу менежментийн тал дээрээ түлхүү ашиглын хэрэглэх шаардлагаар гэдгийг сэрж мэдэн аж үйлдвэрийн практик үйл ажиллагаандаа бодитайгаар ашигласан болно.
- Гурав дахь шат: (хурдацтай хөгжлийн үе шат) 1992-2005 -иад он. Хятад улс нь 1992 оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд орж эхэлсэн юм. Иймээс энэ үе шатанд инноваци гэх ойлголтыг маш зөвөөр хүлээн авч ашигласан учраас аж үйлдвэр, эдийн засгийн хөгжил маш хурдацтай хөгжин, 2001 онд Дэлхийн

¹⁵⁸ Жан Жихэ, Шие Жунчуан, Жөу Гуохуа, Жан Чуанбо(Zhang Zhi He, Xie Zhong Quan, Zhou Guo hua, Zhang Chuan Bo.).Аж үйлдвэрийн инновацийн онолын тойм ба хөгжлийн чиг хандлага[J].Технологийн эдийн засаг, 2008(01):35-43+48.

худалдааны байгууллагад элссэн орсон. Ийнхээр аж үйлдвэрийн инновацийн практик хөгжил өндөр хурдацтай хөгжсөн байна.

- Дөрөв дэх үе шат: (бие даасан инновацийн хөгжлийн үе шат) 2006 оноос өнөөг хүртэл хэмээн тодорхойлсон. Хятад улс нь 2006 онд инновацид суурилсан хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх санал дэвшүүлж, мөн тус онд инноваци бүхий улс орныг төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлсэн байна. Иймээс үйлдвэр аж ахуйн хөгжилд бие даасан инновацийн хөгжлийг түлхүү санаачлан хэрэглэж, төр засгийн газраас дэмжлэгээ үзүүлэн, аж үйлдвэрийн инновацийн практик хөгжил нь нэн хүчтэй хөгжиж чадсан байна.

Дүгнэлт

1. Аж үйлдвэрийн салбар нь нийгэм эдийн засгийн хөгжлийн чухал хэсэг болохоор барахгүй инновацийг гол түлхүү ашигладаг салбарын нэг болно.
2. Хятадын ААН-үүдийн 60 гаруй хувь нь судалгаа шинжилгээний ажил хийгээгүй байдаг учраас Хятадын аж ахуйн нэгжүүдэд инновацийг хөгжүүлэн, судалгаа, хөгжлийн үйл ажиллагаа явуулахад ашиглах асар их нөөц боломж байдаг байна.
3. Инноваци нь аж үйлдвэрийн хөгжлийн дунд маш чухал үр нөлөө өгч байдаг бөгөөд гинжин хэлхээний шинэчлэлийг бий болгон, аж үйлдвэрийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг удирдан хөтлөн чиглүүлдэг бөгөөд тухайн салбарт шинээр гарч ирж буй салбаруудын хөгжлийг жолооддог байна.
4. Инновацийн хөгжлийн чиг хандлага нь инновацийн онолын хөгжлийн дагуу хувьсан хөгждөг. Одоогийн байдлаар инновацийн онолын хөгжил нь экосистемд тулгуурласан хөгжлийн үе шатанд байж, хөгжлийн чиг хандлага нь төр засгийн газар-их дээд сургууль-эрдэм шинжилгээний байгууллага-үйлдвэр аж ахуйн нэгж- бусад дэмжих байгууллага зэрэг бүүрэлдэхүүн хэсгүүд хоорондын уялдаа холбоотойгоор харилцан дэмжиж, хамтын харилцаа холбоо байгуулан үйл ажиллагаагаа үнэ цэнэтэй явагдуулах чиг хандлагатай хөгжиж байна.
5. Хятадын аж үйлдвэрийн хөгжил дахь инновацийн практик хөгжлийн чиг хандлага нь улсын буюу төрийн эдийн засгийн бодлогын нөөлөөг нэлээд их хүртээдэг мөөртлөө бодлогын дагуу маш сайн явагдаж чаддаг байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- [1] Peter F. Drucker. (2008). The Best of Sixty Years of Peter Drucker's Essential Writings on Management. HarperBusiness. [M].
- [2] Joseph Alois Schumpeter. (1934). The Theory of Economic Development. [M].
- [3] Дун Жинжүн (Dong Jin Jun), Вү Жинши (Wu Jin Xi) нар. Инновацийн онолын хөгжлийн дөрвөн үе шат: тойм ба тайлбар[J]. Байгалийн диалектик, 2018.
- [4] Ян Ронг (Yang Rong). Инновацийн экосистемийн тодорхойлолт, шинж чанар, бүтээн байгуулалт[J]. Шинжлэх ухаан ба менежмент, 2014.

- [5] Жан Жихэ, Шие Жунчуан, Жөу Гуохуа, Жан Чуанбо(Zhang Zhi He, Xie Zhong Quan, Zhou Guo hua, Zhang Chuan Bo.).Аж үйлдвэрийн инновацийн онолын тойм ба хөгжлийн чиг хандлага[J].Технологийн эдийн засаг, 2008(01).
- [6] Л.Оюунцэцэг. (2019). Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол, арга зүйн үндэс. Монограф, ШУТИС.
- [7] М.Заяа. (2016). Байгууллагын инновацийн чадавхын үнэлгээний арга зүйн асуудал. Доктор (PhD)-ын диссертаци. ШУТИС.
- [8] Г.Жаргал.(2019). “Аж ахуйн нэгжийн инновацийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээний арга зүйн асуудал (Орон нутгийн бизнесийн байгууллагуудын жишээн дээр)”. Доктор (PhD)-ын диссертаци. ШУТИС.
- [9] Ж.Эрхэмтөгс. (2016). “Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам (Соёл урлагийн салбарын жишээн дээр)”. Доктор (PhD)-ын диссертаци.ШУТИС.
- [10] Хятадын үндэсний статистикийн эмхэтгэл 2022.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ: ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЕНЕЖМЕНТ

3. Ундрах

Магистр (МВА), (ХААИС, Эдийн засаг бизнесийн сургууль)



Түлхүүр үг:

экспорт, амьжиргаа,
диверсификаци, үр нөлөө,
тогтвортой аялал
жуулчлал

Хураангуй

Аялал жуулчлалын салбар нь олон улсад “үл үзэгдэгч экспорт”, “улс орнуудын найрамдал, хамтын ажиллагааг идэвхжүүлэгч” зэргээр сайшаагддаг. Монгол Улсын хувьд валютын гурав дахь том эх үүсвэр бол аялал жуулчлал юм. Аялал жуулчлалын салбарын үр ашиг зөвхөн байр, хоол, тээврийн үйлчилгээний салбар төдийгүй, хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэл, худалдаа зэрэг 10 гаруй салбарт шууд болон шууд бус эерэг нөлөөг үзүүлж байдаг. Аялал жуулчлалын үйлчилгээг хэрэглэгч-жуулчин өөрийн биеэр тухайн улс, орон нутагт хүрэлцэн очиж худалдан авдаг тул “хилийн доторх экспорт” болдог, эдийн засгийг солонгоруулах чухал ач холбогдолтой.

Аялал жуулчлалын үйлчилгээний хувьд мэргэисэн хүний нөөцөөс гадна орон нутгийн иргэд, малчид өөрсдийн уламжлалт ахуйг жуулчдад таниулах, үндэсний хоол ундаар үйлчлэх зэргээр оролцож болдог. Иймд бэлчээрийн мал аж ахуйн салбараас олох үр ашиг буурах тохиолдолд малчид амьжиргааны өөр эх сурвалж болох аялал жуулчлалд оролцох оролцоогоо нэмэгдүүлэн өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

УДИРТГАЛ

Аялал жуулчлалын салбар нь дэлхийн улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, улмаар үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмждэг, үр ашиг нь тодорхой нэгэн хэсэгт бус нийгэм-эдийн засгийн бүхий л салбарт, иргэдэд хүрдэг онцлогтой. Дэлхийн улс орнууд экологийн тэнцвэрт байдлыг хадгалах замаар эдийн засгийн өсөлтийг бий болгоход стратегийн чухал салбар нь аялал жуулчлал хэмээн анхаарах болсон өнөө үед Монгол Улс ч мөн аялал жуулчлалын салбарын хөгжлийг чухалчлан үзэж байна.

Энэхүү судалгааны ажлыг аялал жуулчлалын салбарын бодлого нь бусад салбар, ялангуяа бэлчээрийн мал аж ахуйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилготой хийв.

ҮНДЭСЛЭЛ

Тогтвортой аялал жуулчлал

Дэлхийн II дайны дараа 1948 онд НҮБ-ын Хүний эрхийн тунхаглалд "... Хүн бүр цалинтай ээлжийн амралт эдлэх ... амрах, зугаацаж цэнгэх эрх эдэлнэ" хэмээсэн бөгөөд улс орнуудын эдийн засаг өсөж, хүн амын орлогын түвшин дээшилснээр аялал жуулчлал 1960-аад оноос хөгжиж эхэлсэн байна. Дэлхийн аялал жуулчлалын Манилагийн тунхаглал (1980)-д "Хүн бүрийн амьдрах нөхцөлийг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх нь аялал жуулчлалын нэн тэргүүний зорилго мөн..." гэснийг авч үзэхэд аялал жуулчлалын салбарт өгөх ач холбогдол цаг үеэ даган өөрчлөгдсөөр байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (ДАЖБ)-аас 1994 онд гаргасан тунхаглалд "... жуулчин хүрээлэн буй орчин, соёлын өвийг хадгалан хамгаалах хариуцлагаас үүрэлцэх ёстой..." хэмээн заасан төдийгүй 1999 онд Аялал жуулчлалын Ёс зүйн даяаршсан код (Global Code of Ethics for Tourism) гэдгийг баталжээ. Тус кодоод жуулчин аялах эрхээ эдлэхийн зэрэгцээ аялж буй орныхоо зан заншлыг хүндэтгэн ёс суртахуунтай байх, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах, энх тайвныг даян дэлхийд тогтооход өөрийн хувь нэмрээ оруулах ёстой хэмээн заасан байна.

Дэлхийн хүн ам өсөн нэмэгдэж, хол зайд хурдан тээвэрлэх боломжууд бүрдсэнээр аялал жуулчлал нь байгаль болон соёлын өв хадгалж үлдсэн газар нутаг руу илүү чиглэх болов. Тиймээс байгалийн үр шимээр тэтгэгддэг аж үйлдвэрийн салбаруудаас ялгаатай нь аялал жуулчлалд байгалийн үзэсгэлэнт газар, зэрлэг ан амьтан, онгон дагшин нутаг, уугуул соёл, ёс заншил зэрэг нь гол нөөц болдог. Аялал жуулчлал, хүрээлэн буй орчны харилцан хамаарлын тухай судлаачид хэлэлцэн байгалийн болон нийгмийн орчны талаар судалгааны маргаан өрнүүлсээр байна. Судлаач Джорж Янг 1970 оны эхээр аялал жуулчлалын үзүүлэх нөлөөг "аврал бас гэсгээл" хэмээж дараа нь Клауд Каспер өөрийн бүтээлдээ аялал жуулчлалын шүүмжлэлт талын шинэ чиглэлийг гарган "хүрээлэн буй орчны экологи" гэх ойлголтыг тодорхойлсон байна. Шведийн экологич Жост Криппендорф "Амрагч хүмүүс" бүтээлдээ нийтийн (mass) аялал жуулчлалыг эсэргүүцэн өөр хувилбар эрэлхийлэх санал гаргажээ. 1980-аад оны үеэс аялал жуулчлалын шүүмжлэлд "... аяллын биет болон хүмүүний үр нөлөө, байгаль орчинд хандах зан төлөвийг илүү хариуцлагатай болгох" талаар уриалах болов (Butler, 1995). Энэхүү "илүү хариуцлагатай байх" сонирхол нь аялал жуулчлалын олон төрлийн ойлголт, хэлбэрийг санаачилж зөөлөн, чанартай, эко, хариуцлагатай, хамгийн бага үр нөлөөтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн, ногоон, ёс зүйт аялал жуулчлал гэх мэтчилэн нэрлэх болсон бөгөөд энэ бүх төрөл, хэлбэр нь байгаль орчин, нийгэм, ёс зүй, улс төрд тэвчиж болохгүй нөхцөлийг бий болгоод байгаа нийтийн аялал жуулчлалыг орлох хувилбар хэмээн сайшаах болсон байна. (Mihalic, 2006)

Судлаачид жуулчдын туршлагыг тасралтгүй сайжруулахад чиглэдэг эдийн засаг, байгаль орчин, нийгмийн асуудлыг харгалзсан аялал жуулчлалын хөгжил бол тогтвортой аялал жуулчлал хэмээн үздэг. Тиймээс тогтвортой аялал жуулчлалын хөгжил нь ирээдүйн боломжийг хадгалах, хамгаалахын зэрэгцээ жуулчдын болон зочлон буй бүс нутгийн

хэрэгцээнд нийцэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, энэ нь соёлын бүрэн бүтэн байдал, экологийн үндсэн үйл явц, биологийн олон янз байдал, амьд бодгалийг дэмжих системийг хамгаалах улмаар эдийн засаг, нийгэм, гоо зүйн хэрэгцээг хангахуйц бүх төрлийн нөөцийг удирдахад чиглэгдэнэ. Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн талаарх олон янзын тодорхойлолт байдаг ч ерөнхий утга санаа нь нийтлэг юм. Эд бүгд *байгаль орчин хамгаалах, аялал жуулчлалын хөгжлөөс угшилтай бохирдлыг бууруулах, орон нутгийн иргэдийн эрх, хэрэгцээг харгалзан тэдний оролцоог хангах, дэлхий дахины түүх, соёлын өвийг хадгалах, хамгаалах, орон нутгийн эдийн засгийг дэмжих, орон нутагт ажил эрхлэх боломж олгох* зэрэг асуудлыг авч үздэг.

Тогтвортой аялал жуулчлалын зорилго нь урт болон богино хугацааны алинд ч амьдралын чанар, стандартыг дээшлүүлэх үүднээс хүрээлэн буй орчныг хамгаалах, соёлын бүрэн бүтэн байдлыг хадгалах, нийгмийн шударга ёсыг тогтоох, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх улмаар эдгээр арга замын тэнцвэрийг бий болгох явдал юм (WTO, 2001).

Монгол Улсын аялал жуулчлал

Аялал жуулчлал нь улсын ард иргэдийн эх орноороо бахархах сэтгэлийг бэхжүүлэх бол Монгол Улсад зочлон ирэх гадаадын жуулчдад унаган байгаль, нүүдэлчин соёлыг мэдрүүлснээр дэлхийн улс орнуудаас ялгарах давуу талыг таниулах, хоногшуулах ач холбогдолтой. Аялал жуулчлалын салбар 2019 онд ДНБ-ий 7.2 хувийг эзлэх хүртлээ хөгжсөн ч дэлхий нийтийг хамарсан халдварт өвчний үед салбар уналтад орсон байна. Шинэ хэвийн нөхцөл байдал бүрэлдэх энэ үед аялал жуулчлалын салбарыг төрийн бодлогоор дэмжих оролдлого хийгдэж байна.

1. Монгол Улсын урт хугацааны бодлого “Алсын хараа 2050”-д аялал жуулчлалыг үндэсний хөгжлийн гурван тулгуурын нэг болгосон нь уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн бүтцийг өөрчлөх зорилготой байгааг илтгэнэ. Энэхүү бодлогын баримт бичигт аялал жуулчлалын хөгжлийг “8. Бүс, орон нутгийн хөгжлийн зорилго”-д хамруулж, Монгол Улсыг 6 хэсэгт бүсчилж, тухайн бүс нутаг бүрийн хөгжлийн зорилгыг тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлсон аялал жуулчлалын бүс

№	Эдийн засгийн бүс	Хамрах аймаг, хот
1.	Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг
2.	Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүс	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймаг
3.	Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймаг
4.	Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүс	Баян-Өлгий, Увс, Ховд аймаг
5.	Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	Архангай, Булган, Дархан-Уул, Завхан, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг

6.	Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс	Төв аймаг, Улаанбаатар хот
----	--	----------------------------

Эх сурвалж: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”


2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлэгт эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн гуравдугаарт аялал жуулчлалын хөгжлийг онцлоод, “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэж тодорхойлсон. Үүнд нэгд, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэг саяд хүргэх; хоёрт, “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор” байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх; гуравт, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хөвсгөл, Хэнтий, Архангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан зэрэг аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлэх гэжээ.
3. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2019-2026)-ыг Засгийн газар 2019 онд баталсан. Монгол улсын аялал жуулчлалын бодит байдалд дүн шинжилгээ хийн, “Монгол Улс нүүдлийн соёл, түүхэн аялал жуулчлалын олон улсын төв болно” хэмээн алсын харааг дэвшүүлсэн. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилгыг “*Үндэсний онцлог бүхий, хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино*” хэмээн тодорхойлжээ.

Ийнхүү Монгол улс аялал жуулчлалын салбарыг хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын удаах ач холбогдол бүхий салбар гэж үзэн, сүүлийн 20 орчим жилд урт хугацааны бодлогодоо чухалчлан тодорхойлж ирсэн. Байгалийн нөөц, уламжлалт нүүдлийн ахуй, агуу их гүрний түүхэн өлгий гэдгээр олон улсын жуулчид эко-аялал, түүхэн аялал, адал явдалт аяллын зорилгоор зорчиж, аялал жуулчлалын салбарын орлого жилээс жилд өссөн. Тодруулбал, Монгол Улсад аялах жуулчдын тоо сүүлийн таван жил тогтмол өсөж 2019 онд 577.3 мянгад хүрч, салбарын орлого 607 сая ам.долларт хүрсэн дүнтэй байна (Зураг 2). Аялал жуулчлалын салбар зах зээлийн эдийн засагт хөлөө олох гэж 30-аад жилийг туулахдаа хувийн хэвшлийн голлох оролцоотой хөгжиж ирсэн байна. Энэ хугацаанд зохион байгуулалтгүй, ганцаарчилсан аялагчдын урсгалаас аяллын операторын зохион байгуулалттай аяллын хэлбэр лүү аажмаар шилжиж байна. Үүний үр дүнд нэг жуулчинд ноогдох орлого сүүлийн жилдүүдэд тогтвортой өсөж 2019 онд нэг жуулчин дунджаар 950 ам.доллар зарцуулсан дүнтэй байна.

Монгол Улсад аялж буй жуулчдын тоо хандлагаараа нэмэгдсээр байгаа бөгөөд нийт гадаад жуулчдын талаас илүү хувь нь Ази-Номхон далайн бүс доторх аялагчид байна. Монгол Улсад ирж буй жуулчдын (давхардсан тоогоор) 70 орчим хувь нь үзэсгэлэнт байгалийг, 50 орчим хувь нь нүүдлийн соёл, уламжлалт ахуйг, 25 орчим хувь нь Монгол Улсын түүх, Чингис хааны түүх, 15 орчим хувь нь адал явдалт аялал зэргийг сонирхдог. Үүнээс гадна

зэрлэг амьтдын ан агнуур, загасчлал гэх мэт олон төрлийн зорилготой зочилдог байна (МИРИМ, 2016).


Зураг 2. Монгол улсад аялсан гадаад жуулчдын тоо



Эх сурвалж: Монголын Үндэсний Статистикийн Хороо

Монгол Улсын аялал жуулчлалын үйлчилгээнээс олох орлого 2007 оноос эхлэн буурч 2011 онд 156 сая ам.доллар (ДНБ-ий 1.5%) -т хүрсэн хэдий ч 2011 оноос эхлэн эрчимтэйгээр өссөн байна (Зураг 3). Аялал жуулчлалын салбарын ДНБ-нд эзлэх хувь 2002-2004 онуудад 10 орчим хувьтай байсан бол уул уурхайн салбарын хөгжлийн үр нөлөөгөөр аялал жуулчлалын салбарын орлого өссөн ч эзлэх хувь хэмжээ сүүлийн 10 орчим жилд 2-4 хувийг эзлэх болжээ. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 7.2 хувьд хүрч 989.2 сая ам.доллаароор хэмжигдэн, олон улсын гийчдийн зарцуулсан зардал нь 605.5 сая ам.доллар болж, энэ нь экспортын нийт орлогын 6.8 хувийг бүрдүүлсэн билээ. Дэлхийн Аялал Жуулчлалын Консулын мэдээллээр 2019 онд жуулчлалын урсгалын 31 хувийг дотоодын аялал жуулчлал эзэлсэн дүнтэй байгаа бөгөөд энэ нь цаашид өсөх хандлагатай гэжээ.

Зураг 3. Аялал жуулчлалын салбарын орлого



Эх сурвалж: www.worlddata.info

Монгол Улсад аялах жуулчдын урсгал цар тахлын улмаас зогсонги байдалд хүрч 2020 онд 58.9 мянган жуулчин (оны эхний хагаст голдуу) ирснээр өмнөх онтой харьцуулахад 89.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хил хамгаалах газраас гаргадаг мэдээллээр сүүлийн дөрвөн жилийн эхний улиралд Монгол Улсын хилээр орж ирсэн гадаад зорчигчдын урсгалыг харьцуулан авч үзсэн (Хүснэгт 2).

Дэлхийн улс орнууд цар тахлын дараах хүнд үеийг даван туулж, шинэ хэвийн нөхцөл байдалд шилжих үеийг 2024 он хүртэлх хугацаанд авч үзэж байгаа бөгөөд 2019 оны үеийн хэвийн түвшинд эргэж сэргэх үе гэж тодорхойлж байна. Монгол Улсын Засгийн газраас цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг боловсруулан, төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжих багц асуудлуудыг шийдвэрлэхээр тодорхойлсон байна. Энэхүү бодлогын хүрээнд аялал жуулчлалын салбарыг сэргээх зорилгоор 2023-2025 оныг Засгийн газраас “Монголд зочлох жил” болгон зарлаж, 2023 оноос эхлэн нэг сая жуулчин хүлээн авах зорилгыг дэвшүүлжээ (Хүснэгт 2). Монгол Улс аялал жуулчлалын салбарын ач холбогдлыг чухалчилж анх 2003 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж байснаас хойш даруй 20 жилийг үдсэн байна.

Хүснэгт 2. Аялал жуулчлалын салбарын төлөвлөлт, гүйцэтгэл

№	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэл		Төсөөлөл		
		2019 он	2022.10.30-ны байдлаар	2023	2024	2025
1.	Жуулчдын тоо /мян.хүн/	577.3	230.0	1'000.0	1'600.0	2'000.0
2.	Аялал жуулчлалын салбарын ДНБ-нд эзлэх хувь	7.2 %	2.2%	11.5%	16 %	20%
3.	Салбарын орлого /сая, ам.долл/	989.2	278.0	1200.0	2000.0	2500.0
4.	Ажлын байрны тоо	64'900	50'000	120'000	160'000	160'000

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны ажлыг хангайн бүсийг төлөөлүүлэн Өвөрхангай, Архангай аймаг, говийн бүсийг төлөөлүүлэн Дундговь, Өмнөговь аймгуудад явуулав. “Тогтвортой аялал жуулчлал” загварын хүрээнд эдгээр аймгуудын малчдын амьжиргаа, амьжиргааны стратеги, аялал жуулчлалд оролцох оролцоог судлах үүднээс аялал жуулчлалын урсгал илүү идэвхтэй явагддаг сумдыг хамруулав. Судалгаанд нийт 104 малчин хамрагдсан бөгөөд Архангай аймгийн Их Тамир, Цэнхэр, Тариат, Хотонт; Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Уянга, Хархорин, Хужирт; Дундговь аймгийн Гурвансайхан, Говь-Угтаал, Адаацаг, Сайхан-Овоо; Өмнөговь аймгийн Сэврэй, Ханхонгор, Гурван тэс сумдын хүрээнд судалгааг явуулав.

Малчдаас авсан судалгааны асуулга нь үндсэн 5 бүлэг бүхий бүтэцтэй, тоон болон чанарын 48 асуултаас бүрдсэн болно. Мөн аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцдог, оролцох хүсэлтэй малчдад хандсан санал, зөвлөмж боловсруулахын тулд аялал жуулчлалын компаниудтай холбогдон асуулгын судалгаа авсан бөгөөд 31 туроператор компани хамрагдаж аялал жуулчлал дахь малчдын оролцоонд анхаарах асуудлыг тодорхойлов. Малчдаас авсан судалгаанд анхан шатны боловсруулалт хийж өгөгдлийн санг бэлдэн SPSS 25 программд хөрвүүлснээр өгөгдлийг шинжилж үр дүнг гаргав. Онолын үндсэн загварын үзүүлэлтүүдээр үнэлэн дүгнэхдээ үл хамаарах түүврийн t-шинжүүр, тусгаар байдлын Хи

квадрат тест, нэг чиглэлт вариацийн шинжилгээ зэрэг статистик шинжилгээний аргаар өгөгдлийн шинжилгээ хийлээ.

Тогтвортой аялал жуулчлалын шинжилгээ



- Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөж
- Аялал жуулчлалын нийгэм-соёлын үр өгөөж
- Аялал жуулчлалын байгаль орчны үр өгөөж
- Оролцогч талуудын хамтын ажиллагаа
- Аялал жуулчлал дахь орон нутгийн иргэд, малчдын оролцоо

Судалгаанд оролцох боломжит өрх, иргэдийн мэдээллийг аймаг, сумын засаг даргын тамгын газраас цуглуулж, улмаар тэдгээр хүмүүстэй утсаар холбогдон өгөгдөл, мэдээллээ цуглуулав. Өгөгдлийг статистик мэдээлэл боловсруулалтын SPSS, Stata зэрэг программуудаар боловсруулж, хүчин зүйлс, үзүүлэлт хоорондын шууд болон дам нөлөөллийг шинжлэн дүгнэлээ. Тооцооллын эхэн үед хүчин зүйлсийн шинжилгээгээр үзүүлэлтийг бүлэглэн асуулгын найдвартай байдал болон түүврийн оновчтой байдлыг шинжиллээ. Хүчин зүйлсийн хамаарал, шууд болон дам нөлөөллийг судлах үүднээс ‘бүтцийн тэгшитгэлийн загвар’-ыг тооцоолж дүгнэлт боловсруулав.

Өгөгдлийн шинжилгээ

Судалгааны ажлын найдвартай байдлыг шалгадаг статистик шинжүүр бол кронбах альфа (Cronbach’s Alpha)-ын утгыг шинжих байдаг. Энэхүү шинжүүр нь $0 \leq \alpha \leq 1$ хооронд утгаа авах ба $0 \leq \alpha$ байх нь ач холбогдолтой буюу судалгааны асуултуудын найдвартай байдлыг илэрхийлдэг. Судалгааны өгөгдөлд кронбах альфа буюу судалгааны асуулгын найдвартай байдлын шинжүүрийг тооцоолж үзэхэд эдийн засгийн болон нийгэм-соёлын үр өгөөж, оролцогч талуудын хамтын ажиллагаа 0.7-оос дээш утгатай байгаль орчны үр өгөөж үзүүлэлтийн хувьд 0.67 утгатай байна (Хүснэгт 24). Хэдийгээр байгаль орчны үр өгөөжийн хувьд альфа нь 0.7-оос доош утга авч байгаа ч, 0.6-аас дээш утга бүхий асуулгыг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд гэж үзэх (Joseph and et.al, 1995) тул Хүснэгт 30 дахь асуулга, үзүүлэлтээр дараа, дараагийн хүчин зүйлсийн шууд болон дам нөлөөллийн шинжилгээ хийж ажилласан юм.

Хүснэгт 9. Тогтвортой аялал жуулчлалын хүчин зүйлсийн шинжилгээ

№	Хүчин зүйлс	Дундаж утга	Стандарт хазайлт	Cronbach's alpha
1	Эдийн засгийн үр өгөөж	2.038	1.005	0.8261
1.1	Орон нутагт явагдаж буй аялал жуулчлалын салбараас хүртэх өгөөжийг орон нутгийн иргэд илүү хүртдэг.	2.134	1.393	0.7742
1.2	Орон нутгийн иргэд, малчид өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг жуулчны байгууллагад, жуулчдад хангалттай борлуулж орлого олдог.	2.000	1.222	0.7359
1.3	Жуулчид орон нутгийн иргэд, малчдад хангалттай мөнгө төлдөг тул амьдралын чанар дээшилдэг.	2.307	1.394	0.7624
1.4	Малчид мал аж ахуйгаас илүүтэй аялал жуулчлалаас орлого олж чаддаг.	1.711	0.877	0.8326
2	Нийгэм-соёлын үр өгөөж	4.072	0.900	0.7950
2.1	Аялал жуулчлал бол орон нутгийн иргэдэд ажлын байр бий болгон хөрөнгө оруулалт оруулдаг.	3.855	1.368	0.7599
2.2	Аялал жуулчлалын хөгжлийг дагаад зам, эрчим хүч, сургууль цэцэрлэг гэх мэт дэд бүтэц хөгждөг.	3.740	1.386	0.6909
2.3	Аялал жуулчлал бол үндэсний соёлыг хадгалах, өвлүүлэхэд чухал ач холбогдолтой.	4.442	0.735	0.7732
2.4	Аялал жуулчлалд оролцсоор малчдын мэдлэг, мэдээлэл дээшилдэг.	4.250	0.952	0.7371
3	Байгаль орчны үр өгөөж	4.062	0.920	0.6740
3.1	Орон нутгийн иргэд, малчид аялал жуулчлалд оролцсоноор байгаль хамгаалах боломж бүрддэг.	4.375	0.894	0.6370
3.2	Аялал жуулчлалаас орлого олдог малчид малын тоог чухалчилдаггүй.	3.750	1.350	0.6821
4	Оролцогч талуудын хамтын ажиллагаа	0.478	0.912	0.7650
4.1	Төрийн байгууллага нь орон нутгийн иргэдийн аялал жуулчлалд оролцох оролцоог дэмжиж урамшуулдаг.	1.817	1.130	0.6895
4.2	Орон нутагт аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг хувийн компаниуд малчид, иргэдтэй ойр харилцаатай байдаг.	2.067	1.216	0.6439
4.3	Аялал жуулчлал дахь орон нутгийн иргэдийн оролцоог дэмжих төрийн бодлого байхгүй	4.009	1.218	0.7764
4.4	Дотоод, гадаадын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үр дүнд орон нутгийн иргэд, малчид аялал жуулчлалд идэвхтэй оролцдог.	2.038	1.198	0.7171

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүчин зүйлийн шинжилгээ хийхэд Kaiser-Meyer-Olkin (KMO) болон Barletts тест хийж тухайн хүчин зүйлийг үүсгэж буй түүврийн хэмжээ оновчтой байгаа эсэхийг тодорхойлдог. KMO шинжүүр нь $0 \leq t \leq 1$ хооронд утга авах ба $0 \leq t$ тохиолдолд түүврийн хэмжээ хангалттай байгааг илэрхийлдэг.

Хүснэгт 31-ээс авч үзэхэд үзүүлэлт бүрт түүврийн хэмжээ хангалттай, ач холбогдолтой байгааг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, судалгааны алдсан байх магадлалыг 5% (0.050) байхаар тодорхойлоход Sig. 0.0000 байгаа нь дэвшүүлсэн таамаглалаас хэтрэхгүй, судалгааны алдаа бага байгааг илтгэж байна.

Хүснэгт 10. Түүврийн найдвартай байдлын шинжилгээ

Хүчин зүйл	Үзүүлэлтийн тоо	Kaiser-Meyer-Olkin (KMO) Test for Sampling Adequacy	Barlett's test of Sampling Adequacy
Эдийн засгийн үр өгөөж	4	0.7879	0.0000
Нийгэм-соёлын үр өгөөж	4	0.8215	0.0000
Байгаль орчны үр өгөөж	2	0.8655	0.0001
Оролцогч талуудын хамтын ажиллагаа	4	0.7434	0.0000
Орон нутгийн иргэдийн оролцоо	6	0.8491	0.0000


Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Нөлөөллийн шинжилгээ


Судалгааны зорилгын дагуу оролцогч талуудын хамтын ажиллагаа нь аялал жуулчлалаас үзүүлэх эдийн засгийн, нийгэм-соёлын, байгалийн үр өгөөжид хэрхэн нөлөөлж улмаар орон нутгийн иргэдийн амьжиргаа, сэтгэл ханамжид нөлөөлж байгаа эсэхийг шинжлэв (Зураг 3). Аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөж нь хамтын ажиллагаанд нөлөөлөх бөгөөд цаашлаад орон нутгийн иргэдийн амьжиргаа болон сэтгэл ханамжид эерэгээр (sig. 0.000) нөлөөлж байгааг Зураг 3(а) болон (б) харж болно. Загвараас хамтын ажиллагааг авч тооцоолол хийхэд ач холбогдолтой багатай байсан (0.15*) болон ач холбогдолгүй байсан (0.024) утга ач холбогдолтой болжээ. Тиймээс аялалын жуулчлалын эдийн засгийн үр нөлөө, орон нутгийн иргэдийн амьжиргаа, сэтгэл ханамж хоорондын хамааралд оролцогч талуудын хамтын ажиллагаа нь бүрэн нөлөөтэй (fully mediation) байна. Энэ нь аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлснээр орон нутгийн амьжиргааг сайжруулах үйл явцад иргэдтэй хамтран ажиллах нь чухал болохыг илтгэж байна.

Зураг 3 (в) болон (г) дэх аялал жуулчлалын нийгэм-соёлын үр өгөөж нь хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг, гэхдээ цаашлаад орон нутгийн иргэдийн амьжиргаа, сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөлөөтэй болохыг харуулж байна. Загвараас хамтын ажиллагааг хасвал ач холбогдолгүй байсан (0.25; 0.51) нь амьжиргаа, сэтгэл ханамжид нөлөөлөх нөлөө аль аль нь ач холбогдолтой үр дүн (-0.21*; -0.19*) болж хувирч байна. Өөрөөр хэлбэл, оролцогч талуудын хамтын ажиллагаа нь бүрэн нөлөөтэй хэдий ч аялал жуулчлалаас хүртэх нийгмийн өгөөж нь орон нутгийн иргэдийн амьжиргаа, сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөл болж чадахгүй байна.


Зураг 3. Орон нутгийн иргэдийн амьжиргаа, сэтгэл ханамжид хамтын ажиллагааны үзүүлэх нөлөө




Зураг 28(а). Эдийн засгийн үр өгөөж ба Амьжиргаа




Зураг 28(б). Эдийн засгийн үр өгөөж ба Сэтгэл ханамж




Зураг 28(в). Нийгэм-соёлын үр өгөөж ба Амьжиргаа



Зураг 28(г). Нийгэм-соёлын үр өгөөж ба Сэтгэл ханамж



Зураг 28(д). Байгаль орчны үр өгөөж ба Амьжиргаа



Зураг 28(е). Байгаль орчны үр өгөөж ба Сэтгэл ханамж

Тэмдэглэл: * $p < 0.05$ магадлалтай статистикийн ач холбогдолтой, ** $p < 0.01$ магадлалтай статистикийн ач холбогдолтой, *** $p < 0.001$ магадлалтай статистикийн ач холбогдолтой.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Байгаль орчны үр нөлөө нь бүтцийн тэгшитгэлийн загвараар мөн адил ижил үр дүнтэй гарсан байна (Зураг 3 (д), (е)). Иймд аялал жуулчлалаас хүртэх нийгэм-соёлын болон байгаль орчны үр нөлөөг дээшлүүлэх шаардлага энд тавигдаж байна.


Аялал жуулчлалын компанийн судалгаа

- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцоотой орон нутгийн иргэд, байгууллагыг үнэлсэн байдал

Аялал жуулчлалын салбарт орон нутгийн /аймаг, сумын үндсэн харъяат/ иргэд, байгууллагын оролцоог үнэлэх асуултанд судалгаанд оролцогчдын 36 хувь нь сайн, 32 хувь

дунд гэсэн хариулт өгсөн байна (Зураг 4). Энэ дундаас аялал жуулчлал идэвхтэй бүс нутгийн хувьд буюу Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь аймгийн орон нутгийн иргэд илүү сайн оролцоотой гэж дүгнэжээ.

Зураг 4. Орон нутгийн иргэдийн оролцоог үнэлсэн байдал



Эх сурвалж: Судалгааны ажлын өгөгдөл боловсруулалт


Орон нутгийн иргэд, байгууллагын хувьд дараах асуудалд анхаарч аялал жуулчлалд оролцох оролцоогоо дээшлүүлэх хэрэгтэй гэж судалгаанд оролцогчид үзсэн байна.

- Захиалгын дагуу ажлаа бүрэн төгс гүйцэтгэдэггүй
- Амлалтаа биелүүлдэггүй
- Цаг барьдаггүй
- Экологи, байгаль орчин, хог хаягдлын менежментийн талаар мэдлэг дутмаг
- Жуулчныг зөвхөн мөнгө гэж харах хандлага ихэсч байгаа
- Жуулчинд хэдэн жил үйлчлээд зан хандлага нь эвдэрдэг үзэгдэл түгээмэл
- Боловсон үйлчилгээ, ёс зүй, хэлний бэрхшээл дутагдалтай
- Хог хаягдал, боловсон жорлон, үйлчилгээний чанар муу
- Шаардлага гомдол хүлээн авдаггүй.
- Зохион байгуулалт байхгүй. Хариуцах эзэнгүй.

- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцоотой малчдыг үнэлсэн байдал

Аялал жуулчлалын салбарт орон нутгийн малчин /мал бүхий/ иргэдийн оролцоог үнэлэх асуултанд 41 хувь дунд, 37 хувь нь сайн, 11 хувь нь муу гэсэн үнэлгээ өгчээ (Зураг 5).

Зураг 5. Малчдын оролцоог үнэлсэн байдал



Эх сурвалж: Судалгааны ажлын өгөгдөл боловсруулалт

Аялал жуулчлалын идэвхтэй бүсийн малчид оролцоо сайтай боловч жуулчинд үйлчлэх үйлчилгээг сайжруулах зүйлс их байгааг онцолсон байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцдог малчдын оролцоонд тулгамддаг асуудлыг судалгаанд оролцсон компаниуд дараах байдлаар онцлон тодорхойлсон байна.

Малчдын хувьд:

- Хариуцлага сул, харилцааны соёлд анхаарах
- Боловсрол мэргэжлийн ур чадвар дутмаг
- Хэлний бэрхшээл их
- Улирлын байдлаас шалтгаалан харилцан адилгүй үйлчилгээ үзүүлдэг
- Жуулчдыг улс, үндэстэн болон орлогоор ялгаварладаг
- Зохион байгуулалтад ордоггүй
- Дураараа асуудлыг шийддэг
- Малчин иргэдийн дэргэдэх гэр буудлууд стандарт шаардлага хангадаггүй
- Морь, тэмээ унахад аюулгүй ажиллагаа, тоног хэрэгсэл муу
- Ариун цэвэр, эрүүл ахуйн тал дээр малчин иргэд ач холбогдол маш муу өгч байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалын загвар

Тогтвортой аялал жуулчлалын онолын үндэслэл хийгээд Монгол улсын аялал жуулчлалын салбарт баримталж буй бодлогод үндэслэн судлаач “Нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалын загвар”-ыг боловсруулав (Зураг 6). Монгол улсад явагдаж буй аялал жуулчлалын зорилго нь байгаль, түүхийн болон нүүдлийн соёлын онцлогийг танин мэдэхэд чиглэгддэг тул аялал жуулчлалын үйлчилгээг хүргэх нэг гол оролцогч нь орон нутгийн иргэд, малчид байдаг. Уг онцлог, ялгаралаар олон улсын зах зээлд давуу талыг бий болгох, аялал жуулчлалын өрсөлдөх чадвараа дээшлүүлэхээр хөгжлийн бодлогод тодорхойлсон байна. Энэ үүднээс авч үзвэл Монгол улсын аялал жуулчлалын олон улсын зах зээлд өрсөлдөх харьцангуй давуу тал нүүдлийн соёл юм. Нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлал (НИТТАЖ) нь нүүдлийн аялал жуулчлал буюу бэлчээрт түшиглэсэн аялал жуулчлал байдаг тул мал, малчин, бэлчээр гурвын харилцан шүтэлцээг илэрхийлнэ (Д.Гантөмөр, 2021). НИТТАЖ загвараар зөвхөн аялал жуулчлалын систем бус бэлчээр ашиглалтын нийгэм-экологийн системийг авч үзэн малчдын тогтвортой амьжиргааг хангах менежментийн цогц уялдааг тодорхойлсон байна.

Зураг 6. Нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалын загвар




Эх сурвалж: (Zagarkhorloo, 2021)

Энэ хүрээнд аялал жуулчлалд оролцогч малчдын амьжиргаа болон мал аж ахуйгаас олох орлого, аялал жуулчлалаас олох орлогын бүтцийг харуулан судлав.

Судалгааг аялал жуулчлалын идэвхтэй сумдын хүрээнд явуулж, малчдын амьжиргаа буюу орлогын эх үүсвэрийг дараах орлогын төрлүүдээр тодруулав. Малчин өрхүүд аялал жуулчлалын салбараас тодорхой хэмжээний үр ашиг хүртэж байгаа нь орлогын бүтцээс илэрч байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцоо сайтай малчин өрхийн хувьд уг салбараас олох үр өгөөж өрхийн орлогын 28 хувийг эзэлж байхад оролцоо багатай өрхийн хувьд энэ үр өгөөж 8 хувьтай байна. (Зураг 7, 8).

Зураг 7. Аялал жуулчлалд оролцоотой малчин өрхийн орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Аялал жуулчлалд оролцоо багатай малчин өрхийн орлогын бүтэц, хувиар



Малчин өрхийн орлогын эх үүсвэрийн ялгааг судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн хувьд хангайн болон говийн бүсээр харьцуулан (Хүснэгт 4) нэг чиглэлт Вариацийн шинжилгээ хийж үзэхэд орлогын бараг бүх төрөлд ялгаа илрээгүй бөгөөд “бүлгүүдийн дундаж утга хоорондоо ялгаатай” гэсэн таамаглал няцаагдсан болно. Харин ганцхан жуулчдад үзүүлсэн үйлчилгээнээс олох орлогоор ялгаа илэрч, хангайн бүс нь говийн бүсээс ахиу хэмжээний орлого олж байна.

Хүснэгт 4. Малчдын өрхийн орлогын харьцуулалт,

Нэг чиглэлт Вариацийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Дундаж утга		F	p-утга
	Хангайн	Говийн		
Мал аж ахуй	4.51	5.68	2.128	.150
МАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл	4.09	2.68	3.079	.084
Жуулчдад үзүүлсэн үйлчилгээ	1.67	0.63	3.947	.050
Аялал жуулчлалын цалин хөлс	0.33	0.22	0.052	.820
Тэтгэвэр тэтгэмж	1.23	0.74	.0686	.411
Газар тариалан	0.05	0.11	0.738	.394
Байгалийн баялагаас олох орлого	0.09	0.05	0.686	.411

Энэхүү тооцоонд орлогын эх үүсвэр бүрийн нийт орлогод эзлэх хувийг 1-10 шкалаар үнэлүүлэн, дундаж утгыг харьцуулан шинжиллээ.

Малчин өрхийн амьжиргааны гол эх үүсвэр болсон мал аж ахуйг бүсийн хэмжээнд харьцуулан үзэхдээ малын тоо толгойг хувьсагч болгон ашиглаж малчдын бүлгийн хувьд үл хамаарах түүврүүдийн t-шинжүүрийг тооцоолов (Хүснэгт 5). Тооцооллоор малын тоо толгой хангайн болон говийн бүсийн хувьд ялгаатай бөгөөд говийн бүс дэх малчин өрх хангайн бүсээс 2 дахин малтай байна. Малчин өрхийн малын тоо толгой нь бүсийн экосистемийн хувьд ялгаатай байгаа ч, бүлгийн зохион байгуулалтаас хамаарч буурахгүй байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт 5. Малын тоо толгойг бүс нутгаар харьцуулсан үр дүн, Малчдын бүлгээр

Хувьсагч	Дундаж утга		F	p-утга
	Хангайн	Говийн		
Малын тоо толгой	225.93	500.37	14.100	.000
<i>Зохион байгуулалт</i>	<i>Малын тоо толгой, дундаж</i>			
Бүлгийн гишүүн өрх	233.68	519.13		
Бүлгийн гишүүн биш өрх	219.79	486.73		

Орон нутгийн амьжиргааны чухал ач холбогдолтой нөөц бол байгалийн нөөц. Үүнийг судалгаанд бэлчээрийн чанар, худаг усан хангамж гэсэн хоёр үзүүлэлтээр төлөөлүүлэн тодорхойлов. Эдгээр хувьсагчдын хувьд бүсийн ялгаатай байдлыг авч үзэхийн тулд Хи-квадрат тестийг ашиглан үр дүнг Хүснэгт 6-д харьцууллаа. Бэлчээрийн чанарын хувьд бүсийн ялгаа байхгүй, харин усан хангамжийн хувьд ялгаатай байдал илэрч байна. Говийн бүсийн эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь усан хангамж хүртээмжтэй, хангайн бүсийн эмэгтэйчүүдийн олонх нь хүртээмж муутай гэж дүгнэв.

Хүснэгт 6. Байгалийн нөөцийг бүс нутгаар харьцуулсан үр дүн, малчин эмэгтэйчүүд бүлгээр

Хувьсагч	Үнэлгээ		χ^2	p-утга
	Хангайн	Говийн		
Бэлчээрийн чанар	74 хувь хангалтгүй	81 хувь хангалтгүй	3.749	.290
Усан хангамж	62 хувь хангалтгүй	51 хувь хангалттай	15.432	0.004

Нүүдлийн мал аж ахуйн уламжлалд малчид хот айл, нэг голынхон зэрэг зохион байгуулалттай хөдөлмөрөөр хорших, нэгдэх, харилцан хамтран тусалж дэм дэмэндээ амьдарч ирсэн түүхтэй. Уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, байгалийн гамшиг, хөдөөгийн хүн амын шилжилт, амьжиргааны нөхцөл байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан малчид зохион байгуулалтад орж малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоо байгуулж ажиллах болсон бөгөөд малчдын бүлгийн үйл явцыг хоёр бүсийн хэмжээнд харьцуулан судлав (Хүснэгт 7). Судалгааны үр дүнгээр хангайн бүсийн малчдын бүлгийн гишүүд оролцоо сайтай, хамтран ажиллаж орлогоо тэгш хуваарилан ажилладаг, бүлэг дүрэм журмаа сайтар тодорхойлж, түүнийгээ олонх нь мэддэг, мөрддөг гэжээ. Харин говийн бүсийн малчдын бүлгийн гишүүдийн идэвх, оролцоо, хамтран ажиллах байдал дутмаг, бүлэг дүрэм журмаа сайн боловсруулсан ч үүнийг мэдэж, дагаж мөрдөх нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 7. Малчдын бүлгийн үйл ажиллагаан дахь гишүүдийн идэвх оролцоо, хувиар

Бүлгийн үйл ажиллагаа		Хангайн бүс	Говийн бүс
Гишүүд бүлгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.	Тийм	52	20
	Үгүй	4	16
	Зарим нь	41	48
Гишүүд хадлан тэжээл бэлдэхэд хамтран ажилладаг.	Тийм	85	28
	Үгүй	11	56
Гишүүд хамтран бизнес хийж, орлогоо тэгш шударга хуваарилдаг.	Тийм	74	28
	Үгүй	22	56
Гишүүд хамтдаа бэлчээрийн төлөвлөгөө гаргаж мөрддөг.	Тийм	37	24
	Үгүй	7	40
	Зарим нь	52	20
Гишүүд дүрэм журмаа сайн мэддэг.	Тийм	30	20
	Үгүй	4	16
	Зарим нь	63	48
Бүлэг дүрэм, журмаа сайн боловсруулсан.	Тийм	85	60
	Үгүй	11	24

Амьжиргааны стратеги

Орон нутгийн тогтвортой амьжиргааны шинжилгээнд малчин өрхийн амьжиргааны стратегиа хэрхэн тодорхойлж төсөөлж байгаа нь тогтвортой байдлын үр дүнд нөлөөлөх үзүүлэлт юм. Малчид одоогийн амьжиргаандаа сэтгэл хэр хангалуун байдал нь энэхүү стратегийн суурь нөхцөлийг илтгэх тул хоёр бүсийн хувьд харьцуулан шинжлэв. Мөн сүүлийн 10 жилд амьжиргаанд гарсан өөрчлөлтийн тухай асуулгаар тодруулан Хи-квадрат

тестээр үнэлсэн (Хүснэгт 8). Энэхүү шинжүүрийн үр дүн нь сүүлийн 10 жилд амьжиргаанд гарсан өөрчлөлт бүсийн хувьд ялгаатай байгааг илтгэх бөгөөд говийн бүсийн хувьд хангайн бүстэй харьцуулахад сайжирсан үнэлгээтэй байна. Мөн амьжиргаандаа говийн бүсийнхэн илүү сэтгэл хангалуун байгааг илтгэж байгааг үр дүнгээс харьцуулан харах боломжтой.

Хүснэгт 8. Амьжиргааны үнэлгээ, стратегийн харьцуулсан үр дүн, малчдын бүлгээр

Хувьсагч	Үнэлгээ		χ^2	p-утга
	Хангайн	Говийн		
Сүүлийн 10 жилд амьжиргаанд гарсан өөрчлөлт	51 % буурсан 32 % хэвэндээ	52 % хэвэндээ 47 % дээшилсэн	16.028	.000
Одоогийн амьжиргаандаа сэтгэл хангалуун эсэх	50 % хангалуун, 48 % хангалуун бус	84 % хангалуун, 15 % хангалуун бус	6.631	0.025

Энэхүү шинжилгээг бүсийн дотор бүлгийн гишүүн болон гишүүн бус малчдын хувьд шинжилж үзэхэд хангайн бүсийн малчдын зохион байгуулалтын хувьд ялгаа илэрч бүлгийн гишүүн бус малчдын 58 % нь сүүлийн 10 жилд амьжиргаа буурсан гэжээ. Харин говийн бүсийн хувьд зохион байгуулалтаас хамааралтай амьжиргааны ялгаа илрээгүй.

Малчдын хувьд цаашид амьжиргаандаа ямар стратеги баримтлах талаар тандахдаа малын тоо толгойн төлөвлөлтийг судлан үүнийг үл хамаарах түүврүүдийн t-шинжүүрээр харьцуулахад (Хүснэгт 9) хоёр бүсийн дундаж утга ялгаатай байна. Өөрөөр хэлбэл говийн бүсэд малын тоо толгойг өсгөх илүү их хүсэлтэй байгааг үр дүнгээс харагдаж байна.

Хүснэгт 9. Малчдын малын тоо толгойн төлөвлөлт


Хувьсагч	Дундаж утга		F	p-утга
	Хангайн	Говийн		
Малын тоо толгойн төлөвлөлт	325.36	608.82	24.013	0.000
<i>Зохион байгуулалт</i>				
Бүлгийн гишүүн малчин	315.79	587.5		
Бүлгийн гишүүн биш малчин	345.56	627.78		
<i>Аялал жуулчлал дахь оролцоо</i>				
АЖ-н үйл ажиллагаанд оролцоотой малчин	309.29	611.11		
АЖ-н үйл ажиллагаанд оролцоогүй малчин	341.43	606.25		

Малын тоо толгойг цаашид хэрхэн төлөвлөж байгаа байдал нь бүлгийн зохион байгуулалтын хувьд ялгаатай байгаа ба аль, аль бүсийн экосистемд бүлгийн гишүүн бус малчид илүү олон тооны малтай болохыг эрмэлзэж байгаагаа илэрхийлжээ. Харин аялал жуулчлалд оролцоотой хангайн бүсийн малчид хамгийн бага малын тоо толгойг төлөвлөсөн байна.

Эдгээр үзүүлэлтээс гадна нийт малчдын дунд амьжиргаагаа сайжруулах арга замын талаар нээлттэй хариултын хувилбараар тодруулахад (Зураг 6) 29 хувь нь мал аж ахуйг эрчимжүүлэх, 27 хувь нь малын үүлдэр угсааг сайжруулах, 15 хувь аялал жуулчлалын

компанитай хамтарч жуулчдад үйлчилгээ үзүүлэх, 13 хувь нь малчидтайгаа нэгдэн хамтарч аялал жуулчлалын үйлчилгээг гардан зохион байгуулж үзүүлэх гэж хариулсан байна.

Зураг 6. Амьжиргаагаа сайжруулах арга зам



НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Bramwell, B. L. (2008). Research perspectives on responsible tourism. *J. Sustainable Tourism* 16 (3), 253-257.
- Butler, R. (1995). *Introduction*. In: Butler, R., Pearce, D. (Eds.), *Change in Tourism: People, Places and Processes*. New York: Routledge.
- J.Vaske, J. (2008). *Survey research and Analysis. Applications in Parks, recreation and human dimensions*. Pennsylvania: Venture Publishing, Inc.
- Mihalic, T. (2006). *Tourism and its Environments: Ecological, Economic and Political Sustainability Issues*.
- MNET. (2018). *Tourism development in Mongolia*. Takhkent, Uzbekistan.
- Sinh, B. D. (2016). Stakeholder model application in tourism development in Cat Tien district, Lam Dong, Vietnam. *Journal of Advanced Research in Social Sciences and Humanities*, 73-95.
- Timothy Slaper, T. H. (2011). The Triple Bottom Line: What Is It and How Does It Work? *Indiana Business Review*.
- WTO. (2001). *The concept of sustainable tourism*.
- Zagarkhorloo, U. (2021). Managing Herder-Community based tourism: An Institutional framework for an Integrated Social-Ecological System. *Sustainability*, v13, issue7.
- Д.Гантөмөр. (2021). *Аялахуйн философи*. Улаанбаатар.
- МИРИМ. (2016). *Аялал жуулчлалын салбарын нийслэлийн нийгэм, соёлд үзүүлэх нөлөөллийн судалгааны тайлан*. Улаанбаатар.
- Ч.Наранчимэг, Д. (2009). *Бизнесийн статистик, эконометрикийн үндэс*. Улаанбаатар.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

УЛСЫН ТӨСВИЙН БОЛОН ГАДААД ХУДАЛДААНЫ АЛДАГДЛЫН УРТ ХУГАЦААН ДАХЬ ХАМААРАЛ

Ч.Наранчимэг¹, Ч.Даваасүрэн²

¹ Доктор (Ph.D.), профессор (СЭЗИС)

² Магистр (M.Sc.) (СЭЗИС)



Түлхүүр үг:

экспорт, төсвийн тэнцэл,
урсгал данс, импорт,
хугацааны хожимдол

Хураангуй

Монгол улсын төсвийн алдагдал 2022 оны гүйцэтгэлээр 0.98 их наяд төгрөгт хүрч оны үнээрх ДНБ-ий 1.9% - ийг эзэлж өмнөх оноос 4.8 хувиар буурсан үзүүлэлттэй байсан бол экспорт импортын дүнгээс 3,836.0 сая ам.доллаар давж, экспортын худалдаа 12,540.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 35.7% буюу 3,299.0 сая ам.доллаар өссөн, мөн импорт 8,704.0 сая ам.долларт хүрч 27.2% буюу 1,859.0 сая ам.доллаар нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 60.1% буюу 1,440.0 сая ам.доллаар нэмэгдүүлсэн байна. Иймээс бид улсын төсвийн алдагдал, худалдааны алдагдал хоёрын хоорондох урт хугацааны хамаарлыг тодорхойлох зорилгоор 2000-2022 оны хугацааны цуваан өгөгдөл ашиглан, жижиг нээлттэй эдийн засагт тохирох Мандел-Флемингийн онол арга зүйн хүрээнд авторегрессийн хугацааны хожимдолтой лаг тархалттай загвар ба динамик ердийн хамгийн бага квадратийн аргын загваруудыг ашиглан эмпирик судалгаа шинжилгээ хийлээ.

УДИРТГАЛ

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурч 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 17,198.5 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба эргэн төлөгдөх цэвэр зээлийн дүн 18,177.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 979.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оноос 1,929.5 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ ойролцоогоор 2% болж, өмнөх оноос 4.8%-аар буурсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 1,929.5 тэрбум төгрөгөөр буурсантай холбоотой юм. Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч 2022 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр урсгал тэнцэл 2,653.4 сая ам.долларын, санхүүгийн тэнцэл 2,715.3 сая ам.долларын алдагдалтай тус тус гарсан нь төлбөрийн тэнцэл

нийт дүнгээрээ 750.9 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оноос 529.3 сая ам.доллаар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 21,245.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 32.15 буюу 5,158.2 сая ам.доллаар өсөж, гадаад худалдааны тэнцэл 3,836.0 сая ам.долларын ашигтай гарсан байна. [1]

СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Төсвийн болон гадаад худалдааны алдагдлын хамаарлыг судалсан ажлууд дотоодын судлаачдын хувьд ховор байх бөгөөд төстэй ойролцоо сэдэв бүхий дараах судалгааны ажлуудыг авч үзлээ. Үүнд: Л.Даваажаргал, О.Цолмон (2019) Төсвийн бодлого эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү? судалгаанд төсвийн бодлогын эдийн засгийн өсөлтөнд нөлөөлдөг эсэхийг судалж төсвийн алдагдлаар тэлсэн бодлого нь эдийн засгийн өсөлтийг сааруулдаг, төсвийн бодлогын цочрол нь эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлдэг, импортын хэмжээг бууруулж, өр нэмэгдэж ханш суларч улмаар эдийн засгийн өсөлт саарч импортын хэмжээг бууруулдаг иймээс төсвийн алдагдлыг ямар ч тохиолдолд бууруулах шаардлагатай урт хугацаанд улсын төсвийн бүтцийн реформ хийх хэрэгтэй байна гэж дүгнэсэн. Д.Энхзаяа (2010) төсвийн ба урсгал тэнцлийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн судалгаанд төсвийн алдагдал ба урсгал тэнцлийн алдагдал буюу хос алдагдлын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тодорхойлж эдгээр нь зэрэг өсөхөд инфляци өсөхийн зэрэгцээ ханш сулрах үр дагавар гарч, төсөв, урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэх нь цаашид харилцан нэгнийхээ алдагдлыг өдөөж, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг улам хүчтэй болгох үр дагавартэй гэж дүгнэжээ. Иймээс манай улс макро эдийн засгийн төлөв байдал бодлогын нөлөөтэй гэхээс илүүтэй гадаад зах зээлийн төлөв байдлаар тайлбарлагдах талтай гэсэн дүгнэлтийг хийсэн. Мөн гадны судлаачид төсвийн алдагдал, гадаад худалдааны алдагдлын хамаарлыг судалсан маш олон гадны эмпирик судалгааны ажлууд байдаг. Тухайлбал, Saleh (2006), Acaravci (2018), Akbostanci, Tunc (2001), Alkswani (2000), Chowdhury (2007) нарын судлаачид улсын төсвийн алдагдал, гадаад худалдааны алдагдал, хос алдагдлын урт болон богино хугацааны хамаарлын эмпирик судалгааг хийж дүгнэжээ.

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН АЛДАГДАЛ

Монгол улсын төсвийн тэнцэл 1998 оноос хойш ихэнх жилүүдэд алдагдалтай байсан бөгөөд төсвийн алдагдлыг ихэвчлэн гадаад зах зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж ирсэн байна. 2003 онд Засгийн газрын бонд гаргаж, мөн өмч хувьчлалын орлогоор, 2008 онд харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр, 2009 онд олон улсын санхүүгийн байгууллагуудаас олгосон зээл болон хандивлагч орнуудын зээл, буцалтгүй тусламжаар, 2010 онд төсөвт шилжүүлэх урт хугацаатай бонд гаргах болон гадаад эх үүсвэрээс төслийн зээл авч тус тус санхүүжүүлж байсан. [2] Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогийн хэмжээ 1995 онд 144.6 тэрбум төгрөг байсан бол 2021 оны гүйцэтгэлээр 14.3 их наяд төгрөг, зарлага цэвэр зээлийн хэмжээ 1995 онд 132.1 тэрбум төгрөг байсан бол 2021 оны гүйцэтгэлээр 15.6 их наяд төгрөг болон өслөө. 2000 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 86.8

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, оны үнээрх ДНБ-ий 7.1%, 2005 онд 73.3 тэрбум төгрөгийн ашигтай гарч, оны үнээрх ДНБ-ий 2.4%, 2005 онд 41.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч, оны үнээрх ДНБ-ий 0.4%, 2015 онд 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, оны үнээрх ДНБ-ий 5 %, 2016 онд хамгийн өндөр буюу 3.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, оны үнээрх ДНБ-ий 15.3 % эзэлж байсан бол 2021 оны гүйцэтгэлээр 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, оны үнээрх ДНБ-ий 6.7% -г эзэлж байна. Харин 2022 онд ДНБ-ий 1.9% -ийг эзэлж өмнөх оноос 4.8 хувийн пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1. Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөг, 1995-2022 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн зардал нь урсгал зардал, хөрөнгийн зардал болон цэвэр зээлээс бүрддэг ба төсвийн алдагдлын өсөлтийн нэг шалтгаан нь урсгал зардал энэ зардлын хэмжээ жилээс жилд өссөөр байна. Төсвийн зардал нь хэмжээнээс гадна макро эдийн засаг болон эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй байдаг. Тухайлбал, урсгал зардлаас илүүтэйгээр хөрөнгийн зардлаа нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих сайн талтай бол урсгал зардлыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг богино хугацаанд дэмжих хэдий ч урт хугацаанд сөрөг нөлөөтэй байдаг.[3] Төсвийн зардлын бүтцээс харахад 2000 оноос бүтцэд бараг өөрчлөлт гараагүй урсгал зардал нийт төсвийн 70 орчим хувийг, хөрөнгийн зардал 20 орчим хувийг эзэлж иржээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-ийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг тогтоосон. (Хүснэгт 1)


Хүснэгт 1. Төсвийн алдагдлын тухайн жилийн оны үнээр ДНБ-д эзлэх %

Он	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
%	10.4	9.5	6.9	12.5	8.8	5.1	3.6	2.8	2

Эх сурвалж: Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

Төсвийн алдагдал, урсгал тэнцэл, засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувийг дараах зургаар харуулав. 2000 оноос макро эдийн засгийн байдал харьцангуй тогворжиж эдийн засаг өсч эхэлсэн боловч 2006 оноос төсөв тэлж, эдийн засаг халж эхэлсэн. 2006 онд төсвийн зарлага 61% хүртэл өсч улмаар 2008 онд 41% хүрч 2009 онд 3% хүртэл буурсан боловч 2010 оноос дахин өсч 2011 онд 62% -д хүрсэн. Төсвийн алдагдлын 22 жилийн дунджаар оны үнээрх ДНБ-ий 3.6%-ийг эзэлж хамгийн ихдээ 2015 онд 15.3%-ийг эзэлж байжээ. Хүснэгт 1-д харуулсан 2021 оны тогтоосон хувь хэмжээнд 2021 оны төсвийн алдагдлын хувь хэмжээ 8.8 хувьд хүрээгүй 6.7 хувь боловч энэ үзүүлэлт 2010 онд батлагдсан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ний 2 хувиас илүүгүй алдагдалтай, ашигтай байх гэсэн төсвийн тусгай шаардлагуудын нэгийг зөрчинө. Гэхдээ 2015 оны энэ хуулийн өөрчлөлтөөр төсвийн бодлогын дүрмийг жил бүрийн төсвийн төсөлтэй уялдуулан өөрчлөх боломжтой болгосон тул бодлогын дүрэм тогтворгүй хэвээр байна.[4]

Зураг 2. Төсвийн алдагдал, урсгал тэнцлийн ДНБ-д эзлэх хувь, төсвийн алдагдлын өсөлт, 2000-2021 он



Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

2022 онд Монгол улс дэлхийн 161 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 21,245.0 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 5,158.2 сая ам.доллар буюу 32.1 хувиар өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн 5 жил дараалан ашигтай гарчээ. (Хүснэгт 1). 2022 оны жилийн эцсийн байдлаар 3,836.0 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оноос гадаад худалдааны ашиг 1,440.0 сая ам.доллар буюу 60.1 хувиар өсөхөд импортын 1,859.0 сая ам.долларын, экспортын 3,299.0 сая ам.долларын өсөлт тус тус нөлөөлсөн байна. Экспорт импортын дүнгээс 3,836.0 сая ам.доллаароор давж, экспортын худалдаа 12,540.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оноос 35.7 хувь буюу 3,299.0 сая ам.доллаароор өссөн, мөн импорт 8,704.0 сая ам.долларт хүрч 27.2 хувь буюу 1,859.0 сая ам.доллаароор нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 60.1 хувь буюу 1,440.0 сая ам.доллаароор нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллараар/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирал					Өөрчлөлт	
	2018	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлт	12887.0	13747.0	12875.0	16087.0	21.245.0	5158.0	32.1
Экспорт	7012.0	7620.0	7576.0	9241.0	12540.0	3299.0	35.7
Импорт	5875.0	6128.0	5299.0	6846.0	8704.0	1859.0	27.2
Тэнцэл	1137.0	1492.0	2277.0	2396.0	3836.0	1440.0	60.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт болон импортын худалдаанд хөрш ОХУ болон БНХАУ ихэнх хувийг эзэлж ирсэн. Тухайлбал, 2022 байдлаар хөрш орнууд нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 76.8%, экспортын 85%, импортын 65%-ийг тус тус эзэлж байна. 2022 оны жилийн эцэст гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 64.4% буюу 13,608.3 сая ам.долларын худалдааг БНХАУ, мөн 13.1% буюу 2,703.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. Харин бусад улс оронтой хийсэн гадаад худалдаа нь нийт бараа эргэлтийн 22.5%-ийг эзэлж байна. БНХАУ нийт экспортын 89.1% /10.6 тэрбум ам.доллар/, нийт импортын 33.6% /3.04 тэрбум ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ-ын хувьд нийт экспортын 0.9 хувь, нийт импортын 28.2 хувь /2.6 тэрбум ам.доллар/-ийг тус тус эзэлж байна. Экспортын худалдаа 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,540.0 сая ам.доллар болж, цар тахлаас өмнөх буюу 2019 онтой харьцуулахад 4,920.0 сая ам.доллар буюу 64.6 хувиар өссөн бол 2021 оноос 5,158.2 сая ам.доллар буюу 32.1%-аар өссөн байна. (Хүснэгт 1). Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 10,542.0 сая ам.доллар болж, өмнөх оноос 3,031.6 сая ам.доллар буюу 40.4 хувиар өссөн, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 1,998.4 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 267.7 сая ам.доллар буюу 15.5% өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2022 оны гүйцэтгэлээр 91.9% болж, өмнөх оноос 10.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. [1] Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн зэрэг эрдсийн бүтээгдэхүүний 2022 оны зэсийн хилийн дундаж үнэ 2057.9 ам.дол/тн, нүүрсний хилийн дундаж үнэ 252.8 ам.дол/тн, төмрийн хүдрийн хилийн дундаж үнэ 90.5 ам.дол/тн байгаа нь экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

ОНОЛ АРГА ЗҮЙ

Мандел-Флемингийн загвараар жижиг нээлттэй эдийн засагт засгийн газрын болон гадаад худалдааны тэнцэл нь эерэг хамааралтай гэж үздэг. Жижиг нээлттэй эдийн засагт дараах (1) тэгшитгэлийг авч үзье.

$$Y = C + I + G + (X - M) \quad (1)$$

Энд, Y- ДНБ, G- засгийн газрын зардал, C- хувийн хэрэглээний зардал, (X - M) – нь цэвэр экспорт. Эсрэгээр дээрх хамаарал нь

$$Y = C + S + T \quad (2)$$

тэгшитгэлээр тайлбарлагдаж болно. Энд, Y- ДНБ, S –хадгаламж, C- хувийн хэрэглээний зардал, T – нь татвар байна. (1) тэгшитгэлд (2) тэгшитгэлийг орлуулж эмхэтгэвэл бид дараах

(3) гэсэн тэгшитгэлийг гарган авч цэвэр экспорт нь хувийн болон улсын хадгаламжийн нийлбэртэй тэнцүү болохыг харлаа.

$$X - M = (S - I) + (T - G) \quad (3)$$

Мандел-Флемингийн онол арга зүйн загвараар улсын төсвийн зардал нь хэрэглэгчийн зардал өссөний улмаас худалдааны алдагдлыг нэмэгдүүлдэг гэж тайлбарладаг. (Флеминг 1962, Мандел 1963). Түүнчлэн Кэйнсийн онолоор төсвийн алдагдал ихсэх нь дотооддоо шингээх байдлыг өдөөж улмаар импортийг тэлж энэ нь урсгал дансын алдагдлыг нэмэгдүүлнэ.

Эконометрик арга зүй

Тус судалгаанд 2000-2022 оны жилээрх хугацааны цуваан өгөгдлийг ашиглан төсвийн алдагдал, гадаад худалдааны алдагдлын урт хугацаан дахь хамаарлыг жижиг нээлттэй эдийн засагт тохирох Мандел-Флемингийн онол арга зүйн хүрээнд авторегрессийн хугацааны хожимдолтой лаг тархалттай загвар (ARDL) ба динамик ердийн хамгийн бага квадратийн аргын (DOLS) загваруудыг ашиглан эмпирик судалгаа шинжилгээ хийнэ. Загварыг үнэлэхэд шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг онолын загварт тулгуурлан сонгож, Үндэсний статистикийн хороо, Монгол банк, Сангийн яамны эх сурвалж бүхий төсвийн алдагдал (BD), гадаад худалдааны алдагдлын (TD) ДНБ -д эзлэх хувь, мөн хоёр хувьсагчийн логирифм хэлбэрийг эконометрик судалгаандаа авч үзсэн. Тоон мэдээлэл, үзүүлэлтүүдийн тогтвортой эсэхийг ADF (Augmented Dickey Fuller) ба DF-GLS шалгууруудаар шалгаж тухайн өгөгдлийг эмпирик шинжилгээнд ашиглаж болох эсэхийг авч үзнэ. ADF шалгуур нь дараах тэгшитгэлд үндэслэдэг.

$$\Delta y_t = \alpha y_t + x_t \delta + \beta_1 \Delta y_t + \beta_2 \Delta y_{t-2} + \dots + \beta_p \Delta y_{t-p} + v_t \quad (4)$$

Энд, y_t – хугацаан цуваа, v_t - алдааны илэрхийлэл

DF-GLS шалгуур нь стандарт ADF тестийн тэгшитгэлийг үнэлэхтэй холбогдох бөгөөд анхны y_t – цувааны хувьд трендийг арилгасан ялгавар бүхий дараах тэгшитгэлээр тодорхойлогдоно.

$$\Delta y_t^d = \alpha \Delta y_{t-1}^d + \beta_1 \Delta y_{t-1}^d + \dots + \beta_p \Delta y_{t-p}^d + v_t \quad (5)$$

Энд, y_t^d – трендийг арилгасан цуваа, v_t - алдааны илэрхийлэл.

DF-GLS харьцаа нь зөвхөн тогтмолтой Дикэй-Фүллэр тархалттай ба ассимптот тархалт нь хэрвээ тогтмол болон трендийг хоёуланг нь агуулбал өөрчлөгдөнө.

Авторегрессийн лаг тархалттай загвар (ARDL) ба коинтеграци

Энд бид хоёр аргачлал загварыг ашиглан улсын төсвийн болон худалдааны алдагдлын урт хугацааны хамаарлыг судална. Эхний аргачлал нь коинтеграцийн техник буюу авторегрессийн лаг тархалттай загвар (ARDL) юм.[4] Энэ нь хувьсагч бүрийн хувьд алдаа засварлалтын загварын хэлбэрээр урт хугацааны хамаарал байгаа эсэхийг илрүүлэх процедур юм. Эндээс бид хязгаарлалтгүй дараах загварын хэлбэрүүдийг авч үзнэ.

$$\log\left(\frac{BD}{GDP}\right) = \alpha_0 + \sum_{i=1}^n \alpha_i \Delta \log\left(\frac{BD}{GDP}\right)_{t-i} + \sum_{i=0}^n \alpha_i \Delta \log\left(\frac{TD}{GDP}\right)_{t-i} + \alpha_1 \log\left(\frac{BD}{GDP}\right)_{t-1} + \alpha_2 \log\left(\frac{TD}{GDP}\right)_{t-1} + \mu_{1t} \quad (6)$$

$$\ln\left(\frac{TD}{GDP}\right) = \beta_0 + \sum_{i=1}^n \beta_i \Delta \log\left(\frac{TD}{GDP}\right)_{t-i} + \sum_{i=0}^n \beta_i \Delta \log\left(\frac{BD}{GDP}\right)_{t-i} + \beta_1 \log\left(\frac{TD}{GDP}\right)_{t-1} + \beta_2 \log\left(\frac{BD}{GDP}\right)_{t-1} + \mu_{2t} \quad (7)$$

Энд $\log(BD)$, $\log(TD)$ нь харгалзан улсын төсвийн болон гадаад худалдааны алдагдлын натурал логарифм хувьсагчид, Δ – ялгавар оператор, μ_{1t}, μ_{2t} – стохастик алдааны хэсэг. Урт хугацаан дахь хамаарлыг шинжлэхийн тулд $\alpha_1, \alpha_2, \beta_1$ ба β_2 коэффициентүүдийн хувьд хязгаарлалт тавьж таамаглал шалгана. (6) загварын хувьд үндсэн таамаглалыг $H_0: \alpha_1 = \alpha_2 = 0$, харин (7) загварын хувьд үндсэн таамаглалыг $H_0: \beta_1 = \beta_2 = 0$ F тестээр шалгаж урт хугацаандаа хамааралтай байгаа эсэхийг дүгнэнэ.

Урт хугацааны хамаарлыг тогтоох DOSL арга зүй

Сток болон Ватсон нарын 1993 онд хөгжүүлсэн загвар болох хамааран болон үл хамааран хувьсагчдын хоорондох урт хугацааны хамаарлыг тогтоох хоёр дахь арга зүйг авч үзье. Энэ процедур нь хамааран хувьсагчийг үл хамааран хувьсагчдийн бүх түвшин, хугацааны хожимдол лаг болон I(1) агуулсан регрессийг үнэлнэ. Эдгээр үл хамааран хувьсагчид нь хазайлтыг багасгах ба мөн түүврийн хэмжээ бага байгаагаас шалтгаалах хазайлтыг ч багасгана. DOLS загварын тэгшитгэл нь дараах байдлаар тодорхойлогдоно.

$$X_t = \gamma_0 Z + \varphi_1 Z_t + \sum_{j=-p}^p \gamma_j \Delta Z_{t-j} + \varepsilon_t \quad (8)$$

Энд, X_t – хамааран хувьсагч, Z_t – нь вектор үл хамааран хувьсагч, Δ – хожимдлын оператор

ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Интеграцийн түвшинг тодорхойлохын тулд ADF болон DF-GLS хоёр шалгуурийг ашигласан бөгөөд эдгээр хоёр тестийн үр дүнд үр дүнг хүснэгт 2-д харуулж 1 болон 5 хувийн ач холбогдлын түвшинд хувсагчдын I(0) процесс стационар бус, I(1) процесс нь стационар байна гэж дүгнэсэн.

Хүснэгт 2. Нэгж язгуурын тестийн үр дүн

Хувьсагчид	ADF шалгуур		DF-GLS шалгуур	
	Level	First difference	Level	First difference
log (BD)	-3.84**	-4.30*, **	-2.11**	-4.07
log (TD)	-1.53	-4.64*, **	-1.56	-4.67*, **

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

* - 1% ба ** - 5% хувийн ач холбогдлын түвшинд статистик ач холбогдолтой.

Дараа нь бид ARDL загвараар хоёр хувьсагчийн хоорондох урт хугацааны хамаарлыг тодорхойлохдоо өгөгдсөн ач холбогдлын түвшинд 2 критик утгуудыг авч үзсэн. Эхнийх нь бүх хувьсагчид нь I(0), хоёр дахь нь I(1) түвшинд тооцоолсон F статистикууд нь дээд критик

хязгаарын утгыг давбал үндсэн таамаглалыг няцаах үндэслэлтэй байна. Хэрвээ F тест статистикийн утга дээд, доод критик утгуудын хооронд оршдог бол тестийн үр дүнг дүгнэх боломжгүй гэж үзнэ. Эцэст нь F тест статистикийн утга доод хязгаарын критик утгаас бага бол коинтеграцигүй байна. ARDL тестээр шалгахын өмнө хугацааны хожимдлын р нь вектор авторегрессийн загварын тусламжтай тодорхойлогдсон юм.

Хүснэгт 3. Урт хугацааны хамаарал байгаа эсэхийг тогтоох F тест статистик

	Хамааран хувьсагч	
	log(BD)	log(TD)
Тооцоолсон F статистик	0.78	2.68**
Критик	Доод хязгаар	Дээд хязгаар
5%	3.62	4.16
10%	3.02	3.51

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

** - 5 хувийн ач холбогдлын түвшинд статистик ач холбогдолтой.

Хязгаарын тестийн үр дүнг хүснэгт 3-т харуулав. Үр дүнгээс харахад урт хугацааны хамаарал хэрвээ улсын төсвийн алдагдал нь хамааран хувьсагч байх үед оршиж байгаа бөгөөд F тест статистикийн утга нь доод критик хязгаарын утгаас бага байна. Хэрвээ гадаад худалдааны алдагдал нь хамааран хувьсагч байвал урт хугацаан дах хамаарал тодорхойлогдохгүй ба өөрөөр хэлбэл F тест статистикийн утга дээд, доод критик утгуудын хооронд оршиж байна.

Хүснэгт 4. DOLS арга зүйгээр тооцсон урт хугацаан дах хамаарлын коэффициентууд

	Үл хамааран хувьсагчид			
	log(TD)		log(BD)	
	коэффициент	t-харьцаа	коэффициент	t-харьцаа
Тогтмол	1.58	2.87 [0.01]	1.26	3.71 [0.00]
log(BD)	1.07	1.30 [0.09]	-	-
D(log(BD(1)))	1.10	2.71 [0.08]	-	-
log(TD)	-	-	-0.18	-0.64 [0.52]
D(log(TD(1)))	-	-	0.31	-0.80 [0.39]
D(log(TD(2)))	-	-	-0.13	-0.27 [0.64]
R2	-	0.33	-	0.45
F статистик	-	2.97	-	2.55
Prob (F статистик)	-	0.07	-	0.08

Эх сурвалж: Судлаачдын тооцоолол

DOLS арга зүйгээр бид урт хугацааны хамаарлын коэффициентуудыг тооцсон. Хүснэгт 4-т нэгтгэсэн үр дүнгээс харахад улсын төсвийн алдагдал нь урт хугацаандаа гадаад худалдааны алдагдалд эерэг нөлөөг үзүүлдэг гэж хэлэх статистик нотолгоо олдсон бөгөөд урт хугацаанд үзүүлэх гадаад худалдааны алдагдлын мэдрэмж нь улсын төсвийн алдагдлаас нэгээр их байна. Улсын төсвийн алдагдал нь гадаад худалдааны алдагдлыг дараагийн жилүүдэд өдөөж өгөх бол урт хугацаандаа гадаад худалдааны алдагдал улсын төсвийн алдагдалд нөлөө үзүүлэхээргүй байна.

ДҮГНЭЛТ

Энэ судалгаагаар бид улсын төсвийн болон гадаад худалдааны алдагдлын урт хугацааны хамаарлыг тэсвэртэй коинтеграцийн техник, арга зүйг ашиглан тодорхойллоо. Үүнд;

1. Улсын төсвийн алдагдал нь урт хугацаандаа гадаад худалдааны алдагдлыг бий болгодог мөн эерэг нөлөө үзүүлж байна.
2. Гадаад худалдааны алдагдал нь улсын төсвийн алдагдалд нөлөө үзүүлдэггүй болохыг судалгааны үр дүнгээр харлаа.

Эндээс бид хүмүүсийг илүү их хадгаламжтай болохыг уриалах нь хадгаламж болон хөрөнгө оруулалтын хоорондын зөрүүг багасгах ба улмаар цахилгаан үйлдвэрлэл, байгалийн баялаг, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн хөгжил нь экспортийг нэмэгдүүлж татварын орлогыг өсгөх үндэс суурь болно гэж судлаачдын зүгээс үзэж байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- [1] УИХ-ийн тамгийн газар. МУ -ын макро ЭЗ-ийн 2022 оны эцсийн урьдчилсан гүйцэтгэл
- [2] Л.Даваажаргал, О.Цолмон. “Төсвийн бодлого эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү?”, 2019
- [3] Л.Энхтайван, Ц.Батсүх, Л.Ариунаа. Мөнгөний болон төсвийн бодлогыг зохистой уялдуулах нь, 2017
- [4] Б.Эрдэнэбат. “Хугацаан цуваан эконометрик”. УБ, 2017
- [5] Д.Энхзаяа. Төсвийн ба урсгал тэнцлийн алдагдлын эдийн засагт үзүүлэх нөлөө, 2010
- [6] Д.Даваасүх, Д.Энхзаяа. “Хос алдагдал ба хөтөлбөрийн санхүүжилт”, 2013
- [7] Ч.Наранчимэг, Ч.Даваасүрэн “Улсын төсвийн алдагдлын макро эдийн засагт үзүүлэх нөлөө”, 2022
- [8] Acaravci Ali, Ozturk Illan. “Twin deficits Phenomenon: Emperical evidence from the ADRL” (2013)
- [9] Chowdhury K and Saleh A S. “Testing the Keynesian proposition of twin deficits in the presence of the trade liberalization: Evidence from the Sri Lanka” (2007)



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

ИННОВАЦ БА ЭНТРЕПРЕНЕРШИП, МАРКЕТИНГ,

ОЛОН УЛСЫН БИЗНЕС

ISBN: 978-9919-9906-1-9

ДИЖИТАЛ МАРКЕТИНГИЙГ АШИГЛАН БРЭНД ХОНОГШУУЛАЛТ БИЙ БОЛГОХ БОЛОМЖИЙН СУДАЛГАА

Э.Жаргалмаа

¹ Магистр (МВА) СЭЗИС



Түлхүүр үг:

Дижитал маркетинг,
брэнд хоногшуулалт,
контент бүтээх

Хураангуй

Дэлхий дахинаа технологийн шилжилт эрчимтэй хийгдэж буй энэ эрин үед хүн бүх төрлийн бизнесийн байгууллагууд мөн хувь хүмүүс дижитал шилжилт хийх зайлиггүй шаардлагатай болж байна. Дижитал эрин үе нь брэндийн хувьд байгууллагад олон давуу талыг бий болгож, брэнд болон хэрэглэгчдийн хооронд эерэг харилцааг тогтоож, өрсөлдөөний давуу талыг бий болгож байгаа ч зарим талаараа сул талыг бий болж байдаг. Маркетингийн мессежийг хэсэгчлэн хувааж, янз бүрийн дижитал сувагт бүтээлчээр оруулах ба хэрэглэгчдэд зөв цагт нь хүргэх ёстой. Байгууллагууд хэрэглэгчдээ танихаа больсон гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй бөгөөд технологи, мэдээллийн урсгал нь хэрэглэгч байгууллагаас үргэлж хэдэн алхмын өмнө байх боломжийг олгож байдаг. Иймд хэрэглэгч байгууллагаас илүү хурдан хөгждөг. Дижитал эрин үеийн хэрэглэгчдийн худалдан авалтын шийдвэр гаргалт нь дижитал сувгуудын нөлөөллөөс хамааран брэндэд үнэнч байх байдал нь буурдаг байна. Сошиал медиад хамгийн түгээмэл ашиглагддаг контентуудыг жишээ болгон авч хэрэглэгчдэд брэндийн мессежийг зөв хүргэх, брэнд хоногшуулалт бий болгох нь зүйтэй. Тодорхой брэндийг өрсөлдөгчөөс ялгарахад тусладаг зүйл бол бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, сэтгэлд хоногшсон контент хүргэх нь чухал байна. Ямар сурталчилгаа хүний чихэнд хоногшиж, аманд аялагдаж, ам дамжигдан яригдах талаар анхаарлаа хандуулж “Яаж олон хүнд хүргэх вэ?” бус “Хэрхэн олон хүний анхаарлыг татах вэ?” гэх асуултанд хариулагдах контент бүтээж хэрэглэгчдийн оюун санаанд брэндийг хоногшуулах нь зүйтэй.

УДИРТГАЛ

Санхүү эдийн засгийн их сургуулийн “UFE SCIENCE NAADAM 2023” эрдэм шинжилгээний бага хурлын хүрээнд “Дижитал маркетингийг ашиглан брэнд хоногшуулалт


бий болгох боломжийн судалгаа” сэдвийн хүрээнд судалгааны ажил өрнүүлж, онол практикийн уялдаа холбоог шүүн тунгааж, шинэлэг санаа, шийдлийг дэвшүүлж ажиллах юм. Дижитал орчинд явагдаж буй маркетингийн үйл ажиллагаа нь дижитал эрин үеийн хэрэглэгчдэд хүрч ажиллаж чадаж байгаа эсэх талаар өнөөгийн байдлыг шинжилж, тулгамдаж буй асуудлыг тодруулж, холбогдох санал зөвлөмжийг боловсруулж, гарц гаргалгааг дэвшүүлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Аж үйлдвэрийн IV хувьсгал нь бидэнд шинэ эрин буюу “дижитал эдийн засаг”-руу авчирсан бөгөөд дижитал шилжилтийг бизнестээ нэвтрүүлэхэд шинэ сорилтуудыг бий болгосон. Дижитал эрин үе нь брэндийн хувьд байгууллагад олон давуу талыг бий болгож, брэнд болон хэрэглэгчдийн хооронд эерэг харилцааг тогтоож, өрсөлдөөний давуу талыг бий болгож байгаа ч зарим талаараа сул талыг бий болж байдаг. Дэлхий дахинаа 90 гаруй сая хүн үздэг “Super bowl” тэмцээнд 30 секундийн сурталчилгааг байршуулахын тулд брэндүүд 5 сая орчим доллар төлдөг. Энэ хугацаанд тухай брэнд сайн сурталчилгаа хийж чадвал түүнийгээ аварч болно, харин муу сурталчилгаа хийвэл брэндээ устгах хэмжээний ч аюултай. Мэдээлэл нь үйлдвэрлэгчид болон хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй байдаг тул тэдгээрийг хамгийн сайн аргаар ашиглах ёстой. Орчин үеийн технологи, дижитал эрин үе гарч ирснээр хэрэглэгчдийн хандлага, ухамсар өөрчлөгдөж байгаа ба залуу үеийнхэн дижитал медиаг илүү өргөн ашиглах болсон. (Boric S. &., 2016)

2023 оны байдлаар дэлхий даяар 5.18 тэрбум интернэт хэрэглэгч байгаа буюу энэ нь нийт хүн амын 64.6%-тай тэнцэнэ. Үүнээс 4.8 тэрбум идэвхтэй сошиал хэрэглэгч байгаа нь дэлхийн нийт хүн амын 59.9%-тай тэнцэж байна. Энэ үзүүлэлт нь 2022 онтой харьцуулахад 180 сая хэрэглэгч буюу 3.9%-р өссөн үзүүлэлт юм. Манай орны хувьд 2023 оны байдлаар 2.5 сая идэвхтэй сошиал хэрэглэгч байгаа нь нийт хүн амын 73%-тай тэнцэж байна. Дэлхийн нийт сошиал идэвхтэй хэрэглэгчид /16-64 нас/-н 59.3% нь мэдээлэл авах зорилгоор интернэтийг ашигладаг бол 43.1% нь бараа бүтээгдэхүүн болон брэндийн талаар судлахын тулд интернэтийг ашигладаг. (Kemp, 2023) Үүнээс харахад Монгол улсад төдийгүй дэлхий дахинаа дижитал хэрэглээ нэмэгдэж байгаа бөгөөд цаашдаа ч тогтмол нэмэгдэх хандлагатай байна. Брэнд мессежүүд нь янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр, телевиз, сонин заримдаа цахим шуудангаар дамжуулан хэрэглэгчдэд хүрдэг. Өмнө нь хэрэглэгч зөвхөн лангуун дээрх бараагаа харьцуулж үзэн өөрт тохирсон брэндийг сонгодог байсан бол одоо дижитал маркетингаар дамжуулж хязгааргүй хэмжээний мэдээлэлтэй болох болсон. Энэ нь зах зээл дээрх өрсөлдөөнийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох, хэрэглэгчдэд оновчтой мессежийг илгээх хэцүү сорилтыг бий болгосон.

Уламжлалт маркетинг нь хэвлэл, телевиз, радио, шуудан, утсаар дамжуулан сурталчилгааны үндсэн дөрвөн сувгийг ашигладаг байсан. Дижитал эрин үе эхлэхээс өмнө эдгээр нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар шаардлагатай мэдээллийг өгдөг байсан. Дижитал маркетинг нь компьютер, ухаалаг гар утас, таблет зэрэг электрон төхөөрөмжийн тусламжтайгаар оролцогч талуудыг холбодог маркетинг юм. Иймд интернэтэд холбогдох боломжтой ямар ч төрлийн төхөөрөмж дижитал маркетингд оролцох боломжтой. Сошиал медиагаар дамжуулан бүтээгдэхүүн, брэндийн мессежийг хүргэх, хэрэглэгчийн үнэнч байдлыг нэмэгдүүлэх зэрэг маш олон боломжийг бий болгосон. (Desai, 2019) Дижитал маркетингийн мөн чанар нь зорилтот бүлэгтэй тасралтгүй холбоотой байж, хэлэлцээ хийдгээрээ уламжлалт маркетингаас ялгаатай.

Зураг 1.5 Шинэ дижитал маркетинг



(Boric S. &, 2016)

Маркетингийн мессежийг хэсэгчлэн хувааж, янз бүрийн дижитал сувагт бүтээлчээр оруулах ба хэрэглэгчдэд зөв цагт нь хүргэх ёстой.

Байгууллагууд хэрэглэгчдээ танихаа больсон гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй бөгөөд технологи, мэдээллийн урсгал нь хэрэглэгч байгууллагаас үргэлж хэдэн алхмын өмнө байх боломжийг олгож байдаг. Иймд хэрэглэгч байгууллагаас илүү хурдан хөгждөг. Дижитал эрин үеийн хэрэглэгчдийн худалдан авалтын шийдвэр гаргалт нь дижитал сувгуудын нөлөөллөөс хамааран брэндэд үнэнч байх байдал нь буурдаг байна.

Зураг 6.2 Шинэ хэрэглэгчдийн худалдан авалтын шийдвэр гаргалт



(Boric S. &, 2016)

Иймд дижитал маркетингийг брэндийн дүр төрхийг төлөвшүүлэх, бэхжүүлэхэд ашиглах боломжтой байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ:

Эрдэм шинжилгээний хурлын хүрээнд гүйцэтгэж буй судалгааны арга зүй, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй харуулж өгсөн ба судалгааны ажлын талаарх ерөнхий мэдээллийг доорх хүснэгтэд тусгав.

Хүснэгт 2.11 Судалгааны ажлын ерөнхий мэдээлэл

№	Мэдээллийн өгөгдөл	Тайлбар
1	Судалгааны ажлын нэр	Дижитал маркетингийн өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаа
2	Судалгааны ажлын зорилго	Дижитал шилжилтийн эрин үед маркетингийн өнөөгийн байдлын асуудлууд ямар түвшинд тавигдаж байгааг тодорхойлох
3	Судалгааны ажлын бүтэц	Судалгааны ажил нь 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд: ✓ I хэсэг: Дижитал хэрэглээний чиг хандлыг тодорхойлох /8 асуумж/ ✓ II хэсэг: Оролцогчдын ерөнхий мэдээлэл /3 асуумж/
4	Судалгааны ажлын хэлбэр	Цахим
5	Судалгааны ажилд ашиглах талбар	Google forms
6	Судалгааны ажлын цахим холбоос	https://forms.gle/64MSZi4XDCxqWAFQA

Судалгааны ажлын арга зүй:

Судалгааны ажлыг цахим хэлбэрээр гүйцэтгэж, боловсруулсан бөгөөд арга зүйг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 12.2 Судалгааны ажлын арга зүй

№	Арга зүй	Тайлбар
1	Судалгааны арга	Тоон судалгаа – Асуулгын арга
2	Судалгааны түүвэр, тоо	Санамсаргүй түүвэр, 60
3	Судалгааны хугацаа	Ажлын 2 хоног

Судалгааны ажлын үр дүн:

Цахим талбарт боловсруулагдсан судалгааны ажил нь ажлын хоёр хоногийн туршид цахим хэлбэрээр, санамсаргүй түүврээр 60 оролцогч оролцсон. Судалгаанд оролцогчдын хүйсийн хувьд авч үзвэл 63.3% нь эмэгтэй, 36.7% нь эмэгтэй бөгөөд насны бүлгийн хувьд 70% нь 18-26 нас, 23.3% нь 27-35 нас, 5% нь 36-42 нас үлдсэн нь бусад насны ангилалд хамаарагдана. Нийгмийн статусын хувьд авч үзвэл 56.7% нь оюутан, 38.3% нь хувийн байгууллагын албан хаагч, үлдсэн бүлгэм нь хувиараа бизнес эрхлэгч нар байна.

Нийт оролцогчдын 95% нь өдөр тутамдаа социал орчинд “Facebook”, “Instagram”, “Youtube” гэсэн платформуудыг тогтмол ашигладаг байна.

Зураг 2.7 Оролцогчдын дижитал хэрэглээний чиг хандлага



Оролцогчдын 93.3% нь гар утсаараа социал орчинд ханддаг бол үлдсэн хэсэг нь суурин болон зөөврийн компьютерээс ханддаг байна. Оролцогчдын 98.3% нь социал орчинд нэвтэрсэн үедээ аливаа байгууллагын маркетингийн зар сурталчилгаатай таарсан байна. Энэ үзүүлэлтээс харвал дижитал маркетингийн орчин идэвхтэй байдлаар явагдаж байна.

Зураг 2.8 Оролцогчдын дижитал хэрэглээний чиг хандлага


Төрөл бүрийн платформд олон хэрэглэгчийн өмнө явагдаж байгаа маркетингийн үйл ажиллагааг оролцогчид хэрхэн хүлээн авч, ямар хариу үйлдэл тухай асуухад дараах үр дүнтэй байна.



Аливаа маркетингийн сурталчилгаа гарч ирсэн тохиолдолд та ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ?




Танд дээр дурдагдсан платформуудыг ашиглаж байх үед гарч ирдэг маркетингийн сурталчилгаа ашиггүй төвөгтэй мэт санагддаг уу?



Эдгээр гарч ирж буй маркетингийн сурталчилгаа нь ашиггүй төвөгтэй мэт санагддаг эсэх тухай асуухад үр дүн дараах байдалтай байна.


Дараах асуулгаар дижитал орчин дэх маркетингийн үйл ажиллагаа, сурталчилгааны үнэлгээний шалгуур бүрд дундаж үнэлгээ өгсөн байгааг доорх үзүүлэлтээс харна уу.

Зураг 2.9 Маркетингийн сурталчилгаанд өгсөн үнэлгээ




Сошиал орчинд хамгийн их үзэлтгэй контентийн төрлүүдээс хамгийн их давтагддаг болон сэтгэлд хоногшин үлдэх тухай хамаарлын асуулга авахад үр дүн дараах байдалтай байна. Оролцогчдын дийлэнх хэсэг нь сошиал орчинд өдөр тутмын амьдралдаа идэвхтэй байж, интернетийн сүлжээгээр дамжуулан олон төрлийн платформуудыг ашигладаг.

Зураг 2.10 Сошиал контентуудын хамаарал



Энэ хугацаандаа дижитал маркетингийн сурталчилгаатай тогтмол таардаг бөгөөд хэт их давтамжтай байгаа нь хэрэглэгчдийг залхаах төвөгшөөх хандлагатай болжээ. Хэрэглэгчдэд хамгийн түгээмэл хүрч буй контентуудын төрлөөс харагдах давтамж болон сэтгэлд хоногшин үлдэх байдлаар нь ангилан үзвэл анимешн болон мэмэ контентууд хамгийн ихээр сэтгэлд хоногшин үлддэг байна.

Зураг 11 Контент бүтэх



Байгууллагууд дижитал маркетинг хийхдээ эдгээр контентуудаас хамгийн ажиллагаа ихтэй бүтдэг болон хэрэглэгчдэд хамгийн их хүрдэг /viral/ байдлаар нь харвал дараах байдалтай байна.

Дижитал маркетингаар дамжуулж хэрэглэгчдэд оновчтой зөв мэдээллийг хүргэх нь чухал бөгөөд байгууллагууд өөрсдийн гэсэн имиж, брэндингийг бүрдүүлэх нь чухал бөгөөд

чанартай цөөн тооны контентыг хүргэх шаардлагатай байна. Бусдаас ялгарч хэрэглэгчид цоо шинэ шийдлийг санал болгож сэтгэлд хоногших нь брэнд бүтээх үндсэн суурь байдаг.

ДУГНЭЛТ:

Дижитал орчин эрчимтэй хөгжиж буй энэ үед байгууллагууд олон тооны хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээг сурталчилах нэг арга зам нь дижитал маркетингийг ашиглах байна. Сошиал медиа орчинд контентын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгууллага болон хувь хүн бүр контент үйлдвэрлэгч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болж байна. Жишээлбэл, фэйсбүүкийн мэдээний тойм хэсэгт олон тооны контент харагдаж байдаг ба хамгийн их хамааралтай гэснийг хиймэл оюун ухаанаар шүүж харуулдаг. Фэйсбүүк пэйжийн алгоритм органик байдлаар харагдах хувийг 2018 онд багасгаж 1-2%-руу оруулсан ба цаашдаа ч улам багасах төлөвтэй байна. Иймд чанартай контент илүү ялгарч харагддаг. Их контент үйлдвэрлэх нь их цаг хугацаа шаардах ба үүнээс болж контентын чанар мууддаг. Хийгдэж буй контент бүхэн брэндийн USP эсвэл ESP тулгуурлаж байна. Контент шууд борлуулалтад хөтлөх, брэнд хоногшуулалт үүсгэх, brand awareness үүсгэх гэх зэрэг тодорхой зорилгын хүрээнд хийгдсэнээр энэ нь эргээд өгөөжтэй, үр дүнтэй байна. Хэрэглэгчдэд харуулсан харуулаагүй ялгаагүй, брэндийн нэр хүнд өсгөх, хэрэглэгчдийн залхаах, үр өгөөжгүй контент хийхгүй байх шаардлагатай. Хэрэглэгчдийн хүслийг үргэлж санаж, тэдний хандлагыг мэдэх нь туйлын чухал юм.

САНАЛ ЗӨВЛӨМЖ:

Тодорхой брэндийг өрсөлдөгчөөс ялгарахад тусладаг зүйл бол бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, сэтгэлд хоногшсон контент хүргэх нь чухал байна. Ямар сурталчилгаа хүний чихэнд хоногшиж, аманд аялагдаж, ам дамжигдан яригдах талаар анхаарлаа хандуулж “Яаж олон хүнд хүргэх вэ?” бус “Хэрхэн олон хүний анхаарлыг татах вэ?” гэх асуултанд хариулагдах контент бүтээж хэрэглэгчдийн оюун санаанд брэндийг хоногшуулах нь зүйтэй.

Хэрэглэгчтэй тасралтгүй харилцаа холбоо тогтоож, шаардлагатай мэдээллийг чанартай контентоор дамжуулах нь чухал бөгөөд цуврал видео контент үйлдвэрлэх хэрэгтэй. Байнга шинэ контентын санаа олох нь өөрөө маш их цаг зав шаардах ба бас хүндрэлтэй. Контентын үндсэн шинж, зорилгыг нь хадгалж агуулга болон хэлбэрийг сонирхолтой байдлаар өөрчилж урт хугацаанд явуулах нь зүйтэй.

Хэрэглэгчид аливаа түүх өгүүлсэн, бодит явдал, дурсамж агуулсан контентыг илүүтэй уншиж бас үзэж цааш нь онлайн орчинд түгээж байна. Контент түүх өгүүлснээр илүү баялаг, "амьтай" болж илүү сонирхол татах, цаашлаад хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөх нэг сэжиг болж өгдөг.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- Boric, S. &. (2016). Analysis of digital marketing and branding for the purpose of understanding the consumers in digital age. *International Conference on Applied Internet and Information*, (pp. 375-381).
- Boric, S. &. (2016). nalysis of digital marketing and branding for the purpose of understanding the consumers in digital age. (pp. 375-381). *International Conference on Applied Internet and Information Technologies*.
- Desai, D. M. (2019). Digital Marketing: A Review. *Fostering Innovation, Integration and Inclusion Through Interdisciplinary Practices in Management* (pp. 196-200). *International Journal of Trend in Scientific Research and Development*.
- Kemp, S. (2023). *Digital 2023 April global statshot report*. Data reportal.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БА ТЕХНОЛОГИЙН
МЕНЕЖМЕНТ

ISBN: 978-9919-9906-1-9

ТООН ГАРЫН ҮСГИЙН АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ НЬ (ГАДААДАД ОРШИН СУУГЧ ИРГЭДИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Ц.Соёлмаа¹, Л.Эрдэнэсайхан²

СЭЗИС, МСМТ^{1, 2}

erdenesaikhan.l@ufe.edu.mn, soyolmaatsogt2@gmail.com



Түлхүүр үг:

Төрийн цахим үйлчилгээ,
гадаадад оршин суугаа
иргэн

Хураангуй

Энэ судалгааны ажлаар гадаадад оршин суугч Монгол улсын иргэд цахим орчинд тоон гарын үсэг ашиглан төрийн үйлчилгээг аюулгүй, найдвартайгаар авах боломж нөхцөл, тулгарч буй асуудал, шийдвэрлэх боломж болон тоон гарын үсгийн ашиглалтыг сайжруулах арга замуудыг тодорхойлохыг зорьлоо. Тоон гарын үсгийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр бичигдсэн судалгааны ажлууд, онолын суурь ойлголт ховор байсан тул чанарын судалгаа хийв. Судалгаанд ЦХХХЯам, нэг банк, хоёр гэрчилгээ олгогч байгууллагын (ГОб) төлөөллийг оролцуулан, нийт 6 экспертээс ярилцлагын аргаар судалгаа авсан. Өгөгдлийг эмх цэгцтэй боловсруулахын тулд индексийн хүснэгт болон сэдэвчилсэн хүснэгтийг бэлтгэсэн. Дараа нь судалгааны ижил төстэй, ялгаатай байдал, уялдаа холбоог гаргахын тулд түлхүүр үгээр агуулгын шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнг боловсруулахдаа анх дэвшүүлсэн судалгааны асуултын дагуу, хариултын найдвартай байдлыг хангах үүднээс онолын судалгаатай харьцуулах байдлаар дүгнэсэн.

Удиртгал

Техник технологи өдрөөс өдөрт хурдацтайгаар хөгжиж буй энэ цаг үед тогтсон хэв маяг болох тамга, гарын үсэгтэй цаасан баримт бичгээс хэт хамаарах нь үр ашиггүй цаг үрэх, хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмжийг бууруулах, үргүй зардлыг нэмэгдүүлэх нөхцөл болж байна. Тоон гарын үсэг хэрэглээнд бүрэн нэвтэрснээр эдгээр асуудлыг шийдвэрлэхээс гадна, хувь хүн болон албан байгууллагууд орон зай, цаг хугацаанаас үл хамааран төрийн байгууллагатай үүсэх аливаа албан харилцааг цахимаар явуулах боломжтой билээ.

Дэлхийн улсуудад 1980 оноос, Монгол улсад 2000 оноос эхлэн мэдээллийн технологийг компани, аж ахуйн нэгжүүдэд өргөн нэвтрүүлж байгууллага бүр өөрийн ажил, үйлчилгээг интернетийн орон зайд явуулах болсон. Шинжлэх ухаан техникийн дэвшил, нийгмийн

амьдралын глобаль өөрчлөлт явагдаж буй өнөөгийн мэдээллийн нийгмийг үр нөлөөтэй цахим албан хэрэг хөтлөлтгүйгээр төсөөлөх аргагүй болсон.

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем нь иргэнийг танилт нэвтрэлтийн ДАН системийг ашиглаж нэвтрүүлдэг. Тус системд 2021 оны 6-р сарын 1-н байдлаар 908,842 иргэн бүртгэгдсэн байна. ДАН системийн үндсэн 3 төрлийн танилт байдаг. Үүнд :

1. Онлайн банкны эрхээ ашиглан нэвтрэх
2. Өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаар ашиглан нэвтрэх
3. Тоон гарын үсэг ашиглан нэвтрэх хувилбарууд байдаг.

Энэхүү нэвтрэлтийн боломжууд нь гадаад улсад удаан хугацаагаар оршин суугаа иргэдэд тулгамдсан асуудал болжээ. Үүнийг шийдвэрлэхийн тулд цахим орчинд Монгол Улсын иргэнийг найдвартай байдлаар таньж баталгаажуулах шийдлийг боловсруулах шаардлага тулгарч байна (EMongolia, 2023).

11-11 төвд (иргэд олон нийттэй харилцах) иргэд цахим шуудан, фэйсбүүк хуудасанд хандаж төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох И-Монголиа үйлчилгээтэй холбоотой ирсэн санал хүсэлтээс харахад гадаадад оршин суугч Монгол иргэд И-Монголиа системд нэвтрэн төрийн үйлчилгээг авах хүсэлтэй байдаг болохыг Зураг 1-т харуулав.

Зураг 1. И-мэйлээр ирсэн хүсэлт




Зураг 2. Фэйсбүүр-ээр ирсэн хүсэлт



Одоогийн байдлаар И-Монголиагаас иргэд 704, байгууллагууд 709, гадаадын иргэнд 29 нэр төрлийн үйлчилгээ авах нөхцөл боломж бүрдээд байна. Эдгээр үйлчилгээг гадаадын улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэд ч авах боломжтой юм.

Зураг 3. Төрийн цахим үйлчилгээ- Байгууллага, иргэн, гадаадын иргэнээр



Эх сурвалж: (EMongolia, 2023)

Төрийн үйлчилгээний нэгдсэн систем И-Монголиагаас өнөөдрийн байдлаар бид иргэний хувьд 25 төрлийн 704 үйлчилгээ, байгууллага 28 нэр төрлийн 799 үйлчилгээ, гадаадын иргэн 8 нэр төрлийн 29-н үйлчилгээ авах боломж бүрдсэн байна. Энэ бүх үйлчилгээг гадаад байгаа Монгол иргэд ч авах боломжтой юм (EMongolia, 2023).

Судалгааны асуудал

Тоон гарын үсэг ашиглан нэвтрэх боломж

Зөвхөн ажлын цахим урсгалыг хангах, эдийн засаг, цаг хугацааны хэмнэлт гаргахын тулд тоон гарын үсгийг хэрэглэхээс гадна баримт бичгийн үнэн мөнийг батлах, шалгах, агуулгын бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах хатуу шалгууруудтай, цахим орчинд итгэлцлийг

үүсгэх найдвартай хэрэгсэл учир өргөн ашигладаг (Монпасс СА ХХК). Тиймээс цахим орчинд тоон гарын үсэг нэвтрүүлэх, ашиглах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Асуудал. ЭСЯямуудын үйл ажиллагаанд иргэний шинэчилсэн бүртгэлээ хийлгэн тоон гарын үсгээ авах хууль эрх зүй, бодлого журам нь бүрдээгүй байна (И-Монголиа).

Онлайн банкны эрх ашиглан нэвтрэх

Монгол улсын “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай” хуулийн 7-р зүйлд:

7.1. Банк, эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ.

Асуудал. Уг хуулийн 7.3. Банк, эрх бүхий хуулийн этгээд дансгүй, эсхүл санхүүгийн тогтвортой харилцаа үүсгээгүй этгээдэд цахим хэлбэрээр аливаа данс нээхийг хориглоно гэж тусгасан байдаг.

Өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаар ашиглан нэвтрэх

Иргэдэд цахим үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох үүднээс холболт, хөгжүүлэлтийг хийн дэлхийн аль ч өнцгөөс өөрийн нэр дээрх LIME Монгол дугаарыг ашиглан “ДАН” системд нэвтрэх боломжтой болсон талаар “Цахим хөгжил, харилцаа холбооны яам”-ны цахим хуудсанд мэдээлжээ. Ийнхүү хилийн чанадад оршин суугаа иргэд танилт нэвтрэлтийн системд холбогдон төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээг цахимаар авах боломжтой (*Ikon.mn, 2022*).

Асуудал: LIME монгол дугаарыг ашиглах нь нэг талдаа гадаадад байгаа монголчуудад төрийн үйлчилгээг цахимаар авах боломж олгосон боловч гар утсандаа 1 удаагийн 4 оронтой нэвтрэх код ашиглаж байгаа нь Монгол улсад аюулгүй байдал, хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. (*EMongolia, 2023*).

Судалгааны хэсэг

Энэхүү судалгааны ажлаар “Цахим орчинд төрийн үйлчилгээг гадаад улсад амьдарч байгаа Монгол иргэдэд хамгийн эрсдэлгүй арга зам болох тоон гарыг үсгийг ашиглан хүргэх боломж”-ийг тодорхойлоход зорьсон бөгөөд энэхүү зорилгынхоо хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Гадаадын улс оронд ажиллаж амьдарч байгаа иргэдэд төрийн үйлчилгээг авах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг судлагдсан байдлын хүрээнд тодорхойлж судлах;
2. Төрийн үйлчилгээг цахим орчинд авах боломжууд, түүний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, дэлхийн улс орнуудын өнөөгийн нөхцөл байдал

түүнчлэн олон улсад цахим хөгжлөөрөө тэргүүлэгч улс орны туршлага, харьцуулалт хийн судлах;

3. Төрийн үйлчилгээг цахим орчинд авахад ашиглагдаж байгаа программ хангамж, техник технологиудыг ашиглах, турших байдлаар хэрэглэж мэдээлэл цуглуулахаас гарна үл итгэх байр сууринаас хандах байдлаар асуудал, хүндрэл байгаа эсэхийг судлах;
4. Эмпирик судалгааны өгөгдлүүдийг боловсруулж, дүн шинжилгээ хийх;

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү судалгаанд дараах байгууллагууд оролцсон. Үүнд:

- Төрийн үйлчилгээг цахим орчинд нэвтрүүлэгч И-Монголиа Академи
- Тоон гарыг үсэг түүний хууль эрх зүйн орчин, дэд бүтцийн удирдлага, бодлого чиглэлээр ханган ажиллаж байгаа ЦХХХЯам
- Тоон гарын үсгийн төрийн үйлчилгээнд ашиглаж байгаа ХНХЯамны харьяа Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн системийн газар
- Тусгай зөвшөөрөлтэй ГОБ-уудаас тэргүүлэх байр суурьтай ажиллаж байгаа “Тридиум Кэй” ХХК, “Монпасс Са” ХХК
- Судалгааны үндэслэлийг тодорхойлоход оролцсон Иргэд олон нийттэй харилцах төв 1111
- Тоон гарын үсгийг цахим үйлчилгээндээ нэвтрүүлж байгаа Хаан банк
- Тоон гарын үсэг авсан 3 иргэн
- Азийн улс оронд ажиллаж амьдарч байгаа 50-н МУ иргэн

Судалгааны арга зүй

Судалгааны дизайн

Судалгааг хандлагаар нь дедуктив (Aristotle), индуктив (Ray Solomonoff, 1960) гэж ангилдаг. Дедуктив аргыг дэвшүүлсэн таамаглалыг шалгах, эмпирик мэдлэг бүтээх зорилгоор ашигладаг (Rene Descartes). Индуктив хандлага нь тусгайгаас ерөнхийд чиглэж, баримт өгөгдөл цуглуулан шинжилж, дүгнэлт гарган онолоор тайлбарладаг (Francis Bacon). Энэ судалгааг Дедуктив болон Индуктив хандлагын аль аль хандлагийг ашиглан ерөнхийгөөс тусгайруу, тусгайгаас ерөнхийрүү таамаглал дэвшүүлэх дарааллаар хийж гүйцэтгэсэн болно. Тодруулбал цахим гарын үсгийн тухай ерөнхий ойлголтоос төрийн цахим үйлчилгээний тухай тусгай ойлголтруу шилжиж үүнээсээ гадаадад байгаа МУ иргэн тоон гарын үсэг ашиглан төрийн үйлчилгээг цахимаар авахад тулгарч байгаа асуудлыг тодорхойлж, түүний учир шалтгааныг таамаглах байдлаар хийсэн.

Судалгааны өгөгдөл цуглуулах

Ярилцлагын судалгаа

Судалгааны ярилцагчийн түүврийг бүрдүүлэхэд тоон гарын үсгийн талаар мэдлэг, ур чадвар, туршлагатай оролцогчид шаардлагатай байсан тул цасан бөмблөгийн арга буюу эхний ярилцагчаас дараагийн ярилцагчийг асууж тодорхойлох замаар хийсэн. Судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь байгууллагын стратегийг тодорхойлох, дээд шатны удирдлага болон тоон гарын үсгийн чиглэлээр ажиллаж байсан мэдлэг, ур чадвар, туршлагатай екпертүүд гэдгээрээ онцлог.

Ярилцлагын судалгааны оролцогчдийн ерөнхий мэдээлэл

Ярилцлагын арга ашиглан хийсэн судалгаа 2023 оны 02-р сарын 14-ний өдрөөс 2023 оны 03-р сарын 17-ний өдрийг хүртэл үргэлжилсэн. Дараах хүснэгтэд судалгаанд оролцогч байгууллага, ажилтны албан тушаал, ярилцлага үргэлжилсэн хугацаа, ярилцлага авсан хэлбэрийг харуулав. Зарим ярилцагчдын хүсэлтээр нэрийг нууцалсан болно.

Хүснэгт 1. Судалгааны ярилцлаганд оролцогчдын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Байгууллага	Үргэлжилсэн хугацаа	Ярилцлагын хэлбэр
1	Оролцогч I Э.Балдансамбуу	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ЦХХХЯам - Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	2 удаа нийт 2 цаг	Биечлэн уулзсан
2	Оролцогч II Энхбат	Мэдээллийн системийн мэргэжилтэн	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам	40 мин	Биечлэн уулзсан
3	Оролцогч III Төрбат	Үйл ажиллагаа хариуцсан захирал	“Тридиум Кэй” ХХК	1 цаг 30 мин	Биечлэн уулзсан.
4	Оролцогч IV	Мэргэжилтэн	“Монпасс Са” ХХК	20 мин	Утсаар холбогдсон
5	Оролцогч V	Цахим банкны алба	Хаан банк	30 мин	Биечлэн уулзсан
6	Оролцогч VI	И-Монголиа 2.0 төслийн удирдагч	Нийтийн мэдээллийн системийн газар	1 цаг	Гүүгл мийт
7	Оролцогч VII - IX	Тоон гарын үсэг авсан иргэн – 3 хүн	Тоон гарын үсэг хэрэглэгч	1 цаг	Утсаар холбогдсон

Ярилцлагын шинжилгээ, боловсруулалт

Ярилцлага бүрийн дараа судалгааны хариултуудыг текст хэлбэрээр буулгаж, гол сэдвүүдээр үндсэн ангилал, түүнд холбогдох чухал асуултаар дэд ангилал үүсгэсэн. Түүний дараа

ангиллыг дугаарлаж индексжүүлэн, сэдэв тус бүрээр хүснэгт зохиож, сэдэвчилсэн хүснэгтийг бэлтгэсэн. Мэдээллүүдийн хоорондын холбоо хамаарлыг тогтоох, ерөнхий төлөв, зүй тогтол байна уу гэдгийг судалсан. Шинжилгээний үр дүнг тайлбарлахдаа дэвшүүлсэн асуултуудад бүрэн хариулт авсан байна уу, ямар үр дүнд хүрсэн байна вэ гэсэн асуултуудад чиглэж, тайлбар дүгнэлтээ хийгээд түүнийгээ онолын болон бусад судалгааны тайлбартай харьцуулж судалсан.

Ярилцлагын сэдвүүдийн хүрээнд оролцогчдын гол санааг индекс тус бүрээр тодорхойлов.

Хүснэгт 2. Сэдэвчилсэн хүснэгт

Асуулт	Ярилцагч	Гол санаа
1.1. Цахим гарын үсэг гэж юу вэ	Оролцогч I	Цахим гарын үсэг нь маш ерөнхий ойлголт юм. Олон төрлийн цахим гарын үсэг байдаг.
	Оролцогч II	Цахим гарын үсгийн хууль гэж яригддаг боловч тоон гарын үсгийн тухай ойлголт яригдаж байгаа.
	Оролцогч V	Тоон гарын үсгийн хуульд цахим тамга гэсэн тодорхойгүй ойлголт байгаагаас гадна цахим гарын үсэг гэдгийг ойлгомжгүй тайлбарласан байна.
1.2. Тоон гарын үсэг гэж юу вэ	Оролцогч I	Цахим орчинд шифрлэгдэн хэрэглэгддэг аюулгүй хэрэгсэл юм.
	Оролцогч II	Тээгч төхөөрөмжид суурилуулсан хувийн түрхүүр болон нийтийн түлхүүр, гэрчилгээнээс бүрдсэн эзэмшигчийнхээ мэдээллийн агуулсан байдаг.
2.3. Цахим болон тоон гарын үсгийн ялгаа	Оролцогч I	Олон төрлийн цахим гарын үсэг байгаагаас ОУ-ын стандартад хүлээн зөвшөөрөгдсөн нь тоон гарын үсэг юм. Тоон гарын үсэг олон хэлбэрээр олгогдож байгаа нь төөрөгдөл үүсгэж байж магадгүй. УБЕГ иргэдэд үнэ төлбөргүй, ГОБ байгууллагуудад тодорхой хураамжтай, Татварын газраас зөвхөн татвар төлөгчдөд зориулсан өөр хувилбараар олгогдож байна.
2.4. Тоон гарын үсгийн давуу тал	Оролцогч I	Олон улсын стандарт мөрдөгддөг, цахим хөгжил хийхэд түлхэц болохоос гадна аюулгүй байдлыг хангаж чадах хамгийн зөв шийдэл болно.
	Оролцогч II	Цахим орчинд өөрийгөө нотолж банк санхүү, төрийн байгууллага, оператор компаниудтай харилцах боломжтой.
2.5. Тоон гарын үсэг ашиглан төрийн үйлчилгээг	Оролцогч I	Хөдөлмөрийн бүтээмжийн нэмэгдүүлэх, ажлийн шат дараалал, үе шатыг бууруулах, хүнд суртал, зардал бууруулахаас гадна төрийн үйлчилгээг хаанаас ч хэзээ ч хүртээмжтэй байдлаар үйлчилгээ авч чадна.

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛИЙН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ - 14 (2023)

цахимаар авахын давуу тал	Оролцогч II	1 төхөөрөмж дээр 5 хүртэлх гарын үсэг суулган ашиглах боломжтой, дэлхийн хаанаас ч ашиглаж чадна. Төхөөрөмж нь өөрөө код ашиглаж байгаа тул эрсдэл хамгийн бага.
3.1. Цахим орчинд төрийн үйлчилгээ авах бусад улс орны өнөөгийн байдал	Оролцогч I	Бид олон улсын жишигтэй ойр явж байгаа. Тоон гарын үсгийн хэрэглээ улам бүр нэмэгдэж байна. Энэ нь шинээр улс орнууд өөрийн улс орондоо нэвтрүүлж байгаатай холбоотой.
	Оролцогч II	Улс орон бүрд хэрэглэгдэж байгаа төхөөрөм хүчин чадлын хувьд өөр өөр, үүнийг дагаад үнэлгээ нь өсдөг. Бид монголдоо хамгийн сайн боловч ОУ-д дунжийг нийлүүлж байна.
	Оролцогч VI	Цахим хөгжилөөрөө Сингапур улс тэргүүлж байсан бол сүүлийн жилүүдэд БН Эстони улс тэргүүлж байгаа.
3.2. Цахим орчинд төрийн үйлчилгээ авах Монгол улсын өнөөгийн байдал	Оролцогч I	ЦХХХЯамны зүгээс дэд бүтцийн талаас хангалттай сайн хийгдсэн гэж дүгнэнэ. И-Монголиа төслийн хүрээнд цахим хөгжилд маш их хөрөнгө оруулалт хийгдсэн. Төрийн олон үйлчилгээг цахим хэлбэрт оруулж чадсан. Үр ашигаа өгч чадаж байгаа. Гол нь аль аль шатандаа ашиглаж сурах асуудал байгаа.
	Оролцогч VI	Нэгдсэн бодлого байхгүй байгаа нь гол хүндрэл болж байна.
4.1. Боломж, үр ашиг	Оролцогч I	Төрийн боломжит бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байгаа. Саяхныг хүртэл бид иргэний үнэмлэхийн лавлагаа, нийгмийн даатгалын тодорхойлолтыг биечлэн очиж авдаг байсан.
	Оролцогч II	Нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсэг ашиглан илгээх процессийн алхмыг 2 дахин багасгах боломж байгаа.
	Оролцогч III	Цахим хөгжилд тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой байгаа тул нэгдсэн мэдээллийн системүүд рүү нэвтрэх олон боломжууд байгааг цуцлаж зөвхөн тоон гарын үсгээрээ нэвтэрдэг болгох хэрэгтэй байна.
4.2. Хүндрэл бэрхшээл	Оролцогч I	Тоон гарын үсгийн олон боломжит хямд, хялбар хувилбарууд цаг үеэ даган гарч ирж байгаа боловч үүнийг бид ГОБ-ууддаа тулгах боломжгүй байдаг. Бизнес явагдаж байгаа учраас. Мөн ЦХХХЯам өөрсдийн ажлын хүрээнд шаардлагатай зүйлсийг хийж байгаа боловч улс төрийн тогтворгүй байдал хэрэгжилтэд удаашрал үүсгэдэг нь үнэн.


	Оролцогч VII	УБЕГ-аас олгосон тоон гарын үсгийн нууц үг нь өөрт цээжлэхэд хялбараар өөрчилж болдоггүйгээс гадна цээжлэх хүндрэлтэй байдаг.
	Оролцогч II	Бүх тайлан илгээгчдэд тоон гарын үсэг ашиглах шаардлага таних нь ашиглаж чадахгүй байхаас гадна төлбөртэй тоон гарын үсгийг худалдаж авах шаардлага тавих нь хүндрэлтэй байдаг. УБЕГ-аас үнэгүй олгож байгаа тоон гарын үсгийг ашиглан тайлан илгээх нь одоогоор зорицуулагдаагүй байгаа. Хэрвээ энэ зохицуулалт хийгдвэл иргэн өөрийн нэр дээр үнэ төлбөргүйгээр олгогдсон тоон гарын үсгээ ашиглах боломжтой юм.
	Оролцогч VII	Нууц үгээ мартсан, хэрхэн сэргээх талаар мэдээлэлгүй байгаа.
	Оролцогч VIII	Тоон гарын үсгээ авсан боловч хэрхэн ашиглах, ашиглах боломжууд нь гарч ирэхгүй байна.
	Оролцогч IX	УБЕГ-аас өгсөн нууц үгийг өөрт цээжлэхэд хялбараар өөрчилж болдог эсвэл хэрэгдэгчийн хүсэлтээр нууц үгийг нь хийж өгдөг болгомоор байна.
	Оролцогч VI	Лайм гар утасны дугаар ашиглах нь шийдэл биш юм. Учир нь хуурамч бүртгэл үүсгэдэг аппликэйшнүүд бий болж байна. Мөн эрх зүйн зохицуулалтууд байхгүй байна.
4.3. Хууль эрх зүйн орчинд үүсэж буй асуудал	Оролцогч I	Ганц хууль батлаад бүх асуудал шийдэгдэхгүй, холбоотой хууль, бодлого журам боловсруулах ажил, цахим аюулгүй байдалтай холбоотой бусад хууль журам хийгдээгүй байна.
	Оролцогч III	ГОВ-уудтай холбоотой дүрэм журамд хийх сайжруулах асуудал тэдгээрийн шударга өрсөлдөөний нөхцөлийг тодотгож өгөх хэрэгтэй байна.

Асуулгын судалгаа

Асуулгын судалгааг хийхдээ судалгааны ажлын үндэслэлд дурдагдсан хоёрдогч судалгаанд тусгаарлан гадаадад байгаа Монгол улсын иргэд тоон гарын үсгийн хэрэглээний боломжийн талаар ойлголт байна уу, түүнийг ашиглаж хэвшсэн эсэх, эс бөгөөс тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлоход чиглэсэн.


Уг асуулгад азийн улс оронд байгаа Монгол улсын 51 иргэн хамрагдсан бөгөөд судалгаанд оролчдын 80% нь цахимаар төрийг үйлчилгээ авдаггүй, шаардлага гарвал харъяа ЭСЯамуудаараа биеээр очиж үйлчилгээ авдаг гэсэн дүгнэлт гарсан. Эдгээр хүмүүс яагаад цахимаар үйлчилгээ авдаггүй байдлыг тандах судалгааны асуулгад 44,4% нь “Мэдээлэл байдаггүй, мэддэггүй”, 36,1% нь үйлчилгээ авах шаардлага байдаг боловч зөвшөөрөгдсөн нэвтрэх хэрэгслүүдийн аль нэг нь байдаггүйн ултаас ашигладаггүй бол үлдсэн 19,4% нь шаардлага гардаггүй гэж үзсэн байна.

1. Та амьдарч байгаа улс орноосоо Монгол улсын иргэн, аж ахуйн нэгжүүдэд зориулсан төрийн үйлчилгээнүүдээс (И-Монголиа) авч байсан уу?
45 хариулт



• Үгүй
• Тийм

5. Хэрвээ гадаад улсад байхдаа төрийн үйлчилгээг цахимаар авдаггүй бол яагаад авдаггүй вэ?
36 хариулт



• Мэдээлэл бийгүй, мэддэггүй
• Нэвтрэх харгалзлууд нь байдаггүй. Эзгээрэйг олж авах нь тулгарсан асуудал болж байна.
• Харгалцаа байдаггүй. Харгалзах шаардлага гардаггүй.

Системийн хэрэглээ, туршилт

Энэхүү судалгааны ажид дурдагдсан системүүдийг ашиглаж, хэрхэн ашиглах байдалтай танилцаж тэдгээрийн давуу болон сул тал, хүндрэл бэрхшээл байвал түүнийг хэрхэн шийдвэрлэх боломжийг тодорхойлоход чиглэсэн. Түүнчлэн нийгмийн даатгалын тайлан тоон гарыг үсэг ашиглан илгээх үе шатыг сайжруулах санал боловсруулж танилцуулсан болно.

Системийн судалгааны шинжилгээ, боловсруулалт

Системийн шинжилгээний хүрээнд хийгдсэн судалгааны ажлын хүрээнд систем тус бүрийн хувьд дүгнэлт хийв.

Хүснэгт 3. Системийн судалгааны шинжилгээ, боловсруулалт

№	Ангилал	Системийн тайлбар
1.	Тоон гарын үсэг цахим орчинд захиалах	
1.1.	Тоон гарын үсэг онлайнар захиалах, төлбөр шилжүүлэх	Тоон гарын үсэг захиалах процессыг бүрэн цахимаар хийж байгаа боловч бүртгэлийн мэдээллүүдээ баталгаажуулах, Токен төхөөрөмжийг хүлээлгэн өгөх процесс цахимжаагүй байна. Үүнийг И-Монголиа системийг ашиглан автоматжуулах боломж байгаа гэж дүгнэв.
1.2.	Тоон гарын үсгийн систем (Клиент программ) суулгах	ГОВ бүр өөр өөрсдийн хөгжүүлсэн Клиент программыг хэрэглэгчдэдээ санал болгодог. Үүнээс гадна Үндэсний дата төвийн хөгжүүлсэн ESIGN клиент программ байдаг ба үүнийг аль ч ГОВ-ын хэрэглэгчид ашиглах боломжтой. Гэвч ESIGN клиент программ нь 2019 оноос хойш хөгжүүлэлт хийгдээгүй байгаагаас шартгаалан хэрэглээ нь хязгаарлагдсан байна. Тиймээс ГОВ-уудийн дунд Клиент программын хөнгжүүлэлтээрээ өрсөлдөж хэрэглэгчдээ татах нэг хэрэгсэл болдог байна. Гэхдээ энэ байдал нь тоон гарын үсгийн хэрэгдэгчдэд бие биенээ дэмждэггүй Клиент программ нь хүндрэл төөрөгдлийг үүсгэж байна.
1.3.	Тоон гарын үсэг ашиглан гэрээ хийх	Тоон гарын үсэг ашиглан гэрээ хийх нь тухайн гэрээг шифрлэж хамгаалалт үүсгэнэ. Хэрвээ гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдол тухайн гэрээний гарын үсгийн мэдээлэлд анхааруулга мэдээлэл үүснэ.
2.	Өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаар	
2.1	Өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаар	Лайм аппликэйшнд тухайн улс орондоо ашиглаж байгаа бүртгэлтэй дугаараа ашиглан 8-н оронтой Лайм дугаар 2 минутын дотор үүснэ.

	цахимаар үүсгэх	
2.2	Өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаар ашиглан цахимаар төрийн үйлчилгээ авах	Үүссэн Лайм дугаараа ашиглан зааврын дагуу иргэний үнэмлэхээрээ бүртгүүлж И-Монголиа систем рүү нэвтрэх боломжтой.
3.	Тоон гарын үсэг ашиглах	
3.1.	Тоон гарын үсэг ашиглан Хаан банк руу хүсэлт явуулах	Туршилтын явцад хэрэгдэгчийн бүртгэлтэй мэдээлэл зөрүүгүй байх шаардлага өндөр түвшинд тавигдаж байсан. Үүнээс гадна ГОБ бүрийн тоон гарын үсэг хэрэглэгч нэвтрэх боломжоор ханган ажиллаж байна.
3.2.	Тоон гарын үсэг ашиглан Нийгмийн даатгалын тайлан илгээх	Энэ системийн туршилтын явцад тайлан баталгаажуулах процесс нь олон байсан. Үүнийг багасгах санал, боломжийг НДЕГазарын мэдээллийн системийн мэргэжилтэнд танилцуулсан. Хэрэгжих боломжтой гэж үзсэн.

Эх сурвалж: (Судлаачийн эмхэтгэл, 2023)

Дүгнэлт, санал зөвлөмж

Иргэнийг таньж баталгаажуулснаар тухайн иргэн хувийн мэдээлэлдээ хандах, төрийн үйлчилгээг цахим орчинд авах эрх үүсэх тул ямар нэг алдаагүй таних шаардлагатай. Үүнийг зөвхөн технологийн аргаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд хэд хэдэн чиглэлээр зэрэг ажиллах шаардлага тулгарч байна. Иймээс тоон гарын үсгийн ашиглалтыг сайжруулах дараах зөвлөмжүүдийг санал болгож байна.

1. Техник, технологийн арга хэмжээ:
 - a. Тоон гарын үсэг олгох. Энэ тохиолдолд гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан олгох тул гадаадад оршин суугаа Монгол иргэдэд хүндрэлтэй байх болно. Гэхдээ нэг удаа авсан тохиолдолд олон төрлийн иргэний болон бизнесийн харилцаанд оролцох үүд нээгдэх ба аюулгүй байдал талаасаа хамгийн сайн шийдэл болно.
 - b. Хурууны хээг уншиж ХУР системд дамжуулан иргэнийг таних боломжтой. Гэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хуульд зааснаар хаалттай мэдээлэл буюу хурууны хээний зурган мэдээллийг гадаад улсын сүлжээгээр дамжуулах, эсвэл гадаад улсын мэдээллийн систем (SDK) ашиглах нь аюулгүй байдлын эрсдэлүүд үүсгэж болзошгүй.
 - c. Гадаад паспорт эсхүл иргэний үнэмлэхийн зураг болон тухайн иргэний видео/зургийг ашиглан таних аргыг сүүлийн үед гадаадын болон дотоодын байгууллагууд ашиглаж байна. Энэ арга нь бүх иргэний танихгүй боловч 50% буюу түүнээс дээш хувийн иргэдэд үр дүнтэй байж болно.
2. Захиргааны арга хэмжээ
 - a. Иргэний бүртгэлийн байгууллага, Мэдээллийн аюулгүй байдлын газартай хамтран ажлын хэсэг байгуулж дээрх технологийн шийдлүүдийг үнэлж, эрсдэлийн үнэлгээ хийсний үндсэн дээр хамгийн бага эрсдэлтэй, хамгийн өндөр таних чадвартай шийдлийг олж тогтоон аль нэгийг буюу бүх шийдлийг хослуулан

хэрэглэх талаар дүгнэлт зөвлөмж гаргах.

- b. Цахим орчинд иргэний таних үйл ажиллагааг 24/7 хариуцан тухайн иргэнтэй цахим хэлбэрээр харилцаж, бүртгэлийг зөвшөөрөл өгөх, цаашид иргэний цахим бүртгэлтэй холбоотой гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий бүртгэлийн нэгжийг байгуулан ажиллуулах. Үүнд Улсын бүртгэлийн байгууллагын эрх бүхий улсын бүртгэгч ажиллах шаардлагатай.
3. Эрх зүйн арга хэмжээ
- a. Иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулан төрийн үйлчилгээ авах хэлбэр, аргачлалыг баталсан тогтоосон Засгийн газрын тогтоол эсвэл бусад захиргааны актыг гаргах.
 - b. Бусад хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай эсэхийг хянаж, цахим хөгжлийн багц хуулиудыг дагалдуулан батлах.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

EMongolia (2023), дотоод тайлан.

Цахим болон тоон гарын үсгийг нэвтрүүлэгч "Цахим хөгжил, харилцаа холбооны яам", "Үндэсний Дата Төв" УТҮГ: <https://esign.gov.mn/faq-аас> гаргасан.

IDI handbook on it audit for supreme audit instutions, intosai (2014).

Эстони болон Монгол Улсын цахим хөгжлийн харьцуулалт Б.ДАВААБАЗАР (2019.12.04): Ikon.mn (2022). <https://ikon.mn/n/1qlt> -ээс гаргасан.

Xanthopoulou, P., & Plimakis, S. (2021). Digitalization and Digital Transformation and Adoption in the Public Administration during the Covid19 Pandemic Crisis. European Scientific Journal, ESJ, 17(31), 60. <https://doi.org/10.19044/esj.2021.v17n31p60>.

Мобиком. Ундрал Амарсайхан (2020). <https://unread.today/c/techworm-msign-ээс> гаргасан

Гадаадын иргэн харьяатын газар (2021 оны November 13). Дотоод мэдээ.

З.Гантоогоо. (2020, December 24). Монгол Улсын дижитал шилжилтийн тогтолцоо бэлэн биш байна. <https://ikon.mn>.

Монпасс ХХК (2022).

https://monpass.mn/storage/uploads/download_files/Тоон_гарын_үсэг_ашиглаж_буй_байдал.pdf -аас гаргасан

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021).

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

С.Мөнхбаатар (2020). E-Mongolia: Монголчууд цахим шилжилтэд. Монцамэ.

Тридиум ХХК (2022). <https://www.tridum.mn/default> -аас гаргасан

Хууль зүй дотоод хэргийн яам (2022). <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/02/Niitiin-medeelel-law-.pdf>

ЦХХХ Яам (2022). Дотоод мэдээ.



ЭКСПОРТЫН БОЛОМЖИЙГ ХӨГЖҮҮЛЭХҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ
МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ БА ТЕХНОЛОГИЙН
МЕНЕЖМЕНТ

ISBN: 978-9919-9906-1-9

ПРОГРАМ ХАНГАМЖИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Н.Саранчимэг¹, О.Хулан², С.Гэрэлт-Од³

¹Магистр (MSc), СЭЗИС-ийн Мэдээллийн системийн менежментийн тэнхим

²СЭЗИС-ийн Мэдээллийн системийн магистрант

³СЭЗИС-ийн Мэдээллийн системийн магистрант



Түлхүүр үг:

Програм хангамжийн чанар, Програм хангамжийн чанарын баталгаажуулалт, Програм хангамжийн чанарын хяналт, Програм хангамжийн чанарын менежмент, Програм хангамжийн чанарын хэмжүүр

Хураангуй

Техник технологийн хурдацтай хөгжил дэвшлийг даган байгууллагын үйл ажиллагааг оновчтой, үр ашигтай удирдан явуулахад туслах, хэрэгцээ шаардлагыг хангасан, үр ашигтай, найдвартай, цаг хугацаа болон төсөвт багтсан чанартай програм хангамжыг бүтээх шаардлагатай тулгарч байна. Standish Group-ээс жил бүр гаргадаг CHAOS 2020 тайланд дурдсанаар технологийн төслүүдийн 66% нь (дэлхий даяар 50,000 төслийн дүн шинжилгээнд үндэслэн) хэсэгчлэн эсвэл бүр мөсөн бүтэлгүйтдэг хэмээн дурдсан байдаг. Gartner болон The Standish группын судлаачдын хийсэн судалгааны үр дүнгээс дээрх бүтэлгүйтлийн гол шалтгаан нь бүрэн бус шаардлага хангасан програм хангамжын бүтээгдэхүүн гэж үзжээ. 2020 оны CISQ-ын тайланд АНУ-ын байгууллагуудын амжилтгүй бүтээн байгуулалтын төслийн нийт зардал 260 тэрбум ам.доллар, харин чанар муутай програм хангамжаас үүдсэн үйл ажиллагааны доголдлын нийт зардал 1.56 их наяд доллар гэж тооцоолсон байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд дотоодын байгууллагуудын програм хангамжийн чанарын менежментийн талаарх ойлголт, хэрэгжүүлэлтийн түвшинг тодорхойлохоос гадна хэрэглэгчдээс програм хангамжын бүтээгдэхүүний чанарын хэмжүүр үзүүлэлт, шинж чанаруудаар үнэлгээ хийж харьцуулсан шинжилгээ хийсэн болно.

Оршил


Мэдээллийн технологийн төслүүд хэрэглэгч, захиалагчийн хэрэгцээ шаардлагыг хангасан чанартай программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь салбарын хувьд хамгийн тулгамдсан асуудал болоод байна. Мэдээллийн технологийн төслүүдийн бүтэлгүйтлийн

хувь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр хувийг эзэлсээр байна. Төслийн удирдлагын гурвалжингаас гадна төслийн чанарын менежментийг зарим мэргэжилтнүүд төслийн менежментийн явцад бий болсон зардал, цаг хугацаа, хамрах хүрээний хоорондын уялдаа холбоонд *чанарыг* дөрөв дэх хэмжигдэхүүнээр оруулах ёстой гэж үздэг. (PMI, 2020)

Gartner болон The Standish группын судлаачдын хийсэн судалгааны үр дүнд Мэдээллийн технологийн төслийн бүтэлгүйтлийн шалтгааныг Зураг №1-т үзүүлснээр хамгийн их хувь бүхий эхний 3 шалтгааныг авч үзэхэд:

- Шаардлагыг бүрэн бус хангах (13.1 хувь)
- Хэрэглэгчийн оролцоо дутмаг (12.4 хувь)
- Нөөцийн хомсдол (10.6 хувь)

Зураг 1. IT-ийн төслийн бүтэлгүйтлийн шалтгаан



Эх сурвалж: (Martin deMartini, 2016)

Үүнээс хэрэглэгчийн шаардлагыг бүрэн тодорхойлж чадаагүйгээс, хэрэглэгчийн оролцоо дутмаг, мэдээллийн системийн нөөцийн хомсдол их байгаагаас шалтгаалан төсөл бүтэлгүйтэх, төсөл чанаргүй болох магадлал 36.1% байна.

Эдгээр чанаргүй програм хангамжын бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх эрсдлийг үүсгэж байгаа асуудал, бүтэлгүйтлийн шалтгаан

нь програм хангамжын бүтээгдэхүүний чанарын менежменттэй холбогдож байгаа юм. Иймд судалгааны ажлын хүрээнд программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудын програм хангамжын чанарын менежментийн талаарх ойлголт, хэрэгжүүлэлтийн түвшинг тодорхойлох, програм хангамжын бүтээгдэхүүний чанарын хэмжүүр үзүүлэлтүүдийг тодорхойлон үнэлгээ, харьцуулсан шинжилгээ хийсэн болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Онолын судалгаа

Програм хангамжийн бүтээгдэхүүн, түүний чанарын талаарх ойлголт

20-р зууны сүүл үед программ хангамжийн бүтээгдэхүүний чанарыг хэрэглэгчид болон сонирхогч талуудын тогтоосон шаардлага, хүлээлт, хэрэгцээг хангаж буй түвшин (Пфлегер, 1997)-р хэмжихээс гадна тухайн үеийн чанарын олон улсын стандартад тусгаснаар бүтээгдэхүүний илэрхий, далд хэрэгцээг хангах чадварт хамаарах онцлог, шинж чанаруудын нийлбэр хэмээн тодорхойлсон байна. (ISO, 2001)

21-р зууны эхэн үеийн судалгааны бүтээлүүдэд дурдсанаар программ хангамж нь түүний шаардлага, техникийн нөхцөл, гэрээний хэлэлцээрт нийцэж байгаа түвшингээр тодорхойлогддог өөрийн тогтоосон шаардлагыг хангах чадвар (Pressman, 2014), “Байх ёстой (inherent) шинж чанарууд цогцоороо шаардлагуудыг хангаж байгаа эсэх хэмжээс”-ээр илэрхийлдэг гэж тодорхойлсон байна. Харин чанарын олон улсын стандартад програм

хангамжийн бүтээгдэхүүний чанар нь "Програм хангамжийн бүтээгдэхүүний шаардлагад нийцүүлэх чадвар" хэмээн шинэчлэн тодорхойлсон байна. (ISO, 2021)

Олон улсын стандартуудад дурдагдсан тодорхойлолтуудыг авч үзвэл 20-р зууны сүүл үед программ хангамжийн бүтээгдэхүүний чанар нь бүтээгдэхүүний шаардлагад нийцсэн байдлаар тодорхойлогддог байсан бол 21-р зууны эхэн үеэс программ хангамжийн чанар гэдэг нь илэрхий, далд хэрэгцээг багтаасан программ хангамжийн бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлага, стандарт, хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтийг хангаж байгаагаар тодорхойлогддог болсон байна.

Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалт

20-р зууны сүүл үед программ хангамжийн бүтээгдэхүүний чанарыг тодорхойлогдсон эсвэл далд хэрэгцээг хангахад нөлөөлдөг бүтээгдэхүүний шинж чанар, шинж чанаруудын нийлбэр (Stockman et al, 1990) бөгөөд бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа гэдэгт итгэлтэй байхын тулд төлөвлөсөн, системтэй үйлдлийн загвар (EEE Std 730-1998) юм хэмээн тодорхойлжээ.

(Galín, 2004) программ хангамжийн бүтээгдэхүүнд зориулсан программ хангамж боловсруулах эсвэл засвар үйлчилгээ хийх үйл явц нь хуваарь, төсвийн хязгаарлалтын хүрээнд тогтоосон шаардлагад нийцэж байгаа гэдэгт итгэлтэй байх шаардлагатай арга хэмжээний багц юм. Чанарын баталгаа гэдэг нь тухайн бүтээгдэхүүн зөв ажиллаж байгаагийн баталгаа, итгэл үнэмшил юм (Feldman, 2005) гэж тодорхойлсон байна.

(ISO/IEC 25000:2014)-д дурдсанаар программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөгийн туршид чанарын тогтоосон шаардлагыг хангасан төлөвлөгөөт, системтэй үйл ажиллагааны цогц, (ISO 9000:2015)-д бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын шаардлагыг хангахын тулд чанарын системд хэрэгжүүлсэн төлөвлөсөн, системтэй үйл ажиллагаа хэмээн тодорхойлсон байна. Программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь чанарын тогтоосон шаардлагыг хангаж байгаа гэдэгт хангалттай итгэлтэй байх шаардлагатай төлөвлөсөн, системтэй үйл ажиллагааны багц хэмээн тодорхойлсон байна.

Програм хангамжийн чанарын менежмент

(Juran, J. M., & Godfrey, A. B. (1998) Программ хангамжийн чанарын менежмент нь программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрээнд хэрэглэгчийн хүлээлтийг бий болгох, холбогдох стандарт, журамд ашиглах үйлчилгээнд ашиглах баталгаат үйл ажиллагааны багц. Программ хангамж хөгжүүлэх амьдралын мөчлөгийн туршид программ хангамжийн чанарыг системтэй, идэвхтэй удирдах үйл явц (Rothman, J. 2001)-ын цогц хэмээн тодорхойлсон байна.

21-р зууны эхэн үеийн судалгааны бүтээлд (Kan, S. H. 2002) программ хангамжийн бүтээгдэхүүн, үйл явц нь чанарын зорилгодоо нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахад ашигладаг бодлого, журам, практикийн багц гэж үзэхээс гадна чанарын удирдлага нь программ хангамж, программ хангамж боловсруулах үйл явцыг бие даан шалгах боломжийг олгодог хэмээн тодорхойлсон байна (Zsold Dr. Ulbert 2014).


Чанарын олон улсын стандартад дурдсанаар программ хангамжийн чанарын менежмент нь программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтоосон чанарын шаардлагыг хангаж, ашиглахад тохиромжтой болгох үйл ажиллагааны цогц (ISO/IEC 25010:2011) бөгөөд

программ хангамжийн бүтээгдэхүүн нь шаардлагад нийцэж, хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтийг хангах үйл ажиллагааны цогц (ISO 9000:2015) юм хэмээн тодорхойлсон байна.

Програм хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь чанарын тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, бүтээгдэхүүний процессыг цаг хугацааны явцад тууштай хэрэгжүүлж, сайжруулах зохион байгуулалтын үйл явц (ISO/IEC 12207:2017) тэр дундаа программ хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээг функциональ байдал, найдвартай байдал, ашиглах боломжтой байдал, үр ашиг, засвар үйлчилгээ, зөөвөрлөх чадвар зэрэг чанарын шинж чанаруудын хувьд хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэн хангах үйл явц юм гэж тодорхойлсон байна. (ISO/IEC 12207:2017)

Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын менежментэд нөлөөлөх хүчин зүйлс

Зураг 3 Чанарын амьдралын мөчлөг



Эх сурвалж: – Quality in the lifecycle (Figure C.2 in ISO/IEC 25010, 2010)

Хүснэгт 4. Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх хүчин зүйлс

Дотоод чанар	<p>Дотоод чанар нь программ хангамжийн бүтээгдэхүүний код, архитектур, дизайны чанарыг хэлнэ. Дотоод чанар нь программ хангамжийн бүтээгдэхүүний засвар үйлчилгээ, өргөтгөл, дахин ашиглах чадварт нөлөөлдөг учраас чухал юм.</p> <p>Сайн дотоод чанар нь программ хангамжийн бүтээгдэхүүнийг хадгалах, өөрчлөх, цаг хугацааны явцад сунгахад хялбар байдаг гэсэн үг юм. Дотоод чанарт нөлөөлдөг нийтлэг хүчин зүйлүүд нь кодын нарийн төвөгтэй байдал, код унших чадвар, кодыг хадгалах чадвар зэрэг орно.</p>
Гадаад чанар	<p>Гадаад чанар гэдэг нь программ хангамжийн бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгчдэд хүлээн зөвшөөрөгдсөн чанарыг хэлнэ. Гадаад чанар нь хэрэглэгчийн сэтгэл ханамж, программ хангамжийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд нөлөөлдөг учраас чухал юм.</p> <p>Гадаад сайн чанар гэдэг нь программ хангамжийн бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн, хэрэглэхэд хялбар байхыг хэлнэ. Гадаад чанарт нөлөөлдөг нийтлэг хүчин зүйлүүд нь функциональ байдал, найдвартай байдал, гүйцэтгэл юм.</p>

Ашиглалтын чанар	<p>Ашиглалтын чанар гэдэг нь хэрэглэгчид программ хангамжийн бүтээгдэхүүнтэй харьцахад хялбар байдлыг илэрхийлдэг. Ашиглалтын чанар нь хэрэглэгчийн бүтээмж, сэтгэл ханамжид нөлөөлдөг учраас чухал юм.</p> <p>Ашиглалтын чанар сайтай гэдэг нь программ хангамжийн бүтээгдэхүүн нь ойлгомжтой, сурахад хялбар, ашиглахад үр дүнтэй байхыг хэлнэ. Ашиглахад нөлөөлдөг нийтлэг хүчин зүйлүүд нь хэрэглэгчийн интерфэйсийн дизайн, хэрэглэгчийн туршлага, хүртээмж зэрэг юм.</p>
------------------	--

Эх сурвалж: *Quality in the lifecycle ISO/IEC 25010, 2010*

1.1 Програм хангамжийн бүтээгдэхүүн чанарын олон улсын стандарт

Дэлхийн 170 гаруй улсад нэг сая гаруй компани, байгууллага ISO 9001 стандартын гэрчилгээтэй байдаг. Энэхүү стандарт нь үйлчлүүлэгчдэд дээд зэргээр анхаарал хандуулах, дээд удирдлагын үр дүнтэй, оновчтой зохион байгуулалт, байнгын сайжруулалт зэрэг чанарын удирдлагын хэд хэдэн зарчимд суурилдаг. Эдгээр зарчмуудыг ISO-ийн чанарын удирдлагын зарчимд илүү дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.


Энэхүү судалгааны ажлын хүрээнд програм хангамжийн бүтээгдэхүүний чанартой холбогдох ISO 9001, ISO 9000, ISO 12207, ISO 25000, ISO 15939, ISO 25010 стандартууд нь Олон улсын стандартчиллын байгууллагаас (ISO) боловсруулсан стандартууд боловч тэдгээр нь өөр өөр зорилготой бөгөөд чанарын удирдлагын янз бүрийн тал дээр төвлөрдөг.

- ISO 9000 нь чанарын удирдлагын систем (ЧУС) болон чанарын баталгаажуулалтын заавар, хэрэгслээр хангадаг стандартуудын нэгдэл юм.
- ISO 9001 нь ISO 9000-ийн бүлгийн тодорхой стандарт бөгөөд ЧУС-д тавигдах шаардлагуудыг тодорхойлдог.
- ISO 12207 нь төлөвлөлт, дизайн, хөгжүүлэлт, туршилт, байршуулалт, засвар үйлчилгээ зэрэг программ хангамжийн амьдралын мөчлөгийн үйл явцын хүрээг бүрдүүлдэг стандарт юм.
- ISO 25000 стандарт нь программ хангамжийн бүтээгдэхүүний чанар, ашиглалтын чанар, чанарын загвар зэрэг программ хангамжийн чанарын шаардлага, үнэлгээний хүрээг бүрдүүлдэг стандарт юм.
- ISO/IEC 15939 стандарт нь хэмжилтийн төлөвлөлт, хэмжилтийн тодорхойлолт, хэмжилтийн хэрэгжилт, хэмжилтийн шинжилгээ, тайлагнал зэрэг программ хангамжийн хэмжилтийн талаар зааварчилгаа өгдөг стандарт юм.
- ISO 25010 нь функциональ байдал, найдвартай байдал, ашиглах боломжтой байдал, үр ашиг, засвар үйлчилгээ, зөөврийн байдал, нийцтэй байдал зэрэг программ хангамжийн чанарын шинж чанар, үнэлгээний хүрээг бүрдүүлдэг стандарт юм. (<https://www.iso.org/>)
- ISO/IEC 25023:2016 нь систем болон программ хангамжийн бүтээгдэхүүний чанарыг ISO/IEC 25010-д тодорхойлсон шинж чанар, дэд шинж чанарын хувьд тоон байдлаар үнэлэх чанарын хэмжүүрүүдийг тодорхойлсон бөгөөд ISO/IEC 25010-тай хамт ашиглахаар хийгдсэн байна. (<https://www.iso.org/>)

- ISO/IEC/IEEE 12207 стандартын гурав дахь хэвлэл [2017] нь программ хангамжийн амьдралын мөчлөгийн үйл явцын хүрээг бүрдүүлдэг стандарт юм. Энэ нь төлөвлөлт, дизайн, хөгжүүлэлт, туршилт, засвар үйлчилгээ зэрэг программ хангамжийг хөгжүүлэхэд оролцдог үйл явц, үйл ажиллагаа, даалгаврын багцыг тодорхойлдог. ISO/IEC/IEEE 12207 нь программ хангамжийг хөгжүүлэх илүү уламжлалт арга бөгөөд хөгжүүлэлтийн үе шаттай, төлөвлөгөөт арга барилд төвлөрдөг.

Товчхондоо ISO 9001 болон ISO 9000 нь чанарын удирдлагын тогтолцоо, чанарын баталгаажуулалтад, ISO 12207 нь программ хангамжийн хөгжүүлэлтийн процессуудад, ISO 25000 болон ISO 25010 нь программ хангамжийн чанарын шаардлага, үнэлгээнд, ISO/IEC 15939 нь программ хангамжийн хэмжилтэд чиглэдэг. Мөн программ хангамж хөгжүүлэх ISO 9001 гэрчилгээ нь байгууллагуудад программ хангамж хөгжүүлэх үйл явцыг сайжруулах, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, программ хангамжийн алдаа, согогийн эрсдэлийг бууруулахад тусалдаг.

Зураг 4 ISO Стандартын хоорондын хамаарал



Эх сурвалж: Судлаач

Судалгааны ажлын хүрээнд судалсан судалгааны ажлуудаас дүгнэхэд Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын менежментийг сайжруулахын тулд:

- Нэгдүгээрт: Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарт нөлөөлөх хүчин зүйлүүдийг удирдах,
- Хоёрдугаарт: Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын зарчмуудыг хангах,
- Гуравдугаарт: Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын менежментийг сайжруулах системчилсэн арга зүйг ашиглах нь чухал бөгөөд байнгын тасралтгүй тууштай байдлыг шаарддаг.

Зураг 5 Чанарын менежментийн процесс



Эх сурвалж: Ben Tomac “WHAT IS QUALITY MANAGEMENT SYSTEM (QMS)?”

2. Судалгааны арга зүй


Судалгааны ажлын хүрээнд монгол улсад үйл ажиллагаа явуулж буй программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллагуудын программ хангамжийн чанарын менежментийн түвшинг үнэлэх судалгаа болон программ хангамжийн бүтээгдэхүүн захиалагч, хэрэглэгч талаас бүтээгдэхүүний чанарыг үнэлэх судалгааг олон улсын ISO стандартын хүрээнд боловсруулж үр дүнг тодорхойлсон.

Судалгааны ажлын хамрах хүрээ

Судалгааны ажлыг тоон ба чанарын аргаар гүйцэтгэсэн бөгөөд анхдагч өгөгдлийг Компьютер програмчлалын үйл ажиллагаа явуулж буй 15 аж ахуй нэгж байгууллагаас асуулга болон ярилцлага хосолсон хэлбэрээр авахаар тодорхойлогдсон. Судалгаа авахдаа программ хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллага талаас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар судалгаа авах оролцогчдын шинж чанарыг хангасан төлөөллийг сонгож нөгөө талаас тухайн байгууллагын программ хангамжийн бүтээгдэхүүний захиалагч, хэрэглэгч талын төлөөллийг сонгож судалгаагаа авахаар төлөвлөсөн.

А. Байгууллагаас авах судалгааны асуулгыг ISO 12207 стандартын чанарын менежментийн процесс болон Чанарын баталгаажуулалтын процессын хэрэгжүүлэлтэд чиглэсэн асуулгуудаар боловсруулсан. Судалгааны үр дүн нь Дотоодын программ хангамж үйлдвэрлэгч байгууллагуудын Програм хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын менежментийг хэрэгжүүлж буй түвшинг тодорхойлж санал зөвлөмж боловсруулахад чиглэсэн. Судалгааны дизайн чанарын менежментийг үнэлэх, чанарын баталгаажуулалтын түвшинг тодорхойлох үндсэн 2 хэсэг, 8 дэд хэсгээс бүрдсэн 43 сонгох хариулт, 5 нээлттэй асуулт байхаар бүтэчилсэн.

Зураг 6. Байгууллагын судалгаа авах асуулгыг боловсруулсан чиглэл



Эх сурвалж: *The four life cycle process groups of ISO 12207 [ISO 17]*

В. Захиалагч, Хэрэглэгчээс авах судалгааны асуулгыг ISO 9126 стандартаар тодорхойлсон программ хангамжийн бүтээгдэхүүний гадаад болон дотоод чанарын шинж чанарын загваруудад тулгуурлан боловсруулсан. Эцсийн хэрэглэгчийн судалгааг явуулснаар программ хангамж хөгжүүлэгчид болон менежерүүд өөрсдийн программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын талаар үнэ цэнэтэй ойлголттой болж, сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлох боломжтой. Судалгааны дизайн нь ISO 9126 стандартаар тодорхойлогдсон программ хангамжийн гадаад, дотоод чанарын зарчмуудын шинж чанаруудад суурилсан үйл ажиллагаа, найдвартай байдал, хэрэглэхэд хялбар байдал, үр ашигтай байдал, тогтвортой байдал, зөөвөрлөх боломж гэх мэт 6 дэд хэсгээс бүрдсэн нийт 8 нээлттэй асуулт, 28 сонгох хариулт бүхий асуулгаас бүрдэнэ.

Зураг 7. Хэрэглэгчийн судалгаа боловсруулахад баримталсан чанарын хэмжүүр




Эх сурвалж: – Quality model for External and Internal Quality – ISO 9126-1[2]

С. Судалгааны ба үр дүн

Судалгаанд нийт ПХ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 15 байгууллагын 20 бүтээгдэхүүний жишээн дээр 35 ажилтнаас судалгаа авсан бөгөөд дээрх 20 бүтээгдэхүүний хэрэглэгч болох 75 эцсийн хэрэглэгчээс судалгаа авсан. Нийт 110 оролцогчоос байгууллагын болон хэрэглэгчийн судалгааг авсан болно.

Програм хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарын менежментийн түвшинг тодорхойлоход Байгууллагын судалгааны үр дүн

Зураг 8 Байгууллагын судалгааны үр дүн



Судалгааны үр дүнгээр програм хангамжийн компаниудын программ хангамжийн бүтээгдэхүүний чанарын менежмент (цаашид ПХБЧМ)-ын түвшин дунджаас дээгүүр гэсэн үнэлгээг авсан бөгөөд судалгааны асуулгын үзүүлэлтүүд болох ПХБЧМ-ын төлөвлөлт, чанарын үнэлгээний үнэлгээ, бэлэн байдал, баталгаажуулах үйл явц, гүйцэтгэлийн хэмжүүр зэрэг үзүүлэлтүүд дээр дунджаар 70-80% орчим хувийн үнэлгээг авсан. Гэсэн хэдий ч ПХБЧМ-ын сургалт, хяналтыг сайжруулах санаа зэрэг үзүүлэлтүүд дээр 64-72% орчим хувийн үнэлгээ авсан байна.

Судалгааны үр дүнгээс харахад програм хангамжийн компаниуд ПХБЧМ-ын хэрэгжүүлэлт тодорхой түвшинд хэрэгжиж байгаа хэдий ч хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэхийн тулд ПХБЧМ-ын

сургалтын процессоо сайжруулж, ПХБЧ-ын хяналтыг сайжруулах шинэ санааг идэвхтэй эрэлхийлж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Байгууллагын судалгааны нээлттэй асуулгын үр дүнг нэгтгэсэн дүгнэлт:

Танай байгууллагын чанарын удирдлагын бодлого, зорилт, журам юу вэ? дурдаж бичнэ үү гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдын 17% орчим хувь нь бодлого, журам байхгүй гэж хариулсан байна. Байгууллага нь чанарын удирдлагын бодлого журам байгаа гэж хариулсан хариултуудыг нэгтгэн дүгнэвэл чанарын удирдлагын бодлого, журамтай компаниудаас ПХБЧМ-ын хүрээнд олон улсад дагаж мөрдөж буй стандартыг хэрэгжүүлдэг байгууллага 12% орчим хувийг эзлэж байгаа нь харьцангуй хангалтгүй үзүүлэлт болох нь харагдаж байна. Байгууллагуудын үлдсэн 75% орчим хувь нь ПХБЧМ-тэй холбоотой дотоод журам, аргазүйг дагаж мөрддөг гэж хариулсан байна.


Дээрх асуулгын хариултуудад дүн шинжилгээ хийж дүгнэхэд байгууллага олон улсын стандартад нийцсэн албан ёсны ПХБЧМ-ын тогтолцоо, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ тогтвортой байдлыг хангах, чанарыг сайжруулахын тулд олон улсын стандартад нийцүүлэн сайтар тодорхойлсон бодлого, журамтай байх нь чухал юм.

Танай байгууллага програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын талаар сургалт явуулдаг уу, Хэрэв тийм бол ямар төрлийн сургалт явуулж байгааг заана уу? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогч байгууллагуудын 45% орчим хувь нь сургалт явуулдаггүй гэсэн хариултыг өгсөн бөгөөд үлсэн 55 орчим хувь нь ПХБЧ-ын анхан шатны сургалт болон ПХБЧМ-ыг хариуцсан ажилтанд сургалт явуулдаг гэж хариулсан байна.

Дээрх асуулгын хариултуудад дүн шинжилгээ хийж дүгнэхэд дийлэнх байгууллага програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын процессын талаар нэгдсэн төлөвлөгөөт болон стандарчилсан сургалт явуулдаггүй нь эргээд ПХ-ын бүтээгдэхүүний чанарт сөргөөр нөлөөлж эцсийн дүндээ амжилтгүй, чанаргүй ПХ-ын бүтээгдэхүүнийг зах заалд нийлүүлэх эрсдэлийг бий болгож байна. Мөн байгууллагууд ажилчиддаа ижил түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхийн тулд ПХ-ын чанарын баталгаажуулалтын стандартын дагуух сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

1-10 оноогоор дүгнэвэл та байгууллагынхаа чанарын баталгаажуулалтын ерөнхий үйл явцыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.


Зураг 9. Байгууллагын судалгааны үр дүн



Судалгааны үр дүнгээс дүгнэвэл ажилчдын дийлэнх нь байгууллагынхаа ПХБЧМ-ын ерөнхий үйл явцыг дундаж болон сайн гэж үнэлсэн бол цөөн хувь нь маш сайн болон муу гэж үнэлжээ. Байгууллага ПХ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг байнга сайжруулахын тулд ажилтнуудынхаа санал хүсэлтийг үндэслэн арга хэмжээ авч сайжруулах нь чухал юм.

Програм хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг үнэлэх Хэрэглэгчийн судалгааны үр дүн

Зураг 10 Хэрэглэгчдийн чанарын хэмжүүр үзүүлэлтүүдийн үнэлгээ



Хэрэглэгчдийн судалгааны үр дүнгээр компаниудын зах зээлд нийлүүлж буй программ хангамжийн бүтээгдэхүүний чанар дундаж буюу 3,8 гэсэн үнэлгээ авсан байна. Гэвч программ хангамжийн бүтээгдэхүүний найдвартай байдал, тогтвортой ажиллагаа, зөврийн чадварын зэрэг үзүүлэлтүүдэд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад бага байгаа нь байгууллагын судалгаанд дурьдагдсан олон улсын стандартад нийцсэн албан ёсны ПХБЧМ-ын тогтолцоо, мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Байгууллага болон хэрэглэгчийн судалгааны дүгнэлт:

Судалгааны үр дүнд үндэслэн энэ салбарын компаниудын ПХБЧМ-ийн практикийн түвшинд ихээхэн ялгаатай байна гэж дүгнэж болно. Зарим компаниуд үнэлэгдсэн бүх

чиглэлээр өндөр үнэлгээ авсан ПХБЧМ-ийн тогтолцоо сайн тогтсон байдаг бол зарим нь харьцангуй бага үнэлгээтэй, сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Байгууллагын судалгааны үр дүнгээс үзэхэд програм хангамжийн компаниуд чанарын менежментийн түвшин харьцангуй сайн байгаа бөгөөд бэлэн байдал, төлөвлөлт, чанарын үнэлгээ зэрэгт хамгийн өндөр үнэлгээ авсан бол ПХБЧМ-ийн сургалт, хяналтыг сайжруулах санаа гэх мэт чиглэлээр доогуур үнэлгээ авсан байна.

Хэрэглэгчдийн санал асуулгын үр дүнгээс харахад программ хангамжийн компаниуд гүйцэтгэл, үр ашгийн хувьд сайн ажиллаж байгаа ч найдвартай байдал, ашиглахад хялбар, тогтвортой ажиллагаа, зөөврийн байдлын хувьд анхаарал шаардлагатай үнэлгээ авсан.

Судалгааны үр дүнгээс харахад ПХБЧМ-ийн тогтолцоо, хэрэгжүүлэлтийн өндөр түвшин нь үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн өндөр үнэлгээтэй эерэг хамааралтай болох нь тодорхой байна. ПХБЧМ-ийн өндөр үнэлгээтэй компаниуд бүтээгдэхүүний гүйцэтгэл, найдвартай байдал, ашиглахад хялбар байдал, үр ашиг, тогтвортой ажиллагаа, зөөвөрлөх чадвар зэргээрээ өндөр үнэлгээтэй байна.

Иймээс тухайн компанийн ПХБЧМ-ийн түвшин болон үйлчлүүлэгчдийн үзэж буйгаар бүтээгдэхүүний чанар хоёрын хооронд өндөр эерэг хамааралтай байгаа нь харагдаж байна. Бүтээгдэхүүнийхээ чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхийг хүсч буй компаниуд ПХБЧМ-ийн арга барилаа сайжруулах, ялангуяа бага үнэлгээ авсан газруудад анхаарлаа хандуулах хэрэгтэй

Санал зөвлөмж

Байгууллагын судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр салбарын түвшинд ПХБЧМ-ийг сайжруулах дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

ПХБЧМ:

- *ПХБЧМ-ийн төлөвлөлтөд анхаарлаа хандуулах:* Судалгааны үр дүнгээс харахад ихэнх програм хангамжийн компаниудад төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах шаардлагатай байна. ПХБЧМ-ийг сайжруулахын тулд компаниуд төлөвлөлтийн бүтэцтэй арга барилыг баримтлах ёстой. Програм хангамжийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төлөвлөлтийг байгууллагын бодлого, журам, стандартын дагуу хийхийг зөвлөж байна. Үүнд програм хангамжийн шаардлага, хамрах хүрээ, зорилго, дизайн, кодчилал, туршилт, байршуулалт зэрэг програм хангамжийг хөгжүүлэх амьдралыг мөчлөгийн бүх талыг харгалзан цогц төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.
- *Бэлэн байдлыг сайжруулах:* Програм хангамжийн компаниуд бүтээгдэхүүнтэй холбоотой аливаа асуудалд хурдан хариу өгөхөд бэлэн байх ёстой. Тэд үйлчлүүлэгчдийн гомдлыг шийдвэрлэх, асуудлыг шийдвэрлэх нарийн тодорхойлсон үйл явцтай байх ёстой. Мөн компаниудад програм хангамж хөгжүүлэх зорилтоо биелүүлэхэд шаардлагатай нөөцтэй байхын тулд нөөцийн удирдлагын төлөвлөгөө боловсруулахыг зөвлөж байна.
- *Чанарын удирдлагын үнэлгээ:* Програм хангамж боловсруулах үйл явц, бүтээгдэхүүний үр нөлөөг хянахын тулд чанарын хэмжүүрүүд болон гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг бий болгох хэрэгтэй. Үүнийг хийхийн тулд компаниуд

чанарын хэмжүүр болон гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг ашиглан програм хангамж хөгжүүлэх үйл явц, бүтээгдэхүүнийхээ үр нөлөөг хянах боломжтой.

ПХ-ын чанарын баталгаажуулалт:

- *Баталгаажуулах үйл явцыг сайжруулах:* Програм хангамжийн бүтээгдэхүүнийг алдаа дутагдалгүй, хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэхийн тулд баталгаажуулалт нь маш чухал юм. Компаниуд автоматжуулсан туршилтын хэрэгсэл, арга техникийг нэвтрүүлэх зэрэг баталгаажуулалтын үйл явцыг сайжруулахад анхаарлаа хандуулах хэрэгтэйгээс гадна Компаниуд өөрсдийн програм хангамжийн бүтээгдэхүүнийг баталгаажуулах бүтэцтэй арга барилыг хэрэгжүүлэх ёстой.
- *ПХБЧМ-ийн сургалтад анхаарлаа хандуулах:* Програм хангамжийн чанарын удирдлагыг сайжруулахын тулд компаниуд ажилчдаа програм хангамж боловсруулах хамгийн сүүлийн үеийн техник, шилдэг туршлагыг мэддэг байх нь чухал юм. ISO 12207 стандартын хүрээнд компаниудад програм хангамж хөгжүүлэх амьдралын мөчлөгийн бүх талыг хамарсан сургалтын хөтөлбөрийг бий болгохыг зөвлөж байна. Компаниуд ажилчдынхаа онцлог хэрэгцээг хангах сургалтын хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй.
- *Програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын хяналтыг сайжруулах санаачлагыг дэмжих:* Компаниуд ажилтнуудаа програм хангамжийн бүтээгдэхүүний чанарын хяналтын үйл явцыг сайжруулах санааг гаргахад нь урамшуулах хэрэгтэй. Тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлж, чанарын хяналтын илүү сайн туршлагыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсан ажилчдыг урамшуулах ёстой.
- *Гүйцэтгэлийн хэмжүүр дээр анхаарлаа төвлөрүүлэх:* Компаниуд бүтээгдэхүүнээ хэрэглэгчийн хүлээлтэд нийцэх эсвэл давсан эсэхийг баталгаажуулахын тулд гүйцэтгэлийн арга хэмжээнд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Компаниуд ахиц дэвшлийг хянах, сайжруулах шаардлагатай газруудыг тодорхойлохын тулд гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжихийг зөвлөж байна.

Дээрх санал зөвлөмжүүдийг програм хангамжийн компаниуд ISO 12207 (2017) олон улсын стандартад заасан удирдамжийг дагаж мөрдөн хэрэгжүүлэх боломжтой бөгөөд энэ нь програм хангамжийн амьдралын мөчлөгийн үйл явц, ПХБЧМ-ийн практикийн хүрээг бүрдүүлдэг. Энэхүү стандартад заасан шилдэг туршлагыг хэрэгжүүлснээр програм хангамжийн компаниуд чанарын удирдлагын тогтолцоогоо сайжруулж, хэрэглэгчдийнхээ хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн өндөр чанартай програм хангамжийн бүтээгдэхүүнээр хангах боломжтой.

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлснээр байгууллагууд програм хангамжийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, бизнесийн болон өрсөлдөх давуу байдлыг бий болгох боломжтой юм.

Хэрэглэгчийн судалгааны үр дүнд үндэслэсэн програм хангамжийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах санал зөвлөмжүүд:

Найдвартай байдлыг сайжруулах: Найдвартай байдлыг сайжруулахын тулд компаниуд туршилт, баталгаажуулалтын үйл явцынхаа чанарыг сайжруулахад анхаарлаа хандуулах

хэрэгтэй. Үүнд илүү дэвшилтэт тест, туршилтын хэрэгсэл, арга техникт хөрөнгө оруулалт хийх, тестийн ажилтнуудын ур чадвар, сургалтыг сайжруулах зэрэг орно.

Тогтвортой үйл ажиллагааг сайжруулах: Тогтвортой үйл ажиллагааг сайжруулахын тулд компаниуд санах ой, боловсруулах хүчин чадал, эрчим хүчний хэрэглээ зэрэг нөөцийг ашиглахдаа илүү үр ашигтай, үр дүнтэй байхаар програм хангамжийн бүтээгдэхүүнээ төлөвлөхөд анхаарах ёстой. Энэ нь илүү үр ашигтай алгоритмуудад хөрөнгө оруулалт хийх, кодыг оновчтой болгох, хамгийн сүүлийн үеийн техник хангамжийн технологийн давуу талыг ашигласан програм хангамжийг хөгжүүлэх зэрэг орох юм.

Зөөврийн чадварыг сайжруулах: Зөөврийн чадварыг сайжруулахын тулд компаниуд программ хангамжийн бүтээгдэхүүнээ платформоос илүү хараат бус байдлаар зохион бүтээхэд анхаарлаа хандуулж, ингэснээр тэд илүү өргөн хүрээний төхөөрөмж болон үйлдлийн систем дээр ажиллах боломжтой болно. Үүнд стандарт API болон хүрээг ашиглах, салбарын стандарт, шилдэг туршлагауудад нийцсэн програм хангамжийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зэрэг орно.

Компаниуд үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн өндөр чанартай програм хангамжийн бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлж байхын тулд төлөвлөлт, үнэлгээ, бэлэн байдал, гүйцэтгэлийн арга хэмжээ зэрэг ПХБЧМ-ийн үйл явцыг сайжруулахад анхаарлаа хандуулах ёстой.

Мөн бид цаашид энэхүү судалгааны ажлынхаа хүрээнд нэмэлт мэдээллүүдийг байгууллагаас судлах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүнд:

- Хөгжүүлэлтийн хугацаа
- Сайжруулалтын/version/ давтамж
- Судалгааны түүврээр сонгогдсон ажилчдад илүү нарийн шалгуур тавих
- Алсын хараа болон зорилго зорилтыг судлан Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн программ хангамжийн үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөөтэй эсэх мэдээллүүдийг цуглуулах.

Судалгаанд оролцсон нийт компаниудын 20 орчим хувь нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ПХБЧМ-тэй холбоотой стандартыг хэрэгжүүлж байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

ПХ-ын зах зээл өдөрөөс өдөрт өсөн нэмэгдэж сүүлийн жилүүдэд Ази номхон далайн бүс нутгийн жилийн нийлмэл өсөлтийн хурд хамгийн өндөр байгаа бөгөөд энэ нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй програм хангамжийн байгууллагуудад таатай боломжийг бүрдүүлж байгаа юм. Энэхүү таатай боломжийг ашиглахын тулд Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын удирдлагын стандартыг хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд компаниуд програм хангамж боловсруулах үйл явцад хэрэглэж болох чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлдэг ISO 9001 зэрэг чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх ёстой. Програм хангамжийн амьдралын мөчлөгийн үйл явцын хүрээг бүрдүүлдэг ISO 12207 стандартыг програм хангамж хөгжүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэхэд ашиглаж болно. Олон улсын стандартуудыг програм хангамжийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл явцдаа нэвтрүүлэн дагаж мөрдсөнөөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд

програм хангамжийн бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, олон улсын түвшинд хүргэх боломжтой. Энэ нь дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай болгож, хэрэглэгчдийнхээ эрэлт, хүлээлтийг хангах боломжтой болохоос гадна өрсөлдөх давуу байдлыг бий болгох юм.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- ASQ. (2021). What is software quality. *ASQ*, Retrieved.
- Colantonio, J. (2022 оны 8 31). *Test Guild by Joe Colantonio*. testguild.com:
<https://testguild.com/software-quality-management-testops/>-ээс Гаргасан
- Documentation, I. S. (2013). <https://standards.ieee.org>. <https://standards.ieee.org/ieee/829/3787/>:
<https://standards.ieee.org/ieee/829/3787/>-ээс Гаргасан
- Dr.Ulbert, Z. (2014). *Software development process and software quality assurance*. Hungary: University of Pannonia.
- Emanuel Irrazabal, F. V. (2011). Applying ISO/IEC 12207:2008 with SCRUM and Agile Methods. *Software Process Improvement and Capability Determination* (хуудсд. 169–180). Dublin, Ireland: Springer. https://link.springer.com/chapter/10.1007/978-3-642-21233-8_15:
https://link.springer.com/chapter/10.1007/978-3-642-21233-8_15-ээс Гаргасан
- Emanuel Irrazabal, F. V. (2011). <https://link.springer.com/>. https://link.springer.com/chapter/10.1007/978-3-642-21233-8_15: https://link.springer.com/chapter/10.1007/978-3-642-21233-8_15-ээс Гаргасан
- Foundation, B. (2021). <https://software.org/>. <https://software.org/reports/software-supporting-us-through-covid-2021/>: <https://software.org/wp-content/uploads/2021SoftwareJobs.pdf>-ээс Гаргасан
- Group, W. B. (2018). <https://documents.worldbank.org/>.
<http://documents.worldbank.org/curated/en/576101543874150141/Mongolia-Systematic-Country-Diagnostic>: <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/576101543874150141/mongolia-systematic-country-diagnostic>-ээс Гаргасан
- Help, S. T. (2023 оны 3 21). www.softwaretestinghelp.com.
<https://www.softwaretestinghelp.com/software-quality-assurance/>:
<https://www.softwaretestinghelp.com/software-quality-assurance/>-ээс Гаргасан
- Juran, J. M., & Godfrey, A. B. (1998). *Juran's quality handbook*. USA: R. R. Donnelley & Sons Company.
- Kan, S. H. (1994). *Metrics and Models in Software Quality Engineering*. USA: Addison-Wesley Longman Publishing Co., Inc. ISBN:978-0-201-63339-9.
- Laporte, C. Y., & April, A. (огноо байхгүй). <https://olea.org/>. https://olea.org/recursos/2017-Laporte_April-Software_Quality_Assurance/2017-Laporte,%20April-Software%20Quality%20Assurance,%20First%20Edition-9781119312451.pdf:
https://olea.org/recursos/2017-Laporte_April-Software_Quality_Assurance/2017-Laporte,%20April-Software%20Quality%20Assurance,%20First%20Edition-9781119312451.pdf-ээс Гаргасан
- Lee, M.-C. (2014 оны 7). <https://www.researchgate.net/>.
https://www.researchgate.net/publication/264121662_Software_quality_factors_and_software_qua

lity_metrics_to_enhance_software_quality_assurance_BJAST:

https://www.researchgate.net/publication/264121662_Software_quality_factors_and_software_quality_metrics_to_enhance_software_quality_assurance_BJAST-ээс Гаргасан

Lee, M.-C., & Chang, T. (2013). Software measurement and software metrics in software quality. *International Journal of Software Engineering and Its Applications*, 16-17.

Marketsandmarkets. (2023). *Market, Quality and lifecycle Management Software*.: Marketsandmarkets.

Martin deMartini, S. V. (2016 оны 11 08). *3 Premium Ways To Prevent IT Project Failure*. MSP insight: <https://www.mspsights.com/doc/premium-ways-to-prevent-it-project-failure-0001>-ээс Гаргасан

Owens, D. M., & Khazanchi, D. (2009). Software Quality Assurance. D. M. Owens, & D. Khazanchi-Д, *Software Quality Assurance* (хуудсд. 242-263). USA: Information Science Publishing.

PMI, P. M. (2020). *Information Systems Project Management Managing Project Costs and Quality*. Project Management Institute (PMI).

Pressman, R. S. (2010). *Software engineering : a practitioner's approach — 7th ed*. 1221 Avenue of the Americas, New York, NY 10020: Raghothaman Srinivasan.

Rawat, M. S., Mittal, A., & Dubey, S. (2012). *Survey on Impact of Software Metrics on Software Quality*.

report, M. a. (2018). *Quality Management Software Market Size, Share & Trends Analysis Report By Solution, By Deployment, By Enterprise Size, By End-use, By Region, And Segment Forecasts, 2023 - 2030*. Grand view research. <https://www.grandviewresearch.com/industry-analysis/quality-management-software-market#>: <https://www.grandviewresearch.com/industry-analysis/quality-management-software-market#>-ээс Гаргасан

Rothman, J. (2009). *Manage Your Project Portfolio: Increase Your Capacity and Finish More Projects*. Pragmatic Bookshelf ISBN: 978-1-934356-29-6.

Saunders, M. L. (2012). Research Methods for Business Students. *Scientific research*, 134.

Standardization, I. -I. (2000). <https://www.cse.unsw.edu.au/>. <https://www.cse.unsw.edu.au/~cs3710/PMmaterials/Resources/9126-1%20Standard.pdf>: <https://www.cse.unsw.edu.au/~cs3710/PMmaterials/Resources/9126-1%20Standard.pdf>-ээс Гаргасан

Standardization, I. -I. (2000). *Quality in lifecycle*.

Standardization, I. -I. (2007). <https://www.iso.org>. <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec:15939:ed-2:v2:en>: <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec:15939:ed-2:v2:en>-ээс Гаргасан

Standardization, I. -I. (2011). www.iso.org. <https://www.iso.org/standard/35733.html>: <https://www.iso.org/standard/35733.html>-ээс Гаргасан

Standardization, I. -I. (2014). www.iso.org. <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec:25000:ed-2:v1:en>: <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec:25000:ed-2:v1:en>-ээс Гаргасан


Standardization, I. -I. (2015). www.iso.org. <https://www.iso.org/iso-9001-quality-management.html>: <https://www.iso.org/iso-9001-quality-management.html>-ээс Гаргасан

Standardization, I. -I. (2017). www.iso.org. <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec-ieee:12207:ed-1:v1:en>: <https://www.iso.org/obp/ui/#iso:std:iso-iec-ieee:12207:ed-1:v1:en>-ээс Гаргасан

Statista. (2022). <https://www.statista.com/>. <https://www.statista.com/forecasts/954176/global-software-revenue-by-segment>: <https://www.statista.com/forecasts/954176/global-software-revenue-by-segment>-ээс Гаргасан

- The Project Management Institute, I. (. (2008). *Project management body of knowledge (PMBOK GUIDE)*. USA: The Project Management Institute, Inc.
- Томас, В. (2019). <https://www.youtube.com/>. <https://www.youtube.com/watch?v=c1CpcZuDUtQ>:
<https://www.youtube.com/watch?v=c1CpcZuDUtQ>-ээс Гаргасан
- Toni Somers, “. (2019). Strategic Information Systems. *The Journal of Strategic Information Systems* , 19:207-228.
- Пфлегер, Ф. б. (1997). Glossary of Software Engineering Terminology. *IEEE Standard Glossary of Software Engineering Terminology, IEEE Std* , 610.12-1990.
- С.Анхбаяр. (2022). <https://ikon.mn/>. <https://ikon.mn/n/2pq9>: <https://ikon.mn/n/2pq9>-ээс Гаргасан

НАА - 74.58
ДАА - 378
Ц - 395



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
Глобал Эдийн Засгийн Судалгааны Хүрээлэн

Хаяг: 13381. Монгол Улс. Улаанбаатар-49.
Энхтайваны өргөн чөлөө 5а. БЗД. С байр, 1108 тоот өрөө
Утас: +976-7000 8085 + (1050, 1051)
Факс: +976-11-458378
E-mail: rdp@ufe.edu.mn
URL: www.ufe.edu.mn